

ШЯДЯР ГҮРВЯН ЦЭРЭГ



ЯВКСЯНАР АЮМЯ



Александр Дюма

ШАДАР ГУРВАН ЦЭРЭГ

www.ibooks.mn

I. Д'АРТАНЬЯН ЭЦГИЙН ГУРВАН БЭЛЭГ

1625 оны дөрөвдүгээр сарын эхний нэгэн даваа гаригт билээ. Дээр цагт "Саргай цэцгийн тухай роман бичсэн хүний мэндэлсэн бяцхан Менг хотод хугенотууд Ларошелийн явдлыг дахин гаргахаар завдан байгаа юм уу гэмээр тэр хотын хүн ард үймэлдэн сандарч байв. Бүсгүйчүүд төв гудамж өөд гүйлдэж, хүүхэдбосгон дээрээ уйлалдахыг үзсэн хотын зарим иргэд хуяг дуулгаа яаран өмсч сүр бадруулах гэж зарим нь цахиур буу, зарим нь алман сүх бариад "чөлөөт тээрэмчид" гэгч зочид буудал өөд тэмүүлцгээв.

Буудлын өмнө хэрэгт дуртай баахан хүн цугларчихсан минут тутам олширсоор байлаа. Юм л бол ингэж үймээн дэгддэг цаг билээ. Аль нэг хотгүүх судартаа ийм явдал тэмдэглэхгүй өнгөрөх өдөр ховорхон байдаг сан.

Ихэс дээдсээс хоорондоо арцалдаж, ван эзэн өөрөө их хамбатай тэмцэлдэж, Испаничууд вантай байлдаж байсан цаг. Ил далд, илэрхий, нууцаар болж байсан тэр тэмцлийн хажуугаар бүгдтэй дайсагнасан гуйлгачин, хугенот тэнүүлчин зарц нар гэж бас байсан юмаа.

Хулгайч тэнүүлч, зарц нараас сэргийлж хотын иргэдзэвсэг барин байн байн язгууртан ихсийн өөдөөс, хааяа заримдаа вангийн өөдөөс эсэргүүцдэг боловч, хамба лам испаничууд хоёрын өөдөөс хэзээ ч гар хөдөлдөггүй байв. Тэр 1625 оны дөрөвдүгээр сарын эхний даваа гаригт нэг их чимээ шуугиан сонссон хотын иргэд улаан шар тэмдэг, Ришелье герцогийн зарц нарын хувцас аль алиныг олж харалгүй нөгөө л дадал болсонзаншлаараа "чөлөөт тээрэмчний" буудал өөд гүйлджээ. Хөл үймээний учир тэнд очсон хойно л сая хүмүүст ил боллоо.

Залуу эр... төрх байрыг нь гаргаж хэлэхийг хичээвээс: ердөө арван наймтай Дон Кихот хуяг дуулга халхавч сэлтгүй, тунгалаг цэнхэр, шаргал хоёрын хооронд болж гандсан хөх ноосон цамцтай явж байна л гэж бод. Гонзгойдуу бор царайтай, товгор шанаатайгий нь харваас лав зальтай байж таармаар ажээ. Гаскон мужийн хүнийг уул нь нутгийн мухар малгайгаа өмсөөгүй байлаа ч гэсэн, айхтар чийрэгжсэн эрүүний булчингаар нь андалгүй таньж болох авч, залуу эр өдөрхүү юмаар гоёсон мухар малгай бас тавьжээ. Харц нь шулуун ухаалаг монхордуу гэлээ ч дэгжин хянга хамартай, бага хүү гэвэл хэт горзгор, том хүн гэхэд арай намхан нуруутай... Явган явахад хөлий нь гуядаж, мордсон хойно морины нь үсийг сөргөөх суран тоногтой урт, хатгуур илд зүүгээгүйсэн болж гэм, туршлага муутайхан хүн түүнийг нэг тариачин эзний хүү юманд явж байгаа байх гэж санамаар.

Юу гэвэл, мань залуу морьтой, тэхдээ бүр хүн бүхэн сониучирхмааргойд содон морь унажээ. Залуугийн хонгор шарга морь уул нь Беари нутгийн унага, арван хоёр, арван дөрөв ч хүрсэн байж мэдэхээр хөгшин, сүүл нь шодон болоод сагагаараа хавдар суужээ. Шарга морь толгойгоо өвдөгнөөсөө доош унжуулаад, эзэндээ жолоо татуулж тээр бололгүй шогшихдоо бас яг ч үгүй, өдөрт долоон мод явчихдаг гэнээ. Гай болоходшаргал морины тэр чанар нь ёозгүй зүс сүр жавхаа муутайдаа дарагджээ. Хүн бүр морь мэддэг байсан тэр цагт беари нутгийн тэр морь Менг хотын хаалгаар орж ирээд мөч хир болохдоо хүн амьтны нүдэнд базаалтгүй харагдаж, эзнийхээ сүрийг хүртэл дарж байлаа.

Залуу Артаньян (шинэ Росинант унасан шинэ Дон Кихотын алдар нь юмсанжээ) моринд

хэдий сайн гэлээ ч, ийм унаатай явахдаа инээдтэй харагдах ёстойг өөрөө сайн мэдэж, улам ч сүрхий зовж явав. Эцэг Артаньяны энэ бэлгийг авахдаа хүү өөрийн эрхгүй санаа алдсан нь ч бас аргагүй шүү. Тийм морины үнэ дээр хаяад хорин ливраас хэтрэхгүйг тэр хүү сайн мэдэж байв. Гэхдээ энэ бэлгийг өхөд хэлсэн үгийнүнэтэйг бас үгүйсгэхийн эрх байхгүй.

-За хүү минь, энэ морь арван гурван жилийн өмнө манайд гарснаасаа хойш энэ завсар тусаа өгсөөр ирсэн унаа шүү. Тэхлээр ч морио хайрлах биз, юу ч болсон чи морио битгий зараарай, зөнд нь асарч байгаад үхүүлчээрэй, энэ морьтойгоо аян дайнд явах болбол хүн хөгшин зарцаа өрөвддөг шиг үүнийгээ хайрлаж яваарай гэж ёстой беари аялгуугаар ярьдаг тэр гаскон нутгийн тайж хүүдээ захив. IV Генрих хүртэл бас нутгийнхаа аялгуунаас насан туршаа салж чадаагүй юм гэдэг. д'Артаньян эцэг үгээ залган,-чи эртний язгуур сурвалжтай хүн болохоор ордонд ойр шадар болж болох л ёстой.

Тэхлээр ордонд ойр шадар болбол өөрийгөө, ойр дотно хүмүүсээ бодож эцэг дээдэс мааньтаван зуун жилийн турш нэр төртэй авч ирсэн тайж алдраа өргөж яваарай. Ойр дотно хүмүүс гэж би төрөл садан, сайн нөхдийг чинь хэлж байгаа юм. Ван, их хамба хоёроос өөр хэнд ч бүү захирагд. Манай үед тайж хүн ердөө эр зоригоор л дуулж байгаа биз, ганцхан зоригоор л замаа олж байгаа юм. Хүн эгшин зуур дальдрахад л тэр эгшинд заяаж байсан хишгийг алдаад тавчихаж мэдэх юм шүү. Чи идэр залуу байна. Нэгд чи гаскон хүн. хоёрт миний хүү болохоороо, энэ хоёр шалтгаанаар чи эр зоригтой байх ёстой. Цаг зуурдын юмнаас айлгүй, төвөгтэй хэрэг эрж л яв. Би чамд сэлэм барьж сурах боломж өгсөн. Чигартаа бүлтэй сэлмэнд гарамгай болсон. Алив шалтгаар л хүнтэй тулалдаж, эрүүл тулалдаан хийж яв. Эрүүл тулалдаан хориотой, тэх тусам тулалдахад хоёр дахин их зориг хэрэгтэй болох нь байна шүү дээ. Би чамд хүү минь бэлэн мөнгө гэвэл ердөө арван таван экю, морь, бас сая өөрийн чинь дуулсан зөвлөлгөө, эднийг л өгье дөө. Ээж чинь үүн дээр зүрхнийхээс бусад алив шарх эдгээх гайхамшигт чадалтай нэг тосны жор хэлж өгнө. Эд бүгдийг хэрэглэ, урт удаан, жаргалтай сайхан амьдраарай. За над одоо хэлмээр ганц л юм байна. Юу гэвэл дууриал болох хүн чамд зааж өгөх хэрэгтэй. Би өөрийгөө зааж чадахгүй, үнэн шажны төлөө дайнд сайн дураараа явж байснаас биш би ордонд шадар явсангүй. Дээр цагт манай хөрш байсан Де Тревиль гуайг би зааж өгье гэж байгаа юм. Бурхан минь багадаа тэр манай талийгаач XIII Людовик вантай тоглож байсан хүн. Тоглоом нь шоглоом болж зодоо гарах удаа ч байдаг, зодолдохдоо ван тэр болгон дийлдэггүй байсан даг. Ван ингэж цохиулсандаа де Тревиль гуайд нөхөрсөг сайн болж их л хүндэтгэдэг болсон юм. Де Тревиль гуай хожим Парис хотод анх очих замдаа таван удаа бусадтай тулалдсан. Талийгаач ван нас бараад, залуу ванг насанд хүртэл, аян дайныг оролцуулахгүйгээр долоон удаа, ванг насанд хүрснээс хойш одоо хүртэл лав зуу дахин тулалдсан хүн дээ! Тэгээд л алив горим журам, тушаал, тогтоолыг харгалзалгүйгээр де Тревиль гуай одоо шадар цэргийн, ухаандаа цезарийн торгон цэргийн захирагч болоод байна. Ванд ихээ үнэтэй, их хамбыг ч зүрхшүүлдэг хүн дээ. Өөрөө бол юмнаас айх нь бараг байдаггүйг хэн хүн андахгүй. За түүнээс гадна де Тревиль гуай жилдээ арван мянган экюгийн цалин авдаг юм. Тэхлээр яриагүй л ихэсдээдсийн нэг дээ. Эхлэхдээ бол тэр чам шиг л эхэлсэн хүн. Энэ захиаг аваад өөр дээр нь оч, түүнээс дууриал авч түүн шиг яв гэлээ.

Ингэж хэлээд эцэг д'Артаньян гуай хүүдээ өөрийнхөө илдийг хайрлаж,. хоёр хацрыг нь энхрийлэн үнсээд, сайн сайхан явахыг ерөөв. Залууг эцгийнхээ өрөөнөөс гартал нөгөө сүртэй

эмний жорхэлж өгөхөөр хүлээж байсан эхтэйгээ дайралдав. Дээр эцгийн өгсөн зөвлөгөөгөөр явах болж гэм, тэр эмийг хэрэглэх цаг олон л гарах бололтой. Эцгийг бодвол эх хүү хоёр хагацахдаа ихээ удаж энхрий уян байсан нь чухамдаа эцэг нь ганц хүүдээ хайргүйгээс ч болсон хэрэг биш ээ. д'Артаньян гуай сэтгэлээ дураар нь тавихыг эрхүнд зохихгүй зүйл гэж санадаг байсан гэхэд д'Артаньяны авгай бол эх хүн, бүсгүй хүн байлаа. Авгай гашуун нулимс асгаруулна. Бага д'Артаньян гуай ч гэлээ хөөрхий алсдаа шадар цэрэг болох хүн гэж биеэ барихыг хэдий хичээвч сэтгэл нь дийлээд зөндөө уйлж, нулимсныхаа хагасыг арай чарай гэж нуусан билээ. Залуу эр эцгийнхээ өгсөн арван таван экю, морь, де Тревиль гуайд өгөх захиа ийм гурван бэлэг аваад алс замдаа мордов. Зөвлөгөө мэдээжээр бэлгийн тоонд орохгүй шүү дээ. Бид намтарч хүний хувиар залуугийн дүрийг гаргаж дээр хэлэхдээ нөгөө Сервантесийн баатартай сүрхий оновчтой зүйрлүүлсэн шүү дээ. Замдаа иймэрхүү сургаал аваад мордсон д'Артаньяны төрх байр, сэтгэл санаааль алинаараа Дон Кихотоос ялгарах юмгүй байлаа. Дон Кихот салхин тээрмийг үлэмж биет, хонин сүргийг их цэрэг гэж эндүүрдэг байсан. д'Артаньян инээмсэглэл бүрийг доромжлол, харц бүрийг өдөлт гэж үзэн явлаа. Тэхлээр Тарбаас Менг хүрэх зам зуураа зангидсан гараа тайлсангүй, илднийхээ ишийг арваас цөөнгүй шүүрч явлаа. Гэхдээ залуу эр нударгаараа хүний эрүү зад цохисонгүй, илдээ хуйнаас нь сугалаагүй билээ. Ясан хэдрэг болсон золгүй морьтой дайралдсан хүний инээд хүрэх нь хүрэх боловч, уртын урт илд морины хавирга гуядаж, дээшлээд бас эзний нүд бардам ихэмсгээсээ илүү омог хилэнгийн очоор гялалзаж байгааг хараад нөгөө улс инээдээ барина. Даанч хөгийн санагдаж болгоомжлоод, болгоомжлоод инээдээ барьж дийлэхгүйд хүрсэн хүн эртний баг шиг ядаж өрөөсөн талаараа инээхийг хичээнэ. д'Артаньян ихэмсэг дүрээ хадгалж дүрэлзсэн түргэн омгоо гаргалгүй явсаар гайтай Менг хотноо хүрч ирлээ.

д'Артаньян "чөлөөт тээрэмчний" үүдэнд тулж ирээд, гийчний дөрөө түшиж өгөх буудлын эзэн зарц юм уу морь маллагч аль нэг хүний тусламжгүй өөрөө буув. Тэнд хоёрдугаар давхарт нээлттэй байгаа нэг цонхны цаана өндөр нуруутай ихэмсэг дүрт тайж хүнбайхыг харлаа. Яравгар хүйтэн царайтай тэр тайж, хажуудаа байгаа хоёр хүнд нэг юм ярьж нөгөөдүүл нь хичээнгүйлэн сонсож байх бололтой.

д'Артаньян болсон хойно, дороо л өөрийнхөө тухай ярьж байгаа бий гэж хардаад чих тавин чагнаваас энэ удаа оночихсон, бараг оночихсон байв. Чухамдаа өөрий нь тухай ч биш, морины нь тухай яриабож байжээ. Тэр хүн янз нь морины хамаг эгзгийг тоочиж байгаа бололтой. Цаадуул нь миний түрүүн хэлснээр түүнийг маш хичээнгүйлэн сонсож, үг дуугарах бүрд тачигнатал хөхрөлдөж байв. Инээмсэглэх төдийд л манай баатрын шар хөөрөөд ирдгээр жишээд бодоход ингэж бөөн инээдэм, хөөр болж байгааг хараад чухам яасны нь таахад хялбар билээ. д'Артаньян юуны өмнө өөрийгөө шоолж зүрхэлсэн сонжуургүй этгээдийн царайг харах гэлээ. Тэр хүний эгц өөдөөс зоримог харцаар ширтвэл хурц хар нүд, цонхигор царай, том хамартай, сүрхий нямбай зассан хар сахалтай, дөч эргэм насны хүн байлаа. Тэр хүний өмссөн ягаавтар өнгийн өмд цамц мөн тийм өнгийн бүчтэй, ердийн онооноос өөр элдэв янзгүй, онооны нь завсраар дотуур цамц цухуйж харагдана. Цамц өмд хоёул хэдий шинэ боловч авдранд удтал дарагдсан аян замын хувцас аятай сүрхий үнгэгджээ. д'Артаньян нарийн ажигч хүний хувьд, амьдралдаа тэр хүнтэй сүрхий харгалдах тавилантайг зөнгөөр гадарласан ч байж магадгүй, эгшин зуур эд бүгдийг ажиж амжив.

За тэгээд, ягаан цамцтай хүн рүү д'Артаньяныг харах үед цаадах нь Беари морины тухай

хамгийн давстай, хорон үгнийхээ нэгийг хэлэв. Чагнаж байсан хоёр тачигнатал хөхөрч өөрийг нь лав ховорхон баясдаг болтой царай хүртэл инээмсэглэх аятай болов. д'Артаньяныг ёстой доромжилсон нь одоо ч бүр эргэлзэх юмгүй боллоо. Мань залуу тэрний нь сайн мэдээд, мухар малгайгаа дарж духдуулав. Гасконнутгаар явсан язгууртан ихсээс харж авсан ордны зан заншлыг дууриах санаатай нэг гараа илднийхээ ишнээс барьж нөгөөгөөрөө ташаа тулан урагшаа алхав. Гай болоход уурандаа өөрөө улам улам автсаар бардам ихэмсэг үгээр тулалдах дуудлага хийх бодолтой байснаа эцэстээ, зүгээр учир зүггүй занган, хэдэн ширүүн үг хэлэхээс өөр чадалгүй болжээ.

-Хүүе эрхэм ээ! Та. Цонхны цаана нуугдаад байгаа тэр хүн та! Юу ингэтэл шоолоод байгаагаа хэлж хайрлаач, цуг инээе!-гэж хашгирав.

Зам яваа сурвалжит хүн мориноос хараагаа алгуурхан эзэн рүү нь шилжүүлэв. Өөрийгөө ийм хачин хүн зэмлэж байна гэдгийг тэр хүн даруйдаа ойлгосонгүй бололтой. Эцэстээ эргэлзэх газар нэгэнт үгүй болсон хойно, хөмсгөө үл мэдэг зангидав. Нэлээдудаан дуугүй байснаа зүйрлэн хэлэхийн эрхгүй егөөтэй дээрэнгүй өнгөөр:

-Өршөөлт эрхэм ээ, би тантай яриагүй байна санж-гэж хариулав.

Сонжуургүй байдал, ёсорхуу зан, хүндэтгэл басамжлал, холилдсон тэр үгэнд залуу д'Артаньяны хилэн бадарч:

-Тэгвэл би тантай ярьж байна! гэж дуу алдав.

Цаад хүн хэсэг зуур д'Артаньяныг нүд салгалгүй ширтэж байснаацонхноос холдож буудлаас алгуурхан гарч ирээд, залуугаас хэдэн алхам газар, морины нь халз өөдөөс харж зогсов. Нөгөө хүний ёжуун амгалан царай, цонхны дэргэд зогсож үлдсэн нөхдөө бүр ч хөгжөөлөө. Түүнийг ойртож ирэхэд, д'Артаньян илдээ сайн тохой сугалав.

д'Артаньян хэдийгээр тэр хүн морь хоёрын дунд зогсож байсан боловч, цаадах нь гаскон залуугийн зэвүүцэж байгааг үзээгүй аятай нөгөөдүүл рүүгээ хандаж яриагаа залган, нээрээ, энэ морь шав шар зүстэй, үгүй, нарийн яривал урьд тийм зүстэй байж шүү. Ургамлын аймагт өргөн дэлгэрсэн энэ өнгө шиг морины зүс ийм байх нь өнөө хүртэл тун ховор үзэгдсэн юм гэлээ. Де Тревилийг дуурайгч залуугийн омог бадарч

-Эзний нь дооглох зүрхгүй этгээд лмориор оролддог юм! гэж хашгирав.

Цаад хүн хариуд нь,

-Эрхэм минь, би ховорхон инээдэг хүн. Миний царайг хараад та тааварлаж байгаа байхаа. Гэхдээ би дуртай цагтаа инээх эрхгүй байх санаатай юм шүү гэв.

Тэгвэл би таныг дуртай цагтаа инээлгэхгүй гэж д'Артаньян сөргөв.

-Нээрэн тийм үү, эрхэм ээ? гэж цаад хүн амгалан гэгч нь лавлаад, -Яая гэх вэ, аргагүй л зөв дөө гэлээ. Тэгээд өсгий дээрээ эргэж буудлын хаалга руу алхав. д'Артаньян сая орж ирэхдээ,

тэнд эмээлтэй морь байхыг харсан ажээ.

д'Артаньян гэдэг тэгж өөрийгөө дооглож зүрхэлсэн хүнийг зүгээр, явуулчхаар хүн биш байв. Илдээ хуйнаас нь суга татажаваад доромжлогч этгээдийн хойноос ухас хийж: -Эргээрэй араас чинь цохих нь байна шүү. Эргэж үзээрэй! гэж хашгирав.

-Надыг цохих гэж үү? гэж нөгөө хүн дуу алдаад өсгий дээрээ цочмог эргэн залууг гайхсан, басамжилсан байртай хараад, хонгор минь, яаж байгаа нь тэр билээ. Та лав солирсон дог шүү гэлээ.

Цааш нь ганцаараа байгаа юм шиг аяархнаар залган:

-Бас гай яа! Тэгээд ч буучдынхаа тоог нөхөх гэж зоригтой эрс газар сайгүй эрж байдаг их эзэнтэнд л сайхан олз байна...

Энэ үг хэлж дуусаагүй байтал нь д'Артаньян уулгалан дайрсанд мань эр амжиж зайлаагүйсэн бол энэ хошигнол лав түүний эцсийн үг болохсон бизээ. Хэрэг биш болж байгааг цаад хүн ойлгож, илдээ суга татаад, довглогч руу мэхийн, үнэнээсээ хариуцахаар зэхэв. Гэтэл яг энэ үеэр нөгөө ярилцаж байсан хоёр нь буудлын эзэнтэй хүч хавсран саваа, хүрз, галын шилээвэр барьсаар д'Артаньян руу дайрч учир зүггүй нүдэв. Гэнэт ингэж дайрсан нь тулалдааны явцыг эрс өөрчилж д'Артаньян зайгүй бууж байгаа цохилтоос биеэ хамгаалахаар эргэснийг цаадах нь ашиглаж илдээ тайван гэгч нь хуйлчихав. Гарсан хэрэг төвөгт өөрөө биеэрээ оролцох алдсанаа, хөндлөнгийн хүн болчихоод ердийнхөө хэнэггүй байдлаар харж байлаа. Гэлээ ч мань эр, -Энэ гаскончуудыг ер чөтгөр алгадмаар улс шүү гэж үглээд

-Наадахаа тэр шар морин дээр нь мордуулчих. Мөрөөрөө арилаг цаашаагэв. д'Артаньян гурван дайсныхаа өөдөөс халз зогсоод зай завсаргүй буусаар байгаа цохилтыг чадах хирээрээ няцааж:

-Хулчгар минь чамайг алахаас нааш явахгүй гэж хашгирав.

-Гасконы сайрхалт байна! Нээрээ энэ гаскончууд засаршгүй улс шүү, та минь! За яахав, өөрөө дурлаад байгаа юм бол сайн нүдээд өг! Тэсэхээ байгаад ирэхээрээ өөрөө хэлнэ биз, гэж тэр хүн үглэв.

Гэтэл хаашаа зөрүүд хүнтэй учирснаа тэр мэдсэнгүй. д'Артаньян өршөөл гуйхаар эр биш аж. Иймээс тулалдаан бас хэдэн секунд үргэлжлэв. Эцэстээ залуу хүн тэнхээ тасарч шийдмэнд хуга цохиулсан илдээ алдчихлаа. Дараачийн цохилт духыг нь хага цохиж, мань хүү цусаа савируулсаар бараг ухаан алдан ойчив.

Яг энэ үеэр ардиргэд хэрэг гарсан газар руу тал талаас гүйж ирэв. Буудлын эзэн элдэв үг ярианаас айж, зарцтайгаа хамжин шархадсан залууг гал зуух руу дамжилж ороод аар саархан тусламж үзүүлжээ.

Харин цаад хүн нөгөө цонхныхоо дэргэд буцаж ирээд, цугларсан олныг сүрхий зэвүүцсэн байртай илт дургүйцэн хялалзаж байв.

Үүд онгойх чимээгээр тэр хүн эргэж, сэтгэл тавтай эсэхийг нь лавлахаар ирсэн буудлын эзнээс, -Цаад хэнээт чинь яаж байна! гэж асуув.

-Эрхэм та өөрөө гэмтэж бэртсэн юмгүй биз дээ? гэж буудлын эзэн асуув.

-Эв эрүүл, эелдэг эзэн минь. Гэхдээ манай залуу эр яасныг би мэдмээр байна. -Тэр засарч байна. Бүр ухаан алдчихсан гэж буудлын эзэн хариулав.

-Нээрээ юу? гэж нөгөө хүн лавлав.

-Гэхдээ ухаантай байхдаа хамаг хүчээ шавхаад таныг дуудаж, харааж, тулалдахыг шаардаж байсан.

-Ёстой чөтгөр юм даа! гэж цаадах нь дуу алдав. Буудлын эзэн элэг барьж ярвайгаад хариу маргаж,

-Ердөө тийм бишээ, эрхэм минь ухаангүй хэвтэх зуур нь бид түүнийг нэгжээд үзсэн, боодолтой юманд нь ердөө ганцхан цамц, хэтэвчинд нь арван нэгэн экю байна билээ. Тэгсэн мөртлөө тэр залуу ухаан алдахдаа энэ явдал Парист болсон болж гэм таныг дороо гэмшихэд хүрэх байсан, хожим гэмших л болно доо гэж үглэсээр байсан.

-Тэгвэл, вангийн угсаат тайж хувцсаа сольчихоод яваа юм байгаа биз гэж нөгөө хүн хүйтнээр дуугарав.

-Эрхэм таныг мэдэж аваг, сэргийлэх нь зүйтэй гэж би бодлоо шүү гэж буудлын эзэн дуулгав. -Цаадах чинь уурандаа хүний нэр дурсаагүй биз!

-Дурсахаар барах уу! Хармаагаа алгадаж "Де Тревиль гуай өмөгтөө байгаа хүнийг ингэж доромжилсныг мэдээд юу гэхийнх үзье" гээд л байна билээ.

Цаад хүн сэрт гэж,

-Де Тревиль гуай гэнээ? Хармаагаа алгадаж, Де Тревиль гуайн нэр дурсаад байлаа гэнээ?... За тэгээд яав хүндэт эзэн гуай? Мань залууг ухаангүй байх зуур та лав хармаа руу нь хараад аваа шүү дээ. Тэнд тэгээд юу байх юм?

-Шадар цэргийн даамал де Тревиль гуайд гэж хаягласан захиа байна.

-Тийм бий?

-Яг л эрхэм танд миний айлтгаж байгаа ёсоор юм. Энэ үгийг дуулаад цаад хүний царай хаашаа өөр болсныг онц ажигч биш буудлын эзэн харсангүй. Тэр хүн, сая болтол яс модыг нь түшээд зогсож байсан цонхноосоо зайлж, сэтгэл тавгүй болж хөмсгөө зангидаж, шүдээ зуун; -Шулам гэж хараал тавив. Энэ гаскон залууг над руу Тревиль явууллаа гэж үү дээ! Даанч балчир юм даа. Гэсэн ч илдээр бүлэх л юм шүү дээ, бүлээд орхиход хүний нас юун хамаатай вэ. Тэр дундаа жаал хүү бүр ч сэжиг төрүүлэхгүй юм байгаа биз. Ер нь хэтийн их зорилгонд шалигүй саад хөндөлдчих явдал байдаг -гээд хэсэг зуур бодолд автлаа. Эцэстээ тэр ам нээж

буудлын эзэнд

-Та байна шүү. Цаад хэнхэг эрээсээ надыг нэг ангижруулаад өгөхгүй юу? Ална гэхэд арай сэтгэл төвдөхгүй байна. Гэхдээ...гээд царай нь хүйтэн харгис болж,-цаадах чинь над тээр болоод байна. Одоо хаа байгаа вэ?

-Хоёрдугаар давхарт, манай эхнэрийн өрөөнд байна. Шархы нь боож байгаа юм. -Юм хүмээ өөрөө авч яваа юу? Гадуур цамцаа тайлаагүй биз!

-Авч яваа юм, цамц аль аль нь доор гал зууханд үлдсэн нэгэнт энэ хэнээтэй жаал танд тээр болоод байгаа хойно...

-Тээр болохгүй яахав дээ. Цаадах чинь танай буудалд үймээн тарьж, тохитой томоотой улсын тав алдуулж байна... Та явж миний тооцоог бодоод, манай зарцад дуулгачих.

-Юу? Эрхэм та манайхаас бүр явах болчихов уу?

-Та үүнийг түрүүн дуулсан шүү дээ. Би морио эмээллэ гэж танд тушаасан, миний хэлснийг хийгээгүй гэж үү?

-Хийсэн. Морь эмээлтэй, үүдэнд зогсож байгааг эрхэм та хараад үнэмшиж болно. -Сайн, за тэгээд миний хэлснээр хийчих.

"Хачин юмаа бас! арай л хүүхдээс айсан юм биш байгаа даа" гэж буудлын эзэн бодов. Гэвч цаад хүний тушаангуй харц эзний бодлыг замхруулж, мань хүн хичээнгүйлэн мэхэсхийгээд гарч одов.

"Энэ новш эрхэм хатагтайг л харчих бий дээ. Юу юугүй л үүгээр өнгөрөх ёстой. Тэр ч байтугай хожигдож байна гээч. Ер нь би мориор өөдөөс нь тосвол дээр дэг... Тэр де Тревильд гэсэн захианд юу байгааг би мэдээд авч чадвал!.." гэж нөгөө хүн дотроо бодсоор байв. Тэр хүн амандаа юм үглэсээр гал зуухны өрөө рүү явлаа.

Буудлын эзэн ч яахав залуу эрийг байгаа болохоор л нөгөө хүн буудлаас явахад хүрч байна гэж лавгайбодсоор эхнэрийнхээ өрөөнд оров. д'Артаньян бүр сэхээ оржээ. Буудлын эзэн өөрөө цаадахыг язгууртан их хүн гэдэгт эргэлзээгүй болохоороо, язгууртан ихэстэй муудалцлаа гэж цагдаагийн газар танаас өө сэв эрэх магадгүй гэж д'Артаньянд цухуйлгаад, түүний ядарсны нь хайхралгүй ятгаж байгаад мордуулахыг хичээв. д'Артаньян дүйрсээр байгаа толгойгоо алчуураар боожээ. Босч, эзнээр аяархан түшүүлсээршатаар бууж эхлэв. д'Артаньян гал зуухны босгыг алхаад санамсаргүй цонхоор хартал, өөрий нь доромжлогч этгээд, норманд үүлдрийн том хос морь хөллөсөн замын сүйхний гишгүүр дээр зогсож, нэг хүнтэй тайван ярилцаж байгаа харагдав. Сүйх тэрэгний цонхоор ярьж байгаа хүний толгой харагдах нь хорь, хорин хоёр насны залуу эмэгтэй байв. д'Артаньян хүний нүүр царайны онцлогийг эгшин зуур тусгаж нүдлэх чадвартайг бид дээр дурссан билээ. д'Артаньянд гуа сайхан залуу эмэгтэй харагдлаа. Өнөө хүртэл д'Артаньяны сууж байсан өмнөт Францад тун ховор үзэгдэх гуа үзэсгэлэн байсан болохоор залууд бүр ч гайхалтай санагдав.

Мөрөө хүрсэн урт, цайвар үс усгал цэнхэр нүд, ягаан уруултай, цав цагаан гар, цонхигордуу нүүртэй эмэгтэй байлаа. Эмэгтэй нөгөө хүнтэй нэг юм шохоорхон ярьж харагдав. Бүсгүй: -За тэхлээр их гэгээнтний тушааснаар би... гэхэд,

-Даруй Англид буцаж очоод, герцогийг Лондоноос мордох юм бол шууд мэдээ ирүүлэх юм. - Бусад даалгавар нь?...

-Бусад нь энэ хайрцагт бий. Үүнийг та Ламаншийн хоолой гаталсан хойноо л нээх юм шүү. - Сайн байна. За, та өөрөө яах бодолтой байна даа?

-Би Парис руу буцлаа.

-Тэр эдгүй жаалыг сургаж өгөлгүй юү?

Нөгөө хүн хариулах гээд ам нээж амжаагүй байтал яриаг цөм сонссон д'Артаньян үүдэн дээр гарч ирэв.

-Эдгүй жаал өөрөө зохих этгээдийг залхааж өгнө! Залхаах санаатай байгаа хүн чгэлээ энэ удаа зайлж чадахгүй биз гэж найдна гэж д'Артаньян дуу алдав.

Нөгөө хүн хөмсгөө зангидаад, -Зайлахгүй биз гэнээ гэв.

-Таныг бүсгүй хүн харсаар байтал арай зугатаачиж зүрхлэхгүй байх л гэж санаж байна шүү дээ.

Нөгөө хүн илдийнхээ ишийг шүүрч байгааг харсан эрхэм хатагтай.

-Ялихгүй саатвал хамаг хэрэг нурааж болохыгсанаач, санаж үзээч! гэж дуу алдав -Таны зөвөө гэж нөгөө хүн хурдан өчив.

-Та замаараа яв. Би ч замаараа явлаа.

Тэгээд эмэгтэйд мэхийн ёслоод мориндоо үсрэн мордов, Сүйхний улаач ч гэсэн мориныхоо нуруу руу ташуураар хэдэнтээ буулгав. Танихгүй хүн бүсгүй хоёр, тал тал тийшээ давхин одлоо. Зочин хөлсөө төлөлгүй яваадөгөхий нь хараад буудлын эзний найрсаг нь гүн зэвүүцэл болж, хойноос нь, -Тооцоо, тооцоо хэн төлөх юм бэ?...гэж хашгарав.

Нөгөө хүн мориныхоо амыг таталгүй, -урагшгүй золиг, чи төлөөч! гэж зарцаа зандарсанд, цаадах нь буудлын эзний хөл рүү мөнгөн зоос хэдийг чулуудаад эзнийхээ хойноос давхилаа. д'Артаньян ч гэсэн бас зарцынхойноос ухас гэж

-Хулчгар новш, тайж нэр зээлдэгч! гэж хашгичив. Даанч мань залуу ийм ширүүн хөдөлж чадахааргүй тамирдсан болохоор арван алхам газар гүйж амжилгүй чих нь шуугьж, толгой эргэн, цусан үүл нүд бүрхэх шиг болж: -Хулчгар! Хулчгар! Хулчгар! гэж үглэсээр гудамжин дунд уначхав. Үлгэрт гардаг эмгэн хумсыг цахлай дөнгөх шиг буудлын эзэн хөөрхий залууг хуурч манж үгээр итгэл олохыг хичээн д'Артаньян руу ойртоод

-Нээрээ, арчаагүй хулчгар этгээд байна! гэв.

-Тиймээ, муухай хулчгар амьтан. Харин эмэгтэй нь яасан гуа сайхан хүн бэ гэж д'Артаньян шивнэнэ.

-Юун эмэгтэй вэ? гэж буудлын эзэн лавлав.

д'Артаньян, эрхэм хатагтай гэж дуугараад дахин ухаан алдлаа.

-Яая гэхэв дээ. Хоёр зочин алдчихлаа. Энэ нь хэд хоног лав байх болно. Юу ч гэсэн арван нэгэн эки олох л юм бизээ гэж эзэн хэлэв.

Арван нэгэнэки гэдэг маань д'Артаньяны хэтэвчинд үлдсэн хамаг мөнгө гэдгийг бид мэднэ. Зочноо арван нэг хоног хэвтэж, хоногт нэг эки төлнө гэж буудлын эзэн боджээ. Гэхдээ зочноо ямар шүү хүн болохыг тэр мэдсэнгүй. Дараа өдөр д'Артаньян өглөө таван цагт босоод өөрөө гал зуух руу очиж, жаал зугаа эмийн зүйл захив. Чухам юу юу захисан жагсаалт нь бидэнд үлдээгүй юм. Бас дарс, тос, далайн саргай цэцэг, аваад ээжийнхээ өгсөн жорыг гартаа барьсаар эмнэх тос найруулж. Өдий төдий бэртэнгэ шархандаа тэр тосоо түрхэж, ямар ч эмч биендээ хавьтуулалгүй байсаар өөрөө боолтоо солив.

Лав сайн тосны ачаар, магадгүй эмч байгаагүйн ачаар ч юм уу, д'Артаньян тэр оройдоо босоод маргааш нь эв эрүүл болчихжээ.

Мань залуу энэ хугацаанд хоол ундаа хатуу хэмжиж байсан болохоор ердөө л энэ зуур хэрэглэсэн дарс, тос, далайн саргай цэцгийн үнээ төлөхөд, хонгор морь буудлын эзний мэтгэж байгаагаар биеий нь хэмжээтэй нь жишээд бодоход гурав дахин их өвс идчихсэн гэнэ. д'Артаньян хармаагаа удалтал арван нэгэн экиүтэй элэгдмэл хилэн хэтэвчээс өөр юм байсангүй. Де Тревиль гуайд гэсэн захиа алга болчихжээ.

Залуу эхлээд захидлаа уйгагүй сайн эрэв. Цамц өмднийхөө хармааг хорь гаруй удаа эргүүлж, богцоо дахин дахин тэмтэрнэ. Гэвч захиа үгүй болсныг лав мэдээд мань залуугийн уур хилэн дүрэлзэн. бадарч золтой л дарс, үнэрт тосны хэрэгцээ дахин гарахад, хүрсэнгүй. Залуу зочин айхтар хилэгнэж. захиагаа олдоггүй юм болж гэм энэ буудлын бүх юмыг яйртал цохино гэж сүрдүүлэхийг үзээд эзэн өөрөө шийдэм, эхнэр нь шүүр, зарц нар нөгөө хоёр хоногийн өмнө хэрэглэсэн саваагаараа зэвсэглэжээ.

д'Артаньян,-захидал, танилцуулах захидал! хар чөтгөрүүд захиагий минь аль! Үгүй бол та нарыг өт хорхойшиг шорлож орхиё! гэж хашгачна.

Залууг занаснаараа шорлоход нь гай болж саад болох нэг юм байлаа. Эхлээд тулалдахад залуугийн илд дундуураа хуга үсэрсэн гэж бид яриагүй юу. Өөрөө үүнийг таг мартчихсан байжээ. Тэгээд илдээ суга татаад авах гэсэн чинь хэдхэн сөөм хугархай гараад ирж дээ. Буудлын эзэн үүний нь аятайхан хуйлчихаад, үзүүрээр нь юм шарах шор хийх санаатай нуучихсан юм байжээ.

Хэрэв буудлын эзэн өөрөө зочныг захиагаа нэхсэний нь зүйтэй шаардлага гэж эцэстээ

бодоогүйсэн бол мань түргэн залуу илд хугарсан төдийд хоригдохгүй байсан бизээ. Буудлын эзэн шийдмээ тавьж, үгүй нээрээ тэр захиа хаашаа орчихов? гэсэнд д'Артаньян харин захиа яачихваа? Нэгд тэр чинь де Тревиль гуайд очих захиа, олох ёстой захиа гэдгийг та нарт анхааруулъя олддоггүй юм бол де Тревиль гуай та нараар лав олуулна бий! гэж зандчив. Буудлын эзэн энэ үгнээс бүр айчихлаа. Ван их хамба гуай хоёрын дараа нь де Тревиль гуайн нэрийг ер нь цэргийнхэн төдийгүй хотын иргэд ч гэлээ их дурсдагбайжээ. Бас "Жозеф ламтан" гэж байх нь байсан...Гэхдээ түүний нэрийг хэлэх юм бол заавал шивнэдэг байж. Их хамба Ришельегийн найз "бор хувилгаанаас" хүмүүс тэгтлээ их сүрддэг байжээ.

Буудлын эзэн шийдмээ хаяад эхнэрээ шүүр, зарц нарыг саваагаа хая гэж дохив. Өөрөө сайн үлгэр үзүүлэн захиа эрж гарлаа.

Дэмий баахан эрсний дараа буудлын эзэн,

-Үгүй тэгээд, үнэ цэнэтэй юм захиан дотор хийсэн хэрэг үү гэж асуув.

Тэр захианы ачаар замаа олохыг горьдож явсан гаскон залуу,

-Хэлээд яахав! Миний хамаг хөрөнгө түүн дотор явсан юм гэж дуу алдав. Сэтгэл зовсон эзэн,
-Испани мөнгөний баталгаа юу гэж асуув.

-Их эзэнтний сангаас мөнгөө авах баталгаа гэж хариулав. д'Артаньян тэр захианы ачаар вангийн цэрэгт орохыг горьдож явсан болохоор ийм нэг жаахан болчимгүй хариу хэлчих эрхтэй гэж өөрийгөө боджээ.

Буудлын эзэн бүр цөхрөөд,

-Чөтгөр алгад! гэж дуу алдана.

д'Артаньян гаскон нутгийнхны зангаар

-Мөнгө ч яахав гайгүй хэрэг. Яамай хамаг чухал юм л тэр захиа өөрөө байгаа юм. Тэр захидлаа алдсанаас, алтан зоос мянгыг хаясан нь дээр гэж жишим ч үгүй ярив.

Идэр залуу насны даруу зандаа баригдаагүйсэн бол мань хүн ер нь "хорин мянгыг" гээд хэлчихэж болох байсан даа.

Буудлын эзэн хамаг байраа дэмий онгичиж явснаа гэнэт санаа авч:

-Захиа ерөөсөө хаягдаагүй юм байна гэсэнд д'Артаньян сэрт гэж

-Юу гэсэнд

-Үгүй захиаг хулгайлчихаж, -гэлээ.

-Хэн хулгайлчихаа вэ?

-Өчигдрийн танихгүй тайж. Таны цамц гал зуухны өрөөнд байхад тэр тийшээ ороод, ганцаараа тэнд үлдсэн. Лав тэр хүний хийсэн хэрэг мөн гэж мөрийцье.

-Та тэгж санаж байна уу? гэж Артаньян эргэлзэв. Чухамдаа ганц өөрт нь л хэрэгтэй, захиа байсныг д'Артаньян хэнээс ч илүү мэдэх юм чинь, хэн нэг хүн түүнд шунах юм гэж санагдахгүй байлаа. Буудалд буусан хүн, зарц нарын алин ч гэлээ тэр захиаг аваад ашиггүй байлаа, -Та тэгээд тэр сонжуургүй тайжийг сэжиглэж байна гэв үү? гэж д'Артаньян лавлав. - Яриагүй мөн гэж би танд хэллээ шүү дээ. Эрхэм таныг де Тревиль гуайн өршөөлд багтсан хүн, тэр эрхэмсэг язгууртанд очих захиа танаар явна гэдгийг би тэр хүнд нь дуулгахад сэтгэл нь илт тавгүй болоод явчихсан. Захиа хаа байгааг надаас асуугаад даруй гал зуух руу очсон юм даг. Таны цамц тэнд байсныг өөрөө мэдэж байсан юм гэж буудлын эзнийг хэлсэнд. - Тэгвэл хулгайлсан этгээд тэр мөн! Де Тревиль гуайд би гомдол мэдүүлж, де Тревиль гуай ванд мэдүүлнэ дээ! гэж д'Артаньян дуу алдсанаа хармаанаасаа ихэмсэг байртай хоёр экю гаргаж эзэнд өгөв. Цаадах нь малгайгаа авч зочноо хаалга хүртэл үдэж өглөө. Мань залуу улбар шар морин дээрээ үсэрч мордоод Парис хотын Сет-Антуанхаалга хүртэл элдэв учрал тохиолдолгүй явж ирэв. Тэнд д'Артаньян морио гурван экюгээр зарчихлаа. Аян зам дуусахын даваан дээр эзэн морио сүрхий доройтуулсныг бодоход зэгсэн үнэ хүрлээ. Иймд мөрийг саяны хэлдгээр авсан дамчин ер бусын хачин зүсэнд нь болоод л ийм дуулаагүй өндөр үнээр авчихлаа шүү дээ гэсэн байрын үг залууд цухуйлгажээ.

Ингээд д'Артаньян Парис руу жаал зугаа юмаа сугавчилсаар явган орж ядуухан хирдээ тохирсон өрөө хөлсөлтлөө гудамжаар баахан тэнэлээ. Дээврийн хонгилтой төстэй тэр өрөө люксембургийн хавьцаа авсны гудамжинд байлаа.

д'Артаньян урьдчилгаа төлөөд даруй өрөөндөө оров.. Тэр өдөртөө сууж, эцэг д'Артаньян гуайн бараг цоо шинэ цамцнаас эх нь хуу татаад сэм хүүдээ өгсөн чимгийг цамц өмдөндөө хадлаа. Дараа нь Төмөр царил гэгч газар очиж илдэндээ шинэ төмөр хийлгэхээр өглөө. Тэгээд мань залуу вангийн орд руу очиж анх дайралдсан шадар цэргээс де Тревиль гуайнхыг сураглав. Тэгсэн чинь тэднийх Тагтааны хуучны үүр гудамжид д'Артаньяны буусан газрын хажууханд байгаа юмсанжээ. Үүнийг мань хүн амжилтын билэг тэмдэг гэж олзуурхав.

Менг хотонд өөрийгөө эр хүн шиг байсан гэж д'Артаньян сэтгэл хангалуун өнгөрсөнд гэмших юмгүй, орчин цагтаа итгэж, ирээдүйн сайн сайханд төгс найдаж, орондоо орж амар сайхан унтав.

Жинхэнэ хөдөө нутгийн эр болохоор өглөө есөн цаг хүртэл унтаад босч, эцэг д'Артаньян гуайн боддогчлон улсын дотор гуравдах их хүн, эрхэмсэг де Тревиль гуайд бараалхахаар явлаа.

II. ДЕ ТРЕВИЛЬ ГУАЙН ХҮЛЭЭХ ӨРӨӨ

Де Тревиль гуайн нэрээр түүний ураг сад Гасконд өнөө хүртэл нэршсээр явна. Хожим өөрөө Парист ирээд де Тревиль гэх болсон тэр хүн амьдралынхаа замыг нээрээ л д'Артаньян шиг эхэлсэн юм гэнээ. Өөрөөр хэлбэл өвөртөө сохор зоосгүй л байснаас биш сүрхий зоримог, хурц ухаалаг, авхаалжтай эр байжээ. Үүнийхээ ачаар, гасконы хамгийн ядуу өчүүхэн тайж нар, эцгийнхээ хэтийн бэрх хүслэнг биелүүлж өвлөж авсан үнэн сайхан нөхцөл дээр тулгуурласан Беари нутгийн лут баян тайж нараас илүү их амжилт олдог удаа олон билээ.

Де Тревиль гуай булай зүрхтэй, илдний ир мөндөр шиг буух цагт бүр илүү хийморьтой байдгаараа "ордонд дэвших" гэж нэртэй шатны ноён оройд гурав гурван гишгүүр алгассаар өргөгдөн гарсан юм байжээ.

Ван, өөрийн эцэг IV Генрихийн дурсгалыг гүнээ хүндэлдэг байсныг хэн бүхэн мэднэ. Ван, де Тревильгуайд сайн байлаа. Генрихийг лигийн эсрэг дайтахад де Тревиль гуайн эцэг түүний цэрэгт явж шударга сайн зүтгэжээ. Ван Парисыг эзэлж авсны дараа мөнгө дутагдалтайн эрхээр болж эцэг де Тревиль гуайд сүлдэн дээрээ үнэнч бөгөөд хүчтэй гэсэн бичигтэй гал улаан дэвсгэрт арслан нэмж сийлэхийг зөвшөөрчээ. Энэ нь их өргөмжлөл боловч олз ашиг багабайв. Беари нутгаас гаралтай тэр ван насан туршаа бэлэн мөнгөөр дутагдаж, бүх өрөө ганц бэлэн байдаг цэцэн үгээрээ л төлж явсан хүн гэнээ. Их Генрихийн цуут тэр шадар хүн нас барахдаа хүүдээ үлдээсэн юм гэвэл сүлд, илд хоёр л гэнээ: Энэ өв, тэгээд бас өөрийнхөө цэвэр нэр төрийн ачаар хүү де Тревильгуай залуу хун тайжийн ордонд алба хаах болжээ. Де Тревиль гуай үнэнч, хүчтэй гэсэн нэр төрөө сайн хадгалж, илдээ цог золбоотой хэрэглэж явлаа. Улсдаа илдэнд гарамгай хүмүүсийн нэгд ордог XIII Людовик хэрэв миний нөхдөөс хүнтэй тулалдах боллоо гэвэл, гэрчээр нэгд өөрийгөө хоёрт де Тревиль гуайг урь гэж зөвлөхсөн, магадгүй, үгүй ер нь де Тревилийг өөрөөсөө дээрд тоолох ёстой гэж хэлдэг байсан гэнээ.

XIII Людовик, де Тревиль гуайд үнэхээр сайн, сайндаа яахав дээ ван хүний дээрэнгүй сэтгэлийн үүднээс, гэлээ ч сайн л байжээ.

Юу вэ гэхэд, тэр бэрх цагт ихэс дээдэс ер нь де Тревиль маягийн хүмүүсээр хүрээлүүлэхийг эрхэмлэдэг байв. Де Тревиль гуайн сүлдэн дээрх бичигний хоёр дахь үг "хүчтэй" гэдэгт нэр орохоор тайж нар олон байсан боловч, нэгдэх тодорхойлолт "үнэнч" гэдгийг сүлдэндээ сийлье гэх нүүртэй тайж ховорхон байв. Де Тревиль гуай энэ тухайд нүүр бардам байв. Өөрөө илүү дутуу үгүй, сайн нохой шиг сохроор захирагдаж чаддаг ховор хүмүүсийн нэг байсны дээр гоц авхаалжтай, эрдүү чадмаг хүн байлаа. Ванг хилэгнүүлсэн хүнийг андахгүй олох хурц нүдтэй: хилэгнүүлсэн Бема ч юм уу Мореве, Больтро, де Мере, Витри аль нэг этгээдийг ниргэж чадах лут гартай. Де Тревиль гуайд чадал чанараа үзүүлэх аятай учрал тэр болтол дайралдаагүй, түүнийг хүлээж, тохиолдол гарахын хамт л шүүрч авахаар зэхээстэй байгаа хүн билээ. III Генрихийн орон тооны биехамгаалагчид, XI Людовикийн шотланд торгон цэрэг шиг чухал үүрэг гүйцэтгэдэг шадар цэргийнхээ даамлаар XIII Людовик де Тревилийг тавьсан нь учиртай юм.

Их хамба ч гэлээ энэ талаар вангаас хоцорсонгүй. XIII Людовик өөрийгөө шилдэг эрчүүлээр

ингэж бат хүрээлүүлснийг үзээд францын дэд эзэн, чухамдаа гэвэл тэргүүн эзэн Хамба өөртөө бас торгон цэрэгтэй болохыг хүсчээ. Ингээд XIII Людовикийн жишээгээр их хамба өөрийн торгон цэрэгтэй боллоо. Эрх дархтай хоёр өрсөлдөгч цэрэг эрийн гавьяа алдартай хүмүүсийг францын бүх муж төдийгүй харь орноос хүртэл шилж авах болжээ. Ришелье, XIII Людовик хоёр оройдоо шатар тавьж суухдаа цэргүүдийнхээ чадал чанарын тухай маргалдах удаа гардаг байсан гэнээ. Хэн хэн нь л цэрэг эрсийнхээ сургуультай, зүрхтэйг гайхуулж, хагаралдах, тулалдахыг аман дээрээ буруушаах мөртөө бие хамгаалагчдаа далдуур тулалдуулахаар өдөөдөг байлаа. Өөрийнхөө шадар цэргийн дийлж, дийлэгдсэн тухайд үнэн голоосоо баярлаж, үгүй бол үнэхээр гонсойдог байв. Юу ч гэсэн өдий төдий ийм ялалт, цөөхөн тооны ялагдалд биеэрээ оролцож явсан хүн дурдатгалд л ингэж бичсэн байгаа юм.

Тууштай нөхөрлөдөг гэсэн нэр олж чадаагүй ванг Тревиль өөртөө удтал сайн байлгасны учир гэвэл, эзнийхээ сул талыг тааж авсанд байв. Арман Дю Плеси Ришелье их хамбын өмнүүр түүнийг шадар цэргээ ёслолын жагсаалаар хэгжүүн дүртэй өнгөрөөхөд нь их гэгээнтний хорыг буцалган буурал сахлы нь өрөвсхийлгэдэг байв. Нэг бол дайсны хөрөнгөөр эсвэл өөрийн нутгийнхны хөрөнгөөр амьдрахаас өөр замгүй байсан тэр цагийн дайныуран чадварыг де Тревиль нарийн мэддэг хүн байв. Түүний торгон цэрэг ганц өөрт нь захирагддаг ёстой юунаас ч буцдаггүй, танхайчууд байлаа;

Вангийн, чухамдаа гэвэл де Тревиль гуайн шадар цэрэг гэж хааш яаш хувцасласан шалбарсан нүүр царайтай хүмүүс наргиан, зугаалганы газар, мухлагаар халамцуухан хэсэж сахал ирмэж, илд хангинуулан үймээн шуугиан тарин их хамбын бие хамгаалагчдаас замдаа дайралдвал дуртай өдөж хатгана. Тэгээд гашуун шог үг урсгасаар илдээ хуйнаас нь суга татдаг билээ. Өөрсдөө алагдах удаа ч бас гардаг, тэгвэл өөрийнхөө хойноос нөхдийгөө харамсаж гашуудаад, өшөө авна гэдэгт бат итгэж тайвнаар амьсгаа хураадаг, голдуу л де Тревиль гуай өөрсдий нь шоронд хатаалгахгүй, лав тавиулна гэдэгт найдан, өөрсдөө алдаг байв. Эд де Тревиль гуайг чадлаараа шагшин магтаж, биширдэг, өөрсдөө танхай нь хэтэрсэн улс мөртөө, даамлынхаа өмнө сургуулийн хүүхэд багшаасаа сүрдэх шиг чичирч, үгнээс нь өчүүхэн гажилгүй, үл ялих зэмлэлий нь цагаатгахын төлөө үхэхэд бэлэн явдаг хүмүүс байв.

Тэр лут хөшүүргийг де Тревиль гуай эхний үед ван, түүний шадар хүмүүсийн эрх ашигт нийцүүлэн ашиглаж байснаа, хожим хувийнхаа, нөхдийнхөө эрх ашигт зориулах болжээ. Гэхдээ өдий төдий дурдатгал үлдээсэн тэр цагийн аль ч дурдатгал бичигт тэр хүндэт хүнийг үнэнч итгэлтэй цэргээрээ тусламж үзүүлсний шан авдаг гэсэн үг дайсан хүмүүс хүртэл хэлээгүй байгаа юм. Гэтэл де Тревиль гуайд үзэг барьдаг, илд барьдаг улсын аль алины нь дунд дайсан цөөнгүй байсан билээ. Будлиан хутгахдаа аль ч чадмаг хүнээс дооргүй авьяастай мөртлөө де Тревиль гуай шулуун шударга хэвээр үлджээ. Тэр ч байтугай де Тревиль гуай хүнд аян дайн, цэргийн ядаргаатай амьдралд дарагдалгүй зугаатай хэрэг төвөг цөхрөлтгүй эрж явдаг, цагтаа бас бүсгүй хүнд таалагдах нарийн аргатай, хэрэг болбол яруу шүлэг дуугаар ч билээ гайхуулж чадах хүн байсан гэнээ. Де Тревиль гуай энэ тэр бүсгүйн дурыг булааж чадсан тухай хориод жилийн өмнө энэ талаар Бассомпьерийн тухай шуугьдаг байснаас багагүй яриа болдог нь бас учиртай байлаа. Шадар цэргийн даамал бусдыг бишрүүлэх, сүрдүүлэх, дурлуулах болж өөрөөр хэлбэл аз жаргалын дээжийг амсжээ.

XIV Людовик өөрийн бадарсан их сүрээрордныхоо хамаг шадар хүмүүсийг дарж авсан бол,

эцэг нь, тэр болгон надтай адилшихгүй гээд шадар дотно хүмүүсээ хувьдаа сүр жавхаатай яваг гэдэг байлаа: Ван, их хамба хоёрт өглөө хүмүүс бараалхахаас гадна Парис хотонд бас хоёр зуу гаруй айлын ийм "өглөөний хүлээн авалт" сүрхий нэр хүндтэй байжээ. Тэдний дунд де Тревиль гуайн өглөөний хүлээн авалтад хамгийн олон хүн ирдэг байв.

Тагтааны хуучин үүр гэгч гудамжинд байгаа тэдний байшин зуны цагт өглөө зургаан цагаас, өвөл бол найман цагаас аваад хуаран шиг болчихдог байв. Өвч зэвсэглэсэн, юунаас ч буцахааргүй тавь, жаран шадар цэргүүд хашаан дотуур байнга холхино. Тэдний тоог үргэлж ахиухан байлгахгаар цаг цагт сэлж байдаг бололтой. Одоо цагийн барилгачин оронд нь бүхэл бүтэн байшин барьчихаар өргөн шатаар өршөөл энэрэл эрсэн хүмүүс, зах мужаас ирээд шадар цэрэг болохыг эрмэлзсэн тайж эздийнхээ зараалаар ирсэн олон өнгийн хувцастай зарц нар дээш доош сүлжилдэнэ. Хүлээх өрөөний хана дагасан урт вандан сандал дээр сайчуул, өөрөөр хэлбэл, гэрийн эзэн өөрөө урьсан хүмүүс сууна. Хүлээхөрсөөнд өглөөнөөс орой хүртэл шуугиан тасрахгүй. деТревиль гуай өөрөө залгаа өрсөөнд сууж, ирсэн хүн хүлээж аваад гомдол саналы нь сонсоно, тушаал заавар өгнө. Ван ордныхоо жавдан дээр гардаг шиг цонх руугаа очоод, шадар цэргийн зэвсэг сэлтэд үзлэг хийж бас чадах ажээ.

д'Артаньяныг анх тэнд очсон өдөр цугларсан улс ялангуяа хөдөө нутгийн хүнд онц сүртэй харагджээ.

Гэвч мань хүн хөдөөдөө гаскон нутгийн хүн байлаа. Тэдний нутгийнхан ямар ч юмыг амархан гайхах улс биш гэж тэр цагт алдартай байжээ. Гаднаас ирсэн хүн, дөрвөлжин тавтай лут хадаасаарбөхөлсөн хүнд хаалгаар ороод баахан зэвсэгтэй хүмүүс дунд орчихдог аж. Тэр хүмүүс хашаан дотуур сэлгүүцэж бие биенээ дуудаж нэг бол маргаж, үгүй бол тоглоом наадам болцгооно. Үймэрч шуугилдсан тэр хүмүүсийн дундуур дарга даамал ихэс дээдэс юм уу хөөрхөн хүүхнээс өөр хүн нэвтэрч гарахын эрхгүй аж.

Мань залуу, хэт урт илдээ чөргөр хөлөндөөхавчиж, аягүйрхэж зогссоноо нуухыг хичээсэн хөдөө нутгийн хүний зангаар эвгүй инээмсэглэсээр, малгайнхаа өргөн хүрээнээс нэг гараа салгалгүй явж тэр шахцалдан үймсэн хүмүүсийн дундуур арай чарай урагшаа дөхнө. Нэг бөөн улс өнгөрөхөд д'Артаньяны дотор жаал уужран санаа алдана. Гэхдээ хажуугийн хүмүүс хойноос нь харж байгааг сайн мэдэрч, амьдрал турш өөрийгөө овоод бодож явсанмань хүн энэ удаа болхи, инээдтэй харагдаж байгаа гэж саналаа.

Яг шатанд тулж очоод байдал бүр ч зовлонтой боллоо. Шатны доод гишгүүр дээр, дөрвөн шадар цэрэг сайхан тоглож арав, арван хоёр орчим нөхөд нь довжоон дээр, тоглоомд оролцох ээлжээ хүлээж зогсоно. Дөрвийн нэг нь бусдаас нэг гишгүүр дээгүүр зогсоод, цаад гурвыгаадээш гаргахгүйг оролдож байв. Нөгөө гурав илдээ чадмаг хэрэглэж довтолж байв.

д'Артаньян анхандаа тэднийг сургуулийн, үзүүртээ хамгаалалттай илдээр наадаж байгаа юм болгосон чинь, удалгүй тоглож байгаа улсын нүүр царай эсгэгдсэнийг хараад, хурцлахын хирээр хурцалсан илд барьцгаасныг ойлгов. Илдний үзүүрт дахин эсгэгдсэн тухайд, харж байгаа хүмүүс төдийгүй, эсгүүлсэн хүн өөрөө хүртэл бөөн инээд хөөр болох аж. Энэ удаа дээд гишгүүр дээр зогссон бууч цаадуулаасаа гайхалтай сайн хамгаалж байв. Тэднийг тойрч хүн цугларав. Илдний үзүүрт эсгүүлсэн хүн даруй тоглоомноос гарч, түүний дотогшоо орохоор хүлээж байгаа ээлжинд дийлсэн хүн ордог тийм болзолтой тоглоом байжээ. Тавхан

минутын хирд, гурав нь илдэнд эсгэгдсэн байв. Тэдний нэг гар дээрээ, нөгөө нь эрүүн доороо, гуравдахийн чих эсгэгджээ. Гэхдээ шат хамгаалсан хүн ганц ч эсгүүлсэнгүй. Тоглоомын журмаар ингэж гарамгай тоглосон хүний ээлж гурван хүний урьд ордог ажээ.

Холоос ирсэн мань залууд гайхагдах, чухамдаа гайхсан байдлы нь гаргахад хэдий бэрх боловч, энэ тоглоом хачин гайхалтай санагджээ. Эдний нутагт түргэн зантай улс хэдий олон гэлээ ч тулалдахад эрхбиш нэг шалтаг шаардагддаг билээ. Гаскон нутагт хүртэл урьд хожид түүний дуулсан юман дотроос хамгийн гайхалтай нь дөрвөн шадар цэргийн тулалдаан санагдав. Нөгөө Гулливерийн аялж яваад очиж айж үхэхэд дөхсөн аврага том хүнтэй үлгэрийн хачин оронд хүрээд ирсэн юм шиг д'Артаньянд санагджээ. Гэтэл бас хүрэх газар өдий, шатны дээд тавцан хүлээх өрөө хоёр үлдээд байв.

Тавцан дээр тоглохоо нэгэнт болиод, хүүхний тухай яриа дэлгэж, хүлээх өрөөнд вангийн ордны тухай хов жив ярилцах ажээ. д'Артаньян тавцан дээр царай нь улайснаа хүлээх өрөөнд орж ирээд айж хэлмэгдэв. д'Артаньян зоримог хурц ухаанаараа Гаскон нутгийнхаа залуу шивэгчин, хааяа залуу эзэгтэй нарт нь ч гэлээхалтай хүн юмсанжээ. Гэхдээ хүслэнгийн далайд хэдий умблаа ч гэлээ энд ярьж байгаа урагш бүтэмжтэй дурлалын тоймгүй олон, амт шүлтний тэн хагас байтугай нэг мөч нь ч мань эрийн ой тойнд багтмааргүй байжээ. Тэхдээ их хүний нэр гарч, хамаг нарийн нууцы нь эрээ бараагүй тоочих нь бүр ч гойд сонирхолтой ажээ. Тавцан дээр ирээд д'Артаньян их хамбын сайн үйл явдалтай эргэлзэх болсон гэвэл хүлээх өрөөнд ороод хүндэлж үзэх сэтгэл нь тээнэгэлзжээ. Бүх европыг чичрүүлж байгаа улс төрийн бодлогыг шүүмжлэн хэлэлцэхийг д'Артаньян сонсоод хачин их гайхлаа. Их хамбын хувийн амьдралыг сөхөж харахыг оролдсон өдий төдий ихэс дээдэс хөөрхий болсныг д'Артаньян мэдэж байлаа. Гэтэл энд хамбын хувийн амьдралыг бас муучлах ажээ.

Эцэг д'Артаньян гуайн гүнээ хүндэлдэг тэр их хүн энд де Тревиль гуайн шадар цэргүүдийн доог тохуу болдог аж. Тэд хамбыг майга хөлтэй бөгтөр нуруутай гэж доог тохуу болгоно. Хамбын сэтгэлтэй болсон д'Эжльон авгай, хамбын зээ охин де Комбалэ авгай хоёрын тухай шог дуу аялж, бусад нь хамбын хиа, бие хамгаалагчдыг өдөж даажигнах тухай тохиролцож байх нь д'Артаньянд санаанд багтамгүй зэрлэг явдал санагдлаа. Хамбыг ингэжхорноор даажигнасан ярианд вангийн нэр санамсаргүй оролцоод орхивол энэ шогч улсын амыг нэг далдын гараар түр таглаад авах шиг болох ажээ. Шуугилдаж байсан хүмүүс де Тревиль гуайн өрөөнд дуугаа дуулдчих бий гэж айсан байдалтай зовж эргэж харна.

Гэтэл ялимгүй нэг цухуйлгаад орхихын хамт дахиад л их гэгээнтний тухай яриа болж, хүмүүсийн дуу чангарна. Суут их гэгээнтний хэрэг явдлаас сөхөгдөлгүй өнгөрөх юм ганц ч үгүй аж.

д'Артаньян хэлмэгдэж эднийг лав цөмийг нь Бастили шоронд хийгээд дүүжилнэ бий. Би ч гэсэн нэгэнт эдний яриаг чагнаж, дуулсан болохоор бас хуйвалдсанд тооцогдож хоморгонд нь орох биз. Хамбыг хүндэлж яваарай гэж өчнөөн чухалчлан захисан эцэг маань намайг иймзадгай зоргоороо улсын дунд орчхоод байгааг мэдвэл юү гэх бол! гэж бодлоо.

Тэхлээр д'Артаньян гэр ярианд оролцоогүйг тааварлахад юмгүй шүү дээ. Гэхдээ тэр ганц ч үг үлдээхгүй санаатай хамаг анхаарлаа тавин бүлтийгээд, хичээнгүйлэн чагнаж байв. Мань хүн эцгийнхээ сургамжийг хэдий хүндлэх боловч зан төрхөө дагаж, энд болж байгаа бүхнийг

буруушаахаасаа сайшаах төлөвтэйбайлаа.

д'Артаньян чухамдаа де Тревиль гуайнхан дотор гаднын хүн болохоос гадна энд анх үзэгдэж байгаа болохоор хүн ирж хэрэг учры нь асуув. Асууж ирсэн зарцад д'Артаньян нэр усаа төв байдлаар хэлж, өөрийгөө де Тревиль гуайн нутгийн хүн гэдгийг дуулгаад хэдэн минут бараалхах зөвшөөрөл авч өгөхийг зарцаас гуйлаа. Зарц цагий нь болохоор таны хүсэлтийг дамжуулья гэж өршөөнгүй дуугарав.

д'Артаньян эхлээд бишүүрхэн байснаа жаал дасч дэмий байхаар, тойрсон улсын нүүр царай, хувцас сэлтийг ажиж чадахтай болов.

Сүрхий их шуугилдаж байгаа нэг бөөн хүний голлогч нь бусдын анхаарал татмаар янзтай хувцалсан ихэмсэг царайтай өндөр хүн байлаа. Эрх чөлөөгөөр багавгар гэлээ ч их зоргоороо тэр цагт цэрэг цамцаа заавал өмсөх албагүй байсан билээ. Тэр хүн сүрхий гандаж элэгдсэн цэнхэр хөх өнгийн камзол цамц өмсч, дээр нь цэлмэг өдөр үдийн нарны туяа усанд тусч зурайх мэт гялбасан алтан хатгамалтай ганган мөрөвч зүүжээ. Гал улаан хамба хилэнгээр хийсэн урт нөмрөг шадар цэргийн мөрнөөс дэгжин намирсан нь нөгөө нүд гялбам мөрөвчийг зөвхөн урьд талаас нь үзэгдэх болгожээ. Мөрөвчинд мундаг урт илд зүүлттэй байв. Энэ цэрэг дөнгөж сая харуулаас буусан юм байж, салхи цохиулчхав гээд зориуд ханиаж, ингээд л нөмрөг нөмрөхөөс өөр аргагүй боллоо гэж сахлаа имрэн хайхрамжгүй дуугарахад тойрсон улс тэр дундаа Д'Артаньян алтан хатгамалт мөрөвчийг шагшин магтана.

-Яая гэх вэ дээ. Улс одоо мөрөвч зүүдэг болоод байна. Энэ ч их үрлэг, өөрөө мэдээд л байна. Цагийн аяс, яая гэх вэ ер нь гэрээс ирүүлж байгаа мөнгий чинь яаж ч гэлээ нэг үрэхээс биш яахав дээ гэж нөхөддөө ярилаа.

Цуг байсан нэг хүн дуу алдаж,

-Ээ Портос чи өглөгч эцгийнхээ ачаармөрөвчтэй болсон гэж бидэнд үнэмшүүлэхийг хичээгээд дэмий. Ням гаригт Сент-Онорэ хаалганы тэнд чи нэг нүүрээ битүүлсэн авхайтай цуг явж байгаад надтай дайралдсан. Тэр чинь бэлэглэсэн юм биш биз дээ гэв. Цаад Портос гэгч нь: Үгүй нэр төрөө барьж ам алдъя. Тайж хүний үнэн үг, нээрээ энэ мөрөвчийг чинь би өөрийнхөө мөнгөөр авсан гэж хариулав. Шадар цэргүүдийн нэг нь үг хавчуулж,

-Миний энэ шинэ хэтэвч авсан шиг болж л дээ. Хуучин хэтэвчинд, хайртынхаа хийсэн мөнгөөр шинийг авчихсан юм гэсэнд Портос маргаж-Үгүй нээрээ шүү. Үүний чинь арван хоёр алтан зоосоор авснаа би гэрчилж чадна гэлээ.

Шагшин магтсан дуу нэмэгдэвч. эргэлзээ бас үлдлээ. Портосөөр нэг шадар цэргээс -Тийм биз дээ Арамис аа? гэж асуув.

Арамис гэж дуудсан тэр цэрэг өөрөөс нь шал ондоо хүн байлаа. Хорин хоёр, гурав насны хар нүдтэй залуу эрийн улаа бутарсан хацар, намрын интор аятай зөөлөн шар үстэй, цайлган царай нь ялихгүй нялуувтар байртай аж. Дээд уруул дээр нь нарийхан сахал эв эгцхэн зурайжээ. Арамис гараа буулгахдаа шөрөмсөө чинэхээс айж байх шиг санагдана. Чихнийхээ үзүүрийг аятай цайвар байлгахыг хичээж байн байн чимхэнэ. Арамис үг цөөтэй алгуур

ярьдаг, найр тавин бөхөлзөх дуртай сайхан шүдээ цухуйлган дуугүй инээнэ. Ер нь биеэ айхгар арчилдагчлан, шүдээ бас нямбай сайн цэвэрлэдэг болтой. Найзынхаа асуусан юмыг баталж Арамис толгой дохив. Энэ хүний баталснаар, гайхалтай сайхан мөрөвчний тухайд алив эргэлзээ арилавболтой. Мөрөвчийг улс шохоорхсоор боловч, тэр тухай ярихаа болиод, яриа аяндаа өөр шинэ сонин юм руу орлоо.

Шадар цэргийн нэг нь хүн онцлолгүй нийтийн дунд,

-Де Шаль гуайн агтач ярьсан юмыг та юу гэж санаж байна? гэж асуусанд Портос ихэмсгээр - Тэр юу яриа вэ? гэлээ.

-Их хамбын үнэнч зарц Рошфортой Брюссельд дайралдсан гэж тэр ярьжээ. Рошфор капуцик гэлэн хувцастай байж. Тэр хараал хүрмэр чинь тэгж зүсээ буруулсны ачаар де Лэг гуайг муухай малласан гэнээ.

-Муухай маллаж гэнээ?

Үнэн юм биз дээ гэж Портос лавшруулав.

Үүнийг би Арамисаас дуулсан юм гэж цаад цэрэг хэллээ.

-Тийм гэж үү? Арамис ам нээж,

-Портос, та үүнийг сайн мэднэ шүү дээ. Өчигдөр би өөрт чинь яриагүй юу даа. Дахин яриад байх хэрэг алга гэсэнд Портос дуу алдаж:

-Дахин ярих хэрэг алга гэнэ шүү?-Та тэгж санаж байна уу? Дахин хэрэг алга гэлээ! Чөтгөр алгад! Та бас амархан шийдчихэв ээ! Тийм бий! Тайж хүнийг хамба мөрдөнтагнаж, урвагч луйварчин, алуурчин этгээдийн тусламжтайгаар захиагий нь хулгайлж аваад, мөн л нөгөө тагнуулаа ашиглан, захианы нь үндсэн дээр бас Шале, ванг олж, Орлеаний герцогийг вангийн хатантай суулгах гэсэн гэдэг санаанд багтахгүй муухай шалтгаар Шалейг цаазаар авахуулах гэж байдаг! Үүний гогцоог хэн ч олж чадахгүй байтал, та өчигдөр, ашгүй бидэнд дуулгалаа. Тэгээд биднийг сэхээ авч амжаагүй байхад өнөөдөр, "Түүнийг дахин яриад байх хэрэг алга" гэнэ шүү! За та тэгж дурлаад байгаа юм бол дахиад ярья л даа, гэж Арамис хүлцэнгүй зөвшөөрөв. -Би л де Шале гуайн агтач байсан бол тэр Рошфорыг ганц хашраах байсандаа! гэж Портос дуу алдахад, Арамис амгаланаар,

-Өөрий тань улаангерцог хашраахсан гэж үг хаяв. Портос сайшааж толгой тохин алга ташиж:
-Улаан герцог гэнэ шүү! Мөн дөө хөө!

-Улаан герцог гэдэг чинь догь байна.

-Энэ хурц үгий чинь би тараахыг хичээнээ гайгүй. Энэ Арамис бас хурц үгтэй хүн шүү! Өвгөн минь чи авьяастай юмаа. Хөөх боломжгүй нь харамсалтай. Ямар айхгар хувраг гарах байсан бол!

-Энэ цаг зуурын саад л даа,-нэг цагт би хувраг болохоо л болно. Үүнийгээ мэдээд би бурхны

ном үзсээр байгааг Портоc та мэднэ гэж Арамисыг ярихад Портоc,

-Эрт орой хэдийд ч гэлээ мань хүн санасандаа хүрнэ гэв.

-Эрт нь л дөхөх бий! гэж Арамис хариулав.

-Энэ ердөө шүүгээн дотроо цэрэг хувцасны ард өлгөөтэй байдаг хувраг хувцсаа дахиад өмсөх цагийг л хүлээж явдаг хүн гэж нэг цэрэг хэлэв.

-Тэгвэл Арамис юугаа хүлээсэн юм бэ! гэж бас нэг нь асуув.

-Вангийн хатныг улсдаа угсаа залгамжлах хүү төрүүлэхийг л хүлээж байгаа хүн. -Портоc өгүүлрүүн; Эрхмүүд ээ, энэталаар тоглоом хийх хэрэг ер алга. Вангийн хатан бурхны өршөөлөөр хүү төрүүлбэл төрүүлэх л насан дээрээ байна гэв.

-Бекингэм Лорд Францад байгаа гэнэ шүү! гэж Арамис дуу алдаад, энэ гэмгүй үгээ нэг далд учиртай хэлсэн янзтай учиртайхан инээв. Портоc үгий нь таслан Арамис анд минь энэ удаа чиний буруу шүү. Уран үгэнд дуртайдаа болоод хэрээс хэтрэхэд хүрч байна. Де Тревиль гуай энэ үгий чинь дуулчихвал та хэцүүднэ бий гэв.

Арамисын дөлгөөн харцанд гэнэт хилэгнэл бадраад,

-Портоc, та арай намайг сургамжлах гээгүй биз? гэж асуув. Портоc хариуд нь -Наиз минь шадар цэрэг хувраг хоёрыг зэрэг эрлийзлээд байлгүй аль нэг нь байж үз. Атос хэд хоногийн урьд өөрийг чинь тавиур бүхнээс зооглодог гэснийг сана. Үгүй үгүй, хоёулаа муудалцаад юу хийх вэ, хэрэг алга. Атос та бид гурав хэлцэж тохирсон юмаа өөрөө санаж бэйгаа шүү дээ. Та д'Эжльон авгайнхаар эргэж тойрдог де Шеврез авгайн үеэл де БуаТраси авгайнд бас очдог, тэгээд ч авгайд их нүүр талтай гэж ярилцдаг шүү дээ. Ээ бурхан минь танд энэ азтай явдлаа тоочих хэрэг алга. Танаас нүглээ наминчлахыг шаардсан хүнэр алга. Даруу зангий чинь хэн эс мэдэх билээ. Нэгэнт та амаа барьж чадах авьяастайгаас хойш, их эзэгтэйн тухай ярихдаа түүнийгээ бас бүү март л даа. Ван хамба хоёрын тухай хэн дуртай нь юу дуртайгаа донгосч л байг, харин вангийн хатан халдашгүй ариун, түүний тухай ярих юм болж гэм, ердөө сайн лхэлэг гэв.

-Арамис ам нээж, Портоc та Нарцисс аятай их биеэ тоодог хүн байна шүү, өөрөө мэдэж ав. Миний сургамжлуулах дургүйг ганц Атосын үгийг л дуулахад бэлэн байдгийг өөрөө мэднэ шүү дээ, өөрийн чинь хувь гэвэл хонгор минь хэт ганган мөрөвчөөр чинь таныг нандин сайхан сэтгэлтэй хүн. гэх гойд итгэл төрөхгүй л байна даа. Хэрэгтэй гэсэн цагтаа би хувраг болно. Шадар цэрэг байгаа цагтаа би юу дуртай юмаа ярьж байна. Одоохондоо гэвэл танд дургүй хүрч байгааг хэлчихье.

-Арамис!

-Портоc!

-Эрхмүүд ээ! Эрхмүүд ээ! гэж тал талаас улс хориглов.

Зарц дотор өрөөний үүд нээж, д'Артаньян гуайг де Тревиль гуай хүлээж байна! гэхэд тэдний дуу намдав.

Энэ зуур өрөөний үүд нээлттэй байсан болохоор цөм дуугүй боллоо. Гаскон залуу ингэж нам гүм байх зуур, хачин хэрүүл нэг тийш болоход байлцалгүй, цагаа олж холдох болсонд голоосоо баярласаар хүлээх өрөө өнгөрч бууч цэргийн даамал дээр оров.

III. НҮҮР УЧРАВ

Де Тревиль гуай тун ааш муутай байсан гэлээ ч Гаскон залуу газар хүртэл шахуу мэхийгээд амар мэндий нь асуухад эелдгээр уулзаж, үгий нь инээмсэглэн сонслоо. Залуугийн Беари аялгуу де Тревиль гуайд залуу цаг, төрсөн нутгий нь санагдуулав. Төрсөн нутгаа дурсахад хөгшин залуу алив хүнд аятайхан байдаг билээ. Гэвч де Тревиль гуай даруй хүлээх өрөөний үүд рүү очоод, эхлээд бусад ажил хэргээ дуусгаж, дараа өөртэй нь ярилцах зөвшөөрөл д'Артаньянаас гуйж байгаа дохио болгон гараа өргөөд, гурван удаа.

-Агос! Портос! Арамис! гэж хашгарав. Тэхдээ тухай бүр дуугаа чангаруулан захирахаас өгсүүлээд, хилэгнэх хүртэлх өнгө оруулан хашгарав. Бидний өнөө танилцаж амжсан саяны нэртэй хоёр хүн даруй нөхдөөсөө тасран өрөөнд оров. Тэднийг босго алхмагц хойноос ньүүд хаагдла. Энэ хүмүүсийг бараг бурхан, даамлы нь ниргэхээр зэхсэн аянга цахилгааны бурхан аятай санаж байсан д'Артаньян, хоёр шадар цэргийн сэтгэл төдий л тавгүй ч гэлээ чамбай номхон төлөвийг зэрэг илчилсэн жирийн байдал төрхөөр байгаад нь бахдав.

Хоёр цэрэг орж ирээд үүд хаагдаж, хүлээх өрөөнд шадар цэргүүдийн тухай шинэ яриа дэгдсэн болтой, хүмүүсийн шуугиан улам ихсэж, де Тревиль гуай хөмсгөө зангидан өрөө дотуур хэд хэдэн удаа Портос, Арамис хоёрын хажуугаар дуугүй холхиж, цаад хоёр ч жагсаалын үзлэг болж байгаа аятай номхон дуугүй зогсож байтал даамал гэнэт тэдний өмнө зогсож хөлөөс нь толгой хүртэл ууртай хараад ам нээж;

-Өчигдөр оройхон ван над юу гэснийг та эрхмүүд дуулсан уу? дуулсан уу, үгүй юү? гэсэнд хоёр цэрэг хэсэг дуугүй байснаа,

-Үгүй, ноёнтоон, бид юу ч дуулаагүй-гэж зэрэг хариулав. Арамис намбатайяа мэхэсгээд маш эелдгээр цааш нь нэмж;

-Таныг дуулгаж гялайлгах байлгүй гэж санаж байна гэв.

-Ван цаашдаа хамба гуайн торгон цэргээс шилж өөрийнхөө шадар цэрэгт авч байя гэж над хэлсэн.

-Хамба гуайн торгон цэргээс гэнэ? Яаж байгаа нэтэр вэ! гэж Портос дуу алдав. -Эсэглэн муу дарсаа, сайн дарсаар сэлбэх хэрэгтэй болж гэж ван дүгнэсэн байна. Хоёр шадар цэргийн царай хувьс гэв. д'Артаньян орох газраа олохгүй, газрын гаваар ч болов орчиход бэлэн байв. Де Тревиль гуай улам шатаж:

-Тиймээ. тийм. Яриагүй их эзэнтний зөв, юу гэвэл, эрхэм шадруудад ордонд тун шалихгүй үүрэгтэй байгаа юм. Хамба гуай өчигдөр орой шатар тавих зуур над, танай хараал идсэн буучид, хэргийн эзэд,-энэ үгээ эгдүүтэй хэлсний нь яана,-орой Феру гудамжны нэг мухлагт хориотой цаг болсон хойно сууж байсан гэнэ гэж мануулан нүдээрээ өөдөөс минь ширтэн айхгар өрөвдсөн дүрээр хэлэхэд миний зэвүү хүрснийг хэлээд яахав. Улаан нүүрэн дээр, дооглож инээд алдчих гэж бэйгаа юм шиг, -Эргүүл хийж явсан манай торгон цэргүүд шөнийн амгалан байдал алдагдуулсан тэднийг барихаас өөр аргагүй болж дээ гэлээ шүү. Чөтгөр алгад, ямар учиртайг та нар мэдэж байна уу? Шадар цэргүүдийг баривчлах шүү! Тэр бүлэгт

та нар... тиймээ, бүү марга, та нарбиеэрээ байсан гэнэ. Битгий мэтэг. Та нарыг таньсан байна. Хамба нэрээр чинь цохоод хэлж байна. Миний буруу, би өөрөө хүнээ шилж авдаг болохоор өөрий минь хохь! За ингэхэд Арамис танд хувраг их зохидог байтал юунд надаас шадар цэргийн хувцас гуйсан юм бэ? Портос та ч... сүрэл илд зүүх санаатай ийм дэгжин алтанмөрөвч зүүгээ биз дээ? Би Атос.Атос үзэгдэхгүй байх чинь... хайчаав гэлээ.

-Эрхэм ноёнтоон, Атос өвчтэй, хүнд өвджээ,-гэж Арамис гунигтай дуугарав. -Өвчтэй гэнэ? Хүнд өвдөж гэв үү та? Ямар өвчин тусчихаа юм бол?

Үг хэлэхийг хичээж байсан Портос өгүүллрүүн:

-Цэцэг өвчин биш байгаа гэж айж байна, ноёнтоон тун тоогүй хэргээ. Энэ өвчин царайгий нь гутааж мэднэ гэлээ.

-Цэцэг ий? Портос та бас хачин юм ярьдаг хүнээ! Атосын насан дээр цэцгээр өвдөх гэж үү! Яасан ч үгүй! Тэр лав шархадсан уу... аль алагдсан... Мэдэж болдогсон ч болоосой... Чөтгөр алгад! Эрхэм шадар цэргүүд ээ! Манайхан олхио муутай газраар хэсэж, гудамжинд хэрүүл маргаан тарьж харанхуй буланд илдээр хатгалцаж яваасай гэж хүсэхгүй байна. Тэгээд ч манайхан хамба гуайн торгон цэргийн доог болоосой гэж би ер хүсэхгүй. Тэр торгон цэргүүд ер нь журамтай номхон, овжин эрс юм гээч. Тэд баривчлагдах хэрэг өдүүлэхгүй, тэгээд ч бас баривчлагдаж явахаар эрс биш л дээ.

Би сайн мэдэж байна? Тэд чиньганц алхам ч гэсэн ухарсанд орохноо доороо үхвэл дээр гэж үзэх улс. Амь зулбах, зугатаах, буруулах гэдэг чинь вангийн шадар цэргүүдийн ганц чаддаг ажил даа! Портос, Арамис хоёрын хилэн бадарч, чичирнэ. Де Тревиль гуай өөрсдөд нь голоосоо хайртай болоод л ийм үг ярьж байгааг тэр хоёр дотроо мэдрээгүйсэн болж гэм багалзуурдаадавахад бэлэн байв. Хоёр цэрэг өсгийгөөрөө хивс дэвслэж, уруулаа цус шүүртэл хазлан, илднийхээ ишийг чадлаараа атгана.

Атос, Портос, Арамис гурвыг дуудахыг хүлээх өрөөнд сонсож, де Тревиль гуайн дуугаар сүрхий хилэгнэсний нь мэджээ. Хэрэгт дурласан арваад хүн үг унагаахгүй санаатай үүдэнд наалдаж чагнав. Үүдний завсраар чих тавиад цөмийг сонсож даамлын хэлж байгаа эгдүүтэй үгийг давган нийтэд дуулгаж байхдаа тэдний царай уурласандаа зэвхийрч байв. Эгшин зуур өрөөний үүднээс аваад, шатны доод довжоо хүртэл бүх байшин буцалсан тогоо шиг болчихлоо. Де Тревиль гуай дотроо цэргүүдээсээ багагүй шатаж, сонсож байгаа улсын цээжинд хутга шаах мэт үг бүрээ нухацтай хэлэн,

-Ийм л байдаг юм байж! Вангийн шадар цэргүүд хамбын торгон цэрэгт баривчлагдаж явдаг байж! Хамбын зургаан торгон цэрэг их эзэнтний зургаан шадар цэргийг баривчилдаг юм байна хөөш! Чөтгөр алгад! Би ч хувьдаа шийдлээ! Одоо гараад л шуудхан Лувр руу очиж халагдъя, Вангийн шадар цэргийн даамал цолоо буулгая, тэгээд хамбын торгон цэрэгт дэслэгч болохыг гуйя. Болохгүй гэвэл, чөтгөр алгад, би хувраг болно гэв.

Энэ үгийг дуулаад өрөөний гадаах улсын дургүйцсэн яриа бөөн шуугиан болчихлоо. "Чөтгөр алгад!" гэх шиг янз янзын хараал тасрахгүй дуулдана. д' Дртаньян араар нь ороод нуугдчихмаар нэг хөшиг хайж ширээн доогуур шургачмаар санагдаад болж өхгүй байлаа.

Портос бүр биеэ барьж чадахаа болиод,

-Ийм юм, даамал гуай, бид нээрээ зургуулаа, тэд ялгаагүй зургуул байсан үнээн. Тэхдээ биднийг булангийн цаанаас гэнэт дайрч, илдээ сугалж амжихаас өмнө хоёр маань доороо алагдсан байлаа. Атос хүнд шархдаад, алагдсанаас өөрцгүй ойчлоо. Атос хоёр дахин босох гэж оролдоод хоёуланд нь чадалгүй уначихсан. Тэгсэн ч гэсэн бид бууж өгөөгүй. Үгүй биднийг хүчээр чирээд явсан. Замдаа бид зугатаачихсан. Атосын хувьд бол, түүнийг үхсэнд тоолоод оролдохын хэрэггүй гэж санаад дайрсан газраа зөнд нь орхисон юм. Ийм л хэрэг болсон юм даа. Чөтгөр алгад, Даамал минь! Тулалдаан бүхэнд дийлж болохгүй шүү дээ.

Их Помпей хүртэл фарсалийн тулалдаанд дийлдсэн, овоо эр гэж миний дуулсан нэгдүгээр францис ван ч гэсэн Павийн дэргэдэх тулалдаанд дийлдсэн гэдэг гэв.

Арамис өгүүлрүүн:

-Танд хичээнгүйлэн илтгэхэд дайрсан хүмүүсийн нэгийг би өөрий нь илдээр дүрчихсэн гэх юм уу алчихсан ч гэсэн ялгаагүй. Миний өөрийн илд эхлээд л дороо хугарчихсан юм, алсан гэнэ үү, бүлсэн гэнэ үү, тааллаараа үз гэв.

Де Тревиль гуай жаал зөөлөрч.

-Би үүнийг мэдээгүй шүү. Хамба гуай янз нь жаал нэмүүлсэн болтой гэв.

Де Тревиль гуай жаал зөөлөрснийг Арамис үзээд юм гуйхаар зүрхлэн.

-Эрхэм ноёнтоон танаас хичээнгүйлэн гуйя. Атосыг шархадсан гэж хэнд ч бүү ярьж үзээрэй, Ванд энэ дуулдчих юм бол Атос өөрөө зовж сүйд болно. Шарх тун хүнд, илдний үзүүр мөрий нь шувт гараад, цээж рүү нь орчихсон болохоор, айхад учир...

Яг энэ үеэр үүдний хөшиг сөхөгдөж, нүдэнд дулаахан, сайхан боловч, хариугүйцонхигор царайтай шадар цэрэг босгон дээр зогсож харагдлаа. Хоёр шадар цэрэг.

-Атос! гэж зэрэг дуу алдав. Де Тревиль гуай мөн дагалдан.

-Атос! гэв. Атос де Тревиль гуай өөд харж, дорой боловч амгалан дуугаар,

-Даамал гуай та намайг дуудаа юу. Таныг дуудлаа гэж над нөхөд хэллээ. Тэгээд би яарч ирлээ. Тушаалыг сонсьё эрхэм ээ гэж хэллээ.

Ингэж хэлээд, хэзээнийхээ зангаар төв аятай хувцасласан, тэр шадар цэрэг, цэх алхан өрөөнд орж ирэв. Ингэж эр зориг гаргасанд сэтгэл нь гүнээ уярсан де Тревиль гуай өөдөөс нь тосч очоод,

-Дөнгөж сая энэ эрхмүүдэд, шадар цэргүүд хэрэгцээгүй цагт амь насаа дуйж явахыг хориглоно гэж хэлсэн юм. Эр зоригтой эрчүүд ванд үнэтэй, та нар хорвоо дээр хамгийн зоригтой улс гэдгийг ван мэдэж байгаа юм. Атос таны гарыг барья! гэлээ.

Де Тревиль гуай нөхөрсөг сэтгэлээ ингэж илчлээд, суулд орж ирсэн хүний хариу "хэлэхийг хүлээлгүй баруун гары нь шүүрч аваад чадлаараа атгахдаа Атос хэдий биеэ барьж чаддаг боловч, өвдсөндөө бие нь загзас хийгээд, царай нь цаашаа цайрах нөхцөлгүй мэт харагдавч, улам зэвхийснийг анзаарсангүй.

Үүд жаахан нээлттэй хэвээрээ. Уул хэрэг нууц байсан мөртлөө Атосын шархтсаныг олонхи хүн мэдэж байсан болохоор өөрөө хүрээд ирсэнд улс мэл гайхжээ. Даамлын саяны үгийг дуулаад гаднах улсын сэтгэл онгойж магнай тэнийсэн болтой бөөн шуугиан дэгдэж, хөөрсөн хоёр гурван хүний толгой үүдний хөшгөн завсраар цухуйв. Де Тревиль. гуай ингэж горим журам алдсанд ширүүн үг хэлэх л байсан биз. Гэтэл өөрий нь барьж байсан Атосын гар гэнэт огцом чичирсхийхийг мэдэж шадар цэрэг өөд хартал цаадах нь юу юугүй ухааналдах гэж байв. Ингэтэл, өвдсөнөө даах гэж хамаг чадлаа шавхаж байсан Атос, өөрийн эрхгүй дийлдэж. шалан дээр үхсэн хүн шиг уначихав. Де Тревиль гуай,

-Эмч! Миний юм уу, вангийн тэргүүн эмчийг дууд! Эмч дуудахгүй бол миний зоригт Атос үхэж мэднэ. Чөтгөр алгад гэж хашгарав.

Де Тревиль гуайг хашгарахад хүлээх өрөөнд цугларсан улс цөм өрөө рүү чихэж орлоо. Де Тревиль гуай үүдээ хаая ч гэж санасангүй. Цөм шархтанг тойрч үймнэ. Эмч де Тревиль гуайнд байгаагүйсэн бол яаж ч оролдоод дэмий байхсаан. Эмч улсын дундуур шахцалдсаар ухаангүй хэвтсээр байгаа Атост ойртож, үймээн шуугиан саадтай байсан болохоор юуны өмнө шархтанг зэргэлдээ өрөөнд аваачихыг шаардав. Де Тревиль гуай өөрөө үүд нээж түрүүлэн, нөхрөө өргөж явсан Портос, Арамис хоёрт зам заалаа, хойноос нь эмч дагаж эмчийн араас үүд хаагдлаа. Тэгээд орсон хүнд айдас төрүүлдэг де Тревиль гуайн нөгөө өрөө даруй хүлээх өрөөний нэг хэсэг болчихов.

Хүн бүр чанга дуугаар яриа дэлгэн, болох болохгүй үг гэж айхгүй, хараал ерөөл тавьж хамбыг чөтгөршулам руу тонилоосой гэж зүхнэ.

Жаал азнаад Портос, Арамис хоёр гарч ирлээ. Шархтны дэргэд де Тревиль гуай, эмч хсёр л үлдэв.

Тэгж тэгж, де Тревиль гуай гарч ирээд, шархтан ухаан орсныг дуулгав. Ганцхан цус их алдсанаас болж шархтны бие тамир алдарснаас өөр нөхдөд нь сэтгэл зовохоор юм огт алга гэж эмч үзжээ.

Тэгээд Де Тревиль гуайг гараа дохисонд д'Артаньянаас бусад нь цөм гарч одов. Мань хүн уулзах завшаан олдсоноо марталгүй гаскон хүний шургуу зангаар дороо үлджээ.

Улс цөм гараад үүд хаагдсан хойно де Тревиль гуай эргэтэл маань залуутай нүүр тулгарав. Саяны явдлаас болоод де Тревиль гуай мартчихсан байжээ. Тэр шургуу хүн өөрөөс нь юу хүсэж явааг де Тревиль гуай сонирхов.

д'Артаньян нэрээ хэлэхэд де Тревиль гуай өнгөрсөн, одооны явдлуудыг сая санах. Де Тревиль гуай инээмсэглээд

-Нэг нутгийн залуу минь уучилж үзээрэй, Би таны тухай бүр мартчихжээ. Яая гэхэв дээ, даамал гэдэг чинь өрхийн тэргүүлэгч эцэг л гэсэн үг, ялгаатай нь л ерийнэцэг хүнээс илүү их хариуцлагатай юм. Цэрэг гэдэг чинь насанд хүрсэн хүүхдүүд, тэгээд ч би ван болоод ялангуяа хамба гуайн тушаал биелүүлж байхыг шаарддаг болохоор... гэж ярихад нь д'Артаньян тэссэнгүй инээмеэглэв. Энэ инээмсэглэлээс де Тревил гуай өмнөө тэнэг биш хүн байгааг мэдээд шууд ажил төрлийн ярианд оров.

-Би танай эцэгт тунсайн байсан юм. Хүүд нь би юугаар тус хүргэж болмоор байна? Түргэхэн ярьчих. Би заваар тун муухан байна гэж де Тревиль гуай хэлэв. д'Артаньян:

-Тарбаас Парис орохоор мордохдоо таны мартаагүй байгаа энэ нөхөрлөлд долдойдон танаас шадар цэргийн хувцас гуйх санаатай байсан юм. Гэвч энэ хоёр цагийн дотор үзэж өнгөрсөн бүрдийг бодоход энэ тун өндөр хишиг юм байна, би үүнийг хүртэж чадахгүй болов уу гэж айх боллоо гэж хэлэв.

Де Тревиль гуай хариуд нь

-Энэ чиг үнэхээр хишиг шүү залуу минь. Гэвч таны хувьд гэвэл, өөрийн чинь бодож байгаа юм уу аль бодсон дүр үзүүлж байгаа шиг тийм болшгүй зүйл биш байж болох юм. Гэхдээ их эзэнтний нэг захирамжинд, иймэрхүү учралын тухай урьдчилан заасан зүйл бий. Тэгээд хэнч гэсэн хэд хэдэн тулалдаанд шалгарч, ямар нэг гялалзсан гавьяа байгуулахаас нааш юм уу, арай доор бусад хороонд хоёр жил алба хаахаас нааш шадар цэрэгт авдаггүйг би аргагүй л өөрт чинь дуулгах болж байна гэв.

д'Артаньян дуугүй мэхэсхийв. Хүссэндээ хүрэхэд хэдий бэрхийг дуулах тусмаа шадар цэргийн хувцас өмсөх хүсэл улам хүчтэй төрнө.

Де Тревиль гуай нутгийнхаа залуугийн нарийн бодлыг таах гэсэн юм шиг өөдөөс нь хянуур гэгч хараад,

Гэхдээ, түрүүнийхээ хэлсэнчлэн, таны эцэг хуучин андаа хүндлэх сэтгэлийн үүднээс залуу танд эрхбиш тус болохыг хүсч байна. Манайбеари нутгийн залуус баян байх нь ховорсон. Намайг төрсөн нутгаасаа гарснаас хойш байдал нэг их өөр болчихоогүй байлгүй. Бодвол таны авчирсан мөнгө амь зуухад хүрэлцээгүй л байгаа биз гэлээ.

д'Артаньян хэнээс ч юм горьдоогүйгээ төрх байдлаараа харуулан толгойгоо бардам өргөсөнд де Тревиль гуай:

-За боль, боль залуу минь, наад зангий чиньби андахгүй. Парист би өвөртөө дөрвөн экютэй ирсэн хүн. Гэхдээ намайг Лувр орд худалдаад авч дийлэхгүй гэж хэлж зүрхэлсэн хүнийг ирүүл тулалдаанд дуудах байсандаа гэв

д'Артаньян толгойгоо улам өргөв. Морио зарсны ачаар де Тревиль гуайд эхлээд байснаас д'Артаньян дөрвөн экюгээр илүү мөнгөтэй байв.

-Ингэхлээр, та мөнгө ихтэй ирсэн гэлээ ч түүнийгээ гамнах хэрэгтэй, цаашлаад зэвсэг

барихад улам төгс мэрэгжих хэрэгтэй, тайж хүнд энэ зайлшгүй чухал. Би өнөөдөртөө вангийн цэргийн дээд сургуулийн захиралд захиа бичье, маргаашаас аваад тэр таныг ямар ч хөлсгүй сургаж эхэлнэ. Үүнээс бүү татгалз. Манай залуу тайж нар, хамгийн сурвалжтай, баян тайж нар ч гэлээ тэнд орох гэж зөндөө хөөцөлддөгл юм. Та морин, илдний, бүжгийн сургуультай болно. Та тэнд хэрэгтэй сайн улстай танилцана, хааяа наашаа ирж хир урагштай яваагаа дуулгаад, туслуулмаар юм байвал хэлнэ биз гэж даамал хэлэв.

Ордны өнгөц зан д'Артаньянд хэдий шингээгүй байсан гэлээ ч нэг л хүйтнээр хүлээн авч байгааг тэр аргагүй мэдэрчээ.

-Ээ харла! гэж д'Артаньян дуу алдаад,-Эцгий минь өгсөн танилцуулах захидал хир их үгүйлэгдэж байгааг би сайн ойлгож байна даа гэв.

Де Тревиль гуай,

-Үгүй нээрээ, та ийм хол замд гарахдаа манай беари хүний ганц амин чухал түлхүүр болсон захиа аваагүйд би гайхаж байна гэж хариулав.

-Над захиа байсан юм, ноёнтон эрхэм ээ, бурхны авралаар, бичих ёсоор л бичигдсэн захиа байсан. Гэтэл хорон санаагаар түүний минь хулгайлчихсан юм гэж д'Артаньян дуу алдав. Тэгээд мань хүн Менг хотонд болсон явдлыг нэгд нэггүй ярьж, үл таних тайжийн төрх галбирыг гаргаж хэлэв. Залуугийн шамдангуй голч итгэмжтэй яриа де Тревиль гуайд таалагдав. Шадар цэргийн даамал бодолд автан;

-Хачинявдал байна. Та тэгээд миний нэрийг чангад дурссан юм биз дээ? гэв. -Тэгэлгүй яахав. Би тийм л болгоомжгүй байж дээ. Өөр яах вэ дээ. Таных шиг ийм нэр над замын халх болох ёстой байлаа. Та өөрөө бодоод үз. Би олон л удаа түүгээр түрээ барьж яваа шүү дээ.

Тэхэд зусар, явцтайбайсан цаг. Де Тревиль гуай бусад алив ван хамба нарын адил сайшаал магтаалд авгамтгай байжээ. Де Тревиль гуай өөрийн эрхгүй таатай инээмсэглэснээ, доороо больчихоод, Менгд болсон явдлыг өөрөө дахин сонирхож.

-Тэр тайжийн чамархайн дээр бүдэгхэн сорви байгаагүй биз хэлээч? -гэв.

-Байсаан. Сумны ором шиг сорви байсан.

-Сүрхий буйртай эр байсан уу?

-Тийм ээ.

-Өндөр нуруутай юу?

-Тийм.

-Хар үстэй, цонхигор царайтай юу?

-Тийм, тийм, яг тийм хүн. Ноёнтоон, та тэр хүнийг яаж таньдаг юм бэ? ээ дээ, Нэг цагт би

түүнийг олж чадвал уу, танд ам алдъя. Тамаас ч болсон, заавал эрж олноо би түүнийг... -Тэр нэг эмэгтэйг хүлээж байсан уу?

-Тэр хүн юу ч гэсэн, хүлээж байсан эмэгтэйтэйгээ хэдэн үг сольсон хойноо л явсан даа. -Юу ярьсны нь та мэдэхгүй биз?

-Тэр хүн эмэгтэйд нэг хайрцаг өгөөд, дотор нь зохих захирамж бий, Лондон орсон хойноо л нээгээрэй гэсэн.

-Тэр эмэгтэй Англи хун байсан уу?

-Наадах нь тэр эмэгтэйг Миледи эрхэм хатагтай гэж байна билээ.

-Тэр мөн гэж де Тревиль гуай шивнэв. Тэр мөн. Би: түүний чинь Брюссельд байгаа юм бодсон юм.

д'Артаньян дуу алдаж,

-Ээ ноёнтоон! Тэр хүний хаанахын хэн болохыг хэлж өгч үз. Би танаас юу ч гуйхаа больё. Шадар цэрэг болгож өхийг ч гуйхаа больё! Юуны өмнө би түүнтэй тооцоо хийх ёстой хүн гэв. Де Тревиль гуай мөн дуу тавьж,

-Бурхан таныг түүнээс авраг,залуу минь! Та түүнтэй гудамжинд дайралдвал бушуухан нөгөө талд нь гарч бай. Тэр байц цохиотой бүү мөргөлд, шил шиг бут үсрэх бий, гэсэнд д'Артаньян, -Тэгсэн ч гэсэн би түүнтэй уулздаг л юм бол... гэж дуугарав.

-Юу ч гэсэн одоохондоо түүнийг эрээд юу хийхэв гэж зөвлөмөөр байна, гэж де Тревиль гуай хэлэв.

Де Тревильд гэнэт хачин сэжиг төрөөд дуугүй болчихов. Эцгийнхээзахиаг хулгайлсан гэж байгаа хүнд залуу хүү ингэж учиргүй их өшсөн байх...Энэ өшөөний цаана ямар нэгэн хорт санаа бүгж байхыг хэн байг гэх вэ? Их гэгээнтэн энэ залууг над руу явуулсан юм биш байгаа? Де Тревиль намайг гэнэдүүлэх санаатай ирсэн хүн биш биз дээ? Өөрийгөө д'Артаньян гэж байгаа энэ хүн манайд шургалж итгэл олсон хойноо намайг хөнөөх гэсэн тагнуул этгээд биш байгаа? Бусдыг тэгээд л хөнөөж байсан шүү дээ гэж бодох зуур де Тревиль залуу хүүг улам ч хянуур ажив. д'Артаньяны залирхуу, ухаалаг хуурмагхан даруу төлөв үзүүлсэн хувирамтгай царай даамлын сэтгэлийг нэг их тайвшруулсангүй. "Үнэндээ гаскон нутгийн хүн нь андашгүй байна. Гэхдээ энэ залуу авхаалж чадвараа хамба бид хоёрын алинд ч нэг адил өгч болох юм шүү дээ. Туршаад үзье..." гэж Де Тревиль бодлоо. Де Тревиль алгуурхан яриа үүсгэж.

-За, хуучин найзынхаа хүүг өөрт чинь даруй мэдэгдтэл хүйтэн угтаж авсан гэмээ би цагаатгаж манай улс төрийн бсдлогын нууцыг чамд тайлж өгье. Тэр захианы талаар ярьсан бүгдэд би итгэж байгаа болоод тэр шүү дээ. Ван хамба хсёр дотно анд улс. Тэд ганцхан тэнэгүүдийг хуурахын тулд хоорондоо эв муутай дүр үзүүлдэг юм. Нэг нутгийн минь, урагштай явахаар хиймортой төрсөн жавхаатай сайхан залуу энэ илбэнд хууртаад төөрөлдөж,

бусад олон хүний нэг адил үүнд хүзүүгээ хугалаасай гэж бихүсэхгүй байна. Энэ хоёр хүчирхэг дээдэст би үнэнч зүтгэдэг хүн гэдгийг санаж яв. Би алхах бүрдээ Ван, францад урьд хожид төрөөгүй суут ухаантны нэг хамба гуай хоёрын төлөө зүтгэхийг эрхэмлэдэг юм. Залуу та үүнийг одоогоос эхлээд ухаарч ав. Ер нь тэгээд гэр бүл, нөхдийн талыг татаж юм уу, өөрийнхөө дур эрмэлзлэлд автан олонх тайж нарын адил хамбад дайсагнах сэтгэл та өвөрлөж явдаг бол ингээд салцгаая. Би алив нөхцөл байдалд өөрт чинь тусална. Гэхдээ өөртөө шадар дотно болгохгүй. Юу ч болсон миний ингэж харамгүй хэлсэн үг та бид хоёрыг нөхөд болгох биз гэж найдна. Юу гэвэл миний урьд хожид ингэж илэн далангүй ярьсан залуу ганцта л байна гэлээ.

Де Тревиль дотроо "Энэ үнэгийг хамба гуай над руу явуулсан бол, өөртөө миний хир дургүйг тэр мэдэх болохоор над итгэл олж шургалахад өөрийнхөө тухай элдэв муу юм хэлэхийг сайн арга гэж тагнуул этгээдээ захиа байлгүй. Тэгээд энэ зальт этгээд, миний үгийг хайхралгүй даруй их гэгээнтэнд дургүйгээ гайхаж гарах биз" гэж бодлоо. Гэтэл хэрэг Де Тревилийн санаснаас шал ондоо боллоо. д'Артаньян эрс шулуухан хариулсан нь

-Ноёнтоон би Парист яг тийм санаатай ирсэн юм. Миний эцэг над ван хамба та гурваас өөр хэнд ч бүү захирагд гэж захисан юм. Энэ гурван хүнийг зцэг минь францын ихэс дээдэс гэж үздэг юм гэж төлөвхөн хэллээ.

Ажвал д'Артаньян эхний хоёр нэрэн дээр, Де Тревиль гуайн нэрийг өөрөө нэмжээ. Өөрийн нь бодлоор ингэж нэмэхэд хэрэг буруудахааргүй байжээ. д'Артаньян цааш өгүүлрүүн -Иймд би хамба гуайг гүнээ хүндэлж, үйл ажлы нь биширдэг юм... Хэрэв та үнэхээр хэлж байгаагаараа харамгүй ярьж байгаа бол над сайн л байна. Тэгвэл бидний үзэл нийлж байгааг та над харуулж итгүүллээ. Харин та надыг бүрэн итгэхгүй байж болох юм. Тэгээд намайг туршсан бол, миний энэ үг мэдээжээр намайг танд үнэ цэнэгүй болгох хэрэг. Гэсэн ч хамаагүй, та миний шулуун шудрагыг үнэлж үзэх бизээ. Танд овоо хүн гэж санагдах нь хорвоо дээр над юунаас ч үнэтэй юм гэлээ.

Де Тревиль гуай маш гайхав. Ийм хурц ухаан, эршүүд үнэн үг бахдал төрүүлэвч эргэлзээ бүрэн арилахгүй байв. Бусад залуу хүний дэргэд энэ залуугийн давуу тал хэдий тодрох тусам. Де Тревильд, түүнд итгэх нь зөв үү? буруу юу? гэдгийг эрэгцүүлэн бодож болгоомжлох үндэс улам их аж. Де Тревиль гуай д'Артаньяны гарыг атгаад,

-Та голч шудрага хүн юм. Гэхдээ би хэлснээсээ илүү тус хүргэж чадахгүй. Манайд та дуртай цагтаа орж гарч байгаарай. Аль ч үед надтай уулзаж, чухамдаа зохистой уеийг ашиглах боломжтой болохоор цаашдаа та лав эрмэлзсэн зүйлдээ хүрэх бизээ гэв.

-Чухамдаа гээд яривал, та надыг тийм хишиг хүртээж болохоор хүн мөнөө үзүүлэхийг хүлээж байх шив дээ, гэж д'Артаньян дуугараад, гаскон хүний хэнэггүй байраар За яахав. Та удаан хүлээхгүй биз гэв.

-Тэгээд ч цаашдын хамаг хэргийг ганц өөрөө даах юм аштай мэхийж ёслоод явахаар завдлаа. Де Тревиль түүнийг дуудаад.

-Үгүй байз л даа. Цэргийн дээд сургуулийн даргад захиа бичиж өгье гэж би амласан шүү дээ.

Үгүй бол залуу минь та надаас тийм захиа авахааргүй их сэхүүн зантай хүн уу? гэсэнд д'Артаньян хариуд нь.

-Үгүй ноёнтоон, түүнийг би эцгийнхээ захидал шиг хүний гарт оруулахгүйг амлая. Захидлы тань лав хүрэх газартаа очихоор нандигнан хадгална. Надаас түүнийг хулгайлах гэж оролдсон хүний хохь болог! гэлээ.

Де Тревиль гуай энэ бардам үгийг дуулаад инээмсэглэв. Сая ярилцаад зогсож байсан цонхны дэргэд залуу хүүг үлдээгээд, Де Тревиль амласан захиагаа бичихээр ширээнд суулаа. Хийх юмгүй үлдсэн д'Артаньян энэ зуур цонхны шил тоншин нэг дууны аялгуу оруулна. Ганц нэгээрээ цуварсаар явж байгаа шадар цэргийг ажиглаж, гудамж тойртол хойноос нь харж байлаа.

Де Тревиль гуай захиагаа бичиж дуусч, дугтуйлаад босч залууд өхөөр очив.

д'Артаньян захиа авах гээд гараа сарвайтал гэнэт зог тусч, дүрсхийж уурлаад, өрөөнөөс. - Үгүй, чөтгөр алгад! Одоо чи надаас зайлахгүй бий! -гэж хашгачин гүйж гарсанд Де Тревиль их гайхлаа. Де Тревиль,

-Хэн бэ, хэн тэр вэ? гэж хэд асуухад.

-Нөгөө, нөгөө хулгайч! муу хар новш! -гэж Артаньян явуут хэлээд гарч одлоо. -Солиотой эрээ! гэж Де Тревиль үглээд, алгуурхнаар -харин, хуурч чадаагүйдээ, зугтаах гэсэн арга л биш бол гэж дуугарав.

IV. АТОСЫН МӨР, ПОРТОСЫН МӨРӨВЧ, АРАМИСЫН АЛЧУУР

Хүлээх өрөөгөөр д'Артаньян галзуу хүн шиг харайж гараад, шатны тавцандээр гүйж гарлаа. Шатаар дэгдээд буучих санаатай яваад мань хүн гэнэт де Тревиль гуайнхаас хажуугийн хаалгаар гарч явсан шадар цэрэгтэй мөргөлдчихөв. Шадар цэрэг дуу тавьж, онож хэлбэл өвдсөндөө ёоллоо. д'Артаньян цаашаа явах санаатай;

-Уучлаарай, Би баахан яараад.. Уучлаарай, гэв.

Залуу хүү дараагийн тавцанд хүрч амжаагүй явтал мөрөвчнөөс нь төмөр мэт хүчтэй гар шүүрч аваад зогсоов. Үхдэл шиг зэвхийрсэн шадар цэрэг,

-Та яарч явдаг. Тэр шалтгаар намайг мөргөчихөөд "уучлаарай" гэсэн төдийгөөр хэрэг шувтарлаа гэж үзэж байна уу? Арай тийм бишээ, залуу минь. Де Тревиль гуай өнөөдөр бидэнтэй ширүүн ярьсан болохоор биднийг басамжлан үзэж болох юм гэж та арай санаагүй биз? Андуурч байна, залуу минь та чинь Де Тревиль гуай биш шүү гэж дуу алдав.

Боолгочоод буцаж яваа Атосыг д'Артаньян сая таньж,

-Нээрэн би санамсаргүй мөргөчихлөө. Санамсаргүй мөргөчихөөд би уучлаарай гэсэн шүү дээ. Миний санахад ингээд болмоор юм. Би яарч яваагаа, тандяхав дахиад хэлье. Энэ ч илүү юм шив дээ. Тэхлээр та надыг одоо тавь даа, битгий садаа болж үзээч гэв.

Атос мөрөвчий нь тавиад,-эрхэм ээ та бүдүүлэг эр байна. Холоос ирсэн гэдэг чинь ил байна-гэлээ.

Доошоо гурван гишгүүр буучихаад байсан д'Артаньян, Атосын үгийг сонсоод доороо зогсов. -Чөтгөр алгад! Би алсаас ирсэн үнэн боловч, танаар горим ёс заалгахгүй гэдгийг сануулъя. Эрхэмээ!-гэж хэлэв. Атос хариуд нь хэн мэдхэв дээ! гэхив.

-Ээ, ингэж их яараагүйсэн болдоо! Нэг хүний хойноос хөөгөөгүйсэн болж гэм гэж д'Артаньян гаслав.

-Сандруу эрхэм минь та надыг хөөцөлдөлгүй олж болно шүү, дуулав уу?

-Хаа тэрвэ хэлчихгүй юу?

-Дешо хийдийн ойролцоо.

-Хэдэн цагт?

-Арван хоёрын үед.

-Арван хоёрын үед гэнээ? За, тэнд очоод байж байя

-Намайг хүлээлгэхгүйг хичээгээрэй. Ганц мөчийн дотор чихий чинь огтлоод өгөмц. -За арван хоёр цагт арван минут дутуу байхад очно гэж д'Артаньян доороос хашгарав. Нөгөө хүн

түрүүн аажуу явж байсан болохоор холдож чадаагүй баймаар.

д'Артаньян гүйцэх санаатай хар эрчээрээ гүйлээ.

Хаалганы дэргэд Портос манааны хүнтэй ярилцаад зогсож байгаа харагдав. Тэр хоёрын хоорондуур нэг хүн гүйгээд гарчихмаар зай байв. д'Артаньян энэ зайг боломжтой гэж үзээд, тэдний хорондуур сүм шиг харайгаад гарчих санаатай чигээрээ гүйлээ. Тэхдээ мань хүн салхийг бодолцсонгүй. Ярилцаж зогсох хоёрын дундуур д'Артаньян яг гарах үеэр Портосын өргөн нөмрөгийг салхи дэрвүүлж, мань хүн өргөн хуниас дотор нь орооцолдож орхив. Портост тэр хувцаснаасаа салахгүй байх чухаг учир байсан болтой, зориуд Портос гараараа барьж байсан хормойгоо тавихын оронд өөр рүүгээ татсаны гайгаар д'Артаньян хормой дотор эргэлдээд хилэн нөмрөгөнд бүр орооцолдчихлоо.

Цэргийн хараал урсгаж байх зуур д'Артаньян хуниасыг сохроор тэмтрэн нөмрөгнөөс мултрахыг оролдов. Нөгөө хээнцэр алтан мөрөвчий нь гэмтээгээд орхих бий гэж мань хүн их зовж байв. Гэтэл нүдээ сэм нээж харвал нүүр нь Портосын яг хоёр далны хооронд, өөрөөр хэлбэл мөрөвчинд тулсан ажээ.

Гай дайрахад, манай хорвоо дээр зөвхөн өнгөндөө гял цал болсон юм бишгүй байдагчлан Портосын мөрөвч зөвхөн урдаасаа алтан хатгамлаар гялалзаж, ардаа зүгээр үхрийн шир байсан юмсанж. Портос аргагүй их гайхуулах дуртай хүн болохоор, бүхлээрээ алтан хатгамалтай мөрөвч, олж авах тэнхээгүйн эрхээр ядаж өмнөө хатгамалтайг олж авчээ. Тэгээд л хуурмаг ханиад хүрч, нөмрөгний хэрэгцээ гарсан юм байж.

Портос ардаа мунгинаж байгаа д'Артаньянаас салах санаатай чадлаараа оролдон. -Шулам! хүн рүү ингэж дайрдаг чинь галзуураа юу? гэж орилно.

д'Артаньян лут эрийн тохой доороос цухуйж,

-Уучлаарай, би тун их яарч яваа юм. Би нэг хүний хойноос хөөж яваад... гэж дуугарав. -Хүний хойноос хөөх болохоороо та нүдээ гэртээ мартчихдаг хүн үү?-гэж Портос хашгачна. Артаньяны дургүй хүрч,

-Үгүй, үгүй, миний нүд чинь бусдын үзээгүй юмыг хүртэл үздэг юм гэж хэлчихэв. Портос ойлгосон, үгүйг бүү мэд, юу ч гэсэн байдгаараа шаралхаж,

-Эрхэм ээ, та шадар цэргүүдийг өдөөд байвал, баларч дуусна гэдгийг сануулъя-гэж занав. -Баларч гэнээ. Та арай дэндүүлээгүй байгаа? гэж д'Артаньян лавлав.

-Дайсныхаа өдөөс нүд дальдралгүй харж заншсан хүний л хэлсэн үг дээ.

-Хэлээд яахав! Та хэнд ч араа үзүүлэхгүйг би сайн мэдэж байна, гээд залуу хүү хошин шог үг хэлсэндээ тачигнатал хөхөрсөөр цаашаа явлаа.

Уур хорсол нь бадарсан Портос доромжлогч этгээд рүү ухасхийхийг завдтал, д'Артаньян өөдөөс нь:

-Дараа, дараа, таныг нөмрөгөө тайлсан хойно больё гэж хашгарав.

-Тэгвэл Люксембургийн ордны ард, нэг цагт уулзъя.

-За тэгье. Нэг цагт-гэж д'Артаньян хариулаад, гудадмж тойров. Гэтэл д'Артаньяны гүйж яваа, ойр хавийн нүдэнд ил гудамжны алинд ч нөгөө хүний бараа байдаггүй. Тэр хүн хэдий алгуур явж байсан гэлээ ч бараагүй болсон юм уу, нэг тийшээ орж амжжээ. д'Артаньян дайралдсан хүн бүрээс нөгөө хүнийг сураглаж, гарам руу бууснаа, эргэж Сений гудамжаар яваад, бас улаан загалмайн гудамжаар оров. Ерөөсөө юу ч байдаггүй. Гэлээ ч энэ эрэл түүнд тус болов. Духан дээр хөлс бурзайж ирэх тутам дотор уужирч явлаа.

Мань хүн сая болсон явдлын тухай эрэгцүүлэн бодов. Мундахгүй юм болсноос бүгд ая муутай санагдана. Дөнгөж өглөөний арван нэгэн цаг болж байв. Гэтэл энэ өглөө де Тревиль гуайн дургүйг хүргэж амжлаа. Өөрий нь тэгж юу хийгээд алга болсныг де Тревиль гуай хайш хэрэг танхай зан гаргалаагэхээс өөрөөр яаж үзэх вэ,

Нэмэр дээр нь бас хоёр хүнтэй тулалдах болчихдог. Тэдний аль аль нь д'Артаньяны дайтай гурвыг дөнгөчихөөр улс байдаг, чухамдаа гэвэл өөрөө гүнээ хүндэлж, дотроо ер хүн бүхнээс давууд үзэж биширдэг хоёр шадар цэрэгтэй шүү тэгээд.

Хүндхэн л юм боллоо. д'Артаньян өөрөө Атост алуулна гэж лавтай бодож байсан болохоор, Портостой тулалдах тухайдаа мэдээжээр нэг их санаа зовохгүй байлаа. Гэхдээ итгэл найдвар ер хүнд хамгийн сүүлд тасардаг болохоор мань хүн лут шархдах нь лав боловч, амьд үлдэж юу магад гээд, цаашдынхаа амьдралын замыг бодон хийсэн алдаагаа өөрөө буруушааж байв. "Би ер ямар бүдүүлэг тэнэг амьтан бэ!" Зоригт Атос хөөрхий яг миний толгойгоороо мөргөчихсөн мөрөндөө шархадсан юм шүү дээ. Тэр доороо л намайг цааш харуулчаагүй нь хачин юм. Тэхэд буруудах газаргүй. Ямар их айхтар өвдөө бол, Портосын хувьд ч нээрээ инээдтэй юм болсои шүү...

Мань залуу тэгээд гунигтай юм бодож явсан мөртөн инээдээ барьж чадсангүй, гэхдээ ингэж учир шалтаггүй инээхэд, бас нэг хүн гомдоод орхих бии гэж ийш тийшээ харлаа. "Портосын хувьд гэвэл инээдтэй хэрэг. Гэхдээ л би гэж тэнэг амьтан. Хүн тэгж мөргөж яаж болох вэ. Үгүй ер бас хүний доогуур ороод нууцы нь үзчихдэг. Тэр намайг уучлах байсан, би тэр хараал хүрсэн муу мөрөвчний талаар дайраагүйсан бол уучлалгүй яахав. Биүнэндээ үг цухуйлгаад л орхисон гэхдээ догь цухуйлгасандаа харин ч. Ээ би гаскон чөтгөр болохоороо тамын хайруул дээр шарагдаж байлаа ч хошигнож байх хүн дэг шүү!" гэж мань хүн өөртөө аргагүй ихээ нөхөрсөг хандан, "За д'Артаньян найз минь чи хэдий горьдлого бага боловч амьд үлддэг юм болж гэм хойшид догь эелдэг хүнболж уз. Одоогоос аваад л хүн бур чамайг бахдаж, цөм чамаас дууриал авахаар болог. Эелдэг, нийцтэй байх гэдэг чинь аймхай хулчгар гэсэн үг арай бишээ. Арамисыг хар л даа. Хонь шиг номхон тэр аяараа хээнцэр дэгжин эр байна шүү дээ. Арамис тэгээд Арамисыг хулчгар гэж хэлэх санаа ер хүнд төрөх үү дээ.

Мэдээжээр үгүй. Одоогоос аваад Арамисаас л бүх талаар үлгэр авья, үгүй ер, өөрөө бас энд байж байдаг байна шүү!"

д'Артаньян ингэж ганцаараа ярьсаар яваад д' Эгильоны байшингийн зэргэлдээ ирээд, яг

байшингийн өмнө вангийн хоёр торгон цэрэгтэй ярилцаад зогсож байсан Арамисыг харжээ. Арамис ч бас д'Артаньяныг харав. Энэ залуугийн дэргэд өглөө де Тревиль гуай тэгж айхтар шатсаныг Арамис мартаагүй байв. Шадар цэргүүдийн муугаар хараалгаж байгааг сонссон хүн өөрт нь аягүй санагдсан болохоор Арамис, д'Артаньяныг хараагүй байр үзүүлэв. Гэтэл д'Артаньян нөгөө эелдэг нийцэрхгийн дууриал болох гэсэн санаандаа автсаны зрхээр, тэр залуусын өөдөөс очиж маш найрсаг инээмсэглэн дэгжнээр мэхийн хүндэтгэв. Арамис үл мэдэг мэхэсхийсэн боловч инээмсэглэсэнтгүй. Тэр гурав яриагаа даруй тасалчихав.

д'Артаньян өөрөө тээр шаагдаж байгаагаа ухаарахаар сэргэлэн хүн мөртөө, сайн танихгүй хүмүүс дээр очоод тэдний өөртөө хамаарахгүй ярианд саад болчихсон хүний эвгүйбайдлаас аятайхан гарчихаар, ихэс дээдсийн нарийн арганд төгс боловсроогүй байжээ. Мань хүн эндээс эвий нь олоод, нэрээ авч холдохыг мэрийж байтал, Арамис алчуураа унагаад, янз нь анзааралгүй дээр нь гишигчив. д'Артаньянд эвгүй байдлаас гарах аятай шалтаг олдох шиг санагдлаа. Мань хүн бөхийж буучийг чадлаараа чанга гишгээд байгаа хөл доороос алчууры ньээлдэг байраар суга татаж авлаа.

д'Артаньян туйлын найрсгаар,

-Эрхмээ таны алчуур энэ байна. Хаячихвал танд лав хайран байхсан бизээ гэж дуугарав. Үнэхээр ч гуа сайхан хатгамалтай, өрөөсөн үзүүрт нь сүлд, титэм хоёр товойлгосон алчуур ажээ. -Мөөн, мөн, гэж нэг торгон цэрэг дуу алдаад,-Буа Траси авхайтан үүнд алчуураа хайрласан болохоор, мань Арамис хэдий юмаа нуух дуртай гэлээ ч одоо авхайтантай муу байдаг гэж бидэнд мэтгэхээ болино биз гэв.

д'Артаньяны өөдөөс Арамис зэрэвхийн харсандаа голоосоо өшит дайсантай болсныг харцаараа тодорхой ойлгуулжээ. Гэвч даруй эргэж ердийн нялуувтар дуугаар:

-Та эрхмүүд андуурчээ, энэ алчуур ерөөсөө минийх биш, харин яагаад алчуурыг та нарын нэгэнд өгөлгүй, тухайлан над өгмөөр энэ эрхэмд санагдсан юм бол, бүү мэд, миний үгний унэнийг яриагүй батлах зүйл гэвэл алчуур минь хармаанд байна.

Ингэж хэлээд Арамис хармаанаасаа өөрий нь нэрний толгой үсэгнээс өөр элдэв хатгамал сэлтгүй боловч мөн л дэгжин, нимгэн торгон алчуур гаргав. Тэр цагт ийм алчуур их үнэтэй байж билээ. Энэ удаа д'Артаньян алдаа гаргаснаа ойлгоод дуугүй өнгөрөв. Гэтэл Арамисын ингэж мэтгэн ярилцахад нөхөд нь амар итгэсэнгүй. Тэдний нэг нь зориуд төв дүр үзүүлэн, шадар цэргээс. -Хэргийн байдал нээрээ чиний мэтгэн байгаа шиг юм бол Арамис найз минь, би наад алчууры чинь нэхэж авахаас өөр аргагүй нээ. Буа Трас миний сайннайз гэдгийг өөрөө мэднэ. Тэхлээр эхнэрий нь эд юмаар өөр нэгэн хүн гайхуулж яваасай гэж хүсэхгүй байна гэсэнд Арамис: -Чи зохих ёсоор гуйхгүй байна. Чиний шаардлагын зөвийг хүлээвч, гаргаж хэлсэн хэлбэрий нь бодоод би татгалзана гэж хариулав.

д'Артаньян:

-Үнэндээ би алчуур яг Арамис гуайн хармаанаас ойчихыг хараагүй шүү. Арамисгуайг гишигчихээр л бн өөрий нь алчуур юм байх гэж бодсон юм, гэж хулгасхийн дуугарав. д'Артаньяны гэмээ цагаатгах санаатай мэрийж байгааг Арамис хараагүй юм шиг хүйтнээр, -

Тэгээд андуурч дээ гэв.

Буа Траситай нөхөрлөдөг гээд байсан нөгөө торгон цэрэгт Арамис;

-Одоо санавал би ч гэлээ БуаТраси гүнтэй танаас дутуугүй дотно холбоотой сайн нөхөд юм. Тэхлээр,..алчуур мөн чиний ч хармаанаас ойчсон байж болох юм гэж хэлэв.

-Үгүй ам алдъя нээрээ! гэж их эзэнтний торгон цэрэг дуу алдав.

-Чи ам алдээд, би үнэнийг барьж батлаад нэг маань л лав худалч болов болтой. Тэхээр, Монтарон, уүний чинь зүгээр хуваачихъя.

-Алчуурыг уу?

-Тийм

Торгон цэргийн хоёр найз,

-Естой догь! Соломон хаан шиг шүү дээ!

Арамис чи үнэхээр гойд цэцэн хүн юм байна шүү! гэж зэрэг дуу алдав.

Залуус хөхрөлдөөд, хэрэг явдал яахав мэдээжээр тэгээд л зогслоо. Хэдхэн минут болоод яриа дуусч, тэд элэгсгээр гар барилцаад салав. Торгон цэргүүд нэг тийшээ, Арамис нөгөө тийшээ алхлаа.

"Энэ сайн хүнтэй эвлэрэхаятайхан цаг ирлээ" гэж энэ яриа болох зуур холхон зогсож байсан д'Артаньян бодлоо. Тэгээд мань хүн сайхан сэтгэлэгт автан, өөрийгөө огт хайхралгүй алхаж байсан шадар цэргийг яаравчлан гүйцэв.

д'Артаньян, шадар цэргийг гүйцэж очоод,

-Эрхэм ээ, би таныг уучлах биз гэж найдна, гэсэнд Арамис үгий нь таслан,

-Өршөөлт эрхэмээ, та сая шудрага журамт хүний хиймээргүй юм хийснийг өөрт чинь дуулгая гэв.

-Юу гэсэн үг вэ, Өршөөлт эрхэм ээ?

Үгүй та юу гэж саналаа гэж үү...гэж Артаньян дуу алдав.

-Би таныг тэнэг хүн биш байх гэж санаж байна. Та хэдийгээр Гаскон нутгаас ирсэн боловч, шалтгаангүйгээр нусны алчуур дээр гишигдэггүйг эрхбиш мэдмээр юм. Чөтгөр алгад, Парист торго дэвсээтэй биш ээ.

д'Артаньяны найрсаг сэтгэлийг түргэн зан нь дийлж эхлээд,-эрхэмсэг, та намайг дайрах гэж хичээгээд яах вэ. Би нээрээ Гасконоос ирснээ өөрөө ч мэднэ, та ч мэдэж байна. Тэгээд

Гаскон нутгийнхан онцын хүлцэнгүй хүмүүс биш, гэдгийг сануулахын ч хэрэггүй биз. Өөрөөтэнэг юм хийчихээд ч гэлээ нэгэнт уучлал гуйвал, түүнийгээ бүр болохын ихээр боллоо гэж боддог улс шүү.

-Эрхэм ээ, би үүнийг тантай хэрүүл маргаан эрж хэлсэн юм биш. Бурхны авралаар би нэг хэрүүл маргааны түүс болсон этгээд биш, түр шадар цэрэг байгаа хүн. Аргагүйн эрхээр тулалддаг тэхдээ тун дургүй шүү. Энэ удаа бол уул хэрэг тоглоом биш, та бусгүй хүний нэр төрд хор хүргэлээ.

-Бид хоёр хор хүргэж гээч гэж! Артаньян дуу алдав.

-Та яагаад энэ алчуурыг над өгсөн юм бэ?

-Та яагаад энэ алчуурыг ойчуулсан юм бэ?

-Энэ алчуур миний хармаанаас унаагүй гэдгийг би танд хэлсэн, давтаад хэлж байна. - Ингэхлээр эрхэм та давхар худал хэлчихлээ. Би хармаанаас чинь унахыг өөрөө харсан юм. - Ухай, гаскон эрхэм та ингэж хамаагүй донгосч зүрхэлдэг бий...яаж зөв явахыг танд сургаад өгье!

-Аа би таныг мөргөл үйлддэг газарт чинь буцаагаад явуулчихъя, гэлэн гуай. Илдээ гаргаж үз, гуйя танаас, алив бушуухан.

-Үгүй үгүй, хонгор минь, юу ч гэсэн энд болохгүй хамбын талынхнаар дүүрсэн д' Эгильоны байшингийн халз өмнө бид байж байгааг та харж байгаа биз. Их гэгээнтэн, миний толгойг аваад ир гэж танд даалгаагүйг хэн над нотлох юм бэ!" Би толгойндоо горьгүй их хайртай юм, миний толгой биендээ яггүй аятайхан зохисон аятай өөрт санагддаг. Би таныг алахад татгалзах юм алга, бүү санаа зов. Гэхдээ өөрий чинь хэнд ч үхлээрээ гайхуулж чадахааргүй зайдуухан газар их сүр бололгүй аламц.

-За тэгье яахав. Ганцхан биеэ хэтэрхий их тоогоод дэмий энэ алчуураа, таных мөн ч бай, биш ч бай аваад очоорой, хэрэг болж мэдэх бий.

-Эрхэм та гаскон хүн үү? гэж Арамис ёжилж асуув.

-Тиймээ. Гаскон хүн ер тулалдахаа болгоомжлоод хойшлуулдаггүй юм шүү. -Болгоомжлох гэдэг шадар цэрэгт илүү зан гэдгийг эрхэм минь би мэднэ. Харин сүм хийдийн хувраг хүнд болгоомж заавал хэрэгтэй. Тэгээд би цаг зуурдын цэрэг болохоороо болгоомжтой байх нь дээр гэж санадаг юм. Хоёр цагт би де Тревиль гуайнд тантайуулзах завшаан гарах буйзаа. Тэхдээ тулалдах аятай газар танд зааж өгье.

Хоёр залуу ингээд салж, Арамис Люксембургийн ордон өөд чиглэсэн гудмаар явж, д'Артаньян цаг сүрхий оройтсоныг үзээд Дешо сүм рүү чиглэн алхав.

"Яая гэх вэ дээ. Засаж залруулах арга нэгэнт алга. Алагдвал шадар цэрэгт алагдана гэж сэтгэл засах юм биз дээ" гэж дотроо бодож явлаа.

V. ВАНГИЙН ШАДАР ЦЭРГҮҮД, ХАМБА ГУАЙН ТОРГОНЦЭРГҮҮД

д'Артаньян Парист таних хүн ганц ч үгүй болохоор Атостой тулалдахаар гэрчгүй очиж цаад талын гэрч хүмүүсээр л болгоё гэж шийдэв. Гэхдээ д'Артаньян зоригт шадар цэргийн өмнө мятрах байдал гаргалгүй хирэнд нь тааруулсгээд уучлал гуйхаар хатуу шийдэв. Эр чадал төгс залуу хүнд шархдаж суларсан хүнтэй иймэрхүү байдлаар тулалдсаны хойт уршгаас болгоомжлон уучлал гуйхаар шийдсэн аж. Цаад хүн дийлбэл, ялсан хүн давхар бахдах болно. д'Артаньян өөрөө дийлчихвэл итгэл алдаж шархтай хүнийг төвөггүй дийлсэн гэх биз. Мань төвөгтэй явдал эрэгчийн зан төрхийг бид л муу дүрсэлж гаргаагүй бол д'Артаньян жаал хачин хүн болохыг уншигч өөрөө ажиг ёстой доо. Иймд, д'Артаньян үхэхцаг ирсэн гэж өөрөө үглэсээр боловч арай зориг муутай, дотор давчтай хүмүүсийн нэг адилаар зайлшгүй үнэн гэдэг бодолд автан хүлцэнгүйгээр эвлэрч чадахгүй байв. Тулалдах болсон улсын зан төрхийг хооронд нь жишиж, тунгаан бодоод д'Артаньян байдлаа тод сайн ухааж авлаа. Атосын төв царай, төвшин аятай галбир д'Артаньянд их таалагдсан болохоор, уучлал гуйгаад цаашдаа нөхөрлөх сэтгэл төрүүлэхийг горилжээ. Мөрөвчний тухай яриагаар Портосыг айлгаж, дороо л алагдчихгүй юм болж гэм тэр мөрөвчний тухай аяыг нь олоод ярьж тараахаар сүрдүүлнэ гэж сэтгэлээ хуурч явлаа. Тэгж тараавал Портосыг найз нөхдийн нь элэг доог болгож чадахгүй яхав. Нөгөө овжин Арамисын хувьд гэвэл тэр д'Артаньянд нэг их аймаар хүнсанагдахгүй байв. Арамисын ээлж болдог юмаа гэвэл д'Артаньян түүнийг нэг бол доор нь үгүй хийх, эсвэл Помпейн цэргүүдийг Цезарь нүүр рүү нь цохь гэж зөвлөсөнчлөн мөн нүүр өөд нь хатган илтэд бахдаж явдаг царайгий нь гутаахаар хатуу шийджээ.

Үүнээс гадна д'Артаньян эцгийнхээ "Ван, хамба, де Тревиль гуайгаас өөр хэнд ч бүү захирагд" гэж захисныг баримтлан хэлбэршгүй зоримог байв.

д'Артаньян Дешо сүмийн зүг алхсангүй хар хурдаараа харайсны учир энэ билээ. Хагарч гүйцсэн цонхтой тэр хаягдмал сүмийн эргэн тойрон хов хоосон. Сен-Жермен де Пре сүмийн өмнө оюутнуудын зугаалдаг, тулалддаг зүлэг шиг тэр хоосон талбайд мөн цаг багатай хүмүүс ирж тулалддаг газар ажээ.

Сүмийн тэр хоосон талбайд д'Артаньяныг хүрч ирэхэд үдийн арван хоёр цаг цохив. Атос түүнийг дөнгөж таван минут төдий хүлээсэн болохоор мань хүн цагаа нарийн баримталж чадсан. Тулалдааны горимонд хэдий чанга шүүгч ч гэлээ түүнд хэлэх үггүй байхсаан. Атосын шархыг де Тревиль гуайн эмч шинээр боож өгсөн боловч сүрхий шаналаасан хэвээр, чулуун дээр суугаад, тулалдах этгээдээ ердийн амгалан, төлөв тохитой байдлаар хүлээж суув. д'Артаньяныг хараад босч, ёс бодож өөдөөс нь хэд алхав. д'Артаньян мөн малгайгаа гартаа, өдий нь газар шүүртэл доор барин тулалдах хүн рүүгээ дөхөж ирэх нь хүндэтгэн ёс бодсоны тэмдэг билээ.

-Эрхэм ээ би гэрч болох хоёр нөхдийнхөө хойноос хүн явуулсан нөхөд маань ирээгүй байна. Тэднийг хожимдож байгаад би гайхаж байна. Тэгдэг зантай улс биш л юмсан гэж Атос хэлэв.

-Над гэрч гэх хүн байхгүй. Би дөнтөж өчигдөр Парист ирсэн, энд над де Тревиль гуайгаас өөр таних хүн ганц ч байхгүй. Манай эцэг урьд де Тревиль гуайтай үерхэж байсан юм гэнэ,

тэгээд намайг өөр рүү нь явуулсан юм гэж д'Артаньяныг өгүүлэхэд,

Агос түр зуур бодол болж, байгаад;

-Та ердөө де Тревиль гуайтай л танил гэнээ? гэж асуув.

-Тиймээ, эрхэм ээ. Би ганц түүнийг л танина.

Агос хажуудах хүндээ дуулгах гэхээс илүү өөрөө өөртөө,

-Хэцүү хэрэг ээ бас! Үгүй бас хэцүү ээ! Би таныг алчих юм бол хүүхэд залгигч нэр авна даа, гэж дуугарав.

д'Артаньян аятайхан нь аргагүй мэхэсхийж, хариу марган,

-Арай тийм биш эрхэм ээ, та яриагүй их тээртэй байгаа шархаа хайхралгүйгээр надыг тоож тулалдах болсон хойно тийм биш шүү дээ гэв.

-Нээрээ их тээртэй байна үнэндээ гэхэд та намайг эолиг шиг их өвтгөсөн шүү. Би илдээ солгой гартаа барина. Иймэрхүү үед тэгдэг заншилтай юм. Өөрийгөө хожоотой болно гэж бүү бодоорой. Би хоёр гараараа адилхан чөлөөтэйажилладаг хүн. Харин ч танд жаал эвгүй л болох бий. Хүн дасаагүй болохоороо солгой хүнтэй тулалдахад зовлонтой байдаг юм. Би үүнийг танд урьдаас дуулгаагүйдээ харамсаж байна.

-Та, тун эелдэг хүн юм эрхэм ээ. Би гүнээ талархаж байна гэж д'Артаньян дуугарав. Агос маш эелдгээр:

-Би нээрээ таны яриаг дуулаад зовох шиг. Та дургүйцэхгүй бол хоёулаа өөр юмны тухай ярья. Ээ солиг гэж! Та надыг ямар их өвтгөвөө. Мөр халуу оргиод л байна! гэв.

Та зөвшөөрдөгсөн бол...гэж д'Артаньян хулгасхийж дуугарав.

-Юу тэр вэ, эрхэм ээ?

-Над шарх эдгээдэг гайхалтай сайн тос бий. Тэр эмийг над ээж өгсөн юм. Биеэрээ хэрэглэж үзсэндэг.

-Тэгээд юү гэж?

-Яахав дээ, та гурав хонолгүй эдгэрч орхино. Би лав мэдэж байна. Гуравхан хоног өнгөрсний эцэст, таныг эрүүл саруул болсон хойно тантай илдээ зөрүүлэхийг би их завшаан гэж үзнэ. Энэ үгийг д'Артаньян магтууштай эелдэг энгийнээр, тэхдээ өөрий нь эр зоригт эргэлзэхийн эрхгүй эрсхэн хэлэв.

-Бурхны нэр барьж амлахад, таны үг над таатай дуулдаж байна.

-Би үүнийг зөвшөөрөхгүй гэхдээ, тайж хүний шудрага сайн чанар барааны холоос илэрч

байгаад тэр шүү. Их Карлын үед цэрэг эрсийн уг хэл, ажиллагаа иймэрхүү байсан юм. Тайж хүн бүр тэднээс үлгэр авах ёстой. Гай болоход бид суут их эзэн хааны үед амьдарч байгаабишээ, хүндэт хамба гуайн үед амьдарч байна. Гурав хоногийн дотор бид нууцаа хэдий чанд хадгаллаа ч гэсэн бидний тулалдах гэж байгааг заавал мэдээд, санасандаа хүрэхэд маань саад тотгор хийнэ. Үгүй өнөө хоёр чинь бүр алга болж гүйцээ шивээ хөөш!

д'Артаньян сая минутын өмнөхөн Атост тулалдаанаа гурав хоног хойшлуул гэсэн шигл хэвийн эршүүд байдлаар

-Эрхэм ээ та яараад, надтай хэрэг явдлаа түргэхэн дуусгачихмаар байвал, зовоод юу хийх вэ одоо эхэлье гэв.

д'Артаньян өөд найрсгаар толгой дохиод,

-Энэ үг ч билээ над таатай л санагдаж байна. Энэ лав шудрага журамтай, тэнэг биш хүний үгээ. Эрхэм ээ, би тан шиг зан төрхтэйхүнд дуртай юм. Бид нэг нэгээ алчихгүй бол хожим тантай яриа хөөрөө аятайхан нийлэх байх. Миний нөхдийг хүлээж үзье. Надад яарах юм огт алга, хүлээвэл таарна байх. Ашгүй нэг нь тэр ирэв болтой? гэв.

-Нээрээ ч Вожирар гудамжны үзүүрт аврага том Портосын бараа харагдсанд д'Артаньян дуу алдаж;

-Юу? таны нэг гэрч Портос гуай юм уу?

Тиймээ, танд аль нэгэн шалтгаар эвгүй юм биш биз ээ?

-Үгүй, үгүй!

-Хоёр дахь нь энэ ирлээ.

Атосын заасан зүг рүү д'Артаньян эргэж хараад Арамисыг таньж, мань хүн түрүүчийнхээсээ илүү гайхсан дуугаар;

-Юу?

Таны бас нэг гэрч Арамис гуай юм уу?

-Тэгэлгүй яахав. Бид ер хоорондоо салдаггүй, шадар цэргийн дунд ч гэлээ, торгон цэргүүд ч ялгаагүй, ордон хот хааяагүй биднийг Атос, Портос, Арамис юм уу, салдаггүй гурав гэдэг юм Гэлээ ч та Дакса юм шүү По...

-Тарбаас ирсэн

-...Тэхлээр та ийм нарийн юмыг мэдэхгүй байж болох юмаа.

-Нээрээ та нарын энэ чинь нууц нэрэндээ хөөрхөн нэр байна шүү өршөөлт эрхмүүд минь. Надтай болсон энэ хэрэг явдал олонд дуулдвал та нарын нөхөрлөл зан төрхийн ялгаатайд

биш, төстэйд түшиглэсний гэрч боллоо гэж д'Артаньян хэлэв.

Энэ зуур дөхөж ирсэн Портос гараа өргөж Атостой мэндлээд эргэж д'Артаньяныг танихтайгаа зэрэг мэдрэн зогсов.

Энэ зуур Портос мөрөвчөө тайлж, нөмрөгөө орхиж амжсаныг далимаар хэлчихье. -За. энэ чинь юу гэсэн үг вэ? гэж Портос уянгалуулан асуув.

Атос гараа талархах маягаар зангаад,

-Би энэ эрхэмтэй тулалдах юм гэв.

-Үгүй би бас яг үүнтэй чинь л тулалдах хүн дээ. -гэж Портос дуулгав.

д'Артаньян түүнийг тайвшруулж,

-Гэхдээ нэг цагт шүү гэв. Арамис мөн дөхөж ирээд:

-Би ч мөн энэ эрхэмтэй тулалдах юм -гэж хэлсэнд д'Артаньян алгуур тайван хэвээрээ, Тэхдээ хоёр цагт шүү, гэж дуугарав.

-Атос чи ямар шалтгаар тулалдах болоо вэ? гэж Арамис асуув.

-Чухам, хариулахад хэцүү л байна шүү, гэж Атос хэлэв. Энэ намайг мөр рүү өвдтөл түлхчихсэн юм.

-Портос чи?

-Би яахав, зүгээр тулалдмаар болоод л тулалдаж байгаа юм, гэж хариулаад Портос царай нь улайв.

Гаскон залуугийн урууланд үл мэдэг инээмсэглэл тодроод өнгөрөхийг нарийн ажигч Атос андсангүй. Залуу хуу

-Бид хувцас хунараас болж маргасан юм гэлээ.

-Тэгвэл чи Арамис?

-Арамис тулалдах болсон үнэн учрыг нуух дохио д'Артаньянд өгөөд,

-Бид хоёр шашны нэг асуудлаар зөрсөн юм. Тэгээд л тулалдах боллоо гэв.

Гаскон залуугийн уруул дээгүүр үл мэдэг инээмсэглэл дахин тодроод өнгөрөхийг Атос ажлаа. -Нээрээ гэж үү? гэж Атос лавлав.

-Августийн гэгээний нэг номлолоос бид хоёр санал зөрсөн юм гэж д'Артаньян дуугарав. "Маргаангүй ухаантай хүн юм" гэж Атос бодов.

-За одоо өршөөлт эрхмүүд минь, та бүгд цугларсан хойно уучлал гуйхыг зөвшөөрнө үү-гэж д'Артаньян үгүүлэв.

"Уучлал" гэдэг үгийг дуулаад, Атосын царай барайж, Портос элэг барьсан янзтай мөшийж, Арамис толгой сэгсрэв.

д'Артаньян толгойгоо өргөхөд нарны элч тусч зоримог цэвэрхэн царайгий нь гийгүүлэв. - Эрхмүүд миний үгийг ойлгосонгүй. Би та гурвын цөмийн хүслийг хангаж чадахгүй байх юу магад гэсэндээ уучлал гуйсан юм. Атос гуай эхлээд намайг алчих эрхтэй болохоор, үүгээр Портос танд би нэр төрийн өрөө төлөх боломжгүй болох юу магад. Арамис танд өгсөн ам бүр хоосон шахуу юм болж байна шүү дээ. За одоо дахиад хэлэхэд өршөөлт эрхмүүд минь энэ талаар л уучилж үзээрэй... Одоо эхлэх үү дээ?

Гаскон залуу ингэж хэлээд илдээ зоримог суга татав.

Зориг нь бадарчээ. Энэ минутанд мань хүн Атос, Портос, Арамисын өөдөөс илд сугалсан шигээ улсын бүх шадар цэргийн өөдөөс илд суга татахад бэлэн байв.

Арван хоёр цаг арван таван минут болжээ. Үдийн нар голлоод, тулалдах газрыг төөнөж байв. Атос мөн илдээ сугалж, Халуун байна. Гэтэл гадуур цамц тайлж болдоггүй. Миний шархнаас лав цус шүүрч байгаа болтой. Өөрий нь асгаруулаагүй цусаар тулалдах хүнийхээ сэтгэлийг зовоохоос айж байна гэсэнд д'Артаньян хариуд нь,

-Тиймээ, эрхэм ээ. Таны цусыг би ч асгаруулсан бай, өөр хүн ч асгаруулсан бай ер нь ийм зоригт тайжийн цус харахад над хэзээд аягүй байна. Би бас адилхан гадуур цамцаа тайлалгүй тулалдъя гэв.

-Эд бүгд ч сайн л юм, одоо нялуурч дуусвал таарна. Бид басээлжээ хүлээж байгааг бүү мартаарай гэж Портоснг хэлэхэд үгий нь таслан: Арамис;

-Иймэрхүү тэнэг юм Портос хувиасаа л хэлж байж үз. Энэ хоёр эрхмийн хэлсэн бүхэн миний хувьд бол шудрага жүрамтан тайж нарын л хэлүүштэй сайхан үг санагдлаа.

Атос байрандаа зогсоод,

-Би бэлэн боллоо. Эрхэм ээ,-гэхэд д'Артаньян өөдөөс нь илдээ зөрүүлэн:

-Би таны үгийг л хүлээж байна гэв. Зөрсөн илд хангинаж амжихын зуургүй хамбын бүлэг торгон цэргүүд де Жюссак гуайгаар толгойлуулан сүмийн булангаас гарч ирэв. Портос, Арамис хоёр нэг зэрэг:

-Хамбын торгон цэргүүд! гэж дуу алдаад,-Эрхмүүдээ илдээ бушуухан хуйлаарай, Илдээ хуйлаарай! гэв.

Гэвч нэгэнт оройтжээ. Хоёр этгээд ямарсанаатай байгааг эргэлзэхийн эрхгүй байраа эзлэн зогсож байгаад харагдчихлаа.

Де Жюссак захирсан улсдаа хойноосоо дагах дохио өгөөд, урагшаа дөхөж,

-Хөөе! Шадар цэргүүдээ! Та нар энд тулалдахаар цуглаад байнаа? Горим журмыг яах билээ? гэж хашгарав.

Де Жюссак хоёр өдрийн өмнө болсон нөгөө шөнийн лайралтанд оролцсон болохоор Атос ондууцаж,

-Эрхэм торгон цэргүүд та нар айхтар эелдэг улс юмаа. Бид та нарыг тулалдаж байхад дайралдвал лав саад болохгүй байхсан. Нээрээ шүү. Биднийг зөнд маань орхи. Тэгээд та нар төвөг ургуулалгүй, ханатлаа харж болно гэв.

-Өршөөлт ноёд минь, гүнээ харамсавч тэхийн аргагүйг та нарт дуулгахаас өөр зам алга. Юуны өмнө бид үүргээ биелүүлэх ёстой. Илдээ хуйлаад, бидний хойноос дагаж үз гэж де Жюссак хэлэв.

Де Жюссакийг Арамис шоолж,

-Эрхэм ноёнтоон, бидний дураар болдогсон бол ч бид таны эелдэг саналыг маш дуртайяа зөвшөөрөхсөн. Гай болоход тэхийн эрх алга, де Тревиль гуай бидэнд үүнийг хориглосон юм. Замаараа л явж үз. Та нарт түүнээс дээр юм үгүй дээ гэж, даажигнасанд де Жюссакийн шар хөөрч,

-Та нар үг дагахгүй бол бид дайрлаа, шүү-гэж сүрдүүлэв.

-Эд тавуулаа, бид дөнгөж гурвуул байна. Бид дахиад л дийлэгдэнэ, үгүй бол доороо үхэхээс өөр аргагүй, дийлэгдэх юм бол даамлын нүдэнд би үзэгдэж чадахгүй гэдгээ та нарт дуулгая гэж Атос шивэглэв.

Атос, Портос, Арамис гурав даруй хоорондоо ойртож. де Жюссак мөн доороо нөхдөө эрэмбэ замбараатай болгов.

Тэрхэн зуур д'Артаньян амжаад шийдлээ. Хүний хувь заяаг тодорхойлж өгдөг чухал үйл явдлын нэг тохиолджээ. д'Артаньян одоо ван, хамба хоёрын нэгийг шилж түшиглэх, нэгий нь шилж аваад, тэр талаа тууштай барих ёстой болжээ. Тулалдаанд оролцох гэдэг хуулинд үл захирагдан, толгойдоо халтайхэрэг хийж, вангаас илүү хүчирхэг сайдын өштөн болох гэсэн үг байлаа. Энэ бүгдийг залуу хүү эгшин зуур ойлгов. Тэгээд залууг магтаж хэлэхэд. мань хүн эгшин зуур ч эргэлзсэнгүй.

Атос, түүний нөхөд рүү эргэж,

-Эрхмүүд ээ, та нарын хэлснийг би залруулбал яана, Та нар өөрсдийгөө гурвуул гэх шиг, миний санахад бид дөрвүүл байх шиг байх юм, гэж д'Артаньян хэллээ. Портос маргаж, -Та шадар цэрэг биш шүү дээ, гэсэнд д'Артаньян хүлээж:

-Тэр үнэн, Би бууч хувцасгүй болохоос сэтгэл санаагаараа бол шадар цэргэг. Миний зүрх шадар цэргийн зүрх, би үүнийгээ мэдээд шадар цэргийн ёсоор явах хүн гэлээ.

д'Артаньян нүүр царайны байдал, дохио сэлтээр де Жюссак санаагий нь тааварласан болтөй:

-Залуу чи холд! Чи холдож болно. Бидэнд дургүйцэх юм алга. Амиа зулбаж үз! Бушуул! гэв.

д'Артаньян байрнаасаа хөдөлсөнгүй. Атос залуугийи гарыг бариад,

-Та нээрээ сайн залуу байна гэв. Де Жюссак,

Алив бушуул, шийд! гэж хашгарлаа. Портос. Арамис хоёр ам нээж,

-Бушуухан, нэг тийшээ болох хэрэгтэй гэлээ.

-Энэ залуу өгөөмөр сайхан сэтгэлтэй хүн юм гэж Атос дуугарав.

Гэхдээ д'Артаньян даанч залуу, туршлага үгүйд гурвуулаа зовж байв.

-Бид дөнгөж гурвуулаа, тэр дундаа нэг маань шархтай нэг залуу бараг хүүхэд нэмэртэй, тэгээд дөрвүүлээ байсан гэх болно доо.

-Үгүй тэгээд ухралтай биш дээ! гэж Портос дуу алдав.

-Тэх арга байхгүй, гэж Атос дуугарав.

Тэдний тээнэгэлзээд байгаа учрыг д'Артаньян ойлгож:

-Өршөөлт эрхмүүд минь, намайг туршаад үз. Бид ялагддаг юм болж гэм би эндээс хөдлөхгүй, шудрага нэрээ барьж андгайлъя гэв.

-Зоригт залуу, таны нэр хэн билээ? гэж Атос асуулаа. д'Артаньян гэдгээ, эрхэм. -За тэгвэл, Атос, Портос, Арамис, Артаньян нар! Урагшаа! гэж Атос хашгарав. -За яав эрхмүүд ээ, шийдэж үзэх нь уу. тэгээд ер гэж де Жюссак асуулаа.

Нэгэнт шийдсэн, эрхмээ! гэж Атос хэлэв.

-Яахаар шийдэв дээ?

Арамис нэг гартаа илд нөгөө гартаа малгайгаа өргөөд бид та нарыг дайрнаа гэв. -Үгүй ер эсэргүүцэх юм бий! гэж де Жюссак дуу алдав.

-Чөтгөр алгад! Та бас гайхаж байна уу? Ингээд тулалдах есөн хүн өөд өөдөөсөө улайран дайрахдаа бас тийм ч бодлогогүй биш байв.

Хамбын шадар, Каюзак гэгч хүнтэй Атос тулалдаж, Портос Бикаратай дайралджээ. Арамис хоёр хүнтэй халз тулгарлаа.

д'Артаньяны хувьд гэвэл де Жюссактай өөртэй нь тулалдах болж дээ.

Гаскон залуугийн зүрх цээжиндээ багтаж ядан оволзов. Бурхан мэднэ, айсандаа тэр биш, хумсын төдий ч айх сэтгэл төрсөнгүй, хөөрсөндөө оволзжээ. Догширсон барс аятайтулалдаж

дайснаа тойрон, байр, арга хоёроо хорь дахин солино. Де Жюссак тэр цагт ярьдагчлан "илдний эзэн" байсны дээр лут туршлагатай хүн байлаа. Гэсэн мөртөө де Жюссак тэр бултамхай, шалмаг хүнээс арай ядан өөрийгөө хамгаалж байв. Цаадах нь нийтийн баримталдаг аргыг үл хэрэгсэж, минут тутам элдэв арга зэрэг хэрэглэн довлох мөртөө арьсаасүрхий хайрлаж байгаа хүн аятай дайсны илдийг алдалгүй хааж байлаа.

Сүүл сүүлдээ де Жюссак ингэж тулалдсаар тэсвэр алдаж эхлэв. Бараг хүүхдэрхүү юм санасан нөгөө этгээдээ өдий болтол дийлж чадахгүй дээ де Жюссак шар нь хөөрч, дараа дараагаар эндэх боллоо. д'Артаньян туршлагаар их биш мөртөө онол сайн санаж байгаа болохоор хөдөлгөөнөө хоёр дахин хурдасгав. Жюссак дайсан этгээдээ даруй хөнөөх санаатай айхтар сайн бүлээд авахыг завдан ухас хийв, д'Артаньян илдий нь чадмаг цохиж зайлуулаад, де Жюссакийг дээшээ болох зуур гар доогуур нь могой шиг гулган орж илдээрээ шувт бүлэв. Жюссак хадуурт өртсөн өвс аятай ойчоод өгөв. Дайсан этгээдээ дарж авсан д'Артаньян тулалдааны талыг яаравчлан эрэгцүүлж харав:

Арамис хоёрынхоо нэгийг нэгэнт дарж аваад хоёрдахь нь Арамисыг сүрхий тэвдүүлж харагдана. Гэсэн ч Арамисын байдал муу биш, хамгаалж чадахаар байжээ.

Бикара Портос хоёр илдээр чадмаг тулалдаж, Портос нь мөрөндөө, Бикара гуяндаа шарх олсон, гэлээ ч аль алины нь аминд аюултай юмгүй аж. Хоёулаа илдний сургуульд гарамгайгаа үзүүлэхийг мэрийж авцалдсаар байлаа.

Атос дахин Каюзакийн гараас шарх олоод царай нь улам улам зэвхийрэх мөртөө алхам ч ухрахгүй байна. Илдээ зүүн гартаа сольж бариад, солгой гараараа тулалдана. Тэр цагийн тулалдах горимын ёсоор, д'Артаньян тулалдаж байгаа нөхдийнхөө аль нэгийг дэмжих эрхтэй байв. Хэнд нь тусламж илүү хэрэгтэй байгааг мэдэхгүй эргэлзэн зогстол гэнэт Атосын харцтай тулгарав. Зүрх шимшрэм, илт ойлгогдохоор харав. Атос ер туслаач гэж хашгарахаасаа, үхсэн дээр гэж үзэх хүн. Гэхдээ нөхөр рүүгээ харж, харцаараа тусламж гуйж болох юм. д'Артаньян ойлгоод, ухас гэж, Каюзакийн хажуугаас дайрав.

-Наашаа эргээрэй, торгон цэрэг гуай! би таныг аллаа шүү! Каюзак эргэж ирлээ. д'Артаньян эшгүй амжиж тусалжээ, чулуу шиг лут зүрхгэйдээ тэсч байсан Атос өрөөсөн өвдөг дээрээ сөхрөөд!

-Хараал хүрэг! Залуу минь наадахаа битгий алаарай.

Би эдгэрч сайжирсан хойноо наадахтай чинь хуучин тооцоогоо гаргах ёстой хүн. Зэвсэггүй болго. илдий нь мулт цохь. Ухай даа! үгүй бас сайн байна.

Каюзакийн илд хорин алхам хол үсрээд явчихыг хараад Атос ингэж дуу алдав. д'Артаньян Каюзак хоёр нэг нь олзолж авах, нөгөө нь эргүүлж авах санаатай илдний хойноос зэрэг ухас хийв. д'Артаньян илүү шаламгайгаараа түрүүлж очоод үзүүр дээр нь гишгиж орхив. Каюзак нөгөө Арамист алагдсан торгон цэрэг өөд гүйж очоод илдий нь авч д'Артаньян руу ирж явтал замдаа Атостай тулгарав. Энэ ахар хугацаанд амс хийсэн Атос дайсан этгээдээ д'Артаньянд алуулчих бий гэж айсандаа өөрөө тулалдахааршийджээ.

Саад хийх гэвэл Атосыг гомдооно гэж д'Артаньян ойлгов. Нээрээ ч хэдхэн секунд бололгүй Каюзак унаад өглөө. Атосын илд гүрээгий нь шувт бүлжээ.

Мөн энэ үеэр Арамис цаад этгээдээ унагаагаад илдээ цээжинд нь тулган дийлдсэний нь хүлээлгэв.

Одоо Портос Бикара хоёр үлдэв. Портос маяглаж, Бикараас хэдэн цаг болж байгааг асууна. Бикарынах Наваррийн хороонд суман командлах болсонд баяр хүргэнэ. Гэтэл ингэж элэг доог барьснаар юу ч олохгүй аж. Бикара үхэхээс нааш салдаггүй хатан зүрхт эрсийн нэг байв, Гэтэл дуусгах цаг болоод байлаа. Харуулынхан хүрч нрээд тулалдсан бүх хүнийг эрүүл өвчтэй, аль аль талынхныг баривчилж болох байв. Атос, Арамис, д'Артаньян нар Бикарагтойроод бууж өхийг шаардав. Өдий олон хүний нөдөөс ганцаараа, тэгээд бас гуяндаа шархтай мөртөө Бикара бууж өхгүй билээ. Гэтэл Жюссак тохой дээрээ өндийгөөд Бикараг бууж өг гэж хашгарав. Цаадах нь д'Артаньян шиг бас Гаскон нутгийн хүн юмсанж. Үг ер дуулах шинжгүй, хариуд нь хүйтнээр инээв. Тулалдах зуураа мань хүн илднийхээ үзүүрээр газар зааж судар бичгээс иш татан, -сая хамт байсан нөхдийн нэг Бикара энд үхнэ гэв.

-Ганц чиний өөдөөс наадуул чинь дөрвүүл байна шүү дээ, Бууж өг, чамд тушазж байна! -Чи тушааж байгаа бол өөр хэрэг. Чи миний дарга, би захирагдахаас өөр яах вэ гэж Бикара хэлэв.

Бикара гэнэт хойшоо усэрч гараад, илдээ дайсанд олзлуулахгүй гэж хуга цохиод сүмийн хэрэм давуулан чулуудаж, гараа элгэн дээрээ зөрүүлэн хамбын нэг дуу исгэрч зогсов. Эр зориг, дайсны эр зориг ч гэлээ хэзээд аятайхан санагддаг билээ. Шадар цэргүүд эр зоригт илдээ өргөж ёслоод хуйлав. д'Артаньян мөн тэднийг дууриагаад, дараа нь эсэн мэнд үлдсэн ганц торгон цэрэг Бикаратай хамжиж Жюссак, Каюзак, мөн Арамисын нөгөө шархдуулсан хүн гурвыг сүмийн довжоо руу зөөж аваачив. Дөрөвдөх хүн бүр алагдсаныг бид дээр ярьсан шүү дээ. За тэгээд үүдний хонхыг цохичихоод дийлэгдсэн тавын дөрвөн илдийг авч мань хүмүүс баяр хөөр болон де Тревиль гуайн гэр өөд алхав.

Тэд нар хөтөлцөн гудамжны зайг бүхэлд нь эзэлж, дайралдсан шадар цэрэг бүхэнтэй ярилцаар явахад сүүлдээ бүр нэг ёсны ялгуусан баярын жагсаал болчихов. д'Артаньяны баярлаж хөөрснийг хэлээд яахав. Атос, Портос хоёрын дунд, найзархаг тэврэлдээд алхаж явлаа. Де Тревиль гуайн босгон дээр ирээд, шинэ нөхөддөө д'Артаньян:

-Би шадар цэрэг арай биш юмаа гэхэд сурагч нь болсон гэж болох байхаа, Тийм биз? гэж хэлжээ.

VI. ИХ ЭЗЭНТЭН АРВАН ГУРАВДУГААР ЛЮДОВИК ВАН

Энэ хэрэг бөөн шуугиан дэгдээв. Де Тревиль гуай цэргүүдээ өнгөн дээрээ хараах боловч сэм сайшааж байв. Гэхдээ цаг дэмий үрж болохгүй, ванд даруй дуулгаж болгоомжлох хэрэгтэй тул де Тревиль гуай Лувр ордон руу яарав. Гэсэн чинь хожигдоод орхижээ. Ван хамба хоёр хаалгаа түгжиж аваад суучихсан байв. ДеТревильд одоо ажилтай байгаа болохоор хэнтэй ч уулзахгүй гэж хэлүүлжээ. Орой ванг хөзөр тоглож байх үеэр де, Тревиль дахин очлоо. Ван уулын яггүй харамч хүн болохоор хожиж байгаадаа ааш сайхантай байлаа.

Де Тревилийн барааг хармагцаа,

-Даамал гуай та нааш ир ээ. Таныг сайн аашлаад өгье. Ойртоод ир. Их гэгээнтэн танай шадар цэргийнталаар гомдол гаргаж ирээд, их догдолж, тэр ч байтугай ярьж дуусаад хэвтчихсэнийг та дуулсан уу? Танай тэр цэргүүд чинь хүний толгой авдаг золигнууд уу?

Ван ам нээсэн даруй хэрэг хаашаа хазайж байгааг де Тревиль ойлгож,

-Үгүй шүү, их эзэнтэн минь, үгүй, харин манай тэр бурхан шиг номхон зөөлөн сэтгэлт цэргүүдийн санаж явдаг ганц юм гэвэл, илдээ зөвхөн их эзэнтэн таны үйл хэрэгт л зориулан сугалж байхсан гэж эрмэлздэг юм. Тэгээд одоо яая гэхэв дээ, хамбын торгон цэргүүд тэднийг газар сайгүй өдөөд явуулахгүй болохоор хөөрхий тэр залуус хорооныхоо нэр төрийг бодсон ч гэсэн биеэ хамгаалахаас өөр аргагүй болдог юм байна гэж хариулсанд Ван дууалдаж, -Де Тревиль гуай та дуулж бай! Зүгээр нэг бүсгүйчүүдийн хийдийн тухай яриа аятай л байх болж. Нээрээ зүгээр эрхэм даамал минь, таны даамал цолыг аваад, Де Шемро авхайд өгчмөөр ч санагдах юм. Авхайгби хийдийн тэргүүн болгох ам өгсөн юм. Өөрнйн чинь үгэнд зүгээр л итгэчихнэ гэж ер бүү бодоорой. Намайгшудрага Людовик гэдэг юм шүү. Де Тревиль гуай, одоо хоёулаа үзэмз...

-Чухам таны шудрагад найдаж их эзэнтэн таны шийдвэрийг сэтгэл тэнэгэр, тайван хүлээж байна.

-Хүлээж бай, хүлээж л бай. Би гайгүй таныг нэг их удаан хүлээлгэхгүй бий,-гэж ван хэлэв. Энэ үеэр хөзөрт вангийн аз баахан хариад ирсэн болохоор зугатаахад бэлэн байв. Ингээд хэлчихсэний маань уучлах болтугай. Хэсэгхэн зуур болоод ван босч өмнөө байсан голдуу хожиж авсан баахан мөнгийг хармаалаад:

-Ле Васвиль миний оронд суу. Де Тревиль гуайтай чухал хэрэг ярих болоод байна. Аа тийм наана чинь миний наян луй байсан юм. Хожигдсон улсыг хохироохгүйн тулд мөн төдий хирийг тавиарай. Юуны өмнө шудрага явдал чухал гээд Де Тревильтэй эргэж,

-За тэгээд эрхэм та тухайлан их гэгээнтний торгон цэрэг танай шадар цэргүүдийг өдсөн гэж байх шив? гэж хоёулаа нэг цонх руу явах зуураа асуув.

-Тэгсэн, ер нь л тэгдэг шүү дээ их эзэнтэн.

-Яагаад тийм хэрэг гарсан юм бэ дээ? Яриач! Шүүгч хүнхоёр талын аль алины өчиг сонсох ёстойг эрхэм даамал та мэднэ шүү дээ.

-Тэнгэр бурхан минь! Зүгээр л нэг ийм хэрэг гарч л дээ. Их эзэнтний нэрий нь сайн мэдэх, таны албанд чин сэтгэлээсээ зүтгэж үнэнчээ танд удаа дараа үнэлүүлж явсан манай гурван шилдэг цэрэг Атос, Портос, Арамис нар нэг гаскон залуу нөхөртэйгөө хэдүүл зугаалж явж л дээ. Тэр залууг би өнөө өглөөхөн цаадуулд нь захиж өгсөн юм. Тэд Сен-Жерменд шиг билээ дээ, очихоор тохирч Дешо сүмийн дэргэд уулзахаар болзсон юм байж. Гэнэтхэн хаанаас ч юм бэ, де Жюссак гуай Каюзак гуай, Бикара, бас хоёр торгон цэрэг дагуулсаар гараад иржээ. Тэр эрхмүүд ийшээ төдий олуул ирснийг бодвол лав л зарлиг зөрчих санаатай байсан бололтой. - Тийм бий. Би сая л ойлголоо. Тэд нар өөрсдөө энд тулалдах санаатай иржээ дээ? гэж ван хэлэв.

-Тэднийг би лав тэгсэн гээгүй байна их эзэнтэн минь. Гэхдээ их эзэнтэн өөрөө бодоод үз дээ, тэр зэлүүд сүм рүү таван хүн зэвсэглээд өөр юу хийхээр ч очно ажээ дээ?

-Яриа алгаа Тревиль, чиний зөв.

_ Миний шадар цэргүүдийг хараад тэдний өөр хоорондын дайсагнал намдаж хороодын хоорондын дайсагнал дийлээд мань эрс санаагаа өөрчилж л дээ. Ванд, ганц ванд үнэнчбайдаг шадрууд хамба гуайд үнэнч, торгон цэрэгтэй эвлэршгүй дайсагнадгийг их эзэнтэн мэднэ шүү дээ.

Ван гутарсан дуугаар,

-Тиймээ, Тревиль тийм байгаа юм. Франц ингэж хоёр тал болсныг үзэхэд хар буудаг юм. Нэг улсад хоёр толгой байдаг ч бас тоогүй хэрэг. Үүнд эцэс болох цаг ирнэ. Дуусгавар болноо. Тревиль. За тэхлээр торгонцэргүүд шадар цэргүүдийг эхэлж өдсөн гэж та хэлж байх шив дээ? Лав тийм хэрэг болж таарсан байх гэж би хэлж байна. Баталж чадаагүй үнэнийг олоход хир хэцүү байдгийг та мэднэ. Үүний тулд XIII Людовик шиг нэвтэрхий хурц ухаантай байх ёстой юм. Тэгээд ч та шудрага Людовик гэж алдаршаа шүү дээ.

-Тревиль чиний зөв, гэхдээ танай шадар цэргүүдтэй хамт бараг хүүхэд шахуу бас нэг хүн цуг явсан юм биш үү?

-Тиймээ, их эзэнтэн минь. Тэгээд бас нэг нь шархтай, байсныг яана. Вангийн гурван шадар цэрийн нэг нь шархтай, нэг хүүхэдтэй хамт хамба гуайн торгон цэргээс хамгийн цуутай таван хүний өөдөөс тэссэнээр барахгүй, дөрвийнх унагаажээ. ,

Вангийн царай гийж,

-Үгүй энэ чинь ялалт болжээ! гэж дуу алдав.

-Тиймээ, их эзэнтэн, Сэгийн тэндэх шиг л төгс ялалт болсон.

-Дөрвөн хүнээс нэг нь шархтай, нөгөө нь бараг хүүхэд шахуу гэсэн байхаа та? -Түүнийг ер

эрийн цээнд хүрсэн залуу гэж хэлэхийв эрхгүй дэгээ. Гэхдээ тэр тулалдааны үед унэхээр эр зоригтой байсан гэнээ, тэхлээр тэр залууг албандаа аваач гэж танд хэлж зүрхэлмээр байна.

-Хэн гэдэг юм бэ?

-д'Артаньян гэдэг юм, их эзэнтэн. Миний хуучин нөхдийн нэгний хүү л дээ. Их эзэнтэн таны эцгийн төлөө дайнд сайн дураараа явж байсан хүний хүү юм.

-Тэгээд тэр залуу эрхүн шиг байсан гэвүү та? Тэр тухай нэг сайн яриад орхиоч. Дайн тулалдааны тухай ярианд миний дуртайг чи мэднэ шүү дээ Тервиль, гээд ХШ Людовик ихэмсгээр хойшоо налайгаад сахлаа имрэв.

Де Тревиль үгээ залган, -Их эзэнтэн, д'Артаньяныг бараг хүүхэд гэж би түрүүн ярьсан, тэгээд ч шадар цэрэг байх завшаан олдоогүй хүү болохоор иргэний хувцастай байж л дээ. Хамба гуайн торгон цэргүүд хүүгийн даанч залуу бага, тэгээд ч цэрэг биший нь бодоод довтлохоосоо өмнө зайл гэж түүнд хэлсэн гэнэ.

Ван хажуугаас нь:

-Харж байгаа биз дээ. Тревиль, эхлээд тэд нар дайрсан байна шүү гэв.

-Яриа алга, их эзэнтэн эргэлзэх газаргүй байгаа юм. За тэгээд торгон цэргүүд залуу хүүг явж үз гэж л дээ. Цаадах нь өөрийгөө сэтгэлээрээ шадар цэрэг их эзэнтэн танд голоосоо үнэнч зүтгэх хүн болохоор шадар цэргүүдтэй үлдэнэ гэж хариулжээ.

-Сайн залуу! гэж ван амандаа дуугарав.

-Нээрээ ч шадар цэргүүдтэй үлдэж тэгээд их эзэнтэн та лут сайн цэрэгтэй болж дээ. Илдээрде Жюссакийг тэгтэл айхтар хатгачихаад хамба гуайн шарыг хөөргөөд байгаа хүн чинь тэр бага хүү шүү дээ.

-Жюссакийг тэр хүү шархдуулсан юм гэж үү?

-Тэр үү? Хүүхэд тэр үү? яалаа гэж дээ Тревиль гэж ван дуу алдав.

-Их эзэнтэн танд миний айлтгаснаар л болсон гэнэ дээ.

-Жюссак чинь бүх францын хэмжээгээр шилдэг илдчин хүн шүү дээ!

Яахав дээ, их эзэнтэн минь. Тэр чинь давуу чадмаг хүнтэй тулгарч дээ.

-Би тэр залууг үзмээр байна, Тревиль. Би уулзмаар байна, тэгээд бас тус хүргэж болмоор бол бодье.

-Түүнийг хэзээ их эзэнтэн танд бараалхуулах вэ?

-Маргааш үдийн үеэр больё, Тревиль. Ганцаарангий нь авчрах уу?

-Үгүй, дөрвүүлий нь аваад ир. Би цөмд нь зэрэг ач хариулах санаатай байна. Үнэнч хүмүүс ямар нэг их элбэг байдаг биш дээ. Тревиль үнэнч зүтгэлд шагнал хүртээх ёстой юм. -Үдээр бид ордонд ирээд байнаа, их эзэнтэн минь.

-Хажуугийн үүдээр ирээрэй Тревиль, хажуугийн үүдээр ирээрэй. Хамбад юм мэдүүлэхийн хэрэг алга.

-Дууллаа их эзэнтэн минь.

-Зарлиг гэдэг бол зарлиг гэж та мэднэ. Тревиль, чухамдаа гэхэд тулалдахыг хорьсон шүү дээ ер нь:

-Гэхдээ тэр тулалдаан ерийн нэг ирүүл тулалдаантай адилших юм алга шүү дээ, их эзэнтэн минь. Ёстой мөргөлдөөн болж хамба гуайн таван торгон цэрэг миний гурван цэрэг д'Артаньян гуайн, эсрэг дайрсныг харахгүй юу даа.

-Тиймээ гэхдээ арын хаалгаар ирээрэй дээ, Тревиль, гэж ван дуугарав.

Цаадах ньинээмсэглэв. Багшдаа дургүйцэх сэтгэл энэ балчир хүүд төрүүлж чадсан нь Тревильд их юм байлаа. Ванг хүндлэн мэхийгээд, зөвшөөрөл гуйж гадагшаа гарав.

Хишиг хуртэх болсон тухайгаа гурван шадар цэрэг тэр оройдоо дуулжээ. Тэд ванг эртний таньж мэдэх болохоор төдий л их хөөрсөнгүй. Харин гаскон хүний хэтрүүлэмтгий зантай д'Артаньян энэ явдлыг цаашдын урагш, хийморийн бэлэг тэмдэг болгож үзээд шөнөжингөө элдэв сайхан юм санааширсаар хонолоо. Өглөөний найман цаг болоход мань хүн хэдийнээ Атосын яваад ирлээ. Ванд үдийн үеэр бараалхах учиртай болохоор Атос өөрөө Люксембургийн хавь дахь морины саравчны ойролцоо нэг зуушны газар очиж, бөмбөг чулуудаж тоглохоор Портос, Арамис хоёртой болзсон ажээ. Тэгээд д'Артаньяныг цуг явья гэж ярьсанд цаадах нь уул тоглоомы нь мэддэггүй хир нь дагаж зөвшөөрөв. Дөнгөж өглөөний есөн цаг болж байсан болохоор д'Артаньян цаг яаж нөхцөөхөө мэдэхгүй байсан билээ.

Портос Арамис хоёр хэдийнээ хүрээд ирчихсэн, илд шидэлцэн зугаагаа гаргаж байв. Алив хөдөлгөөнт дасгал сэлтэд гойд сайн Атос нэг талд нь д'Артаньянтай зогсож, цаадуултайгаа үзэлцьегэв. Атос зүүн гараараа тоглох гэсэн боловч тоглож эхлэхийн хамт л шархаа ийм хөдөлгөөнтэй дасгал хийхээр эдгэрэх яагаа ч үгүй байгааг мэдлээ. Ингээд д'Артаньян ганцаараа үлдэж, дүрэм ёсоор тоглоё гэхэд даанч гар дасаагүй байгаа учраа хэлсэн болохоор хоёр шадар цэрэг зүгээр л тоогүйгээр илд чулуудалцаж байв. Портосын лут гараараа чулуудсан нэг илд д'Артаньяны хацрыг золтой л шүргэлгүй өнгөрсөнд, хажуугаар өнгөрөлгүй, нүүр рүү цохичихсон бол би ордонд очих сэхээгүй болж Ванд бараалхах маань лав өнгөрөх байсандаг шүү гэж залуугийн дотор бодогдов. Гэтэл гаскон зантай д'Артаньянд хамаг ирээдүй нь тэр бараалхалтаас шалтгаалах юм шиг санагдаж байж. Портос Арамис хоёрт эелдгээр мэхэсхийгээд, өөрсөдтэй нь үзэлцэх чадалтай болсон хойноо энэ тоглоомоо үргэлжлүүлэе гэлээ. Ингэж хэлээд д'Артаньян хүрээлж татсан олсны цаана гарч үзэгч улсын дунд орж суув.

д'Артаньяны гайгаар их гэгээнтний нэг торгон цэрэг үзэгчдийн дунд байжээ. Саяхан нөхдөө

тэгтэл айхтар дийлдсэнд хор нь буцалсан тэр торгон цэрэг тэднийхээ өшөө авахаар дотроо андгайлсан юмсанж. Одоо тэгээдтохиромжтой цаг болсон шиг түүнд санагдав. Энэ залуу илднээс айсанд гайхах юм алга. Энэ лав шадар цэргийн шавь биз гэж тэр торгон цэрэг хажуугийнхаа хүнд хэллээ.

д'Артаньян могойд хатгуулчих шиг цочмог эргэж ийм тэрсүүд үг хэлсэн торгон цэргийг эгцлэн ширтэв.

Торгон цэрэг сахлаа имрэнхэн дооглонгуй байртай:

-Юу болоод орхив? хонгор минь над өөд хичнээн л бол хичнээн хар, би хэлэх юмаа хэлчихсэн гэв.

-Таны хэлчихсэн юмны учир хэтэрхий илхэн, тайлбар хэрэггүй байгаа болохоор миний хойноос гарчүзнэ үү,-гэж Д'Артаньян хариулав

Торгон цэрэг мөн л дооглонгуй байртай

-Хэзээ тэр вэ? гэж асуулаа.

-Одоохон, гуйя танаас.

-Бодвол та миний хэн болохыг мэдэж байгаа биз?

-Би огтхон ч мэдэхгүй, тэгээд мэдсэн мэдээгүй хамаа алга.

-Дэмий дээ! Миний нэрийг мэдээд орхихоороо та ингэтэл их яарахгүй ч болж мэднэ. -Таныг тэгээд хэн гэдэг юм бэ?

-Танд зарцлагдахад бэлхэн Бернажу гэгч байна.

-За Бернажу гуай таныг би гарах хаалган дээр хүлээе, гэж д'Артаньян тайван хариулав. -Явж бай, эрхэм ээ. Би таны хойноос гарна. Бидний цуг гарахыг хэнд ч ажиг авахуулахгүйн тулд та дэндүү бүү яараарай. Бидний хийхгэж байгаа хэрэгт илүү гэрч хэрэггүй. Өөрийн нь нэр зохих сэтгэлэг төрүүлсэнгүйд гайхсан торгон цэрэг

-За сайн, -гэж санал нийлэв.

Үнэхээр ч Бернажугийн нэрийг ганцхан д'Артаньян гэхээс, бусад хүн цөм мэддэг байжээ. Юу гэвэл ван хамба хоёрын хориглосон зарлигийг хайхралгүйгээр өдөр бүр болж байдаг тулалдаан, мөргөлдөөн болгонд шахуу оролцож явдаг хүний нэр байсан юм.

Портос, Арамис хоёр тоглоомондоо айхтар улайж Атос тэднийг их шохоорхон ажиж байсан болохоор залуу хүүг гадагшаа гарч, торгон цэрэгт хэлсэнчлэнгээ босгон дээр очиж зогсохыг тэдний аль нь ч харсангүй. Торгон цэрэг түр азнасгээд цаадхынхаа хойноос дагаж гарав. д'Артаньян үдийн үед ванд бараалхахаасаа хожимдох бий гэхээс айж яарна. Эрэгцүүлээд хартал гудамжинд хүнгүй байв.

д'Артаньян дайсагнагч хүндээ хандаж:

-Та Бернажу гэгч гэх боловч чухамдаа танд их аз дайрлаа шүү нээрээ! Та ердөө л шадар цэргийн шавьтай тулгарлаа. Гэхдээ санаа зовох явдалгүй би чадах бүхнээ хийнэ. За биеэ хаацайлж үз! гэлээ.

д'Артаньяны дуудлага хаясан цаад торгон цэрэг нь,

-Газраал муухан сонгож авсан юм шиг над санагдах юм.

Уул нь Сен-Жерменийн хийд юм уу Бре-о Клеркээс цаахна гарвал бидэнд тохиромжтой байхсан гэв.

-Таны үг аргагүй л зөв зүйтэй ч над зав байхгүй нь л харамсалтай. Яг арван хоёр цагт би хүнтэй уулзах болзоотой юм. Ингэхлээр биеэ хамгаалж үз дээ эрхэм ээ, хамгаалж үз! гэж д'Артаньян хэлэв.

Бернажу өөрөө ийм үгийг хоёр дахин хэлүүлж байхаар хүн биш байв. Эгшин зуур гарт нь хатгуур илд гялсхийж, хайс өөдөө ухас гэхдээ цаадхыгаа бага залуу болохоор айлгачих горьдлоготой байжээ.

Гэвч д'Артаньян үүний өмнөхөн сайн дасгал хийж авсан, дийлэхсэн гэхээс хөөрөн бахдаж дээд өршөөл хүлээж байгаадаа бардан, алхам ч ухрахгүй зориг шийдмэг байв. Илд зөрөн хангинав. д'Артаньян бат зогсох тул цаадах нь алхам ухрахаас өөр эрхгүй боллоо. Ингэж хөдлөхдөө Бернажугийн хатгуур илд ялихгүй хажуу тийшээ болсныг д'Артаньян самбаачилж илдээ чөлөөтэй болгон урагшаа үсэрч илднийхээ үзүүрээр дайсны мөрийг хатгав. Тэгсэн дороо хойш болж илдээзүгээр өргөв. Гэтэл Бернажү энэ чинь юу ч биш гэж хашгараад урагшаа зоригтойёо ухас гэснээр д'Артаньяны илдний үзүүрт өөрөө бүлэгдчихэв. Гэсэн хир нь Бернажу унасангүй өөрийгөө дийлэгдсэнд тооцохгүй, зөвхөн л язгууртан Тремуль гуайн байшингийн зүгт ухарч байлаа. Тэднийд өөрий нь садангийн нэг хүн алба хаадаг юмсанж. Дайснаа сүүлчийн удаа хир хүнд шархдуулснаа д'Артаньян мэдэх аргагүй болохоор шаламгайлан зазгадуулсаар алчихаж ч мэдэх байсан билээ. Гэвч гудамжинд гарсан шуугиан бөмбөг тоглож байсан өрөөнд дуулдлаа. Торгон цэргийн хоёр найз нь нөхрийнхөө д'Артаньянтай хэдэн үг солиод, дараа нь түүний хойноос дагаж гарахыг харсан болохоор илдээ сута татан авч гүйж гараад дийлэгч рүү довтлов. Яг тэр үеэр Атос Портос, Арамис гурав босгон дээр гарч ирээд, залуу найз өөдөө довтолсон хоёр торгон цэрэг өөд дайрч өөрсөд рүүгээ эргүүлэв. Ингэх хооронд Бернажу ойчоод, дөрвийн эсрэг хоёулхнаа болсон торгон цэргүүд дуу тавьж:

-Де Тремуль гуайнхан наашаа! гэж хашгарав. Тэхийн хамт де Тремуль гуайнд байсан улс цөм гүйж гараад дөрвөн шадар цэрэг өөд дайрлаа. Шадар цэргүүд ч мөн ээлжиндээ "шадар цэргүүдээ туслаарай" гэдэг дайчин дуудлагаа дуудав.

Энэ дуудлагыг тосч авах хүмүүс хэзээд ч олддог аж. Шадар цэргүүд их гэгээнтний өстөн гэдгийг хүн бүхэн мэддэг болохоор хамбатай ингэж дайсагнадгаараа олонд хайрлагддаг аж. Иймд Арамисын улаан Герцог гэж хочилсон хамбад алба хаадаггүй бусад торгон цэргийн

хорооныхон тийм тулалдаан гарсан тухайд вангийн шадар цэргийн талд ордог билээ. Дезэссар гуайн хорооны гурван торгон цэрэг яг хажуугаар явж тааралдсанаа, хоёр нь дөрвөн нөхдөд тусдахаар ухасхийгээд, нэг нь де Тревиль гуайн гэр өөд хурдаараа гүйж шадар цэргүүдээ туслаарай! туслаарай гэж хашгарав. Ер нь де Тревиль гуайн хашаагаар хорооны нь цэргүүд хэзээд дүүрэн байдаг болохоороо тэд нар нөхөддөө туслахаар гүйлдэв. Бөөн их тулаан болсон гэвч шадар цэргүүд хүчээр давуутай байлаа. Хамбын торгон цэрэг де Тремуль гүайнхан гэрийнхээ хашаа руу ухарч ороод цаадуулыгаа золтой л нэг юм хойноосоо оруулчихалгүй, хаалгаа хааж амжив. Шархдаад сүрхий муудсан Бернажуг үүнээс аль өмнө гэрт оруулсан юм байж. Шадар цэрэг тэдний найз нарын хорсол ихэд хөдөлсөн болохоор, Де Тремуль гуайнхныг вангийн шадар цэргүүдэд халдаж зүрхэлсний өшөөнд байшингий нь шатаачих уу гэдэг санал ч гарч байв. Нэг хүний амнаас гарсан энэ саналыг баяр хөөр болцгоон дэмжих гэтэл ашгүй арван нэгэн цаг цохилоо. д'Артаньян нөхөдтэйгөө ванд бараалхах учиртайгаа санаад ийм догь явдлыг өөрсдий нь үгүйд хийчих бий гэж айсандаа зоримог нөхдөө тайвшруулахыг хичээв. Гэхдээ л хашааны үүд рүү хэд хэдэн чулуу шидэцгээлээ. Харин хаалга нь бат бэх аж. Үүндхөөрсөн улсын сэтгэл жаал дарагдсанаас гадна, толгойлсон улс нь олноосоо нэгэнт тасраад Де Тревиль гуайнх өөд явж байлаа. Де Тревиль гуай болсон явдлыг хэдийн дуулчихаад өөрсдий нь хүлээж байлаа. -Бушуухан л ордон руу очъё!

-Ганц ч минут алдалгүй ордонд очиж, хамбыг дуулгачихаас өмнө вантай уулзахыг хичээе. Энэ хэргийг бид ванд өчигдрийн явдлын үргэлжлэл юм шиг айлтгая, хоёулаа нэгэн хэрэг болоод өнгөрөх бий гэж де Тревиль гуай хэлэв.

Де Тревиль гуай дөрвөн найзыг дагуулсаар ордон руу яаран одов. Очсон чинь буга намнахаар Сен-жермений ой руу явчихсан гэхийг дуулаад шадар цэргийн даамал ихэд гайхав. Де Тревиль гуай энэ үгийг хоёр дахин хэлүүлээд, тухай бүр царай нь улам барайж:

-Их эзэнтэн анд явахаар бүр өчигдөр шийдсэн хэрэг үү? гэж асуув.

-Үгүй, эрхэмсэг ноёнтон, өөрт нь тухайлан буга хашлаа гэж ахлах анчин өнөө өглөө айлтгасан юм. Ван эхлээд явахгүй гэснээ сүүлдээ тийм сайхан цэнгэлээс татгалзаж чадалгүй, яваад өгсөн л дөө гэж хиа хариулав.

Де Тревиль, ван явахынхаа өмнө хамбатай уулзсан болов уу?-гэж асуусанд хиа, -Лав тэгсэн байхаа, их гэгээнтний сүйх өнөө өглөө үүдэн дээр хөллөөтэй зогсож байх харагдсандаг. Түүнийг хаашаа морилох гэж байгаагийг нь намайг асуухад "Сен-жермен өөд" гэж хариулсан гэв.

-Биднээс өрсчихжээ эрхмүүдээ, өнөө орой би вантай уулзана. Та нарын тухайд гэвэл вангийн нүдэнд бүү үзэгдээрэй гэж зөвлөө, гэж Де Тревиль гуай хэлэв.

Уул зөвлөлгөө учир ухаантайн дээр гол нь ванг тэгтлээ сайн мэдэх хүн түүнийг өгсөн болохоор дөрвөн нөхдөд маргах санаа төрсөнгүй. Тэднийг гэр гэртээ хариад, цаашдаа өөрөөсөө юм дуулахыг хүлээ гэж де Тревиль гуай хэлэв.

Де Тревиль гуай гэртээ ирсэн хойноо, шалмаг хөдөлж, өөрөө эхлэн гомдол мэдүүлбэл зүйтэй

гэж бодлоо.

Де Тревиль гуай нэгэн зарцаа де Тремуль гуайн руу явуулж захиа хүргүүлэв. Захидалдаа хамбын албанд байдаг тэр торгонцэргийг гэрээсээ хөөж явуулаад, шадар цэрэг рүү довтолж зүрхэлсэн өөрийнхөө хүмүүсийг аашилж үзнэ үү гэж бичжээ. Де Тремуль гуай өөрөө Бернажугийн садан болох агтчаасаа тэр хэргийн тухай нэгэнт дуулчихсан болохоороо, де Тревиль гуай өөрөө, мөн шадар цэргүүд ч гэсэн гомдол мэдүүлэхээр юм юу ч үгүй, харин гомдол мэдүүлүүштэй хүн гэвэл өөрөө л байна, юу гэвэл шадар цэргүүд зарц нары маань дайрч гэр орны минь түймэрдэхээр завдаж байсан гэж хариулжээ. Тэр хоёр ихсийн маргаан удтал үргэлжилж, хэн хэн нь өөрийнхөөрөө зүтгэх байсан биз, Гэвч де Тревиль гуай бүх юмны учрыг олох арга сүвэгчилжээ. Де Тремуль гуайтай биеэрээ очиж уулзахаар шийдэв.

Де Тремуль гуайнд ирээд, ирсэнтухайгаа гэрийн эзэнд дуулгахыг гуйв.

Хоёр ихэс ёсорхог мэндлэв. Хэдийгээр сайн нөхдийн барилдалгаагүй боловч эд бие биеэ хүндэлдэг улс билээ. Хоёулаа хэн хэн нь цэх шудрага, уудам сэтгэлтэй хүмүүс юм. Де Тремуль гуай уул нь протестант шашны хүн болохоороо ордонд бараалхах нь ховор учраас алив намд элсээгүй бусад хүний тухайд урьдаас тиймийм хүн гэж өөртөө бодчихсон юм ихэвчлэн байдаггүй хүн билээ. Хэдий тийм гэлээ ч де Тревильтэй энэ удаа эелдэг боловч ердийнхөөсөө хүйтэвтэр уулзлаа.

-Эрхэм ээ, бид хэн хэн маань өөрийгөө гомдсонд тооцож байна, тэхлээр би тантай хамт хэргийн хамаг үнэн учрыг олъё гэж ирлээ, -гэж шадар цэргийн даамал хэллээ. Де Тремуль гуай үүнд:

-Учрыг нь дуртайяа ололцъё, ганцхан энэ тухай ихээ лавгай сайн дуулсан, хамаг буруу танай шадар цэргийн талд бийг би урьдаас хэлчихье гэв.

-Эрхэм та өөрөө миний хэлэх гэж ирсэн саналаас татгалзахааргүй их ухаалаг шудрага хүн билээ.

-Хэлж үз дээ түүнийгээ, гуйя эрхэм ээ.

-Танай агтчийн садан болох Бернажугуайн бие ямар шүү байна даа?

-Тэр хүн тун хариугүй байнаа, эрхэм ээ. Онц айгаад байхаар юмгүй мөрнийх нь шархнаас гадна дахиад бас уушгий нь хөндсөн сүрхий шарх олсон юм байна. Эмч ер нь эдгэрнэ гэж горьдохгүй байх болтой.

-Шархтан ухаантай байгаа юу?

-Ухаан санаа нь ч зүгээрээ.

-Юм ярьжчадах уу?

-Ярих нь ч яринаа, зовж л ярих юм.

-Тэгвэл, эрхэм ээ, Бернажу дээр очоод, хамаг үнэнээ хэлэхийг бурхны нэрээр андгайлж гуйя. Мөдхөн тэр өөрөө эрлэгийн өмнө очиж мэдэх болсон хүн шүү дээ. Яахав тэр өөрөө өөрийнхөө хэрэгт шүүгч нь болог, би хувьдаа юу гэсэнд нь итгэнээ, эрхэм ээ.

Де Тремуль хэсэгхэн зуур бодсоноо, илүү ухаалаг санал гаргахад бэрхтэйг мэдээд, даруй зөвшөөрөв.

Хоёулаа доошоо, шархтны хэвгэж байгаа өрөө рүү бууж очлоо. Өөрий нь эргэж ирсэн тэр ихсийг хараад шархадсан Бернажу орон дээрээ. өндийхийг хичээсэн боловч тун дорой байсан болохоор хүч гаргасандаа тамирдан буцаад бараг ухаан тавин ойччихлоо.

Де Тремуль гуай шархадсанхүн рүү ойртож, давстай хөөрөг нүүрэнд нь ойртуулсанд цаадах нь ухаан оров. Шархадсан хүнийг албадсан гэж буруушаагдахаас болгоомжилсон де Тревиль гуай Тремуль гуайг дорой байгаа хүнээс өөрөө үг асууна уу гэлээ.

Бүх хэрэг де Тревиль гуайн санаснаар боллоо. Үхлийн даваан дээр гарчихаад байсан Бернажу үнэнийг нууж чадсангүй, хэрэг явдлаа чухам болсон байраарнь ярьж өглөө.

Ингүүлэхийг л де Тревиль гуай эрмэлзсэн билээ. Бернажуд даруйхан эдгээрэй гэж ерөөгөөд, де Тремуль гуайгаас салж гэртээ буцаж ирсэн дороо дөрвөн нөхдийг үдийн хоолон дээр хүлээнэ гэдгээ хэлж хүн явууллаа.

Де Тревиль гуайнд хамгийн өөгүй шилдэг далиманд нь хэлэхэд цөм хамбын эсрэг хүмүүс цугладаг билээ. Тийм болохоор хоолны үеийн бух яриа хөөрөө их гэгээнтний торгон цэргүүдийг хоёр дахин дийлсэн явдлын тухай болсон нь мэдээж хэрэг. Хоёр тулалдааны баатар нь д'Артаньян байсан болохоор цөм түүнийг л ам нийлэн магтахад Атос, Портос, Арамис гурав, зөвхөн сайн нөхдийн хувьд ч төдийгүй, мөн өчнөө төчнөө магтуулж явсны хувьд энэ удаа өөрсдийнхөө хувиас татгалзаж болохоор тул үүнд дуртайбайлаа.

Зургаан цагийн хирд де Тревиль гуай ордон руу явах цаг болсныг дуулгав. Бараалхуулахаар тогтоож өгсөн цаг нэгэнт өнгөрсөн болохоор де Тревиль гуай жижиг хаалгаар орох зөвшөөрөл нэгэнт гуйсангүй дагуулж ирсэн дөрвөн хүнтэйгээ хүлээх өрөөнд оров.

Ван ангаас хараахан буцаж ирээгүй.

Манай залуу нөхөд хагас цаг хиртэй хүлээчихээд байтал гэнэт үүд хаалга цэлийтэл онгойлгон их эзэнтний ирснийг дуулгав.

Д'Артаньяны бие зарсхийгээд явчихлаа. Энэхэн минутанд түүний цаашдын хамаг хувь заяа лав шийдвэрлэгдэх бизээ. Вангийн морилж ирэх хаалга рву амьсгаа даран ширтэнэ. XIII Людовик үүдээр ороод ирлээ. Хамт явсан улсаасаа түрүүлжээ. Ван тоосонд дарагдаж орхисон ангийн хувцас, гутал өмсч, гартаа ташуур барьжээ. д'Артаньян хармагцаа л загнуулахаас зайлахгүй болсныг мэдэв.

Ван муухай ааштай байгаа нь хэдий илт байвч, ордныхон цөм замын нь дагуу эгнэн зогсов. Вангийн хүлээх өрөөнд байгсад, вангийн нүдэнд огт үзэгдээгүй явснаас ууртай харцанд

өртөж явсан нь дээр гэж үздэг аж.

Ийм болохоор гурван шадар цэрэг эргэлзэлгүй урагшаа дөхөж алхахад, д'Артаньян харин тэдний ард нуугдахыг хичээв. Атос, Портос, Арамисыг ван өөрөө таньдаг мөртөө өөдөөс нь харсан ч үгүй, дуугарсан ч үгүй. Огт үзээгүй хүн шиг хажуугаар нь өнгөрөөд явчихлаа. Де Тревиль гуайн хувьд гэвэл вангийн харц өөр дээрээ тусахад өчүүхэн ч үл дальдарсанд ван өөрийн эрхгүй өөр тийшээ харав. Үүний дараа, их эзэнтэн нэг юм дуугараадөрөө рүүгээ орчихов.

Атос инээмсэглээд,

-Хэрэг ажил базаахгүй дэг, өнөөдөртөө л бидэнд одон зүүлгэхгүй нь шив, -гэлээ. -Энд арван минут хүлээ, тэр хооронд намайг эргэж ирэхгүй бол манай руу очоорой. Илүү хүлээгээд тусгүй, -гэж де Тревиль гуай хэлэв.

Дөрвөн нөхөд арван минут, нэг мөч, хорин минут хүлээлээ. Де Тревиль гуайгарч ирэхгүйд мань хүмүүс сэтгэл зовсоор гарч явлаа.

Тэр зуур де Тревиль гуай вангийн өрөөнд зоригтой орж, их эзэнтний аль муухай ааштай цагаар тааралдав. Ван зөөлөн сандал дээр сууж, ташуурын үзүүрээр түрийгээ ороолгоно. Де Тревиль зовж шантралгүй, эзэнтний лагшин тунгалаг эсэхийг тайван асуулаа.

-Муу, эрхэм ээ, миний бие тавгүй байна. Би уйдаад байна гэж ван хариулав.

Үнэхээр ч XIII Людовик вантны хамгийн хүнд өвчний нэг нь уйтгар байсан юм. Заримдаа бараа бологчдынхоо нэгийг дагуулж аваачаад цонх руу очиж "уйдаж байна эрхэм ээ, хоёулаа цуг уйтгарлая" гэдэгсэн.

-Юу! гэж де Тревиль дуу алдав. Их эзэнтэн та уйдлаа гэнээ? Их эзэнтэн та өнөөдөр ан агнаж цэнгээгүй гэж үү?

-Цэнгэл л юм даа, юу ч гэх вэ! Юм бүхэн өөр болоод байнаа, нээрээ шүү. Ан амьтан ингэж ул мөрөө үлдээхийг больчихсон юм уу, ноход үнэрлэж чадахаа болио юмсанж уу бүү мэд. Бид нэг том буга хөөж, зургаан цаг турш элдээд юу юугүй гүйцэх болж, Сен Симон нэгэнт дийлсэн бүрээ үлээхээр завдаж байтал хамаг нохой харин нэг янзага хөөж хажуу тийшээ давхиулчихлаа. Би бүргэдээр агнахаа больчихсон шиг нохой тавьж агнахаа нэг больчихно бий дээ, хараад байгаарай. Ээ, де Тревиль гуай, би ч мөн золгүй ван юм даа. Над ганц том шонхор байсан тэр маань уржигдар үхчихлээ.

-Нээрээ их эзэнтэн таны цөхрөөд байгааг би ойлгож байна. Бөөн гай дайрч. Гэхдээ танд харцага, шонхор гэх шиг анч шувуу зэгсэн олон үлдээ биз дээ?

-Тэдний чинь сургах хүн ганц ч байхгүй. Шонхор сургадаг улс үхээд дууслаа. Шонхроор агнах аргыг ганц би л мэдэж байна.

Миний дараа тэгээд цөм өнгөрнө. Хавх, занга, хуурамч нүх гэх мэтийн л юмаар ан хийдэг

болох бий. Би уул нь хүн сургаадхаж амждагсан бол ч. Гэтэл болох зам алгаа, хамба гуай над Испани, Австри, Английн тухайцаг ямагт үглээд ганц ч минут амар заяа үзүүлэхгүй юм! За ингэхэд, хамба гэснээс, де Тревиль гуай танд би дургүй хүрээд байна.

Ийм ч юм болно гэж де Тревиль хүлээгээд байсан билээ. Вангийн занг тэр өөрөө сайн мэддэг болохоор энэ их гомдол чухамдаа зөвхөн үгийн далим, үгээ хэлэхийн дэвсгэр мөнийг ойлгож байсанаж. Одоо вантан нэг ярих гэсэн юмныхаа тухай ярина даа.

Де Тревиль мэл гайхчихсан царай гарган.

-Их эзэнтэн таны өмнө би юугаар буруут болов? -гэж асуув.

Ван, Де Тревилийн үгэнд шууд хариулахаас нөөж:

-Үүргээ та ингэж биелүүлдэг хүн юм бий дээ, эрхэм ээ. Таны захиргаанд байгаа улс, хүн амьтан алж, хотын бүхэл бүтэн нэг хэсэгт бөөн үймээн тарьж, Парис хотыг л золтой бүхлээр нь түймэрдэж орхих шахаж байг гэж таныг би шадар цэргийн ахлагчаар тавьсан юм уу? Тэр тухай та ядаж ганц үг цухуйлгадаггүй байна шүү! Би дэмий ч таныг зэмлэж байж болох юм. Гэмтэн хүмүүсийг бодвол нэгэнт баривчилчихсан, тэднийг гэсгээн цээрлүүлчихсэнтухайгаа та над дуулгахаар ирсэн байлгүй гэв.

Де Тревиль үүнд,

-Үгүй их эзэнтэн, харин ч шүүж ялгаж өгөхийг танаас л гуйх гэж би ирээд байна гэж тайван хариуллаа.

-Хэнийг залхаалгах гэж тэр билээ? гэж ван дуу алдав.

-Гүтгэгч нарыг гэж де Тревиль хэлэв.

-Энэ чинь хачин юм байна!

-Танайтэр гурван хараал идсэн шадар цэрэг Атос, Портос, Арамис, Беари нутгаас ирсэн тэр гайхалтай хамт, золгүй муу Бернажу өөд галзуу юм шиг дайрч ороод сэгчиж одоо хөөрхий амьтан амьсгал хураахад ойрхон болчихоод байгааг та арай мэлзэх гээгүй биз? Тэгснийхээ дараа тэд нар де ла Тремуль герцог гуайн байшинг бүсэлж аваад шатаахаар завдажбайсныг арай үгүйсгэх үгүй биз? Дайны үед бол бас ч яахав тэднийх чинь ёстой нэг хугенотуудын уур болсон айл, харин энх амгалан цагт тийм хэрэг бусдад тун ч үлгэр жишээгүй муухай юм болох билээ. За хэлчих дээ та эд бүгдийг арай үгүйсгэх гээгүй байгаа? Де Тревиль мөн л биеэ барьсан хэвээрээ, -Их эзэнтэн танд хэн ингэтлээ худлаа залж орхио вэ? гэж дуугарав.

-Хэн хэлээв гэнээ, эрхэм ээ? Намайг унтаж байхад сэрүүн байж зугаа цэнгэл хийж байхад ажилдаа зүтгэн, улс орны дотоод гадаад франц, европод бүх хэргийг хөтөлж байдаг хүнээс өөр хэн над дуулгах билээ?

-Их эзэнтэн та лав бурхан тэнгэрийг өгүүлж байхболтой. Юу гэвэл бурхан л их эзэнтэн танаас өдий өндөр дээгүүр байж болох юм шиг над санагддаг гэж де Тревиль хэлэв.

-Үгүй, эрхэм ээ. Вант улсын маань түшиг тулгуур, миний ганц зарц, ганц анд хамба гуайг би хэлж байна.

-Хамба гуай бол их богд хараахан биш билээ.

-Та юу хэлэхгээд байна, эрхэм ээ?

-Богд ламтан л хилэнцээс тайлагдсан, хамба мяндагтан хилэнцээс тайлагдаагүй гэдгийг. -Та тэгвэл хамба намайг хуурч, надаас урваж байна гэх санаатай байх шив. Тэхлээр та түүнд ял тулгаж байна? За шуудхан хэлчих, ял тулгаж байгаагаа хүлээгээд орхи.

-Үгүй, их эзэнтэн харин тэр өөрөө хууртжээ гэж бихэлэх гэсэн юм. Түүнд худлаа юм дуулгажээ гэж би хэлж байна. Их эзэнтэн таны шадар цэргүүдэд тэр өөрөө муухан байдаг болохоороо ял тулгах гэж яарчээ. Муу хүнээс үг дуулжээ гэж би хэлэх гэсэн юм. -Ял тулгалт нь де Тремуть гуай, герцогоос өөрөөс нь гарсан юм.

-Энэ хэрэг Герцогт өөрт нь ойрхон хамаарах болохоор өөгүй шудрага байна гэж түүнд итгэхүйеэ бэрх гэж би хариулж болохсон, их эзэнтэн минь. Гэвч над тэгж хэлэх санаа огт алгаа, их эзэнтэн Герцог гуай өөрөө шулуун шудрага, сайн хүн гэдгийг би мэднэ, түүний үгэнд би итгэхэд бэлэн байна. Тэхдээ ганцхан л болзол...

-Ямар болзол вэ? тэр чинь?

Их эзэнтэн та түүнийг дуудаж ирүүлээд, өөрөө, гаднын хүнгүйгээр нүүр нүүрээ учран байцааж үзээсэй. Герцогийг явмагц л их эзэнтэн та шууд надтай уулзаасай гэж би гуйх гэсэн юм. -Үгүй ер! Тэгээд та де ла Тремуть гуайн юу л гэсэнд бүрэн итгэх юм бий дээ? гэж ван лавлав. -Тиймээ их эзэнтэн.

-Түүний гаргасан саналыг та дагах юмбиз?

-Тиймээ.

-Түүний юу л гэж шаардсаны дагуу, эрэлт хүсэлтий нь хангаж өгөх үү?

-Тэгнээ, их эзэнтэн.

-Ла Шене! Ла Шене! гэж Ван дуудав, XIII Людовик вангийн үүдний дэргэд ямагт байдаг, итгэмжилсэн хиа нь өрөөнд орж ирэв.

-Ла Шене, Де ла Тремуть гуай руу одоохон хүн явуулаач. Өнөө оройдоо түүнтэй ярилцах хэрэг над байна гэж ван айлдав.

-Де ла Тремуть гуай, бид хоёрын хооронд өөр хүн бараалхуулахгүй гэж их эзэнтэн над ам өгөх үү? гэж де Тревиль асуусанд

-Хэнийг ч оруулахгүй гэж ван хариуллаа.

-Тийм бол маргааш болтол баяртай, их эзэнтэн.

-Маргааш болтол, эрхэм ээ.

-Их эзэнтэн хэдэн цагт намайг ир гэхсэн бол?

-Дуртай цагтаа ирээрэй.

-Дэндүү эрт ирээд их эзэнтнийг сэрээчих бий гэж би зовсон юм.

-Намайг сэрээх ий? Би унтдаг болох нээ? Би унтахаа больсон шүү эрхэм ээ. Хаа нэг зүүрмэглэдэг, ердөө л тэр дээ. Хэдий ч эрт хамаагүй, дуртай цагтаа л ир. Долоон цагт ч гэсэн хамаагүй. Харин танай шадар цэргүүд буруутай болж гэм сайхан мэдээрэй.

-Миний шадар цэргүүдийн буруутай байвал гэмтэй нэгий нь их эзэнтний гарт өгнөө. Та тэднийг яахаа тааллаараа болох биз. Их эзэнтэн танд өөр соёрхох ямар нэг юм үгүйсэн болов уу? Би сонсож, дагаж гүйцэтгэхэд бэлэн байна.

-Үгүй эрхэм ээ, юмгүй. Намайг шудрага Людовик гэдэг нь дэмий ч юм биш. Маргааш болтол баяртай эрхэм ээ. Маргааш болтол,

-Их эзэнтэн таныг бурхан өршөөх болтугай.

Вантангийн нойр хэдий муу ч гэлээ, де Тревиль энэ шөнийг улам ч тавгүй өнгөрүүлэв. Гурван шадар цэргээ нөхрийнхөө хамт өглөө зургаан цаг хагаст өөрийндөө яг ирээд байгаарай гэдгийг хэлүүлж тэр оройдоо хүн илгээсэн билээ. Де Тревиль тэднийг ордон руу дагуулан явахдаа юу ч амласангүй, ямар ч багтай юм хэлсэнгүй тэдний болон өөрий нь хувь заяа дээсэн дөрөөн дээр дэнжигнэж байгааг ч хэлсэнгүй.

Бага хаалгаар ороод де Тревиль цаадуулыгаа хүлээлгэв. Ван тэдэнд хилэгнэсэн хэвээрээ байгаа бол тэд сэм яваад өгчиж болох, вантэднийг бараалхуулья гэвэл дуудах юм аж. Де Тревиль вангийн хүлээн авах дотоод өрөөнд ла Шенетэй уулзсанд, цаадах нь, де ла Тремуль герцогтой өчигдөр орой гэрт нь дайралдаж амжаагүй, ордонд бараалхуулахын эрхгүй даанч орой гэртээ буцаж ирсэн болохоор Герцог сая ирсэн. одоо вантай уулзаж байна гэж дуулгав. Де Тревильд энэ явдал их аятайсанагдлаа. Де Ла Тремуль, ванд бараалхаад гарах, өөрий нь бараалхах хоёрын завсар гаднын ямар ч харш нөлөө орж амжихгүйд багтай итгэж болохтой боллоо.

Үнэхээр ч арван минут болоогүй байтал үүд нээгдэж де ла Тремуль гуай гарч ирж яваа харагдлаа. Герцог шуудхан де Тревиль руу хүрч ирээд,

-Де Тревиль гуай, манай гэрийн дэргэд болсон хэргийн тухай тодорхой дуулах гэж их эзэнтэн намайг дууджээ. Би үнэний нь тухайлбал манай хүмүүс өөрсдөө буруутай байсныг айлтгаад, таныөмнө уучлал гуйхад бэлэн байгаагаа хэлсэн. Би тантай, нэгэнт энд дайралдсан хойно, одоо танаас уучлал гуйя мөн намайг хэзээд нөхдийнхөө нэгэнд тооцож явна уу-гэж Герцог хэллээ. Де Тревиль өгүүлрүүн:

-Герцог гуай, таны хэлбэршгүй шудрага журамтайд би гүнээ итгэдэг болохоор вангийн өмнө танаас өөр хүнээр өмгөөлүүлэхийг хүсээгүй юм. Үүндээ би хууртагдсангүй. Таны тухай хэлсэн үгээ эндэлгүйгээр хэлчихэж болох тийм эрчүүд франц оронд бас үлджээ. Танд би их талархаж байна гэлээ.

Үүдэн дээр зогсож байгаад энэ яриаг цөмийг дуулсан ван

-Сайн. Их сайн. Ганцхан л де ла Тремуль гуай өөрийгөө таны нөхөр гэж байгаа болохоор, намайг ч мөн нөхдий нь тоонд багтахсан гэж хүсдэгийг де Тревиль та хэлчихээрэй. Наадах чинь надыг хайхардаггүй юм. Өөрий нь барааг хараагүй одоо бүтэн гурван жил болчихоод сая л хойноос нь хүн явуулж байж нэг юм уулзлаа. Миний өмнөөс үүнийг хэлээрэй. Юу гэвэл энэ чинь ван өөрөө хэлчихэж болохооргүй зүйл билээ гэв.

-Гялайлаа, их эзэнтэн минь, гялайлаа. Гэхдээ их эзэнтэн танд өдөр бүр дуртай цагт нүдэнд чинь үзэгдэж байдаг бүхэн өөрт тань илүү үнэнч биш гэдгийг айлтгая. Энэ үг харин де Тревиль гуайд хамаарахгүй нь мэдээж хэрэг билээ.

-Ингэхлээр миний юу гэснийг герцог та дуулаа шив? Тэх тусмаа сайн гэж ван дуугараад өрөөнд ороод

Аа! Энэ чинь Тревиль та шив? Танай нөгөө шадар цэргүүд чинь хаа байна? Үгүй тэднийг аваад ирээрэй гэж би уржигдрын хэлээгүй билүү? Та яагаад гүйцэтгэсэнгүй вэ?

-Тэд доор ирчихээд байгаа их эзэнтэн. Та соёрхвол: Ла Шене тэднийг одоо дуудна. -Тэгэг ээ тэгэг, тэд даруйхан бараалхаг. Мөдхөн найман цаг болох нь, есөн цагт би нэг хүнтэй уулзах юм. Герцог таявж болно, тэгээд ордонд заавал ирж байгаарай... Тревиль ор ор. Герцог мэхийн ёслоод үүд рүү явлаа. Түүнийг шатны дээд тавцан дээрх үүдээр яг гарч байхад гурван шадар цэрэг д'Артаньяны хамт орж ирлээ. Тэднийг Ла Шене дагуулан авчирчээ. За зоригт эрчүүл наашаа ойрт, ойрт. Та нарыг нэг сайн загнаад орхиё, гэж ванөгүүлэв. Шадзр цэргүүд мэхийн өөдөөс нь дөхөж, д'Артаньян араас нь дагав.

-Мянган чөтгөр! Үгүй та нар чинь яаж хоёрхон өдрийн дотор дөрвүүлхнээ хамбын долоон торгон цэргийг жагсаалаас гаргачихав аа? Энэ чинь олон, дэндүү олдож байна. Цаашдаа иймэрхүү янзтай үргэлжлэх юм бол гурван долоо хоноод их гэгээнтэн сумангийнхаа бүрэлдэхүүнийг шинэчлэхэд хүрэх нь байна. Тэгээд би тун ч чанд зарлиг гаргахад хүрэх нь. Нэгийг бол ч одоо яая гэх вэ, би нэг л их татгалзашгүй. Гэтэл долоон хүнийг хоёр өдөрт гэдэг дахиад хэлэхэд олон, дэндүү олдож байна гэж XIII Людовик ван хэллээ,

-Тэгээд л наадуул чинь зовж гүйцээд, голоосоо гэмшиж өршөөл гуйж байхыг ихэзэнтэн та харж байгаа биз ээ.

-Зовон үнэн голоосоо гэмшиж гэнээ? Хн-гэж вантан үл итгэх байртай лавлаад, эдний энэ залирхуу царайд би итгэхгүй байна. Ялангуяа тээр нэг гаскон маягийн царайтайд нь. Алив наашаа дөхөөд ир, эрхэм ээ!

Энэ үгийг өөрт нь хэлсэн болохыг д'Артаньян мэдээд тун ч номой байртай дөхөж очив. -Үгүй

ер! Та юу гэж над нэг залуу хүн гэж яриад байсан юм бэ? энэ чинь хүүхэд, шал балчраараа хүүхэд байна шүү дээ! Жюссакийг энэ хүү тэгж айхтар хатгачихсан юм гэж үү? -Мөн Бернажуг илдээрээ хоёр дахин лут хатгасныг бас яана.

-Нээрээ юу?

-Каюзакийн гараас энэ намайг авраагүйсэн бол их эзэнтэн танд би гүн хүндэтгэлээ энэ минутанд дэвшүүлж байх завшаангүй байхсан гэдгийг бас оролцуулаагүй байна шүү гэж Атос үг хавчуулав.

-Тэгвэл танай энэ беари залуу чинь ёстой шулам юмаа. Манай талийгаач эцэг лав, мянган чөтгөр гэх байсан байх. Хэрэг байдал иймд амархан олон цамц хүүлж, цөөнгүй илд хугачна даа. Ингэхэд гаскончууд аанай л ядуу хэвээрээ биз.

-Ихэзэнтэн минь, үнэнийг хэлэхэд, эдний нутгийн ууланд алтны уурхай хараахан олдоогүй л байна, уул нь ч тэднийхэн таны эцгийг ван ширээнийхээ төлөө тэмцэж байх үед халуун дэмжсэний шагналд бурхан тийм шид үзүүлж таарах байсан юм гэж де Тревиль хэллээ. - Ингээд бодохоор, би эцгийнхээ хүү болохоор гаскончууд намайг ван болгосон үгээ дээ, үнэн биз, Тревиль ээ? Яах вэ? сайхан хэрэг, энэ чинь над таатай байна... Ла Шене яваад миний бүх хармаануудыг уудлаад үзээч, дөчин алтан зоос гарах нь уу, үгүй юү, гарвал нааш нь аваад ир. Одоохондоо залуу минь болсон бүх хэргийг чин үнэнээр нь над нэг яриад орхи. Өчигдрийн болсон явдлыг д, Артаньян нарийн дэлгэрэнгүй ярив. Их эзэнтнийг үзнэ гэхээс баярласандаа нойр хүрч өгөхгүй болохоор бараалхах цагаас гурван цаг дутуу байхад нөхөд дээрээ ирсэн, цөмөөрөө цуг зуушны газар руу явсан, мөн өөрийн бөмбөг нүүр рүүгээ оночихоос айхыг Бернажу үзээд тохуурхаж гарсан, түүнийхээ төлөө Бернажу амиа алдах дөхөж ор мөртөө байсан де Тремуль гуай гэрээ сүйтгүүлэхэдшахсан зэргийг ярилаа.

-Тиймээ!. Цөм л яг Герцогийн хэлсэнчлэн болсон юм байна. Хөөрхий хамба! Хоёр өдрийн дотор долоон хүнээ, тэр мөртөө хамаг дотно сайн улсаа алдаж гэдэг! За одоо болноо, эрхмүүд ээ, дуулав уу? Боллоо! Феру гудамжинд болсон хэргийн хариуг та нар авлаа, авахдаа бүр хэтрүүлж авлаа. Та нарын сэтгэл одоо ханаж болно.

-Их эзэнтэн таны сэтгэл ханасан болж гэм биднийх мөн ханасан, гэж де Тревиль өчив. - Тэгсээн, би одоо ханалаа, гэж ван хэлээд Ла Шенегийн гараас атга алтан зоос авч д'Артаньяны гар дээр тавьж цааш нь:

-За тэгээд миний сэтгэл ханасны гэрч энэ байна гэв. Одоо манай үед дэлгэрчихээд байгаа бардам сэтгэлийн тухай ойлголт тэр цагт жам болчихоогүй байв. Тайж хүн вангийн гараас мөнгө авдаг тэхдээ өөрийгөө дордод үзэгдлээ гэх сэтгэл өчүүхэн ч төрдөггүй агсан билээ. Тэхээр д'Артаньян дөчин зоосоо зовох юмгүй хармаандаа хийчихээд их эзэнтэнд талархлын үг урсгаж гарав. Ван ханын цаг өөд харснаа:

-За их сайн, одоо найман цаг хагас болчихоод байна та нар явж болно. Есөн цагт нэг хүн ирэхийг хүлээж байгаагаа би дуулгасан шүү дээ. Эрхмүүд та бүхний үнэнч зүтгэлтэйд гялайлаа. Би үүнээс хойш ч энэ үнэнч зүтгэлийг батгайд санаж явах болно, тийм биз? гэв. Дөрвөн нөхөд нэг дуугаар,

-Их эзэнтэн Вангийнхаа төлөө бид биесээхэсэгчин огтчуулахаас буцахгүй,-гэв. -Сайн, сайн! огтчуулалгүй байцгаавал дээр. Тэгвэл над ашигтай-гээд, Залуучуулыг гарч явах зуур ван аяархан дуугаар, -Тревиль, манай хороонд сул орон тоо байхгүй, тэгээд ч бид хороондоо, шалгаваргүйгээр хүн авахгүй гэж ярилцсан болохоор, энэ залууг өөрийнхөө хүргэн Дезессар гуайн торгон цэргийн суманд оруулчих... Аа чөтгөр алгад! Хамба гуайяаж ярвайх бол гэж бодоход бүр одооноос баяр хүрээд байна. Тэр бас нэг шатаж гарнаа, гэвч над падгүй би шудрага үнэнийг бодож хийсээн гэв.

Тэгээд Ван, де Тревилийг яв гэж элэгсгээр дохисонд, цаадах нь, шадар цэргүүд дээрээ ирэв. Де Тревилийг ирэхэд дөрвөн нөхөд д'Артаньяны авсан дөчин зоосыг хувааж байв. Вангийн таасанчлан хамба үнэхээр их хорсож бүхэл долоо хоногтоо шатар тавихаар орой ирэхгүй байлаа. Хэдий тийм боловч ван түүнтэй уулзах тухайдаа дур татам инээмсэглэж эелдэг нь аргагүй дуугаар, -таны үнэнч бие хамгаалагч, хөөрхий тэр Бернажу, Жюссак нарын бие ямар байна?-гэж асуудаг байлаа.

VII. ШАДАР ЦЭРГҮҮД ГЭРТЭЭ

Лувр ордноос гараад, д'Артаньян дөчин зоосноос авсан хувиа яаж зарвал дээрийг нөхдөөсөө асуусанд, Атос "Нарсны боргоцой" буудалд сайхан хоол захиал, Портос зарц хөлсөл, Арамис таарсан сайн амрагтай бол гэж зөвлөцгөөв.

Тэр өдөртөө нийлцгээж хоол идэх болоод, шинэ зарц хоолон дээр үйлчилж байв. Хоолы нь Атос захиалж, зарцы нь Портосолжээ. Пикард нутгийн хүн, тэр Планше гэдэг шинэ зарц Турнель гүүрэн дээр зогсож ус руу нулимаад, тарж байгаа дугуй долгиог ажиглан зогсож байхад нь мань шадар цэрэг дайралдаад мөн энэ хоолон дээрээ үйлчлүүлэхээр хөлслөн авчирчээ. Зарцын тэгж зогссон нь яриангүй юм бясалган, эргэцүүлэн бодох дуртайн гэрч мөн гэж Портос мэтгэнэ, тэгээд чэлдэв юм асууж шалгаалгүй дагуулаад ирсэн юм байж. Энэ хүний л зарц болох юм байх гэж санасан, тайж гуайн ихэмсэг байр Планшетийн сэтгэлд таатай санагдсан боловч Мушкетон гэгч нэг хүн нэгэнт уул ажил хийдгийг үзээд баахан урам хугарав. Портос, өөрийнхийгөө хэдий дорвилог айл боловч нэг л зарцын хэрэгцээтэй байдаг, тийм болохоор өөрий нь д'Артаньян гуайнд ажил хийх болно гэж Планшед дуулгав. Гэвч эзэн болсон хүнийхээ хийж буй найран дээр үйлчилж байгаад, тооцоо хийхийн цагт цаадах нь бөөн алтан зоос өврөөсөө гаргахыг үзмэгцээ Планше жаргал нэгэнт ирж гэж бодоод, ийм баян тарган хүнтэй дайралдсандаа тэнгэрт залбирав. Бүр хоол идэж дуусаад, үлдэгдлээр нь удтал мацаг барьсан гэдсээ дүүргэж авах хүртлээ Планше итгэсээр л байлаа. Гэтэл орой, эзнийхээ орыг засахын цагт сайхан горьдол нь замхраад явчхав. Үүдний, унтах хоёрхон өрөөтэй байранд нь ердөө л ганцхан ортой аж. Планше үүдний өрөөнд, д'Артаньяны орноос хуулж авсан бүтээлгэн дээр хэвтэж цаадах нь энэ цагаас аван нөмрөх юмгүй аргацаахад хүрлээ.

Атос мөн онцгой барилаар хүмүүжүүлсэн нэг зарцтай аж. Зарцын нэр Гримо. Энэ сайн эрхэм, мэдээжээр бид Атосыг хэлж байна, их дуу цөөтэй хүн. Портос, Арамис хоёртой дотно нөхөрлөн амьдарсаар одоо тав зургаан жилийн нүүр үзэж энэ зуур Атосын инээмсэглэж байхыг түүний нөхөд харах нь харсан боловч хөхөрч байхыг нь ер дуулсангүй, үг хэл нь товч, ухамжтай, хэзээд хэлье гэсэн юмнаасаа илүү юм дуугардаггүй элдвээр гоёж чимж барих гэж үгүй зөвхөн гол чухал юмны тухай ярихаас дэлгэрүүлж үл нуршина.

Атосын нас гучаас хэтрээгүй, өөрөө бие сэтгэлээр гуа сайхан хэдий боловч түүнийг амрагтай байлаа гэж дуулсан хүн ер үгүй. Атос өөрөө бүсгүйчүүлийн тухай ярих нь ер үгүй, бусдын ярихад тэр саад үл хийнэ, гэхдээ иймэрхүү ярианд өөрөө хааяа нэг гашуун үг, тааруухан юм хэлж ут нэмэрлэдэг өөрт нь тун ч аягүй байх нь илт аж. Атосын биеэ барьсан, зожиг, дуугүй зан нь түүний байрыг өвгөжрүүлэх аятай. Иймд Атос энэ заншлаа өөрчлөх дургүй болохоор зориуд алив хүслэнгээ жирийн нэгдохио уруулын хөдөлгөөн сэлтээр тааж гүйцэлдүүлдэг болгон сургажээ. Зарцтайгаа Атос тун нэг онцгой юм учирвал сая ярилцах билээ. Эзэндээ их хайн болж дассан саруул ухаанд нь биширдэг хэдий боловч ухаан жолоогүй айдаг Гримо, Атосын хүслэнг таалаа гэж бодоод ухас хийтэл яг хүссэний эсрэг юм хийчих удаа байдагсан. Тэгвэл Атос мөрөө хавчис гээд зарцаа ямар ч уур хилэнгүйгээр зүгээр нүдчихдэг билээ. Тийм учрал болсон өдөрт Атос арай үг олонтой байх жишээтэй.

Портос бол бидний нэгэнт ажиж амжсанчлан Атосоос тэс ондоо хүн билээ. Портос. их

яриагаар барахгүй ярихдаа чанга ярина. Гэхдээ хүнийг бас дэгстүүлээд яахав, үгий нь хүн чагнаж байгаа үгүйг харин Портос үл хайхарна. Хувийнхаа цэнгэлийн үүднээс, өөрөө өөрийгөө таатайяа чагнахын үүднээс Портос юм ярьдаг билээ. Портос шинжлэх ухаанаас л өөр юм бүхний тухай үг дэлгэдэг, гэхдээ эрдэмтэд хар багаас нь аван гүнээ жигших сэтгэл төрүүлдэг байсан. гэх билээ. Төрх байдал нь Атосынх шиг эрхэмсэг биш, тэгээд танилцаж байх эхний үед Атосын давуу байдлыг ухамсарлан дургүй хүрэх удаа цөөнгүй байжээ. Тэхлээр Атосоос ядаж дэгжин хээнцэр хувцаслахаараа илүү гарахыг хамаг чадлаараа мэрийнэ. Гэтэл хуучны жирийн хувцастай Атос дээхнүүр харсгээд ганцхан алхахын төдийд зохих буурь суурь нь тодорч, гоёж гоодсон Портосын сүрийг дарчих билээ.

Портос сэтгэлээ зогоох санаатай де Тревиль гуайн хүлээх өрөө, Лувр ордны харуулын байранд бүсгүйчүүдийн сэтгэлийг булаасан тухайгаа чанга чанга ярьж гардаг. Атос бол хэзээ ч тэгдэггүй билээ. Сүүлийн үед, мань хүн нэртэй төртэй шүүгч нарын эхнэрээс аваад алдар цуут дайчин эрсийн гэргий, түшмэл нарын эхнэрүүдээс аваад барон хэргэмтний гэргийчүүлийг дайруулж гараад өөртөө мөн сэтгэл татагдсан харь газрын нэг хатан ахайн тухай бас тодоос тод үг цухуйлгах болжээ.

Эх нь хээр алаг бол унага нь шийр алаг гэж хуучны үг байдаг. Тэхлээр Атосын зарцаас, Портосын зарц руу, Гримогоос Мушкетон руу орж ярья.

Мушкетон уул нь норманд гаралтай хүн, Бонифаций гэдэг дөлгөөн аятай нэрийг нь Портос чихэнд яриагүй чимэгтэй Мушкетон гэдэг нэрээр сольсон юм байна. Портост зарцаар орохдоо хоол хувцсаа даалгах, тэхдээ сайн хооллуулж аятайхан хувцаслуулах болзол тавьжээ. Түүнээс гадна, бусад бүх зардалдаа зарах юм олохын тулд тавьсан болзлууд Портосын сэтгэлд таатай, тохиром санагдсанд түүний нь зөвшөөрчээ. Портос өөрийн хуучин, илүү хувцас сэлтээс Мушкетонд хасуулж аргалуулж юм хийлгэдэг аж. Хуучин юмы нь эргүүлж барьж аргалдаг нэг чадмаг оёдолчны ачаар, эзнээ дагалдаад явж байхдаа Мушкетон сүрхий буурьтай харагддаг болжээ. Оёдолчны эхнэр, Портосыг язгууртны хээнцэр зангаас нь ангижруулахыг илтэд хичээдэг билээ.

Арамисын хувьд гэвэл зан төлөвий нь бид нилээд сайн гаргаж бичсэн, гэхдээ түүний, мөн нөхдийн нь зан төлөвийг цаашдаа нарийн ажиглаж үзлээ. Зарцын нь нэр Базен. Эзэн нь нэгэн цагт хувраг болох горьдлоготой хүн болохоор Базен хувраг хүний зарцад зохих хар өнгийн хувцаснаас үл салах билээ. Базены уул нутаг Берри, гучин тав дөчөөд настай, өөрөө намхан, бүдүүн, амарлингуй зантай хүн билээ. Эзнийхээ гаргаж өгдөг чөлөө цагт Базен шашны ном уншина. Хэрэгтэй болоод ирвэл хэдхэн янзын боловч сүрхий сайхан хоол хийж чадна. Бусад юмны хувьд тэр чухам нэгсохор, дүлий, хэлгүй хүн мэт, эзэндээ хэлбэршгүй үнэнч сайн ажээ. Эзэд болон зарц нартай хальт боловч нэгэнт танилцсан хойно, одоо орон байры нь авч ярья. Атос феру гудамжинд, Люксембургээс хэдхэн алхам газар сууна. Атос хоёр жижгэвтэр, тов хийсэн хэрэгсэлтэй өрөө, байшингийнхаа эзэгтэйгээс хөлслөн суудаг. Эзэгтэй өөрөө хөгширчхөөгүй, гуа сайхан хэвээрээ байгаа эмэгтэй, Атос руу хэдий энхрийлэн харц чулуудавч талаар өнгөрдөг аж. Жирийн нэг төвхөн тэр сууцны хананд хуучин баян хээнцэр агсны зарим үлдэгдэл бас үзэгдэнээ. Ухаан нь, баян сайхан хийц чимэгтэй, аль нэгдүгээр франциск вангийн үеийн байж таарах сайхан илд. Энэ илдний үнэт чулуугаар иший нь чимэглэсэн ганц бариул лав хоёр зуун алтан зоосноос нааш байхгүйсэн билээ. Гэвч

хамгийн гачигдалтай цагт хүртэл Атос тэр илдийг зарах юм уу ганц ч удаа барьцаанд өгөхийг үл зөвшөөрөх билээ. Удаан болтол энэ илд Портосын хүслэн болж байлаа. Тэр илдийг эзэгнэхийн тулд арван жилийнхээ амьдралыг ч билээ өгөхөөс татгалзахааргүй байв.

Нэг герцогийн хагагтайтай хийсэн болзоондоо очихоор зэхэж байхдаа Атосынилдийг Портос түр зүүгээд өгье гэжээ. Атос юм дуугаралгүй хамаг хармаагаа эргүүлж, байсан хамаг үнэ цэнэтэй, хэтэвч, алтан оосор, сэлтээ цөмийг хамаад Портост өгөх гэжээ. Илдийн хувьд гэвэл хананд хадаастай юм эзнээ энэ байрнаас гарахын цагт л хамт гарах юм гэж Атос хэлжээ. Илднээс гадна, III Генрих вангийн үеийн ихэс дээдэс болох гойдхээнцэр сайхан хувцасласан гэгээн бурхны одон энгэртээ зүүсэн нэг эрхмийн зураг мөн нүдэнд туслаа. Тэр зураг Атостой жаал төстэй, төрх байранд нь адил гэхээр юм бий болохоор вангийн одон зүүсэн тэр сурвалжит дээд эрхэм өөрий нь өвөг удам байсныг харуулна.

Энэ бүгдээс гадна илд, зураг хоёр дээр байгаа тэр сүлдэн чимэгтэй, инжээнийгайхам уран хийц бүхий сайхан хайрцаг зуухны дээд тавцан дээр тавиастай, орчны бүх юмнаасаа уран нарийнаараа гойд ялгарч байв. Тэр хайрцгийн түлхүүрийг Атос үргэлж биендээ авч явна. Гэвч нэг удаа тэр хайрцгаа Портосын дэргэд уудалсанд дотор нь янаг амрагийн захиа, гэр бүлийн бичиг баримт сэлт болов уу гэмээр дан цаас, захиа байдгийг нүдээрээ үзсэн аж. Хуучин Тагтаат гудамжнаа, гаднаасаа баян хээнцэр харагдах нэг томоо байранд Портос сууна. Нөхдийнхөө хэн нэгтэй цуг цонхныхоо дэргэдүүр өнгөрөх бүрд Портос гараараа зангаж "миний орон байр маань энэ дээ" гэдэгсээн. Цонхны нэгэн дээр Мушкетон ямагт зарц хүний гоёлын хувцастай зогсож байдаг аж, гэтэл Портосыг гэртээ байхад нь хэн ч дайралдаж чаддаггүй, өөрөө хэнийг ч хэзээ ч гэртээ орохыг урьдаггүй болохоор, ингэж баян хээнцэр харагддагийн цаана чухам ямар баялаг байдгийг тухайлж чадах хүн ер үгүй билээ.

Арамисын хувьд гэвэл, зочдын унтах, хоол идэх гурван, өрөө бүхий жижиг байртай аж. Унтах өрөө нь бусад өрөөнийхөө нэг адил доод давхарт сайхан ургаж бий сахлаг жижигхэн цэцэрлэг рүү харсан цонхтой, цэцэрлэгийн өтгөн ногоон навчис өрөөг сониучхан улсын харцнаас бат халхална.

д'Артаньян яаж шүү суурьшсаныг бид мэднэ, мөн зарц Планшетэй нь чбилээ танилцаж амжсан шүү дээ.

д'Артаньян уулаасаа хэрэгт дуртай, ер нь овжин улс бүхний олонход байдаг зан хойно. Атос, Портос Арамис гурав чухам юун улс болохыг мэдэх гэж д1 Артаньян байдаг хүчээ шавхана. Юу гэвэл энэ нэрээр тэд цөм жинхэнэ тайж нэрээ нууж байв. Тухайлахад Атосын жинхэнэ сурвалжит хүн болох нь бүтэн мод газрын тэртээгээс танигддаг билээ. Атос, Арамис хоёрын тухай юм дуулах санаатай мань хүн Портосоос асуулаа. Портосын тухай Арамисаас дуулах гэж оролдлоо.

Гай болоход, дуу цөөнтэй нөхрийнхөө тухай Портос улсын дам ярилцдаг юмсыг мэдэхээс цаашгүй аж. Атосыг их зовлон үзэж өнгөрүүлсэн, түүний шалтаг хайр дурлал, байсан, хэн нэгний хорон муухай урвалтхувиралтаас болж энэ сайнаас сайн хүний амьдрал бусничихсан юм гэлцдэг байх.

Тэхдээ тэр урвалтын нөхцөл байдлыг мэдэх хүн нэг ч үгүй билээ.

Портосын жинхэнэ нэрнээс бусад, амьдралын нь хамаг байр төлөвийг мэдэж ядаад байх юмгүй, нэрий нь, хоёр нөхрий нь нэрийг мөн ялгаагүй ганцхан л де Тревиль гуай мэддэг юм байж. Сайрхуу, ам задгай хүн болохоор, өөрөө усан болор мэт нэвт шувт харагдана. Ганцхан өөрөө өөрийнхөө тухай сайрхан ярьсан бүхэнд нь итгэж орхивол, түүний тухай ташаарчхаж болохсоон. Гэтэл Арамист ямар ч нууц сэлтгүй, илхэн цагаан хүн мэт харагдах мөртөө ёстой нууцын хөрөнгө ажээ. Бусдад хамаарах, асуудалд там тумхан хариулаад, өөртөө хамаарах юм бүхнээс хичээнгүйлэн тойрно. Нэг өдөр д'Артаньян удтал шалгаасны эцэст тэд бүхний найз Портос нэг герцог хүний хатагтайн сэтгэлийг татаж чадсан гэнэ гэж Арамисаас дуулаад, дуулгаж байгаа хүнийхээ янаг амрагийн явдлын нууцыг мэдэх санаатай оролдов.

-Аа эелдэг найз та өөрөө, барон гүн, герцог улсын хатагтай нартай бусдын нөгцсөн тухай сайхан ярьж суудаг таа өөрөө, яадаг вэ дээ?... гэж д'Артаньян хэлсэнд Арамис үгий нь таслан: - Уучлаарай.

Портос өөрөө энэ бүгдийг чалчаад явдаг, энэ аятайхан явдлаа миний дэргэд чанга ярьсан болохоор л би энэ тухай дуулгаж байгаа юм. Гэхдээ, энэ тухай би хөндлөнгийн хүнээс дуулсан байх юм уу, аль Портос өөрөө үүнийгээ над нууцлан, итгэмжлээд ярьсан бол би хүний наминчлал сонссон хувраг хүнээс ч даруу байхсан, итгэж үз, эелдэг д'Артаньян гуай минь гэв. -Үүнд би эргэлзэхгүй байна, гэхдээ, зарим нэг гэрийн сүлдийг та ч гэлээ сайнаас сайн мэддэг шиг над санагдах юм. Бидний танилцахын завшаан болж өгсөн нэг хатгамалтай алчуур үүнийг гэрчилсээн гэж д'Артаньянхэллээ.

Энэ удаа Арамис уурласангүй маш даруу царайлан, эелдгээр хариу болгон:

-Би хийдэд орж суухаар зэхэж байгаа болохоор хорвоогийн алив цэнгэлээс хөндий байдгийг найз минь бүү мартаарай. Таны үзсэн алчуурыг хүн надад бэлэглэсэн юм биш, миний нөхдийн нэгний салнаас болж манайд мартагдчихсан байсан юм. Миний найз, түүний сайн байдаг цаад хүүхэн тэрхоёрын нэрийг бодоод алчууры нь би нуухад хүрсэн юм... Өөрийн минь хувьд гэвэл амраг гэж үгүй надтай мөн нэг адил зүрхний амраг гэж байдаггүй. Атосын мэргэн дуурайлыг баримталж байлгахыг ч хүсдэггүй юм гэв.

. -Үгүй, та нэгэнт л шадар цэрэг хойно, гэлэн арай биш юм байгаа биз дээ, чөтгөр алгад! - Ердөөл зуурдын шадар цэрэг хамбын хэлсэнчлэн өөрийн эрхгүй шадар цэрэг болж яваа хүн дээ, сайн найз минь.

Гэвч сэтгэл дотроороо би нээрээ шажны хүн. Намайг эрхэлсэн нэг ажил төрөлтэй байлгах л гэж Атос, Портос хоёр намайг нааш нь оруулчихсан юм байхгүй юу. Миний яг сахил хүртэх ёстой болсон тэр цагт нэг... юутай жаахан будлиан болчихсон юм. Ер эд бүгд танд юу нь сонин байх ажээ. Би хайран цагий чинь дэмий үрж байна.

-Огтхон ч үгүй, эд бүхэн над хачин сонин байна. Тэгээд над одоо хийх юм юу ч алга гэж д'Артаньян дуу алдсанд ,

-Миний залбирал унших цаг болчихлоо, дараа нь д'Эгильон авхайтны бичиж өгөөч гэж гуйсан шүлгийг бичих ёстой. Дараа нь Сент Онорэгудамж орж де, Шеврез авхайтны гуйсан энгэсэг авна. Ингэхлээр, найз минь, танд яараад байх юм үгүй гэхэд миний их яарах ёстойг

харж байгаа биз дээ гэж Арамис хэлээд залуу найзтайгаа эелдгээр гар барилцаад салав.

д'Артаньян чармайгаад, чармайгаад гурван шинэ нөхдийнхөө тухай өөр юм мэдэж амжсангүй. Одоохондоо нөхдийнхөө өнгөрсний тухай улсын ярилцдагтитгэдэг, арай тодорхой уг үндэстэй юм цаашдаа дуулдана биз гэж найдах болов. Одоохондоо Атос өөрт нь адил л биеэрээ, Портос Аякс, харин Арамис, Иосиф мөн аятай санагдах билээ.

Ерөнхийдөө тэр залуусын амьдрал зугаатай, Атос мөрийтэй тоглож, голдуу хожигдоно. Атос байгаагаар нөхөдтэйгөө хуваахад ямагт бэлэн байх мөртөө өөрөө тэднээс ганц ч зоос зээлдэггүй билээ. Хүнд өгнө гэж нэг амласан байвал маргааш өглөө нь л зургаан цаг болмогц өртэй хүнээ сэрээлгэж мөнгий нь гардуулна.

Портос хаа нэг тоглоно. Хожоод азтай байх цагтаа зоримог зан, ааш сайтай нь аргагүй хожигдож орхивол хэдэн өдрөөр сураггүй алга болчихсоноо царай алдаж цонхийчихсон, гэлээч хэтэвчиндээ мөнгөтэй буцаж ирдэг билээ.

Арамис ерөөсөө тоглодоггүй. Шадар цэргийн зан заншилд сайн нийлэлцэж чаддаггүйд хамт байхад хамгаас уйтгартай хүн л Арамис аж. Ямагт ийм тийм ажил гарав гэж үглэдэг байв. Найр наргиан ид дундаа, дарсанд халж, яриандаа хөөрсөн улс дахиад хоёр, магадгүй гурван ч цаг сууж наргих юм бодож байтал Арамис цагаа нэг харснаа босож, эелдэг инээмсэглэсээр нөхдөөсөө салаад, уулзахаар тохирсон номтой ламтан дээр очно гэгчхээд яаран одох удаа байдагсан. Дараа нэг өдөр нь Арамис гэртээ харьж, мяндаг ахиулах ёстой юм бичихдээ яараад садаа оруулахгүй байхыг нөхдөөсөө гуйна.

Тэх тухайд Атос нүдэнд дулаан, сайхан царайнд нь гойд сайхан зохидог, сэтгэл татаж аятайхан байраар инээмсэглэнэ. Портос дарс уусаар, Арамис сайндаа л нэг хөдөө тосгоны лам болох бий гэж ам алдана.

д'Артаньяны зарц Планше өөртөө ингэж аз дайрсныг зүй ёс шиг үзэж байв. Өдөрт гучин мөнгө авч, бүхэл сарын турш гэртээ ирэхдээ ааш зан сайхан нь аргагүй, эзэндээ эелдэг, анхаарангүй л байлаа. Авсчины гудамжин дахь байранд муу цаг ирж өөрөөр хэлбэл, XIII Людовик вантны хайрласан дөчин алтан зоос бараг урсаад өнгөрөхийн үед Планше гомдож үглээд горьгүй болов. Атос үүний нь олхиогүй. Портос ая зохисгүй, Арамис ердөө л инээдтэй зүйл гэж үзжээ. Атос энэ муу золгио халаад явуулчих гэж д'Артаньянд зөвлөнө. Портос урьтаад сайн саваад гэнэ. Арамис бол эзэн хүн өөрийнхөө чихэнд чимэгтэйгээс биш юм ер дуулахёсгүй гэв.

д'Артаньян үүнд,-Та нарт ярих ч амархан л байна. Атос та Гримотой таг дуугүй суудаг, үг ярихы нь хориглодог болохоор хэзээ ч муу үг дуулдаггүй Портос та баян хээнцэр амьдардаг болохоор Мушкетондоо шүтээн юм чинь,

Арамис та бол ямагт бурхан ном, буянд шохоорхдоогоороо уулын номхон сүжигтэй зарц Базендаа гүнээ хүндлэгдэж чадах юм. Гэтэл би дороо тулах суурь амьжралга сэлтгүй, шадар цэрэг биш, ядаж торгон цэрэг ч биш болохоор Планшед юугаараа хүндлэгдэж, өөртөө сайн байлгах сэтгэл яаж төрүүлэх билээ? гэв.

-Чухаг л асуудал. Энэ чинь айл гэрийн дотоод асуудал. Зарцаа, бүсгүйчүүлийн нэг адил ямар шүү байлгахсан гэсэн байраараа эхлээд л байлгахёстой юм. Үүнийг өөрөө жаал эргэцүүлээд үз, -гэж гурван нөхөд нь хариуллаа.

д'Артаньян эргэцүүлж үзээд юу ч болсон Планшег зодохоор шийдэж, ер нь юмыг ултай сайн хийдэгчлэн сайнаас сайн зодлоо. Планшег болтол нь сайн зодож орхиод, гэр, албаа өөрийнхөө зөвшөөрөлгүйгээр орхиж явахыг хориглов.

Миний ирээдүй лав аятай сайхан болно гэдгийг бодоорой чи. Сайн цаг ирнэ. Тэгээд надтай үлдэх юм бол би аж амьжирлагатай болно. Би уул нь сайн санаатай, өөрийн чинь гуйж байгаачлан чамайг явуулчихаад, замы чинь алдуулчихааргүй сайн эзэн болохоор явахыг зөвшөөрөхгүй гэж д'Артаньян ухуулав.

Ингэж аргалсныг дуулаад д'Артаньяны юмны ая олох их чадвартайд шадар цэргүүд бишрэв. Планше мөн эзэндээ бишрэх болоод халагдаж явах тухай үг дуугарахаа нэгэнт больжээ. Залуу нөхдийн амьдрал аяндаа зузаан барилдлагаатай болж ирэв. Хөдөө нутгаас ирж эрс, өвөрмөц орчинд орсон д'Артаньян өөрийн гэх дадал заншилгүй болохоор нөхдийнхөө дадал заншилд дасав.

Өвлийн цагт өглөө найм, зун бол зургаан цагт босоод, харуулын нууц дохиог мэдэж авах, гадуур шинэ сонин юу дуулдаж байгааг сонсох санаатай Де Тревиль гуайн руу очно. д'Артаньян өөрөө шадар цэрэг биш, гэлээ ч албанд мэрийн зүтгэх нь сэтгэл уяруулам. Нөхдөөсөө харуулд гарах болсон нэгий нь заавал дагаж явдаг болохоор ямагт харуулын алба гүйцэтгэнэ. Шадар цэргүүдийн байранд д'Артаньяныг цөм танина. Цөм сайн нөхөр гэж үздэг аж. Анх харсан цагаасаа аван үнэлж чадаад, өөрт нь үнэхээр сайн байдаг Де Тревильгуай д'Артаньяныг ванд ямагт магтана.

Мань гурван шадар цэрэг бас залуу нөхөртөө тун сайн байдаг. Дөрвөн нөхөд хоорондоо бат сайн үерхдэг, тэрчлэн ямар нэгэн хүнтэй тулалдах болсон хэрэг юм уу, цэнгэж наргих, өөр нэг хэргийн учир өдөртөө хэд дахин уулзалдах хэрэгцээ гараад, бүхэл өдөржин бие биеэ эрж гүйдэг аж. Люксембургээс Сен Сюльписийн талбай юм уу, хуучин тагтаат гудамжнаас Люксембург хүрэх зам зуур нэг нэгнээ эрээд гүйж яваа салшгүй дөрөвтэй ямагт тааралдаж болохсон. Тэр зуур де Тревиль гуай өгсөн амандаа алгуур хүрч л байлаа. Нэг өдөр бараа бологч Дезессарт торгон цэргийн сумандаа д'Артаньяныг ав гэж ван зарлиг болов. д'Артаньян санаа алдаад торгон цэргийн жагсаалын хувцас өмслөө. Үүнийгээ шадар цэргүүдийн нөмрөгөөр солихын тулд арван насаа өгөхөөс ч буцахгүй аж. Гэтэл деТревиль гуай д'Артаньяныг хоёр жилээс доошгүй сорьж байж тийм өршөөл үзүүлнэ. гэхдээ ванд тус болох учрал д'Артаньянд дайралдах юм уу өөр нэг янзаар тодрох юм бол уул хугацааг сааж болох юм гэжээ. д'Артаньян тийм ам аваад даруй явж маргаашаас нь эхлэн алба хаах боллоо.

д'Артаньяныг харуулд гарахын цагт хамт явж байх ээлж одоо Атос. Портос,Арамис гуравт ирлээ. Иймд, д'Артаньяныг ирснээр, Дезессар гуайн суман нэг хүнээр биш дөрвөн хүнээр нэмэгджээ.

VIII. ОРДНЫ ЭЛДЭВ БУДЛИАН

Тэр зуур, хорвоо дээр эхэлсэн юм бүхэнд дуусах цагбайдаг жамтай юм болохоор XIII Людовик вангийн хайрласан дөчин зоос дуусчихлаа. Тэр цагаас аваад дөрвөн нөхдөд хүнд цаг ирлээ. Эхний үед Атос бүгдийгээ аргацааж жаал байснаа Портос нэг удаа алга болдгоороо алга болсны ачаар залгаж авлаа. Портосын ийнхүү алга болоод өгдөгт нөхөд нь нэгэнт дасчихсан билээ. Хоёр долоо хоног хирдээ Портос бүгдийнхээчухаг хэрэгцээг аргацаагаад байхтай байв. Явж явж Арамисын ээлж ирсэнд бурхан шашны номоосоо зараад хэдэн зоос олов гэжээ. Дараа нь ердийнхөөрөө де Тревиль гуайгаас тусламж эрэхэд хүрлээ. Цаадах нь гурван шадар цэргүүдийн авбал зохих цалингаас цөөнийг урьдчилан олгосон боловч, багагүй өр ширтэй болчихсон гурван шадар цэрэг мөн өр ширтэй болж хараахан амжаагүй нэг торгон цэрэг үүгээр төдий удаан аргацааж яахан чадах билээ.

Тэгж тэгж, аргагүй хэрэгцээтэй юмаар гачигдах цаг тулаад ирж байгаа нь илт болохын цагт мань нөхөд арай ядан байж найм юм уу, арван алтан зоос гаргаад, Портос түүний нь авч мөрийцөхөөр явлаа. Гай болж Портос энэ удаа аз муутай байснаа юу ч үгүй алдчихсанаар барахгүй хорин таван зоос дараа өгөхөөр ам гарч нэмээд алдчихжээ.

Тэгэхийн хамт ховор живэр байснаа нэгэнт гачигдаад явчихлаа. Өлсөж орхисон шадар цэргүүд зарцаа дагуулсаар нөхдийн хэн нэг урьж хооллуулах бий гэсэндээ гудамж, байруудаар тэнүүчилж яваа нь харагдах боллоо. Юу гэвэл Арамисын хэлдгээр ийм үедээ өөрсдөө уригдаж болохтой байхын тулд явах үедээ хэн тохиолдсон хүнийг урьж хооллуулаад байх хэрэгтэй байдаг аж.

Атос дөрвөн удаа урилга авч, дөрвүүлэн дээр нь нөхдөө. зарц нары нь хамт дагуулж аваачив. Портос зургаан удаа уригдаж, мөн энэ завшаанаа нөхдөдөө ашиглуулав. Арамис найман удаа уригдлаа. Энэ хүн сүр бадруулах нь бага мөртөө их юм хийдгийг бид нэгэнт ажсан хойно. Нийслэл хотноо танил тал гэх юм ер үгүй, д'Артаньяны хувьд гэвэл, уул нь Гасконь нутгийн, нэг хувраг айлынд ганц удаа өглөөний цай чихэртэй ууж, мөн торгон цэргийн даргын гэрт хоолонд уригдсан төдий л билээ Хуврагийн дөрвөн дагуулж ирээд, хоёр сарын нь нөөцийг бүхэлд нь устгачихсан гэнэ Харин даргынх яриагүй их элбэг дэлбэг дайлсан, гэхдээ Планшегийн хэлсэнчлэн "идээд идээд юу барав. ганцхан л удаа идэх юм чинь".

Атос, Портос, Арамис нарын ачаар өдий их наргичхаад өөрөө тэднийг дөнгөж бүтэн хагас удаа хооллуулсандаа д'Артаньян зовж байлаа. Юу гэвэл хуврагийн өглөө цай уусан нь хагас хоолны дайтай л байх уу үгүй юу. Залуу хүний цагаан цайлган зангаар хамаг нөхдөө бүтэн сарын турш хооллож байснаа мартчихаад, бусдадаа тээр болж байх шиг өөрт нь санагдана. Сэтгэл зовсон залуугийн ухаан элдэв арга сүвэгчилнэ. Авхаалж шийдмэг зоригтой, дөрвөн залуус нийлсэн хойно, хөлчүүрэхийн зугаа цэнгэл хөөцөлдөх, илдний сургууль хийх, яахав овоо чадмагаар ч гэлээ дүрсгүйтэхээс өөр эцээхэн юманд зорих ёстой гэж д'Артаньян бодлоо.

Нээрээ үнэхээр ч эдэн шиг нэг нь нөгөөгийнхөө төлөө хэтэвчнээсээ аваад амиа хүртэл өгөхүйц бэлхэн, шийдсэн юмаа нийлээд юм уу, нэг нэгээрээ хийхэд бие биеэ ямагт дэмжин хэзээ ч буцаж няцдаггүй ийм дөрвөн эрчүүл алив дайсанд дөрвөн зэрэг юм уу тус тусдаа ч гэлээ хүч нийлэн заналхийлэх дөрвөн нударга, эд тавьсан зорилгодоо хэдий хол, хэдий

хүрэхүйеэ бэрх байвч ил юм уу далд шууд юм уу тойруу зам, арга заль юм уу хүч чадал алинаар боловч заавал хүрч чадахаар байлтай, Ганцхан энэ санаа яагаад аль хэдийнээ төрөөгүйд гайхна.

д'Артаньян энэ тухай ихээ гүнзгий бодол болж, энэ ер бишийн, дөрөв дахин нэмэгдсэн хүчийг аль замаар чиглүүлбэл таарахыг эргэцүүлж байв. Энэ хүчинд, Архимедын хөшүүрэг мэт тулгуурлан ертөнцийг эргүүлж болноо гэдэгт эргэлзэхгүй байв. Ингэж суутал гэнэт үүд аяархан тогшив. д'Артаньян даруй Планшег сэрээж үүд нээж өг гэв.

"Планшег сэрээж" гэхлээр уншигч та шөнө болчихсон юмуу, үүр цайгаагүй байгаа юм гэж бүү бодоорой, огтхон ч тийм биш. Дөнгөж сая дөрвөн цаг цохисон билээ. Хоёр цагийн өмнө Планше эзэн дээрээ ирээд хоол өгөхийг гуйсанд, цаадах нь "унтах, хоол идэх хоёр адилхан" гэж хариулсан юм байж.

Планше тэгээд хоолыг нойроор орлуулж байсан нь энэ аж.

Даруухан' хувцалсан, үзвэл хотгазрын бололтой хүнийг Планше өрөөнд орууллаа. Юун тухай яриа болохыг сонсож, хоолны дараах амттан зуушаа оруулах санаа Планшед их байсан боловч, ирсэн хүн нууцыг хадгалбал зохих чухаг юмны тухай ярилцах хэрэг байна гэж д'Артаньянд дуулгав,

д'Артаньян Планшег явуулаад, ирсэн хүнийг сууна уу гэв.

Жаал дуугүй байцгааж, зочин, эзэн хоёрбие биенийхээ тухай юм гадарлах санаатай өөд өөдөөс харна. Эцэстээ, д'Артаньян мэхэс гэж зочны үгийг сонсоход бэлхэн байгаагаа илтгэв. - д'Артаньян гуайг зоригтой залуу эр гэж би дуулсан юм, нээрээ та ийм алдар олохуйц сайн хүн болохоор нууцаа танд итгэмжлэх сэтгэл над төрлөө гэж ирсэн хүн дуугарав. Энэ хэргээс эрхбишашиг гарах төлөвтэйг зөгнөж таасан д'Артаньян үүнд,

-Ярь ярь, эрхэм ээ гэв.

Ирсэн хүн дахин хэсэг зуур дуугүй байснаа:

Манай эхнэр вангийн хатантны нэг бараа бологч юм, эрхэм ээ. Уул нь царайлаг ухаантай бүсгүй. Намайг тэр хүнтэй суулгаснаас хойш одоо гурван жил бэлж байна. Инж гээд байхаар их юм байгаагүй ч гэсэн хатантны шадар бараа бологч де Порт гуай эхнэрийн хамаатан болох хун, өмөг түшигтээ багтааж байдаг юм... гэв.

д'Артаньян яаруулж:

-За тэгээд цаашаа?...

-Цаашаа юу болоо вэ? гэнээ.

Цаашаа юу... цаашаа байнаа, өчигдөр манай эхнэрийг цагаан хэрэгслийн агуулахаас гарах үед хулгайлж аваад явчихжээ, гэж ирсэн хүн өчив.

-Танай эхнэрийг хэн тэгж хулгайлж орхив?

-Би ч мэдээжээр товгой юу хэлж чадах вэ. Гэхдээ би нэг сэжиг төрөөд байнаа. -Танд сэжиг төрүүлсэн тэр хүн чинь хэн бэ? -Аль эртнээс эхнэрийг мөрдөөд байсан нэг хүн -Ээ золиг, чөтгөр алгад!

-Гэхдээ зүрхэлж дуулгахад байнаа, эрхэм ээ, энэ явдалд дурлал гэхээсээ улс төрийн бодлого, дийлэнх бололтой санагдах юм.

-Дурлал гэхээсээ, улс төрийн бодлого гэнээ,-гэж д'Артаньян бодол болон давтаад,-Та тэгээдчухам юу гэж төсөөлж байгаа юм дээ?

-Мэдэхгүй, төсөөлж байгаа юмаа би тэгээд танд хэлж. болох болов уу даа... -Эрхэм ээ, би танаас юу ч асуугаагүй гэдгийг бодоорой.. Та өөрөө над дээр ирсэн. Нууцаа над итгэмжлэх санаатай байна гэж та өөрөө хэлсэн шүү. Тааллаараа л болж үз. Та одоохондоо надюу ч хэлэлгүйгээр яваад өгч болохоор байна.

-Үгүй үгүй! эрхэм ээ, та шударга сайн залуу шиг над санагдаж байна. Тэгээд нууцаа би танд илчилье. Миний санахад энэ хэргийн шалтаг гэвэл манай эхнэрийн өөрий нь янаг амрагийн хэрэг биш, харин өөрөөс нь их өндөр дээд нэг хатагтайн янаг амрагийн хэрэг бололтой. Ирсэн хүний өмнө ордны амьдралын тухай сайн дуулсан хүн болж харагдахыг хичээсэн д'Артаньян,-

-Уухай Арай Де Буа Траси гуайн хатагтайн янаг амрагийн хэрэг биш биз гэж дуу алдав. -Үгүй эрхэм ээ, түүнээс их өндөр дээд хүнийх -д' Эгильон гуайн авгайн уу? -Үгүй, дээгүүр -де Шеврез гуайн хатагтайн уу?

-Дээгүүр их дээгүүр -Үгүй, арай...

-Тиймээ, эрхэм ээ, чухам тийм гэж ирсэн хүн айж сүрдэн, дөнгөж дуулдахтай шивэгнэв. - Хэнтэй?

-Хэнтэй гэж, герцогоос... өөр хэн байх билээ.

-Герцогтой? гэнээ?...

-Тиймээ, эрхэм ээ, -гэж ирсэн хүн улам ч бүдэг дуугарав

-Үгүй эд бүгдийг та хаанаас дуулсан юм бэ? -Ээ...хаанаас дуулсан гэж санана! -Тиймээ, хаанаас мэдсэн юм? Итгэвэл, итгэсэн шиг итгэх хэрэгтэй... үгүй болж гэм...та өөрөө мэднэ хойно!..

-Энэ бүхнийг би эхнэрээсээ, өөрийнхөө, эхнэрээс дуулсан юм эрхэм ээ.

-Эхнэр чинь өөрөө хаанаас дуулаа вэ?

-де Ла Порт гуайгаас. Де Ла Порт гуай бол манай эхнэрт сахиус зүүлгэсэн хүн гэдгийг би

танд дуулгаагүй гэж үү? За тэгээд их эзэгтэйг дэргэдээ итгэмжилж болох хүнтэй байг гэж де Порт гуай манай эхнэрийг хатагтайн дэргэд албанд оруулсан юм. Хөөрхий хатагтайг ван хайхрахаа больчихсон, хамба мөрдөөд амраадаггүй, хүн бүхэн урваж байдаг юм.

-За тийм байж Байдал тодорхой болж байна.

-Эрхэм ээ, манай эхнэр дөрвөн өдрийн өмнөнд дээр ирсэн юм. Эхнэрийн албанд орохдоо тавьсан нэг болзол гэвэл долоо хоногт надтай хоёр удаа уулзах зөвшөөрөлтэй юм. Манай эхнэр над их сайн юм "гэдгийг танд би завшаанаар нэгэнт дуулгасан, тэгээд над дээр ирээд, хатагтайн сэтгэл одоо их түгшүүртэй байгааг аминчлан дуулгасан юм.

-Нээрээ тийм үү?

-Тиймээ манай эхнэрийн үгээр бол хамба гуай одоо хатагтайг урьд урьдынхаасаа илүү их мөрдөн хавчиж байгаа гэнээ. Нөгөө Испани бүжигний үед болсон явдлын улмаас хамба одоо хатагтайд өшөөрхөөд байгаа юм. Тэр бүжгийн үед болсон явдлыг дуулаа биз дээ? -Дуулалгүй яахав. Би болоод түүнийг дуулалгүй байх уу? гэж юу ч дуулаагүй мөртлөө бүхнийг мэддэг хүн болох гэсэн д'Артаньян хариулав.

-Тэхлээр одоо хамба үзэн ядахаар барахгүй өшилж байгаа

хэрэг

-Нээрээ юү?

-Тэгээд хатагтайн төсөөлж байгаагаар ... -Хатагтай юу гэж төсөөлөв өө? -Бекингем герцогт өөрийнхөө нэрийг зээлдэж захиа явуулсан болов уугэж хатагтай төсөөлөөд байгаа гэнэ.

-Хатагтайн нэрийг зээлдэж үү?

-Тиймээ, герцогийг Парис руу хуурч авчраад нэг занганд оруулах санаатай тэр байхгүй юү. -Ээ золиг чөтгөр алгад! Ингэхэд эрхэм ээ танай эхнэр энэ бүгдэд ямар хамаатай байдагсан билээ.

-Эхнэрийн хатагтайд үнэнч байдгийг бүгдээр мэднэ. Нэг бол түүнийг эзэгтэйгээс нь холдуулах гэж, эсвэл айлгаж сүрдүүлээд их эзэгтэйн нууцыг хэлүүлж авах, үгүй бол мөнгөөр татаж тагнуул туршуулаа болгох гээ биз.

-Магадгүй, эхнэрийг чинь хулгайлсан хүнийг та мэдэх үү гэж д'Артаньян хэлэв. -Мэдэх юм шиг санагдаад байна гэдгээ танд түрүүн хэлсэн билээ. -Нэр нь? -Нэрий нь би мэдээгүй юм. Хамба гуайд нохойшиг үнэнч зүтгэдэг шадар хүн нь мөнийг л мэднэ.

-Тэр хүнийг та үзсэн удаа байна уу?

-Үзсэн, эхнэр нэг удаа над тэр хүнийг зааж өгсөн юм.

-Танигдахаар содон тэмдэг тэр хүнд үгүй юү?

-Байлгүй яахав! Хар үстэй, царай нь боровгор, айхтар хурц харцтай цагаан шүдтэй, зэгсэн ихэмсэг байрын эрхэм. Санчигдээрээ бас сорвитой, гэсэнд д'Артаньян дуу алдаж, -Санчиг дээрээ сорвитой гэнээ?

-Тэгээд бас цагаан шүдтэй, хурц харцтай, бор царайтай хар үстэй ихэмсэг байрын гэнээ. Тэр чинь Менгэд дайралдсан нөгөө хүн мөн дөө!

-Менгэд дайралдсан нөгөө хүн мөн гэв үү та?

-Тиймээ тийм. Энэ ч ажил төрөлд хамаагүй юм. Үгүй би эндүүрч байна. Энэ чинь уул хэргийг ихээ хялбарчилж байна, Таны дайсан хүн бас миний дайсан болохоор би хоёулангийнхаа өмнөөс өшөө авна. Ердөө л энэ дээ. Харин тэр хүнийг би хаанаас олох билээ?

-Үүнийг би мэдэхгүй юм даа.

-Тэр хүний суудаг газрын талаар дуулсан юм танд тун үгүй биз?

-Огт үгүй. Нэг өдөр эхнэрээ би Лувр ордон руу хүргэж өгтөл эхнэрийг орсон дорхон тэр хүн цаанаас нь гараад ирсэн тэгээд л эхнэр над зааж өгсөн юм.

-Ороолон! Ороолон! юм даа тэр чинь? Энэ бүгд тун учир бүрхэг "юм даа. Танай эхнэрийн хулгайлагдсаныг хэн танд дуулгав.

-де Ла Порт гуай

-Танд тэр тэгээд ямар нэг тодорхой юм хэлэв үү? Өөрт нь мэдэх юм байсангүй. -Өөр газраас дуулж мэдсэн юм танд бас үгүй юү?

-Жаал зугаа юм мэдсээн ... Би юу авсан ... -Юу авсан гэж?

-Миний хувьд энэ их болгоомжгүй явдал байж мэдэх юм даа. бүү мэд..

-Та дахиад эргэлзэжбайх шив. Буцна гэвэл нэгэнт оройтож орхисныг танд хэлүүштэй байна.

-Үгүй би буцах гээгүй байна. Мянган чөтгөр гэж ирсэн хүн хараалын хүчээр зориг орох санаатай дуу алдаад Бонасьегийн нэр төрийг барьж ам өгье гэв.

-Таны нэр Бонасье юу?

-Тиймээ, энэ миний нэр.

-Ингээд та Банасьегийн нэр төрөөр ам өгье... гэсэн байхаа. Таны үгийг тасалсанд та уучлаарай. Ингэхэд таны нэрийг бинэг газар дуулсан шиг над санагдах юм.

-Магадгүй ээ эрхэм ээ. Би энэ байшингийн эзэн юм.

-Аа тийм бий! Та энэ гэрийн эзэн юм бий? гэж д'Артаньян өндөс гэж мэхийн дуугарав. -Тийм

тийм эрхэм ээ. Та манай байшинд суугаад гурван сар болчхож байгаа, тэгээд олон чухал ажил төрлийнхажуугаар байрныхаа хөлс төлөхийг мартчихсан бололтой, Би хувьдаа таныг зовоож байгаагүй, тэхлээр миний санахад та ингэж эелдэг байсны минь харгалзаж үзээд. -Тэгэлгүй яахав,тэгэлгүй яахав,Бонасье гуай! Ингэж эелдэг байсны ачийг би чухагт санаж танд алив юмаар тус болж болохтой байвал туслахыг өөрийн үүрэг гэж үзнэ... гэж д'Артаньян хэлэв.

-Би танд итгэж байна. Итгэж байна, эрхэм ээ үүнийгээ л би танд хэлэх гэсэн юм. Бонасьегийн нэр төрөөр амлая,би танд бүрэн итгэж байна.

-Тийм бол үгээ үргэлжлүүл, дуустал нь ярьж аль. Ирсэн хүн хармаанаасаа нэг цаас гаргаад д'Артаньян өөд сарвайсанд

-Захидал уу? гэж мань залуу дуу алдав. . -Өнөө өглөө авсан захидал.

д'Артаньян. захидлыг задлаад бүрэнхий болж байсан цаг болохоор цонх руу очив. Зочин араас нь дагана.

д'Артаньян уншвал: "та эхнэрээ бүү эрээрэй, хэрэгцээ нь өнгөрсөн хойно эхнэрий чинь буцааж өгнө. Та эхнэрээ эрж олох арга сүвэгчлэх юм бэл баларна шүү" гэжээ.

-Юу ч гэсэн энэ чинь шууд тодорхой юм байна, үгүй явж явж энэ маань ч ердөө л сүрдүүлэг байна шүү дээ гэж д'Артаньян хэлэв.

-Тиймээ, гэхдээ энэ сүрдүүлэг миний үсийг өрвийлгөөд байна. Эрхэм минь, би эр цэргийн хүн биш Бастили гяндангаас айх юм.

-Хээ! Бастилид би ч гэлээ танаас илүү их дуртай хүн биш. Харин илд далайххэрэгтэй цаг тохиолдлоо гэх юм бол өөр хэрэг.

-Аа эрхэм минь энэ хэргийн хувьд миний тэгээд танд найдсаныг яана!

-Нээрээ юү?

-Таныг хэзээд л догь сайхан шадар цэргүүдтэй нийлдэг, тэд нар де Тревиль гуайн шадар цэргүүд тэхлээр хамба гуайд дайсагнагч улс гэдгийг мэдээд, таны нөхөд, та нарыг хөөр . хий хатны талд. орж, дашрамд нь гэгээнтнийг нэг сайн хорлохоос дургүйцэхгүй байх л гэж бодсон юмсан.

-Мэдээж хэрэг.

-Цааш нь мөн та над байрны хөлс гурван сар төлөөгүй өртэй би тэр тухай ер сануулж төвөг удаагүй болохоор . •

-Тиймээ, тийм, та энэ үгээ түрүүн хэлж байсан, би ч мөн зөв гэж үзэж байна. -Цаашдаа, манай гэрт та хэдий удаан суулаа ч гэсэн мөн хөлс энэ тэр гэж төвөг удахгүй санаатай байдаг, үүнийгээ бодоод...

-Сайн, сайн.

-Үүнээс гадна, юмыг яаж мэдэх вэ, хэрэв таныг өнөөгөөр мөнгө муутайхан байгаа бол бас тавин алтан зоос авах үгүй юу гэх гэсэн юм...

-Аа их сайн! Ингэхлээр Бонасье гуайта баян хүн байх нээ" -Үнэний нь хэлбэл, би амжирлагатай хүн. Би аар саар юмны наймаа хийж жаал хөрөнгө хураасан юм, тэр маань жилдээ хоёр гурван мянган экю хиртэй орлого өгдөг юм. Түүнээс гадна нэрт далайчин Жан Макийн сүүлчийн аялалд би жаал зугаа хөрөнгө оруулсан. Ингэхлээр эрхэм та өөрөө ойлгоно шүү дээ, үгүй энэ чинь юу вэ хөөш! гэж Бонасье гуай гэнэт дуу тавьсанд, д'Артаньян

-Юу вэ? гэж асуулаа.

-Тэнд тэнд ... -Хаана?

-Манай гудамжны нөгөө талын гудамжинд хаалган дээр! Нөмрөгөөр биеэ ороочихсон хүн зогсож байнаа.

д'Артаньян, Бонасье хоёр хэн хэн нь дайснаа таниад нөгөөдөх чинь байна! гэж нэг зэрэг дуу алдав..

-Аа хаа! Одоо ч чи надаас мултрахгүй бий гэж Артаньян зүхээд, илдээ шүүрэн авч гүйж гарлаа. Өөрийнд нь ирж явсан "Атос, Портос хоёртой шатан дээр тулгараад цаад хоёрыгоо зай тавиад өхөд д'Артаньян хоорондуур нь сум шиг харайгаад гарлаа.

Хоёр шадар цэрэг араас нь,-чи хаашаа гүйгээ вэ? гэж хашгарав.

Нөгөө Менгэд дайралдсан хүн! гэж д'Артаньян хариу хашгараад далд оров.

Тэр хүнтэй учирсан, мөн аяллаар явсан сайхан бүсгүйн гарч ирсэн, тэр бүсгүйд цаад хүн нэг чухаг бичиг итгэмжилж өгсөн тухай д'Артаньян нөхдөдөө удаа дараа ярьж өгсөн билээ. Эцгийнхээ захиаг д'Артаньян үймээн дунд хаячихжээ гэж Атос боддог аж. д'Артаньяныг дүрслэн ярьж, бий төрх байраар үзэхэд цаадах нь лав тайж хүн байж таарна тэхлээр Атосын бодлоор тайж хүн хүний захиа хулгайлах тийм булай юм хийж явахааргүй билээ. Портос бол энэ бүх хэргийг бүсгүй хүнээс эрэгтэй хүндээ юм уу, эрэгтэй нь бүсгүйдээ болзоо хийж уулзаад байхад нь д'Артаньян, шаргал морьтойгоо саад хийснээс болсон гэж үздэг аж. Арамис бол энэ явдалд нэг нууц далд юм байна, тиймэрхүү юмны учрыг тайлах гэж оролдоогүй нь дээр гэж-хэлжээ.

Тэхлээр д'Артаньяны амнаас тэр үг гармагц юун тухай хэлсний нь даруй ойлгов. д'Артаньяны цаад хүнээ гүйцээд ч юм уу бараагийг нь алдчихаад ч юм уу, буцаж ирнэ биз гэж бодоод тэр хоёр дээшээ өгсөв.

Тэр хоёрыг ороход д'Артаньяны өрөө хоосон байв. Байшингийн эзэн, гэртээ, суусан хүн, цаад хүн хоёрын хооронд завал болох тулалдааны хойчоос айж, мөн д'Артаньяны саяхан өөрөө гаргаад хэлж байсан тэр ааш зангийг нь бодоод, холдсон нь дээр гэж үзжээ.

IX. Д'АРТАНЬЯНЫ АВИР ТӨРХ ТОДОРЧ ИРЭВ

Атос, Портос хоёрын бодсончлон, хагас цаг өнгөрөөд д'Артаньян гэртээ буцаж ирэв. Энэ удаа мөн л ид шидтэй юм шиг алга болоод өгсөн нөгөө хүнээ олж чадсангүй. д'Артаньян гартаа илд барьсаар ойр хавийн гудамжаар гүйж үзсэн боловч эрсэн хүнтэй нь төстэй хүн тун ч харагдаж өгсөнгүй_

Эцсийн эцэст нөгөө хүний налаад зогсож байсан үүдийг очиж цохив, уул нь эхлээд л тэгэх ёстой байсанбайж болох юм. Үүдий нь алхаар арав, арван хоёр гурав цохиод, цохиод хүн гарч ирсэнгүй. Гарсан чимээнээр айл зэргэлдээх улс зарим нь үүдэн дээр гарч, зарим нь цонхоороо цухуйгаад, энэ байрын бух үүд хаалга түгжээтэй, хүн амьтан суулгүй одоо лав зургаан сар болж байна гэлцэв.

д'Артаньяныг гудамжаар гүйж, үүд хаалга цохиж байх зуур Арамис хоёр нөхөр дээрээ ирж амжсан болохоор д'Артаньяныг буцаад ирэхэд хамаг нөхөд нь цуглачихаад байв. Хамаг хөлс нь цувж уурласандаа царай нь үрчийж ярвайчихсан д'Артаньяны орж ирэхийг гурван шадар цэрэг үзээд.

-За яахав гэж нэгэн дуугаар асуув. Залуу хүү малгайгаа орон дээр чулуудаад. -Яахав дээ. Тэр хүн ёстой нөгөө шулам нь мөн дөг. Сүүдэр хий юм, чөтгөр шиг алга болоод орхилоо гэж дуу алдав.

-Хий юманд та итгэдэг үү? гэж Атос Портосоос асуув.

-Би үзсэн юмандаа л итгэдэг хүн. Хий юм гэгчийг нэг ч үзээгүй болохоор итгэдэггүй шүү гэж Портос хариулав.

Хий юм байдаг гэж бурхны номд айлдсан байдаг. Самуилийн сүнс Саул дээр ирж байжээ гэдэг шашны энэ баримтлалыг би эргэлзэшгүй зүйлд үзнээ гэж, Арамис дуугарав.

-Юу ч гэсэн тэр, энэ ер хүн ч бай шулам ч бай, биетэй бодитой ч гэсэн хий сүүдэр ч гэсэн хоосон зэрэглээ ч гэлээ үнэн бодит юм ч гэлээ энэ хүн намайг хөнөөх тавилантай төрсөн дөгөө. Тэр этгээд зугтаачихсанаар, зуу, илүү ч их алтан зоос олж болох хэрэг миний гараас мултраад явчихлаа.

-Яаж тэр вэ, хөөш? гэж Портос, Арамисхоёр зэрэг дуу алдав.

Илүү үгэнд уулын дургүй Атос залуу өөд ердөө л асуух байртай харав.

Ярианы сэжмийг ч гэлээ сонсоод авах санаатай үүд ялихгүй онгойлгоод, завсраар нь толгойгоо цухуйлгаж байсан зарцдаа д'Артаньян,

-Планше доошоо бууж, энэ байшингийн эзэн Бонасье гуай дээр очоод тав зургаан лонх Божанси дарс бидэнд явуулна уу гэж хэл. Энэ дарс над бусдаасаа илүү дээр санагдаад байдаг юм -Портос дуу алдаж,

-Энэ бас догио! та янз нь эзнийхээ гэрээс юу дуртайгаа дураараа хэрэглэх эрхтэй хүн юмаа? гэсэнд д'Артаньян

-Тийм ээ, өнөөдрөөс эхлээд тэр, Бүү санаа зов, дарс нь муу байж таарвал бид сайн дарс авчруулна.

-Хэрэглэх хэрэгтэй, гэхдээ хэтрүүлж болохгүй гэж Арамис сургамжлангуй дуугарав.

-Бид дөрөв дундаас хамгийн ухаалаг нь д'Артаньян гэж би эс хэлдэг билүү, -гэж Атос дуугараад, ердийнхөөрөө дуугүй болчихов.. д'Артаньян үгэнд нь хариу мэхэсгэв.. -За тэгээд, чухам юу болсон юм дээ? гэж Портос асуусанд Арамис тосч аваад, -Нээрээ энэ нууцаа бидэнд тайлж өгөөч найз минь. Гэхдээ энэ явдалд бүсгүй хүний нэр төрийн хэрэг оролцоогүй л юм бол тэр шүү. Оролцсон юм бол та нууцаа дотроо хадгалж явсан нь дээр.

-Бүү сэтгэл зов, миний. Та бүхэнд дуулгах юмнаас болж хэний ч нэр төр гутчихгүй гэж Артаньян хэлэв.

Тэгээд гэрийн эзэнтэй ярилцсан бүхнээ нөхдөдөө нэгд нэгэнгүй ярьж, мөн гэрийн эзний эхнэрийг хулгайлсан хүн нөгөө"чөлөөт тээрэмчин" гэгч буудалд будлиан гаргасан нөгөө танихгүй хүн дүрээрээ гэдгийг нэмж дуулгав.

Атос дарснаасаа сайн муугий нь мэдэх хүний байртай балгаж, сайн дарс болохы нь толгой дохиж гэрчлээд,-

-Муугүй хэрэг ээ, энэ сайн санаат хүнээс тавь жаран зоос гаргуулаад авчижболох л юм. Ганцхан жаран зоосноос болж дөрвөн толгойгоо аюултай юманд оруулахын хэрэг байна уу? үгүй юу гэдгийг л эргэцүүлж үзье гэв. .

-Энэ хэрэг чухамдаа бүсгүй хүний тухай, эзэгтэйдээ үнэнч шударга байлаа гэж хулгайлагдаад элдэв сүрдүүлэг, магадгүй эрүү шүүлт үзэж бий бүсгүй хүний тухай гэдгийг бүү мартаарай гэж д'Артаньян дуу алдав.

-Болгоомжтой, д'Артаньян минь, болгоомжтой байж үз! Миний бодоход Бонасьегийн гэргийн хувь заяаг та хэтэрхий өөриймсөг үзээд байх бололтой. Эм хүн биднийг хөнөөхөөр төрсөн улс, ер нь бидний хамаг гай зовлонгийн уг сурвалж нь эм хүн юм шүү гэж Арамис хэлэв. Арамисын энэ үгийг Атос дуулаад, царай нь барайж,. хөмхийгөөзуув.

-Бонасье гуайн гэргийн төлөө л би санаа зовоод байгаа юм биш ээ. Гянданд хаягдаж орхиод хамбад хавчигдаж ойр дотно хүмүүсий нь толгой дараа дараагаар унасаар байгааг харж бий хөөрхий хатагтайн тухай зовж байгаа юм гэж д'Артаньян хэлэв.

-Бидний хамгийн өштэй дургүй улс, Англи, Испанийнханд хатан юунд тэгтлээ хайртай байдаг юм бэ?

-Испани бол хатагтайн эх орон, төрсөн нутгийнхаа испаничуудад сайн байдаг нь арга байж уу. Таны хоёрдох зэмлэлийн тухайд гэвэл, миний дуулснаар хатагтай англичуудад хайртай

байдаггүй ганц англи хүнд хайртай юм гэнэ билээ

-Үнэнийг хэлэхэд тэр англи хүн арга ч үгүй хайр булаахуйц хүн. Герцогоос илүү нүдэнд дулаан царайтай хүн би ер үзээгүй гэж Атос өчсөнд

-Хүн хүнээс гойд хувцасладгий нь бас дурсаад яахав,,

Герцогийг Лувр ордонд сувдаа цацаж байхад нь би тааралдсан юм, хоёрыг олж аваад, сүүлд тус бүр арван алтан зоосоор өгсөөн. Арамис чи тэр хүнийг мэдэх үү?

-Та нарын мэдэж байгаа шиг л сайн мэднээ, эрхмүүдээ. Герцогийг амены цэцэрлэгт барьсан хүмүүсийннэг нь би байсан юм даг. Намайг хатны агтач де Пютанж гуай тийш нь дагуулж аваачсан юм. Миний нөгөө шашны сургуульд байх үед юмсан. Тэр явдал вангийн хувьд гутамшигтай юм мэт над санагддаг гэж Арамис хэлэв..

-Тэглээ ч гэсэн Бекингем герцог гуайн хаа байгааг би мэддэгсэн бол ядахдаа хамбын хорыг маажих гэж герцогийг гараас нь хөтлөөд хатан дээр аваачихсан.

Манай хамгийн хэрцгий дайсан гэвэл хамба мөн, тэгээд түүнийг хорон муугаар чадаж болох завшаан гарвал би толгойдоо халтай байлаа ч буцахгүйсээн гэж д'Артаньян ярив. - Бекингэмийг нааш нь хуурмаг захиагаар ирүүлэх гэж дуудсан болов уу гэж хатан зовж байгаа болтой сэдвийг аар саар юмны худалдаачны үгнээс та мэдээ юү. д'Артаньян? гэж Атос асуув.

-Хатагтай тэгж айж байна.

-Байзнаарай гэж Арамис дуугарахад

-Юу болов? гэж Портос асуулаа.

-Үгүй зүгээр ярь ярь. Зарим нөхцөл байдлын талаар би юм санах гэж оролдсон юмаа. -Энэ бүсгүйг хулгайлсан явдал бидний сая ярилцсан хэрэг явдалтай уялдаатай гэж би одоо бат итгэж байна. Магадгүй Бекингем герцогийн Парис хотноо ирчихсэнтэй уялдаж байж мэдэх бий гэж д'Артаньян хэлэв.

-Гасконь нутгийн энэ хүн тун их ухаалаг юмаа ер! гэж Портос бишрэн дуу алдсанд Атос -Би үүний юм ярихыг чагнах дуртай, дуудлага нь над хөгтэй санагддаг юм гэв. -Өршөөлт эрхмүүд минь миний үгийг дуулж үзээч! гэж Арамис дуугарахад -Арамисын үгийг дуулья гэж нөхөд нь зөвшөөрөв.

-Өчигдөр би хотын нэг буйд хэсэгт нэг номтой ламынд очсон юм.

Бичиж байгаа номынхоо талаар зөвлөгөө авах хэрэгцээ гарахаар би хааяа очдог юм л даа... гэсэнд Атос инээмсэглэв. Арамис яриагаа залган.

-Тэр хүн эрхэлдэг ажлынхаа байдал, зан төлөвгөө тохируулан буйдхан хол суудаг юм. За тэгээд намайг тэднийхээс яг гарч иртэл... гээд түгдрэв.

-За тэгээд? Таныг тэднийхээс яг гарч иртэл яагаав? гэтэл Арамис нэг ухасхийснээ гэв гэнэт саадтай тулгарсан хүн шиг хүчилж чармайв. Тэгээд сонсож байсан улсын нүд өөдөөс нь ширтэж, ярианы нь үргэлжлэлийг хичээнгүйлэн хүлээх тул нэгэнт буцахынэрхгүй болжээ. - Тэр номч хүний нэг зээ охин байдаг юм, гэж Арамис ярив.

-Аа тийм бий! Тэднийд охин бий юм бий! гэж Портос үгий нь таслав. -Ихээ тохитой сайн авхай гэж Арамис тайлбарласанд гурван нөхөд инээлдлээ. -Та нар инээлдэж, миний үгэнд эргэлзэж байгаа бол өөр юу ч дуулахгүйгэж Арамис хэлэв.

-Бид танд бурхан шиг итгэж загас мэт дуугүй байя гэж Атос амласанд Арамис дахин яриандаа орж,

-За тийм бол би цааш ярья. Тэр зээ охин нь хааяа авга дээрээ очдог юм байж. Өчигдөр орой мөн тэнд намайг байх үеэр очиж таараад, би тэр бүсгүйг сүйхэнд нь хүргэж өгөх боллоо... гэсэнд Портос амаа барьж чаддаггүй нэг их муу зантай хүн болохоор мөн хажуугаас нь орж - Уухай, тийм бий! Номч хүний зээ охинд сүйх байсан байх нээ? Догь хүнтэй танилцаж дээ. Найз минь гэв.

-Портос та ер жаал даруу биш зантай, энэ чинь л бүсгүйчүүлийн нүдэнд таныг хөөдөөд байх юм гэж нэг удаа өөрт чинь сануулсан билээ гэж Арамис хэлэв.

Хэрэг явдлын үнэн голыг ойлгож эхэлсэн д'Артаньян дуу алдаж.

-Эрхмүүд ээ, эрхмүүд ээ, энэ их чухаг хэрэг болноо. Болж өгвөл тоглоом тохуу хийхээ больё. Арамис ярьж үз, ярьж үз гэв.

-Гэнэт өндөр нуруутай хар үстэй, тайж байрын д'Артаньян таны нөгөө дайралдсан хүнтэй төстэй...

-Дүрээрээ мөн байсан байж мэдэх бий, гэж д'Артаньян дуугарав.

-Тавзургаан хун хойноосоо арваад алхмын хир зайтай дагуулсаар над дээр ирээд: "Герцог гуай" гэснээ миний гарыг түшиж явсан бүсгүй рүү хандаж "хатагтай та" гэсэн... -Номч хүний зээ охиныг тэр биз?

-Үгүй Портос та амаа татаач, аргалах аргагүй хүн байна шүү та, гэж Атос зандрав. -"Сүйхэнд сууж хайрла эсэргүүцэх юм уу, өчүүхэн ч болов чимээ шуугиан гаргах гэж бүү оролдоорой" гэж тэр хүн хэлсэн.

-Тэр чинь таныг Бекингем гэж эндүүрчээ, -гэж д'Артаньян дуу алдав. -Би мөн тэгж тааж байгаа юм,гэж Арамис хэлэв.

-Аа авхайг? гэж Портос асуулаа.

-Авхайг яахав, вангийн хатан гэж боджээ гэж Артаньян хариулав.

-Түмэн зөв гэж Арамис хэлсэнд

-Энэ Гасконь нутгийн эр ер нь ёстой шулам байна шүү гэж Атос дуу алдав. -Юу ч андахгүй юм?

-Нээрээ Арамисын нуруу, явах хөдлөх байр нь гуалиг герцогтой төстэй гэж Портос хэлсэнд үгүй тэхдээ Арамисын шадар цэргийн хувцас...

-Би урт нөмрөгтэй явсан юм,-гэж Арамис хэлэв.

-Зуны дунд сард шүү та минь! Чиний тэр номтой лам чинь чамайг хүн таниад орхихоос айдаг юм уу? гэж Портос дуу алдаж

-Тагнагч этгээд нуруугий чинь хараад хууртаж болох л юм гэтэл царай... -Би өргөн хүрээтэй малгай өмсч явсан юм, -гэж Арамис тайлбарлав. -Ээ тэнтэр минь! Буян ном судлахадер хэчнээн ч их болгоомжлох юм билээ гэж Портос дуу алдав.

д'Артаньян хажуугаас нь

-Эрхмүүд ээ, эрхмүүд ээ! тоглоом тохуу хийж цаг үрэхээ больё. Цөм тал тал тийшээ тараад. энэ аар саар юмны худалдаачны эхнэрийг эрж эхэлье. Хамаг хэрэг явдлын оньсого тэнд л лав байна, гэв.

-Тийм дорд угсааны бүсгүй юу? д'Артаньян та тэгж бодож байна гэж үү? гэж Портос дорд уруулаа басамжлангуй унжуулан дуугарав.

-Тэр бүсгүй хатагтайн итгэмжлэгдсэн бараа бологч де Порт гуайн садан юм. Эрхмүүд та бүхэнд би үүнийг дуулгаагүй билүү? Түүнээс гадна, их эзэгтэйд энэ удаа ийм доорд хүнээс түшиг дэмжлэг ирэх хэрэгцээ гарсан ч байж болох юм. Ихсийн толгой алсаас бараатай байдаг, тэр тусмаа хамба гуайн хараа хурц хойно доо.

-За яахав,. цаад наймаачинтайгаа ярилцаж тохир, олигтойхон шан авахыг бодоорой, гэж Портос хэлэв.

-Тэхийн хэрэггүй ээ, энэ хүн бидэнд ач хариулдаггүй юмаа гэхэд сайнаас сайнаар хариулах өөр хүн олдох юм шиг над санагдах юм, гэж д'Артаньян хариулав. Энэ үеэр шатаар яарсан хүний хөлийн чимээ гараад үүд сүрхийн нээгдэж, нөхдийн зөвлөж суусан өрөө рүү золгүй наймаачин орж ирээд дуу тавьж,

-Эрхмүүд ээ! Буян бодож намайг аварч үзээч! Доор дөрвөн цэрэг ирчихээд намайг барих гэж байна, аварч үзээч! Аварч өг гэв

Портос Арамис хоёр суудлаасаа босов.

-Азнаарай гэж д'Артаньян дуу алдаад, хоёр нөхөртөө дутуу сугалсан илдээ буцааж хуйл гэж дохиж.-Энд эрзориг биш, арга заль хэрэгтэй болоод байна.

Портос маргаж, -үгүй бид харсаар байгаад яаж... гэтэл Атос хажуугаас нь:

-д'Артаньяид дураараа болох боломж олгоё. Дахиад хэлэхэд д'Артаньян бидэн дотроо хамгийн ухаалаг маань юм. Юу ч гэсэн би л хувьдаа д'Артаньянд захирагдаж байгаагаа дуулгая. д'Артаньян та өөрийнхөө санаснаар л, бол гэлээ.

Энэ минутад үүдний өрөөнд дөрвөн цэрэг ороод ирснээ илд зүүсэн дөрвөн шадар цэргийг хараад дотогшоо орж зүрхлэлгүй зогсчихлоо, д'Артаньян өөдөөс нь:

-Орцгоо, эрхмүүдээ, орцгоо!

Та бүхэн манайд ирээд байна, бид бүгдээрээ л ван, хамба гуай хоёрын үнэнч зарц нар шүү дээ гэв. -Тийм бол, биднийг авсан тушаалаа биелүүлэхэд өршөөлт эрхмүүд саад тотгор хийхгүйсэн бол уу? гэж багийн дарга бололтой нэг нь хэллээ.

-Яалаа гэж эрхмүүд ээ, хэрэгтэй бол та нарт бид туслахнаа ч бэлэн.

-Үгүй, энэ чинь хаашаа юм яриад байнаа? гэж Портоос үглэнэ.

-Чи тэнэг байна, дуугүй бай! гэж Атос шивнэв.

-Үгүй та над ам өгсөн шүү дээ... гэж золгүй наймаачин дуулдахтай үгүйтэй дуугарсанд д'Артаньян

-Бид өөрсдөө чөлөөтэй сул байж гэмээнэ л таныг аварч чадна. Одоо бид таныг өмгөөлөх гэх юм бол тантай цуг баригдчихна шүү дээ гэж Бонасьед хурдхан шивнэлээ.

-Миний санахад... д'Артаньян чангаар:

-Тэгж үз, эрхмүүд ээ, тэгж үз. Энэ хүнийг өмөөрч байх шалтаг над ер үгүй. Өнөөдөр л энэ хүнтэй би анх учирсан, тэхдээ ямар шүү хэргээр учирсан гэж санана. Энэ өөрөө та бүхэнд хэлж өгөх бий. Надаас байрны үнэ нэхэх гэж ирсэн юм. Би үнэн юм ярьж байгаа биз, Бонасье гуай?

-Аргагүй үнэн гэж гэхдээ шадар цэрэг гуай... гэж наймаачин аман дотроо бувгнав. -Миний тухай, нөхдийн тухай ганц ч үг бүү дуугар, ялангуяа хатны тухай бүү үг дуугар, эсвэл та бүгдийг хөнөөнө шүү! гэж д'Артаньян шивнээд хөдөлж үз, эрхмүүд, хөдөлж үз! Энэ хүнээ барьж аваад яв гэж чанга хэлэв.

Хэлмэгдэж гүйцсэн наймаачныг д'Артаньян цэргүүдийн өөдөөс түлхэж орхив. -Хонгор минь таёс үл мэдэх бүдүүлэг хүн. Мөнгө нэхэж ирнэ гэнээ, тэхдээ бүр надаас шүү! шадар цэргээс тэр шүү та минь! Гянданд хий! Дахиад хэлэхэд эрхмүүдээ, энэ хүнийг шоронд аваачиж хийгээд намайг байрын хөлс төлөх мөнгө цуглуултал удаахан байлгаж үзээрэй. Хуягууд талархлын үг урсгасаар олзны хүнээ авч одлоо. Тэднийг шатаар нэгэнт бууж явталд'Артаньян гэнэт даргын нь мөрөн дээр алгадаад.

-Та миний, би таны эрүүл энхийн төлөө нэг нэг уучих юм биш үү? гээд Бонасьегаас авсан божанси дарсаар хоёр хундага дүүргэв.

-Над тун өндөр хишиг байна, их гялайлаа гэж хуягуудын дарга дуугарлаа. -За тэхлээр таны эрүүл энхийн төлөө хэн гуай, таны нэр хэн билээ? '

-Буаренар!

-Буаренар гуайн төлөө.

-Өршөөлт эрхэм таны эрүүл энхийн төлөө! Таны гэгээн алдар хэнсэн бол? Одоо асуухыг соёрхоно уу?

-д'Артаньян

-д'Артаньян гуай таны эрүүл энхийн төлөө!

-Гол нь, хэний эрүүл энхийн төлөө вэ гэхээр, вантны эрүүл энх, хамбын эрүүл энхийн төлөө! гэж д'Артаньян хөөрөн дуу алдав.

Муухан дарс байсан бол хуягуудын ахлагч д'Артаньяны үгийн үнэнд эргэлзэх байсан байж мэднэ, *гэтэл сайн дарс байсан болохоор тэр хүн итгэлээ.

Нөгөө хуягуудын даргыг дорд хүмүүсийнхээ хойноос гарч, дөрвөн нөхөд хэдүүлхнээ үлдсэн хойно Портос:

-Та ямар булай юм хийчихэв ээ? Яасан ичдэггүй юм бэ! Дөрөв дөрвөн шадар цэргүүд байж өөрсдөөсөө аврал эрж ирсэн хөөрхий хүнийг бариулчихаж байдаг! Тайж хүн байж муу туршуултай дарс уух гэж! гэж ундууцав.

-Портос оо, чамайг тэнэг байна гэж Атос хэлсэн шүү дээ, би ч мөн санал нийлэхээс горьгүй нээ, д'Артаньян чи их хүн юм. Чамайг де Тревиль гуайн байрыг эзлэхийн цагт өөрөөс чинь би өмөг түшиг гуйж сүмийн даа лам болохдоо дэмжүүлнэ гэж Арамис хэлсэнд. -Юу болж байгаа юм, бүү мэд, д'Артаньяны хийснийг га нар сайшааж байх шив? гэж Портос дуу алдана.

-Тэгэлгүй яахав, чөтгөр алгад! Үүний хийсэн юмыг сайшаах байтугай, баяр хүргэж байна гэж Арамис хэллээ.

д'Артаньян тэгж авирласныхаа учрыг Портост тайлбарлаж өгөхийг ч завдсангүй. -За эрхмүүд минь одоо нэг нь бүгдийнхээ төлөө .бүг" дээрээ нэгнийхээ төлөө, манай уриа одоо энэ болж байна, тийм биз? гэв.

-Үгүй... гэж Портос ам нээтэл, Атос Арамис хоёр;

-Гараа сунгаад андгайл гэж нэгэн зэрэг дуу алдав. Портос тэднийг эрхгүй дууриаж, амандаа нэг юм үглэсэн хэдий боловч гараа сунгалаа Тэгээд дөрвөн нөхөд, д'Артаньяны хэлсэн "нэг нь бүгдийнхээ төлөө бүгдээрээ нэгнийхээ төлөө" гэдэг үгийг дуу нийлүүлэн давтлаа. д'Артаньян бүхэл насан туршаа хүн захирсаар ирсэн хүн шиг:

-За сайн. Одоо цөм гэр гэртээ харьцгаая. Болгоомжтой байж үзээрэй юу гэвэл энэ цагаас

аваад бид хамбатай тэмцэлдэж эхэлсэн шүү гэжээ.

Х. АРВАН ДОЛДУГААР ЗУУНЫ ҮЕИЙН ОТЛОГО ГЭГЧ НЬ

Отон баривчлах гэгч өнөө цагт сэдэвлэж олсон зүйл бишээ. Нийгэм тогтнож, цагдах газар бий болохын хамт л цагдан сэргийлэхээс отон баривчлах арга сүвэгчилжээ.

Манайуншигч нар Парис хотын цагдаагийнхны өвөрмөц хэл ярианд дасаагүй, мөн бид өөрсдөө арван таван жил гаруй юм бичиж байхдаа энэ үгийг анх удаа хэрэглэж байгаа сэлтийг харгалзан дээрх үгийн учрыг тайлах гэж оролджё.

Ямар ч ялгаагүй нэг айлд гэмт хэрэгт сэжиглэгдсэн нэг хүнийг баривчлаад, түүнийгээ нууц байлгана. Үүдний өрөөнд дөрөв таван цагдаасэм нуугдан суугаад, үүд тогшсон бүхэнд тайлж өгнө, ороод ирмэгц хаалгаа хаачихаад баривчилж авах жишээтэй. Иймэрхүү янзаар хоёр гурав хонолгүй л тэр айлд байнга орж гардаг улс бүхнийг баривчлаад орхидог юм байна. Отлого хийх гэгч энэ дээ.

Бонасье гуайн гэрт яг тийм отлого хийгээд, ирсэн хүн бүхнийг баривчлан, хамба гуайн хүмүүс байцааж байлаа.

д'Артаньяны суудаг хоёрдугаар давхарт тусгай хаалгаар ордог болохоор тэднийд ирэх хүмүүст ямар ч гай тоггор болохгүй аж.

Гэхдээ д'Артаньян дээр ердөө гурван нөхөд нь л ирнэ. Гурвуулаа тус тусынхаа аргаар хөөрхий бүсгүйг эрэвч, одоохондоо олж, илрүүлсэн юм юу ч үгүй хэвээр. Атос тэр байтугай бүр де Тревиль гуайгаас хэдэн юм асуучихсанд, шадар цэргийнхээ уулын дуу цөөтэйг мэдэх даамал нь үүнд их гайхжээ. Гэвч де Тревиль гуай ван, хатан, хамба л гуравтай сүүлчийн удаа уулзахад, хамба нэг зовсон ч юм шиг, вангийн сэтгэл түгшүүртэй ч байх аятай, хатагтайн нүд улайчихсаныг үзвэл нэг уйлсан, эсхүл нойргүй хоносон хоёроос гарахгүй гэхээс өөр юм мэдэхгүй байлаа. Хатагтайн нүд улайсанд де Тревиль их гайхсангүй, нөхөрт гарснаасаа хойш хатагтай олон удаа уйлж, олон шөнө нойргүй хонодог байжээ.

Де Тревиль гуай юу ч болсон вантанд, ялангуяа хатанд үнэнч зүтгэх ёстойг Атост сануулаад, үүнийг нөхдөдөө мөн хэлээрэй гэв.

д'Артаньяны хувьд гэвэл, мань хүн гэрээс гарахгүй сууж, өөрийнхөө өрөөг хянах байр болгов. Отлогонд ирж, баригдаж байгаа хүн бүрийг цонхоороо харж байлаа. Дараа нь зүймэл шалныхаа хэдэн модыг авч, хар шалаа мөн аргацаагаад, байцаалт явуулж бий дорд давхар өрөө хоёрынхоо хооронд ганцхан нимгэн адар л үлдээснээр, байцаагч болон байцаалгаж буйулсын юу ярьсан бүхнийг дуулах боломжтой болов. Баривчилсан хүнийг урьдчилан нэгжсэний дараа эхэлдэг байцаалт нь ерөнхийдөө иймэрхүү л аж:

-Бонасьегийн гэргий танаар нөхөртөө юм уу, өөр хүнд юм өгүүлээгүй, хэлүүлээгүй биз? - Бонасье гуай өөрөө танаар эхнэртээ юм уу, өөр хүнд юм өгүүлээгүй, хэлүүлээгүй биз? -Тэд нар танд ямар нэгэн нууц итгэмжилж дуулгаагүй биз?

"Эд ямар нэгэн юм мэдэж байгаасан бол ийм юм асуухгүй дэг Одоо мэдүүштэй юм гэвэл эд чухам юу мэдэхийг хичээгээд байгаа юм бол? Янз нь Бекингем Парист ирсэн эсэх, хатантай

уулзаа юу уулзах нь уу гэдгийг мэдэх гэсэн болтой" гэж д'Артаньян бодлоо.

Артаньян энэ таавраа л голлосоннь, алив бух байдлыг харгалзаад үзэхэд ортой байж болохтой билээ.

Одоохондоо отох газар отсон хэвээр, д'Артаньян мөн анхаарлаа сулруулахгүй л байв. Золгүй муу Бонасье гуайг баригдсаны маргааш орой Атосыг де Тревиль гуайн руу яваад өгчихсөний дараа, цаг дөнгөж ес болоод, унтахаар ор засаагүй байсан Планше сая л засахаар завдаж байтал гудамжинд нэг хүн орох хаалга тогшиж. Үүд даруй онгойж, тэр хүн отлогонд орж баригдаад орхилоо.

д'Артаньян нөгөө шалаа авсан газар руу ухас гэж, түрүүлгээ харан хэвтээд чих тавилаа. Удалгүй хүн дуу алдаад, төдхөн ёолоход амы нь барив бололтой, байцаах төлөв ер үгүй. "Шулам! энэ янз нь бүсгүй хүн болтой, цаадуул нь нэгжиж, наадах нь ноцолдож байх шиг санагдах юм.. Эд муусайн хүч хэрэглэж байна... Новшнууд!..." гэж, Артаньян бодлоо. Доор болж байгаа хэрэгт оролцохгүйн тулд д'Артаньян арай чарай л биеэ барьж байв. -Би энэ гэрийн эзэгтэй, Бонасье авхай мөн гэдгээ эрхмүүд та нарт би хэлж байна шүү, би хатагтайн дэргэд алба хаадаг хүн гэж хөөрхий бүсгүй гоншгононо

Бонасье авгай! гэж д'Артаньян шивнэлээ, над ийм аз дайрлаа гэж үү? Бүх нийтээрээ эрээд байгаа хүнийг би олов

00?

-Тавыг л бид хүлээгээд байсан юм гэж хариулах дуулдлаа.

Хүмүүсийн дуу улам бүдгэрнэ. Ноцолдох чимээ гарлаа. Бүсгүй хүн хирээрээ дөрвөн эрчүүлтэй ноцолдон цааргалж байх бололтой.

-Тавь намайг... тавь гэж бүсгүй хүний дуу гарав. Үүнээс цаашаа дуулдахаар юмгүй болчихлоо.

-Тэд нар бүсгүйн аманд юм чихэж байна, одоо аваад явах нь гэж д'Артаньян дуу алдаад, огло үсрэн босов.

-Алив илд! Аа зүүлттэй байнаа... Планше

-Юу гээ вэ?

-Атос, Портос, Арамис гурвын хойноос гүй. Тэр гурвын нэг нь ядаж гэртээ лав байх биз. Гурвуулаа ч гэртээ ирчихсэн байж магад. Зэр зэвсгээ аваад наашаа шалавхан гүйж ир гээ... Аа тийм, Атос, де Тревиль гуайнд бий.

-Үгүй та хайчих нь вэ, эрхэм ээ, та өөрөө хайчих юм?

-Би цонхоор доошоо буулаа. Тэгвэл хурдан, чи шалаа буцааж хийтээд шүүрдэж орхи тэгээд үүдээрээ гараад миний хэлсэн газар өөд гүй гэж д'Артаньян хашгарав. -Еэ эрхэм ээ, та бяц ойччихно доо! гэж Планше дуу алдав.

-Дуугүй бай, мангуу минь! гэж д'Артаньян зандраад, цонхны тавиураас барьж унжсанаа аз болоход төдий өндөр биш хоёрдугаар давхраас үсрэн буухдаа өвдсөн ч үгүй. Тэгээд даруй орох хаалга руу очоод аяархан тогшихдоо;

Би одоо мөн отлогонд чинь ороод орхиё, иймэрхүү амьтан барих гэж оролдсон отогчийн хохь болох бий гэж шивэгнэв.

Үүд цохиод орхихын хамт доторх чимээ нам гүм болоод орхилоо. Хүний хөлийн чимээ гарч үүд нээгдэв. д'Артаньян илдээ сугалж бариад, Бонасье гуайн гэрт дайран оров. Янз нь пүрштэй болтой үүд өөрөө хаагдчихлаа.

Тэгтэл, хэлмэгдэн хашгарах, хүн гүйлдэх, илд хангинах гэрийн юм хүмийг хөдөлгөж бөөн шуугиан дэгдэхийг энэ золгүй байшинд суудаг бусад улс, ойр айл хөршийнхөн хүртэл дуулав. Төдхөн, гарсан шуугианд хиртхийсэн, мөн хэрэгт дурлаж цонхоороо цухуйж байсан улсыг харж байтал үүд дахин нээгдэж, хар хувцастай дөрвөн хүн түүгээр шулуухан, цочсон хар хэрээ аятай огло харайн гарцгаав. Далавчнаас нь суга татагдсан өд шигхувцас, нөмрөгнөөс нь огло татагдсан тасархайнууд шал, ширээний өнцөг сэлтээр хэвтэнэ.

д'Артаньян дийллээ, байцаагч нарын нэг нь л зэвсэгтэй байсан, тэгээд ч дүр үзүүлж л түүнийгээ хэрэглэсэн төдий болсон болохоор яд 1ж цөхөлгүй дийлснийг хэлэх хэрэгтэй. Бусад нь бас ч сандал, мухар сандал, цэцгийн ваараар хүртэл залууг чулуудаж цохих гэсэн. ГэвчГасконь залуу илдээ тэдэнд хэд хөнгөхөн хүргээд орхихын хамт сүнс нь зайлчихлаа. Тэднийг бүрэн дийлэхэд арван минутаас илүү цаг орсонгүй, тэгээд д'Артаньян тулалдааны талбар дээр дийлж үлдэв. Элдэв бослого, зэвсэгт тулалдаан юм л бол гарч байдаг агсан тэр цагийн Парис дахь хүмүүсийн заншлаар цонхоо сэжээргүй онгойлгосон айл хөршийнхөн хар хувцастай дөрвийг зугтаагаад орхихын хамт цонхоо хаачихлаа. Одоохондоо энэ явдал үүгээр дууссаныг тэд тааварлажээ. Түүнээс гадна мөн нилээд орой болчихсон байсан цаг, тэхэд Люксембург ордонтой залгасан хэсэгт одоогийн •шигээ л эрт унтдаг байсан юм.

д'Артаньян ганцаараа Бонасье авгайтай үлдээд өөдөөс нь эргэж харав. Хөөрхий эмэгтэй бараг ухаан алдчихаад зөөлөн сандал дээр хэвтэнэ. д'Артаньян бүсгүйг хурдхан ажиг. Хорин тав, зургаа орчим насны хар үстэй, монтгордуу хамартай, шүдний нь сайхан гэж гойд, цэнхэр нүдэн, гуа бүсгүй аж. Цасан цагаан царай нь ул бутран гэрэлтэнэ. Тэр эмэгтэйг ихэс дээдэс гэж болмоор шинж ердөө энэ төдий аж. Гар нь цав цагаан мөртөө хэлбэр барагтайхан, хөл нь ч гэлээ өндөр язгууртных гэгдмээргүй аж. д'Артаньяны аз болоход иймэрхүү юм сэтгэлийг нь үймүүлэхээр болчихоогүй байв.

Бонасье авгайг эргэцүүлж хараад, хөлийг нь ажиж байтал нарийн торгон алчуур шалан дээр уначихсан байхыг хараад сурсан заншлаараа газраас авлаа. Алчуурын булан дээр урьд нэг үзсэн, түүнээс болж Арамистай хоёул золтой л хоолойгоо огтлолцчихоогүй нөгөө сүлдхарагдлаа. Тэр цагаас аваад д'Артаньян сүлдтэй алчуурыг хараад аягүйцдэг болсон юм байж. Тийм болохоор мань хүн юм ч дуугарсангүй, газраас авсан алчуураа Бонасье авгайн халаасанд хийчихлээ. Энэ үеэр залуу эмэгтэй сэргэж ирж. Нүдээ нээгээд, орчноо хэлмэгдэн харснаа гэрт хүнгүй, аврагч хүнтэйгээ хоёулхнаа байхыг үзээд хүүхэн даруй инээмсэглэн залуу өөд гараа сунгав. Бонасье авгайн инээмсэглэх нь үнэнхүү дур булаам аж.

-Ээ, эрхэм ээ, та намайг аварлаа. Танд гүнээ ач санаж явья гэж бүсгүй дуугарав. -Миний оронд алив тайж хүн нэг бүрийн хийхүйц юмыг л би хийсэн авхайтан. Тэхлээр та над ач санах юм ер үгүй гэж д'Артаньян хариулав.

-Үгүй, хаанаас хүнийчийг хариулж чаддагаа танд үзүүлж чадна байх гэж би горьдоно Үгүй, эхлээд миний тэр хулгайч гэж бодсон улс надаар яах гэсэн юм бол? бас Бонасье гуай яагаад гэртээ үгүй байгаа юм бэ?

-Тэд нар, хулгайгаас хавьгүй илүү аюултай хүмүүс байлаа авхайтан. Тэд чинь хамба гуайн хүмүүс. Танай нөхрийн хувьд гэвэл, өчигдөртүүнийг барьж аваад Бастили гянданд хорьчихсон болохоор энд үгүй байгаагийн учир тэр.

-Миний хар хүн Бастили гянданд орчихлоо гэнээ! Бурхан минь ээ, бурхан, тэр маань ямар хэрэг хийчихсэн юм бол. Үгүй тэр чинь ёстой л нэг мөрөөрөө амьтан юмсан. Тэгээд залуу бүсгүйн айж хэлмэгдсэн хэвээр байх царайд нэг инээмсэглэлэрхүү юм тодрох мэт болов.

-Түүнийг авгатайн та ямар хэрэг хийж орхисон юм бол гэв үү? Түүний хийсэн ганц гэмт хэрэг л гэвэл таны нөхөр болох тэр хүнд аз, гай хоёр зэрэг учирсных болов уу гэж над санагдана. -Тэгвэл эрхэм та юуг... мэдэх юм...

-Таны хулгайлагдсаныг би мэднэ.

-Тэхдээ чухам хэнд хулгайлагдсаныг та мэдэх үү? Та мэдсэн юм бол над хэлээд өг. -Дөч дөчин тав орчим насны хар үстэй, зүүн шанаан дээрээ сорвитой, бор царайт хүн... -Зөв, зөв, түүний нэр нь?

-Нэрий нь үү? Харин түүнийг мэдэхгүй.

-Миний хулгайлагдсаныг миний нөхөр мэдэж байсан уу?

-Үүнийг хулгайлагч этгээдийн өөрөө бичсэн захианаас танай нөхөр мэдсэн. Бонасье авгай жаахан овсхийгээд

-Тэр тэгээд хулгайлсан шалтгийг гадарлажбайна уу? гэж асуув.

-Танай нөхөр энэ хэрэгт улс төрийн бодлого оролцжээ гэж таамаглаж байсан шиг санаж байна.

-Эхний үед би өөрөө энэ талаар эргэлзэж байсан юм. Одоо мөн тэгж санах болсон. За тэгвэл миний сайн санаат нөхөр намайг өчүүхэн ч хардаж байсангүй...

-Еэ өчүүхэн ч үгүй! Таны ухаалаг өөртнь хайр сэтгэлтэйд ихэд бахдаж явдаг хүн байна. Залуу сайхан бүсгүйн улбархан уруул дээгүүр дахин нэг мишээх байдал тодорс гэв. -Ингэхэд та яаж оргож амжив аа? гэж д'Артаньян шалгаана.

-Ганцаараа үлдсэн зайг ашиглачихсан. Намайг ямар шалтгаар хулгайлсан нь өнөөдөр над илт болсон болохоор цагаан даавуугаа ашиглаад цонхоор буучихсан. Нөхөр маань гэртээ байгаа

юм бодоод наашаа гүйж ирсэн юм.

-Нөхрөөсөө өмөг түшиг эрэх гэж үү?

-Тэр ч үгүй! хөөрхий хонгор нөхөр минь! Тэр маань намайг өмгөөлж чадах хүн биш гэдгийг би мэднэ. Гэвч тэр маань бидэнд өөр юмаар тус болж болох байсан болохоор би дуулгах санаатай ирсэн юм.

-Юун тухай тэр вэ?

-Үгүй, энэ ч миний өөрийн нууц биш юм! Тэхлээр би задалж чадахгүй. -Ингэхэд авгатайн, уучилж үзээрэй. Би өөрөө торгон цэргийн хүн хэдий боловч, таныг болгоомжтой байгаасай гэмээр байна. Алив нэгэн нууцыг итгэмжилнэ гэхэд энэ газар тун зохимжгүй мэт над санагдах юм. Сая миний Хөөгөөд явуулчихсан мөрдөгчид, одоо хүч сэлбэж аваад буцаж ирнэ. Биднийг энд байж байтал маань ороод ирвэл бид дүүрлээ гэсэн үг. Би гурван нөхөд рүүгээ хүн явуулах нь явуулсан Тэд гэртээ байсан ч юм уу, үгүй ч юм уу хэн мэдэх билээ гэж д, Артаньян дуугарав.

, -Нээрээ тийм шүү, таны хэлдэг зөв зугтаая, бушуухан эндээс далд орё гэж Бонасье авгай хэлмэгдэн дуу тавив.

Ингэж хэлээд бүсгүй д'Артаньяны гарыг шүүрэн авч үүд рүү хөтлөв.

-Үгүй тэгээд, хаашаа зугтаах вэ? хаана нуугддаг билээ? гэж д'Артаньян самгардав. -Одоо даруй энэ байшингаас холдье. Тэгж байгаад больё.

Тэр хоёр байшингаас гараад үүдээ ч хаалгүй авсны гудамжаар гүйж, вангийн шуудуу гэгч өөд эргээд, бүр Сен -Сюльпис талбай дээр ирж байж сая зогсов.

-За одоо бид яах ёстой болж байна? Таныг би хааш нь хүргэж өгөх вэ? гэж д'Артаньяныг асуусанд:

-Танд юу гэхээ би нээрээ мэдэхгүй байна шүү. -Би нөхрөө явуулж де Порт гуайтай уулзуулаад, сүүлийн гурван өдрийн дотор Лувр ордонд юу болсон, мөн тийшээ очвол над аюултай болов уу гэдгийг мэдэх гэсэн юмсан гэж Бонасье авгай хэлэв.

-Үгүй тэгвэл би яваад, де Порт гуайг дуудчихаж болно шүү дээ гэж д'Артаньян хэлэв. -Тийм л дээ. Даанч Бонасье гуайг ордонд таньдаг болохоор оруулчихна, таныг бол танихгүй болохоор оруулахгүй байх даа, энэ л гай байна.

-Энэ гайгүй Лувр ордны нэг хаалган дээр таны итгэлтэй сайн хаалгач бий л биз. Тийм хүн, нууц болзоот үг сонсоод гэж д'Артаньяныг хэлэхэд Бонасье авгай залуугийн өөдөөс хянуур ажиглаад,

Би танд тэр нууц болзоот угийг хэлээд өгчихвөл та түүнийг ашиглаад өнгөрсөн доороо мартчиж чадах уу-гэж бүсгүй шивнэв.

-Тайж хүний хувьд ам өгье! гэж д'Артаньян эргэлзэхийн эрхгүй шударга байртай дуугарав.

-За сайн. Танд би итгэж байна. Та янз нь сайнаас сайн залуу бололтой. Таны үнэнч зүтгэлээс таны ирээдүй шалтгаалах байж ч мэдэх юмаа.

-Танаас би амлалт шаардалгүй, зүгээр ванд хүчин зүтгэж, хатантанд таалагдахын тулд би сайн санааны үүднээс хүч хүрэх бүхнээ хийнээ. Намайг нөхрөө гэж итгээд зарж үз гэж д'Артаньян өчив.

-Гэтэл энэ зуур та намайг хаана нууж байлгах вэ?

-Та өөрөө түр хоргодож байгаад, де Порт гуай тань дээр ирж болохоор тийм айл өөрт чинь үгүй юу?

-Үгүй, энэ хэрэгт би хэнийг' ч оролцуулахыг хүсэхгүй байна. -За байз. Бид Атосын байрны дэргэд ирчихээд байна. Тиймээ, яриагүй,

-Атос гэж хэн бэ?. -Миний нэг нөхөр.

-Үгүй тэр хүн гэртээ байж байгаад намайг харчихвал яана?

-Тэр одоо гэртээ байхгүй. Тэднийд таныг оруулчхаад түлхүүрийг нь би биендээ аваад явчихнаа.

-Аа эзэн өөрөө хүрээд ирвэл яах вэ?

-Тэр одоо эргэж ирэхгүй. Яахав ирдэгюмаа гэвэл, намайг бүсгүй хүн дагуулж ирсэн. Тэр бүсгүй өөрийнд нь байгаа гэж хэлнэ биз.

-Үгүй энэ чинь миний нэрэнд тун их хор болж болно шүү та ойлгож байна уу? -Танд ямар ялгаа байгаа юм бэ?

Тэнд таныг таних хүн ганц ч байхгүй. Тэгээд ч бид одоо ихэс дээдсийн ёсгоримыг дагахтай мантай байдалд орчхоод; байна шүү дээ.

-За тэгье Танай найзынд оръё. Тэр чинь хаа суудаг юм дээ?

-Феру гудамжинд, эндээс хэдхэн алхам газарт.

-За явья.

Тэгээд тэр хоёр цаашаа яаран гүйлээ. д'Артаньяны таасанчлан Атос гэртээ байсангүй. д'Артаньяныг Атосын нөхөр болохоор түлхүүрийг нь үг дуугүй өгдөг юмбайж Тэд шатаар дээшээ гарч бидний дээр ярьж байсан нөгөө жижиг байранд Бонасье авгайг оруулав. -Гэртээ л байгаа км шиг байгаарай, байзнаа, үүдээ дотроос нь түгжиж орхи, ингэж гурав тогшихоос нааш хэнд ч бүү тайлж өгөөрэй, гээд д'Артаньян гурав дахин тогшихдоо хоёр дахин даруй даруй зэгсэн чанга тогшсоноо жаахан азнасхийгээд нэг сулавтар тогшиж үзүүлэв. -За тэгье,

Одоо миний танд чинь юм захих ээлж боллоо гэж Бонасье авгай хэлэв. -Таны үгийг сонсож байна.

Лувр руу очоод Эжель гудамж руу харсан хаалгыг цохиод Жермен гэгч хүнийг асуу. -За Тэгээд цаашаа?

-Жермен гарч ирээд таны юу гэж явааг асууна бий. Тэхлээр хариу хэлэхийн оронд "Тур ба Брюссель" гэдэг хоёр үг хэлээрэй. Тэхийн хамт Жермен таны хэлсэн бүхнийг бүтээж өгнө. - Би түүнд юу гэж хэлэх юм дээ?

-Хатантны шадар бараа бологч де ла Порт гуайг дуудаж аль гээрэй.

-Жермен очиж дуудаад, де Ла Порт гарч ирэхээр?

-Гараад ирэхээр нь наашаа явуулчхаарай.

-Их сайн. Харин тантай өөртэй чинь би хаана хэзээ дахин уулзах вэ?

-Танд надтай дахиад уулзмаар байна уу?

-Тэгэлгүй яахав?

-Тэгвэл би энэ тухай бодож үзье. Санаа бүү зовоорой.

-Би таны үгэнд найдлаа.

-Найдаж болноо.

Бонасье авгай өөд д'Артаньян гүнээ хайрласан харцаар жижигхэн биеий нь хамран хараад, мэхийн ёслов. Тэгээд шатаар доошоо бууж явахад нь хаалга хаагдаж цоожинд түлхүүр хоёр дахин эргэх чимээ гарлаа. д'Артаньян нүд ирмэхийн зуур Лувр руу гүйж хүрээд, ордны Эжель гудамж руу харсан хаалган дээр очиход арван цаг цохиж байх дуулдав. Сая бидний тодорхойлж бичсэн энэ бүх явдал ердөө хагас цагийн дотор болж өнгөрсөн ажээ.

Юм бүхэн, Бонасье авгайн хэлсэнчлэн боллоо. Нууц болзоот үгийг дуулаад Жермен мэхийн ёслов. Арван минут болоогүй байхад де ла Порт, хаалгачны өрөөнд орж ирэв. Болсон явдлыг д'Артаньян түүнд хэдхэн үгээр хэлж өгөөд, Бонасье авгайн байгаа газрыг зааж өгөв. Ла Порт гуай хаягийг сайн цээжилж аваад яаран одов. Тэгснээ хоёр алхалгүй даруй буцаж ирээд, - Залуу хүн танд би нэг зөвлөгөө өгөх үү гэж д'Артаньянд хэлэв.

-Ямар зөвлөгөө вэ?

-Энэ хэрэг танд гай чирч магад юм.

-Та тэгж санаж байна уу?

-Тиймээ. Цаг нь хожимдож яваа найз хүн танд үгүй биз?

-Тэгээд юу гэж?

-Хожим есөн цаг хагаст тэднийд таныг байсан гэж гэрчлүүлэхийн тулд тэр, хуулийн хүмүүс үүнийг "алиби" гэдэг юм.

д'Артаньян энэ зөвлөгөөг зохистойд үзээд де Тревиль гуайн руу хар хурдаараа гүйв. Гэхдээ хэзээд олон хүнтэй байдаг зочдын өрөөнд оролгүйгээр даамлын ажлын өрөөнд орох зөвшөөрөл гуйв. д'Артаньян энд байн байн ирдэг болохоор зарц, түүнийг даруй тийш нь оруулаад, нутгий нь залуу ирж, өөрт нь нэг чухаг юм дуулгахын тулд уулзъя гэж байгааг де Тревиль гуайд айлтгахаар явлаа. Таван минут хир болоод де Тревиль гуай өрөөнд орж ирээд д'Артаньянд юугаар дус болж чадах, юу гэж өдий орой болсон хойно ирсэн учры нь асуув.

Ганцаараа үлдсэн үеэ ашиглаад, цагны зүүг гурван мөч ухрааж амжсан д'Артаньян үүнд, - Уучлаарай эрхэм ээ, есөн цаг хорин таван минут сая болж байхад танд дээр ирэхэд тийм ч орой биш байх гэж би санасан юм гэв.

-Есөн цаг, хорин таван минут гэнээ? гэж деТревиль гуай дуу алдаад ханын цаг өөд эргэж харав. Үгүй арай ийм байлтай гүйсэн гэв.

-Та өөрөө хар л даа. Тийм л байна гэж д'Артаньян хэлэв.

-Нээрээ тийм байна, арай орой болчихсон л гэж би бодоод байсан шүү. За тэгээд танд юу хэрэгтэй болоо вэ?

Тэхлээр нь д'Артаньянхатагтайн тухай яриа урсгаж гарлаа. Хатны одооны байдалд сэтгэл зовж байгаагаа хэлээд, Бекингэмийг эсрэг хамбын зохиосон арга залины талаар дуулсан юмаа ярилаа. Энэ юмаа хүн аргагүй үнэмшихүйц тайван ярьсанд де Тревиль үнэмшихээс өөр яах билээ. Тэгээд, ван хамба хатан гурвын харилцаа сүүлийн үед нэг жигтэй болчихоод байгааг де Тревиль гуай ажаад байсныгбид дээр цухуйлгасан шүүдээ.

Арван цаг цохихоор д'Артаньян де Тревиль гуайнхаас явах болж цаадах нь ийм юм дуулгасанд нь талархаад, ван хатан хоёрын төлөө ямагт үнэнч шударга зүтгэж явахыг зөвлөөд зочдынхоо өрөөнд эргэж ордоо.

д'Артаньян шатаар бууж явгал таягаа мартсанаа гэнэт санасан хүн болж эргэж дээш гараад, цагийн буруу явааг маргааш нь хүн мэдүүзэй гэж зүүгий нь бушуухан ухраав. Ингээд өөрий нь гэгийг лав гэрчлэх хүнтэй боллоо гэж, доош бууж, гадагш гарлаа.

XI. ХЭРЭГ БУДЛИАН ЛАВШИРЛАА

Де Тревиль гуайнаас гараад д'Артаньян бодолд автан хамгийн тойруу замаар гэр өөдөө харьж явлаа.

Гаскон нутгийн залуу, замаасаа өдий хазайчихаад од мичид өөд нэг харж нэг инээвхийлж нэг санаа алдсаар юу бодож явсан юм бол?

Мань хүн Бонасье авгайг бодож явлаа. Шадар цэргийн сурагч залууд энэ бүсгүй бараг л янаг сэтгэл булаах гуа сайхан дээд шиг санагдана. Царайлаг, бөөн нууц дотроо агуулсан, ордны бараг хамаг л хэрэг будлианыг мэдэж байдгийн улмаас хөөрхөн царайнд нь сэтгэл зовонгуйрсны нэг онцлог шинж илэрсэн тэрбүсгүй нэг их халгаахгүй хүн ч биш шиг санагдана. Янаг дурлалын хэрэгт туршлага багатай хүний нүдэнд энэ нь бүсгүй хүнийг улам ч дур булаам болгодог билээ. Үүнээс гадна нэгжих аягүй бол тамлахаар завдаж байсан шуламнуудын гараас д'Артаньян булааж гаргасан болохоор мартагдашгүй энэ тус бүсгүй дотор цаашаа гүнзгийрхүйеэ маш хялбархан, талархлын сэтгэлэг төрүүлсэн билээ.

Хүний хүслэн, мөрөөдлийн жигүүр цаглашгүй хурдан байдаг болохоор залуу бүсгүй явуулсан хүн өөдөөс гараад ирж яваа, хүрч ирээд уулзаж учрах болзсон зурвас өгөөд алтан гинж юм уу доржпалам шигтгэсэн бөгж бас явуулсныг өгч байх нь д'Артаньянд дүрслэгдэн бодогдох аж. Тэр цагийн залуус эзэн вангаасаа бэлэг хүлээж авахдаа зовдоггүй байсныг бид дээр ярьсан. Хэтэрхий хатуу биш зан суртахуунтай тэр цагт залуус мөн амрагуудаасаа тэгтэл их нэрэлхдэггүй байсныг бас нэмээд дуулгачихья. Тэдний амраг бүсгүйчүүл хийсвэр сэтгэлий нь бөх бат билгээр уяж тогтоохыг эрмэлзсэн юм шиг үнэт, урт удаан эдлэгдэх юм дурсган өгцгөөдөг байсан аж.

Тэр цагт бүсгүйчүүлийн тусламжтайгаар замаа засаад түүндээ зовдоггүй байсан юм. Ердөө л гуа сайхан төрсөн бүсгүйчүүл гуа сайхнаа л амрагтаа өгнө “хамгийн гуа сайхан охин ч гэлээ, байгаагаас илүү юу өгөх вэ” гэдэг үг эндээс гарсан байж болох. Баян бүсгүйчүүд мөнгө хөрөнгөөсөө амрагтаа өгдөг байв. Адал явдал элбэг байсан тэр цагийн баатрууд дундаас амрагийнхаа ганзагалуулж өгсөн дүүрэн дунд хавтгагүйсэн болжгэм тулалдааны талбар дээр ч дийлж явахааргүй, хэргэм ямба ч олохооргүй хүн олон байсан гэж болноо. д'Артаньян ядуу хүн байлаа. Хөдөө нутгийн хүний зоримог биш зан уулын бөх бат биш арилхуйяа хялбархан зүйл болохоор гурван шадар цэргээс нөхөртөө өгдөг зан суртахууны хувьд их өндөр гэгдэхээргүй өдий төдий зөвлөлгөөний ачаар даруй ор мөргүй болчихсон аж. Тэр цагийнхаа хачин заншлыг дагаж д'Артаньян Парис хотноо байхдаа өөрийгөө бараг байлдан дагуулчихсан хотноо байгаа хүн шиг санах аж. Ухаан нь фландрийд байгаа юм шиг, тэнд болж гэм Испаничууд байх юм биз, энд болж гэм бүсгүйчүүл байна гэх жишээтэй. Тэнд ч гэлээ, энд ч гэлээ ялгаагүй тэмцэлдвэл зохих, дийлсэнхойноо татвар төлөөс ноогдуулбал зохих дайсан байх аж.

Хэдий тийм гэлээ ч д'Артаньянд одоо илүү сайхан өгөөмөр сэтгэл төрж байгааг хэлэх хэрэгтэй. Наймаачин өөрийгөө хөрөнгөтэй гэж байсан үнэн. Бонасье гуай шиг тийм цагаахан нөхөртэй айлд мөнгө сэлт эхнэрийн гартбайж таарахыг д'Артаньян тааварлахад бэрхтэй байв. Гэвч эд бүгд цөм Бонасье авгайг үзээд д'Артаньянд төрсөн сэтгэлд нь ер нөлөөлсөнгүй,

залуугийн зүрхнээ дүрэлзэн байгаа хайр дурлалд элдэв ашиг завшаан хичээх муу бодол бараг харш аж. Би “бараг” гэлээ, юу гэвэл юутай сайхан, эелдэг найрсаг цэцэн цэлмэг, тэгээд ч бас баян бүсгүй тухай мөрөөдөхөд сэтгэл татагдахад саад болно гэж үгүй, харин ч улам ихэсгэх билээ. Гуа үзэсгэлэндээ аятайхан зохицдог язгууртны элдэв аар саар юмс баян чинээлгээс хамаардаг юм.

Өнгө үзэмж төгс нарийн сайхан оймс, сүлжмэл зах хээнцэр дэгжин гутал, үсэнд зүүсэн гоё тууз сэлт нийлээд муухай бүсгүйг хөөрхөн болгочих нь үгүй л биз. Тэгэхдээ царайлаг бүсгүйг гуа сайхан болгоно. Тэгээд ч бас чинээлэг байдлаас болж бүсгүй хүний гар сайхан байдгийг яриагүй байна шүү. Бүсгүй хүний гар сайхнаараа байна гэдэг чинь ажил хийхгүй байна гэсэн үг. Үүнээс гадна д'Артаньяны мөнгө хөрөнгөний байдлыг бид уншигчдаас нуугаагүй болохоор д'Артаньян цаглашгүй баян чинээлэг хүн биш гэдгийг мэднэ. Өөрөө нэгэн цагт баян болно гэж горьддог нь үнэнтэй боловч, тийм аятай өөрчлөлт ирэх цагийг өөрөө холоос холд тооцдог билээ. Одоохондоо бол хайртай бүсгүй маань өчнөө төчнөөн аар саар юмтай байхсан гэж мөрөөддөг байхы нь үзсээр байж, тэр өдий төдий аар саархан юмы нь аваад өгчих боломжгүй байх гэдэг мөн ч шаналгаатайяа. Бүсгүй өөрөө баян бол бүстэйгийнхээ бэлэглэж болох, өөртөө хэрэгцээтэй юмыг ядаж өөрөө худалдаад авчина шүү дээ.

Тэр аар саар юмыг бүсгүйчүүл нөхрийнхөө мөнгөөр ихэвчлэн авах боловч, тэглээ гээд нөхөртөө баярлах нь ховор

Бүсгүйн халуун дотно янаг нь болохыг мөрөөдөж яваа д'Артаньян үнэнч сайн нөхөр хэвээр аж. Хамаг сэтгэл санаа нь гуа Бонасье авгай дээр явчихаад байгаа хэдий боловч мань хүн нөхдөө мартсангүй. Атос, Портос, Арамис гурвыг дагуулчихаад Сен-Денийн талбар юм уу Сен-Жерменийн захаар Бонасье авгайтай цуг зугаалбал эр хүнд аятайхан л байх бүсгүй. Ийм бүсгүй сэтгэлийг татаж чадсанаараа мань хүнд цаадуулынхаа өмнө гайхуулсхийхээс буцахгүй аж. Цаашаа удтал зугаалбал хоол идэх дур хүрнэ. Сүүлийн үед д'Артаньян үүнийг ажиг болов. Тэгвэл цаг цагт сайхан наргиан хийж, нөхдийнхөө гартай гар нийлэн, амрагийнхаа хөлтэй хөлөө нийлүүлэн сууж, хоол иднэ. Эцэст нь аргацаах нөхцөлгүй болсон хүнд цагт д'Артаньян өөрөө нөхдөө бэрхшээлээс гаргаж байх болно.

Үгүй, өнөөх Бонасье гуай яах вэ? д'Артаньян өөрөө ил муулж хуягуудын гарт барьж өгөөд аварч тусална гэж өөрийн нь шивэгнэсэн тэр хүний яахав? Бид уншигчиддаа үнэнийг хэлэхээс өөр яахав, д'Артаньян тэр хүний тухай бүр марчихжээ, хааяа санахдаа ч гэсэн тэр хүнийг хаа байгаа тэр газраа л байх болтугай гэж бодно. Хүний элдэв шунал дотроо хамгийн хар амиа хичээхэд хүргэдэг нь дурлал даг.

Гэхдээ манай уншигч вагай нар бүү санаа зов, д'Артаньян байрныхаа эзнийг мартчихсан, аль хаашаа аваад явчихсаны мэдэхгүй гэдэг нэрийдлээр мартчихсан дүр үзүүлж байгаа юм гэхэд бид түүнийг мартаагүй хаа байгаагийг нь мэдэж байгаа. Гэхдээ одоохондоо дурлалд автсан гаскон залуу дууриаж, эрхэмсэг наймаачны тухай хожим эргэж ярья.

Дурлалын санаашралд автсан д'Артаньян шөнийн тэнгэртэй ярилцаж, од мичид өөд инээмсэглэсээр Шеүш-Миди буюу тэр цагт Шасс-Миди гэдэг байсан гудамжаар өгсөн явлаа. Арамисын гэрийн зэрэгцээ хүрч ирчихээд отлого хийсэн газраар яаран ирж гэж нөхөртөө хэлүүлсний учрыг хэлж өгье гэж бодов. Планшег ирэхэд Арамис гэртээ байсан л бол авсны

гудамж руу яарсан нь магад тэгээдхоёр нөхөртэйгээ дайралдаагүй бол өөр хэнтэй ч дайралдаагүй болохоор эд бүгд ямар учиртайг ойлгоогүй нь лав тэгэхээр юу гэж дуудсан учраа найздаа хэлэх хэрэгтэй гэж д. Артаньян амандаа үглэж явжээ. Сэтгэлийнхээ гүнд бол д'Артаньян үүнийг зүрх сэтгэлий нь биш юмаа гэхэд ухаан санаагийн нь бүрэн эзэмдчихээд байгаа Бонасье авгайн тухай ярих аятайханшалтаг гэж үзжээ. Анх дурлаж байгаа хүнээс амаа барьж чаддаг байхыг шаардахын хэрэггүй билээ. Анхны дурлал хүнд багтаж ядсан их баяр баясгалан авчирдаг болохоор гадагш гаргаж ярихгүй юм бол дотроо багтаж шингэдэггүй билээ.

Парис хотноо харанхуй болохоор нэгэнт арван хоёр цаг хир өнгөрчихсөн гудамжаар хүн амьтан бараг үзэгдэхгүй болж байв. Сен-жерменийхавийн цагууд цөм арван нэг цохичихлоо. Нам гүм, дулаан аятай ажээ.

д'Артаньян одоогийн Ассаа гудамж байгаа тэр газраар явж байлаа. Вожирар гудамжин дахь цэцэрлэг оройн хяруу шөнийн сэрүүнд сэргэн анхилах сайхан үнэрий нь салхин агаараар түгээжээ. Нэгэнт гуанзны газар наргиж байгаа хүмүүсийн дуулах нь цонхны хаалтан цаанаас бүдэг боловч дуулдсаар байна. Гудамжны булан хүрээд д'Артаньян зүүн тийшээ эргэв. Арамисын суудаг байшин, Кассет, Сервандони хоёр гудамжны дунд байдаг юм байна. д'Артаньяны нэгэнт Кассет гудамж өнгөрөөд, найзынхаа гэрийн үүдний бараа харахтай боллоо. Үүдний өмнүүр ургасан агч модны мөчрийг зэрлэг усан үзэм өтгөнөөр ороон ургаж ногоон хөшиг болсон билээ. Гэнэт Сервандони гудамжны зүгээс нэг сүүдэр сүүмэлзээд гарч ирэх шиг д'Артаньянд санагдлаа. Тэр хүн нөмрөгтэй байсан болохоор эхлээд эрэгтэй хүн шиг санагдсанаа, гэвч намхан нуруу, цэмцгэр алхаахөдөлгөөн сэлт нь бүсгүй хүн болохыг даруй илчлээд өгөв. Өөрийн нь эрж байгаа байшин мөн эсэхийг эргэлзэн байх шиг хаа байгаагаа эргэцүүлж дээшээ хараад зогсосхийж хэдэн алхам ухарснаа дахин урагшаа явлаа. д'Артаньян үүнд шохоорхов. “Энэ бүсгүйд тус больё гэх юм бил үү? Алхаж гишгэхий нь харвал залуу бүсгүй болтой, царайлагч байж мэднэ. Бололгүй яахав. Гэтэл өдий орой гудамжаар ганцаараа гүйж явдаг бүсгүй ганцхан л болзоот амрагтайгаар уулзахаар яваа байж таарна. Чөтгөр алгад! “хүний болзоонд саад болно гэдэг чинь хүнтэй танилцах адгийн арга даа”” гэж д. Артаньян бодов. Энэ зуур залуу бүсгүй байшин цонхыг тоолсоор урагшаа явна. Гэхдээ үүнд төдий их цаг орж, төвөг удаад байх юмгүй аж. Гудамжны тэртээ талд дөнгөж гурван байшин байгаагаас, хоёрхон цонх наашаа харна. Хоёр цонхны нэг нь Арамисын суудаг байшинтай залгаж барьсан жижиг дайвар барилганы цонх, нөгөөх нь Арамисын өрөөний цонх билээ.

Номч хүний зээ бүсгүйн тухай гэнэт санаанд нь орсон д'Артаньян “Бурхан минь, энэ оройтсон хонгор, манай найзын гэрийг эрж байгаа бол бас их хөгтэй байх юмсан, тийм болж таарна гэж толгойгоо тавьж мөрийцмөөр байна. За Арамис найз минь энэ удаа би үнэн мөнийг олж мэднээ гэж одов.

Тэгээд д'Артаньян аль болох бараагүй болохыг хичээж нэгэн доголд тавьсан чулуун сандлын хажуудах хамгийн харанхуй буланд нуугдав.

Залуу бүсгүйн наашаа ойртсоор. Залуу юм гэдэг нь одоо нэгэнт эргэлзээгүй боллоо. Залуу хүн болохы нь бараг илчлээд өгч байгаа алхаанаас нь гадна дуу нь бас бариад өглөө. Юу гэвэл бүсгүй ханиалгаад орхисонд цангинасан залуу дуутай хүн болохы нь д'Артаньян мэдээд авлаа. Мөн энэ ханиад урьдаас болзсон дохио байх гэж түүнд бодогдов.

Тэр дохионд нь мөн тэгж хариулсан юм уу аль ирэх ёстой газраа ирснийг бүсгүй өөрөө гаднын тусламжгүйгээр эцэстээ мэдсэн юмуу, юу ч гэсэн Арамисын цонх руу шийдмэг дөхөж очоод цонхны тавиурыг хуруугаараа гурав дахин жигд зайтай тогшив.

За тэгнээ тэр, энэ бүсгүй Арамисын цонхыг тогшиж байна гээч.

Тийм байдаг бий мэхчинэрхэм. Та буяны ном яаж судалдгий тань би одоо мэддэг боллоо гэж д. Артаньян шивэгнэв.

Бүсгүй тогшоод орхихын хамт дотоод цонх нээгдэж гэрэл гялсхийв.

-Уухай, бүсгүйн ирэхийг хүлээж байж гээч. Цонхны хаалт одоо нээгдээд бүсгүйг дотогш нь өргөөд авна даа. Догь оо гэж үүдний дэргэд биш ч гэсэн хонхны дэргэд сэм чагнаж байсан мань хүн дуугарав.

Гэтэл цонхны онгойхгүй хэвээр байхыг үзээд д'Артаньян маш гайхав. Гялсхийсэн гэрэлгүй болчихоод дахин хав харанхуй болчихлоо. Энэ чигээрээ удахгүй гэж бодсон д'Артаньян нүд чих тависаар зогсоно.

Түүний санасан зөв болжээ. Төдхөн цонхны дотор талаас хоёр удаа огцом цохих дуулдлаа. Гудамжинд зогсож байсан залуу бүсгүй хариуд нь нэг удаа цохисонд хаалт нээгдэв. д'Артаньяны хир их шуналтай харж чагнаж зогссоныг хэлээд яах вэ.

Гай болоход гэрлээ өөр өрөөнд оруулчихсан аж. Гэвч залуугийн нүд харанхуйд дасчихсан тэгээд одоо ч бас гаскон хүний нүд муурынхтай адил харанхуйд сайн хардаг гэлцдэг билээ. Залуу бүсгүй халааснаасаа боодолтой цагаан юм гаргаад даруйзадлахыг д'Артаньян харлаа. Тэр нь алчуур байв.

Алчуураа дэлгээд, ярилцаж байгаа цаад хүндээ өнцгий нь үзүүлэв.

Бонасье авгайн хөлийн дэргэдээс олоход, Арамисын унагасан нөгөө алчуурыг санагдуулсан тэр алчуур д'Артаньяны санаанд ороод орхив.

-Энэ алчуур ер нь ямар учиртай юм бэ чөтгөр алгад. Гаскон залуугийн зогсож байсан тэр газраас Арамисын царай харагдаж өгөхгүй цонхны дор зогсож байгаа бүсгүйтэй Арамис ярьж байгаа гэдэгт мань хүн огтхон ч эргэлзсэнгүй. Хэрэгт дурлах нь болгоомжлох сэтгэлээ дийлээд, хоёр хүний алчуур үзэж байх зайг ашиглан мань хүн нуугдсан газраасаа гараад эгшин зуур гудамжийг чимээгүй гүйж гараад, Арамисын өрөөний гүнийг харж болохтой газар очиж хананд наалдан зогсов.

Шөнө оройтож ирсэн бүсгүйтэй Арамис биш өөр нэг бүсгүй ярилцаж байхыг д'Артаньян цонхоор хараад гайхсандаа золтой л дуу алдчихсангүй. Мань хүн харанхуйд бүсгүй хүний бие байрыг харж чадахтай боловч, царайгий нь харж чадсангүй нь харамсалтай.

Энэ үеэр өрөөнд байсан бүсгүй хармаанаасаа өөр алчуур гаргаад авсан алчуурныхоо оронд өгөв. Ингээд хоёр бүсгүй хэдэн үг солилцсоноо салж явлаа. Сүүлд нь цонхны хаалтхаагдав.

Гудамжинд зогсож байсан бүсгүй эргээд д. Артаньянаас гурав дөрвөн алхмын зайтай өнгөрөхдөө нөмрөгнийхөө юүдэнгээр нүүрээ халхаллаа. Гэвч ингэж болгоомжилсон нь хожимдож д'Артаньян Бонасье авгай байхыг таньчихав.

Бонасье авгай байнаа! Түрүүн хармаанаасаа алчуур гаргаад ирэхийн хамт мөн байх гэдэг хар төрж байсан. Гэхдээ де Порт гуайн хойноос явуулсан, түүнтэй цуг Луврордонд буцаж очих ёстой Бонасье авгай шөнийн арван нэгэн цаг хагаст дахин хулгайлагдахаас айхгүй гудамжаар гүйж явах гэгч даанч санаанд багтмааргүйеэ.

Ингэхлээр лав нэг их чухаг юмны тулд ингэж яваа байх нээ. Хорин таван настай бүсгүйд дурлалаас өөр чухаг юм байдаг билээ.

Гэхдээ өөрийнхөө төлөө юу, өөр бусад хүний төлөө ийм аюултай юманд яваа нь энэ үү? д'Артаньян ийм юм өөрөөсөө асууж явлаа. Хэзээ язааны янаг сэтгэлийн холбоотой хүн шиг хардах муу сэтгэл зүрхий нь базална.

Гэхдээ Бонасье авгайн хаашаа ингэтэл яарч байгааг мэдэж болох амархаан арга байв. Хойноос нь мөрдөх хэрэгтэй байлаа. Энэ уул нь энгийн хялбар арга болохоор д'Артаньянолон ч юм бодолгүй мөрдөхөөр шийдэв.

Хананы завсраас хөшөө гараад ирж байгаа юм шиг гараад ирсэн залуугийн барааг харж, хөлий нь чимээг сонсмогцоо Бонасье авгай дуу тавиад зугатаачихав.

д'Артаньян хойноос нь хөөлөө. Урт өргөн хувцсандаа орооцолдож яваа бүсгүйг гүйцэх гэдэг д'Артаньянд юухан байхав. Тэр бүсгүйг эргэж зугатаасан гудамжныхаа гуравны нэгэн хувийг өнгөрч амжаагүй байтал нь гүйцэж авлаа. Хөөрхий бүсгүй цуцсандаа биш, айсандаа бүр тэнхээ нь тасраад д'Артаньяныг мөрөн дээр нь гараа тавихын үед өрөөсөн өвдөг дээрхээ сөхрөн ойчоод бөглөрсөн дуугаар:

-Намайг албал ал? яасан ч би юм хэлэхгүй хүн гэж дуу алдав.

д'Артаньян бүсгүйг өргөж тэврэв. Гэвч бүсгүйг гардээрээ тэгнэж байхыг үзээд ухаан алдахад холгүй байгаагий нь ойлгож өөрт нь үнэнч сайнаа хэлж даруй тайвшруулахыг яарлаа. Гэвч үнэнч сайн гэх төдийгөөр Бонасье авгайг тайтгаруулах аргагүй байлаа, юу гэвэл хамгийн муухай хар санаа өвөрлөөд ийм юм ярьж болох билээ. Гэхдээ энэ үгийг ярьж байгаа дуу тэр дуу л их чухаг учиртай болов. Энэ дуу нэг танил юм шиг залуу бүсгүйд санагдаад, нүдээ нээж өөрийгөө тэгтэл их айлгасан хүний өөдөөс харвал д'Артаньян мөнийг таниад баярласандаа дуу алдан:

-Ээ энэ чинь та юу? Бурханы ач аврал гэхэд нь

-Тиймээ, би байна.

Таныг харж хамгаал гэж бурхны илгээсэн хүн би байна гэж д'Артаньян хэлэв.

-Тэгээд л та миний хойноос дагаа юм бий дээ? гэж зугаатай хошин зан нь нэгэнт хөдөлж

ирсэн залуу бүсгүй залирхуу инээмсэглэн асуув. Дайсан гэж санасан хүнийг нөхрөө байхы нь таниад айхаа бүр болилоо.

-Үгүй, Үгүй танд үнэнээ хэлье, хар аяндаа би таны зам дээр дайралдчихлаа.

-Манай нэг нөхрийн цонхыг бүсгүй хүн ирж цохихыг би хараад... Гэж д'Артаньяныг ярьтал Бонасье авгай үгий нь таслав, таны нөхөр гэнээ гэв.

-Тэгэлгүй яахав. Арамис чинь миний хамгийн дотно нөхдийн нэг байхгүй юу

-Арамис гэнээ? Тэр чинь хэн бэ?

-За боль доо. Та над Арамисыг танихгүй гэж мэтгэх нь үү?

-Энэ нэрийг би одоо л сонсож байна.

-Тэгвэл та энэ байшинд анх удаа ирж байгаа байх нь ээ

-Тэгэлгүй яахав

-Энэ байшинд нэг залуу хүн суудгийг та тэгээд мэдэхгүй байх нь ээ?

-Үгүй

-Шадар цэргийг үү?

-Үгүй гэм, үгүй

-Тэгэхээр та түүнийг эрж ирээгүй байх нээ?

-Үгүй байлгүй яахав. Намайг бүсгүй хүнтэй ярилцаж байхыг та өөрөө хараа биз дээ

-Тэр үнээн. Тэр бүсгүй тэгэхээр Арамисын найз байх нь ээ?

-Мэдэхгүй

-Тэднийд л байдаг хойно?

-Тэр над хамаагүй хэрэг

-Үгүй тэрбүсгүй тэгээд хэн юм бэ?

-Өө, энэ чинь миний хувийн нууц биш

-Хонгор Бонасье авгай та дур булаам сайхан бүсгүй мөртөө бөөн нууц агуулсан...

-Үүнээс болж би доордлоо гэж үү?

Үгүй та харин ч улам дур булаам байх юм

-Тэгвэл би таны гар дээр тулья

-Дуртай. За одоо?...

-Одоо намайг хүргэж өг

-Хааш нь?

-Миний очиж яваа газар өөд

-Үгүй та хаашаа явж байгаа юм дээ?

-Та намайг үүдэнд нь хүргэж өгөх болохоор өөрөө үзнээ

-Таны хүлээх хэрэг байх уу?

-Тэр дэмий.

-Тэгвэл та ганцаараа буцахгүй байх нээ?

-Тийм ч байж болно. Үгүй чбайж болно.

-Гэхдээ таныг хүргэж өгөх тэр хүн эрэгтэй хүн байх уу, бүсгүй хүн байх уу?

-Одоогоор мэдэхгүй байна

-Тэгвэл би мэднэ

-Яаж тэр вэ?

-Би хүлээж байгаад хэнтэй гарахы чинь үзнэ

-Тийм боломж гэм одоо хагацъя

-Яаж байгаа нь тэр билээ?

-Та над хэрэггүй.

-Үгүй та өөрөө гуйхдаа...

-Тайж хүний тусламж гуйсан болохоос туршуул муу этгээдийг мөрдөөд өгөөч гээгүй юм.

-Энэ үг чинь дэндүү хатуу байна.

-Хүнийг өөрийн нь хүслийн эсрэг мөрддөг хүнийг юу гэж нэрлэдэг юм.

-Даруу биш хүн гэдэг юм.

-Энэ үг чинь дэндүү зөөлдөж байнаа.

-Яая гэх вэ, авгайтан. Таны бүх хүслэнг биелүүлэхээс өөр замгүй юм байна.

Энэ хүслэнг шууд биелүүлсэн гэгдэх гавьяагаа та юунд баллав.

-Гэмших гэгч мөн гавьяагүй хэрэг юм уу?

-Та нээрээн гэмшиж байна уу?

-Өөрөө ч мэдэхгүй байна. Очих тэр газар чинь хүргэж өгөхийг зөвшөөрөх юм бол хүссэн бүхнийг чиньхийхэд бэлхэн байгаагаа би мэдэж байна.

-Дараа та намайг тэгээд орхино биз?

-Тэгнээ.

-Миний хойноос мөрдөхгүй биз?

-Үгүй.

-Ам өгч байна уу?

-Тайж хүний ёсоор амлаж байна

-За тэгвэл гараа алив. Явцгаая.

д'Артаньян гараа өгч Бонасье авгайг түшээд авгай чичирсээр хэдий боловч инээвэл инээхтэйгээ боллоо. Хоёулаа тэгжявсаар Лагерп гудамжны адаг хүрлээ. Энд ирчихээд залуу бүсгүй түрүүн Божирар гудамжинд очоод эргэлзэж байсан шигээ эргэлзэн байх шиг болов. Тэгснээ зарим юмны баримжаагаар хэрэгтэй хаалгаа таних шиг бололтой. Бонасье авгай тэр үүд рүүгээ очоод:

-За одоо,би ийшээ орноо. Таны өгөөмөр тусалсанд цаглашгүй баярлалаа. Би ганцаараа явсан бол учирч болохтой бүх аюулаас та аварч хамгааллаа. Таны өгсөн амандаа хүрэх цаг аргагүй боллоо доо. Би хэрэгтэй газраа нэгэнт хүрээд ирчихлээ гэв.

-Буцах замдаа танд айх юм ер үгүй юу?

-Хулгайчаас л айх юм биз

-Энэ чинь тэгээд юм биш үү?

-Надаас хулгайч юу авах юм бэ? Би биендээ сохор ч зоосгүй яваа.

-Сүлд хатгамалсан сайхан алчуураа та мартчихаа юу?

-Ямар алчуур?

-Таны хөлийн дор уначихсан байхаар нь би аваад хармаанд чинь хийчихдэг тэр алчуур яагаав.

-Амаа тат, дуугүй байж үз, таминь: аль та намайг хөнөөх гээ юу гэж бүсгүй дуу алдав.

-За тэр шүү. Танд аюул учрахад холгүй хэвээрээ байгаа юм байна. Ганцхан үг хэлээд орхихын хамт л та хэлмэгдэж, энэ үгийг хэн хүн дуулчих юм болж гэм өөрийгөө дүүрлээ гэж байна. Миний үгийг дуулж үздээ авгайтан гэж, д'Артаньян бүсгүйн гарыг шүүрэн авч янагийн халуун харцаар өөдөөс нь ширтэн байж дуу алдаад –Миний үгийг дуул даа, зоволтгүйгээр над итгэж орхи. Зүрх сэтгэл минь өөрт чинь татагдаж орхисныг та миний харцаар мэдсэнгүй гэж үү дээ гэв.

-Над тийм юм шиг санагдана. Миний хувийн нууцын тухай та надаас юм асууж лавлаж болноо, харин бусдын нууцыг бол өөр хэрэг.

-За яахав, тэдний чинь би өөрөө олж мэднээ. Тэр нууцууд таны амьдралд нөлөөлж болохоос хойш би тэднийг мэдэх ёстой гэж д'Артаньян зөрөв.

-Тийм юм хийхээс бурхан таныг авраг-гэж залуу бүсгүйн дуу алдахад, голоосоо хэлмэгдэн түгшсэн дуу гарсан болохоор д'Артаньяны бие эрхгүй зарсхийв. Надад хамаатай юунд ч үл оролцож, өөрийн минь ноогдсон үүргийг биелүүлэхэд тус болох гэж бүү оролд гэдгийг чухалчлан гуйя.

Таны над сайн байдаг тэр сэтгэл, өөрт минь үзүүлсэн, амьд явахын цагт хэзээ ч үл мартагдах их тусы чинь бодож би танаас гуйя.

Миний үгэнд итгэж үз дээ. Миний тухай хойшид бүү бодож яв, намайг ор байхгүй, ерөөсөө уулзаагүй юм шиг л санаж яв.

Бүсгүйн үгэнд эгдүү нь хүрсэн д'Артаньян

-Арамис мөн над шиг тэгж мартаж ёстой байх уу, үгүй юу гэж асуув.

-Эрхэм та энэ нэрийг хоёр, гурван удаа дурслаа. Гэтэл танихгүй юм гэдгээ би өөрт чинь хэлсэн биш билүү.

-Мөөн цонхы нь очиж тогшдог айлынхаа эзнийг та таньдаггүй байнаа. Та намайг дэндүү хийсвэр хүнд тооцож байна.

-Надаас үг дуулах л гэж ийм юм зохиож бас тэр Арамисыг худлаа гаргаж ирсэн биз дээ, үнэнээ хэлчих.

-Би юу ч туршиж, юу ч зохиогоогүй байнаа авгайтан. Би яахын эрхгүй үнэнл юм ярьж байна.

-Танай нэг нөхөр тэр байшинд суудаг гэж та хэлсэн байхаа тэгээд.

-Би тэгж хэлсэн, одоо гуравдахаа хэлж байна. Тэр байшин чинь миний найзын суудаг байшин, тэр найзы маань Арамис гэдэг юм.

-Эд бүгд цаашдаа учир нь олдоно, одоохондоо дуугүй байж үз дээ-Эрхэм минь гэжбүсгүй шивнэв.

-Таны өмнө нээлттэй байгаа зүрх сэтгэлий минь та мэддэгсэн бол энэ хэргийг хир их сонирхож байгаа минь, мөн өөрт чинь яаж цаглашгүй халуун хайртай байгааг минь үзээд хэргийн учрыг над даруй тайлж өгөхсөн дөө. Өөрт чинь ингэтэл хайрлан байгаа хүнээс айж болгоомжлох хэрэг үгүй юм даа.

-Хайр сэтгэлийн тухай тамөн хурдах ярих боллоо-гэж залуу бүсгүй дуугараад, толгой сэгсрэв.

-Хайр сэтгэл над анх төрж байгаа нь энэ. Яах ийхийн зуургүй л төрөх юм байна. Ингэхэд би чинь хорин нас ч хүрээгүй яваа хүн шүү дээ.

Бонасье авгай өөдөөс нь хяламхийв.

-Та миний үгийг дуул даа, би одоо зах зухын мэдлээ.

-Гурван сарын өмнө би яг таны сая Арамисынд байсан бүсгүйд үзүүлсэнтэй чинь ижилхэн мөн тийм сүлдтэй алчуураас болж Арамистай өөртэй нь золтой л тулалдах дөхсөн билээ гэж д'Артаньян хэллээ.

-Та шалгаасаар байгаад намайг бүр залхааж байна шүү эрхэм ээ,гэж залуу бүсгүй дуугарав.

-Үгүй авгайтан, та ийм болгоомжтой хүн. Таныг барьчихаад ийм алчуур биенээс чинь гарвал таныг бариад өгчихгүй гэж үү.

-Яагаад тэр вэ. Миний өөрийн нэрний толгой биш гэж үү “К.Б” гэдэг чинь Констанция Бонасье байхгүй юу.

-Эсвэл, Камилла де Буа-Траси ч гэж байж болноо.

-Амаа тат, эрхэм ээ, дуугүй байж үз.

Над учирч байгаа аюулыг юманд боддоггүй юм гэхэд өөртөө тулгарч байгаа гай уршгийн тухай бодож үзээч.

-Над уу.

-Тиймээ танд. Надтай танилцсанаас болж та шорон гянданд орж, амиа алдаж ч мэднээ.

-Тийм юм бол би одоо танаас ер холдохгүй.

-Эрхэм ээ, эр цэргийн хүний цэх шударга, тайж хүний өгөөмөр, сайхан сэтгэлээ гаргаж үзээч, явж үз дээ. Дуулж байна уу. Шөнийн арван хоёр цаг цохиж байна. Энэ үеэр намайг энд

хүлээж байгаа юм гэж залуу бүсгүй гуа гараа базална.

д'Артаньян мэхэсхийгээд

-Надаас ийм янзаар гутсан юманд би үгүй гэж чаддаггүй хүн юм, авгайтан минь, тайвширч үз, би явлаа гэв.

-Та миний хойноос дагахгүй, намайг мөрдөхгүй биз.

-Би даруйхан гэртээ харилаа.

-Ээ, таныг шударга сайн залуу гэж би мэдэж байсан юмаа гэж Бонасье авгай дуу алдаад нэг гараа залуу өөд сунгах зуур нөгөө гараар чулуун ханад гаргасан жижигхэн үүдний цуургыг авлаа. д'Артаньян сунгасан гары нь шүүрч аваад халуунаас үнсэв.

-Тантайер уулзаагүй нь дээр юмсанж гэж мань залуу алдав.

Ингэж түс тас хэлчихсэн үгнээс хүний сэтгэлийн цаана наанахыг мэдэж болдог, хайр сэтгэл нь оюун ухаанаасаа давж байгаа нь харагддаг болохоор бүсгүйчүүлд энэ нь эелдэг нандин үгнээс илүү таалагдах нь олонтой байдаг.

Бонасье авгай өөрий нь гарыг ч тавилгүй байсаар байсан д'Артаньяны гарыг атгаад бараг энхрийлсэн дуугаар үгүй би тэгж хэлж чадахгүй. Өнөөдөр бүтээгүй юм хожим бүтэж мэднэ.

-Нэгэн цагт би чөлөөтэй болчихоод таны сонирхож байгаа хэргийн учрыг тайлж өгч болохтой болохыг хэн мэдэх вэ...гэлээ.

-Минийхайр сэтгэл мөн тийм цаг ирэхийг горилон хүлээж болох тэгээд? гэж баярлаж хөөрсөн залуу дуу алдаад

-Еэ, энэ талаар ч би ам өгөхийг хүсэхгүй байна. Таны надад төрүүлж чадах сэтгэлээс л энэ чинь хамаарах юм.

-Тэгвэл одоохондоо авгайтан...

-Одоохондоо эрхэм минь над зөвхөн л ач санах сэтгэлэг төрөөд байна.

-Та даанч хөөрхөн хонгор юм даа миний хайр сэтгэлтэйг та ашиглан хөөрхийдүүлж байна гэж д'Артаньян уйтгарлангуй дуугарав.

-Үгүй, эрхэм минь ердөө л таны шударга журамтайг би ашиглаж байна. Гэхдээ, амласан юмаа марталгүй байж чаддаг хүн бас байдаг юм шүү нээрээ.

-Еэ та намайг үхэх үйлтний дундаас хамгийн жаргалтай нь болголоо. Энэ оройг, сая өгсөн амаа бүү мартаж үзээрэй.

-Бүү зов. Цагий нь ирэхээр би бүгдийг санана. Одоо явж үз, буян бодоод явж үз дээ. Намайг

бүр яг арван хоёр цагт хүлээж байгаа би бүр хождоод байна.

-Ердөө л таван минут

-Тодорхой нөхцөл байдалд таван минут гэгч таван зуун жилтэй дүйцэжбайдаг.

-Хайрлаж дурлаж байгаа цагт уу.

-Үүнийг тэгээд. Хайрлаж, дурлаж байгаа хүний хэрэг явдал биш гэж хэн танд хэлчихэв.

-Таныг эрэгтэй хүн хүлээж байгаа юм байна. Лав эрэгтэй хүн гэж

д'Артаньян дуу алдав.

-За тэр, бидний маргаан дахиад л эхнээсээ аваад гарч ирлээ гэж дуугараад Бонасье авгай инээвхийлэхэд, тэсч ядсан байдал бас илэрхий.

-Үгүй, үгүй, би явлаа, явлаа, үнэнч сайн байдагт минь таныг итгээсэй гэж би хүсэх юм, үнэнч сайн байх гээд бараг тэнэг юм хийх гэж байгаа хэдий гэлээ ч тэр. Баяртай авгайтан баяртай. Бүсгүйн гарыг мань хүн албаар л эс бол тавих чадалгүй болчихсон юм шиг гэнэт цаашаа ухасхийн зугатаачихлаа. Энэ зуур Бонасье авгай үүдний тогшуурыг авч түрүүн цонх тогшсон шигээ гурав дахин жигд алгуурхан тогшив.

д'Артаньян гудамжны булан гүйж хүрээд эргэж харахд үүд онгойгоод, хаагдаж амжаад жижиг барааны наймаачны хөөрхөн эхнэр нэгэнт үгүй болчихжээ.

д'Артаньян цаашаа явлаа. Бонасье авгайн хойноос мөрдөхгүй гэж амласан, тэгэхээр авгайн чухам хаашаа явсныг мэдэх юм уу, хэнтэй цуг явахы нь мэдсэнээс амь нас нь шалтгаацах байлаа ч гэсэн ялгаагүй, гэртээ харина л гэж ам өгснөөс хойш харих хүн байлаа.

Таван минут ч болоогүй байхад мань хүн авсны гудамжинд хүрч ирлээ.

-“Хөөрхий Атос! Эд бүгд юун учиртайг тэр лав мэдэхгүй дээ. Маньхүн намайг хүлээж хүлээж нойрсож байгаа юу, аль гэррүүгээ очоод гэрт нь бүсгүй хүн байсныг мэдсэн болов уу. Атосынд бүсгүй хүн байсан гэдэг догио! Үгүй ингэхэд Арамисынд бүсгүй хүн байж л байсан шүү дээ. Эд бүгд тун жигтэй, эд бүгд яаж дуусдаг бол, мэдэх юмсан”

-Муу байнаа, эрхэм ээ муу байнагэх дуу гарахад Планшегийн дуу гэж д'Артаньян танив. Юманд хэт их санаа зовсон улсын зангаар д'Артаньян ганцаараа яанга ярьсаар яваад өөрийн рүүгээ өгсдөг шатны өмнөх үүдээр ороод ирчихсэн байжээ.

-Юу муу гэж! Чи юу хэлэх гээ вэ, тэнэг минь? Энд юу болчихоо вэ гэж д'Артаньян асуув.

-Элдэв гайболоод байна.

-Ямар

-Нэгд, Атос гуайг барьж аваад явчихсан.

-Барьж авсаан. Атосыг барьсан гэнээ? Яалаа гэж?

-Манайд байхад нь тааралдаад таныг гэж андуурсан.

-Хэн түүнийг баривчилсан бэ?

-Хуягууд. Таны нөгөө хөөгөөд явуулчихдаг хар хувцастай улс тэр хуягуудыг дуудсан байна билээ.

-Үгүй, Атос юунд нэрээ хэлсэнгүй вэ, тэр хэрэгт ямар ч хамаагүйгээ юунд хэлж өгсөнгүй вэ?

-Тэр ерясан ч тэгэхгүй байсан дагаа, эрхэм ээ. Тэгэхийн оронд Атос гуай над руу дөхөж ирээд “Одоо би сул байснаас, танай эзэн сул байх нь чухаг байгаа юм. Тэр чинь бүгдийг мэдэж байхад би юу ч мэдэхгүй. Яахав. Түүнийг бариад авчихсан гэж бодож байг, энэ түүнд юмаа хийх завшаан олгоно. Хоёр гурав хоноодби эдэнд хэн болохоо хэлнэ, тэгээд намайг суллахаас өөр эд яахав” гэж шивэгнэсэн.

-Сайн байна, Атос өгөөмөр сайхан сэтгэлт хүн гэж д'Артаньян шивэгнээд тэр чинь чухам л ийм юм хийхээр хүн дээ. Хуягууд тэгээд яав? Гэвэл,

-Дөрөв нь Атос гуайг аваад, Бастили гяндан юм уу, Фор-Левек гяндан хоёрыналин руу явсныг бүү мэд. Хоёр нь нөгөө хар хувцастай улсуудтай үлдээд, тэд нар хамаг бичиг цаасыг чинь онгичиж, цөмий нь аваад явчихсан. Бас хоёр нь энэ үеэр гадаа үүд манаж байсан, дараа нь байры маань цөлмөж дууссан хойноо үүд дэлгэж хаяад цөм явчихсан.

-Портос, Арамис хоёр?

-Намайг очиход байгаагүй, наашаач ирээгүй.

-Үгүй тэд чинь юу юугүй наашаа хүрээд ирж мэднэ. Миний хэлснийг хэлээрэй гэж захисан биз.

-Тэгсээн эрхэм ээ.

-За сайн. Тэгвэл энд, байсандаа байж бай. тэднийг ирвэл юу юу болсныг ярьж өгөөрэй. Тэд намайг “нарсны боргоцой шогшгой” гэгч гуанзанд очиж хүлээг. Энд байх гэдэг тэдэнд халтай болж мэднэ. Манайхыг одоо тагнаж байж болох юм. Би гүйж де Тревиль гуайнд очиж ямар хэрэг гарсныг дуулгаад тэдний хойноос тэр гуанз өөд очъё, гэлээ.

-Сонслоо, эрхэм ээ гэж Планше өчив

-д'Артаньян эргэж ирээд, тэгэхдээ чи энд байх уу? Хулчийхгүй биз? гэж зарцаа жаал зориг оруулах санаатай асуулаа.

Планше өөдөөс нь бүү зов эрхэм ээ. Та намайг бас сайн мэдэхгүй байнаа даа. Дураа хүрвэл

би зоригтой ч байж чаддаг хүн, нээр шүү. Дур хүрэх гэдэг л хамаг учир байгаа юм. Түүнээс гадна би Пикарди нутгийн хүн.

-За тэгвэл, шийдлээ шив.

Чи байраа хаяад явснаас алагдсан нь дээр гэх юм байгаа биз, гэж д'Артаньян хэлэв.

-Тэгнээ, эрхэм ээ. Эзэндээ хир их үнэнч сайнаа үзүүлэхийн тулд над хийж үл чадах тийм юм гэж ер үгүй.

“Догио! Энэ хүүгийн хувьд миний хэрэглэсэн арга тохиров бололтой. Энэ аргы чинь хэрэгтэй цагт хэрэглэх байх юм байна” гэж д'Артаньян бодов.

Тэгээд д'Артаньян өдөржин гүйж зэгсэн ихядарсан хөлнийхөө чадлын хирээр хуучин Тагтаат гэгч гудамж өөд ярав.

Де Тревиль гуай гэртээ байсангүй. Суман нь луврт харуулд гараад даамал өөрөө сумантайгаа цуг ордонд байгаа аж.

Юу боловч Тревиль гуайтай уулзаж, болсон хэрэг явдлын тухай түүнд дуулгах хэрэгтэй байв. д'Артаньян лувр ордноо нэвтрэх арга сүвэгчилж үзэхээр шийдлээ. Дезассар гуайн сумангийн торгон цэргийн жагсаал, хувцас, ороход тус болох ёстой байв.

д'Артаньян гараад Пти-Огюстен гудамжаар орж цаашаа шинэ гүүрээр гарах санаатай голын эрэг даган явлаа. Ус гатлагч завийг ашиглах санаа төрөөд эрэг рүү нэгэнт буучихсан хойноо гараа санамсаргүй халаасандаа хийтэл завьчинд төлчихөөр юм юу ч үгүй байв. Цаашаагаа Генего гудамж хүрч явталгэнэт Дофина гудамжны булангаар тойроод гарч ирж яваа хүмүүс харагдлаа. Гарч ирсэн эрэгтэй эмэгтэй хоёр хүн д'Артаньянд нэг л хачин санагдлаа. Бүсгүйн бие байдал Бонасье авгайг санагдуулж, эрэгтэй нь Арамистай тун адилхан харагдаад болж өгөхгүй.

Тэгээд ч бүсгүй нь бас хар нөмрөгтэй тэр нь нөгөө Вожирар гудамжин дахь цонхны наана мөн Лагарп гэгч гудамжин дахь үүдний өмнө Бонасье авгайн мөрөн дээр байж нүдэнд хоногшсон өнөө нөмрөгтэй яг адил аж.

Эрэгтэй хүн нь шадарцэргийн хувцастай юм.

Бүсгүй нөмрөгнийхөө юүдэнгээр нүүрээ халхалж эрэгтэй нь алчуураар нүүрээ таглажээ. Ийнхүү болгоомжилсныг үзвэл энэ хоёр хүн танигдахгүйг хичээсэн нь илт.

Тэр хоёр хүн гүүрээр гарлаа. д'Артаньян ч лувр очих гэж явсан болохоор тэдний хойноос тийшээ явалгүй яахав.

Цаашаа арав ч алхаагүй байтал бүсгүй нь Бонасье авгай, эрэгтэй нь Арамис мөн гэдэгт д'Артаньян эргэлзэх боллоо.

Тэгэхийн хамт жөтөөрхөх сэтгэлийн харгайгаар төрж байсан бүх сэжиг дотор нь даруй

сэргээд ирэв.

Нөхөртөө хууртаж, мөн нэгэнт амрагаа гэж үзэж явсан бүсгүйдээ хууртжээ.

Бонасье авгай бурхан шүтээн барьж ирээд л Арамисыг мэддэггүй гэж андгайлаад байсан. Гэтэл мөч өнгөрөөгүй шахуу байхад Арамистай хөтөлцчихөөд яваа тааралдаж байдаг. Наймаачин хүний хөөрхөн эхнэртэй дөнгөж гуравхан цагийн өмнө танилцсан, авгай өөрий нь нөгөө отож, хулгайлахаар завдаж байсан улсын гараас гаргаж авсанд ач санахаас өөр хамаарах талгүй, амалж хэлсэн юм юу ч үгүй гэдгийг д'Артаньян эргэцүүлж чадсан ч үгүй. Өөрийгөө хууртан доромжлогдож, элэг доог бариулсан амрагт тооцлоо. Уур хилэн нь буцлан, нүүр нь халуу оргиод ирэв. Мань хүн үнэн мөнийг олж мэдэхээр шийдэв.

Залуу бүсгүй, тэр хүн хоёр араасаа нэг хүн дагаж, мөрдөж явахыг мэдээд алхаагаа хурдасгав. д'Артаньян бараг гүйх шахам явж тэднээс түрүүлж гарснаа, нэг баримлын дэргэд асаатай, гүүрний тэрхэн хавиа гэрэлтүүлэх дэнгийн хажуугаар тэр хоёрыг өнгөрөх үед эргэж өөдөөс нь тулгарав.

д'Артаньян тэдний замыг хөндөлсөн зогссонд цаад хоёр нь аргагүй зогсов.

-Та яах гээ вэ эрхэм ээ? гэж бүсгүйтэй цуг явсан шадар цэрэг гэдрэг алхам ухрангаа асуув. Тэр хүний харийн аялгуугаар ярихыг сонсоод д'Артаньян нэг таавар нь худал болсныг мэдээд,

-Арамис биш байна! гэж дуу алдав.

-Үгүй, эрхэм ээ Арамис биш. Таны дуу алдахыг үзвэл та намайг өөр хүнтэй андуурсан бололтой, тийм болохоор би уучилъя.

-Та намайг уучиллаа гэнээ?

-Тиймээ. Надад тухайлсан хэрэг танд үгүйгээс хойш бид одоо явья даа гэж тэр хүн хэлэв. д'Артаньян үүнд, Таны зөвөө, эрхэм ээ. Танд тухайлсан хэрэг над байхгүй. Гэхдээ тантай цуг яваа бүсгүйн хувьд над бас хэрэг байна гэлээ.

-Миний цуг яваа бүсгүйд үү? Та энэ бүсгүйг танихгүй гэж тэр хүн гайхан дуугарав.

-Эрхэм та эндүүрч байна. Энэ бүсгүйг би таньдаг юм. Бонасье авгайн үүнд зэмлэх байртай, Үгүй та над эр цэргийн хүн, тайж хүний хувиар ам өгсөнбиш билүү. Таны үнэнч шударгад би итгэж болохтой хүн гэж миний бодсоныг яана гэж хэллээ.

-Аа та өөрөө...та...та өөрөө над ам өгсөн шүү дээ... гэж д'Артаньян зовсхийн дуугарлаа.

-Авгайтан миний гарыг түш. Цаашаа явьяа гэж харийн хүн хэллээ.

Самгардаж алмайрсан д'Артаньян гараа элгэндээ зөрүүлээд Бонасье авгайхамт яваа хүн хоёры өмнө зогссон хэвээр.

Шадар цэрэг урагшаа алхаж, д'Артаньяныг түлхэн зайлуулчихлаа.

д'Артаньян гэдрэгээ үсрээд суга татсанд, харийн хүн мөн илдээ гялсхийн суга татлаа. Бонасье авгай тэдний хоорондуур гүйж орон илднээс шүүрч аваад –Буян бодож больж үз. Милорд гуай гэж дуу тавилаа.

Эгшин зуур санаа авсан д'Артаньян мөн,

-Милорд гэнээ! гэж дуу алдаад,Милорд ..уучилна уу эрхмээ...үгүй тэгээд та ингэж...

-Милорд, Бекингэм герцог гэж Бонасье авгай залууд шивнээд,та одоо биднийг цөм хөнөөж болох нь дзээ гэв.

-Милорд, авгайтан та ч гэсэн намайг уучилж үз дээ. Би авгайтанд сэтгэлтэй болохоор жөтөөрхөөд энэ хайр сэтгэл гэгч ямар байдгийг Милорд та өөрөө мэднэ газар. Намайг уучилж үз, тэгээд таны төлөө над амиа өгч болохоор хэрэг байхгүй юу, хэлж өгөөч.

Герцог үүнд д'Артаньяны өөдөө гараа сунгасанд цаадах нь хүндэтгэнгүйгээр гар барилцав. Та шударга сайн залуу байна. Над тус больё гэж та хэллээ. Тэгж үз. Биднийг лувр хүргэж өг, бидний хойноос мөрдөжяваа хүн харагдвал тийм хүнийг үгүй хийгээрэй.

Илдээ сугалж барьсан д'Артаньян, Бонасье авгайг хамт яваа хүнтэй нь хориод алхам хиртэй түрүүлүүлээд, араас нь дагаж, нэгдүгээр Карл вангийн шударга журам, хээнцэр сайдын туншаалыг ёсчлон дагахад бэлэн явлаа.

Аз болоход, үнэнч зүтгэлээ хэрэг дээр илчлэх учрал энэ орой залуу баатарт маань тохиолдсонгүй, залуу бүсгүй бараа сүртэй шадар цэрэгтэй цуг гай түгшүүр дайралдалгүй явсаар лувр ордон хүрч, Эшель гудамж руу харсан хаалгаар орж явчихлаа. д'Артаньян ч яахав. “Нарсны боргоцой” гэгч гуанзны газар хүлээж байгаа Портос, Арамис хоёр өөд яарлаа. Ямар тухай тэдэнд төвөг удсанаа тайлбарлалгүйгээр, зөвхөн өөрсдийн нь тусламж шаардаж болмоор санагдсан тэр хэргээ өөрөө хийчиж чадлаа л гэж нөхөддөө дуулгав.

Манай яриаг сонирхож байгаа уншигчид маань гурван нөхөд одоо гэр гэртээ харьцгаана л биз, бид Бекингэм герцог залуу бүсгүй хоёрын хойноос ордны гудмаар дагацгаая. Милорд гэж Английн хэргэмтнийг өргөмжлөн дуудах үг. Ноёнтон гэсэн утгатай.

ХИ. ДЖОРЖ ВИЛЛЬЕРС БЕКИНГЭМ ГЕРЦОГИЙН ТУХАЙ

Бонасье авгай, герцог хоёронцын төвөггүй ордонд нэвтэрлээ.

Бонасье авгайг вангийн хатны бараа бологч хүн гэж улс танина, герцог өөрөө, тэр өдөр ордонд харуултай байсан гэж бидний дээр дурссан де Тревиль гуайн сумангийн цэргийн хувцастай байлаа. Ер нь Жермен бол хатанганд сохроор итгэж, үнэнч сайн байдаг болохоор ямар нэг юм боллоо ч гэсэн Бонасье авгайг ламрагаа луврт дагуулж ирлээ гэж зэмлээд өнгөрөхсөн билээ. Бонасье авгай яахав гэм бурууг хүлээгээд өнгөрнө. Бүсгүй сайн нэрээ алдах нь мэдээж боловч, энэ хорвоогийн эрхтэн дархтны нүдэнд өчүүхэн нэг наймаачин хүний эхнэрийн нэр яахин юман чинээ санагдах билээ. Бонасье авгай, герцог хоёр ордонд орсон хойно чулуун хашаа дагаж жаал явлаа. Тэгснээ Бонасье авгай өдөр онгорхой, шөнө голдуу цоожтой байдаг, ажилтай улсын орж гарах жижиг хаалгыг түлхэв. Үүд онгойж, тэр хоёр орлоо. Тэнд лав харанхуй байсан боловч ордонд ажил хийдэг улсад гаргаж өгсөн, ордны тэр хэсгийн ордог гардаг бүх газрыг Бонасье авгай андахгүй аж. Орсон үүдээ сайн хаачихаад, герцогийн гараас хөтөлж харанхуйд тэмтэрсээр хэд алхсанаашатны бариул олж бариад, хөлөөрөө гишгүүрий нь тэмтрээд дээшээ өгсөж гарлаа. Герцог, бүсгүйн араас дагана. Өгссөөр гуравдугаар давхар хүрлээ. Тэндээс Бонасье авгай баруун тийшээ эргэж хамт яваа хүнээ урт гудмаар дагуулж гараад, дахин нэг давхар доошоо буулаа. Цаашаа хэд алхаад нэг өрөөний цоожийг тайлж шөнийн дэнгийн бүдэг гэрэлтэй нэг өрөөнд герцогийгоруулчихаад,

-Милорд, герцог та энд хүлээзнэж үз. Одоохон морилж ирнээ, гэж бүсгүй шивнэв. Ингэж хэлээд орж ирсэн хаалгаараа, гарч, гаднаас нь цоожилчихсонд герцог гуай ёстой л нэг баригдчихсан хүн гэгч боллоо.

Бекингэм герцог хэдий цор ганцаараа үлдчихсэн боловч айх сэтгэл төрөөгүйг хэлүүштэй. Тэр хүний зан авирын нэг гойд тал гэвэл аливаадал эрж, романтик юм бүхэнд дурладаг билээ. Эр зориг авхаалж самбаатай эн хүн иймэрхүү байдалд аминдаа халтай юм хийж байгаа нь ганц энэ бишээ. Өөрийн нь Парис руу яаран ирэхэд хүргэсэн Австрийн Анна хатны захидал хуурмаг, өөрий нь занганд оруулах зорилгоор бичигдсэн болохыг нэгэнт мэдчихсэн байлаа. Гэтэл даруй Лондондоо буцахын оронд, учирсанэнэ завшааныг ашиглаж хатагтайтай уулзахаас нааш Лондондоо буцахгүй гэж хэлүүлсэн аж. Хатагтай эхний үед эрс татгалзаж байснаа эцэстээ тэгж татгалзсанд герцог цөхөрч, бухимдахдаа ямар нэг болчимгүй хэрэг төвөг гаргачих бий гэж болгоомжлоод, даруй буцаж харь гэж өөрөөс нь гуйхын тулд бараалхуулахаар болсон юм байж. Ингэж шийдсэн орой нь герцог руу очоод дагуулж ирэх даалгавартай байсан Бонасье авгайг хулгайлаад явчихсан байлаа. Бүсгүй юунд өртсөнийг хоёр өдрийн туршид мэдсэн хүн гэж ер үгүй, түр түдгэлзэсхийгээд байж байлаа. Бонасье авгай дөнгөж мултарч гараад, де ла Порт гуайтай уулзахын хамт ажил хэрэг дахин хөдөлж хулгайлагдаагүйсэн бол гурав хоногийн өмнө бүтээх байсан аюулт даалгавраа тэр бүсгүй гүйцэтгэж амжлаа.

Герцог ганцаараа үлдээд толь руу очиж үзвэлшадар цэргийн хувцас өөрт нь их зохисон аж. Гучин таван настай энэ хүн англи, Франц хоёрын аль алины ихэс дундаас хамгийн царайлаг сайхан, дэгжин хээнцэр гэгддэг нь аргагүй юмаа.

Хоёр ванд талтай, цаглашгүй баян чинээлэг, өөрийнхөө л дураар нэг үймээн дэгдээж, нэг тайвршуулж байдаг улс орондоо хэмжээгүй их эрх мэдэлтэй, Бекингэм герцог Жорже Вилльерс үлгэр туужинд гардгийн адил, зуун жил өнгөрсний дараа ч билээ хойч үеийнхэнд гайхагдахаар сайхан амьдарч байлаа.

Өөртөө итгэж, эрх мэдэлдээ эрдсэн, бусдыг захиран дагуулагч хууль ёсон өөрт нь үл хамаарах зүйл гэж лавтай үздэг тэр хүн санасандаа хүрэх гэж, бусад хүн бол санаж ч үл зүрхлэх тийм өндөр, хүрч гүйцэлдэшгүй санаандаа ч гэлээ хүрэхийг л шууд эрмэлздэг аж. Эд бүгд мөн нийлээд хүрч ойртохын эрхгүй өндөр дээд, гуа үзэсгэлэнт Австрийн Анна хатагтайтай уулзах, уулзаад өөрийнхөө өнгө үзэмжээр хатагтайн сэтгэлийг татан хайр сэтгэлтэй болгох зориг хүслэн герцогт төрүүлсэн юм байж.

За тэгээд Жорже Вилльерс толины өмнө очиж зогссоныг бид дурссан,

Шадар цэргийн бүрх малгайнд ялимгүй дарагдчихсан сайхан шаргал үсээ засаж, сахлаа имрээд, удтал хүлээсэн минут ойртож байгаад сэтгэж ханаж, баярлан тэнийсэн герцог толинд байгаа дүрс өөдөө бахдал, найдвар төгс инээмсэглэсээр зогсоно.

Яг энэ үеэр, хананы гоёлоор нууцлагдсан үүд нээгдэж, бүсгүй хүн ороод ирэхийг герцог толинд хартал, хатагтай мөнийг үзээд дуу алдав.

Австрийн Анна хатан тэр цагт хорин зургаа, долоон настай, гуа үзэсгэлэн ид бүрдэж явсан цаг нь.

Алхах гишгэх нь хүртэл аргагүй хатан хүн дагина шиг гуа сайхны туйл болсон маргад эрдэнийн өнгөт нүд нь усгал зөөлөн мөртөө ихэмсэг сүртэй.

Жижиг шүрэн улаан уруулны үзэмж сайхныг, ялихгүй цорвойсон доод уруул нь хүртэл бууруулж чадахаагүй, инээмсэглэхдээ дур булаам сайхнаас гадна гүнээ басамжлангуй ярьвайж бас чадах аж. Ер нь Австри вюангийн угсааныхан ийм доод уруул нь цорвогордуу байдаг билээ. Анна хатны бие булбарай, зөөлнөөрөө цуутай, гар, мөр, сэлтний нь гуалиг сайхныг гаргаж хэлэхүйеэ бэрх, тэр цагийн хамаг шүлэг дуучдын магтаал бахдал болж байжээ. Бас залуу багад нь цайвар байгаад яваандаа харлаж яваа дэгжин засаж, яоихгүй тавьж янзалсан үс хатагтайн царайнд зохисныг хэлээд яана. Хичнээн ч жархай нүдтэй, өөч хүн байлаа гэсэн хатагтайн царай ийм хэтэрхий өнгөлөг биш, хамар нь арай нарийн гуа л байгаасай гэх байсан уу гэхээс өөр юу ч хэл чадахааргүй гуа юмаа.

Гялбаж орхисон Бекингэм герцог эгшин зуур алмайрчихав. Урьд найр цэнгэл, баяр наргианы цагт Анна хатагтай одоо жирийн цагаан торгон хувцастай орж ирээд байгаа шигээ ерийн гуа сайхан санагдаж байгаагүй аж. Хатагтайг Эстефани авгай дагалдаж явлаа. Хатагтай бараа бологч испани авхайчуул дундааж вангийн жөтөөрхөл, Ришелье хамбын хар арга явуулгын золиос болоогүй үлдсэн ганц хүн энэ бүсгүй юм байна.

Анна хатагтай герцогийн өөдөөс нэг алхам дөхлөө. Бекингэм, хатагтайн хөлөнд сөхрөн ойчоод, харж амжихаас нь өмнө хатагтайн хувцасны хормойг авч үнсэв.

-Герцог оо тэр захидлыг би хэлж бичүүлээгүй гэдгийг та мэдсэн шүү дээ.

-Тэгсэн хатагтай, тэгсэн их эзэгтэй минь гэж герцог дуу алдав. Цас мөснөөс илч гарч , гантиг чулууг амилах юм шиг санасан би нээрээ тэнэг мангуу хүн юмаа. Яая гэх вэ?, хайр сэтгэлтэй болохоор, хүний хариу хайр сэтгэлд даанч амархан итгэх юм байна шүү. Тэгээд ч таныг л нүдэндээ нэгэнт олж харснаас хойш би наашаа дэмий явсангүй.

-Тиймээ, гэхдээ яагаад тантай уулзахыг зөвшөөрсний учрыг та мэднэ биз. тачухам миний элдэв зовлонг хайхардаггүй хүн болохоороо энэ хотноос явж өгөхгүй зөрөөд байлаа. Энд байгаад байх гэдэг, таны аминд халтай, миний шударга нэр төрд халтай билээ. Бид хоёрыг гүн далай, хоёр гүрний дайсагнал, өргөсөн ариун тангараг, юм бүхэн тусгаарлаж байна. Үүнийг өөрт чинь хэлье гэж уулзахыг би зөвшөөрсөн юм. Эд бүгдийн эсрэгтэмцэнэ гэгч нүглээ. Милорд, цаашаа бид дахин уулзалдах ёсгүй гэдгийг танд хэлэх гэж би өөртэй чинь уулзъя гэсэн юм.

-Яриад байгаач, юм яриач хатагтай, таны уяхан сайхан дуу хэлсэн үгний чинь хагуу ширүүнийг зөөлрүүлэх юм. Нүгэл гэж та ярилаа. Бурхнаас нэг нөгөөд нь заяаж төрүүлсэн хоёр сэтгэлийг хагацаах гэдэг мөн нүгэлшүү гэж Бекингэм дуугарав.

-Милорд! Таны хайр сэтгэлтэй гэж би ер дуугараагүйг та мартчихсан бололтой,гэж хатан дуу алдав.

-Үгүй над дур сэтгэлгүй ч гэсэн та ер хэлээгүй шүү. Нээрээ тэгж хэлэх гэдэг нь эзэгтэй таны зүгээс үнэхээр хүний мөсгүй хэрэг байхсаан. Хагацаж холдоод цаг улираад, итгэж горьдох юмгүй мөртөө үлбуурч буцдаггүй, минийх шиг ийм хайр сэтгэл та хаанаас олох вэ, хэл л дээ. Таны амнаас санамсаргүй гарсан үгийг дуулаад унагаачихсан туузыг тань олж авадаа, бодол болсон харцы чинь харахын төдийгөөр ханаж баясаж явдаг ийм сэтгэл хаана байх вэ? Хатагтай таныг анх харсан цагаас одоо гурван жил болоод байна, танд өдий халуун хайр сэтгэлтэй болсоор одоо дүнхийсэн гурван жил болж байна. Анх таныг үзэхэд ямар хувцастай явсныг тань одоо хэлэх үү? Тэр ч байтугай таны өмсч байсан хувцасны эмжээр, гоёлт сэлтийг би нэгд нэггүй санаад хэлэх үү? Таны тэхэд байсан чинь миний санаанд ив илхэн ургаж байна. Та испани нутгийн заншлаар олбогон дээр сууж байсан, та ногоон пүүсүүгээр хийсэн, алт мөнгөн хатгамалтай, бошинз өмссөн, урт өргөн ханцуйгаа тохойноосоо дээш шамлаж, гуа сайхан гараа ил гаргаад байсан. Таны энэ гайхам сайхан гар ил гарчихсан, ханцуй чинь том алмас чулуун товчоор торгоостой байсан. Хүзүүгээрээ нэхмэл алчуур боосон, толгой дээрээ та даашинзныхаа өнгөтэй жижиг малгай өмсч, малгай дээр чиньцахлай шувууны өд хатгаатай байсан, үгүй нээрээ шүү, нүдээ анихад л таны тэхэд байсан дүр байдал ургаад ирэх юм. Нүдээ нээхээр одоогийн чинь байгаа шиг, үгүй одоо та улам ч зуу дахин гуа сайхан байна.

Өөрий нь уул байдлыг зүрхэндээ өдий нандин хадгалж явдаг герцогт Анна хатагтай уурлаж чадсангүй.

-Юун дэмий тэнэг юм бэ! гэж шивнэв. Ийм юм санан санан сэтгэлээ тэжээх гэдэг юун тэнэг хэрэг вэ? гэв.

-Өөр юугаар би сэтгэлээ тэжээж амьд явах юм бэ? Ингэж дурлахаас өөр юм гэж над байхгүй

юм чинь! Миний хамаг жаргал, хамаг баялаг, хамаг итгэл найдвар ганц энэ л юм чинь. Тантай учирсан, уулзсан бүр маань миний сэтгэлийнхээ гүнд хадгалдаг эрдэнэ юм. Өнөөдрийн энэ уулзалт бол таныг унагаачихаар тань миний түүж авч байгаа дөрөв дэх эрдэнэ юм. Гурван жил болоход хатагтай таныг би ердөө л дөрөвхөн удаа олж харж байгаа юм. Анх дайралдсан тухайгаа би танд ярьсан, дараа нь Шеврез гуайн гэргийнд, гурав дахь удаа Амьенийцэцэрлэгт уулзсан билээ.

Хатагтайн царай улайсхийгээд,

-Тэр үдшийн юмыг герцог та бүү дурсаарай! гэв.

-Үгүй харин түүнийг дахин нэг дурсъя хатагтай! Миний амьдралын ганц баяр, жаргалтай орой тэр юм. Ямар шүү шөнө байсныг та санаж байна уу? Тэнгэр дөлгөөн, аятай сайхан үнэр анхилаад тэнгэрт од түгж гялалзсан, сайхан шөнө байсан. Тэгэхэдтэрхэн зуур хатагтай тантай хоёулханаа үлдэх их завшаан над олдож билээ. Тэгэхэд та өөрийнхөө ганцаардмал байдал, сэтгэл санааны зовлонг над цөмийг ярихад бэлэн байж билээ. Та миний гарыг, яг энэ гарыг түшээд явж... Доошихноо бөхийх бүрдээ таны сайхан үс хахцарт минь хүрч, хүрэх бүрийд миний хамаг бие зарсхийж байсан. Хатагтай хатагтай минь! Тийм нэг агшинд хичнээн их өнөдийн жаргал, диваажингийн цэнгэл агуулагддагийг та мэдэхгүй!... Тийм нэг шөнө, тийм нэг эгшний төлөө би хамаг эрх мэдэл, эд хөрөнгө, нэр төр, цаашдаа амьд явах үлдсэн өдөр хоногоо цөмийг өгөхсөөн. Юу гэвэл тэр шөнө, тэр шөнө та над сайн байсанвмаа, нээр шүү хатагтай.

-Тийм байж болох юмаа, Милорд. Газар орны үзэмж, тэр оройн цаглашгүй сайхан таны харцны нөлөө, ер нь бүсгүй хүнийг хөнөөхийн тулд юм л болбол нийлээд орхидог элдэв бүх нөхцөл тэр орой миний эсрэг нэгдчихээд байсан юм. Гэхдээ Милорд, дийлдэж байсан бүсгүйд хатны хүнд эрх хэргэм тусалж, таныг ердөөл үг цухуйлгаж зүрхэлмэгц таныг ялихгүй задгай зан гаргаж, хариулах хэрэгтэй болохын хамт би бараа бологчдоо дуудсаныг санаж байгаа биз.

-Өөр тэр үнээн. Минийхээс өөр алив хайр сэтгэл байсансан болж гэм ийм шалгаврыг лав даахгүй байхсан. Харин миний хайр сэтгэл үүнийг даваад улам хүчтэй болох, зүрхэнд минь үүд хадагдлаа. Та Парисдаабуцаж ирээд надаас холдож чадсан гэж бодсон байх. Миний эзэн надаад хадгалуулсан тэр их баялгаас надыг салаад ирж чадахгүй юм бодсон байх. Гэхдээ эд баялаг, хорвоогийн хаад, вангууд над ямар пад байх билээ? Долоо ч хоноогүй байхад хатагтай минь, би эргээд ирлээ. Энэ удаа намайг зэмлэх юм юу ч байсангүй. Вангийнхаахайр ивээлийг алдаж, амь насаа үрж болох аюулаас няцалгүй, таныг эгшин зуурч билээ харах л гэж ирсэн, тэгээд би таны гарт ч хүрсэнгүй. Харин миний гэмшиж байгаа хүлцэнгүйг үзээд та уучлав бололтой.

-Гэвч хов живэнд дуртай улс миний гэм буруу оролцоогүй энэ болчимгүй явдлуудыг ашиглаж байна. Миний гэм буруугүйг Герцог та мэднэ шүү дээ. Хамба гуайн өдлөг хатгалгаар ван айхгар хилэгнэсэнд –д.Верне авгайг эндээс холдуулсан, Пютанжийг хөөж орхисон, де Шеврез авгай үүнээс болж дээдсийн хайр ивээлийг алдсан. Таныг Францад элчин сайдаар эргэж ирэх гэхэд ван өөрөө татгалзаад болоогүйг та санаж байгаа бил, Милорд,

-Вангийн тэгж татгалзсаны хариуд франц улс манайтай дайтахад хүрнэдээ. Хатагтай тантай уулзаж учрах арга над алга, яахаа өдөр бүр миний тухай танд дуулдаж байга, Ре арал дээр цэрэг явуулсан, Ларошель хотын тэрслүүдүүдтэй миний холбоо тогтоох гээд байгаагийн үнэн зорилго чухам юу байх гэж та бодож байна... Таныг үзэх горьдлого юм. Парис хотыг дайраад эзэлчихэж чадаагүйгээр би мэдэж байна. Гэвч энэ байлдааны дараа найрамдал тогтох хэрэг болно. Найрамдал тогтооход хэлэлцээ хийх хэрэг гарна, хэлэлцээг манай талаас би хийх болно. Тэгвэл намайг Парис хотноо ирэхэд дургүйцэж чадахгүй, тэгэхээр тантай хурамхан зуур ч болов уулзлаа гэвэл над их жаргал. Миний тэр жаргалын тулд мянга мянган хүний амь үрэгдэх биз. Тантай л уулзвал энэ надад огтхон ч хамаагүй зүйл. Эд бүгд магадгүй цөм болчимгүйдсэн хэрэг байж мэднэ, гэхдээ хайртай бүсгүйдээ над шиг ийм голгүй сайн хүн хаа байнаа, хэлдээ та ямар вангийн хатагтайд надаас илүү үнэнч сайн зарц байна уу?

-Милорд, таны өөрийгөө зөвгөх гэсэн үг, өөрий чинь харин буруутгаж байна. Таны хайр сэтгэлтэйгээ үзүүлэх гэж байгааарга чинь чухамдаа гэмт хэрэг байна, Милорд,

-Ганцхан та өөрөө над хайр сэтгэлгүй болохоор л тэгж санагдаж байгаа юм. Та өөрөө над сайн байсан бол эд бүгд танд өөрөөр санагдах байсансан. Гэхдээ та над сайн... хайртай байсансан болж гэм миний жаргал хэтрээд, би солиорчих байсан биз. Де Шеврез авгай, таны дөнгөж сая дурсаж байсан де Шеврез авгай илүү зөөлөн сэтгэлтэй хүн байж, гол нь тэр авгайд хайртай, авгай мөн хариу сэтгэлтэй байсан. Ийм гүнзгий хайр сэтгэлийг үзээд биеэ барьж дийлэхгүйд хүрсэн Анна хатан,

-Де Шеврез авгай чинь вангийн хатан биш шүү дээ гэж шивнэв.

-Хатагтай та тэгэхээр вангийн хатан байгаагүйсэн болжгэм над сайн байх байжээ. Хэл дээ, сайн байх байсан уу? Таныг зөвхөн хатан нэр төрд баригдан ийм хатуу сэтгэлтэй байгаа юм гэж итгэж болохсон болов уу? Та уул нь де Шеврез авгай байсан бол хөөрхийн Бкнигэм бас горьдлоготой байж болохсон гэж би бодож болох уу? Энэ сайхан үгэнд чинь гялайлаа хатагтай-түм дахин гялайлаа, гуа хатагтай минь!

-Милорд, та миний үгийг арай эндүү ойлгож, гажуу тайлбарлаж байна. Би уул нь хэлэхдээ...

-Больдоо битгий юм хэлж үз эндүүрлээр ийм жаргал над иржээ гэвэл бүү хатуу сэтгэл гаргаж түүнийг залруул даа. Намайг хуурч данганд оруулахаар дуудсан гэж та хэлсэн. Энэ явдал миний аминд халж болж ч мэднээ... сүүлийн үед би нэг хачин л, мөдхөн үхэхээ зөгнөөд байх болж... гэж Герцог хэлээд уйтгарлангуй хир нь сэтгэл татам сайхан инээмсэглэв.

-Өө бурхан минь! гэж Анна хатан дуу алдахад, түүний хэлмэгдэн цочсонбайдал өөрөө герцогт гаднаа харуулах гэж оролддоогоосоо дотроо хир их сайныг нь илчлээд өгчихлөө.

-Таныг айлгая гэж би үүнийг хэлээгүй юмаа, хатагтай. Огт үгүй! Миний саяны хэлдэг нээрээ зүгээр инээдтэй зүйл. Тийм юм зөгнөгдлөө гээд би өчүүхэн ч санаа зовохгүй хүн. Таны амнаас сая гарсан үг, над бараг горьдлого төрүүлсэн энэзүйл хожимдоо над ямар ч гай дайрлаа гэсэн, түүнтэй тэнцэхүйц их жаргал юмаа.

-Одоо би ч гэсэн танд үнэнээ хэлье герцог. Би бас муу дагнаж зүүдлээд байх болсон. Би

таныг шархтай, цусаа гоожуулсаар газар хэвгэж байна гэж зүүдэлсэн гэж Анна дуугарав.

-Зүүн тал руугаа хутгалуулчихсан байгаа биз гэж герцог хажуугааснь хэлэв.

-Харин тийм, зүүн тал руугаа хутгалуулчихсан. Намайг тийм юм зүүдэллээ гэдгийг хэн танд хэлчихдэг билээ? Бурханд залбирахаасаа өөр цагт үүнийг би дурссан удаа ер үгүйсэн.

-Ингээд боллоо, хатагтай. Та над хайртай сайн юм байна. Яриагүй тийм байна.

-Би танд сайн гэж үү? Би юу?

-Тиймээ, та, та, над хайртай сайн байгаагүйсэн болж гэм бурхан та бид хоёрт ижил зүүд өгнө гэж үү? Бидний амьдралыг зүрх сэтгэл минь холбоогүйсэн болж гэм, бидний зөн нэг адил байхсан гэж үү? Хатагтай минь, та над хайртай сайн юмаа. Миний хойноос та харамсаж гашуудах уу?

-Ээ, бурхан минь бурхан минь! гэж Анна хатан дуу алдаад,-үүний чинь би тэсвэрлэж чадашгүй юм байна. Герцог, та буян бодож, намайг орхиод яваач! Танд хайртай сайн юм уу, үгүй юу гэдгээ би мэдэхгүй, ганцхан өргөсөн тангаргаа няцахгүй гэдгээ л би хатуу мэдэж байна. Намайг өрөвдөөд, нутаг орондоо харьж үз дээ! Таныг францад байхад чинь шархдуулчих юм уу, аль та францад байж байгаад амь алдчих юм болж гэм, та над хайртай сайн байснаасаа болоод амиа алдлаа гэдэг өчүүхэн ч сэжиг над төрөхөөр л байх юм бол би тэсвэрлэж чадахгүй солиорчихно шүү. Нутаг орондоо буцаж үз, гуйя, та явж үз!

-Үгүй та одоо юутай гуа сайхан харагдана вэ? Танд би ер хичнээн хайртай юм бэ! гэж Бекингэм дуу алдав.

-Явж үз! Явж үз, гуйя таныг! Хожим та эргээд ирнэ биз. Шадар сайд, элчин сайдын хувиар таныг өмгөөлж хамгаалах үүрэгтэй бараа бологч бие хамгаалагчдаа дагуулаад буцаж ирээрэй. Тэгвэл би таны амь насны төлөө айж бэмбэгнэхгүй, өөрий чинь үзэхдээ баяртай байх болноо.

-Таны хэлж байгаа үг үнэн гэж үү?

-Тиймээ..

-Тэгвэл та намайг уучилж байгаагаа үзүүлж, эд бүгдийг зүгээр зүүдлээд өнгөрөөгүй юм гэдгийг үнэмшүүлж байхуйц өөрийнхөө эдэлж хэрэглэж байсан нэг юм дурсгаж хайрлаач. Өөрийнхөө зүүж явсан, би мөн зүүж явж болохоор нэг бөгж, хүзүүний чимэг гинж.... Тиймэрхүү юм хайрлаач....

-Таны хүсэж байгаа юмыг би өгвөл та нутагтаа харих уу?

-Тэгнэ.

-Даруй юу?

-Тийм

-Францаас явж, Англидаа очно биз?

-Тэгнээ би амлаж байна

-За тэгвэл, азнаж бай.

Анна хатан өрөө рүүгээ орсноо дорхноо өөрийн нь нэрийн толгойг сийлсэн алтан тоногтой улбар модон хайрцаг барьсаар орж ирэв.

-Үүнийг ав, Милорд, аваад намайг дурсан хадгалж яв гэжхатан хэлэв.

Бекингэм герцог хайрцгийг аваад дахин хатагтайн хөлд сөхрөн ойчив.

-Та явна гэж над ам өгсөн шүү, гэж хатан дуугарав.

-Би хэлсэн үгэндээ хүрнээ. Над гараа өг дөө хатагтай, гараа нэг өгчих, тэгээд би явлаа...
Анна хатан гараа сунгахдаа тэнхээ тасрах шахсанаа мэдээд нүдээ аньж нөгөө гараараа Эстефанийг түшив.

Хатны сайхан гарыг Бекингэм шүүрч аваад шуналтайяа озов.

Бекингэм босохдоо,газартэнгэрийг нураахад хүрлээ ч гэсэн тэр, хагас жилээс хэтрэхгүй би дахин хатагтайдаа ирж уулзана гэж дуугарав.

Тэгээд хэлсэн үгэндээ хүрдэг Бекингэм өрөөнөөс яаран гарч одов.

Гудманд түүндтэй Бонасье авгай дайралдаад, түрүүчийнх шигээ болгоомжтой. Чадмагаар лувр ордноос дагуул гаргав.

ХИШ. БОНАСЬЕ ГУАЙ

Энэ бүх хэрэг явдлын үед хүндээс хүнд байдалд нэг хүнийг хайхарсан хүн үгүйг ер уншигчид ажсан байхаа. Сайн эрчүүлийн гавьяа зүтгэл, янаг амрагийн явдлаар элбэг агсан тэр цагт улс төр, янаг амрагийн хэрэг нягт ээдрэлдэж хутгалдсан дайсагналын золиосонд гарсан эрхэм Бонасье гуайг ийнхүү үл хайхарчээ.

Аз болоход, түүнийг марталгүй хараандаа байлгахыг бид амласныг уншигчид чухам санаж байгаа юу үгүй юу.

Түүнийг баривчилсан цагдаанар шууд Бастили гяндан руу аваачиж, тэнд буугаа цэнэглэж зогсоон бүтэн санаа цэргийн өмнүүр бэмбэгнүүлсээр тууж өнгөрөв.

Цаашаа газарт суулгаж барьсан давхрын урт гудамжаар туугдаж явахад нь нөгөө цагдаа нар их муухай аашлан элдвээр хараан зүхсэн гэнэ. Баригдсан хүн тайж угсаатан бишийг цагдаа нар мэдээд, түүнийг адгийг гуйлгачингээс дээргүй үзнэ.

Хагас цаг хир болсны дараа нэг бичээч ирж Бонасье гуайг байцаах өрөөнд аваач гэснээр энэ зовлонгоос гаргасан боловч сэтгэлий нь амраасангүй. Баригдсан улсыг голдуу өрөөнд нь ирж байцаадаг боловч, Бонасье гуайтай ёсорхоод байхын хэрэггүй гэж үзжээ. Золгүй муу наймаачныг хоёр хуяг тууж хашаан дотуур гаргаад, нэг үүдээр оруулсанд, гудманд нь гурван манаач зогсож байв. Тэнд мөн нэг үүд онгойлгоод бөмбөгөр оройтой нэг өрөөнд түлхэн оруулбал, тэнд ширээ сандал хоёроос өөр юу ч үгүй нэг байцаагч сандал дээр суугаад юм бичиж байв.

Хүргэж ирсэн хуягууд гэмтнийг ширээ рүү ойртуул авчраад байцаагчийн зангаснаар цаашаа холдон тэдний үгийг дуулж чадахаагүй зайтай газар очлоо. Байцаагч тэр болтол бичиг шагайн тонгойж сууснаа хэнийгоруулаад ирснийг харах гэж толгойгоо өргөв. Байцаагчийн царай онц эелдэг биш, шонтгор хамартай, шанаа нь айхгар овойсон, нүд нь онигор боловч, хянуур хурц аж. Энэ хүний царай зоримог мөртөө залирхуу шинжтэй. Шүүгчийн хар жанчийн захны цаанаас цухуйсан хүзүү нь урт, толгой нь яст мэлхийн толгой хуяган дороосоо цухуйж байгаатай төстэй ийм тийшээ найгалзана.

Бонасье гуайн нэг овог, эрхэлсэн, ажил газар сэлтийг байцаагч юуны өмнө асуув. Байцаагдаж байгаа хүн үүнд, нэрээ Жак-Мишель Бонасье гэдэг, тавин нэгэн настай, хуучин жижиг барааны мухлаг гаргаж байгаад одоо больчихсон, Авсчны гудамжинд арван нэгдүгээр байшинд суудаг гэж хариулав.

Үүний дараа байцаагч байцаалтаа үргэлжлүүлэхийн оронд улс төрийн явдалд оролцох гэдэг өчүүхэн хүнд учрах аюул гай гамшгийн тухай баахан яриа дэлгэв. Цаашаа мөн хамба гуайн эрх мэдэл хүч чадлын тухай урьдын бүх сайд агсан улсаас ялгаран товойж, хойшид сайд суух улсад үлгэр дууриал болсон тэр хосгүй сайн их сайдын ажил төрөл, эр зоригийг эсэргүүцсэн хэн боловч муугаа үзэх тухай мөн баахан юм ярилаа.

Ийнхүү сэнхрүүлж дуусаад, байцаагч гуай Бонасьегийн өөдөөс бүргэд харцаар ширтэж байж, ямар байдалд орсноо эргэцүүлэн бодохыг сануулав.

Наймаачинд бодож ядаад байх төвөгтэй юм ч байхгүй. Де Порт гуайн садан бүсгүйгээ өөртэй нь суулгая гэж санасан тэр өдөр, ялангуяа эхнэр нь хатны дотуур хувцас сэлтийг хариуцахаар албанаа орсон тэр өдөр цагийг л дотроо харааж байлаа.

Бонасье гуай гол зан чанар гэвэл хар амиа үхтэл хичээж, эд хөрөнгөө нарийлахын дээдээр нарийлдаг, тэгээд ч бас аймхай хулчгар юм байжээ. Залуу гэргийдээ сэтгэлтэй сайн боловч тэр нь саяны дурласан энэ төрөлх чанаруудтай эн зэрэгцэхээргүй дэдэд орох зүйл аж. Өөртөө хэлсэн юмыг Бонасье нарийвчлан бодож үзлээ.

-Ингэхэд эрхэм байцаагч гуай, манай төрийн жолоог барьж бид бүхнээ гийгүүлж байгаа содох гэгээнтний хамаг саныг нь би хэн хэнээс ч илүү ухаарч, үнэлж явдаг хүн билээ, гэж Бонасье гуай тайваан гэгч өчив.

-Тийм гэж үү? За энэ чинь нээрээ тийм юм бол та яагаад Бастилид орчихсон байдаг билээ? гэж байцаагч гуай итгэлгүйхэн асуув.

-Яагаад, чухам юуны төлөө энд орох болсноо өөрөө мэдэхгүй байгаа хүн чинь танд юу ч гэж хэлэхийн арга алга.

-Юу ч гэсэн хамба гуайд л үл таалагдахаар хэргийн учир лав биш байх.

-Таныг улс төрд тэрсэлсэн хэрэгт ял тулгаж байгаа болохоор та заавал нэг хэрэг өдүүлсэн байж таарна даа

-Улс төрд тэрсэлсэн гэнээ? гэж Бонасье айж хэлмэгдсэн дээ хашгираад, улс төрд тэрсэлсэн гэнээ?... үгүй, тэрслүү номтонд дургүй, испанийхныг үзэж чаддаггүй, хөөрхий наймаачин би яаж улс төрд харшилсан байх билээ.

Байцаагч гуай та өөрөө бодоод үз л дээ. Энэ чинь ерөөсөө хүний санаанд багтмааргүй зүйл байна шүү!

Байцаагч онигор нүдээрээ, гэмт хүний дотоод санааг нэвт харж чаддаг юм аятай эгц ширтсээр,

-Бонасье гуай, та эхнэртэй биз дээ? гэж асуув.

Төвөгтэй юм одоо л гарч ирнэ гэдгийг гадарласан наймаачин.

-Тийм ээ эрхэм ээ. Над... би эхнэртэй байсан гэж чичирхийлсэн дуугаар хариулав.

-Юу “байсан” гэж? Танд эхнэр байсан л юм бол та тэгээр эхнэрээ яачихсан хүн бэ?

-Эхнэрий минь хүн хулгайлаад авчихсан.

-Хулгайлаад авчихсан гэнээ? гэж байцаагч лавлаад,

-Тийм бий!

“Тийм бий” гэж байцаагчийн дуугарсан байрнаас, өөрийнхөө хэрэг улам яршигтай болж байгааг Бонасье гадарлалаа.

Байцаагч үгээ залган

-За тэгээд эхнэрий тань хүн хулгайлаад авчихсан байж. Аа чухам ямар хүн авчихсаны нь та өөрөө мэдэх үү?

-Мэдэх юм шиг санагдах юм

-Ямархүн бэ?

-Би юу ч лавтай хэлж чадахгүй, зүгээр л сэжиглэж байгаа гэдгийг байцаагч гуай та анхаарч үзээрэй.

-Та ямар хүнийг сэжиглэж байгаа юм дээ? За илэн далангүй хариулаарай.

Ер юм мэдэхгүй хүн болоод мэлздэг байж уу, аль байдаг бүхнээ тоочоод тавьчих уу, Бонасье гуай тэвдэж орхилоо. Хэрэв таг мэлзээдбайвал, өөрий нь зөндөө их юм мэддэг мөртлөө үнэнээ хэлж зүрхлэхгүй байна гэж хардах бий. Үнэнээ хэлчихвэл өөрийнхө санаа зөвтэй хүн болохыг харуулчих болно. Ингээд бүх юмаа хэлье гэж Бонасье шийдлээ.

-Би нэг хар үстэй, бор царайтай, ихэмсэг байрын харвас ихэс дээдэс хүн бололтой өндөр хүнийг сэжиглээд байгаа юм.

Байцаагч нэг сэрдхийгээд явчих бололтой.

-Тэр хүний нэр?

-Үгүй, нэрий нь би мэдэхгүй юм. Гэхдээ тэр хүнтэй би нүүр учирдаг юмаа гэвэл, мянган хүний дундаас ч гэлээ түүнийг лав танина. Нээрээ шүү.

Байцаагч хөмсгөө зангидав.

-Тэр хүнийг та мянган хүн дундаас ч билээ танин гэв үү.. гэж давган асуулаа. Эс таалагдах юм хэлчихсэнээ Бонасье даруй мэдээд.

-Би уулнь юу... юу л гэх гэсэн юм гэж бувгнав.

-Та түүнийг үзвэл танина гэж хариулсан. За сайн сайна. Өнөөдөртөө ингээд боллоо. Энэ яриагаа цааш үргэлжлүүлэхээс өмнө, таны, эхнэрээ хулгайлсан хүнийг мэдэж байгаагийн чинь зохих хүнд дуулгах хэрэгтэй байна гэж байцаагч хэллээ.

-Хулгайлсан хүний мэдэж байна гэж танд би хэлээгүй шүүдээ. Би бүр шал ондоо юм хэлж байхад..... гэж Бонасье сандран хашгична.

Хоёр хуягт,

-Хэрэгтнийг аваад яв гэж байцаагч тушаав.

-Хааш нь аваачих вэ, үүнийг? гэж бичээч асуув.

-Хорих өрөөнд

-Ямар?

-Үгүй, ямар ч яахав дээ бурхан минь. Бөхөөхөн цоожтой л байвал барлаа гэж байцаагчийн хайш хэрэг дуугарахад, Бонасьегийнүс өрвөсхийгээд явчихлаа.

“Бурхан минь ! Надад бөөн гай дайрлаа! Манай авгай нэг айхтар муухай хэрэг үйлдсэн байх. Намайг хуйвалдсан хүнд тооцож, хамт цээрлүүлэх нь байна. Авгай лав хэргээ хүлээгээд, над хамаг юмаа нуулгүй ярьсан гэж хэлсэн дэгээ. Бүсгүйчүүл гэдэг чинь хулчгар дорой амьтад хойно! Аль дайралдсан өрөөнд хорь гэнэ шүү, та минь! гарцаа байхгүй. Шөнө богино хойно... Маргааш болмогц тэлдэг юм уу, дүүжилдэг ч юм уу! Ээ бурхан минь, намайгаа өрөвдөж үзээч” гэж Бонасье бодно. Ерөөс үглэж гомдлохыг үзэж дөжирсөн хуягууд Бонасье гуайн гомдолж үглэхийг огтхон ч хайхралгүй, хоёр талаас нь сугадаж аваад нэг өрөөнд аваачиж хорьчихлоо. Байцаагч доороо нэг юм яаран бичиж гарлаа. Бичээч хажууд нь хүлээж зогсоно. Тэр шөнө Бонасье нүд аньсангүй. Хоригдсон өрөө дэндүү тохигүйд ч тэр биш сэтгэл их түгшин зовсондоо Бонасье цурам хийж чадсангүй. Шөнөжингөө модон вандан дээр сууж өчүүхэн чимээ гарах бүрийд давхийнэ. Тэгсээр цонхны сараалжаар нар тусч ирэхэд, нар хүртэл нэг баргар болчихсон юм шиг санагджээ.

Гэнэт үүдний түгжээ тайлагдаж байх чимээ сонсоод айсандаа огло харайгаад, өөрийгөө авч цаазны газар хүргэхээр ирсэн байх гэж бодлоо. Тэгсэн чинь, алуурчны оронд өчигдөр байцаагч бичээчтэй хоёулахнаа орж ирэхийг үзээд мань хүн тэднийг хүзүүдэж авах нь холгүй баярлав.

-Хонгор минь, таны хэрэг явдал өчигдрөөс хойш бүр будилж орхилоо. Үнэнээ хэлэхийг л танд зөвлөе. Гэм буруугаа чин үнэнээр хүлээж, гэмшиж гэмээн л та хамба угйан хилэнг намжааж болох юм гэж байцаагч хэлэв.

-Үгүй би бүх юмаа хэлэхэд бэлэн байна шүү. Яахав, юу мэдэж байгаагаа л тэр шүү дээ. Та надаас асууж үз гэж Бонасье дуу алдав.

-Юуны өмнө, эхнэрийнхээ байгаа газрыг хэлчих

-Эхнэрийн маань хүн хулгайлсан гэж би танд хэлсэн биш билүү.

-Тэгсэн. Гэтэл өчигдөр үдээс хойш, эхнэр чинь таны тусламжтайгаар оргочихсон байна.

-Манай эхнэр оргосон гэнээ! гэж Бонасье дуу алдаад, Харласан амьтан! Гэхдээ тэр чинь оргосон нь үнэн болж гэм эрхэм ээ, үнэхээр минхий буруу биш шүү танд тангараглаж хэлье!

-Өчигдөр өдөртэ байшиндаа суусан д'Артаньян дээр юунд орж, юун тухай тэгж удал ярилцаа вэ?

-Тэр чиг үнээн, байцаагч гуай. Би буруугаа хүлээе. Миний алдаа болж. Би гэмшиж байна. Би нээрээ д'Артаньян гуай дээр орсон.

-Яах санаатай та тэднийд орсон юм бэ?

-Миний эхнэрийг эрж олж өгөхийг гуйх гэж. Би уул нь эхнэрээ олж авах эрхтэй юм санасан юм. Янз нь би андуурсан бололтой, тэгэхээр өршөөлийг гуйя.

-д'Артаньян танд юу гэсэн бэ?

-д'Артаньян гуай над тусалж өгье л гэсэн. Гэвч миний эсрэг хорон муу санаа агуулж байсан нь дороо мэдэгдсэн.

-Та шүүж мөрдөх газрыг төөрөлдүүлэх санаатай байна. д'Артаньян тантай ярилцаж тохирсон, тэгж тохирсноороо, тэр хүн чиньтанай эхнэрийг баривчилж байсан цагдаагийн газрын улсыг хөөж явуулчихаад, эхнэрий чинь аваад зайлчихсан байна.

-д'Артаньян гуай миний эхнэрийг хулгайллаа гэж үү? Та юун дэмий юм яриад байнаа?

-Аз болохд д'Артаньян гуай бидний гарт байгаа таныг түүнтэй нүүрэлдүүлнэ дээ.

-Яахав би түүнд чинь үнэндаа баярлаж байна! гэж Бонасьегуай дуу алдаад, ганц ч билээ таньдаг хүний нүүр үзэхсэн.

-Харуулын улсад гэв.

-д'Артаньян гуайг оруул! гэж байцаагчийг тушаасанд харуулын улс Атосыг оруулж ирэв. Байцаагч Атос өөд хандаж,

-д'Артаньян гуай, энэ хүн та хоёрын хооронд юу болсныг над ярьж өгөөч гэв.

-Үгүй энэ чинь д'Артаньян гуайерөөсөө биш байна шүү гэж Бонасье хашгирав. Байцаагч мөн хашгичин:

-Юу, Артаньян биш гэж? хэлэв.

-Биш байлгүй яахав, гэж Бонасье өчив.

-Энэ эрхмийг хэн гэдэг юм бэ? гэж байцаагч асуулаа.

-Танд хэлж өгч би чадахгүй. Энэ эрхмийг би танихгүй.

-Та энэ хүнийг танихгүй гэнээ?

-Тийм

-Та энэхүнийг ер үзээгүй юу?

-Үзэж байсаан. Гэхдээ нэрий нь мэдэхгүй

-Таны нэр? гэж байцаагч асуулаа.

-Атос гэж шадар цэрэг хариулав.

-Үгүй энэ чинь хүний нэр биш нэг уулын нэр байна шүү дээ гэж толгой нь эргэсэн хөөрхий байцаагч дуу алдав.

-Миний нэр ийм юм даа гэж Атос тайван хэлэв.

-Та өөрийгөө д'Артаньян гэдэг гэсэн шүү дээ.

-Би тэгж хэлсэн гэж үү?

-Тиймээ та !

-Болиорой. Надаас: “д'Артаньян гэгч та юу?” гэсэн. Үүнд би: “та тэгж санаж байна уу?” гэсэн. Хуягууд яахын аргагүй д'Артаньян мөн гээд л хашгиралдахаар нь би маргалдаагүй. Түүнээс гадна би бас андуурсан байж болох юм аа.

-Эрхэм ээ, та шүүхийг элэг барьж байна.

Атос үүнд тайвнаар ердөө ч үгүй гэж хариулав.

-Та д'Артаньян гуай мөөн

-Харж байгаа биз, та бас л мөн гэж зүтгээд байна шүү дээ.

-Үгүй байцаагч гуай, энд чинь эргэлзээд байх юм ер алга, нээрээ гэм. д'Артаньян гуай манай байшинд суудаг тэгэхээр хөлсөө төлдөггүй ч гэсэн эсвэл чухам хөлсөө төлдөггүй болохоор нь би түүнийг сайн таних учиртай. д'Артаньян гуай сайндаа арван ес, хорьтой залуу хүн, энэ эрхэм доор хаяад гуч хүрчихсэн хүн байна. д'Артаньян гуай Дезассар гуайн сумангийн тойргийн цэрэг, энэ эрхэм чинь де Тревиль гуайн сумангийн шадар цэрэг хувцсы нь хар л даа, байцаагч гуай, хувцсы нь хар гэж Бонасье хашгичав.

-Нээрээ тийм юмаа. Чөтгөр алгад энэ чинь нээрээ тийм байна шүү! гэж байцаагч үглэв. Энэ үеэр үүд нээгдэж Бастили гяндангийн нэг харгалзагч нэг элч оруулж ирсэнд, тэр хүн байцаагчид нэг бичиг гардуулав.

-Аа муу эм! гэж байцаагч дуу алдав.

-Юу? Та юу гэв ээ? Та хэнийг хэлж байна? Арай манай эхнэрийн тухай биш байгаа?

-Тиймээ, яг танай эхнэрийн тухай. Танай хэрэг ч мөн урагштай байнаа, юу гэхэв! Бүрмөсөн цөхөрс орхисон наймаачин дуу алдаж,

-Энэ чинь юу болж байна? Намайг энд сууж байх зуур манай эхнэрийн аль нэг юм хийснээр, энд гянданд сууж байгаа миний хэрэг яаж урагшгүй болдгийн учрыг байцаагч гуай та над нэг хэлээд өгч үзээч.

-Танай эхнэрийн хийж байгаа юм бүхэн та хоёрын хамт бодож боловсруулсан төлөвлөгөөгөөр муухай төлөвлөгөөгөөр хийгдэж байгаа хэрэг болохоор тэрээ.

-Танд бүр андгайлъя, та сүрхий эндүүрч байна, манай эхнэр юу ч хийх гээд байсан хүн юм бүү мэд. Түүний хийсэн хэрэгт би өчүүхэн ч хамаа байхгүй. Хэрвээ манай эхнэр өөдгүй юм хийсэн бол тэр миний эхнэр биш, би түүнтэй дамцаглаж байна гэв. Атос гэнэт хажуугаас оролцон

-За тэгэхээр, байцаагч гуай, танд би одоо хэрэггүй бол нэг тийшээ аваачуулаач. Танай энэ Бонасье гуайгаас чинь залхмаар болж байна гэв.

-Баригдсан улсыг өрөө өрөөнд нь аваачиж хий. Эднийг аль болох сайн харж манаж байг, гэж Бонасье, Атос хоёр өөд ижилхэн дохив.

-Та бүхэн д'Артаньян гуайтай хэрэг учиртай юм бол, би юугаараа тэр хүнийг орлож чадахаа нэг л мэдэхгүй юм гэж Атос ердийнхөө тайван зангаар үгүүлэв.

-Алив, тушаасан ёсоор хий та нар! Гэж байцаагч хашгирав. Гаднын алив улстай ер битгий уулзуулаарай. Дуулаа биз!

Атос мөрөө хавчаад харуулын хүмүүсийн хойноос дагав. Бонасье гуай туугдан явах зуураа, барын сэтгэлийг боловч уяруулмаар их уйлж хайлан сүйд болно.

Наймаачныг урьд шөнийн өрөөнд авчирч хориод өдөржингөө байлгав. Бонасье гуай өөрөө эр зоригийн зай ч байхгүй гэдгийг өөрөө хүлээж байсанчлан өдөржингөө толгой өөд таталгүй уйлав. Аргагүй л нэг наймаачин даа.

Орой есөн цагийн үед, нэгэнт унтахаар завдаж байтал нь хүний хөлийн чимээ дуулдлаа. Хөлийн чимээ Бонасьегийн өрөөний үүд рүү ойртсоор ирж үүд нээгдэн харуулын цэргүүд орж ирлээ. Цэргүүдтэй цуг орж ирсэн цагдан сэргийлэхийн түшмэл,

-Намайг дагаад яв гэлээ.

-таныг дагаж яв гэнээ! гэж Бонасье гуай дуу алдаад, Өдий орой болчихсон хойно таныг дагаж явах гэнээ? Хаашаа тэр вэ бурхан минь?

-Таныг аваач гэж бидэнд тушаасан тэр газар руу.

-Үгүй, энэ чинь хариулт биш байна шүү дээ.

-Биднийтанд хэлж чадах ганц юм энэ байна.

-Ээ бурхан минь! одоо ч бүр дүүрлээ гэж хөөрхий наймаачин шивнэв.

Тэгээд сэтгэлээр бүр унаж гүйцсэн Бонасье харуулын цэргүүдийн хойноос дагаж гарахдаа эсэргүүцэж барьсан ч үгүй.

Бонасьегийн түрүүн авчирсан гудмаар тууж, хашаан дотуур өнгөрөөд өөр нэг байшинг нэвт гараад гадаа хашааны хаалга хүрлээ. Тэнд дөрвөн морьтой хүн дагалдсан сүйх зэхээстэй байлаа. Бонасьег сүйхэнд суулгаад цагдаагийн түшмэл хажууд нь орж суугаад хаалгы нь цоожилж орхисонд тэр хоёр нэг ёсондоо сүйхэн шоронд орчих мэт болов. Сүйх гашуудлын тэрэг шиг алгуур хөдлөв. Цонхыг халхалсан сараалжаар гэмтэн хүнд зөвхөн байшин, гудамжны цаад зах нь харагдах аж. Гэвч Бонасье гуай уулын Парис хотын хүн болохоор гудамж бүрийг байшингийн өмнөх хаяг, дэнлүү, энэ тэрхнээр гудамж бүрийг таньж байв. Сүйх тэрэг Павел гэгээнтний сүм рүү ойртож ирэхэд Бонасье золтой л ухаан тавьчихсангүй тэр сүмийн дэргэд Бастили гянданд хоригдож байсаар цаазлуулах болсон гэмтэнгүүдийг цаазалдаг билээ. Сүйх юу юугүй л зогсоод орчих байх гэж Бонасье бодож явталзогссон ч үгүй хажуугаар нь гараад явчихлаа. Жаахан цаашаа яваад Бонасье гуай дахин айж хэлмэгдэв. Тэд, улс төрийн хэрэгтний яс тавьдаг, Яков гэгээний оруулах газрын хажуугаар өнгөрч явжээ. Хэрэгтнийг энд оруулахын өмнө голдуу тэднийг толгойг хяргадаг. Гэвч Бонасье гуайн толгой одоо хирдээ мөрөн дээрээ байсаар байгаад сэтгэл нь жаахан тайвширч явлаа. Тэгтэл сүйх тэрэг Гревийн талбай руу эргэж, хотын захиргааны байшингийн шовх орой харагдаж ирээд, хаалган доогуур нь орж явчихын хамт Бонасье гуай ёстой дүүрлээ гэж бодоод цагдаагийн түшмэлийн өмнө нүглээ наминчлахыг оролдож үзлээ. Цагдаагийн түшмэг үгий нь дуулахаас татгалзсанд Бонасье өрөвдмөөр муухай хашгичиж гарвал цаад хүн аманд нь юм чихнэ гэж сүрдүүлэв.

Ингэж сүрдүүлсэнд Бонасьегийн дотор жаахан онгойх шиг Гревийн талбайд тэд нэгэнт хүрээд ирчихсэн болохоор энд өөрий нь цаазлах гэж байгаа бол ам таглаж байх хэрэг үгүй байхсан биз. Одоо айвал зохих газар Трауарскийнзагалмай гэгч газар байлаа. Тэгтэл сүйх яг л тийшээ эргэлээ шүү.

Одоо ч эргэлзэх юм алгаа. Трауарскийн загалмай гэгч газарт дорд язгуурын хүмүүсийг цаазалдаг билээ. Бонасье өөрийгөө, Павел гэгээний юм уу, Гревийн талбайд цаазлагдахаар их хүнд тооцож байсан нь дэмий байж. Түүний явах зам амьдрах хоногийн тоо Трауарскийн загалмай гэгч газарт очиж дуусах тавилантай юм байж дээ. Гайтай эр загалмайн бараа хараахан харагдахгүй хэдий гэлээ ч тэр загалмайл улам улам дөхсөөр байгаа нь Бонасьед мэдэгдээд байх шиг. Тэр гайтай газарт хориод алхам хиртэй ойртоод очиход, цугларсан олон хүний шуугилдах чимээ дуулдаж сүйх зогсож орхилоо.

Түрүүнд нь өдий төдий сэтгэлийн зовлон үзэж давсан хөөрхийн Бонасье үүнийгүзээд үнэхээр тэссэнгүй. Амьсгаа хурааж байгаа хүн эцсийн удаа ёолох адил сулхан дуу тавиад ухаан алдчихав.

XIV. МЕНГ-Д ДАЙРАЛДСАН ХҮН

Талбай дээрх улс, дүүжлэх хүн хүлээгээгүй нэгэнт дүүжлүүлсэн хүнийг үзэхээр цугларсан юм байж.

Иймд сүйх тэрэг түр саатаж зогсосгээд хөдөлж, улсын дундуур гараад, Сент-Онорэ гэгч гудамжаар өнгөрч, Сайн хүүхдийн гудамжаар эргэж намхавтар хаалганы өмнө очиж зогсов. Сүйхний үүд нээгдэж, цагдаагийн түшиж байгаа Бонасьег хоёр торгон цэрэг тосч авлаа. Бонасьег доод давхрын уудам өрөөнд түлхэж оруулснаа, нэг шатаар дээш гаргаж, хүлээх өрөөнд оруулаав орхив.

Бонасье гуай хөдөлж явж байгаагаа ч сайн ухаарахгүй явлаа.

Зүүдэлж байгаа юм шиг явж, орчин тойрон манандотор бүрэлзэх мэт. Гаднын алив чимээ авиаг дуулах авч ухааран тунгааж үл чадна. Яг энэ үеэр Бонасье цаазаллаа гэвэл өөрөө биеэ хамгаалах гэж өчүүхэн ч хөдлөхгүй, өршөөл ивээл гуйж ганц ч үг дуугарахаагүй аж.

Бонасье харуулын хүмүүсийн суулгаж орхисон тэр газарт, гараа унжуулж, хана налсан хэвээрээ, гөлийн суусаар аажимдаа орчин тойрны юмБонасьегийн нүднээ тусч, хүний аминд харштай, айж сүрдэхүйц энд огт үгүй.

Ханыг зөөлөн сайн эдээр бүрж, том том улаан торгон хөшгүүдийг алтан туузаар хумьж татсан өөрийн нь сууж байгаа вандан ч гэлээ зөөлөн аятай нь аргагүйг үзээд дэмий айж сүрдсэнээ мэдлээ. Тэгээд өрөөний байдлыг дээгүүр доогуургүй эргэцүүлж харав.

Хөдөлж байхад саад хориг хийсэн хүнгүй болохоор Бонасье жаахан зориг орох мэт болж, эхлээд нэг хөлөө нугалж зүрхэлснээ бас нөгөө хөлөө нугалчихав. Бүр сүүлдээ хоёр гараараа олбогт вандан дээрээ тулаад өндийж босчихлоо шүү.

Энэ үеэр нэг ихээ буурь суурьтай байрын дарга, үүдний наадах хөшгийг сөхөж зэргэлдээ өрөөнд байгаа нэг хүнтэй юм ярилцаж байснаа хэрэгтэн өөд эргэж:

-Бонасье гэж та юу гэв.

-Тиймээ, дарга гуай. Тэр чинь би, танд хүчин зүтгэхүйд бэлхэн,гэж үхтлээ айж мэгдсэн наймаачин өчив.

Дарга үүнд,

-Ийшээ ор гээд хажуу тийшээ болж хэрэгтнийг оруулав. Бонасье тушаалыг үг дуугүй дагаж, өөрийн нь хүлээж байгаа бололтой өрөө рүү орлоо.

Тийшээ орвол ажлын уудам өрөө аж.

Ханаар нь элдэв янз маягийн зэр зэмсэг дүүжилсэн, гаднаас ганц ч дуу чимээ нэвтэрч ирэхээргүй өрөө байв.

Дөнгөж намрын эхэн сар шувгарчбайсан гэвч задгай зуухнаа гал дүрэлзэнэ. Өрөөний голд тавьсан томоо дөрвөлжин ширээ эзэлсний дээр нос цаас овоолоостой, Ларошель хотын зураг мөн дэлгээстэй харагдана. Ил галын дэргэд ихэмсэг дээрэнгүй царайтай, хянуур хурц харцтай, өргөн магнайтай дунд хир нуруутай хүн зогсож байлаа.

Эцэнхий царайгий нь ямаан сахал улам урт болгож харагдуулахын гадна, урууландаа мөн шөрөвгөр сахалтай аж. Тэр хүн ер гучин зургаа, долоон наснаас яасан ч хэтрээгүй мөртөө, үс сахланд нь буурал орох шинж харагдана. Илд зүүгээгүй хэдий боловч, цэргийн хүний байртай, гутал дээрх өлөн тоосыг харвал өнөөдөр лам мориор явжээ. Арман Жан Дю Плесси, де Ришелье Хамба ламтан гэгч энэ хүн юм байж. Энэ хүнийг манайхан хүнд өвчинд нэрвэгдэн зовюж, дуу нь суларчихсан, амьдаараа авсанд орчихоод байгаа юм аятай зөөлөн сандалд шигдэн суусан өндөр настай өвгөн, зөвхөн ганц оюун ухаанаараа амь голоо тэжээж, бүхэл бүтэн европ тивтэй тэмцэж байсан юм шиг дүрсэлдэг нь ташаа билээ. Тэр цагт чухамдаа хамбын бие сулавтар байсан гэдэг хэдий үнэн боловч, шалмаг авхаалжтай, эелдэг сайхан ааштай овжин эр, оюун ухаан, эршүүд шуудхан сэтгэлтэйн ачаар цаг үедээ хамгийн сод хүмүүсийн нэг байж билээ. Неверийн герцогоос өөрийнхөө Шантуан дахь эдлэн газарт байгаа Ним, Кастр, Юзеес зэрэг газрыг эзлэхэд нь хамба ламтан дэмжлэг үзүүлээд, одоо Ре арлаас Англичуудыг хөөн гаргаж Ларошелийг бүслэхээр зэхэж байгаа ажээ.

Иймд анх түүнийг харахад хамба ламтан болохын шинжтэй юм ер үгүй, нүүр царайгий нь үл таних хүн бол хэнтэй уулзаж байгаагаа мэдэхийн эрхгүй аж.

Золгүй муу наймаачин үүдэнд хулган зогсоход саяны хүн түүнийг нэвт шувт харж, хамаг түүх намтрыг нь мэдье гэх аятай.

Тэр хүн хэсэг зуур дуугүй байснаа

-Нөгөө Бонасье чинь энэ үү? гэж дуугарав.

-Тиймээ, гэгээнтэн, гэж дарга өчив

-За, тэр бичиг цаасы нь цааш өгөөд, бид хоёрыг орхи. Дарга, ширээн дээрээс хэлсэн бичиг цаасыг авч өгөөд, хүндэтгэн мэхийгээд гарч одов.

Тэр бичиг цаас, Бастилид өөрий нь байцаасан асуулт хариулт мөнийг Бонасье танилаа. Ил галын дэргэд зогсож байгаа хүн үеүе толгойгоо өргөж өөдөөс нь харахад хоёр хурц хутга өр зүрх хүү нь чиглээд ирэх шиг Бонасьед санагдлаа.

Арван минут байцаалты нь уншиж, арван секунд ажсаны дараа хамба, ламтан учрыг бүрэн ойлгов.

-Энэ хөөрхий амьтан хуйвалдаанд ер оролцож яваагүй дэгээ. За яахав туршаад үзье гэж амандаа шивэгнэлээ.

-Та, улс төрд тэрсэлсэн хэрэгт ял тулгагдаж байна гэж хамба ламтан алгуурхан дуугарав.

-Гэгээнтэн минь над энэ тухай нэгэнт дуулгасан. Гэхдээ танд амлаж хэлэхэд би өөрөө тэр тухай юу ч мэдэхгүй юм гэж Бонасье асууж байгаа хүнийг даргын өргөмжилж дуудсанчлан хариулав. Хамба инээдээ барьж,

-Та, өөрийнхөө эхнэр, де Шеврез авхай, Бекингэм Герцог нартай хуйвалдажбайжээ.

-Нээрээ ч гэгээнтэн минь, манай эхнэр тэр нэрсийг миний дэргэд дурсаж байсан шүү гэж Бонасье өчив.

-Юун тухай тэднийг дурсаж байсан бэ?

-Да Ришелье хамба өөрөө Бекингэм герцогийг Парис руу нааш нь хуурж ирүүлээд, түүнийг хөнөөж, хамтад нь хатныг хөнөөхөөр завдаж байна гэж байсан.

-Бүр тэгж хэлж байсан уу? гэж хамба хилэгнэн хашгирав.

-Тэгж байсаан гэгээнтэн. Гэхдээ би өөрт нь тийм юм ярьж болохгүй, их гэгээнтэн уулаасаа тиймэрхүү юм хийхээргүй... гэтэл хамба хажуугаас нь,амаа тат, тэнэг минь гэв.

-Гэгээнтэн минь, манай эхнэр ч гэсэн яг л тань шиг ингэж намайг зандарсан.

-Танай эхнэрийг хулгайлсан хүнийг өөрөө мэдэх үү?

-Үгүй, гэгээнтэн

-Үгүй, та нэг хүн сэжиглэсэн биш бил үү?

-Уул нь тэгсээн, гэгээнтэн. Гэтэл тэр сэжиглэсэн маань байцаагч гуайд нэг таалагдсангүй бололтой байхаар нь би түүнээсээ няцсан.

-Танай эхнэр оргосон, үүнийг та мэдэх үү?

-Үгүй, гэгээнтэн. Энэ тухай би шоронд байхдаа лбайцаагч гуайгаас дуулсан. Тэр их эелдэг сайн хүн билээ.

Хамба дахиад л инээдээ барьж,

-Танай эхнэр оргоод, хаашаа явчихсаныг та мэдэхгүй юм шив дээ?

-Юу ч мэдэхгүй дээ, гэгээнтэн минь. Бодвол лувр ордонд буцаж очсон байлтай.

-Өнөө шөнийн нэг цаг болж байхад л тэр бүсгүй лав ордонд ирээгүй байсан.

-Бурхан минь! тэр ер яаж орхио юм бол доо?

-Яасны нь учир нь олдноо, бүү сэтгэл зов. Хамба бүгдийг олж мэднээ, хамбын хараанаас юу ч нуугдаж чадахгүй.

-Тэгвэл манай эхнэрийн хайчсаныг хамба ламтан над дуулгахаас татгалзах болов уу, гэгээнтэн та юу бодож байна.

-Магадгүй. Гэхдээ танай эхнэр, де Шеврез авгай хоёрын харьцааны тухай та юу мэдсэн бүхнээ урьдчилан ярьж өгөх хэрэгтэй.

-Үгүй, гэгээнтэн минь би даанч юм мэдэхгүй юм даа. Тэр авгайтныг би ерөөсөө үзээгүй.

-Таныг эхнэрийгээ лувраас тосч авахад цаадах чинь гэртээ шулуухан харьдаг уу?

-Бараг үгүй. Нэг бөс бараа худалддаг улстай уулзах хэрэгтэй болдог, би тийш нь хүргэж өгдөг байсан.

-Тийм худалдаачин хэд байсан бэ?

-Хоёр байсан, гэгээнтэн.

-Тэр худалдаачид хаа суудаг вэ?

-Нэг нь вожирар гудамжинд, нөгөө нь лагарп гудамжинд

-Тэднийхэнд, та авгайтайгаа цуг ордог байсан уу?

-Ер үгүй. Авгайг би гадна хүлээдэг байсан.

-Ганцаараа орох гэдгээ юугаар тайлбарладаг байсан бэ?

-Юу чгэдэггүй байсан. Намайг хүлээж бай гэхээр нь л би хүлээдэг байсан юм.

-Та мөн ч номхон сайн нөхөр байна даа, эелдэг ааштай Бонасье гуай минь! гэж хамба лам хэллээ.

“Энэ хүн намайг “эелдэг Бонасье гуай” гэж байна шүү гээч” гэж наймаачин бодов.

-Авгайнхаа орж байсан үүдийг та заагаад өгччадах уу?

-Чаднаа

-Хэддүгээр хаалга болохыг нь санаж байна уу?

-Санаж байна...

-Хэлээд орхи.

-Вожирар гудамжны хорин тавдугаар хаалга, Лагарп гудамжин дахь нь далан тавдугаар хаалга.

-За сайн гэж хамба хэлээд ширээн дээрээс мөнгөн хонх авч цохив. Нөгөө офицер орж ирлээ.

-Рошфорийн хойноос хүн явуул. Эргэж ирсэндороо наашаа ир гээ, гэж Ришелье аяархан тушаав.

-Гүн өөрөө энд ирчихээд, их гэгээнтэн тантай уулзах чухаг хэрэгтэй гээд л байна, гэж дарга хариуллаа.

-Орог, орог. Гүнг оруул, гэж хамба баярлалаа. Хамба ламтны бараа бологчид, эзнийхээ тушаалыг гүйцэтгэх гэж яардаг заншлын дагуу дарга өрөөнөөс яаран гүйж гарав.

-Яанаа “Их гэгээнтэн” гэвээ! –гэж Бонасье шивэгнээд, нүд нь бүлтийчихэв.

Даргыг гараад таван секунд ч болоогүй байтал үүд нээгдэж, шинэ хүн орж ирлээ.

-Энэ мөн байна гэж Бонасье хашгирав.

-Хэн мөн байна гэж? гэж хамба асуув.

-Энэ миний эхнэрийг хулгайлсан хүн. Хамба дахин хонх цохисонд дарга орж ирэв.

-Энэ хүнийг аваачаад, нөгөө тууж ирсэн цэргүүдэд нь тушаа. Намайг дахин дуудтал хүлээж байг гэж хамба тушаав.

-Үгүй, гэгээнтэн, энэ хүн биш байна. Энэ яах аргагүй биш байна. Би эндүүрчээ! Энэ хүнтэй ер адилгүй өөр нэг хүн манай эхнэрийг хулгайлсан юм. Энэ эрхэм бол шударга сайн хүн гэж Бонасье хашгирав.

-Наад золигоо аваад яв! гэж хамба эгдүүцэв.

Дарга, Бонасьегийн тохойноос барьж, үүдний өрөөнд оруулбал, харуулын цэргүүд хүлээж байв. Хамбын өрөөнд сая орж ирсэн хүн Бонасьегийн гарахыг хүлээж ядах аятай харж байснаа үүд хаагдахын хамт даруй Ришелье өөд дөхөж очоод,

-Тэр хоёр уулзаж амжжээ, гэв.

-Хэн тэр вэ? гэж хамба асуув.

-Тэр хоёр

-Хатан, Бекингэм Герцог хоёр уу? гэж хамба дуу алдав.

-Тиймээ

-Хаана тэр вэ?

-Лувр ордонд

-Та лавтай мэдэж байна уу?

-Лавтай мэдэж байна.

-Танд хэн дуулгаа вэ?

-Их гэгээнтэн танд чин үнэнч, сайн байдаг де Ланнуа авхай.

-Үүнийгээ тэр яагаад түрүүний дуулгаагүй юм?

-Зүгээр тэгж таарсан юм санж үү, аль сэжиг төрсөн юм уу, хатан өөрөө де Сюржи авгайг өөртэйгээ цуг хоно гэж тушаагаад, маргааш өдөржингөө салж өгсөнгүй.

-За... Бид хожигдож орхиж. Даагаа нэхэхийг бодож үзье дээ.

-Гэгээнтэн танд тус болохын тулд би хамаг чадлаа шавхана.

Над итгэж байж болно.

-Яаж уулзсан юм бол?

-Шөнө дунд хэлбийж байх үед хатан, бараа бологч бүсгүйчүүлтэйгээ сууж байжээ...

-Хаана тэр вэ?

-Унтдаг өрөөндөө.

-За тэгээд?

-Тэгтэл хатанд явуулсан нэг алчуурыг хүн авчирчөгчээ...

-Цаашаа!

-Хатан дороо их сандрах байртай болж, хацартаа энгэсэг тавиад байсан мөртөө царай нь цайраад явчих нь мэдэгдсэн гэнэ.

-Цаашаа!...Цаашаа тэгээд!

-Хатан суудлаасаа босоод “намайг эндээ арваад минут хүлээж бай, би мөд ирнэ” гэхдээ дуу нь хачин болчихсон байж гэж. Тэгээд л гараад явчихсан гэнэ.

-Де Ланнуаавхай юунд тэр доор нь танд тэр тухай дуулгасан үгүй вэ?

-Авхай өөрөө сайн үнэмшээгүй байж. Тэгээд ч хатан өөрөө “намайг хүлээж бай” гэсэн хойно, үгнээс нь зөрж зүрхэлсэнгүй.

-Хатан гараад хэдий хир удаа вэ?

-Гурван мөч хиртэй

-Бараа бологч бүсгүйчүүлээс хатантай цуг гарсан хүн ер үгүй юу?

-Ганцхан л Эстефания авхайтан.

-Дараа нь хатан эргэж ирсэн үү?

-Тэгжээ. Гэхдээ, өөрийнхөө нэрний толгойн үсгийг сийлж чимсэн зандан хайрцгийг авахаар орж ирсэн, аваад дахин гарсан гэнээ.

-Хатантан буцаж ирэхдээ хайрцгаа авч ирээ юу?

-Авчирсангүй.

-Хайрцган дотор юу байсныг де Ланнуа авгай мэдэхгүй юм уу?

-Мэдэх юмаа. Их эзэнтнээс хатанд бэлэглэсэн алмаасан унжуурга байсан гэнэ.

-Тэгээд хатан буцаж ирэхдээ хайрцгаа авч ирээгүй гэнээ?

-Тийм гэнэ.

-Тэгэхээр хайрцгийг хатантан Бекингэм герцогт өгчээ гэж де Ланнуа авхай тааж байгаа хэрэг үү?

-Тэгснээс зайлахгүй гэж авхай бодож байна.

-Яагаад тэр вэ?

-Өдөр Ланнуа авгай хатны өрөө байрыг даасан хүний хувьд хайрцгийг газар сайгүй эрж алга болсонд нь сэтгэл зовсон царай үзүүлсээр эцэстээ хатнаас, ийш тийшээ хийсэн эсэхийг асуужээ.

-Тэгэхэд нь хатан?

-Хатны царай час улайж өчигдөр нэг унжуурга эвдчихээд, инжээнд засуулахаар өгсөн гэж гэнэ.

-Вангийн инжээнд дээр очиж, үнэн худлыг мэдэх хэрэгтэй.

Би тийшээ очсон.

-Тэгээд яав? Инжээн юу гэж байна?

-Инжээнд дуулсан юм ер алга.

-Сайн Рошфор минь, их сайн. Хэрэг явдал арай ч бүрмөсөн урагшгүйтэж орхисонгүй. Ингэсэн нь сайн ч болж болохыг хэн мэдэх вэ.

-Их гэгээнтэн таны суут ухаан... юу яана гэдэгт би өчүүхэн төдий ч эргэлзээгүй байсан юмаа.

-Миний ухаан тагнуул туршуулуудынхаа алдааг залруулна гэж хэлэх гэв үү?

-Их эзэнтэн та над санаагаа бүрэн илчлэх боломж өгсөн бол би яг л тэгж хэлэх санаатай байсан юм.

-Аа одоо...Бекингэм герцог, де Шеврез авгай хоёр хаа нуугдаж байсныг та мэдэж байна уу?

-Үгүй, гэгээнтэн, миний тагнуул туршуулууд энэ талаар нарийн тодорхой юм ер дуулгаж өгдөггүй.

-Тэгвэл би мэднэ.

-Та юу гэгээнтэн?

-Тиймээ, юу ч гэсэн гадарлаж байна.

-Их эзэнтэн та, тэр хоёрыг надаад баривчлуулахсан гэж байна уу?

-Оройтсоон. Тэд лав яваад өгч амжаа биз.

-Юу ч болсонмагадлаад үзэж болох юмаа даа

-Миний торгон цэргүүдээс арвыг дагуулж очоод тэр хоёр байшинг нэгжээд үз.

-Сонслоо, их гэгээнтэн гээд Рошфор яаран гарч одов.

Хамба ганцаараа үлдэж минут хир бодол болсноо гуравдахь удаа хонх дуугаргасанд нөгөө л дарга орж ирлээ.

-Гэмтэн хүнийг аваад ир! гэж хамба тушаалаа. Бонасье гуайг дахин өрөөнд оруулж ирээд, дарга өөрөө хамбын зангасан ёсоор гарч одлоо.

-Та намайг хуурсан байна гэж хамба ширүүн дуугарав.

-Би юу? Өндөр их гэгэнтэн таныг би хуурлаа гэж үү? Гэж Бонасье хашгирав.

-Танай эхнэр Вожирар гудамж, лагарп гудамжруу очихдоо бөс бараа худалддаг улстай уулздаг нь худал байна.

-Өршөөл бурхан минь, тэр чинь тэгээд хэнтэй уулздаг байгаа вэ, та минь?

-Танай эхнэр, Бекингэм герцог, де Шеврез авгайтай уулздаг байжээ.

-Тэгнээ, тэр гэж Бонасье нэг юм санаж ядан байх бололтой байснаа-тэгнээ тэр. Их гэгээнтэн таны зөв. Бас эд худалддаг улс тийм байшинд, гаднаа хаяггүй байшинд суудаг нь хачинюм гэж

би эхнэрт хэд хэд дахин хэлж байсан. Хэлэх бүрд манай эхнэр хөхрөөд л байсан, ээ, гэгээнтэн минь, гэж Бонасье их гэгээнтний хөлд сөхрөн унаад, -Та чухамдаа чухам нэг их хамба, хүн бүхнийг бишрүүлсэн суут их хамба мөн юмаа гэв...

Өдий адгийн амьтныг ингэтэо бишрүүлэх гэдэг хэдий өчүүхэн зүйл боловчхамбын сэтгэл түрхэн зуур аятайхан л байлаа.

Тэгснээ , гэнэт санаа хамбад төрөв бололтой, инээвхийлээд, наймаачин өөд гараа сунгав.

-Босож үз, нөхөр минь. Та шударга сайн хүн юм гэлээ.

-Хамба ламтан миний гарт хүрч би суут их хүний гарт хүрлээ шүү та минь! Их хүн намайг нөхрөө гэж хэллээ... гэж Бонасье дуу алдав.

-Тиймээ, та миний нөхөр! гэж хамба энэрэнгүй сайхан дуугарлаа. Ришельег сайн мэдэхгүй улс л энэ дуунд хууртах билээ. Танд дэмий ял тулгасан байна, тэгэхээр өөрийг чинь бас хохироолгүй өнгөрөөх ёстой, энэ хэтэвчий минь авч үз, энд зуун алтан зоос бий, тэгээд миний бурууг уучлаарай.

Бонасье хэтэвчтэй мөнгөнд гар хүрч зүрхлэхгүй, эд бүгд ердөө янз үзсэн сорилт байж таарна гэж айгаад...

-Гэгээнтэн таныг би уучлах гэнэ шүү та минь! Та намайг баривчларх гэвэл баривчилж, эрүүдвэл эрүүдэж дүүжилж хороовол хороох билээ, та бидний эзэн мөн юм хойно, би үг ч дуугарч чадахгүй байхсан. Гэгээнтэн таныг уучилна гэдэг! Санахаас ч айдас хүрэх шиг! гэв.

-Үгүй Бонасье гуай та ер гайхалтай сайхан өгөөмөр сэтгэлт хүн юмаа. үүний чинь үзээд танд баярлаж байна. За тэгэхээр та энэ хэтэвчийг аваад явахдаа над онц их гомдохоо болино бизээ.

-Би танд чухам гүнээ биширч байна.

-За тэгвэл ингээд салцгаая. Баяртай, ингэхэд бид дахиад уулзах бий гэж би горьдоно гэжхамба хэлэв.

-Таны таалал болсон цагт уулзъя, их гэгээнтэн. Би ч хэзээд л их гэгээнтэн танд хүчин зүтгэхэд бэлэн.

-Бид цаг цагт уулзаж байх болноо гайгүй, бүү зов.

Тантай ярилцахад над тун таатайхан байлаа.

-Ээ, их гэгээнтэн минь...

-За баяртай Бонасье гуай, баяртай.

Хамбыг гараараа зангахад Бонасье хариуд эргэн мэхийнөслов. Бонасье ухарсаар яваад гармагцаа үүдний өрөөнд хар чадлаараа “манай гэгээнтэн мандтугай!” Суут их хамба

мандтугай! гэж хашгирах нь хамбад дуулдав.

Бонасье хөөрч биширсэн сэтгэлээ ийнхүү илчлэн дуу тавихыг хамба инээвхийлэн сонсож зогслоо.

Наймаачны дуу холдсоор намжисны дараа, Энэ цагаас аваад миний төлөө амиа өгөх хүн энэ байна даа, - гэж тэр дуугарав.

Тэгээд хамба нөгөө ширээн дээр дэлгээстэй байсан гэж бидний ярьсан Ларошель хотын зургийг маш хянамгай үзэж, бүтэн хагас жил өнгөрөөд хотоос далайн ам хүрэх замыг хаасан алдарт далангийн зургийг дээр нь тэмдэглэн эхлэв. Хамбын санаа бодол энэ ажилдаа автаж гүйцээд байтал гэнэт үүд нээгдэн Рошфор орж ирлээ.

-За яав? гэж хамбашохоорхон асуугаад, хамбын яаран өндийхийг үзвэл, гүнд даалгасан зүйлээ, ихээ чухагт үзэж байсан нь илт.

-Ийм юм болжээ. Их гэгээнтэн таны зааж өгсөн байшингуудад үнэхээр ч хорин зургаа, долоон насны бүсгүй, гучин тав, дөч эргэм насны хар хүн хоёр түр сууж байсан. Эрэгтэй нь дөрвөн өдөр, эмэгтэй нь таван өдөр тэндбайжээ. Бүсгүй нь урьд шөнө, бүстэй нь өглөө яваад өгчихсөн гэж гүн өчив.

-Яахын эрхгүй тэд мөн байж! гэж хамба дуу алдсанаа ханын цаг өөд хараад, тэдний араас улс явуулж нэхнэ гэхэд нэгэнт оройтож, герцогийн авгай өдийд Тур хотонд, Бекингэм аль хэдийн Булони хүрчихсэн байгаа. Лондон хотонд нь л очиж гүйцэхээс биш дээ, гэв.

-Их гэгээнтэн таны тушаах юм юу байхсан бол?

-Болсон хэрэг явдлын тухай ганц ч үг бүү алд. Хатан юм гадарлахгүй, нууцаа бидэнд алдсанаа мэдэхгүй байж байг. Яахав биднийг нэг хуйвалдаан илрүүлэхээр ажиллаж байгаа юм гэж санаж байг... Тэр Сегье захирагчийг нааш нь дууд.

-Тэр хүнийг их гэгээнтэн яасан бэ?

-Ямар хүнийг?

-Тэр Бонасьег

-Яах ёстой байсанбэ, түүнийг л хийсэн дээ. Тэр хүнийг би тагнуул туршуулаа хийсэн, тэр хүн эхнэрээ тагнаж байх болно.

Гүн Рошфор эзнийхээ хавьгүй давуу ухаанд бишрэх байртай мэхэсгээд гарч одлоо. Хамба ганцаар үлдмэгц дахин суудалдаа сууж нэг захиа татлаад дугтуйлж, тамгаа дараад хонх дуугаргалаа. Нөгөө л үүд харсан дарга дөрөвдөх удаагаа орж ирэв.

-Битрег наашаа ир гээ. Хол явахад бэлтэг гэж бас хэлээрэй, гэж хамба дуугарлаа. Хэдхэн минутын дараа тэр дуудсан хүн нь замд гарахуйц бэлхэн урт түрийтэй гутал өмч давируул зүүгээд хамбынд зогсож байлаа.

Ришелье түүнд,

-Битрег, та даруй Лондон руу давхиж үз. Замдаа хаа ч өчүүхэн ч бүү саатаарай. Энэ захиаг та Миледид өөрт нь гардуулж өг. Май, энэ хоёр зуун алтан зоос авах гарын үсэг. Миний сангийн няравт очиж үзүүлээд бэлэн мөнгөөр ав. Миний даалгасан юмыг сайн гүйцэтгээд, зургаа хоногийн дараа эргэж ирэх юм бол танд дахиад хоёр зуун алтан зоос өгнө гэв. Элч хариу ганц үг дуугарсангүй, захидал, гарын үсэг хоёрыг аваад гарч одлоо. Тэд захидалд бичсэн нь:

”Миледи! Бекингэм герцогийн очих эхний найр наадам дээр оч. Түүний цамцан дээр арван хоёр алмас чулуун унжуурга зүүлттэй байх бий. Ойртож байгаад, унжуурганаас хоёрыг нь хайчилж ав.

Унжуургыг гартаа ормогц над дуулга” гэжээ.

XV. ЦЭРГИЙНХЭН БА ШҮҮХИЙНХЭН

Энэ бүхэн хэрэг явдал болж өнгөрсний маргаашөдөр д'Артаньян, Портос хоёр Атосыг ирэхгүй болохоор түүний үгүй болчихсон тухай де Тревиль гуайд дуулгав.

Арамис ч яахав таван өдрийн чөлөө аваад, өөрий нь хэлснээр бол гэр орныхоо хэргээр Руан орохоор явсан гэнэ.

Де Тревиль гуай цэргүүдийнхээ ёстой л эцэг болсон хүн шадар цэргийн л хувцас өмссөнөөс хойш хамгийн нэр цуугүй эгэл нэгэн цэрэг хүртэл де Тревиль гуайг өөрийн төрсөн ах дүү мэт үзэн өмөг түшигт нь найдаж болох билээ.

Де Тревиль ийм хүн тул даруй эрүүгийн хэргийн ерөнхий шүүгч дээр очлоо. Улаан загалмайн дэргэд харуулыг захирч байсан даргыг дуудаж уулзав. Ингээд мэдсэн, дуулсан юмаа харгуулан бодож үзээд, Атос Фор-Левик гянданаа байгааг мэдэж авлаа.

Бонасьегийн үзэж өнгөрсөн шалгавар бүхнийг Атос үзэж өнгөрөөлөө.

Хоёр хэрэгтнийг нүүрэлдүүлж байсан тухай бид дээр ярьсан. д'Артаньяныг мөрдөж ажил төрлөө чөлөөтэй хийх боломж өгөхгүй болуузай гэж айгаад тэр болтол юм дуугарч өгөхгүй байсан Атос өөрийгөө д'Артаньян биш Атос мөн болохыг нотолж гарав.

Бонасье гуай, Бонасье авгай хоёрын ал алиныг ер танихгүй, нэг ч удаа сольж үзээгүйгээ хэллээ. Оройн арван цагийн хирд өөрийн сайн нөхөр д. Артаньяныдаа очсон, түүнээс өмнө де Тревиль гуайнд хоол идэж, тэнд байж байсан, үүнийг хориос доошгүй хүн гэрчилж чаднаа гээд Атос хэд хэдэн хүндтэй улсын нэрсийг дурьдсаны дотор де ла Тремуль герцог оржээ.

Энэ шадар цэргийн цэх шулуун хариултыг сонсоод эхлээд байцаасан хүний нэг адилдахин байцааж байгаа хоёрдахь байцаагч мөн жаал мухардлаа. Гэхдээ шүүхийнхэн ер нь цэргийн хүнийг дийлээд гарах санаатай байдагчлан Атосыг дийлчихсэн гэж тэр хүн бодоод байж. Гэсэн мөртөө де Тревиль, де Тремуль герцогтны нэрийг дуулаад байцаагч тээнэгэлзэж орхив. Атосын мөн хамба ламынд аваачсан боловч гай болоход хамба Лувр ордонд вантай уулзахаар явчихсан байжээ.

Яг энэ үеэр де Тревиль гуай эрүүгийн хэргийн ерөнхий шүүгчийнхээс гарч, Фор-Левек гяндангийн даамалтай уулзаад, Атостой уулзаж чадалгүй ванд бараалхахаар очжээ. Де Тревиль гуай шадар цэргийн даамлын хувиар вантай дуртай цагтаа уулзах эрхтэй юм. Ван хатнаа хир их харддаг, тэрнийг нь хамба ламтан хичнээн чадмаг даамжруулдаг байсныг бид дурссан. Ийм хэрэгбудлианы талаар хамба өөрөө бүстэйчүүлд орхноо бүсгүйчүүлээс их айж болгоомжилдог хүн байсан. Вангийн ингэж хардаад болдоггүйн нэг гол шалтаг гэвэл, Анна хатан өөрөө де Шеврез авгайтай үерхдэгт байлаа. Испанитай байлдаж магад. Англи улстай эв муудлаа, улсын сан хоосорч будлиантлаа гэж ван санаа зовохоос илүү тэр хоёр эмэгтэйд их зовдог байлаа. Вангийн санадаг, бат итгэдгээр бол де Шеврез авгай хатны улс төрийн явуулганд төдийгүй янаг амрагийн хэрэгт тус болж өгдөг байлаа.

Тур хотноо цөлөгдөөд, тэнд сууж байсан де Шеврез авгай, нууцаар Парис хотноо ирж, цагдаа

тагнуулуудыг мэхэлж чадаад тав хоносон тухай хамбыг үг цухуйлгахын хамт вангийн уур хилэн бадраад явчихлаа. Ааш муутай, хувирамтгай ван өөрийгөө “шударга Людовик”, ”ариун журамт Людовик” гэж нэрлүүлэх дуртай. Тэр вангийн ааш занг харуулах гэж оүүхэнд олоон жишээ дурдсанаас биш, тогтоож хэлсэн юмгүй хожмын улс учры нь олоход бэрхтэй байх бизээ. Хамба ламтан цаашаа де Шеврез авгай Парис хотноо, ирсэн төдийгүй, хатагтай мөн нууц арга хэрэглэж авгайтай холбоо барьсныг дуулгав. Тэгээд цаашаа энэ хэрэг явдлын нарийн учрыг олж, хатан болон цөлөгдмөл бүсгүй хоёрын дунд хэл залгаж явсан нэг бүсгүйг гэмт хэргийн хамаг баримт нотолгоотойгоор газар дээр нь барихыг завдаж байтал уул хэргийг зөв шударгаар шүүн үзээд ванд айлтгахын тулд албаа хийж байсан шүүхийн дөрвөн түшмэл рүү нэг шадар цэрэг илд сугалан дайрч ороод хамаг хэргийг бусниулаад хаячихлаа гэж хамбыг айлтгахад XIII Людовик ван бүрч биеэ эзэмдэж чадахаа болив. Дотроо ингэтэл буцалсан уур хорсол нь гадагшаа дэлбэрэн гарахын үед, хамгийн харгис хатуу үйл үйлддэг энэ эзэрхэн захирагч вангийн царай зэвхийрээд, хатны өрөө байр руу ордог хаалга өөд алхав. Гэтэл Бекингэмийн нэрийг хамба лам бас дурсаагүй байхад тэр шүү.

Яг энэ үеэр орж ирсэн де Тревилийн царай төлөв, эелдэг байдал нь өөгүй төв харагдлаа. Хамба энд ирчихээд байгаа, вангийн царай хувирсаныг хараад, энд юу болсныг гадарласан де Тревиль өөртөө мунхгуудтай тэмцэлдэх ухаантан мэргэд мэт хүч чадалтай хүн санагдлаа. Хаалганы бариулаас атгачихаад байсан XIII Людовик ван, хүний хөлийн чимээ дуулаад эргэж харав.

Уур хилэнгээ дураар нь тавьчихсан ван нэгэнт юм хүм нууж далдалж чадахгүй болчихоод,

-Ашгүй та яг хэрэгтэй цагт орж ирлээ. Танай шадар цэргүүдийн тухай овоо юм дуулдаж байх шив, гэжээ.

Де Тревиль үүнд, их эзэнтэн таны шүүгч нарын тухай хэлмээр овлоо юм ч мөн над байна гэж хүйтнээр егөв.

-Таныюу гэх гээд байгааг би ойлгохгүй байна гэж Ван дээрэнгүй дуугарлаа.

Де Тревиль мөн нөгөө амгалангуй байраараа,

-Их эзэнтэн танаа завшаанаар дуулгахад, миний шадар цэргүүдийн нэг, чухам гэвэл их эзэнтэн таны нэг шадар цэрэг аль сайн талаас нь таныг ч билээ мэднэ гээд хэлчиж зүрхэлсэн болохуйц, шударга журам хшн, нэрд гарсан Атос гуайг эрх сүртэй боловч, цэргийнхэнд айхгар өштэй, бүлэг, түшмэд, байцаагч, цагдаагийнхан нэг айлаас баривчилж аваад гудамжаар ил туусаар явж Фор-Левик гянданд аваачиж хорьсон байна. Эд бүгдийг нэгэн тушаал зааврын дагуу хийсэн гэх боловч, надад үзүүлэхгүй юм гэнэ, гэлээ.

-Атос гэнээ гэж ван бараг өөрийн эрхгүй давтаж хэлчихээд нээрээ ч энэ нэрийг би дуулсан юм шиг... гэв.

-Ихэзэнтэн та санаж үз. Атос гуай, нөгөө таны мэдэх гайтай нэг тулалдаан дээр де Каюзак гуайг хүнд шархдуулж харлаагүй юу гэж де Тревиль хэлснээ эргэж хамбаас үгүй ингэхэд Каюзак гуайн бие бүр сайжраа биз, их гэгээнтэн гуай? гэв.

Хамба уур нь бадарч, хөмхийгөө зуугаад

-Засарч байгаа, гялайлаа танд гэж дуугарлаа.

ДеТревиль үгээ залган,

-Атос уул нь нэг нөхрийндөө очиж л дээ. Цаад хүн нь их эзэнтний торгон цэрэг, Дезассар гуайн суманд бүртгэгдсэн беари нутгийн нэг залуу. Тэр залуу гэртээ байсангүй. Атос гуай нөхрөө хүлээх санаатай, нэг ном аваад сандал дээр суутал бөөн цагдаа, цэргүүднийлэн дайрч ирээд л тэднийхийг бүсэлж, үүд хаалга хэмхчиж...

“Сая танд миний дуулгаж байсан хэрэг” гэж хамба дохиогоор ванд тайлбарлав.

-Бид үүнийг чинь цөмийг мэдэж байна, юу гэвэл бидний ашиг сонирхлын үүднээс хийсэн юм гэж ван айлдав.

Де Тревиль тос аваад,

-Тэгвэл таны ашиг сонирхлын үүднээс миний ямар ч гэм хийгээгүй нэг шадар цэргийг баривчилжээ. Таны ашиг сонирхлын үүднээс тэр хүнийг адгий муу этгээд мэт хотын гудамжаар өдий төдий хүмүүс дундуур хоёр цэрэг тууж шударга журамт тэр хүнийг элдвээр доромжлуулсан юм байж. Атос гуай их эзэнтэн таны төлөө хэдэн арав дахин цусаа урсгасан, одоо ч хэдий хэрэгтэй цагт дахин урсгахад бэлэн байгаа хүн гэлээ.

Ван үүнийг сонсоод тээнэгэлзэж,

-Үгүй та юу гэнээ? үнэхээр өөрийн чинь ярьж байгаа шиг тийм юм болсон гэж үү? гэв. Хамба ламтан мөн төгс амгалан хэвээр

-Тэр гэм зэмгүй шадар цэрэг, шударга журамт хүн баривчлагдахаасаа нэг цагийн өмнө, нэн чухаг хэргийг шүүж учры нь олуулахаар миний явуулсан дөрвөн байцаагч нар руу илд барин довголсныг де Тревиль гуай танд хэлэхээ мартчихлаа гэв.

-Их гэгээнтэн та тэгвэл хэлсэн үгээ нотлоод орхи! гэж де Тревиль гаскон нутгийнхны цайлган цэрэг хүний гүдэсхэн зангаар дуу алдаад, Юу гэвэл тэр хэрэг болохоос нэг цагийн өмнө, их эзэнтэнд зүрхлэн айлтгахад, өндөр дээд угсаатай Атос гуай манайд хоол идэлцэж соёрхоод, манай зочдын өрөөнд, де Тремуль герцоггуай, де Шалю гүн гуай нартай юм ярьж суусан билээ. Ван, хамба лам өөд харав.

Вангийн ингэж харцаараа асуусанд хамба хариу болгон,

-Миний сая хэлсэн бүхэн, тэр довтлуулсан хүмүүсийн хийсэн баримт бичигт бий. Их эзэнтэн танд би тэр бичиг баримтыг үзүүлье гэж хэлэв.

-Шүүхийн түшмэлүүдийн бичсэн бичиг цэрэг хүний амласан амнаас үнэтэй байдаг юм гэж үү? Гэж де Тревиль бардангуй асуув.

-За, за Тревиль амаа тат, гэж ван дуугарлаа.

-Хэрэв их гэгээнтэн, миний шадар цэргүүдийн хэн нэгийг сэжиглэж байгаа юм бол хэргин учрыг хянаж үзэхийг гуйя. Хамба, ламтны үнэнч шударгыг хүн бүхэн мэдэх юм хойно гэж де Тревиль өчив.

Хамбаанай амгалан хэвээрээ, тэр нэгжилгээ болсон айлд би андуураагүй бол тэр шадар цэргийн нөхөрлөдөг беари нутгийн нэг залуу суудаг байхаа? гэж дуугарлаа.

-Их гэгээнтний янз нь д'Артаньяныг хэлж байнаа?

-Де Тревиль гуай таны өмөг түшигтээ багтааж байдаг залуу хүний тухай би ярьж байна.

-Яриагүй үнэн, их гэгээнтэн минь.

-Тэр залуу...хэнд муу нөлөө үзүүлсэн байж болохгүй гэж та санаж байна уу?

-Ерөөсөө хоёр дахин ахмад хүн Атос гуайд тэр үү? гэж де Тревиль хажуугаас нь хэлэв. Үгүй гэгээнтэн, болшгүй зүйл гэж үзэж байна. Түүнээс гадна д'Артаньян мөн манайд тэр орой байсан юм даг.

-Хачин хэрэг болох нээ! гэж хамба дуу алдав. Янз нь тэр орой хүн болгон л танайд байсан болох нь шив?

Уурласандаа де Тревилийн царай улайгаад,

-Их гэгээнтэн та миний үгний үнэн худалд арай эргэлзэж байгаа юм биш биз? гэж асуулаа.

-Яалаа гэж, бурхан өршөө! гэж хамба дуугарав, үгүй д'Артаньян ингэхэд хэдэн цагийн үед танайд байсан юм бэ?

-Үүнийг ч би их эзэнтэн танд бүр яг хэлээд өгчиж чадна. Түүнийг орж ирэхэд, уул нь над орой л болчихсон юм шиг санагдсан, гэтэл цаг хартал есөн цаг хагас болж байсан.

-Хэдэн цагийн үед д'Артаньян танайхаас явсан бэ?

-Арван цаг хагасын үед. Тэр хэрэг явдалболж өнгөрснөөс хойш цаг хир болоод доо. Де Тревилийн үгэнд өчүүхэн ч эргэлзэх хамба оамтан дийлдэж таарах тийшээ хандаж байгааг мэдэв.

-Үгүй гэлээ гэхдээ, Атосыг Авсчны гудамжинд байдаг тэр байшинд байхад нь баривчилсан шүү дээ гэж хамба хэллээ.

-Нөхөд улс нэг нэгнийдээ орж гарах хоригтой юм гэж үү? Манай сумангийн шадарцэргүүд, Дезассар гуайн сумангийн торгон цэргүүдтэй ах дүү шиг дотно сайн байцгаах хориотой юм уу?

-Атосын нөхөртэй очиж уулздаг тэр байшин сэжигтэй байсан байвал яах вэж? гэхэд, Ван хажуугаас нь үг оруулж, тэр байшин чинь сэжигтэй юм, үүнд л хамаг учир байна. Та өөрөө үүнийг мэдээгүй байж болох юмаа гэв.

-Тиймээ, их эзэнтэн, би үүнийг үнэхээр мэдээгүй. Гэхдээ лавтай хэлэхэд л тэр айлын д'Артаньян гуай суудаг хэсэг л яасан ч сэжигтэй байж тохирохгүй. Юу гэвэл их эзэнтэн танд түүнээс илүү үнэнч зарц гэж байхгүй, тэр өөрөө хамба ламтныг гүнээ хүндлэн биширдэг хүн үүний би баталж байна.

Ондууцаж царай нь улайчихсан хамбалам өөд вантан харснаа Кармелистон сүмийн дэргэд болсон золгүй тулалдааны үед де Жюссакийг шархдуулсан хүн чинь д. Артаньян биш биз? гэж асуув.

Де Тревиль яаран тосч аваад, маргааш өдөр нь Бернажуг дийлээгүй юу. Тиймээ их эзэнтэн тэр хүн мөн л дөө, та их ойтой хүн юм гэв.

-За тэгээд бид юу гэж шийдэх вэ? гэж ван асуулаа.

Хамба үүнд,

-Энэ чиг одоо миний шийднэ гэхээсээ, таны л шийдэх хэрэг дээ, их эзэнтэн. Тэр Атосыг би гэмтэй л гэж үзээд байна гэв.

-Тэгвэл би үгүй гэж байна гэж Де Тревиль дуу алдав. Гэвч их эзэнтэнд шүүгч нар гэж байдаг, тэгэхээр энэ хэргийгтэд л шүүж олог.

-Яриагүй зөв, гэж ван зөвшөөрөв. Энэ хэргийг шүүгч нарт шилжүүлье. Тэд ер нь шүүж учир олох ёстой улс хойно.

Де Тревиль дахин ам нээж,

-Одооных шиг ийм... зэвүүн цагт хүн хамгийн цэвэр сайнаар амьдарч, өөгүй сайн явлаа ч гэсэн шившиглэгдэж, хавчигдахаас зайлж чаддаггүй нь харамсалтай юм. Табүхэнд баттайяа хэлэхэд цагдаагийн элдэв аар саархан хэрэг будлианаас болж хатуугаар хавчигдэж мөрдөгдөх болсондоо цэргийнхэн тийм нэг их дуртай байхгүй л байх даа гэчихлээ.

Үг ч яриагүй болгоомжгүй үг. Де Тревиль үгнийхээ үнэ цэнийг мэдэж байгаад хэлж. Тэсрэлт гаргавал, түүнтэй уялдан гарах гэрэл гэгээнд орчин тойрон нь гийдэг болохоор Тревиль тэсрэлт гаргахыг хичээсэн юм байж.

-Цагдаагийн аар саар хэрэг төвөг гэнээ! гэж Тревилийн үгийг ван өлгөж дуу алдав. Цагдаагийн аар саар хэрэг төвөг гэнээ?

Энэ бүх хэргийн талаар эрхэм та ер юу мэдэж байгаа хүн бэ? Цаад шадар цэргүүдээ л даргалаад байж үз, биднийг бүү үймүүл. Таны хэлж байгаагаар бол нэг шадар цэргийг баривчлаад орхихын хамт Франц улс аюулд орчих юм шив. нэг шадар цэргээс болж юун их шуугиан бэ? Хэдэн арваар нь баривчил гэж би тушаанаа! Зуугий нь бүхэл сумангаар нь

баривчилъя даа байз! Тэгээд хэний чинь ч үг дуугарахыг хүлээхгүй.

-Хэрэв шадар цэргүүд, их эзэн танд сэжигтэй санагдаж байгаа болж гэм тэд гэмтэй гэсэн үг. Тэгэхээр их эзэнтэн танд би илдээ хураалгахад бэлэн. Юу гэвэл, хамба ламтан миний цэргүүдэд ял тулгаж байгаагаараа эцсийн эцэст над ял тулгаж байгаа гэдэг эргэлзээгүй хэрэг. Тэгэхээр би өөрийгөө нэгэнт баривчлагдаад байгаа Атос гуай, мөн лав л мөдхөн баривчлагдах д'Артаньян гуай нартай цуг баривчлагдсанд тооцвол дээр бизээ гэж де Тревиль хариулав.

-Гасконий зөрүүд хар чи ер дуугүй байна уу?, үгүй юу! гэж ван зандарлаа.

-Их эзэнтэн, нэг бол миний шадар цэргийг эгүүлж аль, үгүй бол хэрэг явдлы нь шүүж аль гэж де Тревиль дуугаа ер л үл намсган шаардав.

-Түүнийг шүүнээ гэж хамба хэллээ.

-Тийм бол бүр ч сайн. Тэгвэл түүнийг өмгөөлөх зөвшөөрөл надад хайрла их эзэнтэн минь. Ван бөөн хэрэг дэгдэхээс айв.

-Хэрэв их гэгээнтэнд, хувийн чанартай юм байхгүйсэн болж гэм гэж ван хэлэв. Ван юу хэлэх гэж байгааг хамба тааж мэдээд сэрэмжиллээ.

-Өршөөгөөрэй. Их эзэнтэн та намайг энэ хэргийн хувийн сонирхлын үүднээс үзэх үндэстэй гэж үзэж байгаа бол би шүүхийн ажилд оролцохоос татгалзаж байна, гэж хамба дуугарав.

-За тэгэхээр, энэ хэрэг явдлын үеэр Атос танайд байсан, үүнд оролцоогүй гэдгийг миний эцсийн нэр барьж ам алд гэж ван айлдлаа.

-Танай алдарт эцэг болон хорвоо дээр бүхнээс илүү хүндэтгэн хайрладаг таны нэрийг барьж андгайल्या.

-Эргэцүүлж үз дээ их эзэнтэн! Барьсан хүнээ бид таньчих юм болж гэм хэргийн үнэн учрыг өөрсдөө хэзээч олж мэдэхгүйд хүрнэ шүү дээ гэж хамба хэллээ.

-Шүүхийн эрхмүүдийг байцаах хэрэгтэй гэж үзсэн тухайд Атос хэзээд гар доор байх болноо. Атос хаашаа ч далд орчихгүй, хамба гуай та бүү санаа зов. Түүнийг би өөрөө дааж авьяа гэж де Тревиль хэлсэнд Ван зөвшөөрч,

-Нээрээ ч Атос алга болчих юм биш, де Тревиль гуайн хэлж байгаачлан хэзээ ч түүнийг олж болно. Түүнээс гадна гээд Ван дуугаа намсгаж хамба өөд царайчлах байртай харж, эдний дургүйг хүргээд яахав. Энэ чинь сайн бодлого юм шүү гэв.

ХШ Людовик Вангийн энэ бодлогыг дуулаад Ришельегийн инээд хүрч,

-Их эзэнтэн та зарлиг бол доо. Та л өршөөж хэлтрүүлэх эрхтэй шүү дээ.

Мөчөөгөө өгөхгүй санаатай байсан де Тревиль үүнд,

-Гэм хийсэн хүнийг л өршөөж болох юм биз. Миний шадар цэрэгт хийсэн гэх байхгүй, тэгэхээр их эзэн та түүнд өршөөл үзүүлэхгүй, шударга ёсыг гүйцэтгэх юм гэлээ.

-Агос тэгээд Фор-Левик гянданд байгаа юм уу? гэж ван асуулаа.

-Тиймээи их эзэнтэн, ганцаараа нэг өрөөнд, гаднын алив хүнтэй уулзах эрх байхгүй, хамгийн адгийн ялтан шиг чанд хоригдож байна.

-Чөтгөр алгад! Яалтай юм дээ? гэж Ван амандаа үглэнэ.

-Суллах тушаал бичээд л энэ хэрэг дуусах юм биш үү гэж хамба хэлэв. Их эзэн тантай би санал нийлж байна. Мөн де Тревиль гуайн даалтыг энээс цаашгүй сайнбаталгаа гэж үзэж байна гэлээ. Тревиль маш баярлаж, мэхийн ёслоход, сэтгэлд нь бас хар орж ирлээ. Хамба ламтан ингэж гэв гэнэт буулт хийсэнд орохноо, зөрж тэмцээд байсан нь Тревильд дээр санагдахсан билээ. Суллах тушаал, Ван гарын үсэг зурсанд, де Тревиль түүний нь авч яаран одов.

-Их эзэнтэн таны шадар цэргүүдийн даргацэрэг хоорондоо мөн ч санаа нэгтэй сайхан юм. Ажил албанд энэ их тустай, бүхэл сумангийн нэр төрөнд сайн зүйл байна гэж хамба хэлэв. “Хамба ламтан мөдхөн надыг нэг лут чадна гэдэг ч лавтай хэрэг. Ийм хүний дотроо юу бодож байгааг таахын эрх тун ч үгүй. За яаралгүй горьгүй. Ван яах ийхийн зуургүй шийдвэрээ өөрчилж мэднэ, дөнгөж сая сулласан хүнээ Бастили юмуу, Фор-Левик гянданаа эргүүлэх хорих гэдэг нэгэнт гянданд байгаа хүнийг гаргахгүй үлдээхээс ямар чгэсэн төвөгтэй шүү дээ” гэж де Тревиль бодлоо.

Де Тревиль гуай Фор-Левикт ихэмсгээр явж очоод амарлангуй хайшраг дүртэй байсаар агсан Агосыг суллаж авлаа.

Де Тревиль гуай д'Артаньянтай уулзсан даруйгаа хэлсэн нь:

-Энэ удаа таны аз дайрчээ. Де Жюссакийг шархдуулсан төлөөсийг өөрөөс чинь авсан, Бернажугийн шархны төлөөс бас үлдээд байгаатэгэхээр сэрэмжтэй байж үзээрэй гэв. Хамба ламтанд үл итгэн, хэрэг явдал бүрэн дуусаагүй гэж үздэг Де Тревилийн зөв байлаа. Шадар цэргийн даамлыг дөнгөж гараад хаалга хааж гүйцээгүй байхад их гэгээнтэн Ван өөд эргэж:

-Одоо бид хоёулахнаа үлдсэн хойно, их эзэнтэн та таалбал чухал ажил төрлийн тухай ярилцъя. Их эзэнтэн! Бекингэм герцог Парис хотноо тав хоноод дөнгөж өнөө өглөө мордсон байна гэж дуулгалаа.

XVI. ЗАХИРАГЧ СЕГЬЕ СУРСАН ЗАНШЛААРАА ХОНХНЫ СЭЖИМНЭЭС УГЗЧИХ ГЭЭД ОЛООГҮЙ ТУХАЙ

XIII Людовик ванд энэ үг чухам ямар сэтгэгдэл төрүүлснийг гаргаж өгүүлхүйеэ бэрх. Ван улс хийгээд явчихсанаа, царай нь дорхноо царцчихлаа. Ингээд хамба алдсан байраа ганц цохилтоор эргүүлэн авч чадсанаа даруй ойлголоо.

-Бакингем герцог Парис хотноо ирсэн гэнээ! Тэр юугаа хийж наашаа ирсэн юм бэ? гэж ван дуу алдав.

-Бодвол, танай дайсан Испаничууд, буруу номтон нартай хуйвалдаан хийхээр ирээ биз. -Үгүй! үгүй гэдгийг би андгайлъя! Де Шеврез авгай, де Лонгвиль авгай, ер нь Кондагийхантай хуйвалдаж миний нэр төрийг бузарлахаар иржээ.

-Их эзэнтэн минь! Таны толгойд яаж ийм тусгүй санаа төрнө вэ. Хатан өдий ухаалаг, тэгээд ч гол нь их эзэнтэн танд тийм их сайн юм чинь

-Хамба гуай, бүсгүй хүн гэгч сул дорой амьтан, сайн, хайртайгийн, хувьд гэвэл, би энэ талаар өөр саналтай байдаг юм

-Тийм гэлээ ч, Бекингем герцог наашаа данулс төрийн хэргээр ирсэн гэж би лавтай хэлж байна.

-Аа шал ондоо хэргээр ирсэн гэж би лавтай мэдэж байна. За гайгүй, хатан буруутай бол хохь нь дээ!

-Үнэхээр ч, тийм байж болно гэж санах хүртэл над хунд хэдий боловч... Их эзэнтэн та над нэг зүйлийг санууллаа. Их эзэнтэн таны даалгасан ёсоорде Ланнуа авгайг би хэд хэд дахин байцаасны эцэст их эзэгтэйг уржигдар шөнө орой болтол унтаагүй, өнөө өглөө хатагтай их уйлсан, өдөржингөө нэг юм бичээд л байсан юм гэж өнөөдөр над дуулгасан, гэж хамба айлтгав.

-Бүгдийг нь ойлголоо! мэдээжээр түүнд л бичиж. Хамбаа та над хатагтайн хамаг бичиг захидал сэлтийг аваад аль.

-Үгүй, яаж авах юм бэ, их эзэнтэн?

Миний санахад их эзэнтэн та, бид хоёрын аль алин нь үүнийг өөрсдөө хийж болохгүй мэт над санагдах юм.

Багтарч ядсан уур хилэнгээ барьж чадахгүй болсон ван дуу алдаж,

-д' Анкра Маршалын эхнэрийг яалаа даа? Хамаг шүүгээ шургуулгыг нь нэгжсэний эцэст, өөрийг нь нэгжсэн шүү дээ гэв.

-д' Анкра Маршалын эхнэр бол ердөө л Маршалын эхнэр, Флоренцоос ирсэн элдэвт дуртай

нэг бүсгүй байсан. Гэтэл их эзэнтний гэргий, өндөр сурвалжит Австрийн Анна хатан бол франц улсын вангийн хатан, өөрөөр хэлбэл хорвоо дээрх дээд их эрх сүрт хүмүүсийн нэг билээ.

-Тэх тусмаа хатны үйлдсэн гэм их хүнд юмаа. Герцог хүндэт их эрх хэргэмээ тэр хэдий хялбархан мартсан тусмаа, өөрөө төдий их гүн гутамшиг болжээ. Ер нь тэгээд ч энэ янаг амраг, улс төрийн элдэв хэрэг будлианыг тас цохъё гэж би аль эртний шийдээд байгаа юм. Хатны дэргэд би эндүүрээгүй бол де Порт гэж нэгхүн бий байхаа?

-Үнэнээ хэлэхэд тэр хүнийг ч би энэ бүх хэрэг будлианы гол оньс гэж тооцдог юмаа гэж хамба үг нэмэрлэв.

-Тэгвэл та миний нэг адил хатанг надад үнэнч биш байна гэж санадаг юм шив? -Хатагтайг вангийн төрийн эсрэг хуйвалдаан хийж байна гэж би хэлсэн, хэлж ч байна, гэхдээ вангийн нэр төрд харшлаа гэж хэлээгүйсэн билээ.

-Тэгвэл аль алины нь эсрэг хуйвалдаж байна гэдгийг би хэлж байна. Хатан над хайр дургүй, өөр хүнд сайн юм гэж би хэлж байна. Тэр муу Бекингемд хатныг сайн юм гэж би хэлж байна. Түүнийг энд Парис хотонд байж байхад нь та яагаад баривчлаагүй юм бэ?

-Герцогийг баривчлах гэнээ? Нэгдүгээр Карл вангийн тэргүүн сайдыг баривчлах гэж үү! Яаж болох вэ, их эзэнтэн минь! Ямар их шуугиан дэгдэх байсансан болоо! Хэрвээ тэгээд их эзэнтэн таны сэжиг их бага ч болов ор мөртэй болчихвол үүнд би одоо ч гэсэн эргэлзсээр л байна. Ямар их хэл ам, ямар айхавгар үзэгдэж дуулдаагүй их шившиг болохсон болоо!

-Тэр өөрөө л нэг муу, тэнүүлчин, хулгайч шиг биеэ аюулд учруулж явсан юм хойно, уул нь... гэснээ,

XIII Людовик ван амнаасаа гарчих шахсан үгнээс өөрөө айгаад луугүй болчихлоо. Тэгээд вангийн аман дээр гарч ирсэн тэр үгийг дуулчих гэж Ришелье дэмий хүзүүгээ сунган чих тавилаа.

-Уул нь юу гэж?

-Үгүй зүгээр, юу ч гээгүй...

-Гэхдээ Бекингэмийг Парис хотноо байх энэ хугацаанд та эрхбиш нүд салгалгүй мөрдөж байсан биз?

-Тэгсээн их эзэнтэн.

-Тэр хаа сууж байсан бэ?

Лагарп гудамжны далан тавдугаар байшинд.

-Тэр чинь хаа юм бэ?

-Люксенбург ордны хавьд.

-Бежимгэмийг, та тэгээд, хатантан уулзаагүй гэж лавгай мэдэж байна уу? -Хатанг би зохих үүргээ шударга үнэнч гүйцэтгэдэг хүн гэж үздэг.

-Гэхдээ, тэд нар бичгээр харилцдаг юм байна. Хатан бүхэл өдөржингөө түүнд л захиа бичээ шүү дээ. Герцог! Тэр захидлыг би заавал авч үзэх ёстой.

Их эзэнтэн минь ингэхэд...

-Герцогоо, Юу боллоо ч гэсэн би тэр захиаг олж авах хүсэлтэй байна.

-Гэсэн ч би их эзэнтэн танд нэг юм айлтгамаар...

-Хамба гуай та бас надаас уравчихлаа гэж үү, юунд миний хүссэн юм бүхнийг сөрөөд байх болчихоо вэ? Та хүртэл мөн Испаничууд, Англичууд Де, Шеврез авгай, хатан, эд бүгдтэй хуйвалдаад байгаа юм гэж үү?

Хамба санаа алдаад,

-Их эзэнтэн минь, ийм сэжигнээс өөрийгөө би гадуур юм бодож байсан юмсан гэлээ. -Тэр захидлуудыг олж авахсан гэж миний хэлснийг хамба гуай та дуулсан уу. -Авах ганцхан л арга байна...

-Ямар?

-Энэ хэргийг захирагч Сегье гуайд л даалгая, энэ чинь түүний хийвэл зохихажил яриагүй мөн.

-Тэгвэл, Сегьегийн хойноос даруй хүн явуулья.

-Тэр одоо манайд байх ёстой. Түүнийг би дуудсан юм. Тэгээд наашаа ирэхдээ хүлээлгэж байгаарай гэсэн юм даг.

-Хойноос нь даруй хүн яваг.

-Их эзэнтэн, таны тааллаар больё, гэвч...

-За бас юун "гэвч" вэ?

-Үгүй хатан тэр зарлигийг дагахаас татгалзаж мэдэхюм шүү дээ.

-Миний зарлигаас даврах гэж үү?

-Тийм ээ. Энэ зарлигийг ван өөрөө өгсөн гэж лавгай итгэхгүй бол тэгж болох юм. -За тэгвэл,

хатны эргэлзээг таслахын тулд би өөрөө очиж үүнийг урьдаас дуулгая.

-Хагарал гаргуулахгүйн тулд миний чадах хирээрээ" чармайсныг их эзэнтэн мартаггүй байгаа гэж горьдоно.

-Мартахгүй, герцог, хатагтайд таны гойд өршөөнгүй байдгийг би мэднэ. Дэндүү ч өршөөнгүй байдаг байж. Танд бүр урьдаас сануулчихъя, бид энэ тухай сүүлд дахин ярилцана. Их эзэнтний таалсан цагт ярилцъя. Гэхдээ, Францын ван вангийн хатан, та хоёрыг эвтэй найртай байлгахын тулд би биеэ гаргуунд гаргахад хэзээд ч сэтгэл бардам, сайхан байх болно.

-За сайн, сайн хамба гуай. Одоохондоо захирагчийн, хойноос хүн явуулж үз. Би хатан дээр очлоо.

Ингээд XIII Людовик ван үүд нээж, ордны өөрий нь суух хэсгийг Австрийн Анна хатны өргөөтэй холбосон гудамж руу орлоо.

Хатан бараа бологч бүсгүйчүүл, де Гито авгай, де Сабле авгай, де Монбазон авгай, де Гемене авгай нартай цуг сууж байв. Өрөөний буланд, Мадридаас хатантай цуг ирсэн Эстефания авхай сууна.

Де Гемене авгай юм уншиж, хатнаас бусад нь уншиж байгаа юмыг анхааран сонсоно. Хатагтай чагнах дүр үзүүлэн суугаад элдэв юм эргэцүүлж бодож сэтгэлээ дураар нь тавих боломжтой байх гэж юм уншуулья гэсэн байж.

Хатагтайн сэтгэлд, хожуу төрсөн дурлал нөлөөлж чимэгтэй байх хэдий боловч санаа бодол ер нь гунигаар дүүрэн. Эр нөхрийнхөө итгэлийг алдаж хамбын янаг сэтгэлийг үл ойшоосноор өс хонзон өвөрлүүлж хяхагдан хавчигдах болсон Австрийн Анна, вангийн эхийн явдлаас санамж авч, болох байлаа. Мөн хамбын янаг сэтгэл, өс хонзон, вангийн эх, Мария Медичи хатныг насан турш шаналган зовоосон билээ. Гэтэл тэр цагийн хүмүүсийн дурдатгал бичигт итгэх юм бол Хамба ламтны хүсэл сэтгэлийг Мария Медичи эхний үед хүлээн, гийгүүлж байсан юмбайх аа. Анна хатан үүнээс эрс дургүйцсээр байгаа билээ. Өөрийнхөө хамгийн үнэнч зарц нар, итгэлт нөхөд, дотно хайртай хүмүүсээ хөнөөгдсөөр байгааг Австрийн Анна хатан нүдээрээ үзэж байлаа. Золгүй хувьтай төрсөн улсын нэгэн адилаар хатагтай хавьтаж ойртсон бүхэндээ гай болдог байв. Үерхэж нөхөрлөсөн хүндээ хатан хөө болж, хавчлага мөрдлөгт оруулна. Де Шеврез авгай, де Верне авгай нарыг цөлчихсөн, де Порт хүртэл хэдийд л баривчлагдах бол гэж хүлээж байгаагаа өөрийн эзэгтэйгээс нуухгүй болжээ.

Хатан ийм гунигт бодолд автан сууж байтал үүд гэнэт нээгдэж, ван орж ирэв

Юм уншиж байсан хүн ч дороо таг болоод, бүсгүйчүүл: суудлаас босч, нам гүм болов. Ван мэндэлсэн ч үгүй, урагшаа хэдалхаад хатны өмнө очиж:

-Хатагтай, захирагч гуай одоо тань дээр орж ирнэ. Тэр хүн, танд өөрт чинь дуулга гэж миний даалгасан нэг юмыг дуулгах байх гэж зэвүүн дуугарав.

Хөөрхий хагагтайг баривчилна, цөлнө, шүүхэд ч билээ өгнө гэж сүрдүүлдэг болохоор, энгэсэг тавиад байсан мөртлөө царай нь цайраад явчихлаа.

Хатагтай биеэ барьж чадалгүй,

-Юу болоод тэр хүн ирэх гэж байгаа юм бэ, их эзэнтэн? Таны өөрөө над дуулгаж үл болохуйц ямар юм, захирагч гуай над дуулгадагсан билээ? гэж лавлав.

Ван юм хариулалгүй, өсгий дээрээ огцом эргэлээ, яг энэ үеэр харуул харж байсан торгон цэргийн даамал Гито, захирагч ирснийг дуулгав.

Захирагчийг орж ирэхэд ван өрөөнд байхгүй, нөгөө үүдээр гарч амжсан байлаа. Зовж хулгасандаа захирагчийн царай улайсан боловч, инээмсэглэсээр орж ирлээ.

Цаашаа яриан дундаа, энэ хүнтэй бид лав дахин уулзах байлгүй, тэхлээр одоо даруй ойр танилцаад авахад илүүдэх юмгүй.

Захирагч гэж сониноос сонин хүн юмсанж. Эх дагинын сүмийн гэсгүй де Рош Маль гэгч урьд цагт хамбын хиа явсаннэг хүн де Сегье гуайг их гэгээнтэнд шударга сайн хүн гэж танилцуулж өгсөн юм байж. Хамба тэр үгэнд итгэсэн, итгэсэн нь ч зөв болжээ.

де Сегье гуайн тухай элдвийн яриа явдгийн дотор, нэг сонин юм ярилцдаг билээ.

Залуу насаа цалгиж өнгөрөөсний эцэст, мань хүн залуу цагийнхаа болчимгүй явсан нүглийг наманчлахаар түрзуур хийдэд суухаар шийдэж гэнэ.

Гэтэл тэр ариун сүмд орохдоо хөөрхий нүгэлт хүн хойноосоо хаалга сайн хааж амжсангүй, нөгөө амар заяа үзүүлдэггүй шунал тачаал мөн араас нь цуг дагаад орчхож дээ. Сегье гуай цаг ямагт шунал тачаалд автан зовоод болдоггүй тэгээд хийдийн ширээт ламд учир зовлонгоо гаргаж хэлсэнд шуналд автагдсан цагт, тачаалын шулмыг хөөхийн тулд, хонхны сэжмээсшүүрч аваад байдаг чадлаараа угзарч бай гэж зөвлөж гэнэ. Хонхны чимээг гэлэнгүүд дуулаад, өөрсдийнхөө нэг нөхөр тачаалд автан зовж байгааг мэдэж цөм мөргөл үйлдэх болно гэжээ.

Энэ үг, хожим захирагч болох тавилантай байсан Сегье гуайн санаанд таалагдаж гэнэ. Муу шулмыг Сегье гуай өдий төдий санваартны үйлдсэн бөөн их мөргөл уншлагаар хөөгөөдбайж, гэтэл нэг нөгцсөн шулам тийм ч амархан тонилдоггүй юмсанж: Мөргөл уншлага олдоод байхын зэрэгцээ шулам хөөрхий хүнийг улам ч их тачаадуулах болж нүглээ наманчилж байгаа хүний шунал тачаалаа дарах гэсэн хүслийг хонхны дуу тасралгүй илтгэн жингэнэх болжээ.

Санваартнуудад амар заяа үзэх ганц ч минут байдаггүй. Өдөржингөө мөргөлийн өргөө рүү шатаар дээш доошоо холхидог санваартнууд шөнийн цагт зохих залбирал мөргөлөөсөө гадна лав хорь гуч дахин босон харайж, өөрийнхөө шалан дээр сунан мөргөөд залбирал уншихад хүрдэг байжээ.

Эцэстээ шулам тонилж таарсан юм уу, санваартнууд залхаж халсан юм уу, бүү мэд, юу ч

болсон гурван сарын дараа нүглээ гэмшиж байсан хүн хийдээ орхиод ирчихсэн, улсын дунд, хорвоо дээр урьд хожид үзэгдээгүй их дэггүй хүн гэдэг цуутай л болчихсон юм гэнэ.

Хийдээс гарч ирээд мань хүн шүүгч цолтой болж, цаашаа авга ахынхаа оронд Парламентын дарга болсон, хамба ламтны талд орж захирагчийн тушаалд томилогдсон юм байж. Хамбын талд орсноор Сегье гуайн алсын хараатай нь мэдэгдэж байгаа хэрэг. Хамба ламтнаас вангийн эх, хатагтайг өсөлж мөрдөн хавчихад тусалдаг байсан ба Австрийн Анна хатны эсрэг арга явуулгаа хийхэд үнэнч туслагч болж байгаа юм гэнэ. Шалегийн хэрэг гэгчийг шүүж байхад шүүгч нарыг өдөөн хатгаж байсан, эдийн засгийн их ухаантан Лафемагийн сэдсэн хэрэг бүхнийг дэмжиж байсан, тэг тэгсээр хамбын итгэлийг арга буюу бүрэн хүлээх болсон хүн юм. Тэгээд одоо ер бусын хачин даалгавар авсныгаа гүйцэтгэе гэж хатан дээр ирээд байгаа нь энэ билээ.

Захирагчийг орж ирэхэд хатан зогссон хэвээр байснаа, түүнийг хармагцаа даруй суудалдаа сууж, бараа бологчдоо мөн сандал, олбогон дээрээ суу гэж дохив. Тэгээд орж ирсэн хүн өөд ихэмсгээр эргэж:

-Та яах гээ вэ, эрхмээ? Ямар хэрэгтэйта наашаа ирэв? гэж асуулаа.

-Их эзэгтэй таныг би хэдий гүнээ хүндлэн үздэг боловч, вангийн зарлигаар, таны бүх бичиг сэлтийг нарийвчлан нэгжихээр ирлээ гэсэнд хатан дуу алдаж,

-Юу гэнээ, эрхэм ээ? Намайг нэгжинэ гэнээ?... намайг уу? ямар дуулдаагүй, булай муухай хэрэг вэ!

Намайг өршөөж үз, их эзэгтэй, Одоо би зөвхөн вангийн тааллыг дагаж байна. Их эзэнтэн сая өөрөө энд ирж, намайг ирэхэд бэлэн байхыг танд захиагүй гэж үү?

-Нэгжиж үз эрхэм ээ. Бодвол би гэмт хэрэгтэн хүн юм байлгүй. Эстефания миний бүх ширээ, шүүгээний түлхүүрийг энэ хүнд өг.

Өдөр бичсэн чухаг захидлаа хатагтай ширээ, шүүгээнд хадгалаагүйг захирагч гуай хэдий сайн мэдэж байсанболовч, ёс болгож онгичив.

Шүүгээ, ширээний нүднүүдийг хорь дахин уудалж онгичсоныхоо дараа захирагч гуай хулчганасхийх сэтгэлээ барьж, энэ хэргээ шувглах, өөрөөр хэлбэл хатныг нэгжихэд хүрлээ.

Захирагч гуай Австрийн Анна хатан өөд эргэж хараад

-Одоо, би нэгжих гол юм уруугаа орохоос өөр замгүй боллоо гэж Сегье гуай хэлэхэд дууны нь өнгөнд зовж, тэвдсэн байдал илэрхий.

Захирагчийн санааг ойлгоогүй юм уу, ойлгохыг зүрхшээсэн хатан.

-Ямар? гэж асуув.

-Хатагтайн өнөөдөр захиа бичсэнийг их эзэнтэн багтай мэдэж байна. Тэр захиаг явуулах хүнд

нь явуулж амжаагүйг их эзэнтэн бас мэдэж байна. Таны ширээ шүүгээ аль алинд тэр захидал алга. Гэтэл тэр захиаг энд нэг газар нуусан байх ёстой.

-Та арай хатан эзэгтэйдээ гар хүрч зүрхлэх гээгүй биз! гээд Австрийн Анна босч, захирагчийн өөдөөс, заналхийлсэн харцаар ширтэв.

-Би вангийн. үнэнч зарц их эзэнтний тушаасан бүхнийг гүйцэтгэдэг хүн. -Яахав ээ. тэр чинь үнэн. Хамба ламтны тагнуул туршуул этгээд үнэнчээр мэрийж. Би нээрээ өнөөдөр захиа бичсэн, тэр захидлаа илгээгээгүй, энд байна гэж хатан хэлэв.

Ингээд хатан сайхан гараа элгэн дээрээ тавилаа.

-Тийм бол их эзэгтэй, та тэр захидлаа надад өгч, үз, гэж захирагч гуйв. -Үүнийг би ганцхан ванд л өөрт ньөгнөө, эрхэм ээ гэж хатан хариуллаа.

-Ван өөрөө энэ захидлыг танаас авья гэсэн бол өөрөө танаас гуйхсан бизээ. Тэхээр, ван энэ захидлыг шаардаж ав гэдгийг над даалгасан гэдгийг дахин өчье.

Таныг дагахгүй болж гэм.. Тэгээд!

-Намайг аваарай л гэж ван даалгасан.

-Юу? Та юу гэх гээд байна?

-Надад их эрх олгосон, тэр захидлыг олохын тулд, их эзэгтэй таны биеийг хүртэл нэгжих эрх олгосныг дуулгая.

-Ямар муухай шившиг вэ гэж хатан дуу тавилаа.

-Мм, хатагтай та аяыг дагаж үз дээ.

-Та даанч хэрцгий балмад загнаж байна. Та үүнийгээ ойлгож байна уу, эрхэм ээ? -Вангийн зарлиг, их эзэгтэй минь. Намайг өршөөж үз.

-Үүнийг би тэсвэрлэж чадахгүй, зүгээр үхсэн нь үүнээс дээр? гэж хатан дуу тавилаа. Испани, Австри орнуудын эзэд дээдэс угсаатай хатны бардам зан хөдөлжээ.

Захирагч гүнээ мэхийн ёслов. Дараа нь даалгасан зүйлийг гүйцэтгэхээс, өчүүхэн ч үл ухрах шинжтэй, нэгэнт сүхээ далайсан яргачин мэт шийдмэгээр Австрийн Анна өөд дөхөж, ирэхэд, хатны нүднээс хорссондоо нулимс асгаран гарлаа.

Хатан үнэхээр гуа сайхан хүн байсныг бид дээр дурсаж байсан. Тэхээр хэн нэг хүнд ийм юм даалгах гэгч халтай байсан гэвч Бекингэм герцогт жөтөөрхөх сэтгэлдээ автсан ван хатнаа өөр хэнтэй ч жөтөөрхөх сэхээгүй байж.

Сегье захирагч энэ минутад бодвол нөгөө хонхныхоо сэжмийг хавьдаа лав хайсан байх, тэгээд сэжим олдохгүй болохоор хатны өөрт нь захиа байгаа гэж хэлсэн тэр газар өөд гараа

сунгалаа.

Австрийн Анна хатан гэдрэгээ алхам ухраад, амь тавихын даваан дээр байгаа мэт зэвхий царайлаад явчихлаа. Унахгүйн тулд хатагтай ардаа байсан ширээг нэг гараараа тулаад, нөгөө гараараа цээжиндээ нуусан захидлыг авч захирагчид өгөв.

-Энэ захиаг авч үз, эрхэм ээ гэж хатан догдолсондоо тасалдсан дуугаар хэлээд наадахаа аваад, миний нүдэнд булай болохгүй тонилж аль гэв.

Захирагч, яахав арга буюу сэтгэл догдолсондоо чичирсээр захидлыг авч, доор мэхийн ёслоод гарч одов.

Түүнийг гарч үүд хаав уу. үгүй юу, хатагтай, бараа бологч бүсгүйчүүлийнхээ гар дээр бараг ухаангүй ойчоод өглөө.

Захирагч захидлыг үзсэн ч үгүй ванд аваачиж өгөв. Захидал авахаар сарвайсан вангийн гар чичирнэ. Гаднах хаягийг нь эрээд олсонгүй, вангийн царай аягүй зэвхий даагаад явчихлаа. Захидлыг алгуур тэнийлгээд, эхний нь мэрийг унштал Испанийн ванд бичсэн захидал байхыг үзээд хурдхан гүйлгэж уншив.

Энэ захиа чухамдаа Хамба руу довтлох бүхэл бүтэн төлөвлөгөө аж.

Австрийн вангийн угсааг доромжлон дайрахыг ямагт эрмэлзэгч Ришельегийн явуулж байгаа бодлогыг өөрсдийгөө доромжилсон хэрэгт тооцдог ахыгаа болон, Австрийн ванг Францад дайн зарлахаар сүрдүүлээд, харин хамба ламтныг тушаалаас нь огцорвол харилцан найрамдалтай байж болох юм гэсэн болзол тавиагч гэж Анна хатан гуйжээ.

Янаг дурлалын тухай энэ захианд ганц ч үг байсангүй.

Вангийнсанаа даруй амраад, хамба ламтан ордонд байгаа эсэхийг мэдэхээр хүн явуулав. Их гэгээнтэн ажлын өрөөнд вангийн зарлигийг хүлээж сууна гэж дуулгалаа.

Ван даруй хамба дээр орлоо.

-Үгүй, ингэхэд, герцог таны зөв, миний буруу байж таарчээ. Бух явуулга цөм улс төрийн чанартай, тэгээд, энэ захианд хайр сэтгэлийн тухай ганц ч үг алга. Гэхдээ таны тухай энд их бичиж дээ гэж ван хэллээ.

Хамба захидлыг авч маш хянуур уншиж үзсэнээ, эцсийг нь хүрээд дахин нэг эргэж уншив.

Яая гэх вэ, их эзэнтэн. Миний өстнүүд яах дээр тулж байгааг өөрөө үзэж байгаа биз. Намайг халахгүй юм бол танд хоёр зэрэг дайн зарлахаар сүрдүүлж байна. Би л та сан бол өдий хүчтэй шахалтын дор аргагүй л буулт хийх байсандаа. Нээрээ шүү. Би ч хувьдаа ажил албанаас холдвол их жаргахсаан гэж хамба өчлөө.

-Та юу гэвээ, герцог!

Энэ эх захгүй хүнд ажил чадал, оюун шавхсан хурц тэмцлээс болж миний эрүүл мэнд сүйдэж байгааг айлтгаж байна, их эзэнтэн. Ларошель хотыг бүсэлж авах үеэр ядрах туйлдахыг би янз нь дийлэхгүй дээ гэж байна. Тэгээд та дайн дажны хэргийг жинхэнэ эрхэлж явуулбал зохих де Конде гуайд тэр хэргийг даалгаж үз.

Сүм хийдийн ажил төрөл эрхлэх ёстой намайг уул авьяас тавилантай юманд минь зүтгүүлэхгүй, огт дур хүсэлгүй өөр юм албаар хийлгээд яах билээ. Ингэвэл тагэр бүлийн хувьд ч улам жаргалтай сайхан болно, гадаад улсад ч билээ, таны нэр төр улам дээшилнэ гэдэгт би лав итгэж байна.

Ван үүнд хариу болгож,

-Герцог та бүү санаа зов. Би өөрөө бүх учрыг ойлгож байна. Энэ захидалд нэр гарсан хүн бүхэн зохих цээрлэлээ хүлээнэ. Хатагтай ч мөн түүнээс зайлахгүй гэлээ.

-Ээ. их эзэнтэн та юү гэвээ! Бурхан өршөө та минь, надаас болж хатагтай өчүүхэн ч болов аягүй юм үзвэл ч дүүрчээ! Их эзэнтэн таны өмнө би хатагтайг ямагт өмгөөлдгийг та өөрөө гэрчилж болох хэдий боловч, хатан намайг дайснаа гэж үзсээр ирсэн юм. Харин хатагтай санаагаа буруулж их эзэнтэн таны нэрийг шившиглэсэн бол би л хүнээс түрүүн: "гэмтэнд өршөөл гэж байхгүй" гэх байсан. Аз болоход энэ тухай яриа ч алга. их эзэнтэн та үүнд дахин үнэмшлээ шүү дээ:

-Энэ ч зөв өө, хамба гуай. Та ер нь дандаа зөв байдаг хүн хойно. Гэлээ гэхдээ, хатагтайд миний уур хүрч байна.

-Их эзэнтэн, та өөрөө хатны өмнө буруутай. Хатан танд уурлах юм бол буруу гэх газар огт үгүй. Их эзэнтэн та, хатагтайд хэт ширүүдсэн.

-Өөрийнхөө болон таны өстнүүдтэй би яг л ингэж хатуу ширүүн үзэх болно, тэд хэдий өндөр эрх хэргэмтэй байлаа ч гэсэн тэр, ингэж хатуулснаар өөрт минь хэдий халтай байсан ч тэр. - Хатан миний өстөн хэдий боловч их эзэнтэн таны өстөн бишээ. Харин ч өөлөх өөгүй үнэнч дуулгавартай сайн гэргий билээ. Их эзэнтэн таны өмнө хатагтайг өмөөрье. -За тэгвэл яахав хатан өөрөө зөөлөрч, эвлэрэхийн сэжмийг хатан өөрөө гаргаг. -Үгүй харин их эзэнтэн та сайхан үлгэр дууриал болж үз. Ингэхэд хатанг харддаг таны буруу байсан шүү дээ.

-Би эхэлж эвлэрэхийн арга хийх гэж уу? -Яасан ч үгүй гэж ван дуу алдав. -Тэгж үз, их эзэнтэн гуйя танаас,

-Үгүй тэгээд, ямар аятай шалтаг олох юм билээ? -Хатагтайд таалагдахуйц нэг юм хийхгүй юу.

-Юу тэр вэ?

-Бүжиг наадам зохио. Хатагтайн бүжигт дуртайг та мэднэ хойно Ингэж анхаарал өршөөл үзүүлбэл хатагтайн уур эрхгүй тавигдана, би баталъя.

-Ийм элдэв цэнгэлд миний дургүйг хамба гуай та мэдэхсэн биш билүү.

-Тиймэрхүү цэнгэлд таны дургүйг хатан мэддэг тусмаа, танд улам чбаярлана. Тэгээд ч бас нөгөө төрсөн өдрийн нь ойгоор таны бэлэглэсэн, сайхан алмазан унжуургаа зүүж харуулах завшаан хатагтайд гарч байна Түүнийгээ зүүж гоёх учрал ер тохиолдоогүй байгаа шүү дээ.

Хатныг өөрт нь нэг их юман чинээ санагдахгүй хэрэгт гэмтэй болж, айж зовж байсан хэрэгт нь цагаан гарсанд сэтгэл тэнийсэн ван, хатантай эвлэрэхэддуртай байсан болохоор: -За яахав үзье хамба гуай. Үзэж байж больё. Чухам гэхэд та ер хатанд дэндүү өршөөнгүй байна шүү.

Хамба үүнд, -Их эзэнтэн, хатуу ширүүн аашлах ажлыг сайд нарт ноогдуулчих, сайн үйл, нигүүлсэнгүй занг ван өөртөө ноогдуулж, түүнийг мөрдөөд үз, лав тус болох бий. гэж хариулав. Ингээд, арван нэгэн цагцохихыг хамба ламтан сонсоод доор мэхийн ёсолж, явж амрах зөвшөөрөл ирэв. Хатантай эвлэрэхийг вангаас дахин гуйгаад, харьж одлоо.

Захидлыг нь булааж авснаас хойш, зэмлэл сонсохыг хүлээж байсан Австрийн Анна хатан, маргааш өдөр нь ванг эвлэрэх аян шалтаг эрээд байхыг үзэж гайхлаа. Эхний үед

хатагтай эвлэрэхээс татгалзахад бэлэн байв. Бүсгүй хүний бардамсэтгэл, хатан хаан хэргэмийг хэтэрхий хүнд доромжилсон тул гомдлоо даруй мартаж чадахгүй байлаа. Гэхдээ бараа бологч бүсгүйчүүлийн ятгалгад орж, эцсийн эцэст болсон явдлыг мартаж байгаа дүр үзүүлэх боллоо. Хатны ааш ийнхүү зөөлөрч байгааг ван ашиглаж, ойрын өдрүүдэд том бүжиг наадам зохиох санаатай байгаагаа дуулгав.

Хөөрхий Австрийн Анна хатанд бүжиг наадам гэгч гойд ховор цэнгэл болохоор үүнийг дуулмагцаа хамба ламтны гадарлаж байсанчлан гоморхохын шинж, зүрх сэтгэлээс нь гэхээ байя, царайнд нь л лав үгүй боллоо. Тэр баяр наадам ямар өдөр болохоор тогтоосныг хатан асуусанд, энэ талаар хамбатай урьдчилан ярьж тохирох хэрэгтэй гэж ван хариуллаа.

Үнэхээр ч тэр баяр наадмаа хэдий хийхийг ван өдөр бүр хамбаас асуухад, цаадах нь ямар нэг шалтгаар өдрийг Я1 тогтоохоос булзсаар байлаа.

Бүтэн долоо хоног өнгөрлөө.

Сая биднийг ярьсан хэрэг явдал болж өнгөрснөөс найм хоногийн дараа хамба Лондон хотоос бичсэн нэг захидал авсанд ердөө ийм хэдхэн мөр бичсэн нь:

"Битүүнийг олж авлаа. Мөнгө дутагдаад, Лондонгоос гарч чадахгүй байна Над таван зуун алтан зоос явуулна уу, мөнгө авснаас хойш би дөрөв, тав хоноод Парист очсон байх болно" гэжээ.

Хамбыг энэ захидал хүлээн авсан тэр өдөр ван түүнээс нөгөө л хугацааг асуув. Ришелье хуруу даран тоолж үзээд, дотроо:

" Мөнгө аваад дөрөв юмуу тав хоноод ирнэ гэж авгай бичсэн байна. Мөнгө Лондонд очтол тав хононо, өөрөө иртэл мөн тав хоног, зуурдын алив саад, далай гатлахад сөрөх салхи гарах, ядрах сэлтийг оролцуулж бодоод арван хоёр хоног ..." гэж бодлоо.

-За яав, герцог, та бодож гүйцэв үү? гэж Ван асуув.

-Тэглээ, их эзэнтэн. Өнөөдөр намрын эхэн сарын хорин. Хотын ахлагч нар дунд сарын гурванд баяр хийх юм. Ингээд сайхан аяс гарч байна. Таныг хатанд ая засаж байна гэж тэхлээр хэний ч толгойд орохгүй.

Хамба Ламтан жаал дуугүй байснаа ам нээж:

-Ингэхэд байна, хатагтайд нөгөө алмазан унжуурга нь зохих эсэхийг үзэхсэн гэж байгаагаа сануулахыг та бүү мартаарай гэв.

XVII. БОНАСЬЕ ГУАЙ, БОНАСЬЕ АВГАЙ ХОЁР

Энэ алмазан унжуургын тухай хамба ламтан яриандаа хоёр дахин дурсаж байгаа болохоор, энэ зөвлөгөөний цаана нэг нууц юм байна гэж XIII Людовик ван бодлоо.

Хамба лам, хэдий өнөө цагийн нарийнаар тагнан мөрдөгч цагдаагийн газарт хүрэхгүй гэлээ ч сайнаас сайн тагнуул туршуулуудтай болохоороо вангийн гэр бүлийн хэргийг вангаас өөрөөснь илүү сайн мэдэж байдагт аягүйцэх удаа ванд олон учирч байжээ. Энэ удаа Австрийн Анна хатантай ярилцвал үл ойлгогдох энэ хэргийн сэжим нэг мэдэгдэх юм магад гэж ван бодлоо. Ингээд их гэгээнтний мэдэж ч байж болох үгүй ч байж мэдэх нэг нууц юмны учрыг олж мэдчихээд хамбатай эргэж уулзахаар горьдож байв Альч байлаа гэсэн ингэвэл ван өөрөө сайдынхаа нүдэнд өргөмжлөгдөхсөн билээ.

XIII Людовик ван хатан дээрээ очоод, ердийнхөө заншлаар, ойр дотнын нөхдийг нь хөнөөхөөрөө сүрдүүлж яриа үүсгэв. Энэ бөөн зэмлэлийг Анна хатан нэг л дуусах байлгүй гэж горьдоод доошоо харан чагнаж суулаа. Гэтэл Ван яриагаа тэгж дуусгахыг хүссэнгүй. Ван хэрүүл гаргаж хэрүүлэндээ улайрахын үед энэ хэргийн учир, ямраар ч хамаагүй илэрч болох юм гэж бодлоо. Хамба ламын дотор нэг юм байна. Хүний санаанд багтахгүй нэг айхавтар юм гэнэт гаргаж ирэхээр бэлтгэж байна гэдгийг ван лавтай мэдэж байв. Хамба тийм юм хийхдээ уулын гарамгай хүн. Ван буцалтгүй зэмлэсээр байгаад, хатны дургүйг хүргэж чадлаа.

Битүүлэг үг цухуйлгаж зэмлээд салахгүй байхаар Анна хатан тэсэж чадалгүй унтууцаж,

-Их эзэн та дотроо бодсон юмыг шуудхан гаргаад хэлчхэд яасан юм бэ? Би юу хийчхээ вэ? Ямар гэмт хэрэг үйлдэж орхив? Энэ бүх үг яриаг, их эзэн та лав л минийахад бичсэн захидлаас болж дэгдээгээгүй баймаар юм гэлээ.

Ингэж эрс шууд асуусанд, ван хэлэх үгээ даруй олсонгүй. Баяр наадмын өмнөхөн хэлбэл зохих байсан тэр угийг хэлэх хамгийн тохиромжтой цаг гэж ван шийдээд,

Ихэмсгээр.

-Хатагтай, ойрын өдрүүдэд хотын яамны байранд бүжиг наадам болноо. Тэхлээр манай сайн ахлагч нарыг хүндэтгэж та бүжиг наадамдээр гоёлын хувцастай мөн төрсөн өдрийг тань тохиолдуулж миний бэлэглэсэн алмазан унжуургыг заавал зүүж очоорой. Миний хариу энэ дээ гэв.

Хариу ч аймшигтай хариу байлаа. Ван хамаг хэргийн учрыг мэдчихсэн, зөвхөн хамбын хатгалгаар л энэ бүх бүтэн долоо хоногийн турш биеэ барьж явсан юм байх гэж Австрийн Анна хатан бодлоо. Ер нь ч ванд юмаа нуугаад байдаг тийм зан байдаг юм байж. Хатны царай хачин зэвхийрээд, цагаан лаваар барьсан юм аятай харагдах гуа сайхан гараараа жижиг ширээ түшиж авлаа. Вангийн өөдөөс айж хиртхийсэн харцаар ширтээд, ганц ч уг дуугарсангүй

-Хатагтай та дуулав уу? гэж хатны ийнхүү тэвдэж байгааг үзээд, хэдий учрыг нь олоогүй боловч, бах нь ханасан ван асуулаа.

-Дууллаа, эрхэм ээ гэж хатан шивнэлээ.

-Тэр бүжиг наадамд та очих уу?

-Очноо.

-Та тэгээд, алмазан унжуургаа зүүх үү?

-Зүүнээ.

Хатны царай улам зэвхийрэв. Ван үүнийг ажлаа. Тэгээд хатны мухардаж байгаад бах нь ханаж, өөрийнхөө зан төрхийн хамгийн аягүй тал болох цэвдэг хүйтэн зангаараа ажиг ч үгүй хэлсэн нь: -За тэгвэл, шийдлээ шив. Миний дуулгах гэсэн юм ердөө л энэ дээ гэв. -Үгүй ингэхэд, бүжиг наадмаа хэдэнд хийхээр тохирсон юм бэ? гэж Австрийн Анна хатан асуулаа.

Хатны дуу чухам нэг амьсгаа хурааж бий хүний дуу шиг байсанд, ван энэ асуудалд нь хариулахын хэрэггүй юм гэж мэдээд,

-Асар удахгүй дээ, хатагтай, гэхдээ би өдрийг нь яг санахгүй байна. Хамба гуайгаас асуух юм байна гэж ван дуугарлаа.

-Тэгвэл их гэгээнтэн бүжиг наадам зохиохыг танд зөвлөж ээ? гэж хатан дуу алдав. -Тэгсээн, авгайтан. Та юунд үүнийг асуугаа вэ? гэж ван гайхав.

-Алмас эрдэнийн унжуурганы тухай над сануулахыг мөн хамба хэлээ юу?

-Танд юу ч гэх юм дээ...

-Тэр тэгжээ, их эзэнтэн, лав тэр тэгсэн байна шүү! -Тэр ч тэгсэн юм уу, би ч хэлсэн юм уу адилхан юм биш үү? Энэ гуйлтыг та арай буруутайд үзээгүй биз?

-Үгүй эрхэм ээ?

-Тэгвэл та очих юм шив?

-Очноо.

-За сайн. Таныг хэлсэн амандаа хүрэх биз гэж би горьдоно гэж ван гарч явахдаа хэлэв. Хатан ёсыг дагалаагэхээсээ, өвдөг ий нугарчих гээд байсан тул нахисхийн ёслов. -Ван ихээ сэтгэл ханамжтай гарч одлоо.

Би дүүрлээ, дүүрлээ. Хамба бүгдийг мэджээ. Ван одоогоор юу ч мэдэхгүй байгаа, гэхдээ мөдхөн бүгдийг мэдэх болноо. Хамба л ванг миний өөдөөс турхираад байгаа хэрэг. Би ч дүүрчээ. Бурхан минь! Бурхан минь гэж хатан шивгэнэв.

Хатан сөхрөн суугаад, чичирхийлсэн гараар нүүрээ таглан, залбирал уншиж гарав.

Байдал үнэхээр хүнд болжээ. Бекингэм герцог Лондонд буцаад харьчихсан, де Шеврез авгай Тур хот руу буцчихсан байлаа Өөрийгөө урьд урьдынхаас илүү чанд мөрдөн хянаж байгааг хатан мэдэж, бараа бологч шивэгчдийн нэг нь өөрий нь туршин ховлож байгааг бүдэг бадаг гадарлавч. чухам хэн болохыг мэдэхгүй байлаа. Ла Порт гуай ордноос гадагшаа гарах боломж байдаггүй, хатагтайд итгэж найдчихаар хүн даанч гэгээн ертөнцөд алга байлаа.

Өөртөө тулгарч байгаа аюул хир их болоод, өөрөө ийнхүү ганцаардаж байгаагаа бодоод хатагтай тэсэж чадсангүй эхэр татан уйллаа.

Гэнэт , нэг бусгүй хүний гүнээ өрөвдсөн, усгал дуу гарч,

-Их эзэнтэн танд би ямар нэг юмаар тус болж чадахгүйсэн болов уу? гэлээ.

Хатан цочмог эргэж харлаа. Ийм дууг сонсоод эндүүрхүүеэ бэрх, зөвхөн нөхөр хүнээс л ийм дуу гарч чадах билээ.

Үнэхээр ч хатны өрөө рүү орох хаалгануудын нэгэн дээр хөөрхөн Бонасье авгай зогсож байв. Бонасье авгай зэргэлдээ бяцхан өрөөнд хатны бошинз, дотуур хувцсыг янзалж байгаад, ванг орж ирэх үед явж амжаагүй байжээ. Тэгээд хамаг яриаг сонссон юмсанж.

Хатан өрөөндөө өөр хүн байсныг мэдээд чанга дуу

алдав.

Айж сандарчхаад байсан хатан Ла Порт гуайн олж өгсөн залуу бүсгүйг даруйдаа таньсангүй.

Эзэгтэйнхээ ийнхүү цөхөрч ядсаныг үзээд залуу бүсгүй өөрөө мөн нулимс урсган, гараа базалсаар,

-Их эзэгтэй та бүү зов. Би чухам бие сэтгэлээрээ их. эзэгтэй танд үнэнч хүн. Та бид хоёрын хооронд хэдий их зайтай, таны дэргэд би хэдий өчүүхэн хүн боловч их эзэгтэй таныг гай зовлонгоос гэтэлгэх арга сүвэгчилж чадсан шиг надад санагдах юм гэв.

-Та юу? Ээ бурхан минь! та юу? гэж хатан дуу алдаад,. Алив наашаа эгц хар, биеэ худалдсан муу улс намайг хүрээлж байдаг юм. Танд тэгээд би итгэчих болох юм уул

Залуу бүсгүй хатны өмнө сөхрөөд,

-Их эзэгтэй! Таны төлөө би амиа өгөхөд бэлхэн гэдгээ тангараглаж байна! гэж дуу алдав. Залуу бүсгүйн сэтгэлийн гүнээс гарсан энэ дууны үнэн эсэхэд эргэлзэхийн эрхгүй байв.

Бонасье авгай үгээ залган, таны хэлдэг үнэн, урвасан муу хүн энд бий. Гэвч, гэгээн дар эхийн нэрийг барьж андгайлахад их эзэгтэй танд надаас илүү үнэнч сайн хүн ер. үгүй. Вангийн асуугаад байгаа тэр унжуургыг та Бекингэм? герцогт өгсөн. Тийм биздээ? Түүний аваад явчихсан зандан. хайрцган дотор тэр унжуурга байсан биз? Миний хэлж байгаа үнэн биз, аль би эндүүрч байгаа болов уу?'

Айсандаа шүд нь тачигнатал чичирч байгаа хатагтай,

-Бурхан минь! бурхан минь! гэж шивнэнэ.

-Тэхлээр тэр унжуургыг одоо эгүүлж авчрах хэрэгтэй болж байх шив гэж Бонасье авгай хэллээ.

-Тиймээ, эгүүлж авчрах хэрэгтэй байлгүй яахав. Үгүй. тэгээд яаж түүнийг авчирдаг билээ та минь? гэж хатан луу тавилаа.

Герцог руу нэг хүн явуулах хэрэгтэй.

-Хэнийг тэр вэ? Хэнийг? Итгэж болох хүн хэн байна.

-Их эзэнтэн та надад итгэ. Надад тийм их өршөөл; үзүүлбэл, явах хүн би олъё. -Үгүй тэхлээр юм бичижтаарнаа!....

. -Тэгэлгүй горьгүй. Таны гараар бичсэн ганц хоёр ч билээ үг, мөн таны өөрийн тамга хэрэгтэй. -Үгүй тэр хоёр үг чинь, миний ялын баримт, нөхрөөсөө салж, цөлөгдөх гэрч шүү дээ,

-Үл бүтэх этгээдийн гэрт орвол тэгнээ. Гэвч тэр зурвас хүргэх хүндээ хүрнэ гэж би танд амлаж байна.

-Бурхан минь! Амьдарлаа, шударга сайн нэр төрөө би танд л итгэж бариулах болж байна. - Тиймээ хатагтай. Гэхдээ би таныг аварч чаднаа.

-За яаж тэр вэ? ядаж над нэг сайн хэлээд өгөөч.

-Миний нөхрийг хоёр гурван хоногийн өмнө сулласан байна билээ. Би түүнтэй уулзаж амжаагүй яваа, манай нөхөр хайрлаж дурлах, үзэн ядахын аль алиныг үл мэдэх, жирийн нэг, цагаан санаат хүн, миний юу хүссэн болгоныг тэр хийж өгнө. Манай нөхөр юун захидал авч яваагаа мэдэлгүй Лондон өөл явж, таны захиа гэдгийг гадарлалгүй хүргэх хүнд нь хүргэж өгнөө гэж Бонасье авгай ярив.

Хатан сэтгэл хөөрч баярлахын эрхэнд, бүсгүйн гарыг шүүрч чанга атгаад, сэтгэлийн нь гүнд байгаа бүхнийг нэвт харах гэсэн янзтай эгцлэн ширтэв.

Бүсгүйн сайхан харцанд үйлгүй үнэнч сайны байр илрэхийг мэдээд энхрийлэн үнсэв. -За тэгж үз! Тэгвэл чи миний амь амьдрал нэр төрийг аварнаа гэж хатан дуу алдав.

-Аз болж танд тус хүргэх завшаан над учирсныг та бүү хэтрүүлж үнэл. Над авраад байх юм байхгүй. Их эзэгтэй та чинь хорт бузар явуулгын золиос болж байгаа хүн шүү дээ.

-Энэ үнээн хүү минь чи эндүүрсэнгүй, гэж хатан дуу' арлаа.

-За тэгвэл, их эзэнтэн та над тэр зурвасаа өг. Цаг хугацаа давчуу шүү дээ. Хатан, дээр нь үзэг

цаас, бэх байсан жижиг ширээ рүү яаран очоод хоёр мөр юм таталж, тамга дараад Бонасье авгай өөд сарвайлаа.

-Үгүй, бид нэг онц чухаг юмны тухай мартчихжээ. гэж хатан санаа авлаа. -Юуны тухай?

-Мөнгөний тухай.

Бонасье авгайн царай улайчхаад,

-Нээрээ ч, манай нөхөр, үнэнийг хэлэхэд... гэж бүсгүй дуугарахад хатан тосч аваад: -Танай нөхөрт мөнгө байхгүй. Та тэгж хэлэх гээ биз дээ?

-Үгүй, мөнгө ч түүнд бий. Гэхдээ тэр их харамч, хамаг муу нүгэл нь эндээ л байдаг хүн. Гэхдээ их эзэгтэй та бүү санаа зов. Би арга олж....

-Над мөнгө байдаггүй харласан юм л даа... (Де Моттвиль авгайн Дурдатгал бичгийг уншиж үзсэн хүн, энэ хариултыг сонсоод гайхахгүйсэн билээ) За байз... гээд.

Австрийн Анна хатан шүүгээ рүүгээ очлоо.

-Май энэ бөгжийг ав. Үүнийг их үнэтэй эд гэлцдэг юм. Үүнийг над миний ах, Испанийн ван бэлэглэсэн юм энэ чухам миний өөрийн юм болохоор үүнийг би өөрөө мэдээд

зарж болох зүйл. Энэ бөгжийг аваад мөнгө болго, тэгээд танай нөхөр бушуу явж үзэг. -Цагийн дараа таны тааллаар болноо.

Хаягийг нь чи үзэж байгаа биз, Лондон хот Милорд Бекингэм герцогт шүү гэж хатан дуулдахын төдий шивэгнэв..

-Захидлыг түүний гарт хүргэж өгнөө. Сайн санаат охин, гэж хатан дуугарав. Бонасье авгай хатны гарыг үнсээд захидлыг цээжиндээ нууж өрөөнөөс шувуу шиг хөнгөхөн гарч одов.

Арван минутын дараа Бонасье авгай гэртээ хүрээд ирчлээ. Нээрээ ч хатанд ярьж байсанчлангаа нөхрийгөө тавигдсанаас хойш нөхөртэйгөө уулзаагүй яваа юм байж. Мөн хамбыг нөхөр нь урьдынхаасаа өөрөөр үзэх болж, ялангуяа Бонасье гуайн сайн нөхөр болсон Рошфор гүн эднийд хоёр гурав дахин ирсэн явдал мөн энэ талаар их дөхөм болсныг залуу бүсгүй мэдэхгүй байлаа.

Эхнэрийг нь хулгайлсан явдалд ямар ч муусанаа зорилго байгаагүй, зөвхөн улс төрийн урьдчилан сэргийлэх чухаг арга хэмжээ байсан юм гэж Бонасьед гүн гойд төвөггүй итгүүлж чаджээ.

Гэргийгээ ирэхэд Бонасье гуай ганцаараа байлаа. Хөөрхий хун гэр орноо арай ядан нэг төвхнүүлж байгаа аж. Хамаг хогшил эвдэрч сүйдсэн, шүүгээнүүд бараг хоосон болсон ажээ.. Шүүх гэгч янз нь Соломон хааны улмөр ул үлдээх гурван зүйл гэж нэрлэсэн юмны нэгэнд ордоггүй бололтой. Зарц охин ч яахав, эзнийгээ баривчлагдсан доор л зугтаагаад явчихжээ, Хөөрхий бүсгүй их айснаасаа болоод, өөрийн төрсөн нутаг Бургунд гэгч газарт хүртэл

Парисаас гараад зогсолтгүй явчихжээ.

Хүндэт наймаачин гуай гэртээ ирсэн дороо эсэн мэнд гарч ирснээ эхнэртээ даруй мэдэгдсэнд эхнэр ньдуулаад баярлалаа, ажил төрлөөсөө зав зайтай болмогц нөхөртэйгөө уулзахаар харинаа гэж хариу хэлүүлсэн юм байж.

Зав гарахыг бүтэн таван өдөр турш хүлээхэд хүрсэн нь. өөр цагт Бонасье гуайд удаан санагдах байсан биз. Гэвч хамбатай учирсан, Рошфор гүн ирэх болсон зэргээс болж бодох. юм мундахгүй гарчээ. Юм бодоод байхад цаг хурдан өнгөрдөг хойно доо.

Тэгээд ч, Бонасье гуайн бодол баяртай сайхан гэж аргагүй. Рошфор өөрий нь сайн нөхрөө, эелдэг найзаа гэж нэрлэдэг, мөн хамбыг Бонасьег тун сайн хунд тооцог гэж үнэмшүүлнэ. Наймаачин өөрийгөө баян тарган, нэр хүндтэй болох замд орлоо гэж санаж байлаа.

Бонасье авгай мөн энэ зуур ихээ юм бодож өнгөрч, гэхдээ авгайн бодолд нэр төр эрэлхийлсэн юм ер байсангүй. Өөрт нь төдий их сайн болчихсон бололтой зоригт сайхан залуу өөрийн эрхгүй байн байн санагдаад байдаг байв. Бонасье гуайтай арван наймтайдаа сууснаас хойш, өдий дорд язгуурын хүнд баймааргүй ариун сайхан сэтгэлтэй залуу бүсгүйн хайрыг

158

татаж чадахааргүй, нөхрийнхөө болон бусад элдэв улсын дунд байсаар байгаад, хүнд сайн болж явсангүй юм байжээ. Мөн тайж язгууртан тэр үед хотын сул иргэдэд хэзээ хэзээнийхээ их сэтгэлэг төрүүлдэг байсан цаг, тэгтэл д'Артаньян бол тайж хүн байлаа. Түүнээс гадна д'Артаньяны өмссөн торгон цэргийн хувцас шадар цэргийн хувцасны удаа бүсгүйчүүлд ихээ тоогддог байлаа. Дахиад хэлэхэд д'Артаньян залуу, царайлаг, авхаалж хийморьтой хүн байв. Хайр сэтгэлийн тухай ярихдаа мөн үнэхээр хайр сэтгэлд автаад. хүний хайр сэтгэлийг буцаахсан гэж мэрийж байгаа хүн шиг ярьж байсан. Эд бүгд нийлээд хорь гарч яваа залуу бүсгүйн толгойг эргүүлэхээ л эргүүлэхтэй зүйл. Гэтэл Бонасье авгай дөнгөж хорин гуравтай ид залуугаараа хүн байв.

Иймд эр эм хоёр бүтэн долоо хоног уулзаагүй, энэ долоо хоногийн дотор өөрсдөд нь чухаг хэрэг учрал тохиолдсон хэдий боловч уулзахын цагт хэн хэн нь хувийнхаа бодолд автан байлаа. Гэхдээ Бонасье гуай чин сэтгэлээсээ баярлаж. гэргийнхээ өөдөөс гараа сунгасаар угтав.

Бонасье авгай нөхөртөө духаа өгч үнсуулээд,

-Бидэнд ярих юм байна гэж хэллээБонасье гуай гайхан

-Юун тухай тэр билээ гэв.

-Танд би нэг онц чухаг юм хэлэх ёстой гэж Бонасье авгай үгээ эхлэв.

Бонасье үгийг нь таслан,

-За, ингэхэд, би ч мөн өөрөөс чинь хэд хэдэн чухаг юм асуух ёстой байна. Таныг яагаад

хулгайлсан юм бэ, над хэлж өгөөч гэв.

-Одоо энэтухай би ярих гээгүй байна гэж бүсгүй хариулав.

-Аа тэгээд юун тухай ярих билээ? миний хоригдож байсан тухай юу?

-Тэр тухай би өдөрт нь мэдсэн. Гэхдээ танд хийсэн хэрэг огт байгаагүй, ямар ч хэрэг будлианд та оролцсон явдалгүй мөн өөртөө ч, бусдад ч хор болохоор ямар нэг үг алдья гэхнээ мэдэх юм танд байгаагүй болохоор би энэ хэрэгт зохих хирээр л сэтгэл зовж байсан.

Гэргийгээ ийнхүү хааш хэрэг хандсанд Бонасье гомдож.

-Танд ч хэлэхэд амархан л байгаа. Намайг бүтэн өдөр шөнө хоёр Бастили гянданд өнгөрөөснийг та мэдэх үү? гэлээ.

• Өдөр. шөнө юу байхав, дороо л өнгөрнө. Таны хоригдож байсан тухай одоо ярихаа больё, одоо миний наашаа ирсэн хэргийн тухай ярилцъя.

-Юу "наашаа ирсэн хэрэг" гэж? бүтэн долоо хоног уулзаагүй нөхөртэйгөө уулзъя гэж та наашаа ирээгүй юм гэж үү? гэж дургүй .нь хүрсэн наймаачин асуулаа.

-Мэдээжээр юуны өмнө тэгж ирэлгүй яахав. Гэхдээ. өөр бас юм байна. -За ярь;

-Энэ маш чухал хэрэг. Та бидний хамаг ирээдүй үүнээс шалтгаацаж байж мэдэх юм.

-Бонасье авгай тантай уулзаагүй байсан энэ хугацаанд бидний байдал их өөр болсон ингээд хэдэн сарын дараа, олоон хүн биднийг хараад атаархмаар болчихлоо гэхэд би гайхахааргүй болсон.

-Ялангуяа, миний хэлэх юмыг та яв цав гүйцэтгэвэл заавал тийм болноо. -Би юу?

-Тиймээ та, Нэгэн чухаг, ариун сайн үйл бүтээх хэрэгтэй байна. Тэгвэл асар их мөнгө олж болох юмаа.

Мөнгөний тухай дурсвал нөхрийнхөө сайн аашийг хөдөлгөж болно гэдгийг авгай мэдэж байлаа. Гэхдээ аливаа хүн, наймаачин хүртэл, Ришелье хамбатай арван минут яриад орхихын хамт өөр хүн болчихдог билээ. Бонасье гуай доод уруулаа цорвойлгон:

-Их мөнгө гэнээ? гэж сөргөж асуув.

-Тиймээ их мөнгө

-Ухаан нь хэдий Хир мөнгө тэр вэ?

-Бүхэл мянган алтан зоос ч байж мэдиээ.

-Тэгвэл таны надаас гуйх гэж байгаа юм тун чухаг байжтаарах нээ?

-Тиймээ.

-Юу хийх хэрэгтэй юм дээ?

-Та даруйхан юманд явна. Танд би нэг захиа өгнө, та түүнийг хар нүднийхээ цөцгий шиг хадгалж яваад хүргэвэл зохих хүнд нь гардуулж өгнөө:

-Хаашаа явах~ юм бэ дээ, Би тэгээд?

-Лондон руу,

-Би юу? Лондон руу гэнээ? Та бүү тоглоом хий. Надад Лондон орох хэрэг байхгүй. Үгүй таныг Лондон оруулах хэрэг өөр хүнд байна шүү дээ.

-Өөр хүн гэдэг чинь хэн тэр вэ? Би таамгаар юу ч хийхгүй, юуны тулд амь дүйж байгаа, хэний төлөө амь дүйж байгаагаа би заавал мэдэхийг хүснэ гэдгээ танд эрт. хэн дуулгачихъя, - Нэг язгууртан бүсгүйтаныг явуулж байгаа юм, язгууртан бүсгүй таныг хүлээх болно, Таны санаанд багташгүй их хишиг шан хүртээнэ, Үүнээс өөр юм би танд хэлж чадахгүй. -Дахиад л хэрэг будлиан! Дандаа л хэрэг будлиан. Больё доо! Одоо ч намайг тэгж амархан хуурчихгүй бий, хамба гуай над юмны зах зухыг тайлбарлаж өгсөөн гэсэнд -Хамбааа? гэж Бонасье авгай дуу алдан, та хамбатай уулзаа юу? гэв.

-Тийм. Хамба ламтан намайг дуудсан юм, гэж наймаачин бардам дуугарав Та тэгээд дуудсанаар нь очоо юу. Мөн ч гэнэн хүнээ дээ та.

-Үнэнийг хэлэхэд, очих уу байх уу гэж сонгож байх боломж над байгаагүй, намайг хоёр хуяг тууж аваачсан. Мөн үнэнээ хэлэхэд их гэгээнтнийг би тэр цагт сайн мэддэггүй байсан болохоор, уулзахаас зайлсхийх боломж байсан бол дуртайяа л зайлсхийх байсан, -Таныг хамба тэгээд их аашилж сүрдүүлсэн үү?

-Хамба надтай гар бариад намайг сайн нөхрөө гэсэн сайн нөхөр гэсэн шүү! дуулав уу та? Би чинь суут их хамба ламтны сайн нөхөр шүү?

-Суут их хамба лам ий?

-Та түүний энэ алдар цууг арай булаалдах гээгүй биз,

-Би юу ч булаалдах гээгүй харин сайд гуайн өршөөл баттай биш, зөвхөн солирсон улс ч сайдтай хувь заяагаа холбодог байх гэж байна. Сайдын эрх хүчнээс дээгүүр хүний дур зориг юм уу, аль нэг хэрэг явдал үр дүнгээс болдоггүй, үнэн эрх мэдэлтэй, хүч чадалтай улс бий Тэдэнд л зүтгэх ёстой юм гэж хэлж байна.

-Миний хүчээ өгч зүтгэх завшаан олдсон их хүнийхээс өөр эрх засаг гэж надад үгүй нь харамсалтай байна авгай минь.

-Та хамба ламд зүтгэж байгаа хүн үү?

-Тиймээ авгайтан. Тэгээд хамбын зарц хүний хувиар би таныг улсын аюулгүй тайван байдлын эсрэг хуйвалдаанд оролцож, уулаасаа франц хүн биш болохоор ямагт Испанийг бодогч бүсгүйн элдэв хэрэг будлианд та нарт туслахыг би зөвшөөрч чадахгүй. Манайд их хамба лам байгаа нь аз, түүний үл зүүрмэглэгч хурц хараа бүхнийг ажиж хүний доторхыг хүртэл нэвт харж байдаг юм.

Рошфор гүнгээс дуулсан үгээ Бонасье үгчлэн давтсан нь энэ ажээ. Үгийг цээжилж аваад, хэлж гайхуулах тохиромжтой цагийг л хүлээж байсан хүн. Нөхөртөө найдаж, үүндээ болон их хатанд ам өгч орхисон хөөрхий бүсгүй өөртөө гай зовлон чирэх дөхөж өөрөө арчаагүй байдалд орсноо бодож үзээд зүрхшээж ирэв. Хэдий тийм боловч нөхрийнхөө сул тал ялангуяа ховдог шунахайг сайн мэддэг болохоор зорьсон юмаа, шахаж хийлгэх горьдлого хараахан тасраагүй байв. Бүсгүй:

-Мөөн, тэхлээр эрхэм та чинь хамбын талын хүн шив! Тэхлээр та чинь вангийн хатныг доромжилж, таны гэргийг чинь тарчилгадаг улсын талд байгаа хүн шив.

-Бүх нийтийн эрх ашгийг бодвол ганц хүний эрх ашиг юухан ч биш. Бихувьдаа улс орноо аврагч хүмүүсийн талыг барьдаг хүн! гэж Бонасье сүржин дуугарав.

Энэ бас л Рошфор гүнгийн хэлсэн үг, мань хүн цээжилж аваад үгний завсар хавчуулах учрал олсон нь энэ байж.

-Та наад улс гэж яриад байгаа юмныхаа учрыг мэдэж байгаа юм уу даа гээд гэргий нь мөрөө хавчисхийв, Элдвээр арвилалгүй, жирийн нэг хүн хэвээрээ л байж үз. Тэгээд өөрт чинь илүү ашиг өгч байгаа хүний талд л орж яв.

-Харин ээдээд Бонасье хажуудаа байсан дүүрэн уутыг алгадахад мөнгө хангинан дуугарлаа. Та үүнийг юу гэх вэ, сайхан ятгагч авгай

-Энэ юун мөнгө вэ?

-Та гадарлахгүй байна уу?

-Хамба өгөө юу?

-Хамба, мөн миний нөхөр Рошфор гүнгийн хайрласан хишиг.

-Рошфор гүн гэнээ? үгүй "тэр чинь намайг хулгайлсан" хүн шүү дээ.

-Тэгсэн байж болноо.

-Та тэгээд тэр хүнээс мөнгө авч байдаг хэрэг үү? I

-Ганцхан л улс төрийн зорилгоор таныг хулгайлсан гэж та яриагүйсэн билүү?

-Гэхдээ, надад эрүү шүүлт тулгаж байгаад үг хэлүүлж, эзэгтэйн алив нууцыг хэлүүлэх, түүгээр өндөр угсаат дээд эзэгтэгийн нэр төр, аягүй бол амьдралд нь. хор хөнөөл учруулах

гэсэн юм шүү дээ.

-Авгатайн, таны тэр дээд угсаат эзэгтэй чинь итгэл эвдэгч Испани бүсгүй, Хамба лам чухам хийвэл зохих юмыг хийж байгаа юм гэж Бонасье хэлэв.

Залуу бүсгүй ундууцаж,

-Эрхэм ээ, таны аймхай, шунаг тэнэг гэдгийг би мэдэж л байсан, Харин таныг ийм адгийн амьтан гэж би мэдэхгүй явсан юм шүү! гэж дуу алдав.

Эхнэрээ ингэтэл хилэгнэхийг анх үзэж, гэр дотрын хэрүүл маргаанаас айж төвөгшөөсөн Бонасье,

-Авгатайн, үгүй та юу гээд байнаа? гэв. Нөхрийгөө няцаж эхэлж байгааг үзсэн Бонасье авгай үүнд

-Яахав таныг адгийн амьтан юм байна л гэж байна. Ингэхлээр, та улс төрийн. хэрэгт оролцох болж, тэр мөртөө бүр хамбынталын хүн болчихоо юм биз дээ. Ингэхлээр та бие сэтгэлээ шуламд өгч, өгөх өгөхдөө бүр мөнгөөр худалдаа шив? гэлээ.

-Шуламд биш, хамба ламтанд

-Ялгаагүй гэсэн үгээ! "Ришелье" гэж байгаа хүн ер нь "Шулам" л гэж байгаатай адил гэж залуу бүсгүй дуу алдав.

-Амаа татаж үз, авгайтан, амаа тат! Таны үгийг хүн дуулчхаж мэднэ шүү. -Тиймээ, таны зөв. Таны ийм хулчгарыг хүн мэдчихвэл над өөрт минь ичгэвтэр байхсан. -Үгүй, та ингэхэд, чухам яалгах гээд байгаа хүн бэ?

-Би танд түрүүний хэлсэн билээ. Та нэн даруй мордоод миний өөрт чинь даалгаж өгч байгаа ажлыг шударга сайн биелүүлээд ир. Энэ ажлыг бүтээвэл тань саяны бүх байдлыг би мартаад, уучлахад бэлхэн байна. Тэр ч байтугай би танд хуучин шигээ сайн байх болноо, гээд залуу бүсгүй өөдөөс нь гараа сунгав.

Бонасье аймхай шунаг хүн боловч эхнэртээ сайн юм болохоор сэтгэл уярав. Тавин настай нөхөр хорин гуравтай эхнэртэйгээ удтал муудалцах гэдэг амаргүй. Эргэлзэж эхэлж байгаагий нь Бонасье авгай ажаад

-За яав? Та шийдэв үү? гэв.

-Үгүй, хонгор минь, намайг яалгах гэж байгаагаа өөрөө бодоод үз? Лондон гэдэг чинь Парисаас хол, даанч хол, түүнээс гадна, таны даалгаж байгаа зүйл аюултай ч юм байж болно.

-Аюулаас та тойроод л гарчхаас хойш, хамаатай юу даа!

Наймаачин үүнд,

-За ер нь Бонасьеавгай, би эрс татгалзаж байна. Хэрэг будлианаас би айж байна. Бастили гэгчийг • чинь үзлээ шүү дээ. Ий! Бастили гэдэг мөн ч аймаар! Санахын хамт л нуруу руу хүйт даагаад ирэх юм. Намайг эрүү тулгана гэж занасан. Эрүү шүүлт гэж юу байдгийг та мэдэх үү? хөл гарын хурууны завсраар модон хадаас хийгээд, ясыгнь цав гартал шаадаг юм.. „ Үгүй, яасан ч үгүй. Би явахгүй. Чөтгөр алгад, та өөрөө яагаад явж болдоггүй юм бэ? Таны тухайд би өнөө хүртэл эндүүрч явсан бололтой, та эр хүн, тэхдээ бүр хамгийн зоримог эрчүүлийн нэг аятай над санагдах боллоо гэв.

-Аа та өөрөө аргагүй эм хүн, тэнэг мунхаг, дорой муу эм. Тийм бий! Та айгаад байна уу! Сайн даа. Тэгвэл, одоо даруй таныг би хатагтайн нэрээр баривчлуулаад, тэр их айгаад байдаг Бастилид чинь хийл! энэ дээ.

Бонасье гүн бодол болов Хамба, хатан хоёрын хэн нь илүү их аюултай вэ гэдгийг мань хүн дотроо нарийн цэгнэж үзэв. Хамбыг хилэгнүүлчихвэл, хавьгүй их аймшигтай билээ. Сүүлд нь: -Хатны нэрээр намайг баривчлуулна гэнээ? тэгвэл би их гэгээнтний нэрийг барина даа гэж тэр дуугарлаа.

Хэрэггүй юм хэлж ам алдсанаа Бонасье авгай сая мэдэж хиртхийв Айж хэлмэгдэхийн эрхээр буцалгүй шийдсэн байдал илэрхий байгаа нөхрийнхөө тэнэг царай өөд залуу бүсгүй сэтгэл зовон ширтсэнээ;

-За яахав. Явж явж, таны зөв ч байж магад. Эрэгтэйчүүл улс төрийн бодлогын учрыг илүү олдог. Тэр дундаа Бонасье гуай та, нэгэнт ^хамбатай уулзсанаас хойш, үүнийг сайн мэдэж байгаа биз.

Гэлээ ч миний нөхөр хайр, сэтгэлд нь итгэж болохтой юм шиг над санагдаж байсан хүн маань миний нэг дүрсгүйтээд гуйчихсан юмыг гүйцэтгээд өгөхгүй байгаад их гомдож байна, гэж бүсгүй хэллээ.

Бонасье үүндөршөөнгүй дуугаар,

-Таны тэр дүрсгүй чинь дэндэж байж мэднэ. Үүнээс би айгаад байгаа юм гэлээ. Залуу бүсгүй санаа алдав.

-Сэдэвлэсэн юмаа орхихоос биш яахав за тийм болог. Энэ тухай дахин яриад юу хийхэв. Бонасье хэсэг зуур дуугүй байснаа, эхнэрийнхээ нууцыг мэдэж бай гэж Рошфорын захисныг баахан хожуу санаад.

-Лондонд очоод миний юу хийх ёстойг та олигтойхон хэлж өгөхсөн ч болоосой гэв.

-Үүнийг мэдэх хэрэг танд ер үгүй. Заримдаа бүсгүйчүүлийн үхэлдээд байдаг нэг аар саархан юм худалдаж авчрах хэрэг байсан юм. Тэгвэл овоо юм өөрөө олж болох байсан юм даа гэж нэгэнт итгэхээ больсон залуу бүсгүй хариулав.

Залуу бүсгүй санаагаа нуух гэжих оролдохын хамт өөрт нь итгэж хэлэхгүй байгаа тэр нууц их чухаг юмаа гэдгийг Бонасье улам ч лавтай үнэмшив, Иймд мань хүн даруй Рошфор дээр

яаран очиж, хатан Лондон руу явуулах хүн эрж байгааг дуулгахаар шийдэв.

-Уучлаарай, хонгор минь би таныг орхиод явах хэрэгтэй байна. Таны өнөөдөр ирэхийг мэдэлгүй би нэг нөхөртэйгөөуулзахаар болзож орхисон юм. Би ер удахгүй, та намайг жаахан хүлээж байвал, би нөхөртэйгөө ярих юмаа ярьчхаж ирээд таныг ордон руу хүргэж өгье. Одоо нэгэнт бүрэнхий болж байна гэж Бонасье заль зохиов.

Залуу бүсгүй үүнд,

-Гялайлаа. Эрхэм ээ, та надад ямар нэгэн тус үзүүлж чадахаар эр зориггүй хүн. Ордон руу би ганцаараа явчхаж чадна гэв.

-Бонасье авгай та тааллаараа бол бид мөд дөө дахин уулзах уу? Гэж наймаачин эр асуулаа.

-Дараагийн долоо хоногт нэг жаахан чөлөө цаг над гарах байх, тэхлээр ирж гэр орныхоо энэ эмх замбараагүй болчихсон юмыг янзалья.

-За сайн, би таныг хүлээнэ. Та надад уурлаагүй биз.

-Би юу огт үгүй.

-За тийм бол, мөдхөн уулзъя, Баяртай.

-Баяртай.

Бонасье эхнэрийнхээ гарыг үнсээд, яаран гарч одов. Нөхрийгөө гарч, үүд хаагдаад, ганцаараа үлдэхийн хамт Бонасье авгай,

-Энэ муу тэнэг бас хамбын талд орох нь дутаж дээ. Үгүй би тэхэд, хатны өмнө баттай үг хэлж, хөөрхий золгүй эзэгтэйдээ ам өгснийг яана... Бурхан минь! Хатан намайг одоо өөрий нь тагнаж туршихаар; тавьсан, ордноор дүүрэн байдаг бузар амьтдын нэг гэж тооцно доо. Ээ Бонасье гуай гэж! Хэзээний танд би төдий их сайн байгаагүй, одоо бүр ч болилоо. Өөрийг чинь би үзэн яддаг боллоо, гайгүй нэг хариугаа авна даа гэж ганцаараа үглэв.

Дөнгөж, үүнийг хэлж дуустал адрыг хүн тогших чимээ гарч, залуу бүсгүй дээшээ харав. - Хонгор Бонасье авгай, шатан дээрх жижиг хаалгаа онгойлго, би одообууж очлоо, гэж нэг хүний дуу дээрээс гарлаа.

XVIII. НӨХӨР АМРАГ ХОЁР

Залуу бүсгүйн нээж өгсөн хаалгаар д'Артаньян орж ирээд

-За даа, танд гэж хэлэхэд авгайтан, танай нөхөр ч мөн хөөрхий амьтан юм даа гэв. Бонасье авгай сэтгэл зовсон байртай д'Артаньяны өөдөөс хараад,

-Та чинь бидний яриаг чагнасан байх нээ? гэв.

-Эхнээс нь аваад дуустал.

-Яаж тэр вэ, бурхан минь?

-Хамбын туршуулууд та нарын нөгөө үүнээс арай илүү хөгжөөнтэй яриаг сонсож чадсан тэр аргаараа.

-Манай ярианаас та, тэгээд юу мэдэж авав?

-Өдий төдий олон юм. Нэгд, танай нөхөр чинь аз болоход, тэнэг мохоо хүн юм. Цаашаа, та одоо төвөгтэйбайдалд ороод байгаа юм байна. Үүнд би хагартлаа баярлаж байна, юу гэвэл өөрт чинь тус болох боломж гарч байна. Таны төлөө би гал руу ч орохоосоо буцахгүй байгааг бурхан мэдэж байна. Цаашаа Лондон орж, даалгавар биелүүлээд ирэх үнэнч зоримог, авхаалж хийморьтой хүн хатанганд хэрэгтэй болж байгаа юм байна. Шаардагдах энэ чанарын ядажзарим нь над бий, тэхээр би одоо таны зааврыг хүлээж байна.

Бонасье авгай даруй хариу дуугарсангүй, гэвч баярласандаа зүрх нь цохилж горьдлого төрөн нүд нь галтай болоод ирлээ.

-Энэ үүргийг би танд итгэмжлэхээр шийдлээ гэхэд, над юу барьцаа болж өгөх вэ? гэж бүсгүй асуув.

-Миний өөрт чинь сайн хайр сэтгэл үүнд барьцаа болог. За, хэлж үз, тушааж үз, би юу хийх ёстой байнаа?

-Бурхан минь, ийм чухаг нууцыг би танд итгэж болох уу, үгүй юу! Та чинь чухамдаа бараг хүүхэд байна шүү дээ гэж залуу бүсгүй шивэгнэв.

-Янз нь, над итгэж болох, үгүй хоёрыг танд өөр нэг хүн зааж хэлж өгвөл сайн байх шиг байнаа!

-Тэгж болдогсон бол миний сэтгэл их л амрахсан.

-Атосыг та таних уу?

-Үгүй.

-Портосыг?

-Үгүй

-Арамисыг?

-Үгүй, Энэ эрхмүүд чинь юун улс вэ?

-Их эзэнтний шадар цэргүүд. Шадар цэргүүдийн даамал, де Тревиль гуайг та таних уу? - Танинаа. Тэр хүнийг би нүүр танихгүй, гэхдээ дуулсан юм. Тэр хүнийг шударга, ариун журамт явдалт тайж хүн гэж хатагтай олон удаа ярьж байсан.

-Тэр хүнийг хамбад сайн хүн болж, өөрий чинь хөнөөнө гэж та арай сэжиглэхгүй биз? -Үгүй байлгүй яахав.

-Тэгвэл де Тревиль гуайд та тэр нууцаа илчилж өгөөд, хэдий чухаг, нандин, аймшигтай нууц зүйл байлаа ч гэсэн надад итгэмжилж болох эсэхийг асуу.

-Үгүй, энэ чинь миний нууц биш, би үүнийг задруулж байж таарахгүй шүү дээ.... -Үгүй та, Бонасье гуайд түүнийгээ итгэмжлэх гэж байсан шүү дээ гэж д'Артаньян гоморхож дуугарав.

-Захидлыг модны хонгил, тагтааны далавч, нохойны хүзүүнд итгэмжилдэг шиг л итгэх гэсэн юм.

-Өөрт чинь миний хир сайн, хайртайг та харж байна шүү дээ.

-Тиймээ, та тэгж хэлж л байгаа.

-Би шударга хүн!

-Би ч мөн тэгж санаж байгаа.

-Би зоригтой

-Үүнийг ч би нүдээрээ үзэж үнэмшсэн.

-Тэгвэл намайг туршаад үз л дээ.

Бонасье авгайн доторх эцсийн эргэлзээ арилж ядан залуу өөд харлаа. Залуугийн харц гал шиг гялалзаж, дуу нь үнэхээр итгэл төрүүлэх тул бүсгүй залуудитгэмжилмээр дур хүрлээ. Тэгээд ч өөр зам байсангүй. Туршаад үзэхээс өөр аргагүй байлаа.

Хэт болгоомжлох нь хэтэрхий итгэхийн адил хатагтайд аюултай байв. Тэгээд ч үнэнийг хэлэхэд энэ залууд өөрийн эрхгүй сайн болж байгаа сэтгэл нь бас дийллээ.

-За дуулж бай. Таны гуйгаад байгаа үгэнд би орж, танд итгэв. Гэхдээ, бидний үгийг дуулж байгаа бурхны нэрийг барьж андгайлья. Та намайг мэхэлдэг юм бол, манай өстнүүд намайг өршөөлөө ч гэсэн, миний үхэлд таныг ялтай гэж бодож, би амиа тэвчиж орхино, шүү гэж бүсгүй хэлэв.

д'Артаньян,

..-, Би мөн бурхны нэрийг барьж андгайлахад, би таны даалгаврыг биелүүлж яваад, баригдчихлаа гэхэд, аль нэгэн хүний нэр төрд харш болох юм хийх юм уу, хэлсэнд орохноо, амиа өгнөө гэлээ.

Ингээд залуу бүсгүй, нөгөө гүүрэн дээр зах зух нь залууд мэдэгдсэн чухаг нууцыг залууд хэлж өглөө.

Тэр хоёрын хайр сэтгэлийн үгээ илчилсэн нь энэ боллоо.

д'Артаньян бахдал, жаргалд авган гийж байлаа. Мэдэж авсан чухаг нууц, хайрлаж байгаа гуа бүсгүй хоёрнь залууд баатрын их чадал хүч сэлбэх шиг.

-Би явлаа. Одоохон явлаа гэж д'Артаньян хэлэв.

-Та юу явлаа гэж? Дарга чинь, алба чинь яах юм бэ? гэж бүсгүй дуу алдав.

-Хайрт Констанция танаас болоод би хамаг юмаа мартчихаж шүү нээрээ. Таны зөвөө, над чөлөө авах хэрэг байна.

-Дахиадл саад! гэж Бонасье авгай цөхрөн дуугарав. д'Артаньян хоромхон зуур юм бодоод,

-Энэ саадыг ч би амархан давна бүү сэтгэл зов гэлээ.

-Яаж тэр вэ?

-Би өнөө оройдoo де Тревиль гуай дээр очоод та өөрийнхөө хүргэн, Дезэссар гуайгаас чөлөө авч өгөхийг гуйя.

-Ингээд бас гүйцэхгүй шүү...

-Бонасье авгайүгээ гүйцээж чадахгүй түдгэлзээд байгааг үзэж д'Артаньян -Та юунд бас зовоод байнаа? гэж асуув.

-Танд мөнгө байхгүй юм биш биз

-Асуугаад ч яахав дээ гэж д'Артаньян инээмсэглэн хариулав.

-Тийм бол гээд Бонасье авгай шүүгээ онгойлгож, хагас цагийн өмнө нөхрийнхөө энхрийлэн илбэж байсан уутыг гаргаж ирээд,

-Май энэуутыг авч үз гэлээ. Бидний мэдэж байгаачлан, шалаа ховхолж авсны ачаар нөхөр гэргий хоёрын үгийг нэгд нэггүй сонссон д'Артаньян

-Хамбын ууттай мөнгө үү! гээд инээд алдав.

-Тиймээ, хамбын ууттай мөнгө гаднаасаа харахад сүрхий бараатай юм байна шүү дээ гэж Бонасье авгай нотлов.

-Чөтгөр алгад, Хамбын мөнгөөр хатныг аврах гэдэг чиньдавхар давхар сонин хэрэг болж байна гэж залуу хэллээ.

Бонасье авгай үүнд,

-Та эелдэг, аятайхан залуу юм. Их эзэгтэй ачийг чинь лав хариулна гэсэнд д'Артаньян дуу алдаж

Ээ, би хайр шагналд бүрэн ханаад байна! Би танд хайртай, үүний минь та сонсохоо дургүйцэхгүй байна. Ийм их жаргал над ирнэ гэж би горьдоо ч үгүй явсан хүн.

-Чимээгүй! гэж Бонасье авгай гэнэт шивэгнээд хамаг бие нь арзас хийв. -Юу болов?

-Гудамжинд хүн юм яриад байна...

-Хэний дуувэ?

-Манай нөхрийн. Тиймээ, би лав таньж байна. Артаньян үүд рүү гүйж очоод түгжиж орхисноо:

-Намайг явахаас нааш түүнийг оруулж болохгүй, намайг явчхаар та түүнд тайлж өгнө биз.

-Үгүй би ч мөн явах ёстой шүү дээ.

Би энд байж байх юм бол, мөнгө яагаад алга болсон гэж хэлэх вэ?

-Таны зөв, эндээс гаралгүй горьгүй.

-Гарах аа? яаж тэр вэ? Биднийг гараад явбал, цаадах чинь харчихна шүү дээ. -Тэгвэл дээшээ, миний өрөө рүү орох хэрэгтэй байна.

-Пээ, таныг ингэж хэлэхийг дуулахад аймаар байна, гэж Бонасье авгай дуугарав.

Үүнийг хэлэхдээ, бүсгүйн нүдэнд нулимс гүйлэгнэж харагдлаа. д'Артаньян тэр нулимсыг үзээд, уярч, ичингүйрсхийсэндээ бүсгүйн хөлд сөхрөн,

-Манайд та, сүм хийдэд орсонтой адил айх юмгүй, амар байна. Тайж хүний хувьд ам өгье, гэж тэр хэллээ.

-За явъя, сайн нөхөр минь, танд би биеэ итгэн даатгаж байна, гэж бүсгүй хариулав. д'Артаньян үүдний түгжээг аяархан тайлчхаад, хоёулаа дотор хаалгаар сэмээрхэн шатны довжоон дээр гарч, цаашаа д'Артаньяны өрөөнд оров.

Өрөөндөө орж ирсэн хойноо, мань залуу хэрэг төвгөөс болгоомжлон үүдээ сайн бэхлэв.

Дараа нь тэд цонх руу очтол Бонасье гуай, нэг нөмрөгөөр биеэ ороосон хүнтэй ярилцаж зогсох харагдав. Тэр нөмрөгтэй хүнийг үзмэгцээ д'Артаньяны бие зарсхийж илдээ бараг суга татан үүд рүү ухасхийв.

Тэр нөгөө Менгхотноо учирсан хүн мөн аж.

-Та юу хийх гэж байнаа? Та бид бүгдийг хөнөөх нээ! гэж Бонасье авгай дуу алдав. -Үгүй, энэ хүнийг би алахаар андгайлсан юм гэж д'Артаньян өчив.

-Та одоо авсан даалгавраа биелүүлэхэд амь биеэ зориулах ёстой, Дураараа аяглаж болохоо байсан. Зам зуур чинь учрахаас өөр аюулдамь биеэ дүйж болохгүй гэдгийг хатны нэрийн өмнөөс захирч байна.

-Та өөрийнхөө нэрээр над юу ч тушаахгүй юу? гэсэнд Бонасье авгайн сэтгэл ихэд хөдлөөд,

-Өөрийнхөө нэрээр би мөн л үүнийг танаас гуйж байна. Алив. Наадуулын чинь үгийг сонсьё, янз нь миний тухай ярьж байх бололтой.

д'Артаньян цонх руу эргэж очоод чагналаа.

Бонасье гуай хаалгаа онгойлгож, гэртээ хүнгүй байхыг үзээд, түр ганцаараа үлдээсэн нөмрөгт хүн дээр буцаж ирэв.

-Манай эхнэр яваад өгчээ, бодвол Лувр руу буцсан байх гэж Бонасье хэлэв. -Таны яах гэж гарсныг авгай чинь сэжиг аваагүй гэж та лав мэдэж байна уу? гэж нөмрөгтэй хүн асуулаа:

Бонасье үүнд биеэ тоосон дуугаар:

-Үгүй. Манай тэр чинь ийм юм сэжиглэхээргүй, хөнгөмсөг бүсгүй гэлээ. -Залуу торгон цэрэг гэртээ бий юу?

-Үгүй дэгээ. Цонхны хаалт нь хаалттай, завсраар нь гэрэл харагдахгүй байна шүү дээ. -Юу ч гэсэн үзэхэд илүүдэхгүй.

-Яаж үзэх гэж?

-Очиж үүдий ньтогшихгүй юу.

-Би очиж, зарцаас нь асуугаад орхиё:

-Тэг, тэг.

Бонасье дотогшоо үгүй болсноо, нөгөө хоёрын түрүүн оргож ирсэн тэр хаалгаар дээшээ гарч, д'Артаньяны үүдний өмнөх довжоон дээр хүрч ирээд үүд тогшив.

Хэн ч хариу юм дуугарсангүй. Портос тэр орой, сүр бадруулах гэж Планшег гуйж аваачсан байж. д'Артаньянч өөрөө яахав амьд амьтан байгаа шинж мэдэгдэхгүйг хичээж байлаа.

Бонасье үүд тогшиж гарахад хоёр залуугийн зүрх шимшрэн, түгшиж байв.

-Энд хүн алгаа гэж Бонасье дуугарав.

-Юу ч гэсэн тэр, танайд орьё. Гудамжинд зогсож байснаас л дээр байх, гэж цаад хүн дуугарав.

-Ээ харла! Одоо бидэнд юм дуулдахаа боллоо гэжбүсгүй дуу алдав.

-Үгүй, харин ч одоо бидэнд илүү сайн дуулдана гэж д'Артаньян сэтгэлийг нь амраалаа.

д'Артаньян зүймэл шалныхаа хэдэн дөрвөлж модыг сугалж авснаар өрөөнөөсөө юм чагнах боломжтой болж шалан дээр нэг хивс хаяад, сөхрөн сууж, Бонасье авгайг мөн тэр нүх рүү бөхийж чагна гэж зангав.

-Таны гэрт, хүн байхгүй нь лав юм биз? гэж нөгөө хүн асуув.

-Үүнийг ч би бүр дааж байна гэж Бонасье хариуллаа.

-Таны бодоход, эхнэр чинь...

-Ордон руу буцаж очсон дог оо.

-Хэнтэй ч юм ярьж барилгүйгээр үү?

-Лав тэгсээн.

-Үүнийг яг мэдэх нь их чухаг юм, ойлгож байна уу? -Тэгвэл, танд миний дуулгасан зүйлийг онц чухагт үзэж

болох юм шив?

-Онц чухаг гэдгийг, хонгор Бонасье танаас нуухгүй

байна.

-Тэгвэл хамба ламтан над баярлах байхдаа?

-Лав тэгнээ.

-Суут их хамба ламтан!

-Танай эхнэр өөртэй чинь ярилцахдаа энэ тэр хүний нэр дурсаагүйг та сайн санаж байна уу?

-Үгүй шиг санагдах юм...

-Де Шеврез авгай, Бекингэм герцог, де Верне авгай нарын нэрийг дурсаагүй биз?

-Үгүй, зүгээр л, ихээ өндөр дээд хүнд тус болохын тулд намайг Лондон явуулах санаатай байна гэсэн.

-Урвасан муу новш! гэж Бонасье авгай шивнэв.

Аяархан, гэж д'Артаньян шивнээд бүсгүйн гарыг барьсанд цаадах нь бодол болсоор гараа авсан ч үгүй. Нөмрөгтэй хүн үгээ залган,

-Гэсэн ч та зөвшөөрч байгаа дүр үзүүлдэггүй, бас тэнэг хүн. Тэгсэн бол захиа одоо таны гарт орчихсон, аюулд тулгарч байгаа улс орон маань аврагдсан, аа та өөрөө...

-Аа би?..

-Та... өдийд тайж язгуурт өргөмжлөгдсөн байх байсан.

-Өөрөө танд хэлж байсан уу?

-Тиймээ, таныг хамба гэнэт тэгж баярлуулах санаатай байсныг би мэднээ.

-Бүү сэтгэл зов, манай эхнэр над ухаангүй сайн юм. Бас ч хождоогүй байна гэж Бонасье хэллээ.

-Бонасье авгай үүнд, Тэнэг хар! гэж шивнэсэнд

-Аяархан гэж д'Артаньян сонстох төдий хэлээд бүсгүйн гарыг улам чанга атгав. -Юу нь "хождоогүй гэж?" гэж нөгөөнөмрөгт хүн асуулаа.

-Би Лувр ордон руу очиж, Бонасье авгайг дуудаад, явахаар шийдлээ гэж хэлээд, захидлыг нь авч, хамбад аваачаад өгье.

-За сайн. Түргэлээрэй. Таны юу хийж амжсаныг мэдэхээр би төдхөн эргээд ирнээ гээд нөгөө хүн гарч одов.

-Муу новш! гэж Бонасье авгай нөхрөө хараалаа.

-Аяархан! гэж д'Артаньяндахин шивнээд, бүсгүйн гарыг улам чанга атгалаа.

Гэнэт муухай хашгарах дуу гарч, д'Артаньян, бүсгүй хоёрын бодлыг замхраав. Нөхөр нь ууттай мөнгө үгүй болчихсоныг үгүйлээд амьтан хүн дуудаж байгаа нь энэ аж:

Бонасье авгай дуу алдан

-Бурхан минь, яанаа! Энэ хавийн хамаг амьтныг энэ чинь үймүүлж орхих нь гэв.

Бонасье удтал хашгарлаа, гэвч Авсчдын гудамжинд ингэж хашгарах олон дуулдаг болохоор, ялангуяа наймаачны гэр ойрдоо сэжигтэй муу нэртэй болж байгаа болохоор хэн ч ирж барьсангүй. Ирэх хүн амьтан үгүйг Бонасье үзээд орилсоор гэрээсээ гүйн гарч, Добак гэгч

гудамж руу чиглэхэд, муухай дуу нь удтал тасрахгүй байлаа.

-За одоо тэр хүн яваад өгснөөс хойш, таны явах ээлж боллоо. Эр зоригтой, ялангуяа хянуур болгоомжтой яв. Таны амь бие хатагтайд зориулагдсаныг бүү мартаарай гэж Бонасье авгай хэллээ.

-Хатагтай, та хоёрт шүү! Гуа сайхан Констанция та бүү санаа зов. Би хатны талархлыг хүлээж чадахаар урагштай яваад ирнэ, гэхдээ таны хайр сэтгэлийг мөн татаж чадахсан болов уу?

Үүний хариуд, залуу бүсгүйн царай час улайгаад явчихлаа. Хэдхэн минутын дараа д'Артаньян мөн нөмрөгөөр биеэ ороосоор гудамжинд гарахад, хормойг нь урт илд сүртэйеэ дэрвийлгэж харагдана.

Бонасье авгай залуугийн хойноос удтал эелдэг харцаар ширтэн зогсов. Бүсгүйчүүл сэтгэл татагдсан хүнээ л тэгж хардаг билээ.

Залууг гудамжны булан ороож далд орохын хамт Бонасье авгай сөхрөн ойчоод, -Бурхан минь, хатныг өршөөж үз, намайг өршөө! гэж залбирлаа.

ХИХ. АЯН ЗАМЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

д'Артаньян юуны өмнө де Тревиль гуайнх руу очив. Их гэгээнтний шадар бараа бологч болохоос зайлахгүй, нөгөө хараал идсэн хар хүнээс энэ бүх хэрэг явдлыг хамба төдхөн дуулчихна гэдгийг мань залуу сайн мэдэж байлаа. Тэхлээр ганц ч мөч саатаж болохгүй гэж бодсон нь аргагүй зөв байв.

Мань залуу дотроо бөөн баяр хөөр болж явлаа. Алдар нэр, мөнгө аль алины нь зэрэг олж авах учрал түүнд дайралдлаа, хамгийн гол нь санаа сэтгэлийг нь эзлээд байсан бүсгүйтэй энэ явдал өөрийг нь ойртуулж өгөв. Хувь зохиолоор урьд хожид, мань хүн өөрөө санааширч явсан их юм гарт орж ирлээ.

Де Тревиль гуай зочдынхоо өрөөнд, өндөр сурвалжит хуучин нөхдийнхөө дунд байж байлаа. Энэ гэрийнхнийг цөмийг нь таних д'Артаньян, гэрийн эзний ажлын өрөөнд явж ороод, даамалтай чухал хэргийн учир уулзах гэснээ зарцаар хэлүүлэв.

Таван минут ч хүлээгээгүй байтал де Тревиль гуай орж ирлээ. Мань залуугийн баярлаж гялалзсан царай өөд нэг харахтайгаа зэрэг, нэг шинэ чухаг юм болсныг хүндэт даамал даруй гадарлав.

Де Тревиль гуайд нууцаа итгэмжлэх үү, аль нэгэн чухаг "ууц хэргийн учир дураараа ажиллах боломж өгөөч гэж гуйх уу гэдгийг д'Артаньян зам зуураа эргэлзсээр явж иржээ. Гэвч де Тревиль гуай д'Артаньяны хувьд ямагт хүн мөстэй хандаж, байдаг, ван хатан хоёрт үйлийн үргүй үнэнч сайн. хамба ламтанд голоосоо дургүй нь үнэн болохоор бүгдийг түүнд ярьж өгөхөөр шийдлээ.

-Миний залуу нөхөр, надтай уулзахсан гэж гуйгаа юу? гэж де Тревиль гуан хэллээ.

д'Артаньян үүнд,

-Тиймээ эрхэм ээ, ямар шүү чухаг хэргийн учир уулзах гэснийг дуулаад, төвөг удсаны миньта уучлах биз гэж хариуллаа.

-За тэгвэл ярь, би сонсьё.

-Энэ ердөө хатны нэр төр, аягүйдвэл амь амьдралтай холбогдсон хэрэг юм, гэж д'Артаньян дуугаа намсган хэлэв.

-Юу гэнээ та хөөш! гэж де Тревиль дуу алдаад хүн амьтан чагнаж байх бий гэж эргэн тойрон харснаа, дахин залуугийн өөдөөс асуух байртай ширтэв.

-Эрхэм ээ. Нэгэн чухаг нууцыг би зүг учралаар олж мэдлээ... гэж д'Артаньян хариулав. -Тэр нууцыг залуу та тэгээд амь наснаасаа хагацахад хүрлээ ч гэсэн чанд хадгалах юм байгаа биз.

-Тэхдээ үүнийг би танд илчлэх ёстой болоод байна, юу гэвэл, их эзэгтэйгээс над даалгасан зүйлийг гүйцэтгэхэд, ганц та л над тус болж чадах билээ:

-Тэр нууц чинь, таны хувийн нууц уу?

-Үгүй, эрхэм ээ. Хатантны нууц. /

-Энэ нууцаа над илчлэхийг их эзэгтэй танд зөвшөөрсөн юм уу?

-Үгүй, эрхэм ээ, тэр ч байтугай чанд хадгалж явахыг надад тушаасан юм. -Та тэгээд юунд үүнийг над илчлэх гэж байгаа юм бэ?

-Яагаад гэвэл, таны тусламжгүйгээр би юу ч бүтээж чадахгүй юм гэдгийг танд дуулгасан билээ. Мөн юуны төлөө намайг өөрөөсөө тусламж гуйж байгааг мэдэхгүй бол таныг над тус өршөөл үзүүлэхээсээ татгалзах болов уу гэж айсан юмаа.

-Өөртөө итгэмжилсэн нууцыг дотроо хадгалж яв, залуу минь тэгээд юу хүсэж байгаагаа хэл.

-Дезэссээр гуайгаас та над хоёр долоо хоногийн чөлөө авч өгвөл сайн байна. -Хэзээ?

-Өнөө шөнөөс эхлээд.

-Та Парис хотоос явах болоо юу?

-Даалгаврыг гүйцэтгэхээр явах болж байна

-Хаашаа явж байгаагаа та над хэлж болох уу?

-Лондон орно.

-Таны хүрэх газраа бүү хүрээсэй гэж хүсэхээр хүн байх уу?

-Намайг саатуулахын тулд, хамба ламтанюу байдгаа өгсөн байх гэж санагдана. -Та тэгээд ганцаараа явж байгаа юм уу?

-Би ганцаараа явж байна.

-Тэгвэл та Бонди гэгч газраас цааш холдож чадахгүй, де Тревиль би танд хэлж байна. - Яагаад?

-Замд чинь хүн явуулаад алуулчихнаа -Яахав, би үүргээ гүйцэтгэж яваад л амь алдана. -Гэтэл танд даалгасан юм биелэхгүй хоцорно шүү дээ.

-д'Артаньян энэ үнэн... гэв.

-Миний үгийг итгэж хүрэх газраа нэг нь явж хүрье гэвэл иймэрхүү ажилд чинь дөрвүүлээ явах хэрэгтэй юм, гэж де Тревиль хэллээ.

-Таны хэлдэг зөвөө, эрхэм ээ, гэж д, Артаньян зөвшөөрөөд, тэгвэл та Атос, Портос, Арамис гурвыг мэднэ, мөн би тэднийг дагуулаад явж болохыг та бас мэднэ шүү дээ. -Миний мэдэхийг

хүсээгүй нууцыг илчилж өгөлгүйгээр үү?

-Бид нэгэндээ сохроор итгэж, үүрт үнэнч сайн явахаар андгайлсан юм. Түүнээс гадна над бүрэн итгэж байгаа та тэр нөхдөд маань хэлчих юм бол тэд таны нэг адил над итгэх болно гэв.

-Тэдэнд, би хоёр хоёр долоо хоногийн чөлөө олгож болно. Атосын шарх эмзэглээд байгаа болохоор Форжийн Рашаанд очиж орно биз. Портос Арамис хоёр тийм муу байгаа нөхрөө ганцааранг нь орхилттой биш, хамт явна гэнэ биз. Чөлөө олгосон бичиг нь та нарыг миний зөвшөөрөлтэйгөөр явж байгаагийн гэрч болно биз.

-Танд гялайлаа, эрхэм ээ татуйлгүй сайн хүн юм.

-Даруй цаадуул дээрээ оч. Өнөө шөнөдөө л явсан байх хэрэгтэй... Аа тийм, одоо Дезессар гуайд өргөдөл бич. Магадгүй таны алхам бүрийг одоо тагнуул туршуул хүмүүс ажиж байж мэднэ. Тэгвэл манайд орж ирсний учир шалтаг нь ойлгомжтой болноо Үүний чинь хамба дуулж таарна шүү дээ.

д " Артаньян өргөдөл бичлээ. Гасконь залуугийн гараас Де Тревиль гуай өргөдөл хүлээж авахдаа, чөлөө олгосон дөрвөн бичгийг, явах дөрвөн хүний тус тусын байранд хоёр цагт багтааж хүргэсэн байна гэж амлав.

-Миний бичгийг Атосынх руу явуулж өгөөрэй, гэж д'Артаньян гуйгаад, Гэртээ харивал ямар нэг олиггүй муу явдалтай тааралдаж мэднэ гэж би чухамдаа айж байгаа юм. -Бүү санаа зов. Баяртай, замдаа сайн яваарай... гэснээ Де Тревиль гуай, байз, жаахан азнаа гэж хашхирсанд д'Артаньян буцаж ирэв.

-Танд мөнгө бий юу?

д'Артаньян халаасандаа байгаа ууттай мөнгийг алгадав. Хүрэх юм уу гэж де, Тревиль асуув. - Гурван зуун алтан зоос.

-Элбэг, ийм мөнгөтэй улс хорвоо тойрсон ч хүрнэ. За тэгвэл явж үз.

д'Артаньян, де Тревиль гуайд мэхийн ёсолсонд цаадах нь гараа сунгав. Гасконь залуу баярлаж, гарыг нь хүндэтгэн барив. Парис хотноо ирсэн цагаасаа аваад д'Артаньян,

ямагт хүн мөстэй, өгөөмөр, шулуун шударга байдаг энэ сайхан хүнийг бахдаад ханахгүй байдаг билээ.

д'Артаньян эхлээд Арамисынд очив. Бонасьеавгайн хойноос ажиж байсан тэр нэг өдрөөс хойш мань хүн нөхрийндөө ирээгүй юм байжээ. Тэр ч байтугай сүүлийн үед залуу шадар цэрэгтэй төдий л олон дайралдаагүй, дайралдах бүрд нөхрийн царай гүн их гунигтай байх шиг санагддаг байлаа.

Тэр орой Арамис унтахаар хэвтээгүй, бодолд авгаж, ааш муухантай байлаа. Нөхрийнхөө юунд уйтгарласныг д'Артаньян мэдэх гэж оролдлоо. Арамис үүнд, Августын гэгээний номын арван

найм дугаар бүлгийг дараачийн долоо хоног хүртэл латины хэлээр бичнэ, үүндээ сэтгэл зовоод байгаа аятай юм ярилаа.

Хоёр нөхөр нэлээд хэдэн минут юм ярьж суутал де Тревиль гуайн нэг зарц ирээд Арамист дугтуйтай бичиг өгөв.

-Энэ юу вэ? гэж шадар цэрэг асуув.

-Эрхэм таны чөлөө гуйсныг зөвшөөрсөн бичиг гэж зарц хариулав.

-Үгүй би ер чөлөө гуйгаагүй юмсан! гэж Арамис гайхав.

-Дуугүй ав гэж д'Артаньян Арамист шивгэнээд зарцад,

-За май авчирсны шан, тал зоос ав. Арамис гуайг гү нээ талархаж байна гэж де Тревиль гуайд хэлээрэй гэв.

-Зарц, доор мэхийн ёслоод гарч одов.

-Энэ чинь юу гэсэн үг вэ? гэж Арамис лавлав.

-Хоёр долоо хоног хир юманд яваад ирэхэд хэрэг болох хамаг юмаа аваад миний хойноос яв.

-Үгүй би одоо, Парисаас явна гэхэд... гээд

Арамис дуугүй болчхоор д'Артаньян, Арамисын үгийг залгаж аваад

-... Тэр бүсгүйн яасныг мэдэлгүйгээр гэжүү, гэв.

-Хэнийг тэр вэ? гэж Арамис сөргөөж асуув.

-Энд байсан бүсгүй, хатгамалтай алчуурт бүсгүйн яасныг,

-Энд бүсгүй хүн байсан гэж хэн танд хэлээ вэ? гэж Арамис дуу алдаад, царай нь хувхай цагаан болчхов.

-Би өөрөө харсан юм.

-Тэгээд хэн гэдгийг нь таньсан уу?

-Юу ч болсон гадарлаж байна.

-Үгүй та элдэв юм ингэж их мэддэг юм бол тэр бүсгүйн яасныг мэдэхгүй биз? гэж Арамис асуув.

-Бодвол Тур хотод эргэж харьсан байх.

-Тур хотонд ий? За магадгүй. Та түүнийг мэддэг юм байна. Тэгвэл, яагаад надад ганц ч үг

хэлэлгүй. Тур рүү буцаад явчихсан юм бол?

-Баригдахаас айсан юм.

-Надад яагаад юм бичсэнгүй вэ?

-Танд гай чирэхээсээ айсан байхгүй юу?

-д'Артаньян, чи намайг дахиад амилуулах гэж байна! гэж Арамис дуу алдав. Намайг ойшоохгүй, мэхэлж байгаа юм байх гэж би бодсон юм. Дахиад түүнтэй уулзахдаа миний баярласныг яана. Миний төлөө баривчлагдахаас айлгүй наашаа иржээ гэж би бодоогүй юм. Нөгөө талаас өөр ямар эргээр тэр наашаа Парист ирсэн байдаг билээ?

-Мөн тэр хэргээр өнөөдөр бид Англи орохоор явах болж байна

Арамис үүнд,

-Тэр чинь юун хэрэг юм бэ? гэж асуув.

-Нэгэн цагт Арамис та үүнийг олж мэднээ. Одоохондоо, би номтой хүний ач охиныг санаж илүү үгнээс болгоомжилъё.

Нөхдөдөө нэгтийм юм зохиож ярьснаа Арамис санаад инээмсэглэв.

-За яахав, тэр нэгэнт Парис хотоос яваад өгсөн, та тэгж бат итгэж байгаагаас хойш, өөр энд над хоргодоод байхаар хэрэг байхгүй болохоор тантай цуг явахад бэлэн байна. Та хэлэхдээ бид...

-Юуны өмнө Атосын очно. Та надтай цуг явах гэж байгаа бол түргэлээрэй бид тун их цаг үрчихлээ.

-Базен бас бидэнтэй цуг явах хэрэг үү?

-Магадгүй. Юу ч болсон, тэр бас Атосынх руу очсон нь дээр.

Арамис, Базенийг дуудаад өөрийнхөө хойноос даруй Атосынх руу оч гэж тушаав.

-За тэгвэл явья гэж Арамис хэлээд, нөмрөг, илдээ авч, гурван гар буугаа бүсэндээ хавчуулав. Тэгснээ энд тэнд ганцнэг зоос үлдсэн байж магад гэж хэд хэдэн шүүгээ татаж үзсэнээ дэмий болохоор, д'Артаньяны хойноос хаалга руу алхав. Энд өөрийнд нь бүсгүй хүн сэм айлчилж байсныг залуу торгон цэрэг хаанаас ингэж сайн мэдэв, мөн тэр бүсгүйн хаачсаныг яаж надаас илүү мэдэж байдаг билээ гэж гайхав. Бүр гэрээс гарч явахдаа Арамис, д'Артаньяны мөрөн дээр гараа тавиад:

-Тэр бүсгүйн тухай та хэнд ч юм ярихгүй биз? ^ гэж асуув.

-Хорвоо дээр, нэг ч хүнд үг дурсаагүй.

-Атос Портоос хоёрт ч гэсэн тэр үү?

-Ганц ч үг цухуйлгаагүй

-Ашгүй дээ

Ингээд энэ талаар санаа амарсан Арамис цаашаа д'Артаньянтай цуг явсаар, удалгүй хоёулаа Атосын дирлээ.

Тэднийг ороход Атос нэг гартаа чөлөө олгосон зурвас нөгөө гартаа де Тревиль гуайн захидлыг бариад зогсож байв.

-Дөнгөж сая миний авсан энэ чөлөөний зөвшөөрөл захидал хоёрын учрыг та бүхэн хэлж өгч чадахгүй биз? гэж гайхан асуув.

" Эрхэм Атос. таны эрүүл мэндэд аргагүй хэрэгтэй байгаа юм бол танд хоёр долоо хоногийн чөлөө олгохыг би зөвшөөрч байна. Форжийн рашаан юм уу, өөр дуртай газраа явж болноо, хурдан эдгээрэй".

Ёсолсон "Тревилль" гэсэн захиа байв.

-Энэ захидал, эрх чөлөө олгосны учир гэвэл, Атос та надтай цуг явах ёстой гэсэн үг. - Форжийн рашаанд тэр үү?

-Тийшээ юм уу, өөр нэг тийшээ.

-Вангийн албаар тэр үү?

-Ван, хатан хоёрын хэргээр. Бид чинь их эзэнтэн нарын албатууд биз дээ. Яг энэ үеэр Портоос орж ирэхдээ,

-Чөтгөр алгад гэж дуу тавиад,

-Хэдийнээс эхлээд, шадар цэргүүдийн гуйгаагүй байхад чөлөө олгоод байдаг болчихоо вэ?

-Орноос нь чөлөө гуйчихдаг нөхөртэй болсон цагаас хойшоо,

-Мөөн! Янз нь нэг сонин юм болоо шив гэж Портоос дуугарав.

Арамис хариуд нь, -тийм ээ, бид юманд явах болоод байна гэлээ.

-Хаашаа тэр билээ гэж Портоос асуулаа.

-Үнэндээ сайн мэдэхгүй байна шүү, гэж Атос хариулаад, д, Артаньянаас асуу гэлээ. д'Артаньян тосч аваад,

-Бид Лондон орох болж байна эрхмүүдээ, гэж хэллээ.

-Лондонд гэнээ, Лондонд бид юу хийх хэрэг вэ? гэж Портос гайхав.

-Үүнийг эрхмүүд та бүхэн, хэлж өгөх эрх над алга. Та бүхэн над итгэхээс өөр арга үгүй дээ.

-Үгүй Лондон ортол явахад мөнгө хэрэгтэй гэтэл над юу ч байхгүй гэж Портос дуугарав.

-Надад ч юм байхгүй.

-Над ч гэсэн.

д'Артаньян халааснаасаа мөнгөтэй уут гаргаж ширээн дээр хаяад,

-Над мөнгө байна, энэ уутанд гурван зуун алтан зоос бий. Хүн бүр үүнээс далан тав, тавыг авья. Лондон ороод ирэхэд энэ элбэг хүрэлцэх мөнгө. Гэхдээ, бид цөмөөрөө Лондонд хүрч чадахгүй, бүү санаа зов.

-Яагаад тэр билээ.

-Яагаад гэвэл зарим маань замд хоцрох хэрэг болох

-Энэ чинь юу вэ та минь, бид дайнд мордож байгаа хэрэг болох нээ? -Тэх мөртөө, онц аюултай хэрэг шүү, Эртхэн хэлье.

-Чөтгөр алгад! гэж Портос дуу тавиад. бид амь алдаж 1 мэдэхээр юманд явжбайгаа болохоор, Ядаж юуны төлөө тэр вэ гэдгээ мэдмээр байна.

-Мэдсэнээрээ, чамд хөнгөн болох уу? гэж Атос асуулаа. Арамис мөн. -Үнэнээ хэлэхэд, би Портостой санал нийлж байх юм гэлээ.

-Ван ер нь бидэнд тайлан тавьдаг заншилтай билүү? Үгүй. Ван зүгээр л эрхэм үү дээ,

Гасконь ч юм уу, фландри мужид дайтаж байгаа, явж дайтацгаа л гэдэг шүү дээ. Тэгээд л бид явдаг. Юуны төлөө тэр вэ? Энэ тухай бид санаанд ч ордоггүй биш билүү гэсэнд Атос:

д'Артаньяны зөвөө, де Тревиль гуайн ирүүлсэн бид гурвын чөлөөний хуудас энэ байна. Мөн хэн өгсөн нь мэдэгдэхгүй гурван зуунзоос энэ байна. Явуулж байгаа зүгт нь явж амь дүйцгээе. Амьдрал гэдэг чинь ингэтэл олон юм шалаад байхаар эд үү? д'Артаньян би чамайг дагаад явахад бэлэн байна.

-Би ч мөн бэлэн гэж Портос хэллээ.

Би мөн бэлэн. Ер нь ч одоо би Парисаас гарч явахад дуртай, сэтгэлээ сэргээмээр байна гэж Арамис хэлэв.

-Зугаа гаргах юм мундахгүй, эрхмүүдээ, сэтгэлээ бүү зовцгоо гэж д'Артаньян өчив. -За сайн. Бид хэдийд явах вэ, тэгээд? гэж Атос асуулаа.

-Одоо ингээд ганц ч минут алдаж болохгүй юм гэж д'Артаньян хариуллаа.

-Хөөе, Гримо, Планше, Мушкетон, Базен, бидний гутлыг тослоод, морьдыг маань авч ир гэж дөрвөн нөхөд зарц нартаа тушаав.

Тэр цагт шадар цэрэг болгон нийтийн байранд, өөрсдийнхөө морьдыг зарцынхаа морьтой адуулж байдаг заншилтай байсан юм. Дөрвөн зарц эздийнхээ тушаалыг гүйцэтгэхээр гүйлээ.

-За одоо аян замын төлөвлөгөөгөө хийе. Эхлээд бид хаашаа явах вэ? гэж Портоc хэлэв. -Кале руу Лондон орох хамгийн ойр зам тэршүү дээ гэж д'Артаньян хариулав. -Портоc эхлэн за тэгвэл миний санахад...

Ярь.

Дөрвөн хүн нэг чигт явж байгаад сэжиг төрүүлж болох юм. д'Артаньян бид бүгдэд зохих заавар өгнө биз. Би түрүүлээд замаа тагнахаар Булонь өөд явлаа. Үүнээс хоёр цагийн дараа Атос Амьен хаалгаар гарч явна биз. Арамис хойноос нь Нуайноор гараад яваг. д'Артаньян яахав дуртай

замаараа явна биз тэхдээ Планшегийн хувцсыг өмсөөд, Планше торгон цэргийн хувцастай д'Артаньян болоод яваг.

-Эрхмүүд ээ, Миний бодоход ийм. хэрэгт зарц нарыг оролцуулаад хэрэггүй байх. Тайж хүн нууцыг санамсаргүй алдаж болно гэхэд зарц хүн барагтай л бол худалдаж орхино шүү гэж Атос татгалзав.

д'Артаньян үүнд. Портоcын төлөвлөгөө надад оновчтой биш санагдаж байна. Юуны урьд та нарт ямар заавар өгөхөө би мэдэхгүй. Би захиа авч яваа ердөө л энэ. Тэр захиа битүүмжлэгдсэн дугтуйтай учир би гурван хувь хуулж чадахгүй, тэхлээр бид цуг л явцгаах хэрэгтэй шиг санагдана. Захиа энэ халаасанд байгаа шүү. Намайг алуулчихвал та нарын нэг нь энэ захиаг аваад цаашаа явцгаана. Тэр хүн алуулчихвал дараачийн хүний ээлж ирнэ. Тэгсээр яваад нэг маань л хүрвэл болох хэрэг.

-д'Артаньян чи цэцэн байна. Би мөн чамтай санал нийлж байна, ер нь ч тэгээд юманд дэс дараатай байх ёстой. Би рашаанд орохоор яваа юм гэлээ, та нарнамайг дагаж яваа улс бол, Форжийн рашааны оронд би далай руу явж байна. Хаашаа ч явсан миний дур юм хойно биднийг баривчлах гэвэл би де Тревиль гуайн захидлыг та нар чөлөөний хуудсаа гаргаж үзүүлнэ биз. Хүн довтолбол бид биеэ хамгаална. Биднийг шүүхэд өгөх юм бол далайн усанд нэг хоёр умбах гэснээс өөр юм бидэнд үгүй л гээд байя. Ганц ганцаараа явж байгаа дөрвөн хүнийг дийлж дөхөх юмгүй, гэтэл дөрвөн хүн хамт явбал нэг баг шүү . дээ. Дөрвөн зарцаа бид урт буу, гар буюгаар зэвсэглэж орхиё. Бидний өөдөөс бүхэл арми явууллаа ч гэсэн тулалдаад үлдсэн нэг маань д'Артаньяны хэлснээр захидлыг хүргэж өгнөбиз гэж Атос хэлэв.

-Атос чи дуу цөөнтэй хүн, гэхдээ нэг яривал уран үгт Иоанне гэгээнээс дутах юмгүй. Атосын төлөвлөгөөг би зөвшөөрөв.

Портос чи яахав? гэж Арамис хэлэв.

-д'Артаньян зөвшөөрвөл,би ч мөн зөвшөөрнөө, захидлыг итгэмжилж өгсөн д'Артаньян мэдээжээр манай энэ явалтын ахлагч нь болно яахав, д'Артаньян өөрөө шийдэг, бид зааврыг нь биелүүлье.

-За тэхлээр би шийдлээ. Атосын төлөвлөгөөг хүлээж аваад хагас цагийн дараа мордье гэж д'Артаньян хариулав.

-За тэгье гэж гурван шадар цэрэг зэрэг дуугарав. Тэгээд ууттай мөнгөнөөс тус бур далан таван зоос тоолж аваад, хагас цагийн дараа мордоход бэлтгэж гарав.

XX. ЗАМДАА ОРСОН НЬ

Манай адалявдал эрэгч дөрөв Парис хотоос шөнийн хоёр цагт Сен-Денийн хаалгаар гарч одлоо. Орчиндоо харанхуй байх үед минь хүмүүс чимээ аниргүй явлаа. Шөнийн харанхуй өөрийн' эрхгүй тэдний сэтгэхүйд нөлөөлж, газар сайгүй л отоод байх шиг санагдана.

Нарны туяа дөнгөж мандмагц мань улс дуу шуутай болж нартай хамт ердийн наргиантай зан авир нь гарч ирлээ. Тулалдаанд орохоор зэхээд байгаа юм шиг зүрх догдлон царай инээмсэглэнэ. Амьдралаас хагацах болж мэдэх юм даа гэтэл амьдрал гэдэг чухамдаа тийм муугүй зүйл санж гэж бодогдоод ч байх шиг.

Цувран яваа эдний бараа ихээ сүртэй. Шадар цэргүүдийн харц, морьд, цэрэг эрсийн сайн нөхөр болсон энэ морьдын жагсаалд явж заншсан, жигд чийрэг алхааг харахад л ихээ нарийн юмыг гадарлан мэдэж болууштай.

Дөрвөн нөхдийн ард, шүдээ хүртэл зэвсэглэсэн зарц нар нь дагаж явлаа. Өглөөний найман цагт мань нөхөд Шантиль гэгч газар хүрч иртэл хэрэг төвөг учирсангүй. Цай уух хэрэгтэй байв. Үүдэн дээрээ, Мартин гэгээн нөмрөгнийхөө талыг гуйлгачин хүнтэй хуваалцаж байгаа зурагтай буудлын газрын өмнө тэд мориноосоо буув. Зарц нарыг мориныхоо эмээлийг авалгүй, даруй цаашаа хөдлөхөд бэлхэн бай гэж захилаа.

Дөрвөн нөхөд, нийтийн өрөөнд орж ширээний ард суув. Дөнгөж сая Даммаржепын замаар ирсэн нэг тайж хүн мөн тэр ширээний ард суугаад хоол идэж байлаа. Тэр хүн цаг агаарын байдлын тухай яриа үүсгэв. Мань хүмүүс үүнд хариуллаа. Цаад хүн өөрсдийн эрүүл мэндийн төлөө хундага өргөсөнд, мань хүмүүс мөн эрүүл мэндийн төлөө хундага өргөв,

Мушкетоныг морьд бэлэн боллоо гэж дуулгахаар орж ирээд, дөрвөн нөхдийг ширээний араас босох үед нөгөө хүн Портост хамбын эрүүл мэндийн төлөө хундага өргөө гэж хэллээ. Портос үүнд тэр хүнийг мөн вангийн эрүүл энхийн төлөө хундага өргөвөлтатгалзах юм алга гэж хэллээ. Цаад хүн үүнд их гэгээнтнээс өөр ван гэж байдгийг мэдэхгүй гэж дуу алдав. Портос түүнийг согтуу хар гэж хэлчихсэн чинь, цаадах нь илдээ суга татаж авлаа.

-Та тэнэг юм хийлээ гэж Атос хэлэв. За яая гэх вэ, одоо нэгэнт өөр аргагүй болж. Наад хүнээ алж орхиод бушуухан бидний хойноос гүйцэж оч.

Гурван нөхөд мориндоо мордоод хар хурдаараа давхин одох тэр зуур Портос цаад хүнээ илдийн ухаанд байдаг бүх аргаар сийчнэ гэж амлаж байв.

Тэндээс таван зуугаад алхам холдсоны дараа Атос, за нэгдэх нь энэ боллоо шив гэлээ.. -Үгүй, тэр яагаад бидний нэгийг өдөлгүй заавал Портосыг өдөв өө? гэж Арамис асуусанд, д'Артаньян:

-Портосыг бүхнээс чанга дуутай болохоор тэр хүн бидний ахлагч гэж санажээ гэв. -Энэ Гасконь залууг би гойд цэцэн цэлмэг хүн гэдэг гүйсэн билүү гэж Атос тэндээ дуугарав.

Ингээд тэд цаашаа явсандаа л явлаа.

Бове гэдэг газарт мань хүмүүс хоёр цаг зогсож морьдооамраахдаа, Портосыг гүйгээд ирэх болов уу гэж бас горьдож байлаа. Хоёр цаг өнгөрөөд Портос үзэгдэхгүй, хэл чимээгүй болохоор тэд цаашаа явлаа.

Бовегаас цаашаа нэг мод хир яваад, зам хоёр талаасаа шахагдаж явцуурсан нэг газар найм, арав орчим хүн тэндхийн зам засагдаагүйг далимдуулан засаж байгаа дүр үзүүлэн байгаа дайралдав. Чухамдаа тэд нүх ухаж, шавартай ховилыг хичээнгүйлэн гүнзгийлж байлаа.

Арамис тэр зориуд зуурсан шаварт гутлаа будахаас болгоомжлон тэр улсыг ширүүхэн зандарчхав Атос түүний! хорих гэж оролдсон нь хожигджээ. Ажилчид зам яваа хүмүүсийг элдвээр дооглож, даварсан хэгжүүн байдлаараа уулын амгалан Атосын уурыг хүргэсэнд, Атос тэдний нэг өөд мориороо тулж очлоо.

Тэгвэл тэр улс цөм суваг руу гүйж ороод, тэнд нууж тавьсан буугаа авлаа. Манай хэд шууд л суман дундуур дайрч гарахад хүрлээ. Арамис мөрөндөө шархдаж, Мушкетоны өгзөг рүү бас сум орчихжээ. Гэхдээ ганц Мушкетон л шархаа харах аргагүй тул түүнийгээ их хунд юм бодсон бололтой. Мориноосоо унаж хоцров

-Эд биднийг отоож байж Буудалцах явдалгүй, цаашаа явцгаа гэж д'Артаньян хэлэв. Арамис шархадсан боловч мориныхоо дэлээс зуурч, морь нь бусдын хойноос дагаж давхилаа. Мушкетоны морь сул давхиж ирээд мөн тэдэнтэй нийлэв.

-Бид нэг хөтөлгөө морьтой боллоо гэж Атос дуугарлаа.

! -Илүү малгай байсан бол над дээр байхсан, миний малгайг сум аваад хаячихсан. Авч яваа захидлаа, малгайд нуугаагүй маань бөөн аз болжээгэж д'Артаньян хариулав. Арамис үүнд, - Тэр ч ТИРМ. Харин энэ улс хөөрхий Портосыг үүгээр "өнгөрөхөд нь алчихна даа, гэсэнд Атос:

-Портос босох сөгөөтэй байсан бэл аль хэдийн биднийг гүйцээд ирэх ёстой. Миний бодоход, тэр согтуу хүн. тулалдах болохоороо эрүүл болчихсон догоо гэв.

Морьд тун их цуцаж цаашаа явж чадахаа байчих бий гэж зовмоор болж ирсэн боловч тэд цаашаа хоёр цаг хиртэй давхилаа.

Зам яваа хэд элдэв учралаас зайлсхийх санаатай зөрөг замаар орлоо. Гэвч Кревкере гэдэг газар хүрч ирээд Арамис цаашаа явах чадалгүй боллоо гэв. Нээрээ ч Арамис гадаад хээнцэр байдал, дэгжин байр төрөхөөрөө нууж байдаг болохоос лут, их зоригтой хүн тулдаал энэ хүртэл тэсэж иржээ. Явах тутмаа Арамисын царай улам зэвхийрч эмээл дээр нь тушиж явахад хүрч байлаа. Арамисыг нэг буудлархуу газрын дэргэд буулгаад, Базенийг дэргэд нь үлдээв. Базен чухамдаа зэвсэг бариад тулалдахын цагт нэрмээс болно уу? гэхээс нэмэр болохгүй хүн билээ. Ингээд Амьен гэгч газар хүрч хонох санаатай цаашаа хөдлөв.

Тэгээд хоёр эзэн хоёр зарц дөрвөн хүнтэй жижиг баг цаашаа замаар давхих үед Атос, - Чөтгөр, одоо дахиад би эдний гох дэгээнд яасан ч өртөхгүй. Эндээс аваад бүр Калэ хүртэл тэд намайг үг дуугаргаж чадахгүй, андгайल्या гэв.

д'Артаньян хажуугаас нь;

Бүү андгайл, морьд бахардаж орхихгүй бол жаал хурдхан явбал дээр юмсан гэлээ. Ингээд зам яваа улс морьдоо давирахад, морьд хүч сэлбэх шиг улам хурдална. Амьен гэгч газарт тэд шөнө дунд хүрч, "алтан линхуа" гэгч буудлын өмнө мориноосоо буулаа.

Буудлын эзэн гэж хорвоо дээр ховорхон эелдэг хүн аж, Эзэн нэг гартаа лаа, нөгөө гартаа шөнийнхөө овоодойг барьсаар зочдоо угтав. Хоёр зочиндоо, нэг нэг сайхан өрөө өгье, ганцхан харамсалтай нь хоёр өөрөө байшингийн хоёр үзүүрт байдаг юм гэсэнд д'Артаньян Атос хоёр үгүй гэв. Эрхмүүдэд тэнцэм өөр өөрөө байхгүй гэж эзэн хариулсанд зам яваа улс нийтийн өрөөнд шалан дээр дэвсгэр дэвсээд унтана гэлээ. Эзэн жаал гуйх гэтэл, зочид зөрөөд болж өгсөнгүйд, тэдний хүслийг дагахаас өөр замгүй болов.

Мань хоёр дэвсгэрээ дэвсэж, үүдээ хааж амжаагүй шахуу байтал, цонхны хаалтыг хүн тогшлоо. Хэн бэ гэж асуутал зарц нарын нь танил дуу гарав.

Үнэхээр ч Планше, Гримо хоёр байлаа.

-Морьдыг ганц Гримо л харвал боллоо. Эзэд зөвшөөрвөл би энд үүд хөндлөн унтъя. Тэхлээр эзэд санаа зовох юмгүй амарч болно гэж Планше хэлсэнд д'Артаньян;

-Чи тэгээд юун дээр хэвтэх юм бэ? гэв.

-Миний дэвсгэр энэ байна гэж Планше нэг тэвэр сүрэл үзүүллээ.

' -Чиний зөв, наашаа ороод ир, гэж д'Артаньян хэллээ. Буудлын эзний царай надад нэг л аягүй санагдсан, тун нялуун оргиод.

-Надад ч бас нэг аягүй санагдсан гэж Атос үг нэмэрлэв, Планше цонхоор орж ирээд үүд хөндөлсөн хэвтлээ. Гримо харин морины саравчинд очиж унтахаар явахдаа маргааш өглөө таван цагт дөрвөн морь бэлэн байна гэж амлав.

Шөнө овоо тайван өнгөрлөө. Хоёр цагийн үед нэг хүн үүд онгойлгох гэж оролдсон хэдий боловч, Планше сэрээд "Хэн бэ" гэж хашгирсанд, үүд андуурчээ гэж хэлээд холдов,

Дөрвөн цагийн үед морины саравчнаас бөөн их шуугиан дэгдэв. Тэгсэн чинь, Гримо, агтач нарыг сэрээх гэж үзсэнд цаадуул нь түүнийг занчжээ. Цонх онгойлгоод хартал хөөрхий Гримо хашаан дотор ухаангүй хэвтэж байв. Гримогийн толгойг сэрээний ишээр хага цохижээ.

Планше морьдоо эмээллэх гэж хашаа руу гарлаа. Гэтэл морьдын хөлд цус буучихжээ. Урьд өдөр нь тав зургаан, цаг сул явсан Мушкетоны морь л ганцаараа зам явж болмоор аж. Гэтэл буудлын эзний морьдын нэгний хөлийг хануулах гэж дуудсан гэж малын эмч яагаад ч юмэндүүрч Мушкетоны морийг ханачихсан байв.

Байдал төлөв санаа зовууштай болж ирлээ. Дараа дараалсан энэ гай, цөм тохиолдлын хэрэг байж болох авч мөн хуйвалдааны үр дүн байж болох байв.

Атос , д'Артаньян хоёр гадагшаа гарлаа. Орчин тойронд гурван морь, худалдаад авчиж болохтой газар бий эсэхийг мэдэх гэж Планше явлаа. Буудлын үүдэн дээр эмээлхазаартай ядарч эцээгүй хоёр морь зогсож байлаа. Энэ бол мань улсад яг хэрэгтэй юм нь байв. Морьдын эзэд хаа байгааг Планше асуусанд, эзэд нь энд буудалд хоносон одоо эзэнтэй тооцоогоо хийж байгаа гэж хариулав. Атос, тооцоогоо бодох гэж доошоо буугаад, д'Артаньян Планше хоёр хаалган дээр зогсож үлдэв.

Буудлын эзэн байшингийн алс нэг намхан адартай өрөөнд байжээ. Атосыг мөн тийшээ орохгүй юу гэж гуйлаа. Өрөөнд ороод, ажиг сэжиггүй байсан Атос хоёр алтан зоос авч буудлын эзэнд өглөө. Буудлын эзэн нэг шүүгээний цаана, нэг нүдээ онийлгочихоод сууж байлаа. Тэр; хүн зоосыг авч эргэцүүлэн үзэж байснаа, гэнэт хуурамч зоос байна. Атосыг нөхдийн нь хамт хуурамч зоос хийдэг улс гэж баривчлуулнагэж хашхичив.

-Муу хар новш! чихийг чинь огтлоод орхиё чамайг гэж Атос дуу алдаад, өөдөөс нь давшлав.

Яг энэ үеэр шүдээ хүртэл зэвсэглэсэн дөрвөн хар хүн хажуугийн хаалгаар орж ирээд Атос руу дайрлаа.

-Би занганд орлоо! д'Артаньян мордоод давхиарай! хурдлаарай! гэж Атос байдаг чадлаараа хашгараад хоёр гар буугаараа буудав!

д'Артаньян, Планше хоёр дахин гуйхыг хүлээсэнгүй, үүдэн дээр уяатай байсан хоёр морийг тайлж аваад давирч, замаар ороод давхилаа.

д 'Артаньян хар хурдаараа давхих зуур,

-Атосыг яасныг чи хараагүй биз? гэж Планшегаас асуусанд:

-Өө эрхэм минь, хоёр буудаад дайрч ирсэн дөрвөн хүний хоёрыг унагаад орхино билээ. Тэгээд үүдний шилний цаана бусадтай нь илдээрээ үзэлцэж байх шиг над харагдсан шүү гэв.

-Сайн эрээ! Атос, гэж д'Артаньян шивнэнэ, түүнийг тэгээд. орхиход хүрлээ гэдэг бас хэцүүеэ. Ер нь бид ч хэдхэн алхаад тийм болж магад. Давхиарай, Планше, давхиарай чи лут эр юм байна гэв.

-Пикард нутгийн хүнийг аажимдаа л мэднэ гэж танд би хэлээгүй билүү, эрхэм ээ. Тэгээд ч би энд төрсөн нутагтаа яваа маань над зориг оруулж байна гэж Планше хариуллаа.

Тэгээд хоёулаа морьдоо улам давирч, зогсолгүй давхисаар Сент Омера гэгч газар хүрч ирлээ. Сент Омерт ирээд морьдоо амрахдаа, элдэв гэнэтийн учралаас болгоомжилж цулбуураа тавилгүй байж гудамжинд жаахан юм яарч үмхээд цаашаа давхилаа.

Калэ хотын хаалганаас зуугаад алхмын наана д'Артаньяны морь бахардаж ойчоод, яагаад ч босч чадахгүй, хамрын нүх, нүднээс нь цус гарлаа. Планшегийн морь үлдсэн боловч хөдөлж өгсөнгүй.

Аз болоход бидний хэлсэнчлэн тэд хотын хаалганаас зуугаадхан алхам газар ирчихсэн тул

морьдоо зам дээр орхиод хөлөг онгоцны зогсоол руу явгаар гүйлээ. Дөнгөж сая ирсэн бололтой нэг тайж хүн зарцынхаа хамт тэднээс тавиадхан алхмын өмнө мөн зогсоол руу явж байгааг Планше үзээд д'Артаньянд анхааруулав.

Хартал мөн нэг тийшээ яарч яваа бололтой тэр хүнийг мань хоёр гүйцэхээр шийдлээ. Тэр хүний гутал тоосонд дарагдаж гүйцсэн, өөрөө даруй Англи руу явж болох эсэхийг сураглаж байв. Хөдлөхөд бэлхэн байгаа нэг жижигхэнхөлөг онгоцны эзэн тэр хүнд,

-Уул нь түүнээс амархан юу байх билээ, гэтэл өнөө өглөө, хамбын тусгай зөвшөөрөлгүйгээр хэнийг ч явуулж болохгүй гэсэн тушаал гарсан л даа, гэж хариулав.

Нөгөө тайж халааснаасаа нэг Цаас гаргаад,

-Надад тийм зөвшөөрөл бий, энэ байна, гэв.

-Үүнийг чинь боомтын дарга тэмдэглэж орхиг. Тэгээд минийхээс өөр онгоц та бүү эрээрэй гэж, хөлөг онгоцны эзэн хэлэв.

-Дарга нь одоо хаа байгаа вэ?

-Зуслангийн байшиндаа бий дээ

-Тэр байшин нь тэгээд?...

-Хотоос дөрвөн мод хиргазар байдаг юм. Тээр нэг гүвээний бэлд. Эндээс одоо харагдаж байна даа.

Ирсэн хүн,

-За сайн гээд зарцаа дагуулж, даргын гэр өөд алхав. Тэднийг таван зуугаад алхам явуулаад д'Артаньян

Планше хоёр араас нь дагалаа.

Хотын захад гараад д'Артаньян алхаагаа нэмж, саяны тайжийг нэгэн бяцхан төглийн цоорхой дээр гүйцэж ирэв.

д'Артаньян яриа үүсгэж,

-Эрхэм ээ, та янз нь их яарч байх шив гэв.

-Их яарч байна, эрхэм ээ, д" Артаньян үгээ залган,

-Их тоогүй дээ, би ч мөн их яарч байгаа болохоор. Танаас нэг тус үзүүлэхийг гуймаар байна гэв.

-Юу тэр вэ.

-Та намайг урдаа оруулж үз,

-Тун арга байхгүй, эрхэм ээ жаран мод газрыг би дөчин дөрвөн цаг явж ирээд байгаа хүн, тэгээд маргааш үд болоход заавал Лондон орсон байх учиртай юм гэж нөгөө тайж хариулав. - Мөн энэ замыг би дөчин цаг явж ирсэн хүн, тэгээд маргааш өглөө арван цагт би Лондонд байх учиртай юм.

-Тун тоогүй байна эрхэм ээ, гэхдээ би түрүүлж ирчхээд, сүүлд чинь орж чадашгүй. -Тоогүй дээ, эрхэмээ, би сүүлдэж ирсэн хэдий боловч, түрүүлж явна даа. -Вангийн тушаалаар тэр үү гэж нөгөө тайж зандрав,

-Өөрийнхөө дураар тэр ээ гэж д'Артаньян дуугарав.

-Үгүй та чинь, хэрүүл өдөөд байх шив.

-Өөр яанабайгаа гэж та бодоов.

-Танд юу хэрэгтэй юм бэ.

-Та мэдэхсэн гэж хүсээд байна уу.

-Тэгэлгүй яахав.

-Тэгвэл танд байгаа тэр зөвшөөрөл над хэдий чухаг хэрэгтэй боловч байхгүй, тэхлээр тэр чинь л хэрэгтэй байна.

-Бодвол, та тоглож байгаа биз.

-Би уулаасаа тоглодоггүй хүн.

-Алив, би явъя.

-Таныг явуулахгүй.

-Зоригт залуу минь, би тархийг чинь хага буудна даа. Любен! Буу өгөөд орхи! -Планше зарцыг нь чидөнгө, би эзний нь дөнгөө гэж д'Артаньян хэлэв.

Анхныхаа гавьяанд зоригжоод явсан Планше, Любен руу дайрч ороод, уулын чадалтай, овжингийн ачаар цадахыгаа гэдрэг нь харуулж унагаад цээжин дээр нь өвдөглөж, -Эрхэм та хийх юмаа хий, би хийхээ хийчихлээ гэж хашгарав.

Нөгөө тайж үүнийг үзээд, илдээ суга татан, д'Артаньянөөд дайрав. Гэвч тэр хүн сүрхий дайсантай тулгарсанд гурван агшин зуур, д'Артаньян өөрий нь гурав дахин шархдуулж тухай бүр.

-Май Атосын хариу энэ, Май Портосын хариу энэ май Арамисын хариу энэ гэж байлаа.

Гурвантаа бүлүүлчихээд тэр хүн нам уначхав.

Түүнийг үхчихсэн юм уу, юу ч болсон ухаан алдсан байх гэж д'Артаньян бодоод нөгөө зөвшөөрлийг нь авахаар ойртож очив. Тэгээд нэгжих санаатай гараа сунгатал шархдаад илдээ гараасаа салгаагүй байсан наад хүн д'Артаньяны цээж руу бүлээд ,

-Май таны өөрийн хувь энэ гэж хэлэв.

-Май энэ миний хариу! Хамгийн эцсийнх, тогтоож үз! гэж д'Артаньян дөрөвдөх удаагаа тэр хүний гэдэс рүү бүлж, газартай хадахдаа уурсан хашгарав.

Энэ удаа тэр тайж нүдээ аниад ухаан тавилаа.

Ирсэн хүний зөвшөөрлөө хийсэн халаасыг дарж үзээд д'Артаньян түүний нь өөртөө авлаа. Зөвшөөрлийг де Вард гүнгийн нэрэн дээр бичжээ.

Энд ухаангүй, магадгүй алчхаад үлдээж байгаа, хорин таваас яасан ч хэтрээгүй, залуу сайхан хүн рүү д'Артаньян сүүлчийн удаахялам хийж хараад, хүмүүс ер нь өөрсдийнхөө байдаг үгүйг ч мэдэх нь ховор, өөрсдөдөө огт хамаагүй гурав дахь хүмүүсийн ашиг сонирхлын үүднээс ийнхүү нэг нь нөгөөгөө хөнөөж байдаг хачин хувь тавилантайг бодоод санаа алдав.

Гэтэл Любен байдаг чадлаараа аварч туслахыг гуйж хашгараад энэ бодлыг нь даруй замхраалаа. Планше тэр зарцын хоолойг байдаг чадлаараа базаад,

-Эрхэм ээ, намайг ингээд базаж байх зуур энэ чинь дуугүй байна, тавиад орхихын хамт л дахиад орилно доо. Энэ чинь Норманд хүн байна, эд чинь бүр болдоггүй зөрүүд улс юм шүү гэж Планше хэллээ.

Үнэхээр ч Планшег хоолойгий нь төдий чанга базаад байхад хүртэл Любен дуугарах гэж мэрийгээд байлаа. Тэхлээр нь д'Артаньян,

-За байз гэж алчуураа гаргаж ирээд, зөрүүд эрийн аманд чихчихэв.

-За одоо үүнийг модтой бариад хүлчихье, гэж Планше

санал гаргав.

Хоёулаа Любенг дангинатал хүлж хаячхаад, де Вард гүнг зарцын нь хажууд авчирч тавив. Шөнө болж байв. Шархадсан хүн, гар хөл хүлээстэй зарц хоёр замаас зайдуу, бутан дотор байсан болохоор лав л өглөө болтол тэндээ байх төлөвтэй байлаа.

-За одоо, боомтын дарга дээр очье гэж д'Артаньяныг хэлэхэд Планше. -Үгүй та чинь шархадсан байна шүү дээ гэв.

-Ялихгүй юм эхлээд аль болох яаралтай юмаа хийж аваад, миний шархыг сүүлд үзнэ биз. Янз нь энэ тэгээд тийм ч аюултай биш дэг.

Ингээд хоёулаа хүндэт түшмэлийн гэр өөд түргэн алхав. Граф де Вард ирлээ гэж даргад илтгээнд, д'Артаньяныг өрөөнд ор гэв.

-Танд хамбын гарын үсэгтэй зөвшөөрөл бий юу гэж дарга асуулаа.

д'Артаньян хариуд нь

-Тиймээ, эрхэм ээ, энэ байна гээд өгөв.

-За, бичиг баримт чинь ёсоороо байна. Тэр ч байтугай танд тусал гэсэн заавар бий. -Тэгэлгүй яахав. Би өөрөө гэгээнтний шадар хүний нэг юм гэж д'Артаньян хэлэв. -Их гэгээнтэн янз нь нэг хүний Англи ороход саад хийх гэж байгаа юмаа даа,

-Тиймээ, д'Артаньян гэж нэг хүнд, Беари нутгийн тэр тайж, Парисаас гурван нөхрөө дагуулж гараад, Лондон орох санаатай яваа гэж гэнэ билээ.

-Та үүнийг таних уу?

-Хэнийг?

-Тэр д'Артаньяныг?

-Сайн танина.

-Тэгвэл над байр төрхийг нь нэг сайн хэлээд өгөөч.

-Ядах юу байх вэ, гээд, д'Артаньян тэр даргад де Вард гүнгийн төрх байрыг нарийн сайн хэлж өгөв.

-Ямар хүн дагуулж яваа вэ?

-Любен гэдэг зарцаа дагуулж яваа.

-Тэдний чинь хараад байя, бидний гарт нэгордог юм бол их гэгээнтэнд санаа зовох юм байхгүй, сайн манаа харуултайгаар Парис руу буцаагаад хүргэчихнэ ээ.

-Түүгээр та хамбын хайр ивээлийг хүртэнэ, гэж д'Артаньян дуугарав. -Хариад та хамбатай уулзана биз гүн гуай?

-Яриа юу байхав.

-Намайг хамбад үнэнч сайн хүн гэдгийг дуулгаж үзээрэй.

-Заавал хэлнэ.

Энээгэнд урамшсан боомтын дарга зөвшөөрөл дээр цохолт хийгээд д'Артаньянд эгүүлж өгөв.

д'Артаньян хэт их эелдэг аашилж цаг үрсэнгүй, даргад мэхийн ёслоод талархсанаа дуулган

гарч одов.

Зам руу гарсан хойноо Планше тэр хоёр хоёул алхаагаа нэмж, модны нөгөө талаар тойрч, хотын өөр хаалгаар оров.

Жижиг хөлөг онгоц, түрүүчийнхээрээ хөдлөхөд бэлэн эзэн нь эрэг дээр зогсоод хүлээж байв. д'Артаньяныг хараад, За яав?. гэж тэр хүн асуулаа.

-Боомтын даргын цохсон, миний явах зөвшөөрөл энэ байна.

-Нөгөө эрхэм яах юм бол?

-Тэр хүн өнөөдөр явахгүй юм байна гэж д'Артаньян хэлэв. Гэхдээ та бүү санаа зов. Би хоёр хүний хөлс төлнө.

-За тийм бол замдаа орьё гэж хөлөг онгоцны эзэн хэлэв.

Явах гэж д'Артаньян мөн шамдана.

Планше тэр хоёр завинд ирж суугаад, хэдхэн минутын дараа хөлгөн дээр гарч суув.

Золтой л амжжээ. Эргээс нэг хагас мод хиртэй холдоод байх үед эрэг дээр. гал улс гэхийг д'Артаньян хартал. Их буу дуугарав.

Боомт хаасныг мэдэгдэн, дохио өгч байгаа нь тэр байжээ.

Шархаа үзэх цаг боллоо. Аз болоход д'Артаньяны тааж байснаар шарх төдий л аюултай биш аж.

Илдийн үзүүр хавирганд тулаад хажуу тийшээ халтирчээ. Дотуур цамц тэр дороо шарханд наалдаад ердөө хэдхэн дусал цус гарсан байв.

д'Артаньян хариугүй ядэрчээ. Онгоцны тавцан дээр дэвсгэр засаж өгсөнд, д'Артаньян хэвгээд даруй унтчихлаа.

Маргааш нь үүрээр мань улс Английн эргээс дөнгөж гурав дөрөвхөн мод газар ирчихсэн байлаа. Шөнө турш зөөлөн салхи сэвэлзэж онгоц овоо хурдан явсан юм байж.

Арван цагт, хөлөг онгоц Дуврийн боомтод зогсов.

Арван цаг хагаст д'Артаньян Английн газар дээр хөл тавиа д,

-Арай гэж нэг зорьсондоо дөхөж ирлээ гэж хашхирав.

Цаашаа бас явдал их, Лондон хүрэх хэрэгтэй байлаа. Англи улсад шуудан жигд сайн ажилладаг юм. д'Артаньян, Планше хоёр нэг нэг морь хөлслөв. Улаач өмнө нь давхина. Ингээд дөрвөн цаг яваад тэд нийслэл хотын хаалган дээр хүрч ирэв.

д'Артаньян Лондон хотыг мэддэггүй, Англи хэлээр ганц ч үг мэдэхгүй байсан боловч, цаасны тасархай дээр Бекингэм герцогийннэрийг бичсэнд, даруй түүний ордонг зааж өгөв. Герцог өөрөө Винтерийн ой гэгч газар вантай цуг авлаж яваа аж.

д'Артаньян герцогийн ийш тийшээ явах бүрдээ дагуулж явдаг, франц хэлэнд сайн шадар хиаг дуудуулав. Гасконь залуу тэр хиад дөнгөж сая Лондон хотноо; ирлээ, тун чухаг хэргийн учир герцогтой юм ярих хэрэгтэй байгаагаа хэлэв.

д'Артаньяны ярьж байгаа байр байдал сайдын тэр хиа Патрик гэгчийг үнэмшүүлж чаджээ. Хоёр морь эмээллэ гэж хүнд тушаагаад, залуу торгон цэргийг өөрөө газарчилж аваачих боллоо. Планшегийн хувьд гэвэл, мориноос түүнийг буулгаж авахын үед мань хүн бүр хөшиж орхиод, ядрахын туйлд хүрчихсэн байв. д'Артаньян чухам төмөр шиг биетэй хүн аж.

Виндзорын шилтгээнд хүрч ирээд, герцог хаа байгааг тэд сураглав. Тэндээс хоёр гурван мод хиртээ газарт ван, Бекингэм герцог хоёр шонхортой ан хийж байгаа гэв.

Хорин минутын дотор д'Артаньян газартайгаа зааж өгсөн газарт давхиж хүрлээ. Удаа ч үгүй шонхроо дуудаж байгаа эзнийхээ дууг Патрик дуулав.

-Милорд герцогт таныг хэн гэж айлтгах вэ? гэж Патрик асуув.

-Лувр ордны хажуу дахь шинэ гүүрэн дээр, тантай хэрүүл өдсөн залуу хүн гэж хэл. - Айлтгахад хачин үгээ.

-Энэ үг, өөр ямар ч үгнээс дутдаггүйг та үзнэ ээ.

\

Патрик цаашаа цогиулж герцогийг гүйцээд, элч ирээд хүлээж байгаа учрыг, д'Артаньяны үгээр илтгэв.

д'Артаньян юм байна гэдгийг герцог даруй мэдээд, өөрт нь дуулгавал зохино гэж үзэхүйц нэг юм Францад болжээ гэдгийг ойлгов. Тэгээд тэр мэдээг авчирсан залуу хаа байгааг асуулаа. Торгон цэргийн жагсаал хувцсыг өөрөө холоос таниад ухасхийж, шууд д'Артаньян дээр давхиж очив.

-Хатагтайд элдэв муу юм болоогүй биз? гэж герцог дуу тавьсанд хамаг хайр сэтгэл, санаазовж явдаг бүхэн нь үүгээр илэрч харагдав.

-Үгүй байхаа, гэхдээ, хатагтайд их аюул тулгарч байна, түүнээс эрхэм та л хатныг хаацайлж чадах юм шиг санагдана.

-Би юу? нээрээ хатанд ямар нэг юмаар тус хүргэх завшаан над тохиолдлоо гэж үү? Яриач тэгээд бушуухан хэлээч!

-Май энэ захиа гэж д'Артаньян өгөв. -Захиа гэнээ? Хэнээс тэр вэ?

-Бодвол их эзэгтэйгээс байхдаа.

-Их эзэгтэйгээс ий? гэж герцог лавлан асуугаад, царай нь аягүй цайраад явчихсанд, герцогийн дотор муухай болоогүй байгаа гэж д'Артаньян бодов.

Герцог захидлыг авч задлав,

Захианы нэг нэвт цоорсон газрыг зааж энэ чинь юу вэ? гэж д'Артаньянаас асуулаа.

-Ээ, би харсангүй шүү. Янз нь де Вард гүнгийн илд, миний цээж рүү орохдоо ингэж цоолчихсон байх нээ, гэж д'Артаньян хариуллаа.

Герцог захидлыг задлах зуураа, та шархдаа юу? гэсэнд д'Артаньян:

-Үгүй жаахан шалбарсан юм гэв.

-О, бурхан минь! Энэ чинь юу вэ таминь! гэж герцог дуу алдаад, Патрик чи эндээ үлд... үгүй зүгээр ванг хаа байгаа газар нь гүйцэж очоод намайг их эзэнтнээс уучлал гуйж байна, онц чухаг хэргийн учир Лондон руу буцлаа гэж байна гээ. Явья эрхэм ээ явья.

Ингээд хоёулаа нийслэлийн зүг хар хурдаараа давхилаа

XXI. ВИНТЕР ГҮНГИЙН ГЭРГИЙ

Герцог зам зуураа д'Артаньянаас, болж өнгөрсөн юм бүхний тухай эс гэхнээ, юу ч болсон мэдэж байгаа бүхний нь асууж лавлав. Залуугаас дуулсан юмыг өөрийнхөө санаанд байгаатай, Бекингэм герцог харьцуулж үзээд, үнэн байдлын тоймыг төсөөлж болох байсны дээр хатны захиа хэдий товч, тодорхойгүй байсан боловч, хүнд байдалд орсныг цухуйлгажээ. Гэхдээ, хамба ламтан энэ залууг Англи руу ирүүлэхгүйг мэрийх ёстой байтлаа саад болж чадаагүйд герцог онц гайхаж байлаа. Герцогийг ийнхүү гайхсаны хариуд, хэрхэн хамба ламтан саатуулах арга хэрэглэсэн, яаж шархдаж цусаа цувуулж байгаа нөхдөө замд зөнд нь хаяад эцэст нь өөрөө, тэр хатны захиаг цоолдог илдээр нэг бүлүүлж салаад, де Вард гуайгаас хариултавч, ирсэн тухайгаа д'Артаньян ярьж өгөв. Эд бүгдийг жирийн нэг ярьж явсан д'Артаньяны яриаг дуулахдаа герцог байн байн залуугийн царай өөд харж, өдий их хянуур ухаан, эр зориг, үнэнч зүтгэл ийм балчир дөнгөж хорь хүрсэн үү, үгүй юу хүнд байна гэдэгт итгэж ядаж байх аятай.

Морьд салхи шиг хурдалж, хэдхэнминут болоод тэр хоёр Лондонгийн хаалга хүрэв. Хотод орж ирээд, герцогийг мориныхоо амыг татах юм байх гэж д'Артаньян бодож явсан чинь герцог мөн хар хурдаараа л давхиж, зарим болгоомжгүй явсан улсыг дайраад ойчуулчихсандаа санаа зовох ч үгүй аж. Хотын төвөөр явж өнгөрөхөд тиймэрхүү юм хэд хэд тохиолдоход хөөрхий улс яагаа бол гэж Бекингем эргэж ч харсангүй. Эргэн тойронд улс хашхиралдах нь хараал зүхэлтэй тун төстэй байсан боловч д'Артаньян хойноос нь даган давхиж байлаа.

Ордныхоо хашаанд орж ирээд, герцог мориноосоо үсрэн бууж, морио зөнд нь сул хаячхаад довжоо өөд гүйн гарав. Түүний хойноос д'Артаньян дагаж явахдаа эрмэг чадлыг нь сая туршиж үзсэн сайхан морьдод бас сэтгэл зовж л явлаа. Ашгүй гал зуухны газар, морины саравчнаас хэд хэдэн зарц гүйж гараад, морьдыг хөтлөн аваачихыг харж мань хүний сэтгэл амрав.

Герцог тун шалмаг алхах тул, д'Артаньян арай л гүйцэж явлаа. Бекингэм хэд хэдэн зочлох өрөөгөөр өнгөрсөнд Францын ихэс дээдсийн санаанд ч багтахааргүй хээнцэр сайхан засаж янзалсан байлаа. Цаашаа явсаар унтах өрөөнд ороод ирвэл, элбэг баян, хээнцэр дэгжний туйл гэгч энэ мөн ажээ. Өрөөний гүнд, ханыг гадарласны дээр нууцалсан нэг хаалга харагдана. Герцог хүзүүндээ, алтан оосроор зүүсэн түлхүүр гаргаж тэр хаалгыг онгойлгов.

Даруу сэтгэлийн үүднээс д'Артаньян холхон зогсож үлдтэл, нандин өрөөнийхөө босгон дээрээс залуугийн тэвдэхгүй байгааг харсан Бекингэм эргэж:

-Орьё, их эзэгтэйд бараалхах аз танд гарвал, энд үзсэн бүхнээ цөмийг ярьж өгөөрэй гэв. Ингэж урьсанд урамшсан д'Артаньян герцогийн араас дагаж ороод, үүд хаав,

Үзтэл ханы нь Перс газрын алтан хатгамалт торгоор бүрж өдий төдий лаа хурц гэрэлтсэн жижиг цамхаг аж.

Бурхны ширээ маягийн юман дээр цэнхэр хамбахилэнгээр бүрэн, улаан, цагаан өнгийн үнэт өдөөр чимсэн суурин дээр Австрийн Анна хатны хүний өндрийн хэмжээгээр зурсан хөрөг байв. Хатагтайтай даанч эгэлгүй адилхан, юу юугүй үг хэлэх гэж байх шиг. д'Артаньянд .

санагдсанд мань хүн дуу алдчихав.

Ширээн дээр, хөрөгний дэргэд нөгөө алмазан унжуургатай хайрцаг байгаа харагдана. Бекингэм ширээний өмнө ойртож очоод шүтээндээ мөргөх гэж байгаа лам шиг өвдөг дээрээ сөхрөв. Тэгээд хайрцгийг нээлээ.

Хайрцаг дотроос, цул алмас эрдэнэ гялалзсан ,томоо цэнхэр тууз гаргаж ирээд, -Май ав. Тэр чухаг унжуурга чинь энэ дээ, намайг үүнтэй хамт оршуулах болно гэж би амалсан юмсан. Хатан үүнийг над өгсөн юм хатан эгүүлээд авч байна. Юундээр ч гэсэн. хатны хүсэл надад ямагт бурхны зарлиг шиг байх юмаа гэв.

Тэгээд эгүүлж өгөх болж байгаа тэр унжуургыг гегцог нэг нэгээр нь үнсэж гарлаа. Гэнэт Бекингэм муухай хашгарчихав.

-Юу болов оо? Милорд та яав аа? гэж д'Артаньян сандран асуув.

-Хамаг хэрэг баларчээ! гэж дуу алдаад, герцогийн царай зэвхий дааж хоёр унжуурга байдаггүй. Энд дөнгөж арван унжуурга үлдээд байна.

-Милорд, тэр унжуургыг хаячихаа юм болов уу. аль хулгайд алдсан байх гэж санаж байна уу? - Унжуургыг хулгайлжээ, хамбын явуулгаар үүнийг хулгайлсан хэрэг. Хараач, зүүлттэй байсан туузийг тас хайчилсан байхгүй юу.

-Хэн хулгайлсан байж болохыг та гадарлавал, унжуурга одоохондоо тэр этгээдийн гарт байж мэдэх юм даа.

-Байз, байз! гэж герцог дуу алдав. Унжуургыг би ганцхан удаа зүүсэн. Нэг долоо хоногийн өмнө, Виндзорын шилтгээнд болсон вангийн бүжиг наадам дээр юм даг. Урьд надтай эв муутай байсан, Винтер гүнгийн гэргий тэхэд надтай эвлэрэх гэж илтэд оролдоод байсан юм. Тэр бол чухамдаа, жөтөөрхөг бүсгүйн хорон санаа байх нь. Тэр өдрөөсхойш гүнгийн авгай миний нүдэнд ер үзэгдээгүй. Тэр бүсгүй, хамбын тагнуул этгээд лав мөн

д'Артаньян үүнд,

-Үгүй хамбын тагнуул этгээдүүд гэдэг чинь хорвоогоор нэг болчихсон хэрэг үү? гэв.

-Ээ тэр ч тийм, тэр чинь аймшигтай дайсан. Үгүй тэр бүжиг наадам чинь хэдийд болох юм бэ? гэж Бекингэм цухалдаж хорсон, хөмхий зуун дуугарав.

-Дараачийн даваа гаригт.

-Дараачийн даваа гаригт ий! Дахиад тав хоног цаг ч элбэг амжихаар юм байна. Патрик. нааш ир! гэж герцог хашгарав.

Герцогийн хиа хүрч ирлээ.

-Миний инжээн нарийн бичгийн дарга хоёрыг бушуул!:

Хиа, эзэндээ үг дуугүй сөхрөөд үйлчилж сурсан байртай бушуухан дуугүй гарч одов.

Хэдийгээр инжээнийг түрүүлж дуудсан боловч, нарийн бичгийн дарга ордон дотор байдаг болохоор аргагүй түрүүлээд орж ирэв. Нарийн бичгийн даргыг орж ирэхэд Бекингэм унтах өрөөндөө, ширээний ард суугаад, нэг тушаал өөрөө бичиж суув.

Герцог, орж ирсэн хүнд,

-Жексон гуай та даруй ерөнхий захирагч гуай руу очоод, миний энэ тушаалыг гүйцэтгэх ажлыг намайг өөрт нь даалгаж байна гэж хэл. Энэ тушаал нэн даруй нийтлэгдсэн байх ёстой юм шүү гэв.

Нарийн бичгийн дарга, бичсэн юмыг хурдхан гүйлгэж уншаад,

-Гэгээн сайдаа ийм чухаг арга хэмжээ авч байгаагийн учрыг ерөнхий захирагч гуай надаас асуувал би юу гэх вэ? гэж асуув.

-Миний таалал л тэр, юу хийж байгаа тухайгаа бихэнд ч тайлагнах ёсгүй гэсэн гэж хариул. Англи улсын боомтуудаас нэг ч хөлөг онгоц гадагшаа гарч болохгүй болсны учрыг их эзэнтэн яагаад ч юм мэдэхсэн гэвэл ерөнхий захирагч гуай мөн ийм хариу дуулгах уу? гэж нарийн бичгийн дарга инээмсэглэж асуув.

-Үүнд Бекингэм, таны зөвөө, эрхэм ээ, Тэгвэл намайг дайн зарлахаар шийдсэн, Францын эсрэг явуулж байгаа миний анхны дайсагнах бодлого энэ юм гэж ерөнхий захирагчид хэлнэ биз гэв.

Нарийн бичгийн дарга мэхийн ёслоод гарч одов. Герцог, д'Артаньян өөд эргэж: -Бид энэ талаар санаа зоволтгүй боллоо. Тэр унжуургыг Францад явуулж амжаагүй бол таныг буцаж харьснаас хойш л тэнд хүрнэ.

-Яагаад тэр вэ?

-Их эзэнтний аль нэгэн боомтод байгаа алив хөлөг онгоц хөдөлж явахыг би сая хориглож орхилоо. Тэхлээр тусгай зөвшөөрөлгүйгээр нэг ч хөлөг онгоц хөдөлж чадахгүй болсон.

Вангийн итгэж хайрласан хэмжээгүй эрх мэдлээ, хайр дурлалынхаа хэрэгт ашиглаж чадаж байгааг хүнийг д'Артаньян гайхаж харна. Гасконь залуугийн царайгаар дотор нь юу бодогдсоныг Бекингэм гадарлаад,

-Үнэндээ, Австрийн Анна хатан миний жинхэнэ хатан. Хатны нэг уг дуугарвал би эх орон, ван эзэн, бурхан шүтээнээсээ ч урвахад бэлхэн хүн. Ларошель хотын тэрслүү номтонд бүү дэмжлэг үзүүлээч гэж хатан надаас гуйхаар нь би туслахаарамлачихсан байсан мөртөө больж л орхисон. Тэнд хэлсэн амандаа би хүрээгүй, гэхдээ хатны тааллыг л дагасан хойно над ямар хамаа байх вэ. Та тэгээд бодоод үз л дээ. тэгж дуулгавартай байсандаа би хир сайхан шан хүртэх вэ?

Номхон хүлцэнгүйн шанд энэ хөргийг над хайрласан юмаа гэж Бекингэм ярилаа. Ард түмний

хувь заяа, олон хүний амь нас заримдаа чухам ямар өчүүхэн, үл ажиглагдах юман дээр торж байдгийг д'Артаньян гайхан бодов.

Мань залууг ийм бодолд автаж байтал инжээн хүрч ирэв. Энэ Ирланд үндэсний инжээн гойд уран хүн юм байж. Энэ инжээн Бекингэм герцогийн захиалгыг хийгээд жилд зуун мянган фунт стерлинг олдгоо өөрөө ч билээ ярьдаг гэнэ.

Герцог тэр хүнийг цамхагт дагуулж ороод,

-Рейли гуай та энэ алмазан унжуургыг үз. Тэгээд тус бүр ямар үнэтэй байхыг над хэлж өг гэв. Алмасыг уран сайхан засаж хийсний нь инжээн хармагц мэдэж, тус бүрий нь үнийг бодоод: - Унжуурга бүр нэг мянга таван зуун алтан зоос болно гэж шуудхан хэлэв. Ийм хоёр унжуурга хийхэд, хэдэн өдөр орох вэ? Хоёр нь алга байгааг та харж байгаа биз? -Нэг долоо хоног болно, Милорд гуай.

-Би унжуурга бүрд гурван мянган алтан зоос өгнөө. Надад одоохон л хэрэгтэй байна. - Милордод хийж өгье.

-Та чухам цаглашгүй чухаг хүн юмаа, Рейли гуай. Гэхдээ үүгээр зогсохгүй, энэ унжуургыг хэнд ч гэж итгээд өгч болох зүйл биш. Эднийг энд, ордон дотор хийх хэрэгтэй.

-Арга байхгүй дээ, Милорд, ганцхан би өөрөө л шинэ хуучин хоёрын ялгааг мэдэгдэхээргүй хийж чадна.

-Ингэхэд байнаа Рейли гуай та над шууд л олзлогдсон хүн гэж мэд. Ухаан нь та одоо манай ордноос гараад яв гэсэн ч чадахгүй. Тэхлээр үүнтэй эвлэрч үз. Туслагч нар дотроосоо хэрэг болох нэгий нь дуудуулаад, ямар ямар багаж авчрахыг хэлж өг.

Инжээн өөрөө Бекингэмийн занг сайн мэдэх болохоор, маргаад тусгүйг ойлгож, аргагүй болсон хэрэгт даруй дагав.

-Эхнэртээ дуулгахыг надад зөвшөөрөхсөн болов уу? гэж тэр хүн асуулаа.

-Өө, Рейли гуай минь, танд эхнэртэйгээ уулзахыг хүртэл зөвшөөрнө. Бүү санаа зов, таныг тэгж чанд хорихгүй. Гэхдээ хүнд төвөг нэгэнт удсан хойно, шагнах ёстой. Май; унжуурга бүрийн тохиролцсон үнэнээс гадна, танд бас нэг мянган алтан зоос шагнав. Үүнийг аваад өөртөө төвөг удсаны минь мартаж үз.

Эд баялаг, хүнийг ийнхүү зоргоороо зарж байдаг сайдыг үзээд д'Артаньян гайхаж барахгүй байв.

Энэ зуур инжээн гэргийдээ захиа бичиж мянган алтан зоос авах баримтыг мөн явуулав. Туслагч нарынхаа хамгийн чадмаг нэгийг нь, баахан алмас, хэрэг болох багаж хэрэгслийн хамт ирүүлэхийг гуйжээ. Мөн авчруулах алмазны жин чанар, байдлыг нарийн тодорхойлж бичив.

Инжээнийг , нэг хагас цагийн дотор ажлын өрөө болгож амжсан, ажил хийх өрөөнд нь

дагуулж авчирлаа. Ингээд хаалга болгон дээр харуул зогсоож, өөрийнхөө хиа Патрикаас өөр хэнийг ч оруулж гаргахгүй чанд тушаал өгөв. Инжээнболон туслагч хоёрыг алив нэг шалтгаар өрөөнөөс гарахыг чанд хориглосон тухай дурсаад яах вэ. Герцог ийм тушаал заавар өгчхөөд д'Артаньян дээр эргэж ирээд:

-За залуу нөхөр минь, Англи улс одоо та бид хоёрын мэдэлд байна. Танд юу хэрэгтэй байна, ямар юм хүсэхсэн бол? гэв.

Үүнд д'Артаньян,

-Ор дэр хэрэгтэй үнэнийг хэлэхэд, одоогоор над үүнээс чухаг юм алга санж гэв.

д'Артаньяныг өөрийнхөө унтах өрөөний хажуугийн өрөөнд оруул гэж герцог тушаав. Итгэсэнгүйдээ ч залууг өөрийнхөө ойр байлгая гэж герцог санасангүй, ганцхан хатны тухай цаг ямагт ярилцаж болох хүнтэй ойр байхыг хүсжээ.

Франц өөд ачаа бараа, элдвийг тээвэрлэх хөлөг онгоц боомтоос хөдлөхийг хориглосон зарлиг цаг болоод нийтлэгдэв. Шуудангийн хөнгөн онгоцыг хүртэл явуулахгүй болжээ. Хоёр улсын хооронд дайн зарлалаа гэсэн үг боллоо гэж улс амьтан боджээ.

Нөгөөдөр өглөө нь арван нэгэн цагт унжуурга бэлэн боллоо. Даанч уран эгэлгүй адилхан хийж чадсан тул Герцог өөрөө шинэ хуучны нь ялгаж чадахгүй байв. Тэр ч байтугай ийм юмандихээ мэргэшсэн хүмүүс хүртэл нэг адил ялгаж чадахааргүй байжээ.

Герцог даруй д! Артаньяныг дуудаад;

-За. таны авах гэж ирсэн алмазан унжуурга энэ байна,

хүний хуч хүрэх бүгдийг л хийсний минь гэрч болж үзээрэй

гэв.

-Милорд та бат итгэ, үзсэн харсан бүхнээ би ярина. Гэхдээ, эрхэм та, унжуургыг над хайрцаггүй өгч байна.

-Хайрцаг таны замд тээр болно. Тэгээд ч над ганц тэр хайрцаг л үлдэж байгаа болохоор нандин чухаг юмаа. Намайг аваад үлдсэн гэж та хэлээрэй.

-Милорд, таны хэлснийг би дутаахгүй дамжуулна.

-За одоо, би яаж таны ачийг жаахан ч билээ хариулдаг юм билээ гэж герцог залуу өөд эгц харж өгүүлэв.

д'Артаньяны царай улс хийгээд явчихлаа. Герцог өөрөөсөө ямар нэг юм бэлгэнд авахуулах арга эрж байгааг залуу ойлгоод өөрийн нь болоод нөхдийн нь асгаруулсан цусны хариуг английн алтаар төлөх гэж байна гэж санахаас гүнээ зэвүүцэн сэжиглэв.

Тэгээд д'Артаньян: Милорд, Ний нуугүй ярилцах, учраа ололцохын тулд бүгдийг цэгнэж үзье. Би өөрөө Дезессар гуайн суманд торгон цэргийн алба хааж, Францын ван эзэн, хатан хоёрт хүчээ өгдөг хүн. Манай дарга өөрөө де' Тревиль гуайн хүргэн, их эзэнтэн нарт чин үнэнч сайн хүн. Үүнээс гадна, таны сэтгэлд их эзэгтэй чухгийн адил мөн надад чухаг нэг бүсгүй байгаагүйсэн бол би энэ ажилд явахгүй чбайсан байж мэдэх билээ гэв.

-Тиймээ, тэр бүсгүйг би таних байх, тэр чинь... гэж герцогийг инээмсэглэтэл, залуу торгон цэрэг хажуугаас нь яаран:

-Эрхэм ээ, тэр хүний нэрийг би дурсаагүй билээ гэв.

-Зөвөө тэхлээр зүй нь би тэр бүсгүйд ач санах ёстой болж байна, гэж герцог дуугарлаа.

-Яриагүй үнээн, гэгээнсайдаа. Юу гэвэл одоо дайн юу юугүй эхлэх гэж байхад үнэнийг хэлэхэд, гэгээн сайд таныг ердөө л Англи хүн, тэхлээр дайсан гэж үзэж байна. Дайсантай би Виндзорын ойд юм уу, Лувр ордны гудамжинд дайралдахаасаа дайны талбар дээр дуртайяа учрахсаан. Гэхдээ би авсан даалгавраа мэрийн гүйцэтгэх хэрэгтэй болбол амиа өхөд энэ зүйл саад болохгүй юм. Дахиад хэлэхэд гэгээн сайд тантай би анх учрахдаа төдий л тус болоогүйчлэн, дахин уулзахдаа ч их тус болоогүй, надад ач санаад байх юм танд үгүй билээ.

Герцог манайхан, шотланд хүн шиг бардам зантай юм гэж хүнийг хэлдэг гэж аман дотроо дуугарав.

-Манайхан "Гасконь хүн шиг бардам зантай" гэж хүнийг хэлдэг Гасконыхан гэдэг чинь францын шотландчууд нь юм шүү дээ гэж д'Артаньян хэлээд, герцогт мэхэсхийж хүндэтгээд гарч одохоор завдав.

-Юу? Та яваад өгөх гэж байна уу?

Үгүй та ямар замаар явах санаатай байна? Англиас та яаж гарах юм бэ?

-Үгүй, нээрээ...

-Үгүй бас хачнаа! Энэ францууд ер юманд цочоогүй улс шүү та минь!

-Англи гэдэг чинь нэг арал, түүний эзэн нь та юм гэдгийг би мартаад орхиж,

-Боомт руу очоод "Зунд" гэсэн хөлөг онгоцыг асууж олоод, энэ захидлыг даамалд нь өг. Тэр хүн таныг фракцын загасчдаас өөр улс бараг буудаггүй нэг жижиг зогсоолд аваачиж буулгана.

-Тэр чинь ямар зогсоол бэ?

-Сен Валери, үгүй азнаж бай л даа. Тэнд очоод та, ёстой л нэг далайчдын орогнож байхад таарсан, нэр усгүй нэг муу буудлын газарт ороорой. Та эндүүрэх юмгүй, тэнд ганцхан л тийм, газар бий. -Тэгээд?..

-Эзний нь дуудаж; уулзаад "Forward" гэдэг ганц үг хэлээрэй.

-Юу гэсэн үг вэ?

-" Урагшаа" гэсэн үг, дохио юм. Тэхийн хамт буудлын эзэн тэнд эмээлтэй морь өгөөд, явах замыг чинь зааж өгнөө. Таны зам дээр дөрвөн солио морь бий. Та хүсвэл, зогссон газартаа Парист суудаг хаягаа хэлээд өгчихвөл, дөрвөн морьдыг таны хойноос явуулах болно. Тэдний хоёрыг та мэднэ. бидний нөгөө Виндзорын ойгоос давхиж ирдэг хоёр морь, та морь мэддэг хүний хувьд өөрөө үзсэн дээ. Бусад нь, миний үгэнд итгэ, дутахгүй морьд. Тэр дөрвөн морьдыг аян дайны байдлаар тоноглосон байгаа. Та хэдий бардам зантай хүн боловч, тэдний нэгийг өөрөө аваад, нөхдөдөө нэг нэгий нь ав гэхээс татгалзахгүй биз. Ер нь тэр морьд чинь бидэнтэй дайтахад тус болно шүү. Танай нутагт зорилгодоо хүрэхэд ямар чарга хэрэглэж болно, гэдэг юм:

-За яахав, би зөвшөөрье, Милорд бурхан гэрч болох бий. таны бэлгийг бид, ашиглаж чаднаа гайгүй, гэж д'Артаньян хэлэв.

-За залуу минь гар бариад салъя. Мөдхөн бид дайны талбар дээр уулзажбайж мэднэ. Гэвч, одоодоо бид сайн нөхдийн ёсоор салж байгаа байхаа?

-Тиймээ, Милорд. Гэхдээ, мөдхөн дайсан бололцох горьдлого байна.

-Бүү санаа зов. Лав тэгнэ гэж танд амалъя.

д'Артаньян герцогт мэхийн ёслоод даруй гарч одлоо Лондоны цамхгийн тушаа нөгөө хэлсэн онгоцы нь олж. аваад, герцогийн захидлыг даамалд нь өгсөнд, тэр хүн боомтын даргад очиж, тэмдэглүүлээд, даруй хөдлөв.

Хөдлөхөд бэлэн болсон тавиад хөлөг онгоц зогсоолд хүлээж байв.

" Зунд" гэдэг хөлөг онгоц тэдний хажуухнаар бараг шүргэн өнгөрөхөд, нөгөө Менг хотноо дайралдсан хүний Миледи гээд байсан өөрт нь их гуа сайхан санагдсан бүсгүй зэрвэсхэн харагдаад орхих шиг д'Артаньянд санагдав.

Гэвч хүчтэй урсгал, аясын салхи хоёрт жижиг онгоц хурдан явж байсан болохоор зогсоолд байсан онгоц төдхөн бараагүй боллоо.

Маргааш өглөө нь есөн цагийн үед жижиг онгоц Сен Валерид ирж зогсов.

д'Артаньян даруй нөгөө буудлын газрыг хайж, тэнд бөөн улс шуугилдаж байгаагаар нь таньж олов. Англи, франц хоёр дайн хийх нь гарцаагүй болсон хэрэг мэтярьцгаан, далайчид хөлтэй гэгч наргиж байв.

д'Артаньян хүмүүсийн дундуур явж, буудлын эзэн дээр очоод, "Forward" гэж хэлэв. Буудлын эзэн, даруй хойноосоо яв гэж дохиод, хашаа руу орох хаалгаар гарч, мань залууг морины саравчинд дагуулж ирэв. Тэнд эмээлтэй морь зэхээстэй байв, өөр хэрэгтэй юм бий эсэхийг асуув. Аль замаар явахаа би мэдэх ёстой гэж д'Артаньян хэлэв.

-Эндээсээ Бланжи хүртэл яваад, Бланжигээс цаашаа Нефшатель хүртэл яв, Нефшательд очоод

"алтан хадуур" гэдэг буудалд бууж, эзэнд нь дохио үгээ хэлээрэй. Тэнд мөн, эмээлтэй морь байх бий.

-Танд би хэчнээн юм өгөх ёстой вэ? гэж д'Артаньян асуув.

Бүгдийн үнийг төлчихсөөн төлөхдөө хангалтай их юм хайрласан. Явжүз дээ бурхан таныг өршөөх болтугай, гэж эзэн хариулав.

-За болтугай гээд залуу мордож давхилаа.

Дөрвөн цаг болоод д'Артаньян Нефшатель гэдэг газар хүрч ирлээ.

Мань залуу авсан заавраа чанд баримталлаа. Энд Сен Валерийн нэг адил, эмээлтэй морь бэлэн байв. Түрүүчийн морины эмээлд байсан гар бууг авч, шинэ морины эмээлд хийхгэтэл тэнд мөн ижил гар буу байлаа.

-Хотод суудаг газраа та зааж өгөөч гэж буудлын эзэн гуйв.

-Дезессар гуайн сумангийн торгон цэргийн байр гэвэл болноо.

-За сайн гэж буудлын эзэн дуугарав.

-Би аль замаар явах вэ?

-Руан хот орох замаар явж үз. Гэхдээ та хотоо зүүн талаар нь тойроод Экуи гэгч жижиг тосгонд очиж буугаарай. Тэнд "Францын бамбай" гэгч, ердөө ганц буудлын газар бий. Гадна байдлаар ньтүүнийг бүү голоорой, тэндхийн саравчинд, мөн энүүнээс дутахгүй сайн хөлөг морь хүлээж баагаа.

-Мөн нөгөө л үгээ хэлнэ биз гэж д'Артаньян асуув.

-Мөн тэр үгээ хэлнээ,

-За баяртай хэн гуай гэж д'Артаньяныг хэлэхэд,

Баяртай торгон цэрэг гуай. Биднээс хэрэглэмээр юм өөрт тань үгүй юу? гэж буудлын эзэн асуулаа.

д'Артаньян толгой сэгсрээд, цаашаа ухас хийв. Экуи хотонд мөн үүний адил, эелдэг зантай буудлын эзэн, эмээлтэй бэлэн морь тааралдлаа. д'Артаньян энд мөн өөрийнхөө хаягийг үлдээгээд, цаашаа Понтуаз гэгч газар руу давхилаа. Понтузад мань хүн сүүлчийн удаа морио сольж унаад есөн цагийн уед де.Треவில் гуайн хаалта руу цогиогоороо орж ирэв.

Арван хоёр цагийн дотор, д'Артаньян жар гаруй мод газар давхиад иржээ.

Де Треவில் гуай түүнтэй ердөө л өнөө өглөө уулзаад салсан хүн шиг тосч авлаа. Залуугийн гарыг ердийнхөөсөө арай чанга атгаад, Дезессар гуайн суман Лувр ордонд харуултай байгаа

болохоор харуулынхаа байр руу даруй явж болно гэлээ.

XXII. МЕРЛЕЗОНИЙН БҮЖИГ НААДАМ

Хотын ахлагчдаас Ван эзэн, хатан хоёрт зориулж, бүжиг наадам зохиох болсон, түүн дээр ван эзний дуртай, Мерлезоний алдарт бүжгийг их эзэнд тоглох тухай, үүний маргааш, бүх Парисаар нэг ярна болж байв.

Үнэхээр ч хотын яаман дээр энэ чухаг баярын бэлтгэлийг бүхэл долоо хоногийн өмнөөс эхлэн элдвийг зэхэж хийж гүйцээсэн аж. Хотын мужаан, уригдсанбүсгүйчүүлийн суух тавцан барьж, хотын наймаачид тэнхимд хоёр зуун цагаан лаа асаасан нь тэр цагтаа үзэгдэж дуулдаагүй их элбэг, хээнцэр явдал ажээ. Үүнээс гадна хийл хөгжим барьдаг хорин хүн уриад, тэдэнд ерийнхээсээ хоёр нугалж илүү шан өгөхөөр тогтоожээ. Юу гэвэл, тайланд бичсэн ёсоор, тэд шөнө дөлөн тоглох ёстой байжээ.

Өглөөний арван цагтвангийн торгон цэргийн дэслэгч де Ла Кост гуай цагдаагийн газрын хоёр дарга, хэдэн цэрэг дагуулсаар хотын нарийн бичгийн дарга Клеман дээр ирээд хотын яамны бүх байр, хашаа өрөө тасалгааны түлхүүрийг аль гэж шаардав. Түлхүүрийг даруй гардуулан өгсөнд, тус бүрд нь дугаар, таних тэмдэгтэй пайз зүүжээ. Энэ цагаас аваад де Ла Кост гуайдяам руу очих бүх гудамж, хаалга үүд сэлтийг манах үүрэг ногдлоо.

Арван нэгэн цагт торгон цэргийн ахмад Дюалье тавин цэрэгтэй хүрч ирээд, яамны зохих хаалгууд дээр тэднийг хувиарлан зогсоов.

Гурван цагт торгон цэргийн хоёр суман хүрэлцэн ирсэнд нэг нь франц, нөгөө нь швейцар суман байлаа. Франц сумангийн хагас нь Дюалье гуайн, хагас нь Дезессар гуайн цэргүүд байлаа. Оройн зургаан цагаас аваад, уригдсан хүмүүс ирж эхлэв. Тэднийг ирэхэд, тусгай бэлтгэсэн тавцан дээр байрлууллаа.

Есөн цагт вангийн бэргэн морилж ирсэнд, хатны удаах тэр өндөр дээд зочныг хотын ахлагч нар өөрсдөө тосон аваад, хатны суух байрны өөдөөс харуулсан байранд оруулав.

Арван цагийн үед Иоанн гэгээний сүмийн нэг талд цай хоолны мөнгөн хэрэглэлтэй, дөрвөн цэргээр мануулсан, жижиг өрөөнд ванд зориулсан хөнгөн зууш зэхэв.

Шөнө дундын алдад улс хашгаралдаж, баяр хүргэж бөөн шуугиан дэгдлээ. Лувр ордноос хотын яам хүрэх, өнгийн дэнлүүгээр гийгүүлсэн гудамжаар ван морилон ирж яваа нь энэ аж.

Хотын ахлагч нар ёслолын одончуу хувцас өмсөж, бамбар барьсан зургаан бага дарга дагуулсаар ван эзэнг гадаа шатны довжоон дээр угтаж авлаа. Ван оройтсондоо уучлал гуйгаад, хамба ламтай арван нэгэн цаг болтол улсын ажил ярьж байгаад ийм боллоо гэв.

Ван баяр ёслолын хувцастай, өндөр дээд ван угсаат Орлеаний герцог, де Суассон гүн, де Лонгевиль герцог, де, Эльбеф герцог, д, Аркур гүн, Рошфор гүн, де Крамльиль де Лианкур, де Барада, де Сувре гуай нар, ванд бараа болж явлаа.

Ван эзэн нэг л юманд сэтгэл зовж, уйтгарлангуй байгааг улс ажив.

Ван эзэнд нэг өрөө мөн вангийн дүү, Орлеаний герцогт нэг өрөө засаж аль алинд нь багт наадмын хувцас зэхжээ. Мөн вангийн хатан, бэр хоёрт мөн тэгж зэхсэн байлаа. Их эзэнтэн нарын бараабологч, эрхмүүд болон бүсгүйчүүл мөн зэхэж бэлдсэн өрөөнд хоёр хоёроороо орж хувцаслах ёстой байв.

-Ван өрөөндөө орохын өмнө, хамбыг ирмэгц өөртөө дуулгаарай гэж тушаав. Ванг ирснээс хагас цагийн дараа мөн бөөн шуугиан дэгдсэн нь хатан морилон :ржээ. Ахлагч нар мөн нөгөө бага дарга нараа дагуулсаар хатныг түрүүчийнх шигээ хүндлэн угтаж авав. Хатан тэнхимд орж ирлээ. Вангийн нэг адил жаахан уйтгарлангуй, гол нь ядарсан байртай байхыг улс ажив.

Энэ үеэр, хөшиг нь өнөө болтол хаалттай байсан жижиг өрөөний хөшиг дутуу онгойж, Испанийн язгууртан болж хувцасласан хамбын цонхигор царай цухуйв. Хатны өөдөөс эгцлэн ширтээд бах нь ханах бололтой зэвүүн инээмсэглэв. юу гэвэл хатагтай алмазанунжуурга зүүгээгүй байлаа.

Хатан тур саатан зогсож хотын ахлагч нарын баяр хүргэхийг сонсон, язгууртан бүсгүйчүүлийн мэндчилэн мэхэлзэхэд хариулж байв. Гэнэт тэнхимийн нэг хаалган дээр ван эзэн хамба ламтай цуг гарч ирэв. Хамба лам нэг юм шивнэж вангийн дарай зэвхийдүү болжээ.

."Ван эзэн нүүрэндээ баггүй, цамцныхаа бүчийг хайнгуут уячихсан, улсын дундуур, хатан руу дөхөж ирэв.

Хатагтай ингэхэд та ер яагаад алмазан унжуургаа зүүсэнгүй вэ? Зүүгээд ирсэнсэн бол над аятайхан байхсан гэдгийг та мэдэж байсан шүү дээ гэж ван хэлэхэд сэтгэл догдолсондоо дуу нь хачин болчихсон байлга.

Хатныг эргэж харахад хамба лам ард нь зогсоод хортойго жуумалзаж байв.

Хатны сэтгэл мөн хөдөлж, их эзэнтэн энэ хөл үймээн дунд юм болуузай гэж бодоод би зүүсэнгүй гэв.

-Та алдаа хийжээ. Таныг зүүж байгаасай гэж би тэр чимгийг танд бэлэглэсэн билээ. Дахиад хэлэхэд, хатагтай та алдаа хийжээ.

Уур хилэн нь шатсан вангийн хоолой чичирч, улс амьтан юу болж байгааг ойлгохгүй чих тавин чагнана.

-Ван эзэнтээн унжуурга Луврт байж л байгаа. Би хойноос нь хүн явуулчихья тэхлээр таны таалалд нийцүүлж болноо гэж хатан өчив.

Үүнд ван:

-Явуулж үз, хатагтай, явуулж үз, аль болох хурдан явуулж үз, нэг цагийн дараа бүжиг эхэлнэ шүү дээ гэв.

Хатан үг дуулж байгаагийн тэмдэг болгон толгой дохиод өрөөндөө дагуулж аваачих бүсгүйчүүлтэй цуг явлаа. Ван мөн өрөөндөө орлоо.

Тэнхимд байсан улс түр зуур хиртхийн нам гүм болов.

Ван эзэн, хатан хоёрын хооронд нэг эвгүй юм болсон гэдэг ч ил харагдаж байлаа, гэхдээ хоёулаа тун аяархан ярилцаж, хүмүүсч мөн тэднийг хүндэтгэн зайдуу зогссон, хөгжимчид чадлаараа тоглож байсан болохоор хэн ч юм олж дуулсангүй.

Түрүүлээд ван анчны дэгжин хувцастай тэнхимд орж ирэв. Өндөр язгуурт Орлеаны герцог, болон бусад сурвалжит ихэс мөн ийм хувцас өмсжээ. Өмссөн хувцас нь ванд үнэхээр зохиж, ингэж хувцаслаж байхдаа ван аргагүй л улс гүрэнд тэргүүнсайхан хүн шиг харагдах аж.

Хамба лам, ванд ойртож ирээд, жижиг хайрцаг барив. Түүний нь ван аваад нээж үзвэл хоёр алмазан унжуурга байлаа.

-Ван эзэн энэ чинь юу юм бэ? гэж хамбаас асуув.

-Гойд ч юм биш, гэхдээ хатагтай унжуургаа зүүхгүй л байхаа даа, зүүвэл та тоолж үзээрэй, тоолтол дөнгөж арав байвал энэ хоёр унжуургыг их эзэгтэйгээс хэн хулгайлсан байж болохыг асуугаарай гэж хамба хариуллаа.

Хамба өөд ван асуусан байртай хараад, юм асууж амжаагүй байтал, хүн бүхний амнаас гайхан шагших дуу гарав. Ван эзэн улс гүрэндээ төв сайхан тайж шиг харагдсан гэвэл хатагтай францын хамгийн гуа сайхан бүсгүй гэдэг ч дамжиггүй ажээ.

Анчны хувцас хатанд бас гайхалтай сайхан зохиж хатан цэнхэр өдтэй бүрх малгай, алмас эрдэнийн товчтой сувдан саарал өнгийн хамба хилэн цамц, мөнгөөр хатгамлаласан хээтэй, цэнхэр торгон банзал өмсжээ. Зүүн мөрөн дээр нь өд банзал хоёртой нь өнгө нийлсэн цэнхэр өнгийн туузад тогтоосон алмазан унжуурга гялалзаж харагдана,

Ван баярласандаа, хамба уурласандаа аль алинынь зүрх нь ёг хийгээд явчихлаа. Гэхдээ тэр хоёр, хатны унжуургыг тоольё гэхэд нэлээд зайтай байлаа, хатан унжуургаа зүүх нь зүүж гэхдээ хэд байгаа бол, арав уу, арван хоёр уу?

Энэ үеэр хийл хөгжим жингэнэж, бүжиг наадам эхэлснийг мэдэгдэв. Ван эзэн цуг бүжиг хийх ёстой бэргэн рүүгээ өндөр язгуурт Орлеаны герцогтанхатан руу очив. Цөм байраа эзлэн зогсоод бүжиг наадам эхлэв.

Ван эзэн хатны өөдөөс харж бүжиг хийх зуур, хажуугаар нь өнгөрөх бүрдээ, тэр унжуургыг чадлаараа ширтэвч. тоолж тун амжихгүй байлаа. Хамбын магнайгаар хүйтэн хөлс дааварлажээ.

Арван зургаан гаралттай бүжиг нэг цаг хир үргэлжлэв. Бүжиг дуусмагц тэнхимээр нэг алга нижгэнэж, эрэгтэйчүүл, бүсгүйчүүлээ суудалд нь хүргэж өгцгөөнө, Ван л өргөмжлөлт эрхээ ашиглан цуг бүжиглэсэн хүнээ орхиод хатан руу яарав.

Ван эзэн, хатан дээр очоод,

-Миний хүслийг ийнхүү анхааран гийгүүлсэнд, хатагтай танд баярлалаа гэхдээ таны унжуурганаас, хоёр дугуу байх шив, тэхлээр май танд би эргүүлж өгье гэв.

-Юу гэнээ эзэнтэн? гэж залуу хатан гайхсан хүн болж дуу алдав. Та надад дахиад хоёрыг бэлэглэж байгаа юм уу? үгүй, тэгвэл би арван дөрвөн унжуургатай болно шүү дээ.

Ван тоолоод үзвэл, арван хоёр унжуурга цөм их хатагтайн мөрөн дээр байлаа. Ван эзэн, хамба ламыг дуудлаа.

-За хамба гуай энэ чинь юу гэсэн уг вэ? гэж ван ширүүн дуугарав.

Хамба үүнд,

-Уул нь энэ хоёр унжуургыг би хатагтайд бэлэглэх гэснээ, хэлж зориглолгүй ийм арга зохиосон км гэв.

Хамбын самбаатай эелдэгтхатан огт хууртаагүй нь илтээр инээмсэглээд,

-Их гэгээнтэн танд энэ хоёр унжуурга бодвол их эзэнтэнд арван хоёрыг цөмийг хийлгэхээс хүнд байсан байлгүй тэхлээр өөрт чинь би улам ч илүү талархаж байна гэв. Ингээд хатан түрүүн хувцсаа сольж өмссөн өрөөндөө дахин өөрийнхөө хувцсыг өмсөхөөр ван эзэн хамба хоёрт мэхийж ёслоод цааш одлоо.

Манай ярианд гарч байгаа ихэс дээдэст анхаарал тавьж байгаад Артаньяныг түр орхиход хүрсэн билээ. Австрийн Анна хатан хамбыг ийнхүү лут чадаж гарах нөхцөлийг хийж өгсөн мань хүн олны ард нэгэн үүдний дэргэд зогсоод ван эзэн, хатан их гэгээнтэн өөрөө энэ дөрөвхөн хүн л учры нь мэдэж байгаа явдлыг ажиглаж, харж эргэлзэхийн хэнд ч үл хайхрагдан зогсож байлаа.

Хатан өрөөндөө орчихлоо.

д'Артаньян нэгэнт явахаар завдтал, гэнэт нэг хүн мөрөнд нь аяархан хүрэх шиг эргээд хартал нэг залуу бүсгүй хойноосоо дагаад гэж дохив. Залуу бүсгүй нүүрэндээ хар хилэн баг өмсжээ. Чухамдаа өөрөөс нь ч биш, өрөөл бусдаас болгоомжлон ийнхүү зүс царайгаа нуусан байсан гэлээ ч, д'Артаньян үүний өмнө хүргэж, хүргэлцэж байсан, ухаалаг сэргэлэн Бонасье авгайг даруй танилаа.

Үүний өмнө тэр хоёр, хаалгачин Жермений байранд д'Артаньян бүсгүйг дуудаад халыг уулзсан билээ. Хатагтайд урагштай явж ирсэн баярт мэдээг сонсох гэж залуу бүсгүй яараад болж өгөөгүй сэтгэлтэй болсон хоёр дөнгөж хэдхэн үг сольж амжсан юм. Иймд маньзалуу бүсгүйн араас дагаж явахдаа хайрлаж дурлах, сонирхох хоёр сэтгэлд автан явлаа.

Замдаа , гудманд хүн улам цөөрөөд ирэхийн үед, д'Артаньян залуу бүсгүйг зогсоох гарыг нь шүүрч авах, ядаж ганд агшин ч билээ сайхан царайгий нь харах сэтгэлээ баясгах гэхэд, овжин бүсгүй тухай бүр түүнээс шувуухай шиг бултан мултарч амжина. Цаашаа мань хүнийг юм

ярих гэтэл бүсгүй жижигхэн хуруугаа өхөөрдмөөр хөөрхөн мөртөө захирангуй байраар уруулдаа хүргэн зангахад, дагаж захирагдахаас өөр замгүй өчүүхэн ч гомдол гаргаж үл болох гаднын нэгэн хүн бий гэж д'Артаньян санав. Явж, явж өдий төдий гудам, хаалга нэвтэрсээр Бонасье авгай нэг үүд онгойлгоод мань залууг нэг тас харанхуй өрөөнд оруулчихлаа. Энд мөн дуугүй бай гэж бүсгүй түүнд зангаад, хөшигний цаана далд байгаа үүдийг онгойлгоод гарчихлаа. Үүдэн завсраар хурц гэрэл наашаа тусна.

д'Артаньян хором хиртэй дуугүй зогсоод хаана байгаагаа гайхан эргэцүүлээ, гэвч хажуу өрөөнөөс тусч байгаа гэрэл, анхилан орж ирэх дулаан сайхан агаар, мөн тэр өрөөнд хоёр гурван бүсгүйчүүдийн дуу гарч, хүндэтгэсэн байдалтай болж ирээд ёсорхуу хээнцэр үг ярилцах, хэд хэдэн удаа их эзэгтэй гэж өргөмжлөн дуудахыг үзвэл, хатны өрөгтэй зэрэгцээ өрөөнд байгаа нь дамжиггүй мэдэгдлээ.

Мань залуу сүүдэрт нуугдаад хүлээж гарав.

Хатагтай сайхан ааштай сэтгэл хангалуун байгаа, үүнд ямагт сэтгэл санаа төвшингүй, уйтгарлаж байдагт нь дасаж орхисон бараа бологч бүсгүйчүүл жаал гайхаж байгаа бололтой. Хатан ингэж сайхан ааштай байгаагаа бүжиг наадам сайхан болсон, бүжиг хийж цэнгэснээр тайлбарлалаа. Хатныг уйлж байлаа ч инээж байлаа ч нэгэнт үг зөрөх ёсгүй болохоор бүсгүйчүүл цөм Парис хотын ахлагч нарын эелдэг сайныг шагшин магтлаа.

д'Артаньян хатныг үл таних боловч, удалгүй дуугий нь нэгд үл мэдэг харийн аялгуу, хоёрт өндөр хэргэмтэй улсын үг бүрд аргагүй харагддаг захирангуй өнгөөр нь бусдынхаас ялгадаг боллоо.

Энэ нээлттэй үүд рүү хатагтай нэг ойртож, нэг холдон холхиж байгааг д'Артаньян дуулж байв, мөн хоёр гурван ч удаа нэг хүний сүүдэр үүдэн завсраар орох гэрлийг халхлав.

Тэгтэл нэг хүний гайхам гуа сайхан цагаан гар хөшигний завсраар гэнэт цухуйгаад ирлээ. д'Артаньян үүнийг өөрийнхөө шагнал мөн гэж ойлгоод сөхрөн ойчиж, гарыг шүүрэн аваад хүндэтгэнгүй зөөлөн үнсэв. Тэгтэл нөгөө гар алгандээр нь нэг юм тавьхаад алга боллоо, үзвэл бөгж ажээ.

Үүд төдхөн хаагдаад, д'Артаньяны байсан өрөө таг харанхуй болчихов.

д'Артаньян бөгжийг авч зүүчхээд дахин хүлээж гарлаа. Үнэнч зүтгэлийг шагнасны дараа хайр сэтгэлийн хариу ирнэ гэж бат итгэж байв.

Үүнээс гадна, бүжиг наадам төгссөн хэдий боловч, найр наргиан дөнгөж л сая эхэлж байлаа. Оройн хоол гурван цагт идэхээр тогтсон. Гэтэл Иоанна гэгээний дуганын цамхгийн цаг дөнгөж сая хоёр цаг дөчин таван минут болж байв.

Үнэхээр ч зэргэлдээ өрөөний яриа чимээ, аажмаар холдсоор намдаад үүд дахин нээгдэж Бонасье авгай гүйн орж ирэв.

-Та юу? Ашгүй нэг ирэв үү, гэж д'Артаньян дуу тавилаа.

Залуу бүсгүй амыг нь гараараа таглаад,

-Дуугүй бай, дуугүй, сая ирсэн замаараа гараад яв гэхэд'Артаньян дуу алдан, -Үгүй тэгээд би хаана хэзээ тантай уулзах юм бэ. энэ чинь! гэв.

-Үүнийг та гэрт чинь байгаа зурвасаар олж мэднээ, яв даа явж үз, гэж залуу бүсгүй хэлээд, гудам руу гарахүүдийг нээж, д'Артаньяныг гаргав.

д'Артаньян өөрөө ганц ч үг маргаж өчүүхэн ч зөрөлгүй хүүхэд шиг үгэнд нь ороод гарч одсоныг үзвэл мань хүн үнэхээр дур сэтгэлтэй болсны гэрч билээ.

XXIII. БОЛЗОО

д'Артаньян гэртээ гүйж ирэв. Хэдийгээр шөнийн гурван цаг болж байгаа, өөрөө Парис хотын хамгийн аюултай хэсгээр явж өнгөрөх ёстой байсан боловч, ганц ч аягүй учрал дайралдсангүй. Согтуу хүн, дурласан хүн хоёрт харж үзэх тэнгэр байдгийг бүхнээрээ мэддэг билээ. Гадаа хаалга нь дутуу хаалттай байсанд д'Артаньян орж дээшээ шатаар гараад зарцынхаа л мэдэх тусгай маягаар үүлээ тогшив. Хоёр цагийн өмнө, хотын яаман дээрээс, гэртээ хариад хүлээж бай гэж явуулсан Планше үүдтайлж өглөө.

д1 Артаньян. даруй,

-Над захиа авчирч өгсөн үү? гэж асуув.

-Үгүй, эрхэм ээ захиа авчирч өгсөн хүн ер үгүй, харин өөрөө хүрээд ирчихсэн нэг захидал бий гэж Планше хариулав.

-Юу гэсэн үг вэ энэ чинь, тэнэг минь? гэж эзнээ асуусанд, зарц нь.

-Юу гэсэн үг вэ гэвэл, намайг гэртээ хүрч ирэх үед таны унтдаг өрөөний ширээн дээр нэг захидал байна билээ, гэтэл манай түлхүүр миний халаасанд байсан, би ер түлхүүрээ биенээсээ салгаагүй билээ гэв.

-Тэр захидал чинь тэгээд хаа байна?

-Эрхэм ээ, тэр байсан газраас нь би хөдөлгөөгүй. Айлд захиа тийм янзаар орж ирнэ гэсэн чинь ер үзэгдэж, харагдсан хэрэг үү, та минь! За яахав, цонх нээлттэй юм уу, ядаж дутуу хаалттай байсан гэвэл өөр хэрэг, тэгвэл би юм хэлэхгүйсэн, гэтэл үгүй шүү, Цонх бүр таг хаалттай байсан. Эрхэм ээ, та болгоомжилж үзээрэй гай муу ёроор л ирсэн захидал даг гэж Планше ярив.

д'Артаньян түүний үгийг цааш сонсолгүй өрөөндөө гүйж ороод, захидлыг даруй задлав, Бонасье авгайгаас бичсэн, ийм хэдэн мөр байлаа.

" Өөрийнхөө болон өөр хүний өмнөөс таны ачийг халуунаар хариулах гэж байна. Өнөө оройн арван цагт, Сен Клу гудамжинд, д' Эстре гуайн байшинтай залгасан жижиг байшингийн дэргэд байгаарай."

"К.Б" гэж ээ.

Энэ захидлыг уншиж суухдаа, хайр дурлалд авгсан хүмүүсийн зүрхийг нэг шаналгаж, нэг уяруулдаг амттай сайхан сэтгэл д'Артаньяны зүрх нэг тэлж, нэг базах шиг өөрт нь санагдаж байв.

Энэ залуугийн авч байгаа анхны зурвас, өөртэй нь хийж байгаа анхны болзоо энэ юм байна. д'Артаньяны зүрх нь хайр сэтгэл гэдэг хорвоогийн диваажингийн босгон дээр зогсчихыг шахан байв. Эзнийхээ царай нэг улайж нэг цайхыг ажсан Планше ам нээж,

-За яав, эрхэм ээ. Би лав тааж орхио биз, нэг өөдгүй хэрэг гарч уу? гэсэнд д'Артаньян, - Планше чи эндүүрчээ, үүний баталгаа болгож, ай чамд нэг зоос өгчихье дарс аваад миний эрүүл мэндийн төлөө уучих гэв.

-Зоос хайрласанд их гялайлаа, эрхэм ээ, таны хэлснийг "ёсчлонгүйцэтгэнээ, гэхдээ! л хаалга үүд нь цоожтой айлд иймэрхүү янзаар орж ирдэг захидал чухам Даа...

-Хонгор минь чухамдаа тэнгэрээс бууж ирдэг юм гэж д'Артаньяныг тосч хэлсэнд, Планше.

-Тэгвэл эрхэм танд таалалтай байгаа юм шив гэнэ.

-Планше хонгор минь хорвоо дээр би чинь хамгийн жаргалтай хүн.

-Тэгээд таны жаргалтай сайханбайгааг би ашиглаад хэвтэж унтвал яахсан бол? -Тэг тэг унтаж үз.

-Эрхэм минь, тэнгэрийн ивээл танд хүртэх болтугай, гэлээ гэхлээ, захиа тэгж...

Ингээд Планше толгой сэгсэрсээр цаашаа гарахыг үзвэл д'Артаньяны зоос хайрласнаар эргэлзээ бүрэн тасарсангүй бололтой.

д'Артаньян ганцаараа үлдээд зурвасыг дахин давтан уншиж, гуа сайхан хайртынхаа бичсэн үг бүрийг үнсэж үнсэж орхив. Эцэстээ мань хүн нэг юм хэвтээд, амар сайхан нойрслоо.

Өглөөний долоон цагт д'Артаньян босоод, Планшег дуудлаа. Хоёр дахь удаа дуудахад Планше үүдээр шагайсан боловч, өчигдрийн хэлмэгдэж гайхсаны ул мөр царайд нь бас л илт.

-Планше би явлаа. Бүхэл өдөржингөө ирэхгүй байж магад. Тэхээр чи оройн долоон цаг хүртэл чөлөөтэй, харин долоон цагт хоёр морьтой бэлэн байгаарай гэж д'Артаньяныг хэлсэнд Планше:

-Уухай тийм бий! Янз нь бид дахиад л арьсаа хүүчүүлэхээр явах нь ээ гэв. -Урт богино бугаа аваарай, гэхэд Планше дуу алдаад:

-За тэр би хэлээгүй юү? Тэгж бүр мэдсэн юмаа, гайтай муу захидал гэлээ. -За тайвширч үз, тэнэг минь ердөө л нэг зугаалах гэсэн юм.

-Харин тийм ээ, нөгөө нэг бууны суман бороо орж, газар дороос занга ургаж ирээд байдаг зугаатай аялал шиг л юм байгаа биз.

д'Артаньян үүнд,

-Ингэхэд Планше гуай та айгаад байгаа бол би ганцаараа явнаа. Айж дагжиж байгаа хүнтэй ханилж явсан дорохноо, ганцаараа явсан нь дээр гэвэл, Планше. ,

-Эрхэм ээ та намайг гомдоож байна, миний яаж байхыг та өөрөө үзээгүй билүү гэв. -Тэр үнэн, гэхдээ чи хамаг эр зоригоо нэгмөсөн шавхчихсан юм шиг над санагдлаа.

-Надад бас жаал зугаа юм үлдсэнийг эрхэм та хэрэг болоход үзэх бий. Миний эр зоригийг удаан хугацаанд хүрэлцээтэй байгаасай гэх юм бол та битгий хэт өгөөмөр зарцуулаарай харин.

-Аа өнөө оройны явдалд тэр эр зориг чинь хүрэхсэн болов уу, чи юу гэж бодож байна? -Хүрэх байх гэж горьдож байна.

-За сайн. Тэгвэл би чамд найдаж байна.

-Болсон цагт би бэлэн байна. Гэхдээ торгон цэргийн морины саравчинд, таны ганц л морь бий шиг санасан юм.,

-Одоо ганцхан байж болноо. Орой тийшээ дөрөвтэй болно.

-Тэгвэл бид чинь морь худалдаж авахаар явсан . улс байх нээ? гэж Планшег асуухад, Д'Артаньян:

-Яриагүй зөв гээд, гарахдаа Планше өөд долоовор хуруугаараа тоглож занав.

Гадаа үүдэн дээр Бонасье гуай зогсож байв. д'Артаньян хүндэт наймаачинтай үг дуугаралгүй өнгөрөөд явах гэсэн боловч цаадах нь тун эелдэг сайхан ааштай мэхийн мэндэлсэнд айлд хөлсөөр суусан хүн хариу мэхийхээр барахгүй юм ярихад хүрэв.

Тэгээд ч эхнэр нь өөртэй чинь энэ оройдоо, Сен Клууд Эстре гуайн байшингийн хавьд болзоо хийсэн байхад хар хүнтэй нь яаж ч жаал өршөөлгүй эс байх юм билээ. д'Артаньян наймаачин руу чадах хирээрээ эелдэг байртай дөхөж очив.

Хөөрхий Бонасье гуайн шоронд байсан тухай ярилцсан нь мэдээж. Бонасье гуай, Менг хотод учирсан нөгөө хүнтэй ярилцсан юмыг нь д'Артаньян дуулчихсан гэдгийггадарлаагүй болохоор Лафема гэгч гайхал хамбын яргачны хатуу харгисын тухай ярин түүнийг яриандаа яргачин гэхээс өөрөөр нэрлэхгүй байв, мөн Бастили гяндан гийн тухай, үүд хаалганы түгжээ, гэгээвч, салхивч, сараалж, эрүү шүүлт тулгадаг багаж хэрэгслийн тухай дэлгэрэнгүй ярьж гарлаа.

д'Артаньян түүний үгийг чих тавин чагнана.

Цадахыгаа ярьж дууссаны дараа д'Артаньян Бонасье авгайг тэхэд хэн хулгайлсныг та мэдсэн үү? Тэр нэг харамсалтай хэргийн учир, өөртэй чинь танилцах завшаан над тохиолдсоныг би мартаагүй шүү, гэлээ.

-Аах гэж Бонасье гуай санаа алдаад,

-Түүнийг мэдээж хэрэг яаж надад хэлэх билээ, манай эхнэр ч мөн мэдэхгүй гэж андгайлсан. Аа та ингэхэд гэж Бонасье гуай тун цагаан цайлган дүрээр яриа дэлгэж сүүлийн хэдэн өдөр үзэгдэхгүй энэ чинь хайчаа вэ? Таныг ч тэр, танай нөхдийг гэлээ би ер үзээгүй, тэгээд очигдөр Планшегийн таны гутлаас гөвж цэвэрлэсэн тэр их тоосонд та лав Парисын гудмаар явж дарагдаагүй дэгээ гэв.

-Бонасье гуай таны зөвөө, би нөхөдтэйгөө жаахан аялал хийгээд ээ

Хол тэр үү?

-Үгүй нэг дөчөөдхөн мод хирийн газар, Атос гуайг бид форжийн рашаан хүргэж өгөөд нөхөд маань тэнд үлдсэн

Бонасье гуайн царай айхавгар залирхаг байртай болоод.

-Та ч яахав мэдээж хэрэг буцаад ирээ биз. Тань шиг сайхан эрийг амраг бүсгүйчүүд удаан хугацаагаар холдуулдаггүй Парист таныг хүн хүлээж ядаж байсан биз гэв. Мань залуу инээд алдаад,

-Үнэндээ ч хонгор Бонасье гуай минь танд үнэнээ хэлэхээс биш, тэгээд өөрөөс чинь юм нууж ер болшгүй хүн бололтой. Тиймээ намайг хүлээж байсан аргагүй л тэсч ядан хүлээж байсан даа гэв.

Бонасье гуайн царай д'Артаньянд ажиглагдахааргүй жаахан барсхийгээд явчихлаа. Бид тэгээд, таны шалмаг түргэний шагналыг хүртэх юм бий дээ? гэхдээ наймаачны дуу жаахан хувирчхыг д'Артаньян, түрүүн эрхэм хүний царай барсхийхийг ажаагүй шигээ эс ажив. -Ая! таны зөн бэлэг биелэх л болтугай гэж залуу инээв.

-Таныг ирэх эсэхийг мэдэхийн тулд л би танаас үүнийг асууж байгаа юм гэж наймаачин хариулав.

-Энэ чинь юу гэсэн үг вэ, Эрхэм ээ? Та арай намайг хүлээх гээгүй биз дээ? гэж д'Артаньян гайхав.

-Үгүй гэхдээ өөрөө баривчлагдаж гэрт маань хулгай орсноос хойш, хаалга дуугарах бүрд, ялангуяа шөнө дуугарахад би айгаад байх болсон юм. Яая гэх вэ, би чинь эр цэргийн хүн биш хойно.

-За тэгвэл, намайг шөнийн нэг хоёр юм уу, гурван цагт буцаж ирэх юм уу, ерөөсөө ирэхгүй байлаа ч гэсэн та бүү айж үзээрэй гэж д'Артаньян хэлэв.

Энэ удаа Бонасье гуайн царай айхавгар зэвхийрээд явчихсанд д'Артаньян ажаад, юу болсныг асуув.

-Зүгээр, зүгээр надад гай зовлон учирснаас хойш үе үе бие аягүй болдог муу зантай болчихоод байгаа юм, дөнгөж сая миний нуруугаар хүйт даагаад явчихлаа. Надыг бүү хайхар, танд жаргалаа хөөх, өөр ажил бий шүү дээ, гэж Бонасье гуай хариулав.

-За тэгвэл надад үнэхээр зав чөлөө байхгүй байх нээ, Юу гэвэл би үнэхээр жаргалтай сайхан байна.

-Одоохондоо үгүй шүү, та өөрөө орой болно гэж хэлсэн шүү дээ.

-Яахав дээ, бурхны авралаар, орой болоод орхино. Магадгүй та өөрөө миний нэг адил жаргалаа тэсэж ядан хүлээж байж мэднэ Бонасье авгай өнөөдөр нөхөр дээрээ ирж болноо доо гэж д'Артаньяныг хэлэхэд бүсгүйн нөхөр ихэмсгээр хариу марган:

-Бонасье авгай өнөө орой ажилтай байна. Авгайн алба ажил түүнийг ордноос гаргадаггүй юм гэв.

-Эелдэг зантай Бонасье гуай мнн танд л тоогүй юм даа. Өөрт минь жаргалтай сайхан байвал хавь ойрын маань улс мөн тийм байгаасай гэж би боддог юм. Янз нь энэ бүтэшгүй зүйл бололтой гэж д'Артаньян хэлэв.

Ингээд даажигнасан үгнийхээ учрыг ганцхан өөрөө л мэдэж байгаа гэж санасан мань залуу тачигнатал инээсээр цаашаа одов.

Бонасье араас нь, сайхан зугаацаарай гэж дорой дуугарав.

Гэтэл д'Артаньян энэ үгийг дуулахааргүй хол явчихсан байлаа. За тэгээд дууллаа ч гэсэн сэтгэл санаа нь ингэтэл хөөрчихөөд байсан болохоор анхааралгүй өнгөрөхсөн биз.

д'Артаньян ингээд де Тревиль гуаинд очнхоор явлаа. Өчигдөр нэг түрхэн ороод гарах зуур юуны ч тухай олигтой ярилцах зав олдоогүйг бид санаж байгаа.

Түүнийг ирэхэд де Тревиль гуай бөөн баяр болчихсон байв. Бүжиг наадам дээр ван эзэн, хатан хоёр өөрт нь тун эелдэг сайн байсан, харин хамба сүрхий хүйтэн царайлаад байсан гэнээ. Де Тревиль гуай бие муудлаа гэж шалтаглаад шөнийн нэг цагийн хирд гэртээ иржээ... Харин их эзэнтэн нар өглөөний зургаан цаг болгож байж Луврт буцаж харьсан гэнэ.

-За одоо, гээд де Тревиль гуай дуугаа намсгаж, үнэхээр хоёулхнаа байгаагаа баттай мэдэх гэж өрөөгөө хянуур зэрэгцүүлэн харж одоо залуу нөхөр минь, хоёулаа өөрийн чинь тухай ярилцъя. Юу гэвэл ван эзэн баяртай байгаа, хатан дийлж бахадсан болон их гэгээнтний давагдсан эдбүгдийн шалтаг чухамдаа өөрийн чинь' урагштай яваад ирсэнтэй аль нэг талаар холбоотой гэдэг .хартал илт байна. Тэхлээр одоо соргог байлгүй горьгүй гэсэнд д'Артаньян өөдөөс нь:

-Их эзэнтэн нарт аятай харагдах завшаантай байгаа цагтаа би юунаас айж болгоомжилж явбал таарах хэрэг вэ? гэлээ.

-Миний үгийг итгэж юм бүхнээс болгоомжлоорой. Хамба өөрийгөөмуугаар даажигнасан хүнтэй тооцоо бодолгүй орхичих хүн огт биш, гэтэл миний танил нэг гаскон хүн ингэж даажигнажээ гэж надад санагдаад тун болж өгөхгүй байна гэж де Тревиль гуайг хэлэхэд.

-Хамба ламтан, тантай адил юм болгоныг сайн мэдсэн тухайлан намайг л . Лондон ороод ирсэн гэж та санаж байна уу? гэж д'Артаньян гайхав.

-Чөтгөр алгад! Ингэхлээр та Лондон ороод ирсэн хэрэг үү? Наад хуруун дээрээ гялалзаж байгаа сайхан алмазан бөгжийг арай Лондонгоос олоод ирсэн юм биш биз? д'Артаньян,

дайсны өгсөн бэлэг гэгч сайн зүйл биш юм шүү болгоомжлоорой. Энэ тухай чинь нэг латин шүлэг хүртэл байдаг юм даг, гэж де Тревиль гуай хэллээ.

Латин хэлний зах зухаас чиг цээжилж ер чаддаггүй, даанч муу болохоор багшаа хүртэл цөхрөөдөг байсан д'Артаньян үүнд,

-Тэр ч тийм байлгүй нэг шүлэг байж таараа бий... гэтэл уран зохиолд дуртай де Тревиль гуай.
-Тийм шүлэг ч бүр бий, саяхаан де Бенсерад гуай надад уншиж өгч л байсан юмсан...
Байзаарай... Аа тийм санаанд, орлоо.

...Timeo Danaos et Dona terentes энэ чинь бэлэг өргөж байгаа дайснаас сэрэмжил гэсэн үг юм гэв. Энэ алмасыг дайсан биш, хатан эзэн надад бэлэглэсэн юм гэж д'Артаньян хариулав.

-Хатан гэнээ! Оёо гэж де Тревиль гуай дуугарав. Нээрээ энэ чинь хатан хүний бэлэг байнаа. Энэ бөгж лав, мянган алтан зоосноос багагүй үнэтэй. Хатан танд үүнийг хэнээр дамжуулж өгөө вэ?

- "Хатан өөрөө надад өгсөн юм гэж д'Артаньян хэлэв.

-Хаана тэр вэ?

-Хатны хувцсаа сольж байсан өрөөтэй зэргэлдээ өрөөнд.

-Ямар шүү янзаар тэр вэ?

Надад гараа үнсүүлэхээр сунгаж өгөөд, гэсэнд де Тревиль гуай д'Артаньян өөд гайхаж хараад,
-Хатны гарыг та үнсээ юу? гэж дуу алдав.

-Их эзэгтэй надад тийм хишиг хүртээсэн юмаа, гэж залууг хэлэхэд,

-Хүний дэргэд тэр үү? Ээдээ бас болгоомжгүй, даанч болгоомжгүй хүнээ дээ, гэж де Тревиль гуай хэлэв,

-Үүнд д'Артаньян,

-Үгүй эрхэм ээ, тайвширч үз. Үүнийг харсан хүн ер үгүй гээд болсон бүх явдлыг де Тревиль гуайд ярьж өгөв.

-Ээдээ бүсгүй улс уу! гэж хашир цэрэг дуу алдаад, хийсвэр сэтгэлээрээ даруй танигддаг улс. Нууц, далд юм бүхэн л тэдэнд аятай сайхан...Ингэхэд та гар л үзсэн, өөр юмгүй юм шив. Хатантай өөрөө тааралдвал та түүнийг танихгүй, хатан тантай мөн тааралдаад хэн болохы чинь танихгүй юм шив.

-Үгүй, энэ алмас бөгжөөр танина шүү дээ гэж залуу маргав.

-Ингэхэд байнаа, танд нэг зөвлөгөө, нөхөр хүний сайн зөвлөгөө өгөх үү? гэж де Тревиль гуай хэлэхэд д'Артаньян:

-Тэгвэл та надыг их гийгүүлэх сэн эрхэм ээ гэв.

-За тэгвэл яваад, эхлээд дайралдсан инжээнд л энэ бөгжөө инжээний өгсөн үнээрөгч орхи. Хэдий шулаачин муу хүнтэй дайралдлаа ч гэсэн танд лав найман зуун алтан зоос өгнөө. Зоосонд чинь нэр гэж байхгүй, наад бөгжинд чинь зүүж яваа хүнээ хөнөөж болох айхавтар нэр байна шүү дээ залуу минь, гэсэнд д'Артаньян дуу алдаж:

-Энэ бөгжийг худалдах гэж үү? Эзэн хатны хайрласан бөгжийг худалдахгэж үү. Яасан ч үгүй! гэлээ.

-Тэгвэл мунхаг минь, наад чулууг нь эргүүлээд зүүчих, юу гэвэл, Гасконийн ядуу тайжид ийм үнэт зүйл эх нь хайрцагнаасаа гаргаад бэлэглэдэггүйг хэн хүн андахгүй гэхэд:

-Ингэхэд цаашдаа айж сэргийлбэл зохих юм надад байна л гэж бодоод байнаа? гэж д'Артаньян асуув.

-Залуу минь, уугьж байгаа угас залгасан дарьтай авдар дээр нойрсож байгаа хүн хүртэл өөрийг чинь бодвол айх юм огт үгүйтэй адил гэж би хэлж байна шүү.

Де Тревиль гуайн ярианы өнгөнд үнэмшиж, сэтгэл зовж эхэлсэн д'Артаньян,

-Чөтгөр алгад! Би тэгээд яамаар байнаа? гэв.

-Хаа ч явсан, хэдийд ч гэлээ сэрэмжтэй бай. Хамба юмыг мартдаггүй, урт гартай хүн шүү. Миний үгийг үнэмшиж үз, цаадах чинь нэг сайн чадах бий гэж де Тревиль гуай хэлэхэд: -Яаж тэр вэ? гэв.

-Хээ би яаж мэдэх вэ. Шулмын бүх муу арга заль хамбын эрхшээлд байдаггүй гэж үү? Хамгийн наад захын муу юм гэвэл өөрийг чинь баривчилж мэднэ.

-Юу? их гэгээнтний албанд байгаа цэргийн хүнийг зүрхэлж барих хүн бий гэж үү?

-Чөтгөр алгад! Үгүй тэд чинь Атосыг баривчлахдаа зовоогүй шүү дээ. Нэг үгээр хэлэхэд л, гучин жил ордонд бараа болж байгаа хүний үгийг үнэмшиж үз, сэрэмжтэй л байхгүй бол та дүүрлээ Ер нь газар сайгүй л өстөн бий гэж хардаж яв Би үүнийг өөрт чинь хэлж байна. Аль нэг хүн арван настай хүүхэд ч гэсэн хэрүүл маргаан өдвөл зайлсхий, өдөр шөнө хэдийд ч ялгаагүй өөрт чинь хүн дайрвал ичих юмгүй шууд зугтаа, гүүрээр гарах юмаа гэхэд гишгэх газраа сайн туршиж үз, юу гэвэл гишгэсэн банз чинь цөм үсрээд орхиж мэднэ, шинэ барьж байгаа байшингийн хажуугаар өнгөрөх болбол дээшээ сайн харж яв, толгой дээр чинь чулуу унаж мэднэ, шөнө орой гэртээ ирэх хэрэг тохиолдвол зарц чинь итгэлтэй хүн бол сайн зэвсэглүүлээд дагуулж . яв. Хун бүрээс, нөхдөөсөө, ах дүүгээсээ, амрагаасаа...ялангуяа амраг бүсгүйгээс сэрэмжилж бай, гэлээ.

д'Артаньяны царай улайчхаад

-Амраг бүсгүйгээс гэнээ гэж давтан хэлээд, аа яагаад би тэгж амраг бүсгүйг бусдаас илүү их сэжиглэж байх ёстой юм бэ?

-Хамбын хэрэглэдэг, бусдаасаа илүү, түргэн арга нь амраг бүсгүйчүүдийг ашиглах юм. Бүсгүй хүн өөрийг чинь арван зоосоор худалдаж орхино шүү. санаж яв, д'Артаньян та ариун юм мэдэх үү? гэж де Тревиль гуай хэлэв.

Энэ оройдоо, Бонасье авгайтай болзсон нь д'Артаньяны санаанд орлоо. Гэхдээ шударгаар хэлэхэд ер нь бүсгүйчүүлийг де, Тревиль гуайн ингэж муугаар санаж явдаг нь д'Артаньянд хөөрхөн амрагаа өчүүхэн ч сэжиглэх сэтгэл төрүүлсэнгүй.

Де Тревиль гуай яриагаа залган,

-Ингэхэд, танай цуг явсан гурав хаачсан бэ гэсэнд д'Артаньян?

-Танаас би бас асуух санаатай байсан юм. Та ер сураг чимээ сонсоогүй биз? ГЭВ. -Ер үгүй

-Аа би тэднийг замд орхисон л доо. Шантилы гэгч газар Портос юу юугүй хүнтэй тулалдах болоод үлдсэн. Кревкере гэгч газар Арамис мөрөндөө шархтай, Амьен гэгч газар Атос хуурамч мөнгө үйлдэн борлуулсан ялд унах болоод үлдсэн,

-Тийм бий! Үгүй, та өөрөө тэгээд яаж мултраад явчихсан хүн бэ? гэж де Тревиль гуан асуув.

-Үнэнээ хэлэхэд эрхэм зэ, азаар мултарсан, де Вард гуайн илдээр дээж рүүгээ хатгуулаад, азаар өөрийг нь Калэгийн зам дээр, эрвээхэйг ханатай хадаж байгаа юм шиг газартай хадаж байгаад мултарч хүрсэн дээ.

-Энэ чинь л дугаад байж! Хамбын шадар хүн, Рошфорын садан де Вардийг шүү та минь, чиний хэлэхийг сонсоод надад, нэг санаа төрлөө, нөхөр мннь, гэж де Тревиль гуай хэлэв. . .

-Ямар санаа вэ, эрхэм ээ?

-Таны оронд би байсан бол нэг юм хийгүүштэй байна,

-Чухам юу тэр вэ?

-Их гэгээнтэн Парис хотоор намайг эрж байх зуур би бол дахин сэм Пикарди нутаг орж, цуг явсан нөхдөө яасныг мэдэх байсан даа. Та, ер нь тэр нөхөддөө, ийм анхаарал санаачлага тавихад болохтой дэг гэж де, Тревиль гуай хэлэв.

-Таны энэ сайн зөвлөгөө байна би маргааш мордноо,

-Маргааш гэнэ шүү! Өнөө оройдоо явахад яагаад болдоггүй юмбэ?

-Өнөөдөр, хойшлуулшгүй чухаг хэргийн учир би Парист байлгүй горьгүй.

-Ээдээ, залуу минь, зуурдын сэтгэлд автаа юу? бүсгүйчүүд биднийг урьд өмнө хөнөөсөөр ирсэн, цаашид Шц хөнөөх юм шүү дахиад хэлье. Миний үгэнд ороод, өнөө оройдоо мордож үз гэж де Тревиль гуай хэлэв.

-Эрхэм ээ, энэ чинь болшгүй.

-Тэхлээр, та амлачихсан юмаа?

-Тиймээ, эрхэм ээ.

-За, тэгвэл өөр хэрэг, харин өнөө шөнө өөрий чинь алчихдаггүй юм бол маргааш тийшээ явна гэж надад, амлачих гэж де Тревиль гуайг хэлэхэд д'Артаньян:

-Амлая гэв.

-Танд мөнгө хэрэггүй биз?

-Надад тавин зоос бий. Энэ надад хүрэх байхаа,

-Танай нөхдөд юм бийюу?

-Бодоход, тэд мөнгөтэй байхаа. Парисаас мордохдоо хүн тус бүр далан алтан зоостой байсан юмсан,

-Мордохоосоо өмнө надтай уулзах уу?

ч -Гойд шинэ юм болохгүй бол уулзахгүй л байхаа даа, эрхэм ээ.

-За тэгвэл, замдаа сайн яваарай гэхэд,

-Гялайлаа эрхэм ээ гэж д'Артаньян дуугараад, шадар цэргүүдийнхээ төлөө Тревиль гуайнингэж эцэг ёсоор санаа тавьдагт нь сэтгэл уярсар гарч одов.

Ингэхэд Атос, Портос, Арамис гурвын байраар орвол нэг нь ч эргэж ирсэнгүй. Зарц нар нь бас байхгүй, аль алины нь тухай сураггүй аж.

Залуу нөхдийнхөө татвар эмсийг д'Артаньян мэддэг байсан бол тэднээс сураглах байсан, гэтэл Портос, Арамис хоёрын амрагуудыг мэдэхгүй байлаа. Атос ч яахав, ерөөсөө амраг бүсгүй гэж үгүй байлаа.

Торгон цэргийн хуарангийн хажуугаар өнгөрөхдөө, д'Артаньян морины саравч руу шагайтал, дөрвөн морьдын гурав нь ирчихсэн харагдав.

Гайхаж хоцорсон Планше, морьдыг хусаж, хоёрыг нь цэвэрлэж гүйцчихээд байлаа. Планше д'Артаньяныг үзээд баярлаж,

-Ээ та надтай амармэнд уулзсан нь болж дээ, эрхэм ээ гэв.

Юу болоов гэв. Планше? гэж залууг асуухад,

-Манай байрны эзэн, Бонасье гуайд та итгэдэг үү?

ГЭВ.

-Би юу? Огтхон ч үгүй,

-За энэ чинь зөв дөө, эрхэм ээ.

-Үгүй, чи юунд үүнийг асууж байгаа юм бэ?

-Яахав таныг түүнтэй ярилцажбайхад, юу ярьж байгааг чинь би дуулаагүй, гэхдээ хажуугаас нь ажиглаж байсан. Тэгтэл байна шүү, эрхэм ээ Бонасьегийн царай хэд хэд дахин хувираад явчихна билээ,

-Нээрээ юу?

-Та нөгөө авсан захидлынхаа тухай бодсоор байгаад түүнийг ажаагүй Тэхэд би захидал манайд хачин янзаар ороод ирсэнд сэтгэл зовж явсан болохоор түүний царайнаас нүд салгаагүй юм гэж Планше хэлэв.

-За тэгээд, түүний царай чамд ямар санагдав.

-Мэхчин дайсны царай шиг санагдсан. Нээрээ юу?

-Тэгээд ч бас, та түүнээс салж булан тойрохын хамт Бонасье малгайгаа бушуухан авч үүдээ цоожлоод, гудамжаар нөгөө тийшээ гүйсэн шүү гэв.

Нээрээ ч, Планше чиний зөв. Эд бүгд цөм над их сэжигтэйсанагдаад байна. Гэхдээ чи бүү зов, энэ бүгдийн учир нарийн тодорхой болохоос нааш бид байрны хөлс түүнд ер төлөхгүй. - Эрхэм та мөн, төглоом тохуу хийсээр байна, за яахав, азнаж байгаад өөрөө үзэх бий.

Яая гэх вэ, Планше үйлтэй юмнаас зайлж болохгүй шүү дээ.

-Та тэгээд, оройн зугаалгаа хийхээ болихгүй л юм биз дээ эрхэм ээ?

-Яалаа гэж Планше минь. Бонасьед хэдий их дургүй хүрэх тусмаа чиний сэтгэлийг зовоогоод байгаа, тэр захидалд дурдсан болзоонд би улам ч дуртай явах юм.

-Үгүй эрхэм ээ, таны шийдвэр чинь хэрэв...

-Хөдөлбөргүй шийдсэн, юм найз минь. Ингэхлээр, есөн цагт энд хуаран дээр бэлэн байж бай, би наашаа ирнэ, гэж д'Артаньян хэлэв.

Эзнийхээ хийх гэсэн юмыг хориглох ямар ч найдвар үгүйг Планше үзээд, их санаа алдаж гурав дахь морийг цэвэрлэж гарав. д'Артаньян чухамдаа туйлын болгоомжтой залуу болохоор гэртээ харихын оронд, нөгөө бэрх цагт дөрвүүлээ чихэртэй цай уусан Гасконь нутгийн хуврагийнд очиж хоол идэхээр явлаа.

XXIV. АСАР

Есөн цагт д'Артаньян торгон цэргийн хуаранд иртэл Планше бэлэн хүлээж байв. Дөрөв дэх морь ирчихжээ.

Планше урт богино буугаа авсан, д'Артаньян илдтэй, бүсэндээ хоёр богино буу хавчуулжээ. Хоёулаа мордоод аяархан цаашаа хөдлөхөд таг харанхуй байсан болохоор тэдний яваад өгөхийг хун харсангүй. Планше эзнийхээ хойноос арваадалхмын газар дагаж явна

д'Артаньян голын эрэг барьж явснаа Конферансын хаалга гэгчээр гарч, тэр цагт одоогийнхоосоо үзэмж сайнтай байсан Сен Клу орох замаар язлаа. Хотоор явж байх зуураа Планше өөрөө тогтоосон зайгаа барьж эзнээсээ хүндэтгэнгүй хоцорч явснаа замд хүн улам улам цөөрөн, харанхуй болж ирэхэд эзэндээ ойртсоор Булонийн ой руу орохын үед эзэнтэй зүгээр зэрэгцээд ирлээ. Өндөр мод найгалзан, өтгөн шугуйн завсраар сарны гэрэл гялалзсан энэ газарт Планше сүрхий айж явсныг бид нуугаад ч яахав. Зарц нь нэг л болохоо болчхоод байгааг д'Артаньян ажаад:

-За Планше гуай, та чинь юу болоод байна? гэв.

-Ой мод ер, сүм дугантай адил юм шигтанд санагдахгүй юм уу, Эрхэм ээ? -Юугаараа тэр вэ, Планше?

-Сүмд ч тэр, ойд ч гэлээ чанга ярьж зүрхэлмээргүй юм. Планше чи яагаад чанга ярьж айгаад тэр биз?

-Тиймээ эрхэм ээ, хүн бидний угийг сонсчих бий гэж айх юм.

-Хүн сонсчих бий шүү! Бид тийм булай муухай юм яриагүй, хэн ч үүнийг зохисгүйд үзэж чадахгүй байхаа хонгор Планше минь,

Планше санаж явсан гол юм руугаа орж,

Үгүй эрхэм ээ! Тэр Бонасьегийн хөмсөг нэг л муухай залирхаг байртай, тэгээд уруулаа бас хачин татвалзуулах юм билээ гэв.

Чи ямар чөтгөрөө хийж, тэр Бонасьег одоо дурсаа вэ?

-Хүний санаанд чинь, эрхэм ээ, юу орж ирсэн нь л орж ирэхээс биш, хүний өөрийн дураар болдоггүй шүү дээ.

Энэ чинь, Планше чи өөрөө аймхай болохоор л тэгж байгаа юм.

-Болгоомжтойг аймхайтай хутгаж болохгүй шүү. Эрхэм ээ болгоомжлох чинь сайн үйл. - Планше чи тэгээд, сайн үйлтэй хүн, тийм биз? гэтэл Планше:

-Эрхэм ээ тэнд гялалзаад байгаачинь юу вэ, бууны ам шиг оргиод, юу ч гэсэн бид доошоо

бөхийвөл яасан юм гэв.

Де Тревиль гуайн сурган хэлсэн үг д'Артаньяны санаанд орж ирсэнд аман дотроо - Үгүй нээрээ ч, нээрэн энэ муу мал явж явж намайг ч бас айлгачих нь байна гэж үглэв.

Тэгээд д'Артаньян ухасхийж хашгарав. Планше чухам нэг эзнийхээ сүүдэр аятай хөдөлгөөн бүрий нь дуурайгаад, даруй зэрэгцлээ.

-Яах юм бэ, эрхэм ээ, бид шөнөжин явах уу? гэж Планше асуув.

-Үгүй, Планше чи ирэх газраа нэгэнт ирчихээд байна.

-Юу би идчихээр гэж? та өөрөө яах юм бэ, эрхэм ээ?

-Аа би цаашаа нэг жаахан явнаа.

-Намайг тэгээд ганцааранг минь энд үлдээх нь үү?

-Планше чи айгаад байна уу? .

-Үгүй, эрхэм ээ. Ганцхан танд хэлэхэд байнаа, шөнө хүйтэн болно, хүйтрэхээр үе мөчний өвчин тусдаг, үе мөчний өвчинтэй зарц бол ялангуяа тань шиг шалмаг хүнд муу хань болно шүү дээ гэв.

-За тэгвэл, Планше чи даараад байвал тэр харагдаж байгаа гуанзархуу юманд оч. Маргааш өглөө зургаан цагт намайг үүдэн дээр нь хүлээж байгаарай.

-Эрхэм ээ, таны өнөө өглөө хайрласан мөнгийг би ууж идчихсэн, тэхээр бээрээд ирлээ гэхэд надад ганц ч зоос байхгүй гэж Планше өчив.

-Май хагас алтан зоос ав. Баяртай. д'Артаньян мориноос бууж, Планшед цулбуураа бариулаад нөмрөгөөр биеэ ороон даруй цаашаа одов.

-Эзнийхээ дөнгөж бараа тасрахын хамт Планше,

-Бурхан минь, үгүй би мөн их даарч байна! гэж дууалдав. Тэгээд даруй дулаацахыг яаран гадаад бүх байдлаараа хотын зах хавийн гуанз мөн бололтой нэг байшингийн үүдийг цохив.

Энэ зуур, нарийн зөрөг рүү эргэж орсон д, Артаньян явсаар Сен Клуд ирээд, энд мөн гол гудамжаар явалгүй шилтгээнийг тойрч, хөл цөөтэй нарийн гудамж хүрч удалгүй цаашаа, нөгөө захидалд дурссан асрын өмнө хүрч ирэв. Тэр асар тун бөглүү зэлүүд газар байх ажээ. Гудамжны нэг талд өндөр хэрэмтэй, түүний хажууд нөгөө асар байгаа, нөгөө талд нь хайстай жаахан цэцэрлэг, түүний гүнд нэг ядуухан сууц харагдана.

д'Артаньян болзсон газартаа ирээд, ирсэн тухайгаа ингэж тэгж мэдэгдээрэй гээгүй болохоор хүлээж эхлэв.

Энд нийслэл хотоос зуун мод алс байгаа гэж бодмоор нам гүм аж. д'Артаньян эргэн тойрон жаал , ажиглаад, хайс түшиж зогсов. Энэ хайс, цэцэрлэгээс цааш эх захгүй уудам газар өтгөн мананд нуугдаж, тэнд харанхуйлж харагдах ёроолгүй гүн хавцал болсон хуурамч хоосон Парис хот,үүний гэрэлт цэг болох хэдэн бүдэг одтой Парис гэгч там нойрсож байгаа.

Харин д'Артаньяны нүдэнд юмбүхэн аятай сайхан харагдаж, сэтгэл санаа нь хөөрч хөгжөөд, харанхуй газар ч гэлээ гэгээтэй саруул юм шиг санагдаж байв. Уулзах цаг юу юугүй болно. Үнэхээр ч Сен Клугийн цамхаг дээрх цаг төдхөн арав дахин цохих дуулдав. Шөнийн харанхуйд ёолж байгаа энэ хүрлэн дуу нэг л ёрын.

Гэвч энэ цохилт бүр удталхүлээсэн чухаг цагийн нэг

агшин болохоор залуугийн чихэнд чимэгтэй уянгатай нь аргагүй. ,

д'Артаньян хэрэмний дэргэдэх асрын хоёр дахь давхар хаалтгүй орхисон нэг цонхноос нүд салахгүй байлаа. Тэр цонхоор бүдэгхэн гэрэл гарч хайсны цаана бөөгнөрөн ургасан модны найгасан навчсыг мөнгөлөг өнгөөр гийгүүлнэ. Ингэж таатайхан гийсэн цонхны цаана хөөрхөн Бонасье авгай түүнийг хүлээж суугаа нь илт.

Ийм амттай бодолд автсаар д'Артаньян жижиг хөөрхөн байшингаас нүд салгалгүй байж хагас цаг хүлээхдээ нэг их тэсэж ядсангүй. Байшингийн алтадсан чимэгтэй адрын тал нь гаднаас харагдаж, байшингийн бусад тавьц сэлт хээнцэр сайхан байх ёстойг харуулна.

Сен Клугийн цамхгийн цаг арав хагас болсныг мэдэгдэв.

Энэ удаа д'Артаньяны бие нэг л арзас хийгээд явчих шиг болсны тэр учрыг өөрөө хэлж мэдэхгүй билээ. Өөрөө жихүүцэж эхэлж байсан болохоороо зүгээр бие махбодтой холбогдсон юмыг сэтгэл санаашрагтай эндүүрч байж болох юмаа. Тэгснээ л арван цагт болзоогүй, арван нэгэн цагт гэснийг өөрөө буруу уншаа байлгүй гэж санаав.

Цонх уруу ойртож, гэрэлд гараад, зурвасыг дахин уншиж үзтэл андуураагүй, үнэхээр л арван цагт гэж болзоо тавьсан байв.

д'Артаньян түрүүн зогсож байсан байрандаа эргэж ирээд зогстол хүн амьтангүй, хав харанхуй хоёр, сэтгэлд нь жаахан эвгүй санагдах болж ирэв.

Арван нэгэн цаг цохичихлоо.

Бонасье авгайд гай зовлон дайраагүй байгаа гэж д'Артаньяны сэтгэл зовж эхлэв. Амрагуудын ердийн дохиогоор д'Артаньян гурвантаа алга ташлаа. Гэтэл хариу юм юу ч үгүй, ядаж цуурай ч үгүй байв. Тэгээд залуу бүсгүй өөрийг нь хүлээж байгаад унтчихаа юм уу гэж жаахан урам хугарч бодов.

Хэрэм рүү очоод авирах гэж үзсэн чинь хэрмийг шинээр шавардаж зассан, болохоор д'Артаньян дэмий хумсаа хугалахаас өөр юм болсонгүй.

Тэгтэл нөгөө навчинд нь мөнгөлөг туяа туссан мод нүдэнд нь өртөөд тэдний нэг гудамж руу

бөхийж ургасан болохоор мөчир дамжиж гараад өрөөний дотор талыг харж болох юм гэж санав.

Модон дээр гарах ч амархан аж. Тэгээд ч д'Артаньян дөнгөж хорин настай болохоор багынхаа дасгалыг мартаж амжаагүй байсан хэрэг. Агшин зуур мөчир дамжиж дээшээ гараад өрөөн доторхыг харав.

д'Артаньяны нүдэнд аймшигтай юм харагдаж, нуруу руу нь хүйт даагаад явчихлаа. Тэр таатай аятайхан гэрэлд айхавтар муухай эвдэж сүйтгэсэн өрөө харагдав. Цонхны нэг шил хага үсэрсэн, өрөөний үүдийг эвдлээд хаячихсан, нугас нь санжганаж байв. Дээр нь нандин сайхан зууш тавиастай байсан бололтой ширээг унагаад, бяц гишгэгдсэн жимс, лонхны хагархай сэлт шалан дээгүүр хэвтэнэ. Өрөөний бүх юмыг харахад, энд цөхрөнгөө бартал ноцолдож тэмцэлдсэн байр илэрхий. Ингэж бөөн нурж сүйдсэн юман дотор хувцасны тасархай, мөн ширээний бүтээлэг, цонхон дээр хэд хэдэн цусан толбо байх шиг д'Артаньянд санагдав.

д'Артаньяны дотор муухай болоод гудамжинд мөн хүчирхийллийн ул мөр байгаа эсэхийг ажих гэж яаран доошоо буув.

Нам гүм шөнийн харанхуйд аятайхан бүдэг гэрэл гийсэн хэвээрээ. Ингэтэл, үүний өмнө нарийн сайн ажих санаа төрөөгүй байсан д'Артаньян одоо түрүүн ажаагүй юм олж харлаа. Зарим газраа дагтаршсан, мөн онгичиж зөөллөсөн хөрсөн дээр хүний мөр, морин туурайн мөр үзэгдлээ. Мөн Парис хотоос ирсэн бололтой тэрэгний хоёр дугуй зөөлөн хөрсөнд гүнзгий мөр үлдээж, асарт хүрээд, дахин хотын зүг эргэжээ.

д'Артаньян цаашаа ажиглаж явталхананы хажууд бүсгүй хүний бээлий урагдчихсан хэвтэж байлаа. Тэр бээлий шороонд хүрээгүй газраа шив шинэхэн, бүсгүйчүүлийн хөөрхөн гараас дурласан эрэгтэйчүүл хуу татахдаа дуртай байдаг анхилуун сайхан бээлий байв.

Цаашаа ажиглах тусмаа д'Артаньяны духанд хүйтэн хөлс улам улам дааварлаж, сэтгэл шимшрэн зовоод, амьсгаа давхацна. Гэвч өөрөө сэтгэлээ зогоож энэ асар Бонасье авгайдхамаагүй, залуу бүсгүй энэ асрын ойролцоо гэж болзсоноос, дотор нь гээгүй, тэгээд ажил төрөл нь болж өгөөгүй юм уу, нөхөр нь хардаад Парист үлдсэн байж болох юм гэж бодно.

Гэтэл зарим үед, цаглашгүй их гай гамшигт орлоо гэж дотор бодогдоод, дотор харанхуйлж зовоох сэтгэлд автдагчлан д'Артаньян мөн үүнд автаад дээрх бодол цөм оргүй арилна. д'Артаньян тэгээд, солиорсон хүн шиг болж, их зам руу даруй ороод, саяныхааирсэн чиг рүү гүйсээр, усан гарам дээр очиж, гаталгагчийг шалж эхлэв,

Орой долоон цагийн үед тэр завьчин, нэг хар ууж өмссөн, зүс, царайгаа хүнээс илтэд нууж байгаа бүсгүйг голоор наашаа гаргаж өгсөн гэнэ. Тэхдээ тухайлан тэгж танигдахгүйг хичээгээд байгаа нь завьчны анхаарлыг татаж, сайн харвал залуу сайхан бүсгүй байжээ.

Тэр үед, одоогийнхтой мөн ялгаагүй, царай зүсээ нуусан залуу сайхан бүсгүйчүүл Сен Клу өөд их л очдог байсан гэлээ гэхдээ завьчны үзсэн бүсгүй Бонасье авгай мөн гэдэгт

д'Артаньян огт эргэлзсэнгүй.

Завьчны овоохойд байсан дэнг ашиглаж д'Артаньян Бонасье авгайн захидлыг дахин уншиж үзвэл Сен Клюд Эстре гуайн асрын ойролцоо, тэр гудамжинд уулзахаар яах аргагүйзөв, өөр газарт биш байв.

Юм бүхнийг харьцуулан үзвэл, Артаньяны зөн зөвдөж, их гай зовлон учирсан гэдэг үнэнтэй болж байгаа нь илт.

Энд байж байх зуур нь асарт ямар нэг өөрчлөлт гарч.шинэ юм дуулдах юм шиг д'Артаньянд санагдаад буцаж гүйв. Гудамж нөгөө л хүн амьтангүй хэвээр бүдэгхэн зөөлөн гэрэл гийсээраж. Тэгтэл нөгөө цэцэрлэг дотор байсан харанхуй жижиг урц д'Артаньяны санаанд орж, лав юм үзэж харсан байх магадгүй ярилцсан ч байж болно гэж бодогдов.

Явган хаалга хаалттай байсанд д'Артаньян сараалжин, дээгүүр харайж ороод уяатай нохойн хуцахыг хайхралгүй явсаар урц руу очив.

Үүд тогшиход, эхлээд хүн дуугарахгүй, нөгөө асар шиг нам гүм, гэвч д'Артаньяны эцсийн найдвар энэ урц л болохоор, тогшоод байлаа. Удалгүй муу урцын дотор аяархан хөдлөх чимээ гарч, энэ чимээгээ дуулаад чимээ гаргасан хүн өөрөө айж байх бололтой санагдана.

Тэхлээр д'Артаньян үүд тогшихоо болиод гуйж гарсанд дуу нь аргагүй сэтгэл түгшсэн, айсан, гуйж царайчилж, сайныг амласан байртай болохоорхэдий аймхай хүнийг боловч тайвшруулмаар аж. Эцсийн эцэст цонхны өмхөрч ойчиход хүрсэн муу хаалт дутуу нээгдсэнээ, урцын булан дахь дэнгийн гэрэлд, д'Артаньяны мөрөвч; илд болон, богино бууны бариул харагдаад орхихын хамт л даруй дахин хаагдаж орхив. Энэ хэдий агшин зуурын хэрэг боловч, д'Артаньян өвгөний толгойг хальт харж амжив.

-Буян бодожта миний үгийг сонс доо. Би нэг хүн хүлээсэн юм, тэгсэн чинь алга. Миний сэтгэл тун их шаналж байна. Ойр хавьд элдэв гай зовлон болоогүй биз хэлж өгөөч дээ гэж д'Артаньян гуйв.

Цонх дахин алгуур нээгдэж, өвгөний царай үзэгдсэнд, түрүүчийнхээсээ ч улам зэвхийрсэн харагдлаа.

д'Артаньян өвгөнд, бүх явдлаа зөвхөн хүний нэр ус дурсалгүйгээр үнэн ярьж, энд нэг залуу бүсгүйтэй уулзахаар болзсон, хүлээж ядаад модон дээр гараад харсан чинь өрөөн дотор хамаг юмыг сүйтгэж түйвээсэн харагдлаа гэж хэлэв.

Өвгөн түүний үгийг анхааралтай сонсож, толгой дохиж байснаа, яриад дуусахаар толгой сэгсрэх нь тун олигтой юмны шинж биш бололтой.

-Та юу хэлэх гэв ээ? Энэ чинь юу гэсэн үг вэ, бурхан минь хэлж өгөөч! гэж д'Артаньян Үүнд өвгөн эрхэм минь, надаас юу ч бүү асуугаарай, би үзсэн юмаа танд хэлээд өгчих юм болж гэм надад эргээд бөөн гай болно, гэж хариулав.

-Тэгвэл танд үзсэн юм байх нээ? гэж д'Артаньян асуугаад өвгөнд нэг алтан зоос хаяж, үзэж харсан юмаа буян бодоод надад ярьж аль, таны үг бүрийг чанд хадгална гэж би тайж хүний хувиар амлая гэлээ.

д'Артаньяны царай өвгөнд үнэхээр голч шударга гуньж гутсан байртай харагдсанд,-дуулж бай гэж дохиод аяархан ярьж эхлэв.

-Орой есөн цагийн үед гадаа гудамжинд нэг чимээ гарч дуулдсан. Юу юм бол гээд гарах гэж үүд рүү ойртож явтал нэг хүн манай цэцэрлэг рүү орох гэж байгаа харагдав. Би ядуу болохоороо хулгайчаас айдаггүй хүн тэгээд хаалгаа нээгээд гартал гурван хүн над руу бүр дөхөөд ирлээ. Цаана харанхуйд морьд хөллөсөн сүйх тэрэг, эмээлтэй морьд харагдсан. Тэр морьд янз нь тайж маягаар хувцасласан энэ улсынх бололтой байв.

"Эрхмүүдэд юу хэрэгтэй вэ? гэж би асуулаа. Даргаболлолтой над санагдсан нэг нь" -Чамд шат бий юу? гэж асуусан.

"Бий дээ эрхэм ээ, миний жимсээ хураахад хэрэглэдэг шат л байна гэсэн".

" Түүнийгээ бидэнд өгөөд гэртээ ор. Май чамд хэрэг төвөг удсаны шан, энэ зоос ав. Чамд би юу ч гэсэн тэр, чи заавал харж бидний үгийг чагнах болно, тэхээр үзсэн дуулсан юмаа хүнд цухуйлгалаа л юм бол дүүрлээ гэж мэдээрэй" гэж тэр хүн хэлэв.

Ингэж хэлээд нэг зоос хаяж өгсөнд би түүнийг олж авсан тэд шат аваад явсан. " Би тэдний хойноос очиж хаалга хаагаад, буцаж гэртээ ирсэн дүр үзүүлснээ, даруй арын хаалгаар гарч, тэр харагдаж байгаа бут руу гэтэж очоод бүгдийг харж, бүгдийг дуулсан.

" Ирсэн гурван хүн сүйхээ чимээгүй хөдөлгөж ойртуулаад нэг ахимагдуу намхан бүдүүн хүн буулгасан. Элэгдсэн хар хувцас өмссөн тэр хүн шатаар хулчганасаар дээш гарч, өрөө рүү болгоомжтой гэгч харж үзсэнээ доош бууж ирээд:

-Мөн байна гэж шивнэсэн.

" Надтай юм ярьсан нөгөө хүн хармаанаасаа түлхүүр гаргаж асрынүүдийг даруй онгойлгоод далд орж, хоёр нь шатаар авирсан. Өвгөн сүйхний үүдэнд үлдэж, сүйхний морьдыг хөтөч, эмээлтэй морьдыг зарц барьж байлаа".

" Гэнэт байшин дотроос муухай хашхирах дуулдаж нэг бүсгүй хүн цонхоор харайж гарах гэсэн байртай гүйгээд иртэл нөгөө хоёр хүнийг үзээд гэдрэгээ болсонд, тэр хоёр өрөө рүү үсэрч орлоо".

Цаашаа надад харагдсан юмгүй, Харин гэрийн хогшил мөгшлыг эвдэлж, бүсгүй хүн тусалж аврахыг гуйн орилж байснаа, төдхөн дуугүй болчихсон. Гурван хар хүн цонх руу хүрч ирээд хоёр нь бүсгүйг дамжлан буугаад сүйхэнд суулгаж хөгшин бас сүйхэнд орж суусан. Өрөөнд үлдсэн нэг нь цонх хаачхаад үүдээр гарч ирсэн. Цуг явсан хоёр нь мориндоо мордож орхиод хүлээжбайлаа. Бүсгүйг сүйхэн дотор байгаа эсэхийг тэр хүн шалгаж үзээд мөн мордсон зарц хөтөчтэй зэрэгцэн суугаад, гурван хүнээр хамгаалуулсан сүйх яваад өгчихсөн дөө. Өөр үзэж

дуулсан юм надад үгүй" гэж ярив.

Энэ аюулт мэдээг дуулаад гол харласан д'Артаньяны сэтгэлд уур хар буцлан шаналж, хөшөө чулуу шиг таг зогсоно.

Ийнхүү дотроо цөхрөншаналж байгаа нь өвгөний сэтгэлийг уйлж бархирснаас илүү хөдөлгөсөн -Эрхэм минь, ингэж гутраад яах вэ. Тэд чинь таны тэр сайн хүнийг алчхаагүй, энэ чинь гол зүйл шүү дээ гэв.

-Энэ бузар хэргийг толгойлсон хүнийг та гадарлаж, байна уу? гэж д'Артаньян асуусанд. - Үгүй, би түүнийг танихгүй юм гэв.

-Та тэр хүнтэй юм ярьсан болохоороо түүний царайг хараа шүү дээ.

-Аа, та байр төрхийг нь асууж байгаа юм уу?

-Тийм.

-Өндөр туранхай бор царайтай үс, сахал нь хар, гадаад байдлаараа тайж хүн дээ. д'Артаньян дуу алдан,

-Тэр шүү, нөгөөх мөн байна. Бас л тэр хүн. Тэр янз нь миний хувьд учирсан шулам боллоотой. Аа, цаад хүннь?

-Аль цаад хүн? гэж?

-Намхан хүн гэдэг чинь

-Еэ тэр ч лав язгууртан хүн биш. Тэр хүн илд зүүгээгүй, бусад нь түүнтэй ярих барихдаа тун тоомсоргүй байж билээ.

•-За тэгвэл нэг зарц энэ тэрхэн л байж хөөрхий амьтан, тэд түүний минь ер яагаа бол гэж д'Артаньян үглэнэ. Өвгөнүүнд,

-Намайг илчилж өгөхгүй гэж та амласан шүү дээ гэвч гэсэнд д'Артаньян. -Дахиад ам өгье. Би тайж хүн, тайж хүн нэг үгтэй байдаг юм, тэр үгээ би нэгэнт хэлчихсэн та санаа бүү зов гэв.

Гарам руу дахин буцаж явахдаа д'Артаньяны зүрх базална. Өвгөний ярьсан тэр хүүхэн Бонасье авгай биш болох уу гэж заримдаа бодогдоод маргааш Луврт дайралдах биз гэж горьдоно. өөр нэг хүнтэй бас учир явдалтай байгаад жөтөөрхөг янаг нь мэдчихээд хулгайлчхаа юм уу гэж бас бодогдоно. Элдэв юм тааж бодон зүрх шимширч дотор харлан гутарна.

-Нөхөд минь надтай цуг байсан болоосой, тэгсэн бол түүнийгээ олох найдлага надад ядаж байхсан. Гэвч нөхөд маань яасныг хэн мэдэх билээ гэж д'Артаньян үглэв.

Шөнө дунд хир болчихсон, Планшег эрж олох хэрэгтэй байлаа. Гэрэл харагдсан гуанз бүрийн

үүдийг цохиж үзсэнд Планше ер байсангүй. Зургаа дахь гуанзанд орсон хойноо д'Артаньянд ингэж эрээд ер нэмэргүй гэж санагдав. Зарцыгаа өглөөний зургаан цагт хүлээ гэсэн болохоор, тэродоо хаа ч байсан хамаагүй хэрэг билээ.

Тэгээд ч энэ нууц хэрэг явдал гарсан газрын ойролцоо байвал шинэ юм дуулдах юу магад гэж залууд мөн санагджээ. Ингээд зургаа дахь гуанзанд д'Артаньян саатаж сайн дарс нэг шилийг залгиад, өглөө болохыг хүлээхээр хамгийн харанхуй буланд очиж суув. Гэвч, түүний горьдлого бүтсэнгүй энд наргижбайгаа зарц, уран дархан, хөтөч зэрэг, хүндэт хүмүүсийн хараал, наргиан наадмын үг сэлтэд хулгайлагдсан хөөрхий бусгүйн ул мөрийг гаргах үг, чагнаад чагнаад ер дуулдсангүй. Тэхлээр яахав,. бусдад сэжиг төрүүлэхгүйн тулд шилтэй дарсаа ууж дуусаад буландаа аль болох эвгэйгээр сууж унтахыг оролдохоос өөр зам байсангүй. д'Артаньян хорин настай байсан энэ насан дээр хамгийнх гуньж гутарсан хүн ч гэлээ нойронд автдаг юмаа.

Өглөөний зургаан цагт д'Артаньян сэрвэл, шөнийг муу өнгөрөөгөөд сэрэхэд байдагчлан дотор эвгүй байлаа. Бэлтгэж цөхөөд байх юмгүй унтаж байхад хүн юмы нь авчихаагүй байгаа гэж бөгж хэтэвч, буу зэвсгээ тэмтэрч үзээд, босч дарсныхаа үнийг төлөөд гарлаа. Зарцаа эрэхэд, шөнийг. бодвол өглөө дээр байх болов уу гэж горьдоно. Үнэхээр ч, шөнө хажуугаар нь огт үзэлгүй өнгөрсөн жижигхэн гуанзны өмнө шударга журамт Планше, хоёр мориобариад хүлээж байгаа харагдав.

XXV. ПОРТОС

д'Артаньян шулуухан гэртээ харихын оронд де Тревиль гуайн гадаа мориноосоо буугаад, шатаар яаран дээшээ гарлаа. Энэ болсон бүх явдлыг де Тревиль гуайд ярьж өгөхөөр шийджээ. Энэ бүх хэргийн талаар де Тревиль гуай сайн юм зөвлөж чадах нь дамжиггүйгээс гадна, хатантай өдөр бүр уулздаг хүн болохоор, эзэгтэйдээ үнэнч сайн байсныхаа төлөө зовлонд орсон хөөрхий бүсгүйн тухай тэндээс юм дуулж болохтой билээ.

Де Тревиль гуай залуугийн яриаг төлөв, хянуур чагнахыг үзвэл, энэ хэргийг ерийн нэг янаг амрагийн явдлаас чухагт үзэж байгаа нь илт.

д'Артаньяныг ярьж дуусмагц, харин энэ хэрэгт их гэгээнтний гар хуруу орсон нь илт байна гэлээ.

-Одоо тэгээд яах вэ? гэж д'Артаньян асуув.

-Яах ч хэрэг алга, миний өөрт чинь хэлж байсанчлан, Парисаас аль болох түргэн явахаас өөр яах ч хэрэг алга. Би хатантай уулзаад, хөөрхий бүсгүйн яаж алга болсон тухай тодорхой ярьж өгнө, хатан лав мэдээгүй байж таараа бий. Нарийн тодорхой юм дуулахаар хатагтайд нэг сэжим гарч магад, тэгээд таныг эргэж ирэхийн цагт би сайн юм дуулгах болоод байж юу магад. Надад найд гэж де Тревиль гуай хэлэв.

Де Тревиль гуай хэдийгээр гаскон нутгийн хүн боловч хоосон ам өгдөг заншилгүй, хэрвээ нэг юм амлалаа гэвэл, хэлснээс илүү их юм хийдгийг д'Артаньян мэддэг билээ. Ингээд, д'Артаньян, түүний тус болсон, тус болох гэж байгаад нь гүнээ талархан мэхийж, мөн энэ зоримог, эр зоригт залууд үнэхээр сайн байдаг хүндэт даамал бас түүнтэй нөхөрсгөөр гар бариад, замдаа сайн явахыг ерөөв.

Де Тревиль гуайн зөвлөснөөр даруй мордох гэсэн д'Артаньян юмаа зэхэж байгааг харахаар Авсчны гудамж уруу явлаа. Гэртээ ойртож иртэл Бонасье гуай гэрийн тэрлэгтэй үүдэн дээрээ зогсож байгаа харагдав. Байрныхаа хар санаат эзний тухай хянуур зантай Планшегийн хэлж байсан бүхэн одоо д'Артаньяны санаанд орж, түүнийг түрүүчийнхээсээ ихээ хянуур ажиж харав. Үнэхээр ч энэ хүн шаналснаас магадгүй өөр ч шалтгаар юм уу шарлангуй цайвар царайтайгаас гадна царай нүүрий нь үрчлээ нэг хачин муухай овжин байдалтай аж. Мэхчин этгээд инээхдээ шулуун шударга хүнтэй адилгүй худлаа уйлж байгаа нулимс үнэн нулимснаас ялгаатай билээ. Худал хуурмаг бүхэн хүний өмссөн баг адил, тэр багийг хэдий сайн хийсэн байлаа ч гэсэн сайн харах юм бол үнэн царайнаас ялгаж болохтой билээ.

Ингээд Бонасье баг багдаа бүр хамгийн олхиогүй муухай баг өмссөн юм шиг д'Артаньянд санагдлаа.

Энэ хүнийг уулаас жигшдэг болохоороо д'Артаньян үг дуугаралгүй хажуугаар нь өнгөрөх гэтэл Бонасье гуай өчигдрийн шигээ өөрөө яриа үүсгэв.

-Ингэхлээр залуу минь, бид чинь шөнө сайхан өнгөрөөж байх шив! Чөтгөр алгад, одоо чинь өглөөний долоон цаг болчихоод байна. Янз нь та ёс горимыг жаал өөрчилж, бусдыг гэрээсээ

гардаг цагт буцаж ирдэг болчхоо шив гэлээ. .

-Эрхэм Бонасье таныг харин ингэж зэмлэхийн эрхгүй, та төлөв томоотойн дуурайл болсон хүн. Тэгээд ч залуу сайхан эхнэртэй хойно жаргал эрж давхих хэрэг юу байхав, жаргал өөрөө гэртээ хүрээд ирэх юм хойно. Тийм биз дээ, Бонасье гуай? гэж залуу асуув.

Бонасье гуайн царай хувхай цайгаад, худлаа инээмсэглэсэн байр үзүүлж.

-Ха ха та бас наргиантай хүнээ, үгүй ингэхэд, залуу нөхөр минь, та чинь энэ шөнө хаагуур тэнүүчлээ вэ? Хөдөөний зам зугаалахад их таатай биш бололтой юмаа гэв.

д'Артаньян тоосонд пиг дарагдсан гутлаа хартал наймаачны оймс шаахай хоёр нүдэнд санамсаргүй туслаа. Үзвэл өөрийн нь гуталтай ягнэг адил шавраар туучсан юм шиг, будагдсан шавар нь тун ижилхэн аж.

Тэгтэл д'Артаньянд нэг санаа орж, хиртхийв. Нөгөө сүйх тэргэнд сууж явсан намхан, бүдүүн хижээл хүн, зэвсэг зүүж, морь унасан хүмүүсийн тэгтэл үл тоомсорлож байсан зарц аятай өвгөн гэдэг Бонасье өөрөө байж таарлаа. Эхнэрээ хулгайлах ажлыг нөхөр өөрөө удирдаж шүү.

д'Артаньянд наймаачныг багалзуурдаж алчихмаар бодол хүчтэй төрсөн хэдий боловч, бид дээр дурдсанчлан хянуур болгоомжтой залуу болохоор уураа дарлаа. Гэхдээ түүний царай мэдэгдэм хувирсанд Бонасье айж гэдрэг ухрах гэтэл, хаалганы яг хаалттай самбарын өмнө зогсож байсан болохоор түүнд тулаад дороо зогсож байхад хүрэв.

Тэгээд д'Артаньян,

-Эрхэм та надаар даажигнаж байна, гэхдээ миний гутлыг цэвэрлэмээр байна гэхэд, таны оймс шаахай хоёрт мөн сойз хүргэмээр юм шиг надад санагдах юм. Эрхэм Бонасье гуай та хүртэл нэг газарт адал явдал эрэлхийлж явсан гэж үү? Тэгвэл ч таны хир насны, тэгээд бас өдий залуу сайхан эхнэртэй хүнд энэ чинь уучилшгүй хэрэг шүү гэж хэлэв.

Бонасье үүнд хариулан,

-Оо, яалаа гэж бурхан минь. Өчигдөр би нэг чухал хэрэгтэй зарц бүсгүйн тухай сураглаж Сен Манде гэгч газар очсон юм. Одоо зам муухай байгаа болохоор тэгээд ингэж шавар шавхай болчхоод цэвэрлэж амжаагүй байгаа юм гэлээ.

Бонасьегийн очлоо гэж тэр газрын нэрийг хэлсэн нь д'Артаньяны сэжгийг нэг талаар бас баталлаа. Юу гэвэл Бонасьегийн хэлсэн Сен Манде гэгч, Сен Клугийн эсрэг зүгт байх газар билээ.

Энэ таавар д'Артаньяны сэтгэлийг нэг жаал тайвшрууллаа. Эхнэрийнхээ хаа байгааг Бонасье мэдэж байгаа бол, ийн тийм арга хэрэглэж байгаад, наймаачныг үг алдуулан, нууцыг нь дуулж болно. Ганцхан энэ таамаглалыг лавшруулах л хэрэг байлаа.

-Эрхэм Бонасье гуай, миний эрээгүйзанг та уучилж үзээрэй, гэхдээ нойргүй хоноход чинь чухам ам хатчих шахах юм. Танайхаас ганц аяга ус уухыг зөвшөөрнө үү, айл хөршийн улс ийм

Өчүүхэн юманд дургүйцэхгүй биз гэж д'Артаньян гуйв.

Тэгээд гэрийн эзний зөвшөөрөхийг хүлээлгүй, бушуухан дотогшоо ороод ор уруу халт харвал, дэвсгэр сэлт нь огт хөдлөөгүй, ингэхлээр Бонасьеурьд шөнө унтаж хэвтээгүй аж. Тэгвэл энэ хүн саяхан, нэг хоёр цагийн өмнө гэртээ эргэж ирж, тэхээр эхнэрийгээ хүргэх газарт нь, үгүй ядаж анхны өртөө хүртэл хүрэлцсэн байх нээ. д'Артаньян аяга ус ууж дуусаад,

-Гялайлаа эрхэм Бонасье, надад энэ л хэрэгтэй байсан юм. Одоо би өрөөндөө орж Планшегаар гутлаа цэвэрлүүлье. тэгээд хэрэгтэй бол, дуусахаар нь таныхыг цэвэрлүүлэхээр явуулья.

Ингээд наймаачныг үлдээхэд, цаадах нь энэ хачин үгэнд эргэж орхиод, өөрөө өөрийнхөө худлаа хэлсэн үгэнд орооцолдож орхисон юм биш байгаа гэж гайхсаар хоцров.

Шатны дээд тавцан дээр д'Артаньян айж мэгдсэн Планшетэй уулзав.

Эзнийгээ үзмэгц Планше дуу алдаж ээ, эрхэм ээ, бас сонинтой, таныг бүр хүлээж ядлаа гэв. Үүнд д'Артаньян юу болоо вэ? гэж асуулаа.

-Таныг үгүй хоорондуур хэн энд ирснийг та мөрийцөвч таахгүй дээ, эрхэм ээ, -Хэдийд вэ тэр чинь?

-Хагас цагийн өмнө, таныг де Тревиль гуайнд байхад

-Үгүй тэгээд хэн ирсэн юм бэ? бушуу хэл.

-Де Кавуа гуай,

-Де Кавуа гуай гэнээ?

-Биеэрээ морилж ирсэн.

-Их гэгээнтний торгон цэргийн даамал уу?

-Тэр хүн.

-Тэр хүн тэгээд намайг баривчлахаар ирээ юу?

-Өөрөө хэдий их нялуун ааштай байсан ч гэсэн надад тэгж л санагдсан. -Тэгвэл тэр хүн их сайхан. ааштай байсан байх нээ?

-Үгүй эрхэм ээ, зүгээр сүйд болоод л байсан шүү.

-Нээрээ юу?

-Их гэгээнтэн танд сайн байдаг, тэгээд Пале Рояль ордондоо морилж очихыг урьж байна гэж байсан.

-Планше чи өөрөө түүнд юу гэж хариулав.

-Таныг гэртээ үгүй болохоор яаж очих билээ, үгүй байгааг та өөрөө харж байна шүү дээ гэсэн.

-Тэхээр чинь тэр хүн юу гэв?

-Таныг өнөөдрийн дотор их гэгээнтнийд заавал оч гээрэй гэсэн. Тэгээд надад "их гэгээнтэн танай эзэнд тун сайн байдаг, магадгүй энэ уулзалтаас түүний цаашдын хувь заяа шийдвэрлэгдэж болох юм гэж эзэндээ хэлээрэй" гэж шивнэсэн.

д'Артаньян инээвхийлж, энэ арга хамба ламтных гэхэд их л болхи юм гэв.

-Тийм учраас л би мөн ажиж аваад, таныг буцаж ирээд иххарамсана байх гэж хэлсэн. "Хаашаа явсан юм бэ?" гэж де Кавуа гуайг асуухад "Труа шампань гэдэг газар очихоор явсан" гэж би хариулсан. "Хэзээ явсан юм бэ?" гэхэд "өчигдөр орой" гэсэн.

-Планше, найз минь, чи үнэхээр чухаг сайн хүн юм гэж д'Артаньян үгийг нь таслав.

-Ингэхэд эрхэм ээ, тахэрэв Кавуа гуайтай уулзахсан гэвэл, дуртай цагтаа миний үгийг няцааж, ерөөсөө хаашаа ч яваагүй л гэнэ биз гэж би бодсон юм. Тэгвэл яахав би худлаа хэлсэн болно биз, тайж хүн биш болохоор би худлаа хэлж болно шүү дээ.

-Санаа амарч үз, Планше чи шударга сайн нэрээ алдахгүй, бид үнэхээр нэг мөч болоод мордлоо.

-Би дөнгөж сая танд үүнийг зөвлөх санаатай байсан юм. Ингэхэд, нууц биш бол бид хаашаа явахыг хэлээч?

-Мэдээжээр, де Кавуа гуайд чиний хэлж өгсөн чигээс эсрэг зүгт л явж таарна. Тэгээд ч, Атос, Портос, Арамис гурвын тухай миний юм дуулахсан гэж яарч байгаатай адил чи мөн Гримо Мушкетон, Базен гурвын тухай дуулахсан гэж яарч байгаа биз? гэж д'Артаньян асуув.

-Тэгэлгүй яахав, эрхмээ би одоо ингээд ч мордсон бэлэн байна. Миний санахад одоохондоо танд Парисийн агаараас хөдөө нутгийн агаар тохиромжтой байх тэхлээр...гэж Планшег яриа дэлгэх гэтэл д'Артаньян хажуугаас нь:

-Тэхлээр, Планше, юмаа бэлд, тэгээд явъя. Эхлээд би,алив нэг сэжиг төрүүлэхгүйн тулд гар хоосон явлаа. Хоёулаа

торгон цэргийн хуаранд уулзъя. Мартсан, манай байрны эзний хувьд, Планше чиний хэлдэг зөв юм байна,цаадах чинь их гарын новш байна шүү гэв.

-Тэгнээ! хэн нэг хүний тухай миний хэлсэнд, эрхэм та зүгээр итгэж бай, хүнийг би царайгаар нь шинждэг юм.

Ярилцаж тохирсон ёсоор д'Артаньян түрүүлж доош буув. Мөн хашир байхын тулд гурван

нөхдийнхөө байраар бас нэг орж үзлээ. Тэдний тухай сураг чимээ ер үгүй, ганцхан Арамисын байранд, жижиг дэгжин бичгээр хаягласан, сайхан үнэр анхилсан нэг захиа ирсэн байв. д'Артаньян түүнийг эзэнд нь хүргэж өгөхөөр ав/.аа. Арван минутын дараа Планше хойноос нь торгон цэргийн хуарангийн морины саравчинд хүрч ирэв. Цаг дэмий үрэх дургүй, д'Артаньян өөрөө морио эмээллэв.

Планше хайрцгаа даруулж боосны дараа, за сайн. Одоо

үлдсэн гурван морьдыг эмээллэ, тэгээд явья гэж д'Артаньян

хэлэв. ,

Планше залирхуу байр гаргаж,

Бид хүн тус бүр хос морьтой явбал түргэн байна гэж та бодож байна уу? гэжасуулаа.
д'Артаньян үүнд,

-Үгүй наргианы эзэн минь, дөрвөн морьтой явбал нь бид, гурван нөхдөө эсэн мэнд байдаг юм бол аваад ирж болох юм гэсэнд Планше:

-Тэгвэл их азтай хэрэг болохсон. Гэхдээ бурхны хайр ивээлд хэзээ ч цөхрөхийн хэрэггүй гэв.

-Болтугай гэж д'Артаньян дуугараад мордов. Ингээд торгон цэргийн хуарангаасгарч хоёр тийшээ салаад, нэг нь Парисаас Лавильтийн хаалгаар нөгөө нь Монмартрын хаалгаар гарч, Сен Денид уулзахаар болов. Энэ арга заль хоёулаа нарийн гүйцэтгэсэн болохоор урагштай бүтэж Пьерт гэгч газар хоёулаа зэрэг хүрч ирэв.

Өдрийн цагт Планше шөнийнхөөсөө зоригтой байсныг хэлэх хэрэгтэй.

Гэхдээ төрөлхийн хянуур зангаа тэр хоромхон зуур ч орхисонгүй, анх явахад дайралдсан муу явдлуудаас нэгийг ч мартсангүй, замд дайралдсан бүхнийг дайсанд тооцож явлаа. Үүний улмаас Планше юм л бол малгайгаа аваад байсанд, д'Артаньян түүнийг хэтэрхий эелдэг зан гаргаснаар нэг өчүүхэн хүний зарц шиг харагдуузай гэж санаад, сайн гэгч зандарчихлаа.

Гэхдээ, замд дайралдсан улс үнэхээр Планшегийн эелдэгт сэтгэл уярсан юм уу, аль энэ удаа д'Артаньяны замд саад хийхээр явуулсан хүн үгүй байсан юмсан уу, юу ч гэсэн мань хоёрт алив хэрэг төвөг учралгүй явсаар Шантильид ирж анх удаа явахдаа буусан нөгөө Гран Сен Мартен гэгч буудлын гадаа ирж буув.

Араасаа хоёр морь хөтөлсөн зарц дагуулсан залууг үзээд, буудлын эзэн үүдэн дээрээ хүндэтгэн тосож авлаа. Арван нэгэн мод хир явчихсан д'Артаньян, Портосыг энд байсан байгаагүй хамаагүй буух хэрэгтэй гэж үзлээ. Үүнээс гадна, шадар цэргийн тухай даруй асууж сураглах гэдэг бас болчимгүй хэрэг. Ингэж бодоод д'Артаньян хэний ч тухай юм асуулгүйгээр мориноос бууж, цулбуураа зарцад өгөөд, нийтийн өрөөнд орохыг үл хүссэн зочдын ордог жижиг өрөөнд оров. Ингээд нэг шил хамгийн сайн дарс, аль болох сайн хоол захиалаад, зочныг анх хараад хүндэтгэх сэтгэл төрсөн эзэнд бүр ч буурьтай санагдлаа.

Ингээд д'Артаньяны захисан юмыг агшин зуур авчирч өглөө.

Торгон цэргийн хороонд улсын шилдэг тайж нараас шилжавдгийн дээр, дөрвөн лут морьтой, зарц дагуулсан д'Артаньян, хэдий энгийн нэг хувцастай гэвч, энд сүрхий буурьтай харагдах ёстой билээ.

Буудлын эзэн өөрөө түүнд үйлчлэх гэв. д'Артаньян үүнийг үзээд хоёр аяга авчруулаад яриа үүсгэв.

д'Артаньян хоёр аяганд дарс дүүргээд, ам нээж,

-За буудлын эелдэг эзэн гуай, танаас би хамгийн сайн дарс өгөхийг гуйсан. Тэгээд та намайг хуурсан бол чухамдаа өөрийгөө шийтгэх чинь энэ дээ. Юу гэвэл би ганцаараа юм уух тун дургүй хүн, тэхээр та надтай цуг уух болно. За ингээд хэн хэнийгээ гомдоохгүйн тулд юуны төлөө хундага өргөх билээ? За танай буудлын урагш бүтэмжийн төлөө уучихья гэв.

-Эрхэм минь, тун их өршөөл сайхан ерөөл хэлсэнд их гялайлаа гэж эзнийг хэлэхэд, д'Артаньян маргаж:

-Ганцхан миний үгэнд бүү хууртаарай, үүнд чинь, таны бодож байгаагаас илүү их хувиа хичээсэн юм байгаа хэрэг. Зөвхөн ажил төрөл нь урагшаа бүтэмжтэй байгаа буудалд л хүнийг сайн зочилдог. доройтож яваа буудалд, зам яваа хүн буугаад буудлын газрын хомсхон муу байдлаас болон тохь алдахад хүрдэг юм. Би өөрөө нааш цааш их явдаг, голдуу энэ замаар их явдаг хүн болохоор энэ зам дагуу бүх буудлын газрыг урагш бүтэмжтэй байгаасай гэж боддог хүн гэв.

-Тэгнээ тэр тантай үүний өмнө нүүр учрах завшаан надад тохиолдсон юм шиг санагдаад байсан юм гэж буудлын эзэн хэлэв.

-Тэхгүй яахав. Шантилаар би лав арав шахуу удаа явж өнгөрч байна. Үүнээс хоёр гурван удаа танай үүгээр дайрч байсан даа. Үгүй, энд би дөнгөж арав, арван хоёр хоногийн урьд буусан" шүү дээ. Би өөрийн нөхөд шадар цэргүүдээ гаргаж өгч явсан, яахав танд сануулаад өгч болно, тэдний нэг нь, эхлээд түүнийгөдсөн нэг хүнтэй муудалцаагүй юу.

-Тийм, тийм тэр явдлыг би сайн санаж байна. Эрхэм. та янз нь Портос гуайн тухай ярьж байх шив дээ? гэж буудлын эзэн хариулав.

-Тиймээ, миний цуг явсан хүн тийм нэртэй юм. Бурхан өршөө, түүнд золгүй муу юм дайралдаагүй биз дээ, эелдэг. аашт эзэн минь.

-Тэхдээцаанаа явж чадаагүйг эрхэм та өөрөө мэдээ шүү дээ.

-Тэр үнээн, биднийг гүйцэж очно л гэсэн юм. Тэр цагаас хойш бид уулзаагүй шүү. -Портос гуай энд үлдэж биднийг гийгүүлсэн юм.

-Юу? энд үлдсэн гэнээ?

-Тиймээ эрхмээ энэ буудалд. Тэгээд үнэнийг хэлэхэд бид баахан зовууртай байгаа. -Юунд тэр вэ?

-Түүний зарим зарлаганд.

-Зовоод байх юу байгаа юмбэ? Хэрэглэсэн юмныхаа үнийг Портос төлнө биз.

-Өө, эрхэм минь та, чухам нэг миний шарханд эм түрхэж байна, бид түүнд их юм зээлдүүлчихээд байгаа, өнөө өглөө хүртэл түүнийг мөнгөө төлөхгүй юм бол залилснаар нь надаас мөнгөө авна гэж эмч гуай сүрдүүлсэн

-Портос тэгээд шархадсан юм гэж үү?

-Эрхэм ээ, үүнийг би танд дуулгаж чадахгүй.

-Юу дуулгаж чадахгүй гэж. Түүний тухай, та чинь бусдаас илүү сайн мэдэж байх ёстой шүү дээ?

-Тэр ч үнэн л дээ, эрхмээ. Бидний хирийн улс мэдсэн бүхнээ, тэхдээ бүр ам алдах юм бол чихээ огтлуулна гэж сануулга авсны хойно мэдсэн бүхнээ ярьж болдоггүй юм. -За тэгвэл, Портостойби уулзаж болох уу?

-Бололгүй яахав, эрхмээ, шатаар дээшээ гараад, нэгдүгээр хаалгыг тогшоорой. Гэхдээ нэрээ урьдаас хэлэлгүй. болохгүй гэлүү.

-Нэрээ урьдаас хэлэх гэнээ?

-Тиймээ, тэхгүй бол танд муу юм учирч магадгүй.

-Таны бодлоор надад ямар муу юм болж мэдэх юм бэ?

-Портос гуай таныг манай гэрийнхний нэг гэж үзээд уурласандаа илдээр бүлчих юм уу, толгойгий чинь хага буудчих магадгүй.

-Та нар түүнийг яасан юм бэ?

-Бид түүнээс мөнгө гуйчихсан юм.

-Аа, чөтгөр алгад, одоо би ойлголоо. Энэ үгийг Портос мөнгөгүй цагтаа дуулах тун дургүй хүн, гэхдээ бидний мэдэж байгаагаар, түүнд мөнгө байх л учиртай юм сан.

-Бид мөн тэгж л бодсон юм эрхмээ манай буудал уулын нарийн журамтай болохоор долоо хоног бүрийн эцэст бид тооцоогоо гаргадаг юм. Тэгээд л долоо хоногийн эцсээр тооцоогоо хийе гэсэн юм. Бид янз нь зохисгүй цагт дурсчихсан юм байлгүй, мөнгө гэж дурсаж амжаагүй шахуу байтал биднийг харааж загнаад гарсан. Харин түүний өмнө мөрийтэйтоглосон хүн дэг.

-Портос тоглосон гэнээ? Хэнтэй тэр вэ?

-Пээ бурхан минь, хэн мэдэх вэ? Нэг явуулын эрхэмтэй хоёулаа тоглоё гэж өөрөө гуйсан байх.

-Хамаг хэргийн учир янз нь үүнд байгаа даг. Хөөрхий Портос хуу хожигдож орхиж л дээ.

-Морио хүртэл алдсан даг, эрхмээ, юу гэвэл, тэр хүнийг явахболоход зарц нь Портос гуайн морийг эмээллэж байгаа харагдсан. Энэ тухай тэр хүнд сануулсан чинь биднийг хүний хэрэгт хөндлөнгөөс оролцлоо, энэ морь минийх гэсэн. Бид тэр дороо энэ тухай Портос гуайд мэдэгдвэл, тайж хүний үгэнд та нар эргэлзэж байгаа бол өчүүхэн муу улс, тэр хүн морийг өөрийнх л гэж байгаа бол, тийм байж таарна гэж Портос гуай хэлсэн гэв.

-Аргагүй л Портос мөн дөө гэж д'Артаньян хэлэв. Буудлын эзэн яриагаа үргэлжлүүлэн,

-Тэхээр нь үнэ цэнийн талаар бид ер тохиролцохгүй улс бололтой, тэхээр, ядаж "Алтан бүргэд" гэдэг өөр буудалд шилжиж суух сан болов уу гэж түүнд би хэлсэн чинь, миний буудлыг дээр юм, эндээ үлдэнэ гэлээ. Энэ хариу миний сэтгэлд аятай санагдсан болохоор би зөрөөд байж чадсангүй. Иймд, өөрийнхөө суужбайгаа буудлын ганц олигтой өрөөг суллаад дөрвөн давхарт байгаа аятайхан өрөөнд орж үзэхгүй юу гэлээ. Тэгсэн өөрийнхөө амраг, ордны бараа бологч, өндөр хэргэмтэй бүсгүйн юу юугүй ирэхийг хүлээж байгаа болохоор, одоо сууж гийгүүлж байгаа өрөө нь ч гэлээ үүнд маш буурай болохыг би ойлгох ёстой гэнээ. Гэхдээ өөрийн нь үг аргагүй зөвгэйгби зөвшөөрөх хэдий боловч би аргагүй өөрийнхөөрөө зүтгэх хэрэгтэй болсонд, Портос гуай надтай маргалдаж төвөг удахыг хүссэн ч үгүй, богино буугаа гаргаж жижиг ширээн дээр тавиад, өөр өрөө юм уу, өөр буудалд шилжиж орох тухай яриа үүсгэж өөрийн нь хэрэгт болгоомжгүйгээр оролцсон хүний толгойг хага буудна гэлээ. Тэр цагаас аваад, өөрийннь зарцаас өөр хэн ч түүний өрөөнд орж зүрхэлдэггүй юм.

-Тэгвэл Мушкетон энд бий юмаа?

-Энд бий. Та нарыг явснаас хойш тав хоног хиртэй болоод бас л их зан муутай эргэж ирсэн. Замд нь нэг аягүй юм болсон бололтой доо. Гай болоход, тэр хүн эзнээсээ илүү их овжин юм. Эзэндээ хэрэгтэй юмыг өгөхгүй нь гэж мэдээд, түүнийхээ төлөө юунаас ч буцахгүй, одоо хаа байгаа газраас нь дураараа авдаг болсон.

-Тиймээ, Мушкетон ер эзэндээ ховор их үнэнч сайн авхаалжлаг хүн шиг надад харагдаад байдаг юм гэж д'Артаньян дуугарав.

-Тун ч магадгүй юм эрхмээ. Гэхдээ ийм үнэнч зүтгэлтэй, авхаалжлаг хүн манайд жилдээ дөрөв дахин учирлаа гэвэл бид хоосорч гүйцэх нь тэр.

-Үгүй, тэр тийм биш, юу гэвэл Портос, танай юмыг төлж өгнө.

Буудлын эзэн итгэмж муутайхан.

-Хээн...гэж дуугарав.

-Портост нэг өндөр язгууртан бүсгүй талтай сайн байдаг юм, тэгээд түүний танайд тавьсан

өр мэт өчүүхэн юмнаас болоод тэр бүсгүй яалаа гэж сайн хүнээ хүнд байдалд орхих билээ гэж д'Артаньян хэлэв.

-Энэ тухай юу бодож байгаагаа би танд дуулгаж зүрхэлдэгсэн болж гэм...

-Та юу бодож байгаа юм бэ?

-Бодож байгаагаар ч барахгүй, мэдэж байгаа юм шүү!

-Юу мэдэж байгаа юм бэ?

-Мэдэж байгаагаар ч барахгүй, лавтай үнэмшсэн зүйл... Юунд та үнэмшиж орхио вэ, ярь л даа.

-Тэр язгууртан бүсгүй чухам хэн болохыг би мэднэ.

-Та юу?

-Тиймээ, би.

-Үүнийг та ямар янзаар мэдээ вэ?

-Хэрэв таны даруу зантайд би итгэж болохтойсон болж гэм..

-Тайж хүний хувьд амлая надад итгэсэндээ харамсах явдал өөрт чинь тохиолдохгүй. -Сэтгэл зовоод ирэхээр элдэв юм хийхэд хүрдгийг эрхэм та ойлгож байгаа шүү дээ, -Та тэгээд юу хийчихсэн юм дээ?

-Авцаатай хүний эрхээс хэтэрсэн тийм юм би ер хийгээгүй.

-Тэгээд?

-Портос гуай тэр Герцогтны авгайд захидал бичээд шууданд өг гэж бидэнд өгсөн юм. Тэхэд өөрийг нь зарц ирээгүй байсан цаг. Өөрөө өрөөнөөсөө гарч чадахгүй байсан болохоор арга буюу биднээс гуйхад хүрсэн юм.

-Тэгээд цаашаа? гэж д'Артаньян асуув.

-Захидлыг зарим үед итгэл муутай болдог шуудангаар явуулахын оронд манай нэг зарц Парис хот руу явах байсныг би ашиглаад, захидлыг өндөр язгуурт авхайданд биеэрээ хүргэж өг гэлээ. Тэр захидлын төлөө их санаа зовоод байсан Портос гуайн хүсэлд л нийцүүлсэн хэрэг шүү дээ, энэ чинь тийм биз.

-Бараг тийм юм биз.

-За тэгээд тэр язгууртан бүсгүй чухам хэн болохыг та мэдэх үү?

-Үгүй, тэр тухай би Портосоос өөрөөс нь л дуулснаас цаашгүй.

-Тэр хуурмаг их язгууртан бүсгүй чухам хэн болохыг та мэдэхгүй юм биз дээ? гэж буудлын эзнийг асуухад, д'Артаньян:

-Би танихгүй гэдгээ, дахин дуулгая гэлээ.

-Тэр чинь Шатле хавийн хөгшин прокурорын, наана хэлэхэд тавиас доошгүй настай, тэр мөртлөө жөтөөрхөг бүсгүйн маяг үзүүлдэг Кокнар авгай юмаа. Өндөр язгууртан бүсгүй мөртөө, баавгайн гудамжинд суудаг гэхэд нь би ч гэсэн эргэлзээд байсан юм.

-Эд бүгдийг та яаж мэдсэн юм бэ?

-Яахав захидлыг аваад авгай их уурлаж, Портос гуайг тогтворгүй амьтан лавбүсгүйн төлөө илдээр бүлүүлээ биз гэж аашилсан гэнэ билээ.

-Тэгвэл, Портос илдээр бүлүүлсэн юм шив?

-Оо бурхан минь, энэ чинь, би юу хэлчхэв ээ?

-Портосыг та илдээр бүлүүлсэн гэж хэлсэн.

-Тийм нь ч тийм, гэхдээ энэ тухай ярихыг тэр өөрөө чанд хориглосон юм. -Яагаад тэр билээ?

-Яагаад гэнээ! Яахав та нарыг явахын үед нөгөө хэрүүл өдсөн хүнээ нэвт бүлнэ гэж

амлаад байсан, гэтэл Портос гуай хэдий сайрхсан боловч цаад хүн өөрийг нь харин бүлээд унагаачихгүй юу. Тэхээр адал явдлаа ярьж сэтгэлийг нь уяраахыг оролддог нөгөө язгууртан бүсгүйгээсээ бусад бүх юмны хувьд тун бардам зантай Портос гуай илдээр бүлүүлснээ хэнд ч мэдэгдэх дургүй байгаа юмаа.

-За тэгвэл ингэж бүлүүлсэн дээ л Портос хэвтээд байгаа юм бий.

-Тиймээ, танд гэж хэлэхэд, лут бүлүүлсэн шүү. Танай нөхрийн амийг биетэй нь лав хадаасаар бөхөлсөн юм даг шүү.

-Тэгвэл, тулалдах үед та харж байсан байх нээ?

-Хэрэгт дурлаж, тэдний хойноос дагаж очоод өөрсдөд нь үзэгдэхээргүй газраас харсан юм.

-За тэгээд яаж шүү тулалдав даа?

-Тиймнэг их удаан ч юм болсонгүй. Тэд байраа эзлэн зогстол цаад хүн хурдан гэгч ухас хийлээ, Портос гуай хамгаалах гэтэл цээжинд нь уртын урт төмөр нэгэнт бүлээстэй байж байхгүй юу? Портос гуай, гэдрэгээ хараад ойчсон, цаад хүн даруй илдийнхээ үзүүрийг цээжин дээр нь тавьсанд Портос гуай хүний гарт бүрэн орсноо мэдээд дийлдсэнээхүлээсэн. Тэхлээр цаад хүн нэрий нь асууж, түүнийг д'Артаньян биш, Портос гэдгийг дуулаад, буудалд

түшиж авчраад мориндоо мордож алга болж өгсөн.

-Тэгвэл тэр хүн д'Артаньянтай хэрүүл өдөх санаатай байсан хүн юмаа? -Тийм л бололтой.

-Тэгээд тэр хүний яасныг та ер мэдэхгүй гэж үү? гэж д'Артаньян асуулаа. -Үгүй, түүний өмнө түүнээс хойш ч гэсэн тэр хүнтэй ер дайралдаагүй.

-За сайн. Дуулах гэсэн юмаа би цөмийг дууллаа. Тэхлээр Портосыг хоёрдугаар давхрын нэгдүгээр өрөөнд байгаа гэсэн байхаа?

-Тиймээ эрхмээ манай хамгийн сайн, энэ зуур арав дахин хүн оруулж болох өрөөнд сууж байгаа хүн.

-д'Артаньян үүнд инээд алдаад,

-Заболь сэтгэл бүү зов, Портос танд Кокнар Герцог гуайн гэргийн мөнгөөр өрөө төлнө биз гэлээ.

-Өө эрхэм минь, тэр бүсгүй Герцог хүний ч гэргий бай, Прокурор хүний ч гэргий бай, ганцхан хэтэвчнийхээ амыг онгойлгоо л бол барав. Гэтэл үгүй шүү. Портос гуайн мөнгө нэхэх, мөн бусдыг илүүд үзэх хоёрт хаширчгүйцлээ, ганц ч сохор зоос явуулахгүй гэсэн байна билээ.

-Та тэгээд авгайн хариуг, өөрт нь дуулгасан уу?

-Үгүй шүү. Тэх юм болж гэм биднийг даалгасан зүйлийг нь хэрхэн биелүүлснийг өөрөө гадарлачих байлгүй яахав.

-Тэгвэл тэр мөнгөө хүлээсээр л байгаа хүн юм биз дээ?

-Хүлээгээд байгаа даа л хамаг учир байгаа юм. Дөнгөж өчигдөр Портос гуай тэр авгайд дахин нэг захиа бичсэн, харин энэ удаа түүний зарц шууданд аваачиж өгсөн дөө. -Та тэгээд, прокурорын авгайг хөгшин, царай зүс муутай гэсэн байхаа? -Наад зах нь тавин настай, Патогийн хэлж байгаагаар болж гэм царай зүс тун дорой даг. -Тэгвэл бүү санаа зов, тэгж тэгж авгай заавал зөөлөрч таарна. Тэгээд ч Портос танд тийм их өр тавьсан байж таарахгүй дээ.

-Юу таарахгүй гэж? Эмчийг оролцуулалгүйгээр, хориод алтан зоос болсон. Ер юу дуртайгаа хэрэглэдэг, элбэг дэлбэг амьдарч сурсан нь бүр илт байна.

-За яахав, амраг бүсгүй түүнийг хаячихдаг юмаа гэхэд Портост нөхөд бий гэдгийг би лавтай хэлж чадна. Тэхлээр сайн буудлын сайхан ааштай эзэн та язгуурт хүн түүний хир хэмжээнд тэнцэх сайнаар үйлчилж л бай, гэж д: Артаньян хэлэв.

-Эрхэм ээ, та прокурорын эхнэрт шархны тухай үг цухуйлгахгүй гэж амласан шүү дээ гэж буудлын эзэн сануулав.

-Үүнийг надад сануулах явдалгүй, би амласан шүү дээ.

-Мэдэх л юм бол Портос гуай намайг алчихна шүү.

Бүү ай, тэр чинь чухамдаа гадаад сүр шигээ тийм их аймшигтай хүн биш гайгүй. д'Артаньян ингэж хэлснээр амь мөнгө хоёртоо сэтгэл их зовж байсан буудлын эзнийг жаал тайвшруулж орхиод шатаар дээш гарав.

Дээд давхрын гудманд бусдаасаа арай аятайхан харагдах нэг хаалган дээр хар бэхээр "Г" гэж томоос том бичжээ. д'Артаньян үүд цохиод дотроос замаараа яв гэхийг дуулж, үүд, нээгээд өрөөнд оров.

Портос гараа дасгах гэж орон дээрээ хэвтээд Мушкетонтой тоглож байна. Мөн ил гал түлэх пийшин дотор ятууны мах шорлон шарж том пийшингийн хоёр талын ширмэн дээр хоёр савтай юм буцалж дарсаар амталсан загас, туулайн махаар чанасан шөлний хорхой хүргэсэн сайхан үнэр гарах аж. Ширээ, шүүгээний гантиг өр сэлтэн дээгүүр дарсны хоосон лонх дүүрэн өрөөстэй харагдав.

Нөхрөө үзээд, Портос баярлан дуу алдав. Мушкетон хүндэтгэн босож, д'Артаньянд суудлаа тавьж өгөөд, өөрийнхөө хяналтад байгаа бололтой савтай хоолоо үзэхээр очив.

-Портос баярлан, ээ чөтгөр алгад, та хүрээд ирээ юм бий. Тун сайн байна. Намайг босохгүй байгаад бүү муу юм санаарай, үгүй ингэхэд миний яасныг та мэдсэн үү? гэж д'Артаньянаас жаахан зовсон байртай асуув.

-Үгүй шүү гэж д'Артаньян хэллээ.

-Буудлын эзэн танд юм ярьсангүй юу?

-Таны хаа байгааг би түүнээс асуугаад, шуудханнаашаа хүрч ирлээ гэсэнд Портосын дотор жаал онгойв бололтой.

-За тэгээд Портос та чинь яачихсан бэ? гэж д'Артаньян асуув.

-Үгүй яахав би нөгөө хүнийг илдээрээ гурав бүлчихээд, бүрмөсөн дуусгах санаатай дөрөв дөх удаагаа бүлэх гэж байгаад чулуунд бүдэрч унаад өвдгөө булгалчихгүй юу -Үгүй, ерөө хөөш.

-Үнэхээр тэгсэн шүү. Тэрмуугийн зол болж тэр байхгүй юу, үгүйсэн бол би тонилгочих байсан шүү, нээрээ,

-Тэр хүн тэгээд хайчсан бэ?

-Үнэндээ мэдэхгүй шүү. Тэр надаас сайн гэгч хишиг хүртээд, хариугий нь өгөх гэж оролдолгүй яваад өгсөн. Ингэхэд д'Артаньян минь та нар юу болов доо?

-Тэгвэл тэр өвдгөө булгалснаасаа болоод л хэвтээд байгаа хэрэг үү, Портос? гэж д'Артаньян бас асуулаа.

-Харин тийм дэмий юм байх юм л даа. Гэвч хэд хоноод би босноо.

-Үгүй, та яагаад өөрийгөө Парис уруу аваачуулсангүй вэ, энд уйтгартай гэж жигтэйхэн байгаа биз дээ?

-Уул нь би тэх л санаатай байсан юм, гэхдээ найз минь, танд л гэж хэлэх юм бас бий. -Юу тэр вэ?

-Ийм хэрэг боллоо. Намайг үнэхээр өөрийн чинь хэлснээр уйдаад хэцүүдэж гүйцээд, мөн өөрөөс чинь авсан далан таван зоос хармаанд байсан болохоор би энд буусан нэг явуулын тайж хүнийг жаахан зугаа гаргах санаатай ирж шоо хаяж тоглохгүй юу гэлээ. Тэр хүн зөвшөөрөөд тоглосон чинь, миний далан таван зоос тэр хүний хармаанд орчих нь тэр. Морийг минь нэмэр болгож хөтлөөд явчихсаныг ч бүр хэлээд яахав. За тэгээд д'Артаньян та яасан бэ ингэхэд?

-Яая гэх вэ, Портос минь, юм бүхэнд урагштай байж ямар болох биш "тоглоомд азгүй хүн дурлалдазтай байдаг" гэж зүйр уг бий шүү дээ. Дурлалд та дэндүү их азтай байдаг хүн тэхээр гай болж тоглоомд азгүй байгаа нь тэр. Аз харьсан ч танд тэгээд юухан байхав дээ. Та ер золиг шиг азтай хүн хойно, таны нөгөө герцогийн гэргий өөрт чинь даруй туслахгүй гэж үү?

-Харин, тоглоомд тиймаз муутай болохоороо би түүнд одоогийн минь байдалд аргагүй хэрэгтэй байгаа том алтан зоос тавийг ирүүлээч гэж захиа бичсэн л дээ, гэж Портос хэнэггүй хариулав.

-Тэгээд яасан бэ?

-Яахав, нэг эдлэндээ яваа бололтой, би хариу авсангүй

-Үгүй ер өө?

-Тийм, хариу байдаггүй, өчигдөр би тэгээд, түрүүчийнхээсээ итгэмжтэй нэг захиа бичээд явуулсан. Үгүй ингэхэд сайн найз минь та ирчхээд байна, таны тухай ярилцъя. Үнэнээ хэлэхэд та нарын тухай би жаал зовж эхэлж байлаа шүү.

д'Артаньян хоолтой сав хоосон лонхнуудыг зааж,

-Эд бүгдийг үзэхэд, буудлын эзэн танд их муугүй юм шив дээ гэсэнд, Портос:

-Хаанаас тэх вэ! Гурав, дөрвөн хоногийн өмнөтэр ичгүүргүй золиг надад тооцоогоо .барьж ирэхээр нь би тооцоотой нь хамт хөөгөөд гаргачихсан. Тэхлээр энд одоо би дийлсэн хүн, нэг ёсондоо түрэмгийлэгчийн байртай сууж байгаа болохоор довтолгооноос айж, зэвсэглэхийн сайнаар зэвсэглэж орхиод байхгүй юу.

д'Артаньян сав лонх уруу хуруугаараа зааж, Үгүй та нар тэгээд, үе үе гарч дайралт хийдэг юм шив дээ? гэж инээд алдав.

-Гай болоход би биш л дээ. Золигийн муу хөл булгарчхаад босож чадахгүй хэвээр байна.

Мушкетон л газар орны байдлыг хараад, идэж уух юм олдог юм гэж Портоос хариулснаа, Мушкетон минь, бидэнд хүч нэмэгдэж ирсэн байна, тэхээр нөөцөө арвижуулах хэрэгтэй болжээ гэв.

-Мушкетон чи надад нэгтус үзүүлэх хэрэгтэй байна гэж д'Артаньян хэллээ. -Ямар тус вэ, эрхмээ?

-Энэ аргаа Планшед зааж өг. Би мөн бүслэгдсэн байдалд орж болно, тэхийн цагт чиний эзнээ ингэж аятай тохитой байлгаж байгаа шиг Планше намайг байлгаж сурвал муугүй санж. Мушкетон үүнд даруу байдлаар,

-Эрхэм ээ, үүнээс амархан юу байхав. Жаахан авхаалжаас өөр юу ч хэрэггүй. Би хөдөө тосгонд өссөн хүн, манай эцэг чөлөө цагтаа, бусдын эдлэнд жаахан ан хийдэг хүн байсан юм.

-Бусад цагтаа юу хийдэг хүн байсан юм бэ?

-Надад их ашигтай юм шиг санагддаг нэг ажил эрхэлдэг байсан.

-Ямар ажил тэр вэ?

-Католик шашинтан хугенотуудтай тэмцэл хийдэг байсан цаг юм. Католикууд хугенотынхныг, хугенотынхан католик шажны талынхныг шашин номын төлөөнөө хөнөөсөөр байгааг үзээд манай эцэг католик, хугенот хоёр шажны аль алины талыг барьж болдог холимог шажинтай болжээ. Тэгээд манай эцэг замын хажуугийн таримал бутны цаагуур буу үүрээд сэлгүүцэж явснаа, ганц нэгээрээ явж байгаа католик шажны талын хүн үзэхтэйгээ зэрэг даруй нөгөө талын шажинд сүжиг орчхоод, цаад хүн рүү буу шагайж арваад алхам ойртоодирэхээр нь яриа үүсгэхэд хүмүүс голдуу хэтэвчтэй мөнгөө өгч салдаг байсан. Гугенотын талын хүнтэй дайралдаад орхихын хамт манай эцэг мэдээжээр католик шажинд халуун их сүжиг ороод энэ ариун шажны давууд, ганцхан мөчийн өмнө яагаад эргэлзэж байснаа мартчихгүй яахав. Эрхмүүдээ би өөрөө католик хүн, тэхлээр манай аав өөрийнхөө зарчмыг баримталж манай ахыг гугенотын талын шажинтай болгосон юм шүү гэлээ.

-Тэр хүн тэгээд эцэстээ яасан бэ гэж д'Артаньян асуув.

-Өө эрхэм ээ, их муугаар төгссөн шүү. Нэг өдөр манай эцэг нарийн зөрөг дээр, түрүүн сүрдүүлсэн католик, хугенотын талын хоёр хүнтэй зэрэг тааралдаад, цаад хоёр нь хүч хавсран эцгийг дүүжилчихсэн юм. Ингээд тэр хоёр ойрбайсан тосгонд хүрч ирээд, ах бид хоёрын юм ууж суусан гуанзанд яг орж ирээд гайхуулж гарлаа...

-Та хоёр тэгээд яасан бэ? гэж д'Артаньян сонирхсонд Мушкетон:

-Бид тэдний үгийг сонсож авсан, тэгээд тэр хоёр гуанзнаас гарч салаад явахаар нь, би хугенотыг, ах католикийг зам дээр нь очиж отсон доо. Хоёр цагийн дараа ажил дуусаж, бид хоёр хэн хэн нь хийх ёстой юмаа хийчихсэн. Тэхдээ хөөрхий эцэг маань болгоомжтойдоо биднийг ингэж хоёр төрлийн шажинтайгаар хүмүүжүүлсэнд бахдаж байсан гэж хариулав.

-Мушкетон, танай эцэг үнэхээр авхаалжтай хүн байсан даг. Чөлөө цагтаа тэр хүн, бусдын газарт ан хийдэг байсан гэсэн байхаа?

-Тиймээ, эрхмээ. Тэгээд манай эцэг л намайг занга тавих, загас барих ажилд сургасан юм. Тэгээд манай буудлын энэ олиггүй эзэн биднийг элбэг их боловч бидний нарийн сайн хоолонд дассан гэдсэнд таарахгүй, хар борчуулд таарах муу хоол өгөөд гарахаар нь би хуучин ажилдаа сэмхэн эргээд орсон юм. Би хун тайжийн ойд зугаалж явахдаа буганы гүйдэл замд занга тавьж, их эзэнтний нуурын захад хэвтэж байхдаа загас барьдаг байсан. Одоо бурхны авралаар, өвчтэй хүн бидэнд чухаг хэрэгтэй шувуу, туулай, загасны мах зэрэг хөнгөн сайн махаар бид дутагдахгүй байна.

-Үгүй дарс яаж аваа вэ? Хэн та нарт дарс авчирч өгдөг юм бэ? Буудлын эзэн үү? гэж д'Артаньян асуув.

-Танд юу гэмээр юм дээ. Тийм ч гэмээр, үгүй ч гэж болох юмаа.

-Юу "Тийм, үгүй," гэж?

-Тэр бидэнд дарс нийлүүлж байгаа үнэн боловч, энэ сайн үйлээ тэр өөрөө мэдэхгүй байгаа юм.

-Мушкетон чи надад тайлбарлаад өг, тантай ингэж ярилцахад сургамжтай байна. -Тэгье, эрхэм ээ, Олон газраар явж, тэр дундаа америк орж үзсэн нэг испани хүнтэй би тэнүүчилж явахдаа дайралдсан юм.

-Энэ тавиур дээр өрөөстэй байгаа лонх америк хоёр ямар холбоотой байдагсан билээ. - Жаахан хүлээж үз, юм бүхний учир цагтаа олдоно, эрхмээ,

-Зөвөө, Мушкетон танд найдаад би дуугүй чагнаа.

-Тэр Испани хүнийг Мексик нутгаар явахад нь дагаж явсан нэг зарц байсан юм. Тэр зарц манай нутгийн хүн байсан болохоор бид хоёр төдхөн сайхан үерхдэг болчихлоо. Түүнээс гадна зан төлөвөөр хүртэл бид төстэй улс байсан. Бид хоёр ан хийхэд адилхан их дуртай, тэр тэгээд пампас пуггийн бүдүүлэг иргэд, жирийн нэг бугуйлаар бар, зэрлэг бух зэрэг аюулт араатан амьтдыг бугуйлдан агнадаг тухай ярьж өгдөг байлаа. Хорь гучин алхам газрын цаанаас бугуйлыг хаа дуртай газраараа оруулж чаддаг болтол тийм сүрхий сурч болмооргүй юм шиг оргиод итгэгдэж өгөхгүй байсан гэтэл удалгүй би үүнд үнэмшихээс аргагүй болсон. Миний найз гучаад алхам газар лонх тавиад бугуйл хаях бүрдээ хүзүүгээр нь оруулчихдаг аж. Би ч мөн шамдан сургууль хийж эхэлсэн тэгээд би уулын жаахан авьяастай төрсөн хүн, одоо ямар ч Мексик хүнээс дутахгүй бугуйл хаядаг юм. Одоо учрыгнь олж байгаа биз дээ? Манай буудлын эзэнд дарсны том зоорь байгаа юм, гэхдээ тэр өөрөө түлхүүрээсээ сална гэж огт байхгүй. Ашгүй зооринд нэг салхивч байдаг, тэр салхивчаар нь би бугуйл шиддэг юм. Сайн дарс хаа байгааг би одоо мэддэг болсон, тэндээс л юм нөөцлөх болсон доо. Ингэхлээр, америк орон, энэ шүүгээсаван дээр байгаа лонхтой ийм холбоотой юмаа, эрхмээ. Одоо тэгээд, эрхэм та манай дарснаас амсаж үзээд, ямар шүү дарс болохыг шударгаар хэлж өгнө үү гэв.

-Гялайлаа, түнш ээ, гай болоход би дөнгөж сая юм идчихээд ирлээ, гэж д'Артаньян хэллээ.

-За яахав, Мушкетон, ширээ зас, чи бид хоёрыг хоол идэж байх зуур, бидний уулзаагүй энэ арав хоногийн дотор юу болсныг д'Артаньян ярьж өгөг гэж Портос хэлсэнд, д'Артаньян хариуд нь:

-Дуртайяа ярьж өгье гэв.

Портос , Мушкетон хоёр, эдгэрч байгаа улс болохоор хоолондоо дуртай, гай зовлонд учирч ижилдэн дассан болохоороо дотно элэгсэг байртай өглөөнийхөө хоолыг идэж байх зуур Арамис хэрхэн шархдаад Кревкертүлдэх болсон, Атос хуурамч мөнгө хийж зарсан ялд унаж Амьенд үлдсэн, д'Артаньян өөрөө англи хүрэхийн тулд арга буюу де Вард гүнгийн гэдсийг хагалахад хүрсэн тухайгаа тэдэнд ярьж өгөв.

д'Артаньян үүнийг яриад л цааш нь амаа татаж, англиас дөрвөн сайхан морь, нэгийг нь өөртөө, бусдыг нь нөхдөдөө авч"ирсэн, мөн Портосынморь буудлын газрын морины саравчинд ирээд байгаа тухай л дуулгаад зогсов. •

Энэ үеэр Планше орж ирээд, морьд амарчихлаа, явж Клермон хүрээд хонож болох юм гэж эзэндээ дуулгав.

д'Артаньян одоо. Портосын хувьд нэгэнт санаа бараг амраад, бусад нөхдөө яасны нь мэдэх гэж яарч байсан болохоор, шархтай нөхрийнхөө гарыг бариад, бусад нөхдөө эрэхээр явлаа гэдгээ хэлэв. Тэхдээ өөрөө мөн энэ замаараа буцаж ирэх, тэгээд нэг долоо хоног хиртэй болоод, Портосыг Гран Сен Мартен буудлаас явчхаагүй байвал аваад явах санаатай байлаа. Портос үүнд булгарсан хөлөөсөө болоод түүнээс нааш лав явж чадахгүй бий гэж хариулав. Түүнээс гадна өөрөө энэ Шантильд байж нөгөө герцог хүнийхээ гэргийгээс хариу хүлээх ёстой гэнэ.

д'Артаньян аятай сайхан хариу авахыг Портост ерөөж түүний төлөө сайн санаа тавьж байхыг Мейдстонд дахин захиад, буудлын эзэнтэй тооцоогоо хийлээ. Ингээд нэг хөтөлгөө мориноосоо салж амарсан Планшетэй цуг цаашаа замдаа гарав.

XXVI. АРАМИС ЦОЛ ХАМГААЛСАН НЬ

Портосын шархадсан болон прокурорын гэргийн талаар дуулсан юмнаасаа д'Артаньян өөрт нь уг цухуйлгасангүй. Манай гаскон залуу хэдий нас бага боловч хашир хүн билээ. Сайрхуу зантай шадар цэргийн ярьсан юм бүхэнд итгэсэн дүр үзүүлэв. Юу гэвэл, хүний нууцыг илчилчих юм бол ялангуяагэр нууц, цаад хүнийг ичээж зовооход хүрэх юм бол ямар ч сайн нөхөрлөл эвдэрдэг гэдгийг мэдэж байжээ. Тэгээд ч амьдралыг нь нарийн сайн мэдэх хүнээс бид өөрсдөө сэтгэл санааны нэг давуу талтай мэт санагддаг билээ. Иймд, цаашдаа хэрэг будлианд оролцох төлөвлөгөөтэй д'Артаньян чухамдаа Атос, Портос, Арамис гурвыг амжилтынхаа зэвсэг болгох санаатайбайсан болохоор, дөрвөн нөхдийгөө барьж байхад дөхөм болох нууц сэжмийг урьдаас олж мэдэж байхаас буцахгүй байв.

Гэхдээ зам зуур д'Артаньян өөрийнхөө үнэнч зүтгэлийг шагнах гэж байсан залуу, сайхан Бонасье авгайн тухай гуниглалд автан шаналж явлаа. Харин гаскон залуу шагналаа алдсанд сэтгэл зовсон юм биш, хөөрхий бүсгүйд нэг их гай учирсан байх гэхээс л ингэж зовж явсан юм гэдгийг бушуухан тайлбарлалчихья.

Тэр бүсгүйг хамба лам өсөлжээ гэдэгт д'Артаньян огтхон ч эргэлзэхгүй байлаа, гэтэл их гэгээнтэн өс авахдаа хир хатуу байдгийг бүхнээр мэддэг. билээ.

д'Артаньян өөрөө чухам яагаад сайд хамбад таалагдсаныг мэдсэнгүй. Уг нь торгон цэргийн даамал де Кавуа гуайг ирэхэд гэртээ байсан бол учрыг нь лав хэлж өгөх байсан бий.

Нэгэн бодолд авгаж явахад зам юу юунаас илүү амархан хорогддог юм. Хүн өөрөө зүүрмэглэж байгаа юм шиг, бодож байгаа бодол нь зүүд шиг болчихдог юм. Ингэж бодолд автаад ирэхийн үед цаг өнгөрөх мэдэгдэхээ болиод, зам богиносох мэт болно. Тэр хүн нэг газраас гараад лярна, нэг л мэдэхэд нөгөө газар хүрээд л ирчихсэн байдаг юм. Замд дайралдсан уул, ус, тал, ой модыг бүрэг бараг багцаалахаас өөр юм санаанд нь тусч үлддэггүй юм. д'Артаньян мөн ингэж бодолд автан, явах хурдыг мориндоо мэдүүлж Шантильиас, Кревкер хүртэлх зуураа долоон мод замыг туулж гарлаа. Тэр тосгонд хүрээд ирэхийн хамтзамд дайралдсан бүхнийг мартчихлаа.

Бүр хүрээд ирчихсэн хойноо д'Артаньян толгой сэгсрээд Арамисыг орхисон гуанзыг үзмэгц ухасхийн хагируулж очоод үүдэн дээр нь зогсов.

Энэ удаа түүнийг буудлын эзэн угтсангүй, эзэгтэй тосож авлаа. Хүний байр байдлыг царайгаар нь гадарлахдаа сайн

д'Артаньян буудлын эзэгтэйн махлаг, хангалуун царайг хараад, ийм цагаан цайлган царайтай бүсгүйхүнийг муу юм хийх бий гэж айх явдалгүй, тэхлээр заль гаргаад хэрэггүй гэж үзээд, - Эзэгтэй гуай, арваад хоногийн өмнө бид энд аргагүй үлдээгээд явсан манай нэг нөхөр яасан бол, та хэлж өгөхгүй юу? гэж д'Артаньян хэлэв.

-Хорин гурав, дөрвөн насны дөлгөөн эелдэг зантай сайхан нуруутай, царайлаг залуу хүн үү?

-Тиймээ, бас мөрөндөө шархтай.

-Тийм, тийм.

-Тэгээд яасан бэ?

-Тэгээд, эрхэм ээ, тэр чинь эндээ л байсаар шүү дээ.

-Тийм бий гэж д'Артаньян дуу алдаад мориноосоо буун харайж, цулбуураа Планшед өгөөд эзэгтэй та миний сэтгэлийг бүр амраалаа. Манай сайн нөхөр Арамис хаа байна? Очье, тэвэрье! Үнэнээ хэлэхэд түүнтэй чинь бушуухан уулзмаар байна шүү гэлээ.

-Уучлал гуйя эрхэм ээ, тэр хүн таныг одоохондоо хүлээж авахаар байгаа болов уу даа. -Яагаад тэр билээ? Түүний өрөөнд бүсгүй хүн байгаа юм гэж үү?

-Бурхан багш минь! Хөөрхий залууг та юу гэлээ гэнэ ээ

-Үгүй, эрхэм ээ, түүний өрөөнд бүсгүй хүн байхгүй.

-Хэн байгаа хэрэг вэ?

-Мондидьегийн хар лам, Амьян дахь йпезунт хуврагуудын хийдийн ширээт лам хоёр байгаа.

д'Артаньян дуу алдаж,

-Өө өршөөлт бурхан минь, хөөрхийгийн бие муудаа юу? гэв.

Үгүй, эрхэм ээ сайн болсон. Харин шархадсны дараа түүнд сүжиг төрж, хувраг болохоор шийдсэн.

-Аа тийм, тэр чинь түр зуур л шадар цэрэг болж яваахүн гэдгийг би мартаад орхиж гэж д'Артаньян дуугарав,.

-Ингэхэд эрхэм та түүнтэй заавал уулзах гэсэн юм биз дээ? ' •

-Уулзалгүй бүр ч горьгүй болжээ.

-Тэгвэл хашаанд баруунтай байгаа шатаар өгсөөд гуравдугаар давхарт, тавдугаар хаалга гэж эзэгтэй заан < өглөө.

д'Артаньян заасан зүг рүү яарч, хуучны буудлын газар үзэгддэг гадаад талыннэг шат байхыг оллоо. Гэвч ирээдүйд сүмийн да лам болох хүний өрөөнд орох гэдэг Армидийн цэцэрлэгт нэвтрэн орохоос хялбаргүй аж. Базен гудманд манаж зогссоноо, олон жилийн турш хүлээсээр байж сая зорьсондоо ойртож яваа хүний ёсоор зоримог нь аргагүй зам хөндөлдөв.

Үнэхээр ч Базен хэзээнээс нааш хувраг хүний зарц болохыг хүсэн мөрөөдсөөр ирсэн болохоор эцсийн эцэст Арамис цэрэг нөмрөгөө тайлж, жанч өмсөх цаг ирэхийг санаандаа дүрслэн бодож явдаг билээ . Тэр цаг мөд ирнэ гэж Арамис өдөр бүр амлаад байдгийн хүчинд Базен тогтон шадар цэрэгт зарцлагдаж байгаа аж. Энэ албанд байвал сүнсээ хөнөөх нүгэл

хураагуузай гэж тэр хэлдэг гэнэ.

Ингээд одоо, Базен жаргалын дээдийг эдэлж байлаа. Байдал төлөвийг бодоод үзэхэд, эзэн нь энэ удаа хэлсэндээ буцалтгүй хүрэх шинжтэй. Арамисын бие махбод сэтгэл санаагаар шаналах нийлж Базен хүссэн ёсоор болоход хүргэсэн юм байж. Бие сэтгэлийн зовлон зэрэг эдэлж байсан Арамис эцэстээ сэтгэл санаагаа шажинд хандуулж амраг бүсгүйгээ гэнэт үгүй болсон, мөн мөрөндөө шарх олсныг дээрээс өгсөн сануулга гэж үзлээ.

Сэтгэл санааны байдал иймэрхүү болоод байсан үед эзний нь сэтгэлийг өдий удаан татаж байсан хорвоогийн алив сонирхолд дахин татан оруулж болох хүн д'Артаньяны хүрч ирдэг, Базенд тун тааламжгүй зүйл байв. Буудлын эзэгтэй нэгэнт илчлээд өгчихсөн хойно Арамисыг өрөөндөө үгүй гэхийн эрх байхгүй зүгээр л юу ч болов оруулахгүй арга эрэхээр хатуу шийдлээ. Ингээд, эзний нь сүнсийг аврах буяны яриа өглөө эхэлсэн, шөнөөс нааш дуусахгүй, үүнд саад болох гэдэг үүнээс цаашгүй бүдүүлэг явдал болно гэж үнэмшүүлэхийг оролдов.

Гэтэл Базен гуайн энэ цэцэн үгийг үл ойшоож, нөхрийнхөө зарцтай тоож маргалдахыг хүсээгүй д'Артаньян түүнийг нэг гараараа зайлуулаад, нөгөө гараараа тавдугаар хаалганы бариулаас татав.

Үүд нээгдээд, д'Артаньян өрөөнд оров.

Арамис элбэг хар хувцас өмсөж дугуй хар овоодой толгой дээрээ тавиад, бөөн ном судар овоолсон гонзгой ширээний ард сууж, баруун гарт нь иезуит нарын сүмийн хар лам зүүн гарт нь мондидьегийн ширээт лам сууж байлаа. Цонхны хөшгийг дутуу нээсэн нь өрөөг ном бясалгахад тохиромжтой бүүдгэр гэрэлтэй болгожээ. Залуу хүний өрөөнд тэр дундаа залуу шадар цэргийн өрөөнд баймаар хорвоогийн алив хэрэгцээт зүйл цөм илбийн аргаар үгүй болчихсон аятай, илд, буу, бүрх малгай, элдэв төрлийн сүлжмэл хатгамал гоёлын зүйл сэлтийг хараад, эзнийхээ сэтгэлийг дахин хорвоогийн зүг эргэчих бий гэж айсан Базен эдгээрийг холхон нуусан бололтой.

Эд бүгдийн оронд, харанхуй буланд байгаа нэг хадаасанд өлгөөтэй байгаа юм тачаалаа дарах гэж биеэ ороолгодог ташууртай адилхан юм шиг д'Артаньянд харагдав.

Үүд онгойх чимээнээр Арамис толгойгоо өргөөд нөхрөө таньсан боловч, сэтгэл санаа нь хорвоогийн хоосон сонирхол сэлтээс даанч хол байсан болохоор, төдий лих юм болсонгүйд, д'Артаньян гайхлаа.

-д'Артаньян найз минь сайн байна уу өөртэй чинь уулзахад надад тун таатай байна гэж шадар цэрэг дуугарав.

-Таныг Арамис мөн гэж би сайн итгэхгүй байгаа боловч мөн баярлаж байна гэж д'Артаньян хариу дуугарав.

-Би биеэрээ мөн байнаа, найз минь! Та юунаас болоодтэгж эргэлзэх болчхов? -Анхандаа би нэг гэлэн хүний өрөөнд ороод ирлээ гэж андуураад, дараа нь таныг энэ эрхмүүдтэй цуг байхыг хараад бие чинь их муудсан юм байх гэж бас нэг андуурлаа гэв. Хар хувцастай хоёр

хүн д'Артаньяны цухуйлгасан үгний учрыг ойлгоод түүний өөдөөс муухай харсан боловч д'Артаньян огт тоосонгүй.

Арамис найз минь, би саад болоогүй биз, үзвэл, та энэ улсад нүглээ наманчилж байх бололтой гэж д'Артаньян хэллээ.

Арамисын царай улайсхийв.

-Надад саад болох гэлээ? Хаанаас тэх вэ, эелдэг сайн нөхөр минь, нээрээ шүү. Ингээд үүний баталгаа болгож. эрүүл энх яваад ирсэнд чинь баярлаж байгаагаа дуулгая гэж Арамис хариулав.

"Арайгэж нэг юм санав бололтой, яахав ээ үүнээс ч доор болж болох билээ" гэж д'Артаньян бодлоо.

Арамис сэтгэл уярсан байртай, хоёр хуврагт д'Артаньяныг зааж,

-Юу гэвэл миний нөхөр саяхан лут их аюулаас эсэн мэнд мултарчээ гэв. Цаад хоёр хувраг д'Артаньянд зэрэг мэхэсхийгээд,

-Эрхэм та бурхны ачийг санажяв гэлээ.

-Өршөөлт багш нар минь, би хэдийнээ бурханд мөргөж залбирсан гээд д'Артаньян хариу мэхэсхийв.

Арамис ярианд оролцож,

-Эелдэг сайн д'Артаньян та тун цагаа олж ирлээ. Бидний маргаанд оролцож мэдлэгээрээ тус болж үз. Амьений сүүлийн хар лам Мондидьегийн ширээний лам, бид гурав, эртнээс нааш бидэнд сонирхолтой байсан бурхны номын зарим асуудлаар ярьж сууна, тэгээд, таны саналыг сонсохсон гэж би их хүсэж байна.

Яриа иймэрхүү чиглэлтэй болж ирсэнд сэтгэл зовсон д'Артаньян,

-Цэргийн хүний санал ямар ч жин байхгүй. Та зүгээр миний үгэнд итгэ, энэ эрхмүүдийн эрдэм мэдлэгт бүрэн найдаж болно гэж хариуллаа.

Хар хувцастай хүн хоёр дахин мэхэсхийв. Арамис үүнд маргаж,

-Үгүй, таны санал их үнэтэй болно. Бидний ярилцаж байгаа зүйл маань ийм юм. Ширээт лам гуай бодохдоо миний цол хамгаалах сэдэв голдуу номлол баримталсан, сургаалын чанартай байх ёстой гэж үзэж байна гэлээ.

-Таны цол хамгаалах сэдэв гэнээ! Та тэгээд цол хамгаалах сэдвээ бичиж байгаа хэрэг үү? гэсэнд, ширээт лам хажуугаас:

-Тэгэлгүйяахав сахил хүртэж шажны мяндаг хэргэмтэй болохоор урьдчилан шалгахад заавал

цол хамгаалах ёстой.

Эхлээд буудлын эзний авгай дараа нь Базений хэлсэн үгэнд итгээгүй байсан д'Артаньян:

-Сахил хүртэх гэнээ! Сахил хүртэх шүү та минь! гэж дуу алдаад, өмнөө сууж байгаа хүмүүсийг гайхан мэлрэв. Арамис түшлэгт сандал дээрээ, язгууртан бүсгүйн гоёмсог танхимд өглөөний хүлээн авалтан дээр байгаа хүн шиг тун янзтай хээнцэр, сууж бүсгүй хүнийх шиг булбагар, цагаан гараа, цусыг нь тараах гэж дээш өргөснөө буулган шохоорхож байгаад,

-Ингэхлээр миний цол хамгаалах сэдэв номлол баримтлал байх ёстой гэж ширээт лам гуайн хэлснийг д'Артаньян та дуулсан, гэтэл надад бол гүн ухааны сэдэв байвалдээр санагдаж байгаа юм. Ингээд Ширээт лам гуай надад үүний өмнө өөр хүн ер авч судлаагүй мөн "Utragic manus in benedicendo clericis interioribus necessaria est" гэдгийг тайлбарлахад үнэхээр өргөн боломжтой сэдэв өгч байгаа юм гэв.

Эрдэм чадлы нь хэмжээг бид сайн мэдэх д'Артаньян саяны иш татсан үгийг, нөгөө де Тревиль гуай, Бекингэмээс өөрийн нь бэлэг авчээ гэж бодоод бэлгийн тухайд иш татсан шүлгийг сонсож байсан шигээ хэнэггүй чагнаж суув.

Арамис нөхөртөө тус болох гэж тайлбарлаж,

-Энэ бол "дорд мяндагтай хуваргууд заавал хоёр гараараа адис тавивал зохино" гэсэн сэдэв юм гэв.

Тун сайхан сэдэв гэж ширээт лам дуу алдана.

Латин хэлийг мөн д'Артаньяны дайтай мэддэг хар лам ширээт ламын амыгдагах гэж сайн ажиж байгаад үг бүрийн нь цуурай шиг давтаж,

-Номлол баримтлалын тун сайхан сэдэв гэнэ.

д'Артаньяны хувьд гэвэл хар хувцаст хоёрын баяр хөөр болохыг ер юман чинээ санасангүй. Арамис мөн ам нийлж,

-Тиймээ сайхан сэдэв. Тун аятайхан, гэхдээ бурхны ном гэгээн хутагт нарын сургаалыг сайн уншихыг шаардсан сэдэв. Гэтэл сүм хийдийн номтой хуврагуудын өмнө би хүлцэнгүйгээр үнэнээ хэлэхэд, шөнийн харуулд гарч, ван эзний албыг хаасаар, эрдэм номоос нэлээд хөндийрчихлөө. Тэхлээр надад, одоо ерөнхийлэхэд амар, шажин номын эдгээр хүнд асуудлын дэргэд, жишээлбэл, гүн ухаан, хувилахуйн ухааны асуудал дотроос зан суртахуун гэдэгтэй адил сэдэв сонгон авбал дээр юмаа гэлээ,

д'Артаньяны залхуу их хүрч, мөн хар лам ч залхаж байлаа.

-Үгүй, бас сүрхий оршил хэлж байнаа хөөш! гэж ширээт лам дуу алдав. Хар лам мөн нэг үг оруулах гэж,

-Оршил гэж давтлаа.

-Огторгуйн уудамд хөвөх адил ерөнхий байх юм бий гэж ширээт лам латинаар хэлэв.

Арамис нөхөр рүүгээ хялам хийвэл, д'Артаньян эрүүгээ заачих шахам эвшээж байгаа харагдав. Иймд, ширээт ламдаа,

-Багш минь франц хэлээр ярилцъя, тэгвэл д'Артаньян гуай бидний яриаг илүү сайн үнэлж чадах байгаа гэв,

д'Артаньян ам нийлж,

-Би зам явж ядарчхаад, энэ латин үгнүүдийг чинь санаж ойлгож нэг чадахгүй оргиод байна гэлээ.

Хар лам дотроо туйлгүй баярлаж, д'Артаньян өөд талархан харлаа.. Ширээт лам жаахан эвгүйрхснээ

-За тэгье, за тэгээд энэ сэдвээр юу нотолж болохыг авч үзье. Бурхан номд зүтгэгч Моисей хоёр мутраар адис тавьдаг... Тэр чинь ердөө л нэг зүтгэгч юм шүү. Еврей нарыг дайснаа хороохын тулд хоёр гараараа барьж бай гэсэн байгаа тэхлээр хоёр гараараа адис тавьсан гэсэн үг түүнээс гадна бурхны номд "Хоёр гараар" гэснээс зүгээр, "гараар" гээгүй байна гэж нотлов.

Хар лам гараа хавсран,

-Хоёр гараар тавь гэсэн гэж давгав.

-Гэтэл Петр гэгээнийг бол харин "хуруугаа сунга" гэсэн байгаа юм. Петр гэгээний төлөөний хүн хорвоод пап лам нар билээ. Тэхлээр ойлгож байгаа биз гэж ширээт лам номлов.

Ярианд шохоорхсон Арамис,

-Тэгэлгүй яахав, эд бүгд тун нарийн юм даа гэж хариуллаа.

Хуруу шүү гэж хар лам давтан хэлээд Петр гэгээн хуруугаараа адислана. Тэхлээр пап богд мөн хуруугаараа адислана. Хэдэн хуруугаар адис тавих вэ?

Эцэг , хүү, ариун санааны нэрээр гурван хуруугаар адис тавина гэв.

Цөм загалмайж залбирсанд д'Артаньян мөн бусдыг дуурайх нь зөв гэж үзлээ.

-Пап богд энд Петр гэгээнийг төлөөлөн суугаа. Гурван ариун зүйлийг шингээсэн хүн. Бусад нь доорд мяндагтай хувраг, Архангель гэгээнд, бурхдын нэрээр адиставина. сүм хийдийн хамгийн дорд мяндагтай гэлэн гэцэл нар тоогүй олон хурууны дүрстэй мутраар адис тавина. Сэдвийг хялбарчлан хэлбэл иймэрхүү л юм даа элдэв, гоёл чимэггүйгээр нотолж байгаа нь энээ. Энэ сэдвийг би үүн шиг хоёр боть ном болгохсон гэж ширээт лам хэлээд, ярианд

улайрсандаа болж, цэцэн сургаалт гэгээн Иоаннагийн лут зузаан судар уруу алгадаад авлаа. Тэр судрын хүндэд ширээ хотойж байв.

д'Артаньяны дотор зарс хийв. Арамис ам нээж,

-Би ч мэдээж хэрэг, энэ сэдвийн сайхныг зөвшөөрч байна, гэхдээ, үнэнийг хэлэхэд, өөрөө дийлхээргүй санагдаж байна.

Би өөр "Бурхан номын төлөө биеэ зориулан өгч байтаа хүнд харамсах сэтгэл төрөх нь зүй" гэсэн сэдэв сонгож авсан гэж хэллээ.

-Боль! энэ сэдэв чинь буруу номтой ойртож байна. Эрт орой нэгэн цагт яргачны гарт түлэгдэж таарах, буруу номтон янсенийн муу номд яг иймэрхүү юм бий. Залуу нөхөр минь болгоомжилж үзээрэй, та буруу номоор орох дөхөж байна. Та өөрийгөө хөнөөх нээ гэж ширээт лам дуу тавив.

Хар лам гуныхрах байртай толгой дохин,

-Та өөрийгөө хөнөөх нээ гэнэ.

-Та, өнөөх шулмын муу шунал болох чөлөөтэй сэтгэхүйн тухай ээдрээтэй асуудлыг хөндөж байна. Та пелачианчүүдийн буруу үзэлтэй шууд нийлээд ирж байна гэж хар лам хэлэв.

Өөрийг нь ийм олон нотолгоогоор буруушаан байгаад гайхасхийсэн Арамис, ' -Үгүй, эрдэмтэн багш минь... гэж юм хэлэх гэтэл хар лам үгийг нь таслан.

-Бурханд биеэ зориулан өгч байгаа хүн, хорвоогийн төлөө харамсах ёстой гэдгийг та яаж нотлох юм бэ? Тэгвэл та, бурхан бол бурхан, ертөнц гэдэг шулам гэсэн номлолыг бод. Хорвоогийн юманд харамсах гэгч шулмын хойноос харамсана гэсэн үг, миний дүгнэлт энэ л байна гэлээ.

Хар лам яг дуурайж,

-Минийх ч мөн адил гэнэ.

-Өршөөж үз хаанаас... гэж Арамис дахиж үг хэлэхийг завдлаа.

-Хөөрхий хүн чи шулмын хойноос харамсаж байна шүү гэж ширээт лам хашхичихад:

-Энэ минь шулмыг харамсаад байдаг. Залуу нөхөр минь, шулмын хойноос бүү харамсаж үз, гуйя танаас гэж. хар лам гаслан хэлэв.

д'Артаньяны ухаан мохоод ирэх шиг, солиотой улс суух газар ирчихсэн, өөрөө мөн төдхөн солиорох ч юм шиг санагдав.

Юун тухай яриа болж байгааг даанч мэдэхгүй болохоор тэр өөрөө аргагүй л дуугүй байхаас өөр замгүй байлаа.

-Гэхдээ миний үгийг сонс л доо гэж Арамис эелдэг боловч жааханунтууцах байртай дуугараад,

-Би харамсаж байна гэж хэлээгүй. Үгүй би хэзээ ч тийм үг хэлэхгүй, юу гэвэл энэ үнэн сүжиг бишрэлтэй нийцэхгүй байхсан...

Ширээт лам гараа тэнгэр өөд өргөхөд, хар лам бас дуурайна. Арамис цаашаа, -Гэхдээ бид зөвхөн өөрсдөө бүрмөсөн ханаж цадсан юмаа л бурханд өргөж байж таарахгүй биз дээ. д'Артаньян, чи хэл л дээ. Миний зөв биш гэж үү гэж хэлсэнд, д, Артаньян

-Зөв байлгүй яах юм, чөтгөр алгад! гэж дуу алдав. Хар лам, ширээт лам хоёр өндөс хийлээ.

-Миний гол баримтлал ийм байна. Хорвоод сайн сайхан юм бий, гэтэл би хорвоог орхиж байна, үүгээр би биеэ золиосонд гаргаж байгаа юм. Номд бүр "Бурхны төлөө биеэ золиосонд гарга" гэж илтэд бичээстэй байдаг шүү дээ гэж Арамис хэллээ.

-Энэ үнээн гэж цаад хоёр хүлээв.

Арамис түрүүн гараа цайлгах гэж өргөсөн шигээ одоо чихээ улайлгах гэж чимхээд-Тэгээд ч бас энэ сэдвээр би нэг шүлэг бичээд, ноднин жил Вуатюр гуайд үзүүлсэн, тэр их хүн надыг тун их магтсан билээ гэв.

-Шүлэг гэнэ шүү! гэж ширээт лам басамжлангуй дуугарахад, хар лам зүгээр дуурайж: -Шүлэг шүү бас! гэнэ.

-Түүнийгээ уншаад орхи, уншаач, тэр чинь бидний уйдааг жаахан гаргахсан байгаа гэж д'Артаньян дуу алдав.

Арамис үүнд, -үгүй, тэр чинь шашны утга учиртай шүлэг шүү. Бурхны номлолыг шүлэглэсэн юм байхгүй юу гэж хариулсанд д'Артаньян,

-Юун чөтгөр шиг юм гэж дуугарав.

Арамис тун даруу боловч, хуурамч байдал нь ялихгүй танигдахаар байртай, ийм л шүлэг лдээ гэж уншив.

д'Артаньян хар лам хоёр шүлгийг ихэд бахдаж, ширээт лам хуучнаараа зөрнө. Бурхны номлолд хорвоогийн хэлбэр байдлыг оруулахаас цээрлэ. Августин гэгээний номд юу гэсэн байдаг билээ. Номчийн үг хуурай ширүүн байг гэсэн байдаг юм гэлээ.

Хар лам үүнд, тийм шүү, номлол ойлгомжтой байхын тулд тэгдэг юм гэв.

Өөрийн нь хань хамсаатан төөрөлдөж эхлэхийг ширээт лам мэдээд,

-Ингэхлээр таны цол хамгаалсан зүйл ердөө бүсгүйчүүдэд л таалагдана, өөр юмгүй. Таны цол хамгаалсан зүйл Патрго гуайн өмгөөлөх үг шиг л амжилт олно доо гэж хэлэв.

Тэх л болтугай бурхан минь гэж Арамис дуртайяа дуугарав.

-За тэр шүү! гэж ширээт лам дуу алдав.

-Хорвоогийн сонирхол танд их, тун их хэвээр байна. Залуу нөхөр минь та одоогоор хорвоогийн хоосноос ангижраагүй байна, ингээд сайн сэтгэл чинь дийлж гарахгүй болов уу гэж миний дотор түгшиж байна гэжээ.

-Эрдэмтэн багш та сэтгэл бүү зов, Би биеэ барьж чаддаг хүн гэж Арамисыг хэлэхэд, ламтан хариуд нь:

-Хорвоогийн хоосон сайрхалт гэнэ.

-Ламтан, би өөрөө өөрийгөө сайн мэднэ, одоо нэгэнт буцалтгүй шийдсэн -Та тэгээд, саяны сэдвээр ажиллана гэж зүтгээд байгаа юм шив?

-Би тухайлан энэ сэдвээр ажиллах авьяастай, өөр юм чадмааргүй санагдана. Тэхээр би ажилласнаараа ажиллаад, маргааш таны заасанчлан засвар хийчихлээр, өөрсдөд чинь таалагдах байгаа гэж найдна гэж Арамис хэлэв.

-Ажиллахдаа онц бүү яараарай, бид өөрийг чинь санал сэтгэл шулуудсан, сайхан байдалтай орхилоо шүү гэж хар лам хэлэхэд ширээт лам өлгөж аваад:

-Тиймээ үржил шимт хөрсөнд бид үр тарьсан болохоор, үрийн хагас, чулуун дээр унаж, замдаа сарниад, үлдсэн хагасыг нь тэнгэрийн шувуу тоншиж орхих бий гэж айх юм бидэнд алга гээд, латинаар нэг юм хэлэв.

д'Артаньян бүр туйлдаж гүйцээд "Чамайг наад латин хэлтэй чинь бушуухан хижиг тахал аваачаасай" гэж бодно. Хар лам ашгүй. Баяртай хүү минь, маргааш уулзъя гэлээ. Ширээт лам бас,

-Зоригт залуу минь баяртай, та сүм хийдийн зул мэт номч гэгээн хүн болох төлөвтэй, Тэгээд, бурхан өршөөж, энэ зул мэт болох хүнийг түймрийн дөл болгохгүй биз ээ гэж хэлэв.

Тэсэж ядсандаа бүтэн цаг хумсаа хэмлэж суусан д'Артаньян одоо хуруугаа хазалжгарав. Хар хувцастай хоёр хүн босож, Арамис, д'Артаньян хоёрт мэхэсхийгээд, үүд рүү чиглэв.

Цаг үргэлж үүдний цаана чагнан зогсож, энэ бүх номын маргааныг сонсоод, бишрэн хөөрч байсан Базен лам нарын гараас судар номыг тосон ирж аваад зам заан түрүүлж явлаа. Арамис тэднийг гаргаж өгөхдөө шатаар доош буусан боловч, даруй эргэж, мансуурчхаад сууж байсан д'Артаньян дээр ирэв.

Хоёулхнаа үлдсэн хойно, хоёр нөхөд эвгүйцэн жаал дуугүй суулаа. Хэн нэг нь яриа үүсгэх учиртай болчхоод д'Артаньян нөхрийнхөө амыг хараад байх бололтой тул Арамис ам нээж: - За ингээд, би эртнээс бодож санаж явдаг юмандаа эргэж орлоо гэв.

-Тэгжээ, сая энэ эрхмийн хэлсэнчлэнтанд ариун сэтгэл төрөө шив, гэж д'Артаньян хариу

дуугарав.

-Хорвоогоос холдох сэтгэл над аль эрт төрсөн юм, энэ тухай та надаас мөн олон удаа дуулсан, тийм биз, найз минь?

-Тэгсээн, гэхдээ, үнэнийг хэлэхэд, таныг тоглож л байгаа юм бодож байсан. -Тийм юмаар тоглох гэж үү? Хаанаас даа д'Артаньян.

-Золиг гэж! Үхлээр бид тоглож л байдаг шүү дээ,

-Уул нь дэмий юм байгаа юм шүү д'Артаньян. Үхэл гэдэг чинь, диваажинд юм уу, тамд орох хаалгыг нээж байгаа юм.

-Тийм байж, гэсэн ч Арамис минь, бурхны сургаалын тухай маргахаа больё бурхан минь. Таны хүртсэн хишиг чинь миний бодоход, өнөөдөртөөтанд, хүрэлцээтэй байх бий. Миний хувьд гэвэл, би сурсан хэд гурван латин үгээ мартаж орхисон, ер нь урьд мэдэж ч байгаагүй, түүнээс гадна танд үнэнээ хэлэхэд, өглөө арван цагаас аваад юм идээгүй өлсөөд хариу алга гэж д'Артаньян хэлэв.

-Эелдэг аашт нөхөр минь, бид одоо хоол иднэ, харин өнөөдөр баасан гариг гэдгийг бүү мартаарай, энэ өдөр би мах идэх байтугай бараагий нь ч харахыг зүрхэлдэггүй юм. Та миний хоолоор болно гэвэл, яахав чанасан ногоо, жимс л байна даа гэж Арамис хариуллаа.

-Таны тэр чанасан ногоо гэж юуг хэлдэг юм бэ? гэж д'Артаньян сэтгэл зовж асуусанд Арамис:

Хольсон ногоог хэлж байгаа юм. Гэхдээ танд би өндөг нэмэрлэж өгнө. Чухамдаа үүгээр журмыг сүрхий зөрчиж байгаа хэрэг, юу гэвэл өндөг дэгдээхэй болдог болохоор үнэндээ мах юм гэв.

-Онцын сайхан найр биш бололтой гэхдээ тантай цуг болохоор тэгье дээ гэж д'Артаньян зөвшөөрөв.

-Таныг ийнхүү биеэ тэвчсэнд баярлалаа. Үүгээр таны биенд тус болохгүй юмаа гэхэд, сүнсэнд чинь тустай буян болно гэж Арамис хэллээ.

-Ингээд Арамис та хувраг болж шийдлээ юм бий дээ? Манай нөхөд юу гэх бол? Де Тревиль гуай юу гэх юм? тэр таныг урвагч гэж үзнэ дээ, эртхэн самнуулчихья.

-Би хувраг болж байгаа биш, хуучин байсан, одоо эргээд очиж байгаа хэрэг. Хэрэв би урвагч юмаа гэвэл, хоосон хорвоогийн төлөө шашныг хаяж орхисон болохоор шашинд л урвасан юм шүү. Шадар цэргийн хувцас өмсөх гэж би биеэ хавчсаныг та мэднэ шүү дээ?

-Үгүй би юм мэдэхгүй шүү.

-Юу болоод, би шашны сургуулиа хаяхболсныг та дуулаагүй юу?

-Ер дуулаагүй,

-Надад ийм явдал учирсан юм. Номд хүртэл, "нэг нэгэндээ нүглээ наманчил" гэж бичсэн байдаг юм, тэхлээр д'Артаньян танд би нүглээ наминчлая.

-Аа би нүглийг чинь урьдаас цагаатгаж байна, мөн ч сайхан сэтгэлтэй хүн байгаа биз? - Бурхны ариун юмаар бүү тогло, найз минь.

-За, за ярь, би дуулья гэж д'Артаньян хэлэв.

-Би есөн наснаасаа аван шажны сургуульд ном сурсан хүн. Тэгээд би хорь хүрэхэд гуравхан хоног дутуу, гурав хоноод ширээт лам болж, хамаг хэрэг шувтрах ёстой байлаа. Нэг орой би очих дуртай нэг айлдаа очиж цаг өнгөрөөж байв. Яая гэх вэ, нас залуу, сул дорой байсан цаг. Гэрийн эзэгтэйд намайг бурхны юм уншиж байхыг атаархан хардаг байсан нэг цэргийн дарга гэнэт зөвшөөрөл гуйлгүй ороод ирлээ. Яг тэр орой би Юдифийн түүхээс нэг явдал орчуулж яриад, цуг байсан бүсгүйдээ шүлэг уншиж өгсөнд, бүсгүй намайг их магтаж, миний мөрөн дээр толгойгоо тавьчаад, тэр шүлгийг надтай цуг уншиж байсан юм.. Энэ үнэндээ ч жаал задгайдуу суудал даргын сэтгэлд таалагдсангүй бололтой гэвч юм дуугарсангүй харин намайг гарахад дагаж гарав.

Намайг гүйцэж ирээд "ламба гуай, та бэрээдүүлэхдээ дуртай юу?" гэж тэр хүн надаас асуув. "Эрхэм ээ, өнөө хүртэл хэн ч намайг саваадаж зүрхлээгүй болохоор таны энэ асуултад би хариулж чадахгүй нь" гэж хариулав.

"За тэгвэл ламба гуай та дуулж бай, өнөөдөр надтай дайралдсан айлдаа дахин ирэх болж гэм би зүрхлээд саваадна шүү" гэлээ.

Би айчихсан байхаа, царай минь хувхай цайж, өвдөг нугарчих гээд, хариу хэлэх гэсэн, хэлэх юм олсонгүй, дуугүй өнгөрлөө.

Дарга надаас хариу хүлээж байснаа намайг дуугүй байхлаар тас тас хөхрөөд, эргэжнөгөө айл руу орчихлоо. Би сургууль дээрээ эргэж ирлээ.

"Би жинхэнэ тайж хүн, миний түргэн зантайг д'Артаньян та мэднэ. Намайг тун хүндээр доромжиллоо, тэгж доромжлуулсны минь хүн мэдэхгүй ч гэсэн сэтгэлд тунаж үлдээд шаналгаж байв. Номтой багш нарт би мяндаг тушаал авахаар болж чадаагүй юм байна гэж хэлээд, сахил хүртээх ёслолыг миний хүсэлт ёсоор нэг жил хойшлуулав.

Парис хотын илдний сургууль заадаг тэргүүний багш дээр би очоод өдөр бүр сургууль заалгахаар хэлэлцэж тохироод, нэг жил заалгалаа. Дараа нь доромжлуулсан өдрөөс хойш жил болсон ойн өдөр би хувраг хувцсаа хадаасанд өлгөж, тайж хүний хувцаславал зохихоор хувцаслаад, танил нэгэн бүсгүйн найр наадам дээр очихоор явлаа. Миний өст хүн мөн тэнд байх учиртай байв. Тэднийх форс гяндангийн хавьд, Франбуржда гудамжинд байсан юм".

Дарга үнэхээр ч тэр айлд байлаа. Түүнийг нэгэн бүсгүй руу урсгал харцаар ширтэж, дурлалын дуу аялж байхад нь дөхөж очоод хоёрдугаар бадгийн дунд тасалж зогсоов?!

"Эрхэм ээ, та намайг Пайен гудамжинд байдаг нөгөө байшинд очвол бас л хорих уу? Таны үгнээс гажвал намайг саваадах санаатай хэвээр байгаа болов уу?" гэж би түүнээс асуув.

Дарга миний өөдөөс гайхан харж байснаа:

"Танд юу хэрэгтэй юм бэ, эрхэм ээ? таныг би танихгүй юм" гэж тэр эцэстээ дуугарав. "Би нөгөө бурхны ном уншиж, Юдифийг шүлгээр орчуулдаг залуухан лам шүү дээ".

"Аа тийм, одоосанаанд орлоо гэж дарга дооглонгуй инээгээд танд юу хэрэгтэй юм бэ?" гэж асуув.

"Тантай цуг зугаалах хэрэг надад байна".

"Танд тийм чухаг хэрэг байгаа юм бол маргааш өглөө, дуртайяа хамт зугаалъя". "Үгүй маргааш өглөө биш, одоо".

"Та заавал гэж шаардаад байгаа юм, бол..."

"Тиймээ, шаардаж байна".

"За тэгвэлявья гэснээ цаад бүсгүйдээ хандаж Авхайтнууд бүү санаа зов. Би дөнгөж энэ эрхмийг алчхаж ирээд, та бүхэнд сүүлчийн бадгийг нь дуулж өгнөө" гэв.

Ингээд бид цуг гарлаа. Түүнийг би Пайен гудамжнаа, нэгэн жилийн өмнө над өнөөх эелдэг үгээ хэлсэн тэр газарт аваачив, сартай сайхан шөнө байлаа. Бид "илдээ сугалж, анхны дайралтад л түүнийг би дор нь алчихлаа" гэж ярилаа.

д'Артаньян:

-Чөтгөр алгад! гэж дуу алдав. Арамис яриагаа үргэлжлүүлэн,

-Дуучин нь бүсгүйчүүл дээрээ эргэн ирээгүй, мөн Пайен гудамжнаа түүний илдэнд нэвт бүлүүлсэн хүүрийг олсон болохоор миний хийсэн хэрэг гэж цөм ойлгоод, бөөн шуугиан дэгдээв. Үүний улмаас би хувраг хувцаснаас түр хагацахад хүрсэнийм. Тэр үеэр танилцсан Атос, мөн илдний сургуулийн хажуугаар хэд хэдэн сайн арга зааж сургасан Портоос хоёр намайг шадар цэрэг болох хүсэлт гарга гэж ятгасан юм. Аппрасыг бүсэлж байх үед нас барсан миний эцэгт ван эзэн их сайн байсан болохоор намайг шадар цэрэг болгосон билээ. Одоо тэгээд сүм хийдийн ариун хүрээнд эргэж орох цаг надад ирснийг та өөрөө ойлгож байгаа шүү дээ гэж хэллээ.

-Аа яагаад урьд нь болоогүй, бас хойшлуулж болохгүй заавал одоо гээд байгаа юм бэ? Танд юу учирсан юм бэ? Юунаас болж танд ийм эвгүй сэтгэлэг төрөөд байгаа юм? гэж асуухад. Арамис:

-д'Артаньян минь, энэ шарх надад дээрээс өгсөн санамж боллоо гэв.

-Энэ шарх ий? Юун дэмий уг вэ? тэр чинь бараг эдгэрчхээд байна, тэгээд ч та одоо энэ

шархнаас болж их шаналаад байгаа юм биш гэдгийг би лав мэдэж байна гэсэнд

Арамисын царай улайгаад,

-Өөр юунаас шаналлаа гэж? гэж асуув.

-Арамис та, саяхан шиг, бүсгүй хүнээс бүрайхавтар шаналгаатай сэтгэлийн шарх олсон байна.

Арамисын нүд өөрийн эрхгүй гялалзан сэтгэл хөдөлснөө хайхрамжгүй байдлаар нууж,

-Боль доо тийм юмны тухай яриад байх юу байхав. Би тэгээд янаг сэтгэлийн зовлонд орж гутарч байх гэж үү? Хоосон сүржигнэсэн хэрэг. Таны санахад би солиорчхоо юу, хэний төлөө тэр вэ, та минь? Хуаранд байхдаа хөөцөлдөж байсан нэг завхай бүсгүй юмуу, шивэгчний төлөө юу?.. Ямар булай хэрэг вэ гэж мэтгэлээ.

Уучлаарай, Арамис минь, та чинь арай дээгүүр санаархаж байсан шиг санагдах юм.

-Дээгүүр гэнээ! Би хэн болоод тийм дээгүүр санаа гаргах юм бэ? Би чинь хөрөнгө хогшилгүй, бусдын эрхэнд байх дургүй, ихэс дээдсийн дунд ороод аягүйрхдэг, эгэл нэг шадар цэрэг шүү дээ.

д'Артаньян нөхөр рүүгээ үл итгэх байртай хараад, -Ээ Арамис, Арамис! гэж дуугарав. Арамисын царай барайж:

-Бие гэгч хоосон, буцаад хоосон болно. Амьдрал гэдэг гутрал зовлонгоор дүүрэн, амьдралыг аз жаргалтай холбож байгаа хамаг утас шөрмөс бүхэн, юуны өмнө алтан утас бүр хүний гарт тасардаг юм. Ээ, хөөрхий, д'Артаньян найз минь, миний үгийг дуулж бай, зовлонтой болох цагтаа хүнээс зовлонгоо нууж бай. Дуугүй байх гэдэг чинь зовлонтой хүмүүсийн сэтгэлээ тэжээх эцсийн зүйл мөн. Шархадсан бугын цусыг ялаа шавж уудаг шиг, юманд дуртай улс бидний нулимсыг уудаг юм гэж гутрангуй дуугарав. д'Артаньян мөн гүнээ санаа алдаад,

-Чухмаа, Арамис найз минь та минийявдлыг л надад яриад байна гэв. -Юу?

-Тиймээ? Дөнгөж сая чиний хайрлаж, ухаангүй сайн байсан бүсгүйг хулгайлаад авчихсан. Түүний хаана байгаа, хаашаа аваачсан, шоронд байгаа юм уу, амь алдсан юм уу, алиныг ч мэдэхгүй байна.

-Гэхдээ, тэр бүсгүй таныг хаях гэж хаяагүй, хүчинд авгаж орхисон гэж сэтгэл зогоох юм тандбайна. Тэр бүсгүйгээс сураг чимээ байхгүй байгаа бол яахав захиа бичихийг хориглосон болохоор тэр биз. Гэтэл харин...

-Харин юу гэж?

-Үгүй зүгээр гээд Арамис цаашаа юм дуугарсангүй.

-Ингэхлээр та, хувраг болохоор санаа шулуудаа бий дээ?

-Бур шулуудсан: Өнөөдрийн хувьд та миний нөхөр, маргааш болоход надад зүгээр нэг хоосон сүүдэр шиг юм уу, ор үгүйтэй адил санагдах болно. Хорвоо гэдэг чинь ердөө л авс юм шүү.

-Ээ, солиг! таны ярьж байгаа юм ер, хаашаа уйтгартай юм бэ.

-Яая гэх вэ? Миний тавилан намайг хөтлөн дээш хөөргөж байна гэхэд д'Артаньян инээмсэглээд, хариу юм дуугарсангүй.

Арамис яриагаа залган,

-Хэдий тийм боловч, одоогоор би хорвоод байгаа болохоор таны тухай, нөхдийнхөө тухай ярилцмаар байна гэлээ.

д'Артаньян үүнд,

-Өөрийн чинь тухай өөртэй чинь яримаар юм байвч, та хорвоогийн алив хоосноос хэт холдчихож дэг. Хайр сэтгэлийг та жигшиж үздэг, нөхөд чинь танд хий сүүдэр, хорвоо авс

болчихсон юм байна гэв.

Арамис яая гэх вэ, үүнийг та мөд үзэж үнэмших болно гээд гүнээ санаа алдав.

-За тэгвэл, энэ тухай ярихаа больё, тэгээд, таны нөгөө завхай хүүхний юм уу, эсвэл шивэгчний чинь сэтгэл хувирсан тухай дахин дуулгаж байж таарах нэг захиаг түлчихье, гэж д'Артаньян хэлэв.

Арамис сэргэн

-Юунзахаа вэ? гэж дуу алдав.

-Таны үгүйд танайд ирсэн байгаад, намайг өөрт чинь хүргэж өг гэсэн захидал. -Хэнээс ирсэн захидал бэ?

-Хэн мэдэх вэ. Нэг гуныж гутсан завхай бүсгүй юм уу, аль де Шеврез авгайн шивэгчнээс ч байж магад. Эзэгтэйгээ цуг Тур хот руу буцаж харихад хүрсэн, тэр шивэгчин сүр бадруулахын тулд анхилуун үнэр шингэсэн сайн цаасан дээр захиагаа бичээд, Герцогийн тамгаар тамгалчихсан байна билээ. Өө солиг гэж, би түүний чинь хаяад орхисон бололтой гээд д'Артаньян захиа эрсэн дүр үзүүлж, залирхуу дуугараад, хорвоо гэгч авс, хүмүүс, тэхлээр бүсгүйчүүд мөн хоосон сүүдэр, хайр сэтгэл гэгч таны хэлдгээр "яасан шившгийн юм" гэдэг чинь аз байна гэв.

Үүнд Арамис сандарч,

-д'Артаньян. д'Артаньян чи намайг сүйд хийж байна шүү гэнэ.

-Аа ашгүй энэ байх шив гэж, д'Артаньян дуугараад захидал гаргаж ирэв.

Арамис босон харайж, захидлыг шүүрч аваад шунахайран уншиж орхиод, царай нь гийж ирлээ. -Шивэгчин бүсгүй аятайхан бичдэг хүн шив гэж д,Артаньян хааш хэрэг дуугарав. Хөөрч гүйцсэн Арамис дуу алдан,

-Гялайлаа, д'Артаньян. Тэр маань Тур рүүгээ буцсан юм байна. Түүний сэтгэл хувираагүй, хуучнаараа надад сайн байгаа юм байна. Найз минь нааш ир, нааш ир, миний магнай тэнийлээ найзыгаа тэвэрье гэнэ.

Ингээд хоёр найз цэцэн Иоанна багшийн зузаан судрыг тойрчшалан дээр унасан цол хамгаалах сэдвийн хуудсуудыг зоригтойёо гишигчин бүжиглэж гарав.

Энэ үеэр чанасан ногоо, өндөг барьсан Базен орж ирлээ.

Арамис алчуураа түүний нүүр рүү чулуудаад,

; -Ирсэн газар руугаа бушуу түргэн очиж наад муухай ногоо, өндгөө аваачиж өг. Туулайн мах амталсан шувууны тарган мах, хонины махаар хийсэн халуун хоол сармистай, дөрвөншил сайн бургунд дарсны хамт авчир, гүйгээрэй гэв.

Эзнийхээ өөдөөс ширтээд, зан ааш нь ингэж хувирсны учрыг олохгүй байсан Базен бухимдахдаа өндгөө чанасан ногоон дотроо чанасан ногоогоо шалан дээр унагаж орхив.

-Та хаадын хаанд сэтгэлээ зориулан өгч, түүний таалалд нийцүүлье, гэвэл хамгийн тохиромжтой цаг чинь л энэ байна даа, гээд д'Артаньян латинаар иш татав.

-Таныг наад латин хэлтэй чинь хамт чөтгөр алгад. д'Артаньян найз минь, дарс ууя, чөтгөр алгад сайн гэгч уучихья, та тэгээд тэнд юу болж байгааг цөм надад дуулга гэж Арамис

хэллээ.

XXVII. АТОСЫН ЭХНЭР

Өөрсдийгөө нийслэл хотоос мордсон цагаас хойш тэнд болсон хамаг сониныг баяр хөөр болсон Арамист ярьж өгөөд, мөн сайхан хоол идэж, нэг нь ядарснаа, нөгөө нь цол хамгаалах тухайгаа мартсан хойно д'Артаньян.

-Одоо Атос юу болсныг л мэдэх үлдээд байна гэв.

-Түүнд муу юм учирсан байж мэднэ гэж та бодож байна гэж үү? Атос сэхээ самбаатай, эр зоригтой, илдэд гарамгай хүн шүү дээ гэж Арамис хэлэв.

-Тиймээ, энэ ч яриагүй үнэн. Атосын эр зориг авхаалж хоёрыг би хэнээс ч илүү өндөр үнэлдэг хүн. Гэхдээ миний санахад саваа барьсан хүнтэй илд зөрүүлсэнд орохноо жад барьсан хүнтэй зөрүүлсэн нь дээр санагддаг юм. Борчуул Атосыг жанчиж орхио болов уу гэж айх юм, тэд чинь зодолдохдоо сайн, мөд болихоо мэддэггүй улс юм шүү. Үнэнээ хэлэхэд аль болох хурдан мордохсон гээд байгаа учир энэ гэж д'Артаньяныг хэлэхэд Арамис мөн:

-Морь унаад явж нэг л чадмааргүй оргиод байна, гэлээ ч би цуг явах гэж оролдоодүзье. Өчигдөр би тэр байж байгаа ташуураар өөрийгөө ороолгох гэсэн боловч, шарх өвдөөд тэр буянт үйлд саад болсон гэв.

-Яагаад гэвэл найз минь, буун сумны шархыг ташуурдаж эдгээхээр оролдсон хүн өнөө хүртэл байгаагүй болоод тэр шүү дээ. Яахав та өвчтэй байсан, өвчин гэдэг хүний оюун ухааныг мохоодог, тэхлээр би өөрийг чинь уучилж байна гэж д'Артаньян хэллээ.

-Та тэгээд хэдийд мордох юм бэ?

-Маргааш үүрээр, шөнө сайн унтахыг хичээ. Маргааш тэгээд чадвал цуг явья.

-За тэгвэл сайхан нойрсоорой, та хэдий төмөр мэт биетэй хүн боловч, унтаж амрах хэрэг бас байдаг юм байгаа биз гэж Арамис хэлэв.

Маргааш өглөө нь д'Артаньян Арамисын өрөөнд ороход, Арамис цонхны дэргэд зогсож байв.

-Та юу хараа вэ? гэж д'Артаньян асуулаа.

-Энэ агтач улсын барьж байгаа гурван сайхан морийг шохоорхож байна. Хун тайж хүн л ийм сайхан морь унаж цэнгэх хувьтай байдаг байх гэв.

-Тийм бол Арамис та тэгж цэнгэж болно, юу гэвэл эдний нэг нь таны морь билээ. . -Үгүй байгаа! Аль нь тэр вэ?

-Та аль дуртайгаа л ав. Надад алин нь ч ялгаагүй.

-Тохоостой байгаа сайхан эмээл мөн минийх үү?

-Тиймээ.

-д'Артаньян та надаар тоглоом хийж байна шүү.

-Таныг франц хэлээр ярих болсноос хойш би тоглоом хийхээ больсон шүү.

-Тэр гар бууны алталсан гэр, хамба хилэн олонцог, мөнгөн тоногтой эмээл сэлт цөм минийх юм бий дээ?

-Таныхаа. Тэр туурайгаараа газар цавчиж байгаа морь минийх, тэр толгой хаялаад байгаа морь Атосынх.

-Чөтгөр алгад, гурвуулаа сайхан амьтад юмаа.

-Эд таны сэтгэлд тохирч байгаад би баярлаж байна.

-Энэ янз нь ван эзэн танд ийм билэг өгчээ дээ?

-Юу ч болсон хамба ламынх биш. Ер энэ морьд хаанаас гараад ирчихсэнийг гайхаад яахав нэг нь таных гэдгийг л санаж ав.

-Би, зарцын бариад байгаа хонгор зүстэй тэр морийг авлаа гэж Арамис хэлэв. -Тэг, тэг.

-Бурхан минь, үүнээс чинь болж, миний өвчин арилаад орхих шиг болоо хөөш! Ийм морин дээр, биендээ би гучин сум тусчихаад байхад ч гэсэн мордохсон. Үгүй ямар сайхан дөрөө вэ! Хөөе, Базен чи бушуухан наашаа яваад ир! гэж Арамис дуу алдав.

Нойрноосоо сайн сэрээгүй, гутаж гуньсан царайтай Базен босгон дээр ирж зогсов. -Миний илдийг өнгөл, малгай сэлтийг янзал, хувцас. цэвэрлэ, гар буугий минь сумла гэж Арамис тушаалаа.

д'Артаньян хажуугаас нь, сүүлчийн үг чинь илүүднэ, юу гэвэл таныэмээлэнд байгаа гэрэн дотор сумласан гар буу бий гэв.

Базен санаа алдана.

-Боль доо. Базен, тайтгарч үз. Аль ч язгуурын хүн диваажинд төрж болно шүү дээ гэж д'Артаньян хэлэв.

Базен уйлах дөхөж, манай эзэн бурхны номд өдий их сайн хүн, ингээд явсан бол даа лам, тэр ч байтугай хамба болж болох хүн билээ' гэж үглэнэ.

-Базен чи сонсож бай, миний үгийг сайн эргэцүүлээд хариу хэлээрэй. Хувраг хүн болоод яах юм бэ? Энэ чинь дайтахаас аварч чадахгүй шүү дээ. Чи хараад байгаарай анхны аян дайн болоход л хамба ламтан дуулга өмсөж бамбай бариад оролцох бий. Ногаре Де Лавалет гуайг аваад үз, бас лхамба хүн, шархыг нь хэдэн удаа боосныг чи зарцаас нь асуугаад үзээрэй, гэж д'Артаньян ятгав.

-Тиймээ, хорвоо одоо эргэлдэн урвалдаад хөлөөрөө толгой хийчхээд байгааг би мэднээ,

эрхмээ гэж Базен санаа алдана.

Хоёр залуу, хөөрхий зарцынхаа хамт юм ярьсаар шатаар доошоо буув.

-Алив Базен миний дөрөө түшиж бай гэж Арамис хэлэв.

Тэгээд, төрөлхийн хээнцэр, хөнгөн байдлаараа мориндоо үсрэн мордов. Сайхан мориороо хэд тойрч жаахан явж үзтэл, шарх нь тэсэхийн эрхгүй их өвдсөнд Арамисын царай цайраад эмээл дээрээ ганхаж ирэв. Ийм болж магад гээд нүд салгалгүй харж байсан д'Артаньян ухас хийж очоод түшин авч өрөөнд нь оруулав.

-За ингэхлээр сайн санаат Арамис чи биеэ жаахан сувилж үз, би ганцаараа явж Атосыг эрье гэж д'Артаньян хэлэв. Арамис үүнд, та чухам хүрлээр цуггасан биетэй хүн юмаа гэж хариу дуугарлаа.

-Би жаахан өлзийтэй л байна өөр юмгүй. Намайг үгүй хоорондуур та юу хийж байх вэ, хэлээч? мутраар адис тавих, энэ тэр элдвийн юм номчирхож бясалгахгүй биз, аа? гэхэд Арамис инээмсэглээд:

-Би шүлэг бичнэ гэв.

-Тэг, тэг, Де Шеврез авгайн шивэгчний зурвас шиг анхилсан хээнцэр дэгжин шүлэг бич. Базенийг мөн шүлэг зохиолгож сурга, сэтгэлийг нь тайтгаруулах биз. Морины хувьд гэвэл, өдөрт бага багаар яваад байвал мөд дасах байлгүй.

Арамис үүнд бүү санаа зов, таныг буцаад ирэхийн цагт би хамт явахтай болоод байна гэлээ. Ингээд тэд салж д'Артаньян нөхрөө буудлын эзэгтэй Базен хоёрт урьдчилан захиад, хэдхэн минутын дараа Амьен орох замаар хатирч явлаа.

Атос ямар шүү байдалтай байх бол, ер амьд уулзах болов уу, үгүй юу?

Атосыг өөрөө тун хүнд байдалтай орхисон болохоор үхчихсэн ч байж магад юм. Ийм бодол төрж д'Артаньян дотор харлаад хэд дахин санаа алдаж, өшөө авахаар тангараглав.

Нөхдийн нь дотроос Атос хамгийн ахмад нь болохоор, зан ааш төрх байдлаар д'Артаньянтай хамгийн бага төстэй байх учиртай билээ. Тэгсэн хир нь д'Артаньян түүнд бусдаасилтэд дотно байдагсан, Атосын гадаад төрх байдал төв, хээнцэр өөрөө хэдий даруу байхыг ямагт хичээвч, өгөөмөр ариун сэтгэл нь үе үе хурцаар тодрон харагдана. Хэзээд нэгэн хэв сайхан ааштай байдаг болохоор, үерхэн явахад хамгаас таатай, мөн үг хэл хурц, наргиантай эр билээ. Атос өөрөө гойд их самбаа сэхээтэй бишсэн болж гэм, түүнийхатан зоригийг муйхарлал гэж болохоор билээ. Энэ бүх чанар нийлж д'Артаньянд хүндлэхээс илүү нөхөрсөг сайн байхаас давуу, нөхрөөрөө бахдах сэтгэл төрүүлдэг байв.

Ордны бараа бологч төв, хээнцэр Де Тревиль гуайтай цуг байхдаа хүртэл Атос хийморьлог цагтаа ер дутуугүй харагддаг билээ. Дунд хир нуруутай бие бялдар гойд сайхан зохицсон Атос, тэнхээ ихтэйгээрээ шадар цэргүүдийн дунд нэр цууд гарсан Портостой барилдаад, тэр

аварга эрийг хэд хэдэн удаа дийлж байсан юм. Атосын нүд хурц хамар шулуун, дэгжин эрүүтэй, нүдэнд дулаахан царайнд эрмэг хүч, элэгсэг найртай байдал харагдана. Өөрөө огт хайхарч үзлэггүй гарыг нь хараад, гараа элдэв үнэрт саван, ус, тос сэлтээр байнга янзалдаг Арамис атаархаад сүйд болдогсон. Атосын дуу бүдүүн мөртөө уян сайхан... Гэхдээ ямагт хүний нүдэнд тусахгүйг хичээж, эгэл жирийн байртай байхыг хичээдэг. Атост байдаг гоц гойдын нэг юм гэвэл, түүний алхам бүрд сайн хүмүүжсэн байдал аяндаа илэрч, хамгийн өндөр дээд, хүмүүсийн зан заншлыг хүртэл нэвгэрхий мэддэг байлаа.

Хүн дайлах хэрэг болж гэхэд Атос үүнийг ямар ч ихэс дээдсээс дутуугүй сайн зохиож, хүн бүрийг угсаа гарал, өөрийн нь хир байдалд яв цав тохирсон суудалд хуваарилан суулгаж чаддагсан. Сүлд тэмдгийн тухай яриа гарчээ гэхэд, Атос улсын доторх бүх томоохон тайж нарын сүлд тэмдгийн учир, гарал үүсэл, түүний гэр, түүний гэр бүлийн садан сүлбээ сэлтийг цөм мэддэг байлаа. Ёс горимын өчүүхэн жижигасуудлыг хүртэл Атос ер андахгүй жишээ нь ихээхэн газрын өмчтөн ямар эрх эдэлдгийг сайн мэднэ, мөн нохойтой, шонхортой ан хийхийг бас сүрхий сайн мэддэг, нэг өдөр, ангийн талын юмыг нэртэй сайн мэддэг XIV Людовик вантай энэ тухай ярилцаад гайхагдаж байсан удаа ч бий.

Тэр цагийн бүх өндөр язгууртан хүмүүсийн нэгэн адил Атосилд, морь хоёрт гарамгай билээ. Үүнээс гадна, Атосын боловсролын хүрээ тун өргөн тэр цагийн тайж нар тун ховор судалдаг байсан шинжлэх ухааны мэдлэгээр хүртэл сүрхий, Арамисын гайхуулж, Портосын ойлгож байгаа дүр үзүүлдэг латин үгийг сонсоод Атос зүгээр инээмсэглэж суудагсан. Хоёр гурван удаа Арамис дүрмийн алдаа гаргасанд Атос, үйл үгий нь зохих цагнэр үгий нь зохих тийн ялгалаар нь хэлэн засаж өгсөнд нь их гайхсан билээ. Эцэст нь хэлэхэд эр цэргийн хүн шажин шүтлэг, шударга журмыг, амраг сэтгэлтэн ичгүүр сонжуураа амархан худалдах болсон, мөн ядуучуул бурхны номлолыг юман чинээ бодохоо больсон манай үеийн гүн гэхэд Атос чухамхүү өөгүй шударга нэг үгээр хэлэхэд тун гойд хүн байв.

Гэтэл энэ нандин сайхан ааш зан, хурц оюун билэг, бүхий сайхан хүн; насан буурай болоод, өтлөхийн эрхшээлд автахын адил хар бор ахуй амьдралын эрхшээлд аажмаар авган байгаа нь ажиглагддаг байв. Атост ая муутай байх цаг олон дайралддаг, тэр үед хамаг гэрэлтэй сайхан юм нь бүдгэрч нандин сайн чанар нь нуугдан, өтгөн манан бүрхээд орхих аятай болчихноо.

Бурхан шиг сайхан нь үгүй болоод, дөнгөж л нэг хүн гэгдэх төдий юм үлдэнэ. Толгойгоо унжуулж, хаа нэг үг дуртай дургүй дуугараад нэг бол лонх, аяга юм уу, эсвэл Гримо руу харж удтал гөлрөн сууна. Эзнийхээ гөлийсөн харцаар, алив хүслий нь тааварлан гадарлаж сурсан Гримо юу хүссэний нь даруй гүйцэтгэнэ. Иймэрхүү үед дөрвөн нөхөд уулзлаа гэвэл Атос ярианд оролцож, биеэ албадан байж хэд гурван үг хэлсэн болоод лтаг өнгөрнөө.

Гэхдээ Атос дөрвөн хүний уухыг уух боловч, үүнээс болж согтсон шинжгүй зөвхөн хөмсгөө их зангидан улам улам гунигтай л болж ирдэг аж.

Юмны нарийн учрыг сайн олдог хурц ухаант д'Артаньян хэдий мэрийн хичээсэн боловч Атосын номой байдлын шалтгаан, тийм болсны учрыг хараахан тайлж чадсангүй. Атост ер заха ирдэггүй, Атосюу ч хийсэн нөхдөөсөө огт нуудаггүй байжээ.

Дарс уухлаараа тэгж гунигладаг гэж түүнийг хэлэхийн эрхгүй, харин гунигаа арилгах

санаатай ингэж уухад, энэ эм тус болохгүй улам ч гүнзгийрүүлдэг байв. Мөн Атосын үе үе ийнхүү гуньхардгийг тоглоомд алдаж хожсонтой холбохын эрх бас байхгүй. Юу гэвэл, хувь заяаны эргэлт бүрийг нэг бол дуулж, үгүй болж гэм, хараал ерөөл тавьж угтдаг Портосыг бодвол Атос хожиж байсан ч хожигдож байсан ч ялгаагүй огт тоодоггүй эр билээ. Нэг өдөр Атос шадар цэргүүдтэй сууж тоглоод мянган алтан зоос хожлоо. Тэгснээ түүнийгээ, алтан хатгамалтай, гоёлын мөрөвчтэйгөө цуг алдаж орхив. Дахиад энэ бүгдийг нэхэж хожоод, мөн зуун том алтан зоос нэмж хожихдоо дэгжин хар хөмсөг нь нэг ч хөдлөөгүй, танан цагаан гарын нь өнгө огтхон ч хувираагүй, тэр оройжин дэлгэсэн яриа хөөрөө амгалан аятай байдлаа ер алдаагүйсэн билээ.

Атосын гуньхралыг, манай хөрш англичуудынх шиг тэнгэр муухай сайхан байгаагаар мөн тайлбарлахын эрхгүй, юу гэвэл цаг агаар хамгийн сайхан цагт л Атосын гуниг улам ихэсдэг зантай. Зуны эхэн, дунд сард л Атос бүр ч их зовлонтой байдаг юм.

Өнөө цагт зовлонтой юм гэж түүнд ер үгүй, ирээдүйн тухай ярихад огт үл тоомсорлоно. Ингэхлээр д'Артаньяны чихэнд сонсогдсон цуу үгнээс таавар хийхэд, энэ гуньхралын учир өнгөрсөн үед байж таарах бололтой.

Атосыг хүрээлсэн нууц байдал энэ хүнийг улам чсонирхууштай болгоно. Согтож гүйцээд байхдаа хүртэл хэдий аргатай нарийн юм асуулаа ч гэсэн үг хэл хараа байдал аль нэгээр дотор байгаа юмаа ер илчилдэггүй билээ.

д'Артаньян бодол болсондоо авган:

-Хөөрхий, Атос одоо миний гайгаар амь алдчихсан ч байж мэднэ. Зөвхөн миний төлөө л Атос энэ хэргийн эх төгсгөл алиныг чмэдэхгүй байж, үүнээс өчүүхэн ч ашиг завшаан олох гэсэн бодолгүйгээр үүнд оролцсон юм шүү дээ гэж дуугарав.

Планше үг нэмэрлэж.

-Та бидний амь мэнд гардаг лав түүний ач байж таарна гэдгийг дурсалгүйгээр тэр шүү, "д'Артаньян мордоорой, би занганд орлоо!" гэж хашгирсныг санаж байгаа биз. Дараа гар буугаараа хоёр буудчихаад, илдээ суга татан хангинуулж байгаа харагдсан. Ердөө л харин хүн шиг, чухам. гэвэл хилэгнэж гүйцсэн ширүүн догшин чөтгөр шиг сүртэй байсан гэж хэлэв.

Энэ үг д'Артаньяныг улам яаруулж, тэртэй тэргүй давхиж явсан морио ташуурдахад хүргэв. Бага үдийн алдад тэр хоёр Амьены барааг харж бага уд өнгөрч байхад ёрын муу буудлын өмнө ирж зогсов.

д'Артаньян, эзнээс, өшөө авах, тэгж өшөөгөө авна гэж санахад хүртэл бах ханахаар арга эргэцүүлж бодсоор явжээ. Ингээд мань хүн малгайгаа духдуулж тавиад, илдийнхээ ишин дээр зүүн гараа тавьж баруун гар дахь ташуураа хөдөлгөсөн шүүхэн буудалд орж очив.

Мэхэлзсээр өөдөөсөө тосч ирсэн буудлын эзнээс,

-Та намайг таньж байна уу? гэж асуулаа.

д'Артаньяны зэр зэвсгээс сүрдсэн буудлын эзэн.

-Өндөр эрхмийг өчүүхэн би танихгүй юм даа гэж өчив.

-Аа, та намайг танихгүй байгаа бий?

-Үгүй байнаа, өндөр эрхэм минь.

-За тэгвэл, хоёр үгээр танд, би сануулаад өгье. Хоёр долоо хоногийн өмнө хуурамч мөнгө борлуулсан хэрэгт ял тулгасан тайжийг та яасан бэ? гэв.

д'Артаньян хариугүй цохиод авах байртайболж, Планше эзнийгээ яг дуурайх тул буудлын эзний царай хувхайраад явчихлаа.

Буудлын эзэн дорой дуугаар, иш, өндөр эрхэм минь, надтай энэ тухай бүү ярилц. Тэр эндүүрлийн төлөө, бурхан минь би бас их зовлон амсаж байна. Үгүй би бас их гайтай хүн юмаа гэж дуу тавилаа.

-Тэр тайж яасан бэ? гэж би танаас асууж байна.

-Өндөр эрхэм минь нигүүлсэж үз, миний үгийг сонсож хайрла. Сууж гийгүүлээч дээ.

д'Артаньян сэтгэл зовсон, уурласандаа шүүгч шиг сүртэй, дуугүй суув. Планше эзнийхээ сандлын ард ихэмсэг дүртэй зогсоно.

Буудлын эзэн айсандаа чичирсээр.

-Ийм хэрэг болсон юм, өндөр эрхэм минь... Одоо би таныг танилаа. Сая таны хэлсэн тэр тайжтай хэрүүл үүсэх үед, яваад өгсөн хүн та шив дээ? гэв.

-Тиймээ, би байна. Бүх үнэнээ ярихгүй юм бол өршөөл горьдох юмгүй гэдгийг одоо өөрөө мэдэж байгаа биз.

-Тэгвэл миний үгийг сонсож хайрла, би юухан ч нуулгүй цөмийг ярья. -За сонсьё.

-Манай буудалд хуурамч мөнгө үйлдэгч цуутай хүн, хэдэннөхдийнхөө хамт ирж бууна, тэд цөм шадар, торгон цэргийн хувцастай байна гэж дарга нар над дуулгасан юм. Танай морьд зарц нар, өндөр эрхмүүд, та нарын байдлыг надад нэгд нэгэнгүй хэлж өгсөн билээ.

Энэ шинж тэмдгийг хэн тэгж хэлж өгснийг даруй гадарласан д'Артаньян,

Цаашаа юу болсныг ярь гэв.

-Тэхлээр надад хүчнэмж зургаан хүн ирүүлсэн дарга нарын тушаалыг дагаж, тэр хуурамч мөнгө борлуулдаг гэсэн улсыг баривчлахад хэрэгтэй гэж үзсэн аргаа би хэрэглэсэн билээ.

"Хуурамч мөнгө борлуулагч" гэдэг үгэнд аягүйцсэн д'Артаньян. за бас л биднийг тэгж

дуудаад байна уу? гэж зандрав,

-Өндөр эрхэм минь, ийм уг хэлсэндээ уучлал гуйя, гэвч миний биеэ зөвтгөх учир үүнд л байгаа юм шүү дээ. Дарга нар намайг сүрдүүлсэн гэтэл буудлын эзэн хүн дарга нартай эв түнжинтэй байвал зохихыг та мэднэ хойно.

-Тэр тайж яасан бэ гэж танаас дахиад асууя. Түүнийг яасан бэ? Амьд уу үхсэн үү?

-Өндөр эрхэм минь жаахан хүлцэж үз. Би үүнийг одоохон хэлье. Ингээд таны мэдсэн тэр хэрэг гарч... өөрийг чинь гэнэт яаран мордсон явдлыг зөвтгөх шалтаг мэт болсон гэж эзний залирхуу байртай хэлэхийг д'Артаньян ажиг. Танай нөхөр болох тэр тайж чадлаараа тэмцэлдсэн. Тэр хүний зарц гай болж, надад туслахаар ирүүлсэн агтач хүний хувцас өмсөөд байсан цэргүүдтэй зодоо хийчхээд... гэтэл д'Артаньян дуу алдан.

-Аа, чи муу новш Та нар цөм хуйвалдаад байсан юм бий, цөмийг чинь хүйс тэмтрэхэд надад юу саад болж байгааг бимэдэхгүй байна гэлээ.

-Үгүй, өршөөлт эрхэм минь, гай болоход бид цөм хуйвалдсан байгаагүй юм. Та үүнийг даруй үнэмших болно. Танай нөхөр (тэр хүнд лав байж таарах өргөмжлөлт нэрээр нэрлэхгүй байгаад уучлаарай, бид түүний нь дуулаагүй, хоёр гар буугаараа буудаж хоёр цэрэг унагаад илдээрээ биеэ хамгаалан байж ухрахдаа манай нэг хүнийг бас тахирдугуу болгоод илдийнхээ хавтгайгаар намайг ороолгож унагаасан.

-Үгүй, чи наад яриагаа дуусгана уу, үгүй юу, тамлагч минь? Атос хаа байна? Атосыг яасан бэ? гэж д'Артаньян хашгирав. .

-Өршөөлт эрхэм танд сая миний дуулгасанчлан, ухарч яваад, тэр хүн зоорь руу ордог шатанд тулж очоод, үүд онгорхой байсан болохоор түлхүүрийг нь сугалж аваад, цаашаа орж дотроос нь түгжиж орхисон. Түүнийг тэндээс гарч чадахгүйг хүмүүс цөм мэдэж байсан болохоор хэн ч үүнд саад хийсэнгүй.

-Тийм дээ, та нар түүнийг алах гээгүй, зөвхөн шоронд л хийж авах гэсэн юм хойно хир дээ гэж д'Артаньян хэлэв.

-Бурхан минь шоронд хийх үү бурхан минь үгүй, өршөөлт эрхэм минь, тэр чинь, өөрөө өөрийгөө түгжиж орхисон юм. Гэхдээ тэр чинь үүний өмнө бөөн хэрэг тарьж амжсан. Нэг цэрэг дороо үхэж хоёр нь хүнд шархадсан, үхсэн шархадсан улсаа нөхөд нь аваад явсан, юу болсныг би дахин ер дуулаагүй. Би ч яахав, ухаан ороод, мужийн дарга гуай руу очиж, болсон бүх явдлыг яриад, баривчлагдсан хүнийг яах вэ гэсэнд дарга харин юу ч мэдээгүй дуулаагүй хүн болчихоод, юу ярьж байгааг ойлгохгүй байна гээд, би тийм тушаал ер өгөөгүй харин өөрийгөө энэ хачин хэрэгт холбогдсон гэж хэн нэг хүнд, намайг гайгаар хэлсэн бол дүүжилнэ гэж айлгав. Янз нь би баривчлах ёстой хүний оронд өөр хүн баривчилчихсан, баригдвал зохих хүн арилаад өгсөн бололтой байв.

Засаг захиргааны газраас энэ хэрэгт хэрхэн хандсаныг дуулаад улам ч зэвүү нь хүрсэн д'Артаньян,

-Үгүй Атос хаана байна вэ? Атосыг яасан юм? гэж дуу алдав. Буудлын эзэн яриагаа үргэлжлүүлэн, баривчилсан хүнийхээ өмнө би даруй биеэ цагаатгахыг яаран, зоорь руу очиж, гадагшаа гарахыг тэр хүнээсгуйлаа. Үгүй эрхмээ, тэд чинь хүн биш чухам л нэг чөтгөр юмаа, гар гэж намайг хэлэхэд, үүнийг хуурамч арга, тэхлээр өөрөө болзол тавиад, түүнийгээ биелүүлж өгөхөөс нааш гарахгүй гэв. Их эзэнтний шадар цэргүүд өөд гар далайснаар өөрийгөө ямар байдалд тавьсныг би ойлгож байсан болохоор, түүний тавих болзлыг хүлээн авна гэж хүлцэнгүйеэ хариулав.

" Юуны өмнө, миний зарцыг бүрэн зэвсэгтэй нь эргүүлж өг" гэж тэр шаардлаа. Танай нөхрийн юу хүссэн бүхнийг бид гүйцэтгэх дуртай байсныг та өөрөө ойлгож байгаа хойно энэ шаардлагыг даруй ёсоор болгов. Ингээд Гримо гуай (бас л дуу цөөнтэй хэдий боловч яахав нэрээ бидэнд хэлсэн юм) шархадсан хэдий боловч, зооринд орлоо. Эзэн нь түүнийг тосч аваад үүдээ түгжиж, юмаар дараад биднийг холд гэж тушаасан.

д'Артаньян дуу тавьж,

-Үгүй тэгээд тэр одоо хаана байна? Атос хаана байна? гэж шахав.

-Зооринд байгаа, эрхмээ.

-Юу, муу новш чи түүнийг өдийболтол зооринд хорьж байгаа хэрэг үү?

-Бурхан өршөө. Хаанаас тэгэх вэ, эрхмээ, юу боллоо гэж түүнийг бид зооринд хориод байх билээ. Тэр зоорин дотор танай нөхөр юу хийж байдгийг та мэддэг болоосой! Эрхэм минь, та нөхрөө тэндээс гаргаж чадах юм болж гэм, таны ачийг би насан туршаа санаж, өршөөлт бурханд мөргөжбайхсан гэлээ.

-Тэгвэл Атос тэнд байгаа юм шив? Тиймээ очвол уулзах юм шив?

-Тэгэлгүй яахав, эрхмээ, зөрж зүтгэчхээд, гарч өгөхгүй байгаа юм. Бид өдөр болгон түүнд салхивчаар талх шаардвал мах ч билээ оруулж өгдөг. Харласан чинь, мах, талх хоёроор тэр голлож хооллодоггүй хүн юм. Нэг өдөр би хоёр хүнтэй доошоо орох гэж оролдоод үзсэн, танай нөхөр сүрхий уурласан. Тэр өөрөө хоёр гар бууныхаа замгийг татаж, зарц нь урт бууны замгийг татаж байгаа дуулдсан. Яах гэж байгаагийг нь асуухад, танай нөхөр хариулахдаа, хоёуландаа дөчин сум бий, түүнийгээ дуусахаас нааш бидний нэгийг ч оруулахгүй гэсэн. Тэхээр нь би нутгийн даргад очоод зарга барьсан чиньминий хохь, үүнээс хойш бурхан өршөөж буудалд ирүүлсэн сурвалжит эрхмүүдтэй сайн харилцаж сурах болно гэсэн.

Буудлын эзний өрөвдмөөр царайг хараад, д'Артаньян инээдээ барьж чадалгүй, -За тэгээд, тэр цагаас аваад гэхэд цаадах нь тосч аваад:

-Тэр цагаас аваад бид их зовж байнаа, эрхмээ манай хамаг идэш зуушны нөөц зооринд байдаг. Лонхтой, торхтой дарс, ургамлын тос, халуун ногоо, гахайн мах, хиац цөм тэнд байдаг. Тэгээд тийшээ бид ордог арга байдаггүй болохоор, ирж буусан улсад унд хоол өгч чадахгүй болж байна. Ингээд манай буудал өдөр бүр доройтож байна. Танай нөхөр дахиад нэг долоо хоног зооринд суух юм бол бид хоосрох нь тэрээ гэв.

-Болж муу луйварчин. Бидний байдлыг хараад, хуурамч мөнгө борлуулдаг улс биш, төлөв шударга хүмүүс гэдгийг гадарлаж болохгүй байсан гэж үү?

-Чухмаа, эрхмээ, чухам, таны зөв за та чагнаа, танай нөхөр бас л шуугиан тариад гарлаа гэж буудлын эзэн хариулав.

д'Артаньян үүнд,

-Яахав, түүний тааваар нь байлгахгүй үймүүлээ биз гэж хэллээ.

-Үгүй бид одоо яах вэ? манайд хоёр язгууртан англи хүн буусан юмсан гэж буудлын эзэн дуу тавина.

-Тэгээд юу гэж?

-Юу юу гэж гэнээ. Англи улс сайн дарсанд дуртайг та өөрөө мэдэх хойно. Ирсэн улс

тэгээд хамгийн сайн дарс өгөөч гэсэн юм. Манай эхнэр тэгээд, дарс авч тэр улсад өгөхөөр, Атос гуайгаас оруулахыг гуйсан юм байлгүй. Цаадах нь яахав, ердийнхөө зангаар үгүй гэсэн байж таарна. Өршөөлт бурхан минь дахиад л энэ бөөн хэрэг дэгдлээ гэв.

Үнэхээр, зоорины тэндээс их чимээ шуугиан гараад байв. Цухалдаж цөхрөхдөө гараа базлан яваа буудлын эзнийг дагаж д'Артаньян мөн босоод буугаа бэлэн барьсаар яваа Планшег дагуулсаар хэрэг төвөг үүсэж байгаа газар руу очив. Хоёр Англи хүн урт зам туулж ирээд өлсөж цангасан гэж хариугүй, үүндээ айхавтар уур, нь хүрчихсэн улс байлаа.

Харийн аялгуутай гэлээ ч сайхан франц хэлээр тэр хоёр

-Үгүй энэ чинь, хүчтүрж байгаа хэрэг байна шүү дээ, Гэмгүй хүмүүс өөрсдийнхөө дарснаас авахад энэ өвчтэй амьтан саад болж байна гэдэг чинь. Бид үүдийг нь эвдээд орно, тэр бүр солиорч гүйцсэн амьтан байвал үгүй хийчихнэ биз, ердөө л гүйцээ гэж омгорхоно.

д'Артаньян гар буугаа бүснээсээ сугалж аваад,

-Эрхмүүдээ, аядаж үз. Уучилж үзээрэй, гэхдээта нар хэнийг ч үгүй хийхгүй бий гэлээ.

Үүдний цаанаас, зүгээр, зүгээр наад сагсуу улсаа оруулчих, тэгээд л үзье гэж Атосын амгалан дуу гарав.

Хоёр англи хүн янз нь сүрхий зоригтой эрчүүл бололтой гэлээ гэхнээ өөд өөдөөсөө тэвдэх байртай харав. Зоорин дотор нэг үлгэрийн лут баатар юм уу өлөн мангас суучихсан, түүний агуйд хэн боловч цээрлэл үзэлгүй орж эс чадах юм шиг санагдана.

Минут хир цөм нам гүм болсноо, эцэстээ нөгөө англи хүмүүст няцах гэдэг ичгүүртэй санагдаад, илүү их унтууцсан нэг нь, зоорины үүд рүү буусан тав зургаан гишгүүртэй шатаар бууж очоод үүд рүү хадан ханыг боловч цөм цохимоор чанга өшиглөв.

д'Артаньян; гар бууныхаа замгийг татаад,

-Планше. би тэр дээр байгааг нь аргалъя. чи доор байгааг нь учрыг ол... Эрхмүүд, та бүхэн тэгээд тулалцах гэж байгаа юм шив дээ, за сайн, яахав тулалдаад үзье гэлээ. Дороос өршөөлт бурхан минь, д'Артаньяны дуу гараад байх шиг надад санагдах юм гэж Атосын бүдэг дуу гарав. д'Артаньян мөн чангахан дуугарч,

-Найз минь чи эндүүрсэнгүй, би биеэрээ ирчхээд байна гэж хариуллаа. -За догь байна. Тэгвэл наад зоригт эрчүүлийг чинь сайхан болгож тавья гэж Атос хэлэв.

Хоёр Англи хүн илдээ суга татсан боловч, шургаж хоёр галын дунд оржээ. Агшин зуур тэд эргэлдэж байснаа, түрүүчийн адилаар бардамсэтгэл дийлж хоёр дахь удаа өшиглөхөд, зоорины үүд тэр чигээрээ шажигнав.

-д'Артаньян хажуу тийшээ болоорой, зайлсхийгээрэй. би одоо буудлаа гэж Атос хашгарна.

д'Артаньян хэдийд ч болов юм бодохуйц самбаатай байдаг болохоор,

-Атос оо, жаахан азнаарай гэснээ Англи хүмүүст... Эрхмүүдээ та хоёр эвгүй муухай хэрэгт хутгалдаад, суманд сэгчүүлэхэд хүрэх нь. Миний зарц бид хоёр та нарыг гурван сумаар зоорин дотроос мөн төдий чинээ сумаар буудах болно. Түүнээс гадна үнэнийг хэлэхэд манай нөхөр бид хоёр илд барихдаа бас муугүй юм. Надад бүү саад бол, би тэгвэл өөрийн хэргийг ч бүтээнэ та бүхний хэргийг бүтээж, төдхөн та нарт дарс өгнө гэж амлая гэлээ.

-Дарс үлдсэн бол тэр юм биз дээ яахав гэж Атос ёжлонгуй дуугарсанд, буудлын эзний нуруу руу хүйт даагаад явчихлаа.

"Юу, үлдсэн бол гэж" гэж шивэгнэнэ.

-Чөтгөр алгад, үлдэлгүй яахав. Бүү зов. Хаанаас л тэр хоёр хамаг зоорины дарсыг ууж барсан байхав. Эрхмүүд илдээ хуйлчих гэж д'Артаньян хэллээ.

-За тэгье, харин та бугаа мөн бүсэндээ хавчуулчих гэв.

-Дуртай хавчуулъя гээд д'Артаньян өөрөө үлгэр үзүүллээ. Тэгээд Планше рүү эргэж бууныхаа цэнэгийг ав гэж дохив.

Энэ байдлыг харсан Англи хүмүүс амандаа юм үглэсээр мөн илдээ хуйллаа. Атосын энд орсон учрыг д'Артаньян тэдэнд дуулгасанд, тэд жинхэнэ язгууртан эрхмүүд байсан тул хамаг хэрэгт буудлын эзнийг буруушаав.

-За одоо эрхмүүд минь, дээшээ байрандаа орж үз. Арван минутын дараа, та бүхэнд хүссэн бүхний чиньөгнө гэж д'Артаньян хэлэв.

Хоёр англи хүн мэхийж ёслоод дотогшоо оров.

-Атос найз минь, би одоо ганцаараа байна, үүдээ онгойлгож өгч үз гэж д'Артаньян хэлсэнд,

Атос:

-Одоохон гэж хариулна.

Боодолтой саваа авч хаях, дүнз мод өнхрүүлэх чимээ гарна. Атос барьж бэхэлсэн хамгаалалтаа өөрөө нурааж байгаа нь тэр аж.

Үүдтөдхөн нээгдэж үүдэн завсраар Атосын цонхийсон царай цухуйж, эргэн тойрноо хялам хийж харлаа.

д Артаньян нөхөр рүүгээ гүйж очоод халуунаар тэвэрч авлаа, тэгээд чийгтэн муу нүхнээс нь түшиж дээш гаргаснаа Атосын гуйвж байгааг сая ажаад,

-Та шархадсан уу? гэж тэр асуулаа.

-Би юу? үгүй чиш!. Би ердөө согтож орхиод л байна, Согтох гэж над шиг ингэтлээ их мэрийсэн хүн үгүй дэг. Буудлын эзэн, бурхны нэрийг барьж андгайлахад, лав л миний хувьд зуун тавиад шил дарс ногдсон дог гэв.

-Ээ бүү үзэгд, хэрэв зарц нь эзнийхээ уусны талын дайтай уусан ч гэсэн би хоосорч гүйцэж гэж буудлын эзэн дуу тавилаа.

Гримо дэгтэй журамтай хүн болохоор, миний уусан дарснаас уухгүй. Тэр торхтойгоос л ууж байсан ингэхэд мань хүн бөглөхөө мартсан дагаа нэг юм гоожоод байгаа дуулдана гэж Атос хэлэв.

д'Артаньян үүнд тачигнатал инээд алдсанд, буудлын эзний хүйт даагаад байсан бие халуу оргиод явчихлаа.

Энэ үеэр Атосын араас Гримо бугаа мөрөн дээрээ тавиад гарч ирэхэд, инээдмийнжүжигт гардаг согтуу хүн аятай толгой нь салганаж харагдана. Ар өвөргүй нэл тос болчихсон, буудлын эзэн түүний нь үзээд, өөрийнхөө дээд сайн тос мөн гэж танилаа.

Ингээд тэд явсаар том танхим өнгөрч, хамгийн сайн өрөөнд, д'Артаньян дураараа орж байрлав.

Энэ зуур эзэн, эзэгтэй хоёр удтал хөл хоригтой байсан зоорь руугаадэнлүү барьсаар давхин ортол, элэг эмтэрмээр юм харагдлаа. Атос сая гарахдаа зай гаргасан бэхлэлтийг баглаатай саваа самбар, хоосон торх сэлтээр, байлдааны дээд нарийн аргын ёсоор өрж хийсний цаана, дарс, тос асгаран тунасны дотор гахайн ууцны яс энд тэнд хэвтэнэ. Зоорины зүүн булан тэр аяараа хагархай шил овоолоостой, бөглөөгүй орхисон торхноос эцсийн дусал гарч гүйцэж байв. Эртний яруу найрагчийн үгийг иш татахад, энд дайны талбар аятай үхэл сүйрэл ноёрхож байх ажээ.

Адрын нуруунд өлгөсөн тавин ширхэг хиамнаас одоо арав гаруйхан юм үлдэж. Эзэн, эзэгтэй хоёрын гаслан орилох дуу зоорины гүнээс нэвт дуулдахад д'Артаньян хүртэл өрөвдөх сэтгэл төрлөө. Атос харин эргэж харсан ч үгүй.

Удсан ч үгүй, буудлын эзэн бачимдаж, хар буусандаа болоод шор барьсаар хоёр нөхрийн орсон өрөөнд дайран орж ирэв.

Атос түүнийг хараад,

-Алив, дарс авч ир гэлээ. Гайхаж хоцорсон эзэн,

-Дарс гэнэ шүү хөөш! үгүй та ганцаараа зуу гаруй алтан зоосны дарс уучихсан байна шүү дээ. Би ингээд хоосорч үгүйрч, баларлаа, яанаа гэж дуу халаг боллоо.

-За боль доо! Бид амныхаа цангааг ч сайн гаргаж чадаагүй юм гэж Атос дуугарав. -Үгүй бас зүгээр уугаад зогссон бол яахав гайгүйсэн та хамаг лонх хагачаад хаячихсан байна шүү дээ.

-Та нар намайг тэр бөөн лонх руу түлхчихсэн, тэгээд л хагарах чинь билээ, өөрсдийн чинь буруу.

-Миний хамаг тос үрэгдсэн байна.

-Тос гэдэг шархны сайн эм. Хөөрхий Гримо та нараас олсон шархаа эмнэлгүй яахав. -Миний хамаг хиамыг гударчихсан байна.

-Цаад зооринд чинь дүүрэн үхэр огодой байх чинь билээ.

Уур нь шатсан эзэн,

-Та нар эд бүгдийн унийг надад төлж өгнө дөө хөө! гэж хашгирав.

-Задарч гүйцсэн хар новш! гээд Атос суудлаасаа өндийх гэсэн боловч, дахин лагхийтэл суучхав. Хүч чадал нь барагдаж гүйцжээ. д'Артаньян нөхөртөө тусалж, ташуураа далайсанд эзэн алхам ухраад уйлж гарав.

-Энэ чинь таныг бурхны илгээсэн зочидтой эелдэг харьцдаг болгож сургана даа гэж д'Артаньянхэллээ.

-Бурхан гэнэ шүү! зүгээр чөтгөрийн явуулсан гэвэл дээр гэж эзэн маргана.

Үүнд , д'Артаньян тэгвэл эелдэг аашт хонгор минь чамайг ингэж чихэнд чийр болоод салахгүй бол бид дөрвүүл чиний зооринд орж түгжээд нээрээ тэгтлээ их хохирсон юм уу үгүй юу үзье л дээ гайгүй гэж сүрдүүллээ.

-Зөв, эрхмүүд. Танарын зөв, би буруугаа мэдэж байна. Уучилж болшгүй гэм буруу гэж үгүй шүү дээ. Та бүхэн язгууртан эрхмүүд, би ядуу нэг буудлын эзэн, намайг өрөвдөх ёстой шүү дээ гэж сүрдсэн эзэн бууж өглөө.

-Аа, энэ чинь өөр яриа, ингэвэл чи миний сэтгэлийг уяруулчхаад чиний торхноос дарс гоождог шиг миний нүднээс нулимс гарах бий. Бид гаднаас харагдаж байгаа шигээ ч нэг их аймаар улс биш. Наашаа хүрээд ир, ярилцъя гэж Атос хэлэв.

Буудлын эзэн хулгасаар дөхөж ирлээ.

-Чамайг айлгүй нааш ир гэж байна шүү. Чамтай тооцоо хийх гэж байхдаа, би түрийвчээ гаргаад ширээн дээр тавьсан биз гэж Атос хэллээ.

-Яриагүй үнэн, өндөр эрхэм минь.

-Тэр түрийвчид жаран алтан зоос байсан, тэр хаана байна?

-Шүүхийн газарт өгсөөн өршөөлт эрхэм минь. Түүний чинь хуурамч зоос гэж над хэлсэн юм байхгүй юу.

-За тэгвэл тэр түрийвчийг нэхэж аваад жаран зоосыг өөрөө ав.

-Шүүхийнтүшмэдүүд, гартаа орсон юмыг буцааж ер өгдөггүйг эрхэм та мэднэ шүү дээ. Хуурамч мөнгө байсансан болж гэм бас яахав, горьдож болох юм биз. гай болоход ёстой зоос болохоор санахын хэрэггүй.

-Шүүхийнхэнтэй яаж учраа олно өөрөө мэд, түнш минь. Энэ надад хамаагүй, тэгээд ч надад одоо ганц ч сохор зоос байхгүй гэж Атос хэлэв.

д'Артаньян ярианд оролцож,

-Ингэхэд, Атосын морь хаа байгаа вэ? гэж асуулаа.

-Саравчинд байгаа.

-Тэр морь хэдий үнэ хүрэх вэ?

-Тавин зоосноос хэтрэхгүй.

-Лав наян зоос хүрнэ. Түүнийг ав. тэгээд хэрэг шувтарлаа гэж д'Артаньян шийдэв.

-Юу? Миний морийг, Баязетагий минь чи худалдаж байгаа юмгэж үү? Аа, би юугаар аян дайнд мордох юм бэ? Гримог унаад явах хэрэг үү? гэж Атос гайхлаа.

-Би чамд өөр морь авчирсан гэж д'Артаньян хариуллаа

-Өөрийг авчирсан?

-Мөн ч сайхан морь авчирсан байна билээ гэж эзэн дуу алдав. :

-За яахав өөр залуу сайн морь байгаа юм бол миний морийг аваад дарс авч ир гэж Атос тушаалаа.

Сэтгэл нь бүр мөсөн амарсан эзэн, ямар дарс авчрах вэ? гэлээ.

-Зоорины гүнд сараалжны дэргэд байгаа дарснаас авч ир. Тэнд одоо хорин таван шил дарс

бий, бусад нь намайг унахад хагарчихсан юм даг. Зургаан шилийг авч ир.

-Үгүй энэ чинь, хүн биш, зүгээр ёроолгүй торх юмаа гэж эзэн аман дотроо үглэнэ. Энэ хүн эндээ хоёр долоо хоноод уусан юмныхаа мөнгийг бүрэн төлөх юм бол манай ажил төрөл засарч чаднаа гэв.

-Тэр дарснаасаа дөрвөн шилийг хоёр англи хүнд өгөхийг бүү мартаарай гэж д'Артаньян бас хэлэв.

-За одоо, дарс ирэхийг хүлээж суух зуур д'Артаньян чи бусад нөхөд яасныг ярьж аль гэж Атос хэллээ.

Портос хөлөө булгалчхаад хэвтэрт байсан, Арамис хоёр хуврагтай яаж ном хаяж суусныг д'Артаньян ярьж өглөө. Яриад дуусч байтал буудлын эзэн захиалсан дарс, аз болоход зоорины гадна байсан гахайн мах хоёр барьсаар орж ирэв.

Атос өөртөө мөн д'Артаньянд дарс аягалан за Арамис, Портос хоёр яахав сайн байгаа байж. Аа сайн нөхөр минь, чи өөрөө яасан бэ, юу болсон бэ? Таны царай нэг баргар байх шиг надад санагдаад байх юм гэлээ.

-Гай болоход энэ үнэнтэй, юу гэвэл бидний дотроос хамгийн, золгүй нь би болж таарч байна гэж д'Артаньян хариулав.

-д'Артаньян чи зовж байна гэнээ гэж Атос дуу алдаад юу болчихоо вэ, надад яриад аль гэв.

-Сүүлд ярья гэж д'Артаньян дуугарав.

-Сүүлд ээ! Одоо ярихад яагаад болдоггүй юм бэ? Намайг согтуу байна гэж чи бодож байна уу? Дарс ууж суухдаа миний ухаан хэзээ хэзээнийхээсээ илүү саруул байдаг гэгчийг санаж ав. За ярь би сайн чагнаа гэв.

д'Артаньян түүнд Бонасьеавгайтай учирсан явдлыг ярьж өгөв.

Атос яриагий нь амгалан сууж чагналаа.

д'Артаньяныг яриагаа дууссан хойно, тэр, эд бүгд юу ч биш, дэмий хэрэг гэв. Ер нь Атос "юу ч биш" гэхдээ дуртай хүн билээ.

-Атос та юм бүхнийг дэмий гээд л байна, уулаасаа дурлаж яваагүй хүний амнаас ийм үг гарахад, үнэмшил муутай байна гэж д'Артаньян маргалаа.

Атосын манарсан харц эгшин зуур дүрсхийж ирснээ, төдхөн мөн л бүдгэрэн манарч орхилоо. -Тэр үнээн, би ер дурлаж үзээгүй хүн гэж тэр амгалан гэгч дуугарав.

-Тэхлээр хатуу сэтгэлт хүн чи зөөлөн сэтгэлтэй улс биднийг дэмий зэмлэжээ гэдгийг өөрөө ойлгож байгаа биз дээ.

-Зөөлөн зүрх гэдэг чинь харласан зүрх гэсэн үг гэж Атос хэлэв.

-Та үүгээр юу гэж хэлэх гээв?

-Үүгээр би юу хэлэх гэсэн юм бэ гэвэл, хайр дурлал гэдэг чинь хожсон хүнд үхэл ногддог мөрийтэй тоглоомоос өөрцгүй юм гэсэн үг. Миний үгийг итгэж үз, д'Артаньян минь, та хожигдсон чинь их аз болж. Миний зөвлөх юм гэвэл, хэзээд хожигдож л яв.

-Тэр бүсгүй надад их хайртай юм шиг санагдсан.

-Тэр чинь танд тэгж санагдсан хэрэг.

-Тэр ч үгүй, надад нээрээ сайн байсан юм.

-Балчир байнаа! Амраг бүсгүйдээ, өөрийгөө хайрлагддаг гэж тань шиг итгэж явдаггүй эр хүн гэж байхгүй, мөн амраг бүсгүйдээ эс мэхлэгдсэн эр хүн гэж бас үгүй юм шүү.

-Атос танаас л бусад нь тэр биз дээ танд ямар амраг бүсгүй гэж ер байсан биш. Атос минут хиртэй дуугүй байснаа,

-Тэр үнээн. Надад хайртай хүн гэж ер байгаагүй, за уучихья гэв.

-Үгүй тийм бол гүн ухаантан та намайг зааж тусалж. зөвлөж, сэтгэл санаагий минь тайтгаруулж өгөөч.

-Тайтгаруулах аа? юунд тэр вэ?

-Надад гай зовлон учирсан шүү дээ. Атос мөрөө хавчисхийгээд,

-Таны гай зовлон гэдэг чинь ердөө инээд хүрмээр юм. Нэгэн янаг дурлалын түүхийг өөрт чинь ярьж өгвөл, юу гэх байсан бол, дуулах юмсан гэв.

-Танд учирсан явдал уу?

Эсвэл, миний нөхдийн нэгэнд учирсан хэрэг, ямар ялгаа байх билээ.

-Ярьж өгөөч Атос, ярьж өг.

-Дарсаа ууя, энэ нь дээр байх.

-Уун аа, уугаад ярихаа ярихгүй юу?

-Энэ ч үнэхээр хослуулж болох зүйл гээд Атос дарсаа уучихаад, дахин аягалав. -За би чагнаа гэж д'Артаньян хэллээ.

Атос бодол болж, бодолдоо автаад ирэх тусмаа д'Артаньяны нүдэн дээр царай нь зэвхийрч ирлээ. Жирийн хүн унаад унтахаар согтчихож, гэтэл тэр өөрөө сэрүүнээрээ зүүдэлж байгаа

юм аятай байх аж. Ингэж зүүдлэх аятай согтохыг үзэхэд айдас хүрмээр ч юм шиг байв.

-Та заавал дуулахсан гэж байгаа юм бий дээ? гэж Атосыг асуухад, д'Артаньян: -Би танаас гуйя гэж хариулав.

-За яахав таны хүссэнээр болог. Манайнэг нөхөр манай нэг нөхөр шүү, би биш, манай нутаг Берри мужийн өндөр язгууртай нэг гүн хорин таван настай байхдаа үнэхээр сайхан, арван зургаатай нэг бүсгүйд дурлажээ. Аргагүй насандаа тохирсон, гэнэхэн цагаан зангийн цаанаас бүсгүй хүнийх гэхээргүй, яруу найрагчийн хурц ухаан тодорч байлаа.

Тэр бүсгүй сэтгэл татаад зогсохгүй, хүнийг мансууруулах билээ. Хувраг сахилтай ахынхаа хамт нэг буйдхан газарт суудаг байлаа. Тэр хоёр хэдийгээр энэ нутагт гаднаас ирсэн, хаанаас ирсний нь мэдэх хүн үгүй байсан боловч, дүү хүүхний гуа сайхан, ахын нь сүжиг бишрэлтэйд болоод энэ тухай асууя гэж хэний ч санаанд орсонгүй. Мөн дам сонсвол тэд язгуур гарал сайтай улс гэлцэж байв. Тэр нутгийн эзэн болох миний нөхөр, бүрэн эрхт эзэн болохоор бүсгүйг амархаан хуурчих юм уу, хүчээр өөрийн эрхэнд авч болох байсан, харь нутгийн хүмүүсийн төлөө тэгээд хэн юм дуугарахав дээ. Гай болоход тэр өөрөө шударга хүн байсан болохоор бүсгүйг гэргийгээ болгож авлаа. Мунхаг, тэнэг, илжиг! гэхэд, д'Артаньян:

Өөрөө тэр бүсгүйд сайн байсан юмболж гэм юунд тэр билээ! гэж асуув.

Атос хариулахдаа,

-Чагна л даа. Манай нөхөр түүнийг аваачиж, нутагтаа тэргүүн хатагтай болгов. Тэгээд үнэнийг хэлэхэд бүсгүй энэ байдалдаа үүнээс цаашгүй сайхан нийцэж байлаа, гэхэд: -За тэгээд яагаав? гэж д'Артаньян асуув.

-Яахав. Нэг өдөр хатагтай гүнтэйгээ цуг ан хийж яваад мориноос унаж, ухаан алджээ. Гүн туслахаар яаран очоод, хувцас нь бариу байсан болохоор хутгаар хатагтайн хувцсыг огтчин тайлж байгаад санамсаргүй мөрий нь ил гаргаад орхижээ гэж Атос аяархан боловч түргэн ярьж байснаа. хатагтайн мөрөн дээр юу байсныг д'Артаньян та таа даа гээд хачин чангаар инээд алдав.

-Түүнийг би яаж мэдэх билээ гэж д'Артаньян маргахад Атос хэлсэн нь: -Цэцэг, тэр бүсгүй тамгалуулсан хүн байжээ гэлээ. Ингэж хэлээд Атос барьж байсан аягатай дарсаа нэг мөсөн хөнтөрч орхив.

-Ямар аймаар юм бэ? Тийм юм байж яаж болох вэ? гэж д'Артаньян дуу алдлаа. -Тэр үнэн зүйлээ, хонгор минь сайхан дагина маань шулам байж. Хөөрхий бүсгүй хулгайч хүн байсан юмсанж.

-Гүн тэхлээр яагаа бол?

-Гүн газар нутагтаа бүрэн эрхт эзэн, харьяат хүмүүсээ цаазлах, өршөөх бүрэн эрхтэй хүн болохоор хатны хувцсыг бүр урж хаяад, хатны гарыг ард нь хүлж, модноос дүүжилжээ. - Бурхан минь, үгүй Атос энэ чинь хүн алсан хэрэг байна шүү дээ гэж д'Артаньян хашгирав.

Үхсэн хүн шиг цонхийсон царайтай Атос үүнд:

-Тиймэрхүү, ердөө л нэг хүн алсан төдий хэрэг гэв, үгүй энэ чинь юу вэ? Миний дарс дуусчих шиг болох юм.

Ингэж хэлснээ, Атос бүтэн лонх дарс аваад, жирийн нэг аяга аятай амаар нь ганцхан хөнтөрчихлөө.

Ингэснээ шанаагаа тулан суухад, д'Артаньян айж хиртхийсэн, өмнө нь зогсоно. Гүнгийн энэ явдлыг Атос ярьж дуусгах гээгүй бололтой, дээшээ болоод.

-Үүнээс болж гуа сайхан, дур булаасан, янаг халуун сэтгэлт бүсгүйчүүдэд бидургүй болсон юм. Та мөн тийм болох болтугай. Ууцгаая гэв.

-Тэр бүсгүй тэгээд үхчихсэн хэрэг үү? гэж д'Артаньян аман дотроо дуугарахад Атосын хэлсэн нь:

-Тэхгүй яахав! Алив аягаа нааш тавь, гэснээ, хөөе та нар мах аваад ирээч! Бид цаашаа юм ууж болохоо болилоо гэв.

-Аа бүсгүйн ах яасан бэ? гэж д'Артаньян түдгэлзэсхийж асуулаа.

-Ах нь аа? гэж Атос лавлав.

-Тиймээ нөгөө хувраг хүн.

-Аа, хувраг уу, би түүнийг мөн дүүжил гэж тушаах гэтэл надаас өрсөөд сүмээсээ зугтаачихсан байна билээ.

-Тэр новшийн амьтан, чухам хэн байсныг та хожим ер олж мэдээгүй юу? -Янз нь гуа бусгүйн эхний амраг, хамсаатан нь бололтой, амраг хүнээ нөхөрт гаргаж, элбэг дэлбэг амьдруулахын тулд хуйвалдаж, хувраг дүрээр хувилсан лут эр байх.

Бодоход тэр дөрвөн мөчөө огтлуулж үхээ биз. Аймаар ярианд сэтгэл догдолсон д'Артаньян - Бурхан минь, ээ бурхан минь гэж шивнэнэ.

-д'Артаньян та яагаад гахайн мах идэхгүй байна? Тун сайхан мах юмгээд Атос мах огтолж залуугийн тавган дээр тавиад, зоорин дотор ядаж дөрвөн ширхэг ийм мах байгаагүй нь л тун тоогүй. Байсан бол би лав тавин шил дарс илүү уух байсан юмсан гэв.

д'Артаньян энэ яриаг цааш үргэлжлүүлж дийлэхээргүй ухаан солиорч байх шиг оргиод байлаа. Ингээд гараа дэрлэж хэвтээд, унтсан хүн болов.

Атос түүн рүү харамсах байртай хараад, өнөөгийн залуус ууж чадахаа больжээ. Энэ чинь, сайны сайн нь шүү бас гэлээ.

XXVIII. БУЦАЖ ИРЭВ

Атосын аймаар ярианд д'Артаньяны сэтгэл айхтар догдолжээ. Энэ хагас дутуу илчлэн ярьсан юманд учир тодорхойгүй зүйл нилээд байлаа. Юуны өмнө энэ яриаг шал согтуу хүн ихээ согтсон хүнд ярьсан, гэхдээ хоёр гурван шил бургуйд дарс уучхаар толгой мансуураад ирдэг тэр байдалд байсан хэдий гэхнээ, д'Артаньян маргааш өглөө ньсэрэхэд, өчигдрийн ярианы үг бүр тархинд хадагдсан мэт тов тодорхой санагдаж байв. Тухайлан зарим юм бүдэг бадаг байсан болохоор яг мэдэж авахсан гэдэг хүсэл улам ч хүчтэй төрөөд, өчигдрийн яриаг үргэлжлүүлэхээр хатуу шийдэн нөхөр дээрээ очиход, Атосын архи бүр гарчихсан, өөрөөр хэлбэл хорвоо дээр хамгийн хурц ухаантай өөрийн байдлаа хэнд ч үл мэдэгдэхээр нуусан хүн болчихоод байв.

Гэхдээ д'Артаньянтай гар бариад өөрөө түүний ярих гэсэн зүйлээр үг үүсгэж,

-Өчигдөр би, найз минь айхтар согтжээ. Өнөө өглөө босоод хөл дөнгөн данган хөдөлж, судас мөн хүчтэй лугшсаар байгаагаар гадарлалаа. Лав л би танд санаанд багтамгүй өдий төдий хачин юм яриа биз гэлээ.

Ингэж хэлээд Атос нөхөр рүүгээ айхтар хянуур харсанд цаадах нь жаал аягүйрхэж, -Ер үгүй шүү. Миний санахад л тийм хачин юм яриагүй байх гэж маргав.

-Тийм бий? Хачин юмаа. Танд би нэг гунигт явдлын тухай яриад байсан шиг санагдах юм.

Тэгээд, залуугийн дотоод бодлыг нэвт харах гэсэн юм аятай өөдөөс нь хянуур ширтэнэ. Үгүй, би танаас илүү согтчихсон юм байлгүй, ер санаанд орох юм алга гэж д'Артаньян хариуллаа.

Гэлээ гэхдээ Атосын сэтгэл үүнд огтхон ч тайвширсангүй, яриагаа үргэлжлүүлэн:

-Ер хүн бүр нэг янзтай согтдогийг та өөрөө ажиглаа байх, зарим нь хөгжиж, зарим нэг нь гуньхардаг, би өөрөө согтохоороо гунигтай болж, урьд нэг цагт асрагч эхийн ярьж өгсөн аймаар явдлуудыг хүнд ярихдаа их дуртай болдог хүн. Миний сул тал энэ байгаа юм, чухамдаа их муу тал, үүнийгээ больчих юм бол би ууж чаддаг хүн гэж хэлэв. Атос тун үнэмшилтэй байраар ярих тул д'Артаньяны лавгай байсан бодолд эргэлзээ төрлөө.

-Ээ нээрээ тийм, тийм байхаа биднэг дүүжлэгдсэн улсын тухай яриад байсан юм, аятай санаанд зүүд шиг бүдэг юм орж ирсэн юм гэж, д'Артаньян мултраад явчих гэж байгаа үнэний сэжүүрээс барьж авах санаатай туршиж хэллээ.

-За тэр харав уу! гээд Атосын царай цайрсан мөртөө, инээмсэглэх гэж хүчлэв. Би бүр мэдсэн юмаа, дүүжлэгдсэн улс гэж дандаа солиороод байдаг хүн байгаа юм гэв. д'Артаньян цаашаа тийм, тийм би одоо санаж эхэлж байна...байзаарай...бид бүсгүй хүний тухай ярьж байсан гэлээ.

Атосын царай улам зэвхий цайраад тэгж таарнаа, энэ чинь, цайвар үстэй бүсгүйн тухай миний ярих дуртай зүйл. Түүнийг л би яриад гарсан бол шал согтсон гэсэн уг гэж хэлэв. - Нээрээ тийм, өндөр нуруутай, гуа сайхан, цэнхэр нүдэн бүсгүйн тухай ярьсан гэж д'Артаньян

ХЭЛЛЭЭ.

-Тэхдээ бас дүүжлэгдсэн үү

д'Артаньян нөхөр өөдөө мөн хянуур харж,

-Тэр хүүхний нөхөр, танай нэг нөхөр язгууртан хүн дүүжилсэн юм байх гэж лавшруулав. Атос мөрөө хавчисхийгээд өөрөө өөртөө харамсах байртай,

-Хараа биз дээ, өөрөө юу ярьж байгаагаа мэдэхгүй дэмий үг дэлгэхээр шударга хүний нэрийг ийм амархан хөөдөж болдог байна шүү. д'Артаньян минь, би үүнээс хойш дарс их уухаа больё, муу зан байна шүү энэ чинь, бүр шийдлээ гэв.

д'Артаньян хариу юм дуугарсангүй. Атос гэнэт өөр юм руу орж,

-Үгүй ингэхэд, таны сайхан морь авчирч өгсөнд баярлалаа гэв.

-Тэр морь таны сэтгэлд таарав уу? гэж д'Артаньяныг асуухад, Атос хэлсэн нь: -Тэгсэн, гэхдээ холдоо амархан цуцах морь бололтой гэлээ.

Та эндүүрч байна. Тэр мориор чинь би бүтэн хагас цагийн дотор арван мод илүү газар давхихад, ердөө л Сен Сюльписийн талбайг нэг тойроод ирсэн юм шиг зогсож байсан.

-Тийм бий Тэгвэл би харамсах хэрэг болж байнаа гэв.

-Харамсах гэнээ?

-Тиймээ, би тэр морийг чинь зарчихсан юм.

-Яаж тэр вэ?

-Ийм хэрэг болсоон. Өглөө би зургаан цагт сэрлээ, Та зүгээр үхсэн хүн шиг унтаж байна, би хийх юм олж ядаад, мөн өчигдрийн уусан бас сайн гарч гүйцээгүй байсан юм. Ингээд доошоо нийтийн танхимд ортол өчигдрийн хоёр англи хүний нэг дамын худалдаачидтай морины наймаа ярьж байгаа харагдлаа. Өөрийн нь морь үхчихсэн юм байж. Ойртоод очтол нэг хонгор моринд зуун алтан зоос өгье гэж байгаа дуулдана. Тэхлээр нь би "Эрхмээ, надад бас нэг худалдах морь бий" гэж түүнд хэллээ.

"Танай нөхрийн зарц өчигдөр бариад зогсож байсан тэр морь мөн бол мөн ч сайхан морь байдаг" гэж тэр хүнд хариуллаа. "Таны бодоход, тэр морь тэгвэл зуун алтан зоос хүрэх юм шив?" гэж намайг асуухад тэр хүн "хүрэлгүй яахав. Та тэгээд энэ үнээр надад морио өгөх юм уу?" гэлээ. "Үгүй тоглоомын мөрийд тавьчихъя" гэж намайг хэлэхэд "ямар тоглоомын?" гэж тэр хүн асуулаа, "Шоо хаяж тоглоё" гэж би хэлээд, тоглоод орхисон морио алдчихлаа. Гэхдээ би эмээлээ эргүүлж хожсоон.

д'Артаньян дургүйцсэн байртай ярвайлаа.

-Та үүнд дургүйцэж байна уу? гэж Атос асуув.

-Үнэнийг хэлэхэд тэгж байна. Тулалдааны өдөр тэр морьдоор биднийг таних ёстой байсан юм. Тэр чинь бэлэг, өршөөлийн тэмдэг байсан юм. Атос та тусгүй юм хийжээ гэж д'Артаньян хариулахад, шадар цэрэгхариу маргаж:

-Боль доо, эелдэг аашт нөхөр минь, би үхтлээ уйдаж байлаа тэгээд ч үнэнийг хэлэхэд, англи моринд би дургүй хүн. Хэргийн чухал нь хэн нэг хүн биднийг танихад л байгаа юм бол эмээл байвал боллоо, нээрээ нүдэнд тусахаар эмээл байна билээ. Морины тухайд гэвэл, бид түүний үгүй болсон учрыг зөвтгөхөд амархан. Ер нь морь чинь үхэж үрэгддэг мал шүү. Яахав миний морь нэг өвчнөөр үхэж орхио л юм биз. д'Артаньян хөмсөг зангидсаар байв.

-Тоогүй, та энэ морьдод их хайртай юм шиг байна гэтэл би ярих юмаа дуусаагүй байна шүү гэж Атос хэлэв.

-Та өөр бас юу хийчихээ вэ?

-Өөрийнхөө морийг би мөрийд алдчихаад таны морийг тавьж тоглох санаа надад төрлөө. Ес, арав хоёр тоогоор алдсан шүү, хачнаа? гэв.

-Бодоход та энэ санаагаа арай ёсоор болгоогүй биз?

-Харин би даруй санасанчлангаа тоглож гарсан. Санаа зовсон Артаньян, -Тэгээд яав? гэж дуу алдлаа.

-Би тоглоод хожигдож орхисон.

-Миний морийг алдчихаа юу?

-Таны морийг долоо наймын тоотойгоор алдчихсан. Ганцхан тооноос болоод тэр. Нэг зүйр үг байдгийг мэдэх үү?

-Атос та, чухам солиорчихсон байна шүү.

-Ингэхэд байнаа д'Артаньян найз минь энэ үгийг надад өнөөдөр биш, харин өчигдөр тэр дэмий балай юм чалчиж байхад л хэлэх хэрэгтэй байсан юм. Таны морийг би бүх эмээл, хазаар, юутай хээтэй нь цуг алдчихсан.

-Үгүй энэ чинь хэтэрч байна шүү дээ.

-Байз л даа. Та бас бүгдийг дуулаагүй байна. Би жаахан улайрдаггүй бол тун сайн тоглодог хүн байх юм шүү. Гэтэл би дарс уухдаа улайрдаг шиг жаахан цаашлаад байдаг хүн тэгээд....

-Та тэгээд өөр юу тавьж тоглоо вэ? Танд тавих юм ер байгаагүй шүү дээ. -Үгүй шүү найз минь. Бидэнд бас энэ алмас чулуун бөгж байгаа. Наад хуруун дээр чинь гялалзаж байгаа алмасыг би өчигдөр харж амжсан билээ.

д'Артаньян яаран бөгжөө тэмтрээд,

-Энэ алмас чулуун бөгж гэнэ шүү та минь! гэж дуу алдав.

-Урьд нэг цагт надад мөн алмас чулуу байсан болохоор би чулууны үнэ цэнэ мэддэг хүн. Ингээд, үүнийг мянган алтан зоосоор үнэллээ.

Үхтэл айсан д'Артаньян,

-Бодоход та миний алмазын тухай ганц ч үг дурсаагүй биз дээ? гэж аягүй дуугарав.

Яалаа гэж, найз минь, одооманай ганц горьдлого энэ алмас чулуун бөгж л байсан гэдгийг ойлгож үз. Үүний чинь тавьж байж л би морьдоо мөн зам зуур зарах мөнгө хожиж чадах байлаа шүү дээ.

-Атос, миний сэтгэл догдлоод байна гэж д'Артаньян дуу алдав.

-Ингээд цаад хүндээ би алмазын тухай дурслаа. Тэгсэн чинь тэр хүнбас ажсан байжээ. Нээрээ чиг найз минь чи тэнгэрийн од хуруун дээрээ зүүчхээд хүнд харагдуулахгүй байх санаатай. Энэ чинь болшгүй зүйл шүү дээ.

-За яриагаа дуусгаж үз, найз минь таны наад хэнэггүй байдал намайг алж байна гэж д'Артаньян хэллээ.

-Тэгээд бид энэ алмасыг арав хувааж, зуу зуун алтан зоостой тулгантоглов. -Уур нь шатаж ирсэн д'Артаньян дуу алдаж,

-Та намайг туршиж тоглоом тохуу хийх санаатай байна уу? гэв.

-Үгүй би тоглоом хийгээгүй байна, чөтгөр алгад. Миний оронд та өөрөө байсан сан бол яахыг чинь үзэх юмсан. Хоёр долоо хоног би хүний царай үзэлгүй дан лонхтой цуг суусаар бүр зэрлэгшиж гүйцсэн байлаа гэж Атос хэллээ.

д'Артаньян гараа базлан байж,

-Энэ чинь тэгээд миний бөгжөөр мөрий тавьж тоглохын шалтаг биш шүү дээ гэж маргав.

-Миний яриаг бүтэн чагнаж орхиоч дээ, зуу зуун алтан зоостой тэнцүүлж арав дахин тоглох, нэхэх эрхгүй гэж ярилцлаа. Арван гурав дахь хаялтын дээр би бүгдийг алдаж орхисон. Арван гурав гэдэг тоо над ер нь ээлгүй, ягзуны эхэн сарын арван гурванд...

-Юун хамаатай юм бэ чөтгөр гэж д'Артаньян хашгирав. Өнөөдрийн энэ явдал өчигдрийн яриаг мартуулжээ.

-Жаахан хүлээж чагна л даа гэж Атос хэлэв. Над нэг санаа байсан юм: Тэр англи хүн их хачин зантай юм. Тэр хүн өглөө Гримотой юм ярьж байгаа харагдсан. Тэгээд өөрийнхөө зарц болохгүй юу гэж гуйлаа гэж Гримо над дуулгасан билээ. Тэгээд би Гримогоор үг дуу цөөнтэй

Гримог арав хувааж тавиад тоглох боллоо гэв.

д'Артаньян өөрийн эрхгүй инээд алдан,

-Энэ чинь л харин догь юм байж гэлээ.

-Гримогоор шүү, дуулж байгаа биз хөөш! Ингээд, ганц ч зоос хүрэхгүй Гримог тавьсны ачаар би алмас чулуун бөгжөө эргүүлж хожлоо. За тэгээд зөрүүд гэдэг сайн зан биш гэж хэл л дээ? гэхэд д'Артаньяны дотор онгойж элгээ дарж, инээд алдсаар:

Үнэндээ гэхэд энэ чинь тун хөгийн юм болжээ гэв.

-Азтай байгаагаа үзээд би дахин алмас бөгжөөр тоглож эхэлснийг гадарлаж байгаа биз дээ

-Уухай тийм бий гэж д'Артаньян дуугараад царай нь дахин барайв.

-Таны эмээл морь хоёрыг буцааж хожоод өөрийн эмээл морь хоёрыг бас буцааж хожсоноо дахиад алдчихлаа. Ер нь би таны эмээлийг дахин хожоод, өөрийнхийгөө бас эргүүлж авлаа. Ингээд л зогссон. Энэ тун сайн хаялт болсон би ч тэгээд түүн дээр л зогслоо гэж Атос хэллээ.

д'Артаньяны мөрөн дээр буудлын газар тэр чигээрээ дарж байснаа унаад өгсөн юм аятай болж санаа алдлаа.

-Тэгвэл, алмаас бөгж миний мэдэлд үлдэх нь шив дээ гэж тэр хулгасхийн асуув. -Эелдэг нөхөр минь, таны бүрэн мэдэлд үлдэнэ. Мөн таны дэгжин эмээл ч бас үлдсэн гэв.

-Морьгүй байж, эмээлээр бид юухийх юм бэ?

-Энэ тухайд над нэг санал байна.

-Атос та намайг айлгаад байна шүү.

-д'Артаньян та дуулж бай, өөрөө ойр хавьдаа ер тоглоогүй шүү дээ? -Тоглох ч хүсэл ер алга.

-Бүү ам алд. Тэхлээр та саядаа ер тоглоогүй болохоор тоглоомд азтай байх ёстой гэж би хэлж байна.

-За тийм байж, тэгээд юу гэж?

-Тэгээд үү? Тэр хоёр англи хүн эндээс яваагүй байгаа. Тэр хүн эмээлэнд их харамсаад байхыг би ажсан. Та янз нь мориндоо мөн их хайртай бололтой. Би таны оронд байсансан бол эмээлээ морьтой тулгаж тавиад тоглох байсан гэв.

-Тэхдээ тэр хүн чинь ганцхан эмээлтэй морио тулгаж тавиад тоглохыг зөвшөөрөхгүй шүү дээ.

-Үгүй, хоёуланг нь тавихгүй юу, чөтгөр алгад. Би тань шиг хар амиа боддог хүн биш гэж Атос хэлэв.

Атосын лав итгэлтэй байдалд өөрийн эрхгүй автаж ирсэн д'Артаньян, та бол тавиад үзэх юм биз дээ гэж тээнэгэлзэнгүй дуугарав.

-Үгүй нээрээ ганцхан л хаяад үзэх юм чинь тэхгүй яахав.

Үгүй ингэхэд морио алдчихсан хойно, ядаж эмээл авч үлдэх нь надад их чухал байгаа юм шүү дээ.

-Тэгвэл яахав, алмаас чулуун бөгжөө тавьчих.

-Еэ энэ ч бүр болохгүй, энэ насандаатийм юм би хийхгүй.

-Чөтгөр алгад, уул нь би таныг Планшег тавиад үз гэхсэн. Гэтэл түрүүн тиймэрхүү юм байсан болохоор Англи хүн одоо зөвшөөрөхгүй бий гэж Атос хэлэв.

-Ингэхэд байнаа, эелдэг Атос минь, би юугаар ч аз туршаагүй нь дээр гэж шууд санаж байна гэж д'Артаньян дуугарлаа.

Үүнд Атос хүйтнээр,

-Тоогүй дээ, англи хүний түрийвчээр дүүрэн зоос байна. Үгүй, бурхан минь ганцхан хаяад л үзээ ч дээ. Нэг тоо хаях гэдэг чинь хоромхон зуурын хэрэг шүү дээ.

-Би хожигдож орхивол яах юм?

-Та хожноо.

-Үгүй хожигдож орхивол яана?

-Яахав, эмээлээ өгчихнө биз.

-За яая гэх вэ, нэгхаяад үзэхээс гэж д'Артаньян зөвшөөрөв.

Атос , нөгөө англи хүнийг эрэхээр гараад морины саравчинд ортол, цаадах нь эмээлийг шохоорхон үзэж байлаа. Аятайхан учрал тохиолдож, Атос хоёр эмээлээ нэг морь юм уу, зуун зоостой тулгаж тавья гэсэн болзол тавив. Англи хүн дотроо бодоод үзвэл, хоёр эмээл нийлээд гурван зуун зоос хүрэх аж. Тэхлээр дуртай зөвшөөрөв.

д'Артаньян догдолсоор шоо хаяад орхисон чинь, гурван нүх уначихлаа. Залуугийн царай хэт цонхийгоод ирсэнд Атос айж:

-Муухан л юм буулаа, найз минь. Эрхэм та бүрэн хэрэглэлтэй морьд авах... гэж хэлээд зогсов.

Хөөрсөн англи хүн шоог сэгсэрсэн ч үгүй, лав хожно гэдэгт бат итгэж байсан болохоор

хаяхдаа харсан ч үгүйд'Артаньян аягуйцсэн байдлаа нуух гэж буруу харлаа.

-Үгүй бас хачнаа хөөш гэж Атос тайван дуугарав. Ийм ер бусын нүх би амьдралдаа дөнгөж дөрвөн удаа харж байгаа юм. Хоёр нүх шүү! гэж Атос ердийнхөө байдлаар тайван дуугарав.

Англи хүн, эргэж хараад мэл гайхаж д'Артаньян эргэж баярласандаа таг болчихлоо. Атос яриагаа үргэлжлүүлэн,

-Нэг удаа де Креки гуайнд дараа нь миний шилтгээнд... ер нь намайг шилтгээнтэй явах цагт манай гэрт, гурав дахь удаа де Тревиль гуайнд бууж бид цөм их гайхсан, дөрөв дөх удаа нэг гуанзанд би өөрөө хаяад зуун том алтан зоос оройн хоолтой алдсан билээ гэв.

-Ингэхлээр д'Артаньян та морио буцааж авах шив? гэж англи хүн асуув. -Тэгэлгүй яхав гэж д'Артаньян хариуллаа.

-Тэхлээр би, нэхэж болохгүй нээ?

-Бид нэхэлцэхгүйгээр ярилцсан шүү дээ, та өөрөө санаж байгаа биз.

-Тэр үнээн, морийг чинь танай зарцад өгнөө. Атос хажуугаас,

-Жаахан азнаарай, эрхэм таны зөвшөөрөлтэйгөөр би нөхөртөө хэдэн үг хэлье гэв. -Тэг, тэг гэж англи хүн хэллээ.

д'Артаньяныг Атос хажуу тийшээ дагуулж аваачив.

-За чи бас юу гэж хатгах гээд байна, намайг цаашаа бас мөрийц л гэх гээд байгаа биз дээ! гэж д'Артаньян асуулаа.

-Үгүй. таныг зүгээр нэг юм бодоосой гэсэн юм.

-Юун тухай тэр вэ?

-Та янз нь морио эргүүлж авах гэж байнаа?

-Тэгэлгүй яхав.

-Та алдаа хийж байна. Би бол зуун зоосыг нь авна. Та зуун зоос юм уу, мориныхоо аль дуртайг авахаар тоглосон шүү дээ.

-Тэгсэн.

-Би болж гэм зуун зоос авах байсан.

-Яхав, би морио л авна.

-Дахиад л хэлэхэд та алдаа хийж байна.

Бид хоёр хүн ганц мориорях юм бэ? Би таны хойгуур сундалдаад явж чадахгүй шүү дээ, тэгвэл бид Эмоны, ах дүү нараасаа төөрсөн хоёр хүү шиг харагдах байх даа. Мөн миний хажууд, тэр аян дайны сайхан морин дээрээ хөндөлдөж намайг гомдоох гэхгүй биз. Би бол эргэлзэлгүй зуун. зоос авах байсан. Парис хүрье гэхэд мөнгө бидэнд хэрэгтэй.

-Атос, би тэр моринд чинь онц хайртай юм.

-Дэмий хэрэг дээ, найз минь. Морь нэг бүдрээд хөлөө авчаж болно, өвдөг нь халцарчж болно, өвчтэй морины өвс идсэн тавиураас идээд орхих юм бол морь, чухам гэвэл зуун зоос тэгээд л өнгөрөх нь тэр. Эзэн хүн морио тэжээх болдог, гэтэл зуун зоос бол эзнээ тэжээдэг юмаа.

-Бид тэгээд юу унаж гэртээ харих юм бэ?

-Манай зарц нарын морьдыг унаад явахгүй юу, чөтгөр алгад. Бидний харсан хүн,гэртэй тэргүй жирийн нэг борчуул биш гэдгийг ойлгоно шүү дээ.

-Бид хоёр ийм ясан хэдрэг уначхаад, армаг хүлэг унасан Арамис, Портос хоёртой зэрэгцээд явахаар их аятайхан харагдах бий.

Атос үүнд инээд алдаад,

-Портос, Арамис хоёртой шүү та минь! гэв. Нөхрийнхөө ингэж хөгжсөний учрыг мэдээгүй д'Артаньян.

-Юу болов? гэж асуулаа.

-Үгүй, зүгээр яриагаа үргэлжлүүлье гэж Атос дуугарав.

-Тэхлээр таны бодлоор...

-Зуун зоосыг нь авах хэрэгтэй, д'Артаньян зуун алтан зоосоор бид сарын эцэс хүртэл наргина. Бид цөм их ядарлаа, жаахан амрахад бас зүгээр.

-Амрах ий? Тэр чүгүй, Атос Парист ормогцоо би тэр хөөрхий бүсгүйг эрж гарна гэв. -Тэх тусмаа зоосыг нь ав. Энэ хэрэгт хангинасан алтан зоосноос морь илүү хэрэгтэй болно гэж та бодож байна гэж үү? Зуун зоосыг нь ав, найз минь, зуун зоосыг л ав.

д'Артаньян ер нь зөвшөөрөн алдаад байтал сүүлчийн үг ихүнэмшилтэй санагдав. Тэгээд ч мөн зөрөөд байхаар хар амиа бодсон хүн шиг Атост санагдахаас айж, зөвшөөрөөд, зуун зоос авах болсонд англи хүн даруй тоолж өгөв.

Одоо манай нөхдийг буцах тухай бодлоос саатуулах өөр юм байсангүй. Эзэнтэй эвлэрэхэд Атосын хөгшин мориноос гадна бас зургаан зоос өгөхөд хүрэв.

д'Артаньян Атос хоёр Планше, Гримо хоёрын морьдыг унаад, зарц нар эмээлээ толгой дээрээ тавьсаар явган буцав.

Морьд хэдий муу боловч эзэд нь зарц нараасаа даруй түрүүлээд, Кревкерт урьтаж ирэв. Арамисын барааг тэд холоос харлаа. Арамис цонхны дэргэд үлгэрт гардаг "Аннагийн охин дүү" аятай уйтгарлан сууж, тэнгэрийн хаяагаар суунагласан бөөн тоос руу харж байлаа.

-Хөөе, Арамис чи юунд энд сууж байгаа юм бэ? гэж хоёр найз хашгарав.

-Еэ, д, Артаньян Атос та хоёр уу энэ чинь. Энэ хорвоогийн сайн сайхан ер хир хуурамч вэ гэдгийг би боджээ суулаа. Тэр бөөн тоосон дотор далд ороод өгсөн миний англи морь хорвоогийн алив юм ахар богино хоосон гэдгийн аль алинджишээ боллоо. Манай бүх амьдралыг байсан, байна, болно гэдэг гуравхан үгээр хэлж болох юм гэж залуу шадар цэрэг хэлэв.

Үнэнийг гадарласан д'Артаньян

-Нэг үгээр хэлбэл? гэхэд Арамис:

-Нэг үгээр хэлэхэд, тэр морь таван мод газрыг цагийн дотор хатриад туулж байгааг харвал, надад жаран том зоос өгөөд хуурчихжээ гэлээ.

д'АртаньянАтос хоёр тачигнатлаа инээд алдлаа.

-д'Артаньян найз, надад та бүү уурлаарай гачигдах гэдэг чинь ёс горимд захирагдахгүй юм байна шүү. Тэгээд ч би чухамдаа бүхнээс. их чадагдсан байна, юу гэвэл тэр муу жудаггүй наймаачин надаас лав тавин том алтан зоос шулчихсан байна. Аа харин та нар юмандаа гамтай улс болохоор өөрсдөө зарц нарынхаа морьдыг унаад сайхан армаг хүлгээ явган хүнээр хөтлүүлж, ойр ойрхон амрааж яваа биз гэж Арамис хэлэв.

Энэ үеэр хэдхэн минутын өмнө Амьений замаар ирж яваа харагдсан нэг бүхээгт тэрэг ирж буудлын өмнө зогсоод Планше, Гримо хоёр эмээлээ барьсаар тэрэгнээс бууж ирэв. Тэрэг хоосон Парис руу буцаж явсан, тэгээд тэр хоёрыг суулгасныхаа хөлсөнд зам зуур тэдний мөнгөөр юм ууж явахаар тэрэгч нь зөвшөөрсөн юм байж.

-Юу вэ, энэ чинь ердөө эмээл л байх чинь гаж Арамис гайхав.

-Одоо учир мэдээ биз? гэж Атос асуулаа.

-Нөхөд минь, та нар яг надтай адилхан юм хийжээ. Би яагаад юм бүү мэд бас эмээлээ авч хоцорсон. Хөөе, Базен, миний шинэ эмээлийг авчирч энэ эрхмүүдийн эмээлтэйцуг тавь гэлээ. -Та нөгөө лам нараасаа яаж салав даа? гэж д'Артаньян асуулаа.

~ Маргааш нь би тэднийг урьж хоолонд ирүүлсэн. Энд бас сайн дарс байдаг юм. Тэгээд сайн согтоочихсон чинь хар лам нь намайг цэрэг хувцаснаас салахыг хориглосон, ширээт лам өөрийгөө шадар цэрэг болгохоор хөөцөлдөж өгөхийг надаас гуйсан даагэв.

-Тэхдээ харин цол хамгаалуулахгүй шүү! Цол хамгаалахгүй бол яамай. Цол хамгаалах явдлыг л орхи гэж би шаардана шүү гэж д'Артаньян дуу алдав.

Арамис яриаг аа залган,

-Тэр цагаас хойш, миний амьдрал таатай өнгөрч байна. Би нэг үетэй үгээр шүлэг зохиож эхэлсэн. Энэ зүйл бэрх боловч, алив юмны амтнь бэрх хэцүүдээ л байдаг хойно доо. Агуулга нь янаг дурлалын явдал. Нэгдүгээр бүлгийг нь би та нарт уншиж өгнө. Үүн дотор дөрвөн зуун мөр шүлэг байгаа боловч, ганцхан минутад уншиж барах юм гэлээ.

Шүлэгт латин хэлтэй адилхан шахуу дургүй д'Артаньян үүнд,

-Ингэхлээр байнаа, Арамис найз минь, хүнд бэрх гэдэг сайн тал дээрээ, богино товчхон гэдэг сайн тал бас нэмчих тэхлээр таны яруу найрагт лав хоёроос доошгүй сайн талтай болно гэдэгт эргэлзэхгүй байж болно гэлээ.

-Үүнээс гадна, миний яруу найраг ариун сайхан эрмэлзлээр дүүрэн болохыг та нар өөрсдөө үзнээ. Ингэхлээр, нөхөд минь бид чинь Парис руугаа буцах болж байх шив? За сайн. Би бэлэн байна. Манай сайн Портостойгоо бид дахин уулзана. Би ч баяртай байна. Тэр цагаахан сэтгэлтэй луг эр надад хир үгүйлэгдээд байгааг та нар тухайлж ч чадахгүй дэг. Мань хүн харин, бүхэл бүтэн улс гүрэн өгье ч гэсэн морио худалдахгүй хүн дээ. Армаг хүлгээ унаад бас шинэ эмээлтэй ханхалзаж байхыг нь бибушуухан нэг харах юмсан. Тэр лав их Моголтой төстэй харагдана шүү гэж Арамис хэллээ.

Гурван нөхөд энд морьдоо амраахаар нэг цаг амраад, Арамис буудлын эзэнтэй тооцоогоо хийж, Базенийг нөхөдтэй нь бүхээгт тэргэнд суулгаад цөм цаашаа Портос дээр очихоор хөдлөв.

Портосын бие нэгэнт сайжирчихсан д'Артаньяны анх ирэхэд байсан шигээ цонхигор биш, өөрөө ганцаараа мөртлөө дөрвөн хүний хоол зэхэж тавьсан ширээний ард сууж байв. Сайхан бэлтгэсэн махан хоол, тэргүүн сайн дарс сонгомол сайхан жимс сэлтийг ширээн дээр тавьсан аж.

Портос суудлаасаа босоод,

-Морилцгоо эрхмүүд, та нар яг цагт нь тааруулаад ирлээ, би дөнгөж сая хоол идэхээр суугаад байна та бүхэн цуг зооглож үз гэв.

-Ой ёо, энэ лонхтой чинь нөгөө Мушкетоны бугуйлдаж авчирдаг дарс биш шив. Бас тугалын мах, ер нандин хоол зөндөө... гэж д'Артаньян дуугарав.

-Би биеэ тэнхрүүлж байна, би байна шүү биеэ тэнхрүүлж байгаа хүн. Тэр золигийн муу хөл булгарснаас илүү шаналгаатай юм гэж үгүй юм байна. Атос, та ер хөлөө булгалж явсан уу?

-Үгүй, гэхдээ бид нөгөө Феру гудамжнаа тулалдахад би илдээр бүлүүлчихээд, хоёр долоо, хоног хагас хиртэй болоход, бие минь таны одоогийнх шигбайсан санагдана гэв. -Эелдэг сайн Портос минь гэхдээ энэ хоолыг та ганц өөртөө захиагүй бололтой? гэж Арамис дуугарав.

-Үгүй, би ойр хавьд суудаг хэдэн тайжийг урьсан юм. Гэтэл тэд ирж чадахгүйгээ дөнгөж сая

хэлүүлсэн байна. Та нар тэдний оронд ирлээ, үүнээс би өчүүхэн ч алдахгүй байгаа хэрэг. Хөөе Мушкетон, сандал тавь, дарс дахиж авчир гэв.

Хэсэг зуур болсон хойно, Атос бид юү идэж байгааг та нар мэдэж байна уу? гэж асуулаа. д'Артаньян үүнд,

-Мэдэлгүй яахав. Би хувьдаа тугалын амталсан мах, тархи идэж байна гэв, -Би хонины мах идэж байна гэж Портос дуугарав. Арамис мөн,

-Би ч тахианы өвчүүл идэж байна гэнэ. Үүнд Атос,

-Эрхмүүд та нар цөм эндүүрч байна. Та бүхэн морины мах идэж байна гэж төв байртай дуугарав.

д'Артаньян,

-Боль доо? гэв.

-Морины мах гэнээ? гэж Арамис дургүйцсэн байртай ярвайна.

Ганцхан Портос л юм дуугарсангүй.

-Нээрээ морины мах. Портос, бид нээрээ морины мах идэж байгаа биз. Магадгүй, эмээлтэй нь ч идэж байж магад гэлээ.

-Үгүй эрхмүүд ээ, би эмээлээ ч авч хоцорсоон гэж Портос өчив.

-Үнэндээ бид бас хачин улсаа, яг хэлцэж тохирсон юм шиг гэж Арамис хэллээ.

-Яая гэх вэ? Тэр морь, миний зочдын сэтгэлийг аягүйрхүүлээд байхаар, тэдэнд сайрхахыг би хүссэнгүй гэж Портос хариулна.

-Тэгээд ч танай нөгөө Герцогийн авгай рашаанд амарсаар байгаа биз дээ? гэж л' Артаньян асуулаа.

-Тэндээ л байгаа гэж Портос хариуллаа. Тэгээд байна шүү. миний моринд нутгийн дарга шохоорхоод болдоггүй тэхлээр нь би түүнд өгчихсөн. Өнөөдөр манайд ирэх ёстой хүний нэг нь тэр дарга байсан юм.

-Өгчихсөн гэнээ! гэж д'Артаньян дуу алдав.

-Тэгсээн, бурхан. минь. Яг л өгчихсөн дөө, юу гэвэл тэр морь лав зуун тавин алтан зоос хүрэх морь, гэтэл тэр муу харамч надад паян зоосноос цааш өгдөггүй шүү гэж Портос хэлэв.

-Эмээлгүй тэр үү? гэж Арамисыг асуухад:

-Тиймээ, эмээлгүй гэв.

Атос үүнд, харж байгаа бизэрхмүүдээ. Портос маань л биднээсээ дээр сайн амжуулсан байна шүү гэлээ.

Бөөн инээдэм болоод, хөөрхий Портос бүр зовж орхисонд инээдмийн учрыг түүнд хэлж өглөө. Портос учрыг мэдээд, уулын дуутай шуутай хүн болохоор бусадтайгаа даруй нийлэв.

-За тэхлээр бид цөм мөнгөтэй болоо шив? гэж д, Артаньян асуулаа.

-Би л үгүй шүү гэж Атос маргалаа. Арамисын тэр испани дарс надад тун аятайхан санагдаад, би жараад шилийг тэргэнд ачуулчихсан чинь миний хэтэвч хоосроод явчихсан гэлээ. Арамис мөн,

-Би байна шүү, Мондидьегийн сүм, Амьены хийд хоёрт хамаг мөнгөө өгч нэхэгдээд байсан өрийг нь дарснаас гадна өөрийнхөө болон та нөхдийн төлөө ерөөл тавиулахаар захисан, тэр бидэнд тус болно гэдэг лавтай гэв.

-Аа, миний булгарсан хөл бас яана гэв? Үүнээс болж надаас гарлага гараагүй юм та нар бодож байна уу? Мушкетоны шархыг ч бүр яриад яахав. Түүнээс болж би өдөрт эмч хоёр дахин дуудахад хүрч байлаа. Тэгээд ч үүнийг эм найруулагчид л үзүүлэхээс өөр хүнд үзүүлшгүй газраа шархадсан гэдэг нэрийдлээр, надаас хоёр нугалж өндөр үнэ авч байсан. Цаашид, тийм газраа бүү шархдаж бай гэж би Мушкетонд сануулга өгсөн гэв.

д'Артаньян, Арамис; хоёртой Атос харц солилцоод,

-Яахав, хөөрхий хүнийг та сайн эзний ёсоор асарсан байна гэлээ.

Портос цаашаа,

-Үгүй тэгээд товчхон хэлэхэд, бүх өр ширээ өгсөн хойно надад нэг гучаад энгийн зоос үлдэх болов уу гэлээ.

-Над нэг арваад алтан зоос бий дэг гэж Арамис дуугарлаа.

-За тэгвэл, та нарын дэргэд бид баячуул юм шив. Манай зуун алтан зоосноос хэд үлдлээ д'Артаньян? гэж Атос, асуув.

-Зуун зоос гэнээ? Юуны өмнө, тавийг нь би танд өгсөн.

-Тийм билүү?

-Чөтгөр алгад, тэгээгүй юу

-Өө нээрээ, одоо саналаа, яриагүй зөв,

-Буудлын эзэнд би зургаан зоос өгсөн.

-Үгүй тэр буудлын эзэн яасан сүрхий эд вэ? Та юунд зургаан зоос түүнд өгсөн юм бэ? -Үгүй

та өөрөө намайг өг л гээгүй юу

-Таны зөв, би их зөөлөн сэтгэлтэй хүн юм. Үгүй тэгээд нэг үгээр хэлбэл хэд үлдсэн бэ? -
Хорин таван зоосүлдсэн гэж д'Артаньян хэлэв.

-Надад гээд Атос халааснаасаа задгай мөнгө гаргаж ирсэнд, нөхөд нь танд юу ч алга гэв. -
Нээрээ ч ийм юмыг нийтийн санд нийлүүлээд ч яахав дээ гэж Атос хүлээв. -За одоо бодоод
үзье, Портос танд хэд байгаа билээ?

-Гучин энгийн зоос. -Арамис?

-Арван алтан зоос.

-д'Артаньян танд?

-Хорин таван алтан зоос байна.

-Эд бүгд нийлээд хэд болох билээ гэж Атос асуусанд тооны ухаанд Архимед шиг сайн тоочин
болох д'Артаньян;

-Дөрвөн зуун далан таван энгийн жижиг зоос гэж хариуллаа.

Портос үүнд, Парис очсон хойно бидэнд, эмээлийг оролцуулалгүйгээр бүтэн дөрвөн зуун
жижиг зоос үлдэх юм байна гэлээ.

-Үгүй тэгээд, аян дайнд унах морьгүй яах вэ? гэж Арамис асуув.

-Яахав зарц нарынхаа дөрвөн морьдыг бид хоёр эзний морь болгоно. Дөрвөн зуун энгийн
жижиг зоос гэдэг чинь явган үлдсэн нэгний маань морины тал үнэ гэсэн үг. Тэгээд цөм
халаасаа сэгсрээд юу гарсны нь д'Артаньянд өгнө. Энэ азтай хүн байгаа юм аль ойр байгаа
тоглоомын газарт очиж тоглоод хожно ердөө л гүйцэх нь тэр гэж Атос шийдэв.

-Алив, хоолоо идэцгээе, хөрчихлөө гэж Портос хэллээ. Цаашдын аж төрлийн тухай дөрвөн
нөхөд ийнхүү жаал санаа амраад хоолоо сайн идэж, үлдсэний нь Мушкетон, Базен, Планше.
Гримо нарт өгөв.

Парис хүрч ирэхэд д'Артаньянд деТревиль гуайгаас нэг захидал ирчихсэн байв. Тэр захидалд
д'Артаньяны хүсэлтийг ёсоор болгон. шадар цэргийн эгнээнд орох зөвшөөрөл ван эзэн түүнд
хайрласан гэж дуулгасан байлаа.

Бонасье авгайг олохсон гэхээс гадна д'Артаньяны гол хүсэж мөрөөдөж явдаг зүйл энэ
болохоор дөнгөж хагас цагийн өмнө салсан нөхөд рүүгээ баяр хөөр болсоор гүйж хүртэл
цаадуул нь сүрхий санаа зовж, гутарсан байртай байлаа. Гурван нөхөд юм зөвлөж ярилцахаар
Атосынд цугларсан нь ямагт байдал төлөв нилээд бэрхшээлтэйн тэмдэг мөн билээ.

Их эзэнтэн хаврын адаг сарын эхээр дайн эхлэх шийдвэр төгс байгаа болохоор даруй аян
дайны бүх хэрэгслээ олж авбал зохихыг д' Тревиль гуай тэдэнд сая дуулгасан аж.

Де, Тревиль гуай сахилга батын юманд сүрхий чанд хүн, мань дөрвөн нөхөд бүр мухардаж орхиод өөд өөдөөсөө харж зогсоно.

-Энэ хэрэгслээ бүгдийг хэдий хир үнэнд багтана гэж та нар бодож байна? гэж д'Артаньян асуув.

Арамис үүнд,

Хэргийн байдал базаахгүй байна. Бид сая бодож үзлээ, гэхдээ чухам илүү дутуу юмгүй Спартакчууд шиг нарийн бодож үзтэл хүн тус бүрд доор хаяад л мянга таван зуун энгийн зоос хэрэгтэй байна гэж хариулав.

-Мянга таван зууг дөрвөөр үржүүлэхэд зургаан мянган зоос гэж Атос дуугарлаа.

-Би чухамдаа юмыг Спартакчууд шиг биш, бичээч шиг боддог юм гэлээ гэхдээ миний санахад, хүн тус бур мянган зоостой бол гэж д, Артаньяныг хэлбэл "бичээч" гэдэг үгийг сонсоод Портос сэргэж,

-Үгүй, ингэхэд над нэг санаа төрлөө гэв.

-Санаа төрдөг чинь бас нэг юмаа, гэтэл надад санагдах юм даан ч алга гэж Атос хүйтнээр хариулаад,

-д'Артаньян ч яахав, манай эгнээнд орно гэж баярлаад, юм бодож чадахааргүй болж. Мянган зоос гэнэ шүү, та минь! Үгүй; надад л лав хэлэхэд, хоёр мянган зоос хэрэгтэй, нээрээ шүү гэв.

-Хоёрыг дөрвөөр үржүүлбэл найм гэж Арамис хариу дуугараад, за тэхлээр аян дайны хэрэгслээ бэлтгэхэд найман мянган зоос бидэнд хэрэгтэй байна даа. Гэхдээ ч бидэнд одоо эмээл байгаа шүү гэлээ.

Де Тревиль гуайнд очиж баярласнаа хэлэхээр гарсан д'Артаньяныг хаалга хаасан хойно Атос,

-Түүнээс гадна манай нөхрийн хуруунд гялалзаж байгаа сайхан алмаас чулуун бөгж байна. Чөтгөр алгад! д'Артаньян тийм их үнэтэй эрдэнэ хуруундаа зүүж яваад, нөхдөө гачигдалтай байдалд үлдээхээргүй сайн нөхөр гэж хэлэв.

XXIX. ХЭРЭГСЛЭЭ ТӨХӨӨРӨХӨӨР ХӨӨЦӨЛДӨВ

Дөрвөн нөхдийн дотроос д'Артаньян торгон цэргийн хүн болохоор өндөр сурвалжтай шадар цэргүүдийг бодвол хэрэгслээ төхөөрөхөд хялбар хэдий боловч, мэдээжээр хамгаас их сэтгэл зовж явлаа. Манай гаскон залуу их хянуур. бараг юманд харамч гэмээр хүн болохыг уншигч олон өөрсдөө мэдсэн, гэхдээ мөн гоёж гоодохдоо Портосоос дугуугүй шахам дуртай хүн байлаа. (Ийм эсрэг тэсрэг занг чухам яаж тайлбарладаг юм бүү мэд) гэхдэээнэ үеэр д'Артаньянд гоёж гоодох гэсэн санаандаа хүрэх гэж зовохын хамт, мөн сэтгэл зовох, амь хувиа хичээсэн биш өөр юм байлаа. Хэдий их сураг тавивч Бонасье авгайн тухай юу ч дуулдсангүй. Де Тревиль гуай тэр бүсгүйн тухай хатанд дуулгасан, хатан өөрөө наймаачны залуу гэргий хаа байгааг мэдэхгүй болохоор эрж эхэлнэ гэж амласан, гэхдээ тэр ам их тодорхойгүй байсан болохоор д'Артаньяны сэтгэлийг ер тайвшруулахгүй байлаа.

Атос хэрэгсэл олох гэж огт хөөдөлцөхгүйгээр шийдээд гэрээсээ гарахыг больжээ.

-Бидэнд одоо хоёр долоо хоног үлдээд байна. Энэ хоёр долоо хоног шувтаргал ямар нэг юм олохгүй, чухам гэвэл юм өөрөө олохгүй би бол амиа хорломооргүй шажин шүтлэгтэй хүн болохоор их гэгээнтний дөрвөн торгон цэрэг юм уу, найман англи хүнтэй хэрүүл өдөж, аль нэгэнд нь алагдталаа тулалдана. Төдий хүнтэй хэрүүл өдлөө гэхэд лав алагдаж таарна. Тэгвэл хүмүүс намайг ялгаагүй л ван эзний төлөө амиа өгчээ гэнэ, тэхлээр би хэрэгсэл сэлт бэлтгэлгүйгээр үүргээ гүйцэтгэнэ шүү дээ гэж Атос нөхдөдөө ярьдаг байлаа.

Портоснуруугаа үүрч өрөөгөөр холхиж, толгой сэгсэрч,

-Би нөгөө санаанд орсноо хийнэ гэдэг байв. Арамис үс зүсээ нарийн сайн янзлаагүй, баргар царайлан дуугүй сууна.

Энэ бүх муу шинжийг үзэхэд, нөхдийн дотор их л уруу гутруу байгаа нь илт.

Нөгөө талаас зарц нар үлгэрийн сайн хүлэг морьд шиг эздийнхээ хамт гутарч, Мушкетон талх хатааж, хэзээний сүжиг ихтэй Базен сүмээс гарахаа болив. Планше ялаа тоолж, хэдий цөм ийм гунигт байдалд орсон боловч, эзнийхээ захирсан ёсоор ам нээдэггүй Гримо чулууг боловч уяруулж зөөлрүүлмээр айхтар санаа алдана.

Хэрэгсэл сэлтийг төхөөрөхөөр ганц ч алхам хийхгүй гэж Атос амласныг бид дээр дурссан. Ингээд цаад гурван нөхөд, гэрээсээ өглөө эрт гараад, их орой буцаж ирнэ. Тэр гурав гудамжаар хэсэж, хүн амьтан хэтэвчээ унагачхаагүй болов уу гэсэн шиг чулуу бүхнийг ажиж явна. Ямар нэг хүн мөрдөж яваа юм шиг дайралдсан бүхнийг айхтар хянуур ажиглана. Хоорондоо дайралдахаараа "За? чи юм олсонгүй юү?" гэсэв байртай цөхөрсөн харц солилцоно. Гэхдээ хамгаас түрүүн нэг юм сэдэвлэсэн Портос түүнийхээ тухай шургуу бодсоор бусдаасаа түрүүн түүнийгээ хэрэгжүүлж гарав. Манай эрхэм Портос гуай их эршүүд шийдмэг хүн билээ. Портос нэг өдөр Сен-Ле сүм рүү явж байхыг д'Артаньян хараад нэг юм зөгнөж мэдсэн шиг, хойноос нь сэм дагалаа. Бурхны ариун ордонд орохынхоо өмнө Портос сахлаа имрээд, хувцсаа засах нь хэзээнээс аваад нэг юманд зориглож байгаагийн шинж. билээ. д'Артаньян мөн түүний нүдэнд өртөхгүйг хичээсээр хойноос нь орлоо. Портос очиж нэг багана түшин зогссонд д'Артаньян мөн тэр баганыг нөгөө талаас нь очиж түшив.

Ламтан ид уншлага уншаад сүмд сүсэгтэн олон дүүрэн аж. Портоc энэ байдлыгашиглан бүсгүйчүүдийг сэм ажиж гарав. Мушкетоны хичээл сайтайн ачаар манай шадар цэргийн гадаад байдалд доройтсон шинж ергүй. Чухамдаа малгай нь жаал элэгдэж, өдний сор унаж хатгамлын өнгө бүдгэрч, сүлжмэл гоёлууд нь сүрхий муудсан боловч бүдэг гэрэлд эд бүгд сайн харагдахгүй, Портоc аанай л хээнцэр Дэгжин харагдаж байлаа.

Тэдний түшээд зогсож байгаа баганад хамгийн ойр байгаа нэг вандан сандал дээр хар малгай өмссөн ялихгүй шарланг ясархаг царайтай хижээлдүү насны боловч ихэмсэг цэх суусан авгай байхыг л' Артаньян харлаа. Портоcын хараа энэ бүсгүй дээр сэм тусаад, цаашаа сүмийн гүн рүү халтирна.

Авгай ч мөн сүмд байгаа улсыг хичээнгүйлэн ажиж зогсох тогтворгүй Портоc өөд цахилгаан мэт харц чулуудаадцарай нь байн байн улайна. Портоcын ийнхүү бусдыг шохоорхож байгаад авгайн дургүй тун ч их хүрч байх бололтой, уруулаа цус гартал хазлан, хамрынхаа үзүүрийг маажилж, суудал дээр байж ядан хавчих аж.

Портоc үүнийг ажаад, дахин сахлаа имэрч, хувцсаа засаад, сүмийн голд байгаа гуа сайхан бусгүйд элдвээр дохио өгч эхлэв. Цаад бүсгүй гуа сайхнаар зогсохгүй өндөр сурвалжит хүн бололтой бүсгүйн ард сөхрөн мөргөхөд дэвсэх жинтүү барьсан хар арьстан шивэгчнээс гадна, залбирал уншиж байгаа номын нь баринтаг болох гэрийн сулд хатгамалласан алчуур барьсан зарц бүсгүй зогсож байлаа.

Наад хар малгайтай авгай Портоcын харцыг манаж үзвэл ямагт л нөгөө хилэн жинтүүтэй хар арьст шивэгчин, зарц бүсгүй хоёр дагуулсан язгууртан бүсгүй дээр тусаад байв. Гэтэл Портоc чадамгай арга зохиож, нүдээ ирмэн хуруугаа уруулдаа хүргэж, сэтгэл булаам сайхан инээмсэглэх нь үнэхээр ч наад хаягдсан авгайн зүрхийг зүсэх аж.

Эцсийн эцэст хөөрхий авгай өөрийнхөө буруу гэсэн байртай цээж рүүгээ шаагаад чангаас чанга (хайн) гэж дуугарсанд хүн бүхэн, улаан жинтүүтэй бүсгүй хүртэл тийшээ эргэж харав.

Улаан жинтүүтэй бүсгүй үнэхээр ч гуа сайхан хүн байсанд, өрсөлдөхүйеэ аюултай хүн гэж харсан хар малгайт авгай болон, хар мал гайт авгайгаас ихээ илүү сайхан гэж харсан Портоc, мөн д'Артаньян нарт сүрхий сэтгэлэг төрүүллээ. Тэр бүсгүй нөгөө Менг, Кале, Дувр зэрэг газар дайралдаж байсан, өөрт ньөстэй, хацартаа сорвитой хүний Миледи гэж дуудаж байсан хүн мөнийг д'Артаньян танив.

д'Артаньян тэр улаан жинтүүтэй бүсгүйг хараанаасаа салгалгүй байхын зуур тун хөгтэй санагдсан Портоcын аашлахыг ажсаар байлаа. Хар хувцастай авгайг лав нөгөө Баавгай гудамжнаа суудаг хууль хамгаалагч прокурорын гэргий гэж таалаа, тэгээд ч Сен-Легийн сүм тэндээс онц холгүйбилээ.

Цаашлуулан бодоод Портоc, дээр Шантильигаас бичээд байхад прокурорын гэргий хэтэвчнийхээ амыг онгойлгохгүй зөрүүд байсны өшөөг авах санаатай байгааг мэдлээ.

Гэтэл, Портоcын сээтэн хаяж байгааг харж хариулсан хүн ер үгүйг д'Артаньян ажлаа. Эд бүгд чухам нэг хий хоосон мэх мөн аж, гэлээ гэхдээ үнэн дурлал, жинхэнэ жөтөөрхтөл гэгчид

хий хоосон мэхнээс илүү үнэн юм гэж ер байх биш дээ.

Уншлага дуусаж, прокурорын гэргий аршаантай сав руу очлоо. Портос авгайгаас урьтаж, аршаанд хуруугаа дүрэхийн оронд бүхэл гараа хийчхэв. Портосыг өөрийнхөө төлөө хичээж байна гэж санасан прокурорын гэргий инээмсэглэтэл, гэнэт айхавтар муухай урам хугарахад хүрэв, Авгайг гурван алхам хиртэй дөхөөд ирэх үед Портос цаашаа эргээд, сая суудлаасаа босч шивэгчин, зарц хоёроо дагуулсаар наашаа ирж явсан улаан жинтүүт бүсгүй өөд харчхав.

Улаан жинтүүтэй бүсгүй Портосын дэргэд хүрч ирэхэд манай шадар цэрэг ариун аршаанд дүрсэн гараа авсанд сүсэгтэн гуа бүсгүй нарийхан гараа Портосын луг гарт хүргээд инээмсэглэж загалмайлан залбираад гарч одов.

Энэ даанч дэндүү, Портос язгууртан бүсгүй хоёрын хооронд янаг амрагийн холбоо байгаад прокурорын гэргий одоо бүр эргэлзэхгүй боллоо. Авгай өөрөө язгууртан бүсгүй байсансан болж гэм ухаан алдах байсан, гэвч ердөө л нэг прокурорын гэргий болохоороо яахав, хорслоо барьж ядан байж шадар цэрэгт:

-Тийм бий, Портос гуай. Та чинь пад аршаан утгаж өгөхөө болио шив гэж хэлээд л зогслоо.

Авгайн дууг сонсоод Портос зуун жилийн нойрноос сая сэрж байгаа хүн аятай цочиж.

Пээ , а . . . авгатайн, энэ чинь та юу? гэж дуу алдан, Танай нөхөр, эрхэм Кокнар гуайн бие сайн биз дээ? Танай нөхөр нөгөө харамч хатуу хэвээрээ юү? Үгүй би ер яагаад таныг харсангүй вэ? Уншлага хоёр цаг үргэлжилж байх зуур би таныг олж хардаггүй бас хачнаа? гэв.

Прокурорын гэргий үүнд;

-Танаас би хоёрхон алхмын зайтай сууж байсандаа. Эрхэм ээ. Та сая өөрөө аршаан утган өгсөн, тэр сайхан

! бүсгүйгээс нүд салгаж чадахгүй байсаар намайг харсангүй гэж хариуллаа.

Портос зовсон дүр үзүүлж.

-Еэ тийм үү, та тэгвэл . , . ажсан байхнээ гэж тэр дуугарлаа.

-Түүний чинь сохор л хүн биш бол ажихгүй байхын эрхгүй байсан гэж авгай хариу дуугарав.

Портос үүнд хааш хэрэг,

-Тэр бүсгүй, миний сайн танил, нэг Герцог гуайн гэргий юм. Нөхөр нь айхтар жөтөөрхөг хүн болохоор бид уулзалдахад их хэцүү. Тэгээд тэр маань өнөөдөр энэ бөглүү газар, энэ муу сүмд надтай дайралдахаар ирнэ гэж хэлүүлсэн юм гэлээ.

-Портос гуай, та надад гараа өгч сугадуулаад тавхан минут хир цуг явахгүй юү? Өөртэй чинь ярилцмаар юм байна гэж прокурорын гэргий гуйлаа.

Портос үүнд, тоглоом тоглож байгаад, сайн явах гэж зэхэж байгаа хүний байртай, сэм нүдээ ирмэж инээмсэглээд

-Дуртайяа тэгье авгатайн гэв.

Энэ үеэр, Миледигийн хойноосдагаж явсан д'Артаньян тэр хоёрын хажуугаар өнгөрч гарахдаа эргэж харвал Портосын харцанд дийлсний бах илтэд харагдав. Өөрийнхөө тэр хөнгөмсөг үеийн, хийсвэр зан суртахуунтай д'Артаньян яв цав тохирсон дүгнэлт хийж дотроо, "уухай юу ч гэсэн. Портос л лав тогтоосон цагт хэрэгсэл сэлтээ бэлтгэж чадах даг" гэж бодлоо.

Прокурорын бүсгүйн гарт, залуурандаа захирагдах завь аятай хөтлөгдсөөр явж мань Портос, Сен -Маглуар сүмийн ойролцоо, хоёр талаараа таримал ургамлаар халхлагдсан нэг буйд газарт хүрч ирлээ. Өдрийн цагт энд юм идэж суугаа гуйлгачин, тоглож бий хүүхдээс өөр хүн эс дайралдах билээ.

Энд байнга ирдэг хүүхэд, гуйлгачин нараас өөр үг дуулахаар хүн үгүйг үзээд, прокурорын авгай дуу алдаж,

-Аа Портос гуай, та чухам олон бүсгүйчүүлийн сэтгэлийг их зовоодог хүн юмаа! гэв. Портос цээжээ түхийлгэн,

-Би юу, авгатайн? Та яагаад тэгж бодож байгаа юм бэ? гэж асуулаа.

-Таны дөнгөж сая элдвээр тохио өгөөд байсан, мөн аршаан утгаж өгсөн хоёрыг яахав? Тэр хар арьстан шивэгчинзарц хоёрыг дагуулсан сурвалжит бүсгүй чинь хэн юм бэ?

Доор хаяад л гунж хүн . дэгээ? гэхэд, Портос хариулуун:

-Үгүй, та эндүүрч байна, тэр чинь ердөө л Герцог хүний гэргий гэв.

-Тэгвэл, гадаа үүдэн дээр хүлээж байсан дагуул, ямбаны хувцастай хөтөч жолоодсон сүйх тэрэг сэлт юу юм бэ?

Хөтөч, сүйх альалины нь Портос огт ажигласангүй, харин Кокнар авгай жөтөөрхсөн эм хүний ажигч нүдээр цөмийг харж амжжээ.

Улаан дэртэй бүсгүйг даруй гүнж болгон өргөмжилж яриагүй дээ Портос харамсав. Прокурорын гэргий санаа алдаад,

Ээ дээ, Портос гуай, гуа сайхан бүсгүйчүүл таныг мөн их эрхлүүлэх юмаа даа гэлээ.

-Иймэрхүү царай зүстэй төрсөн хүн болохоор амраг дурлалын алив явдал надад ховор биш тохиолдоно гэдгийг та өөрөө ойлгож байгаа хойно доо гэж Портос хариу дуугарав. Ээ бурхан минь! Эрэгтэйчүүл гэгч ер нь ямар мартагтай хуурамч улс вэ? гэж авгай дуу алдаад тэнгэр өөд харав. Портос үүнд,

-Тэхдээ л бүсгүйчүүд шиг мартамтгай биш дээ ухаан нь би байна. Би өөрөө авгатайн таны тоглоом болсон хүн гэж өөрийгөө лавтай хэлж чадна. Сурвалжит гэр бүлээс гаралтай хүн би, таны нөхөрсөг сэтгэлд итгэж явсаар эхлээд шархдаж тэрнээсээ болж үхэх шахаад, эцэс сүүлдээ Шантильин нэг муу буудалд өлбөрч үхэх шахаад, өөрт чинь халуун дотно захидал илгээгээд байхад та ядаж хариулаа ч үгүй шүү дээ.

Тэр үед, өндөр сурвалжит бүсгүйчүүдийн дэргэд өөрөө аргагүй муу юм хийсэн санагдаад, прокурорын гэргий гэмшиж, Портос гуай та миний үгийг сонс . . . гэтэл Портос цаашаа ...

-! Таны төлөө би . . . бээл гуайн гэргийг хаясан гэлээ.

-Би үүнийг мэднээ.

-Гүн . . . гуайн гэргийг мөн ...

-Оо, Портос гуай миний сэтгэлийг бодож үзээч!

-Бас Герцогде . . . гуайн гэргийг . . .

-Портос гуай та өгөөмөр сэтгэл гаргаж хайрлаач!

-За яахав, авгатайн би амаа татъя.

Үгүй' манай нөхөр, юм зээлүүлнэ гэхийг дуулах ч дургүй байна шүү дээ.

-Кокнар авгай та надад бичээд, миний сэтгэлд хадагдан үлдсэн захидлаа санаад үз гэж Портос дуугарав.

Прокурорын гэргий гүнээ санаа алдлаа.

-Та даанч их мөнгө зээлүүлээч гэсэн болоод л тэр шүү дээ.

-Кокнар авгай, би өөрт чинь илүү сайн болоод л тэгсэн юм. Нэг зурвас бичээд л Герцог де . . . гуайн гэргийд явуулчихвал гүйцэх байсан. Бүсгүй хүний нэрийг хайрладаг болохоор, би нэрий нь хэлэхгүй Ер нь түүнд л бичээд орхисон бол надад тэр дороо мянга таван зуун зоос ирүүлэхсэн билээ.

Прокурорын авгайн нүднээс нулимс гарлаа.

-Портос гуай, танд үнэнээ хэлэхэд, та намайг айхтар хатуу залхаалаа, хэрэв та хожим тиймэрхүү байдалд орох юм болж гэм надад бичээд л орхивол болох нь тэр гэж авгай хэлэв.

-Авгатайн та зовохоо яасан юм бэ? гэж Портос унтууцсан хүний дүр үзүүлээд, -Мөнгөний тухай ярихаа больж үз. Энэ чинь дур гутмаар юм байна гэв

-Ингэхлээр та намайгхайрлахаа нэгэнт больжээ дээ гэж прокурорын гэргий алгуур, гунигтай гэгч дуугарлаа.

Портос ихэмсэг ууртай таг дуугүй зогсоно. -Тэгнээ тэр, таны хариулт энэ биз дээ, би ойлгож байнаа, аргагүй.

Та намайг яаж доромжилсноо санаад үз, тэр чинь миний энд харагдаад байна гэж Портос гараар зүрхээ дарж өгүүлэв

-Итгэж үз надад, хонгор Портос минь, би тэр гэмээ цагаатганаа.

Портос тун гэнэн цагаахан байртай мөрөө хавчисхийж,

-Үгүй, тэгээд, танаас би юу гуйсан билээ? Ердөө л хэдэн мөнгө зээлдүүлээч гэж гуйсан билээ. Чухамдаа би бас учир мэдэхгүй ч хүн биш шүү, Кокнар авгай, таны баян чинээлэг биш, танай нөхөр, заалдсан улсын сүүлчийнх нь сохор зоосыг хүртэл хяхан авч амь зуудгийг би мэдэлгүй яахав. Харин та бээл, гүн, Герцог хүний гэргий байсан болж гэм өөр хэрэг тэгвэл таны тэгж аашилсныг уучлахын эрхгүй байхсан билээ гэв.

Прокурорын гэргийн шар хөдөлчихлөө.

-Ингэхэд байна шүү, Портос гуай, миний мөнгөний авдар, хэдийгээр жирийн нэг прокурор хүний гэргийн авдар боловч, танай тэр олонхоосорч гүйцсэн, маягны гэрүүдийн бүгдийн нь авдраас илүү ч дүүрэн байж мэдэх юм шүү гэж авгай үг хаяв.

Портос гараа прокурорын гэргийн гараас сугалж аваад,

-Тийм болж гэм, Кокнар авгай та намайг давхар давхар доромжилжээ. Та тийм баян байж таны тэгж харамласныг зөвтгөх юм алга гэлээ.

Шаралхаж байж дэндүү их ам алдчихсанаа сая ухаарсан прокурорын гэргий санаа авч, - Миний "баян" гэснийг яг тэгж ойлгох нь ч юу юм. Би баян ч хүн биш, яахав амь зуулгатай л хүн юм гэв.

-За ингэхээр байна шүү, энэ яриаг ингээд дуусгая, авхайтан минь. Та намайг хаясан хүн. - Ачийг боддоггүй муу хүнээ та!

-Үгүй, таны сэтгэлд бас хангалтгүй байна уу? гэж Портос хэллээ.

-Яв, яв, тэр Герцогнын сайхан гэргий дээрээ оч, таныг би хоргоохоо больё. -Яахав ээ, миний санахад, тэр чинь овоо царайлаг бүсгүй шүү.

-Портос гуай, миний үгийг сонс доо, эцсийн удаа асууя надад та одоо сэтгэлгүй болсон уу? гэлээ.

Портос үүнд чадах хирээрээ гунигтай дуугаран -Өө, авгатайн минь, би ингээд аян дайнд мордохоор, миний зөн үнэн бол би алагдаж таарна... гэтэл, прокурорын авгай асгартал уйлан, дуу алдаж,

-Битгий ийм муухай юм ярь даа гэж гуйлаа. Портос улам бүр гунигт авган, -Би нэг л ингэж

зөгнөөдбайгаа хүн дээ гэв.

-Үүнд орохноо, зүгээр өөр хүнтэй сайн болсон гэж ярьсан ч дээр байна.

-Үгүй, үгүй, би үнэнээсээ ярьж байна Ямар ч шинэ хүн миний сонирхлыг татаагүй, тэр ч байтугай сэтгэлийн гүнд танд сайн байсаар байгаа минь мэдэгдээд байна. Та мэдэж ч байж мэднэ, үгүй ч байж мэднэ, хоёр долоо хоногийн дараа бид, тэр аюулт дайнд мордох гэж байгаа болохоор би энэ зуур хэрэгсэл сэлтээ төхөөрөх гээд тун завгүй байх болноо. Ингэхлээр Бретань нутагт ах дүү дээрээ очиж л хэрэгтэй мөнгө сангаа олж ирэх болоод байна гэв.

Ингэтэл авгайн дотор хайр сэтгэл, харамч зан хоёр ана мана тэмцэлдэн байгааг Портосажив.

-Тэгээд таны дөнгөж сая харсан тэр Герцогын гэргийн эдлэн газар манайхтай айл залгаа байдаг болохоор бид цуг явах юм. Хүнтэй цуг явахад зам амархан өнгөрдгийг та өөрөө андахгүй газар даа гэж Портос хэлэв.

-Портос гуай танд тэгвэл Парис хотноо нөхөд гэж үгүй юм шив? гэж прокурорын авгай асуув.

Портос мөн л гунигтай царайлан,

-Би өөрөө бий юм бодсон чинь одоо эндүүрч явснаа ойлгосон гэж Портос хэлэв.

-Портос гуай танд Парис хотонд нөхөд бий шүү гэж прокурорын авгай дуу алдаад, өөрийнхөө сэтгэл ингэтэл догдолсонд өөрөө гайхлаа, маргааш манайд ирээрэй. Та манай нагац эгчийн хүү, тэхлээр миний садангийн хүн. Та Пикард нутгийнНуайои гэгч газраас ирсэн хүн. Та Парис хотноо хэд хэдэн заргатай ирээд өргөдөл сэлт хийлгэх хүн хайж байгаа хүн. Эд бүгдийг тогтоов уу? гэхэд, Портос:

-Сайн тогтоолоо, авгатайн гэв.

-Үдийн хоолны үеэр ирээрэй.

-За сайн.

-Ингэхэд, битгий илүү дутуу уг алдаарай, манай нөхөр далан зургаан настай хир нь тун айхтар ажигч хүн шүү

-Далан зургаан настай гэнээ! Чөтгөр алгад! Сайхан насалжээ гэж Портос хэлэв. -Та янз нь "Өндөр насалжээ" гэх гэв үү. Тийм ээ, Портос гуай, манай муу нөхөр хэзээ

хэзээгүй л намайг бэлэвсэн үлдээж мэдэх болсон хүн гээд прокурорын гэргий Портос өөд учиртай харц чулуудан, аз болоход манай бүх эд хогшил гэрлэхэд хийсэн гэрээ ёсоор цөм үлдсэн нэгэндээ ирэх юм гэлээ.

-Цөм тэр үү? гэж Портос асуув.

-Цөм.

Портос, прокурорын гэргийн гарыг зөөлнөөр атгаад,

-Хонгор Кокнар авгай та иххолын хараатай хүн юмаа, ингэхэд гэлээ.

-Ингээд, хонгор Портос минь, бид эвлэрэх шив? гэж авгай маягласхийн асуухад, Портос мөн тийм байдлаар:

-Бүх амьдралын туршаа гэв.

-За тэгвэл хуурамч сэтгэлт минь баяртай.

-Хувирамтгай хайрт минь баяртай.

-Маргааш уулзъя сэтгэл минь.

-Маргааш уулзъя, баясгалан минь, гэлцээд хоёулаа салав.

XXX. МИЛЕДИ

д'Артаньян Миледигийн хойноос сэм дагасаар, сүйхэнд суухыг нь харж, Сен Жермен рүү явахыг хөтөчдөө тушааж байхыг нь дууллаа.

Хоёр сайн морь хөллөсөн сүйхийг явган дагах гэж оролдвол дэмий хэрэг тул д'Артаньян Феру гудамж өөд эргэв.

Сены гудамжинд Планшетэй дайралдсанд, цаадах нь зуушны мухлагийн өмнө зогсоод, хорхой хөдөлгөм сайхан харагдах амталсан гамбир хараад зогсож байв.

д'Артаньян түүнийг де Тревиль гуайн морины саравчинд очиж өөртөө нэг, эзэндээ нэг морь эмээллээд, Атосын руу гүйцэж оч гэж тушаав. Де, Тревиль гуай морьдоо хэзээ дуртай цагтаа унаж байх эрх д'Артаньянд олгосон юм байж.

Планше Тагтаат гудамж руу явж д'Артаньян Феру гудамж руу эргэлээ. Атос гэртээ сууж, нөгөө Пикард нутгаас авчирсан сайн испани дарснаасаа нэг шилийг гунигтай гэгч ууж байв. д'Артаньянд мөн нэг аяга авчир гэж Гримод дохивол цаадах нь ердийнхөө заншлаар дуугүй гүйцэтгэв.

Сүмд, прокурорын гэргий, Портос хоёрын хооронд болсон бүх явдлыг д'Артаньян Атост ярьж өгөөд, нөхрийгөө лав хэрэгслээ төхөөрч чадах замд орсон байх гэж тааварлав. Үүнд Атос, миний хувьд гэвэл ч сэтгэл амар байна. Миний хэрэгсэл сэлтийг төхөөрөх зардлыг лав л бүсгүй хүн гаргахгүй юм даг гэлээ.

-Үгүй ингэхэд, эелдэг Атос минь, таны сайхан царай, сайн хүмүүжил, өндөр сурвалж цөм нийлээд аль ч гүнж хатны зүрхийг дурлалын сумаар нэвт харавчиж чадах шүү дээ гэв. Атос мөрөө хавчисхийгээд,

-Энэ д'Артаньян бас их залуу байнаа гэлээ.

Ингээд Гримог дахин нэг шил дарс авчир гэж дохилоо. Энэ үеэр Планше үүд нээж, даруу - Юун морьд вэ? гэж Атос сонирхов.

-Намайг зугаалахдаа унаж бай гэсэн де Тревиль гуайн хоёр морь. Энэ морьдоор би Сен Жермен рүү явж зугаалах гэсэн юм гэж д'Артаньян хэлэв.

-Сен Жерменд та юу хийх юм бэ? гэж Атос дахин асуув.

Тэхэд нь д'Артаньян нөгөө хацар дээрээ сорвитой хүний нэгэн адил санаанаас гардаггүй байсан тэр бүсгүйтэй сүмд учирсан тухайгаа ярьж өгөв.

Атос хүмүүсийн тогтворгүй сул зантайд харамсах байртай басамжлангуйгаар мөрөө хавчисхийгээд,

-Өөрөөр хэлбэл, та дээр цагт Бонасье авгайд сайн байсан шигээ тэр бүсгүйд дурлаж орхио

юм бий дээ гэв.

-Би юу? үгүй чиш! гэж д'Артаньян дуу алдаад,

-Зүгээрл тэр бүсгүйтэй холбогдсон нууцыг тайлах сонин санагдсан юм. Яагаад ч юм бүү мэд, өөрий нь би мэдэхгүй өөрөө ч намайг мэдэхгүй тэр бүсгүй миний амьдралд нэг нөлөөтэй юм шиг надад санагдаад байх юм.

-Чухамдаа гэвэл таны зөв. Үгүй болчихсон хойно нь эрж баймаар тийм эмэгтэй байдгийг би ер мэдэхгүй. Бонасье авгайгүй болсон хойно яахав, өөрий нь л хохь, өөрөө олдвол олдоно биз гэж Атос хэлэв.

д'Артаньян үүнд,

-Үгүй Атос, та эндүүрч байна. Хөөрхий Констанцийдаа би урьд урьдынхаас илүү хайртай, хаа байгаагий нь мэддэгсэн бол хорвоогийн зах хязгаар хүртэл ч билээ явж дайсны гараас түүнийг чөлөөлөхсөн, гэтэл хаа байгаагий нь би мэдэхгүй юм, эрээд эрээд тус болдоггүй. Яая гэх вэ! Өөрийгөө саатуулахад хүрэх юм гэв.

-За, за д'Артаньян минь, Миледитэй цэнгэж саатаад уйтгар чинь сатаарах л юм бол цэнгэж л үз, чин голоосоо хүсье.

-Атос оо, аан гэж бай, та гэртээ ингэж хоригдчихсон юм шиг суугаад байхын оронд, морь унаад, хоёулаа Сен Жерменээр зугаалъя гэж д'Артаньян хэлэв.

Атос маргаж,

-Хонгор минь, би морьтой цагтаа мориор явдаг, морьгүй цагтаа явган явдаг хүн гэлээ.

Өөр зүйл дээр болж гэм Атосын ийм сэхүүн зан өөрий нь гомдоож болохтой авч, д'Артаньян үүнд инээмсэглээд,

-Аа би яахав тийм дээгүүр зантай биш, юу олдсоныг нь унаж явдаг хүн. Баяртай, эелдэг Атос минь гэж хариулав.

Шадар цэрэг лонхны бөглөө ав гэж Гримод дохих зуур баяртай гэж дуугарлаа. д'Артаньян, Планше хоёр мордоод Сен Жермен рүү явлаа.

Бүх замын турш, Бонасье авгайн тухай Атосын хэлсэн үг д'Артаньяны толгойноос гарч өгөхгүй байв. Манай залуу гойд их эмзэг сэтгэлгүй боловч, наймаачны хөөрхөн гэргий түүний зүрхэнд гүнзгий ул мөр үлдээжээ.

Үнэхээр ч бүсгүйг эрж олохоор хорвоогийн зах хүрье гэхнээ буцахааргүй байгаа үнэн боловч, хорвоо маань бөөрөнхий, олон зах хязгаартай, хаашаа явахыг мэдэхгүй байлаа.

Одоохондоо , Миледи гэгч ямар шүү хүн болохыг олж мэдэхээр оролдох гэж шийджээ. Миледи нөгөө хар нөмрөгт хүнтэй юм ярьж байсан, тэхлээр таньдаг байж таарна. Гэтэл тэр

хар нөмрөгт хүн түрүүн Бонасье авгайг хулгайлсан шигээ, одоо бас хулгайлсан гэж д, Артаньян лавтай бодож байлаа. Иймд Миледийг эрнэ гэдэг чухамдаа Констанцийг эрнэ гэсэн үг гэж д'Артаньян өөртөө хэлэв. Чухамдаа д'Артаньяны энэ үгийн тал хувь үнэнтэй, тэхлээр энэ чинь бараг худлаа хэлээгүй гэсэн үг шүү дээ.

Эд бүгдийг эргэцүүлэн бодож, морио байн байн давирсаар д'Артаньян замаа анзааралгүй өнгөрөөж Сен Жерменд яваад ирлээ. Арван жилийн дараа XIV дүгээр Людовик ван мэндлэх тавилантай асрыг өнгөрөөд, цаашаа хүн амьтангүй гудамжаар орж, сайхан англи бүсгүйн ул мөр харагдах болов уу гэж баруун зүүн тийшээ харж явтал, нүдэнд дулаахан мөртлөө, тэр цагийн заншлаар, гудамж руу харсан ганц ч цонхгүй нэг байшинтай залгасан, цэцэгт саравчин доогуур нэг хүн холхиж байхыг харав. Тэр хүнийг Планше урьтаж таниад,

-Эрхмээ, та энэ хүний царай зүсийг таньж байна уу? яагаав, энэ амаа ангайгаад, бидний өөдөөс ширтэж байгаа хүнийг? гэж тэрасуулаа.

-Танихгүй байна, гэхдээ лав л үүний өмнө үзсэн хүн байх юм.

-Тэхгүй яахав. Үгүй энэ чинь де Вард гүнгийн зарц хөөрхий Любен байна шүү дээ

Гүнг та нэг сарын өмнө, Калед, боомтын даргын дунд хүрэх замд айхтар чадаагүй юу даа гэж Планше хэлэв.

-Нээрээ тийм, одоо би ч үүний чиньтанилаа. Чи юу гэж бодож байна, цаадах чинь чамайг таньж байгаа болов уу? гэж д'Артаньян хэлэв..

-Үгүй эрхэм ээ, энэ тэхэд, үхтлээ айчихсан болохоор миний нүүр царайг сайн харж амжаагүй байхаа.

-Тийм бол, очиж уулзаад яриа үүсэг, яриан дундаа эзэн нь үхсэн эсэхийг мэд гэж д'Артаньян хэллээ.

Планше мориноосоос эсрч буугаад, шууд Любен дээр очиход, цаадах нь үнэхээр түүнийг таньсангүй. Тэгээд хоёр зарц төдхөн ам хэлээ ололцож яриа дэлгэв. д'Артаньян энэ зуур мориныхоо амыг эргүүлж, байшинг цаагуур нь тойроод, яриаг чагнах санаатан самрын бутны цаана очиж нуугдлаа.

Бутны цаанаас минут хиртэй ажиж байтал сүйх тэрэгний чимээ гарч, хажууханд нь Миледийн сүйх ирж зогслоо. Эргэлзэх газаргүй, сүйхэн дотор Миледи өөрөө сууж байв. д'Артаньян өөрөө харагдахгүй байж байгаад, цөмийг харахын тулд морин дэл рүү бөхийж наалдав.

Миледийн хөөрхөн цайвар толгой сүйхний цонхоор цухуйж, зарц бүсгүйд нэг юм хэллээ.

Хорь , хорин хоёр орчим насны, золбоолог сэргэлэн, аргагүй л язгууртан бүсгүйн зарц байгууштай зарц хүүхэн нь тэр цагийн заншлаар гишгүүр дээр сууж байснаа буугаад, түрүүн Любены байхыг д'Артаньян харсан тэр цэцэгт саравчин тийш алхав.

Зарц бүсгүйн яваа чигийг д'Артаньян дагаж харвал цэцэгт саравч руу явж байгаа аж. Гэтэл үүнээс түрүүхэн, гэр дотроос нэг хүн Любенийг дуудаж аваачаад, саравчин доор Планше ганцаараа үлдчихээд, эзнийхээ хаашаа явчихсаныгтаах санаатай ийш тийшээ харан зогсож байв.

Зарц бүсгүй Планшег Любен юм гэж санаад, очиж зурвасаа өгөөд,

-Танай эзэнд гэжээ.

-Миний эзэнд ий? гэж Планше гайхаж лавлаж асуусанд:

-Тийм ээ, онц яаруу юм шүү. Май бушуухан ав гэжээ.

-Ингэж хэлээд бүсгүй, нэгэнт эргэж зогссон сүйх рүү гүйж очоод, гишгүүр дээр үсрэн гарахад, сүйх тэрэг цаашаа явж одлоо.

Планше зурвасыг жаал эргүүлж үзэж байснаа, элдэв юм бодолгүй, үг дагаж сурсан хүн болохоор саравчнаас гарч булан тойроод, хориод алхтал, бүгдийг харчхаад өөдөөс нь ирж явсан д'Артаньянтай тулгарав.

Планше зурвасаа манай залууд өгөөд,

-Танд өгсөн юм эрхэм ээ гэв.

-Над уу? Чи лав мэдэж байна уу? гэж д'Артаньян асуув.

-Мэдэхгүй яахав, чөтгөр алгад зарц бүсгүй надад өгөхдөө "танай эзэнд" гэсэн. Танаас өөр эзэн надад байхгүй, тэхлээр...үгүй, тэр зарц хүүхэн мөн хөөрхөн амьтан. д'Артаньян захидлыг задлаад уншвал:

"Таныгилүү их сонирхдог нэгэн бүсгүй, хэдийд та сайжирч ойд зугаалж чадахтай болохыг мэдэхсэн гэж байна.

Маргааш, "Алтан тал" гэдэг зочид буудалд хар улаан өнгийн, ямбаны хувцастай зарц таны хариуг хүлээх болно" гэж бичжээ.

"Үгүй ер, хачин учирлаа хөөш! Миледи бид хоёр нэг хүний биеийн байдлыг сонирхож байгаа байхнээ" гэж д'Артаньян бодлоо.

-Хөөе, Планше ээ, де Вард гүнгийн бие ямар шүү байна гэнэ. Үзвэл тэр үхсэнгүй дэгээ?

-Үгүй эрхмээ. Дөрөв шархадсан хүн гэхэд бие нь сайн гэнэ. Таныг бүү зэмлэсэн болог, та тэр хөөрхийг илдээр дөрөв дахин бүлсэн шүү дээ, тэгээд бараг хамаг цусаа алдчихсан болохоор бие их сулхан л байгаа гэнээ. Миний бодсончлон Любзн намайг огт таньсангүй, манай нөгөө адал явдлыг эхнээс нь аваад эцэс хүртэл ярьж өглөө.

-Их сайн, Планше чи зарц нарын хаан юмаа. За одоо шалавлаж тэр сүйхийг гүйцье. Үүнд их

цаг орсон ч үгүй, таван минутын дараа, нөгөө сүйх замын зах руу шахаж зогссон гоё сайхан хувцастай, нэг морьтой хүн үүдний нь дэргэд хөндөлдөж байгаа харагдав. Миледи тэр хүн хоёр яриандаа их улайсан болохоор, д'Артаньяныг ирж сүйхний нөгөө талд зогсоход, хөөрхөн зарц, бүсгүйгээс өөр хэн ч түүнийг харсангүй.

д'Артаньяны мэддэггүй англи хэлээр ярьцгааж байв. Гэхдээ дууны нь өнгө байдлаар хөөрхөн англи бүсгүй сүрхий уурлаж байгааг гадарлав. Эцэстээ тэрбүсгүй дэвүүрээ хорсон базахад бүсгүй хүний тэр хээнцэр байдал мянган хэсэг бут үсэрсэнд, эргэлзэх газар нэгэнт үгүй болов.

Морьтой хүн тачигнатал инээд алдаж бүсгүйн уурыг улам ч шатаав бололтой. Хөндлөнгөөс оролцох цаг боллоо гэж д'Артаньян үзээд, сүйхний нөгөө хаалга руу очиж малгайгаа хүндлэнгүй байртай авч:

-Авхайтан, танд тус болохыг зөвшөөр, энэ морьтой хүн таны зэвүүг хүргэсэн бололтой надад санагдлаа. Ганцхан үг л дуугарчих, тэгвэл эелдэг зан нь дутагдсан энэ хүнийг би цээрлүүлж өгье гэж тэр хэлэв.

д'Артаньяныг үг дуугармагц Миледи гайхан эргэж харав.

Ингээд залууг үгээ дуусмагц цэвэрхэн Франц хэлээр, Эрхэм ээ, надтай маргаж байгаа энэ хүн миний ах биш байсансан бол би дуртайяа таны өмгөөлөлд орохсон гэв.

-Еэ, тийм бол уучилна уу, үүнийг би хаанаас. мэдэх билээ, авгатайн минь гэж д' Миледийн тэр ураг төрлөө гэсэн хүн сүйхний нөгөө хаалга руу бөхийж,

-Энэ төрхгүй амьтан ямар учиртай бусдын хэрэгт оролцож байгаа юм бэ? Энэ яагаад замаараа явахгүй байгаа юм бэ гэж хашгачив.

Та өөрөө төрхгүй амьтан, Энд зогсох дур хүрээд би замаараа явахгүй байна гэж д'Артаньян мөн мориныхоо хүзүү рүү бөхийж, нөгөө талаас хариуллаа.

Морьтой хүн дүүдээ хэдэн үг англиар хэлэв.

-Тантай би франц хэлээр ярьж байна, ёсыг бодоод надад мөн энэ хэлээр хариулж үз. Та яахав энэ бүсгүйн ах юм байж, сайн хэрэг харин аз болоход, миний ах биш шүү дээ гэж д'Артаньян хэллээ.

Миледи бүсгүй хүний аймтгай зангаар хэрүүл үүсэхэд саад хийж цаашлуулахгүйг хичээнэ гэж бодож болохтой билээ. Гэсэн чинь харин ажиг ч үгүй хойшоо налж суугаад хөтчид - Гэртээ харь гэж тушаав.

д'Артаньяны сайхан царайг хараад сэтгэгдэл төрсөн бололтой хөөрхөн зарц хүүхэн манай залуу өөд сэтгэл зовсон байртай харав.

Сүйх явж өгөөд, хоёр хүний дунд тусгаарлах юмгүйхалз тулж зогсов.

Цаад морьтой хүн сүйхний хойноос хөдлөх гэтэл, нөгөө Амьенд өөрий нь морийг хожиж аваад, Атосоос алмас чулуун бөгж золтой хожих дөхсөн англи хүн мөнийг таньсан д'Артаньяны уур улам ч баларч, жолооноос нь угз татаад зогсоов.

-Хөөе, эрхмээ та чинь надаас ч төрхгүй амьтан байх нээ. Бидний хооронд ялихгүй хэрүүл болсныг мартчихсан юм биш биз? гэж хэллээ.

-Аа, энэ чинь та юу, эрхмээ, та янз нь нэг ч биш, янз янзын тоглоомоор хэзээ ямагт тоглож явдаг хүн юмаа? гэж англи хүн хэлэв.

-Тийм ээ, нээрээ би даагаа нэхэх ёстойг та сануулж өглөө. Илдээр та, аягатай шоо шиг чадамгай сайн тоглодог эсэхийг чинь үзье.

-Миний илдгүй явааг та сайн харж байна шүү дээ. Аль та, зэвсэггүй хүний өмнө эр зоригтойгоо гайхуулмаар байна уу? гэж англи хүн хэлэв.

д'Артаньян үүнд маргаж,

-Бодвол танай гэрт илд бий байлгүй. Тэглээ ч гэсэн надад хоёр илд бий, нэгийг нь би танд мөрийцөөд алдчихъял даа гэв.

-Тэх явдалгүй, тиймэрхүү юм надад өөрт минь хүрэлцэхүйц их байдаг юм гэж англи хүн хэллээ.

-За тэгвэл их сайн, хүндэт эрхэм минь гэж' д'Артаньян хариулаад, тэднийхээ хамгийн урт нэгийг авчраад, өнөө орой надад үзүүлж үз гэв.

-Та түүнийг хаана үзэх таалалтай байна даа?

-Люксембургийн ордны цаана. Тиймэрхүү янзын зугаалга хийхэд их зохимжтой газар юм даг.

-За сайн, би тийшээ очноо.

-Хэдийд?

-Ингэхэд танд нэг хоёрын зэрэг нөхөд олдоно байхаа?

-Надад гурван нөхөд бий, цөм надтай дуртайяа хамт ирцгээх улс.

-Гурав гэнээ? Их догь байна. Сайхан тохирчээ надад мөн гурван нөхөд бий гэж д'Артаньян хэлэв.

-За одоо та хэн болохоо надад нэг дуулгаж орхиоч, гэж англи хүн хэлэв. -Миний нэр д'Артаньян, гаскон нутгийн тайж Дезэссар гуайн сумангийн торгон цэрэг, аа та өөрөө?

-Миний нэр Шеффилдийн бээл, Винтер гэдэг.

-За их сайн, өчүүхэн хүн би эрхэм бээл таны дуулгавартай зарц билээ. Харин таны нэр тогтоохуйяа тун бэрх юм байна гэж д'Артаньян хэлэв.

Ингээд морио давирч цогьсоор Парис руу буцаж ирлээ.

Иймэрхүү юм болсон тухайд д'Артаньян шулуухан Атосынд хүрч ирдэг юм.

Атос урт дэвсгэр дээр хэвтээд, өөрийнхөө хэлдэгчлэн аяны хэрэгсэл сэлт нь өөрөө хүрч ирэхийг хүлээж байв.

д'Артаньян де Вардад очих учиртай байсан захидлаас бусад, болсон бүх явдлыг Атост ярьж өгөв.

Атос, бидний дурсаж байсанчлан, англихүмүүстэй тулалдахыг эрэлхийлдэг байсан болохоор ялангуяа англи хүмүүстэй тулалдах болсныг дуулаад их хөөрөв.

Хоёр нөхөд даруй зарц нараа Портос, Арамис хоёрын хойноос явуулж ирүүлээд болсон хэргийг дуулгав.

Портос даруй илдээ гаргаж хана руу хатган гараа дасгаж үе үе бүжиглэж байгаа хүн мэт үсрэн ухарна. Яруу найргаа бичсээр байсан Арамис Атосын ажлын өрөөнд орж хаалгаа түгжээд, тулалдах цаг болтол саад болохгүй байхыг гуйв.

Атос нэг лонх авчир гэж Гримод дохилоо.

д'Артаньяны хувьд гэвэл дотроо нэг жаахан төлөвлөгөө боловсруулж суулаа. Түүнийгээ яаж биелүүлсний нь бид цаашдаа үзнэ, мань залуу бодлогоширсон царайтай, уруулд нь мишээх байдал тодрон буйг ажваас төлөвлөгөө нь цаашдаа аятайхан адал явдалд хүргэх төлөв бүхий бололтой.

XXXI. АНГЛИЧУУД БА ФРАНЦЧУУД

Мань нөхөд болзсон цагтаа дөрвөн зарцаа дагуулсаар Люксембургийн ордны цаадах хашаа бүхий буйд газарт хүрч ирэв. Тэнд ямаа хариулж явсан хүнд Атос цөөн мөнгө өгсөнд, ямаагаа туугаад зайлав. Зарц нарт харуул харах тушаал өгөв.

Удалгүй тэр эзгүй газар руу бас нэг хэсэг хүмүүс чимээ аниргүй явж ирээд, дотогшоо орж шадар цэргүүдтэй нийлэв. Тэгээд английн заншлаар нэр усаа мэдэлцэх боллоо.

Өөрсдөө өндөр дээд язгууртай англи хүмүүс тулалдах улсынхаа хачин нэрийг сонсоод гайхсанаар барахгүй, сэтгэл зовжээ.

Гурван шадар цэргийг нэрээ хэлэхэд Лорд Винтер.

-Үүгээр бидэнд мэдэгдсэн юм юу ч алга. Та бүхний хэн болохыг бид мэдэж чадаагүй хэвээр л байна. Ийм нэг хоньчин үхэрчний нэртэй хүмүүстэй бид тулалдахгүй гэлээ.

-Эд чухамдаа, зохиомол нэр гэдгийг милорд та өөрөө ч мөн гадарлаа биз ээ гэж Атос хэллээ.

-Тэгэх тусмаа жинхэнэ нэрий нь мэдэхсэн гэдэг дур улам их хүрээд байна гэж англи хүмүүс хариулав.

-Гэхдээ, та бүхэн бидэнтэй нэр усаа мэдэлцэлгүй мөрийцөн тоглоод, хоёр морийг минь хожоод авчихсан шүү дээ гэж Атос үг хаяв.

-Таны хэлдэг үнээн. Тэхэд бид ердөө л мөнгөөр тоглосон билээ. Энэ удаа бид амь дүйж байна. Хэнтэй ч хамаагүй тоглож болох юм, харин хэргэм зэрэг адил улстай л тулалдаж болно. -Энэ зөвөө гээд Атос өөртэйгөө тулалдах ёстой англи хүнийг хажуу тийш нь дагуулан аваачаад нэрээ шивнэн хэлж өгөв.

Портос, Арамис хоёр ч мөн тэглээ. Атос тулалдах болсон хүнээсээ,

-Таны сэтгэл ханав уу, надтай илд зөрүүлэхэд язгуур сурвалж тэнцмээр санагдана уу? гэж асуув.

-Тэглээ, эрхэм ээ гэж англи хүн мэхийн хариулав. Атос үүнд хүйтнээр, -За сайн. Тэгвэл одоо би нэг юм хэлье гэв. Англи хүн гайхаж,

-Юу вэ? гэлээ.

-Та уул нь миний нэрийг дуулах гэж шаардаагүйсэн бол дээр байсан юм. -Яагаад тэр вэ?

-Яагаад гэвэл, намайг улс нас барчихсан гэж тооцдог юм, миний амьд байгааг улс бүү мэдээсэй гэж хүсэх чухаг шалтаг надад байгаа юм. Тэхлээр нууцаа тараахгүйн тулд таныг би алж л таарах боллоо.

Англи хүн Атосыг тоглож байгаа юм байх гээд хартал тоглосон шинж ер алгаа. Атос, нөхөд

болон цаад хүмүүст зэрэг хандан, эрхмүүдээ, бэлэн үү? гэж асуув. Англичууд, Францууд нэг дуугаар,

-Бэлэн гэлцэв.

-За тэгвэл эхлэе!

Ингээд, шингэж байгаа нарны элчинд найманилд тэр даруй гялсхийж гараад, давхар өстөн хүмүүс болохоор аргагүй махран, ширүүн хатуу тулалдаж гарав. Атос дасгалын тэнхимд байгаа юм шиг хянуур, тайван тулалдана. Шантильид тохиолдсон хэрэг явдалд хэтэрхий бардам, биеэ тоосон зан нь жаал дарагдсан Портос тун болгоомжтой, овжин тулалдаж байв.

Яруу найргийнхаа гуравдугаар хэсгийг дуусгах ёстой байсан Арамис, аргагүй лзав муутай хүний байртай шалбалзана.

Атос бусдаасаа урьтаж өстнөө аллаа. Ганцхан удаа хатгаж тэхдээ, түрүүн сануулж байсанчлангаа зүрхийг нь нэвт хатгаж үхэхээр шархдуулжээ.

Түүний дараа Портос өстнийхөө гуяыг шувт бүлж хэвтүүлэв. Англи хүн цаашид эсэргүүцэж төдөлгүй илдээ Портост өгсөнд Портос тэр хүнийг өргөж сүйхэнд суулгав.

Арамис өстнөө дайрч сандраасаар байсанд цаадах нь тавиад алхам хиртэй ухарснаа эргэж хар хурдаараа зугтаахад зарц нар хойноос нь дооглож хашгаралдана.

д'Артаньяны хувьд гэвэл зүгээр, биеэ чадмаг хамгаалах арга хийж өстнөө ядраагаад, нэг лут цохилтоор цаад хүний гараас илдийг нь суга цохив. Бээл зэвсгээ алдсаныг үзээд хэдэн алхам ухартал халыг үсэрч гэдрэгээ харан ойчив.

д'Артаньян ганцхан үсэрч бээлийн дэргэд очоод хоолойд нь илдээ тулгаж,

-Таныг би алчхаж болох юм, эрхмээ та миний гарт орлоо. Гэвч би танай дүүг бодоод амийг чинь уучилъя гэж тэр англи хүнд хэлэв.

д'Артаньян бөөн баяр боллоо. Урьдаас бодож боловсруулаад, санахаас л хэдхэн цагийн өмнө тэгж инээд нь хүрээд байсан нөгөө төлөвлөгөөгөө хэрэгжүүлсэн нь энэ байжээ.

Ийм аятай хүнтэй учирсандаа баярласан англи хүн д'Артаньяныг тэвэрч аваад, гурван шадар цэрэгт өдий төдий эелдэг үг хэлэв. Портос тулалдсан хүнээ сүйхэнд суулгасан, Арамисын өстөн зугтаачихсан болохоор цөм алагдсан хүн дээр очлоо.

Шарх нь арай үхэхээргүй байж мэднэ гэж бодоод Арамис, Портос хоёр хувцсыг нь тайлж байтал бүсний нь цаанаас дүүрэн хэтэвч уналаа. д'Артаньян хэтэвчийг аваад Лорд Винтерт өгөв.

-Үгүй, чөтгөр алгад, үүгээр чинь би яах юм бэ гэж англи хүн асуув.

-Алагдсан хүний гэр бүлийнхэнд өгнө биз гэж д'Артаньян хариулав.

-Иймхэн юмаар тэднийхэн яах вэ. Түрээснээс л жил бүр арван таван мянган алтан зоос авахаар хөрөнгөө өвлөж авах юм чинь, наад хэтэвчээ өөрсдөө аваад зарц нартаа өгч үз гэв. д'Артаньян хэтэвчийг халаасандаа хийв.

-За одоо залуу нөхөр минь, таныг нөхөр гэхэд дургүйцэхгүй биз гэж бодно, ингэхлээр та таалбал өнөө оройдоо би таныг манай дүү Кларик авхайтай танилцуулъя. Манай дүү танд мөн сайн болоосой гэж би хүсч байна. Тэр өөрөө ордонд багагүй танил талтай, цаашдаа түүний үг таны ирээдүйд хэрэг болж мэднэ гэж Лорд Винтер хэлэв.

д'Артаньян сэтгэл тэнийсэндээ царай улайчхаад, зөвшөөрсний тэмдэг болгож мэхэсхийв. Энэ үеэр Атос д'Артаньян дээр хүрч ирээд залуугаас шивнэж асуусан нь.

-Та энэ хэтэвчийг яах гэж байна? гэв.

-Эелдэг Атос минь, үүнийг би өөрт чинь өгөх санаатай байна.

-Надад уу? Яагаад тэрбилээ?

-Яахав, та эзний нь алсан шүү дээ. Энэ чинь дийлсэн хүний олз.

-Би тэгээд өстнийхөө өвийг залгамжлах гэж үү? Та намайг ер ямар хүн гэж бодоод байнаа?

д'Артаньян үүнд:

-Цэрэг дайны заншил ийм юм. Хүмүүсийн тулалдаанд мөн ийм заншил байж болохгүй учир хаана байна? гэв.

-Дайны талбардээр хүртэл би ер тэгж үзээгүй билээ гэж Атос маргалаа. Портос мөрөө хавчисхийж, Арамис сайшаах байртай инээмсэглэв.

-За тийм бол энэ мөнгийг Винтер гуайн хэлснээр зарц нарт өгч орхиё гэж Артаньян хэлэв.

Тэгье гэж Атос санал нийлээд, зарц нарт өгье, харин өөрсдийнхөө биш англи хүмүүсийн зарц! нарт өгье гэлээ. Атос хэтэвчийг авч хөтчид хаяж өгөөд;

-Май нөхөдтэйгөө хувааж ав гэлээ. .

Ямар ч хөрөнгөгүй хүний ийм уудам сэтгэлийг Портос хүртэл үзээд бахархав. Цаашаа Лорд Винтер, нөхрийнхөө хамт Францын өгөөмөр сэтгэлийн тухай газар сайгүй ярихад, Гримо, Мушкетон, Планше, Базен нараас бусад сонссон улс цөм бахдаж байсан.

д'Артаньянтай салахдаа, Лорд Винтер дүүгийнхээ гэрийг зааж өглөө. Дүү нь тэр цагт ихэс дээдсийн суудаг байсан Вангийн талбай гэдэг газар зургадугаар байшинд суудаг аж. Гэхдээ бээл өөрөө залууг дагуулан очиж, биеэрээ танилцуулж өгөхөөр ирж аваачья гэлээ. д'Артаньян найман цагийн хирд, Атосын гэрт уулзахаар болзлоо.

Миледийгийн д ийнхүү айлчлах болсондоо мань гаскон залуугийн санаа сэтгэл сүрхий үймэв.

Өнөө хүртэл тэр бүсгүй, амьдралд ямар шүү хачин нөлөө үзүүлсээр ирснийг санаж үзлээ. Тэр бүсгүй хамба ламын тагнуул туршуул этгээдийн нэг мөнийг бат мэдсэн хир нь өөрөө мэдэхийн эрхгүй нэг сэтгэлд авган тэр бүсгүйд өөрийнэрхгүй татагдах ажээ.

Ганцхан өөртэйгөө Менг, Дувр хоёрт учирч байснаа таниад орхих бий гэж д'Артаньян айж байлаа. Тэгвэл өөрий нь де Тревиль гуайн талын хүн, цаашилбал ван эзэнд бие, сэтгэлээрээ үнэнч хүн гэдгийг мэдээд, авгайн нүдэнд өөрий нь баахан муутгах билээ. Харин одоо д'Артаньян бүсгүйг мэдэхгүй байгаачлан, бүсгүй өөрий нь мэдэхгүй байвал үзэлцээд авахад дийлэх дийлдэх болзол тэнцүү байхсаан.

Миледи де Вард гүн хоёрын хооронд янагийн холбоо тогтож эхэлж байгаа тухайд гэвэл, гүн хэдийгээр царай зүс сайхан, хөрөнгө чимэгтэй хамба ламтанд тал ихтэй гэсэн ч дээгүүр санаатай залууд онцын шальтай юм санагдсангүй. Хорин настай байх, тэхдээ бас гаскон нутагт төрсөн хойно гайтай байхаас яах вэ.

д'Артаньян юуны өмнө гэртээ харьж хянуур нямбай хувцаслав. Тэгээд Атосынд очиж, заншсанаараа цөмийг түүнд ярьж өглөө. Атос түүний төлөвлөгөөг сонсоод толгой сэгсэрч, болгоомжтой байхыг захихдаа гутарсан шинжтэй байв.

-Юу гэнээ! Өөрийн чинь ярьж байснаар бол сайн, сайхан, алив талаараа тэгш бүсгүйгээс дөнгөж сая хагацаад байгаа мөртлөө одоо бас ондоог эргүүлэх гэж үү? гэж Атос хэлэв. Энэ зэмлэл д'Артаньянд аргагүй зөвтэй санагдаж,

-Бонасье авгайд би сэтгэлтэй сайн байсан билээ. Миледийг би дотроо бодолтой эргүүлж байгаа юм. Гол нь, энэ бүсгүй ордонд ямар шүү үүрэг гүйцэтгэдгийг би мэдэх гэсэн юм гэж д'Артаньян хариулав.

-Ямар үүрэг гүйцэтгэдгийг гэнээ! Таны хэлж байгаагаар бол гадарлаж ядах юмгүй юм биш үү. Энэ бүсгүй хамба ламын нууц туршуул хүн, өөрий чинь сайхан занганд оруулчихна. Та түүнд орж толгойгоо алдана биз. Тэгээд гүйцэх нь тэр.

-Атос та юмыг дэндүү их муу муухайгаар нь бодох юм байна шүү, нээрээ.

-Яая гэх вэ, хонгор минь, бүсгүйчүүлд ялангуяа цайвар үстэй бүсгүйчүүдэд би итгэдэггүй, итгэхгүй байх учир шалтгаан ч байгаа юм. Миледийн үс цайвар юм гэж та над ярьсан байхаа?

-Үнэхээр урьд хожид би ер үзээгүй сайхан цайвар үстэй хүн.

Атос санаа алдаад,

-Хөөрхий д'Артаньян, гэв.

-Дуулж бай л даа, би хэргийн учрыг олох гэж байна, тэгээд мэдэх гэсэн юмаа мэдмэгц би холдоно.

Атос аман дотроо, олж мэдэж л үз дээ гэж хайнга хэлэв.

Лорд Винтер болзсон цагтаа ирэхэд, урьтаж дуулсан Агос өөр өрөөнд орсон байлаа. Ингэж англи хүнийг ирэхэд д'Артаньян ганцаараа байсанд, даруй дагуулж явлаа. Цаг найман цаг дөхөж байсан билээ.

Гадаа, хоёр сайхан морь хөллөсөн дэгжин сүйх хүлээж байгаад агшин зуур хоёр залууг Вангийн талбайд хүргэв.

Кларик авгай д'Артаньяныг зүгээр нэг хүлээж авлаа. Авгайн харш гойд гоё хээнцэр аж. Ихэнх англи хүмүүс дайн үүсэх төлөвтэйгөөс болж Францаас яваад өгчихсөн юм уу, явах гэж байгаа цаг билээ. Миледи саявтархан их мөнгө зарцуулж гэр орноо янзалсныг үзвэл, англи хүмүүсийг нутаг буцаах тухай ерөнхий шийдвэр авгайд үл хамаарсан аж.

Лорд Винтер дүүдээ Артаньяныг танилцуулж,

-Таны өмнө байгаа залуу тайжийн мэдэлд миний амь нас орсон юм. Би эхлээд энэ хүнийг доромжилсон, мөн англи хүн, тэхлээр бид давхар өстөн байсан хэдий тиймболовч энэ хүн амийг минь хэлтрүүлсэн юм, авхайтан та надад их бага боловч сайн байдаг бол энэ хүний ачийг бодож үзээрэй гэв.

Миледийн царай үл мэдэг барайсхийж, дух нь үл мэдэгдэм үрчийж, уруул нь хачин инээмсэглэхэд нүүр царай нь ийнхүү хувирахыг ажсан д'Артаньяны дотор өөрийн эрхгүй арзасхийв.

Миледийгийн хайртай сармагчин яг энэ үеэр ахын нь хормойноос шүүрч авсанд, Лорд Винтер түүнийг эрхлүүлэх гэж цаашаа харсан тул үүнийг ажсангүй.

-Амгалан морилогтун, эрхэм ээ, өнөөдрөөс эхлээд та миний талархлыг эгнэгт хүлээлээ гэж Миледи дөнгөж сая д'Артаньянд ажиглагдаж байсан сэтгэл тавгүй байдалтайгаа огт үл нийцэх гойд эелдэг зөөлөн дуугаар хэлэв.

Ингэтэл англи хүн наашаа эргэж, тулалдааны тухай нэгд нэгэнгүй ярьж гарав. Миледи түүний яриаг хичээнгүйлэн сонсож, дотоод бодлоо нуухыг ихэд оролдовч, энэ яриа өөрт нь илтэд аягүй байгаа бололтой, бүсгүйн царай нэг цайж, нэг улайж жижигхэн хөлөөрөө тэсэж ядсан байртай шал тогшинхон сууна.

Лорд Винтер юу ч ажсангүй. Ярьж дуусаад, испани архи, аяга тавьсан ширээ рүү очоодхоёр том хундага дүүргээд ууцгаая гэж д'Артаньянд дохив.

Англи хүний эрүүл мэндийн төлөө дарс уухаас татгалзах гэдэг голгүй гомдооно гэсэн үг гэдгийг д'Артаньян мэддэг билээ. Иймд ширээ рүү очоод нэг хундагатай дарсыг нь авлаа. Гэвч Миледийг мөн ажсаар байсан тул, зүс царай нь аягүй хувираад явчхыг толинд харав. Одоо өөрийгөө харж байгаа хүн үгүй гэж бодоод, бүсгүйн царай нэг хачин араатны шинж бүхий болоод алчуураа уурлан хорсож зулгаах ажээ.

Энэ үеэр, д'Артаньяны түрүүн харсан нөгөө залуу хөөрхөн зарц бүсгүй орж ирээд, Лорд Винтерт хэдэн үг англиар хэлэв. Тэгтэл Лорд Винтер хойшлуулшгүй чухаг ажилтай боллоо

гэж, явах зөвшөөрөл д'Артаньянаас гуйгаад өөрийнхөө өмнөөс мөн давхар уучлал гуйхыг дүүдээ захив.

д'Артаньян түүнтэй гар бариад, дахин Миледи рүү очив.

Бүсгүйн царай гайхам хурдан хувирч түрүүчийнх шигээ эелдэг байртай болгон боловч, алчууран дээр үлдсэн хэд хэдэн улаан толбо уруулаа цус гартал хазсаны нь илчилж байв.

Авгайн уруул сайхан нь аргагүй, шүр мэт ув улаан аж.. Яриа хөөрөө сэргэж, Миледи ч янз нь биеэ эзэмдэв бололтой. Лорд Винтерийг өөрийнхөө ах биш, нөхрийнхөө ах, айлын отгон хүүтэй сууж яваад нөхөр нь нас барж өөрөө хүүхэдтэй бэлэвсэрчүлдсэн. Лорд Винтер гэрлэхгүй юм бол тэр хүүхэд, өвийг нь залгамжлах ганц хүн болж байгаа юм гэж д'Артаньянд ярьж өглөө. Эд бүгдийг дуулбал нэгэн нууцыг халхалсан хөшиг байна гэдэг д'Артаньянд ил боллоо, тэр хөшгийг одоогоор сөхөж чадахгүй аж.

Хагас цаг хиртэй яриа дэлгэсний сүүлд, Миледийг франц хүн юм байна гэж д'Артаньян итгэлээ. Франц хэлээр ямар ч өөгүй уран цэцэн ярих нь энэ тухайд эргэлзэх юм огт үгүй ажээ.

д'Артаньян бүсгүйд үнэнч сайнаа илчилж, өдий төдий магтаал үг урсгалаа. Манай гаскон залуугийн хэлсэн энэ бүх дэмий үгийг сонсоод Миледи таалалтай инээмсэглэж байв. Эцэстээ явах цаг болж, д'Артаньян салах үгээхэлээд, зочдын өрөөнөөс хорвоо дээр хамгийн жаргалтай хүн болж гарав.

Шатан дээр түүний өөдөөс хөөрхөн зарц бүсгүй дайралдав. Хажуугаар өнгөрөхдөө тэр бүсгүй д'Артаньяныг үл ялиг шүргэснээ тун ч эелдэг дуугаар уучлал гуйсанд, залуу тэр даруй уучиллаа.

д'Артаньян маргааш нь мөн эднийд ирсэнд, урьдынхаасаа найрсгаар хүлээж авлаа. Лорд Винтер энэ удаа алгабайсанд, зочныг бүхэл оройжингоо Миледи өөрөө саатуулав.

Авгай, залуу хүнийг ихэд сонирхож байх бололтой, нутаг ус, нөхөд сэлтийг нь асуугаад, хамба ламтны албанд орох санаатай үгүйг асуув.

д'Артаньян хорин настай хир нь хянуур залуу тул, Миледийгийн тухай урьд тааварлаж байснаа санаад, авгайн өмнө их гэгээнтнийг сайшаан магтаж хэрэв де Кавуа гуайг де Тревиль гуай шиг сайн таньдаг байсансан бол даруй хамбын торгон цэрэгт орох байсан гэж ярив.

Миледи яриагаа тун аятайхан өөрчлөөд, д'Артаньяныг англи улсад ер очиж байсан эсэхийг хамгийн энгийн байртай асуулаа.

д'Артаньян үүнд де Тревиль гуайн зараалаар морьд худалдан авах тухай ярилцахаар нэг удаа англи орж, дөрвөн морь үзүүлэхээр авчирсан гэв.

Ярианы үед Миледи гурван удаа уруулаа хазав, мань гаскон залуу хашир үзэлцэж байгаа ажээ.

д'Артаньян өчигдрийн явсан цагтаа эднийхээс гарав. Гудманд мөн л хөөрхөн Кэтти

дайралдлаа. Кэтти гэж зарц бүсгүйн нэр юм. Залуугийн өөдөөс тэр бүсгүй учры нь мэдэхгүй байхын талгүй харц чулуудсан боловч. д'Артаньяны хамаг санаа бодол эзэгтэй рүү нь явчхаад эзэгтэйгээс л гарсан юмыг ажиж авахтай байлаа.

д'Артаньян үүний маргааш, нөгөөдөр нь Миледийнд ирвэл улам бүр найрсаг угтаж байлаа.

Орон бүр хөөрхөн зарц бүсгүй нэг бол шатан дээр, үгүй бол гудамд дайралдана. Гэхдээ хөөрхий Кэттийн ийнхүү шургуу дагаж байгааг д'Артаньян огт ажиггүй байсныг биднэгэнт дурьдсан билээ.

XXXII. ПРОКУРОРЫНД ХООЛ ИДСЭН НЬ

Энэ зуур Портос нөгөө тулалдаанд төдий амжилттай оролцсоноор прокурорын гэргийнд хоол идэх тухайгаа огт мартсангүй. Маргааш нь өдрийн арван хоёрын дараа Портосын хувцсанд Мушкетон сүүлчийн удаа сойз хүргээд манай шадар цэрэг хамаг хэрэг урагштай хийморьтой яваа хүний байртай, Баавгайн гудамж руу алхав.

Түүний зүрх цохилох боловч залуу халуун дурлалаар цохилсон д'Артаньяны зүрх шиг биш, өөр ашиг завшаан хичээсэн бодлын үүднээс сэтгэл хөдөлжээ.

Одоо Портос арайхийж энэ алхашгүй босгоор алхаад Кокнар гуайн зооснууд нэг нэгээрээ цувран дээш гарч хуримталсан тэр шатаар дээшээ гарах болжээ.

Санаандаа хорь дахин дүрслэн бодож байсан уртаас урт, гүнзгий, цоож дүүжлээстэй, шаланд хадаастай, зэвэрсэн, сургийг нь их дуулсан тэр нандин авдрыг нүдээрээ үзэх цаг ирлээ Тэгээд прокурорын эхнэрийн жаал хатангир болсон боловч гуа үзэсгэлэнгээ бүр алдчихаагүй хөөрхөн гар тэр авдрыг нээж' нүдийг нь баясгах учиртай болжээ.

Түүнээс гадна, гэр орон, эд хөрөнгөгүй, байнга тэнэж буудлын газар гуанз, мухлагаар байнга хэсэж явдаг цэрэг эрд сайн хоол идэх дур байвч, юу олдсон юмаар болж явахад хүрдэг болохоор сая нэг гэрийн хоолны амт үзэж, гэрийн тав тохитой байдалд амарч, хэдий ядрах тутам хашир дайчдын ярьдагчлан төдий таатай санагддаг бүсгүй хүний дулаан асрамжид орох завшаан ирж байлаа.

Төрөл садангийн хүний хувиар өдөр бүр ирж хоол идэн хөгшин прокурорын шарласан духны үрчлээг тэнийлгэж, залуухан бичээч нарт элдэв тоглоом зааж сургаад шагнал гэхийн оронд сараар хойш тавьж хураасан юмнаас нь хожиж авч байх эд бүгд Портосын санаанд сайхан нийцэж байв. Тэр цагт хүртэл прокурор хүмүүсийн аар саар юмаар хөөцөлдсөн, ховдог шунаг харамчийн тухай өнөө болтол үргэлжилсэн муу яриа явдгийг Портос дуулснаа санах. Гэхдээ хэзээнээс нааш Портост зохисгүй санагдсаар ирсэн үе үе гар татах гээд байдгаас бусдаар прокурорын гэргий хирэндээ овоо л өглөгч байдаг болохоор тэднийхийг сүрхий элбэг дэлбэг айл гэж бодлоо.

Гэвч үүдэн дээр ирмэгц шадар цэрэгт жаахан эргэлзээ төрлөө. Гудамж нь харанхуйвтар сараалжит цонхтой, түүгээр гаднаас бүдэгхэн гэрэл ордог, өмхий муухай, хоёрдугаар давхарт бүдүүн хадааснууд шааж бөхөлсөн Гран Шатле гяндангийн гол хаалга аятай бат жижигхэн үүд байх ажээ.

Портос үүд тогштол нүүр рүүгээ унжсан бөөн их арзгар үстэй, өндөр, цонхигор бичээч ирж үүд нээгээд, хүч чадлыг илчилсэн өндөр Нуруу, нийгэмд зохих буурь суурьтайг үзүүлсэн цэрэг хувцас, мөн элбэг дэлбэг байдалд дассаныг харуулсан цаггалан царай сэлтийг илтэдхүндэлж сурсан байртай мэхийн ёслол.

Арай нам нуруутай өөр нэг бичээч өндрийнхөө хойноос ирж, цаана шатан дээр бас нэг бичээч, түүний ард нэг арван хоёр орчим насны хүү харагдлаа.

Тэр цагт гурван бичээч, нэг хүүг ажиллуулна гэдэг ихээ олон хүнд үйлчилдгийн шинж билээ.

Шадар цэрэг хэдийгээр нэг цагт ирэх ёстой боловч, прокурорын гэргий аль өглөөнөөс аван хүлээж, хайртай хүний маань сэтгэл нь дийлээд юм уу ядаж гэдэс нь өлсөөд ч гэсэн: арай эрт ирж магад гэж горилсоор байсан аж.

Ингээд шадар цэргийг бараг үүдэн дээр ирэх тэр минутад Кокнар авгай дотор өрөөнөөс гарч шатны дээд тавцан дээр ирсэн нь Портосыг ихээ бэрх байдлаасгаргав. Бичээч нар өөдөөс нь шохоорхон ширтчихээд энэ олон хүнд юу хэлэхээ мэдэхгүй, дуугүй зогсож байсан аж.

-Энэ чинь манай садангийн хүү байх чинь. Ор, ор Портос гуай гэж прокурорын гэргий дуу алдав.

Портос гэдэг нэрийг дуулаад бичээч нар хачирхаж инээлдсэнд Портос өөрөө эргэж харвал тэдний царай дахин төв болцгоов.

Прокурорын ажил хийдэг өрөөнд орохын тулд одоо бичээч нарын байж байгаа үүдний өрөөнөөс гарч, тэдний суудаг бичиг цаасанд дарагдсан баргар өрөөгөөр дайрч гарах ёстой юм. Эзэгтэй, зочин хоёр гал зуухны зүүнтэйгүүр өнгөрч гараад, зочдын өрөөнд орлоо.

Нэг нэгтэнтэйгээ залгасан энэ өрөөнүүд Портост аятай сэтгэгдэл төрүүлсэнгүй. Нээлттэй үүдний цаанаас үг бүрийг хүн дуулж болохын гадна, гал тогооны өрөө рүү хялам хийвэл прокурорын гэргийд ичгэвгэр, манай хүнд харамсалтай нь гэвэл, зууш төхөөрөх энэ өрөөнд сайн хоол хийхээр үймэлдэж, гал дүрэлзэж байгаа юм огт үгүй харагдлаа.

Прокурор янз нь зочин ирэх тухай урьдаас дуулсан бололтой, Портосыг орж ирээд, хэнэггүйхэн алхсаар очиж, эелдгээр мэхийн мэндлэхэд гайхсан царай ер гаргасангүй.

Прокурор матмал зөөлөн сандлынхаа бариулд тулж жаахан өндийх төдий болоод.

-Портос гуай, бид чинь хамаатан улс байхаа? гэв Прокурор өөрөө өтөлсөн доройтсон хатангир өвгөн, өргөн хар цамц өмссөн нь түүний хорчгор биеийг бүр халхалжээ. Хоёр нүд нь эрдэнийн чулуу шиг гялалзаж, энэ нүд мурийж үрчийх уруул хоёр нь энэ хүнд амьтай үлдсэн хоёрхон эрхтэн шиг санагдана. Гай болоход энэ арьс яс болсон хүний хөл нь мэдээгүй болж эхэлсэн, зургаан сарын өмнө улам бие доройтсоноос хойш прокурор чухамдаа эхнэрийнхээ боол болсон аж.

Хамаатны хүнийг ердөө үг дуугүй л хүлээж авлаа. Кокнар гуай тэнхээ тамир сайтай байсан бол Портосын садан хамаатан болох гэсэн алив оролдлогыг үл дуулахсан билээ.

Нөхрийг нь тэгтлээ баяр хөөр болон угтана гэж угаасаабодоогүй Портос огтхон ч зоволгүй, - Тиймээ эрхэм ээ бид садан сүлбээтэй улс гэж хэлэв.

-Тэхдээ бүсгүйчүүдийн талаар байхаа? гэж прокурор дооглонгүй асуулаа. Дооглосон байрыг нь Портос ажигласангүй, гэнэн цагаан аашилж байгаа юм санаад дотроо инээмсэглэв. Прокурорын гэнэхэн цагаан аашлах гэдэг ховор зүйл болохыг мэдэх Кокнар авгай

инээвхийлсэн болоод час улайчхав

Портосыг ирсэн цагаас аваад, Кокнар гуай бичгийнхээ царс модон ширээний өөдөөс харуулж тавьсан том шүүгээ рүү сэтгэл зовох байртай хялам хийгээд байсан билээ. Энэ шүүгээ лав нөгөө санаандаа дүрсэлсээр ирсэн авдар мөнийг Портос гадарлаад санаж байснаас нь хэлбэр дүрс ялгаатай хэдий боловч, бодсоноос нь зургаан тохой өндөр болохыг үзэж дотроо баярлав.

Кокнар гуай, садан сүлбээний тухай цаашаа гүнзгийрсэнгүй сэтгэл зовох байртай Портос шүүгээ хоёрыг ээлжлэн харснаа:

-Манай садангийн хүн аян дайнд мордохоосоо өмнө бидэнтэй ядаж ганц удаа ч билээ хоол идэх болов уу гэж горилно, тийм үү, үгүй юу, Кокнар авгай? гэж хэлэв.

Энэ айхтар үг Портосын ходоод руу ёвроод авсанд, сүрхий эмзэглэж, Кокнар авгай ч мөн муу үг хаясныг мэдэв бололтой, юу гэвэл авгай хариуцаж.

-Манай дайлж байгаа маань Портос гуайд эс таалагдвал манайд дахиж ирэхгүй, хэрэв тэхгүй бол явглаа. бараг бүх чөлөө цагаа бидэнд зориулахыг гуйна. Ер нь Парист даанч удахгүй манайд тун цөөн ирж чадах хүн шүү дээ гэсэн билээ.

Кокнар гуай амандаа,

-Оо хөл минь, миний муу хөл гэж үглээд инээвхийлэх царай үзүүллээ.

Хоол ундны талаар хүсэн мөрөөдөж явсан юманд нь ийм аюул тулгарч байх үед авгайн үзүүлсэн энэ дэмжлэг Портост гүнээ талархах сэтгэл төрүүлэв.

Удалгүй хоолны цаг болж, цөм гал зуухны өөдөөс харсан, хоол идэх том өрөөнд оров. Бичээч нар янз нь ер бишийн хоолны үнэр авсан бололтой. цэргийн хүмүүс аятай яг цагтаа ирээд, мухар сандал барьж бэлхэн зогсох аж. Тэдний эрүү ам урьдаас хөдлөн, ханаж цадамгүй харагдана.

Бага хүүг ч мэдээжээр, томчуултай цуг хоолонд оруулаагүй хэрэг, тэгээд тэр гурван өлөн ховдог хүнийг Портос хараад, үгүй ерөө "манай хамаатнуудын оронд би байсан бол ийм ховдог улсаар лав ажил хийлгэхгүй дээ. Эд чинь хөлөг онгоцоор явж сүйрээд, лав л бүтэн зургаан. долоо хоногийн турш идэх юмны бараа хараагүй юм уу гэмээр улс гээч" гэж бодов.

Кокнар гуай, мөн дугуйтай сандал дээр эхнэрээрээ түрүүлсээр ирж явлаа. Портос яаран туслалцаж, түүнийг хоолны ширээний дэргэд аваачлаа.

Прокурор мөн хоолны өрөөнд ороод ирэхтэйгээ зэрэг ам хамар нь бичээч нарынхтай адил хөдөлж эхлэв.

-Үгүй. энэ шөл чинь яасан хорхой хүрмээр үнэртэй юм бэ! гэж Кокнар гуай дуугарав.

" Үгүй, эд чинь энэ шөлийг юунд нь ингэтлээ хачирхаад байгаа юм бэ" гэж Портос, их ч гэсэн тосны нүнжиг үгүй их далайнарал аятай хаа нэг юм хөвсөн шингэн шөлийг хараад дотроо

бодлоо.

Кокнар авгай инээмсэглэв, цөм авгайн дохиогоор яаран суудлаа эзлэв.

Эхэлж Кокнар гуайд дараа нь Портосын тавганд шөл аягалаад, өөрийнхийгөө мөн дүүргэсний эцэст тэсэж ядан хүлээж байгаа бичээч нарт шөлгүй болсон үлдэгдлийг хувааж өгөв.

Энэ үеэр хоолны өрөөний үүд чажнаж нээгдээд, дутуу онгойсон үүдний цаана жаал бичээч байхыг Портос харлаа. Наргианд оролцох хувьгүй тэр хүү хоолны өрөө, гал зуух хоёроос гарах үнэрийг зэрэг авч, ногдсон талхаа идэн сэтгэлээ хуурч буй аж.

Шөлний дараа зарц бүсгүй чанасан тахиа авч ирэхэд, ийм сайхан юм үзээгүй улсын нүд бүлтчих дөхөв. Прокурор гашуунаар инээвхийлж,

-Кокнар авгай та садан төрлийнхөндөө сайн нь аргагүй юм байна. Эд бүгд цөм манай хамаатны ач яриагүй мөн гэв.

Хөөрхий тахиа, ясандаа үл цоологдох ширүүн зузаан арьстай хөгширч гүйцээд, тайван үхэх гэж зогсоол дээрээ нуугдчихаад байхад нь их л эрэл болж байж олж ирсэн бололтой аж. Чөтгөр алгад их гунигтай юм байна даа. Бихөгширсөн амьтныг хүндэлдэг, тэхдээ чанасан шарсан алин боловч тусгүй" гэж Портос дотроо бодов.

Тэгээд бусдын санал өөртэйгөө нийлж байгаа эсэхийг үзэхээр эргэцүүлж харвал огт үгүй, өөрий нь ингэтэл голсон тэр тахиаг хорхой асан ширтэцгээж байлаа.

Кокнар авгай тахиаг ойртуулж тавиад, хоёр том хар хөлийг нь чадамгай салган авч, Кокнар гуайн тавган дээртавилаа. Хүзүүгий нь огтолж аваад толгойтой хамт өөрөө идэхээр хажуу тийшээ тавьж, Портосын тавган дээр хаагий нь авч тавилаа. Ингээд тахиагаа бараг тэр чигээр нь зарц охинд өгсөнд, урам хугарсан улсын нүүр царай зан төлөвөөсөө болон хаашаа болж хувирах байсныг Портос ажиж амжихаас өмнө тахианы мах алга болчхов

Тахианы оронд шошоор хийсэн. их хоол авчирч тавьсанд түүн дээр махтай мэт харагдах хэд хэдэн хонины яс харагдав.

Гэвч бичээч нар үүнд хууртсангүй, тэдний барайсан царайнд хувь заяандаа хүлцэнгүй байх шийдвэр тодорч ирэв.

Кокнар авгай тэр хоолыг бичээч нарын хооронд сайн эзэгтэйн ёсоор татуухан хувааж өгөв. Дарс уух цаг болж ирлээ. Кокнар гуай жижигхэн лонхтой дарснаас бичээч бүрийн аяганд дунд нь хүрэхгүй дарс аягалж өгөөд өөртөө мөн бараг тийм хэмжээтэй аягалав. Лонх тэгээд даруй авгай, Портос хоёрын зүгт ирлээ.

Бичээч нар дарсан дээрээ ус нэмээд талд нь хүртэл ууснаа дахин ус хийв. Ийнхүү хоол идэж дуустлаа усаар сэлбэн уухад тэдний тэр ундаа бадмааргийн өнгөтэй байснаа угаат манан өнгөтэй болж ирлээ.

Портос эргэлзэн байж тахианыхаа хааг идчихлээ. Тэгтэл прокурорын гэргийн өвдөг ширээн доогуур өвдөгт нь хүрсэнд бие нь арзасхийв. Портос мөн тэр дарснаас хагас аяга уулаа, үзвэл, эдний ийнхүү нандигнаж байгаа ундаа нь нарийн юм идэж ууж даасан улсын дургүй хүргэдэг Монрейлийн муухай дарс байв.

Портос дарсыг усаар сэлбэлгүй ууж байхыг үзээд Кокнар гуай санаа алдав.

-Портос гуай, та энэ шошоос идээ ч гэж Кокнар авгай будааг зааж хэлэх дууны нь өнгө, "Миний үгэнд ор, үүнээс бүү ид" гэх байртай

-Юу ч гэсэн би үүнд чинь ам хүрэхгүй гэж Портос амандааүглээд, чангаар: -Баярлалаа. би бүүр цадаж орхилоо гэв.

Нам гүм болчихлоо, Портос цаашаа юу хийхээ мэдэхгүй сууна. Прокурор хэд дахин хэлэхдээ: -Ээ, гялайлаа Кокнар авгай, та биднийг чухам найрын журмаар дайллаа гэнэ.

Энэ зуур Кокнар гуай таваг шөл тахианы хоёр хар хөл жаахан мөлжүүртэй байсан хонины ганц яс төдийг лмөлжиж идсэн болсон билээ.

Хоол унд идэж байгаад ийнхүү нам гүм болчихсоны учир Портост эс ойлгогдовч, бичээч нарт сүрхий утга учиртай байжээ. Тэд нар прокурорын харц, Кокнар авгайн инээмсэглэхийг дагаж суудлаасаа босон алчуураа алгуур эвхэж тавиад, мэхэсхийн хүндэтгээд үүд чиглэв.

-Явцгаа, залуус минь, явж ажлаа хий, ажил гэдэг хоол шингэхэд хэрэгтэйзүйл юм шүү гэж прокурор тэдний араас ихэмсэг дуугарлаа.

Бичээч нарыг гарахын хамт Кокнар авгай босч шүүгээнээс жаахан бяслаг, чанасан жимс өөрөө балаар амталж хийсэн боов сэлт гаргаж ирэв.

Энэ бүх зуушийг хараад Кокнар гуай хөмсөг зангидаж, Портос хоолгүй үлдсэнээ мэдэж уруулаа хазав.

Нөгөө шош будаа ширээн дээр байгаа эсэхийг хартал тэрч алга болчихсон байна. -Үгүй, энэ чинь нээрээ найр болж байна шүү. Ёстой найр байна. Лусын хаан, Лусын хааныд дайлуулж байна гэж Кокнар гуай дуу алдав.

Портос дарс, талх, бяслагаар гэдсээ борлуулах санаатай хажуудаа байсан лонхыг харвал хоосон аж. Кокнар гуай, авгай хоёр үүнийг үл ажсан царай гаргав.

"За сайн, юу ч болсон би сэрэмж авлаа" гэж Портос бодов.

Нэг халбага чанасан жимс идээд, Кокнар авгайн боовноос хазвал шүд наалдчихаад болохгүй байлаа.

"Золиосонд гарлаа. Хэрэв би Кокнар авгайтай хамт нөхрийнх нь шүүгээ рүү өнгийх горьдлогогүй байсан бол уу" гэж дотроо бодно.

Кокнар гуай найр наргиан гэж нэрлэсэн сайхан хоол идэж цадаад амрахаар болов. Портос түүнийг тэр дотроо даруй амрах юм бодсон чинь, гайтай прокурор энэ тухай сонсохыг ч хүсэхгүй тул өрөөнд нь аваачихад хүрэв. Тэхдээ бүр нөгөө шүүгээнийхээ дэргэд очиж, хөлөө ирмэг дээр нь тавьж авглаа дуу таслахгүй байлаа.

Прокурорын гэргий Портосыг зэргэлдээ тасалгаанд аваачаад эвлэрэх суурь тавих гэж оролдов. -Долоо хоногтоо та гурван удаа ирж хоол идэж байж болно гэж Кокнар авгай хэллээ. Портос үүнд,

-Үгүй гялайлаа. би ямар нэг юмыг хэт ашиглаад байх. дургүй хүн. Тэгээд ч би зэвсэг хэрэгслээ олж бэлтгэхийг бодох ёстой хүн гэв.

-Нээрээ тийм, тэр гайтай хэрэгсэл сэлтийн тухай гээч гэж авгай гаслав. -Яая гэх вэ, тэр тухай бодох л болж байгаа юм гэж Портос батална.

-Танай хороонд чинь, юу юу хэрэглэдэг юм дээ, Портос гуай?

-Олон юм хэрэглэнэ. Шадар цэргүүд гэдэг маань сонгомол цэрэг гэдгийг та мэднэ. Тэхлээр торгон цэрэг, Швейцар цэргийн аль алинд хэрэглэдэггүй олон юм хэрэглэдэг улс гэж Портос хэллээ.

-Тухайлбал юу юу юм дээ, надад нэг тоочоод өгөөч, гэв. Нэг хоёр юмны төлөө тус тусад нь маргаж байсанд орохноо бүхэлд нь маргасан дээр гэж үзээд:

-Үгүй, эд бүгдийг хэдий хир үнэнд багтахаар гэж ярьсан ч бас болно шүү дээ гэж Портос хариулав

-Хэдий хир үнэнд тэр вэ, бодвол цаана хаяад... гэснээ авгайн амьсгаа давхцаад, үгээ дуусгаж чадсангүй.

-Оо хаанаас, хоёр мянга таван зуугаас илүү энгийн зоос хэрэггүй. Тэр ч байтугай, жаал нарийлж зарвал би хоёр мянган зоосонд ч багтаж мэднэ гэж Портос дуулгав.

-Өршөөлт бурхан минь, хоёр мянган зоос гэнэ шүү та минь гэж авгай дуу алдаад, үгүй энэ чинь нэг бүхэл бүтэн айлын хөрөнгө байна шүү дээ гэв.

Портос тун ч аягүй ярвайсанд, Кокнар авгай учрыг нь ойлголоо.

Авгай учир гаргаж,

-Миний ах дүү хамаатан дотор олоон хүн наймаа худалдаа хийдэг болохоор, танд хэрэгтэй юмсыг би лав хоёр дахин хямдаар олж чадна гэж бодоод, чухам юу юу хэрэгтэй байдгийг асуусан юм шүү дээ гэлээ.

Портос үүнд:

-Аа тийм юм бий, тэгвэл ч өөр үг шүү гэв.

-Тэр шүү дээ хонгор Портос минь, за ингээд юуны өмнө өөрт чинь морь хэрэгтэй, тийм ээ?

-Тиймээ, морь хэрэгтэй.

-За сайн, чухам танд таарах сайхан хүлэг над бий дээ. Портосын царай гийж, үгүй ер! За тийм бол морины яриа ингээд дуусч цаашаа бүрэн бүтэн тоног хэрэгтэй, энэ нь тэгээд шадар цэрэг хүн өөрөө л олж авахаас өөр мэхгүй, элдвийн юмтай байдаг. Гэхдээ энэ ч яахав, гурван зуун зоосноос хэтрэхгүй зүйл гэлээ.

-Гурван зуун зоос гэнээ, за яахав, гурван зуун зоос л болог гээд прокурорын гэргий санаа алдав.

Портос инээмсэглэнэ. Өөрт нь Бекингэм Герцогийн бэлэглэсэн эмээл байсныг уншигч нар санаж байгаа, тэхлээр мань хүн энэ гурван зуун зоосыг зүгээр өвөртөлчих бодолтой байжээ.

-Цаашаа байнаа, манай зарцад морь, надад хайрцаг хэрэгтэй болоод ирнэ гэв. Харин зэр зэвсгийн хувьд гэвэл, та зовох юмгүй, надад бий.

Прокурорын гэргий үүнд жаал түдгэлзэсхийж, зарцад морь гэв үү? Ингэхэд байнаа, найз минь энэ чинь дэндүү хээнцэр юм биш үү? гэлээ.

-Үгүй ерөө, авгатайн намайг арай нэг гуйлгачин аятай бодоогүй биз гэж Портос бардам дуугарав.

-Хаанаас даа! Сайхан луус заримдаа мориноос доргүй харагддаг, ухаан нь Мушкетонд сайхан луус олоод унуулчихвал... юу шүү дээ л гэж би хэлэх гэсэн юм.

-Болноо, яахав сайхан луус байг гэж Портос санал нийллээ. Таны зөв Испанийн том язгууртан хүний бүх бараа бологчид луус унаад явж байхыг би өөрөө үзсэн юм. Гэхдээ, тэр луус чинь сайхан хударга болоод, хонхтой байх ёстойг авгатайн өөрөө ойлгож байгаа хойно гэв.

Прокурорын гэргий үүнд, бүү санаа зов гэлээ. Портос үг залгаж, за одоо надад хайрцаг хэрэгтэй болноо гэсэнд, Кокнар авгай тосч аваад,

-Үгүй, үүнд та бүү санаа зов. Манай нөхөрт зургаа, долоон хайрцаг бий, дуртайгаа авч үз. Тэдний нэгийг тэр өөрөө юманд авч явах их дуртай байдагсан. Хорвоогийн юм бүхнийг багтаахаар лут том эд л дээ гэв.

-Тэгвэл, тэр хайрцаг чинь хоосон юм байж таарах нээ? гэж Портос цагаахнаар асуув. Прокурорын гэргий мөн цагаахнаар хоосон байлгүй яахав гэж хариуллаа.

Портос үүнд дуу алдаж, үгүй хонгор минь, надад чинь дотроо дүүрэн юмтай аяны хайрцаг хэрэгтэй шүү дээ гэв.

Кокнар авгай мөн л санаа алдаж эхлэв. Мольер тэр үед "Харамчаа" гэдэг зохиолообичээгүй байсан болохоор Кокнар авгай чухамдаа Гарпагонийн түрүүч үеийн хүн болжээ.

Ер нь гэхэд л төхөөрөх хэрэгслүүд бусад бүх зүйлийг иймэрхүү янзтай ширхэгчлэн авч хэлцсэний үр дүнд прокурорын гэргий найман зуун зоос бэлэн өгөх, мөн Портос, Мушкетон хоёрыг алдар гавьяаны аянд морилоход хөл залгах унаа хүлэг олж нийлүүлэхээр болов.

Ийнхүү ярилцаж тохироод, Портос босч Кокнар авгайнхаас явах боллоо. Авгай сээтэн хаялж, Портосын саатуулах оролдлого хийсэн хэдий боловч цаадах нь албаар түрээ барьсанд прокурорын гэргий арга буюу амраг хүнээ ван эзний албанд нь явуулав.

Манай шадар цэрэг гэртээ гэдэс өлөн ууртай нь аргагүй буцаж ирэв.

XXXIII. ЭЗЭГТЭЙ, ЗАРЦ БҮСГҮЙ ХОЁР

Энэ зуур, бидний дээр дурдсанчланд'Артаньян Атосын мэргэн зөвлөгөө, шударга сэтгэлийг үл бодон Миледийд улам улам сайн болсоор байв. Эрт орой алин боловч, хариу сэтгэл төрүүлж чадна гэж итгэх зоригт гаскон залуу тэднийд өдөр бүр очиж эргүүлсээр байв.

Нэг орой манай залуу сайхан ааштай, юуг ч болов бүтээж чадах юм шиг санагдсаар тэднийд хүрч ирээд зарцбүсгүйтэй үүдэн дээр дайралдав. Хөөрхөн Кэтти энэ удаа хажуугаар нь шүргэх төдий болж өнгөрсөнгүй, залуугийн гараас эелдгээр барьж зогсоов.

" За сайн, энэ бүсгүй лав эзэгтэйнхээ надад дамжуулаарай гэсэн нэг юмыг хэлэх гэж байх шиг байна. Миледи өөрөө уулзья гэж надад зүрхлээд хэлж чадахгүйг дамжуулах нь дээ" гэж д'Артаньян бодов.

Ингээд залуу охин руу тун ч сүржин байртай харлаа.

-Эрхмээ, танд нэг юм хэлмээр надад санагдах юм гэж хөөрхөн бүсгүй шивэглэв. -Ярь, ярь охин миль, би сонсож байна гэж д'Артаньян урамшуулна.

-Үгүй, энд яасан ч болохгүй, миний танд ярих юм их. бас тун ч нууц юм. -Тэгвэл, бид яадаг юм билээ дээ?

-Эрхэм та надтай цуг явахаас татгалзахгүйсэн бол гэж Кэтти хулгасхийж хэлэв. -Хаашаа ч гэсэн дуртай цуг явна, гуа бүсгүй минь.

-Тэгвэл явцгаая.

Кэтти тэгээд залуугийн гарыг тавилгүй хөтөлсөөр явж шатаар дээшээ өгсөж, арван тав орчим гишгүүр нигөрөөд нэг үүд онгойлгов.

-Орж үз эрхмээ, энд та бид хоёр, хүн амьтангүй, ярилцаж болно гэв.

-За гуа охин минь. энэ чинь хэний өрөө вэ гэж д'Артаньян асуув.

-Миний өрөө, эрхмээ. Энэ үүдээр эзэгтэйн унтах өрөө рүү ордог юм, гэхдээ сэтгэлзовох юмгүй. Миледи ер нь шөнө дундаас нааш хэвгдэггүй хүн, тэхлээр бидний яриаг дуулахгүй гэв. д'Артаньян өрөөг ажив. Тохилог жижигхэн өрөөг аятай сайхан засаж янзалсан, цэвэр сайхан аж. Миледийн өрөө рүү ордог гэж Кэттигийн заасан тэр үүднээс манай залуу өөрийн эрхгүй нүд салгаж чадахгүй байв.

Залуугийн санаа сэтгэлд юу болж байгааг гадарласан Кэтти санаа алдав.

Ингэхэд та манай эзэгтэйд голгүй сайн юм биз дээ, эрхмээ? гэж бүсгүй асуув. -Тиймээ, Кэтти, үгээр гаргаад хэлж болохооргүй, ухаан жолоогүй сайн юм. Кэтти дахин санаа алдаад;

-Энэ чинь их тоогүй дээ гэлээ.

-Үгүй, яагаад энэ чинь тийм муу юм байдаг билээ, чөтгөр алгад гэжзалуу асуув. Кэтти үүнд,

-Яагаад гэвэл. манай эзэгтэй танд огтхон ч сэтгэлгүй юм даа гэлээ.

д'Артаньян дурамжхан "хээн" гэж дуугараад,

-Чи үүнийг эзэгтэйнхээ даалгавраар ярьж байна уу? гэж асуув.

-Үгүй шүү, эрхмээ үгүй. Би өөрөө таныг өрөвдөөд, үүнийг хэлье гэж санасан юм. -Гялайлаа, хонгор Кэтти минь, гэхдээганцхан сайн санаанд чинь шүү, юу гэвэл, өөрий чинь дуулгаж байгаа зүйл онц таатай юм биш гэдгийг өөрөө сайн мэдэж байгаа хойно доо. -Тэгвэл миний хэлж байгааг та онц итгэхгүй байх шив, тийм ээ?

-Иймэрхүү юмыг үнэмшихэд ер нь хэцүү байдаг юм. Биеэ тоох сэтгэлийн үүднээс гэлээ ч гэсэн тэр шүүдээ, гуа бүсгүй минь,

-Тэхлээр та миний үгийг итгэхгүй байгаа юмаа?

-Чамайг хэлсэн юмаа нэг зүйлээр баталтал, үнэнийг хэлэхэд

-Үүнийг та юу гэж үзэх вэ? гээд Кэтти өврөөсөө жижигхэн зурвас гаргаж ирэв. д'Артаньян зурвасыг шүүрч аваад энэ чинь надад өгсөн

юм уу? гэв.

-Үгүй өөр хүнд.

-Өөр хүнд ээ?

-Тиймээ.

-Хэнд, хэнд тэр вэ? гэж Артаньян дуу алдав. Хаягийг нь унш л даа.

Де Вард гүнд гэсэн байна гээч хөөш!

Сен Жерменд болсон явдал биеэ тоосон гаскон залуугийн санаанд ороод ирлээ.

д'Артаньян зурвасыг задлах гэж байхыг, чухам даа гэвэл яах ийхийн завгүй задлаад орхихыг харсан Кэтти дуу тавьсан боловч тус болсонгүй.

-Ээ бурхан минь, та яаж байгаа нь энэ вэ, эрхэм ээ гэж бүсгүй хэлэв.

д'Артаньян үүнд.

-Гойд юм алга гээд уншиж үзвэл:

" Та миний анхны захидалд хариу ирүүлсэнгүй, яагаа вэ, бие муу байна уу, аль нөгөө де Гиз гуайн наргиан дээр над руу ямар шүү харц чулуудаж байснаа мартаадорхио юу? Гүн танд

аятайхан учрал дайралдаж байна ашиглаж үз" гэжээ.

д'Артаньяны дотор аягүй болж, элэг баригдсан санагдаад, хайр сэтгэлээ муучлуулсанд тооцон царай нь зэвхийрээд явчихлаа.

Кэтти , залуугийн гарыг дахин атгаад гүнээ өрөвдөн дотночилсон дуугаар,

-Хөөрхий хонгор д'Артаньян гуай гэв.

-Сайхан сэтгэлт охин минь, чи намайг өрөвдөж байнаау? гэж д'Артаньян дуугарав. -Тэгж байна, үнэн голоосоо шүү! Хайр сэтгэл гэж ямар байдгийг би мэдэх газар даа гэв. д'Артаньян анх удаа охин өөд анхааралтай гэгч хараад

-Хайр сэтгэл гэж ямар байдгийг чи мэднэ гэнээ? гэлээ.

-Гай болоход, мэдэх боллоо.

-Тийм бол, намайг өрөвдөж байхын оронд, эзэгтэйгээсээ өшөө авахад над тусалж өгөөч. -Та эзэгтэйгээс яаж өшөө авах санаатай байгаа юм дээ?

-Өөрөөс нь илүү чадалтайгаа эзэгтэйд чинь нотлон үзүүлээд, өрсөлдөж байгаа хүнийхээ орыг эзлэхсэн гэж бодох юм.

Кэтти үүнд,

-Үгүй, эрхмээ энэ талаар танд би яасан ч туслалцахгүй дээ гэж эрс маргав. -Яагаад тэр билээ гэж д'Артаньян асуулаа.

-Хоёр шалтгаан байна.

-Чухам ямар?

-Нэгд, манай эзэгтэй хэзээ ч танд сэтгэлтэй болохгүй.

-Чи үүнийг яаж мэдэх юм бэ?

-Та түүнийг үхтэл гомдоосон хүн.

-Би юу? танилцсан цагаасаа аваад, хөлийн нь өмнө боол шиг сөгдөж байгаа би гэдэг хүн Миледийг юугаар гомдоосон байдаг билээ энэ чинь, хэлээд өгөөч, гуйя гэв.

-Үүнийг би сэтгэлийг минь харж мэдсэн хүнд нээж хэлнэ. д'Артаньян охиныг дахин анхаарч харлаа. Охин тун ч залуу гуа сайхан хүн тул энэ өнгө үзэмжийг олоон дээд хэргэмтэн авгайчуул эрх хэргэмээрээ сольж авахаас буцахааргүй ажээ.

-Кэтти хонгор бүсгүй минь чиний сэтгэлийг би дуртай цагт чинь харж бодож үзнэ. Үүнд эргэлзэх юм огт алга гэж д'Артаньян хэллээ.

Ингээд , манай залуу түүнийг үнсчихвэл хөөрхий охины царай интоор шиг улайчхав -Үгүй, та надад хайр сэтгэлгүй хүн!

-Та манай эзэгтэйд л хайртай дөнгөж сая өөрөө ингэж хэлсэн шүү дээ гэж Кэтти дуу алдана.

-Хоёр дахь шалтгаанаа гаргаж хэлэхэд энэ л тэгээд саад болж байгаа хэрэгүү? Залуугийн нүдний урамшуулсан харц болон, үнсүүлсэндээ зориг орсон Кэтти,

-Хоёрдугаар шалтгаан нь гэвэл байнаа эрхмээ, хайр дурлалын хэрэгт хүн бүхэн хувиа хичээдэг юм гэлээ.

Кэттигийн гуниглангуй харц, үүдний өрөө, гудам, шатан дээр дайралддаг дайралдах бүрдээ гар хүрдэг, гүнээ санаа алддаг тэр бүхэн сая л д'Артаньяны санаанд орж ирлээ. Язгууртан бүсгүйн сэтгэлд таалагдахыг мэрийсээр зарц бүсгүйг д'Артаньян анхаарч үзсэнгүй, бүргэд агнаж яваа хүн ямар бор шувуухайг анзаарах биш дээ.

Гэвч Кэттигийн ийнхүү гэнэхнээр юм уу, аль эрээгүйгээр гаргаж илчилсэн хайр сэтгэлээс чухам ямар ашиг олж болохыг энэ удаа манай гаскон залуу даруй цэгнэж үзлээ.

Үүнд де Вард гүнд илгээх захидлуудыг зуураас нь авах Миледийг ажиглах эзэгтэйнхээ унтлаганы өрөөтэй залгаа Кэттигийн өрөөнд дуртай цагтаа орж байж болох аж. Ингээд үзэхэд, итгэл эвдэгч мань залуу хар хүү, Миледийг аргаар буюу хүчээр алин боловч олж авахын тулд хөөрхий охиныг дотроо золиосонд гаргаж байлаа.

-За ингэхлээр хонгор Кэтти чи миний хайр сэтгэлд итгэхгүй, ямар нэг зүйлээрбатлан үзүүлээсэй гэж байгаа юм шив? гэж мань залуу, охинд хэлэв.

Кэтти үүнд,

-Та ямар дурлалын тухай яриад байнаа? гэлээ.

-Чамд сэтгэлтэй дуртай болох шахаад байгаа тухайгаа ярьж байна.

-Үүнийгээ та юугаар нотлох юм бэ?

-Эзэгтэйтэй чинь сууж өнгөрүүлдэг цагаа өнөөдөр өөртэй чинь өнгөрөөе, дуртай юу? Кэтти алга ташин хөөрч,

-Их дуртай байна тэг гэлээ.

-За тийм жаахан хонгор минь наашаа ир. Чамд гэж хэлэхэд, миний урьд хожид үзсэн зарц бүсгүйчүүлийн дотор чам шиг сайхан хүн ер байгаагүй гэж д'Артаньян зөөлөн сандал дээр тавгай сууж өгүүлэв.

Энэ үгээ манай залуу тун итгэлтэй хэлсэнд, тэртэй тэргүй итгэх дуртай байсан хөөрхий охин итгэчихлээ. Гэхдээ хөөрхөн Кэтти сүрхий цэмцгэр зан гаргаж, арганд ер үл ороход д'Артаньян гайхаж байв.

Арга чарга хэрэглэж, няцаагдаж байхад цаг өнгөрөх нь амархан байдаг.

Шөнө дундын цаг цохиж, яг энэ үеэр Миледигийн өрөөнөөс хонхны дуу гарлаа. Өршөөлт бурхан минь, эзэгтэй намайг дуудаж байна яв, бушуу явж үз? гэж Кэтти дуу алдав.

д'Артаньян үгэнд нь орох гэж байгаа хүний байртай босч малгайгаа авснаа, шат руу гарсан үүдийг нээхийн оронд босоо том шүүгээний хаалгыг даруй нээж Миледигийн хувцас хунар дотор нуугдаж орхив.

-Та яаж байнаа? гэж Кэтти дуу алдав.

Шүүгээний түлхүүрийг нь авч амжсан д'Артаньян дотроос нь түгжиж орхиод хариу юм дуугарсангүй.

-Яалаа! гэж Миледи ширүүн зандраад та яачхав аа, унтчихаа юу? Намайг хонх дуугаргаад байхад яагаад ирэхгүй байна? гэв. Миледийн өрөөнд ордог хаалга онгойхыг д'Артаньян сонсов.

-Очлоо Миледи, одоо очлоо гэж Кэтти дуу алдаад эзэгтэйнхээ өөдөөс ухас хийв.

Тэр хоёр цаашаа унтлагын өрөөнд цуг орж үүд нээлттэй үлдсэн болохоор Миледи зарц охиноо үргэлжлүүлэн загнахыг д'Артаньян дуулж байлаа. Миледи эцэстээ нэг тайвширч, Кэттигээр юм хүм хийлгэх зуураа д'Артаньяны тухай яриа үүсгэв.

-Өнөө орой нөгөө гаскон залуу үзэгдсэнгүй шив гэж Миледи хэллээ.

-Юу гэнээ, авхайтан тэр ирээгүй гэж үү гэж Кэтти гайхаад;

Тэр чинь юм болж чадаагүй байж. тийм хөнгөмсөг байж таарах уу?

-Тэр ч үгүй. Де Тревиль гуай. Дезассар гуай хоёрын нэг л саатуулав бололтой. Би чадлаа мэднээ. Кэтти тэр надаас холдож лав чадахгүй.

-Та түүнийг яах юм дээ, авхайтан?

-Би түүнийг яах юм гэнээ?... Бүү сэтгэл зов, Кэттиминь. Тэр хүн бид хоёрын хооронд тэр өөрөө мэдэхгүй нэг юм бий юмаа.

Түүнээс чинь болж би их гэгээнтэнд золтой л итгэлээ барах дөхсөн юм. Чамаас би хариугаа сайн авна даа.

Үгүй, авхайтан таныг түүнд сэтгэлтэй юм байх гэж би бодож байсан юм.

-Сэтгэлтэй байх аа? Түүний чинь би үзэн яддаг хүн. Тэр чинь Винтер Лордийн амийг гартаа барьж байгаад алалгүй тавьсан юм. Түүнээс чинь болж бигурван зуун мянган зоосны орлогоо алдсан юм байхгүй юу.

-Нээрээ ч тийм дээ, хүү тань Винтер гуайн өвийг залгамжлах зээ нь болохоор хүүгээ насанд хүртэл та хөрөнгийг нь мэдэж байх байсан даа.

Энэ дур татам сайхан бүсгүй, өөрий нь нүүрэн дээр нөхөрсөг дотно, сүйд болоод байсан хүнээ алсангүй гэж өөрий ньэмлэж байгааг дуулж, ердийн хээнцэр яриа ярихдаа чадмаг' сайхан зөөлрүүлж чаддаг энэ ширүүн хахир дууг сонсохдоо д'Артаньяны хамаг бие зарсхийгээд явчихлаа. Миледи яриагаа залган,

- Хамба ламтан түүнийг яагаад ч юм өршөөгөөгүйсэн бол би аль хэдийнээ өөрөө өсөө авчих байсан даа гэв.

-Тиймээ! Гэхдээ д'Артаньяны сэтгэлтэй байсан, нөгөө наймаачны залуу гэргийг авгатайн та хайрлаагүй шүү дээ.

-Аа Авсчны гудамжиндсуудаг наймаачны гэргийг үү? үгүй хорвоо дээр тийм нэг бүсгүй байдгийг мань хүн аль хэдийнээ мартчихаа. Үгүй, тэр чинь үнэхээр лут чадсан юм шүү! гэв.

д'Артаньяны духаар хүйтэн хөлс дааварлана. Энэ бүсгүй үнэхээр шулмын амьтан аж. Тэдний яриаг чих тавин чагнаж байтал гай болж шөнийн засал сэлт гүйцжээ.

-За одоо өрөөндөө ор. Миний өгсөн тэр захидлын хариуг маргааш нэг авч үзэхийг бодоорой гэж Миледи хэлэв.

-Де Вард гуайд бичсэн захидлын уу? гэж Кэтти асуулаа.

-Де Вардад бичсэн захидлын л байлгүй яахав дээ.

-Миний бодоход тэр чинь хөөрхий д'Артаньян гуайтай адилгүй, азтай хүн юмаа гэж Кэтти дуугарав.

Миледи үүнд,

-Хонгор минь явж үз, илүү үгэнд би дургүй гэж хариуллаа.

Үүд хаагдаж, хоёр түгжээ дуугарахыг д'Артаньян сонслоо. Миледи дотроосоо түгжиж байгаа нь энэ аж. Кэтти мөн үүдээ аль болохоор чимээ гаргахгүйг хичээсээр түгжлээ. Ингэсэн хойно д'Артаньян шүүгээнийхээ үүдийг онгойлгов.

-Бурхан минь! Та яваа? Царай чинь хачин цайрчихаад? гэж Кэтти шивэгнэв. . -Муухай новш гэж д'Артаньян дуугарлаа.

-Чимээгүй, чимээгүй, явж үз? Миний өрөө Миледигийн өрөөнөөс нимгэн ханаар тусгаарлагдсан, үг болгон тэнд, дуулддаг юм гэж Кэтти хэлэв.

д'Артаньян үүнд

-Тэх тусмаа би явахгүй гэлээ.

-Энэ чинь юу гэсэн үг вэ? гэж Кэттийн царай улайн асуув.

-Явсан ч... сүүлдявна гэж д'Артаньян хэлээд Кэттийг татаж тэврэхэд цааргалахын эрхгүй чимээ гарчих гээд байлаа. Кэтти өөрийн эрхгүй ая дагав.

Энэ нь Миледигээс хариу өс авч байгаа юм аятай байлаа. Өс авах амттай гэж ярилцдаг үүний үнэн болохыг д'Артаньян үзэж үнэмшив. Хэрэв өөрт нь өчүүхэн төдий ч гэлээ үнэн сэтгэл байсансан бол энэ шинэ ялалтдаа сэтгэл амрахсан билээ, гэвч манай залуу дээшээ эрмэлзэх, бардам сэтгэлд автаж байсан юмаа.

Бас ч д'Артаньяныг магтаж хэлэхэд, Кэттийг нөлөөндөө оруулсны жавшаанд юуны өмнө Бонасье авгайн тухай лавлаж сураглав. Хөөрхий охин энэ тухай юу ч мэдэхгүйгээ бурхны нэр барьж андгайллаа. Эзэгтэй нь нууцынхаа зах зухыг л дуулгадаг юмбайж, Тэхлээр Бонасье авгай лав амьд мэнд байгаа гэж баттай хэлж байв.

Мөн ямар шалтгаанаар Миледи хамба ламд итгэлээ барах шахсаныг Кэтти мэдэхгүй байлаа. Гэвч д'Артаньян өөрөө энэ тухай илүү сайн мэдэж байсан билээ. Англиас гарч явах үедээ, хоригдсон хөлөг онгоцнуудын нэгэн дээр Миледи байхыг харсан болохоор лав алмазан унжуурганы тухай яриа мөн гэж ойлгож байлаа.

Гэлээ гэхдээ, д'Артаньяныг Миледи үнэн голоосоо үзэн ядах болсон гол учир гэвэл Винтер Лордыг алаагүйгээс болсон нь мөн илт байлаа.

Дараа өдөр нь д'Артаньян дахиж Миледигийнд ирлээ. Миледи сүрхий зан муутай байсан нь де Вард гүнгийн хариу саатсанаас болжээ гэж д'Артаньян бодлоо. Кэтти орж ирсэнд Миледи түүнтэй айхтар ширүүн байлаа. Кэтти д'Артаньян өөд харц чулуудсан нь: "Өөрийн чинь төлөө миний яаж зовж байгааг харж байгаа биз" гэх байртай.

Гэхдээ оройхон тийшээ сайхан царайт эм араатны ширүүн зан зөөлрөөд д'Артаньяны сэтгэлээ илчилсэн эелдэг үгийг инээмсэглэн сонсож, гараа үнсэхийг зөвшөөрлөө.

д'Артаньян тэднийхээс гарахдаа юу бодох учраа олохоо больчихлоо. Гэвч мань залуу амархан толгой эргэчихдэг хүн биш болохоор Миледийг оролдохын хажуугаар дотроо нэг жаахан төлөвлөгөө зохиожээ.

Үүдний дэргэд Кэттитэй дайралдаад урьд оройн адил тэдний өрөө рүү орлоо. Миледи сүрхий хилэгнэж, Кэттийг урагшгүй гэж аашилсныг дууллаа, Де Вард гүн чухам яагаад хариу өгөхгүй байгаа учрыг Миледи олохгүй гайхаад, өглөө арван цагийн хирд ирж гурав дахь захиа аваарай гэж Кэттид тушаасан гэнэ.

д'Артаньян маргааш өглөө тэр захидлыг өөртөө аваачиж өгнө гэж Кэттигээр ам алдууллаа, хөөрхий бүсгүйн толгой бүр эргэж гүйцээд, хайр сэтгэлт хүнийхээ юу шаардсан болгоныг үггүй дагах аж.

Бүх юм өчигдрийн адил болж, д'Артаньян шүүгээнд нуугдаад Кэттийг Миледи дуудаж аваачив. Унтахын өмнөх заслал сэлтээ хийлгэж аваад Кэттийг явуулж, үүдээ дотроос нь

түгжлээ, мөн өчигдрийн нэг адил д'Артаньян өглөөний таван цаг болгож байж гэртээ харьж ирэв.

Арван нэгэн цагийн хирд Кэтти тэднийд Миледигийн зурвасыг барьсаар хүрч ирлээ. Энэ удаа хөөрхий охин зурвасаа үг дуугүй өглөө. Хайр сэтгэлээ сайхан цэрэгт бүрмөсөн өгөөд юу дуртайгаа хийг гэж бодох болсон байлаа.

д* Артаньян захиаг задлаад:

"Танд хайр сэтгэлтэйгээ би гурав дахь удаа бичиж байгаа маань энэ. Дөрөв дэхудаагаа таныг үзэн ядна гэж бичих бий, болгоомжлоорой.

Хэрэв та ингэж авирласандаа гэмшиж байгаа бол зөв хүмүүжилтэй хүн яаж миний сэтгэлийг зөөлрүүлж болохыг зурвас хүргэж өгөх энэ бүсгүй хэлж өгнөө" гэснийг уншив.

Энэ зурвасыг уншиж байх зуур д'Артаньяны царай нэг улайж, нэг зэвхийрнэ. Залуугийн царайнаас нүдээ хурамхан зуурч салгалгүй ажиж байсан Кэтти дуу алдаж, -Үгүй, та чинь авхайд сайн хэвээрээ л байгаа юм байна шүү дээ гэлээ.

-Үгүй, Кэтти чи эндүүрч байна, би түүнд нэгэнт хайр сэтгэлгүй болсон, гэхдээ ингэж басамжилсанд нь хариугаа авмаар байна.

-Таны яаж хариугаа авах гэж байгаагий чинь би мэднээ, та өөрөө над хэлж байсан шүү дээ.

-Кэтти чамд ямар ялгаа байгаа юм бэ, би ганцхан өөрт чинь л сайныг чи мэднэ хойно. - Үүний чинь мэдэж болдог юм гэж үү?

-Миледийг яахыг харахаараа л чи үзэж үнэмшинээ гайгүй гэв.

Кэтти санаа алдав.

д'Артаньян үзгээ аваад ингэж бичлээ.

" Авхай танаа, би өөрөө ийм их завшаан тохиолдохоор сайн хүн огт биш болохоор анхны хсёр зурвасыг чухам над бичсэн гэдэгт итгэж чадахгүй байсан билээ. Ядаж би өвчтэй байсан болохоор танд тэртэй тэргүй хариу өгөх аргагүй байлаа. Гэвч өнөөдөр, таны сэтгэлд таалагдах азтайдаа итгэх ёстой болов. Юу гэвэл, үүнийг таны захиа төдийгүй, танай зарц охин баталж байна.

Зөв хүмүүжилтэй хүн ямар шүү янзаар таны сэтгэлийг зөөлрүүлж болохыг энэ охин надад зааварлах явдал огт үгүй.

Ингээд өнөөдөр орой арваннэгэн цагт би өөрөө очиж тэр тухай танаас уучлал гуйх болноо. Очихыгоо одоо нэг өдрөөр ч билээ хойшлуулна гэдэг миний санахад таныг дахин доромжлох гэсэнтэй адил үг шиг санагдана.

Таны соёрхлоор хорвоо дээр хамгаас жаргалтай хүн; болсон.

Де Вард гүн гэжээ.

Юуны өмнө энэ захидал хуурамч. цаашлаад манай үеийнхний үзлийн үүднээсбол бүр доромжилсон байртай бүдүүлэг захиа байлаа. Гэвч тэр цагт хүмүүс өнөөгийнхийг бодвол нэг их ёсорхдоггүй байсан юм. Тэгээд ч д'Артаньян Миледигийн өөрий нь үгнээс ихээ чухаг хэрэгт мөс муу юм гаргахаас буцахгүйг нь дуулсан учраас тун ч өнгөцхөн хүндэтгэдэг байв. Хэдий тийм боловч, тэр бүсгүйд нэг хачин, ухаан жолоогүй шунаад байлаа. Нөгөө талаар нэг басамжлангуй сэтгэл төрөлцөвч манаран татагдах шунал, тачаал гэж болох байлаа.

д'Артаньяны төлөвлөсөн нь их энгийн зүгээр л Кэттигийн өрөөнөөс Миледи унтах өрөөнд орж, гайхаж самгардах анхны минутыг ашиглан санасандаа хүрэх санаатай байжээ, санасандаа хүрч чадахгүй байж болох авч, зориглож үзэхгүйгээр юу бүтэх билээ. Долоо хоногийн дараа аян дайнд мордоод явж өгөх хэрэг болно, ер нь л д'Артаньян янаг амрагийн явдлаар зууралдаж байх цаг үгүй байв. Зурвасаа нааж Кэттид өгөөд,

-За май, энэ захиаг Миледид өгөөрэй, энэ чинь де Вард гүнгийн хариу шүү гэлээ. Хөөрхий Кэтти захианы агуулгыг гадарлаж байсан болохоор царай нь хачин зэвхийрээд явчихлаа.

-Хонгор минь чи миний үгийг дуул. Яалаа ч гэсэн эд бүгд нэг дуусах ёстой гэдгийг чи өөрөө мэдэж байгаа шүү дээ. Чамайг анхны захидлыг гүнгийн зарцад биш, миний зарцад өгснийг, мөн де Вард гүнгийн задлах учиртай хоёр дахь зурвасыг намайг задалсан тухай Миледи мэдээд орхиж болох юм. Тэгвэл Миледи чамайг хөөж орхино, тэгээд үүгээр сэтгэлханах бүсгүй биш гэдгийг чи өөрөө сайн мэднэ шүү дээ.

-Ээ чааваас! Хэний төлөө би эд бүгдийг хийж байна даа? гэж Кэтти хариуллаа. -Гуа хонгор минь миний төлөө гэдгийг би сайн мэдэж байна, үнэн голоосоо хэлэхэд чамд би их баярлаж байна л гэж залуу хариуллаа.

-Үгүй тэгээд зурвастаа та юу гэж бичсэн юм бэ гэхэд д'Артаньян:

-Миледи чамд тэр тухай хэлж өгнөө гайгүй гэж өгүүлэв.

-Үгүй тад надад огт сэтгэлгүй би мөн хувьгүй хүнээ, гэж Кэтти дуу алдав.

Ийм зэмлэлийн өөдөөс бүсгүй хүнийг ямагт төөрөлдүүлж чаддаг нэг хариулт байдаг билээ. д'Артаньян мөн тэгж хариулсан. Кэтти үнэн байдлаас холуур төөрлөө.

Захидлыг Миледид өгье гэж шийдэхээсээ наана Кэтти их уйлсан боловч, эцсийн эцэст өгөхөөр шийдлээ. д'Артаньянд үүнээс өөр юу ч хэрэггүй байсан билээ.

Түүнээс гадна орой эзэгтэйгийн өрөөнөөс эрт гараад өөрийн нь өрөөнд очно гэж амлалаа. Тэгээд хөөрхий Кэтти энэ амлалтанд бүрмөсөн тайтгарав.

XXXIV. ПОРТОС АРАМИС ХОЁР АЯН ДАЙНЫ ХЭРЭГСЛЭЭ ТӨХӨӨРСӨН НЬ

Дөрвөн нөхөд хэрэгсэл сэлтээ олохоор оролдох болсноос хойш байнга уулзаж байхаа больжээ. Цөм хаа дайралдсан, чухамдаа гэвэл хаа олдсон газар хоол идэх боллоо. Мөн өдий чухаг, хурдан өнгөрч байгаа шадар цэргийн албаа хааж өнгөрөөнө. Гэхдээ Атос үгэндээ хүрч, гэрээсээ гаралгүй суух болсон тул долоо хоногт нэг удаа өдрийн нэг цагийн алдад Атостай уулзаж байхаар тохирчээ.

Нөгөө д'Артаньяныд Кэтти хүрч ирсэн тэр өдөр яг дөрвөн нөхөд учрах болзоотой байсан юм.

Кэттиг гармагц д'Артаньян Феру гудамж руу явлаа. Түүнийг очиход Атос Арамис хоёр гүн ухааны яриа дэлгэж суув. Арамист сахил хүртэж, хувраг хувцас өмсөх санаа дахин төрөх болсон аж. Атос ердийнхөө заншлаар хориглох ч үгүй, дэмжих ч үгүй байлаа. Тэр ер нь хүн бүхэн өөрийнхөө дураар явах ёстой гэж үздэг хүн. Хүн гуйвал, гуйх гуйхдаа сайн гуйвал л сая юм зөвлөж өгдөг хүн билээ.

Хүмүүс ер нь авсан зөвлөгөөг дагах гэж хүнээс юм асуудаггүй, хаа нэг хүн харин хожимдоо буруугаа тохох хүнтэй байхын тулд л зөвлөгөөг дагадаг гэж Атос ярьдагсан.

д'Артаньян ы дараа Портос хүрч ирлээ. Ингээд дөрвөн нөхөд цөм цугларч гүйцлээ. Нөхдийн царайг ажвал, Портос амгалан, д'Артаньянд горьдлого төрсөн, Арамис сэтгэл зовсон, Атос ер хэнэггүй, ийм өөр өөр байртай ажээ.

Яриа эхлээд минут хир болж, хэрэгсэл сэлтээ олоход нэг өндөр язгуурт бүсгүй туслах ам өгсөн тухай Портос үг цухуйлгаж амжаад байтал Мушкетон хүрч ирлээ. Тэр наашаа Портосыг дуудах гэж ирсэн ба түүний уруу царайлан хэлж байгаа үгээр бол эзэн нь даруй харих чухаг хэрэг гарчээ.

-Энэ чинь миний хэрэгсэл сэлтээ олохтой холбогдсон юм биш биз? гэж Портос асуусанд Мушкетон хэлэхдээ.

-Тийм ч гэмээр, үгүй ч гэмээр юм гэв.

-Үгүй, чи над хэлчхэж болохооргүй юм гэж үү?..

-Явья эрхмээ харья.

Портос босч, нөхдөдөө салах үг хэлээд Мушкетоныг дагаж одлоо. Мөн минутын дараа Базен оржирэв.

Арамисын санаа бодол дахин сүм хийд рүү хандаад ирэхээрээ үг яриа нь зөөлөн эелдэг болдогсон. Ингээд

-Юу болоо вэ, найз минь? гэлээ.

-Эрхэм ээ таийг нэг хүн ирж хүлээгээд байна гэв,

-Хүн гэнээ? ямар хүн тэр вэ?

-Нэг гуйлгачин л байна.

Тэгвэл Базен чи өглөг юм өг, хөөрхий нүгэлт миний төлөө залбирч яваарай гэв.

-Тэр гуйлгачин юу боловч тантай үг солих хэрэгтэй гэнэ. Уулзаад таныг заавал баярлана гэж мэтгээд байна билээ,

Надад юм хүм хэлүүлээгүй биз?

-Хэлүүлсэн Арамис гуай ирж надтай уулзахаас дургүйцвэл "намайг Тур хотоос ирсэн гэж дуулгаарай" гэсэн.

-Турхотоос оо! гэж Арамис дуу алдаад,

-Эрхмүүд ээ уучилж үзээрэй. Тэр хүн янз нь миний хүлээж байсан сураг чимээг авч ирсэн бололтой гээд суудлаасаа босон харайж яаран гарч одлоо.

Агос, д'Артаньян хоёр үлдлээ.

-Энэ сайн эрс хэргээ бүтээчив бололтой, чи юу гэж бодож байна д'Артаньян? гэж Агос асуулаа.

-Портос л лав их урагштай байгааг би мэдэж байна Арамисын хувьд гэвэл би ер үнэнээсээ санаа зовж байгаагүй шүү. Харин Агос, нөхөр минь та... зүй ёсоор танд байх учиртай Англичуудын алтан зоосыг өгөөмөр зангаараа тараагаад өгчихсөн. Та одоо тэгээд яах вэ?

-Би тэр төрхгүй золигийг алсандаа сэтгэл хангалуун байна юу гэвэлангли хүн ална гэдэг чинь буянтай үйл. Гэхдээ түүний хэтэвчийг би өөрөө өвөртөлчих юм бол өөрөө өөртөө олхиогүй санагдаад явж чадахгүй байхсан гэв.

Боль доо Агос таны зарим бодлын учир нь мэдэгдэхгүй юм байна шүү.

-За энэ тухай яриад юу хийхэв, өчигдөр де Тревиль гуай манайд ирж соёрхохдоо өөрий чинь хамба ламын өршөөл ивээлд багтсан сэжигтэй англичуудын гэр орноор их явдаг гэнэ гэсэн, үнэн үү?

-Би нэг англи бүсгүйд, нөгөө танд ярьж байсан бүсгүйд очдог үнэн.

-Аа тийм, цайвар үстэй бүсгүй шүү дээ, тэр талаар танд би хэд хэдэн үг зөвлөсөн мэдээжээр миний үгийг дагах санаа ч танд төрөөгүй тэгээд талаар өнгөрсөн байлгүй яахав

-Танд би учирлаж хэлсэн шүү дээ.

-Тэгсэн нь ч тэгсэн, та хэрэгслээ төхөөрөхөд тус болох байрын юм хэлсэн байхаа.

-Огт үгүй шүү! Тэр бүсгүй Бонасье авгай хулгайлах хэрэгт оролцсон эсэхийг нь магадлах гэсэн юм.

-Ойлгож байнаа. Нэг бүсгүй эрж олохын тулд нөгөө бүсгүйг оролдоно гэдэг хамгийн тойруу арга хэдий боловч, хамгийн аятайхан нь юм даа.

д'Артаньян болсон бүх явдлыг золтой л Атост яриад өгчихсөнгүй. Атос нэр төрийн асуудалд тун ч эмзэг, манай залуу Миледийн тухайд бодож боловсруулсан төлөвлөгөөнд энэ цэмцгэр хүний санаанд үл нийцэх зарим тал байсан болохоор амаа барьж өнгөрлөө. Атосыг лав дургүйцнэ гэж д'Артаньян мэдэжбайсан болохоор дуугүй байсан нь дээр гэж үзлээ. Атос өөрөө ер элдэвт дургүй хүн тул д'Артаньян цаашаа үг дэлгэхэд хүрсэнгүй.

За ингээд, хоёр биендээ онц чухаг юм хэлэх дургүй байгаа хоёр нөхдийг орхиод Арамисын хойноос дагая.

Өөртэй нь уулзахсан гэсэн хүн Турээс ирснийг дуулаад мань залуу, Базены хойноос хир шалмаг гарсныг, чухамдаа Базенаасаа түрүүлээд одсоныг бид дээр дурдсан. Феру гудамжнаас нэг амиар

гүйсээр Вожирар гудамжнаа хүрч ирэв.

Гэртээ ортол үнэхээр нэг ноорхой хувцас өмссөн ухаалаг нүдтэй намхан хүн хүлээж байлаа. - Та надтай уулзахсан гээ юү? гэж залуу шадар цэрэг тэр хүнээс асуулаа. -Би Арамис гуайтай уулзахсан гэсэн юм. Арамис гэж та юү?

Би байнаа. Та надад хүнээс сураг чимээ авч ирээ юү?

-Та нэг хатгамалтай алчуур үзүүлэх юм бол дамжуулж өгөх юм бий.

Арамис дотоод халааснаасаа түлхүүр гаргаж, таних чимэгтэй хар зандан хайрцаг онгойлгож, энэ байна, хар даа гэлээ. Гуйлгачин хүн үүнд, За сайн, та зарцаа явуулчих гэв.

Тэр гуйлгачин эзэнтэй нь уулзах ямар хэрэгтэйг мэдэх гэж тэсэж ядан байсан Базен, Арамисын хойноос яарсаар явж бараг цуг шахуу ирсэн юм байж. Гэтэл ингэж яарсны ашиг гарсангүй, гуйлгачны хэлсэн үгний хариуд эзэн нь түүнийг гар гэж дохисныг Базен арга буюу дагахад хүрлээ.

Түүнийг гармагц, нөгөө гуйлгачин өөр харж, чагнаж байгаа хүн үгүй эсэхийг эргэцүүлж харснаа суран бүсээр хааш хэрэг бүсэлсэн навсархай хувцсаа ярж цамцныхаа дээд энгэрийг ханзлаад захидал гаргаж ирэв.

Захидал дээрх тамгыг Арамис хараад баярлан дуу алдаж дээрх бичгийг нь энхрийлэн үнссэнээ, догдлон чичирсээр захидлыг задалбал, ийм юм бичигдсэн аж.

" Хувь заяаны тавилангаар бид нэг хэсэгтээ бас л бие биеэс хол байх нь, гэвч идэр насны сайхан өдрүүд эгнэгт өнгөрөөгүй байна. Хуаранд та үүргээ гүйцтэг, би өөрийнхийгөө өөр газар гүйцэтгэнээ. Энэ захидал аваачиж өгөх хүний өгсөн юмыг авч хайрла, эр зоригт сайн

тайж хүний ёсоор байлдаарай, миний тухай бодож яваарай. Хар нүдийг чинь энхрийлэн үнсье.

Хагацъя , үгүй мөд уулзъя" гэжээ. Энэ зуур нөгөө гуйлгачин цамцаа алгуур ханзалсаар бохир навтсан дотроосоо Испанийн давхар алтан зоос зуун тавийг гаргажширээн дээр тавиад, гайхаж мэлэрсэн Арамисыг ганц үг дуугарч амжихаас өмнө мэхийн ёслоод гарч одлоо. Манай залуу тэгээд захидлаа дахин уншиж үзтэл эцэст нь: Жич захиа өгсөн хүнийг сайн хүндэлж дайлаарай, энэ хүн гүн хэргэмтэй, Испанийн язгууртан эрхэм шүү гэсэн аж.

Биелсэн сайхан мөрөөдөл энэ байна! Амьдрал гэгч нээрээ сайхан юмдаа. Тиймээ бид идэр залуу байна. Бидэнд жаргалтай сайхан цаг ирнэ гэдэг үнэн. Гуа сайхан хайрт голоосоо янаг ганц чамдаа л би хамаг бүхнээ зориулна! гэж Арамис дуу алдав.

Ингээд ширээн дээр гялалзах алтыг тоож харалгүй захидлаа үнсэн үнсэн энхрийлнэ. Базен үүд аяархан тогшлоо. Түүнийг одоо гадаа байлгах шалтаг Арамист байсангүй болохоор орохыг зөвшөөрөв.

Базен алтны бараа хараад гайхаж гөлөрчихлөө, тэгээд д'Артаньян ирсэн тухай эзэндээ дуулгахаар ирснээ мартчихжээ. д'Артаньян Атосынхаас гараад, Арамисынд юун учиртай гуйлгачин ирснийг сонирхохоор замдаа ороод гарах санаатай ирсэн юмсанж.

Тэгтэл Базен өөрийн нь тухай дуулгахыг мартаж орхисныг үзээд, уулаасаа Арамистай нэг их ёсорхоод байдаггүй болохоороо өөрөө өөрийнхнөө тухайдуулгахаар шийдлээ.

-Үгүй ерөө! Чөтгөр алгад, энэ алтан жимсийг Тур хотоос ирүүлсэн юм бол тарьж ургуулсан цэцэрлэгчид нь миний гүнээ бахдаж байгааг, хонгор Арамис минь дамжуулж үзээрэй гэж д'Артаньян хэлэв.

Уулын юм хүмээ нуудаг зантай Арамис үүнд:

-Энэ чинь миний номыг хэвлэсэн хүн, нөгөө замд явж байхдаа миний эхэлсэн нэгэн үет шүлгийн шагналыг ирүүлжээ гэж маргав.

Өө тийм юм бий, Арамис минь, танай номыг хэвлэдэг хүн тун өгөөмөр хүн юмаа, юу ч гэхэв гэж д'Артаньян дуугарлаа.

-Юу гэнээ эрхмээ, яруу найраглалд ийм их мөнгө өгдөг юм гэж үү? үгүй байлтай л юм даа гэж Базен дуу алдав. Үгүй та тэгвэл юу дуртайгаа хийж чадах нь байна шүү дээ,

Эрхмээ . Та тэгвэл де Вуатюр гуай юм уу, де Бенсеред гуай шиг нэртэй цуутай болж чадах юм байна шүү дээ. Энэ чинь миний сэтгэлд аятай байх юм. Яруу найрагч гэдэг хувраг хүнээс ялихгүй доогуур хүн шүү. Арамис танаас их гуйя, та яруу найрагч л болж үз.

-Базен, та чинь ярианд хөндлөнгөөс оролцоод байх шиг л санагдах юм найз минь гэж Арамис хэлэв.

Базен буруугаа мэдэж, доошоо хараад өрөөнөөс гарч одлоо.

д'Артаньян инээмсэглээд, За тийм байж, та чинь уран бүтээлээ алтаар үнэлүүлдэг хүн юм, мөн ч хийморьтой байнаа найз минь. Гэхдээ хянуур л байж үзээрэй, наад халааснаасаа цухуйгаад байхаа захидлыг хаяж орхив доо. Тэр бас л танай ном хэвлэдэг хүнээс ирсэн байж таарах байх даа гэлээ.

Арамисын царай час улайчхаад, захидлаа лав өвөртөлж цамцаа цэмцийтэл товчилж орхив. - Сайн нөхөр д'Артаньян минь, нөхөддээрээ очъё, одоо би баян болсон, хамтарч хоол иддэг заншлаа сэргээж, таны баяжих ээлж иртэл үргэлжлүүлье гэж Арамис өгүүлсэнд

д'Артаньян тосч аваад, дуртайяа тэгье. Бид олигтой хоол идээгүй болсоор удаж байна. Тэгээд ч өнөө орой би нэг нилээд эгзэгтэй ажил хийх хүн, хэдэн шил хуучин бургунд дарсаар зоригоо чангалахаас буцмааргүй л байна.

-Хуучин бургунд дарс ч бас болно. Надад ч мөн уухаас татгалзах юм огт алга гэж алтны бараа хармагцаа хорвоогоос холдох сэтгэл нь өргөс шиг авгчихсан Арамис санаа нийлэв.

Ойр зуурын хэрэгцээнд гэж давхар алтан зоосноос гурав дөрвийг авч халаасандаа хийгээд, үлдсэн мөнгөө, нөгөө сахиус болсон хатгамалт алчууртай. танан чимэгт хар хайрцагтаа хийгээд хадгалчхав.

Эхлээд хоёр нөхөд Атосын очлоо. Гэрээсээ гарахгүй гэсэн үгнээсээ үл буцах Атос хоолыг гэртээ авчруулахаар захиалъя гэсэнд, зуушны хамаг нарийн нандинг үл андах хүн болохыг нь сайн мэдэх д'Артаньян Арамис хоёр энэ чухаг хэргийг түүнд гардуулж өгье гэв.

Тэд цаашаа Портосын руу очихоор явтал, Торх гудамжны булан дээр Мушкетонтой дайралдвал, нэг морь луус хоёр тууж уруухан царайтай явж байлаа.

-Үгүй энэ чинь миний бор азарга байна шүү дээ гэж д'Артаньян гайхаж дуу алдахад, бас баярласан байдал илэрхий Арамис чи энэ морийг сайн хараа гэлээ.

-Үгүй ямар муухай, морь вэ? гэж Арамис дуугарав.

-Ингэхэд байнаа, найз минь миний унаж Парист ирсэн морь энэ юм шүү гэж дээ д'Артаньян дуулгав.

Мушкетон гайхаж,

-Юу гэнээ эрхэм ээ, та энэ морийг таних юм гэж уу? гэлээ.

-Энэ морь их хачин зүстэй юм гээч би ийм зүстэй морь анх үзэж байна гэж Арамис дуугарлаа.

-Тэхгүй яахав. Үүний чинь тухайлан ийм зүстэйн улмаас би гурвай алтан зоосоор зарсан юм шүү, тэргүй болж гэм надад арван найман энгийн зоос ч өгөх юм энэ моринд байгаагүйсэн билээ. Үгүй ингэхэд энэ морь, яаж чиний гарт ороо вэ, Мушкетон?

-Зүгээр бүү асуу, эрхэм минь, манай энэрэлт бүсгүйн нөхөр герцог гуай биднийг ингэтэл

айхавтар чаджээ.

-Яаж тэр вэ, Мушкетон?

-Нэг язгууртан бүсгүй герцог де...Хэн гуайн гэргий бидэнд их энэрэлтэй байдаг юм. Уучлаарай ингэхэд манай эзэн нэрийг нь хэлэхийг хориглосон юм. Тэр бүсгүй бидэнд жаахан бэлэг, нэг сайхан испани морьд нүд салгахын эрхгүй хөөрхөн андалуз нутгийн луус хоёр ирүүлсэн юм. Нөхөр нь энэ тухай мэдэж орхиод, тэр сайхан амьтдыг наашаа хөтөлж явах зам зуураас булааж аваад энэ муу хоёроор сольчихсон байхгүй юу гэлээ.

-Эднийг чи тэгээд буцаагаад тууж яваа юм байгаа биз? гэж д'Артаньян асуулаа. -Яг тэгж явна. Та бүхэн өөрсдөө бодоод үз л дээ, яаж бид эднийг тэр омголонморь, луус хоёрын оронд авах вэ дээ гэж Мушкетон хариулав.

-Үгүй байлгүй яахав, чөтгөр алгад. Уул нь Портосыг миний бор морин дээр явж байхыг нь харвал аятай байхсан, тэгвэл би өөрөө Парист ирэхдээ ямар шүү байсныг төлөөлж болохсон. Гэхдээ бид, Мушкетон чамайг саатуулахаа больё, эзнийхээ даалгасныг явж хий. Тэр чинь гэртээ бий юу.

-Гэртээ ч бий, харин айхтар ууртай байна билээ, та бүхэн ойлгож байгаа хойно доо гэж Мушкетон хариуллаа.

Мушкетон ингээд цаашаа их Августин эрэг рүү чиглэж, хоёр нөхөд очиж, чадагдсан Портосын үүдийг цохилоо. Гэвч Портос тэдний ирж явахыг харчхаад оруулахыг хүссэнгүй, наадуул хаалга цохиод цохиод дэмий аж.

Энэ зуур Мушкетон морь, луус хоёрыг туусаар шинэ гүүрээр өнгөрч, Баавгайн гудамжнаа хүрээд ирлээ. Хүрч ирээд морь луус хоёрыг прокурорын гэрийн үүдний хонхны сэжмээс уяж орхиод цаашаа юу болох бол гэж санаа зовсон юмгүй буцаж хариад, даалгасан ёсоор хийснээ Портост дуулгав.

Жаал азнасны дараа өглөөнөөс аваад өвс идээгүй хоёр адгуус үүдний хонхны сэжмийг угзчин бөөн шуугиандэгдээв. Прокурор үүнд бага бичээчээ явуулж үзүүлээд, морь луус хоёр хэний болохыг ойр хавийн айл хунараас асуулгав.

Кокнар авгай өөрийнхнөө бэлгийг таньж орхиод ийнхүү эгүүлэн өгсний учрыг олохгүй байтал, төдхөн Портос өөрөө ирж учир тодров. Залуу шадар цэрэг биеэ барих гэж оролдсоор байгаа хэдий боловч, арга буюу дүрэлзээд байгаа уур хилэн харцанд нь илт байхыг үзээд эмзэг сэтгэлт эмэгтэй найз нь зүрх алдаж байлаа. Юу гэвэл д'Артаньян, Арамис хоёртой замдаа уулзсан, мөн бор морийг д'Артаньян өврийнхөө Парист унаж ирсэн морь гэж таниад гурван алтан зоосоор өгсөн тухайгаа ярьсан сэлтийг Мушкетон эзнээсээ нуугаагүй юм.

Портос ирж прокурорын гэргийтэй Сен Маглаур сүмийн хажууд уулзахаар болзоод гарч одлоо. Манай шадар цэргийг явах гэж байгааг прокурор хараад хоол ид гэж уривал Портос ихэмсэг байртай татгалзав.

Кокнар авгай зүрх алдсаар явж Сен Маглаур сүм рүү очлоо. Тэнд очоод зэмлүүлнэ гэдгээ авгай мэдэж байвч, Портосын ихэс дээдсийн галбирт өөрөө арга буюу авгагдсан хүн юм. Эр хүний хувьд доромжлогдсон хүний амнаас гардаг хамаг хараал, зэмлэл бүхнийг прокурорын гэргийн толгой дээр Портос буулгаж гарлаа.

-Ээ бурхан минь, би юу хийж чадахаа л хийсэн юмсан. Манай нэг сүлбээтэн хүн морины худалдаа хийдэг юм. Тэр хүн манайд өртэй, түүнийгээ төлж өгөхгүй байсан юм байхгүй юу. Тэр морь луус хоёрыг би өрөндөө авсан юм. Тэр хүн чинь, Ван эзэнд боловч тэнцэх хүлэг өгнө гэж амласан билээ гэж бүсгүй өчив.

-Тэгвэл байна аа, авгайтан. тэр хүн танд таван алтан зоосноос илүү өглөгтэй л байсан юм бол зүгээр луйварчин байж таарах нээ.

Прокурорын гэргий биеэ өмөөрөх санаатай,

Үгүй Портос гуай хэн боловч хямд төсөр юм эрэхэд буруутай газар үгүй шүү дээ гэж маргав.

Энэ ч үнээн авгайтан, гэхдээ; өөрөө хямд төсрийг эрэлхийлдэг хүн, бусдыг өгөөмөр нөхөдтэй болоход саад болдоггүй байвал таарна.

Ингээд Портос эргэж явахаар завдлаа: Прокурорын гэргий дуу алдаж.

-Портос гуай, Портос гуай! Миний буруу, би буруугаа хүлээж байна. Тань шиг ийм сайхан эрийн аян дайны хэрэгсэл сэлтийг төхөөрөх хэрэгт миний гар татдаг буруу хэрэг гэв. Портос хариу юу ч дуугаралгүй бас нэг алхам холдлоо.

Гэнэт Портосыг гялалзсан сайхан үүл манан хучаад авах шиг, өдий төдий өндөр язгууртан герцог гүнтний гэргийчүүл түүнийг тойрч, дүүрэн алттай хэтэвчээ хөлд нь шидэцгээж байх шиг авгайд санагдаад явчихлаа.

-Портос гуай азнаж үз. Буян бодож түр азна бидэнд ярилцах юм байна гэж авгай дуу алдвал, Портос хариуд нь:

-Тантай ярилцаад надад гай болох юм гэлээ.

-Үгүй та юу хэрэгтэй байгаагаа над хэлээд өг л дөө

-Юу ч хэрэггүй. Яадаг гэвэл танаас юм гуйсан, гуйгаагүй хоёр адилхан юм хойно. Прокурорын гэргий Портосын гараас зуурч аваад, биеэ зэмлэх сэтгэлд автан,

-Үгүй Портос гуай, энэ талаар би ямар юмаа мэдэх вэ дээ. Морь гэж юу байдгийг би ямар мэдэх биш дээ. Эмээл хазаар гэж юу байдгийг би мэдэх биш гэж д/у алдлаа. -Уул нь энэ бүгдийг мэдэх хүн, надаар үүнийг хийлгэххэрэгтэй байсан юм, авгайтан минь. Гэтэл та гар татаж ганц нэг сохор зоос хожих санаатай байсан юм чинь.

-Энэ чинь миний алдаа Портос гуай. Энэ алдаагаа би заснаа, нээрээ шүү засна. -Яаж тэр билээ? гэж манай шадар цэрэг асуулаа.

-Миний үгийг дуул даа. Өнөө орой манай нөхөр өөрий нь. дуудаж нэг юмны тухай өөртэй нь зөвлөө гэсэн де Шону герцог гуайнд очих юм. Тэр лав тэнд хоёр цагаас наашгүй удна. Манайд хүрээд ир, бид хоёулхнаа байж байгаад юу хэрэгтэйгээ бодъё гэлээ.

-За энэ чинь сайн хэрэг, өөр яриа гэж Портос зөөлрөв.

-Та тэгвэл намайг уучилж байх шив?

-Үзэн байжбольё гэж Портос ихэмсэг дуугарлаа. Ингээд хоёулаа гараа барилцан саллаа.

-"Чөтгөр алгад энэ удаа ч Кокнар гуайн авдранд арай хийж нэг хүрэх бололтой гэж Портос явахдаа бодлоо.

XXXV. ПОРТОС Д'АРТАНЬЯН ХОЁРЫН ТЭСЧ ЯДАН ХҮЛЭЭСЭН ОРОЙ АШГҮЙ НЭГ БОЛЛОО

д'Артаньян ердийнхөөрөө есөн цагийн алдад, Миледигийнд хүрч ирлээ. Миледи зан сайтай гэж аргагүй урьд хожид ер ийм найрсгаар угтаж байсан удаагүйсэн. Өөрийн нь де Вардыг төлөөлж бичсэн зурвасыг Миледи авсандаа ийм сайхан ааштай байгааг мань гаскон залуу даруй мэдлээ.

Кэтти жимсний ус барьсаар орж ирэхэд, эзэгтэй нь түүнийг эелдгээр харж гойд сайхан инээмсэглэнэ. Гэтэл хөөрхий охин тун ч их уйтгарт автаад байсан болохоор Миледигийн сайхан аашлахыг ч ажсангүй.

д'Артаньян энэ хоёр бүсгүйг ээлжлэн хараад, байгаль эднийг төрүүлэхдээ алдаа хийж, өндөр язгууртай бүсгүйг хувирамтгай муу зан чанартай. зарц охиныг өндөр дээд хатандбайж зохимоор сайхан сэтгэлтэй болгон төрүүлжээ. Арван цагийн үед Миледийн сэтгэл зовсон янз үзэгдэж эхэлсэнд ямар учиртайг д'Артаньян мэдлээ. Бүсгүй цагаа байн байн харж, нэг босч, нэг сууж, "та их эелдэг хүн юм. гэхдээ одоо явбал бүр ч сайн байхсан" гэх байртай д'Артаньян өөд харж инээмсэглэнэ.

д'Артаньян босоод малгайгаа авсанд Миледи гараа өгч үнсүүллээ. Ингээд залуу хүний гарыг барьсан нь маяглах сэтгэлийн үүднээс биш, хэрэгтэй цагт явж өгсөнд талархсаны тэмдэг билээ. -Миледи, де Вард гүнд учиргүй дурлачихсан юм байна гэж залуу хүн дотроо шивнээд гарч одлоо.

Энэ удаа Кэтти дайралдсангүй, үүдний өрөө, гудам гарах үүдний хажууд хаана ч үзээд алгабайв. Ингээд д'Артаньян жижигхэн өрөө рүү орох шатыг өөрөө эрж ороход хүрэв.

Кэтти нүүрээ дарчихсан уйлаад сууж байв. д'Артаньяны орж ирэхийг дуулсан боловч, толгойгоо өргөсөнгүй, манай залуу очиж охины гарыг барьгал цаадах нь асгартал уйлчихлаа. д'Артаньяны бодож байсанчлан, Миледи захидлыг аваад баярласандаа бүгдийг зарц охиндоо ярьж өгөөд, энэ удаа даалгасныг сайн биелүүллээ гэж хэтэвчээ бэлэглэсэн ажээ. Кэтти өрөөндөө орж ирээд хэтэвчийг нь булан руу хаячихсан, дөрөв таван алтан зоос хивсэн дээр ил гараад уначихсан хэвтэж байгаа харагдав.

Залуу хүнийг өөртөө эелдгээр хүрсэнд охин дээшээ харав. Охины царайг хараад д'Артаньяны зүрх хүртэл шимширлээ, охин гуйж царайчлах байртай гараа сарвайгаад ганц ч үг дуугарч чадахгүй байлаа.

д'Артаньян хэдийгээр онцын зөөлөн сэтгэлтэй хүн биш боловч, охины ийнхүү үг дуугүй гуныхрахад өрөвдөөд явчихлаа. Гэхдээ д'Артаньян санаа нэгэнт шулуудаж, ялангуяа сүүлд боловсруулсан төлөвлөгөөгөө хатуу баримталж байсан болохоор санаснаасаа нэгэнт гажхааргүй болсон байжээ. Иймээс Кэттид горьдлого төрүүлэх шалтаг ер өгсөнгүй, зөвхөн өөрийнхөө энэ явдлыг зүгээрөшөө авах гэсэн хэрэг мэтээр тайлбарлалаа.

Дашрамд нь хэлэхэд Миледи янз нь хайртай хүнийхээ өмнө царай улайхаас болгоомжилсон бололтой, Кэттид гэрийнхээ бүх гэрлийг унтах өрөөнийхөө гэрлийг хүртэл унтраа гэж

тушаасан ажээ. Де Вард гуай мөн үүр гийхээс нааш харанхуйгаар гарч явах ёстой байснаар ийнхүү өшөө авах явдал хялбар болжээ.

Минутын дараа Миледиунтах өрөөндөө орж ирж байгаа дуулдаад, д'Артаньян даруй шүүгээ рүү ухасхийв. Түүнийг дөнгөж тийшээ орж амжмагц хонх дуугарлаа.

Кэтти эзэгтэйнхээ өрөөнд ороод үүдээ хаачихсан боловч завсрын хана нь тун ч нимгэн болохоор хоёр бүсгүйн ярилцсан юм бүхэн дуулдах аж.

Миледи баярлаж хөөрөөд сүйд байх бололтой, Кэттиг де Вард гуайтай уулзсан гэдэгхуурмаг яриаг эх адаггүй олон дахин яриулж, захидлыг ямар шүү янзтай авсан, уншихдаа нүүр царай нь хаашаа байсан жинхэнэ дурласан хүний байр шинжтэй байсан эсэх зэргийг шалгааж байв. Энэ бүх асуудалд тайван хариулах учиртай хөөрхий Кэтти ярихдаа дуу нь чичирч байсан боловч, охины дууны өнгө ийнхүү гунигтай байхыг эзэгтэй нь огтхон ч эсажив. Жаргалтай хүн бусдыг ямар хайхрах биш дээ.

Энэ зуур гүнгийн ирэх болзоотой цаг ойртсонд Миледи үнэхээр ч унтах өрөөнийхөө гэрлийг Кэттигээр унтраалгаад Де Вард гүнг ирмэгц өрөөндөө оруул гэж тушаалаа.

Кэтти удаан хүлээхэд хүрсэнгүй. Шүүгээний цоожин завсраар гэрийн гэрэл унтрахыг д'Артаньян хармагцаа нуугдсан газраасаа ухасхийж гарлаа. Кэтти яг энэ үеэр Миледигийн өрөө рүү орон үүдээ түгжиж байсан юм.

-Юун чимээ вэ? гэж Миледи асуув. д'Артаньян,

-Би байнаа, де Вард гүн байна гэж шивэгнэв.

-Ээ бурхан минь, энэ чинь өөрийнхөө болзсон цагийг хүртэл тэвчиж чаддаггүй байна шүү гэж Кэтти шивэгнэв.

-Тэгээд яагаа вэ? гэхдээ Миледийн хоолой чичрэн.

-Таорохгүй яагаа вэ? Де Вард, өөрий чинь би хүлээсээр байгааг мэдэж байгаа шүү дээ гэв.

Энэ үгийг сонсоод, д'Артаньян гараараа Кэттиг аяархан зайлуулаад өрөө рүү ухасхийж оров. Хайртай хүнийхээ сэтгэлд илүү таалагддаг өрсөлдөгч хүнийхээ нэрийг барьж ирчхээд тэр хүнд хайртай дуртай гэж ам алдахыг сонсох гэдгээс илүү хүнд зовлон байдаггүй билээ. д'Артаньян өөрөө ийм шаналгаатай байдалд орох юм гэж урьдаас бодоогүй билээ. Жөтөөрхөх сэтгэлд автан, энэ үеэр зэргэлдээ өрөөнд уйлж суусан хөөрхий Кэттигээс багагүй шаналж байлаа Миледи өөрийн нь гарыг чанга атгаад,

-Гүн таны уулзах бүрдээ, харц байдлаараа илчлэн байдаг хайр сэтгэлийг бодоход над сайхан байна, нээрээ шүү. Танд би өөрөө бас хайртай. Маргааш маргаашдаа танаас хайр сэтгэлтэйн тэмдэг болсон нэг юм авмаар байна. Намайг мартчихгүйн тулд май үүнийг авч үз гэж энхрийлэн өгүүлнэ.

Ингэж хэлээд хуруундаа байсан бөгжийг авч д'Артаньянд бариулав.

Энэ бөгж нь алмас чулуугаар чимэглэсэн эрдэнийн чулуун бөгж байсныг түрүүн ажсанаа д'Артаньян саналаа.

д'Артаньянд эхлээд бөгжийг нь эгүүлж өгөх сэтгэл төрсөн боловч. Миледи ер авч өгсөнгүй.

-Үгүй, үгүй наадахаа надад хайр сэтгэлтэйн тэмдэг болгон авч үз.... гэж Миледи хэлээд цаашаа үүнийг авснаар та өөрөө мэдэлгүй надад их тус болж байгаа юм гэж сэтгэл догдлон өгүүлэв.

(Энэ бүсгүйгээр дүүрэн нууц далд юм байх юм) гэж д'Артаньян дотроободов. Энэ үеэр д'Артаньян хамаг үнэнээ Миледид, хэлмээр санагдлаа. Өөрөө чухам хэн болох, ямар шүү муу санаа өвөрлөн наашаа ирснээ хэлэх гэж нэгэнт ам нээтэл Миледи энэ үеэр хэлсэн нь:

-Хөөрхий найз минь, тэр муу гаскон гайхал таныг золтой алчихсангүй шүү гэв. Муу гайхал гэдэг нь д'Артаньян өөрөө байжтаарлаа.

-Таны шарх одоо мөн шаналгаатай хэвээрээ юү? гэж Миледи асуув.

Д'Артаньян юу хэлэхээ сайн мэдэхгүй,

-Тийм, их шаналгаантаа байх юм гэв.

-Бүү санаа зов, таны өшөөг би авна хайр найргүй авна гэж Миледи шивэгнэлээ. "Үгүй бид хоёр илэн далангүй байх цаг арай болоогүй л байна" гэж д'Артаньян дотроо бодлоо.

Энэ богино ярианы дараа д'Артаньян даруй сэхээ авч чадсангүй, гэхдээ нөгөө санаж ирсэн өшөө авах сэтгэлээс мөр ч үлдсэнгүй. Энэ бүсгүй өөрий нь эрхшээлдээ гайхам оруулж чадаад бүсгүйг үзэн ядахын чацуу өмнө нь бишрэн хайрлаж байлаа. Ийм эсрэг тэсрэг хоёр сэтгэл нэгэн зүрхнээ хамтран оршиж, нэг хачин их тачаал шуналт сэтгэл болж болох юм гэж д'Артаньян үүний өмнө ербодож байгаагүйсэн билээ.

Ингэж байтал цаг цохиж, явах ёстой боллоо. Миледигийхээс гарахдаа түүнийг орхиод явах болсонд гүнээ харамсахаас өөр сэтгэлгээ д'Артаньян үлдсэнгүй, халуунаар үнсэлцэхийн завсар дараачийн долоо хоногт дахин уулзахаар болзлоо.

д'Артаньяныг өрөөгөөрөө дамжаад гарах үед хэдэн үг хэлж амжина байх гэж хөөрхий Кэтти горилж байсан боловч, Миледи өөрөө залуугхаранхуйд дагуулан үдэж шатан биеэр очиж байж сая салав.

Өглөө болгоод д'Артаньян яаран Атос дээр хүрч ирлээ. Өөрөө тун хачин явдалд орчихсон болохоор Атосоос зөвлөгөө авмаар болжээ. Болсон бүх явдлыг Атост ярьж өгвөл, ярианы дунд Атос хэд хэд дахин хөмсөг зангидлаа.

-Танай тэр Миледи, олхиогүй амьтан шиг санагдаад байна, тэгсэн ч түүнийг хуурснаар та аймшигт өстөнтэй болох алдаа хийжээ гэж Атос хэллээ.

Үүнийг ярих зуураа д'Артаньяны хуруунд байгаа бөгжийг Атос хянуур харж байлаа, хатны

бөгжийг одоо хайрцагт нандигнан хадгалаад оронд нь үүнийг зүүх болжээ.

Ийм өгөөмөр бэлэг авч, нөхдийнхөө өмнө гайхуулах боломжтой болсондоо сэтгэл хангалуун байсан д'Артаньян та энэ бөгжийг харж байна уу? гэж асуув.

Атос үүнд,

Тиймээ энэ чинь манай гэр бүлийн уламжлалт нэг зүйлийг санагдуулах юм гэв. -Сайхан бөгж шүү тийм биз? гэж Д'Артаньяныг асуухад, Атос хариуд нь:

-Яриагүй сайхан. Ийм тунгалаг чулуутай хоёр бөгж хорвоо дээр байдаг юм гэж би ер бодоогүй. Та үүнийг алмас чулуунбөгжөөрөө сольж авсан байх даа? гэлээ.

-Үгүй. Энэ чинь манай сайхан англи бүсгүйн, чухамдаа гэвэл миний сайхан франц бүсгүйн бэлэг юм. Юу гэвэл, тэр хүнээс би, өөрөөс нь асуугаагүй хэдий боловч, лав Францад төрсөн гэж бодож байна гэлээ.

-Та энэ бөгжийг Миледигээс бэлгэнд авсан юм уу? гэж Атос дуу алдсанд их л сэтгэл догдолсон байртай аж.

-Та таачихлаа. Өнөө шөнө Миледи надад үүнийг бэлэглэсэн юм.

-Наад бөгжөө надад үзүүлээч гэж Атос гуйхад д'Артаньян хуруунаасаа аваад: -Май үз гэлээ.

Атос бөгжийг авч анхааралтай үзсэнээ царай нь аягүй зэвхийрээд явчихлаа. Тэгснээ зүүн гарынхаа ядам хуруунд хийж үзвэл яг захиалсан юм шиг таарчбайв. Атосын уулаасаа амгалан царай өшрөн, хорсох байртай барайчхав.

-Үгүй энэ чинь тэр бөгж биш баймаарсан. Яагаад энэ бөгж Миледи Кларикийн гарт орж болдогсон билээ. Ийм адилхан хоёр бөгж байна гэж бодоход бас их хэцүү юм даа гэж Атос, хэлэхэд, д'Артаньян ингэж асуулаа.

-Та энэ бөгжийг таних юм уу?

-Үүнийг би таньж байх шиг санагдлаа, бодвол эндүүрээ байлгүй дээ, гээд Атос бөгжийг д'Артаньянд эргүүлж өгөхдөө нүд салгаж чадахгүй байлаа.

Минут хир болсны дараа,

-Ингэхэд байнаа д'Артаньян та наад бөгжөө авчих, үгүй, гэх нээ чулуугий нь эргүүлчих. Наадах чинь миний дотор тун айхтар юм санагдуулаад байна тэхгүй болж гэм би тантай тайван ярилцаж чадахгүй нь байна ... үгүй байзнаа ... Наад бөгжөө дахиад надад нэг харуулаач, миний ярьж байгаа тэр бөгжний чулуу нэг шалтгаар өрөөсөн талдаа сэвтэй болчихсон юм даг гэлээ.

д'Артаньян бөгжөө дахин авч Атост өгөв. Атос үзээд, бие нь агзасхийж,

-Хараа, хачин юмаа бас? гэж хэлээд бий гэж сая ярьж байсан сэвийг д'Артаньянд үзүүлээ.

-Үгүй, энэ чулуун бөгжийг хэн танд өгсөн юм бэ, Атос оо?

-Миний ээжид эгч нь өгсөн, ээж надад өгсөн юм. Манай гэр бүлийн эртний эд гэж танд би дурссан шүү дээ... Энэ тэгээд манайхаас гадагшаа ер гарахгүй байх ёстой байсан юм.

д'Артаньян жаахан түгдчиж байгаад,

-Та тэгээд...та худалдаж орхисон юм уу? гэж асуулаа. Атос хачин инээмсэглээд,

-Үгүй, би мөн өнөө шөнө янаг дурлалын цагт өөрт чинь бэлэглэсэнчлэн мөн нэг шөнө янаглаж байхдаа хүнд бэлэглэчихсэн юм гэв.

д'Артаньян бодол боллоо, Миледигийн дотор гэж нэг ёроолгүй хар хавцал шиг дүрслэгдэв. Ингээд нөгөө бөгжийг зүүсэнгүй халаасандаа хийчхэв.

Атос түүний гарыг бариад,

-д'Артаньян та миний үгийг дуулж бай. Өөрт чинь би сайн байдаг шүү дээ. Өөрт минь хүү байлаа гэхэд би өөрөөс чинь илүү хайрлаж чадахгүй байхсан. Миний үгэнд орж тэр бүсгүйгээс холд. Тэр хүнийг би мэдэхгүй хэдий гэлээ ч булай муу, хөнөөлийн муухай хортой амьтан гэж зөгнөөд болж өгөхгүй байна гэж гуйлаа.

д'Артаньян үүнд,

-Таны зөвөө. Түүнээс би холдоно. Үнэнээ хэлэхэд, тэр бүсгүйгээс чинь би өөрөө хүртэл нэг л зэвүүцээд байгаа юм шүү гэв.

Шийдэж чадах юм уу даа? гэж Атосыг асуухад д'Артаньян хариулахдаа:

-Чаднаа би даруй л түүнээс холдоно гэв.

Атос гаскон залуугийн гарыг бараг эцгийн ёсоор энхрийлэн атгаад,

-Сайнбайна хүү минь тэгвэл чинь дээр, зөв болно. Таны амьдралд дөнгөж орж амжсан тэр хүүхэн амьдралд чинь айхтар гүнзгий ул мөр бүү үлдээгээсэй гэв.

Ингээд Атос толгой дохиж ганцаараа үлдээд юм бодмоор байгаагаа д'Артаньянд мэдэгдэв.

д'Артаньяныг гэртээ хүрч ирэхэд Кэтти хүлээж байв. Бүтэн сар халуурч хэвлээ гэхэд, хөөрхий бүсгүйнойргүй шаналж өнгөрүүлсэн урьд шөнийн дараах шиг өөр болчихгүй байсансан. Эзэгтэй нь бүсгүйг хуурамч де Вард руу явуулжээ. Де Вардад ухаан жолоогүй дурласан Миледи жаргалдаа ташуурч хайртай хүн нь хэзээ дахин ирэхийг мэдэхсэн гэжээ.

Ингээд золгүй хөөрхий Кэтти д'Артаньяны хариуг догдлон хүлээж цонхийн зогсов.

Залуу хүнд Атос ихээ нөлөөтэй байсан юм. Одоо тэгээд сэхүүн санаа өшөө авах сэтгэл хоёр нь ханаж дарагдсан хойно нөхрийн зөвлөгөө, өөрийн нь бодолтой нийлээд д'Артаньян Миледигээс холдье гэж шийдэх зориг оруулав. Ингээд д'Артаньян үзэг авч ийм юм бичлээ.

"Ойрын өдрүүдэд надтай уулзана гэж авгайтан бүү бодоорой. Эдгэрсэн цагаас хойш надад иймэрхүү ажил гэж зөндөө эмхэлж цэгцлэлгүй горьгүй байна. Таны ээлж ирэхэд би дуулгая. Гарыг таньүнсэн ёсолсон Де Вард гүн гэжээ.

-Бөгжний тухай ганц ч үг дурссангүй. Манай гаскон залуу үүнийг Миледигийн эсрэг баримт болгон хадгалах гэсэн юм болов уу? Аль илэн далангүй ярихад, бөгжийг аян дайны хэрэгсэл сэлтээ олох эцсийн арга болгох гэж үлдээсэн юм болов уу?

Гэхдээ нэг үеийн хүмүүсийн хэрэг явдлыг өөр үеийнүзэл санааны үүднээс авч дүгнэх гэдэг буруу билээ. Өнөө цагийн шударга журамтай хүн бүр бузар булайд тооцох явдлыг тэр цагт зүй ёсонд нийцэх ердийн нэг явдалд үзэж байсан байх юм. Ингээд сурвалжит гэр бүлээс гаралтай залуус голдуу янаг бүсгүйчүүдийн хөрөнгөөр амьдарч байх удаа олон байдагсан.

д'Артаньян захидлыг Кэттид наалгүй өгсөнд охинэхэлж уншаад ойлгосонгүй, гэвч дахин хоёр дахь удаагаа уншиж үзээд хагартлаа баярлав. .

Охиныг ийм сайхан ааштай байхаар нь захианд байсан зүйлийг д'Артаньян амаараа давтан хэлэв. Ингээд, түргэн зантай Миледид ийм захиа гардуулах гэдэг аюултай хэдий гэлээ ч Кэтти, Вангийн талбай руу хар хурдаараа гүйж хүрэв.

Хэдий сайн бүсгүйн зүрх боловч, өрсөлдөгч бүсгүйн зовлонг үл өрөвдөх билээ.

Захидлыг Кэтти яаран авч ирсэн шиг Миледи мөн даруй задаллаа. Гэвч эхний мөрийг уншмагцаа Миледийн царай муухай зэвхийрснээ зурвасыг хумхиж хаяад Кэтти рүү эргэж харахад нүд нь гялалзана.

Энэ чинь юун захиа вэ? гэж Миледи асуухад, Кэтти чичрэн байж:

-Энэ чинь хариу шүү дээ авхайтангэлээ.

-Үгүй, биш байх ёстой. Биш байх ёстой, тайж хүн бүсгүй хүнд ийм захидал бичиж болшгүй! гэж Миледи дуу алдана.

Тэгснээ гэнэт хамаг бие нь зарсхийгээд явчихлаа.

-Ээ бурхан минь, үгүй тэр арай мэдчихсэн юм биш байгаа гэж шивэгнээд дуугүй болчихлоо...

Миледи шүдээ хавирч царай нь үнсэн хөх боллоо.

Цонх руу очиж цэвэр агаар амьсгалах гэсэн хөл нь нугараад гараа сарвайхаас цааш болж чадсангүй, зөөлөн сандал дээр ойчиж орхилоо.

Милетийг ухаан алдчихсан юм байх гэж Кэтти бодоод хувцсыг нь тайлж сулруулах санаатай

гүйж очтол, Миледи даруй өндийгөөд ирлээ.

-Та яах гэж байна? Яаж та миний биед хүрч зүрхлэв гэж тэр хэллээ.

-Авхайтан таныг би ухаан алдчихсан юм байх гэж санаад туслах гэсэн юмсан гэж Миледигийн ширүүн царайг харж сүнс зайлтлаа айсан зарц охин өчлөө.

Ухаан алдах аа! Би юу! Би юү дээ? Намайг арай нэг тэсвэр муутай амьтан гэж бодоогүй биз та? Намайг хүн доромжлохоор би ухаан алддаггүй, өшөөгөө авдаг юм, дуулав уу? Ингэж хэлээд Кэттиг гар гэж дохиогоор тушаав.

XXXVI. ӨШӨӨ АВАХЫН ХҮСЛЭН

Д'Артаньяныг ирмэгц өөр рүүгээ оруулаарай гэж орой нь Миледи тушаалаа, Гэвч д'Артаньян ирсэнгүй.

Өглөө нь Кэтти, бас залуугийнд хүрч ирээд өчигдөр болсон бүх явдлыг ярилаа. д'Артаньяи өшөө авахдаа Миледиг жөтөөрхүүлж хилэгнүүлэх гэсэн болохоор инээмсэглэж сууна. Оройд Миледи түрүүчийнхээсээ улам ч зан муутай болж гаскон залуугийн тухайд өчигдрийнхөө хэлснийг дахин тушаасан боловч, энэ орой мөн л дэмий хүлээсээр өнгөрөөв.

Маргааш өдөр нь д'Артаньяныд Кэтти хүрч ирэхдээ урьд хоёр өдрийнх шигээ цовоо сэргэлэн биш гүнээ гутран гуньсан байртай аж. Хөөрхий бүсгүйгээс яасныг асуувал үг өчихийн оронд өврөөсөө захидал гаргаад д'Артаньянд өгөв.

Миледигийн бичиг мөн, гэхдээ энэ удаа де Вард гүнд гээгүй, д'Артаньянд өөрт нь гэж хаягласан байна.

Зурвасыг задлаад уншвал:

" Эелдэг зантайд'Артаньян гуай, нөхдөө мартагч гэдэг ч ялангуяа мөд урт удаан хугацаагаар холдох гэж байхад муу цэрэг шүү. Винтер гуай бид хоёр таныг өчигдөр уржигдар хоёр дэмий хүлээж өнгөрүүлсэн. Өнөөдөр мөн тэгэх юм гэж үү.

Таныг талархагч Кларик авхай гэжээ.

-Цөм л ойлгомжтой байна, ийм захидал ирэхийг би хүлээж байсан билээ. Де Вард гүнд нүүрээ бараад ирэхийн хамт миний найдлага сэргэж байгаа хэрэг гэж д'Артаньян хэлэв.

-Та тэгээд очих юм уу? гэж Кэтти асуулаа.

Манай гаскон залуу, Атост өгсөн амаа няцах гэж байгаа өөрийгөө зөвтгөхийг хичээж.

-Дуулж бай, хонгор минь, өдий илэрхий урьж байхад очихгүй гэдэг зохисгүй юм болно. Намайг эс очвол, яагаад очихоо больчихсон учрыг Миледи мэдэхгүй, тэхээрээ зарим юмны тухай гадарлаж магад, мэдчихвэл тиймэрхүү хүүхэн өшөөгөө яаж авахыг хэн мэдэх билээ гэв.

-Ээ бурхан минь гэж Кэтти санаа алдав.

-Юм болгоныг та өөрийгөө зөвтгөхөөр тайлбарлаж чадах юм. Та лав авхайг дахиад эргүүлж гарах байх энэ удаа тэгээд өөрийнхөөбиеэр авхайд таалагдчихвал түрүүчийнхээсээ бүр ч дор юм болно доо гэв.

Цаашид болох явдлын тоймыг хөөрхий бүсгүй зөнгөөрөө гадарлажээ.

д'Артаньян түүнийг чадах хирээрээ аргадаж Миледигийн увьдаст автахгүй гэж ам өгөв.

д'Артаньян өөртөө найр тавьсанд туйлаас талархаж байна, өөрийгөө авхайн мэдэлд бүрэн

өгч байна гэж Кларик авхайд дамжуулахыг Кэттид даалгалаа. Гэхдээ, Миледигийн хурц нүдэнд танигдахгүй болтол бичгээ хувиргаж чадахгүй байх гэж санаад, юм бичиж өгөхийг төвдсөнгүй.

Яг есөн цагт д'Артаньян Вангийн талбай дээр хүрч ирлээ. Үүдний өрөөнд байсан зарц нарт урьдаас хэлсэн бололтой, юу гэвэл түүнийг ормогц Миледи хүн хүлээж авч байгаа эсэхийг манай шадар цэрэг асууж амжаагүй байхад зарц нарын нэг нь авхайд дуулгахаар даруй дээшээ гүйв.

Ор гэж гуй гэж Миледи огцом боловч, д'Артаньянд үүдний өрөөнөөс дуултал чанга хэлэв. Зарц, Д'Артаньяныг дагуулан зочдын өрөөнд орууллаа.

-Хэн ч ирлээ гэсэн намайг гэртээ үгүй гэж хэлээрэй, дуулав уу? Хэнд ч гэсэн тэр шүү гэж Миледи хэлэв.

Зарц гарч одлоо.

д'Артаньян ингээд Миледиг шохоорхон ажиглавал царай нь цонхийж, уйлсан юм уу, нойргүй хоносноос юм уу, нүд нь ядрангуй байртай болжээ. Өрөөнд ердийнхөөсөө бүдэг гэрэлтэй зориуд бүрэнхийдүү болгосон гэлээ ч залуу эмэгтэй сүүлийн хоёр хоногт сэтгэл хөдлөн шаналсныхаа мөрийг нууж чадсангүй.

д'Артаньян ердийнхөө элэгсэг байдлаар Миледид ойртож очлоо. Авхай тун ч хүчлэн байж инээмсэглэсэн нь түүний сэтгэл догдлон хувирсан царайтай зохиж өгөхгүй байв.

Авхайн бие ямар байгааг д'Артаньян асуусанд:

-Муу байна ихмуу гэв. д'Артаньян үүнд.

-Тэгвэл танд би тээр удаж байгаа юм байна. Та лав амрах хэрэгтэй, би одоохон явъя гэв.

-Тэр ч үгүй шүү, д'Артаньян гуай та үлдэж үз, эелдэг найрсаг тантай цуг байвал л би жаал саатах байх гэж Миледи хэллээ.

Үгүй ерөө, энэ хүүхэн надтай иймээлдэг байж үзээгүй шүү, сэрэмжтэй байя" гэж д'Артаньян дотроо бодов.

Миледи чадах хирээрээ нөхөрсөг байртай болж яриа хөөрөөг зугаатай наргиантай болгох гэж их оролдов. Түрхэн зуур намжсан сэтгэл нь дахин хөдөлж, нүд гялалзан, царай зүс ул бутарч уруул нь улайгаад ирлээ. Одоо д'Артаньянд Миледи ахиад л сэтгэл зүрхийг нь аль хэдийн татаж авсан гуа сайхны дагина шиг санагдана. Унтарсан мэт д'Артаньянд санагдаж явсан боловч түр дарагдаж байсан сэтгэл нь одоо дахин дүрэлзэх болов.

Миледи инээмсэглэхийн сууж энэ инээмсэглэлийн төлөө д'Артаньян амь насаа өгөхөд бэлэн шиг санагдаж байв.

Гэмших маягийн бодол ч билээ нэг төрж ирлээ.

Энэ зуур Миледи улам яриа хөгжөөнтэй болж байлаа. д'Артаньянд хайртай хүүхэн бий эсэхийг асуулаа.

д'Артаньян үүнд чадах хирээрээ эелдэг дуугаран, Хаанаас даа. та ийм юм надаас асуухаар хатуу сэтгэлтэй хүн юм гэж үү? Таныг харсан цагаасаа хойш би ганц таныг л бодож таны л хүслэн болж явдаг шүү дээ гэлээ.

Миледи нэг хачин инээмсэглээд:

-Та тэгээд надад дуртай юм бий гэж асуув.

Үүнийг гаргаж хэлэх хэрэг байна гэж үү? танд илхэн харагдахгүй байна гэж үү? -Харсан ажсан ч байж болох юм л даа. Гэхдээ хүний сэтгэл хэдий бардам байх тусам түүнийг татаж авахад хүнд байдгийг өөрөө бас мэднэ шүү дээ.

-Үгүй, хүнд бэрхээс би айхгүй байна, ганцхан болшгүй бүтэшгүй гэдгээс л айж байна гэж д'Артаньян хэлэв.

Үүнд Миледи маргаж:

Үнэн дурлалд болшгүй юм гэж ер үгүй билээ гэв.

-Ер үгүй юу, авхайтан?

Ер үгүй гэж Миледи давтан өгүүллээ.

" Чөтгөр алгад, ярианы өнгө шал өөр болчихсон байна шүү үгүй, юмыг яаж мэдэх вэ, энэ маягийн ааштай бүсгүй надад арай дурлачихсан, тэгээд нөгөө намайг де Вардад гэж санаад өгсөн шигээ өөр нэг бөгж надад өөрт минь бэлэглэх гэж байгаа юм биш байгаа? гэж д'Артаньян бодлоо.

д'Артаньян даруй сандлаа хөдөлгөн Миледид дөхөж суулаа.

Ингэхэд, та над яриад байгаа сэтгэлээ илчлэн харуулахын тул юу хийж чадах вэ? гэж авгай асуув.

-Таны юу шаардсан бүхнийг хийнэ. Та тушааж үз, би бэлэн байна.

-Юу ч гэсэн тэр үү?

-Юу ч гэсэн тэр гэж д'Артаньян дуу алдахдаа ийм ам өгснөөр хожимдоо нэг их юм болохгүйг мэдэж байв.

Миледи мөн сандлаа ойртуулаад,

-За тэгвэл хоёулаа ярилцъя гэж хэллээ.

-Авхайтан таны үгийг би сонсож байна. Миледи хором зуур дуугүй, юм бодож, эргэлзэж байх аятай байснаа шийдэв бололтой.

-Над нэг өстөн бий гэж Миледи хэллээ.

-Танд уу даа, авхайтан? гэж д'Артаньян гайхсан хүн болж дуу алдлаа. Бурхан минь. Тийм юм ер байж болох уу? Та өдий сайн сайхан хүн, тэгээд! гэв.

-Ясны өстөн хүн бий.

-Нээрээ юү?

-Тэр өстөн намайг даанч айхтар доромжилсон болохоор одоо үхэх сэхэхээ үзэлцэнэ, таныг би тус түшиг болоххун гэж найдаж болох уу?

-Энэ өширхөг хүүхэнд юу хэрэгтэй болсныг д'Артаньян даруй ойлгоод: -Болноо авхайтан, миний амь, бие илд хоёр хайр сэтгэлийн минь хамт таны мэдэлд, очсон шүү дээ гэв..

-За тийм бол та хайртай сэтгэлтэй шигээ эр зоригтой болж гэм гээд Миледи үгээ дуусгасангүй.

-Тэгвэл юугэж? гэж д'Артаньян асуулаа. Миледи минут хир дуугүй байснаа, -Тэгвэл өнөөдрөөс эхлээд бүтэшгүй, болшгүй зүйлээс айхаа больж болох юмаа гэв. д'Артаньян,

-Үгүй, би тэсгэлгүй их жаргах нь! гээд Миледигийн өмнө сөхрөн унаад гарыг нь дахин дахин үнсэхэд, Миледи гараа булааж авсангүй.

" Тэр новшийн де Вардаас миний өшөөг аваад орхи. Тэгсний эцэст биеэ тоосон тэнэг миний өшөө авалтын сохор зэвсэг болох чамаас би ангижирч чаднаа гайгүй" гэж Миледи шүд зуун бодно.

"Хуурмаг зантай, аюулт бүсгүй чи миний өвөрт өөрөө ороод ир. Тэгсэн хойно чинь миний гараар алуулах гэж санасан тэр хүнтэй чинь хамт би чамайг дамшиглаж инээмз" гэж д'Артаньян бодно. д'Артаньян дээшээ хараад; би бэлэн байна гэв.

-Ингэхлээр, хонгор д'Артаньян та миний үгийг ойлгов шив? гэж Миледи хэллээ. -Таны санааг би ганцхан харцаар чинь л ойлгосон билээ.

-Тэгвэл та, нэгэнт өдий их алдар олж амжсан илдээ миний төлөө сугалахаас буцахгүй юм шив?

-Хэзээ ч гэсэн тэр.

-Үгүй, тэгээд ийм тусыг чинь би юугаар хариулах билээ? Дурласан улс гэдгийг би мэднэ, тэд чинь ер юу ч зүгээр хийдэггүй улс юм гэж Миледи хэлэв.

-Та миний ямар шан горилж байгааг мэднэ. Та бид хоёрын хир зэрэгт таарах ганцхан шан л

бий хойно гэж д'Артаньян хариуллаа.

Ингээд манай хүн авгайг татаж тэвэрлээ.

Авхай бараг эсэргүүцсэнгүй.

Энэ бүсгүй өөрт нь төрүүлж чаддаг янаг тачаалд автсан д'Артаньян дуу алдан.

-Үгүй миний жаргал санаанд багтамгүй их санагдах юм. Энэ минь зүүд шиг сарниад явчих бол уу гэж үргэлж айгаад болж өгөхгүй тэгсэн дээрээс би үүнийгээ бодитой үзэхсэн гэж яарч байна гэв..

-Үгүй, тэгвэл, тэр сайхан санаагаад байгаа жаргалаа эдлэхүйц үйлээ бүтээл дээ. -Би таны юу хий гэснийг хийнээ гэж д'Артаньян хэлэв.

-Энэ чинь үнэн үү? гэж Миледи тээнэгэлзэхээ больж өгүүлэв.

-Энэ гуа сайхан нүднээс нулимс гаргаж зүрхэлсэн муу новшийн нэрийг надад хэлээд орхи.

-Намайг уйллаа гэж хэн танд хэлэв?

-Надад тэгж санагдсан.

Над шиг эмэгтэйчүүл уйлдаггүй юм шүү гэж Миледи хэлэв.

Тэх тусмаа сайн. За тэгээд. түүний нэрийг нададдуулгаад орхи.

-Та бодоод үзээрэй, түүний нэр гэдэг чинь миний хамаг нууц шүү лээ.

-Гэсэн ч түүний нэрийг би мэдэж авах хэрэгтэй шүү дээ.

-Тиймээ, мэдэх хэрэгтэй өөрт чинь аль хир их итгэж байгааг одоо харж байгаа биз дээ.

Над их сайхан байна, түүний нэр нь?

-Та өөрөө тэрхүнийг танина.

-Танина гэнээ?

-Тиймээ, танина.

д/ Артаньян өөрийгөө юу ч мэдэхгүй байгаад, Миледиг итгүүлэх санаатай түдгэлзэсхийсэн хүн болж.

Бодвол, миний нөхдийн нэг арай биш байгаа? гэв. Таны нөхдийн нэг байх юм бол эргэлзэх нээ, тэгвэл гэж Миледи дуу алдаад харц нь аймаар хурц болчхов.

Бахдах сэтгэлд автсан байдлаар д'Артаньян дуу алдаж,

Үгүй төрсөн ах чинь байсан ч ялгаагүй түдгэлзэхгүйсэн гэв.

Манай гаскон залуу учрыг лав мэдэж байсан болохоор болчимгүйдсэн явдал огт үгүй. -Таны сэтгэл ийм үнэнчийг үзэхэд, таатай байна гэж Миледи хэллээ.

д'Артаньян үүнд,

-Еэ чааваас танд таалагдаж байгаа юм минь, ердөө л энэ юм биз дээ гэж асуув. Миледи залуугийн гарыг бариад,

Үгүй би өөрт чинь танд хайртай сайн юм шүү гэлээ.

Ингээд түүний гарыг Миледи чанга атгасанд, бүсгүйн сэтгэл дотрыг шаналгаж байдаг шунал өөрт нь халдаад орхих мэт залуугийн хамаг бие нь арзасхийв.

-Та надад хайртай сайн гэнээ? Еэ бурхан минь, би ч бүр галзуурах нь! гэж д'Артаньян дуу алдаад Миледиг тэвэрч авлаа. Бүсгүй өөрөө үнсүүлэхээс дургүйцэж буруулах ч үгүй үнсэж байхад нь хариу үнсэх ч үгүй аж.

Миледигийн уруул хүйтэн, чулуунхөшөө үнсэх мэт д'Артаньян санагдлаа.

Гэлээ гэхдээ л манай залуу халуун хайр сэтгэлд авган магнай тэнийж, Миледийн янаг хайр, де Вард гүнгийн гэм буруутайд бараг итгэх болж ирлээ. де Вард одоо энд гар доор байсансан бол д'Артаньян алчхаж ч мэдэхээр байлаа.

Миледи энэ мөчийг ашиглан ам нээж:

-Түүний нэр нь... гэтэл, д'Артаньян тосч аваад:

-Де Вард гэдгийг би мэдэж байна гэж дуу алдчихав. Миледи түүний гараас шүүрч аваад, дотоод хамаг бодлыг нь нэвт шувт харах гэсэн байртай эгцлэн ширтээд,

-Та энэ тухай яаж мэдээв? гэлээ.

д'Артаньян сэтгэл хөдөлсөндөө болж үг алдсанаа сая ухаарав.

-Ярь, ярь! яриач гэж! Та энэ тухай яаж мэдэв? гэж Миледи давтан асууна. Би яаж мэдээв гэж үү? гэж д'Артаньян лавлан асуулаа.

-Тиймээ яаж мэдээв?

-Өчигдөр де Вард бид хоёр нэг айлд дайралдсан юм, тэгээд таныг бэлэглэсэн гэж надад нэг бөгж үзүүлсэн юмаа.

-Хүний шаар! гэж Миледи дуу алдав.

Энэ үг д'Артаньянд тун ч аягүй дуулдсан нь аргагүй билээ.

-За тэгээд гэж Миледиг асуух байртай дуугарахад/ д'Артаньян хариуд нь:

-За тэгээд, таны өшөөг тэр муу шаараас би аваад өгье гэж айхгар сүрхий шийдмэг хэллээ.

-Гялайлаа, эр зоригт найз минь, хэдийд миний өшөөг авч өгөх юм бэ? гэлээ. -Маргааш, одоо даруй хэзээ дуртай цагт чинь. Миледи золтой л "одоо даруй" гээд дуу алдчихсангүй, гэвч ингэж яарна гэдэг, д'Артаньяны хувьд онц эелдэг биш юм болно гэж бодов.

-Тэгээд ч бас өдий төдий юм урьдаас захиж, гэрч хүмүүсийн дэргэд, хүнтэй учирч тайлбар ярилцахаас хэрхэн зайлсхийх өдий төдий юм захиж ёстой байлаа. д'Артаньян ганцхан юм хэлээд Миледийн хамаг эргэлзээг таслав.

-Маргааш таны өшөөг авна, үгүй болж гэм би үхнээ гэв.

Миледи үүнд.

-Үгүй та миний өшөөг авна, өөрөө үхэхгүй, тэр чинь хулчгар амьтан гэж хариуллаа.

-Бүсгүйчүүлтэй тийм байж магадгүй, бүстэйчүүлтэй ч тиймгүй дэг үүнийг хэн хэнээс илүү би мэдэлгүй яахав гэж д'Артаньян хэлэв.

Гэхдээ би андуураагүйсэн бол та хоёрын тулалдах үед хувь зохиолд та гомдохооргүй байсан байхаа.

-Хувь зохиол гэгч хуурамч. өнөөдөр надад өлзийтэй байснаа, маргааш хувираад буруудчихаж болдог юм.

-Өөр үгээр хэлэхэд, та одоо эргэлзэж эхлэх шив.

-Үгүй, бурхан өршөө, би эргэлзэж түдгэлзсэн юмгүй гэхдээ надад горьдол төрүүлэхээс өөр юу ч үгүйгээр, амь сөрсөн ажилд явуулах гэдэг шударга хэрэг үү дээ? гэхэд, Миледи "хэрэв хамаг учир үүнд л байгаа юм бэлж гэм, өөрөө л шийдмэгхэн байж үз" гэсэн байртай харцаар хариулаад

-Цаашаа энд харцаа тайлбарлаж,

-Таны зөвөө гэж эелдгээр дуугарлаа.

-Та чухам дагина мөөн! гэж д'Артаньян дуу алдана.

-За ингээд бид юм бүхний тухай ярилцаж тохирох шив гэж Миледи асуулаа. -Тиймээ, өөрөөс чинь миний гуйж байгаа юмнаас бусдыг ярьж тохирлоо. -Миний танд хайртай гэдэгт бат итгэж болно гэж би өөрөө хэлж байхад уу? -Надад маргааш гэж байхгүй, би яаж хүлээх билээ.

-Чимээгүй, манай ахын хөлийн чимээ гарч байна. Тэр таны энд байхыг үзэж болохгүй, гээд Миледи хонхны сэжимнээс татсанд, Кэтти орж ирэв.

Миледи нэг жижигхэн нууц хаалга нээгээд, энэ үүдээр гар, тэгээд орой арван нэгэн цагт хүрч ирээрэй, бид энэ яриагаа дуусгая. Кэтти өөрий чинь нааш нь дагуулж авчирна гэв. Энэ үгийг дуулаад хөөрхий зарц бүсгүй золтой л ухаан алдчихсангүй.

-За авхайтан та юунд модон хөшөө шиг зогсчхов оо? Минийхэлснийг дуулав уу? Өнөөдөр, арван нэгэн цагт та д'Артаньян гуайг миний өрөөнд оруулаарай.

"Янз нь дандаа арван нэгэн цагт болзоо хийдэг бололтой. Ийм заншилтай болчихсон хүн юм байна" гэж д'Артаньян бодов.

Миледи гараа сунгаж өгсөнд д'Артаньян энхрийлэн үнсэв.

" Үгүй ингэхэд, маллагдаад өнгөрчих бий дээ Энэ хүүхэн лав, ямар ч муухай хэрэг хийхээс буцахгүй хүн юм, болгоомжтой байя" гэж Кэттигийн зэмлэлд хариулсан төдий болсоор гарч явахдаа д'Артаньян бодлоо.

XXXVII. МИЛЕДИЙН НУУЦ

Кэтти хэдий гуйж шалсан боловч, д'Артаньян тэднийхээс гараад дээшээ бүсгүйн өрөө рүү орсонгүй, үүнд зэмлэл, гуйлт хүсэлт дуулахаас зайлсхийх, бас өөрийнхнөө сэтгэлийг жаал цэгнэж үзэх болбол бас Миледийн бодол санааг чадах хирээрээ эргэцүүлж үзэх гэсэн хоёр шалтгаанаас тэгсэн билээ.

Энэ байдлаас, мэдэгдэж байгаа ганц зүйл гэвэл Миледид д'Артаньян ухаан жолоогүй сайн болчихсон байхад Миледи өөрт нь огтхон ч сэтгэлгүй аж. Хамгийн зөв арга гэвэл гэртээ буцаж хариад өөрөө өнөө хүртэл де Вардын нэр барьж байсан гэдгийг илчилсэн урт захидал Миледид бичээд, де Вардыг ална гэдэг өөрийгөө ална гэсэнтэй адил болохыг тайлбарласан нь дээр гэж д'Артаньянд бодогдоод өнгөрлөө. Гэтэл өөрөө мөн өшөө авах шуналд хүчтэй автчихсан, тэр бүсгүйтэй өөрийнхнөө жинхэнэ нэрээр бас нэг учирмаар санагдаад байв. Ингэж өшөө авна гэдэг түүний сэтгэлд зарим талаар таатай байсан болохоор үүнийгээ орхичхож тэвчихгүй байв.

Миледийн өрөөний салхивчаар гарч байгаа гэрлийг харах гэж тав арав алхаад л нэг эргэж харсаар Вангийн талбайг тав зургаа дахин тойрлоо. Өнөөдөр Миледи унтах өрөө рүүгээ түрүүчийнх шиг яарахгүй байгаа нь илт байв.

Гэрэл ашгүй нэг унтарлаа.

Гэрэл унтрахын хамт д'Артаньян эргэлзэж тээнэгэлзэхээ бүрмөсөн больж анхны шөнийн байдал тодорхой санагдан зүрх догдолж, нүүр халуу оргисоор тэднийд ороод Кэттигийн өрөө рүү яарав.

Кэттигийн царай үхсэн хүнийх шиг зэвхийрчихсэн, хамаг бие нь чичирсээр амраг хүнээ барьж саатуулахыг оролдов. Гэвч, чих тавин чагнаж байсан Миледи д'Артаньяны орж ирэхийг дуулаад үүдээ онгойлгож:

-Ор, ор гэв.

Эд бүгдийг тун ч нэг ичгүүр сонжуургүй, хүний санаанд багтамгүй улаан цайм байртай хийсэн тул д'Артаньян үзэж сонссон юмандаа итгэж ядаж байлаа. Зөвхөн зүүдэнд ордог хачин явдалд оролцож байгаа мэт санагдана.

Хэдий тийм гэлээ ч мань залуу соронзонд татагдах төмөр мэт Миледид татагдан өөдөөс нь ухасхийв.

Тэдний араас үүд хаагдлаа.

Кэтти тэр үүд рүү бас ухасхийнэ.

Жөтөөрхөл, уур хилэн, доромжлогдож элэг баригдсан зэрэг бүсгүйн зүрхийг шаналгах сэтгэлэг бүхэн нийлж үнэн учрыг илчилмээр санагдана. Гэтэл ийм хатгалга явдалд оролцсон үнэнээ хүлээнэ гэдэг өөрийгөө илчилнэ гэсэнүг. Үүнээс гадна д'Артаньяныг бас үүрд

алдахад хүрэх билээ.

Хайр сэтгэлтэйн улмаас төрсөн сүүлчийн энэ бодол бүсгүйг зөөлрүүлж, сүүлчийн энэ гашуун зовлонг дааж өнгөрөөхөөр болгов.

д'Артаньяны хувьд гэвэл санасныхаа туйлд хүрлээ. Миледи одоо нэрий нь барьсан өрсөлдөгч хүнийг биш, чухам өөрий нь хайрлаж, үгүй гэхдээ хайрласан дүр үзүүлж байлаа. Үнэндээ өөрөө зөвхөн өшөө авах зэвсэг болж байна, өөрийн нь гараар хүн алуулах л гэж энхрийлсэн болж байна. гэдэг санаа төрөх боловч биеэ өргөмжлөх бардам сэтгэл болон ухаан жолоогүй татагдаж шунасандаа энэ дутуу дулимаг санагдах бодлыг дарж байв.

Түүнээс гадна, манай гаскон залуу биедээ итгэх сэтгэлээр дутагдахгүй хүн болохоор өөрийгөө дотроо де Вардтай зүйрлүүлж үзээд чухамдаа өөрт нь үнэхээр дурлаж үл болох шалтаг юунд байх билээ гэж өөрөөсөө асууна.

Ингээд д'Артаньян тэр хурамхан цагийн жаргалд бүрэн автлаа. Миледи одоо хар муухай санаа агуулснаараа өөрий нь түрүүн хиртхийлгэж байсан нөгөө хүүхэн биш, өөрөө хайр сэтгэлд бүрэн автсан халуун янаг бүсгүй мэт байв. Иймэрхүү янзтай хоёр цаг өнгөрөв. Хайр дуртай хоёрын хөөрч оргилсон сэтгэл жаал дарагдаж ирлээ. д'Артаньяны адил мартагнах шалтаггүй байсан Миледид хуучин бодол нь түрүүлж төрөөд, де Вард гүнтэй маргааш өглөө тулалдах ямар нэг шалтаг олсон эсэхийг залуугаас асуув.

Гэтэл д'Артаньяны толгой эргэж гүйцээд, сэтгэл санаа нь эрс өөр болчихсон болохоор, илдээр тулалдах тухай ярилцана гэхэд цаг дэндүү орой болсон байна гэж тоглоом хийв. Өөрийн нь гол зорилт болсон энэ ганц чухаг зүйлд ийнхүү хайхрамжгүй байхыг үзээд Миледи сэтгэл зовж, улам улам тулган шалгаах болов.

Тэхлээр нь, тэр хийж болшгүй тулалдааны тухай ер үнэнээсээ бодож яваагүй д'Артаньян яриаг өөр юм руу оруулах санаатай оролдоод үзвэл хүч хүрсэнгүй. Хурц ухаан, зоримог зантай Миледи түүнийг өөрийнхөө санаснаас өөр юм руу халтируулан оруулахгүй барих аж..

Де Вардыг уучилж, харгис хатуу бодлоо орхиж үз гэж Миледид зөвлөхөөс өөр мэргэн юм Артаньяны санаанд орсонгүй.

Гэвч иймэрхүү үг дөнгөж цухуймагц залуу бүсгүйн бие агзасхийгээд цаашаа холдов. -Эелдэг эрхэм д'Артаньян гуай та арай айчхаагүй биз? гэж Миледи цангинасан дуугаар дооглонгуй байртай асуухад, дуу нь харанхуйд хачин дуулдана.

-Та яаж тэгж бодов оо!

-Үгүй хөөрхий тэр гүн, таны бодож байгаа шиг тийм их буруутай биш байвал яах вэ? гэж д'Артаньян хариуллаа.

-Яалаа ч гэсэн тэр де Вард намайг мэхэлсэн, тэхлээр үхэх ёстой гэж Миледи эрс дуугарав.

Та нэгэнт ял ноогдуулчихсан юм бол тэр гүн үхэг гэж д'Артаньян төвхөн дуугарсан нь

хязгааргүй үнэнч сайныг илчилсэн мэт Миледид санагдлаа.

Тэхлээр, Миледи гаскон залуу руу ойртож хэвглээ.

Миледид шөнө урт байсан эсэхийг бид хэлж чадахгүй юм, д'Артаньянд л лав бүсгүйтэй цугхоёр цаг ч өнгөрүүлээгүй мэт санагдаж байхад салхивчин завсраар үүрийн гэгээ тусч, удалгүй унтах өрөөнд бүүдгэр гэрэлтэй болчхов.

Ингээд д'Артаньян босч явахаар завдаж байгааг үзээд, де Вардаас өшөө авч өгөхөөр амласныг нь Миледи дахин сануулав.

-Би бэлэн байнаа, харин түүнээс өмнө нэг юм үнэмшмээр байх юм гэж д'Артаньян хэлэхэд Миледи асуусан нь:

-Үгүй юунд тэр вэ?

-Таны надад үнэхээр хайртай сайнд.

-Үүнийгээ танд би баталж үнэмшүүлсэн шиг санагдах юм.

-Тиймээ, тэхлээр миний ч гэсэн бас сэтгэл цөм танд зориулагдана.

-Гялайлаа эр зоригт янаг минь! Харин та ч гэсэн хайр сэтгэлтэйгээ, миний үнэмшүүлсний шиг харуулна биз дээ? д'Артаньян үүнд.

-Тэгэлгүй яахав. Гэхдээ та над хэлж байгаа шигээ хайртай юм бол миний төлөө жаахан ч бол айхгүй байна гэж үү! гэв.

-Юунаас айх юм билээ?

Юу, юунаас гэж? Би хүнд шархдах юм уу, алагдаж мэднэ шүү дээ.

-Тийм юм байж болохгүй. Та өдий их эр зоригтой илдэд өчнөөн гарамгай хүн, хаанаас даа гэж Миледи хэллээ.

-Үгүй ингэхэд өшөө адилхан адилхан аваад, тулалдахын хэрэггүй болгох өөр нэг аятай арга олсон нь дээр биш гэж үү?

Миледи нууцгай ханилсан хүн рүүгээ дуугүй харна, үүрийн бүүдгэр гэрэлд бүсгүйн тунгалаг нүдний харц, хачин ёозгүй харагдах аж.

-Үнэндээ, та жаахан айгаад байх шиг санагдах юм, гэж Миледи хэлэв. -Үгүй, би түдгэлзээд байгаа юм алга.

Гэхдээ , хөөрхий гүнд та сэтгэлгүй болчихсоноос хойш үнэндээ түүнийг өрөвдөөд байх юм. Эр хүн таны хайр сэтгэлийг алдсанаар тун ч хүнд цээрлэл үзэж байгаа хэргээ, тэхлээр үүнээс өөрөөр дахин залхаах хэрэг ер үгүй байхаа.

-Түүнд намайг хайртай сайн байсан юм гэж хэн танд хэлээв гэж Миледи асуув.

-Юу ч гэсэн, таныг одоо өөр хүнд сайн байна гээд бодож орхивол, би дэндүү биеэ өргөмжилсөн хэрэг болохгүй болов уу гэж д'Артаньян эелдэг зөөлөн дуугараад, дахиад л хэлэхэд гүнг би өрөвдөж байна гэв.

-Та юу?

-Тиймээ, би.

-Үгүй, яагаад та түүнийг өрөвдөж байгаа юм бэ?

-Яагаад гэвэл... юуг ганц би ганцаараа...

-Юу гэж?

-Гүн таны бодож байгаачлан өөрийн чинь өмнө тийм их буруутай биш, чухамдаа гэвэл буруугүйг мэдэж байна.

Миледи сандарч, түгшсэн дуугаар,

-Учрыг нь хэлээд аль, таны чухам юу гэх гээд байгааг би ермэдэхгүй байна шүү гээд, өөрийгөө тэврээд хэвтэж байгаа, д'Артаньяны өөдөөс харахдаа нүд нь гялалзаж байв. Энэ бүгдийг дуусгавар болгохоор шийдсэн д'Артаньян үүнд,

Би уул нь шударга журамт хүн тэгээд таныг хайр сэтгэлээ надад өгснөөс хойш үүнд үнэмших болсноос хойш.. үгүй би, таны хайртай сэтгэлтэйд бат үнэмшиж болно биз дээ? гэв. -
Болноо, бололгүй яахав, тэгээд?

-Тэхлээр үүнд би хагартлаа баярлаж байна, тэгээд илчилж хэлбэл зохих нэг юм миний сэтгэлийг бас шаналгааж байна.

-Илчилж хэлэх юмаа?

-Таны хайртай сайнд би эргэлзэж байгаасан бол илчилж хэлэхгүйсэн. Гэтэл гуа сайхан янаг минь, надад хайртай шүү дээ. Та надад хайртай сайн, тийм биз дээ? Хайртай байлгүй яахав.

-Тэгвэл танд хязгааргүй хайр сэтгэлтэйгээсээ болоод, өөрийн чинь өмнө би ямар нэг юманд буруут болсон байвал уучлах уу, хэл дээ?

-Магадгүй.

д'Артаньян Миледигийн уруулд уруулаа ойртуулах тэсэн чинь, цаадах нь түлхэж орхив.

-Илчилж хэлэх юм... гээд Миледигийн царай зэвхийрч, юун юм илчлэх болоод байна вэ? гэв.

Энэ дөрөв дөх өдөр, яг энэ өрөөнд де Вард та хоёр уулзсан байх тийм үү?

-Манайд уу? Үгүй, тийм юм ер байгаагүй гэж Миледи төв шулуун дуугаар тун ч хэнэггүй царайтай хэлсэнд, д'Артаньян лав мэдэж байгаагүй бол эргэлзмээр байв. -Миний хөөрхөн дагина, бүү худлаа ярь, энэ чинь тусгүй гэж д'Артаньян инээмсэглэсээр хэллээ.

-Энэ чинь юу гэсэн үг вэ? Хэлээч, та намайг алах нь! гэлээ.

-Үгүй, тайвширч үз миний тухайд буруутай юм өөрт чинь огт байхгүй, би аль хэдийн таныг уучилсан.

-Үгүй тэгээд,, тэгээд юу вэ?

-Де Вардад гайхуулаад байх юм ер үгүй.

, -Яагаад тэр вэ? Таны өөрийн хэлснээр тэр бөгжийг...

-Хайрт минь, тэр бөгж чинь надад бий. Дөрөв дөх өдөр танайд ирсэн де Вард гүн өнөөдрийн д'Артаньян хоёр нэг хүн юм гэв.

Болчимгүй залуу бодохдоо ичингүйрч гайхах жаал муухай аашлаад уйлж гарах байх гэсэн чинь муухай эндүүрчээ. Эндүүрэхдээ удаан ч эндүүрэх зав болсонгүй.

Зэвхийрч, аймаар царайтай болчихсон Миледи өндийж, д'Артаньяныг цээж рүү нь хүчтэй ёворч зайлуулаад, орон дээрээс үсрэн буув.

Бүр гэгээ орчихсон цаг билээ.

д'Артаньян уучлал гуйж, аргадах санаатай, торгомсог нимгэн хувцаснаас нь барьж тагтал Миледи цаашаа мултрах гэж ухасхийв. Ингэж хүчтэй угзраххөдөлгөөнд нимгэн торго урагдаж Миледийн өрөөсөн мөр ил гарав. Тэгтэл цасан цагаан, дугараг хоёр мөрний нэгэн дээр, яргачны бузар гараар тавьдаг үл арилах тамга болох хонхон цэцэг дарсан байхыг д'Артаньян үзээд, гаргаж хэлэхийн эрхгүй их айж хэлмэгдэхдээ, дотуур хувцсыг нь тавьж.

-Өршөөлт бурхан минь? гэж дуу алдав.

Ингээд д'Артаньяныхамаг бие хүйт оргиж, үг дуугарах, хөдлөх сэхээгүй орон дээр таг болчхов.

Гэтэл д'Артаньяны ингэтэл айснаар Миледи нууцаа алдсаныг мэдчихлээ, тамга даруулсныг харжээ гэдэгт эргэлзэхийн эрхгүй байв. Үүний өмнө хэнд ч мэдэгдээгүй байсан аймшигт нууцыг энэ залуу одоо мэдэх боллоо.

Миледи эргэж залуугийн өөдөөс харахдаа уур хорслын туйлд хүрсэн бүсгүй хүн биш шархадсан ирвэс шиг болжээ..

-Хар новш, чи намайг муухай мэхэлсэн чинь багадаад миний нууцыг бас мэдчихэв үү! Чи одоо үхнэ дээ! гэж Миледи зүхээд, гоёл заслалын ширээн дээрээ байгаа сийлбэртэй жижиг хайрцаг руу гүйж очоод, чичирч тэвдсэн гараар түүнийг онгойлгож, алтан бариултай

нарийхан хурц хутга гаргаж аваад эргэж нүцгэн шахуу байгаа д'Артаньян руу дайрав.

Мань залуу зоригтой хүн хир нь бүсгүйн хувирч хачин болчихсон царай, зэвүүн муухай бүлцийсэн нүд, зэвхий хацар, цусан улаан уруул эд бүгд д'Артаньяныг хүртэл шалгаж өөдөөсөө могой дөхөөд ирэхийг харсан хүн шиг хана руу ухарч наалдтал, хөлс даасан гарт нь санамсаргүй илд баригдсанд суга татаж авлаа.

Гэтэл Миледи илдийг үл хайхран өөрий нь хутгалсаар орон дээр гарах гэж тэмүүлж байснаа илдний хурц үзүүр цээжиндээ хүрэхэд сая нэг юм зогслоо.

Тэгээд Миледи тэр илдийг гараараа барьж авах санаатай оролдож эхэлсэндд'Артаньян илдээ бариулахгүй илднийхээ үзүүрийг нүд цээж хоёрт нь ээлжлэн тулгасаар шалан дээр бууж Кэттигийн өрөө рүү орох үүдэнд ойртох арга сүвэгчлэв.

Миледи өөр рүү нь улайран давшилсан хэвээр дайрахдаа ,нэг хачин араатан шиг дуугарах аж. Энэ нь ёстой тулалдаантай адил болж ирсэнд д'Артаньян жаал сэхээ орж ирлээ.

-Засайн, гуа бүсгүй минь их сайн! Ганцхан тогтож тайвширч хайрлахгүй бол таны наад хөөрхөн хацар дээр чинь би дахиад нэг цэцэг зурчихна шүү гэж үглэнэ.

Миледи бахардаж муу новш! муу новш! гэж чарлав.

д'Артаньян үүд рүү ухарсаар биеэ хамгаална. Миледи, залууд хүрэх гэж замд байгаа сандлыг унагаж д'Артаньян биеэхамгаалж, тэдний цаагуур орж бөөн шуугиан дэгдээсэнд Кэтти үүдээ онгойлгов. Уулаасаа энэ үүдэнд ойртохоор дөхөж явсан д'Артаньян энэ үед гурван алхмаас холгүй байлаа. Тэр нэг үсэрч Миледигийн өрөөнөөс зарц бүсгүйн өрөөнд ороод үүдийг бушуухан хааж, Кэттиг түгжиж байх зуур бүх биеэрээ дарж байлаа.

Тэхлээр нь Миледи өөрийнхөө өрөөг зарц бүсгүйн өрөөнөөс тусгаарласан хаалтыг эвдэх гэж оролдохдоо бүсгүй хүнд байшгүй их хүч гаргаж байв. Эвдэж болохгүйг мэдээд, үүд рүү хутгаараа шааж гарлаа. Тэхдээ заримдаа үүдний модыг нэвт шаачхаж байлаа.

Үүд рүү хутгаар шаах бүрийдээ аймаар муухай хараана. Үүд түгжиж орхимогцоо, д'Артаньян шивэгнэж

-Бушуулаарай, бушуулаарай Кэтти намайг эндээс гарахад тусалж аль, үүнд сэхээ авах зав өгөх л юм бол зарц нартаа тушаагаад намайг алуулчихна шүү гэв.

-Үгүй, та тэгээд энэ хэвээрээ явалтай биш, та бараг нүцгэн байна шүү дээ гэж Кэтти хэлэв.

Өмссөнөө сая анзаарсан д'Артаньян,

-Тийм, тийм, нээрээ тийм юу байгаа нэг юмаа надад өмсүүлчих бушуулаарай, энэ чинь үхэх сэхэхээ шийдэх болоод байнашүү, ухаж үз гэв.

Кэтти үүнийг юунаас ч илүү сайн ойлгож байлаа. Бүсгүй хүний нэг цэцэгтэй бошинз, малгай, нөмрөг цамц, өмсүүлээд, хөлөнд нь холхиндог шаахай углаад, доошоо дагуулж гүйв.

Тэд золтой л амжжээ. Миледи нэгэнт хонх дуугаргаж, гэрийнхнийг цөм сэрээж байлаа. Хаалгачийг яг үүд онгойлгож байхад. Миледи мөн нүцгэн шахуу цонхоороо цухуйгаад, Бүү гаргаарай! гэж хашгирлаа.

XXXVIII. АТОС АЯН ДАЙНЫ ХЭРЭГЛЭЛЭЭ ТӨВӨГГҮЙ ОЛСОН НЬ

Залуу хүн зугтаагаад явчихлаа, Миледи цөхөрч арга барагдан хойноос нь занасаар хоцров. Залуугийн бараа тасармагц Миледи ухаан алдаж унав.

д'Артаньяны сэтгэл гүнээ догдолсон тул Кэтти яах бол гэж санасан ч үгүй Парисын талыг гүйсээр өнгөрч Атосын үүдэнд ирээд сая зогсов. Сэтгэл нь үймэрч, айж сандарсан, харуул эргүүлийн улс хашгирч, зарим газар хойноос нь ч билээ хөөсөн, цаг хэдий эрт байсан боловч хэрэг ажлаар явж байсан ганц нэг хүний гуугалж хашгачих эд бүгдээс болж д'Артаньян улам хурдалсаар байжээ.

Хашаа руу ороод, гурван давхарт гарч. Атосын үүдийг учир зүггүй балбалаа.

Унтаж унтаж бүлцийсэн нүдтэй Гримо түүнд үүд тайлж өгөхөд д'Артаньян өрөө рүү эрчээрээ ухасхийж сандчин орохдоо Гримог золтой л дайраад унагачихсангүй.

Хөөрхий Гримо уулын дуугүй хэдий боловч энэ удаа ам нээж:

-Хүүе ичгүүргүй гэзэгт чи хайчих нь вэ, хаашаа зүтгээд байгаа янхан бэ? гэв

д'Артаньян бүсгүй хүний малгайгаа хажуу тийш болгож, нөмрөг цамцан доороос гараа гаргалаа. Сахал, хуйгүй илд хоёрыг үзээд хөөрхий Гримо өмнөө эрэгтэй хүн байгааг ойлголоо.

Тэгээд лав алах нь гэж бодоод:

-Туслаарай, амь авраарай та минь! Туслаарай! гэж хашгачив.

-Дуугаа тат тэнэг миль би д'Артаньян байна, чи намайг таньсангүй гэж үү? эзэн чинь хаана байна? гэж залуу асуув.

-Та, д'Артаньян гуай гэж үү? Ямар хачин юм бэ? гэж Гримо дуу алдана. . Атос унтах өрөөнөөсөө гэрийн тэрлэгтэй гарч ирээд,

-Гримо. та янз нь юм яриад байнаа даа? гэв. . -Үгүй эрхэм ээ хэргийн учир гэвэл... -Дуугүй бай!

-Гримо дуугүй болоод д'Артаньяныг эзэндээ зааж хариулав.

Атос нөхрөө таниад, хэдий төлөв хүн боловч тачигнатал инээд алдлаа. өмнөө бүсгүй хүний малгай духдуулчихсан, шал хүртэл унжсан банзалтай ханцуйгаа шамлачихсан тэгээд өрвийсөн сахалтай сандарсан царайтай хүнийг хараад инээхээс биш яахав.

д'Артаньян дуу алдаж,

-Найз минь бүү инээ, бурхан шүтээнээ санаж, бүү инээж үз, юу гэвэл, инээхээр юм үүнд байхгүй гэдгийг андгайлъя гэв.

Энэ үгийг д'Артаньян яахын эрхгүй төв байртай, үнэг голоосоо айж хирдхийсэн янзтай хэлсэнд Атос даруй инээхээ зогсов.

Атос залуугийн гараас шүүрч аваад,

Наад царай чинь ямар их зэвхийрч орхино вэ, найз минь арай шархадсан юм биш биз? гэлээ. -Үгүй харин сая надад аймаар муухай юм учирлаа. Атос та ганцаараа байгаа юу? -Чөтгөр, алгад, өдийд хэн манайд байх билээ?

-За яамай!

Ингээд д'Артаньян яаран Атосын унтах өрөөнд орлоо. Атос үүдээ хааж, хүн амьтан саад бүү хийг гэж түгжээд,

-За яриарай. Арай ван эзэн нас барчхаагүй биз? Та арай хамба ламтанг алчхаагүй биз! Таны царай бүр хачин болчхож. За бушуухан яриач дээ, миний сэтгэл бүр зовчихлоо гэв. д'Артаньян бүсгүй хүний хувцсаа тайлж, дан цамцтай үлдээд,

-Атос, та нэг хүний санаанд багтамгүй, урьд хожид дуулдаагүй хачин юм сонс доо гэв.

__ Эхлээд энэ тэрлэгийг өмсчих гэж шадар цэрэг хэлэв. д'Артаньян тэрлэгийг өмсөхдөө, ихэд догдолчихсон болохоор ханцуйгий нь олохгүй байлаа.

-За тэгээд? гэж Атосыг дуугарахад д'Артаньян хариуд нь Атосын чих рүү бөхийж, дуугаа намсган

-За тэгээд Миледи чинь нь мөрөн дээрээ шившиглэгдсэн хонхон цэцгийн тамгатай юм гэв.

Энэ үгийг сонсоод, шадар цэргийн зүрх рүү сум тусчих шиг пээ! гэж дуу алдав. Ингэхэд нөгөө бүсгүйг үхсэнгэж та лав мэдэж байна уу? гэж д'Артаньян асуув.

-Нөгөө бүсгүй? гэж Атос бөглөрсөн дуугаар давтаж асуухад д'Артаньян дөнгөж л дууллаа.

-Тиймээ, тийм. Таны нөгөө Амьенд байхад нэг удаа надад ярьж өгсөн тэр бүсгүй гэхэд, Атос ёолоод толгойгоо барилаа. д'Артаньян үгээ үргэлжлүүлэн,

Энэ хүүхэн хорин зургаа, долооорчим настай юм гэв.

-Цайвар үстэй юм уу? гэж Атос асуулаа.

-Тиймээ.

-Тунгалаг, хачин гэмээр тунгалаг цэнхэр нүдтэй, хөмсөг, сормуус нь хар юм уу? -Тиймээ.

-Өндөр нуруутай, гуалиг сайхан биетэй юу? зүүн талын соёоны хажууд нэг шүд нь үгүй байна уу?

-Тиймээ

-Хонхон Цэцгэн тамга нь жижгэвтэр, элдэвюмаар арчсаар дутуухан арилсан юм шиг шаргал өнгөтэй байна уу?

-Тиймээ.

-Үгүй, та түүнийг англи хүн гэсэн шүү дээ?

-Улс түүнийг цөмөөрөө Миледи гэх юм билээ, гэхдээ тэр өөрөө франц хүн байж мэднэ. Винтер гуай чинь, ердөө л түүний нөхрийн ах шүү дээ.

-д'Артаньян, би тэр хүүхнийг үзмээр байна.

-Болгоомжлоорой. Атос болгоомжлоорой Та түүнийг алах гэж оролдсон хүн. Цаадах чинь таныг бас алах гэж оролдоход гар нь чичрэхгүй хүн шүү.

-Тэр хүүхэн ямар нэг юм бусдад ярьж чадахгүй, тэгвэл өөрийгөө барьж өгнө гэсэн үг шүү дээ.

-Тэр ч юу ч хийхээс буцахгүй хүүхэн уурлаж сүйд болж байхыг ньта ер үзсэн үү? -Үгүй.

-Тэр чинь зүгээр барс, ирвэс гэсэн үгээ. Атос найз минь, айхтар муухайгаар өшөө авахуулах аюул хоёр толгойдоо хураав бололтой гэж их айж байна гэв.

Ингээд Миледийн ухаан жолоогүй уурласан, алах гэж занаж аашилсныг цөмийг нь д'Артаньян ярьж өгөв.

-Таны хэлдэг зөв, одоо би, үнэнээ хэлэхэд өөрийнхөө амь насыг сохор зоосны ч төдий бодохгүй. Аз болоход нөгөөдөр бид Парис хотоос явах болж байна. Биднийг лав Ларошель рүү явуулах байх, тэгээд биднийг яваад өгөхөөр... гэж Атос хэлэв.

-Тэр бүсгүй Таныг таньчих л юм бол хойноос чинь хорвоогийн зах хязгаар хүртэл явна байх. Түүний хорсол хилэн ганц миний толгой дээр л бууг.

Үгүй намайг тэр алчихлаа ч гэсэн нэг их сүйд болоод байх юу байна! Намайг аминдааих хайртай гэж арай бодоогүй биз та? гэж Атос хэлэв.

Эд бүгдийн цаана нэг их аймшигт нууц юм байна. Тэр бүсгүй чинь байнаа, хамба ламтны тагнуул мөн, би лав мэдэж байна.

-Тийм бол болгоомжлоорой. Лондон явсан хэргийн хувьд хамба ламтан өөрт чинь биширч сайн болчихоогүй бол лав үзэн ядах болсон байх. Гэхдээтанд илэрхийгээр л ял тулгах шалтаг байхгүй. Үзэн ядна гэдэг заавал нэг талаар илэрч гарах ёстой, тэр дундаа хамба ламтных бол бүр заавал нэг гарч ирнэ, тэхлээр болгоомжил. Гэрээсээ гарвал дандаа ханьтай гарч бай, юм хүм идэж уухдаа болгоомжтой бай, ер нь хэнд ч тэр, өөрийнхөө сүүдэрт ч бүү итгэж бай.

д'Артаньян үүнд,

-Аз болоход бид яаж ийгээд нөгөөдөр орой хүрвэл гайгүй, юу гэвэл хуаранд бид дайснаас өөр айх юмгүй байх болов уу гэж бодогдох юм.

-Аа одоохондоо би гэрээсээ гарахгүй гэснээ больж, газар сайгүй өөртэй чинь цуг явалцах болно. Та одоо Авсны гудамжинд очих хэрэгтэй, би цуг явалцъя гэж Атос хэлэв. -Үгүй, манайх хэдий ойрхон гэлээ ч би яаж ийм янзтай явах вэ дээ гэж д'Артаньян маргав.

-Энэ ч аргагүй гэж Атос зөвшөөрөөд, хонх дуугаргасанд Гримо орж ирлээ. д" Артаньянд очиж хувцас хунар авч ир гэж Атос дохисонд Гримо мөн сайн ойлголоо гэж дохиод гарч одов.

-За тийм байж, тэгтэл энэ явдал аян дайны хэрэгслээ төхөөрөх хэрэгт маань ер тус болохгүй байна шүү дээ, нөхөр минь, юу гэвэл, таны хамаг жаал зугаа юм чинь Миледийнд үлдчихсэн бололтой, тэр бүсгүй лав эргүүлж өгөхсөн гэж санаачлахгүй байхаа. Аз болоход танд нөгөө бөгж бий дээ.

-Тэр бөгж, хонгор Атос таны юм!. Таны гэр бүлийн удмын эдлэл байсан гэж та өөрөө хэлсэн шүү дээ.

-Тиймээ, манай аав түүнийг хоёр мянган зоосоор авсан гэж нэг ярьж байсан юм даг. Манай ээжид өгсөн хуримын бэлэгт тэр бөгж оролцсон юм гэнэ, аргагүй сайхан бөгж. Ээж үүнийг над бэлэглэсэн юм, би гэж тэнэг амьтны тэр бөгжийг сахиус шиг хадгалахын оронд өөрөө тэр муу адгийн бүсгүйд бэлэглэсэн юм.

-За тэгвэл сайн нөхөр минь, энэ бөгжийг та ав, танд хир их чухаг зүйл болохыг би ойлгож байна гэв.

-Энэ бөгжийг би гэмт ялт хүмүүсийн гараар орсон хойно нь авах гэж үү? Хэзээ ч тэхгүй. Наад бөгж чинь бузартчихжээ, д'Артаньян,

-Тэгвэл наадахаа худалдаж орхи.

-Ээжээсээ авсан бөгжийг худалдах гэж үү? Үнэнийг хэлэхэд, үүний чинь тангаргаа няцсан хэрэг гэж санаж байна.

-За тэгвэл үүнийгээ барьцаанд өгчих, та лав мянгаад зоос авах байх. Энэ мөнгө таны хэрэгцээнд элбэг хүрэх ёстой, дараа нь мөнгө олохтойгоо зэрэг бөгжөө авна биз юу гэвэл мөнгө хүүлэгчийн гараар дамжсан болохоор ариусаад танд хүрч ирнэ гэв.

Атос инээмсэглээд,

-Хонгор д'Артаньян та гайхалтай сайн нөхөр юм хэзээд зугаатай сэргэлэн явдаг болохоор уйтгарт автсан золгүй хүмүүсийн сэтгэлийг сэргээх юм. За тэгье, энэ бөгжийг барьцаанд өгчих өө, харин нэг болзол тавина.

-Ямар болзол бэ?

-Таван зуун зоосыг нь та, таван зуугнь би авья.

-Юу гэсэн үг вэ, Атос, надад энэ мөнгөний дөрөвний нэг ч хэрэг байхгүй. Би чинь торгон цэрэгт байгаа хүн, Эмээлээ зараад л хэрэгтэй мөнгөө олоод авна. Над ер юуны хэрэгцээ байна? гэвэл Планшед нэг морь хэрэгтэй өөр юм алга. Тэгээд над ч бас бөгж бийг та мартаж байнагэв.

-Тэр бөгжиндөө та, миний өөрийнхдөө хайртайгаас хол илүү хайртай шүү дээ, юу ч гэсэн над тэгж санагддаг юм.

-Тиймээ, онцын чухаг хэрэгцээ гарахад тэр бөгж биднийг бэрхшээлээс гаргаж болох төдийгүй бас сүрхий аюулаас аварч болох учиртай болохоор хайрладаг юм. Тэр чинь зүгээр нэг үнэт эрдэхийн чулуу биш, увдист сахиус юм аа.

-Таны юун тухай ярьж байгааг би мэдэхгүй байна, гэхдээ таны үгэнд итгэнэ. За тэгээд миний бөгж, чухам гэвэл таны, бөгжний тухай яриагаа дуусгая. Энэ бөгжийг барьцаанд аваад бидэнд өгөх мөнгөний хагасыг та ав. Үгүй бол үүний чинь би Сена мөрөнд хаячихъя. Тэгээд урьд Голикратад нөгөө загас тус болсончлон, ямар нэг загас эелдэг зан гаргаж, та бид хоёрт үүнийг авчирч өгнө гэж би бат итгэхгүй байна тэлээ.

д'Артаньян:

-За сайн, би зөвшөөрье гэв.

Энэ үеэр Гримо, Планшетэй цуг хүрч ирлээ. Эзнийгээ яагаа юм бол гэж сэтгэл зовсон, мөн яасны нь мэдэх гэж бас хэрэгт дурласандаа Планше завшааныг ашиглан өөрөө хувцас авчирчээ.

д'Артаньян хувцсаа өмслөө. Атос ч мөн хувцаслаад, хоёр нөхөд гарахад бэлэн болсон хойно, Атос буу шагайх маягийн дохио Гримод өглөө. Гримо даруй хананд өлгөөтэй байсан буу авч, эзнээ дагаж явахаар зэхлээ.

Тэд сайн явж Авсчны гудамжинд хүрэв. Бонасье үүдэн дээрээ зогсож байгаад, л'Артаньяныг дооглонгуй харж,

-Эелдэг эрхэм минь хурдалж үз, гуа сайхан бүсгүй таныг хүлээж байна. Бүсгүйчүүл ер нь хүлээх дургүй улс юм шүү дээ гэж хэллээ.

-Тэр чинь Кэтти байж таарна гэж д'Артаньян дуу алдаад дээшээ гүйж гарлаа.

Үнэхээр ч тэдний өрөөний өмнөх шатан дээр Кэтти харагдлаа. Хөөрхий бүсгүй үүд налж зогсоод хамаг бие нь чичирч байв.

-Та намайг өмгөөлнө гэж ам өгсөн, тэр авгайн уур хилэнгээс намайг аварна гэж та амласан билээ. Боддоо. Та намайг баллалаа шүү гэж Кэтти хэлэв.

-Тэгэлгүй яахав, Кэтти бүү санаа зов. Үгүй ингэхэд, намайг явснаас хойш юу болсон бэ? гэж

д'Артаньян хэллээ.

Кэтти:

-Би өөрөө ч мэдэхгүй. Түүнийг хашгирч орилохоор зарц нар гүйж ирсэн, Миледи өөрөө ухаан жолоогүй уурлаад байсан. Таны тухай хэлээгүй хараал зүхэл гэж байхгүй. Тэхлээр нь өөрийнхөө өрөөнд таныг миний өрөөгөөр дамжиж орсныг санаад, цөмийг өөртэй чинь хуйвалдсаныг мэдүүзэй гэж айлаа. Би хамаг мөнгөө, аль үнэтэй цайтай гэсэн юмаа аваад зугтааж ирлээ гэв.

-Хөөрхий охин минь минь би ер яая даа, нөгөөдөр би явах болж байдаг. -д'Артаньян гуай та яахыг өөрөө л мэд, намайг Парис хотоос явахад тусалж үз. Францаас явахад тусалж үз.

д'Артаньян маргаж,

-Үгүй Ларошелыг бүсэлж байлдахдаа би өөрийг чинь дагуулаад явалтай биш дээ гэв.

-Нээрээ тэгэлтэй биш. Гэсэн ч та намайг хөдөө газар, өөрийнхөө нутагт ч юм уу, нэг танил хатагтайнд ажил олж өгч болно шүү дээ.

-Хонгор Кэтти минь манай нутагт хатагтай нар зарц бүсгүй хэрэглэдэггүй юм. Байз, ер нь юу хийвэл таарахыг би мэдэж байна. Планше чи Арамисынд очоод ир. Бидэнд ярилцах юм байна даруйхан наашаа ир гээ гэв.

-Би ойлголоо. Үгүй, Портостой ярилцвал яасан юм бэ? Миний санахад, түүний нөгөө хэргэмтэн бүсгүй... гэж Атосын хэлэхэд д'Артаньян инээд алдаж:

-Портосын тэр хэргэмтэн бүсгүй нөхрийнхөө бичээч нараар туслуулж хувцасладаг юм. Тэгээд ч Кэтти өөрөө Баавгайн гудамжинд суухыг хүсэхгүй, тийм биз Кэтти гэв. -Намайг сайн шиг нууж, суугаа газрын минь хүн мэдэхгүй л байвал би хаана ч суусан хамаагүй гэж Кэтти хариуллаа.

-За одоо бид салах боллоо, тэхлээр хойшид чи намайг жөтөөрхөхгүй биз дээ Кэтти? - д'Артаньян гуай, би хол ойр хаана байлаа ч гэсэн хэзээд л танд хайртай сайн байна гэж Кэтти хэлэв.

-Тогтвортой сэтгэл гэдэг чинь, энд л нэг хоргодох газаролсон юм байна шүү чөтгөр алгад гэж Атос амандаа үглэв.

-Би ч гэсэн мөн ялгаагүй хэзээд чамдаа хайртай сайн байна, бүү сэтгэл зов. Ингэхэд надад нэг юм хэлж өг, их чухал зүйл, нэг шөнийн цагт хулгайлагдсан залуу бүсгүйн тухай чи ер юм сонсоогүй биз? гэж д'Артаньян асуув.

-Байзаарай... үгүй бурхан минь, та чинь бас тэр бүсгүйд сэтгэлтэй юм шив дээ? -Үгүй тэр бүсгүйд миний нэг нөхөр сэтгэлтэй, одоо энэ Атос доо.

Атос үүнд могой дээр гишгэх шахсан хүн шиг хиртхийж

-Би юу дээ! гэж дуу алдлаа.

-Тэгэлгүй яахав, чи шүү дээ Атос гэж д'Артаньян Атосын гарыг барьж хэлэв. Тэр хөөрхий Бонасье авгайг бид цөм өрөвдөж байдгийг чи өөрөө сайн мэднэ газар. Тэгээд Кэтти энэ тухай хэнд ч ярихгүй. Тийм биз, Кэтти ингэхэд хонгор оо, тэр бүсгүй чинь сая чиний наашаа ирэхэд гадна үүдэн дээр зогсож байсан тэр муухай амьтны эхнэр юм шүү дээ.

Кэтти дуу алдаж.

-Ээ бурхан минь. та надад түүний тухай санууллаа. Би хичнээн айв аа. Тэр намайг таньчихаагүй байгаасай билээ гэв.

-Юу таиьчихаагүй байгаасай гэж? Тэгвэл энэ хүнийг чи урьд үзсэн байх нь ээ? -Энэ хүн Миледийнд хоёр удаа очсон юм.

-Тийм байж таарнаа. Хэзээ тэр вэ?

-Хоёр долоо хоногийн урьд байна уу. хориод хоногийн урьд.

-Тиймээ, Тийм , яг таарч байна.

-Тэгээд, өчигдөр орой бас дахин очсон.

-Өчигдөр оройюу?

-Тиймээ, таныг орохын өмнөхөн.

-Атос найз минь, биднийг бөөн тагнуулууд тойрч байна. Чи тэгээд өөрийг чинь тэр хүн таньсан байх гэж бодож байна уу?

-Түүнийг хараад би малгайгаа дарж өмссөн, гэхдээ оройтчихсон байхаа. -Атос та доошоо орооч, тэр хүн таныг надаас арай бага сэжиглэдэг байх, тэр одоо хаалган дээрзогссон хэвээрээ байна уу, хараач, гэж д'Артаньян гуйв.

Атос доошоо бууж үзээд, даруй эргэж ирээд:

-Тэр хүн алга. гэрээ цоожилж орхисон байна гэв.

-За тэр чинь. шувуухайнууд цөм үүрэндээ байгааг ховлох гээд явж дээ гэж д'Артаньяныг хэлэхэд, Атос тосч аваад

Тэгвэл цөмөөрөө нисээд явчихья Ганцхан Планшег л энд үлдээчихье, цаашаа юу болсныг бидэнд дуулгана биз, гэв.

-Жаахан байзнаарай, Арамисыг яах вэ? Бид хойноос нь хүн явуулсан шүү дээ. Тэр тийм, Арамисыг хүлээе. Яг энэ үеэр Арамис ороод ирлээ.

Арамист бүх учир явдлыг ярьж өгөөд, түүний өндөр хэргэмтэн танилуудын нэгэнд Кэттиг ажилд оруулах явдал хир чухал болохыг тайлбарлав.

Арамист хэсэгзуур юм бодсоноо, царай нь улайгаад: д'Артаньян танд би нээрээ их тус болох юм уу? гэж асуув.

Би бүх насан туршаа танд ач санаж явах болноо.

Тэгвэл де Буа-Траси гуайн гэргий хөдөөний байна уу, нэг найздаа итгэлтэй сайн зарц бүсгүй олж өгөхийг надаас гуйсан юм. Хэрэв д'Артаньян та өөрөөнэ хүнийг лавтай... -Оо, эрхмээ намайг Парисаас гарахад тус болсон тэр эрхэм авгайд би хязгааргүй үнэнч сайн байх болно гэж Кэтти дуу алдав.

-За тэгвэл энэ хэргийг бүтээж болноо гэж Арамис хэлээд ширээн дээр сууж зурвас бичээд, түүнийгээ бөгжөөрөө тамгалж Кэттид өгөв.

-За одоо хонгор минь энд байх гэдэг чамд ч тэр, бидэнд ч тэр аюулгүй биш гэдгийг чи ойлгож байгаа, ингэхлээр бид хагацахаас яахав. Сайн цагт хоёулаа уулзъя гэж д'Артаньян Кэттид хэлэв.

-Ингэхэд хэзээ, хаана, ямар ч үед уулзлаа гэсэн тэр, танд би одооных шигээ л хайртай байна гэдгийг мэдэж яваарай гэж Кэтти хариуллаа.

д'Артаньян Кэттиг гаргаж өгөхөөр гадагшаа гарсан зуур Атос,

-Дэмий үг гэж дуугарав.

Минутын дараа гурван залуу нөхөд салж явахдаа Планшег гэрээ харуулж үлдээгээд орой дөрвөн цагийн орчим Атосынд уулзахаар болзлоо.

Арамис гэртээ харьж, Атос д'Артаньян хоёр нөгөө бөгжөө барьцаанд өгөхөөр явав.

Манай гаскон залуугийн бодожбайсанчлан бөгжөө барьцаанд өгөөч, ямар ч төвөггүй гурван зуун алтан зоос авлаа. Түүнээс гадна тэднийг бөгжөө өөрт нь бүр зарахаар болбол таван зуун алтан зоос өгөхөд бэлэн байна гэж мөнгө хүүлэгч тэдэнд дуулгав. Панзчины хэлж байгаагаар, энэ бөгж гүүнд байгаа нэг ээмэгтэй хачин сайхан нийлмээр байгаа аж.

Дадлагатай цэргүүд болох Атос д'Артаньян хоёр шадар цэрэгт хэрэгтэй юм бүхнийг төхөөрөхөд, гурван цагаас илүү удсангүй. Тэгээд ч Атос уулын нийцэрхүү зантай, гойд гар султай хүн билээ. Авах гэсэн юм санаанд нь тохирвол, үнийг нь хасах гэж оролдохгүй, хүний хэлснээр л төлөөд авчих аж. Энэ тухай д'Артаньян юм хэльеү гэтэл Атос инээмсэглээд, гараа мөрөндээр нь тавилаа. Тэхэд, гасконы ядуу тайж хүн юмыг үнэ хаялцаж боллоо гэхэд, угсаат хун тайж шиг байдаг хүнд энэ явдал зохихгүйг д'Артаньян ойлголоо.

Шадар цэрэг өөртөө андалуз угсааны, соёолон настай нарийн гуалиг хөлтэй, омголон, цэврүү шиг сайхан, тас хар морь авлаа. Атос морийг шинжиж үзээд, өөлөх юм ер олсонгүй, энэ морийг мянган зоос гэж байлаа.

Магадгүй тэр морийг арай хямд авч болох байсан ч байж. Гэвч д'Артаньяныг панзчинтай үнэ хаялцаж байх зуур Атос аль хэдийн нэг зуун алтан зоос гаргаад ширээн дээр тавьчихсан байв. Гримод Пакару угсааны шандаслаг морь гурван зуун зоосоор худалдаж авлаа.

Ингээд энэ моринд эмээл, Гримод зэвсэгавсны дараа Атосын зуун тавин алтан зоосноос сохор зоос ч үлдсэнгүй, д'Артаньян нөхрийгөө өөрийнхөө мөнгөний хагасыг аваад хожим нэг цагт эгүүлж өгнө биз гэсэнд, цаадах нь зөвхөн мөрөө хавчисхийв.

-Мөнгө хүүлэгч нөгөө бөгжийг бүр авья гэхдээ, хичнээн зоос өгье гэж байна? гэж Атос асуулаа,

-Таван зуун алтан зоос.

-Тэгвэл хоёрзуун алтан зоос илүү өгнөө. Танд зуу, надад зуун зоос, үгүй энэ бөөн хөрөнгө гэсэн үг, найз минь мөнгө хүүлэгч дээр очиж үз гэв.

-Юу та тэгээд тэр бөгжийг...

-Үнэндээ, тэр бөгж мадад тун ч гунигтай явдлууд санагдуулаад байхсан билээ. д'Артаньян. Тэгээд ч түүнийг буцааж авах гурван зуун алтан зоос бидэнд ер олдохгүй, бид зүгээр л хоёр мянган зоосоо дэмий алдана гэсэн хэрэг. Түүнд бөгжөө өгч орхиод хоёр мянган зоостой буцаж ир гэв.

-Атос та сайн бод л доо.

-Манай энэ цагт бол мөнгө гэдэг их чухаг, зарим юмыг гаргуунд хаяж чаддаг байх хэрэгтэй юм. д'Артаньян чи яв яв. Гримо буутайгаа таныг дагаж яваг.

Хагас цагийн дараа д'Артаньян хоёр мянган зоостой буцаж ирэв. Зам зуур элдэв хэрэг төвөг тохиолдсонгүй.

Мөнгөтэй болно гэж огт горьдоогүй байсан Атос иймэрхүү янзаар мөнгөтэй болсон аж.

XXXIX. ХИЙ БАРААГ ХАРАВ

Ингээд дөрвөн цагт, дөрвөн нөхөд Атосын гэрт цугларлаа. Аяндайны хэрэгслээ төхөөрөх ажлаа дуусгацгаагаад, одоо тэдний царай нь зөвхөн тус тусын нь дотоод нандин сэтгэл л илэрч байлаа. Юу гэвэл жаргалтай аль ч үед хүний дотор ирээдүйн төлөө зовох бодол төрдөг юм.

Планше гэнэт д'Артаньянд гэж хаягласан хоёр захидал барьсаар орж ирэв.

Нэг захиа нь дэгжин, урт гонзгой, ногоон лацан дээр амандаа ногоон мөчир зуусан тагтаа товойлгосон гоё тамгатай ажээ

Хоёр дахь нь иш дөрвөлжин, дээрээ их гэгээнтэн герцог хамба ламтны сүртэй тамга бүхий байлаа.

Жижигхэн захидлыг үзээд д'Артаньяны зүрх баярласандаа түгшив. Бичгийг таньж байх шиг санагджээ. Энэ бичгийг өөрөө нэг л удаа үзсэн боловч, түүний тухай дурдатгал сэтгэлд гүнээ хадагдсанаж.

Ингээд д'Артаньян жижиг захидлыг аваад яаран задалбал.

" Ирэх лхагва гаригт оройн зургаа долоон цагийн хооронд Шаногийн замаар зугаалж, хажуугаараа өнгөрөх сүйх рүү сайн харж яваарай. Харин та өөрийнхөө болоод өөртөө хайртай сайн хүмүүсийн аминд хайртай болж гэм, агшин зуур ч болов таны барааг харахын тулд амь дүйж байгаа бүсгүйг таньснаа мэдэгдэх өчүүхэн ч болов хөдөлгөөн бүү хийгээрэй, ганц ч болов үг бүү дуугараарай" гэж бичсэн байлаа.

Гарын үсэг алга,

-Энэ чинь занга байна, тийшээ, бүү оч д'Артаньян гэж Атос хэлсэнд:

-Үгүй би бичгийг нь таньж байх шиг санагдах юм гэж д'Артаньян маргав.

-Бичгийг дуурайлгасан байж болно, өдий үед Шаногийн зам орой зургаа долоон цагийн хирд огт хүн амьтангүй байдаг юм. Тэр чинь Бондийн ойд зугаалахаар явна гэсэнтэй адил уг гэж Атос хэлэв.

-Үгүй бид цөмөөрөө тийшээ явбал яасан юм бэ? гэж д'Артаньян санал гаргаад, юу гэсэн үг вэ, чөтгөр алгад. Бид дөрвийг дөрвөн зарц, морьд зэр зэвсэгтэймаань хамт нэг зэрэг арай залгичихгүй биз дээ.

-Тэгээд ч энэ чинь манай зэвсэг хэрэгсэл сэлтээ үзүүлэх аятай учрал болно гэж Портоc үг нэмэрлэлээ.

-Үгүй үүнийг бүсгүй хүн бичсэн байгаад, тэр бүсгүй өөр хүнд харагдахыг хүсэхгүй байгаа бол д'Артаньян та тэр хүний нэрийг хөөднө шүү дээ. Энэ тухай бодоорой. Тэр чинь тайж

хүнд нийцэшгүй явдал болно шүү дээ гэж Арамис маргалаа.

Портос үүнд,

-Бид яахав ард нь хоцорно, д'Артаньян сүйх рүү ганцаараа дөхөж очиг гэв. -Тэр ч тийм л юм биз, тэгтэл хар хурдаараа давхиж яваа сүйхнээс гар буугаар буудчихад тун амархан шүү дээ.

-Яршиг даа! хий буудаж л орхино биз. Тэгвэл бид сүйхийг хөөж гүйцээд дотор нь байсан бүгдийг хядчихгүй юу. Яахав, манай дайснууд хэдээр ч болов цөөрнө л биз гэж д'Артаньян хариулав.

-Үүний зөвөө, би ч тулалдахаас буцахгүй. Үгүй ингэхэд бид зэвсгээ шалгаж үзэх ёстой шүү дээ та минь! гэж Портос санал нийлнэ.

Арамис ердийнхөө хэнэггүй, цагаахан дуугаар за яахав, ингэж нэг зугаацъя л даа хэдүүлээ гэв. Атос та бүхний дураар больё гэнэ.

-Эрхмүүд ээ, одоо дөрвөн цаг хагас болчхож, бид Шаногийн зам руу арай чарай л амжиж очих нь байна шүү гэж д'Артаньян хэлэв. Портос,

-Тэгээд бид хэтэрхий орой гарах юм бол хэн ч биднийг харахгүй, тэгвэл тун ч тоогүй юм болно. За тэхлээр, явж мордоход бэлтгэе эрхмүүдээ гэв.

-Үгүй, та хоёр дахь захидлын тухай мартчихлаа, гэж Атос хэлэв. Гэтэл гаднах тамгын нь харвал энэ захидлыг задалж таарууштай санагдана. Эелдэг нөхөр д'Артаньян минь үнэнээ хэлэхэд энэ захидалчинь, таны наад өвөртөө нандигнаж хадгалсан зурвасыг бодохноо, миний сэтгэлийг илүү зовоож байна гэв.

д'Артаньяны царай улайчхаад,

-За тэгье, надаас их гэгээнтэн юу хүсэж байгааг харчихъя эрхмүүдээ гэж хэлээд захиаг задалж уншсан нь:

"Ван эзний торгон цэргийн, Дезэссарийн сумангийн д'Артаньян гуайг өнөөдөр орой найман цагт хамба ламын ордонд урьж байна."

Торгон цэргийн даамал Ла Удиньер" гэжээ,

-Чөтгөр алгад, энэ уулзалт чинь нөгөөгөөсөө арай аюултай юм болох нээ гэж Атос дуугарав.

д'Артаньян үүнд.

Би эхний болзоонд очоод, хоёр дахид бас очноо. Нэг нь долоон цагт, нөгөө нь найман цагт гэсэн болохоор цаг элбэг хүрэлцэнэ, гэсэнд Арамис,

-Би бол очихгүйсэн эелдэг зантай хүн бүсгүй хүний тавьсан болзоонд очихгүй байхын эрхгүй, харин хянуур зантай тайж хүн их гэгээнтнийд очилгүй өнгөрөөд биеэ зөвгөх шалтаг

олж болноо. Тэр дундаа лав найрсаг сэтгэлийн үүднээс уриагүй гэж бодох үндэстэй бол очихгүй байж болохсон гэв.

Портос ,

-Би Арамистай санал нийлж байна гэсэнд д'Артаньян хариулсан нь:

-Эрхмүүдээ, их гэгээнтнээс би иймэрхүү урилга де Кавуа гуайгаар дамжуулан авсан удаатай. Тэр урилгыг би тоолгүй өнгөрүүлсний маргааш бөөн гай дайрч, Констанция үгүй. болсон билээ. Юу л болбол болог би очно гэв.

-Та шийдсэн бол оч гэж Атос хэлэв.

-Аа Бастили гяндан яах вэ? гэж Арамис асуулаа.

-Яамай байнаа. Та нар тэндээс намайг гаргаад авна биз; гэж д'Артаньян хэлэв. Юманд итгэмтгий зантай Арамис, Портос хоёр нэг дуугаар, хамгийн хялбар хэргийн тухай ярьж

байгаа мэтээр, -Тэгэлгүй яахав, гяндангаас бид өөрий чинь гаргаад авалгүй яахав, харин нөгөөдөр бид мордох гэж байгаа болохоор, одоохондоо тэр Бастилид орчихгүй байвал зүгээр юм гэлээ.

Атос ам нээж,

-За ингэцгээе. Өнөө оройдоо үүнийг ганцаарангий нь орхихыг ерөөсөө больё, үүнийг хамба ламынд орохоор, бид гурав тус бүр гурван шадар цэрэг дагуулаад, гурван хаалганы гадаа зогсьё. хэрэв тэндээс өчүүхэн ч болов сэжигтэй ямар нэг битүү сүйх гарч явбал бид дайрна биз. Хамба ламтны торгон цэргүүдтэй бид үзэлцээгүй болсоор удаж байна. де Тревиль гуай биднийг лав үхсэнд тооцож байгаа байх гэлээ.

Арамис тосч аваад,

-Догь байна Атос та чухам жанжин байхаар төрсөн хүн. Эрхмүүдээ та нар энэ төлөвлөгөөний тухай юу гэх вэ? гэв.

Залуу нөхөд нэгэн дуугаар,

-Догь сайхан төлөвлөгөө гэж магтлаа.

-За ингэхлээр, би хуаран руу гүйж нөхдөө найман цагт бэлэн байлгахаар урьдаас мэдэгдье. Хамба ламтны ордны өмнөх талбай дээр уулзахаар болзье. Та нар энэ зуур зарц нарт хэлж морьдоо эмээллүүлж бай гэж Портос хэллээ.

-Ингэхэд, би явган байна. Үгүй, де Тревиль гуайн руу моринд явуулж болох юм даа гэж д'Артаньяныг хэлэхэд Арамис хажуугаас нь

-Хэрэггүй, миний морьдын нэгийг ав гэлээ. д'Артаньяныг,

-Та хэдэн морьтой юм бэ? гэж асуухад Арамис инээмсэглээд:

-Гурав гэлээ.

-Найз минь, франц наваррын бүх шүлэгчид дотор тань шиг олон морьдтой хүн үгүй гэж би лав итгэж байна гэж Атос хэллээ.

-Ингэхэд эрхэм Арамис та гурван морио яахыг чухам өөрөө мэдэхгүй байж таарах нээ. Таны гурван морь зэрэг худалдаж авсны учрыг би ер олохгүй юм.

-Гурав дахь морийг яг өнөө өглөө нэг хэнийх нь танигдахааргүй хувцастай зарц хүргэж ирээд, хэнийд ажил хийдгээ нууж өөрийнхөө эзнээс... гэтэл, д'Артаньян үгийг нь таслан: -Аль эзэгтэйгээсээ ч юм уу гэв. Арамисын царай улайгаад,

-: Энэ ч чухал юм биш... тэгээд тэр морийг миний саравчинд авчирч өг гэж эзэгтэйгээ тушаасан, гэхдээ хэн өгүүлснийг бүү хэл гэсэн гэлээ гэв.

Атос төв байдлаар,

-Үгүй, энэ ураншүлэгчдэд л ийм юм учирч байгаа юм шүү гэнэ.

-За тэгвэл ингэе гэж д'Артаньян хэлээд та аль морио өөрөө унах вэ? Худалдаж авсныгаа юу, бэлгэнд авснаа юу? гэж асуув.

-Мэдээжээр хэрэг бэлгэнд авснаа уналгүй яах вэ. д'Артаньян та мэдэж байгаа биз дээ хүнийг тэгж доромжилж болохгүй шүү дээ,

-Үл таних өгөөмөр хүнийг үү, тийм ээ гээд; Артаньяныг хэлэхэд Атос залруулж, -Учиртай өглөгч эмэгтэйг гэв.

-Тэгвэл, таны худалдан авсан морь одоо хэрэгцээгүй болж таарч байнаа? -Бараг тийм ээ,

-Аа та өөрөө тэр морийг үзэж авсан уу?

-Үзэх үзэхдээ их нарийн үзэж авсан гээч, хүний амь ихэвчлэн мориноосоо болдгийг та өөрөө мэднэ хойно.

-За тэгвэл, тэр морио авсан үнээрээ надад өгч орхи л доо.

-Эелдэг нөхөр д'Артаньян минь тэр морийг та аваад, үнийг нь хожим дуртай цагтаа эргүүлж өгнө үү гэж би өөрөө хэлэх гэж байсан юм.

-Та тэгээд, хэдээр авсан юм бэ?

-Найман зуун зоосоо?.

д'Артаньян өврөөсөө мөнгө гаргаж,

-Май энэ дөчин хос алтан зоос байна найз минь тухайлан ийм зоосоортаны шүлгийн шагналыг өгдөг юм даг гэв.

Арамис гайхжээ.

-Та тэгээд баян байгаа юм шив? гэсэнд д'Артаньян хармаандаа байгаа алтан зоосны үлдцийг хангинуулаад:

-Баян, баян, далай шиг баян шүү, найз минь гэв.

-Эмээлээ та шадар цэргийн хуаран руу явуулчих тэгээд таны морийг бусдын хамт аваад ирнэ биз.

-Засайн, мөд таван цаг болох нээ, бид яаралгүй горьгүй.

Мөчийн дараа Феру гудамжны адгаас Портоос испани үүлдрийн сайхан азарга унасаар гарч ирэв, Түүний араас Мушкетон евернск нутгийн жижиг боловч бас л хөөрхөн гэгчийн морь унаад дагаж явна. Портоос чухам баяр бахдалын бэлэг тэмдэг болж явлаа.

Түүнтэй нэг зэрэг гудамжинд нөгөө үзүүрээс Арамис англи угсааны сайхан морьтой, хойноос нь Базен руан нутгийн морь унаж Мекленбург угсааны лут морь хөтөлсөөр гарч ирсэн нь д'Артаньяны морь аж.

Хоёр шадар цэрэг явсаар хаалган дээр ирж, Атос д'Артаньян хоёр тэднийг цонхоор харж байлаа.

-Чөтгөр алгад, эрхэм Портоос таны морь сайхан амьтан байна шүү гэж Арамис хэлсэнд Портоос хариуд нь:

-Тиймээ, нөгөө эхлээд л мадад ирүүлэх ёстой морь чинь энэ байхгүй юу. Гэтэл нөхрийн нь дэмий зангаас болж өөр мориор солигдсон юм, гэвч яваандаа нөхөр нь цээрлэл хүлээж, бүх хэрэг миний тааллын дагуу дууссан юм гэлээ. Удалгүй Планше ирж түүнтэй хамт Гримо эзнийхээ морийг хөтөлсөөр ирэв. д'Артаньян, Атос хоёр гэрээс гарч, мордоод дөрвөн нөхөд замдаа гарлаа. Атос эхнэрийнхээ ачаар, Арамис янаг бүсгүйнхээ ачаар, Портоос прокурорын гэргийн ачаар, д'Артаньян алив янаг бүсгүйгээс илүү өөрийнхөө хийморь золбоотойн ачаар олсон морьдоо унаад гарав.

Зард нар тэдний араас дагав

Портосын бодож байсанчлан улсад манай дөрөв их л сүртэй сайхан харагдаж байлаа. Хайртай хүнээ испани азарга унаад явж байхдаа ийм сүртэй сайхан байхыг нь Кокнар авгай харж чадсан бол нөхрийнхөө мөнгөний авдарт гар дүрсэн дээ харамсахгүй байсан биз.

Лувр ордны ойролцоо, манай дөрвөн нөхөд Сен Жерменээс буцаж ирж явсан де Тревиль гуайтай дайралдав. Тэдний гялалзсан сайхан зэвсэг хэрэгслийг шохоорхох гэж де Тревиль гуай тэднийг түр зогсоосонд, яах ийхийн зуургүй өдий төдий юманд дуртай улс цугларчхав.

д'Артаньян үүнийг ашиглаж, том улаан тамга, герцог хэргэмийн сүлдтэй захидлын тухай д'Треவில் гуайд ярилаа. Нөгөөх захидлын тухай үг дуугараагүй нь мэдээж хэрэг. Нөхдийн гаргасан шийдвэрийг деТреவில் гуай сайшаагаад, маргааш өдөр нь д'Артаньяныг өөр дээрээ очихгүй бол хаа байгаа газраас нь эрж оточ аргыг өөрөө сүвэгчилнэ гэж ам өгөв. Энэ үеэр Самаритянкийн цаг зургаа дахин цохисонд дөрвөн нөхөд болзооны цаг болсныг хэлж уучлалт гуйгаад де Треவில் гуайгаас салж хөдлөв.

Ухасхийн цогьсоор даруй Шаногиин зам дээр гарч ирлээ. Бүрэнхий болж эхлээд, сүйх тэрэг нааш цаашаа сүлжилдэнэ. д'Артаньян хэдхэн алхмын хойно хамгаалж зогссон нөхдийнхөө урьд гарч замаар сүйх рүү шагайн харавч, таних хүн ер үзэгдсэнгүй:

Тэгж байтал, мөч хиртэй хүлээгээд, уулздаг болов уу та минь гэж д'Артаньяныг хэлэхэд Атос тосч аваад, төв байдлаар:

-Үхсэн хүнтэй л энэ хорвоодээр учирч болдоггүй юм даа найз минь энэ талаар та бид хоёр жаал зугаа юм мэднэ тийм биз? Тэхлээр таны хайртай бүсгүй амьд мэнд, сая тухайлан түүнийг л сүйхэн дотор явахыг харсан бол эрт орой нэгэн цагт заавал эрж олно. Магадгүй эрж олохсон гэж өөрөө хүсмээр тэр цагаас өмнө ч олоод уулзажбайж мэднэ гэж уруу царайлан нэмж хэлэв.

Долоон цаг хагас цохилоо, сүйх тэрэг захидалд заасан цагаас хорин минут хожигдож байж өнгөрчээ. д'Артаньянд дахиад нэг болзоо бийг нөхөд нь сануулж, очихоо болино гэвэл оройтоогүй гэдгийг бас хэллээ.

Бараг харанхуй болох дөхөж байхад Севергийн зүгээс нэг сүйх хурдан наашилж яваа харагдлаа. Өөртэй нь болзоо хийсэн бүсгүй тухайлан энэ сүйхэнд яваа гэж д'Артаньяны зөн татаад. зүрх нь хүчтэй догдолсонд мань залуу өөрөө гайхлаа. Бараг энэ минутад сүйхний цонхоор бүсгүй хүний толгой цухуйж ирээд хоёр хуруугаа уруулдаа хүргэх нь үг бүү дуугараарай гэж сануулж ч байх шиг, үгүй бол хий үнсэлт илгээж байх шиг тэр бүсгүй, чухам гэвэл энэ давхиад өнгөрсөн сүйхэнд бараа нь харагдаад алга болсон бүсгүй Бонасье авгай мөн байсанд д'Артаньян баярлан дуу алдав.

Захисан үгийг д'Артаньян мартаж, өөрийн эрхгүй ухасхийн давхиад, төдөлгүй сүйхийг гүйцсэн боловч цонхыг хэдийнээ таг хаачихсан байв, хий үзэгдэл алга болчихжээ.

Тэхэд л нөгөө "Хэрэв та өөрийнхөө болоод өөртөө хайртай сайн хүмүүсийн алийг хайрладаг бол юу ч үзээгүй байдал гаргаарай, ганц ч бүү хөдлөөрэй" гэсэн нь д'Артаньяны санаанд орлоо. Өөрийнхөө төлөө биш, өөртэй нь болзоо хийснээр ихээ аюулд учирч болох бололтой байсан хөөрхий бүсгүйн өмнөөс айгаад д'Артаньян чичрэн зогслоо.

Сүйх тэрэг тэр чигээрээ хурдалсаар Парис руу давхиж ороод алгаболлоо.

Гайхаж хоцорсон д'Артаньян юу бодохоо мэдэхгүй таг зогсоно. Хэрвээ энэ Бонасье авгай мөн байгаад, Парисдаа эргэж ирж байгаа юм бол ингэж түргэн бараа харалцаж, харц солиод, хий үнсэлт илгээн өнгөрөхийн хэрэг юу билээ? Бүрэнхийд эндүүрэхүйеэ хялбар болохоор тэр бүсгүй Бонасье авгай биш байж ч болох юм, тэгвэл өөрт нь хайртайсайнаа хэний ч өмнө

нуугаагүй тэр бүсгүйн нэрийг ашиглан, өөрийн нь эсрэг явуулж байгаа хатгалгын эхлэлт энэ болж байгаа юм биш байгаа гэж бодлоо.

д'Артаньян дээр цуг явсан нөхөд нь хүрч ирлээ. Сүйхний цонхоор бүсгүй хүний толгой цухуйсныг тэд гурвуулаа сайн харсан боловч, Атосоос бусад нь Бонасье авгайг зүс үзээгүй байлаа. Атосын харснаар бол Бонасье авгай яахын аргагүй мөн тэгээд ч Атос тэр хөөрхөн царай руу д'Артаньян шиг шохоорхон ширтээгүй болохоор бүсгүйн толгойноос цаана бас эрэгтэй хүний толгой байхыг ажиж амжжээ.

-Тийм бол тэд хөөрхий бүсгүйг нэг шоронгоос нөгөө рүү аваачиж яваа байх нээ. Үгүй эд хөөрхийг яах гээд байгаа юм болоо, бид хэзээ нэг цагт...

Гэтэл д'Артаньян зөрүүдийн дээр, хэрэгт дуртай хүн билээ. Хамба ламын ордонд очиж, их гэгээнтний өөртөө юу гэхийг дуулна гэж хатуу шийдсэн хойно, яаж ч хориглоод тусгүй билээ.

Сент Онорегийн гудамжинд тэднийг хүрч ирэхэд, хамбын ордны өмнө ирээрэй гэсэн арван хоёр шадар цэрэг дөрвөн нөхдийг хүлээн холхиж байх харагдав. Хэргийн учрыг тэдэнд одоо л хэлж өглөө.

Ван эзний шадар цэргүүдийн хороонд д'Артаньян ихээ нэртэй болчихсон, цаашдаашадар цэргийн эгнээнд орох хүн гэдгийг цөм мэдэж, одооноос өөрсдийн нөхөр шиг үздэг юм. Иймд цөм, энэ хэрэгт дуртайяа оролцох боллоо, тэгээд ч хамба ламтан болон, түүний хүмүүсийн эгдүүг хүргэх завшаан гарч байлаа. Энэ эрхэмсэг тайж нар тиймэрхүү хэрэг хийхэд хэзээд бэлхэн байдаг улс билээ.

Атос тэднийг гурван баг болгож хуваагаад өөрөө нэгийгнь ахалж, хоёрдугаар багийг Арамис, гуравдугаар багийг Портосоор даргалуулав. Ингээд баг тус бүр хамбын ордноос гарах гурван хаалганы өөдөөс харж ойролцоо газарт бүглээ.

д'Артаньяны хувьд гэвэл, манай хүн голын хаалгаар зоригтой ороод явчихлаа.

Манай залуу ардаа хүчтэй тулгуур бүхий боловч өргөн шатны гишгүүрээр дээш гарч явахдаа сэтгэл төдий амгалан бус байв. Миледиг өөрөө хуурсан явдал итгэл эвдсэн хэрэгтэй аргагүй төстэй, гэтэл тэр бүсгүй, хамба лам хоёрын хооронд улс төрийн улбаатай нэгэн холбоо бий гэж өөрөө сүрхий харддаг билээ. Түүнээс гадна нөгөө айхтар чадаж орхисон де Вард бол их гэгээнтний шадар хүмүүсийн нэг, тэгээд их гэгээнтэн дайсанд ширүүн догшинтойгоо адил нөхдөдөө үнэнээсээ сайн байдгийг д'Артаньян өөрөө мэдэж байлаа.

д'Артаньян толгой сэгсрээд "Манай тулалдсан тухай де Вард хамба ламтанд лав ярьсан байж таарна, ярьсан бол хамба ламтан тэгээд миний хэн болохыг мэдсэн бол, мэдсэн байж болохтой зүйл, тэгвэл би өөрийгөө бараг яллагдсанд тооцож, болно. Үгүй тийм бол хамба ламтан юунд өнөө хүртэл хүлээсэн юм бэ? Яах юу байхав, Миледи нөгөө өөрт нь их зохидог хуурамч гунигт царайгаа гаргаж ирээд л миний тухай хамба ламтанд гомдол мэдүүлсэн, энэ хэрэг нэмэр дээр нэмэр болсон байж таарна" гэж бодлоо.

"Аз болоход, миний сайн нөхөд доор зогсож байгаа, намайг булааж авах гэж оролдолгүйгээр

лав явуулчихгүй дээ. Гэхдээ де Тревиль гуайншадар цэргүүдийн нэг суман, Францын бүх зэвсэгт хүчнийг захирч байгаа хамба ламтантай тэрслэлтэй биш дээ. Хамбын өмнө Ван эзэн мэдэлгүй, хатан шонгүй юм чинь. д'Артаньян найз минь чи эр зоригтой, нилээд олон сайн чанартай боловч бүсгүйчүүл чамайг хөнөөх нээ" гэж д'Артаньян дотроо бас бодно.

Үүдний өрөөнд ирж, урьсан захидлыг албаны хүнд өгөхдөө д'Артаньян ийм гунигтай дүгнэлт хийлээ. Цаад хүн залууг, хүлээх өрөөнд дагуулж ороод. өөрөө ордны дотоод өрөө рүү орж алга болов.

Хүлээх өрөөнд хамбын торгон цэргээс тав, зургаан хүн байлаа. Жюссакийг шархдуулсан д'Артаньян орж ирснийг хараад тэд нэг хачин ёозгүй инээмсэглэнэ.

Энэ инээмсэглэл д'Артаньянд муу ёр шиг санагдлаа. Гэхдээ манай гаскон залууг айлгах гэдэг амаргүй хэрэг юм, чухам гэвэл тэдний нутгийнхны зан болсон, биеэ их өргөмжлөх сэтгэлийн үүднээс д'Артаньян дотроо болж байгаа юмыг, тэр дундаа дотроо айх маягтай болж байвал, түүнийгээ хүнд гаргаж үзүүлэх дургүй хүн бичээ. Мань хүн эрхэм торгон цэргүүдийн хажуугаар ихэмсэг байртай өнгөрч гараад, ташаа тулж, зогсоод хүлээж байхдаа сүртэй нь аргагүй харагдана.

Нөгөө түрүүчийн хүн эргэж ирээд д'Артаньяныг цуг явья гэлээ. Торгон цэргүүд араас нь юм шивнэлдэж эхлэх шиг мань залууд санагдав.

д'Артаньян нэг гудмаар өнгөрч, том өрөөгөөр дайраад, номын санд орж, бичгийн ширээний ард суугаад юм бичиж байгаа нэг хүний өмнө очлоо.

Албаны хүн түүнийг оруулж ирээд, ганц ч үг дуугаралгүй яваад өгсөнд д'Артаньян зогсоод нөгөө хүнийг ажиглаж байв.

Эхлээд өмнө нь шүүгч хүн байх шиг санагдсан, гэтэл ширээний цаана суугаа хүн урт богино мөртэй юм бичиж, чухам гэвэл засаж, үе, цохилтыг нь хурууныхаа үеэр тоолж байхыг даруй ажаад, уран шүлэгчийн өмнө ирснээ мэдлээ. Минутын дараа уран шүлэгч гар бичмэлээ хаахад, хавтсан дээр нь

"Мирам, таван бүлэгтэй эмгэнэлт жүжиг" гэсэн байв. Тэр хүнийг дээшээ харахад, хамба ламтан байхыг нь д'Артаньян танилаа.

XL. АЙМААР ХИЙ ҮЗЭГДЭЛ

Хамба лам гар бичмэл дээрээ тохойлдож, шанаагаа тулаад залуугийн өөдөөс хэсэг зуур ажиглан харлаа. Ришелье хамбаас өөр ийм нэвт шувт харсан айхгар хурц нүдтэй хүн үгүй билээ. д'Артаньяны хамаг бие хачин хүйт даагаад явчих шиг боллоо.

Гэхдээ д'Артаньян малгайгаа гартаа барьсаар хэтэрхий бардам биш, хэт номхон биш, төв аятайхан зогсоод, их гэгээнтний ярьж соёрхохыг хүлээж байв.

Хамба ам нээж эрхмээ, Беарн нутгаас ирсэн д" Артаньян гэж та юу? гэлээ.

-Тиймээ гэгээнтэн гэж манай залуу өчив.

-Тарба, тэр хавийн нутгаар д'Артаньяныхан гэж хэд хэдэн айл бий. Та чухам аль д'Артаньяны удам байна даа? гэж хамба асуув.

-Ван эзний эцэг, их Генрих вантай цуг шашны төлөө дайнд оролцож явсан тэр д'Артаньяны хүү юмаа.

-Тийм байхаа, тэгвэл долоо найман сарын өмнө нутгаасаа гарч нийслэл хотноо аз жаргал эрэхээр ирсэн хүн та байх нээ?

-Тиймээ, гэгээнтэн,

-Та Менг хотоор дайрч гарсан, тэнд өөрт чинь нэг юм учирсан чухам юу болсныг санахгүй байна Ер нь жаахан будлиан болсон дог.

-Их гэгээнтэн, тэнд намайг. . гэж д'Артаньяныг ярих гэтэл, хамба үгийг нь таслаад, тэр явдлыг ярих гэж байгаа хүнээс өөрөөс нь дооргүй мэдэж байгаа гэсэн байртай инээмсэглээд,

-Зүгээр, зүгээр яриад юу хийхэв. Де Тревиль гуайд таныг танилцуулж өгөх захидал өөрөө авч явсан байх, тийм биз? гэв.

-Тиймээ гэгээнтэн, тэгээд яг тэр Менгэд болсон гайтай. явдлын үеэр...

Хамба лам тосч аваад,

-Захидал алга болчихсон. Тиймээ, би үүнийг дуулсан. Гэвч де Тревиль гуай хүний байрыг нэг хараад л таньдаг хашир хүн болохоор цаашдаа шадар цэргийн эгнээнд орж болох горьдлого танд төрүүлээд таныг өөрийнхөө хүргэн Дезэсарын торгон цэргийн суманд оруулсан биз гэв.

-Гэгээнтэн та цөмийг сайн дуулжээ гэж д'Артаньян. дуугарлаа.

-Тэр цагаас эхлээд, танд учирсан адал явдал гэж олон, та өөр газарт байвал зохистой нэгэн өдөр Картезианскийн сүмийн цаана зугаалж явсан, хожим та нөхдийнхөө хамт форжийн аршаан руу явсан, нөхөд чинь замд саатаад, та цаашаа явсан. Тэр ч яахав ойлгомжтой байна,

тэнд Англи Улсад очих хэрэг байсан биз.

Гайхаж хэлмэгдсэн д'Артаньян ам нээж, гэгээнтэн, би тийшээ ... гэтэл, хамба залгаж аваад:

-Виндзорын цэцэрлэгт ан хийхээр юм уу. өөр нэг тийшээ л очоо биз, энэ хэнд хамаа. байх билээ. Би энэ тухай мэдэх үүрэгтэй юм болохоор мэдэж байгаа юм. Ажлын байдлаас болж би юм бүхнийг мэдэх үүрэгтэй байж. Тэндээс буцаж ирээд та нэг өндөр дээд, хатагтайд бараалхсан, тэгээд хатагтайн бэлгийг хадгалж явааг тань харахад аятай байна... гэв.

д'Артаньян, хатны бэлэглэсэн бөгжийг бушуухан атгаж чулуугий нь дотогш эргүүлсэн боловч нэгэнт хожигджээ.

-Энэ хэрэг явдал болсны маргааш өдөр нь Кавуа танайд очоод, таныг ордонд бараалхахыг гуйсан билээ. Та ирж гийгүүлээгүй, алдаа хийсэн гэж хамба лам үгээ үргэлжлүүлнэ.

-Гэгээнтэн минь, би их гэгээнтэн таныг хилэгнүүлсэн юм байх гэж айсан билээ.

Юунд тэр билээ, эрхмээ дарга нарынхаа тушаалыг бусдаас илүү их чадмаг, эр зоригтой биелүүллээ гэж үү? Зөвхөн сайшаал магтаал хүлээхээр юм хийчхээд, уур хилэнгээс айж байх гэдэг! Би үг тушаал дагадаггүй хүнийг цээрлүүлдэг болохоос тань шиг. . . онц чармайн дагаж гүйцэтгэдэг хүнийг цээрлүүлдэггүй билээ ... үүний баталгаа нь таны хойноос бие хүн явуулсан тэр өдрийг санаад үз, мөн тэр оройдоо юу болсныг бас бод ... гэлээ.

Яг тэр орой Бонасье авгайг хулгайлсан юм. . д'Артаньяны бие зарсхийгээд явчихлаа. Хагас цагийн өмнө хөөрхий бүсгүйг албаар аваад алга болсон тэр хүчинд авган, өөрийн нь хажуугаар өнгөрч явсныг саналаа.

Хамба лам яриагаа үргэлжлүүлж за тэгээд, хэсэг зуур таны тухай юм дуулдаагүй болохоор, юу хийж байгаагий чинь би сонирхох гэсэн юм. Далимд нь хэлчхэд, та зарим талаар надад ач санах ёстой юм, юу гэвэл тухай бүр таныг өршөөж өнгөрүүлсээр байсныг өөрөө харж байгаа биз дээ? гэв. д'Артаньян хүндэтгэн мэхэсхийв.

Үүний шалтгаан нь зүй ёсны шударга сэтгэлээс гадна, өөрийн чинь тухайд би тодорхой төлөвлөгөө хийсэнд байгаа юм гэж хамбыг хэлэхэд д'Артаньян улам ч гайхчхав

-Энэ төлөвлөгөөг өөрий чинь анх ирээч гэсэн тэр өдөр танд дуулгах гэтэл та өөрөө ирээгүй билээ. Аз болоход ингэж хожигдсоноор саад хор болсон юмгүй, та тэр тухай өнөөдөр дуулах боллоо. д'Артаньян гуай та энд, миний өөдөөс хараад суу, та миний яриаг зогсож сонсохооргүй, шудраг журамт тайж хүн билээ.

Ингээд хамба ламтан залууд суух сандал зааж өгөв. Гэвч, д'Артаньян энэ болж байгаа юманд гайхаж алмайрчихсан болохоор хамба ламтан дахин гуйж байж түүнийг суулгав.

Хамба үгээ залгаж,

-д'Артаньян гуай та эр зоригтой, түүнээсээ илүү чухал нь ухаан авхаалжтай хүн юм. Би ухаантай, зүрхтэй хүнд дуртай юм гэснээ хамба инээмсэглээд, бүү ай, зүрхтэй хүн гэж би эр

зоригтой хүнийг хэлж байгаа юм. Гэлээ гэхдээ та хэдий нас бага. дөнгөж амьдарч эхэлж байгаа хир нь олон хүчирхэг дайсантай болжээ, өөрөө сайн болгоомжтой байхгүй юм болж гэм, тэд таныг хөнөөх болно гэлээ.

-Тийм гэгээнтэн, гай болоход тэд намайг хөнөөж чадахгүй биз, юу гэвэл тэд хүч чадалтайгаас гадна, хүчирхэг өмөг түшигтэй, гэтэл би цор ганцаараа хүн юм гэж манай залуу хариулав.

-Энэ үнэн, гэхдээ та хэдий ганцаар боловч тун их юм хийж амжаад байна, цаашид ч их юм хийнэ гэдэгт би эргэлзэхгүй байна. Гэхдээ миний санахад таны шилж авсан энэ элдэв юм учирч болох осолтой зам дээр, хэн нэг хүн өөрий чинь удирдаж байвал зүйтэй санагдах юм.

Би эндүүрээгүйсэн бол Парис хотноо та хэргэм зэрэг олох, дээгүүр санаа өвөртөлж ирсэн шүү дээ.

-Гэгээнтэн минь, миний нас ер нь хоосон горьдлого итгэл агуулж явдаг нас шүү дээ гэж д'Артаньян хэлэв.

-Хоосон горьдох гэдэг тэнэг улсын зан билээ эрхмээ, гэтэл та өөрөө ухаантан хүн. Та дуулж бай, манай торгон цэрэгт дэслэгч цолтой алба хааж энэ аян дайны дараа суман дарга бол гэвэл танд ямар санагдана? гэв.

-Өө, гэгээнтэн минь!

-Та зөвшөөрч байгаа, тийм биз? д'Артаньян зовж хулгасхийн,

-Их гэгээнтэн минь... гэтэл хамба лам гайхан дуу алдаж:

-Юу, та дургүйцэж байна гэж үү? гэлээ.

-Гэгээнтэн минь, би их эзэнтний торгон цэрэгт алба хааж байна, тэгээд надад түүндээ гомдож дургүйцэх шалтаг алга байна.

Хамба үүнд маргаж,

-Үгүй миний санахад манай торгон цэрэг ч мөн ялгаагүй их эзэнтний торгон цэрэг юм. Францын цэргийн аль ч ангид та алба хаалаа гэсэн ялгаагүй Ван эзэнд алба хааж байгаа хэрэг гэв.

Гэгээнтэн та, миний үгийг буруу ойлгожээ.

-Танд шалтаг хэрэгтэй байна, тийм биз? Ойлгож байна. Яахав, танд тийм шалтаг байна шүү дээ. Цол тушаал нэмэгдэж байна, аян дайн эхлэх болж байна, мөн танд ч гэсэн, өөр хэнд ч гэсэн таатай аятай байж таарах миний саяны үг байлаа тэрчлэн, найдвартай өмөг түшиг бас танд хэрэгтэй. Юү гэвэл д'Артаньян та өдөр шөнийн бүх цагаа ван эзний албанд зориулдаггүй юм байна, таны нэрэн дээр сүрхий гомдол ирснийг та бас мэдэхэд илүүдэхгүй бий гэв.

д'Артаньяны царай улайв.

Хамба нэг бөөн цаасан дээр гараа тавиад, миний энд танд хамаатай бөөн хэрэг байна. Гэвч үүнийг уншиж үзэхээсээ өмнө би өөртэй чинь уулзаж ярилцъя гэсэн юм.

Таныг би шийдмэг хүн гэж мэдэж байна. Таны алба ажлыг зохих ёсоор залж өгвөл танд хор болохын оронд ач тус болох билээ. За ингээд бодож үзээд, шийдвэрлэ л дээ.

-Гэгээнтэн таны уудам сэтгэлийг би биширч байна. Их гэгээнтэн таны оюун чадлын агуу ихийн өмнө би өөрөө өчүүхэн шавьж мэт санагдах юм. Гэхдээ их гэгээнтэн та надад илэн далангүй ярихыг соёрхвол гээд д'Артаньян дуугүй болтол,

-Ярь, ярь.

-Итгэе, их гэгээнтэн танд үнэнийг өчье, миний хамаг танил нөхөд цөм ван эзний шадар цэрэг, торгон цэргүүд дотор байдаг юм. Гэтэл ямар нэг үл ойлгогдох гайгаар, миний хамаг өшт муу улс цөм их гэгээнтэн танд алба хаадаг юм байна. Тэхлээр гэгээнтэн таны хэлснийг зөвшөөрвөл. намайг энд ч муугаар угтаж, нөхөд ч намайг хялайж харах билээ гэв.

-Арай таны бие өргөмжлөх сэтгэл чинь дэндэж орхиод, өөрийн чинь үнэ цэнээс бага юм өгье гэж байна гэж та бодоогүй биз? гэж хамба басамжлангуй инээмсэглэв.

Гэгээнтэн та, миний хирээс зуу илүү сайхан юм хэлж байна, харин ч би таны өршөөлийг хүртэх олигтой юм хийгээгүй гэж өөрийгөө үзэж байна. Мөдхөн Ларошель хотыг бүсэлж байлдах ажил эхлэх гэж байна гэгээнтэн. Их гэгээнтэн таны нүдний өмнө би алба хаах болно. Хэрэв би тэр бүслэлтийн үед таны анхааралд өртөхөөр байлдаж чадвал, тэр цагт, та таалж надад өршөөл үзүүлэх гэвэл, түүнийг зөвтгөх нэг гавьяа би байгуулсан байх юм. Цагийн юм цагтаа байдаг билээ, гэгээнтэн. Ирээдүйд би хүч чадлаа танд бүрэн өгч болохоор тийм эрх олж болох юм, гэтэл одоо энэ чинь танд биеэ худалдчихсан юм шиг харагдах биз ээ гэв.

-Ер нь та манайд алба хаахаас татгалзаж байх шив эрхмээ, за яахав, чөлөөтэй хэвээрээ явж, сэтгэлд аятай, аягүй юмаа дотроо хадгалж яв гэж хамба дургүйцсэн янзтай хэлэхэд, цаанаа бол хүндэтгэсэн байр илрэх шиг оолов.

-Их гэгээнтэн... гэтэл, хамба ламтан үгийг нь таслан:

-За боллоо, боллоо, танд ой уурлаагүй, харин бид нөхдөө өмгөөлж, хайр шан хүртээх ёстой, гэтэл өстөнд юу ч хийж өгөх албагүй шүү дээ. Гэлээ ч танд би нэг зөвлөгөө өгье. д'Артаньян гуай та өнөөдрөөс эхлээд сэрэмжилж яв, энэ минутаас эхлээд би таныг харж хамгаалахаа болихоор, таны амийг хэн ч сохор зоосны төдийд бодохгүй шүү гэв.

д'Артаньян үүнд, өөртөө итгэсэн төв байдлаар,

-Би хичээж үзье, гэгээнтэн гэв.

-Хожим нэгэн цагт танд гай зовлон тохиолдвол, би таны хойноос хүн явуулж, энэ гай зовлонг урьдаас сэргийлэхийн тулд болох бүхнийг хийсэн гэдгийг санаарай гэж Ришелье учиртай гэгч

дуугарлаа.

Д'Артаньян цээжээ дарж, мэхийгээд, цаашдаа өөрт минь юу ч учирлаа гэсэн, их гэгээнтэн таны энэ минутад хүргэсэн ачийг би үүрд санаж явна гэж хариулав.

За ингээд, д'Артаньян гуай таны хэлсэнчлэн бид аян дайны дараа уулзъя. Би таны хойноос нүд тавьж байх болно... Юу гэвэл би мөн тэнд байх болно гээд хамба өөрийнхөө өмсөх сайхан хуяг дуулгыг д'Артаньянд зааж харуулав. Бид буцаад ирсэн хойно тантай тооцоогоо бодно биз гэлээ.

д'Артаньян дуу алдаж, их гэгээнтэн, уур хилэнгийнхээ хүндийг надаас авч хайрла. Шударга ёсыг бодож, намайг шударга журамт хүний ёсоор явдгийг өөрөө үзэж үнэмшвэл, өршөөж хайрлаа гэв.

-Залуу минь, өнөөдөр өөрт чинь хэлсэн үгээ дахин хэлэх завшаан надад тохиолдвол дахиад хэлнэ гэдгийг амлая, гэж Ришелье дуугарав.

Ришельегийн сүүлчийн үгэнд, хачин үл итгэх байр илт, энэ нь урдаас сануулсан үг болохоор, шууд ил занаснаас илүү д'Артаньяныг айлгав.

Ингэхлээр, өөрт нь тулж ирсэн нэг аюулаас хамба лам түүнийг аврах гэсэн байжээ. Манай залуу үг хэлэх санаатай ам нээх гэтэл хамба лам ихэмсэг байртай гараа дохиж, бараалхах цаг дууссаныг мэдэгдэв.

д'Артаньян гарлаа, гэвч босго алхах үед золтой л эр зориг нь шантарсангүй, жаахан л илүү хулчийсан бол буцаад очих байв. Гэтэл Атосын эршүүд, төв царай гэнэт залуугийн нүдэнд харагдах шиг болов, хэрвээ д'Артаньян өөрөө хамба ламтай эвлэрч холбоотон болвол Атос түүнтэй гар барихаас татгалзаж нөхөрлөхөө болих билээ.

Зөвхөн үүнээс айгаад л манай залуу биеэ барилаа. Жинхэнэ шударга сайхан зан авир гэдэг орчиндоо ийм их нөлөөтэй байдаг юм.

д'Артаньян нөгөө ирсэн шатаараа буутал, хаалган дээр Атос дөрвөн буучинтай хамт түүний ирэхийг хүлээж сэтгэл зовж эхэлсэн байлаа.

д'Артаньян даруй тэдний сэтгэлийг тайтгарууллаа, тэгээд Планше, бусад үүд сахисан нөхдөл очиж, эзнээ эгэн мэнд буцаж ирсэн, хаалга сахих явдалгүй гэдгийг дуулгахаар гүйв.

Дөрвөн нөхөд Атосынд буцаж ирсэн хойно Портос, Арамис хоёр энэ хачин уулзалтын учир шалтгааныг асуувал д'Артаньян өөрийн нь хамба лам торгон цэрэгт дэслэгч цолтой алба хаа гэхэд нь татгалзсанаа ярив.

Арамис. Портос хоёр нэгэн двугаар,

-Зөв! сайн байна гэж хашгирав.

Атос гүн бодол болоод, юу ч хариулсангүй. Гэвч хоёулхнаа үлдсэн хойно, нөхөртөө ингэж

ХЭЛЛЭЭ.

-д'Артаньян та хийж таарах юмыг л хийж, гэхдээ буруутсан байж болох юмаа гэе.

д'Артаньян санаа алдлаа. Юу гэвэл энэ үг, түүний дотроо их аюулд тулгарч байна гэж санаж байсан бодолтой нийцэж байлаа.

Маргааш өдөр нь явах бэлтгэл хийсээр өнгөрлөө. Д'Артаньян салах ёс гүйцэтгэхээр де Тревиль гуайнд очив. Тэр үед, шадар цэргүүд торгон цэрэг хоёр салаад удахгүй юм гэж цөм бодож байлаа, юу гэвэл, ван эзэн Парламентад сууж хуралдаад, маргааш өглөө нь гарахаар зэхэж байсан юм. Тийм болохоор де Тревиль гуай ердөө л д'Артаньянд өөрөөр нь туслуулмаар юм бий, үгүйг асуувал, цаадах нь хэрэгтэй бүх юмаа олсон гэж бардам хариулав.

Шөнөдөө Дезэссарын сумагийн торгон цэргүүд, де Тревиль гуайн сумангийн шадар цэрэгтэй нийллээ, тэд хоорондоо ижил дасал болсон улс билээ. Эд одоо бурхны авралаар дахин уулзах горьдлоготой салж байгаа болохоор тэр шөнөө их наргиантай өнгөрөөсөн нь мэдээж хэрэг. Юу гэвэл ийм үед зөвхөн сэтгэлээ бүрэн тэнийж наргиснаар, сэтгэлийн шаналгааныг мартагнаж болдог юм.

Өглөө анхны бүрээ дуугармагц сайн нөхөд салж, шадар цэргүүд де Тревиль гуайн сумангийн хуаран руу, торгон цэргүүд Дезэссар гуайн хуаран руу гүйлдэв. Хоёр даамал төдхөн суман, сумангаа аваад, ван эзэн цэргийн үзлэг хийж байсан Лувр ордон руу авч очлоо.

Ван эзний царай гунигтай, өвчтэй байх шиг харагдаж царайны нь ердийн ихэмсэг дүрийг жаал даруу зөөлөн болгосон байв. Нээрээ ч, үүний түрүүн Парламентын хуралдааны үед вангийн бие халуурсан юм байж. Гэлээ ч ван, тэр оройдоо явна гэсэн шийдвэрээ өөрчилсөнгүй, хүмүүс хэдий хориглож ядсан боловч, хүндэрч байгаа өвчнөө зоригоор дийлэхийг горьдож, цэргийн үзлэг хийнэ гэжээ.

Үзлэгийн дараа, дан торгон цэрэг аянд мордлоо. Шадар цэргүүд аян дайнд зөвхөн ван эзнийг дагаж мордох ёстой билээ. Энэ нь Портост гоё сайхан зэр зэвсэг сэлттэйгээ Баавгайн гудамжнаа очиж үзэгдэх завшаан олголоо.

Портосыг шинэ хувцас өмсч, сайхан морь уначхаад цонхны нь доогуур өнгөрч явахад прокурорын гэргий түүнийг харав. Портостой салах ёс хийлгүй явуулчихмааргүй сайн болохоороо авгай, түүнийг мориноосоо бугаад орж ир гэж дохив.

Портос үнэхээр сүртэй сайхан, хуяг нь гялалзаж, давируул нь хангинан, урт илд хөлийг гуядна. Энэ удаа түүний сүр жавхаатайг үзээд, бичээч нарт инээлдэх санаа ч төрсөнгүй.

Шадар цэргийг Кокнар гуайн өрөөнд орууллаа. Садангийн хүний хамаг хувцас цоо шинэ, гял цал бууж байхыг үзээд прокурорын жижиг хонин нүдэнд уур хорсол дүрсхийв. Гэвч энэ аян дайныг хүн бүхэн ширүүн хэцүү болно гэлцэх тул Портосыг алагдаж магад гэж дотроо найдаж прокурорын санаа жаахан тайвширна.

Кокнар гуайнд Портос хэдэн эелдэг үг хэлээд гарахад, Кокнар гуай мөн хариуд нь

хийморьтой сайн явахыг ерөөлөө. Кокнар авгайн хувьд гэвэл, нулимсаа барьж чадсангүй, гэхдээ авгайн садан төрөлдөө их сайн, тэрнээсээ болж нөхөртэйгөө байнга хэрүүл болдгийг бүгдээрээ мэддэг болохоор үүний нь хэн ч буруугаар ойлгоогүй билээ.

Гэвч жинхэнэ салалт Кокнар авгайн унтлагын өрөөнд болж, үнэнхүү сэтгэл уярам байлаа.

Прокурорын гэргий хайртай хүнийхээ барааг тасартал цонхноосоо гадагшаа сугарч унах шахан цухуйж, алчуураар даллан зогсов. Эд бүгд сэтгэлийн илэрхийллийг Портос өөрөө, иймэрхүү юманд дассан хүний байртай өнгөрүүлж, зөвхөн булан тойрохын үед малгайгаа нэг авч, салахын тэмдэг болгон даллав.

Арамис ч яахав, нэг их урт захидал бичлээ, хэнд бичсэнийг мэдэх хүн ер үгүй. Тэр оройдоо Тур хот руу явах ёстой байсан Кэтти хажуугийн өрөөнд хүлээж байв. Атос, нөгөө испани дарсныхаа сүүлчийн шилтэйг шимэн ууж сууна.

Энэ зуур д'Артаньян, сумантайгаа аль хэдийн аян замд явж байлаа.

Сент Антуан гэдэг эдлэн хүрээд д'Артаньян эргэж Бастили гяндан руу инээмсэглэн харав. Тэгээд зөвхөн Бастили руу харж байсан болохоор бор морь уначхаад, сэжигтэй байрын хоёр хар хүнд өөр рүүгээ хуруугаар зааж байгаа Миледиг харсангүй. Цаад хоёр хүн нь сайн харах гэж даруй жагсаал руу ойртож ирээд, эргэж Миледи рүү асуух байртай харвал, тухайлан тэр хүн мөн гэж Миледи толгой дохив. Одоо өөрийн нь тушаалыг дагаж биелүүлэхэд эндүүрэх осолгүй болсонд үнэмшиж аваад морио давирч цаашаа алга болов.

Үл таних хоёр хүн сумангийн араас дагаж явсаар Сент Антуаны зах хүрч, тэнд таних тэмдэггүй хувцас өмссөн зарцын барьж байсан хоёр эмээлтэй морийг авч унав.

XII. ЛАРОШЕЛЬ ХОТЫГ БҮСЛЭН БАЙЛДСАН НЬ

Ларошель хотыг бүсэлж байлдсан нь XIII Людвиг вангийн төр барьсан үеийн улс төрийн том явдал, хамба ламтны цэрэг дайны том арга хэмжээ болсон юм. Ингэхлээр энэ явдлын тухай хэдэн үг дурдах нь сонин, хэлэлгүй ч болохгүй. Түүнээс гадна бидний ярьж байгаа намтар маань тэр бүслэлтийн зарим зүйлтэй нягт уялдсан тул бид энэ тухай дуугүй өнгөрөхийн эрхгүй билээ.

Тэр бүслэлтийг хийхдээ хамба лам улс төрийн нилээд том зорилт тавьсан юм. Юуны өмнө бид үүнийг дурсаад цаашаа их гэгээнтэнд, үүнээс дооргүй чухаг нөлөөлсөн хувийн чанартай шалтаг руу орж ярья.

IV Генрих вангаас буруу номтонд, өгсөн том хотуудын дотроос бэхлэлттэй нэг нь гэвэл ганц Ларошель үлдээд байлаа. Тэхлээр ард түмний сэтгэлсанаа үймүүлэх, гадаадын аян дайн дэгдээх үр хөрөнгө болсон, буруу номтны тэр эцсийн тулгуурыг устгах явдал чухаг байв.

Зол урагшгүй явсан Испани, Англи, Итали хүмүүс, төрөл бүрийн үндэс угсааны балмад явдалтан, цэргээс халагдсан. элдэв бүлэгт хамаарагдах этгээд цөм анхны уриалгаар л буруу номтны тугийн доор ирж цуглараад нэгэн том нэгдэл болж, түүний салаа мөчир яах ийхийн зуургүй өсөж, бүх европыг хамардаг байв.

Ингэхлээр, бусад хотуудыг унасны дараа онцгой ач холбогдолтой болсон буруу номтны Ларошель хот нэр төр хөөцөлдсөн үймээн самуун дэгдэх явдлын голомт болж байсан юм. Түүнээс гадна Францын вант улс руу Англичуудын цөмрөн орж болох ганц боомт хот Ларошель байсан болохоор; Ларошельд англичуудын орох замыг хааснаар, Жаннад' Арк, де Гиз герцог нарын үйл хэргийг хамба лам туйлд нь хүргэсэн болох юм.

Бассомпьер гэгч, католик шажин, буруу номтны шажин хоёрт зэрэг шүтэгч өөрийнхөө үнэн сүжгээр бол буруу номтон, ариун гэгээний ордны тэргүүлэгч болохоороо католик шажинтан хүн байжээ.

Уул нь Герман гаралтай боловч, сэтгэл санаагаараа Франц болчихсон тэр Бассомпьер гэгч Ларошель хотыг бүсэлж байлдах үед, нэгэн баг цэрэг даргалж, өөр шигээ буруу номтон болох цаад талын тайж нарын тархийг хага буудахдаа

-Хараад байгаарай, бид чинь Ларошелийг байлдан авч тэнэглэх бий гэдэг байжээ.

Тэгээд Бассомпьерийн зөв болж, Ре арлыг их буугаар буудсанаар Ларошелийг авсан явдал, нийтийн горим гэгддэг агсан буруу номтонд дуртай шажнаа шүтэх эрх олгосон ёсыг устгахад хүргэв.

Гэхдээ дээр бид дурдсанчлан, төвөг бүхнийг арилгаж юм бүхнийг амар хялбар болгох гэсэн сайдын энэ түүхэнд орох төлөвлөгөөний хажуугаар дур сэтгэлд автсан эр хүн, жөтөөрхөг өрсөлдөгчийн жижиг эрмэлзэл байсныг судар бичигч хүн эрх биш дурдалтай.

Ришельегийн хатанд дурлаж сайн болсныг цөм мэднэ, энэ нь Ришельед зүгээр улс төрийн

бодлын үүднээс хийсэн явуулга байсан юм уу, аль Австрийн Анна хатан, орчныхоо хүмүүст төрүүлж чаддаг, байсан тэр гүн их хайр сэтгэл мөн байсан эсэхийг бид хэлж мэдэхгүй, юу ч гэсэн энэ туужийн түрүүчийн явдлуудаас үзвэл, Бекинтэм, хамбыг давжгараад, хоёр буюу гурван удаа, ялангуяа алмазан унжуургын хэрэгт, гурван шадар цэргийн үнэнч зүтгэл, д'Артаньяны эр зоригийн ачаар хамбыг сайн даажигнаж чадсан билээ.

Иймд Ришельегийн хувьд, хэргийн чухал нь Францыг дайснаас ангижруулахаас гадна, мөн өрсөлдөгч этгээдээс өшөө авах явдал байв. Тэгээд ч энэ тулалдаанд бидний оронд бүхэл улсын бүтэн цэргийг захирсанхүнд энэ өшөө авалт тохирсон жинтэй, сүртэй сайхан болмоор байсан юм.

Английг ялснаараа, Бекингэмийг ялна, английг дийлж ид хав болсноор, Бекингэмийг дийлж ид хав болсон хэрэг, эцэст нь английн нэрийг европын нүдний өмнө гутааснаар хатны нүдний өмнө Бекингэмийг муучилсан болно гэдгийг Ришелье мэдэж байв.

Бекингэм өөрөө английн нэр алдрыг юунаас ч өндөрт боддог хэдий боловч, мөн хамбатай яг адил юм бодож байжээ. Бекингэм бас л хувийнхаа өшөө авах сэтгэлийг хангах, юу болсон ч Францад элчин сайдын хувиар биш, байлдан дагуулагчийн хувиар буцаж очихыг хичээж байв.

Үүнээс үзэхэд, хайр сэтгэлд автсан хоёр хүний дур зоргоор хоёр хүчирхэг гүрний хооронд явагдсан тэр тулалдаан үнэн чанартаа Австрийн Анна хатны нэг аятайхан харцны төлөө явагджээ.

Эхлээд Бекингэм герцог яллаа. Ерэн хөлөг онгоцтой, хорин мянгаад цэрэгтэйгээр Рэ арал руу гэнэт дайрч ирээд, арал дээр Францын ван эзний төлөөний хүн байсан Туарак гүнгийн цэрэгтэй цус асгаруулан тулалдсаны эцэст арал дээр бууж чадав.

Далимд хэлчхэд Шанталь гүн энэ тулалдаанд алагдаад,, нэг нас зургаансартай жижигхэн охин өнчрүүлэн үлдээжээ.

Тэр охин хожим де Севиньегийн гэргий болж билээ. Де Туарак гүн хуарангийн хамт Сен Мартен гэдэг цайз руу ухарч, Ла Бре боомт гэгч жижиг боомтонд зуугаад хүн үлдээв.

Энэ явдал хамба ламыг яарахад хүргэж, Ван эзэн болон өөрөө нэгэнт шийдсэн Ларошелийн бүслэлтийг удирдахаар Парисаас гарч амжихаасаа өмнө Орлеаний герцогийг анхны тулалдаанууд удирдуулахаар, түрүүлүүлэн явуулаад, мэдэлдээ байгаа бүх цэргийг дайны талбар руу татахыг тушаалаа.

Тэр түрүүний багт манай найз д'Артаньян оролцож явсан юм.

Ван эзэн, Ларошель руу Парламентын хурлын дараа мордохоор зэхэж байсныг бид дурссан билээ. Гэтэл хурлын дараа, зуны дунд сарын хорин гуравны өдөр вангийн бие дахин хүчтэй халуурав. Гэлээ гэхдээ ван мордохоор шийдээд, Парисаас гарсан боловч, замдаа бие нь муудаж Виллерау гэгч газар буужээ.

Ван эзний хаа буусан газар шадар цэрэг мөн буудаг болохоор, ердөө л торгон цэрэгт алба

хаадаг д'Артаньян сайн нөхөд, Портоc, Атос, Арамис гурваасаа юу ч гэсэн л хэсэг зуур холдох боллоо. Өөртөө тулгарч байгаа аюулыг д'Артаньян гадарлаж байсансан бол ийнхүү холдсон нь түүнд аягүйгээр барахгүй, сэтгэлийн шаналгаа болохсон биз.

Ингээд, 1627 оны намрын эхэн сарын арванд д'Артаньян мэнд амар явсаар Ларошелийн дэргэдэх хуаранд ирж буув.

Дайны байдалд гарсан өөрчлөлтгүй. Бекингэм герцог болон түүний англи цэргүүд Ре арлыг эзэгнэсэн хэвээрээ, Сен Мартен гэгч цайз, Ла Бре боомт хоёрыг онцын амжилтгүй боловч дайрч довтолсоор байв. Ларошель хоттой, хоёр гурван хоногийн Ангулемийн герцог хотын орчимд шинэ боомт байгуулснаас болон дайны ажиллагаа эхлээд байв.

Дезэссарын сумангийн торгон цэргүүд францын сүмд байрлав.

Шадар цэрэг болох дээгүүр санаатай д'Артаньян нөхөдтэйгөө их дотно үерхдэггүйг бид мэднэ. Ийм болохоор манай хүн ганцаардаж, элдэв бодолд автах болов.

Элдэв гунигтай юм санаанд орж, Парис хотонд ирээд хоёр жил өнгөрөхөд, өөрөө улс төрийн алив хатгалга явдалд хэд хэд дахин оролцож явлаа, гэхдээ өөрийн нь хувийн байдал алба ажил болон, янаг дурлал, аль алины талаар онцгой урагштай болсонгүй.

Хайр дурлалын тухай яривал үнэхээр сайн болсон ганц бүсгүй нь Бонасье авгай, гэтэл Бонасье авгай үгүй болчихоод юу болсны нь өөрөө өнөө хүртэл мэдэж чадахгүй явна.

Албан тушаалын тухай яривал өөрөө хэдий өчүүхэн хүн боловч, вант улсын дотор ван эзнээс аваад хамаг ихэс дээдсийг чичрүүлдэг хамба ламтантай өстөн болж амжлаа.

Тэр хүн өөрийн нь няц дарчхаж чадах байтал яагаад ч юм тэгсэнгүй. д'Артаньяны хурц ухаанд энэ өршөөнгүй байдал гэрэл гэгээ шиг санагдаж, түүнд сайн сайхан ирээдүй бий гэж горилж байв. Мөн өөрийнхөө бодлоор төдий аюултай боловч, үл ойшоож болохооргүй санагдах өөр нэг хүнтэй бас өстөн боллоо. Тэр өстөн нь Миледи билээ.

Эд бүгдийн оронд, өөрөө хатагтайн өршөөл, талархлыг олж авлаа. Гэтэл тэр цагт хатагтайд талтай болно гэдэг мөрдөгдөж хавчигдах нэг шалтаг болдог байсны дээр, хатны; өмөг түшиг тун ч дорой өмгөөлөл байсны жишээ нь Шале болон, Бонасье авгай нар байв.

Ингэхлээр , энэ хугацаанд үнэхээр олж авсан ганц юм гэвэл тав, зургаан мянган зоосны үнэтэй, өөрийн нь зүүж яваа алмас чулуун бөгж байна. Гэхдээ д'Артаньян дээгүүр санаандаа захирагдаж нэгэн цагт хатны өмнө таних тэмдэг. байлгахаар энэ бөгжөө өөрөө хадгална гэж боддог болохоор энэ үнэт чулуу одоодоо өөрийн нь гишгэчиж яваа замын чулуунаас илүү үнэ цэнэгүй аж.

д'Артаньяны гишиглэж явсан чулууны тухай бид дурсчихлаа, манай хүн дээрх бодолд авгаж, Ангутен тосгон руу явдаг, үзэмжит зөргөөр ганцаараагэлдэрч явлаа. Бодол болж яваад санаснаас хол явчихаж, орой болж байсан хэрэг, гэнэт шингэж байгаа нарны гэрэлд бутны цаанаас цахиур бууны ам гялсхийгээд явчих аятай болов.

д'Артаньян хурц нүдтэй, сэргэг ухаантай хүн болохоор, буу өөрөө энд яваад ирээгүй, түүнийг бариад, бутны цаана нуугдаж байгаа хүн лав нөхөрсөг сэтгэл агуулаагүйг даруй ойлгов. Ингээд манай хүн зугтаах гэж байтал, замын нөгөө талд, том чулууны араас хоёр дахь бууны ам цухуйж байхыг бас харлаа.

Энэ янз нь занга бололтой.

Манай залуу анхны буу руу хартал, өөрийг нь чиглээд доошоо болж байхыг үзэж сэтгэл түгшив. Бууны ам доошилсоор хөдөлгөөнгүй болмогц д'Артаньян дороо ойччихлоо. Энэ үеэр буу тасхийж, толгой дээгүүр нь сум сүнгэнэн өнгөрөх дуулдав.

Түргэлэх хэрэгтэй байлаа. д'Артаньян даруй босон харайхад, нөгөө бууны сум дөнгөж сая хэвтэж байсан газрын чулууг онов.

Өөрийнхөө тухай, ухарсан л гэж хэлүүлэхгүйн тулд дэмий үхэл эрж тэнэг зориг гаргадаг улсын нэг нь д'Артаньян биш юм.

Тэгээд , тухайн учрал дээр эр зориг гэж ярих явдал үгүй, д'Артаньян зүгээр занганд орчихжээ. "Гурав дахь удаа буудвал би өнгөрчээ" гэж д'Артаньян бодлоо.

Тэгээд мань хүн хуарангийн зүгт, нутгийнхаа нэрийг үзүүлье гэсэн шиг хар хурдаараа зугтаалаа.

д'Артаньян хэдий хурдан гүйлээ ч гэсэн, эхэлж буудсан хүн буугаа сумлаж амжаад хоёр дахь удаа буудлаа. Буудахдаа д'Артаньяны бүрх малгайг онож унагатал цэцэн буудлаа... Манай залууд өөр малгай байгаагүй болохоор гүйдэл дундаа малгайгаа шүүрч аваад, амьсгаадаж гүйцсэн, цонхигор царайлан байрандаа гүйж ирээд, хэнд ч юу ч хэлэлгүйгээр сууж бодол бодов.

Саяны явдалд гурван янзын тайлбар байж болох аж.

Нэгдэх , хамгийн үнэмшилтэй нь их эзэнтний торгон цэргээс нэгийг ч гэлээ хорооход баярлах ларошельчүүд отсон байж мэдэх юм. Нэг гэвэл дайсны тоо нэгээр хорогдоно, хоёр гэвэл алагдсан дайсны өвөрт дүүрэн мөнгөтэй хэтэвч олдож магад гэжбодно биз.

д'Артаньян малгайгаа авч суманд оногдсон нүхийг нарийвчилж үзээд, толгой сэгсэрлээ. Сум нь цэрэг улсын барьдаг урт цахиур бууных биш, богинохон ангийн бууных байлаа. Цэцэн буудахыг нь үзээд, лав энгийн буу биш байх гэдэг санаа д'Артаньянд түрүү төрсөн билээ. Сумны нүхийг үзэхэд өөр болохоор, цэргийн хүн отоогүй байж таарлаа.

Хамба ламтан өөрий нь мартаагүй, эелдэг ааштай байгаагийн гэрч байж мэдэх юм. Нарны өршөөлт гэрлийн ачаар д'Артаньян бууны амыг олж харах үедээ яг л их гэгээнтний удтал хүлцэнгүй байгаад гайхан явсныг уншиж та сонсож байгаа биз.

Тэгснээ д'Артаньян дахин толгой сэгсрэв, өөрөө чигчий хуруугаараа няц дарчиж болох хүмүүсийн тухайдих гэгээнтэн иймэрхүү арга хэрэглэх нь ховор байдагсан.

Үгүй бол, Миледийн өшөө байж бас болно.

Энэ л хамгийн ортой нь байж таарах бий.

д'Артаньян алуурчдын зүс царай, хувцас хунарын санах гэж оролдоод ядлаа.

Өөрөө тэднээс яаран зугтаасан болохоороо юу ч харж амжсангүй.

-Сайн нөхөд минь та нар хаа хаабайна. Та нарыгаа бас их үгүйлж байна даа гэж тэр шивэгнэнэ.

Шөнө д'Артаньян тун тавгүй унтлаа. Нэг хүн ор руу нь сэм ирж, хутгалах гээд байх санагдан гурав, дөрөв дахин давхийж сэрлээ. Гэвч харанхуйд элдвийн хэрэг төвөг болсонгүй, өглөө боллоо.

Хэдий тийм боловч, өнөөдөр бүтээгүй зүйл, маргааш биелж болно. д'Артаньянч үүнийг сайн мэдэж байв.

д'Артаньян тэнгэр муухай байна гэдгээр шалтаглаж өдөржин гэрээс гарсангүй өөрөө өөрийгөө зөвтгөх л гэж тийм шалтаг олсон байжээ.

Хэрэг явдал болсны нөгөөдөр өглөөний есөн цагт жагсаалын бүрээ хангинав. Орлеаны герцог хуаран эргэж явлаа. Торгон цэргүүд яаран зэвсгээ аваад жагсаж д'Артаньян нөхдийнхөө дунд байраа эзлэн зогсов.

Өндөр язгууртан герцог жагсаалын өмнүүр явж өнгөрлөө. Дараа нь ахмад дарга нар цөм түүнтэй мэндлэхээр очсонд торгон цэргийн даамал Дезэссар мөн очив.

Минутын дараа, Дезэссар гуай өөрий нь хуруугаараа занган дуудаж байх шиг д'Артаньянд санагдав. Эндүүрсэн байж магад гэж бодоод, даргынхаа дахин дуудахыг хүлээв. Тэгтэл дарга нь дахин ир гэж дохисонд д'Артаньян жагсаалаасаа гарч, тушаал авахаар очив.

-Одоо өндөр язгуурт герцогтон аюултай даалгавар гүйцэтгэхээр сайн дураараа явах хүмүүс эрэх болно. Таныг бэлэн байг гэж хэлэх гэж би дуудсан юм гэж Дезэссар хэлэв.

Герцогийн өмнө гавьяа байгуулах завшаан тохиолдсонд мань гаскон залуу баярлаад. - Гялайлаа, эрхэм даамлаа гэж хариулав.

Урьд шөнө нь бүслэгдсэн хотынхон гадагшаа дайралт хийж хоёр өдрийн өмнө вангийн цэргүүдийн эзэлж авсан цайзыг булаан эзэлсэн байжээ. Тэхлээр тэр цайз одоо хир зэрэг хамгаалагдаж байгааг мэдэхийн тулд тагнах тун ч аюултай ажилд хүн явуулах гэсэн юм байж.

Үнэхээр ч хэдхэн минутын дараа Орлеаны герцог чанга дуугаар:

-Найдвартай хүнээр даргалуулсан гурав дөрвөн шалмаг хүмүүс хэрэгтэй байна гэж хэлэв.

-Найдвартай хүний тухайд гэвэл, өндөр язгууртан минь тийм хүн манайд бий гэж Дезэссар

гуай д'Артаньяныг зааж хэлээд, шалмаг улсын тухайд гэвэл, таныг үг хэлээд орхихын хамт л явах хүн гараад ирнэ гэв.

д'Артаньян малгайгаа өргөөд, надтай хамт амь дүйсэн хэрэгт явах дуртай дөрвөн хүн та нарын дотор байна уу гэж хашгирав

Өдрийн нь нөхөд торгон цэргүүдээс хоёр хүн даруй урагшаа гарч бас хоёр цэрэг дагаж гараад, тоо гүйцсэнд түрүүлж зориглосон хүмүүсийг гомдоохгүйн тулд, бусдыг нь д'Артаньян авч явахгүй гэв.

Ларошельчүүд цайзыг эзэлж авсныхаа дараа цөлмөж орхиод явсан юм уу, аль цэрэг үлдээсэн эсэх нь мэдэгдэхгүй, үүнийг мэдэхийн тулд уул газрыг их ойроос очиж үзэх хэрэгтэй байв. д'Артаньян дөрвөн нөхдийнхөө хамт ухсан шуудуу дагаж тийшээ чиглэв. Хоёр торгон цэрэг өөртэйнь зэрэгцэн алхаж, хоёр цэрэг хойноос нь дагаж явлаа.

Ухсан нүхний чулуун хаалтын цаагуур нуугдаж явсаар тэд цайзаас зуугаад алхам газар очиж сая зогсов. Энд ирээд д'Артаньян эргэж харвал хоёр цэрэг алга болчихсон байна. Тэр хоёрыг айгаад, ард үлдчихсэн юм байж гэж д'Артаньян бодоод, өөрөө улам цаашаа ойртлоо. Ухмалшуудуу хажуу тийшээ эргэсэн нэг газар очтол д'Артаньян хоёр нөхөртэйгөө цайзад жаран алхам газар ойртсон байлаа. Цайзан дээр хүн ер үзэгдэхгүй хоосон юм шиг санагдана. Зоригт гурав зогсоод, цаашаа явах хэрэг байгаа эсэхийг хоорондоо зөвлөж байтал, гэнэт тэр бөөн чулуун дээр утаа манасхийгээд, д'Артаньян тэдний хажуугаар арваад сум сүнгэнэж туслаа.

Тэд мэдвэл зохих юмаа мэдлээ, цайзыг цэрэг хамгаалж байгаа аж. Энэ аюултай газарт одоо үлдэнэ гэдэг болгоомжгүй дэмий хэрэг болохоор д'Артаньян хоёр нөхдийнхөө хамт эргэж, зугтаалаа гэмээр түргэн ухарч эхэллээ.

Ларошеличүүдийн сумнаас тэднийг хамгаалах сувагт бүр ойртоод ирж явгал нэг торгон цэрэг ойчоод орхилоо, дайсны сум цээжинд нь тусжээ. Нөгөө шархдаагүй эрүүл үлдсэн торгон цэрэг тэр чигээрээ хуаран руу гүйгээд явчихлаа.

д'Артаньян нөхрөө орхиж төвдсөнгүй, өргөөд өөрийнхөндөө хүрэхэд нь туслах санаатай бөхийв. Яг тэр үеэр хоёр буу тасхийж, нэг сум нэгэнт шархадсан торгон цэргийн толгойг цоо цохиод, хоёр дахь нь д'Артаньяныг шүргэн алдаж өнгөрөөд, чулуу онож цойлов.

Мань залуу бушуухан эргэж харлаа. Юу гэвэл, шуудууны булангаар халхлагдсан цайзны зүгээс ингэж буудсан байж таарахгүй билээ. Үгүй болсон хоёр цэрэг санаанд орж, гурван хоногийн өмнө өөрий нь алах гэж оролдсон хүмүүсийг санагдуулсанд, д'Артаньян энэ удаа хэргийн учрыг олохоор шийдэж, нөхрийнхөө хүүрэн дээгүүр үхсэн хүн шиг сунаж ойчив.

Энэ газраас гучаад алхам хиртэй газар байгаа хуучин овоолоотой шорооны цаанаас хоёр хүний толгой даруй цухуйж ирсэн нь нөгөө хоёр цэрэг мөн байв. д'Артаньян эндүүрсэнгүй. Энэ хоёр хүн зөвхөн түүнийг алахын тулд цуг гараад, залуугийн үхсэнийгдайсанд алагдсанд тооцох биз гэж горилжээ.

Гэвч д'Артаньян зөвхөн шархадсан байгаад, хожим тэднийг мэдүүлж болох тул, тэр хоёр ирж үзээд, дутуу үхсэн бол гүйцээхээр дөхөж ирлээ. Аз болоход д'Артаньяны залинд тэд хууртаад, буугаа дахин цэнэглэх гэж санасан ч үгүй.

Тэднийг арван алхам хиртэй ойртож ирэхэд унахдаа илдээ гараасаа салгахгүйг хичээсэнд'Артаньян гэнэт босон харайж, тэдний дэргэд ганц үсрээд хүрлээ.

Хэрэв д'Артаньяныг алалгүйгээр хуарангийн зүг зугтаавал өөрсдийн нь хэлчих болно гэдгийг тэд ойлгоод, юуны өмнө дайсны талд гүйж очёе гэдэг санаа төрөв. Тэдний нэг бууныхаа гол төмрөөс барьж шийдэм шиг хэрэглэн д'Артаньяныг хажуу тийшээ үсрээгүйсэн бол лут цохих дөхлөө. Гэвч хажуу тийшээ ингэж үсэрснээр өөдгүй этгээдэд зам тавиад, өгчихсөнд тэр хүн цайз руу зугтаав. Тэр этгээд ямар зорилготой өөрсөд рүүгээ гүйж явааг Ларошеличүүд мэдэхгүй болохоор гал нээсэнд, урвагч этгээд мөрөө сэт буудуулаад ойчив.

Энэ зуур д'Артаньян илдээ барин хоёр дахь цэрэг рүү дайрвал, төдий удаан тэмцэлдэх хэрэг ч гарсангүй. Өөдгүй этгээд биеэ хамгаалахад сумгүй буунаас өөр юмгүй, торгон цэргийн илд одоо ямар ч аюулгүй бууны гол төмрийг даган гулгаж, алуурчны гуяыг шувт хатгав. Алуурчин ойчоод өгсөнд д'Артаньян даруй илднийхээ үзүүрийг түүний хоолой дээр тавилаа.

-Үгүй, намайг бүү алаач, намайг өршөө өршөөж үз, дарга гуай, би бүгдийг танд ярьж өгнө гэж алуурчин дуу тавина.

-Чиний тэр нууц чинь, чамайг өршөөж болохоор тийм чухаг юм уу гэж манай залуу гараа татаж асуув.

-Та аминдаа хайртай л бол чухаг юм. Үгүй та дөнгөж хорин хоёрхон настай, эр зоригтой сайхан эр юу хүссэндээ хүрч чадах хүн шүү дээ гэв.

-Намайг ал гэж хэн чамд тулгасныг бушуу хэл, муу золиг гэж д'Артаньян тушаав. -Нэг бүсгүй, би түүнийг танихгүй, улс Миледи л гэх юм билээ.

-Тэр бүсгүйг чи мэддэггүй юм бол нэрий нь яаж мэддэг юм бэ?

-Түүнийг таньдаг, миний нөхөр л тэгж нэрлэж байсан тэр эмэгтэй надтай яриагүй, миний нөхөртэй ярилцаж тохирсон тэр ч байтугай, Миледийн захидал хүртэл манай нөхрийн өвөрт бий, миний дуулснаар бол тэр захиа танд их чухаг холбогдолтой юм билээ.

-Энэ булай хэрэгт чи яагаад оролцох болсон юм бэ?

-Манай нөхөр, таныг алахад туслалцаач гэж гуйхаар л би зөвшөөрсөн юм. -Энэ "ариун" хэргийн төлөө та нарт Миледи хичнээн зоос төлсөн юм дээ. -Зуун том алтан зоос. Манай залуу үүнд инээд алдаад.

-Үгүй ерөө, миний амийг Миледи өндөр үнэлж байгаа бололтой дог. Зуун том алтан зоос. Та хоёр шиг муусайн новшнуудад зуун алтан зоос гэдэг бүхэл бүтэн хөрөнгө байна. Чиний юунд зөвшөөрсөн учрыг би одоо ойлгож байна нэг жаахан юм хийлгээд чиний амийг уучлахад

бэлэн байна гэлээ.

Хэрэг явдал дуусаагүйг үзээд нөгөө цэрэг зовсон байртай.

-Юу хийлгэх нь вэ? гэж асуув.

-Нөхрийнхөө өвөрт байгаа захидлыг чи надад олж ирэх ёстой.

-Үгүй энэ чинь намайг алах өөр нэг арга байна шүү дээ.

-Цайзны зүгээс буудаад байхад би яаж тэр захидлыг олж ирэх вэ?

-Тэглээ ч гэсэн чи энэ хэрэгт зориглож үзэхээс өөр замгүй дээ, үгүй бол чи миний гарт үхнэ гэдгийг амлая.

-Өршөө, намайг өрөвдөж үз, эрхэм минь, өөрийнхөө хайртай сайн таньдаг тэр залуу бүсгүйг санаж намайг өрөвд! Та тэр бүсгүйг үхсэн гэж санадаг байх, үгүй шүү, тэр бүсгүй амьд бий гэж хашгираад, өөдгүй этгээд сөхөрснөө, цус алдаж тамирдан гараараа газар туллаа.

-Миний хайртай сайн залуу бүсгүй байдаг, түүнийг би үхсэнд тооцдог гэж чи хаанаас мэдсэн юм бэ? гэж д'Артаньян асуув.

-Манай нөхрийн өвөрт байгаа тэр захидлаас мэдсэн гэв. д'Артаньян үүнд,

-Тэхлээр тэр захидлыг би заавал авах ёстойг чи өөрөө ойлгож байгаа биз. За бушуул, хулчганаад юу хийхэв. Үгүй бол чам шиг новшийн цусаар илдээ дахин бузарлах хичнээн дургүй байгаа ч гэлээ, би шударга хүний хувьд хэлэхэд чамайг...

Ингэж хэлээд, д'Артаньян тун аймаар хөдөлсөнд, шархадсан этгээд өндийв.

Цаадах нь айсандаа жаал зориг орж,

-Байзаарай, байзаарай, би явлаа... одоо явлаа гэж хашгирав.

д'Артаньян тэр цэргийн бууг хурааж аваад, цаашаа гаргаж, илднийхээ үзүүрээр, хамсаатан этгээдийн нь зүг түлхэв.

Тэр золгүй амьтан ардаа урт цусан мөр цувуулсаар, үхэлтэй тулгарч яваадаа айжзэвхийрэн, хориод алхмын газар хэвтэж байгаа хуйвалдагч этгээдийнхээ бие рүү үзэгдэлгүй мөлхөж очихыг хичээж яваагий нь харахад хэцүү байв.

Түүний хүйтэн хөлс даасан царайд, айж хэлмэгдсэн байдал даанч илт харагдах тул д'Артаньян түүнийг өрөвдлөө.

-д'Артаньян цэрэг рүү жигшиж хараад за, яахав, эр зоригтой хүн, чам шиг аймхай амьтан хоёрынъялгааг би чамд үзүүлж өгье. Чи эндээ үлд, би өөрөө очье гэв.

д'Артаньян эргэн тойрноо сайн харж, дайсны байрыг алдалгүй ажиглан, газрын өөг сайн мэдэж түргэн алхсаар хоёр дахь цэрэг дээр хүрч ирлээ.

Зорьсондоо хүрэх хоёр арга байв. Шархтныг доор нь нэгжиж үзэх, үгүй бол биеийг нь халх болгож үүрээд, шуудуутайдалд газар аваачаад нэгжиж бас болох байлаа.

д'Артаньян хоёр дахь аргаа зөвд үзээд, алуурчны биеийг үүртэл яг энэ үеэр дайсан гал нээв.

Гурван сум биед тусах бүдэг чимээ гарч аяархан түлхээд авах шиг болоод шархтай хүн сүүлчийн удаа хашгирч, биеэ хураан татганахад д'Артаньян эд бүгдийг үзээд өөрий нь алах гэж байсан хүн одоо аминдаа орсныг мэдэв.

д'Артаньян сувагт буцаж ирээд хүүрийг, хүүр шиг зэвхийрсэн царайтай шархадсан цэргийн хажууд хаяв.

Ингээд даруй нэгжиж гарсанд, үхсэн хүний өв хөрөнгө нь бичиг цаасны савхин сав нөгөө шагналд авсан мөнгөний хагас нь байгаа бололтой хэтэвч, мөрийтэй тоглоомын шоо хаях аяга, хаялаг шоо иймэрхүү л юм байв.

Шоо хаядаг аяга, шоо хоёрыг унасан газарт нь орхиод, хэтэвчийг шархадсан цэрэг рүү хаяж, өөрөө цаас бичигний савыг яаран уудлав.

Хэдэн хэрэггүй цаасны хоорондоос олж авах гэж сая амь дүйсэн захидлаа олж авав.

"Та тэр бүсгүйн мөрийг алдчихсан, тэр одоо сүмд, ямар ч аюулгүй газарт байна, та яасан ч түүнийг тийш нь оруулж болохгүй байсан юм, юу ч болсон эрэгтэйгий нь одоо алдахгүйг хичээж үз. Миний урт гартайг та мэднэ, эс бүтээвэл, надаас авсан зүүн алтан зоосоо та тун өндөр үнээр төлөх болно пүү" гэжээ.

Гарын үсэг үгүй байлаа, гэвч захидлыг Миледи бичсэнд д'Артаньян огт эргэлзсэнгүй. Тэхлээр захидлыг хэргийн баримт болгож хадгалаад, шуудууны хаалтан доор, шархтай цэргийгбайцааж гарав. Шархтай хүн, сая алагдсан нөхрийнхөө хамт, Парис хотоос Лавильетийн харуулыг дайран гарах нэг залуу бүсгүйг хулгайлахаар зөвшөөрсөн боловч, гуанзанд сууж байж арван минут хожигдоод, сүйх тэргийг нь өнгөрөөчихсөн үнэнээ ярив.

д'Артаньяны сэтгэл түгшиж,

-Та нар тэгээд тэр бүсгүйг яах ёстой байсан юм бэ? гэж асуув.

-Тэр бүсгүйг бидВангийн талбай дахь харшид аваачих ёстой байсан юм, гэж шархадсан хүн өчлөө.

-Тэгнэ, тэр яг л тийм байж таараа, Милединд шууд аваачих байж шүү гэж д'Артаньян шивэгнэнэ.

д'Артаньяныг сайн байдаг хүн бүхэнтэй нь хамт хөнөөх гэж ингэтэл мэрийхийг үзвэл Миледийн өшөө авах шунал хичнээн айхтар байгааг, мөн эд бүгдийгмэдэж чадсаныг үзвэл,

ордны алив хэргийг тун нарийн мэдэж байдгийг нь ойлгоод, залуугийн бие зарсхийв. Эд бүгдийг Миледи хамба ламтнаас олж мэддэг бололтой.

Гэвч энэ бүх гунигт бодлын дунд гэнэт нэг санаа түүнд төрж гүнээ баярлуулав. Хөөрхий Бонасье авгай үнэнч сайныхаа төлөө зовж суусан шоронг хатан эцсийн эцэст эрж олоод шоронгоос чөлөөлснийг ойлгов. Бонасье авгайгаас авсан захидал, Шаногийн зам дээр хий үзэгдэл мэт гялсхийгээд өнгөрсөн уулзалтын учир одоо ойлгомжтой боллоо.

Нэвтэрч, үл болох сүм хийд гэж үгүй болохоор, Атосын зөгнөж байсанчлан залуу бүсгүйг эрж олох боломж бий боллоо.

Энэ санаа д'Артаньяны сэтгэлийг бүрмөсөн амраасанд, царай нүүрний хувиралтыг нүд салгалгүй ширтэж суусан шархтай цэрэг өөд эргэж хараад, гараа сунгав,

-За явья, би чамайг энд хаях дургүй байна. Миний гарыг түш, хуаран руугаа эргэж харья гэв.

Шархадсан цэрэг ийм өгөөмөр сайхан сэтгэлд итгэж ядан явья, харин намайг дүүжлүүлэх санаатай авч явах гэж байгаа юм биш биз?" гэж асуув.

д'Артаньян үүнд, би чамд нэгэнт ам өгсөн, одоо дахин амийг чинь уучилъя гэлээ.

Шархадсан хүн сөхөрч унаад, амь аварсан хүнийхээ хөлийг үнсэж эхэллээ. Гэвч дайсанд өдий ойрхон газар байгаад байх хүсэл огт үгүй байсан д'Артаньян ингэж талархахыг нь даруй зогсоов.

Цайзын зүгээс гал нээмэгц хуарандаа буцаж ирсэн торгон цэрэг дөрвөн нөхдөө амь үрэгдсэн гэжээ. Иймээс Д'Артаньяныг эсэн мэнд буцаж ирснийг үзээд хорооныхон их гайхаж, баярлав.

Хамт ирсэн цэргийнхээ илдээр хатгуулсан шархыг мань залуу дайсан гарч дайрсан тухай худлаа юм зохиож тайлбарлав. Мөн хоёр дахь цэргийн үхэл, өөрсдөдөө тулгарсан аюулын тухай зохиож ярив. Энэ яриа д'Артаньяны алдрыг өндөр бадруулж, энэ тулалдааны тухай бүх цэргийн дотор өдөржингөө яриа боллоо. Орлеаны герцог өөрөө д'Артаньянд хүнээр дамжуулж баяр хүргэлээ.

Сайн үйл бүхэн хариу шагнал агуулсан байдаг юм. д'Артаньяны үйлдсэн сайн үйлийн үр дүн гэвэл, манай хүн сэтгэл санааны түгшүүрт байдлаасаа салж амрав. Хоёр дайсны нэг алагдаж, нөгөө нь түүнд туйлгүй үнэнч сайн болсон хойно сэтгэл бүрэн амарч болно гэж д'Артаньян үзэж байлаа.

Ингэж сэтгэл амарсан нь гагцхүү Миледиг д'Артаньян хараахан сайн мэддэггүйн гэрч байжээ.

ХЛЛ. АНЖУЙН ДАРС

Ван эзний нилээд хүнд өвчилсөн тухай мэдээ дуулдсаны дараа түүний бие сайжирч байгаа тухай цуу хуаранд тархаж эхлэв. Бүслэлтэд өөрөө оролцох гэж Ван эзэн их яарч байсан болохоор, морь унаж чадахтай болмогцоо наашаа хөдөлнө гэж улс ярилцана.

Энэ зуур, өнөө маргаашийн дотор цэргийн жанжин тушаалаасаа халагдаж, энэ цолыг хоорондоо булаацалдаж байсан Ангулемийн герцог, Бассомпьер юм уу Шомбергийн аль нэгийг томилогдоно гэж мэдэж байсан Орлеаны герцог хийсэн юмгүй цаг үрж, зөвхөн дайсны хүчийг сорихоос биш Ре арал дээрээс англи цэргүүдийг хөөх ганц ч олигтой тулалдаан явуулж зүрхлэхгүй байв. Францчууд, Ларошелийг бүсэлж байхад, англи цэрэг Сен Мартен цайз, Ла Бре боомтыг бүсэлж дайрсаар байсан юм.

д * Артаньяны хувьд гэвэл сэтгэл амарсны ньбид дурдсан, ер нь аюул өнгөрөөд орхихын хамт бид аюул гэж үгүй шиг санадаг шүү дээ. Одоо д'Артаньянд сэтгэл зовох ганц юм гэвэл нөхдөөсөө ер хэл захиа авахгүй байлаа.

Гэтэл намрын дунд сарын нэг өглөө, Виллерагаас авсан нэг ийм захидлыг үзсэний дараа бүх юмны учир олдох шиг боллоо.

"д'Артаньян гуай,

Атос, Портос, Арамис гуай нар манайд жаахан найр хийж сайхан наргисан, гэхдээ тэд нар дэндүү их үймээн дэгдээсэнд эндхийн дарга их ширүүн хүн болохоор тэднийг хэдэн хоногтоо хорьж шийтгэлээ. Гэсэн хэдий боловч тэдний өгсөн тушаалыг би дагаж, тэдэнд их таалагдсан манай анжуй дарснаас арван хоёр шилийг танд явууллаа, тэд энэ дарсыгөөрсдийнхөө эрүүл мэндийн төлөө ууна уу гэж танаас хүсэж байна

Эрхэм таныг хүндэтгэн, доор мэхийн ёслогч шадар цэргүүдийн буудлын газрын эзэн Годо" гэжээ.

-Арайхийж нэг сураг гарлаа.

Ингэхлээр тэднийгээ би уйтгар гунигтай цагтаа санаж байдаг шиг, тэд маань наргиж цэнгэх цагтаа намайг санадаг юм байна. Тэднийхээ эрүүл мэндийн төлөө би уулгүй яахав дуртайяа ууна. Тэхдээ харин ганцаараа уухгүй гэж д'Артаньян дуу алдав.

Ингээд д'Артаньян нөхөд дотроосоо илүү сайн танилцсан хоёр торгон цэргийг виллеруагаас сайхан анжуй дарс хувааж уулцахгүй юу гэж урихаар явлаа. Гэтэл хоёр торгон цэргийн нэг нь тэр оройдоо нэг айлын үдэшлэгт уригдсан нөгөө нь маргааш оройдоо уригдсан байж таараад, нөгөөдөр нь наргихаар шийдэв.

д'Артаньян гэртээ хүрч ирээд арван хоёр шил дарсаа цөмийг торгон цэргийн нүүдлийн гал зуух руу явуулаад, сайн хадгалахыг тушаав. Тэгээд наргиан хийх өдрөө Планшег өглөө есөн цагт тийшээ явуулаад арван хоёр цагт хоол идэхэд бүх зүйлийг бэлтгэ гэж тушаав.

Найр зохиох хүндэт үүрэгт ногдсондоо Планше бахдаж нэрээ гутаахгүйг хичээв, тиймээс, уригдсан хоёр торгон цэргийн нэгний зарц, Фурро гэгчээр, мөн нөгөө д'Артаньяныг алах гэсэн хуурамч цэрэг хоёроор туслалцуулав. Тэр хүн цэргийн ангид хамаарагдаагүй болохоорманай залуу амийг нь аварснаас хойш д'Артаньянд, чухамдаа гэвэл Планшед зарцлагдах болжээ.

Найрын цаг болж, хоёр зочид ирж суудлаа эзлээд, ширээн дээр өдий төдий хоол эгнүүлэн тавилаа. Планше гар дээрээ алчуур тохож тавиад ширээний ард үйлчилж Фурро лонхны бөглөө авна. Дарсанд замд сэгсрэгдсэнээс тэр юм уу, нэг булинггар маягийн юм байсан болохоор нөгөө шархдаад эдгэрч байгаа Бризмон гэдэг хүн дарсыг шилнээс шилэн саванд юулж байв.

Нөгөө дарсны анхны шил нь ёроолдоо баахан булинггартай байсанд, Бризмон түүнийг аяганд хийгээд, түүний биеийг муухан байсан болохоор д'Артаньян тэр аягатай дарсыг уучих гэж зөвшөөрлөө.

Зочид шөлөө идэж гүйцээд, анхны аягатай дарс, уруулдаа хүргэхэд бэлэн болж байтал гэнэт Людвиг боомт, шинэ боомт хоёрын зүгээс их буу нижгэнэв. Бүслэгдсэн цэрэг юм уу, англи цэргүүд гэнэт довтолсон юм байх гэж бодоод торгон цэргүүд даруй илдээ шүүрэн авсанд, д'Артаньян ч мөн тэднээс хоцорсонгүй бас илдээ аваад, гурвуулаа байр руугаа гүйв.

Гэвч дөнгөж гал тогооны газраас гүйж гармагцаа тэд энэ чимээ шуугианы учрыг ойлголоо. Тал бүрээс, "Ван эзэн мандтугай! Хамба лам мандтугай!" гэж хашгиралдан газар сайгүй бөмбөр дэлдэж байв.

Үнэхээр ч бидний дурдсанчлан, яараад байсан ван эзэн хоёр буудал газар амралгүй явсаар, дөнгөж сая бараа бологчид болон хүч сэлбэх арван мянган цэргийн хамт морилж ирсэн аж. Вангийн өмнө, хойно шадар цэргүүд дагаж явна.

Эгнэж жагссан сумангийнхаа дотроо байсан д'Артаньян өөрийгөө нүд салгалгүй ширтэж байгаа нөхдөө болон, өөрийг нь даруй олж харсан де Тревиль гуайд гараа дохиж баяр хүргэв.

Ван эзний морилж ирэх ёслол дуусмагц нөхөд уулзаж чанга тэврэлдэв. д'Артаньян дуу алдаж чөтгөр алгад та нар бас сайхан тохируулж ирлээ. Бодвол өдийд нэг ч хоол хөрч амжаагүй дэг. Тийм байхаа эрхмүүдээ гэж манай залуу, хоёр торгон цэргээсээ асуугаад тэднийг нөхөдтэйгөө танилцуулав.

-Үгүй ерөө! Бид янз нь найрлах болж байна, гэж Портос баярлана.

Арамис үүнд,

-Танай хоолон дээр бүсгүйчүүд арай байхгүй биз? гэж асуулаа.

-Танай тэр ордонд олигтой дарс бий юу гэж Атос сонирхоно.

-Юу бий юу гэж, чөтгөр алгад! үгүй надад эелдэг найз таны явуулсан дарс бий шүү дээ гэж

д'Артаньян хариулав.

Агос гайхаад

-Бидний дарс аа? гэж лавлалаа.

-Харин тийм ээ та нарын явуулсан нөгөө дарс.

-Бид өөрт чинь дарс явуулсан гэж үү?

-Үгүй та мартчихаа юу? Анжуй үзэмний сулавгархан дарс яагаав!

-Тиймээ, таны ямар дарс хэлж байгааг би ойлголоо.

-Таны, бусад бүх дарснаас илүү дуртай тэр дарс,

-Тиймээ, надад шампан, шамбертен дарс хоёр байхгүй бол тэр чинь дээр байлгүй яахав.

-Одоо яая гэх вэ? шампан, шамбёртен хоёр байхгүйгээс хойш, та нар анжуй дарс л уухаас биш гэж д'Артаньяныг хэлэхэд Портос:

-Та тэгвэл анжуй дарс захиалаа юм биз дээ, д'Артаньян та амтанд басих дуртай хүнээ гэв.

-Үгүй гэмээ! Энэ чинь, та нарын нэрийн өмнөөс, надад ирүүлсэн дарс байхгүй юу. -Бидний нэрийн өмнөөс ий! гэж гурван шадар цэрэг зэрэг дуу алдав.

Агос тэгээд,

-Арамис. та дарс явуулсан юм уу? гэж асуулаа.

-Үгүй, аа Портос та явуулсан юм уу?

-Үгүй, Агос табиш үү?

-Үгүй.

-Та нар явуулаагүй юм бол танай буудлын эзэн явуулж дээ гэж д'Артаньян хэлэв. -Манай буудлын эзэн гэнэ ээ?

-Харин тийм ээ! Танай буудлын эзэн, шадар цэргийн буудлын эзэн Годо яагаав.

-Үгүй ингэхэд, тэр дарс хаанаас гарч ирсэн нь бидэнд ямар хамаа байгаа юм бэ, амсаад үзье, тэгээд сайн дарс байвал уучихья гэж Портос хэллээ.

Агос үүнд маргаж,

-Үгүй, хаанаас ирсэн нь үл мэдэгдэх дарсыг уухаа больё, гэв.

д* Артаньян санал нийлж.

-Атос таны зөв, тэхлээр та нарын хэн нь ч, буудлын эзэн Годог надад дарс явуул гээгүй юм шив? гэлээ.

-Үгүй тэгсэн хир ньГодо, бидний нэрийн өмнөөс танд дарс ирүүлээ юм бий дээ? -Захиа нь энэ байна гэж д'Артаньян хэлээд, нөхдөдөө нөгөө зурвасыг үзүүллээ.

-Энэ чинь түүний бичиг биш байна. Түүний бичгийг би мэднэ, явахын өмнө би түүнтэй нийтийн өмнөөс тооцоо бодсон юм даг гэж Атос өгүүлэв.

Портос мөн,

-Энэ чинь хуурамч захидал байна, биднийг баривчилсан хүн ер үгүй гэнэ. -Д' Артаньян биднийг үймээн тарилаа гэхэд, та яаж итгээ вэ, гэж Арамис зэмлэнгүй дуугарав.

д'Артаньяны царай зэвхийрч, хамаг бие нь зарсхийлээ.

-Чи намайг айлгачихлаа, юү болоо вэ? гэж онцын чухал үед өөрийг нь "чи" гэдэг Атос хэлэв.

-Гүйцгээе, бушуулъя нөхөд минь!

-Надад хачин муухай сэжиг төрлөө. Үгүй энэ чиньдахиад л тэр бүсгүйн өшөө авах оролдлого гэж үү? гэж Артаньян дуу алдав.

Одоо Атосын царай цайраад явчихлаа.

-д'Артаньян хоолны газар руу ухасхийж гүйхэд хоёр торгон цэрэг гурван шадар цэрэг хойноос нь дагалдав.

д'Артаньян хоолны өрөөнд ортол Бризмоны хамаг бие муухай таталдан, шалан дээр хорчилзож байгаа харагдаад орхилоо.

Планше , Фурро хоёрын царай зэвхийрчихсэн түүний зовлонг хөнгөвчлөх санаатай оролдовч, туслах гээд нэмэргүй гэдэг илт байв. Бризмон амьсгаа хураахын өмнөхөн, шаналан татвалзаж байлаа. д* Аотаньяныг үзээд тэр дуу алдаж.

-Та юу энэ чинь! Та миний амийг аварсан дүр үзүүлээд эцэст нь хор өгч аллаа. Үгүй бас муухай хэргээ.

-Би юу! Хөөрхий амьтан, чи юу ярьж байнаа! гэж д'Артаньян сандарна. -Тиймээ, тийм. Та надад тэр дарсыг өгсөн, та намайг уу гэсэн. Та надаас өшөөгөө авах гэжээ, мөн ч муухай яа!

-Бризмон та андуурч байна. Та андуурч байна шүү. Та итгэж үз...ам алдъя. -Үгүй бурхан гэж бий. Бурхан таныг цээрлүүлнэ. Ээбурхан минь! Үүнийг одоо миний тарчилж байгаатай адил тарчилгаасай!

-Бурхны номыг барьж тангараглая! Энэ дарсанд хор хийснийг би мэдээгүй, өөрөө хүртэл уухаар завдаж байсан юм гэж д'Артаньян дуу алдаад,

-Нөгөө цэрэг үүнд,

-Танд би итгэхгүй байна гэлээ.

Ингээд айхтар тарчлан зовсоор амьсгаа хураав. Портос шилтэй дарсуудыг хага хага цохиж байхзуур, Атос,

-Ямар айхтар юм бэ, юун муухай юм гээч вэ? гэж шивэгнэнэ. Арамис, хувраг хүн дууд гэж жаахан хожигдсон тушаал өгөв.

-Сайн нөхөд минь, та нар дахиад л миний аминд, ганц миний ч биш, энэ эрхмүүдийн аминд орлоо гэж д'Артаньян хэлээд, хоёр торгон цэрэгт,

-Эрхмүүдээ энэ үзсэн зүйлийнхээтухай дуугүй байхыг та хоёроос гуйя. Энэ явдалд тун өндөр дээд улс оролцсон байж магад, тэгвэл хамаг гэм буруу бидний толгой дээр л тусч ирэх болно гэв.

Ухаан гартлаа айсан Планше үглэж,

-Пээ эрхэм минь ээ, эрхэм минь, үгүй ингэхэд би азтай гарсан байх нээ! гэнээ. -Юу гэнээ, муу новш чи миний дарсыг уух санаатай байгаа юу? гэж д'Артаньян зандарлаа.

-Ван эзний эрүүл энхийн төлөө тэр л дээ эрхмээ. Ван эзний эрүүл энхийн төлөө жаахан уух гэж байтал, Фурро намайг дуудаж байна гэсэн юм.

Фурро мөн айсандаа дагжтал чичирч, тэр үнээн, би бас үүнийг явуулчхаад, ганцаараа тайван уух гэсэн юм гэж үнэнээ хүлээв.

д'Артаньян, хоёр торгон цэрэгт,

-Эрхмүүдээ сая учирсан явдлын дараа, манай хурим их гунигтай зүйл байхсан гэдгийг та хоёр өөрсдөө мэдэж байгаа. Тэхлээр миний уучлал гуйж байгааг минь тогтоож. авна уу, өөр нэг цагт наргия гэлээ.

Торгон цэргүүд хоёулаа д'Артаньяны уучлал гуйсныг эелдгээрхүлээж аваад, дөрвөн нөхөд хэдүүлээ үлдэхсэн гэж байгааг ойлгон, гарч одов.

Гаднын хүнгүй хэдүүлхнээ үлдсэн хойно залуу торгон цэрэг гурван шадар цэрэг цөм хэргийн байдал маш хэцүү байгааг ойлгож байх байртай өөд өөдөөсөө харна.

Атос ам нээж,

-Юуны өмнө энэ өрөөнөөс гарах. Зуурдаар хорлогдож үхсэн хүний хүүрийн дэргэд байх гэдэг тийм аятайзүйл биш гэв.

-Планше, энэ золгүй хүний хүүрийг чамд тушаая. Яахав үүнийг ээвэр газарт оршуулаг. Энэ хүн гэмт хэрэг хийсэн үнэн боловч, түүндээ гэмшсэн юм гэж д'Артаньян хэллээ. Ингээд нас барсан Бризмоны хүүрийг Планше, Фурро хоёрт даатгаад, дөрвөн нөхөд өрөөнөөс гарлаа.

Буудлын эзэн тэднийг өөр өрөөнд оруулж дутуу чанасан өндөг, Атос өөрөө худгаас авч ирсэн ус хоёроор дайлав. Портос Арамис хоёрт хэргийн голыг хэдэн үгээр хэлж өглөө.

-За ингэхлээр, сайн нөхөр минь харж байгаа биз дээ, энэ чинь заавал толгой залгихаар гүнээ өшиж байгаа явдал шүү гэж Атост д'Артаньян хэлэв.

Атос толгой сэгсэрнэ.

Тиймээ, яриа алга гэж тэр хариулаад, үүнийг ч би ойлгож байна, гэхдээ та түүнийг нөгөө бүсгүй мөн гэж бодоод байгаа юм бий дээ?

-Би лав мэдэж байна.

-Би үнэнээ хэлэхэд, бас эргэлзээд байна шүү.

-Үгүй, тэр мөрөн дээр байгаа хонхон цэцгэн тамгыг нь яах вэ?

-Тэр чинь, франц нутагт ямар нэг гэмт хэрэг үйлдээд тамгалуулчихсанангли бүсгүй байхаа гэж Атос хэлэв.

-Атос, Атос оо! тэр хүн танай эхнэр мөн гэж хэлээд байна шүү. Үгүй хамаг шинж тэмдэг яг нийлээд байсныг та мартчихлаа гэж үү? гэж д'Артаньян мэтгэнэ.

-Юу ч гэсэн л тэр нөгөө хүнийг би тун сайн дүүжилсэн юм даа, үхсэн гэж бодоод байх юм.

Энэ удаа д'Артаньян толгой сэгсрээд:

-Үгүй тэгээд яах вэ? гэж асуув.

-Үргэлж л хутганы ирэн дээр байгаад байж болшгүй. Энэ байдлаас гарах нэг арга заавал олох ёстой гэж Атос хэллээ.

-Ямар арга тэр вэ?

-Тэр бүсгүйтэй уулзаад, учраа ололцохыг хичээж үз. Тэр бүсгүйд ингэж хэл: "эвлэрье, эсвэл халз өширхөлцөх болно шүү. Таны тухай нэг ч үг хүнд дурсахгүй, таны эсрэг өчүүхэн ч юм хийхгүй гэж тайж хүний хувиар амлаж байна. Та мөн өөрөө надад элдвээр хор хүргэхгүй гэж тангарагла. Эс тэгвэл, би ерөнхий захирагч, Ван эзэнд хүртэл очно, тамга дарсан хүнийг эрж олно, ордны ихэс дээдсийн дунд таны нэрийг хугалж, тамга даруулсны чинь зарлана, таныг шүүхэд өгнө, хэрэв шүүх өөрийг чинь цагаатгадаг юмбол таныг буланд, галзуу нохой алж байгаа юм шиг алаад хаячихна шүү, тайж хүний үнэн үгээ хэлж байна" гээ.

д'Артаньян үүнд, ийм арга хэрэглэхэд надад дургүйцэх юм алга. Гэхдээ тэр бүсгүйтэй яаж

уулзах вэ? гэлээ.

-Хонгор найз минь, цаг улирсаар, аяндаа аятайхан учрал дайралдаад орхино, тийм учрал гэдэг чинь хүнд давж гарах давхар болзол өгдөг юм. Хэрэв өөрөө цагийг нь хүлээж чаддаг л бол тавьсан мөрийнийхөө хирээр их хождог юм шүү дээ.

-Тэр ч тийм, гэтэл эргэн тойрон алуурчин, хордуулагч .этгээдүүд тойрчихоод байхад хүлээж сууна гэдэг...

-Зүгээр бурхан биднийг өнөө хүртэл өмгөөлсөөр ирж цаашид ч биднийг өмгөөлөх болно гэж Атос хэлэв.

-Тиймээ, биднийг чухамдаа, бид эр улс, амь дүйж явах гэдэг бидэнд байж болох зүйл гэснээ д'Артаньян дуугаа намсгаж, ганцхан хөөрхий бүсгүй л ... гэв.

-Тэр бүсгүй чинь хэн бэ? гэж Атос асуув.

-Констанция.

-Бонасье авгай юу. Нээрээ тийм, хөөрхий нөхөр минь,. чинийхээ хайр сэтгэлийн зовлонтойг би бүр мартчихжээ.

-Үгүй тэр алагдсан новшийн биенээс олдсон захидлаас та тэр бүсгүй амьд мэнд, сүм Хийдийн газар байгааг мэдсэн шүү дээ, сүм хийдэд байх гэдэг тийм ч муугүй, тэгээд Ларошелийн бүслэлт дуусахын хамт, танд ам өгье, би өөрөө... гэж Арамис хэлэв. Атос хажуугаас нь:

-Тиймээ, тийм. Эрхэм Арамис таны санаа бодол шажинд зорьсныг бид мэднэгэв. Арамис хүлцэнгүй байдлаар.

-Би цаг зуур л шадар цэрэгт байгаа хүн юм гэж дуу гарав.

. Атос үүнд,

-Энэ янз нь амраг бүсгүйгээсээ еураг сонсоогүй удсан бололтой, бүү хайхар, эиэ зангий нь бид мэднэ гэж шивнэлээ.

-Ингэхэд байнаа, миний санавал нэг хялбархан арга байх юм гэж Портосыг хэлэхэд, д'Артаньян түүнээс:

-Ямар арга? гэж асуув.

-Тэр бүсгүйг хийдэд байгаа гэж та нар ярьсан байхаа?

-Тэгсэн.

-Тэгвэл байна шүү дээ? Бүслэлт дуусахын хамт л бид очоод, тэр бүсгүйг хийдээс нь

оргуулаад авчихна биз, тэгээд гүйцэх нь тэр.

-Үгүй, юуны өмнө, аль хийдэд байгаагий нь мэдэх хэрэгтэй шүү дээ. -Тэр ч бас үнээн гэж Портос зөвшөөрнө.

-Хонгор д'Артаньян, үгүй та чинь, хатагтай өөрөө тэр бүсгүйг хийдэд аваачуулсан юм яриагүйсэн билүү? гэж Атос асуув.

-Тиймээ, юу ч гэсэн би л тийм байх гэж бодож байгаа юм.

-Их сайн. Тэгвэл Портос энэ хэрэгт тус болох юм байна.

-Ямар замаар тэр билээ, хэлээд өгч үз.

-Яахав танай хэргэмтэн амраг, герцогийн гэргий гүнжээр дамжуулаад мэдчихгүй юу. Бодвол тэрхүний танил тал гэж тоймгүй юм яваа биз.

Портос нэг хуруугаа амандаа хүргээд,

-Иш, чимээгүй, миний бодоход, тэр чинь хамба ламын талыг барьдаг хүн байх, түүнд юу ч дуулгах ёсгүй юм гэв.

-За тийм бол Бонасье авгайн тухай сураг сонсох хэргийг би даая гэж Арамис хэлэв. Гурван нөхөд нэгэн зэрэг,

-Арамис та юу? ямар аргаар тэр вэ? гэж дуу алдлаа.

-Хатагтайн багш ламтантай би их сайн танил юм, түүгээр дамжуулж дуульа гэж хэлээд Арамисын царай улайчихлаа.

Тарчигхан хоолоо идээд дуусч байсан дөрвөн нөхөд энэ амлалтыг сонсоод, тэр оройдоо дахиж уулзахаар болзоод салав. д'Артаньян, францискийн хийд рүү буцаж, гурван нөхөд, Ван эзний буусан газар өөд явлаа, тэд бас орох байраа хөөцөлдөх ёстой байлаа.

XLIII. "САЙХАН ТАГТААТ" ГЭГЧ ГУАНЗ

Дайсантай нүүр тулгарахыг тэгтлээ яарсаар ирсэн хамбын нэгэн адил, тэндээ хамбыг бодвол ихээ үндэстэйгээр Бекингэмийг мөн үзэн яддаг ван эзэн энэ зуур, англи цэргүүдийг юуны өмнө Ре арлаас хөөж гаргах, дараа нь Ларошеллийг хүчтэйгээр бүслэн дарахаарзохих тушаал зааврыг даруй гаргах гэтэл, нэг талаас. Бассомпьер, Шомберг, нөгөө талаас Ангулемийн герцог нарын дунд хэрүүл маргаан гарч үүнд саад боллоо.

Бассомпьер, Шомберг гуай нар францын маршал цолтой болохоор, шууд ван эзний удирдлагаар бүх цэрэг жанжлах эрхээ эдэлнэ гэж зүтгээд, чухам сүжгээрээ буруу номтон болох Бассомпьерыг нэгэн сүсэгтэн болох Ларошельчүүд болонангли цэргүүдийн өөдөөс хүчлэн хөдлөхгүй байх гэж хамба лам дотроо хардаад, энэ тушаалд Ангулемийн герцогийг тавья гэж байлаа. Ингээд хамбын зүтгэснээр Ангулемийн герцогийг ерөнхий жанжны орлогчоор томилоод, Бассомпьер Шомберг нарыг цэргээс гараад явчхаас болгоомжилж, тус тусад нь биеэ даасан баг цэрэг өгч даргалуулав,

Бассомпьер өөрөө Лале гэгч газраас Домпьер хүртэлх хойт талын хэсгийг, Ангулемийн герцог баруун талын, Домпьерээс Перини гэгч газар хүртэлх хэсгийг, Шомберг өмнө талын, Перинигээс Ангутен гэгч газар хүртэлх хэсгийг тус тус дааж авлаа.

Орлеанийн герцогтны хүрээ Домпьерт, Ван эзнийх Этре, Лажарри гэгч хоёр газарт сэлгэж байв. Хамба ламтны хүрээ гэж чулуун гүүрийн дэргэдээс элсэн толгой дээр ямар ч бэхлэлт сэлтгүй жирийн нэг байшин байв.

Ийм янзаар, Орлеаны герцогтон Бассомпьерыг хянаж, Ангулемийн герцогийн хойноос ван эзэн; Шомбергийг хамба хянаж байв.

Ингээд. цэргийн хүчийг зохих ёсоор байрлуулсны эцэст, Ре арлаас англи цэргийг хөөж гаргах арга дээрээс сүвэгчилж эхлэв.

Нөхцөл байдал үүнд тус дөхөм үзүүлж байлаа. Англи цэргүүд хоол унд сайтай байвал л сайн тулалддагулс, гэтэл тэд зөвхөн шууз, муудсан муу хатаасан талхаар хоол хийж, хуаранд өвчтэй хүн олширчээ. Түүнээс гадна өдий хирд далайн эрэг туждаа их давлагаатай ширүүн байдаг болохоор, өдөр бүр нэг жижиг онгоц сүйрнэ. Ингээд түрлэг болоод өнгөрөх бүрд л Эшльоны хушуунаас аваад, бүр суваг хүртэлх далайн эргээр дүүрэн жижиг, том онгоцны эвдэрхийсүг болчихдог байв. Эд бүгдээс үзэхэд арал дээр зөвхөн зөрүүд зан гаргаад суусаар байгаа Бекингэм, ван эзний цэргийг хөдлөхгүй байгаад байлаа ч гэсэн өнөө маргаашгүй бүслэлтээ орхихоос өөр замгүй болсон аж.

Гэвч, дайсны хуаранд шинэ дайралт хийх бэлтгэл хийж байгааг Туарак гуай дуулгасанд, үүнийг дуусгавар болгоё гэж ван эзэн шийдээд, шийдвэрлэх тулалдаан хийх тушаал өгөв.

Бүслэлтийн тухай ер нь дэлгэрэнгүй бичих гээгүй, зөвхөн манай ярьж байгаа юмтай уялдсан явдлыг дурдах, гэсэн болохоор, товчхон хэлэхэд, энэ хэрэг урагштай бүтэж ван эзэнд их гайхалтай санагдаж, хамба ламтны алдрыг их бадруулсан билээ. Англи цэргүүд алхам алхмаар хавчигдаж тулалдаан бүрд дийлэгдсээр Лув арал руу гарах үедээ бүрмөсөн бут

цохигдоод, дахин хөлөг онгоцондоо суухад хүрэв. Дайны талбар дээр английнхан хоёр мянган хүнээ үлдээсний дотор, таван хурандаа, гурван дэд хурандаа, хоёр зуун тавин ахмад, хорин өндөр язгуурт тайж нар байв. Түүнээс гадна, дөрвөн их буу жаран туг үлдээснийг Клод де Сен Симон Парист авчирч Парисын эх дагинын сүмийн үүдэнд баяр хөөр болгонөлгөв.

Ач санаж баярласан мөргөл эхлээд хуаранд болж, дараа нь бүх Францад мөргөл хийлээ. Ингэхлээр хамба ламтан одоо юунаас ч зовох юмгүй, юу ч болсон л түр зуурдаа англи цэргээс зоволгүйгээр бүслэлтээ үргэлжлүүлэх боломжтой болов.

Гэхдээ, сая бидний хэлсэнчлэн, энэ тайван байдал түр зуурын л хэрэг байлаа.

Бекингэм герцогийн нэг элч Монтего гэгч хүн олзлогдоод, Австри, Испани, Англи, Лотаринг улсуудын хооронд эвсэл байсныг тэр хүнээс олж мэджээ.

Энэ нь францын эсрэг чиглэсэн эвсэл байжээ.

Тэр ч байтугай, Бекингэм хүрээгээ өөрийн санаснаас их яаруу орхиж явахад хүрсэн болохоор тэндээс мөн тийм Эвсэл байгааг баталсан бичиг цаас олджээ.

Хамба өөрийнхнөө "Дурдатгалд" бичихдээ, тэр бичигбаримтыг үзэхэд, де Шеврез авгайн нэрэнд хор болохоор юм байсан, тэхлээр хатагтайн нэртэй мөн холбоотой гэсэн билээ.

Ямар ч хариуцлага хүлээлгүйгээр бүрэн эрхт сайд байж болохгүй болохоор, хамаг хариуцлага хамба ламд тулгарч байлаа. Ингэхлээр хамба ламтан олон талтай хурц ухаанаа шавхан дайчилж, европын бүх том улсад болж байгаа өөрчлөлт бүхнийг өдөр шөнөгүйбичиж байв.

Бекингэмийн зоримог чадалтай, ялангуяа үзэн ядах хүчийг нь хамба лам өөрөө мэддэг байв. Хэрэв Францыг заналхийлж байгаа эвсэл ялчих юм бол хамбын хамаг нөлөө алдагдах юм. Тэгвэл, одоогоор зөвхөн өөрийн талын ганц нэг хүнтэй байгаа Испани, Австрийн улс төрийн бодлого, Лувр ордонд байнгын төлөөлөгчтэй болж, чухамдаа францын үндэсний эрх ашгийг голчлон хамгаалсан сайд Ришелье өөрөө мөхөхсөн билээ.

Хамбын үгэнд хүүхэд шиг орж, өөрийг нь хатуу багшдаа дургүй хүүхэд шиг үзэж чаддаггүй ван эзэн түүнийг хувийн өшөөгөө авахыг боддог өөрийнхөө дүү хатан хоёрын гарт өгчихнө, ер нь л Ришелье ч дүүрч Ришельетэй хамт аягүй бол франц орон ч баларч мэднэ. Эд бүгдийг аргалж өнгөрөөх ёстой байв.

Иймээс, чулуун гүүрний дэргэдэх, хамбын өргөө болгосон жижиг байшинд өдөр шөнөгүй элч нар ирж явж, минут тутам тэдний тоо олширсоор байв.

Тэдгээр элчийн дотор жанч нөмрөгөө даанч эв дүйгүй өмсч, сүм хийдийн биш, цэргийн хүн гэдэг нь илт танигдах гэлэнгүүд, мөн өргөн өмдөн дотроос хүртэл, биений нь хэлбэр ялгарч мэдэгдээд байх, хиа хувцас өмссөндөө түүртсэн бүсгүйчүүл, мөн муухай хар гартай мөртэй гуалиг сайхан биетэй өндөр язгууртан хүн гэдэг нь тээр холоос танигдахуйц тариачин хувцастай хүмүүс зэрэг байв.

Бас аягүй муу зочин ирдэг явдал ч байдаг бололтой, юу гэвэл хамбын амийг хорлох гэж оролдсон тухай хоёр гурав дахин цуу тарж билээ.

Хамбыг өөрөө тэр болхи алуурчдыг хөлсөлж аваад маягладаг, үүгээр өөрөө хэрэгтэй цагт хүч хэрэглэсэн арга хэрэглэх замаа цэвэрлэж байгаа гэж их гэгээнтний дайснууд ярьдаг явдал байсан, гэхдээ сайдын үгийг ч түүний дайснуудын үгийг ч тэр үиэмшихий хэрэггүй юм.

Хамбыг хамгийн адгаар муулах дуртай улс хүртэл түүний эр зоригтойг үгүйсгэдэггүй юм. Хамба ламтан Ангулемийн герцогт ямар нэг чухал тушаал өгөх юмуу, Ван эзэнтэй ямар нэг юмны тухай зөвлөх, эсвэл өөрийнхнөө явуулсан улсын зарим, гэртээ ирүүлэхээс ямар нэг шалтгаар дургүйцсэн нэгтэй нь уулзахаар шөнө орой гадуур сэлгүүцэхэд дээрх явдлууд ер саад болоогүй юм.

Шадар цэргүүдийн тухайд гэвэл, бүслэлтийн үед тэдэнд хийгээд байх онц юм үгүй болохоор, тэднийг нэг их чанд байлгадаг ч үгүй, өөрсдөө зугаатай наргиантай байдаг байлаа.

Шадар цэргүүд наргиж цэнгэж чаддаг улс, тэр дундаа манай гурван нөхөд, де Тревиль гуайтай нөхөрсөг дотно болохоор, түүнээс хуарандаа хожигдож ирэх, гэрэл унтраасан хойно ирэх тусгай зөвшөөрөл байн, байн авдаг байлаа.

Ингээд д'Артаньян сувагт манаатай болохоор цуг явалцаж чадахгүй нэг орой Атос, Портос, Арамис гурав хүлэг морьд унаж, аяны нөмрөгөө нөмөрчхөөд, гар буугаа бэлэн барьсаар "Сайхан тагтаат" гэгч гуанзнаас хуаран руугаа буцаж явлаа. Лажарригаас нааш ирэх зам дээр энэ гуанзны газар байдгийг Атос хоёр хоногийн өмнө мэдсэн юм байж. Тэднийг минут тутам ямар нэг аюултай тулгарахад бэлэн явсныг бид дурссан, тэгээд Буанар тосгоноос дөрвөн мод хиртэй газар явжбайтал гэнэт морин төвөргөөн дуулдлаа, Тэр гурав замын голд яг шахалдан, даруй зогсоод хүлээв, Нэг хормын дараа үүлний цаанаас цухуйсан сарны гэрэлд замын тойруу дээр хоёр морьтой хүн ирж явахыг тэд харлаа. Цаад хоёр хүн мөн зогсоод урагшаа явах, буцах эсэхийг хоорондоо зөвлөж байх бололтой. Ингэж түдгэлзэх нь гурван нөхдөд сэжигтэй санагдаад, Атос урагшаа хэдэн алхам түрүүлж, захирангуй дуугаар:

-Хэн явж байнаа? гэж хашгирав.

Хоёр морьтой хүний нэг мөн өөдөөс нь та нар өөрснөө юун улс вэ гэж асуулаа.

-Наадах чинь хариулт биш байна гэж Атос маргаад хэн болохоо хэл. Хариул, үгүй бол бид буудлаа гэв. Тэгтэл

-Буудаагүй нь дээр байхаа эрхмүүдээгэж захирч сурсан бололтой хүн чанга дуугарав.

-Энэ чинь, шөнийн эргүүл хийж яваа нэг ахлах дарга байна. Бид явал зохих вэ, эрхмүүдээ? гэж Атос шивэгнэлээ.

-Юун улс вэ, та нар? гэж нөгөө захирангуй дуутай хүн асуугаад, -Хариул, үгүй бол та нар үг дагаагүй дээ их харамсах болно шүү гэлээ.

Энэ асуултыг тавьж байгаа хүн? асуух эрхтэй юм байна гэдэгт Атос улам бүр итгээд, -Бид ван эзний шадар цэргүүд байна гэлээ.

-Аль сумангийнх вэ?

Де Тревиль гуайн сумангийнх.

-Наашаа зохих зайнд ойртож ирээд, ийм оройн цагаар энд юу хийж байгаагаа над илтгэ.

Гурван нөхөд одоо өөрсдөөсөө илүү эрх мэдэлтэй хүнтэй учирчээ гэдгээ лав мэдээд, жаал номхорч, урагшаа дөхөж очоод, цаад хүнтэй Атос ярилцах ёстой болов.

Хоёр морьтой хүний нэг, нөгөө ярианд сүүлд оролцсон хүн хамт явсан хүнээсээ арваад алхмын өмнө зогсож байлаа. Атос мөн Портос, Арамис хоёрыг хоцор гэж дохиод ганцаараа дөхөж очив. -Дарга гуай биднийг уучилна уу, бид хэнтэй дайралдсанаа мэдсэнгүй, тэгээд сэрэмжтэй байсан юм. гэж Атос хэллээ.

Нүүрээ дутуу халхалсан тэр дарга,

-Таны нэр хэн бэ? гэж асуув.

Ингэж байцаагаад байхаар дургүй нь хүрсэн Атос үүнд,

-Ингэхэд эрхмээ надаас ингэж юм асуух эрхтэйгээ та баталж үзүүлнэ үү? гэв. Цаад морьтой хүн малгайгаа өргөж, нүүрээ ил гаргаад,

-Таны нэр хэн бэ? гэж давтан асуув.

-Хамба ламтан гэж үү гэж шадар цэрэг гайхан дуу алдлаа.

Хамба гурав дахь удаагаа,

-Таны нэр хэн бэ? гэж шалгаасанд, шадар цэрэг хариулж:

-Атос гэв.

Хамба, хамт явсан хүнээ ир гэж дохиод, яаран ойртож ирлээ.

-Энэ гурван шадар цэрэг биднийг дагалдаж яваг, миний яваад өгснийг хуаранд хүн бүү мэдэг гэж би хүсэж байна, эд бидэнтэй цуг явбал эдний үг алдахгүйд бид бат итгэлтэй байж болох юм даа гэж хамба аяархан хэлэв.

-Гэгээнтэн, бид тайж улс. Бидний амыг аваад, санаа зоволгүй явж болно, Бурхны ачаар бид нууц хадгалж чаддаг улс.

Хамба лам энэ зоригт хүний өөдөөс нэвт шувт эгцлэн ширтээд,

-Атос гуай та их сонор хүн юм байна. Харин, одоо миний хэлэх үгийг сонс. Та нарт итгэхгүйдээ биш өөрийнхөө аюулгүй байдлыг бодоодхамт явахыг гуйя. Тантай цуг бодвол, Портос гуай, Арамис гуай хоёр яваа биз дээ? гэж хамба хэллээ.

Өнөө хүртэл ард зогссоор байсан хоёр шадар цэрэг малгайгаа авч барьсаар ойртож ирэх зуур, Атос,

-Тиймээ их гэгээнтэн гэж хариулав.

Би та нарыг мэднэ, эрхмүүдээ та бүхэн миний нөхдийн тоонд ордоггүйг ч бибас мэднэ, үүнд би

их харамсдаг хүн. Бас та гурвыг эр зоригт голч шударга тайж нар, итгэж болох улс гэдгийг мэддэг юм. Ингэхлээр Атос гуай та. хоёр нөхдийнхөө хамт надтай цуг явж соёрхоно уу, тэгвэл миний бие хамгаалагч нарыг хараад их эзэнтэй өөрөө дайралдлаа ч гэсэн атаархаж болмоор болноо гэж хамба хэллээ.

Гурван шадар цэрэг морьдынхоо хүзүүг хүртэл мэхийн ёслов.

Атос ам нээж., их гэгээнтэн та биднийг дагуулж явдаг тань их сайн хэрэг. Замдаа бид хэд хэдэн аюулт этгээдтэй дайралдаж, тэдний дөрөвгэй нь "сайхан тагтаат" гэдэг гуанзны газар бүр муудалцсан шүү гэлээ.

-Муудалцсан гэнээ? Юунаас болж муудалцаа вэ? гэж хамба асуугаад миний хэрүүл маргаанд дургүйг эрхмүүд мэднэ шүү дээ гэв.

-Тухайлан энэ учраас л би зориглож, их гэгээнтэн танд энэ тухай урьдаас дуулгасан юм. Үгүй энэ тухай та бусдын амнаас дуулаад, үнэн байдлыг хазгай тайлбарласны уршгаар биднийг буруутайд тооцож болохсон билээ.

Хамба хөмсгөө зангидаад,

-Муудалцсаны уршиг тэгээд юу болов доо? гэж сонирхов.

-Таны өмнө зогсож байгаа манай энэ нөхөр Арамис илдээр гар руугаа бага шиг хатгуулсан, гэхдээ маргааш ч билээ дайралтад ороход саад болохооргүй юм. Их гэгээнтэн та дайрах тухай тушаал өгвөл, үүнийг өөрөө нүдээрээ үзэж болох биз.

Хамба лам үүнд эргэлзэж,

-Үгүй та нар чинь илдээр хатгуулчхаад зүгээр байж байхаар улс биш билээ, ингэхэд байна шүү эрхмүүдээ, илэн далангүй ярьчих, та нар лав тэгж хатгуулсныхаа хариуг авах биз? Надад наманчил миний нүгэл цагаатгах эрхтэйг та нар мэднэ шүү дээ гэв.

Үүнд Атос, гэгээнтэн би ер илддээ ч гар хүрээгүй, өөдөөсөө ирсэн хүнийг зүгээр тэвэрч аваад л цонхоор чулуудаж орхисон гээд Атос жаал түдгэлзэсхийж, янз нь унахдаа хөлөө хугалчих шиг болно билээ гэв.

-Аа мөн гэж хамба дуугараад, за, Портоc та яасан бэ? гэлээ.

-Гэгээнтэн, хоорондоо тулалдах хориотойг би мэднэ. Тэхлээр, нэг урт сандал аваад тэр өөдгүй амьтдын нэгийг цохисон мөрий нь хэмхэлчихсэн байхаа.

-Та тийм байж, Арамис гуай та яасан бэ? гэж хамба асуув.

-Гэгээнтэн, би уулын номхонзантай хүн тэгээд ч хувраг болж хийдэд суухаар завдаж байгаа юм, үүнийг их гэгээнтэн дуулаагүй ч байж юу магад. Тэхлээр би нөхдөө аль болохоор хориглож байлаа, тэгтэл гэнэт, тэр муу сайн золигуудын нэг нь гэнэдүүлж, миний зүүн гар руу илдээр хатгачихгүй юу, тэхлээр би хүлцэж чадахаа болиод, илдээ суга татаж авлаа. Тэгтэл тэр хүн над өөд дахин дайрахдаа бүх биеэрээ илдний үзүүр рүү шаачих шиг болсон. Чухам яасныг би сайн мэдэхгүй, лав л тэр хүн ойчсон бусад хоёртой нь хамт өрөөнөөс өргөөд гаргасныг санаж байна гэв.

-Чөтгөр алгад! Жирийн нэг гуанзанд муудалцсанаас болж, гурван хүн жагсаалаас гаргачихдаг. Тийм ээ, та нар тун гар хүндтэйулс шүү. Үгүй, юунаас тийм хэрүүл үүссэн юм бэ? гэж хамба асуув.

-Тэр муусайн амьтад согтуу байсан юм. Буудлын газарт орой нэг бүсгүй хүн ирснийг тэд мэдээд, тийшээ дайрч орох гэсэн юм гэж Атос өчив.

-Бүсгүй рүү дайрч орох гэнээ? Яах гэж тэр билээ? гэж хамба лавлалаа. -Бодвол, тэр бүсгүйд хүч хэрэглэх л гэсэн юм байлгүй тэр золигууд согтуу байсан гэдгийг би их гэгээнтэнд айлтгасан билээ гэж Атос хариулав.

Хамба, жаал санаа зовсон байдалтай, Тэр бүсгүй тэгээд залуу сайхан хүн байгаа юу? гэж асуусанд Атос хариуд нь:

-Бид тэр хүнийг үзээгүй, гэгээнтэн гэлээ.

-Аа, та нар тэр бүсгүйг үзээгүй юм уу за сайн гэж хамба тосч хэлээд бүсгүй хүний нэр төрийг өмгөөлсөн чинь сайн байна, би одоо өөрөө "Сайхан тагтаат" руу явж байгаа болохоор та нарын хэлсний үнэн худлыг олж мэднээ гэв.

Үүнд Атос гэгээнтэн, бид тайж улс, амь зулахын тулд ч гэлээ худлаа хэлэхгүйсээн, гэж бардаж дуугарав

-Үгүй, би, Атос гуай таны үгэнд огтхон ч эргэлзэхгүй байна... гэснээ хамба яриагаа өөрчлөхийг бодож, ингэхэд, тэр бүсгүй ганцаараа байсан юм уу? гэв.

_ Тэр бүсгүйтэй цуг, өрөөнд нь эрэгтэй хүн байсан юм гэвч тэгж их шуугиан дэгдээд байхад гарч ирээгүйг бодвол аймхай амьтан юм байлгүй гэж Атос хэллээ.

- "Хийсвэр бүү дүгнэ" гэж бурхны номд байдаг билээ гэж хамба маргалаа. Атос үүнд хариу мэхэсхийв.

-За одоо эрхмүүдээ үг олдлоо, би мэдэх гэсэн юмаа мэдлээ, тэхлээр миний хойноос явцгаа гэв.

Гурван шадар цэрэг хамбад зам тавьж өмнөө оруулбал хамба дахиж малгайгаар нүүрээ халхлаад, дагаж яваа дөрвөн хүнээ, ес арван алхмын өмнө түрүүлж явлаа.

Төдөлгүй тэд гуанзны дэргэд хүрч ирэхэд хүн амьтангүй чимээ аниргүй бололтой. Эзэн нь ямар гээчийн алдар цуутай гийчин ирэхийг мэдээд, яншаа улсаа эртхэн аргалж явуулсан бололтой.

Үүднээс арваад алхмын наана хамба цуг ирсэн хүн, гурван шадар цэргийг зогс гэж дохилоо, нэг хүний эмээлтэй морь цонхны хаалтаас уяатай байна, хамба болзсон янзаар гурван удаа үүд тогшлоо.

Байшингаас нэг нөмрөгтэй хүн даруй гарч ирээд, хамбатай хэдэн үг солилцоод мордож, Дюрпсер гэдэг газар руу очдог, мөн Парис ордог замаар давхиж одлоо.

Хамба ламтан,

-Эрхмүүдээ, наашаа ир гэснээ, гурван нөхдөд хандаж эрхэм шадар цэрэг үнэнярьжээ.

Манай өнөөдрийн уулзалт та нарт тустай болох нь надаас шалтгаалах юм болохоор, та нарт тус болно. Аа одоодоо мнний хойноос явцгаа гэв.

Хамба мориноосоо буугаад, шадар цэргүүд ч мөн буулаа. Хамба цулбуураа дагаж явсан хүндээ өгсөнд, гурван нөхөд морьдоо цонхны хаалтаас уяв.

Буудлын эзэн үүдэн дээрээ зогсож байна, тэр хүн, хамбыг дээд бүсгүйтэй уулзахаар ирсэн нэг дарга гэж бодож байгаа ажээ.

-Энэ эрхмүүд орж намайг хүлээгээд, дулаацаж байхаар нэг өрөө танай энэ доор байхгүй биз? гэж хамба асуулаа.

Буудлын эзэн нэг жижгэвтэр өрөөний үүдийг нээвэл, тэнд түрүүчийн муу пийшингийн оронд, ил галын том сайхан зуух тавьсан ажээ.

-Энд орог гэж буудлын эзэн хэлэв.

-За тэг гэж хамба хэлээд, эрхмүүдээ тийшээ ороод, намайг хүлээж үз, би та нарыг хагас цагаас илүү хүлээлгэхгүй гэв.

Ингээд гурван буучдыг доод давхрын өрөөнд орж байх зуур хамба тэндхийг сайн мэддэг бололтой элдэв юм асуулгүй, шатаар бушуухан дээшээ гарлаа.

XLIV. ПИЙШИНГИЙН ЯНДАНГИЙН АШИГ НЬ

Манай гурван нөхөд, зөвхөн эр зориг, хүнч сайхан сэтгэлдээ болж өөрсдөө мэдэлгүйгээр, хамба ламтны өндөр ивээлдээ багтаасан нэг бүсгүйд тус болжээ гэдэг илт байлаа. Тэр ер юун бүсгүй байж таарах нь вэ? гэж гурван буучин юуны өмнө бодож үзлээ, гэтэл хичнээн янзаар тааварлаж үзлээ ч гэсэн, олигтой юм болж өгөхгүй болохоор Портоc буудлын эзнийг дуудаад шоо авч ир гэв..

Портоc Арамис хоёр ширээний ард суугаад тоглож эхэллээ. Атос бодол болж өрөөн дотуур холхино. Атос бодол болж холхиж байхдаа дутуу буулгасан пийшингийн яндангийн хажуугаар хойшоо урагшаа өнгөрч байлаа. Энэ яндангийн үзүүр дээд давхар руу орсон аж. Энэ яндангийн хажуугаар өнгөрөх бүр Атост нэг хүний бөглүү дуу дуулдажбайснаа сүүлдээ түүний анхаарлыг татлаа.

Атос ойртож очоод, хэдэн үг чагнатал, тун сонин чухал санагдсанд хсёр нөхөртөө чимээгүй бай гэж дохиод, өөрөө бөхийж яндангийн доод үзүүрт чихээ тавьж чагнавал:

Миледи, та миний үгийг сонс энэ чинь их чухал хэрэг шүү. Энд суу, сайн ярилцъя гэсэн хамбын дуу сонсдов.

-Миледи гэнээ! гэж Атос шивнэв.

-Их гэгээнтэн таны үгийг би анхааралтай хичээнгүйлэн дуулж байна гэж бүсгүй хүний хариу дуу гарсанд, тэр дууг сонсоод шадар цэргийн бие зарсхийв.

Англи цэрэгтэй, дарга нь шадад үнэнч сайн байдаг нэгэн багавтар хөлөг онгоц таныг Шарант голын адаг Ла Пуант боомтын дэргэд хүлээж байх болно.

Тэр хөлөг онгоц маргаашөглөө хөдлөх юм.

-Тэгвэл би өнөө оройдоо тийшээ явж таарах нээ?

-Одоо даруйхан, ер нь миний зааврыг авмагцаа явбал таарна. Эндээс гарахад чинь үүдэн дээр хүлээж байх хоёр хүн таныг замд хамгаалж хүргэнэ. Би эхлээд гарна, та хагас цаг хүлээгээд гараарай.

Тэгье ээ, гэгээнтэн. За ингэхлээр, таны надад өгч соёрхох гэсэнтэр даалгаврын тухай ярилцъя. Их гэгээнтэн танд би цаашид ч гэсэн итгэлтэйгээр зүтгэх санаатай байгаа хүн, тэхлээр тэр даалгавраа надад, ямар нэгэн гэнэн осол гаргахааргүй, тодорхой нарийн тайлбарлаж өгнө үү.

Хоёр хүний яриа хэсэг зуур тасарч, нам чимээгүй боллоо. Хамба хэлэх үгээ урьдаас цэгнэж байх бололтой, Миледи ч мөн хэлсэн бүгдийг нь сайн тогтоож авахаар хамаг анхаарлаа хөвчилж байгаадаг.

Атос энэ минутыг ашиглаж, хоёр нөхрөө, үүд түгжинэ үү гэж гуйгаад, наашаа ирж өөртэйгөө

цуг чагна гэж дохилоо.

Тухлах дуртай хоёр шадар цэрэг өөрсдөдөө нэг нэг, Атост бас нэг сандал авчирлаа. Гурвуулаа сууж толгойгоо ойртуулаад, чих тавивал хамба яриагаа залгаж,

-Та Лондон орно. Лондонд очоод, Бекинтэмтэй уулз гэв.

Миледи хажуугаас нь,

-Алмазан унжуурганы хэргээс хойш герцог намайг түүнд лав холбогдолтой гэж тооцоод, гэгээн ноёнтон надад баахан итгэл муутай болсныг их гэгээнтэнд айлтгая гэлээ. -Үгүй, энэ удаа, та түүнд итгэгдэх тухай яриа биш юм. Та зүгээр л ил шулуунаар миний хэл болж очих юм гэж хамба хариулав.

-Ил шулуун гэнэ гэж Миледи бараг үл ажиглагдах хоёрдмол өнгөөр дуугарав. -Тиймээ, ил шулуун очно.

-Бүх яриагаа илэн далангүй явуулах ёстой юм, гэж хамба түрүүчийнхээ байраар дуугарав.

-Их гэгээнтэн таны зааврыг би яг нарийн биелүүлнэ. тэгээд би таны үгийг бэлхэн сонсож байна.

-Таминий нэрийн өмнөөс Бакингемд очоод түүний хийж байгаа бүх бэлтгэл надад мэдэгдсэн, түүнд миний сэтгэл огт зовохгүй байна, түүнийг дөнгөж анхны алхам хийхтэй хамт л хатныг би хөнөөнө гэж байна гэж хэлээрэй.

-Их гэгээнтэн таныг энэ үгэндээ хүрч чадна гэж тэр итгэх үү?

-Итгэнээ юу гэвэл надад баталгаа бий.

-Тэр баталгааг би Бакингемд өөрт нь гаргаад, тэр түүнийг зохих ёсоор үнэлж үзвэл хэрэгтэй юм даа.

-Тэгэлгүй яахав. Вангийн дүүгийнх багт наадам хийж байсан орой, герцог. хатан хоёр вангийн дүүгийнд уулзсан тухай БуаРобер, де Ботрго хоёрын мэдээлснийг хэвлэнэ гэж намайг хэлсэн гээрэй. Мөн Бакингемд эргэлзээ үлдээхгүйн тулд де Гиз тайжийн өмсч ирэх учиртай байсан их Моголын хувцсыг Бекингэм өөрөө гурван мянган алтан зоосоор худалдан аваад өмсч ирсэн гээрэй.

-Хэлье, гэгээнтэн.

-Бекингэм, ордонд италийн зөнч хүний хувцас өмсөөд явж орсон, шөнө ордноос яаж гарсныг би нэгд нэггүй мэдэж байна. Түүнийг бүрмөсөн үнэмшүүлэхийн тулд та үүнийг хэлээрэй. Бекингэм нөмрөгийнхөө доор, хар гялтгануур, хохимой толгойн яс, чөмөгний зөрүүлсэн яс оёсон өргөн цагаан даашинз өмсөөд гэнэтийн ямар нэг юм тохиолдвол, чухал явдлын өмнө Лувр ордонд үзэгддэг гэж хүн болгоны мэдэх цагаан хатны сүнс болох санаатай байсан.

-Ингээд гүйцээ юу, гэгээнтэн?

-Тэрчлэн Амьен цэцэрлэгт болсон явдлыг нэгд нэггүй мэднэ гэсэн гээрэй. Тэгээд шөнийн тэр явдлыг цэцэрлэг дотор оролцсон гол хүмүүсийн дүр байдалтайгаар, сонирхолтой роман болгож бичүүлнэ гэж байна гээрэй.

-Үүнийг би түүнд хэлье.

-Мөн Монтего миний гарт орсон Бастили гянданд хориостой байгаа түүнтэй хамт ямар нэгэн захидал барьж аваагүй боловч эрүү шүүлтийн хүчээр түүний мэдэж байгаа болгоныг .. тэр ч байтугай мэдэхгүй байгаа юмыг ч гэсэн албадан хэлүүлж болно гэж байна гээрэй.

-Сайн байна.

-Эцэст нь, герцог өөрөө Ре арлаас явах гэж сандраад байрандаа де Шеврез авгайн нэг захидлыг үлдээчихсэн нь хатны нэрийг сүрхий гутаахаар юм, юу гэвэл, их эзэгтэй ван эзний дайсанд хайртай сайн байж чаддагаар барахгүй, францын дайсантай хуйвалдаж байдгийн гэрч болох юм гээрэй. Миний хэлснийг та сайн тогтоосон, тийм биз?

-Их гэгээнтэн, та өөрөө үз л дээ. Ван эзний дүүгийн дэргэд болсон багт наадам. Лувр ордонд шөнө орсон тухай, Амьенд болсон оройн явдал, Монтего баригдсан мөн де Шеврез авгайн захидал, эд байна.

-Зөвөө яг зөв. Миледи та их сайхан ойтой хүн юм. Хамбын энэ магтаалыг хүлээсэн бүсгүй:

-Үгүй эд бүгд нотолгоог хэлсээр байтал герцог зөрүүд загнаж, Францыг заналхийлсээр байвал яах вэ? гэж асуув.

-Герцог ухаан жолоогүй дурлалчигсан чухамдаа гэвэл хайр сэтгэлд толгой нь эргэхээд байгаа хүн гэж Ришелье голоосоо аягүйцэн дуугарав. Хуучин цагийн баатрууд шиг, зөвхөн сэтгэлтэй бүсгүйнхээ таалалд нийцүүлэх гэж герцог энэ дайныг өдөөсөн юм. Энэ дайн түүний өөрийн нь ярьдгаар сэтгэл зүрхийг нь эзэмшсэн хүний нэр төрийг гутааж магадгүй, эрх чөлөөнд нь хүртэл харшилж болохыг тэр мэдвэл дайныг үргэлжлүүлэхээсээ өмнө юм бодох бий.

Миледи өөртөө даалгаж байгаа үүргийг эцэст нь хүртэл ухаж авах гэж илтэд мэрийн, -Үгүй тэгээд Бекингэм бас л зөрүүд зан гаргаад байвал яах вэ? гэж бас асуув. -Түүнийг цаашаа зөрөөд байвал уу... арай л тэхгүй бий гэж хамба хэлэв. -Болох л зүйл дээ.

-Тэр цаашаа зөрөөд байвал... гээд хамба жаал дуугүй байснаа дахин ам нээж, хэрэв ээ, тэр цаашаа зөрөөд байвал улсын нүүр царайг өөрчилдөг нэг их явдал болно байх л гэж би найдах болно доо гэв.

-Их гэгээнтэн та тийм явдлын түүхэн жишээг дурдаж хайрлавал би бас тантай адил найдах болж магад юм даа гэж Миледи хэлэв.

-Жишээг дурдвал ийм байна. Мянга зургаан зуун арван онд яруу алдарт дөрөвдүгээр Генрих ван мөн герцогийн үүнтэй бараг төсөөтэй шалтгийн улмаас, Итали, Фландри хоёр руу гэнэт

цөмрөн ороод, Австрийг хоёр талаас нь довглох гэж байхад, Австрийг аварсан явдал гараагүй гэж үү? Тэхлээр, Австрийн эзэн хаанд учирсан шиг золтой явдал францын ван эзэнд яагаад дайрч эс болох юм бэ? гэж Ришелье хариулав.

-Зэсчний гудамжинд хутгалсан явдлын тухай их гэгээнтэн ярьж байх шиг байна? -Тийм ээ, тэр тухай ярьж байна.

-Равальякийг цаазаар аваачсан явдал, түүний мөрөөр орохгэж санасан бүхнийг айлгаж байгаа гэж их гэгээнтэн бодохгүй байна уу?

-Аливаа цаг үед, аль ч улсад гэлээ, ялангуяа тэр улс шиг дайсагналд идэгдэж байгаа бол, зовлон эдлэгч болохоос өөр юм хүсдэггүй мухар сүжигтэн заавал олддог юм. Ингэхэд пуритан шашинтнууд яг Бекингэм герцогт туйлгүй өшиж тэдний номлогчид герцогийг буруу номын этгээдгэдэг санаанд орж байна.

-Тэгээд юу гэж? гэж Миледи асуув. Хамба хангалуун дуугаар үгээ үргэлжлүүлж,

-Яахав дээ, ухаан нь герцогоос өшөөгөө авахыг хүссэн нэг залуу, царайлаг, авхаалжтай бүсгүйг л олбол хэрэг бүтэх юм. Тийм бүсгүйг олоход хялбар. Герцог өөрөө эмэгтэйчүүдэд их таалагддаг хүн, тэгээд үүрд нэгэн сэтгэл барина гэж герцог андгайлаад олон хүний дотор хайр сэтгэл төрүүлж чадсан гэхэд, мөн үргэлж хувирч байдгаараа бас олон хүний дотор өшлөх сэтгэл төрүүлсэн юм гэв.

-Тиймээ, тийм бүсгүй олдож болох юм гэж Миледи хүйтнээр дуугарав. -Олдлоо гэвэл тийм бүсгүй, ямар нэг мухар сүжигтний гарт Жак Клеман юм уу, Равальякийн балиус хутгыг атгуулаад, францыг аврахсан билээ.

-Үгүй, тэгвэл тэр бүсгүй өөрөө алуурчны хань хамсаа болно шүү дээ

-Равальяк юм уу, Жак Клеманы хань хамсаатны нэр олонд мэдэгдсэн гэж үү?

-Үгүй. Тэхдээ тэр хүмүүсийг илчлэхэд бэрх, өндөр дээд хүмүүс байсан дээрээс тэгсэн байж мэдэх юм. Хүн болгоны төлөө ч шүүхийн тэнхимийг шатаахгүй шүү дээ, гэгээнтэн. -Та тэгвэл шүүхийн тэнхимд гал гарсан явдлыг гэнэтийн явдал биш гэж бодож байгаа юмаа? гэж Ришелье огт дэмий юмны тухай ярьж байгаа янзтайгаар асуулаа.

-Гэгээнтэн минь, би өөрөө юу ч бодоогүй, зүгээр л би өөрөө де Монпансьегийн охин юм уу, Мария Медич хатан байсансан бол одоо жирийн нэг Кларик авхай болохоор ингэтэл их болгоомжилж байгаа шигээ болгоомжлохгүй байхсаан гэж хэлэх гэсэн юм. Ришелье үүнд санал нийлж,

-Таны зөв. Тэхлээр та яахсан гэж? гэв.

-Миний хийвэл зохино гэж үзсэн бүхнийг францын ашиг тусын тулд хийсэн гэж урьдаас баталсан бичиг авахсан гэж бодох юм.

-Үгүй, эхлээд миний хэлсэнчлэн, герцогоос өшөөгөө авахсан гэж хүсэх бүсгүйг олох хэрэгтэй

шүү дээ.

-Тийм бүсгүй байнаа гэж Миледи хэлэв.

-Дараа нь бурхны шударга шүүхийн зэвсэг болж өгөх тэр мухар сүсэгтэн этгээдийг олох хэрэгтэй болно шүү дээ.

-Тийм хүн олдоно.

-Тэхлээр л сая таны гуйсан тэр бичгийг авах цаг ирнэ дээ.

-Их гэгээнтэн таны зөвөө гэж Миледи дуугараад, Тэгээд таны надад өгч соёрхсон даалгавар, энэ хирээрээ хязгаарлагдахгүй юм гэж миний санадаг эндүүрэл болжээ. За ингэхлээр, гэгээн сайдад миний хэлэх юм гэвэл, ван эзний дүүгийн болсон багт наадам дээр, ямар янзын хуурамч хувцас хэрэглэсээр хатны дэргэд очиж чадсаныг нь та мэднэ, мөн Лувр ордонд хатантай уулзсан италийн зурхайч хүн чухамдаа Бекингэм герцог биеэрээ байсан гэдэг баталгаа мөн танд бий, мөн Амьенд болсон явдлыг та цэцэрлэг дотор, уул явдалд оролцсон гол хүмүүсийн дүрийг гаргасан сонирхолтой бага шиг роман болгож бичүүлэхээр тушаасан, Монтего Бастили гянданд бий, тэхлээр эрүү шүүлт тулгавал түүний санаж байгаа бүхнийг, тэр ч байтугай мартчихсан юмыг нь хүртэл хэлүүлж болно эцэст нь гэгээн сайдын өргөөнөөс олдсон, де Шеврез авгайн захидал таны гарт орсон тэр захидал" бичсэн хүнийхээ төдийгүй, нэрий нь өмнөөс бичсэн цаад хүнийг хүртэл муутгахаар агуулгатай юм. Цааш эд бүгдийг герцог хайхралгүйгээр өөрийнхөөрөө зүтгэвэл, миний авах даалгавар саяны тоочсон зүйлээр хязгаарлагдсан болохоор францыг ер бусын ид шид үзүүлж аварч үз гэж зөвхөн бурхнаас л гуйж залбирахаас биш. За ийм байх шив их гэгээнтэн. Өөр надад хийх юм үгүй биз?

-Тиймээ, энэ л байна гэж хамба хүйтэвгэр дуугарав. Ришелье хамба өөртэй нь өөр өнгөөр ярьж эхэлснийг Миледи ажаагүй юм аятай, яриагаа үргэлжлүүлэн,

өштний тухай мөн хоёр үг хэлэхийг надад зөвшөөрнө үү гэж хэлэв.

-Тэхлээр танд бас өштөн байдаг байх нээ?

-Тиймээ, их гэгээнтэн танд зүтгэж яваад би тэдэнтэй өштэй болсон болохоор та бүхий л аргаар тэдний эсрэг намайг дэмжих ёстой юмаа.

-Хэн бэ, тэд чинь?

-Нэгд, нэг өчүүхэн хэрэг будлианы эзэн Бонасье авгай.

-Тэр бүсгүй Мантийн гянданд бий.

-Миледи үүнд маргаж,

-Үгүй нарийн яривал түрүүн тэнд байсан юм. Гэвч хатан ван эзнээс бичиг аваад, тэр бүсгүйг гаргаж, хийдэд суулгасан байна гэв.

-Хийдэд ий?

-Тиймээ, хийдэд.

-Аль хийдэдтэр вэ?

-Мэдэхгүй үүнийг их чанд нууж байна.

-Би тэр нууцыг мэдье.

-Тэгээд, тэр бүсгүй аль хийдэд байгааг, их гэгээнтэн та надад хэлэх үү? -Үүнд би саад болох юм үгүй гэж санаж байна.

-За сайн...Гэвч энэ өчүүхэн будлиан хутгагч Бонасьегаас илүү их аюултай өөр нэг өшгөн байна.

-Хэн бэ?

-Бонасье авгайн амраг нь.

-Түүний нэр нь хэн гэдэг юм?

-Өө, их гэгээнтэн та түүнийг сайн танина! гэж Миледи хорсол бадран дуу алдаад, тэр чинь та бид хоёрын муу зүгийн шулам түүний ачаар, вангийн шадар цэргүүд их гэгээнтэн танай торгон цэргүүдтэй тулалдахдаа дийлээгүй юу. Танай элч де Вард гүнг илдээр гурав дахин бүлээд алмазан унжуурганы хэргийг баллачихсан тэр хүн. Эцсийн эцэст тэр хүн, Бонасье авгайг намайг хулгайлсныг мэдээд намайг алах гэж андгайлсан хүн гэлээ.

-Аа! гэж хамба уянгалуулан дуугараад, хэнийг хэлж байгаагий чинь би ойлгож байна гэв. -Тэр муу д'Артаньян новшийн тухай би ярьж байна.

-Тэр чинь зоригтой эр дээ.

-Тэх тусмаа л түүнээс болгоомжилбол зохих билээ.

-Түүний Бекинтэмтэй нууц харилцаатай байдгийн баталгааг олох юмсан, -Баталгаа гэнээ! би хэдэн арван баталгаа олж ирнэ гэж Миледи дуу алдав.

-За тэгвэл тэгээд л гүйцнэ дээ тэр баталгаа надад өгөөд орхи, би түүнийг чинь Бастили гянданд хорьчихье.

-За тэгье, гэгээнтэн тэгээд хожим нь

хариулаад, ишш чөтгөр алгад гэж, өстнөөсөө ангижрах гэдэг надад таных шиг амархан болоосой, иймэрхүү хүмүүсийн тухай та надаас хариуцлага үл хүлээх баримт бичиг гуйсансан ч болоосой гэв.

-Гэгээнтэн, хоёулаа хүний амийг хүний амиар сольё энэ хүний амийг та надад өг, танд би тэр хүнийхийг өгье гэж Миледи хэллээ.

Хамба лам үүнд, таны юу гэх гэж байгааг би мэдэхгүй байна, мэдэхийг ч хүсэхгүй, гэхдээ танд эелдэг тус хүргэмээр санагдлаа, тэгээд тэр өчүүхэн хүний тухайд, тэр дундаа таны хэлж байгаагаар тэр д'Артаньян чинь завхай тогтворгүй, тулалдахдаа дуртай хүн юм болтаны хүссэнээр болгож болмоор шиг санагдана гэж хариуллаа.

-Тун өөдгүй хүндээ гэгээнтэн үнэхээр муу явдалтай хүн шүү.

-Алив надад цаас, үзэг, бэх аль.

-Май цөм энд байна гэгээнтэн.

Нам чимээгүй болсноор үзвэл хамба лам тэр бичгээ яаж бичихийг дотроо бодож байгаа юм уу, аль бичиж байх бололтой. Ярианы үг бүрийггээлгүй сонссон Атос, нөхдөө хөтөлж өрөөний нөгөө буланд аваачлаа.

-Үгүй, Чамд юу хэрэгтэй юм бэ, чи яагаад биднийг дуустал чагнуулахгүй байгаа юм бэ гэж Портос уурсав.

-Аяархан гэм! гэж Атос шивнээд, бид мэдэх хэрэгтэй юм бүхнээ мэдэж авлаа. Ер та нарын сонсоход би саад хийх гээгүй. Ганцхан би л заавал явах хэрэгтэй байна гэв. -Чамд заавал явах хэрэг байна гэнээ? гэж Портос давтан хэлээд, хэрэв хамба ламтан таны тухай асуувал бид юу гэж хэлэх юм бэ" гэв.

-Өөрөө миний тухай асуухыг нь бүү хүлээ. Манай буудлын эзний зарим үг надад замд аюул байж болзошгүй гэсэн сэжиг төрүүлээд, намайг замаа туршихаар мордсон гэж өөрсдөө түүнд хэлээрэй. Тэгээд ч энэ тухай би хамбын дагуулд үг цухуйлгана, цааших нь миний хэрэг, тэр тухай чи бүү санаа зов гэлээ.

Атос болгоомжлоорой гэж Арамис хэлсэнд Атос хариуд нь:

-Бүү сэтгэл зов, миний биеэ барьж чаддагийг та нар мэднэ шүү дээ гэж Атос хариулав. Портос, Арамис хоёр дахиняндангийн дэргэд суулаа.

Атос ч яахав, бүхний нүдэн дээр гарч, нөхдийнхөө морины хажууд цонхны хаалтнаас уяатай байсан морио тайлж аваад, буцах замаа турших хэрэгтэй байгаа тухай хэдхэн үг хэлж хамбын дагуулыг үнэмшүүлэв. Тэгснээ гар бугаа зориуд айхтар шалгаж үзээд, илдээ амандаа зуугаад, аюултай үүрэг сайн дураараа гүйцэтгэх гэж байгаа цэргийн дүртэй хуаран орох замаар явж одлоо.

XLV. ЭР ЭМ ХОЁРЫН УУЛЗАЛТ

Атосын бодсончлон, хамба ламтан төдхөн доошоо бууж ирлээ. Шадар цэргүүдийн орсон өрөөний хаалгыг татаад үзвэл, Портос, Арамис хоёр тун ч улайран тоглож байлаа. Өрөөг эргэцүүлээд хартал, бие хамгаалагчдын нэг нь дутуу байгааг харлаа.

-Атос гуай хайчаа вэ? гэж хамба асуув.

-Атос урагшаа зам туршихаар түрүүлээд явсан, гэгээнтэн. Манай буудлын эзний зарим үг, зам аюултай байж магад гэдэг хар төрүүлсэн юм байх гэж Портос хариуллаа.

-Портос гуай, та юу хийж байв даа'

-Би Арамисаас таван алтан зоос хожлоо.

-За тэгвэл, одоо надтай цуг буцъя.

-Бид их гэгээнтэн таны төлөө зүтгэхэд бэлхэн байна.

-За, эрхмүүдээ мордьё, цаг оройтжээ.

Дагуул үүдний дэргэд, хамбын морийг шанаадаж бариад хүлээж байв. Жаахан цаашаа, харанхуйд гурван морь, хоёр хүний бараа сүүмэлзэх нь нөгөө Миледиг Ла Пуант боомтноо хүргэж өгөөд хөлөг онгоцон дээр суулгах учиртай улс мөн аж.

Атосын тухай хоёр буучны хэлснийг хамбын дагуул бас нотолж хэлэв. Хамба сайшааж толгой дохиод, наашаа ирэхдээ хэрэглэж байсан болгоомжлох аргаа хэрэглэн буцах замдаа оров. Хамбыг хоёр шадар цэрэг дагуулаараа хамгаалуулан, хуаранд буцна биз гэж орхиод, Атосын тухай ярьв.

Атос зуугаад алхам тэр хэвээрээ аажуухан явлаа.

Тэгээд өөрийгөө харж байгаа хүн үгүйг мэдмэгцээ баруун тийшээ эргэж, тойруу замаар буцаж давхиад, замаас хориодалхам зайтай байгаа хэсэг модон дотор орж нуугдав. Ингээд цаадуулынхаа явж өнгөрөхийг хүлээж байснаа, нөхдийнхөө өргөн хүрээтэй малгай, хамбын нөмрөгийн алтан цацгийг хараад, тэднийг замын тойруугаар далд ортол хүлээв. Тэгээд буцаж буудал руу давхиад ирсэнд түүнийг саадгүй орууллаа.

Буудлын эзэн түүнийг таньжээ.

-Манай дарга, дээр хоёрдугаар давхарт байгаа бүсгүйд нэг чухаг юм хэлэхээ мартжээ. Тэгээд мартсанаа хэлүүлэх гэж намайг явууллаа гэж Атос хэлсэнд, эзэн өөдөөс нь: -Дээшээ гарч үз, тэр бүсгүй одоогоор өрөөндөө бий гэв.

Атос зөвшөөрснийг ашиглаж, аль болох хөнгөн гишгэсээр, шатны тавцан дээр гараад, дутуу нээлттэй үүдний завсраар, Миледи малгайнхаа бүчийг уяж байхыг харав.

Атос өрөөнд ороод, үүдийг ньхаачхав.

Үүдний түгжээ дуугарахыг сонсоод Миледи эргэж харлаа.

Атос үүдний дэргэд, малгайгаа духдуулж нөмрөгөөр биеэ ороогоод зогсоно.

Энэ хөшөө шиг үл хөдлөх, дуугүй хүнийг хараад, Миледи айчихлаа.

-Та хэн бэ? танд юу хэрэгтэй юм бэ? гэж Миледи дуу алдав.

-"Тиймээ, тийм байж таарна. Мөн байна шүү" гэж Атос дотроо бодоод, Нөмөргөө хойш болгож малгайгаа ар тийшлүүлж өмсөөд Миледи рүү дөхөж очоод.

-Авхайтан та намайг таньж байна уу? гэж асуув. Миледи урагшаа болсноо, гэнэт могой үзсэн юм шиг гэдрэгээ огло үсрэв. Атос үүнд

-За сайн та намайг танив бололтой гэлээ.

-Де Ла Фер гүн! гэж Миледи шивнээд, царай нь зэвхийрч, ханандтултлаа гэдрэгээ ухарлаа.

-Тиймээ Миледи, де Ла Фер гүн тантай уулзаж баясахаар, зориуд нөгөө ертөнцөөс биеэрээ ирээд байна. Хамба гуайн хэлдэгчлэн суугаад ярилцъя даа гэж Атос хариулав.

Үнхэлцэг нь хагартлаа айж хэлмэгдсэн Миледи нэг ч үг дуугаралгүй суув. Атос үгээ эхэлж.

-Та чухамдаа амилсан шулам юм. Таны эрх мэдэл их гэдгийг би мэдэжбайна, гэхдээ хүн бурхны ивээлээр хамгийн аюултай шулмыг хүртэл дарсан удаа олонтойг та бас мэднэ. Та нэг удаа миний замд дайралдсан, би өөрий чинь газрын хөрснөөс цэвэрлэчихлээ гэсэн маань, нэг бол би андуурсан юм байх, авхайтан минь, эсвэл та тамаас амилчхаад гараад ирсэн юм байлгүй...

Аймшигт муухай юм санагдуулсан энэ үгийг дуулаад, Миледи битүүхэн ёолоод доошоо харчихлаа Атос үргэлжлүүлэн.

-Тэгжээ, тамаас л та амилаад гарч ирсэн дэг. Там таныг баян болгож, там танд өөр нэр өгөөд, таны нүүр царайг бараг танигдахгүй болтол өөр болгож. Гэхдээ тэр там сэтгэлийн чинь бузар буртгийг ч угаасангүй. Биен дээр чинь байгаа тамгыг ч арилгаж өгсөнгүй гэлээ.

Миледиг дороос нь юм хатгасан юм шиг босон харайгаад нүд нь гялалзана Атос суусан хэвээрээ.

-Та намайг үхчихсэн юм бодсон, тийм биз? Би ч мөн өөрий чинь үхсэн гэж санасан. Атос гэдэг нэр де Ла Фер гүнг нууж, Миледи Кларик гэдэг нэр Анна де Бейль гэгчийг нуужээ. Танай эрхэм ах биднийг суулгаж, адислахүед та тийм нэртэй байсан байхаа?...үгүй. нээрээ, бид хоёрын байдал их хачин юм байна гэж Атос инээмсэглэж хэлээд, бид хоёр нэг нэгнийгээ үхсэн гэж бодоод л өдий хүртэл амьд явлаа, дурдатгал гэгч зарим үед сэтгэлийг шаналгаах боловч, амьд хүн шиг их тээр зовлон болохгүй юм байна шүү дээ гэв.

Миледи хүчлэн байж, та юунд над дээр ирээ вэ? Надаар яах гэсэн юм? гэж хоолой нь бөглөрөн дуугарав.

-Өөрт чинь үзэгдэхгүй байсаар өөрөөс чинь нүдний хараа салгаагүй гэдгийг дуулгая гэсэн юм.

-Миний юу хийж байсныг та мэдэх юм уу?

-Таныг хамба ламын хамсаатан болсон цагаасаа хойш хийсэн бүх юмыг чинь би өдөр дараалан, өнөө оройных хүртэл тоочиж чадна.

Миледигийн зэвхийрсэн уруул ярвайж, үл итгэх байртай жуумалзав.

-Сонсож бай. Та Бекингэм герцогийн энгэр дээрээс хоёр ширхэг алмазан унжуурга хайчилж авсан, Бонасье авгайг та хулгайлсан, та де Вардад сэтгэлтэй сайн болчхоод, түүнтэй хонохын мөрөөдөл болж байж, д'Артаньян гуайг өвөртөө оруулсан, тэгснээ де Вард өөрий чинь хуурсан юм байх гэж бодоод, өрсөлдөгч д'Артаньянаар нь түүнийг алуулах гэж оролдсон. Тэгээд д'Артаньян өөрийн чинь шившигт нууцыг мэдэж орхихоор нь та түүнийг алуулах гэж хоёр хөлсний алуурчин авч буудуулахаар хойноос нь явуулсан. Ингээд тэр суманд д'Артаньян өртөөгүйг мэдээд та хор хийсэн дарс хуурамч захидалтай д'Артаньянд явуулж, түүнийгээ нөхдийн нь бэлэг гэж итгүүлэхийг оролдсон. Эцэст нь та энд, одоо миний сууж байгаа энэ сандал дээр сууж байгаад, дөнгөж сая Ришелье хамбын өмнө, Бекингэмийг хүн явуулж алах үүрэг аваад, түүний чинь хариуд, хамба танд д'Артаньяныг алах зөвшөөрөл өгсөн гэв.

Миледигийн царай үхсэн хүнийх шиг зэвхий даагаад явчихлаа.

-Та чинь өөрөө ёстой босоо ороолон юм байна, гэж тэр шивнэнэ.

-Магадгүй, юу ч гэсэн нэг юм санаж ав. Бекингэм герцогийг та алах юм уу, аль нэг хүн явуулж алдагсанж уу надад хамаа алга. Би тэр хүнийг танихгүй, тэгээд ч тэр англи хүн. Гэхдээ та миний нөхөр д'Артаньяны үсэнд ч гар бүү хүрээрэй, д'Артаньян миний үнэнч нөхөр, би түүнд сайн, өмгөөлж хамгаалж явдаг юм, эс тэгвэл эцгийнхээ нэрийг барьж андгайлъя танаас өшөөгөө тэр дор нь авна шүү гэхэд Миледи бөглүү дуугаар,

-д'Артаньян намайг муухай доромжилсон, д'Артаньян үхэх болно гэв. -Мөн, авхайтан таныг чинь тэгээд чухамдаа доромжилж бас болох юм бий? гэж Атос инээмсэглээд, тэр таныг доромжилсон, тэхлээр үхэх юм бий дээ? гэнээ.

-Тэр үхнээ, эхлээд тэр бүсгүй, дараа нь тэр өөрөө үхэх болно, гэж Миледи давтан хэлэв.

Атосын нүд харанхуйлаад явчих шиг боллоо, даанч бүсгүй хүний намбагүй энэ амьтныг хараад, сэтгэл шаналгасан юмсанаанд нь орж ирлээ. Одоогийнхоос арай аюул багатай тэр нэг цагт энэ бүсгүйг нэр төрийнхөө золиосонд гаргах гэж оролдсоноо саналаа. Энэ бүсгүйг алья гэж аазгай нь дахин барьж болшгүй их хүчтэй хөдлөөд ирлээ.

Атос босоод, гар буугаа шүүрэн авч, замгийг нь татлаа.

Үхсэн хүн шиг зэвхийрсэн Миледи хашгирах гэсэн боловч дуугарч өгсөнгүй, хөшиж орхисон амнаас нь хүний дуутай огтхон ч төсөөгүй хэржигнэсэн дуу гарах нь, зэрлэг араатны архирахтай илүү төстэй аж. Энэ бүсгүй хар хана руу гэдрэгээ наалдаж үс нь арзайчихсан ингээд байж байхдаа айж хэлмэгдэхийн туйл болжээ.

Атос буугаа алгуурхан өргөж, бууныхаа амыг Миледийн духанд хүргэх шахаад.

-Авхайтан та, хамба ламынтанд бичиж өгсөн цаасыг одоо даруйхан надад гаргаж өг, үгүй бол би таны духанд сум шигтгэлээ шүү гэж амь насаа барьж андгайлъя, гэж хөдөлбөргүй шийдсэн тайван дуугаар хэлсэн нь улам ч зүрх алдам айхтар сүртэй аж.

Өөр хүн байсансан бол санаснаараа болно гэхэд Миледи эргэлзэх байсан биз гэвч өөрөө Атосын занг мэдэж байлаа, тэгсэн мөртөө л хөдөлсөнгүй.

-Танд нэг эгшин зуур бодох чөлөө өгье гэж Атос хэллээ.

Ингээд, Атосын царай хачин хувьсхийснээр, юу юугүй буу тасхийхийг Миледи мэдээд, гараа бушуухан өргөж өврөөсөө нэг цаас гаргаад, Атост өгч:

-Май ав, чамд хараал хүрэг гэв.

Атос тэр цаасыг авч, буугаа бүсэндээ хавчуулаад, гэрэлдойртож, уул цаас мөн эсэхийг үзэх гэж дэлгэн уншвал:

"Үүнийг үзүүлэгч хүний хийсэн бүхэн, миний тушаалаар, улсын ашиг тусын тулд хийсэн болноо.

1627 оны намрын сүүл сарын 3

Ришелье гэжээ

Атос нөмрөгөөр биеэ ороож, малгайгаа дарж өмсөөд,

-За хорт могой минь, чиний хэлийг би одоо суга татсан хойно, чадвал хазаарай гэмгүй, гэв.

Ингээдөрөөнөөс гарч одохдоо эргэж ч харсангүй. Буудлын газрын үүдэн дээр, хоёр морьтой хүн, бас нэг морь хөтлөөд зогсож байгааг Атос хараад тэдэнд:

-Эрхмүүдээ хамба гуай, та нарт түрүүн хэлсэнчлэн, энэ бүсгүйг даруй цаг үрэлгүй Ла Пуант боомтонд хүргэж өгөөд, хөлөг онгоцонд дээр суутал нь ганц ч минут бүү холдоорой гэж тушаалаа гэв.

Атосын үг, тэр хүмүүсийн авсан тушаалтай бүрэн нийцэж байгаа болохоор, тэр хоёр гүйцэтгэхэд бэлэн байгаагаа илчилж мэхэсхийв.

Атос ч яахав эмээл цээрээ хөнгөхөн үсэрч гараад, хар хурдаараа давхилаа. Тэхдээ замаар явахын оронд морио давиран, тал дундуур чигээрээ давхиад хаа нэг зогсож юм чагнана.

Ингэж нэг зогсохдоо замаар явж байгаа морьдын туурайн чимээ сонсоод, хамба лам нөхөдтэйгөө явж байна гэж лав мэдэх тул цаашаа бас баахан давхиж байгаад, морио модны навчтай мөчрөөр арчиж, хуарангаас хоёр зуугаад алхам хиртэй газар зам дээр гарав.

Морьтой хүмүүс ирж явахыг хараад, Атос,

-Хэн явж байна вэ? гэж хашгирав.

-Энэ чинь манай зоригт шадар цэрэг шив? гэж хамба асуусанд Атос:

-Тиймээ, гэгээнтэн, би биеэрээ байна гэж хариуллаа.

-Атос гуай та биднийг ингэтэл сайн хамгаалсанд би баяр хүргэе. За бид хүрээд ирлээ, эрхмүүдээ та нар зүүн харуул руу явцгаа, орох нууц үг "ван эзэн Ре" гэнэ шүү. Ингэж хэлээд хамба ламтан, гурван нөхөдтэй толгой дохин салж, дагуултайгаа хамт, хуаранд хонохоор, баруун тийшээ эргэв.

Хамба, лам, тэдний яриаг дуулж чадахааргүй холдсон хойно, Портос Арамис хоёр нэг дуугаар үгүй ингэхэд, Миледийн гуйсан бичгийг хамба лам бичээд өгчив өө гэлээ.

-Тэгсэн, энэ бичгийг бичиж өгсөн юм гэж Атос тайван хариулав.

Ингээд гурван нөхөд, харуулын хүнд нууц үг хэлж нэвтэрснийг эс тооцвол, байраа хүртэл ганц ч үг сольсонгүй.

Тэд нар Мушкетоныг Планше рүү явуулж эзнийгээ сувгийн харуулаас ирмэгц шадар цэргүүдийн байранд даруй ир гээрэй гэж хэлүүлэв.

Миледи ч яахав, Атосын санасанчлан буудлын үүдэн дээр хоёр хүнтэй дайралдаад, ямар ч маргаангүйгээр тэднийг дагаж явлаа. Буцаж, хамба лам дээр очоод, бүгдийг ярьж гэдэг бодол түүний толгойд нэг орж ирсэн боловч, Миледиг үнэнээ ярьж илчлэхэд, Атос мөн юм ярихад хүрэх болно. Атосыг нэг удаа өөрийгөө дүүжилсэн гэж хэлж болох юм гэтэл Атос, өөрий нь тамгалуулсныг хэлэх болно. Тэхлээр нууцаар яваад, авсан хэцүү даалгавраа ердийнхөөрөө чадмаг биелүүлж бүгдийг хамбын таалалд нийцүүлсэн хойноо, өөрийнхөө өшөө авалтад туслахыг шаардсан нь дээр гэж үзлээ.

Ингээд , бүхэлшөнөжин эмээл дээр явж өнгөрөөд, Ла Пуант хотод өглөөний долоон цагт ирээд, найман цаг болоход хөлөг онгоцон дээр нэгэнт суучихсан байв. Ингээд есөн цаг болоход, дайсны худалдааны онгоцыг далайд хөөж барих хамбын гарын үсэг бүхий, засгийн газрын үнэмлэхтэй тэр онгоц Байон гэгч газар руу явна гэж хөдлөөд, Английн эрэг чиглэв.

XLVI. СЕН ЖЕРВЕ ЦАЙЗ

д'Артаньян нөхөд дээрээ иртэл цөм нэг өрөөнд байж байлаа. Атос нэг бодол болж, Портоc сахлаа имэрч Арамис цэнхэр хамбан баринтагтай хавтастай, жижиг хөөрхөн номоор залбирал уншиж сууна.

-Чөтгөр алгад, эрхмүүд надад нэг чухаг юм дуулгах биз гэж найдна тэхгүй бол цайзыг дайран эзэлж, нураасан ийм айхгар шөнийн дараа амраагүйг чинь би ер уучлахгүйг эртхэн хэлье. Үгүй, эрхмүүд та нар л тэнд байгаагүй нь тоогүй, сүрхий халуун тулалдаан болсон шүү.

Портоc сахлаа тун ч дэгжин эргүүлээд,

-Бид бас л тэрнээс чинь дутуугүй халуухан газарт байлаа гэж хэлэв.

-Чиш дуугүй бай, гэж Атос хориглолоо

Шадар цэргийн ингэж хөмсөг зангидсаны учрыг д'Артаньян гадарлаад,

-Уухай! та нарт нэг шинэ юм болжээ? гэв.

-Арамис та уржигдар Кальвинийн гуанзанд хоол идсэн байхаа? гэж Атос асуув.

-Тэгсэн.

-Тэнд ямар шүү юм бэ?

-Мацаг барьсан өдөр байгаад, би ч муухан юм идсэн тэнд ер нь хөнгөн хоол өгч байсан л даа,

-Юу? Далайн боомт газарт загасны мах үгүй байсан гэж үү? гэж Атос гайхлаа.

-Тэдний хэлж байгаагаар бол хамба гуайн байгуулж байгаа далангаас хамаг загас үргээд, далайд гарчихдаг юм гэнэ гэж Арамис дахин буяны үйлээ үргэлжлүүлэх зуураа тайлбарлав.

-Үгүй, Арамис танаас, би энэ тухай асуугаагүй байна, тэнд хоол идэхэд гайгүй чөлөөтэй байв уу хэн хүн танд төвөг удаад байгаагүй биз?

-Тэнд, төвөгтэй улс их олон байгаагүй шиг санагдана... нээрээ Атос таны ярих гэж байгаа юманд тэр гуанз ер тохиромжтой газар даг шүү.

-За тэгвэл тийшээ явъя. Эндхийн хана гэдэг чинь папирус цаас гэсэн үг гэж Атос шийдлээ.

Нөхрийнхөө ааш авирт дасч, хэргийн байдал чухаг болохыг түүний нэг үг, дохио юм уу, зангасан төдийгөөр мэддэг болсон д'Артаньян, Атосыг сугадаж аваад, өөр юу ч асуулгүй хамт гарав.' Портоc, Арамис хоёр нөхөрсгөөр яриа дэлгэн тэдний хойноос дагалаа.

Зам зуураа тэд Гримотой дайралдаад, Атос түүнийг цуг яв гэж дохисонд, цаадах нь ердийнхөө зангаар дуугүй үгэнд орлоо. Хөөрхий хүн бараг үг яриагаа мартчих шахсан аж.

Нөхөд явсаар нөгөө гуанзны газар хүрч ирэхэд өглөөний долоон цаг болж, үүр гэгээрч байлаа. Тэд өглөөний хоол захиалаад, эзний хэлснээр тэдэнд саад болох нэг ч хүн байхгүй байгаа нийтийн тасалгаанд орлоо.

Гай болоход нууц зөвлөгөө хийх цагаа муу сонгож авсан болохоор.. өглөөний босох дохио дөнгөж сая дуугараад, шөнийн нойроо сэргээх, даарсан биеэ дулаацуулахаар нэг хундага дарс уучих гэсэн хүн олон орж гарна. Морин цэрэг Швейцар цэрэг, торгон цэрэг, шадар цэрэг, даруй ээлжлэн цуврах нь эзэнд их таатай боловч, манай дөрвөн нөхдийн санаатай огт нийлэхгүй байв. Иймээс, дайчин нөхдийнхөө мэнд мэдэж, баяр хүргэх, хундага өргөх сэлтэд манай дөрөв баахан дурамжхан хариулж суув.

-Больё эрхмүүдээ, аягүйдвэл, энд бид хэн нэг хүнтэй муудалцаад орхиж мэднэ, одоодоо тийм явдал бидэнд тун хэрэггүй, д'Артаньян та энэ шөнийг яаж өнгөрүүлснээ бидэнд ярьж аль, бид ярих юмаа сүүлд нь ярья гэж Атос хэллээ.

Нэг хундага архи барьж, алгуурхан шимж зогссон морин цэрэг, үл мэдэг ганхан байж ярианд оролцон үгүй нээрээ, эрхэм торгон цэргийнхэн та нар өнөө шөнө сувагт байж байгаад, Ларошельчүүдтэй тооцоо хийсэн байхаа? гэв.

д'Артаньян, ярианд хөндлөнгөөс оролцсон хүнд хариулах уу, байх уу гэж асуух байртай Атос өөд харсанд,

Де Бюзиньи чамаас юм асууж соёрхсоныг чи дуулсангүй юу? Энэ эрхмүүд, шөнийн явдлыг дуулахсан гэж байгаа хойно ярьж өгөөч гэж Атос хэлэв.

Пивоны том аягаар ром дарс ууж суусан нэг швейцар цэрэг, та нар цайзыг дайрч аваа юу? гэж асуулаа.

д'Артаньян хариу мэхэсхийгээд, тэгсээн, эрхмээ. Бидэнд тийм завшаан тохиолдлоо. Та дуулсан ч байж магадгүй, бид цайзын нэг булан доор, дарьтай торх хийж байгаад дэлбэлчихсэнд, сүрхий том нүх гарсан, цайз уул нь хуучин юм болохоор бусад хэрэм нь мөн сүрхий хөдөлж муудсан байна билээ гэв.

Сэлэмнийхээ үзүүрт галууны мах шорлож ирээд, шарахаар зэхэж байгаа нэг морин цэрэг, үгүй, ямар Дайзыг тэр вэ? гэлээ.

-Сен жерве цайз,

Тэр цайзаар халх барьж Хүрээллийнхэн, манай газар ухаж байгаа улсыг сандраагаад байсан юм л даа гэж д'Артаньян хариуллаа.

-Ширүүн юм болов уу тэгээд?

-Хэлээд яахав. Манайхан таван хүнээ алдаж, Ларошельчүүд ес арван хүнээ алуулсан.

-Герман хэлэнд, хараалын муу үг мундахгүй их боловч, франц маягаар харааж заншсан нөгөө Швейцар цэрэг,

-Чөтгөр алгад гэж дуу алдана.

-Үгүй, Хүрээллийнхэн, цайзаа засаж янзлахаар өнөөдөр ажил хийх хүмүүс явуулна байх даа?

-Лав тэх байхаа гэж д'Артаньян хэлтэл Атос хажуунаас.

-Эрхмүүдээ, мөрий тавья гэлээ.

-За тэгье мөрийцье, гэж Швейцар цэрэг тосч авлаа. Морин цэргийн хүн шохоорхож, ямар мөрий вэ? гэхэд нөгөө сэлмэндээ шувууны мах шорлон байсан цэрэг, голын захад байсан хоёр тулгуур дээр сэлмээ дамжуулж тавиад,

-Байзаарай, би бас оролцмоор байна. Хөөе, буудлын эзэн, чи энэ үнэт галууны тосноос, нэг дуслыг ч үрэгдүүлэхгүйн тулд даруй шардаг юм аваад ир гэлээ.

Швейцар цэрэг үүнд,

-Үүний хэлдэг зөвөө, галууны өөхийг чанасан жимстэй идэхэд, сайхан амттай юм шүү гэв.

-За сайн, гэж морин цэргийн хүн санаа амрав бололтой дуугараад за нөгөө мөрийцөх юмаа ярья, Атос гуай таны хэлэх юмыг бид сонсьё гэлээ.

Үгүй, юун мөрий вэ, гэж бас нэг морин цэрэг сонирхоно

-За тэхлээр, де Бюзини гуай, би тантай ингэж мөрийцье. Миний гурван нөхөд, Портос, Арамис, д'Артаньян бид нар Сен Жерве цайзан дээр гарч өглөөний хоол идээд яг нэг цаг тэнд байж чадна. Дайсан биднийг хөөх гэж хэдий оролдлоо ч гэсэн бид нэг минут дутуу ч үгүй, илүү үгүй, яг нэг цаг болж чадна гэж Атос хэллээ.

Портос, Арамис хоёр хэргийн учрыг олж байх бололтой өөд өөдөөсөө харлаа.

д'Артаньян Атосын чихэнд шивнэж, Болиоц, биднийг зүгээр алчихна шүү дээ, гэв. Атос үүнд,

-Харин биднийг тийшээ явахгүй бол гарцаагүй алчих бий гэж хариуллаа.

Портос сандлынхаа арыг түшиж налайгаад,

-Нээрээ, эрхмүүдээ, энэ чинь ёстой догь мөрий байна гэв.

-Үгүй, би ч гэсэн үүнийг ойлгож байна, тэхлээр тавих юмаа л ярилцаж тохирьё гэж де Бюзини хэллээ.

-Эрхмүүд та нар дөрвүүлээ юм байна, бид ч бас дөрвүүлээ тэхлээр найман хүнд, хүн тус бүрийн хүсэлтэй хоолыг захиалахаар мөрийцвөл, та нар юу гэх вэ? гэж Атос санал гаргав.

-Их догь гэж Де Бюзинийг хэлэхэд, морин цэргийн хүн бас,

-Их сайн гэж зөвшөөрлөө. Швейцарь цэрэг санал зүйтэй, нийлье гэв.

Тэр болтол дуугүй байсан дөрөвдөх хүн мөн л юм хэлэлгүй, толгой дохив. Буудлын эзэн ирж,

-Эрхмүүдээ, та бүхний хоол бэлэн боллоо, гэсэнд Атос

-Аваад ир л дээ гэлээ.

Буудлын эзэн хоол авчирсанд, Атос, Гримог дуудаж өрөөний буланд байсан сагс руу заагаад халуун хоолыг боож байх янзтай дохив.

Гадаа агаарт хоол идэх болж байна гэдгийг Гримо даруй ойлгоод, сагс авч хамаг хоолыг тэнд хийгээд, шилтэй дарснууд мөн цуг хийгээд сагсаа барив.

-Та нар хоолоо хаана идэх гэж байгаа юм бэ? гэж буудлын эзэн асуусанд Атос хариуд нь:

-Үгүй таны мөнгийг л төлбөл хамаагүй юм биш үү? гэлээ.

Ингээд Атос хоёр алтан зоос ширээн дээр ихэмсэг байртай хаячихав.

-Эрхэм дарга, хариултаа авахсан болов уу? гэж эзнийг асуухад:

-Хэрэггүй. Зүгээр л хоёр шил шампанск дарс нэмээд хийчих, үлдсэн нь алчуур сэлтийн хөлс болно биз гэв.

Буудлын эзний эхлээд санасан шиг тийм их хожоо гармааргүй болоод ирлээ, тэхлээр тэр хүн манай дөрвөн нөхдийн хоолонд хоёр шил шампан дарсны оронд анжуй дарс хоёр шилийг хийж аргалаад хожоогоо багасгасангүй өнгөрөв.

-Де Бюзины гуай та цагаа минийхтэй тааруулахсан болов уу аль би өөрийнхтэй чинь тааруулах уу? гэж Атос асуув.

-За сайн, өршөөлт эрхмээ, гэж морин цэргийн хүн, алмас чулуун чимэгтэй сайхан цаг гаргаж ирээд долоон цаг хагас болж байна гэв.

Атос үүнд миний цаг долоон цаг гучин таван минут болж байна. Миний цаг таныхаас таван минутаар түрүүлж яваа юм байна гэж мэдье, өршөөлт эрхмээ гэлээ.

Ингээд буудалд байгаа, гайхаж хоцорсон хүмүүст мэхийж ёслоод, дөрвөн залуу нөхөд, сагс барьсан Гримог дагуулсаар Сен Жерве цайз руу алхав. Гримо Атост үг дуугүй захирагдаж сурсан болохоор, хаашаа явж байгаагаа өөрөө мэдээгүй боловч, энэ тухай асууя гэж санаанд нь ч орсонгүй.

Дөрвөн нөхөд, хуаран дундуур явж байх зуураа ганц ч үг сольсонгүй, тэгээд ч мөрийцсөн тухай дуулж амжаад, дөрвөн нөхдийг энэ байдлаасаа яаж мултрахыг нь үзэх гэж хэрэгт дурласан хүмүүс дагаж явлаа. Гэвч дөнгөж хуарангийн бэхлэлтээс гадна гарч талд гармагц, өнөө хүртэл юу ч мэдэж чадаагүй, д'Артаньян, учир асуух цаг боллоо гэж үзэв.

-За, бид одоо хайчих гэж явааг эелдэг нөхөр Атос минь хэлж аль гэв.

-Бид цайзан дээр гарах гэж явааг өөрөө мэдэж байгаа шүү дээ гэж Атос хариуллаа.

-Тэнд очоод бид юу хийх юм бэ?

-Хоолоо иднэ гэдгийг та бас мэдэж байгаа шүү дээ.

-Бид хоолоо саяны гуанзанд идэхэд яасан юм бэ?

-Яагаад гэвэл бид тун чухал зүйл ярилцах ёстой байна. Гэтэл тэр буудалд чинь, орж гараад, элдэв үг яриа дэлгэж төвөг удаад, мэнд ус мэдээд амар заяа үзүүлэхгүй төвөгтэй улс таван минут ч болов тайван ярих боломж өгөхгүй юм. Энд гээд Атос цайз руу зааж, бидэнд саад болох гэж ирэх хүн үгүй байхаа гэв.

д'Артаньян мохошгүй эр зоригтойгоо сайхан нийцсэн хянуур зангаа гаргаж, миний санахад, бид далайн захын нэг гүвээн дотор аятайхан буйд газар олж болох байсан юм биш үү? гэв.

-Тэнд бидний дөрвүүлээ суугаад ярьж байгааг улс цөмөөрөө хараад, мөч болоогүй байхад, хамбын тагнуулууд биднийг юм зөвлөж байна гэж хамбад хов хүргэх байсан даа.

-Тиймээ Атосын хэлдэг үнэн. "Тэднийг эзгүй хээр явахыг нь ч хардаг" гэж байдаг юм, гэж Арамис тосч хэлэхэд, Портос үг нэмэрлэж:

-Эзгүй хээр очвол зүгээр л байхсан, ганцхан гайтай нь л тэр эзгүй газрыг чинь олоход бэрх юм гэлээ.

-Шувуу дээгүүр нь нисээд гарч болохгүй, усан дотроос загас шомбос хийхгүй, бутны цаанаас туулай гараад дэгдэж болохгүй тийм эзгүй газар гэж үгүй. Гэтэл шувуу, загас, туулай цөм хамбын тагнуул туршуул болчихсон юм шиг над санагдах юм. Тэхлээр одоо, нэрээ хугалъя гэхгүй бол нэгэнт буцах нь хожигдсон энэ хэргээ л бүтээхээс биш. Бид урьдаас төлөвлөсөн байж болохооргүй юмаар мөрийцсэн тэхлээр түүний шалтгийг мань хүн гадарлаж чадахгүй дэг. Тавьсан мөрийгөө алдахгүйн тулд бид, цайзын дээр нэг цаг болно. Биднийг дайрч ч магадгүй үгүй ч байж мэднэ. Биднийг дайрахгүй бол бидэнд хамаг юмаа ярилцах цаг элбэг гарна, тэгээд бидний яриаг хэн ч сэм сонсохгүй, тэр цайзны хэрмэнд чих байхгүй гэдгийг би баталъя, биднийг дайрлаа ч гэсэн бид мөн ярилцаж амжина бас өөрсдийгөө хамгаалаад бид алдар цуугаа мандуулна. Ингэхлээр аль ч талаар нь аваад үзсэн бидэнд ашигтай байгааг өөрснөө харж байгаа биз дээ гэв.

-Тийм юмаа гэж д'Артаньян санал нийлээд гэхдээ бид сумнаас зайлахгүй дээ гэв.

-Үгүй, дайсны илгээж байгаа сум, хамгийн аюултай нь биш гэдгийг та мэднэ хойно, гэж Атос маргана.

Портос ярианд оролцож,

-Тиймэрхүү юманд явж байгаа улс ядаж, буугаа авсан бол зүгээр юм шиг санагдах юм гэлээ.

-Портос найз минь чи тэнэг байна. Юунд тийм илүү ачаагаар өөрсдөө тээр болгох юм бэ?

-Дайсантай нүүр учрахын цагт, сайн буу, олонхон сум, дарины сав сэлт надад хэрэггүй санагддаггүй юм шүү.

-Үгүй, д'Артаньяны хэлснийг та дуулсангүй гэж үү? д'Артаньян юу хэлсэн юм бэ?

-Шөнийн дайралтын үед арваад франц мөн төдий хир Ларошельчүүд алагдсан гэж тэр хэлсэн шүү дээ.

-Тэгээд юу гэж?

-Тэднийг тонож амжаагүй байгаа тийм үү? тэр үед тэд илүү чухал ажилтай байсан биз дээ?

-За тэгээд?

-Яагаав дээ тэнд бид алагдсан улсын буу сум, дарины савыг олно. Тэгээд бид дөрвөн буу нилээд олон сум гэхгүй арван хэдэн буу, цаана нь зуугаад сумтай болно.

-Үгүй, Атос чи нээрээ сод хүн юмаа, гэж Арамис дуу алдлаа.

Портос мөн үүнтэй санал нийлж байгаагийн тэмдэг болгож толгой дохив.

Ганцхан л д'Артаньянд Атосын үг их үнэмшилтэй санагдсангүй бололтой.

-Гримо янз нь манай залуутай нэг адил зовоод байх бололтой эхлээд цайз руу явна гэдэгт Гримо эргэлзэж байснаа тийшээ явсаар л байхаар эзнийхээ хормойноос чангаагаад.

"Бид хаашаа явж байгаа юм бэ?" гэж асуух байртай дохив.

Атос, цайз руу заасанд Гримо мөн л дуугарахгүй нөгөө дохиогоороо:

"Биднийг тэнд нухчина шүү дээ" гэв.

Атос, дээшээ тэнгэр рүү хараад, гараа өргөлөө.

Гримо, сагстай юмаа газар тавьчихаад толгой сэгсрэн, газар суучихав.

Атос үүнд гар буугаа авч, сумы нь шалгаж үзээд замгий нь татаж, Гримогийн чихэнд тулгалаа. Тэгтэл Гримо даруй үсрэн босов.

Гримог сагсаа аваад, урд талд яв гэж Атос дохисонд тэр даруй урд ороод явлаа.

-Минутын зуур ийнхүү тохиолдлоос, Гримо юу хожив. гэвэл, ард явснаа л түрүүнд гарлаа.

Дөрвөн нөхөд, цайзан дээр гараад, эргэж харав.

Төрөл бүрийн ангийн гурван зуу гаруй цэрэг хуарангийн харуулын байрны дэргэд

бөөгнөрчихсөн байна, тэндээс жаахан цаана, д' Бюзины, морин цэргийн хүн, швейцар цэрэг, мөрийнд оролцсон бас нэг хүн дөрвүүл бусдаас жаахан зайдуу зогсож байхыг таньж болохоор байв. Атос малгайгаа авч, илднийхээ үзүүрт өлгөөд даллав.

Харж байсан улс үүнд цөм мэхийн ёсолж хариулаад чангаар уухай хашгирах нь манай зоригт дөрөвт дуулдлаа. Ингээд дөрвүүлээ цайзанд орж далд орлоо. Гримо хэдийнээ тийшээ ороод хоргодож амжжээ.

XLVII. ШАДАР ЦЭРГИЙНХНИЙ ЗӨВЛӨГӨӨН

Цайзан дээр, үнэхээр Атосын бодсончлон франц, цэрэг болон Ларошелийн талаас алагдсан арван хоёр хүний хүүрээс өөр хэн ч үгүй байв. Энэ хэргийг толгойлох үүргийг Атос өөрөө хүлээж, эрхмүүдээ, Гримог хоол дэлгэж байх зуур бид юуны өмнө буу, сум цуглуулж авья. Тэгээд ч цуглуулж байх зуураа бид ярих юмаа ярихад саадболох зүйл огт үгүй энэ эрхмүүд. бидний үгийг чагнахгүй гэж алагдсан улсыг зааж хэлэв.

-Үгүй, эдний чинь суваг руу хаячихвал дээргүй юу? Харин өвөрт нь юм байна уу, үгүй юу, урьдаар үзэх юм шүү гэж Портоc хэлэв.

-Тиймээ, тэр ч яахав Гримогийн ажил, гэж Атос дуугарав.

-За, тэгвэл Гримо эднийг нэгжиж үзээд, суваг уруу хаячхаг л дээ, гэж Артаньяныг хэлэхэд Атос хариуд нь:

-Огт болохгүй шүү, эд чинь бидэнд хэрэг болж магад

-Энэ алагдсан улс бидэнд хэрэг болж мэднэ гэж үү? гэж Портоc гайхаад,

-Үгүй эелдэг нөхөр минь, чи солиорч байх шив? гэлээ. "Яаран бүү дүгнэ" гэж бурхны ч номд байдаг, Хамба ламтан ч ярьдаг юм гэж Атос хариулаад, хичнээн буу байна, эрхмүүдээ гэв.

-Арван хоёр буу байна, гэж Арамис хариуллаа.

-Хэдэн сум байна?

-Зуугаад сум?

-Затэгвэл, бидэнд хэрэгтэй юм маань байна гэсэн үг буугаа цэнэглэе. Дөрвөн нөхөд, энэ ажилд орлоо. Гримог хоол бэлэн боллоо гэж дохиход, тэд буугаа сумлаад дуусав.

Атос хариуд нь сайшаах байртай дохиод, харуулын цонх руу заасанд, тэнд очиж харуул харах ёстой, болсныг Гримо ойлгов. Тэхдээ Гримог харуул харахад нь онц уйтгартай байлгахгүйн тулд бөөн талх хоёр хэсэг бөөн мах, нэг шил дарс авахыг Атос зөвшөөрлөө.

-За одоо хоолоо идье гэж Атос уриад, дөрвөн нөхөд, газар дээр турк улс юм уу, оёдолчид шиг завилан суув.

За одоо, хүн сонсчих вий гэж айх юм үгүй болсон хойно, нууц юмаа бидэнд ярьж өгнө байгаа гэж Артаньян хэлэв.

-Эрхмүүдээ, та нарыг би аятайхан цэнгүүлж, мөн алдрыг чинь мандуулах болов уу гэж санана. Та нарыг би сайхан зугаалга хийлгэлээ, амттай сайхан хоол энд байна, тээр тэнд буудах нүхээр таван зуун хүн биднийг харж, байгааг өөрсдөө хар. Тэр улс биднийг нэг бол баатрууд, эсвэл тэнэгүүд гэж санаж байгаа, ер нь энэхөөр янзын тэнэглэлт чинь хоорондоо тун их төсөөтэй юм шүү, гэж Атос хэлэв.

-Үгүй нөгөө, нууц юу боллоо? гэж д'Артаньян асуусанд Атос хариуд нь: -Миний тэр нууц уу, өчигдөр орой би Миледитэй уулзсан юм гэв.

д'Артаньян энэ үед аягатай дарс амандаа ойртуулаад байснаа, Миледигийн нэрийг дуулаад, гар нь хүчтэйчичирсэнд, дарсаа цалгиахгүй гэж аягаа газар тавиад,

-Чи өөрийн э... гэтэл Атос үгийг нь зогсоож чш энэ эрхмүүд таны адил манай гэр бүлийн нууцыг мэддэггүйг бүү мартаарай. За тэгээд, би Миледитэй уулзсан даа? гэхэд Артаньян".

-Хаана тэр вэ гэлээ.

-Эндээс, хоёр мод орчим багцааны газар "сайхан тагтаа" гэдэг буудлын газар. -За тэгвэл, би өнгөрчээ, гэж д'Артаньян дуугарав.

-Үгүй, арай ч бүр балраагүй, юу гэвэл Миледи одоо франц нутгаас гараад явчихсан байх гэж Атос хэлээд, д'Артаньян санаа амарсан бололтой, санаа алдлаа.

-Үгүй ингэхэд, тэр Миледи гэгч чинь, чухам хэн болоод байнаа? гэж Портос сонирхлоо.

Атос хөөсөрсөн сайхан дарсамтлаад, гуа сайхан бүсгүй, гэснээ золигийн муу буудлын эзнийг хараач! Шампан дарсны оронд, анжуй хийчихээд биднийг мэхэлж болно гэж санасан байна шүү!... гэж дуу алдсанаа, яриагаа залган тийм шүү, гуа сайхан бүсгүй, тэр бүсгүй манай найз д'Артаньянд ихээ талтай байсан юм. Гэтэл энэ өөрөө нэг булай юм хийчихсэнд, тэр бүсгүй өшөө авахаар оролдож байгаа юм. Сарын өмнө д'Артаньян руу алуурчин улс хөлслөөд ирүүлсэн, долоо хоногийн өмнө хор өгөх гэж оролдоод, өчигдөрүүний амийг Хамба ламтнаас гуйсан юм.

д'Артаньян айсандаа царай нь зэвхийрээд, -юу? Миний амийг Хамбаас гуйж авсан гэнээ? гэж дуу алдлаа.

-Энэ ч яриагүй үнэн, би өөрөө чихээрээ үүнийг дуулсан юм гэж Портос нотлов. -Би ч мөн дуулсан, гэж Арамис хэллээ.

-Тийм бол тэмцээд тэмцээд дэмий, зүгээр л би духандаа сум зоогоод, энэ бүгдийг нэгмөсөн дуусгавар болгоё, гэж цөхөрч гүйцсэн д'Артаньян өгүүллээ.

-Хэзээ ч тэгж тэнэглэж амжина ганц энэ чинь л засаж болохгүй зүйл дээ, гэж Атос хэллээ.

д'Артаньян хариу маргаж, үгүй, ийм хүчирхэг дайсантай болсон хойно би үхлээс мултарч чадахгүй. Нэгд, Менгэд уулзсан танихгүй хүн байна, дараа нь би илдээр гурав хатгасан де Вард гүн байна, нууцыг нь би санамсаргүй олоод үзчихсэн Миледи байна эцэст нь өшөө авах хэрэгт нь саад болчихсон Хамба ламтан байна, гэв.

-Үгүй, тэд чинь тэгээд тийм олон байна гэж үү? дөрөвхөн л юм байна! Бид бас дөрвүүл шүү дээ, тэхлээр тоо халз тулгарчбайна...

-Чөтгөр алгад, Гримогийн дохиж байгааг харвал янз нь одоо бид арай илүү тооны хүнтэй

тулгарах даг...

-Юу болж байна, Гримо? байдлын чухлыг бодоод ярихыг чамд зөвшөөрье. товчхон л хэлж үз, юу харагдаж байна гэв.

-Баахан улс ирж явна.

-Хичнээн хүн?

-Хорь?

-Юун улс вэ?

-Газар ухах ажилхийх арван зургаан хүн, дөрвөн цэргийн хамт явна.

-Хэдий хир хол байна?

-Таван зуугаад алхмын цаана

-За сайн, бид энэ тахианы махыг идэж дуусаад, д'Артаньян чиний эрүүл мэндийн төлөө нэг аяга дарс уучхаж амжих юм байна, Арамис, Портоc хоёр мөн тосч аваад чиний өлмий бат оршиг, гэв.

-За тэгьеяхав. Та нарын энэ ерөөл надад онц их тус болно байх гэж би горьдохгүй байна гэж д'Артаньян хэлэхэд, Атос сургамжилж;

-Бүү гутар, Лалын шажинтны ярьдгаар аллах тэнгэрийн хүчин агуу их, ирээдүйн бүх явдлыг тэр л мэднэ гэдэг билээ гэв. Ингээд, Атос аягатай дарсаа ууж дуусгаад, аягаа дэргэдээ тавьж, залхуурсан байртайбосоод, гартаа дайралдсан нэг бууг аваад цайзын халхавч руу очив.

Портоc , Арамис, Артаньян гурав түүнийг дууриаж мөн тийшээ очоод, Гримо тэдний ард зогсоод, буу цэнэглэх тушаал авлаа. Минут хир болоод, нөгөө бөөн улс харагдав. Тэд цайз хот хоёрыг холбосон ухмал нарийн сувгаар ирж явлаа.

-Чөтгөр алгад үгүй, хүрз, зээтүү барьсан хотын хориод иргэдээс болж бид нэг сандрах юм уул нь байсангүй үүгээр л Гримо тэдэнд зайл гээд дохиж орхисон бол биднийг сандраалгүй лав яваад өгөх байсан гэж би итгэж байна, гэж Атос хэлэхэд д'Артаньян:

-Үгүй байх аа, дэд чинь наашаа тун шийдмэг алхаад байнашүү. Тэгээд ч энэ хотынхонтой хамт дөрвөн буутай цэрэг дагуулсан дарга явна шүү дээ, гэв. Атос маргаж, Тэд чинь биднийг хараахан хараагүй болохоороо л тэгж их зоригтой яваа юм, гэлээ. -Үгүй, энэ хөөрхий хотынхныг буудах гэдэг, үнэнээ хэлбэл надад тун ч аягүй байна гэж Арамис дуугарлаа.

-Нээрэн Арамисын зөв гэж, Атос санал нийлээд би гарч, тэдэнд хэлье, гэв. Артаньян үгүй, таны чинь ямар чөтгөр хатгачхав аа! Нөхөр минь, чамайг буудаад алчихна шүү дээ гэж Атосыг хориглох санаатай хэлээд үзлээ.

Атос энэ үгийг огт хайхралгүй, цайзын ханын сэтэрсэн газарт очоод, нэг гартаа малгайгаа, нөгөө гартаа буугаа барьж зогсоод ухах улс цэргүүд өөд хандаж, эелдгээр мэхийн мэндчилэв. Ингээд чанга дуугаар:

-Эрхмүүдээ би, хэдэн нөхрийнхөө хамт одоо энэ цайзан дээр хоол идэж байна. Гэтэл хоол идэж байхад, төвөг удах хир аягүй байдгийг та бүхэн мэдэх хойно. Ингэхлээр та бүхэн заавал энд гарч ирэх хэрэгтэй бол, бидний хоолоо идэж дуусахыг хүлээх үгүй юү, эсвэл сүүлд дахиад нэг иржүз. Эсвэл одоо сэхээрч, самуун дэгдээгчдээс салж, бидэн дээр ирээд, францын ван эзний төлөө хундага тогтоовол, бүр ч дээр дээ гэж хэлэв.

Атос , цаадуул чинь, чам руу шагайж байхыг харахгүй байна уу, болгоомжлоорой гэж д'Артаньян хашгирав. Атос үүнд, харах нь харж байна, энэ хотынхон буудахдаа тун муу улс намайг лав онохгүй, гэв. Үнэхээр энэ үеэр дөрвөн буу зэрэг дуугарсан боловч сум нь Атосыг онолгүй хажуугийн чулуунд тусав.

Хариуд нь дөрвөн буу даруй тас хийхэд, цаадуулаас цэцэн тусч, гурван цэрэг нам алагдан ойчиж, газар ухах улсын нэг шархадлаа. Атос нөгөө ил газраа зогссон хэвээр Гримо, өөр буу аль гэнэ. Гримо даруй буу авчирлаа. Атосын гурван нөхөд дахин буугаа цэнэглээд, дахин цөмөөрөө буудахад, даргалж явсан хүн, газар ухах хоёр хүнтэй алагдаад, бусад нь эргэж зугтаав.

Урагшаа , эрхмүүдээ, нэг дайралт хийе, гэж Атос хашгирлаа. Дөрвөн нөхөд, бэхлэлтийн цаанаас гарч дөрвөн буу, даргын жад сэлмийг цуглуулж аваад, буцаж гүйсэн улс хот хүрэхээс нааш зогсохгүй гэдгийг лав мэдэж, олзоован буцаж ирэв.

-Гримо, буунуудаа дахин цэнэглэ гэж Атос тушаагаад, эрхмүүд минь, бид хоолоо идэж, яриагаа үргэлжлүүлье. Бид юу яриад зогслоо доо, гэв.

Миледиг хаашаа яваа юм бол гэж сүрхий сэтгэл зовж байсан Артаньян үүнд, түүнийг сайн санаж байна. Миледиг Францаас гарч явсан гэж чи ярьсан гэв. Миледи Англи орохоор явсан юм, гэж Атос тодрууллаа.

Яах гэж?

-Бекингэмийг өөрөө алах юм уу, хүний гараар алуулах зорилгоор явсан. д'Артаньян, гайхаж, зэвүүцэн:

-Ямар булай хэрэг вэ? гэж дуу алдав.

-Үгүй үүнд би сэтгэл их зовоод байгаа юм алга гэж Атос хэлээд, Гримо чи буугаа цэнэглэж гүйцсэн хойно, тэр даргын жадыг авч, үзүүрт нэг алчуур өлгөөд, манай цайзны цамхаг дээр хатгаж орхи. Ван эзний эр зоригт, шударга цэргүүдтэй тулах учиртайгаа, тэр муусайн самуун дэгдээгч Ларошельчүүд мэдэг гэв. Гримо үг дуугүй, хэлсэн ёсоор хийв. Минутын дараа, манай дөрвөн нөхдийн толгой дээр цагаан туг мандлаа, цэргүүдийн тэн хагас нь хуарангийн ханан дээр овоорч байгаад, үүнийг үзмэгцээ нижгэнэтэл алга ташиж хөөрөлдөв.

д'Артаньян дахин ам нээж, юу гэнээ? Миледи өөрөө Бекингэмийг алах юм уу, хүн явуулж алах нь чиний сэтгэлийг огт зовоохгүй байна гэнээ? Үгүй герцогтон манай нөхөр шүү дээ гэлээ.

-Герцог англи хүн, бидний өөдөөс дайтаж байгаа тэр герцогийг Миледи явал яаг тэр, над энэ хоосон лонх шиг хамаа багатай зүйл. Ингэж хэлээд Атос, доторхыг нь юу ч үгүй аягандаа юулж авсан лонхыг цайзны нөгөө булан руу чулуудаж орхив.

-Үгүй, байзнаарай, Бекингэмийг би тэгж гаргуунд нь орхихгүй. Тэр бидэнд сайхан морьд бэлэглээгүй юу, гэж д'Артаньян хэлэхэд, Портос мөн үг нэмэрлэж:

-Гол нь догь сайхан эмээл өгсөн гэв. Портосын нөмөргөн дээр, эмээлээсээ авсан гялгар чимэг гоёмсоглож байлаа. Тэдний үгийг Арамис дэмжиж, тэгээд бурхан таалахдаа, нүгэлт хүний амийг тэвчих биш, гэмийг нь мэдүүлж, сүжиглүүлэх гэдэг билээ гэсэнд Атос:

-За тэх болтугай, та бүхэнд таалалтай байвал, энэ тухай бид сүүлд ярилцъя! Тэр үед, Миледи, чамаас болон магадгүй бид бүгдээс өөртөө ямар ч халгүйгээр ангижрахын тулд Хамба ламаасгүйж авсан, нэг ёсондоо бүрэн эрхийн үнэмлэх бичгийг булааж авахыг л би юуны өмнө хичээж байлаа.

Үүний учрыг д'Артаньян чи ойлгоно байхаа гэв. Халуун хоол хувааж байсан Арамис өөд Портос тавгаа сунгах зуураа, үгүй тэр бүсгүй чинь, шулам юм уу, юу юм бэ? та минь гэж эгдүүцэн өгүүлэв.

Тэр үнэмлэх, тэр үнэмлэх тэгээд, түүний гарт үлдсэн үү? гэж д'Артаньян асуулаа.

-Үгүй, миний гарт орсон, гэхдээ, тийм ч амархан олдсон гэж би хэлж чадахгүй дээ. д'Артаньяны сэтгэл уярч, Атос найз минь хичнээн удаа та миний аминд оров доо! Амьд яваа минь таны ачаа! гэв.

-Чи тэгээд, тэр бүсгүй дээр орох гэж биднээс түрүүлж явсан юм шив? гэж Арамис асуув. - Харин тэгсэн юм.

д'Артаньян, Хамбын өгсөн тэр үнэмлэх бичиг тэгээд өөрт чинь байна уу? гэж шалгаана.

Энэ байна, гэж Атос нөмрөгийнхөө халааснаас тэр үнэтэй бичгийг гаргаж ирлээ. Артаньян, сэтгэл түгшсэн байдлаа нуухыг оролдсон ч үгүй, чичирсэн гараар тэр цаасыг авааддэлгэж уншвал:

"Үүнийг үзүүлэгч хүний хийсэн бүхэн, миний тушаалаар улсын ашиг тусын тулд хийсэн болно. 1627 оны 12 дугаар сарын 3. Ришелье" гэжээ.

-Үгүй нээрээ энд чинь нүглийг номын ёсоор цагаатгасан юм байна гэж, Арамис хэллээ. Артаньянд, өөрийгөө цаазаар аваачих бичгийг уншаад орхих шиг санагдаад, энэ цаасыг чинь урж хаях хэрэгтэй юм байна, гэлээ.

-Үгүй. яалаа гэж үүний чинь хар нүдний цөцгий шиг хайрлах хэрэгтэй. Надад хичнээн ч алт

мөнгө өгсөн би, энэ цаасыг өгөхгүй гэж Атос маргалаа.

-Миледи одоо юу хийж байгаа бол? гэж Артаньян асуухад Атос хааш хэрэг дуугаар:

-Нэг муу золигийн шадар цэрэг, Атос гэгч хүн бие хамгаалах үнэмлэх бичгийг нь хүчээр булаагаад авсан гэж Хамбад бичнэ биз, мөн тэр захидалдаа, Атосын хоёр нөхөр, Арамис Портос гэдэг шадар цэргүүдийг цааш нь харуулбал дээр гэж Хамбад зөвлөх байх. Өөрийнхөө зам дээр энэ хэдэн хүн олон удаа саад болсныг Хамба санаад, нэг өдөр Артаньяныг баривчил гэж тушаагаад таныг ганцаардуулж уйдуулахгүйн тулд биднийг хань болгохоор Бастили руу аваачина биз гэлээ.

-Үгүй ингэхэд,, эелдэг нөхөр минь, чи баахан муу ёрын юмаар тоглоом хийгээд байх шив, гэж Портос хэлэв.

-Би ерөөсөө тоглоогүй байна гэж Атос хариулав. Портос үүнд, ингэхэд байнаа, тэр гайтай Миледигийн хүзүүг хуга мушгина гэдэг чинь, бидний латин хэлээр уншдаг, энэ мөргөлийг л франц хэлээр уншдагтаа буруут болсон хөөрхий буруу номтныг алахаас бага нүгэл шүү дээ, гэж хэлэв.

-Манай хувраг энэ тухайюу гэх юм бол? гэж Атос тайван асуухад:

-Портостой санал нийлж байна л гэнэ дээ, би, гэж Арамис хариуллаа.

-Би бүр хэлээд яахав гэж д'Артаньян хэллээ.

-Аз болоход, тэр бүсгүй одоо хол байна, тэргүйсэн бол үнэнийг хэлэхэд надад баахан аягүй байхсан гэж Портосыг хэлэхэд Атос:

-Тэр бүсгүй Англидбайхдаа ч гэсэн намайг Францад байгаа шигээ л зовоож байна гэлээ. -Тэр бүсгүй хаа ч байсан намайг зовоож байна гэж д'Артаньян хэлэв.

-Үгүй, тэр бүсгүй чиний гарт нэг л орсноос хойш чи юунд усанд хийчихсэнгүй вэ, багалзуурыг нь шахчихгүй яагаав дүүжлээд орхихгүй яасан юм бэ? гэж Портос асуугаад, үхсэн хүн буцаад ирдэггүйг чи мэднэ шүү дээ гэлээ.

-Та тэгж бодож байна уу, Портос оо? гэж Атос хариулаад аягүй мөшийхөд үүний цаад учрыг ганцхан д'Артаньян л мэдэж байлаа.

-Нэг аятайхан юм санаанд минь орлоо гэж д'Артаньян дуулгасанд шадар цэрэг за ярь гэв.

-Зэвсэглэцгээ гэж Гримо хашгирсанд, дөрвөн залуу даруй буугаа шүүрч авав. Энэ удаа жижигхэн баг, хорь, хорин тав орчим хүн ирж явсан нь газар ухах хүмүүс биш, жагсаалын цэргүүд аж.

-Үгүй бид хуаран руугаа буцах юм биш биз, миний санахад хүчин тэнцүү биш байна гэж Портосыг хэлэхээр Атос хариуд нь:

-Гурван шалтгаанаар тэгэх арга алга. Нэгд бид, хоолоо. идэж дуусаагүй, хоёрт, ярилцах чухал хэрэг бидэнд байна, гуравт мөрийцсөн цаг дуустал арван минут үлдээд байна гэв. -Тэхдээ, яаж тулалдахаа бодож боловсруулах хэрэгтэй дээ гэж Арамис хэллээ.

-Тулалдах арга гэвэл яахав. Дайсныг буун сум тусах газар хүрээд ирэхийн хамт гал нээнэ, дайсан давшаад байвал бид дахин буудна, ингээд сумаа дуусталбуудна, тэгээд амьд үлдсэн нэг нь наашаа дайрах гэж зүрхэлбэл: ёроолын сувагт орсон хойно нь, тэр нэг шидээр дөнгөж тогтож байгаа хэсэг хэрмийг толгой дээрээс нь ойчуулчихья. гэж Атос хэллээ.

Портос дуу тавьж, үгүй бас догь! Атос чи нээрээ жанжин байхаар төрсөн хүн юм. Хамба өөрийгөө цэрэг дайны суут хүн гэж өргөмжлөхболовч, чиний дэргэд юу ч биш гэв. - Эрхмүүдээ хоёулаа нэг хүн рүү бүү шагайгаарай, тус тусдаа буудах хүнээ сайн шилж авцгаая, гэж Атос санууллаа.

-Би буудах хүнээ овоо хараандаа авлаа гэж д'Артаньян хариу дуугарлаа. -Би ч мөн өөрийнхийгөө шагайлаа. Портос дуугарна..

-Би ч гэсэн, гэж Арамис мөн дуугарав.

Атос галлаад! гэж хашгираад, дөрвөн буу зэрэг тас хийж дөрвөн цэрэг ойчоод өглөө.

Даруй бөмбөр дэлдэж цэрэг урагшлан гүйлээ. Дээрээс дахин, дахин түрүүчийнх шигээ мэргэн буудна. Гэвч Ларошельчүүд манай нөхдийн цөөнийг мэдсэн юм шиг урагшаа бутран давшсан хэвээр байв. Гурван бууны дуу гарч, дахин хоёр хүн унаад орхилоо. Гэвч, үлдсэн цэргүүд шантарсангүй.

Цайз руу арван хоёр, арван тав орчим хүн гүйж ирээд ёроолын суваг руу орж, хэрэм өөд авирахаар зэхлээ.

-За нөхдөө, эднийг нэг цохилтоор дуусгая, хэрэм унагая, түлхээрэй! гэж Атос хэлэв.

Дөрвөн нөхөд, тэдэн дээр Гримо бие нэмэрлэн, том ханыг бууны гол төмрөөр хөшиж хөдөлгөж эхэлсэнд, салхинд үлээгдсэн юм шиг хазайснаа сууриасаа мултарч, суваг руу бөөн их чимээтэй унаад явчихсанд, хүмүүс муухай бархирах чимээ гарч. дээшээ бөөн шороо босоод, хамаг хэрэг дуусав.

-Үгүй, бид чинь, цөмийг ньняц дарчхав уу? гэж Атосыг асуухад, д'Артаньян хариуд нь: - Чөтгөр алгад, тэх шиг л боллоо шүү гэв.

Портос үүнд үгүй шүү, тээр тэнд, бүр сэг болчихсон хоёр гурван хүн зугтааж явна гэлээ.

Үнэхээр ч тэр хөөрхий цэргүүдийн гурав, дөрөв нь шороо тоосонд дарагдаж цус нөж болчихсон, хот орох сувгаар цаашаа гүйж явна. Явуулсан баг цэргээс үлдсэн нь ердөө л энэ аж. Атос цагаа хараад:

-Эрхмүүдээ. Бид энд ирээд нэг цаг боллоо. Мөрийгөө бид нэгэнт авсан. Гэхдээ мөрийгөө, олигтойхон авах хэрэгтэй тэгээд ч бас д'Артаньян санаагаа бидэнд хэлж амжаагүй шүү дээ

гэв. Ингээд, мань шадар цэрэг ердийнхөө хэнэггүй байраар хоолоо идэж гүйцэх гэж суув.

-Миний санаа юу гэж д'Артаньян, дахин асуулаа.

-Тиймээ аятайхан санаа төрлөө гэж та өөрөө хэлээгүй юу гэж Атос хариулав.

-Аа тийм, би дахин англид очиж, Бекинтэмтэй уулзъя гэвэл Атос хүйтнээр, д'Артаньян та тэгж болохгүй дээ гэв.

-Яагаад? Би нэг удаа тийш очсон хүншүү дээ.

-Тэр цагт дайн болоогүй байсан, Бекингэм тэр цагт манай дайсан биш, холбоотон байсан билээ. Таны хийх гэж байгаа юмыг эх орноос урвасанд үзнэ.

-Энэ үгийн аргагүй үнэнийг д'Артаньян ойлгоод дуугүй өнгөрөв.

-Над бол нэг муугүй санаа төрсөн шиг санагдана гэж Портос хэлсэнд, Арамис: -Портосын юу бодсоныгсонсьё, гэлээ.

-де Тревиль гуайгаас би чөлөө авъя шалтгийг нь та нар бодож олно биз, би түүнд чинь сайнгүй хүн. Миледи намайг танихгүй, тэхлээр би тэднийд хар авахуулалгүй амархаан орж чадна, тэгээд гуа бүсгүйтэй уулзмагцаа би багалзуурыг нь шахчихъя.

-Үгүй, яахав, бүр арга мухардвал Портосын саналыг би зөвшөөрөх нь байнашүү гэж Атос хэллээ.

-Пээ, бүсгүй хүнийг алах гэнэ шүү гэж Арамис дургүйцээд -Үгүй, харин надад л нэг сайн санаа төрлөө, гэв.

Залуу шадар цэргийг их хүндэлдэг Атос үүнд. -Арамис та юу бодож олсноо хэлээч гэлээ. -Хатанд дуулгаж сэрэмжлүүлэх хэрэгтэй.

-Ээ нээрээ тэгье гэж Портос д'Артаньян хоёр дуу алдаад -Бид зөв арга олох шиг байна гэж д'Артаньян нэмж хэлэв.

-Хатанд дуулгах гэнэ шүү! гэж Атос давгаж хэлээд, яаж хатанд дуулгах вэ? ордонд бидний танил тал бий билүү?. Бид нэг хүн Парис руу явуулчихвал тэр дороо бүх хуаранд мэдэгдээд орхихгүй гэж үү? Эндээс Парис руу хүртэл зуун дөчин мод газар бий. Захидал маань Анжер хүрээгүй явахад л биднийг цөмийг нь барьж аваад шоронд хийчихнэ дээ, гэв.

-Их эзэгтэйд найдвартай аргаар захидал дамжуулахын хувьд гэвэл, би даая, гээд Арамисын царай улайж, Тур хотонд миний таньдаг нэг аргатай бүсгүй байдаг юм...гэснээ). Атосын инээмсэглэж байхыг хараад, дуугүй болов.

-Үгүй. энэ чинь юу гэсэн үг вэ? Атос та энэ саналыг дургүйцэж байна гэж үү? гэж д'Артаньян асуув.

-Үгүй, үүнийг би бүр болохгүй ч гээгүй л байна, гэж Атос хариулаад,-ганцхан Арамис хуарангаа орхиод явж болохгүй, гэтэл, бид өөрсдөөсөө өөр хүнд бол яагаад ч ингэж болшгүй, манай элчийг мордоод хоёр цаг болоогүй байхад, хамбын хамаг тагнуул туршуул, гар хөл болсон этгээдүүд захиагий тань цөм цээжээр мэдэх болно. Тэгвэл таныг таны тэр аргатай бүсгүйн хамт баривчлах болно гэдгийг хэлэх гэсэн юм гэв.

Портос хажуугаас үг оруулж, -Бекингэмийг хатан авраад, биднийг аврахгүй гэдгийг бас бодолцох хэрэгтэй гэв.

д'Артаньян үүнийг зөвшөөрч эрхмүүдээ. Портосын энэ үг үнэний хувьтай юм гэлээ. -Хүүе энэ хотод юу болчхов оо? гэж Атос асуув.

-Түгшүүр зарлаж байна. Нөхөд чих тавин чагнавал, үнэхээр ч бөмбөр цохих чимээ дуулдаж байв.

-За та нар хараарай. бидний өөдөөс тэд нар бүхэл бүтэн хороо цэрэг явуулах бий, гэж Атос хэллээ.

-Та арай бүтэн хорооны өөдөөс тулалдах гээгүй биз? гэж Портос асуухад, манай шадар цэрэг хариуд нь:

-Болохгүй нь юу байгаа юм бэ? Өнөөдөр би азтай байгаа санагдаад байна. Бид уул нь дахиад нэг арваад лонх дарс авчирсан бол бүтэн арми цэргийн өөдөөс ч гэлээ хориглож чадахсан гэв.

-Нээрээ, бөмбөрийн дуу ойртоод байна шүү| гэж д'Артаньян сэрэмжилж хэлсэнд. Атос өөдөөс нь:

-Ойртож л байг, эндээс хот хүртэл лав мөч хиртэй явах газар, тэхлээр, тэндээс ирэхэд мөн ялгаагүй нэг мөч хир удна. Энэ чинь нэг шийдвэр гаргахад элбэг хүрэх цаг, бид эндээс яваад өгчих юм бол юм яримаар ийм тухтай газар ахиад олохгүй. Ингэхэд байнаа, эрхмүүдээ, над яг сая л нэг сайхан санаа орж ирлээгэв.

-Ярь л даа.

-Эхлээд, Гримод бид зохих заавар өгөөд орхиё.

Атос гараараа дохиж зарцаа дуудаад, цайзан дотор байгаа алагдсан улсын хүүрийг зааж: Гримо, энэ хүүрүүдийг хана түшүүлээд, толгойд нь малгай өмсгөж буу бариул гэв. -Чухам нэг сод хүн юмаа та минь, санааг чинь би ойлголоо, гэж д'Артаньян дуу алдлаа. -Та ойлгож байна гэнээ? гэж Портос лавлана.

-Аа, Гримо чи ойлгож байна уу? гэж Арамис асуусанд Гримо толгой дохив.

-Хийвэл зохих юм энэ байна, за одоо миний санаанд орсон юмыг ярилцъя, гэж Атос хэлтэл Портос мэтгэж:

-Үгүй, энэ юмны чинь учрыг би олохсон гэж их хүсээд байна гэв.

-Хэрэг алга.

-Тийм, тийм, Атосын үгийг сонсьё гэж' д'Артаньян. Арамис хоёр зэрэг дуугарлаа.

-Тэр бүсгүй, тэр булай амьтан шулам Миледид хадам ах бий гэж д'Артаньян хэлсэн шиг билээ?

-Тиймээ, би түүнийг их сайн танина тэгээд ч тэр хүн бэрдээ их сайнгүй дэгээ. -Тэр чинь сайн байна, бэрийгээ үзэж чаддаггүй байсанбол бүр ч их сайн байхсан гэж Атос хэллээ.

-Тийм бол, хэргийн байдал бидний хүсэлтэй яв цав нийлжээ.

-Ингэхэд Гримогийп хийж байгаа юмны учрыг мэдэх юм сан гэж Портос дахин хэлэхэд Арамис зогсоож:

-Портос, дуугүй бай гэв.

-Хадам ахын нь нэр хэн гэдэг юм.

-Лорд Винтер

-Тэр хүн одоохаана байгаа вэ?

-Дайн болох тухай сураг гармагц л Лондондоо буцсан. Атос үүнд, Тэр хүн л бидэнд яг таарах юм. Түүнд чинь л урьдчилан мэдэгдэх хэрэгтэй. Бэр чинь нэг хүн алах санаа өвөрлөж, яваа тэхлээр бүү нүд салгаарай гэж түүнд дуулгая. Бодвол, Лондон хотонд, Магдалина дарь эхийн асрах газар юм уу, нүглээ гэмшсэн завхай бүсгүйчүүлийн газар гэх шиг засан сайжруулах газар бий байлгүй. Винтер гуай бэрийгээ тийм газарт хорьж орхино байлгүй, тэгвэл бид санаа амарч болох юм гэлээ.

-Тийм ээ, Миледиг тэр газраасаа мултарч гарах хүртэл тэр шүү дээ, гэж д'Артаньяныг хэлэхэд, Атос өөдөөс нь:

-Та дэндүү их юм шаардах гээдбайна, би бодоод бодоод, санаанд орсон юмаа л хэллээ. Үүнээс өөр юм надад үгүй гэж мэдээрэй, гэв.

Арамис өөрийнхөө саналыг хэлж, миний бодоход, Лорд. Винтер, хатан хоёрын аль алинд хэл өгөх хэрэгтэй байх. гэнэ.

-Тэгээд, Лондон. Тур хоёр руу явуулах захидлыг хэнээр явуулах вэ?

-Би ч Базенийг бүр дааж байнаа, гэж Арамисыг хэлэхэд, д'Артаньян:

-Манай Планшег би даана гэв.

Портос тоог аваад,-үгүй, нээрээ, бид хуарангаас гарч болдоггүй гэхэд, манай зарц нар хамаагүй шүү дээ гэлээ.

Арамис үүнийг зөвшөөрч-яриагүй зөв, бид, өнөө оройдоо захидал бичээд, тэдэнд мөнгө өгөөд явуулья гэв.

-Тэдэнд мөнгө өгье гэнээ? та нарт мөнгө байгаа юм уу? гэж Атос лавлав. Дөрвөн нөхөд, бие биеэ хараад, тэдний сэргэж ирж байсан царай дахиад барайчхав.

-Хараач ээ хөөш! гэж д'Артаньян хашгираад хар улаан юм надад харагдаж байна, тээр хөдлөөд байна. Атос та тэгээд хороо гээд байсныг яана...энэ чинь бүхэл бүтэн арми цэрэг байна шүү дээ! гэв.

-Тиймээ, таны үг зөв, тээр ирж явна. Энэ зальтай амьтдыг хар л даа, бөмбөр цохиж, бүрээ татахгүй, сэмхэн ирж яваагий нь хараач, гэж Атос хэлээд,-Гримо чи гүйцэв үү, гэлээ. Гримо толгой дохиод, ханын дагуу, тун янзтай байрлуулсан арав гаруй хүүрийг заав. Зарим хүн буугаа мөрлөөд нөгөө нь шагайж, бас зарим нь илдээ сугалан барьсан янзтай байв.

-Догь болж! энэ чинь чинийхурц оюунтайг харуулж байна, гэж Атос сайшаав. Үүгээр ер яах гэсний учрыг би мэдэх юмсан, гэж Портос дахин асууж гартал, д'Артаньян хариуд нь: Урьдаар бушуухан л эндээс зайлъя, тэгээд чи өөрөө ойлгоно оо, гэлээ.

-Эрхмүүдээ, азнаарай Гримод сав суулгаа авах зав өгье. -Өө хар,улаан алагласан юмнууд улам ойртож байнагээч. би ч д'Артаньянтай санал нийлж байна. Цаг үрээд байх юмгүй, хуаран уруугаа, бушуухан хуараидаа буцъя, гэж Арамис дуу алдав.

-Тэгье. одоо ухрахад татгалзах юм над ч алга. Бид нэг цаг гэж мөрий тавиад, бүтэн хагас цаг боллоо. Одоо тэхлээр, хэн ч биднийг өөлж чадахгүй явья, эрхмүүдээ, гэлээ.

Гримо сагс, хоолныхоо үлдэгдэл сэлтийг аваад, аль хэдийнээ түрүүлээд гүйчихлээ. Дөрвөн нөхөд, түүний хойноос бууж арваад алхтал гэнэт Атос дуу алдаж:

-Ээ золиг, бид юу хийж байгаа маань энэ вэ эрхмүүдээ, гэсэнд Арамис чи нэг юм мартчихаа юу? гэв.

-Туг маань яагаа вэ, чөтгөр алгад! тугийг хэдий жирийн нэг алчуураар хийсэн гэлээ ч дайсанд үлдээж болохгүй, гэв.

Атос буцаж, цайзны цамхаг дээр гүйж гараад тугаа авлаа. Энэ зуур Ларошельчүүд буун сум тусах газар ойртоод ирчихсэн болохоор, биеэ тоглоом хийж, буун суман доор тавьж өгч байх аятай байгаа хүн рүү буудацгаав.

Гэтэл Атос таринадуулчихсан юм шиг эргэн тойронд исгэчиж байгаа сумны нэг нь ч түүнд туссангүй.

Атос хотынхон уруу нуруугаа харуулан, буруу харж зогсоод, хуарангаа хамгаалагч өөрийнхөндөө баяр хүргэн тугаараа даллав. Хоёр талд бөөн хашгиралдаан болж, нэг талаас хоосон бахардаж хашхиралдаад, нөгөө талаас бөөн баяр хөөр болох чимээ гарна. Хотынхон хоёр дахь удаа зэрэг буудахад алчууранд гурван сум тусч ёстой л туг болгов.

Хуаранд байгаа улс цөмөөрөө, бууж ир, бууж ир гэж хашгарна.

Агос доошоо бууж ирэхэд хүлээгээд, сэтгэл зовж байсан нөхөд нь баярлан утлаа.

д'Артаньян яаруулж, явья, Агос явья, алхаагаа нэмье, одоо мөнгө хаанаас олох вэ, гэдгээс бусад юм бүхний тухай бодож гүйцээд байхад, биднийг алчихвал дэмий явдал болно шүү гэнэ. Гэтэл Агос, нөхдийнхөө гуйхыг үл хайхран ихэмсэг тайван алхсан хэвээр, цаадуул нь мөн гуйгаад гуйгаад дэмий болохоор хөл нийлүүлэн алхав.

Гримо, сагстайгаа тэднээс хол түрүүлж сум нэгэнт тусахааргүй газарт очжээ.

Хором зуурын эцэст буу тачигнав.

-Энэ чинь юу вэ? Тэд чинь хэнийг буудаад байгаа нь энэ вэ? Хариу буудсан сум шунгинах ч дуулахгүй, хүн амьтан ч харагдахгүй байна гэж Портосыг гайхсанд.

Тэд чинь өнөөх үхдэлүүдийг буудаж байна гэж Агос тайлбарлаж:

Үгүй, тэр үхдэлүүд маань урьдаас нь буудахгүй шүү дээ!

-Харин тийм гэм. Тэхлээр цаадуул чинь нэг занга бэлтгэж гэж санаад, зөвлөлдөөн хийнэ, хүн явуулна, тэгж тэгж чухам учрыг олох үед, биднийг нэгэнт онохоо больсон байх бий. Ийм учраас бид яарч, амьсгаа давхцаж явахын хэрэггүй юм.

-Аа, одоо л мэдлээ гэж Портос бахадна.

-За ашгүй дээ! гэж Агос мөрөө хавчисхийлээ. Дөрвөн нөхөд алгуур алхсаар ирж явааг хараад, франц цэргүүд хөөрөн хашгиралдана.

Дахин буу тачигнав, энэ удаа буун сум манай нөхдийн явж байгаа замын чулуунд тусч, чихний хажуугаар ёозгүй шүнгэнэх боллоо. Ларошельчүүд сая л цайзыг нэг юм эзэлсэн аж. - Нээрээ муу бууддаг улсаа тэднийхээс бид хичнээн хүн алав? Арваад биз? гэж Агос хэллээ.

-Арван тав хүрээгүй бол овоо.

-Бас хэдий нь дарж аллаа.

-Наймыг уу, есийг үү,

-Тэгээд, эд бүтдийн хариуд биднийг ганц шалбалж ч чадсангүй! үгүй, энэ чинь!.... д'Артаньян таны гар яачхав? Цус болоо юу даа? гэсэнд д'Артаньян юу ч биш ээ, зүгээр, гэлээ.

-Зэрлэг сум уу?

-Үгүй, сум ч биш,

-Тэгээд, юу юм бэ?

д'Артаньянд Атос төрсөн хүү шигээ хайртай, ширүүн, эршүүд зантай тэр хүн, залууг заримдаа ёстой эцэг хүний ёсоор халамжилдаг билээ.

Шалбалчихсан юм. Хана түлхэх үед, хуруугаа хавчуулаад бөгжнийхөө чулуугаар гарынхаа арьсыг шалбалчихсан юм гэж д'Артаньян тайлбарлалаа.

-Алмаз чулуу зүүнэ гэдэг чинь ийм байдаг юм, өршөөлт эрхэм минь,. гэж Атос зэвүүрхэхсийн дуугарлаа.

-Хүүе нээрээ бөгжний чулуу нь алмас шүү дээ. Бид чинь мөнгөгүй гэж юугаагомдол гаргаад байгаа билээ энэ чинь гэж Портосыг дуу алдахад, Арамис тосч аваад:

-Нээрээ тийм шүү гэв.

-Портос догь юм хэллээ. Энэ удаа та үнэндээ сайн юм санаж гаргалаа гэв. Атосын магтаалд хөөрсөн Портос тэгэлгүй яахав, алмаз чулуу байгаа хойно зарж болно гэв.

-Үгүй, энэ чинь хатны бэлэг юм шүү, гэж д'Артаньян маргалаа.

-Тэх тусмаа үүний чинь зарвал таарах байгаа юм. Хатны бэлэг түүний хайртай сайн хүн Бекингэмийн аминд орно гэдэг яахын аргагүй шударга хэрэг, мөн энэ бэлэг хатны нөхөд болох бидний аминд орно гэдэг яахын эрхгүй сайн хэрэг. Ингэхлээр алмасыг худалдъя. Эрхэм хувраг энэ талаар юу гэж бодож байна? Портосоос асуух юм алга, саналаанэгэнт хэлчихсэн хүн гэв.

Арамисын царай улайж, энэ бөгжийг амраг бүсгүйгээс аваагүй, тэхлээр янаг сэтгэлийн дэнчин биш, иймд д'Артаньян бөгжөө худалдаж болмоор над санагдана гэв.

-Эелдэг нөхөр минь, та аргагүй нэг бурхны номд нэвтэрхий хүн шиг ярих юм. Ингээд, таны саналаар бол...

-Алмас чулууг зарах нь зөв, гэж Арамис хариуллаа. д'Артаньян санал нийлж за яахав, алмаз чулуугаа зарчихъя, тэхлээр энэ тухай ярилцах юм алга, гэлээ.

Хойноос буудсаар боловч, манай нөхөд, буун сум нэгэнт тусахааргүй холдчихсон, Ларошельчүүд зүгээр сэтгэлээ хуурч л буудаж байв.

-Энэ санаа Портост тун хэрэгтэй цагт төржээ. Бид одоо хүрээд ирлээ. Ингээд энэ хэргийн тухай, эрхмүүд минь ганц ч үг бүү дуугаръя. Бидэн рүү улс харж, биднийг тосч байна, баяр хөөр болж угтах нээ, гэв.

Үнэхээр ч, бидний дурссанаар, бүх хуаран догдлон хөөрч, хоёр мянга гаруй хүн жүжиг үзэж байгаа юм шиг, дөрвөн нөхдийн зоригт явдал ашгай сайхан төгссөнд баярлав. Тэхдээ, уул хэргийн цаад, жинхэнэ учрыг хэн ч гадарласангүй. Хуаран даяараа баяр хөөр болон шуугилдаж:

-Торгон цэргүүд мандтугай! Шадар цэрэг мандтугай! гэж хашгирлаа. Де Бюзини гуай

түрүүлэн ирж. Атосын гарыг бариад, мөрий алдсанаа хүлээлээ.

Де Бюзинигийн хойноос морин цэргийн хүн, швейцар цэрэг ирж тэдний хойноос бүх нөхөд нь тойрч ирлээ. Бөөн их баяр хүргэсэн гар барьсан, тэврэлдсэн, юм болж Ларошельчүүдийг шоолж даажигнасан хошин үгний ундарсан гэж тоймгүй. Хуаранд ингэж бөөн шуугиан дэгдсэнд, Хамба лам самуун дэгдээгүй байгаа гэж санаад, торгон цэргийнхээ даамал Удиньерийг хуаранд юу болсныг мэдүүлэхээр явууллаа. Болсон бүх явдлыг улс Ла Удиньерт хамийн хөөрүү байдлаар ярьж өгөв. Түүнийг буцаж ирэхэд, Хамба ламтан юу болоо вэ? гэлээ.

-Нэг торгон цэрэг, гурван шадар цэрэг Сен жерве цайзан дээр өглөөний хоол иднэ гэж де Бюзини гуайтай мөрий тавиад, хоолоо хоёр цаг үргэлжлүүлж, дайсны өөдөөс хориглон тогтож, хичнээн ч юм бүү мэд Ларошельчүүдийг алсан юм гэнээ, гэгээнтэн,

-Та тэр гурван шадар цэргийн нэрийг дуулав уу?

-Тэгсэн, гэгээнтэн.

-Нэрлээд орхи.

-Тэр эрхмүүд, Атос Портос, Арамис гурав юм байна. Хамба аман дотроо "Нөгөө л зоригт гурав байх нээ" гээд торгон цэрэг нь хэн бэ? гэв.

-д'Артаньян гуай.

-Бас л нөгөө овтой залуу байх нь, энэ дөрвөн нөхдийг миний талд оруулж алба хаалгах явдал аргагүй чухаг байгаа. Оройдоо Хамба ламтан, де Тревиль гуайтай юм ярьж байгаад, бүх хуарангаар шуугиан дэгдээж байгаа өглөөний тэр гавьяат хэргийн тухай дурсав. Явсан улсын өөрсдийн нь амнаас тэр тухай дуулсан де Тревиль гуай их гэгээнтэнд нэгд нэггүй ярьж өгөхдөө. алчуураар хийсэн тугны тухай дурсахаа мартсангүй.

-За сайн, де Тревиль гуай, та тэр алчуурыг над явуулчхаарай; би тэр алчуур дээр чинь гурван сараана цэцэг алтаар хатгамлуулаад, танай цэргүүдэд хийморь болгож гардуулья, гэж Хамба хэллээ.

-Их гэгээнтэн, энэ чинь, торгон цэргүүдийн тухайд шударга бус болно шүү дээ. Юу гэвэл, д'Артаньян миний захиргаанд биш. Дезассарын цэрэг шүү дээ, гэж де Тревиль маргалаа. - Үгүй тэгвэл д'Артаньяныг ангидаа ав л даа. Энэ зоригт дөрвөн эрчүүл хоорондоо тийм сайнаас хойш нэг ангид алба хаах нь шударга шүү дээ, гэж Хамба хэллээ.

Тэр оройдоо де Тревиль гуай энэ аятайхан сониныг гурван шадар цэрэг д'Артаньян нарт дуулгаад дөрвүүлэнг, маргааш өглөө нь өөрийндөө ирж хоол идэхийг урив. д'Артаньян ер шадар цэрэг болох л ганц хүсэлтэй байсан шүү дээ, тэхлээр магнай хагартлаа баярлалаа.

-Гурван нөхөд нь ч их баярлалаа.

-Нээрээ чамд сайхан санаа төржээ тэгээд ч чиний хэлсэнчлэн бид тэнд нэр алдраа

бадруулаад, өөрсдөдөө тун чухаг яриа үүсгэлээ, гэж Атост Артаньян хэллээ.

-Түүнийгээ бид одоо хэнд ч хар авахуулалгүйгээр үргэлжлүүлж болно, одоогоос хойш, бид чинь бурхны авралаар Хамбын талынхан гэж тооцогдох болно шүү дээ.

Артаньян мөн тэр оройдоо Дезэссаргуай дээр ирж, хүндэтгэлээ илэрхийлээд, Хамбаас соёрхсон өршөөлийн тухай дуулгав.

д'Артаньянд их сайн байдаг д' Дезэссар гуай энэ тухай дуулаад, нөгөө хороонд шилжихэд, хувцас хунар, зэр зэвсэг гээд их зардал хэрэгтэй байдаг болохоор туслая гэсэнд д'Артаньян тусламж авахаас татгалзсан боловч, аятай учралыг ашиглан алмас чулуугаа үнэлүүлж, мөнгө болгож өгнө үү гээд, өөрт нь өгөв. Маргааш өглөөний нь найман цагт Дезэссарын зарц д'Артаньян дээр ирээд, алтан зоостой уут гардуулж өгсөнд, түүн дотор долоон мянган зоос байв. Хатны хайрласан алмас чулуун бөгжний үнэ энэ аж.

XLVIII. ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ

Атос , гэр бүлийн хэрэг гэдэг таарсан нэр оллоо. Гэр бүлийн хэргийг Хамба мэддэггүй, гэр бүлийн хэрэг хэнд ч хүртээлгүй байлаа. Гэр бүлийн хэргийг хэнээс ч нуулгүй явуулж байж болох байлаа. Ингэхэд Атос, гэр бүлийн хэрэг гэдэг нэр оллоо.

Арамис зарц явуулах санааг гаргалаа. Портост, алмас худалдах санаа төрсөн билээ. Ганцхан, энэ дөрөв дотроос хамгийн их овжин самбаатай д'Артаньян л юу ч бодож олсонгүй үнэнийг хэлэхэд, Миледигийннэр дуулмагц хамаг бодол санаа нь сарничхаад байв.

Ээ , тийм тэр чинь алмаз худалдуулах хүн олсон шүү дээ. Де Тревиль гуайнд өглөө хоол идэж байхад нь цөм наргиантай сайхан байсан бөгөөд д'Артаньян шинэ жагсаал хувцсаа өмсчихсөн ирлээ. Юу гэвэл Арамис, бидний мэдэж байгаагаар яруу найргийнхаа шагналд их мөнгө авсан болохоор, бүх юмаа хосоор захиалсан юм байж, Тэгээд д'Артаньянтай бараг адилхан нуруутай болохоор нэг ээлжийн бүх хувцсаа нөхөртөө өгчээ.

Миледийн тухай бодол, тэнгэрийн хаяанд байгаа хар үүл шиг санаанд бүрэлзээд байдаггүйсэн бол д'Артаньян жаргалын дээдийг эдэлж байв.

Хоол идэж гүйцсэний дараа, дөрвөн нөхөд Атосынд орой цуглаад, төлөвлөсөн хэргээ хийж гүйцээхээр тохиров. д'Артаньян шадар цэргийн шинэ хувцсаа харуулахаар бүхэл өдөржингөө хуаран дундуур хойш урагш сэлгүүцнэ. Орой дөрвөн нөхөд, болзсон цагтаа уулзахад, Миледигийн хадам ахад юу гэж бичих, Турт байдаг аргатай бүсгүйд юу гэж бичих, зарц нарын хэнээр захиагаа явуулах, ийм гуравхан зүйл шийдэх ёстой байлаа.

Бүгд л өөрийнхөө зарцыг явуулья гэнэ. Гримог, эзнийхээзөвшөөрөхөөс нааш ам нээдэггүй, даруу зантай гэж Атос хэлэхэд, Мушкетны бие бялдар лут, жирийн дөрвөн хүнийг амархан балбаж орхино, хүчтэй эр гэж Портос магтана. Базены овжин аргатайд Арамис итгэдэг болохоор, түүнийгээ сайхан үгээр магтахад Планшегийн эр зоригтойд үнэхээр итгэдэг д'Артакьян, Булонийн нөгөө нэг явдалд, хир эр хүн шиг сайн явсныг нь хэлж магтана. Энэ дөрвөн чанарын аль нь чухаг болохыг марган булаацалдаж энэ талаар мундаг мундаг үг хэлэлцсэн боловч, хэтэрхий унжрах болов уу гэж айгаад энд бид дурдсангүй.

-Гай болоход, манай элчид энэ дөрвөн чанар цөм тэгш байх хэрэгтэй юм гэж, Атос хэлэв. - Тийм зарц хаанаас олдох юм бэ?

-Тийм хүн олдохгүй, үүнийг би өөрөөмэдэж л байна, тэхлээр Гримог явуулья гэв. -Үгүй Мушкетон яваг.

-Базен дээр шүү.

-Миний санахад, Планше дээр байх, тэр чинь зоригтой овжин хүн, тэхлээр хоёр чанар байгаа юм.

-Эрмүүдээ, манай зарц нарын дотроос хэн нь илүү даруу, хүч чадалтай, овжин, зоригтойг мэдэх нь бидэнд гол биш хэн нь мөнгөндилүү их дуртайг мэдэх нь чухаг гэж Арамис хэлсэнд

Атос санал нийлж:

-Ихээ мэргэн үг байна хүний сайн чанарт биш, муу талыг нь мэдээж харгалзах хэрэгтэй юм. Эрхэм та сод сургамжлагч юм гэлээ. Арамис үгээ залган, энэ чинь гол юм байлгүй яахав. Бидэнд даалгасан зүйлийн маань урагштай гүйцэтгэхээс гадна мөн уул хэргийг нураачихгүй сайн элч хэрэгтэй. Хэрэг урагшгүй болсон тухайд, зарц толгойгоороо даахгүй...гэтэл Атос зогсоож:

-Аяархан яриарай, Арамис гэв.

-Таны зөвөө...Зарц даахгүй, эзэн даах болно. Танай зарц нар, бидний төлөө амь насаа дүйхээр, бидэнд үнэнч сайн уу? Үгүй шүү дээ.

-Үнэнээ хэлэхэд, Планшегийн тухайд би бараг баталж ч байна гэж д'Артаньян хэлэв. -Тэгвэл, хонгор нөхөр минь, түүний ариун үнэнч зан дээр, жаал хөрөнгө болохуйц нилээд мөнгө нэмчих, тэгвэл, та давхар итгэлтэй байж болноо.

-Тэглээ ч гэсэн таныг мэхэлж орхино доо, тэд чинь мөнгө авах гэж юу дуртайгий чинь амлаж амлаж орхиод зам зуураа айгаад зогсчихно. Тэднийг бариад авмагцаа, хавчаадтулгаад ирнэ. Хавчаад тулгаад ирэхээр тэд бүх үнэнийг хэлж орхино.

Бид ямар нялх хүүхдүүд биш дээ, чөтгөр алгад! Англи ороход, (Атос дуугаа намсгав) Хамбын тагнуул, туршуулаар дүүрсэн бүх Францаар явж өнгөрөх хэрэгтэй, хөлөг онгоцонд сууна гэхэд зөвшөөрөл хэрэгтэй. Лондон орох замаа олохын тулд англи хэл мэдэх явдал шаардагдана. Энэ чинь яггүй л хэрэг шиг надад санагдах юм гэж юмны тухайд итгэлтэй байх мөртөө хүнд үл итгэгч Атос хэлэв.

Уул санасан хэргээ бүтээхсэн гэж их мэрийсэн д'Артаньян маргаж огт ийм тийм биш, миний санахад, гайгүй амархан санагдана. Хамбын хамаг бузар булай бүхнийг элдэв айхтар юм Винтер гуайд бичиж орхивол ч мэдээжээр...гэтэл Атос аяархан гэм! гэж сэрэмжлэв.

Элдэв хатгалгаа явуулга улсын нууц сэлтийг дурсвал, мэдээжээр биднийг бүгдийг нь амьдаар нь тамлах л байлгүй, гэж Атосын анхааруулсныг авч д'Артаньян шивэгнэн: гэтэл, таны өөрийн чинь хэлсэнчлэн бид түүнд гэр бүлийн хэргээр бичнэ гэдгийг, Атос та бүү мартаж үзээч. Миледиг Лондон ормогц нь, цаашдаа бидэнд хор учруулж чадахгүйболгох л гэж бид түүнд юм бичнэ шүү дээ. Түүнд нэг, иймэрхүү захидал би бичнээ...

Арамис , урьдаас шүүмжлэх дур нь хүрсэн янзтай за дуулья, гэв.

- "Эелдэг нөхөр, өршөөлт эрхэм..."

-Мөн дөө англи хүнд "эелдэг нөхөр" гэж бичиж байх гэж, гэж Атос үгийг нь таслаад юу гэх вэ, бузгай сайхан эхэлж байна, таны ганц энэ үгний чинь төлөө тамлахаар барахгүй бүр тарчлааж ална даа гэв.

-За яахав, таны зөв гэж бодъё "би зүгээр л өршөөлт эрхэм" гээд бичнээ. Тогтсон эелдэг ёсыг

баримтлах нь хэзээд зүйтэй гэж үздэг Атос үүнд, Үгүй яахав "Милорд" гээд бичихэд болно шүү дээ гэв.

"Милорд, Люксембург ордны цаана байдаг жижиг талбарыг санаж байна уу?" -Пээмөн догь! Одоо бас Люксембург гэх гэнээ үүний чинь хатан эхийг хэлж байгаа хэрэг гэж үзнэ дээ Бас сайн бодож олов оо, хөөш! гэж Атос инээмсэглэв.

-За тэгвэл яахав зүгээр л "Милорд, таны амийг аварсан жижиг талбарыг санаж байна уу?..." гэж бичье. Атос үүнд д'Артаньян хонгор минь та ерөөсөө юмолигтой зохиодог болохгүй дэг "таны амийг аварсан" гэх юм гэнэ. шүү.

-Түй энэ чинь булай хэрэг, тиймэрхүү тусын тухай, олигтой хүнд сануулдаггүй юм шүү. Хийсэн тусаараа түрээ барих гэдэг чинь доромжлох гэсэн үг гэв.

-Ээ найз минь, та яасан хэцүү хүн бэ? таны л хяналтын доор бичих хэрэгтэй юм болби ерөөсөө больё гэж д'Артаньян хэлэв.

-Тэгсэн нь дээр. Найз минь. илд, буу хоёроор хийх юмаа хийж яв. Тэр хоёрт та ихээ мэргэжсэн хүн, үзгээр хийхийг эрхэм хуврагт өгчих, энэ чинь түүний талын ажил.

-Нээрээ бичих юмаа Арамист даалгачих, энэ чинь латин хэл дээр хүртэл цол хамгаалах юм бичдэг хүн шүү дээ гэж Портос дэмжлээ. Артаньян ухарч, за тэгье, Арамис та тэр зурвасыг зохиогоод орхи. Харин бид бүхний гэгээн багш богд ламын нэрийг барьж гуйхад, тун болгоомжтой бичиж үзээрэй. Би ч бас өөтэй болсон үг байна уу гэж эрэх л болно эртхэн хэлчихье гэлээ.

Яруу найрагч улсын зан болсон, өөртөө итгэлтэй байдлаарАрамис, дуртай зөвшөөрөв. Харин бүх байдлыг надад дуулгаад орхи. Милордын бэрийг их өөдгүй амьтан гэж би олон удаа дуулсан юм. Өөрөө мөн Хамбатай ярилцахыг нь сэм сонсоод үүнийг үнэмшсэн юмаа...

-Үгүй, аяархан гэм, чөтгөр алгад гэж Атос зогсоов.

-Тэхдээ нарийн тодорхой мэдэхгүй гэж Арамис үгээ гүйцээв.

-Би ч мэдэхгүй, гэжПортос дуугарна.

Артаньян, Атос хоёр хэсэг зуур дуугүй өөд өөдөөсөө харлаа. Эцэстээ, Атос сэхээ авч, царай нь ердийнхөөсөө үл мэдэг зэвхийрээд, толгой дохисонд, хариул гэж байна гэж Артаньян ойлголоо.

-Ингэхлээр, юун тухай бичвэл таарах вэ гэвэл, "Милорд танай бэр чинь гэмт хэрэгтэн хүн, таны өв хөрөнгийг залгамжлах гэж, хүнээр өөрий чинь алуулах гэж оролдсон. Гэтэл тэр бүсгүй Францад нэгэнт нөхөртэй байсан болохоор танай дүүтэй суух эрхгүй байсан юмаа тэгээд" гэснээ Артаньян аятай үг эрж байх шиг түгдчин, Атос өөд харлаа.

- "Нөхөр нь түүнийг хөөчихсөн юм" гээрэй гэж Атос хэлэв.-Шившгийн тамга даруулсан болохоор нь хөөсөн юм гэх юм шүү гэж Артаньян нэмлээ.

-Арай үгүй байлгүй, тэр бүсгүй хадам ах руугаа алуурчин явуулах гэсэн юм уу? гэж Портос дуу алдав.

-Тиймээ.

-Тэр бүсгүй урьд нь нөхөрт гарчихсан байсан юм уу?

-Тийм.

-Нөхөр нь тэгээд, мөрөн дээр нь хонхон цэцгэн тамга дарсан байхыг нь хараа юу? гэж Портос асуулаа.

-Тийм.

-Атос ингэжгурав дахин "тийм" гэж хэлэхдээ дуу нь, улам бүр бүдгэрч байлаа.

-Тэр тамгыг хэн харсан юм бэ? гэж Арамис асуулаа. Артаньян, бид хоёр, чухам дэс дарааллаараа бол эхлээд би, тэгээд Артаньян үзсэн юм, гэж Атос хариулав.

-Тэр айхтар амьтны нөхөр нь одоо амьд хэвээр үү? гэж Арамис асуув.

-Тэрхүн амьд бий.

-Та үүнийг лав мэдэж байна уу.

-Лаваа.

Хэсэг зуур нам гүм болоод, тэрхэн зуур хүн бүр сая дуулсан юмнаас төрсөн сэтгэлэгтээ автагдан байлаа.

Атос түрүүлэн ам нээж, энэ удаа, бидэнд Артаньян, сайхан чиглэл гаргаж өглөө, манай захидлыг үүнээс л эхлэх ёстой юм гэлээ.

-Чөтгөр алгад, Атос танызөв юм байна. Иймэрхүү захидал бичнэ гэдэг чинь их ярвигтай ажил байна. Захирагч гуай элдэв тогтоол тун сайн зохиодог үнэн боловч, өдий их учиртай захидал бичнэ гэхэд, сандрах л байсан байх. За яахав! Дуугүй байгаарай. Би бичье гэж Арамис хэлэв. Арамис үзэг авч, жаал бодсоноо, бүсгүй хүнийх шиг дэгжин бичгээр, ес арванмөр бичээд үг бүрий нь цэгнэж үзэх маягтай алгуурхан, нам дуугаар уншсан нь!

- "Милорд оо!"

-Энэ хэдэн мөрийг бичиж байгаа хүнд Ада гудамжны жаахан талбар дээр, тантай илд зөрүүлэх завшаан тохиолдож билээ. Түүнээс хойш, та намайг олон удаа нөхрөө гэж ярьж гийгүүлдэг байсан болохоор, би ч мөн сайн зөвлөгөө өгч нөхөрсөгсэтгэлээ үзүүлье гэж саналаа. Та хоёр удаа ойр төрлийнхөө бүсгүй хүний гарт амь үрэгдэх шахсан юм. Тэр бүсгүй фраицад нөхөрт гарчихсан хойноо англид очоод дахин гэрлэснийг та мэдэхгүй болохоор түүнийг өөрийнхөө өв залгамжлах хүн гэж үздэг юм. Гэтэл гурав дахь удаадаа, өөрөөр хэлбэл

та одоо амь алдаж магадгүй. Төрлийн бүсгүй тань өнөөшөнө Ларошелиэс Англи орохоор гарлаа. Түүний ирэхийг сайн ажиж байгаарай юу гэвэл булай айхтар хар санаа өвөрлөж яваа юм. Тэр бүсгүй юу ч хийхээс буцахгүй хүн болохыг заавал мэдье гэвэл, өнгөрсөн түүхий нь зүүн мөрөн дээрээс нь уншаарай гэжээ.

-За энэ чинь сайхан болж гэж Атос сайшаагаад Арамис та төрийн нарийн бичгийн дарга шиг зохиох юм. Энэ сэрэмжийг Винтер гуай хүлээж авах л юм бол авгайн очиход тосч аваад хатуу цагдана. Энэ зурвас Хамбын гарт орлоо ч гэсэн бидэнд хор болохооргүй болжээ. Харин бидний явуулах зарц маань, Шантельрогоос цааш гаралгүй буцаж ирчхээд, Лондон орсон гэж бидэнтэй мэтгэлцээд байж мэднэ дээ. Тэхлээр, мөнгөнийхөө тэн хагасыг захидалтай цуг өгөөд нөгөө хагасыг нь хариу авчрахаар өгье гэж амалъя, гэснээ, Артаньянаас нөгөө алмаз өөрт чинь яваа юу, гэлээ.

-Надад илүү дээр юм бий мөнгө байна, гээд д'Артаньян хүүдийтэй мөнгөө ширээн дээр хаялаа. Алт хангинах чимээгээр Арамис өндийн харж, Портосын бие зарсхийж, Атос л хэнэггүй хэвээрээ байв.

-Энэ уутан дотор хичнээн мөнгө байгаа юм бэ! гэж тэр асуулаа.

-Долоон мянган зоосны давхар алтан зоос байгаа юм.

-Долоон мянган зоос гэнээ! Тэр муу алмаз чинь долоон мянган зоос хүрдэг байжээ гэж Портос дуу алдав.

-Ширээн дээр байж л байгаагаас хойш, хүрдэг л байж дээ. Миний бодоход, мань нөхөр Артаньян өөрийнхөө мөнгийг үүн дээр лав нэмээгүй дэгээ. Артаньян түрүүчийн саналаа дахин сэргээж, эрхмүүдээ бид элдвийг ярилцах зуур хатанг мартаад байна. Хатны сэтгэлтэй сайн Бекингэмийн тухай бид жаахан санаа тавих ёстой байна. Бидний хатагтайд хүргэвэл зохих хамгийн бага тус л энэ шүү дээ, гэлээ.

Атос үүнийг зөвшөөрч. яриагүй зөв гэхдээ энэ чинь Арамисын мэдэх ажил гэв. -Би юу хийх ёстой болоод байгаа юм бэ? гээд Арамисын царай улайчихав.

-Хамгийнмархан юм, Турт суудаг тэр аргатай бүсгүйдээ захиа бичээд орхи. Арамис дахин үзэг авч, жаал бодоод хэдэн мөр юм бичээд, даруй нөхдөдөө хянуулахаар уншсан нь:

- "Хайрт дүү минь! ..."

Үгүй тэр аргатай бүсгүй чинь танай садангийн хүн байх нээ? гэж Атос тохуурхав. -Миний үеэл дүү болох хүн.

-За яахав, үеэл ч болог л доо.

-Арамис цаашаа;

"Хайрт дүү минь, Францын ашиг тусын үүднээс дайсныг дарж доройтуулахын тулд бурхны өршөөл хүртсэн их гэгээнтэн Хамба гуай одоо Ларошелийн самуун дэгдээгч буруу номтныг

дарж дуусах шахаад байна. Тэдэнд туслахаар ирж яваа английн усан цэрэг лав хотод ойртож ч чадахгүй бизээ. Бодвол ямар нэг чухал явдал Бекингэмийг Англиас гарч явахад саад болох болов уу гэж лавтай бодох юм. Их гэгээнтэн урьд, одоо байгаагүй, хожим ч гэсэн гарахааргүй улс төрийн суут зүтгэлтэн билээ. Өөртөө саад боллоо гэхэд нарыг ч билээ халхлахуйц хүн билээ.

Дүү минь энэ баяртай мэдээг эгчдээ дуулгаарай. Би тэр хараал хүрсэн англи хүнийг үхчихэж гэж зүүдэлсэн, хор уулгасан байл уу хутгалуулчихсан байл уу мартчихжээ, лав л түүнийг үхчихсэн байна гэж зүүдэлсэн миний зүүд их мэргэн байдгийг чи мэднэ шүү дээ. Мөдхөн уулзана гэж бат бодож суугаарай гэжээ.

-Мундаг зохиож хонгор Арамис та яруу найрагчдын хаан юмаа! Та Апокалипсис шиг цэцэн, бурхны ном шиг үнэн үгтэй хүн юм. Одоо ганцхан энэ захидал дээр хаяг бичих л үлдээд байна гэж Атосын маргахад Арамис тэр ч амархан л даа гээд захидлыг дэгжин эвхэж, дээр нь;

" Тур хотноо суудаг, оёдолчин бүсгүй Мишонд" гэж бичив;

Гурван нөхөд, инээлдээд өөд өөдөөсөө харав, заль нь урагштай болсонгүй. Арамис өгүүллрүүн

Эрхмүүдээ , миний садангийн бүсгүй зөвхөн Базеныгтаньж түүнд, итгэдэг болохоор Турт явах захидлыг Базен л хүргэж болох юм. Өөр хүн явуулаад дэмий гэдгийг өөрсдөө, одоо мэдэж байгаа биз. Түүнээс гадна Базен номтой, нэр төрд дуртай хүн, Базен түүх мэднэ, тэр ч байтугай, тавдугаар Сикст богд лам болохоосоо өмнө гахай маллаж явсныг мэддэг юмаа. Базен надтай зэрэг сахил хүртээд, богд биш гэхнээ ядаж Хамба болох горьдлого тасраагүй хүн шүү, Өдий дээгүүр санаа санаж явдаг хүн тийм амар баригдахгүй, баригдлаа гэхэд, ганц ч үг алдсанд орхноо тамлуулсан нь дээр гэх болно гэдгийг та бүхэн өөрсдөө болгоожүз гэв.

-Тэгье, тэгье таны Базеныг дуртайяа явуульа гэж д'Артаньян зөвшөөрөөд харин Планшег мөн явуулж аль, Миледи нэг удаа түүнийг сайн саваадаад гэрээсээ хөөж гарга гэж тушаасан юм даг, Планше юм амар мартдаггүй хүн, тэхлээр өшөө авах завшаан тохиолдсон хойно, тэр чинь үхэхээсээ ч буцахгүй мэрийнэ гэдгийг би баталж байна. Туртявуулах хэрэг Арамис танд хамаатай гэхэд, Лондонд явуулах хэрэг надтай хамаатай билээ. Иймд, Планшег явуулахад бүү татгалз, тэгээд ч Планше надтай цуг Лондон нэг орж үзсэн. "Лондон орох зам зааж өгнө үү, эрхэм ээ" "Манай эзэн, Артаньян гуай" гэж англиар зөв хэлж чадна. Тийм мэдлэгтэйгээр, тэр чинь Лондон ороод, ирэх замаа сайнолно, гэсэнд Атос;

-За тэгвэл, Планшег явахад долоон зуун зоос өгөөд ирэхэд нь мөн төдийг өгнө гэж амлая. Базенд явахад нь гурван зуу ирэхээр нь гурван зууг өгье. Үүгээр манай хөрөнгө таван мянган зоос болтол хорогдоно. Одоо хүн тус бүр мянга, мянган зоос аваад дуртайгаараа үрье, үлдсэн мянган зоосыг нөөц болгож, гэнэтийн хэрэгцээнд зориулж хувраг гуайд өгч хадгалуульа зүйтэй юу?

-Эелдэг нөхөр Атос, та юм бодохдоо грекийн эртний их ухаантан байсан Нерон шиг хүн юмаа гэж Арамис хэллээ.

За тэгвэл Базен, Планше хоёр яваг гэж шийдлээ чухамдаа Гримо үлдсэнд би баярлаж байна. Тэр миний аашинд дадсан болохоор надад чухаг байдаг юм. Өчигдөр тэр их ядарсан байх, тэгээд ийм юманд явуулбал бүр туйлдчих байсан гэж Атос хэллээ. Дөрвөн нөхөд Планшег дуудаад, зохих заавар өглөө, д'Артаньян түүнд эхлээд, нэр төртэй хэрэг болохыг дуулгаж, дараа нь мөнгөний тухай хэлж, эцэст нь аюул учирч магадгүйг дурсаж, учир мэдүүлсэн билээ.

-Захидлыг би нудраганыхаа ард хавчуулаад явна, тэгээд намайг барих гэвэл залгиж орхино гэж Планше хэлэхэд. д'Артаньян өөдөөс нь;

-Тэгвэл чи даалгасан юмыг гүйцэтгэж чадахгүй болно шүү дээ, гэв.

-Өнөө орой надад захидлынхаа хуулбарыг өгчих би маргааш болтол цээжилчихье. Артаньян "За ямар байна, миний хэлдэг үнэн байгаа биз?" гэх байртай нөхөд рүүгээ харлаа. Тэгээд Планшед хэлрүүн:

-Чи найман хоногийн дотор Винтер гуайд явж хүрээд найман хоногийн дотор буцаж ирэх хэрэгтэй. Ингээд арван зургаан хоног. Хэрвээ явснаасаа хойш, арван зургаа дахь хоног дээрээ, оройн найман цагт чи ирдэггүй юм бол таван минут хожигдоод ирлээ ч гэсэн чи бусад мөнгөө авахгүй гэж мэд, гэлээ.

-Тэгвэл надад цаг авч өгөөч. эрхэм ээгэж Планше гуйлаа.

Туйлгүй өгөөмөр зантай. Атос цагаа Планшед өгөөд, май үүнийг аваад, эр хүн шиг үйлстэй яв. Чи нэг газар саатаж, үг алдах юм уу, хүн хард юм ярьчихвал, чамд их итгэж чамайг бидний өмнө заасан эзнийхээ толгойг цусдана гэдгийг санаж яв. Мөн чиний буруугаас д'Артаньянд ямар нэг гайучирвал чамайг хаа ч байсан би эрж олоод, бөөрийг чинь гаргана гэж мэдээрэй гэлээ.

Ингэж хардсанд гомдож, бас шадар цэргийн хэнэггүй байраас айсандаа Планше, -Ээ эрхэм минь! гэж дуугарав.

Портос нүдээ муухай эргэлдүүлж, Би чиний турсгыг амьдаар чинь өвчинө шүү гэлээ. -Пээ эрхмээ!

Арамис ердийнхөө номхон, аятай дуугаар, чамайг би зэрлэг улсын аргаар муу гал дээр шатаана шүү гэв.

-Еэ эрхэм минь! гээд Планше уйлчихав. Хэлсэн үгэнд сүрдсэндээ тэр юм уу, дөрвөн нөхдийн бат нөхөрлөлд сэтгэл уярсандаа тэр үү, бүү мэд. Артаньян гарыг нь бариад, тэвэрч. -Энэ эрхмүүд надад сайн болоод л эд бүгдийг хэлж байгаа юм үнэндээ эд чамд сайн юм шүү дээ гэж хэллээ.

-Эрхэм минь, би даалгасан зүйлийг гүйцэтгэнэ, эсвэл намайг хэсэгчиж хаяг, намаг хэсэг бусаг тасдлаа ч гэсэн нэг ч үг алдахгүй шүү гэж Планше дуу алдав. Планше захидлыг шөнөдөө цээжилж амжаад, маргааш өглөө нь найман цагт замд гарахаар тогтлоо. Гарснаасаа хойш

арван зургаа дахь өдөртөө, оройн найман цагт ирэх учиртай болохоор, үүгээр арван хоёр цаг хожив.

Өглөө Планшег мориндоо мордсон хойно, дотроо Бекингэмд сайн байдаг д'Артаньян түүнийг хажуу тийш дагуулж аваачаад:

-Дуулж бай, захидлаа чи Винтер гуайд өгөөд, уншиж гүйцсэн хойно нь "Гэгээн сайд Бекингэмийг сайн хамгаал, түүний амийг хорлох гэж байна" гэж бас хэлээрэй. Энэ нууц тун гойд чухаг, зүйл болохоор, энэ нууцыг чамд итгэж байгаагаа би нөхдөдөө хүртэл хэлж чадаагүй шадар цэргийн даамал болгоно гэж амласан ч гэсэн энэ тухай би захидалд бичихгүй байсан юм шүү гэж захилаа.

-Бүү сэтгэл зов, эрхмээ намайг итгэж болох хүн гэдгийг үзнэ ээ та, гээд Планше сайхан морин дээр мордоод цогиулан гарав. Тэр морио хуарангаас хориод мод газар орхиж, цаашаа шуудангийн мориор явах ёстой байжээ. Гурван шадар цэргийн хэлснийг санаж сэтгэл жаахан шимшрэх боловч, ерөнхийдөө урамтай сайхан явлаа.

Маргааш өдөр нь Базен Тур хот руу мордлоо. Авсан даалгавраа гүйцэтгээд ир гэж түүнд найм хоногийн хугацаа өгсөн аж. Элчүүд нь яваад ирээгүй байх тэр зуур дөрвөн нөхөд урьд урьдынхаасаа илүү их сэрэмжлэн чих тавьж байсан нь мэдээж хэрэг. Тэд бүхэл өдөржингөө улсын яриаг чагнаж Хамбын ажиллагааг ажиглан Ришельед ямар нэгэн элч ирсэн эсэхийг тагнаж байлаа. Харуул манаанд гаргах гээд гэнэт дуудах үед, сэтгэл нь яг хийгээд явчихдаг удаа олон байв. Түүнээс гадна Миледи бол хүнд нэг таринадаад дор нь унтуулдаг босоо ороолон болохоор тэд амь насаа бас сэрэмжлэх ёстой байлаа.

Найм дахь өдрийн өглөө, дөрвөн нөхдийг нөгөө буудлын газарт сууж байхад Базен ердийнхээрээ цовоолог инээмсэглэсээр орж ирээд, тохиролцсон ёсоор:

Арамис гуай, танай дүү бүсгүйгээс хариу захиа авч ирлээ гэв. Дөрвөн нөхөд, бие биеэ баяртай харав. Хэргийн хагас хэдийгээр арай бага цаг шаардах, хөнгөн хэсэг нь ч гэсэн бүтжээ. Арамис өөрийн эрхгүй улайчхаад, үсгийн алдаатай, эв хавгүй бичигтэй захидлыг авлаа. Ээ бурхан минь! гэж Арамис инээж дуу алдаад-хөөрхий Мишон ер де Ваутюр гуай шиг бичиж огт сурахгүй хүн дэг, би цөхөрчорхилоо гэв.

Захидал ирэх үед дөрвөн нөхөдтэй юм ярьж, байсан Швейцар цэрэг, тэр хөөрхий Мишон гэгч чинь юун хүн бэ? гэж асуув,

-Үгүй, бараг юу ч биш дээ, бурхан минь. Нэг хөөрхөн залуу оёдолчин бүсгүй байдаг юм. Түүнд би их сайн байсан болохоор дурсгал болгож хэдэн мөр бичнэ үү гэж гуйсан юм даа гэж Арамис хариуллаа.

-Тэр бүсгүй, энэ үсэг шигээ том юм бол та их азтай хүн юмаа гэж Швейцар цэрэг тохуурхав. Арамис захидлыг хараад, Атост өгөв.

-Юу гэж бичиж вэ, уншаад орхиоч Атос, гэж Арамис гуйв.

-Атос тэр зурвасыг гүйлгэж хараад, хүнд төрсөн байж болох бүх хар сэрийг арилгахаар, чанга уншсан нь

- "Хайрт ахаа, эгч бид хоёр зүүд тайлахдаа их сайн улс бас зүүднээс их айдаг, гэхдээ тийм зүүдний хувьд гэвэл бүү үнэмш зүүд гэдэг хуурамч гэж хэлж болно байхаа.

За сайн байж, хааяа хааяа өөрийнхөө тухай дуулгаж байгаарай.

Аглая Мишон" гэжээ.

Захидлыг уншиж байх зуур хүрч ирсэн морин цэргийн хүн ямар зүүдний тухай бичиж байгаа юм бэ? гэж асуухад, Швейцар цэрэг мөн тосч аваад:

-Нээрээ ямар зүүд вэ? гэлээ.

-Өө, яахав дээ бурхан минь, би зүүдэлсэн юмаа түүнд бичсэн юм л даа гэж Арамис хариуллаа.

-Тиймээ зүүдээ ярих гэдэг нээрээ амархан, даанч би ер зүүдэлдэггүй юм гэж Швейцар цэрэг хэлэхэд Атос суудлаас босох зуураа:

-Та их азтай хүн юмаа. Би мөн ингэж хэлж чадахтай байсансан бол азтай байхсан гэв. -Атос шиг ийм хүн юухнаар ч гэсэн өөртэй нь атаархаж байгаад Швейцар цэрэг хөөрөөд,

-Ерөөсөө үгүй, тун ч зүүдэлдэггүй, огт үгүй гэж давтана. Атосын босохыг Артаньян хараад, мөн босч, түүнийг сугадаад хамт гарлаа. Морин цэргийн хүн Швейцар цэрэг хоёрын бүдүүлэгдүү хошигнолд Арамис, Портос хоёр хариулж үлдлээ. Базен ч яахав, сүрэл дэвсгэр дээр очоод унтчихлаа. Швейцар цэргээс тэр арай нарийн сэтгэхүйтэй хүн болохоор Арамисыг ромын богд лам болчхоод, өөрт нь хамбын мяндаг хүртээж байна гэж зүүдлэв.

Гэвч Базен сайн явж ирснээр манай дөрвөн нөхдийн сэтгэлийг шаналгаж байсан түгшүүрийн зөвхөн хагас нь арилсныг бид дурссан билээ. Хүлээхээр цаг явж өгөх биш, ялангуяа д'Артаньянд цаг өнгөрөх нь тун удаан санагдаад хоног дөчин найман цагтай болсон гэж мөрий тавихад бэлэн болж байлаа. д'Артаньян далайгаар аялахад, өөрийн эрхгүй удах явдал гардгийг мартаад, Миледигийн хүчин чадлыг дэндүүлэн бодож байв. Шулам шиг санагдах тэр бүсгүйд мөн тийм ер бусын ид шидтэй хамсаатан бий байх гэж Артаньян бодоод ялихгүй чимээ гарах бүрдөөрийгөө барихаар юм уу Планшег, өөртэй нь нөхөдтэй нь нүүрэлдүүлэхээр авч ирлээ гэж айдаг байв. Тэр ч байтугай, сайн зарцдаа итгэсэн итгэл нь өдөр ирэх тутам багасаад байлаа. Артаньяны сэтгэл зовох нь улам ихэдсэнээр, Портос, Арамис хоёрт нөлөөлөв. Ганц Атосын хувьд л ямарч аюулгүй, ердийн явдлыг гажуудуулсан юм юу ч үгүй юм шиг тайван хэвээрээ байв.

Арван зургаа дахь өдөртөө д'Артаньян, түүний нөхдийн сэтгэл туйлгүй хөдлөөд, байж сууж чадахгүй, Планшегийн эргэж ирэх ёстой замаар дэмий холхицгоов.

-Бүсгүй хүн та нарыг ингэтэл айлгаж байгаа юм бол та нар үнэндээ эрчүүл биш хүүхдүүд юм

байна. Чухамдаа бидэнд ямар аюул тулгараад байна вэ? Шоронд орохуу? Тэгвэл биднийг гаргаад авчихна биз? Бонасье авгайг гаргаад авчихсан шүү дээ. Толгойгоо авахуулах уу? өдөр болгон, бид сувагт түүнээс ч илүү аюулын доор, санаа зовохгүй явж л байдаг шүү дээ, юу гэвэл үхэр бууны сум бидний хөлийг яйртал цохиж болно, тэгвэл, эмч, бидний хөлийг тайрахдаа яргачны толгой огтлохоос лав л илүү их тарчлаах байхдаа. Тайван хүлээцгээ, хоёр цаг, дөрвөн цаг, их удахдаа л зургаан цагийн дараа Планше энд ирнэ. Планше ирнэ гэж амалсан, түүний үгэнд би их итгэж байсан юм, овоо сайн хүн шиг надад санагддаг юм гэнэ.

-Түүнийг ирэхгүй бол яах вэ? гэж д'Артаньян асуулаа .

-За ирэхгүй бол яахав, аль нэг шалтгаанаар саатсан л байж таарна. Тэрчинь мориноос унаж болно. гүүрэн дээрээс хальтраад нисчихэж мэднэ, хурдан явснаас болж хатгалга туссан байж болно. Ээ дээ эрхмүүд ээ юу болж мэдэхийг бодолцох хэрэгтэй шүү дээ. Амьдрал гэдэг чинь элдвийн аар саар зовлонгоос хэлхсэн эрих юм. Гүн ухаантан тэгээд түүнийг инээсээр эргүүлж суудаг билээ. Эрхмүүд минь надтай адил гүн ухаанд шүтэж үзалив сууцгаа дарс ууя ирээдүй чинь, шил сайхан дарсны цаанаас л юунаас ч илүү сайхан харагддаг юм шүү гэж Атосыг ярихад энэ ч яриагүй зөв, гэхдээ л лонхны бөглөө авах тутмаа Миледигийн зоориноос ирээгүй байгаа даа гэж үргэлж айсаар хаширч байна гэж д'Артаньян хариулав.

-Та дэндүү хямсгар байна. Миледи чиньх сайхан бүсгүй шүү дээ гэж Атос хэллээ.

-Хүний нүд хужирласан бүсгүй дээ гэж, Портос мохоодуухан хошигноод ерийнхээ заншлаар тачигнатал инээд алдлаа. Атосын бие зарсхийж, хөлсөө арчиж байх шиг магнайгаа илээд босохдоо, сэтгэл хөдөлсөн байдлаа нууж чадсангүй.

Ингэж байтал өдөр өнгөрөөд, хэдийн удаан мэт боловч орой болохоо алдаж буудлын газарт улс олширлоо. Алмас чулууг худалдсанаас, хувиа авсан Атос нөгөө гуанзнаас гардаггүй байлаа. Манай нөхдийг сайхан хоолоор дайлсан Бюзины гуайтай энэ талаар Атос сайн нийлжээ. Тэгээд оройн долоон цаг болоход тэр хоёр ердийнхөөрөө шоо хаяж тоглож байлаа. Гадуур харуул манааг зузаалах улс яваад өнгөрч байх дуулдана, долоон цаг хагас болоход унтах дохио дуугарлаа.

Артаньян бид баларлаа гэж шивэгнэв. Атос өврөөсөө дөрвөн алтан зоос гаргаж ширээн дээр хаяад; Бидний мөнгө баларлаа гэж та хэлэх гээ юу гэж залуугийн үгийг хэнэггүй залруулснаа, за эрхмүүдээ дохио дуу гарлаа явж унтъя даа гэв.

Ингээд Атос д'Артаньянтай цуг буудлын газраас гарлаа. Тэдний араас Арамис, Портос хоёр хөтөлцөж явлаа. Арамис нэг шүлэг аман дороо бувтнаж цөхөрч гүйцсэн Портос сахлаа хайргүй имэрнэ.

Гэнэт харанхуйгаас нэг хүнний бараа тодорсон нь д'Артаньянд танил юм шиг санагдаад, чихэнд хоногшсон дуу, эрхэм ээ таны нөмрөгийг би авчирлаа, өнөөдөр чинь, жихүүхэн орой байна, гэж хэлэв.

Магнай хагартал баярласан д'Артаньян, Планше гэж дуу алдав. Арамис Портос хоёр мөн тосч аваад, Планше байна гэлцэнэ.

-За яагаав, Планше л байна, юунд гайхаад байгаа юм бэ? Энэ чинь найман цагт ирнэ гэж амласан одоо яг л найман цаг цохиж байна. Сайн байна. Планше хэзээ нэг цагт та эзнээсээ салж явах болбол таныг би өөрөө авнаа. та хэлсэн үгэндээ хүрч чаддаг хүн юм байна, гэж Атос хэллээ.

-Үгүй шүү, хэзээ ч би д'Артаньян гуайгаас өөр эзэнтэй болохгүй, гэж Планше маргалаа. Энэ үеэр, Планше гарт нь зурвас атгуулж байгааг д'Артаньян мэдлээ. Планшег явуулахдаа тэвэрсэн шигээ, буцаад ирсэн тухайд нь д'Артаньян тэвэрмээр санагдсан боловч зарцдаа ийнхүү халуун сэтгэлэг илэрхийлж байгаагаар хажуугийн улсад хачин санагдажсэжиг төрүүлэх бий гэж бодоод биеэ барив.

-Зурвасыг би авсан гэж д'Артаньян Атос болон нөхдөдөө дуулгалаа.

-За сайн гэртээ хариад уншиж үзье, гэж Атос хэллээ. Зурвас д'Артаньяны гарыг төнхөх шиг санагдаж алхаагаа хурдасгах гэтэл, Атос тохойноос нь барьж аваад, өөрийн эрхгүй, хөл нийлүүлж явахад хүрэв. Арай гэж хэдүүлээ өрөөндөө нэг хүрч ирээд дэнгээ асаалаа. Гэнэт хүн ороод ирэхээс болгоомжилж, Планше үүдэнд зогсоод, д'Артаньян чичирхийлсэн гараар захианы лацыг ч хэмхэлж, задаллаа.

Захидал гэж жинхэнэ англи бичгээр, хагас мөр бичсэн байсан нь тун товчхон: "thanks, be quite easy" Энэ нь: "гялайлаа сэтгэл бүү зов" гэсэн ажээ. Атос захидлыг д'Артаньяны гараас аваад дэнгийн дээр барьж, үнс болж дуустал нь шатаалаа.

Ингээд Планшег дуудаж хонгор минь чи одоо долоон зуун зоосоо нэхэж болно, гэхдээ чи энэ зурвасыг авч явахдаа онц их аюулд тулгарч байгаагүй л юм байна гэв.

Тэхдээ л зурвасыг бүрэн бүтэн авчрах гэж элдэв арга ов хэрэглэсэн юм шүү, гэж Планше хариулав.

-За алив адал явдлуудаа бидэнд яриад орхи, гэж д'Артаньян хэлбэл Планше: Үүний чинь удаан ярих хэрэг болно шүү дээ гэв.

-Планше чиний зөв. Тэгээд чиг унтах дохио дуугарсан манай дэн бусдынхаас удаан асаатай байвал ажигдах болно гэж Атос хэллээ.

-За тэгье, яахав хэвтэж унтъя, тайван унтажүз Планше, гэж д'Артаньян зөвшөөрөв. -Үнэнээ хэлэхэд, арван зургаан хоногийн турш анх удаа тайван унтах болж байна эрхэм ээ.

-Би ч гэж ялгаагүй, гэж д'Артаньян дуугарав.

-Би ч гэсэн тэр, гэж Портос дуу алдав.

-Би ч гэсэн тэр, гэж Арамис хэллээ.

-Үнэнээ та нарт хэлчихье, би ч гэсэн ялгаагүй гэж Атос хүлээв.

XLIX. МУУ ТАВИЛАН

Тэр зуур, Миледи уурласандаа багтарч ядан хөлөг онгоцонд агуулсан хилэнт араатан шиг, тавцан дээгүүр нааш цаашаа холхив. Далай руу үсэрч ороод, буцаж эрэг тийш сэлж гармаар байжээ. д'Артаньян өөрий нь доромжилж. Атос айлган сүрдүүлсэн, өөрөө тэднээс хариу өшөөгөө аваагүй, франц нутгаас гараад явжбайна гэж бодохоос Миледийн сэтгэл амарч чадахгүй байв. Удалгүй энэ бодол нь Миледиг тэсэхүйеэ бэрхээр шаналгаах болоод, өөртөө элдэв аюул учирч болзошгүйг үл харгалзан, онгоцны даргаас эрэг дээр буулгаж өгөхийг гуйх боллоо. Гэвч Англи Францын цэргийн хөлөг онгоцнуудын хооронд, хулгана, жигүүртэн хоёрын дунд орсон сарьсан баавгай шиг хүнд байдлаасаа даруй гарч английн нутагтхүрэхийг хичээсэн онгоцны дарга тэр гуйлтыг бүсгүй хүний илүү маяг гэж үзээд, шууд татгалзжээ. Гэхдээ, Хамба ламтны онцлон захиж өгсөн тэр бүсгүйг далайн байдал Францчууд хоёр саад болохгүй бол британ нутагт нэг боомт хот, Лориан юм уу, Брестэд аваачиж буулгахаар амлав. Гэтэл салхи өөдөөс сөрж, далай их давлагаалан, цаг үргэлж замаасгажиж аргацаахад хүрч байлаа.

Шарантыгаас хөдлөөд ес хонож, хорсож хилэгнэсэндээ зэвхий царайлсан Миледи Финистер гэгч эргийн униартсан барааг алсаас харав.

Франц нутгийн энэ өнцгөөс Хамбад хүрч очтол доор хаяад гурав хоног хэрэгтэй, мөн буух гэсээр байтал нэг хоног өнгөрөхийг нэмэхээр дөрөв хоног, үүнийг өнгөрсөн есөн хоногтой нийлүүлэхээр, арван гурван хоног хий дэмий үрэгдэхболох нээ. Арван гурван хоног гэдэг чинь, энэ завсар Лондон хотонд өчнөөн ч их" хэрэг явдал гарчихсан байж болох хугацаа шүү дээ гэж Миледи бодлоо. Мөн өөрийгөө буцаад очвол Хамба лам уурлана. Тэхлээр өөрий нь бусдад ял тулгахыг сонсож авахаасаа, бусдын гомдлыг илүү дуртай сонсох болно гэж санаад, хөлөг онгоц Лорион, болон Брестийн хажуугаар өнгөрч байх үед буулгаж аль гэж даргаас дахин шалсангүй дарга ч мөн өөрөө энэ тухай зориуд юм дурссангүй. Ингээд Миледи, яван явсаар, Планшег Портсмутын боомтноо Франц орох хөлөг онгоцонд, сууж байхад тэр боомтноо морилон ирж байлаа.

Дөнгөж сая барьж дууссан дөрвөн том хөлөг онгоц усанд тавьж, хот даяар бөөн хөл хөдөлгөөнтэй байгаа аж. Тавцан дээр Бекингэм цул алт, алмас, эрдэнийн чулуу болсон цагаан өд мөр рүү нь унжсан бүрх малгайтай, мөн бараг өөр шиг нь шахуу гял цал болсон бараа бологч нартай зогсож байв. Өвлийн ховор сайхан нэгөдөр байлаа. Хорвоод нар гэж байдгийг англичууд тийм өдөр л нэг юм санадаг билээ. Илч нь буурсан боловч сүрлэг сайхан гэгээн наран нэгэнт шингэх болж, тэнгэрийн хаяаг улайруулж, далай дээгүүр гал мэт зурвас татуулна. Эртний байшин, барилга цамхаг тийш шингэж бий алтан туяагаа тусгасанд, цонхны шил галын дөл мэт улалзах аж.

Эрэг рүү ойртох тусмаа улам бүр анхилуун болох далайн сайхан салхинд Миледи гарч зогсоод, тэр сүртэй их бэлтгэл ажлыг ажаад эдний их цэргийн хүчин чадлыг ганц бүсгүй би, хэдэн хүүдий алтны хүчээр няц дарах учиртай. тэр хүн юм шүү гэж бясалган бодож, ассирийн цэргийн хуаранд орж үй түмэн дайчин баатар морь, хөсөг, зэрзэвсэг сэлтийг хармагц гараа ганц дохисон төдийхнөөр зэрэглээ мэт замхруулсан Юдифь дагинатай өөрийгөө зүйрлүүлж байлаа. Хөлөг онгоц зогсоолд ирээд, аргамжин дэгээгээ доош буулгах гэж байтал, лут сайн

зэвсэглэсэн жижиг хурдан онгоц дөхөж ирээд, харуулын онгоц гэж мэдэгдэв. Тэр онгоц жижиг завь буулгасанд нэг бага дарга, найман сэлүүрчний хамт суугаад, наашаа, хөлөг онгоцны тавцан дээр гарах шат руу ойртож ирлээ. Даргыг тавцан дээр гарч ирэхэд, цэргийн хүнийг хүндэлдэг заншлын дагуу гүнээ хүндэтгэн угтав. Тэр дарга онгоцны даргатай хэдэн үг сольж, нэг бичиг үзүүлсэнд, даргын тушаалаар онгоцны бүх улс, мөн сууж яваа хүмүүсийг цөм дээш гаргалаа.

Хөлөг онгоцныхон гарч ирээд жагссан хойно тэр дарга, уул онгоц хаанаас хөдөлсөн, хаагуур явсан, хаана зогссон .сэлтийг чанга дуугаар асуувал, онгоцны дарга түгдрэлгүй, даруй хариулж байв. Дараа нь ирсэн дарга тавцан дээр байгаа хүмүүсийг нэг нэгээр ажиглан харсаар Миледи дээр ирээд тун хянуур харсан боловч, ер юм дуугарсангүй. Ингэснээ, хөлөг онгоцны дарга дээр очиж, бас нэг юм хэлээд, онгоцны даргын үүргийг өөртөө авсан юм шиг нэг тушаал өгсөнд, онгоцны улс даруй биелүүллээ.

Хөлөг онгоц цаашаа хөдөлж, жижиг онгоц хажууд нь зэрэгцэн явж, зургаан үхэр бууныхаа амыг тулган сүрдүүлэх мэт. Хөлөг онгоцны хойноос дагаж яваа завь, онгоцны дэргэд жаахан цэг шиг бараагүй харагдана.

Цэргийн дарга, Миледиг ажиг байх зуур Миледи мөн нүд салгаагүй гэдгийг мэдэхэдамархан биз. Тэр хурц нүдтэй бүсгүй, хэдий ажигч, хүний бодол санааг гадарлачхаад байдаг гэлээ ч энэ удаа тун ч хэнэггүй царайтай хүнтэй учраад, хичнээн хянуур харсан боловч юу ч илрүүлж эс чадлаа. Өмнө нь зогсоод өөрий нь дуугүй их хянуур ажиглаж байгаа дарга хорин тав зургаан настай болов уу гэмээр, цонхигордуу царайтай, ялимгүй хөнхөр цэнхэр нүдтэй, цэвэрхэн уруулаа тас жимийсэн зэгсэн урт эрүү нь зоримог зантайг илчлэх боловч, жирийн англи хүмүүст ийм эрүү голдуу зөрүүд зантайгийн шинж байдаг билээ. Шүлэгч, сэтгэгч, цэрэг улсынх шиг палигар магнайгий нь богино тайрсан шингэн үс халхлах төдий болжээ. Эрүүнд нь байгаа сахал, үс хоёр нь сайхан хонгор туяатай юм.

Хөлөг онгоц, дагалдаж яваа жижиг онгоцны хамтаар дотоод зогсоолд орж ирэхэд нэгэнт харанхуй боллоо. Шон дээрх дохионы дэнлүү, эргийн гэрэл гэгээ сэлтийг бороо орохын өмнө сарны бүдгэрдэг шиг бүдгэрүүлсэн манангаас болоод шөнө улам ч харанхуй, агаар чийгтэй хүйтэн ажээ. Тэсвэр хатуужил ихтэй зоримог бүсгүй болох Миледийн бие хүртэл өөрийн эрхгүй зарсхийгээд явчихлаа.

Нөгөө дарга Миледийн юмыг заалгаж юмыг нь доошоо завинд аваачиж тавь гэлээ. Тэгсэн хойно Миледиг өөрий нь хамт хөтлөлцөөд бууя гэж гараа сунгав. Миледи түүний өөдөөс хараад, түдгэлзэхийн зогсоод, өршөөлт эрхэм та юун хүн байна даа. Юун тухайд та, намайг ингэтлээ онцлон анхаарч эелдэг тус болж байгаа юм бэ? гэж Миледи асуув.

Энэ тухай авхайтан та миний хувцсаар гадарлаж болох байсан би английн усан цэргийн дарга хүн гэж цаад залуу хариуллаа.

Ингэдэг заншилтай сан билүү? Английн усан цэргийн дарга нар нутгийнхаа аль нэг боомтод ирсэн англи бүсгүйд биеэрээ үйлчилж, эрэг дээр хүртэл гаргаж өгдөг эелдэг заншилтай болоо юу?

-Тиймээ. Миледи, харин эелдэг зангийн үүднээс ч биш, сэрэмжлэхийн үүднээс ингэдэг юм. Дайны үед, харийн хүмүүсийг тусгай зориулсан буудалд аваачиж буулгаад, тэдний тухай нарийн тодорхой мэдээ цуглуулахаас нааш, харгалзаж байлгадаг юм. Энэ үгийг өөгүй эелдэг, тайвнаас тайван дуугаар хэлсэн боловч, Миледиг бүрэн итгүүлж чадсангүй.

Үгүй, би чинь харийн хүн биш шүү дээ, өршөөлт эрхэм ээ, миний нэр Кларик авхай гэдэг, тэгээд энэ арга хэмжээ.... гэж Миледи Портсмутгоос, Манчестер хүртэлх нутагт урьд хожид ярилцсаар ирсэн хамгийн цэвэрхэн англи хэлээр хэлтэл,

-Энэ арга хэмжээ нийтэд ялгаагүй хэрэглэж байгаа болохоор. Миледи та ганц өөрийгөө жич үзүүлэх гэж оролдоод дэмий бий заа.

-За тэгвэл өршөөлт эрхэм таныг би дагая гээд, Миледи, даргын гарыг түшээд, шатаар бууж, доор нь хүлээж байсан завинд оров. Дарга хойноос нь завинд суугаад, дэвсээтэй байгаа нөмөргөн дээр Миледиг суулгаж, өөрөө хажууд нь суугаад,

-За сэлүүрд гэж усан цэргүүдэд тушаалаа.

Найман сэлүүр даруй усанд далд ороод, тэдний таталтын хүч нийлж, нэгэн түлхэлт болоход, завь усан дээгүүр нисээд гарах мэт санагдав. Тавин минут болоод, завь эрэгт хүрлээ. Нөгөө дарга эрэг дээр үсэрч гараад, Миледид гараа сунгалаа тэднийг нэг сүйх хүлээж байх аж. -Энэ сүйх биднийг хүлээж байгаа юм уу? гэж Миледиг асуухад, дарга хариуд нь: -Тиймээ, авхайтан, гэлээ.

Тэр буудал чинь тийм хол юм уу?

-Хотын нөгөө захад.

-За явья, гэж Миледи хэлээд, түдгэлзэлгүй сүйхэнд орж суув.

Миледийн бүх юмыг бүхээгийн ард өөрөө харж байж сайн баглуулаад, хийж дууссан хойно, Миледийн дэргэд сууж сүйхний үүд хаав. Хөтөч, тушаал өгөхийг хүлээлгүй, тэр ч байтугай хаашаа явахыг ч асуулгүй морио ташуурдан цогиулж сүйх хотын гудамжаар давхилаа. Энэ хачин явдал Миледид их сэжиг төрүүлэв. Залуу дарга юм ярих дургүй байгааг мэдээд сүйхний буланд шигдэж суугаад толгойдоо орсон хамаг тааврыг эргэцүүлж үзэв. Тэгтэл мөч хиртэй болоод, өдий удаан явж байгааг гайхаж, хаана яваагаа үзэх санаатай сүйхний цонх руу бөхийж харлаа. Байшин барилга харагдахаа болиод. мод харанхуйд нэг нэгийгээ хөөж яваа хий юм мэт бүртэлзэх аж. Миледийн бие арзасхийгээд,

Бид чинь хотоос гарчихсан байна шүү дээ, гэж хэллээ. Залуу дарга юм дуугарсангүй. -Хаашаа аваачих гэж байгаагаа надад хэлэхгүй бол би цаашаа явахгүй шүү, өршөөлт эрхэм танд хэлчихье.

Ингэж сүрдүүлэхэд ч мөн хариу юм дуугарсангүй.

-Энэ чинь арай дэндэж байна, гэж Миледи дуу алдаад туслаарай! туслаарай! гэж хашгирав.

Миледийн хашгирахад дуулах хүн ч алга, сүйх тэрэг замаар хурдалсан янзаараа, залуу дарга хөшөө шиг нам сууна.

Миледи үе үе гаргадаг айхгар ширүүн царайгаараа залуу дарга өөд харлаа. Миледийн тийм царай хүний сэтгэлд нөлөөлөхгүй өнгөрсөн нь ховор билээ. Хилэн бадарсан нүд нь харанхуйд гялалзав.

Цаад' залуу нөгөө л тайван янзаараа аж:

Миледи сүйхний үүдийг нээгээд, үсрэн буух гэж оролдоход, болгоомжлоорой, авхайтан, та унаад үхнэ шүү гэж залуу дарга ажиггүй дуугарав.

Миледи уурлаж, арга ядан багтарсаар, дахин суув. Дарга бөхийж өөдөөс нь хараад, саяхан гуа сайхан байсан царай уур хорсолд автан муухай хувирч, бараг дур гутам болсныг

гайхав бололтой. Үнэн дүрээ таниулж орхивол баларна гэдгийг хар санаат бүсгүй ойлгоод, хүлцэнгүй номхон дүр гаргаж гомдоллосон дуугаар:

-Намайг ингэж хүчээр хавчиж доромжилж байгаа чиньтанай засгийн газар уу, та өөрөө юу, эсвэл өөр нэг өштөн байна уу? Би хэнийг гэж мэдвэл таарах вэ? хэлээд өгөөч тэн! гэр минь гэв.

-Авхайтан таныг хүчээр хавчиж байгаа юм огт алга, таныг ингэж аваачиж байгаа явдал бол, англид ирж байгаа хүн бүхэнд бидний хэрэглэхээс өөр замгүй болсон сэрэмжлэх арга хэмжээ юм.

-Та тэгээд намайг ерөөс танихгүй юу?

-Тантай нүүр учрах завшаан надад анх тохиолдож байна. Тэгээд чин сэтгэлээ барьж хэлбэл, намайг үзэн ядах шалтаг танд үгүй биз?

-Үгүй гэж андгайлъя. .

-Залуу хүний дуу эгэлгүй тайван, ажиггүй, тэр ч байтугай зөөлөн байсанд, Миледигийн санаа амрав. Эцэстээ цаг хиртэй яваад, сүйх тэрэг төмөр сараалжин үүдний өмнө зогслоо. Хаалганаас цаашаа төв хэлбэртэй буйд лагс том шилтгээний бараа харагдаж, тийшээ зассан зам явжээ. Сүйхний дугуй торгон элсэн дээгүүр өнхөрч, нижгэнэсэн их дуу Миледигийн чихэнд сонсогдоход далайн давлагаа чулуут эрэг мөргөж байгаа юм байна гэж Миледи ойлгов. Сүйх тэрэг хоёр ч хаалгаар явж өнгөрөөд эцэстээ, нэг дөрвөлжин харанхуй хашаанд ирж зогстол, сүйхний үүдийг даруй онгойлгоод, залуу дарга шалмаг үсрэн бууж, Миледид гараа сунгавал, Миледи түүний гарыг түшиж бузгай амгалан гарч ирлээ.

Миледи орчноо нэг эргэцүүлж харснаа, залуу дарга өөд харж дур булаам сайхан инээмсэглээд юу ч гэсэн би чинь танд баригдсан хүн юмаа. Гэхдээ энд их удахгүй биз гэж горьдоно. Миний цэвэр сэтгэл таны эелдэг сайхан ааш үүний баталгаа болно гэж хэлэв.

Цаад дарга энэ аятайхан магтаал үгэнд юу ч хариулалгүй цэргийн хөлөг онгоцны дээр бага

дарга нарын хэрэглэдэг шиг мөнгөн шүгэл гаргаж ирээд гурав дахин тухай бүр өөр янзаар шүгэлдсэнд зарц нар гарч ирээд хөлөрсөн морьдыг буулгаж сүйхийг саравчин доор аваачиж тавив. Залуу дарга дагуулж ирсэн бүсгүйгээ нөгөө л эелдэг тайван дуугаар гэрт орохыг урилаа. Миледи мөн л инээмсэглэсэн царай үзүүлсээр түүнийг сугадаж. намхан хаалгаар орвол, цаад мухартаа л гэрэл асаасан бөмбөгөр оройтой гудамд орлоо. Тэр гудамны адагт байгаа эргэлдсэн чулуун шатаар Миледи дарга хоёр дээшээ гараад, хүнд лагс үүднийөмнө зогсов. Залуу дарга цоожны нүхэнд түлхүүр хийж эргүүлбэл, хүнд үүд нугасаараа алгуур нээгдэж, Миледигийн суух өрөө онгойлоо. Баригдаж ирсэн бүсгүй бүхэл өрөөг ганц харцаар л.

нарийн ажиж амжлаа Өрөөг засаж янзалсан нь хоригдол хүнд ч таармаар, зүгээр эрх чөлөөтэй хүн ч сууж болмоор аж, гэхдээ цонхондоо сараалжтай, үүд нь гаднаасаа түгжээтэйг үзэхэд шорон байж таарах бололтой. Хамгийн бэрх юм үзэхээрээ болж хатуужсан энэ бүсгүй түрхэн зуур сэтгэл санаагаар унаж, зөөлөн сандал дээр лаг хийтэл ойчоод, элгээ тэврэн толгойгоо унжуулж, юу юугүй шүүгч орж ирээд, байцааж гарах бий гэж дагжин хүлээв.

Гэтэл далайн, явган цэргийн хэдэн хүн хайрцагтай боодолтой юм хум оруулж өрөөний буланд тавиад гарснаас өөр хэн ч орж ирсэнгүй. Залуу дарга нөгөө л хэлбэршгүй тайван байдлаараа цэргүүдэд дохио, шүгэл хоёроор тушаал өгч, өөрөө ганц ч үг хэлэхгүй аж.

Энэ хүн дорд улстайгаа ярилцах хэл байдаггүй, эсвэл хэл хэрэггүй болчихсон юм уу гэмээр Эцэстээ Миледи тэсч чадсангүй яриа үүсгэв.

-Эд бүгд ямар учиртайг буян бодоод хэлж өгөөч, өршөөлт эрхэм ээ?

-Миний гайхаж мэлэрч байгаа юмыг тайлаад өгч үз. Учирч болно гэж би өөрөө бодож байгаа ямар ч аюул дайрч болохыг ойлгож байгаа ямар ч гай зовлонг би туулаад өнгөрөхүйц зоригтой хүн. Би хаана ирээд байгаа юм намайг энд чухам юу гэж байлгах болсон юм бэ? Биэрх чөлөөтэй юм бол юунд төмөр сараалж, төмөрлөсөн үүд хэрэгтэй болсон юм бэ? Намайг хорьсон юм бол би ямар гэмт хэрэг хийчихсэн хүн бэ?

-Авхайтан та, өөрт чинь зориулсан өрөөнд ирээд байна. Таныг тосч очоод, наашаа энэ цайзад авчир гэж над тушаасан юм. Энэ тушаалыг би цэрэг хүний ёсоор туйлбартай, тайж хүний ёсоор эелдэг зөөлөн биелүүлсэн гэж санаж байна. Үүгээр таны тухай санаа тавь гэж надад даалгасан үүрэг, юу ч болсон, одоодоо үүгээр дуусч байгаа юм. Бусдыг нь өөр хүн мэднэ гэв. - Тэр өөр хүн чинь хэн бэ? Түүний нэрийг та надад хэлж чадах уу? гэж Миледи асуулаа. Энэ үеэр шатан дээр давируул чанга хангинах чимээ гарч, хүний дуу дуулдсанаа нам болж зөвхөн наашаа ирж яваа хөлийн чимээ дуулдана.

-За, тэр хүн, одоо ирлээ дээ, авхайтан гэж дарга хэлээд, үүднээс холдож, хүндлэх байртай зогсон хүлээв. Үүд нээгдэж, нэг хүн ороод ирлээ. Тэр хүн малгайгүй, хажуудаа илд зүүсэн, нусны алчуур гартаа нухчих аж. Харанхуйд зогсожбайгаа тэр хүний биеийг Миледи танимаар юм шиг санагдаад сандлынхаа тохойлдох тавиур дээр гараараа тулж урагшаа бөхийж, өөрийн тааварласан зүйлийн үнэн худлыг мэдэх гэж мэрийжээ.

Цаад хүн аажмаар ойртож, дэнгийн гэрэлд гарч ирэх тутам Миледи өөрийн эрхгүй сандал

руугаа улам улам гүн шигдэнэ. Ингээд эргэлзэх юм огт үгүй болоод, Миледи дуу алдаж: -Юу! Винтер гуай та юу, энэ чинь! гэв.

Винтер гуай үүнд, эелдэг ч гэмээр, тохуурхсан ч гэмээр мэхийн ёслоод, тийм ээ гуа хатагтай! Би биеэрээ байна, гэв.

-Тэгвэл энэ шилтгээн чинь

-Минийх.

-Энэ өрөө

-Таных

-Та намайг баривчилсан хэрэг үү? Бараг тийм.

-Үгүй энэ чинь булай муухай хүч түрж байгаа хэрэг шүү дээ!

Хатуу ширүүн үгээр юу хийхэв, ах дүү улсын ёсоор сууж ярилцъя. Винтер гуай эргэж, залуу дарга, цаашдын тушаал заавар хүлээж байгааг хараад:

-За сайн, танд гялайлаа. Одоо Фельтон гуай та, бид хоёрыг орхиж болно гэв.

L. АХ ДҮҮ ХОЁРЫН ЯРИА

Винтер Лорд үүд түгжин цонхны хаалтыг хааж суух ширээгээ бэргэн дүүдээ ойртуулж байх зуур Миледи олон талаар эргэцүүлэн бодсоор, хэний гарт орсноо мэдэхээс нааш бодож олохын эрхгүй, тэр далдуур өөрийнхөө эсрэг хийсэн явуулгын учрыг ойлгов. Хадам ахтайгаа танилцсан цагаас аваад, түүнийг жинхэнэ тайж хүний чанар агуулсан, ан агнах тоглоом хоёрт их дуртай, бүсгүйчүүл эргүүлэхдээ ч мөн сүрхий боловч, элдэв явуулга хийхдээ муу гэж дүгнэсэн билээ. Өөрийг нь ирэхийг Винтер гуай яаж мэдээд барьж авав аа? Яагаад хорих болов? Атос хэдэн үг цухас дурдсанаас Хамбатай ярилцсан юмыг хажуугийн хүн сонсжээ гэж Миледи дүгнэсэн боловч, Атосыг ийм хурдан, зоримгоор хариу цохилт өгнө гэж итгэж чадахгүй байлаа. Юуны өмнө, Англид урьд үйлдэж байсанхэргээ илэрч дээ гэж Миледи айлаа. Алмазан унжуурганаас хоёрыг Миледи тасалж авсныг Бекингэм мэдсэн байж болно. Ингээд хуучин аар саар чадаж байсны өшөөг авахаар шийдсэн юм болов уу. Гэтэл Бекингэм ерөөсөө бүсгүй хүнийг тэр дундаа жөтөөрхөх сэтгэлээс болж гэм хийсэн гэж үзэж байгаа бүсгүй хүнд хүч хэрэглэж чадахааргүй хүн билээ.

Энэ таамаглал Миледид арай илүү үнэмшилтэй санагдаад, өнгөрсний төлөөсийг авахаас биш, ирээдүйн явдлыг сэргэмжлэх гээгүй биз гэж бодлоо. Юу ч болсон жинхэнэ ухаалаг дайсны гарт ороогүй хадам ахынхаа гарт орсонд баярлаж, эндээс арай хялбархан мултарч гарах юм бодож байв. Цаашдаа яаж байвал таарахаа мэдэж авахын тулд, Винтер гуай хэдий их нууж хаалаа ч гэсэн энэ ярианаас мэдвэл зохих юмаа, цөмийг дуулж авна гэж Миледи бодоод за, ярилцъя, эелдэг ах минь гэж бараг цовоо дуугаар хэллээ. Винтер гуай эхлээд

-За тэхлээр та, Англид эргээд ирээ юм бий дээ? Их Британийн хөрсөн дээр хөл тавихгүй гэж шийдсэнээ Парист байхад та олон удаа дуулгаж байсан мөртөө иржээ дээ? гэсэнд Миледи асуултад асуултаар хариулан:

-Ямар аргаар миний хойноос ингэтэл нарийн чанд хараа тавьж, миний ирэхийг мэдэхээр барахгүй, өдөр цаг, буух боомтыг хүртэл яаж мэдэж чадсанаа урьдаар над хэлж өгөөч гэв. Бэрийнхээ баримталж байгаа аргыг, лав хамгийн сайн нь байж таарна. гэж Винтер гуай бодоод, тэр аргыг баримтлан,

Англид юун хэргээр морилж ирснээ миний дүү эхлээд над дуулгачих? гэж хэлэв. -Би тантай уулзахаар ирсэн юм, гэж Миледи хадам ахынхаа таалалд нийцүүлэх санаатай худлаа хариулахдаа д'Артаньяны захидал авсан хадам ах нь энэ үгэнд улам их сэжиглэснийг мэдсэнгүй.

Өө тийм үү, надтай уулзах гэсэн юм уу? гэж Винтер гуай гунигтайхан дуугарлаа. -Харин тийм ээ, тантай уулзъя гэж ирсэн. Юуг нь гайхаад байна?

Та тэхлээр надтай уулзах гэж ирсэн, өөр ямар ч хэрэг зориг байхгүй юм биз дээ? -Байхгүй.

-Ингэхлээр та миний төлөө л Ламаншийн хоолойг гаталж, биеэ чилээгээ юм бий! Таны төлөө л тэр.

-Монди гэж! Юутай уяхан сэтгэл вэ, дүү минь!

-Таны хамгийн ойр төрлийн хүн чинь би биш юм үү? гэж Миледи тун сэтгэл уярам цагаахнаар асуув.

-Тэр ч байтугай, миний өвийг залгамжлах ганц хүн, тийм биз? гэж Винтер гуай сөргөж асуугаад Миледиг эгцлэн ширтэв.

Миледи хэдий биеэ сайн барьж чаддаг гэлээ ч өөрийн эрхгүй бие нь арзасхийлээ. Винтер гуай саяны үгийг хэлээд бэргэн дүүгийнхээ мөрөн дээр гараа тавьсан болохоор Миледийн бие арзасхийхийг ажиглав.

Энэ үг аргагүй голыг нь олж, сайн цохилт боллоо. Миледи эхлээд Кэттиг хов хэлжээ гэж бодов. Хувиа хичээсэн, сэтгэлийн улмаас Винтер бээлд муухан байдгаа зарц бүсгүйнхээ дэргэд болгоомжгүй илчилж байсан, мөн Артаньяныг хадам ахынхаа амийг өршөөлөө гэж болчимгүй уурлаж аашилнаа саналаа.

Цаг хожиж Винтер гуайгаар санааг нь хэлүүлэхийг хичээн, Милорд, таны үгийг би ойлгохгүй байна та юу гэх гээд байна? Таны үгэнд далд утга үгүй биз дээ? гэв.

Винтер Лорд мөн хуурамчаар цагаан цайлган дүр үзүүлж үгүй байлгүй яахав. Та надтай уулзахыг хүсээд англид ирж байна. Би тэр хүслийг мэдэж, үнэндээ гэвэл тэр тухай гадарлаад шөнө боомтод буух, эрэг дээр гарч ирэх элдэвзовлонгоос таныг ангижруулах гэж дарга нарынхаа нэгийг өөдөөс чинь явууллаа. Мөн түүнд сүйх тэрэг өгөөд, тэр хүн таныг нааш нь миний даргалдаг, өдөр болгон наашаа ирдэг энэ шилтгээнд авчирлаа. Ингээд бие биетэйгээ уулзаж байх гэсэн хүслээ хангахын тулд, энд би өөрт чинь өрөө засуулсан. Эд бүгд тэгээд таны надад хэлснээс илүү гайхмаар байна гэж үү? гэв.

Үгүй, ганцхан миний ирэхийг урьдаас дуулсны тань би гайхаж байна

-Тэрний чинь учрыг мэдэж цөхөх юмгүй эелдэг дүү минь. Танай хөлөг онгоцны дарга зогсохоосоо өмнө боомтод орох зөвшөөрөл гуйж, жижиг завиар, онгоцныхоо тэмдэглэл, хөлөг онгоцонд сууж яваа хүмүүсийн нэрсийн жагсаалтыг түрүүлэн явуулсныг та хараагүй юу? Би боомтын дарга болохоор тэр нэрсийг надад авчраад, таны нэр байхыг би үзсэн юм. Таны сая батлан хэлснээр, өнөө үед далайгаар явахад аюултай байхад миний төлөө л амиа тавьж аяллыг туулсны чинь би зүрх сэтгэлээрээ бас мэдээд таныг угтуулж хурдан онгоцоо явуулсан юм. Бусдыг нь та мэднэ газар.

Винтер Лордын худлаа хэлж байгааг Миледи ойлгоод, улам ч сүрдлээ.

Миледи дахин яриа үүсгэж, эелдэг ах минь, биднийг зогсоолд орж ирж байхад, эрэг дээр Милорд Бекингэм харагдав уу үгүй юу? гэлээ.

-Тиймээ, мөн. Аа, мэдлээ! түүнийг үзээд таны дотор үймрээ биз дээ. Түүний тухай бодол хүн бүхнийг зовоож байдаг орноос ирсэн хүн. Бекингэмийн Францтай дайтахаар бэлтгэж байгаа явдал таны дотно нөхөр Хамбын сэтгэлийг их түгшүүлж байгааг би мэднээ.

Миний дотно нөхөр Хамба аа? гэж энэ тухайд Винтер гуайг багтай юм дуулжээ гэж Миледи

ҮНЭМШИН, ДУУ АЛДАВ.

-Тэр таны дотно нөхөр биш юмсан уу? гэж бээл хайшраг эвгүйхэн асуугаад, би эндүүрсэн бол уучлаарай, надад тэгж санагдсан юм. Милорд герцог таны тухай бид сүүлд бас ярилцана аа, одоохондоо, манай яриа их сэтгэл уяруулмаар юм руу орж байсан, өөр сэдэврүү орохоо больё, за тэхлээр та надтай уулзахаар ирсэн гэж байгаа тийм ээ?

-Тийм,

-За яахав, би ч мөн, юм бүхнийг таны хүслийн ёсоор хийсэн, бид өдөр болгон уулзаж байна гэж хариулсан.

Миледи айж хэлмэгдсэн байртай би тэгээд насаараа энд байх хэрэг үү? гэж асуув. -Дүү минь энд байхад тавгүйюм байна уу? Юу дутагдаж байна, хэлээрэй би аргалж өгөхийг хичээе.

-Над шивэгчин ч алга, зарц ч алга

-Авхайтан танд эд бүгд бий болно. Таны түрүүчийн нөхрийн үед гэр орон чинь ямар шүү байртай байдаг байсныг надад хэлээд өг, би ердөө л хадам ах чинь ч гэсэн цөмийг тэр янзаар хийж өгөхийг хичээе.

Миледи хадам ах өөдөө алмайран ширтээд, миний түрүүчийн нөхрийн үед ий? гэж дуу алдав. -Тийм ээ, би дүүгийнхээ тухай яриагүй байна, франц нөхрийг чинь хэлж байна.... та мартчихсан байвал, танай нөхөр амьд мэнд байгаа болохоор, би түүнд захиа бичвэл, хэрэгтэй бүгдийг хэлээд өгөх бий гэхэд Миледигийн духан дээгүүр хүйтэн хөлс бурзайгаад. -Та тоглож байна! гэж бөглөрсөн дуугаар хэллээ.

-Би тэгж тоглож байх шиг байна гэж үү! гэж бээл асуугаад. нэг алхам гэдрэгээ ухрав. -Чухам гэвэл, намайг доромжилж байна,-гэж Миледи сандлынхаа бариулаас салганан зуурч, өндийсхийгээд хэлсэнд Винтер гуай жигшин мөшийгөөд таныг доромжиллоо гэнэ ээ, үгүй авхайтан, таныг доромжилж бас болохоор юм өөрөө бодож явдаг байх нь ээ? гэв. -Өршөөлт эрхэм, та нэг бол согтуу, үгүй бол галзуурчхаад байна. Бушуу зайлаад надад үйлчлэх бүсгүй хүн ирүүл гэж Миледи хэлэв.

-Бүсгүйчүүл үгэнд дуртай улс шүү, дүү минь. Би шивэгчин чинь болж үзвэл яасан юм дээ? тэгвэл манай гэр бүлийн хамаг нууцбидний хооронд үлдэх болно.

Ичгүүргүй амьтан! гэж Миледи дуу алдаад, ухаан алдтал уурлаж бахардан, бээл рүү дайрлаа. Цаадах нь хүлээж, гараа элгэндээ зөрүүлэн зогсохдоо, нэг гараа юу ч болсон илднийхээ ишин дээр тавилаа.

Уухай. таны хүн алдаг заншилтайг би мэднэ, гэхдээ таны өөдөөс ч билээ, биеэ хамгаална шүү гэдгийг дуулгая, гэжбээл хэллээ. Миледи үүнд-үнэн л дээ, та ч бүр бүсгүй хүнд гар хүрэхээс буцахгүй булай хүн гэлээ.

-Тийм байж магадгүй. Тэгээд ч над биеэ цагаатгах шалтаг бий. Таны өөдөөс анх хөдөлсөн

бүстэй хүний гар лав л минийх биш бий. Ингэж хэлээд бээл, гараа алгуур өргөж, Миледийн зүүн мөрөнд хуруугаа хүргэхшахаад зэмлэх байртай зангав.

Миледийн амнаас гиншин ёолох дуу гарах нь араатны архирахтай адил, үсрэхээр зэхсэн ирвэс шиг болчхоод, холын булан руу ухрав.

Архирвал архирч л бай! харин хазах гэж бүү оролд тэгвэл өөрт чинь муу юм болно гэдгийг хэлчихье. Өв хөрөнгө залгамжлах эрхийг урьдаас тогтоодог хууль хамгаалал гэж энд байдаггүй. мөнминий хорьж байгаа гуа бүсгүйн төлөө намайг эрүүл тулалдаанд дуудах хэрмэл баатар гэж бас байхгүй, Харин ч надад бэлэн шүүгч нар байна. Эр нөхрийгөө амьд мэнд байхад хууран мэхэлж дүүгийн минь гэргий болихоос ичээгүй бүсгүйг тэд шүүж, алуурчны гарт өгөөд, нэг мөрийг чинь нөгөөтэй нь адил болгочих бий.

Миледигийн нүд цахилгаан шиг гялалзаж, Винтер гуай бүсгүй хүний өмнө байж байгаа зэвсэгтэй эр хүн мөртлөө айгаад байх шиг санагдав. Гэвч уур нь улам хүрч эхлээд. цаашаа: - Тиймээ, миний дүүгийн өв хөрөнгийг залгамжилж аваад одоо минийхийг авна гэдэг танд аятайхан байхсаан, би мэдэж байна. Та намайг алах юм уу, хүнээр алуулж болно, би энэ тухайд зохих арга хэмжээ авчихсан, миний хөрөнгөнөөс танд сохор зоос ч олдохгүй гэдгийг урьдаас мэд. Та одоо сая орчим зоосны хөрөнгөтэй байж, эд юмаар хангалттай биш гэж үү? Хөнөөлт муу юм хийх шуналтай даа л ингэж байдаггүй юм болж гэм, одоо зогсох болоогүй юм уу? Би дүүгийнхээ дурсгалыг хүндэтгэдэггүйсэн бол таныг улсын нэг шоронд хатаах юм уу, олны өмнө гэсгээн залхаахсан билээ. Би дуугүй байя. Тэхлээр та ч мөн ингэж хоригдож байгаагаа үг дуугүй хүлцэх ёстой. Арван тав, хорь хоноод би Ларошель руу, цэргийн хамт мордоно. Гэвч түүнээс өмнө хөлөг онгоц ирж, таныг аваад, миний нүдэн дээр манай өмнөд колонийн оронд таныг аваачина. Таны дэргэд би нэг хүн тавина, тэгээд өөрий чинь эх газар юм уу, наашаа буцаж ирэхээр оролдохын хамт л духанд чинь сум суулгах бий гэж ярив. Миледи анхааран чагнаж, гялалзсан нүдний хүүхэн хараа нь томрох аж. Винтер Лорд үргэлжлүүлэн та одоо энэ шилтгээнд суух болио. Эндхийн хана зузаан, үүд нь хүнд бөх, цонхны сараалж найдвартай, тэгээд ч танай цонх яг далай руу өнгийсөн юм, Манай ангийн надад үйлийн үргүй үнэнч сайн улс энэ өрөөний үүдийг манаж хашаа руу гарах хамаг нүх сүвийг мөн харж байгаа. Та тийшээ гарч чадлаа ч гэсэн гурван давхар төмөр сараалжнэвтрэх болохсон. Зугатаан оргох гэж байгаа ганц үг, ганц тиймэрхүү алхам л хийвэл таны өөдөөс бууд гэж чандлан тушаасан, таныг алж орхивол яахав, английн шүүхийн газар, элдэв төвөг яршгаас ангижрууллаа гэж над талархах биз... Уухай! Таны царай хэвийн амгалан, өөртөө итгэсэн байдалтай болоод, ирлээ гээч та ингэж бодож байгаа биз. "Арван тав,.. хорь хоног байна ... Би аргатай ухаалаг хүн, гайгүй тэр болтол нэг юм бодож олно. Над шиг гойд ухаантай хүнд өөрийнхөө золиос болгох нэг хүн олдоно. Арван тав хоноход би энд байхгүй " гэж бодож байх шиг байна... Яахав туршаад үзээрэй л дээ.

Винтер гуайг дотоод бодлоо тааж мэдсэнийг үзээд, Миледи, царай байдлаараа сэтгэл түгшин гутарснаас өөр юм үзүүлэхгүй гэж хумсаа алгандаа шигдтэл атгалаа.

Винтер гуай үгээ залган:

-Миний үгүй цагт, энд захирч үлдэх даргыг та нэгэнт үзсэн, тэхлээр түүнийг мэднэ гэсэн үг. Тэр хүн тушаал биелүүлж чаддагийг та өөрөө үзэж үнэмшсэн. Таны занг би ямар эс андах

биш, Портсмутуос наашаа ирэх зам зууртүүнтэй яриа дэлгэх гэж та оролдсон шүү дээ. За тэгээд ямар байна? Гантиг чулуун хөшөө гэхэд, манай хүн шиг ажиггүй, дуу цөөнтэй байж чадах уу? Хүний дур булаах чадлаа та өнөө болтол, олоон хүнд хэрэглэж үзсэн, гай болоход хэзээд л дийлж урагштай байсан. Түүнийгээ энэ хүн дээр нэг хэрэглээд үз, чөтгөр алгад, тэгээд та санасандаа хүрдэг юм бол таныг би чухам шулам биеэрээ юм байна гэж итгэнэ, гэв.

Винтер гуай үүд рүү очоод, гэнэт түлхэн онгойлголоо.

-Фельтон гуайг нааш нь дууд гэж тушааснаа, Миледид таныг одоо би түүнтэй танилцуулъя, гэв.

Ингээд, энэ хоёр хүнд ярих юм олдохгүй. Хачин нам гүм болчихлоо. Тэгтэл өрөө рүү ойртож яваа хүний жигд, алгуур алхах хөлийн чимээ гарсаар төдхөн бүүдгэр гудманд хүний бараа харагдсанаа, бидний нэгэнт танилцсан залуу дэслэгч орж ирээд, бээлийн тушаалыг хүлээн, үүлэнд зогсов.

-За Жон минь ороод ир, орж ирээд үүдээ хаачих гэж Винтер гуай хариуллаа.

Дарга орж ирэв. Бээл цааш хэлсэн нь:

-За тэхлээрэнэ бүсгүйг хар, энэ хүн нас залуу, царай зүс гуа сайхан, хорвоо дээр хүний дур булаам бүх чанарыг агуулсан хүн. Тэгээд юу гэж гээч! Гэтэл энэ бузар амьтан, дөнгөж хорин таван нас хүрэх энэ насандаа, манай шүүхийнхний бүтэн жилийн архивт байгаагаас илүү гэмт хэрэг үйлдсэн хүн. Дуу нь хүний сэтгэлийг татаж, гуаүзэсгэлэнгээрээ хууран, хүнд амласан юмаа биеэрээ төлж өгдөг хүн, энэ талаар харин хөөрхий амласандаа хүрдэг юм шүү. Энэ бүсгүй таны толгойг эргүүлэх гэж оролдоно, алах ч гэж байж мэднэ. Таныг би үгээгүй ядуу байхад чинь өөд татаж аваад, дэслэгч цолтой болгосон, нэг удаа аминд чинь орсон, ямар үед билээ гэдгийг та өөрөө ойлгож байгаа, би өөрийчинь өмөг түшигтээ багтаасан хүн төдийгүй сайн нөхөр чинь билээ. Ач тус хүргэхээр барахгүй эцэг чинь болсон хүн билээ. Энэ бүсгүй миний амийг хорлох арга зохиох гэж англид эргэж ирсэн юм.

Энэ могойг би одоо гартаа оруулчихаад байна. Ингэхлээр сайн нөхөр Фельтон минь Жон хүү минь энэ бүсгүйгээс миний биеийг, ялангуяа өөрийгөөхамгаалж бай гэж гуйх санаатай өөрийг чинь дуудсан юм. Энэ хүүхнийг зүй ёсоор ногдох ёстой ялаа эдлэх болтол харж манаж чадна гэдгийг сүнсээ барьж андгайл Жон Фельтон, үгэнд чинь би итгэж байна шүү!

Жон Фельтон, чиний голч шударгад би итгэж байна гэв. Залуу дарга хамаг сэтгэлээрээ үзэн ядсан харцаар Миледиг хараад:

-Милорд оо, бүгдийг таны тааллаар болгоно гэж би андгайлъя гэв.

Даргын харцыг Миледи бусдын эрхшээлд орсон хүлцэнгүй номхон хүний дүрээр дааж өнгөрүүлээ. Энэ бүсгүйн сайхан царай шиг өдий номхон, хүлцэнгүй царай ер байж болно гэж санагдашгүй аж. Винтер гуай хүртэл, хэдхэн мөчийн өмнө тэмцэлдэх гэж байсан барс мэт бүсгүй ийм болчихсоныг гайхаж байлаа.

Миледи энэ өрөөнөөс гарч болохгүй юм шүү, Жон чи дуулаа биз? хэнтэй ч бичиг захиагаар харилцуулж болохгүй, та өөрөө л үүнтэй. юм ярьж соёрхохгүй юм бол, өөр хэнтэй ч юм яриулж болохгүй гэж Винтер гуайг хэлэхэд залуу дарга:

-Би андгайлсан шүү дээ, Милорд тэхлээр болох нь тэр гэв.

-За олоо авхайтан та бурханд залбирахыг хичээгээрэй, улсын хууль таныг нэгэнт яллалаа, гэхэд Миледи үүнийг дуулаад гутарч байгаа юм аятай уруугаа харлаа.

Винтер Лорд цуг гарья гэж Фельтонд гараараа дохиод гарч одоход, Фельтон дагаж гараад үүд түгжив. Төдхөн алман сүх бүсэндээ хавчуулж, цахиур буу үүрсэн далайн явган цэргүүдийн хүнд алхаа дуулдав, харуулд ирж зогсов.

Цоожны нүхээр хүн харж байж магад гэж Миледи бодоод хэдэн минут хир тэр хэвээрээ байснаа алгуур дээш харахад царай нь дахиад хорсож заналхийлсэн аймаар байртай болчхов. Миледи үүд рүү гүйж очоод чагнаж үзлээ, бас цонхоор гадагшаа хараад, эргэж зөөлөн сандал дээр сууж бодол болов.

Л. ЦЭРГИЙН ДАРГА

Энэ завсар хамба ламтан Англиас мэдээ сураг дуулах гэж чих тавиад байсан боловч түгшүүртэй муу юмнаас өөр аятай юм дуулсангүй.

Ларошель хот баттай бүслэгдэж, хот руу гаднаас завь нэвтгэрч орохыг хорьсон, шинэ далан барьсан зэрэг арга хэмжээний ачаар бууж өгөх нь зайлшгүй мэт боловч, бүслэлт цаашаа урт удаан хугацаагаар үргэлжилж болох нь Ван эзний цэргийн нэр сүрэнд их хортой, Хамбад маш таалалгүй байлаа. Ван эзнийг Австрийн Анна хатантай нь муудалцуулах хэрэг хамбад нэгэнт үгүй болж муудалцуулдгаа муудалцуулж чадсан боловч, хамбад бас хоорондоо муудалцсан Бассомпьер гуай, Ангулемийн герцог хоёрыг эвлэрүүлэх хэрэг байв.

Ван эзний дүүгийн тухайд гэвэл, тэр хүн хот бүслэх ажлыг дөнгөж эхлээд дуусгах хэргийг хамбад тохжээ.

Бүслэгдсэн хотын захирагч хэдий чин зориг барьж шантрахгүй байсан боловч хотынхон бууж өгөх санаатай, самуурах гээд үзсэнд, захирагч самуунд оролцсон бүхнийг дүүжлэх тушаал буулгав. Энэ шийдвэрийн ачаар хамгийн зоримог улс хүртэл номхорч, дүүжлүүрт, өртсөнд орвол өлсөж үхсэн нь нэгд удаан, хоёрт алсдаа амьд үлдэж болох горьдлоготой гэж боджээ. Ларошелийнхнээс байн байн Бекингэм рүү илгээсэн элч юмуу, Ларошель руу Бекингэмийн явуулсан туршуулууд бүслэгчдэд баригддаг байв. Аль ч талаас явуулсан хүнийг шийтгэж ядах юмгүй. Хамба ламтан даруй "дүүжил" гэдэг ганц үг хэлээд, цаазлахдаа Ван эзнийг урина. Ван эзэн төвөгшөөсөн янзтай алхаж ирээд аятайхан газар зогсож цаазлахыг эхнээс эцэс хүртэл сайн хардаг билээ. Тэхдээ ихэд уйдаж, Парисдаа эргэж очих тухай үглээд байгаа Ван эзэндийнхүү тагнуулыг цаазлах нь их зугаа болж чадахгүй боловч сэтгэлийг нь бага зэрэг саатуулж, бүслэлтийн хуаранд байзнахад хүргэдэг байлаа. Ингэж дайсны элч, туршуулууд баригддаггүй байсан бол Хамба ламтан хэдийгээр юм сэдэвлэхдээ сүрхий ч гэсэн Ван эзнийг тогтоох гэж зовох л байсан бий. Цаг хугацаа улираад байдаг. Ларошелийнхэн бууж өгөхгүй л байв. Бүсэлсэн талд баригдсан сүүлчийн элч, Бекингэмд захиа хүргэж явжээ. Захидалд хотын байдал маш хүндэрснийг бичсэн хэдий боловч эцэст нь, "таны тусламж амжиж ирэхгүй юм бол хоёр долоо хоногийн дараа бид бууж өгнө" гэсэн зүйл байсангүй, харин, "танай тусламж хоёр долоо хоногийн дотор амжиж ирэхгүй юм бол та нарыг ирэх үед бид цөм өлбөрөөд үхэжорхисон байх бий" гэжээ.

Ингэхлээр Ларошелийнхэн ганц Бекингэмд л найдаж байгаа юм байна. Бекингэмд л залбирч байгаа энэ улсад, Бекингэмд найдах хэрэг огт үгүйг баттай үнэмшүүлэх юм бол эд тэгээд зориг самбаагаа алдах юм. Иймээс, Бекингэмийг Ларошель руу ирэхгүй гэсэн мэдээ Англиас дуулахсан гэж Хамба ламтан тэсч ядан хүлээж байсан юм. Хотыгдайрч авах тухай вангийн зөвлөлөөр байн байн хэлэлцэх боловч тухай бүр хойшлуулна, нэгд Ларошель хотын хэрэм бат бэх, хоёрт Хамба өөрөө, одоогийн ярьдагчлан, тухайн үедээ дэвшилтэй хүн байсан болохоор францчууд, мөн францчуудынхаа өөдөөс дайрч цус урсгах нь улс төрийн хувьд жараад жилийн өмнөх шиг бүдүүлэг хэрэг гэдгийг Хамба ламтан ухаарч байжээ. Үнэхээр ч 1628 онд бууж өгөхөөсөө, үхсэн нь дээр гэж үзэх гурав дөрвөн мянган хугенот сүсэгтэнг хядаж Ларошелийг баллавал 1572 онд болсон Варфоломейн шөнө гэгчтэй айхтар төстэй хэрэг болохсон. Тэгээд ч өөрөө католик шажинд гүн сүсэгтэй ван эзэн эцсийн энэ аргыг

хэрэглэхээс онц дургүйцэхгүй боловч, бүслэлтэд оролцсон дээд дарга нар хотыг өлсгөлөнгөөс өөрөөр авч болохгүй гэж нотлоод дайрах саналыг няцаадаг байлаа. Хамба ламтан англи руу айхтар бүсгүй явуулсандаа өөрийн эрхгүй жийрхээд, арслан ч гэмээр могой ч гэмээр санагддагийг нь өөрөө бас ажсан болохоороо, урваж орхиогүй байгаа гэж эргэлзэнэ. Үхэж орхиогүй байгаа гэж бодно. Гэхдээ бүсгүйн зан төрхийг хамба сайн судалж мэдсэн болохоор өөрий нь талд буюу урвасан алин боловч, аргагүй

саад учрахгүй бол Миледи гар хумхин, зүгээр суухгүй гэдгийг сайн мэднэ. Гэтэл ямар саад учрах билээ гэдгийг хамба мэдэхгүй байв.

Ер нь Хамба дотроо Миледид бат итгэж байсны учир нь гэвэл тэр бүсгүйн урьд үйлдсэн ноцтой хэргийг ганцхан хамбын өөрийн нь шажны улаан жанч халхалж болох юм гэдгийг гадарлаад, бүсгүйдтулгарсан аюулаас хаацайлж чадах ганц хүн өөрөө мөн болохоор, энэ юм уу аль өөр нэг учир шалтгаанаар Миледи өөрт нь үнэнч байдгийг мэдэж байлаа. Ингээд Хамба ламтан дайныг ганцаараа удирдан явуулж, аз мэдэг гээд хүлээхээр шийджээ. Ларошель хотынхныг өлсгөлөнд учруулах ёстой нөгөө далангаа үргэлжлүүлэн барилаа. Хамба ламтан аз дайрахыг хүлээж байхдаа өдий ихгай зовлон үзэж, өчнөөн их эр зориг гаргаж байгаа хотыг хараад улс төрийн бодлогын талаар өөрийг нь Робеспьер залгамжилсан адил Хамбын өөрөө залгамжилсан, цаг үеийнхээ улс төрийн том зүтгэлтэн Тристанд өмөг түшиг болж явсан хүн болох XI Людовик вангийн мөрдлөг болгодог байсан "захирч эзэмшихийн тулд хуваа" гэсэн үгийг санадаг байлаа. IV Генрих ван Парисыг бүслээд хотын хэрмэн дээгүүр талх, идэш уушны зүйл давуулж хаяхыг тушааж байсан бол Хамба лам мөн Ларошелийнхэн рүү, тэдний дээд дарга нарын баримталж байгаа бодлого хир их буруу, хар амиа хичээсэн харгис хатуу зүйл болохыг тайлбарласан захидал хаяулдаг боллоо.

Ларошелийн дээд дарга нарт талх тариа элбэг байсан боловч хүн арддаа хуваажолгохгүй, эмэгтэйчүүд хүүхэд хөгшид үхэх нь гайтай биш, ганцхан хотын хэрмийг хамгаалах ёстой эрчүүл эрүүл саруул, хүч тэнхээтэй байвал барлаа гэдэг бодлогыг мөрдөж байжээ. Тэр үед энэ мөрдлөг бүхэнд дэлгэрээгүй байсан боловч, хотынхон үүнийг эсэргүүцэх чадалгүй байснаас тэр үү, өөрсдийгөө золиосонд гаргаснаас юм уу, үнэхээр энэ мөрдлөгийг дагах болжээ. Үүнийг илрүүлсэн Хамбын захидал уул явдал яриагүй зөв гэж байсан хүмүүст эргэлзээ төрүүлж үхэх тавилантай болсон эмэгтэйчүүл, багачуул хөгшид гэдэг чухамдаа өөрсдийн нь эхнэр хүүхэд, эцэг эх юм гэдгийг эрэгтэйчүүлд ухаарууллаа. Учирсан зовлонг хот даяараа тэгш хуваалцвал эцэстээ цөм нэгэн санаа шийдэх юм гэдгийг бодоход хүргэв.

Ийнхүү хаясан захидлууд уул зорилгоо биелүүлж, хотын ихэнх иргэд ванэзний цэрэгтэй сэм холбоо барих болов.

Хамба ламтны хэрэглэсэн арга нь урагштай болж байгааг үзэж байсан энэ үеэр Бассомпьер, Шомберг, Ангулемийн герцог нар хотыг бүслэн сэргийлж, тэднийг хамба ламтан сэргийлсээр байтал хотын нэг иргэн, Портсмутуос шууд, яаж чадсан юм бүү мэд, хот руу нэвтрэн ороод, Англид усан цэргийн их хүч цуглараад нэгэн долоо хоногоос хэтрэлгүй наашаа хөдлөхөд бэлхэн болоод байна, мөн Бекингэм Ларошелийн захирагчид хэлүүлэхдээ, францын эсрэг хүчтэй эвсэл сая нэг байгуулагдлаа, ингээд францын вант улс руу герман, итали, английн зэвсэгт хүчин нэгэн зэрэг цөмрөн орно гэжээ. Энэ захидлыг хотын бүх талбай дээр олонд зарлан уншуулж, хуулбарыг нь энд тэнд наасанд ван эзний цэрэгтэйсүлбээтэй

болж байсан хүмүүс хүртэл түр болиод, ингэж бардам амласан тусламжийн ирэхийг хүлээх болов.

Энэ гэнэтийн явдал Ришельегийн сэтгэлийг дахин зовоох болж, далайн тэртээ тийш өөрийн эрхгүй горилон харах болгов. Энэ завсар вангийн цэрэг гол ганц жанжныхаа ийнхүү сэтгэл зовж байгааг үл харгалзан цагийг зугаатай наргиантай өнгөрөөнө. Хуаранд хоол хүнс мөнгө сэлт элбэг, цэргийн ангийнхан хоорондоо элдвээр эр зориг гаргаж зугаацаж цэнгэлдэхээрээ өрсөлдөнө. Цэргийнхэн дайсны элч туршуулуудыг барьж дүүжлэн далай болон далан дээр дайсныг хатгаж хамгийн бүтэшгүй аюултай хэрэг төвөг өдөөгөөд зоримог сайн дүүжлэх зэргээр өдөр хоног өнгөрөөж байв. Өдөр хоног нь тусламж хүлээж цөхрөн өлсөж туйлдаж байгаа Ларошелийнхэнд төдийгүй тэднийг махран бүслээд байгаа Хамба ламтанд хүртэл барагдаж өгөхгүй урт удаан байжээ.

Хамба өөрөө жирийн морин цэрэг шиг үргэлж нааш цааш явж, францын бүх өнцөг булан бүрээс ирсэн мэргэжилтнүүд өөрийн удирдлагаар босгож байгаа, даанч удаан босч байх шиг санагдах даланг харж бодол болно. Ингэж явтал нь де Тревиль гуайн хорооны шадар цэргүүдээс хүн үзэгдвэл ойртож очоодсайн харж манай дөрвөн нөхдийн хэн нэг нь биш гэдгийг таниад хурц хараа, гүн ухаанаа даруй өөр юманд шилжүүлдэг байлаа.

Хамба ламтан бүслэгдсэн хоттой хэлэлцэн тохирох найдлага алдаад, Англиас мэдээ дуулсан юмгүй уйдагын эрхээр нэг өдөр ямар ч зорилгогүй мориор дэмий тэнэх санаатай Каюзак, Ла Удиньер хоёрыг дагуулаад морджээ. Хамба элсэрхэг эргийндагуу элдэв юм эргэцүүлэн бодож, далайн зах хязгааргүй нэлийсэн усыг харж явав. Нэг толгой дээр алгуурхан явж гартал, ойролцоо, бутан дотор, өдий үед ховорхон гардаг наранд долоон хүн ээж хавь ойр нь хоосолсон лонхнууд хэвтэж харагдлаа. Энэ хүмүүсийн дөрөв нь дөнгөж сая авсан нэг захидал уншихаар ирсэн манай нөхөд ажээ. Уул захидалмаш чухаг болохоор түүнээ унших гэж бамбар дээр дэлгэсэн хөзөр, шоо сэлтээ мартсан байв.

Цаад гурван хүн сүрлээр ороосон Колиурсп дарсны том лонхны бөглөөг бөхөлсөн лацыг авч байгаа нь манай нөхдийн зарц нар аж. Бидний дурдсанчлан хамба өөрөө ааш муухантай байсан билээ. Тэгж гутарч муухай аашилсан үедээ бусдын зугаалж цэнгэхэд маш дургүйбайдаг юм. Тэгээд ч тухайлан өөрийн гутрахад хүргэсэн шалтгаанаас болж бусад хүн тийнхүү наргиантай байна гэж итгэдэг хачин зантай. хүн билээ. Ингээд Каюзак, Ла Удиньер хоёрт дороо бай гэж дохиод өөрөө мориноосоо бууж, далдалсан бут, хөлийн чимээ дарсан элс хоёрын ачаар их сэжигтэй баймаар санагдсан ярианаас жаал зугаа юм сэм дуулчих санаатай тийшээ ойртлоо. Далдалсан бутанд арваад алхам дөхөж очоод гаскон мужийн хүний ярианы аялгууг таньж шадар цэргүүд байсныг түрүүн харсан болохоор үлдсэн гурав нь салдаггүй нөхөд гэгддэг Атос, Портос, Арамис гурав мөн гэдгийг лавтай мэдлээ. Үүнийг мэдээд, тэдний яриаг сонсох хүсэл нь улам хүчтэй болсон гэдгийг гадарлахад бэрх биш. Нүдний нь харц хачин болоод, муур шиг сэм гэтэж бутанд ойртлоо! Тэгээд бут руу хэд алхаж, тодорхой учир утга нь үл ухагдах бүдэг дуу дөнгөж дуултал гэнэт огцом хахир дуу гарч Гримо:

-Дарга ирлээ гэж хашгирав.

-Өөдгүй амьтан чи юм хэлэв үү? гэж Атос тохой дээрээ өндийн Гримо руу ширүүн харав.

Гримо цаашаа ганц ч үг нэмж хэлсэнгүй, бутны зүг хуруугаараа занган Хамбыг дагалт хүмүүстэйгээ ирсэн тухай мэдэгдлээ. Шадар цэргүүд эгшин зуур босон харайж, хамбыг хүндэтгэн мэхийв. Янз нь хамбын уур их хүрсэн бололтой: эрхэм шадар цэргүүд өөрсдийгөө харуулаар мануулж байх шив! Англичууд хуурай замаар арай яваад ирээгүй биз? Аль шадар цэргүүд өөрсдийгөө дээд дарга нарт тоолдог болоо юу? гэв

Бусдыгаа сандарч мэгдэж байхад, хэзээд амгалан байдаг ихсийн барилтай Атос ганцаараа сэхээ самбаатай байсан тул:

-Гэгээнтэн,шадар цэргүүд албанаасаа чөлөөтэй юм уу, алба үүргээ хааж гүйцсэнхойно дарс ууж, хөзөр тоглон байхдаа зарц нарынхаа дэргэд их л өндөр хэргэмийн дарга нар юм шүү гэв.

-Зарц нар гэнээ! гэж хамба уцаарлан дуугараад хүн хажуугаараа явсан тухайд эздэдээ мэдээ өгөх үүрэг авсан зарц нар чинь зарц биш, харуул, манаа болчхож байгаа хэрэг гэв|

-Гэхдээ их гэгээнтэн минь, бид ийм сэрэмжлэх арга аваагүйсэн бол, та биднийг нэгэн ангид оруулж ач болсонд талархах аятай учрал дайралдсаныг бид мэдэлгүй өнгөрөөчхөж болох байсныг та өөрөө харж байна шүү дээ, гэж Атос өчөөд-д'Артаньян та дөнгөж сая л баярласнаа гэгээнтэнд айлтгах учрал олдоосой гэж ярьж байсан, одоо энэ учирлыг ашиглаж үзээч гэв.

Аюул тулгарсан үедАтос ийнхүү сэхээтэй амгалан ярьж, туйлын эелдэг ялдам зантайгаараа зарим үед төрөлхийн ван эзэн хүнээс илүү сүр буйртай харагддаг билээ.'

д'Артаньян Хамба руу очиж баярласнаа гаргаж хэдэн үг дуугараад, хамбын аягүй харцнаас болж даруй дуугүй болов. Атосын үг Ришельег анхны санаснаас нь огтхон ч хэлбийлгэж чадсангүй бололтой, ямар ч гэсэн жирийнцэргүүд өргөмжлөгдсөн хороонд байдаг төдийгөөр ихэс дээдсийн барил гаргаж байхыг би таалж үзэхгүй. Тэд бусдын нэгэн адил сахилга журмыг дагах ёстой гэв.

Атос Хамбыг үгээ дуустал нь хүлээгээд санал нийлсний тэмдэг болгож мэхийн хүндлээд:

-Гэгээнтэн, бид сахилга бат зөрчсөн талгүй болов уу гэж найдна. Бид одоо албанаас чөлөөтэй болохоор чөлөө цагаадугаараа өнгөрүүлж болох юм бодож байна. Гэгээнтэн та бидэнд ямар нэг тусгай ажил даалгаж соёрхвол бид тушаалыг дагахад бэлэн байна, гээд Атос энэ байцаалтад уур нь хүрсэн тул хөмсөг зангидан, бид элдэв түгшүүр тохиолдвол бэлхэн байх гэж зэвсгээ авч гарсныг гэгээнтэн та харж байгаа биз дээ, гэв. Ингээд дээр нь хөзөр шоо зэргийг дэлгэж тавьсан бамбарын хажууд бие биеийг нь түшүүлэн босгосон дөрвөн буугаа заав.

-Их гэгээнтэн таныг бидэн дээр ийм цөөхөн бараа бологчтой ирнэ гэж гадарласан бол бид лав угтах байсан шүү, гэж д'Артаньян дуугарав.

Хамба давагдсандаа уруул, сахлаа хазалж байснаа: Та нар ингэж зэр зэвсгээ аваад, зарц нараараа харуул манаа тавьчаад байхдаа ямар улстай адилхан байгаагаа мэдэж байна уу? та нар нэг хуйвалдаан хийж байгаа дөрөв шиг харагдах юм гэв. Атос зөвшөөрч:

-Гэгээнтэн таны зөв. Бид үнэхээр, урьд их гэгээнтэн таныг нэг өглөө үзсэнчлэн хуйвалдаан хийж байгаа юм, тэхдээ Ларошеличүүдийн эсрэг л хуйвалдаан хийдэг улсдаа, гэж өчив.

Хамба ламтан мөн хөмсөг зангидаад, Үгүй, улс төрийн бодлоготон эрхмүүд та бүхний толгойд байгаа бүхнийг сая та нарын намайг үзээд нууж орхидог захидалтай адил уншчихаж болдогсон бол олон юмны нууц тайлагдах бий, гэсэнд Атосын царай барсхийгээд хамбын өөдөөс нэг алхаад:

-Гэгээнтэн та үнэхээр биднийг сэжиглэж ёстой л байцааж байна гэж болмоор байх юм. Тийм бол их гэгээнтэн та хэлж соёрхооч, бид тэгвэл адаглаад юу хийвэл зохихоо мэдэхсэн гэлээ. Хамба үүнд үнэхээр байцааж байлаа ч гэсэн юу гэж? Эрхэм цэрэг та байтугай хүмүүс байцаагдаад, өчиг өгдөг юм, гэж үг хаялаа.

-Тийм болоодл бид их гэгээнтэн таныг байцааж үз, бид өчиг өгөхөд бэлэн байна гэж байгаа юм.

-Арамис таны сая уншиж байгаад, далд хийсэн захидал юун захиа юм бэ? -Бүсгүй хүнээс ирсэн юмаа гэгээнтэн.

-Уухай, тиймэрхүү захиаг нуух ёстой гэдгийг би ойлгож байна. Гэхдээ тийм захиаг хувраг хүнд үзүүлж болдог, тэхлээр намайг хувраг хүн гэдгийг та нар мэднэ шүү дээ гэж Хамба хэлэв.

-Гэгээнтэн, энэ захиа бүсгүй хүнээс ирсэн боловч, Марион Делор юм уу, Д. Джлоом авгайгаас ирээгүй юм, гэж Атос тайван хариулсан нь ийм үг хэлээд толгойгоо алдаж болохуйц тул улам ч аймаар санагдлаа.

Хамбын царай цонхийж цайгаад нүдний нь харц зэвүүн муухай болж, Каюзак, Ла Удиньер хоёрт тушаал өгөх гэж байгаа бололтой эргэв. Энэ хөдөлгөөний нь Атос ажаад, гурван нөхдийнхөө нүд салгахгүй байсан буунууд руу алхам ойртлоо. Хамбын талд өөртэй нь гурван хүн, шадар цэргүүд зарц нартайгаа долуул байлаа. Атос нөхөдтэйгөө үнэхээр нэг юмны тухай нууц хуйвалдсан нь илт тул хүчээр үзээд дэмийболно гэдгийг хамба мэдэж, гэнэт эргэхэд хэзээд бэлэн байдаг зангаа гаргав. Ингээд хилэн нь даруй замхарч сайхан инээмсэглээд:

-За за, та нар өдрийн гэрэлд бардам толгой дээгүүр явдаг, шөнийн харанхуйд үнэнч зүтгэлтэй эрэлхэг залуус билээ. Бусдыг тэгтэл сайн хамгаалдаг улс өөрсдийгөө хамгаалахад гэмтэй юм алга. Эрхмүүдээ та бүхэн намайг тэр шөнө "Улаан тагтаат" хүрэх замд хир сайн хамгаалж явсныг би ер мартаагүй шүү. Одоо миний явах гэж байгаа замд аюул дайралдаж магад байгаасан бол би та бүхнийг хань болооч гэх сэн. Гэвч аюултай юм үгүй байгаа болохоор, дарсаа ууж тоглоомоо гүйцээж, захидлаа уншицгаа, за баяртай эрхмүүд ээ гэж хэлээд, Каюзакийн хөтөлж ирсэн моринд мордожнайрсгаар гараа даллаад давхиж одов.

Дөрвөн залуу нөхөд нэг ч үг дуугаралгүй дороо нам зогсоод хамбыг далд ортол хойноос нь харав. Тэгээд өөд өөдөөсөө харлаа. Хамба хэдий найрсаг байдлаар салж явсан ч дотроо уур хилэн нь багтарч байгааг цөм мэдэж, царай муутай байцгаав. Ганц Атос л үл тоомсорлон элэглэсэн байртай инээмсэглэнэ. Хамба ламтны бараа тасарч холдсон хойно уураа гаргах хүн

эрж ядаж байсан Портос:

Энэ муу золигийн Гримо хожуу мэдэгдээд! гэж зандарлаа.

Гримо биеэ өмөөрч нэг юм хэлэхийг завдтал Атос хуруугаа өргөсөнд дуугүй болов.

-Арамис та захидлаа өгөх байсан уу? гэж д'Артаньян асуусанд Арамис гойд эвлэг аятайхан дуугаар:

Хамбыг захидлаа аль гэж шаардвал нэг гараар захиагаа өгөөд, нөгөө гараар илдээ авч шувт дүрье гэж би шийдээд байсан юм, гэв.

-Би тэгнэ гэж мэдээд ярианд оролцсон юм. Нээрээ энэ хүн эрчүүлтэй ийм янзаар ярилцдаг их гэмтэй хэрэг шүү. Ердөө л бүсгүйчүүл, хүүхэдтэй байсаар байж сурчихсан юм гэж бодмоор хүн гээч, гэж Атос өгүүллээ.

д'Артаньян өөдөөс нь Атос таны зориг самбааг би бахдаж байна, гэхдээ бидний буруу байсан шүү дээ, гэж маргасанд Атос зэвүүцэн:

-Яагаад буруутай байсан юм бэ? Бидний амьсгалж байгаа агаар хэний юм? Бидний харж байгаа далай бидний хэвтэж байгаа элс, бидний сэтгэлтэй сайхан бүсгүйчүүлийн захидал хэний юм? Хамбын юм гэж үү дээ? Тэр хүн өөрийгөө лав хорвоогийн эзэн гэж санадаг хүн шүү. Та түүний өмнө сүрдэж, айчихсан нэг юм бувтнаад байсан... Таны нүдэндБастили гяндан харагдах шиг болж, муу ид шидийн гайгаар луу болж хувирах аюулд тулгараад байгаа юм шиг л байсан. Үгүй хүнд хайр сэтгэлтэй байх гэдэг хуйвалдах гэсэн үг юм уу, хэлээд аль. Хамбын гянданд хорьсон нэг бүсгүйд та сэтгэлтэй сайн байна, түүнийгээ хамбын гараас гаргаж авах гэж та хамбатай өрсөлдөж байна, үүндтань гол юм энэ захидал, тэхлээр гол юмаа өштөнд үзүүлэхийн хэрэг юу байна?'

Тэгдэггүй юмаа. Хамба өөрөө тааж гадарлавал зол нь тэр бид бас түүний санааг тааж тайлж байна шүү дээ гэв.

-Нээрээ Атос таны ярьж байгаа туйлын зөв гэж, д'Артаньян хүлээв.

-За тэгвэл саяны болсон явдлын тухай дахин үг дэлгээд яахав. Арамис хамаатан бүсгүйгээсээ ирсэн захидлыг хамбын саад болж зогссон газраас цааш үргэлжлүүлэн уншиж үз гэлээ.

Арамис өврөөсөө захидал гаргаж, гурван нөхөд нь ойртон суухад зарц нар дарсан дээр бөөгнөрөв.

Та эхлээд ганц хоёр мөр л уншсан байх, тэхлээр бүр эхнээс нь унш гэж д'Артаньяныг хэлэхэд Арамис:

-Дуртай эхэлье гэв.

" Эелдэг сайн үеэл ах минь, эгч маань нөгөө залуу шивэгчин хүүхнийг Степэ гэгч газар бүсгүйчүүлийн хийдэд суулгасан би өөрөө тийшээ явах л болох нь хөөрхий хүүхэн өөр газарт

байгаад сүнсээ хөнөөх аюултай гэдгийг ухааран хувь тавилангаа дагаж байна. Гэхдээ манай гэр бүлийн ажил төрөл бидний санасанчлан эвлэж бүтвэл нүгэл хураахаас буцалгүй санаж мөрөөдөж байдаг улс дээрээ эргэж ирнэ. Тэгээд ч өөрий нь тухай үргэлж бодож санаж байдаг үүнийг хүүхэн өөрөө мэдэж байгаа, одоогоор тэр хүүхэн онцын их зовсои ч юмгүй, ганцхан хайр сэтгэлтэй хүнээсээ захидал авахсан л гэж их мөрөөдөн суугаа. Хийдийн сараалжин дотуур захидал нэвтрэх гэдэг бэрх зүйл боловч, би онцын болхи хүнбиш болохоо танд үзүүлсэн билээ, тэхлээр би авч нэвтрүүлэе. Та нарын үргэлж сайн санаж явдагт манай эгч баярлаж байна. Нэг үе эгч их зовж байсан, гэвч, тэнд цаг зуурын юм учруулахгүйн тулд сэрэмжилж итгэмжилсэн хүнээ тийш нь явуулаад, жаал тайвширсан. Баяртай эелдэг сайн үеэл ах минь. Өөрийнхөө тухай бидэнд мэдээ дуулгах баттайболомж дайралдсан тухай бүр бидэнд аль болох олон захиа ирүүлээрэй. Үнсэж ёсолсон Мари Мишон гэжээ.

-Ээ Арамис та надад ямар их ач болов оо! гэж д'Артаньян дуу алдаад,хайрт Констанция минь арай гэж нэг чиний тухай сураг дуулдаг байна шүү Констанция эрүүл, эсэн мэнд Степэд хийдийн хэрмэн дотор аюулгүй байгаа юм байна! Тэр чинь хаана байдаг газар байх гэж Атос та бодож байна? гэв.

-Лотаринги мужид, Элзасийн хилээс хэдхэн мод газар. Энэ бүслэлт дуусмагц бид тэр нутгаар зугаалж болох юм гэхэд Портос мөн үг нэмэрлэж:

-Тэр цагийг их удаан хүлээхгүй болов уу гэж найдна, Өнөөдөр дайсны нэг туршуул дүүжлэгдсэн, тэр хүн мэдүүлэхдээ Ларошелийнхэн гутлынхаа савхиар амь зогоож байна гэсэн, савхийг нь идэж дуусаад ул руу ньордог юмаа гэхэд сүүлд нь юугаар гол зогоох улс байгаа юм бүү мэд, нэг нэгнийгээ л барьж эс иддэг юм бол, гэлээ.

Атос тэр цагт одоогийнхоосоо доргүй байсан боловч өдий их нэрд гараагүй байсан сайн бордо дарснаас нэг аягыг уучхаад,

-Хөөрхий тэнэгүүд Католик шашныг шүтэхэд хамгийн аятай, зохистой зүйл гэдгийг ухахгүй байх гэж гээд тэд сайн эрчүүл юм гэж аягаа шавхан тамшаалснаа Пээ, Арамис та яаж байна аа чөтгөр алгад? Та тэр захидлыг хармаандаа хийж байна уу даа? гэж асуув.

д'Артаньян мөн санал нийлж нээрээ Атосын зөв. Захидлыг шатаах хэрэгтэй. Ингэхэд үнснээс юм мэдээд авчихдаг аргыг хамба мэддэг ч юм билүү,хэнмэдэх вэ дээ, гэлээ. -Лав мэддэг байж таарна, гэж Атос хэллээ.

-Та наад захиагаа яая гэж байна, гэж Портос асуухад. Атос:

-Гримо нааш ир! гэж дуудлаа. Гримо дуудсан ёсоор босч ирлээ.

-Зөвшөөрөлгүй ам нээсний шийтгэлд хонгор минь чи энэ цаасыг иднэ. Дараа нь бидэнд тэгж тус болсны шанд энэ нэг аяга дарс уучих. Май эхлээд захидал энэ байна, сайн зажлаарай, гэлээ.

Гримо инээвхийлээд, Атосын ирмэгээ хүртэл дарс дүүргэсэн аягыг ширтэн байж цаасыг зажлаад залгиж орхив.

-За сайн, Гримо чи лут эр байна! гэж Атос магтаад. -одоо энэ дарсыг авч уу, зүгээр, талархахгүй байж болно гэв.

Гримо аяга сайн дарс авч дуугүй уухад, жаргалтай, таатай байна гэдэг нь дээшээ хандсан харцанд нь үг ярианы. хэрэггүй илт байлаа.

-За одоо Гримогийн гэдсийг хага ярах мэргэн бодол хамбын толгойд орж ирэхгүй ном бол бид жаал тайван байж болох байгаа гэж Атос хэлэв.

Энэ зуур их гэгээнтэн цаашаа гиюүрэн явахдаа:

-Энэ дөрвөн нөхдийг нададхүчин зүтгэдэг болгох нь тун чухаг байна, гэж аман дотроо үглэж байлаа.

ЛЦ. ХОРИГДСОН АНХНЫ ӨДӨР

Францын тухай ярих гээд түр орхисон Миледи юу болж байсныг одоо ярья

Миледи түрүүчийнх шигээ нөгөө мухардсан байдалтай хэвээр, босгон дээр нь ирээд л хамаг горьдлого нь тасрах мэт болсон тамдаа хар муу бодолд автан, сууна. Миледиайж сандарч, эргэлзэж мухардан үзээгүйгээ анх үзэж байгаа нь энэ билээ. Тэр бүсгүйн аз хийморь хоёр удаа доройтож, агуулсан санаа зорилгыг нь хоёр удаа илрүүлэн мэджээ. Эдний аль алиныг өөрийн нь дарж доройтуулахаар бурхан тэнгэрээс явуулсан байж таарах гайтай хүн хийж. Энэ давагдашгүй арга зальт бүсгүйг д'Артаньян дийлэв.

Тэр хүн бүсгүйн хайр сэтгэлээр даажин хийж, өөрийн нь элэг барин бодож явсан чухал юмаа хийхэд саад тотгор болсон, одоо тэгээд бас хамаг жаргалыг нь эвдэж, хоригдол болгосноор барахгүй амь насанд нь аюул учрууллаа. Үүгээр ч зогсохгүй хамаг хүч чадлын нь эх булаг болох сахиус, нүүр царайгаа далдлагч багны нь зах сэжүүрийг тэр хүн хуулж орхилоо.

Ришельегээс эзэн хатагтайг заналхийлэн, Бекингэм рүү явуулсан гайг тэр д'Артаньян зайлуулж орхилоо. Гэтэл Миледи өөрөө Бекингэмийг хуучин хайрлаж, сайн байсан хирээрээ өшин занаж явсан билээ.

Мөн тиймэрхүү бүсгүйчүүлийн араншин ёсоор Де Вардад түрхэн зуур сэтгэл татагдан эм барын адил барьж, ханашгүй их тачаадан байх үед д'Артаньян бас тэр хүн болж мэхэлсэн. Олж мэдсэн хүн бүхнийг алж үгүй хийхээр андгайлсан айхтар нууцыг нь д'Артаньян бас мэдчихсэн. Эцсийн эцэст хийсэн бүх гэмийг цагаатгаж өшгнөө дарж болох нэг бичиг олж автал түүний нь бас булаагаад авчихсан. Бас л тэр Артаньян одоо өөрийн нь хоригдол болгочоод, булай муухай Ботани бейд, Энэтхэгийн далай дахь Тайбернд цөлөх гэж байна.

Артаньянаас болж өөрт нь өдий их гай учирлаа гэдэг эргэлзээгүй. Өөр хэн Миледиг ингэтэл муухай шившиглэж чадах билээ. Ганцхан Артаньян энэ бүх аймшигт нууцуудыг гай болж дараа дараалан олжмэдсэнээрээ Винтер гуайд дуулгасан байж таарна. д'Артаньян өөрийн нь хадам ахыг танина тэглээр захиа бичсэн байх.

Бүсгүйн дотор үзэн ядах сэтгэл оволзон багтарна. Миледи нам сууж, хоосон өрөөний мухар өөд гөлрөн ширтэв. Үе үе гүнээ амьсгаадахын хамт битүүхэн ёолох дуу эрхгүй гарчхаад, оволзон бий давлагаан энэ их баргар ихэмсэг цайзыг дээр нь барьсан хадан цохионд ойж цохиод хүржгэнэн үсэрч байгаа шуугиантай ая нийлэх мэт.

Бүсгүйн уур хилэнд автсан бэрх ухаанд, Бонасье авгай Бекингэм, ялангуяа д'Артаньянаас хожим хойно өшөөгөө лут авах ямар гээчийн элдэв цэцэн төлөвлөгөө боловсорч байсан гэж санана!

Гэтэл өшөө авна гэхэд сул чөлөөтэй байх хэрэгтэй, гянданд хоригдсон хүн чөлөөтэй болохын тулд хана нүхлэх юм уу цонхны сараалж хуурайдах, доошоо шал нүхлэх хэрэгтэй. Иймэрхүү ажлыг тэсвэр, хүчтэй эр хүн хийж бүтээнэ, гэтэл бүсгүй, тэр дундаа үймэрч самгардсан бүсгүй хүнд ингээд дүүрэхээс өөр зам байхгүй. Тэгээд ч эд бүгдийг хийнэ гэхэд хугацаа сар, жил хэрэгтэй, гэтэл Миледид, өөрийн нь гянданд хорьсон айхтар ах Винтергуайн хэлсэнчлэн

арав, арван хоёроос хэтрэхгүй өдөр л үлдээд байлаа.

Хэдий тийм боловч, Миледи эр хүн байсан гэвэл эд бүгдийг мөн туршиж үзээд амжилт олж ч магад байхсан. Тэнгэр бурхан юунд эндүүрэн бүсгүй хүнийг өдий их эршүүд зоримог зантай болгож төрүүлэв ээ.

Ингээд хоригдсоны эхний үе даанч бэрх, бүсгүй хүний төрөлхийн сул зан дийлж, Миледи хорсон цөхөрч татвалзахгүй байж эс чадлаа. Гэхдээ Миледи хорсол бачимдлаа бага багаар дарж, хамаг бие нь дагжиж татвалзахаа болиод, биеэ атиран, ядарсан могой хүчээ хураах адил, сэхээ аван юм эргэцүүлж гарав.

Миледи толинд, өөдөөс нь юм асуух мэт санагддаг галтай харцаа үзээд, за больё доо, энэ чинь! миний ингэтлээ. цухалддаг маань галзуурснаас ялгаа юу. Бачимдах хэрэггүй, бачимдана гэдэг сул доройгийн шинж. Тэгээд ч энэ арга надад ер тус болж байгаагүй хойно. Бүсгүйчүүлтэй дайралдлаа гэвэл би хүч хэрэглээд, дийлж ч чадах байсан байж болно. Гэтэл одоо би эрчүүлтэй тэмцэлдэж байна, тэдний өмнө би чухамдаа, бүсгүй дорой хүн. Бүсгүй хүний аргаар тэмцэлдээд үзье, миний хүч бүсгүй дорой гэдэгтээ л байна, гэж бодов.

Ингээд ямар л бол ямар дүр үзүүлж чаддаг хувирамтгай нүүр царайгаа хэрхэн өөрчилж чадахаа нүдээрээ үзэж үнэмшье гэсэн байртай зүсээ муухай болтол уурлаж хилэгнэсэн байдлаас аваад, хамгийн усгал зөөлөн, дур булаам инээмсэглэх хүртэл янз янз болгов. Тэгээд царайгаа улам ч сэтгэл татам болгох гэж сурамгай гараараа үсээ янзалж гарлаа.

Эцэстээ сэтгэл бүрэн ханаад:

-Өнгөрчихөөд байгаа ч юм огт алга. Би гуа сайхан хэвээрээ л байна гэж шивэгнэв. Орой найман цаг хир болж байв. Миледи тасалгаанд ор байхыг ажиглаад түрхэн амарсхийгээд авбал ухаан санаа саруул болохоор барахгүй царайны өнгө засарна гэж бодов. Гэвч унтахаар хэвтэхээс өмнө бүр аятайхан санаа толгойд нь оржээ. Оройн хоолнытухай түрүүн яриа болж байхыг Миледи дуулсан, тэгээд энэ өрөөнд ирж цаг илүү болж байгаа болохоор өөрт нь мөдхөн хоол

авчрах ёстой.

Хоригдол бүсгүй цаг алдахыг хүссэнгүй, тэр оройдоо манаж харах хүмүүсийн зан төрхийг ажиж, байр байдалтай нь танилцъя гэж шийджээ.

Үүдний доод завсраар гэрэл тусан, өөрийг нь хорьж, цагдагч улс ирж яваа нь мэдэгдлээ. Босохоор завдаж байсан Миледи яаран сандал дээрээ суув. Толгой нь гэдрэгээ сандлын түшүүрэг налж, гуа сайхан үс мөрөн дээгүүр нь задран унаж, хувцасны нь нухлагдсан сиймгэр зах доороос цээж нь ялихгүй цухуйна. Нэг гараа зүрх тушаагаа тавиад нөгөөгий нь сандлаас сул унжуулжээ Үүдний түгжээ хангир жингэр хийж, нугас чахраад, өрөөнд хүний хөлийн чимээ гарлаа.

-Энэ ширээг тэнд тавь гэж нэг хүн хэлсэн нь Фельтоны дуу байхыг Миледи танив. Тушаал ёсоор гүйцэтгэлээ. Фельтон мөн:

-Лаа авч ирээд, манааг хал гэв.

Залуу дэслэгч энэ хоёр тушаалыг нэг хүнд өгсөн болохоор, өөрт нь нэг л янзын хүмүүс, өөрөөр хэлбэл манааны цэргүүд юмхүм хийж өгч байгааг Миледи мэдэв.

Фельтоны тушаалыг үг дуугүй даруй биелүүлэх нь дорд хүмүүсээ өөгүй чанд сахилга баттай байлгаж захирч чаддагийг гэрчлэх аж.

Миледи рүү өдий хүртэл хараагүй байсан дэслэгч сая нэг эргэж хараад,

Аа, унтаж байх шив. За яахав сэрээд хоолоо иднэ биз, гэж хэлээд үүд рүү алхлаа. Даргашигээ хэлбэршгүй биш нэг цэрэг.

-Үгүй, дэслэгч гуай. энэ бүсгүй унтаагүй байна гэж хэлээд Фельтоныг зогсоов. -Юу унтаагүй гэж? Тэгээд энэ бүсгүй яаж байгаа юм бэ? гэж Фельтон асуув.

-Энэ бүсгүй ухаан алдаж орхиж. Царай нь их зэвхий, би бас чагнаад, чагнаад амьсгаалж байгаагий нь дуулахгүй байна, гэж Фельтон, зогсожбайсан газраасаа Миледи рүү хараад, нэг ч алхам ойртолгүй таны үг үнэн дэг хоригдол бүсгүй нь ухаан алдчихаад байгааг Винтер гуайд мэдэгд ингэж магад гэж зааварласан юм үгүй, би яахаа мэдэхгүй байна, гэв.

Цаад цэрэг даргынхаа тушаалыг биелүүлэхээр гараад, Фельтоны өөрөө үүдний ойр байж таарсан сандал дээр суугаад ганц ч үг дуугарсангүй, огтхон ч хөдөлсөнгүй. Миледи бүсгүйчүүлийн сайн мэдэх нүдээ аньсан юм шиг байгаад урт соромсогныхоо завсраар харах нарийн аргатай хүн. Буруу хараад сууж байгаа Фельтоныг Миледи нүдээ нээлгүй арван минут орчим хараад байвал, хэнэггүй сахиул энэ зуур нэг ч эргэж харсангүй. Винтер гуайн төдхөн ирэх ёстойг Миледи санаад, тэр хүн ирж, сахиулд шинэхүч сэлбэг болно гэж бодлоо. Бүсгүйн эхний туршилт бүтсэнгүй ч цаанаа мундахгүй арга зальтай хүний ёсоор үүнийг хүлцээд толгойгоо өндийлгөн нүдээ хараад, аяархан санаа алдав. Ийнхүү санаа алдахыг Фельтон дуулаад сая нэг эргэж харлаа. Авхайтан, та ашгүй сэрэв үү гэж хэлээд, за тэгвэл энд над хийгээд байх юм алга шив. Юм хэрэгтэй болбол хонх дуугаргаарай гэлээ.

Ээ бурхан минь ямар хэцүү байв аа бие ямар хачин муухай болов оо! гэж Миледиэртний домогт ид шид бүхий бүсгүйчүүл хүний сэтгэлийг татаж хорлоё гэсэн цагтаа дуугардаг гэдэгчлэн урьхан сайхан дуугаар шивнэнэ. Тэгээд дээш болж зөөлөн сандал дээрээ түрүүчийнхээсээ ч илүү хээнцэр мөртөө хайшраг байдалтай суув.

-Фельтон босч:

-Авхайтан танд өглөө есөн цагт, өдөр нэг цагт, орой найман цагт өдөрт гурван удаа хоол авчирч байна. Хэрэвэнэ цаг танд тохиромж муутай санагдвал миний тогтоосны оронд өөрийнхөө таалалтай цагийг хэлж үз, бид таны хүслэнг мөн харгалзана гэв. Миледи үүнд:

-Энэ баргар том өрөөнд би үргэлж ганцаараа байх юм гэж үү, гэж асуулаа: -Ойролцоо суудаг нэг бүсгүйг ирүүлэхээр болсон маргааш тэр хүн шилтгээнд ирнэ, тэгээд таныг цуг байхсангэх тухай бүр тэр бүсгүй ирж байх болно гэсэнд хоригдол бүсгүй, -Гялайлаа, гэж хүлцэнгүйеэ

дуугарав.

Фельтон үл мэдэг мэхэсхийгээд үүд чиглэв. Босгоор гарахыг завдтал нь, Винтер гуай нөгөө Миледигийн ухаан алдсан тухай өөрт нь дуулгахаар явсан цэргийг дагуулан, үнэрлэх давс барьсаар хүрч ирэв.

-За юу болоов? юу гээч болж орхио вэ? гэж Винтер гуай тохуурхах байртай асууснаа, хоригдол бүсгүй нэгэнт сэргэж, Фельтон гарахаар завдаж байгааг үзээд, талийгаач болчихсон хүн маань нэгэнт амилаад орхио шив? Фельтон хүү минь, чамайг жулдрай хүн гэж үзээд, инээдэмт жүжгийн анхдугаар үзэгдэл гэмээр арга маяг үзүүлж байна гэдгийг чи ойлгосонгүй гэж үү, чөтгөр алгад. Тэр жүжгийг бид цаашид дуусталнь үзнэ гэдэг дамжиггүй, гэлээ.

Фельтон хариуд нь Милорд оо, би ч мөн тэгж л бодсон юм гэхдээ хоригдол маань нэгэнт бүсгүй хүн болохоор, өөрийг нь хүндлэх биш гэхнээ, шударга явдалт хүн хэн боловч өөрийгөө хүндлэх сэтгэлийн үүднээс бүсгүй хүнийг хүндэлдэгчлэн, үүнд санаа тавья гэж бодсон юм гэлээ.

Фельтоны үгэнд Миледигийн дотор хүйт оргиж, хамаг бие нь зарсхийгээд явчхав

Винтер гуай инээд алдан, за тэгвэл, энэ янзыг нь догь олоод унжуулсан сайхан үс, цагаан арьс, уйтгарлашгүй харц чиний сэтгэлийг татаж орхиогүй л байна уу, чулуун зүрхт минь? гэсэнд.

-Үгүй Милорд, намайг хөнөөнө гэхэд, чухамдаа бүсгүй хүний арга ов, маягаас арай илүү юм хэрэгтэйгэж мэдээрэй гэж шулуухан сэтгэлт залуу өчив.

-За тийм бол эрэлхэг дэслэгч минь Миледид өөр арга зам хайх боломж олгоод, өөрсдөө явж хоолоо идье. Бүү санаа зов, энэ хүний арга заль гэж их, инээдэмт жүжгийн хоёр дахь үзэгдэл мөдхөн гарна

Ингэж хэлээд Винтер гуай Фельтоныг сугадан авч инээсээр одов.

-Олиггүй муугэлэн гэхнээ гэлэн болж чадаагүй, өөдгүй муу шинэ цэрэг, чи чухам эр цэргийн хувцас биш, лам орхимж ороогоод л явбал таарах амьтан, өөрт чинь яг тохирсон арга би олноо, гайгүй гэж Миледи шүд зуун шивнэлээ.

Винтер босгон дээр зогсоод, Миледид-энэ удаа хэрэг бүтсэнгүй гээд хоолноос гарчихгүйг хичээгээрэй. Дэгдээхэй, загасны мах зоогло, хоолонд хор хий гэж тушаагаагүй гэдгээ андгайлъя. Манай тогооч бузгай сайн, бас намайг үхсэн хойно өвийг минь залгамжлахгүй хүн болохоор би сэтгэл амар, бүрэн итгэж байдаг юм. Тэхлээр надаас үлгэр ав. Баяртай эелдэг аашт дүү минь. Дахин ухаан алдахаар чинь уулзъя гэв. Миледи үүнээс илүү юм тэсвэрлэн хүлцэж үл чадах байлаа. Шүдээ хавиран, сандлын түшүүрэгнээс зуурч байгаад Винтер гуай, Фельтон хоёрын араас үүд хаагдахыг арайхийн харж, ганцаараа үлдмэгцээ дахин цөхөрч гүйцсэн байдалд авгав. Ширээ рүү хартал тэнд хутга гялалзаж байхыг хараад авхай ухасхийн шүүрч авгал, гай болоход хутганы төмөр мухар үзүүртэй гялалзсан мөнгө байхыг үзээд муухай урам хугарав.

Дутуу хаалттай үүдний цаана тачигнатал хөхрөлдөх нь дуулдахад дахин үүд нээгдэж, Винтер гуай дуу алдан:

Ха ха. Хараа биз, хонгор Фельтон минь, чамд юу гэж хэллээ. Энэ хутга чамайг үгүй хийх ёстой байж, чамайг энэ бүсгүй зүгээр алж орхих байсан. Өөртөө саад болсон хүнээс алив нэг замаар ангижрах гэдэг нэг сул талтай хүн байгаа юм. Чиний үгэнд орж энэ бүсгүйд үзүүртэй сайн ган хутга өгсөнсөнбол эхлээд чамайг үгүй хийгээд, дараа нь бид бүгдийг хутгалж дүүрэх байсан юм.

Жон чи харж байгаа биз хутга барихдаа энэ бүсгүйн хир сурамгай байгааг гэлээ. Үнэхээр ч Миледи тэр дайран довтлох гэсэн зэвсгээ чанга атгасаар байснаа, энэ муухай дайрсан үгсийг сонсоод хүч, зориг алдран гар нь тэнийж орхилоо. Хутга ч шаландээр унав.

-Милорд таны хэлдэг зөв байж, таны зөв юм байна, би эндүүрч байжээ, гэж Фельтон голоосоо жигшсэн байртай дуугарахад Миледигийн зүрх ёгхийгээд явчихлаа.

Цаад хоёр гарч одов.

Энэ удаа Миледи урьдынхаасаа илүү анхааралтай чагнаж, хүний хөлийн чимээ гудмаар цаашлан тасрахыг хүлээлээ..

-Би өнгөрчээ! Миний бүх арга залиг, хүрэл чулуун хөшөө шиг огт хэрэгсэхгүй улсын гарт би оржээ. Эд намайг андахгүй мэдэж, миний аль ч овд автахгүй юм байна. Тэгсэн ч энэ бүхнийг эдний санаснаар болгож болохгүй дээ, гэж Миледи шивнэнэ. Үнэхээр ч энэ бүсгүйн саяны бодож байгаа болон, аяндаа өөрт нь горьдлого төрж байгаагаас үзэхэд зориг чангатай ажээ. Энэ хүн айж сүрдэх, гуньж гутрах сэтгэлийн алинд ч удтал автах нь үгүй, Миледи ширээнд сууж, элдэв зуушнаас идэж, испани дарс жаахан уугаад, хамаг зориг чадал нь сэргэх шиг болов.

Унтахаар хэвтэхийн өмнө Миледи учирсан хүмүүсийнхээ хэлсэн үг, хөдөлгөөн алхсан гишгэсэн бүрийг, дуугүй байсан байдлыг нь хүртэл эргэж нарийвчлан хянаж цэгнэн үзсэний үр дүнд, өөрийг нь зовоож бий хоёрын Фельтон нь арай л хялбар гэнэдэж болмоор юм гэж бодов. "Чиний үгэнд би орсон бол..." гэж Винтер гуай хэлсэн тэр нэг үг хоригдсон бүсгүйн толгойд дахин дахин санагдаж байлаа. Тэхлээр Винтер лорд үгэнд нь ороогүй гэхийг бодоход Фельтон, Миледиг өмгөөлж үг хэлсэн бололтой. Үүнээс үзвэл, тэр хүнд намайгөчүүхэн боловч өрөвдөх сэтгэл байжээ Энэ өчүүхэн өрөвдөх сэтгэлийг би өөрий чинь эзэмдэн зовоох болтол тэтгэн хөгжөөнө. Харин Винтер лорд намайг сайн мэднэ, мөн нэг цагт намайг сулраад гарвал өөртөө ямар гай дайрч болохыг сайн мэдэх болохоор түүнийг овондоо оруулах гэж оролдохын ч хэрэг алга. "Харин Фельтон гэдэг гэнэхэн залуу хүн болохоор өөр хэрэг, хиргүй цэвэр сэтгэлтэй сайн үйлт хүн бололтой, тэхлээр уруу татаад орхиж болмоор" гэж бодно.

Ингээд Миледи орондоо ороод унтлаа. Бүсгүйн унтаж байгааг хүн үзвэл, түүнийг залуухан охин юм байна, дараачийн баяр дээр цэцгээр хэлхээ хийж зүүгээд гоёх тухайгаа зүүдэлж байгаа бол уу гэж бодмоор байв.

ЛШ. ХОРИГДСОНЫ ХОЁР ДАХЬ ӨДӨР

д'Артаньян арай хийж нэг өөрий нь гарт орж ирээд, цаазаар авахуулж байхад нь байлцаж байна гэж зүүдлээд яргачны сүхэнд цавчуулсан өшт хүний нь цус үсрэхийг харлаа гэж нойрон дундаа инээмсэглэж байлаа.

Миледи ингээд сая нэг горьдлого төрсөн хоригдол хүний бөх нойроор нойрсож байв. Өглөө өрөөнд нь хүн орж ирэх үед авхай орноосоо босоогүй байв. Өчигдрийн ярьж байсан бүсгүйг Фельтон сая дагуулж ирээд, дотогш оруулж, өөрөө гадаа гудамжинд үлдэв. Ирсэн бүсгүй Миледи дээр ороод тус болоход бэлэн байгаагаа мэдэгдэв.

Миледи уулаасаа цайвар царайтай хүн болохоор анх үзэж байгаа хүнийг хуурчхаж чадахуйц билээ.

-Миний бие муухан байна. Энэ бүх урт шөнийн турш нүд ер аньсангүй. Мөн ч их тарчилж байна даа...Өчигдөр надтай харилцаж байсныг бодвол та надтай арай хүн шиг харилцах болов уу үгүй юу? Ер нь намайг орноосоо босохгүй байхыг зөвшөөрөөч гэж л гуйх гэсэн юм даа гэж Миледи хэлэв.

Цаад бүсгүй үүнд эмч дуудуулахыг та хүсэхгүйсэн болов уу? гэлээ.

Фельтон энэ яриаг сонсоод юу ч дуугарсангүй. Миледи, өөрийнхөө дэргэд, өрөвдөж энэрэх сэтгэл төрүүлж болохуйц хүн хэдий олон байвал Винтер гуай харж харгалзахаа улам чандална гэж бодов. Бас эмч өөрий нь өвдсөн болж баашилсныг илрүүлж болох тул, нэгдэх мэхээ гарзадсан Миледи хоёр дахь удаагаа эндхийг хүсэхгүй байв.

-Эмч дуудуулах аа? яах юм бэ? Энэ эрхмүүд өчигдөр миний өвчнийг инээдмийн жүжиг гэж байна билээ, өнөөдөр мөн л тэх нь магад. Өчигдөр оройноос хойш эд нар эмчийг ч мөн ятгаж амжаа шүү дээ гэв.

Төвөгшөөсөн Фельтон ярианд оролцож, тэгвэл биеэ яаж эмчилмээр байгаагаа та хэлээд орхи л доо гэлээ.

-Яавал таарахыг нь би ямар мэдэх биш дээ! Бурхан минь, миний бие муу л байна тэгээд л тэр, нэг уумаар юм өгөг, юу ч яахав. Энэ эх адаггүй гомдоллоход дургүй нь хүрч гүйцсэн Фельтон, яваад, Винтер гуайг аваад ир гэж тушаасанд, Миледи дуу алдан:

-Үгүй, үгүй, түүнийг бүү дууд гуйя таныг! Миний бие сайн байна, над юу ч хэрэггүй түүнийг л бүүдуудаж үз гэлээ.

Миледи ингэж үнэн голоосоо, үнэмшмээр дуу алдсанд. Фельтон өөрийн эрхгүй өрөөний босгыг алхаад дотогшоо жаал ойртов.

"Энэ над дээр орж ирлээ шүү" гэж Миледи бодлоо.

-Ингээд авхайтан та нээрээ өвчтэй байгаа бол бид эмч рүү хүн явуулья, үгүй зүгээр биднийг

хуурч байгаа бол өөрт чинь л тусгүй, юу ч гэсэн бидэнд өөрсдийгөө буруушаах юмгүй болно гэж Фельтон хэллээ. Миледи үүнд хариу юм дуугарсангүй, гуа сайхан толгойгоороо дэрээ шааж унаад агсартал уйлчихлаа.

Фельтон хором зуур бүсгүйг ердийнхөө хэнэггүй байдлаар харж байснаа уйлаан унжаан удаашрах төлөвгэйг үзээд гарч одсонд, ирсэн бүсгүй мөн дагалдан гарав. Винтер гуай ирэхгүй л байлаа. Миледи дотрооби ойлгож эхэлж байх бололтой гэж магнай тэнийн, ингэж баярласнаа сэм харж байж мэдэх бусдын нүднээс нуухын тулд хөнжилдөө шургалаа.

Хоёр цаг өнгөрлөө. Одоо өвчин эдгэрэх цаг боллоо. Босьё, тэгээд өнөөдөртөө л жаал зугаа юм бүтээхийг мэрийе.

Над дөнгөж аравхан хоногийн зай байгааг нь хоёр дахь нь өнөө орой дуусах гэж байна гэж Миледи бодлоо.

Өглөө, хүмүүс Миледигийн өрөөнд орж ирэхдээ өглөөний хоол авчирсан билээ. Удалгүй ширээ цэвэрлэж юм хураахаар ирэх үед Фельтонтой уулзана гэж Миледи ухаарлаа. Миледи эндүүрсэнгүй. Фельтон дахин ирээд, Миледи хоолонд ам хүрч үү, үгүй юү гэж огт анхааралгүй, голдуу зууштай цуг оруулж ирдэг ширээг гарга гэлээ.

Цэргүүдийг гарах үед нэг юм гартаа барьж явсан Фельтон сүүлдэж, өрөөнд түр саатлаа. Ил гал түлэх зуухны ойролцоо зөөлөн сандал дээр налайж хэвтсэн Миледи гуа сайхан, цонхигор хүлцэнгүй царайтай, ёстой л нэг тамлагдан нөхцөхийг хүлээж бий ариун цагаан дагина мэт санагдана.

Фельтон өөдөөс нь дахин очоод:

-Винтер гуай авхайтан таныг нэг адил католик шажин тан хүн, тэхлээр таныг бурханд мөргөж залбирах боломжгүй болсондоо зовж байгаа болов уу гэж байна. Тэхлээр таныг өдөр бүр мөргөлөө хийж залбирч байхыг зөвшөөрч байна. Мөргөл энэ номон дотор бий гэлээ. Фельтон тэр номыг Миледигийн ойролцоо байгаа ширээн дээр ямар шүү байртай тавьж ямар шүү өнгөөр "мөргөлөө хийх" гэж хэлээд хир их ёозгүй инээмсэглэхийг Миледи ажаад, толгойгоо өргөн залуу даргыг сүрхий хянуур харлаа. Тэгээд, түүний үсээ даруу байдлаар самнаж, зориуд бүдүүн борог хувцасласан болон, гантиг чулуу мэт гөлгөр мөн тийм хүйтэн баргар царайгаар нь, хатуу журамт пуритан сүсэгтний нэг мөнийг танив. Ийм улстай Миледи урьд Яков ван эзний ордон болон францын ван эзний ордонд дайралдаж явсан юм байж.

Тэр сүсэгтнүүдийг францад Варфоломейн шөнө хядсан явдал бий боловч, эд францын вангийн ордонд амь хоргодох удаа байдаг байжээ.

Суут их хүмүүст хамаг хувь заяа, амьдрал нь шийдвэрлэгдэх эргэлтийн чухал үед төрдөг уран санаа Миледийн ухааныг гэнэт гийгүүлэв.

"Танай мөргөл" гэсэн энэ хоёр үгийг бодоод, Фельтон руу сайн харвал, үүнд хэлэх хариуны нэн чухал болохыг Миледи ойлголоо. Ингээд юм хурдан сэтгэж чаддаг хүн болохоор хариулах үг даруй толгойд нь ороод иржээ. Залуу даргын дуунд байсан басамжлах өнгөтэй нийцсэн үл

тоомсорлон жигшсэн дуугаар би. юу! Би чинь эрхэм ээ...Миний мөргөлийг гэнээ...тэр нүгэлт католик шажинт Винтер надтай нэг сүсэгтэн бишээ сайн мэднэ шүүдээ. Энэ чинь намайг чадах санаатай тавьсан урих байна гэв.

Авхайтан та ямар шажин шүтдэг юм бэ? гэж Фельтон асуухад, өөрөө хэдийгээр биеэ сайн барьж чаддаг хүн ч гэсэн энэ удаа гайхсанаа нууж чадсангүй. Миледи хуурамчаар сэтгэл хөдөлсөн хүн болж дуу алдан, үүнийгээ би шажин шүтлэгийнхээ төлөө ханатлаа зовж гүйцсэн тэр өдөрл хэлнээ! гэв. Ганц энэ үгийг хэлээд, Фельтоны дотор хэдий их юм бодогдуулж, амжилт олсноо Миледи цаадахынхаа харцаар ойлголоо. Миледи цаашаа пуритан сүсэгтнийг дууриан хөөрч бахадсан дуугаар би дайснуудынхаа гарт ороод байна. Бурхандаа сүсэглэн бишрэнэ! Нэг бол бурхан намайг аварна, эсвэл би бурхныхаа төлөө амиа тэвчинэ. Миний хариу энэ байна. Та Винтер гуайддамжуулж өгөөрэй. Энэ номыг харин гээд түүнд хүрч биеэ бузарлахаас айсан мэт хүрэлгүй хуруугаараа занган та аваачиж болно, өөрөө хэрэглэж үз, бодвол та аль аль талаараа Винтер гуайн хамсаатан байгаа биз, хүнийг тарчлаахдаа ч гэсэн, буруу, номын шажин шүтэхдээ ч гэсэн тэр гэв.

Фельтон хариу юм хэлсэнгүй, номыг түрүүнийх шигээ жигших байраар аваад, бодол болон гарч одов. Оройн таван цагийн үед Винтер гуай ирлээ. Иймд цаашид ямар шүү янзтай байхаа бодож боловсруулах цаг Миледид хүрэлцжээ. Хадам ахыгаа Миледи бүрэн тайвширсан хүн шиг угтаж уулзлаа.

Бээл орж ирээд Миледигийн өөдөөс харсан сандал дээр налайж хэвтэн, зуухны өмнөх хивсэн дээр хөлөө цээргүй сунган тавиад үгүй, бид чинь, тангаргаа жаахан няцаж орхио юу? гэв.

-Өршөөлт эрхэм та юу хэлэх гээд юу хэлж байна даа?

-Та бид хоёрын сүүлд уулзсан тэр цагаас хойш та шүтлэгээ өөрчилжээ гэж хэлэхгээд байна. Үгүй та гурав дахь удаа гэрлэхдээ нэг буруу номтонтой гэрэлчихсэн юм биш биз? -Милорд та наад үгээ тайлбарлаж өгөөч, таны үгийг дуулаад байгаа мөртлөө юу ч ойлгохгүй байгаагаа хэлчихье гэж хоригдол бүсгүй ихэмсгээр өгүүллээ.

-За яахав та чинь тэгвэл ерөөсөө шажин сүсэглэдэггүй хүн бодог. Энэ ч харин миний санаанд таарч байна гэж Винтер гуай дооглонгуй дуугарсанд Миледи тосон авч хүйтнээр,

-Тэгэлгүй яахав, та ч тиймэрхүү л үзэлтэй хүн дээ гэв.

-Үнэнээ хэлэхэд, таны шүтлэгтэй шүтлэггүй нь надад ер хамаа алгаа!

-Милорд та шажин шүтлэгийн асуудлыг үл тоомсорлодгоо нуудаг байлаа ч гэсэн өөрийн чинь завхай зайдан хууль даруулгагүй явдлууд бариадөгөх байсан биз.

-Уухай. Булай явдлаараа нэрд гарч алдаршсан бүсгүй та намайг завхай гэв үү? Нэг бол би сайн дуулсангүй байж таарах нь эсвэл, та ичих> нүүрэндээ илэг наасан амьтан юмаа чухам, чөтгөр алгад гэв. Миледи үүнд хүйтнээр:

-Бидний яриаг хүн чагнаж байгаа болохоор л ингэж ярьж байна. Цаад хуяг, алуурчин нараа

надад улам дургүй болгох гэж та ингэж ярьж байна шүү дээ гэв.

-Хуягууд алуурчид аа! та ийм янзаар ярьж байгааг үзвэл өчигдрийн шог жүжгийн хэлбэр өнөөдөр эмгэнэлийнх болж таарсан байх нээ. Гэсэн ч яахав, долоо хоногийн дараа та байвал зохих газартаа хүргэгдээд, миний санасан хэрэг ёсоор болох юм.

-Үл бүтэх санаа, муухай санаа яа? гэж Миледигийн дуу алдах нь хилсэдсэн хүн шүүгчийнхээ өөдөөс голоос гомдсон үгээ хэлэхийн адил.

-Үгүй нээрээ, энэ завхуул хүүхэн чинь галзуурч байх шиг санагдах юм, гэж Винтер гуай босоод, за пуритан бүсгүй та тайвширч үз, үгүй бол өөрий чинь шоронд хийчихнэ шүү. Янз нь манай испани дарс толгойд чинь гарсан байж таарах нээ. Ер нь ингэж согтох ямар ч аюулгүй, хойч нь хөнөөлгүй байх гэж үгүй, гэв.

Тэр цагт ихэс дээдэс хүртэл хараал хэлэх нь ердийн явдал байсан цаг болохоор Винтер гуай хараал тавьсаар гарч одлоо. Фельтон үнэхээр хаалганы цаана зогсоод, ярианаас ганц ч үг газар унагаалгүй дуулжээ.

Миледи ч мөн үүнийг гадарлаж байлаа. Ингээд хадам ахынхаа хойноос яв, яв, өөрт чинь хөнөөлтэй балаг мөдхөн болох бий. Тэнэг минь чи түүнийг нэгэнт засаж болох нь өнгөрсөн цагт сая мэдэх бий гэж шивэгнэв.

Байшинд дахиад нам гүм болоод, хоёр цаг өнгөрөв. Цэргүүд оройн хоол авчрах үед Миледи, хоёр дахь нөхрийнхөө зарц пуритан шүтлэгт өвгөний зааж өгсөн мөргөлийг чанга дуугаар уншиж байлаа. Бүсгүй гүн сүслэн юм бясалгаад орчиндоо болж байгаа юмыг анхаарах ч үгүй ажээ. Бүсгүйд бүү саад бол гэж бусдадаа Фельтон дохио өгөөд, бүх юм засаж бэлдэж гүйцээд цэргүүдтэй хамт чимээгүй гарч одов. Цонхны нүхээр хүн ажиж байж болохыг Миледи мэдэх тул мөргөлөө дуустал уншив. Тэгтэл үүдний өмнүүр явдаг манаачийн хөлийн чимээ арай өөр, чагнаад ч байгаа юм шиг санагдлаа.

Энэ оройдоо Миледид өөр юм хэрэг ч үгүй байсан болохоор босч ширээний ард суугаад жаал юм идэж, зөвхөн ус уув. Цагийн дараа цэргүүд ирж ширээ аваачихад Фельтон ирсэнгүйг ажиг. Ингэхлээр Фельтон өөртэй нь олон учрахаа айж байгаа байх нээ. Миледи буруу хараад инээмсэглэв. Даан ч их баярлаж хөөрсөн байдал илт байсан тул буруу хараагүй бол хүн сэжиг авахсан буй заа.

Миледи хагас цаг хиртэй хүлээхэд хуучны энэ шилтгээн дотор нам гүм болоод далайн лут амьсгаал мэт давлагааны мөнх шуугих чимээ л сонсогдоно. Миледи пуритануудын дуртай мөргөлийг уянгатай, цээл сайхан хоолойгоор дуулж гарав. Бурхан чи бидний хүч чадлыг шалган үзэхээр өршөөл авралаасаа гаргаад, зовлон эдэлж чадсан нэгнийг өөрөө эргэн өндөр их өршөөлдөө багтаадаг гэсэн мөргөл билээ.

Энэ мөргөлийн шүлэг уран чадлаар дорой, үзтэл пуритан сүсэгтнүүд шүлэг зохиохдоо гойд гайхуулмаар юмгүй аж.

Миледи мөргөл дуулахын хамтчагнавал манаач үүдний өмнө нам зогсжээ. Өөрийн нь дуулал

хүнд ямар шүү сэтгэгдэл төрүүлж байгааг Миледи үүгээр гадарлаж болох байв. Ингээд цаашаа чин голоосоо сүсэглэн мэрийж мөргөл дуулахад дуу нь цайзан дотор хол тархаж илбийн ид шид мэт барьж хорьсон хүмүүсийн сэтгэлийг зөөлрүүлэн байх мэт өөрт нь санагдав.

Гэтэл яриагүй католик шажинд сүсэглэдэг бололтой манаач уяран зогссоноо санаа авч үүдний цаанаас хашгиран:

-Авхайтан та, дуугүй байгаач, таны мөргөл дуулж байгаа чинь оршуулах үед дуулдаг мэт уйтгар хөдөлгөх юм. Энд харуул харж зогсохдоо бас ийм мөргөл сонсох болбол би бүр дийлэхгүй нээ гэв.

-Дуугүй бай! гэж нэг хүн ширүүн тушаахыг сонсвол Фельтоны дуу аж. Ичгүүргүй амьтан чи өөртөө хамаагүй хэрэгт юунд оролцоо вэ? Энэ бүсгүйн мөргөл дуулахад саад хий гэж чамд тушаасан юм уу? Үгүй шүү дээ. Та нарт энэ бүсгүйг харж манаж бай, оргож зугтаахыг оролдвол буудаарай гэж тушаасан шүү дээ. Оргох, зугтаах гэвэл буудаж алаарай. Харин авсан тушаалаасаа бүү давар гэлээ.

Үүгээр хэлэхийн эрхгүй их баярласан байдал Миледигийн царайнд цахилгаан гялбах адил гэрэлтэж ирснээ, саяны яриаг нэг ч үг унагаалгүй сонссон мөртлөө сонсоогүй юм шиг даруй цаашаа дуулж гарав. Чөтгөрөөс өөрт нь хүний дур булаалгахаар өгсөн хамаг чадлаа гаргаж гойд сайхан дуулна. Гашуун нулимс, хүнд тулалдаан, олон хоригдож, гинжлэгдэхийг даван, гаслант шөнө хоногийг тоолоход залуу нас, үнэнсүсэг гэж байдаг гэж мөргөл дуулав.

Миледигийн гойд сайхан, гүн сүсгэлсэн дуу нь мөргөлийн бүдүүн борог үгтэй муухан шүлгэнд, сэтгэл татах цаглашгүй их хүч, гүн их утга учир оруулснаар сүсэг бишрэлд бүрэн автаж, сэтгэлээ хий тэтгэсэн пуританууд хүртэл өөрсдийнхөө мөргөлийн ийм сайхныг олж мэдээгүй билээ. Галт замд зовж байгаа еврей үндэстний их зовлонтны сэтгэлийг засан дуулж байгаа бурхны дуулахыг сонсох шиг Фельтонд санагдаж байлаа. Миледи цаашаа үргэлжлүүлэн: Өршөөлт их бурхан минь, зовлонгоос ангижрах цаг бидэнд нэг ирнэ. Зориг сэтгэл биднийг хуурдаг юмаа ч гэсэн хэзээд үнэн байдаг үхэл биднийг хуурахгүй гэж дуулав.

Хүний сэтгэл булаах чадалтай энэ бүсгүй саяны дууг байдгаараа мэрийн дуулсандзалуу даргын хөдөлж байсан сэтгэл бүрмөсөн татагдав. Үүд огцом нээж ороод цонхийсон царайтай цог шиг гялалзсан харцаа ийш тийш буруулан байж Миледигийн өмнө очиж зогсоод:

-Та юунд ингэж ийм хоолойгоор дуулдаг юм бэ? гэж дуугарав. Миледи үүнд хүлцэнгүй номхноор энэ айлд миний ингэж мөргөл дуулах зохисгүй гэдгийг санасангүй, уучилна уу. Таны шажиншүтлэгийг би доор үзсэн юм шиг санагдуулчихсан байж мэднэ, харин даанч тэгье гэж санаагүй юм даа. Би их гэм хийсэн байж мэднэ, гэсэн ч нээрээ санамсаргүй ийм хэрэг боллоо, уучилж үз дээ гэв.

Энэ үед Миледи гойд гуа үзэсгэлэнтэй, саяхан нээрээ л мөргөл үйлдэн бясалгасан юм уу гэмээр зүс царай нь тэнгэрлэг байдалтай болохоор тэр өгүүлшгүй өнгө үзэмжид нь автсан Фельтонд сая мөргөл дуулахыг нь өөрөө чагнасан дагина өмнө зогсож байх мэт санагдав.

-Тийм, тийм та энэ гэрийн хүмүүсийн сэтгэл санааг үймрүүлж байна гэж Фельтон хариу дуугарав. Хөөрхий үймэрсэн залуу авцалдаа муутай юм ярьж байгаагаа өөрөө ч ажсангүй, гэтэл Миледи хурц хараагаараа түүний сэтгэлийн гүнд байгаа бодлыг нэвт харах гэсэн мэт ширтэнэ. Миледи номхон хүлцэнгүй дүр үзүүлэхийг байдаг хирээрээ хичээж, аль болох зөөлөн намуу дуугаар, би дахиж дуулахаа больё гээд дахин харав.

-Үгүй, үгүй, авхайтан, зүгээр л аяархан, ялангуяа шөнийн цагаар аяар дуулж байгаарай, гэж Фельтон хэлээд хоригдсон бүсгүйн өмнө хатуу чанд хүний дүр цаашид үзүүлээд байж чадахааргүй болсноо мэдээд өрөөнөөс яаран гарав.

Дэслэгч гуай та зөв юм хийлээ. Энэ бүсгүйн дуулж байгаа нь хамаг сэтгэл үймүүлээд хаячих юм. Гэхдээ, мөд дасна биз дээ, мөн ч сайхандуутай хүн юм, гэж гадаах цэрэг хэлэв.

LIV. ХОРИГДСОНЫ ГУРАВ ДАХЬ ӨДӨР

Фельтон орж ирэх нь ирлээ. Гэвч цаашаа нэг алхам хийж, өрөөнд үлдээх, нарийн яривал үлдье гэж өөрт нь бодогдуулах арга сүвэгчлэх хэрэгтэй юм аа, үүнд чухам ямар шүү ов хэрэглэж санасандаа хүрэхээ Миледи сайн мэдэхгүй байв. Илүү их амжиж, түүнтэй юм ярихболомж олохын тулд өөрөөр нь юм яриулах хэрэгтэй байв. Хүний энгийн ярианаас аваад, тэнгэрлэг сайхан дуулах хүртэл элдэв өнгөөр хувирч чаддаг дуугаа хүний дур булаах угийн хүчтэй юм нь гэж Миледи сайн мэддэг байжээ.

Гэвч Фельтоныг алив юмнаас урьдчилан сэргийлсэн болохоор толгойг нь эргүүлэх гэж ямар ч арга хэрэглээд, хэрэглээд амжилт олж чадахгүй байж мэдэх юм. Иймд Миледи бүх алхмаа, үг нэг бүрээ, энгийн нэг хөдөлгөөн төдийгүй санаа алдлаа гэж хүнд санагдаж болохуйц амьсгалаа

хүртэл нарийн цэгнэх болов. Товчхон хэлэхэд дадаагүй шинэ рольд тоглох гэж байгаа сайн жүжигчний хийдэг бүхнийг Миледи хийж байлаа.

Винтер гуайтай яаж харилцаж байх тухайд нэг их төвөгтэй юмгүй, иймд урдаас бодож боловсруулаад, хадам ахынхаа дэргэд дуу цөөнтэй, ихэмсэг байж, үе үе зориуд үл тоомсорлох дүр үзүүлэн зэвүүгий нь хүргээд, өөрийнхөө хүлцэнгүй номой байдлаас эрс тэс өөр харагдахуйц сүрдүүлэг, хавчлага хэрэглэхэд хүргэж байхаар шийджээ. Эд бүгдийг Фельтон үзээд магадгүй юм хэлэхгүй байж болно гэхдээ цөмийг нь харах болно.

Фельтон өглөө ирдэг цагтаа ирээд өглөөний хоол төхөөрч байх зуур Миледи түүнд юу ч хэлсэнгүй. Гэвч гараад явахынхаа даваан дээр Фельтон өөртэй нь юм ярих санаатай байх шиг санагдаад, Миледид горьдлого төрөв. Фельтоны уруул омолох боловч юм дуугарсангүй, аман дээрээ гарч ирсэн үгийг биеэ хүчлэн байж барин нуугаад гарч одов.

Үдийн алдад Винтер гуай ирлээ. Өвлийн овоо сайхан өдөр болж, Англид гийхээс биш ээдэггүй нарны цайвар туяа Миледийн хоригдсон өрөөний цонхоор тусна. Миледи цонхоор харан, үүд нээгдэх чимээг дуулаагүй дүр үзүүлнэ.

-Үгүй ерөө, бид инээдмийн жүжиг нэг тоглож, эмгэнэлийн жүжиг нэг тоглож үзсэний эцэст уйтгарт автаж байна уу даа, гэж Винтер гуай инээмсэглэв. Хоригдсон бүсгүйг хариу юм дуугарахгүй болохоор Винтер Лорд:

-Таны байдлыг ч ойлгож байна, та энэ эрэг дээр суларч гараад энэ далайн номин долгиог бат сайн хөлөг онгоцоор туулан явж, далай юм уу хуурай газрын аль, нэгэн дээр нөгөө сайн чаддаг ов залиныхаа нэгийг хэрэглэн намайг хөнөөхсөн гэж бодож байна уу. Жаахан тэсч үз, хүлээж үз! Дөрвөн өдрийн дараа та эрэг дээр гарах боломжтой болно. Далай таны өмнө чөлөөтэй болно, таны хүсэж байгаагаас ч илүү их чөлөөтэй болно. Дөрөв хоноод Англи танаас хагацах юм гэв.

Миледи залбирч, сайхан нүдээ тэнгэр өөд хандуулан, байр төрх, дууныхаа өнгөнд үнэн хүлцэнгүй байдал үзүүлэн:

-Тэнгэр минь, энэ хүнийг миний уучилж байгаагийн адил уучилж хайрла гэв.

-Винтер гуайн уур хүрч, хараал хүрсэн эм чи залбир, залбир чиний ингэж залбирч байгаа их уужим сэтгэлээ, юу гэвэл чи хэзээ ч өөрий чинь үл өршөөх хүний гарт орсон гэдгийг андгайлъя, гэв. Винтер гараад явчихлаа. Винтерийг гарч байх тэрхэн зуур үүдэн завсраар нэг хүний хянуур харц өрөө рүү ширтсэнд Миледи өөрт нь харагдахгүйг хичээн шалавхан зайлсан Фельтоныг харчихлаа.

Тэхлээр Миледи шалан дээр сөхрөн унаж, чангаар мөргөж гарав.

-Тэнгэр минь, тэнгэр минь, миний ариун цагаан хэргийн төлөө тарчилж байгааг хэн мэдэх билээ. Зовлонгоос тэсч гарах хүч хайрламуу гэв. Үүд аяархан нээгдэхэд гуа бүсгүй хаалга хяхнахыг үл дуулагчин болон мөргөлөө үргэлжлүүлж, уйлагнасан дуугаар гүнээ сүсэглэн:

-Өршөөлт тэнгэр! Цээрлүүлэгч тэнгэр минь, энэ хүний санасан булай муу хэргийг ингээд бүтээх юм гэж үү? гэлээ. Ингэж хэлснийхээ дараа л Миледи сая Фельтоны хөлийн чимээг дуулсан болж, эгшин зуур босон харайгаад, мөргөж суухад нь хүн орж ирсэнд ичсэн байртай улайчихлаа.

-Авхайтан, мөргөж байгаа хүнд би саад болох дургүй юм, надаас бүү зов гуйя танаас, гэж Фельтон төлөв өгүүлэв;

-Намайг мөргөж байсан юм гэж та юунаас бодоо вэ? та эндүүрч байна, би мөргөөгүй гэж Миледи зангирсан дуугаар хэлэв. Фельтон үүнд урьдын адил төв боловч арай зөөлөрсөн дуугаар, алив хүн бурхны өмнө наманчлан залбирах явдалд өөрийгөө саад болох эрхтэй хүн гэж намайг бодно гэж авхайтан та саналаа гэж үү тэнгэр намайг өршөөг! Тэгээд ч гэмтэй хүн наманчлах гэдэг сайн үйл. Хэдий хүнд хэрэгтэй ч дээд тэнгэрийн өлмийд сөгдөн наманчилж байгаа хүнийг би хүндэлж үзнэ гэв.

-Намайг гэмтэй гэнэ шүү! гэснээ Миледи эрлэг номон хааныг ч болов эргэлзүүлмээр инээвхийлээд, буруутай үгүйг бурхан чи л мэднэ дээ намайг гэмгүй мөртөө шийтгүүлсэн хүн гэж хэл л дээ, тэгвэл үнэний хувьтай болно. Гэвч тэнгэр бурхан зовсон амьтныг нигүүлсэж, дараа үед гэмгүй хүмүүсийг шийтгүүлдэг гэдгийг та мэднэ шүү дээ гэлээ. Тагэмт хэрэгтэн юм уу, зовлон эдэлж байгаа хүн юм уу, алин нь ч гэсэн та мөргөх л хэрэгтэй, би ч гэсэн таны төлөө залбирна.

-Өө шударга журамт хүн гуай! гэж Миледи дуу алдаад Фельтоны өмнө сөхөрч, миний үгийг сонс доо. Танаас би цаашид нуугаад байж чадашгүй нь, тэмцэлд туулан гарч өөрийн шажиншүтлэгээ илэрхийгээр шүтэх хэрэгтэй цаг болоход би зориг мохох бий гэж айх юм. Цөхөрч гүйцсэн хөөрхий бүсгүйн гуйлтыг сонсож хайрла. Таныг хуурч байна, гэхдээ хэргийн гол нь үүнд биш ганцхан юмаар тус болж өршөөл үзүүлэхийг танаас гуйя, тэгвэл би таны ачийг бодож энэ хойт хоёртоо таны төлөө залбирна гэв.

-Манай даргатайярилцаж үз, авхайтан аз болоход, өршөөх шийтгэх эрхийн алин нь ч над ноогдсонгүй, бурхан энэ; хариуцлагыг надаас дээр байгаа хүнд хүлээлгэжээ гэж Фельтон хариулав.

-Үгүй, үгүй ганц та л хариуцна миний нэр төрийг бузарлах, намайг хөнөөх хэрэгт туслалцсанд орохноо, миний үгийг сонсвол дээрсэн билээ.

-Та өөрөө ийнхүү гутамшиг хүлээж, нэр төрөө бузарлуулах хэрэг тарьсан юм бол бурхны тааллыг үг дуугүй хүлээн тэсвэрлэх хэрэгтэй.

-Та юу хэлнэ вэ. Ээ дээ, та намайг мэдэхгүй юм даа! Нэр төрөө гутаалаа гэхдээ би нэг шорон ч юм уу шийтгэлийн тухай ярьж байна гэж та санана уу? Бурхны өршөөлөөр энүүхэн байсан ч болоосой. Гяндан юм уу үхэл гэдэг юухан байхав дээ

-Авхайтан таны үгийг би ойлгохоо болилоо. Хоригдол бүсгүй эргэлзэх байртай инээвхийлэн аль ойлгохоо больсон дүр үзүүлж байна уу? гэв

-Үгүй авхайтан, эр цэргийн хүний нэр төр, христос шажин шүтлэгээ барьж андгайлахад ойлгохгүй байна.

-Юу! Винтер Лорд гуайн намайг яах санаатай байгааг та мэдэхгүй юм уу? Үгүй мэдэхгүй.

-Байж болмооргүй хэргээ. Та чинь түүний итгэмжлэгдсэн хүн шүү дээ. -Би ер худлаа хэлдэггүй хүн шүү авхайтан.

-Үгүй Винтер гуай санаагаануух гэж нэг их оролдохгүй байгаа болохоор гадарлахад амархан байна шүү дээ.

-Би юу ч тааж мэдэх гэж оролддоггүй хүн шүү авхайтан. Надад итгээд дуулгахыг хүлээж байна гэтэл Винтер гуай таны дэргэд хэлж байснаасаа өөр юм над огт яриагүй. -Тэгвэл та түүнтэй хуйвалдсан хүн биш байх нь ээ гэж Миледи маш үнэмшилтэйгээр дуу алдав.

-Тэгвэл тэр хүн намайг хорвоогийн бүх итгэлээс хавьгүй хүнд булай шившиг болгох санаатай байгааг та мэдэхгүй юм аа гэв.

Фельтоны царай улайж хариу марган, үгүй, авхайтан та эндүүрч байна. Винтер гуай тийм хорт муухай хэрэг хийх хүн биш гэв. Миледи дотроо "догь доо, юун тухай яриа болохыг мэдээгүй байжхорт муу хэрэг гэж өөрөө хэлэв ээ" гэж бодлоо. Тэгээд чангаар:

-Муу явдалт хүний нөхөр болсон хүн юу ч хийж мэднэ, гэлээ.

-Муу явдалт хүн гэж та хэнийг хэлж байна.

-Англид энэ нэрэнд тохирох хүн нэгээс өөр байдаг юм гэж үү?

-Та Жорже Вилльерсийн тухай ярьж байна уу? гэж Фельтон асуугаад харц нь гялс хийв.

-Шашин шүтдэггүй буруу номтнууд Бекингэм герцог гэдэг хүнийг хэлж байна. Хэнийг хэлж байгаагаа ингэтэл удаан тайлбарлах хэрэгтэй хүн ер байдаг юм гэж огт бодсонгүй шүү гэж Миледи дуугарав.

-Бурхныг нэгэнт хилэгнүүлсэн хүн, зохих цээрлэлээсээ зайлж эс чаднаа гэж Фельтон хэллээ.

Фельтон бүх англи хүмүүсийнадил Бекингэмийг жигшин үздэг, католик шажинтан хүртэл түүнийг цус сорогч, завхай зайдан олхиогүй этгээд гэдэг, пуритан сүсэгтнүүд ч яахав зүгээр л шулам гэдэг байлаа.

-Тэнгэр минь! Тэр хүнд зүй ёсны цээрлэл үзүүлээч гэж мөргөхдөө би хувийн өшөөрхсөн сэтгэлээс биш, бүхэл бүтэн ард түмнийг зовлонгоос гэтэлгэхсэн гэж санадгийг минь мэдэх билээ! гэж Миледи дуу алдлаа.

-Та тэр хүнийг таньдаг юм үү? гэж Фельтон асуув:

-"Энэ маань надаас сая л нэг юм асууж байнаа" гэж Миледи дотроо тэмдэглээд ийм их амжилт өдий амархан олсондоо цаглашгүй их баярлав.

-Тэр хүнийг таних уу гэж үү? танихаар барах уу! Гай болоход, гайгаар түүнийг би таних юм гэлээ.

Ингээд Миледи бүрэн цөхөрч гутарсан байдалтай гараа нухчиж гарав. Фельтон сэтгэлээ барьж чадахгүй болсноо мэдэв бололтой үүд рүү хэд алхтал, нүд салгалгүй ажиж байсан хоригдол бүсгүй босон харайж, хойноос нь очиж зогсоогоод, Фельтон гуай уудам нигүүлсэнгүй сэтгэлээр миний гуйлтыг болгоож хайрла! гэж дуу алдаад, Надад хутга өгч үзээч, Винтер бээл гуай болгоомжилж над хутга халгаахгүй байгаа юм. Миний яахыг тэр мэдэх хүн.

Миний үгийг сонсож хайрла! Намайг өрөвдөж нигүүлсэх сэтгэлээр хоромхон зуур хутгаа өгч үз... хар л даа, би хөлд чинь сөхөрч байна... Итгэж үз танд би муу юм санаагүй. Тэнгэр мэднэ! Яалаа гэж хүнийг өрөвдөж үздэг сайхан сэтгэлтэй ганц шударга хүнтэй дайралдаад түүнд муу юм санах билээ. Магадгүй намайг аврах хүн та ч байж мэдэх юм... Ганцхан минут хиртэй надад хутгаа хэрэглүүл, танд би үүдний нүхээрбуцааж өгье. Ердөө л ганц минут шүү, Фельтон гуай, тэгвэл та миний нэр төрийг аварч өгөх нь тэр! гэв.

Фельтон айн хиртхийсэндээ, хоригдол бүсгүйн гараас гараа тавиулахыг ч мартаж орхиод, та амиа хорлох гэж байна уу? гэж дуу алдав.

-Би мэдэгдэж орхилоо, гээд Миледи тамир алдарсан байртай шалан дээр сууж би мэдэгдэж орхилоо. Энэ хүн одоо бүгдийг мэдчихлээ. Бурхан минь би өнгөрлөө, гэж шивнэнэ. Фельтон яаж шийдэхээ мэдэхгүй таг зогсоно.

" Энэ хүн бас эргэлзэж байна, тэхлээр би хүн үнэмшмээр байж чадсангүй" гэж Миледи бодлоо. Гудмаар нэг хүн явж байгаа чимээ тэдэнд дуулдаж, Винтер гуайн алхааг Миледи танив. Фельтон мөн таньж үүд рүү хөдөллөө. Миледи хойноос нь ухас хийж, бөглөрсөн дуугаар:

-Нэг ч үг бүү хэлж үзээрэй...миний ярьсан бүх юмнаас та энэ хүнд ганц ч юм бүү яриарай, эсвэл би дүүрлээ гэсэн үг, ер нь та, та л...гэв.

Хөлийн чимээ ойртож, өөрсдийнхөө дууг дуулчих бий гэж айсандаа Миледи дуугүй болов. Туйлгүй их хэлмэгдсэн байдлаар гуа сайхан гараараа Фельтоны уруулыг таглаж сэрэмжлэв. Фельтон гараараа Миледиг аяархан түлхэн зайлуулсанд хойшоо болоод, зөөлөн сандал дээр ойчив. Винтер Лорд зогссонгүй хаалганы хажуугаар өнгөрөөд, алхаа нь холдов. Фельтоны царай үхсэн хүнийх шиг цонхийж, хэсэг зуур зүрх түгшин чагнаж байснаа хөлийн чимээ тасарсны дараа сая сэрсэн хүн мэт санаалдаад өрөөнөөс даруй гарч одлоо.

Миледи мөн чагнаж байгаад Фельтоны хөлийн чимээ Винтер гуай явсны нөгөө тал руу яваад өгөхийг мэдэж, Мөөн! Чи арайхийж нэг миний болов шив гэлээ.

Төдхөн бүсгүйн царай дахин барайчихлаа.

" Хэрэв энэ хүн бээлд хэлчихвэл, миний амиа хорлохгүй гэдгийг бээл мэдэх болохоор Фельтоны дэргэд надад хутга өгчмэднэ тэгвэл энэ их цөхөрч ядсан байдал хуурмаг байсныг тэр ойлгох болно доо" гэж бүсгүй бодлоо.

Толинд өөрийгөө харвал, урьд урьдынхаасаа улам ч гуа сайхан байх аж.

-Үгүй. дэгээ, бээлд тэр лав юм хэлэхгүй, гээд инээмсэглэв.

Оройны хоол авч ирэх үеэр Винтер гуай ирсэнд Миледи хэлсэн нь:

-Өршөөлт эрхэм ээ, миний хоригдож зовоход таны биеэр байлцах явдал заавал нэмэрлэлцэх ёстой юм уу? Та ирж намайг тарчлаахаа боливол болохгүйсэн болов уу? гэлээ.

-Юу гэнээ, эелдэг аашт дүү минь! Үгүй, та өөрөө наад сайхан амаараа хэлэхдээ, надтай уулзаж учрахын тулд, санаж сүйд болоод байхаараа далайд аялж зовох, салхи шуурганд нэрвэгдэх, баривчлагдах алив нэгийг үл хайхран наашаа Англид ирсэн гээгүй бил үү. Тэгээд л би ирж байна, таалж үз дээ. Тэгээд ч энэ удаа би тодорхой зорилготой ирсэн юм гэж Винтер гуай өгүүллээ.

Фельтоныг ярьж орхиж дээ гэж санаад Миледигийн дотор палхийв. Амьдрал туршаа өдий их юм үзэж, элдвээр сэтгэл түгшиж явсан энэ бүсгүйн зүрх ингэтлээ бахардан цохилж явсан удаагүйсэн. Миледи сууж байлаа. Винтер гуай нэг сандал авч бүсгүйд ойртуулан суугаад өврөөсөө нэг бичиг гаргаж алгуураар дэлгэв.

-Үүнийг үз дээ. Би танд нэг ёсны нэг нутагт оршин суух эрхийн үнэмлэх маягтай юм үзүүлье гэсэн юм. Үүнийг би өөрөө бичсэн юм. Энэ үнэмлэх, цаашид таны амьдралын дүрэм ухаантай юм болох юм. Таны амь насыг би уучилж байгаа юм л даа, гэж Винтер гуай хэлэв. Винтер гуай ингээд цаашаа харж чангаар дуудан уншсан нь:

"... гэгч газарт аваачих газрын нэрийг бичээгүй байгаа юм гэж Винтер гуай хэлээд, Лондонгоос мянган бээрээс ойргүй алив нэг газрыг өөрөө дээр гэж үзэж байвал хэлчих, би түүгээр чинь больё гэв. За тэгээд цаашаа уншъя"... гэгч газарт францын вант улсын шүүхээр шийтгэгдэж шившгийн тамга даруулаад суллагдсан Шарлотта Баксоныг цөлөхөөр тушаав. Баксон энэ газарт байнга сууж, хаашаа ч гурван бээрээс илүү холдох эрхгүй болноо. Оргохоор

оролдвол цаазаар аваачна. Баксоны орон сууц, хоолны зардалд өдөрт таван шиллинг зоос олгож байсугай" гэжээ.

Миледи хүйтнээр наад тушаал чинь надад хамаагүй юм. байна. Наадах дээр чинь миний нэрийг тавиагүй байна шүү дээ гэж хариулав.

-Нэр ээ! Танд бас нэр бий юм үү?

-Би танай дүүгийн овгоор овоглож явдаг.

-Та эндүүрч байнаа. Манай дүү таны хоёр дахь нөхөр чинь байсан, гэтэл таны анхны эр нөхөр тань амьд шүү дээ. Түүнийхээ нэрийг хэлээд орхи. Тэгвэл Шарлотта Баксоны оронд тавиад өгье. Нэрлэх дургүй байх шив? Тийм үү? Та юм дуугарахгүй байнаа? За сайн хоригдлуудын бүртгэлд та Шарлотта Баксон гэдэг нэрээр бүртгэгдэнэ, гэв.

Миледи энэ удаа цаанаа бодолтой маягласнаас ч биш, айж сандарсандаа таг дуугүй байв. Энэ тушаалыг даруй биелүүлж, өнөө оройдоо явах юм байх, Винтер гуай явах цагий нь хурдасгасан юм байх гэж айжээ. Бүх юм ингээд дууссан юм шиг Миледийд санагдтал тушаалд гарын үсэг зураагүй байгааг үзлээ.

Үүнийг үзээд баярласан нь даанч их тул нууж ч чадсангүй. бүсгүйн дотор юу болж байгааг ажсан Винтер гуай, Мөн дөө, та гарын үсэг байхгүй байгааг хараад, тушаалд гарын үсэг зураагүй байгаа хойно, намайг айлгах л гэж үзүүлж байгаа юм байна, хэрэг өнгөрөх өдий байна гэж санаж байх бололтой. Та эндүүрч байна. Энэ тушаалын төлөвлөгөөг маргааш Бекингэм рүү явуулж нөгөөдөр гарын үсэг зуруулж, тамга даруулаад авч ирнэ. Түүнээс хойш дөрвөн цаг болоод ёсоор биелэгдэнэ гэдэгт ам өгч болох байна. За баяртай авхайтан, миний дуулгая гэсэн бүх юм энэ дээ, гэв.

-Энэ чинь эрх мэдлийг урвуулан ашиглаж байгаа хэрэг, хүний нэрийн доор цөлөх гэдэг булай явдал юм л гэж өршөөлт эрхэм танд би хариулна даа.

-Миледи та өөрийнхөө жинхэнэ нэрээр дүүжлэгдсэн нь дээр гэж бодож байна уу? гэр бүлийн эсрэг өдүүлсэн хэргийг английн хууль хагуу цээрлүүлдгийг та мэднэ шүү дээ. Илэн далангүй ярилцъя, энэ бузар ярианд миний нэр, нарийн яривал миний дүүгийн нэр хутгалдах хэдий боловч, танаас лавгай, ангижирна гэдгийг бодоод яриа шуугиан дэгдээхээс ч буцахгүй байна гэв.

Миледи, хариу юу ч дуугарсангүй, царай нь үхсэн хүнийх мэт хувхайрчихлаа.

-Мөөн! Алс аялсан нь дээр гэж та үзэж байх шив, хол аялахад залуу нас, сэргэдэг гэж хуучны үгэнд байдаг. Ер нь явж явж таны зөв юм шүү. Амьдралгэгч сайхан зүйл тэр ч учраас би таны гарт амиа алдаж орхихгүйг хичээж байгаа юм. За тэхлээр өдөрт таван шиллинг хэрэглэж байх тухай чинь ярилцаж тохиръё. Би жаахан харамч мэт санагдаж болох юм, тийм биз? Энэ нь таныг харгалзагч улсаа мөнгөөр цохиж аргацаах болуу гэж айснаас болсон хэрэг. Гэлээ ч тэднийг өөртөө татахад таны гуа үзэсгэлэн сэлт чинь үлдэж байгаа хойно. Сая Фельтонд сээтгэнээд үр дүн муутай байгаадаа тиймэрхүү оролдлого хийх дургүй болж орхихгүй бол,

гуа үзэсгэлэн сэлтээ ашиглаарай л даа.

"Фельтон намайг барьж өгсөнгүй тэхлээр. арай ч бүр дүүрчихээгүй байна" гэж Миледи бодлоо. -За баяртай авхайтан, элчээ мордсон тухай маргааш би ирждуулгая, гээд Винтер гуай босч Миледид дооглонгуй мэхийсгээд гарч одов.

Миледи сэтгэл амарсан бололтой санаа алдав. Цаашаа дөрөв хоног байна, дөрөв хоног гэдэг Фельтоны толгойг бүрэн эргүүлэхэд хүрэлцээтэй хугацаа билээ.

Гэтэл Бекингэмийн гарын үсэг зуруулах ажилд Винтер гуай мөн л Фельтоныг явуулж болох юм гэдэг айхтар бодол Миледид төрөв. Фельтон тэгвэл Миледигийн гараас мултран гарна, юу гэвэл санасан зүйлээ сэтгэлчлэн бүтээхийн тулд залуугийн толгой эргүүлэх арга угсран хэрэглэх ёстой байжээ.

Гэхдээ бидний дээр дурьдсанчлан, Фельтон өөрий нь барьж өгөөгүй нэг зүйл дээр Миледигийн сэтгэл тайвширч байв. Винтер гуайн сүрдүүлэгт сэтгэл хөдөлснөө хоригдол бүсгүй ил мэдэгдэхийг хүссэн учир сууж хоол идлээ.

Дараа нь урьдын адил сөхрөн сууж мөргөл дууллаа.

Мөн урьдын адил харуулын цэрэг холхин явахаа больж нам зогсоод чагнав. Төдөлгүй гудмын гүнээс цэргийнхнийг арай хөнгөн алхаа Миледийн чихнээ ялгаран сонсогдоод, явсаар үүдний нь дэргэд ирж зогсов.

"Тэр мөн" гэж Миледи бодов.

Тэгээд урьд өдөр Фельтоны сэтгэлийг тэгтэл хөдөлгөж хөөргөсөн нөгөөх мөргөлөө дууллаа. Бүсгүйн хүчит цээлхоолой урьд урьдынхаас илүү уянгатай үнэн сэтгэлийг илэрхийлэн хангинавч үүд нээгдсэнгүй. Миледи үүдний жижиг цонх руу сэмхэн хяламхийн харвал нарийн торны цаанаас залуугийн гялалзсан харц үзэгдэх мэт болсон.

Гэвч энэ үнэхээр залуугийн харц байсан уу, зүгээр тэгж санагдсан уу Миледи мэдэж чадсангүй. Залуу энэ удаа биеэ барьж өрөөнд оролгүй өнгөрөв.

Гэвч Миледиг дуулж гүйцсэний дараахан хүн гүнээ санаа алдах болоод түрүүчийн гарсан хөлийн чимээ цаашаа дуртай дургүй явах мэт алгуур холдох нь сонсогдлоо.

LV. ХОРИГДСОНЫ ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

Дараа өдөр Фельтоныг өрөөнд орж ирэхэд Миледи зөөлөн сандал дээр гарч зогсоод, нарийн торон алчуур цуулж томоод гогцоолдож барьсан байгаа харагдлаа. Фельтоны үүд нээх чимээгээр Миледи сандал дээрээс хөнгөхнөө үсрэн бууж олс болгож томсон юмаа ардаа нуухыг оролдов.

Залуугийн царай ердийнхөөсөө цонхигор, нойр алдаж нүд нь улайсныг үзвэл шөнө тавтай өнгөрөөсөнгүй гэдэг илт байв. Гэхдээ байдлыг ажиглавал цаашид хэлбэршгүй тэвчээртэй байя гэж шийдсэн царайтай,

Фельтон алгуур алхаж зөөлөн сандал дээрээ суусан Миледид дөхөж очоод, үхэл авч ирэх учиртай олсны санамсаргүй юм уу эсвэл санаатай цухуйлгасан байж мэдэх үзүүрээс барьж: - Энэ юу вэ? авхайтан? гэж асуув.

Энэ үү? юу ч биш, гэж Миледи гунигт байдал гаргаж сайн чаддаг инээмсэглэлээрээ мишээсэн болж хариулаад уйдах гэгч хоригдол хүний гол зовлон билээ. Би мөн уйдаад энэ олсыг томж зугаацсан болж байгаа юм гэв.

Миледийн сандал байсан цаад ханыг харвал, дээр нь хувцас хунир зэр зэвсэг өлгөхөд зориулан хананд зоосон алтадмал дэгээ байхыг үзээд Фельтоны бие зарс хийв. Хоригдол бүсгүйдоош харан суусан боловч юухныг ч үл алдах харцаараа үүнийг бас ажжээ.

-Та сандал дээр гарч зогсоод юу хийж байв аа? гэж Фельтон асуув.

-Та яах гэсэн юм бэ? Фельтон үүнд:

-Би мэдэх санаатай байна гэж зүтгэв.

-Үнэн Христос шажинтан бидэнд худал хэлэх цээртэй гэдгийг та мэднэ, бүү шалгаажүз.

-За тэгвэл таны юу хийсэн, нарийн яривал юу хийхээр завдаж байсныг би хэлье. Та дотроо санаж байсан хөнөөлийн муу бодлоо биелүүлэх гэж байж. Худлаа хэлэхийг бурхан хориглодог гэхэд амиа хорлохыг нэн ч хатуугаар хориглодог болохыг авхайтан та санаарай гэв.

Миледи үүнд гүнээ итгэсэн дуугаар хариу марган,

-Бурхны бүтээсэн нэг амьтан хилс хавчигдаж, нэр төрөө гутаах юм уу, амиа хорлох хоёр замын аль нэгийг сонгохоос өөр аргагүй болсныг үзээд амиа хорлосны нь нигүүлсэн үзэх болно. Тухайн учрал дээр амиа хорлосон гэдэг тарчлан үхсэнтэй чанар нэг шүү дээ гэв. -Та нэг бол хэтрүүлж байна эсвэл үгээ гүйцээж хэлэхгүй байна. Тэнгэрийг бодож бүх үнэнучраа, хэлж үз, авхайтан.

-Танд худлаа зохиосон зүйл гэж хэлүүлэхийн тулд гай зовлонгоо ярих, хавчин шахдаг хүндээ хов хүргүүлэхийн тулд санаа бодлоо гаргаж ярих гэж үү? больё доо, өршөөлт эрхэм минь! Тэгээд ч ял тулгагдсан золгүй бүсгүйн үхэх, амьд явах хоёр танд ямар хамаа байх билээ. Та

чинь миний биеийг л хариуцаж харгалзаж байгаа хүн, тийм биз дээ? Та хүүрийг минь үзүүлээд намайг мөн гэж танивал боллоо, өөр танаас юу ч нэхэхгүй. Харин ч давхар шагнал өгч магад гэхэд Фельтон дуу алдаж:

-Би юу авхайтан, би тэр үү? Таны амь насны төлөө шагнал авч чадах хүн гэж та намайг бодов уу? Та юу хэлж байгаагаа мэдэхгүй байна шүү, гэв.

Миледи улам ч улайран хөөрч:

-Над бүү саад хий Фельтон, бүү саад бол. Цэргийн хүн болгон нэр төрийг эрхэмлэдэг байх ёстой, тийм биз? Та одоо дэслэгч, цолтой миний хүүрийг үдэхдээ та ахмад цолтой болчихсон дагаж явах юм шүү! гэв

Миледийн үгэнд хэлмэгдсэн Фельтон:

-Үгүй хүн амьтан, бурхан тэнгэрийн өмнө та надад ийм их үүрэг хүлээлгэж байхаар би ямар гэм хийчихсэн хүн бэ? Хэлхэн хоногийн дараа авхайтан та энэ шилтгээнээс явна. Таны амь нас миний хамгааллаас гарна, тэр цагт амь насаа яадаг сан тааллаараа болоорой гээд санаа алдав.

Миледи гүнээ зэвүүцсэн ариун сэтгэлээ цаашид барьж чадахгүй болсон байртай. Ингэхлээр, бурхан шүтээнээс айж эмээхтэйгээ байгаа, шударга журамтан гэгдэх хүн та зөвхөн л миний амь насны хэрэгт холбогдох бий, түүнээс болж элдэв юм болох бий л гэж айж байгаа юм шив! гэж дуу алдав.

-Авхайтан таны амь насыг би хамгаалах учиртай, хамгаалж чадах ч байх.

-Үгүй та ямар шүү үүрэг гүйцэтгэж байгаагаа мэдэж байна уу? Таны хийж байгаа энэ зүйл чинь, намайг буруутай байлаа ч гэсэн хатуу харгис хэрэг, би гэмгүй байлаа гэвэл та ингэж байгаагаа юу гэж нэрлэх вэ?

-Авхайтан минь, би цэргийн хүн, авсан тушаалаа биелүүлж байна гэв.

-Эрлэгийн шүүхэд очих өдөр болоод ирэхээр, шударга бус явдалт шүүгч, нар болон, тэдний үгийг сохроор дагасан алуурчин нарын гэм нүглийг бурхан ялган салгана гэж бодож байна уу? Намайг биеэ хөнөөхөд та саад болж байна. Үүгээр миний сүнсийг хөнөөх гэсэн хүмүүсийн хорон санааг та гүйцэтгэгч болж байна! гэсэнд, нэгэнт эргэлзэж эхэлсэн Фельтон хариу өгүүлрүүн:

-Танд ямар ч аюул тулгарч байгаа юм үгүй, Винтер гуайн хувьд би өөр шигээ сайн итгэж байгааг танд дахин хэлье, гэхэд Миледи дуу алдан:

-Мунхаг хүнээ! Хамгаас ухаантай, бурханд илүү таалалтай хүмүүс өөрөө өөрсдийнхөө хувьд батлан хэлж чаддаггүй атал бусдын төлөө батлан амладаг хүн үнэхээр мунхаг аа! Мөн жаргалдаа ташууран, хүч чадалтай яваагийн талыг барьж золгүй дорой бүсгүйг хавчин шахах гэсэн хүн бас мунхаг аа! гэв.

Дотроо энэ үгийн аргагүй шударгыг хүлээн зөвшөөрсөн Фельтон дуулдах төдий, арга алга авхайтан болохгүй. Та хоригдол ахуй цагтаа миний хамсаатайгаар эрх чөлөөтэй болохгүй, амьд ахуй цагтаа миний өөдгүйгээс болж амиа алдахгүй гэв.

-Тиймээ, гэхдээ би аминаасаа илүү чухаг юмаа, нэртөрөө алдах болно шүү дээ! Тэгээд ичиж улайх, бузар булайд хүрэх болсныхоо нүглийг хүн амьтан, бурхан шүтээний өмнө Фельтон танд үүрүүлнэ дээ! гэж Миледи хашгирав.

Фельтон хэдий төвшин төлөв аль тийм байхыг үнэхээр хичээж байсан ч гэсэн энэ удаа нэгэнт өөрий нь татаж дагуулж эхэлсэн далдын хүчний эсрэг зогсож дийлсэнгүй. Хий үзэгдэл мэт хөнгөн гуа сайхан цэвэр ариун энэ бүсгүйн нэг уйлж, нэг занаж байхыг харахын хамт гуа үзэсгэлэн болон гунигийн нь ихэд сэтгэл булаагдсан байх гэдэг элдвийг санаашрагч хүнд даанч бэрх. Сүсэг бишрэлд хэт авгаж хөөрсөн оюун ухаантай хүнд хүмүүсийг голоосоо үзэн ядаж, бурханд голоосоо бишрэн мөргөж явдаг сэтгэлтэй хүнд даанч бэрх байжээ. Залуугийн сэтгэл ийнхүү үймэхийг, энэ сүсэгтэн залуугийн сэтгэлд шунал тачаалын гал дүрэлзэн бийг Миледи зөнгөөрөө гадарлаж мэдээд, дайсан ухрах шахаж байгааг мэдсэн чадамгай жанжин хүн уухайлан дайрахын үлгэрээр эрт цагийн удган, христос шажны гуа дагина мэт үзэсгэлэн жавхаа төгс босч зогсоход хүзүү нь нүцгэрэн ил гарч, үс нь задраад нүдэнд нь залуугийн зүрхийг түрүүнд догдлуулж байсан нөгөө гал цог гялсхийв

Миледи нэг гараар хувцсаа элгэн дээрээ ичингүйрэх байртай тогтоон барьж, нөгөө гараа урагш сунган залуугийн өөдөөс дөхөж хэрэгтэй үед уур хилэн, тачаалын өнгө оруулж чаддаг урсгал сайхан хоолойгоороо мөргөл эхлэн

Ваалын ам руу золиосонд гаргаснаа чулууд,

Зовлонт хөрөхийг арслангийн аманд хаяж өг.

Дээд бурхан өшөөг авна.

Тамын ёроолоос би мөргөн залбирсан гэж дуулав. Ийм хачин яриагаар хандаж хэлэхийг сонсоод Фельтон цочирдон алмайрчихлаа.

Тэгээд алгаа хавсран залбирч та хэн гэгч вэ?, юун хүн бэ? Дээд тэнгэрийн элч үү, тамын эрлэг үү, дагина уу шулам уу, таны нэр элоа юу, Астрат уу? гэж дуу алдах нь гуйж мөрөөдсөн өнгөтэй. -Фельтон чи намайг таньсангүй гэж үү? Би дагина ч биш шулам ч биш, би хорвоод төрсөн чамтай сүсэг нэгтэй бүсгүй байна.

-Тиймээ тэгж таарна! Би эргэлзээд байсан юм, одоо би итгэж байна.

-Чи итгэж байна. Гэтэл тэр Велиалын шийр болсон Винтер гэгчийн хамсаатан болж байна! Чи итгэж байна, гэтэл намайг миний дайсан Английн дайсан, шажин номын дайсны гарт үлдээж байна! Чи итгэж байна, тэгсэн мөртлөө, буруу ном шүтэж завхай зайданявдгаараа хорвоог бузарлаж байгаа булай амьтан болсон Бекингэм герцог, үнэн сүсэгтэнд буруу номтон гэгддэг этгээдэд барьж өгч байна.

-Таныг би Бекингэмд барьж өгч байна гэж үү? Би тэр үү? Та юун юм ярьж байнаа? -Нүдтэй байж харахгүй! чихтэй байж сонсохгүй гэж Миледи дуу алдлаа.

-Тийм тийм, гээд Фельтон эргэлзэх сэтгэлээ үр хөрөнгөөр нь аваад хаячхав гэсэн шиг хөлс дааварласан магнайгаа арчаад тийм ээ нойрон дунд дуудаад байдаг дуу мөн байна. Тиймээ, шөнө болгон над үзэгдэж миний унтахыг үл мэдэх сүнсэнд минь "үгүй хий, Англи орныг авар, өөрийгөө авар, эс тэгвэл чи бурхан шүтээнийг хилэгнүүлээд үхэж арилна" гэж чанга хэлээд байдаг дагинын дүрийг таньж байна. Ярь, ярь, би таны үгийг одоо ойлгох боллоо гэж Фельтон дуу алдав.

Миледийн нүдэнд гялбах цахилгаан мэт зүрх алдам их баярын гал агшин зуур дүрс хийгээд унтрав.

Энэ дүрсхийсэн баярын аймшигт гал хэдий хурамхан зуур тодроод өнгөрсөн боловч Фельтон ажиж амжаад, энэ бүсгүйн сэтгэл зүрхний ёроолгүй харанхуйг тэр галгийгүүлээд орхих мэт санагдаж хамаг бие нь арзас хийлээ. Хүний сэтгэлийг татах Миледийн чадварын талаар Винтер гуайн урьдчилан сануулж байсан зүйл болон сэтгэлийг нь татахаар Миледийн анхны үед явуулж байсан ов арга гэнэт санаанд нь орж Фельтон гэдрэг болон толгойгоо унжуулав. Тэхдээ энэ хачин бүсгүйд илбэдүүлсэн мэт өөдөөс нь харсаар, харцаа салгаж чадахгүй байлаа. Фельтон сэтгэл яагаад тээнэгэлзэж байгааг Миледи зөв ухаж чадахуйц ажигч ухаалаг хүн өнгөндөө сэтгэл хөдөлсөн мэт дүр үзүүлэвч сэтгэл нь цэвдэг хянуур хэвээр л байсан билээ. Фельтоныг дахин ам нээж түрүүчийн сэтгэл хөдөлгөсөн яриаг цааш үргэлжлэхэд хүргэхээс нааш тэгж ярих одоо хүнд болохыг Миледи мэдээд бүсгүй хүний дорой зандаа хөөрүү сэтгэлнь дийлдсэн мэт гараа унжуулан урвайв.

-Үгүй, Олоферийн гараас Ветулийг чөлөөлдөг Юдифь байж би дийлэхгүй нь бурхан дээдсийн илд миний гарт дэндүү хүнддээд даахгүй юм байна. Нэрээ бузарлуулахгүйн тулд амиа тэвчиж, зовж тонилсноор сүнсээ аврахад минь бүү тотгор хий! Танаас би гэмт хэрэг үйлдсэн хүн шиг суллаж өгөхийг гуйхгүй, буруу номтны адилөшөө авч өгөхийг хүсэхгүй үхэхэд минь л бүү саад бол, тэгвэл гүйцлээ. Танаас сөхрөн байж гуйя, надад үхэх боломж хайрла голоо тасрахад би авралт хүн таны төлөө залбирсаар амьсгаа хураана гэж Миледи хэллээ.

Энэ гуйж царайчилсан намуун дууг сонсож, айж хулгасан өрөвдмөөр харцыг хараад Фельтон дахин бүсгүй рүү дөхөв.

Бүсгүй аажмаар нөгөө сэтгэл булаасан дүрээ олж түүнийгээ өөрийн дураар нэг нүдэнд тусган харуулснаа нуучхаж байв. Гуа царай хүлцэнгүй номхон байр, нулимс болон сэтгэл үл автахын эрхгүй тачаал хөдөлгөсөн хамгаас хөнөөлтэй нэг ондоо байдал эд бүгд нийлж бүсгүйг тэгж сэтгэлд татахуйц болгодог ажээ.

-Яая гэх вэ? Та хилс тарчилж байгаа гэдгээ нотолж өглөө гэхэд би зөвхөн өрөвдөхөөс цаашгүй! Гэтэл Винтер гуай танд хүнд ял тулгаж байх юм. Та христос шажин шүтэгч, надтай нэгэн сүсэгтэй хүн байна. Амьдралын туршид ач тус болсон энэ сайхан хүнээс өөр хэнд ч сайн байж үзээгүй, энэ завсар урваж хувирсан бузар муу явдалтнаас өөр хэнтэй ч дайралдаж яваагүй хүн би өөрөө танд сэтгэл татагдаад байх боллоо. Гэтэл авхайтан та ийм гуа сайхан, харвал тун ч гэм хоргүй байртай хүн! Винтер гуайд ингэтэл өшигдсөнийг үзвэл лав нэг хуульд

харш юм хийгээ бизээ гэж Фельтон өгүүлэв.

Миледи үүнд гүнээ гашуудсан дуугаар чихтэй байж үл дуулах нүдтэй байж үл үзэх гэж давгаж хэллээ.

-Үгүй тийм юм бол ярь л даа ярь! гэж залуу дарга дуу алдав. Миледи ичсэн байдлаар царайгаа улайлгаад шившгээ танд тоочих гэж үү? Үгүй, нэгэн этгээдийн үйлдсэнгэмт хэрэг нөгөө хүнийг бузарлах явдал олон байдаг шүү дээ. Бүсгүй хүн би бузарлуулсан шившгээ танд зр хүнд тоочих гэж үү! гэж сайхан нүдээ ичингүйрэх янзтай гараараа дарж үгүй энэ тухай би хэзээ ч яасан ч ярьж чадахгүй гэв.

-Ах дүү шиг чинь болсон над ч тэр үү? гэж Фельтон дуугарав.

Миледи өөдөөс нь залуу даргад эргэлзэж байгаа юм байна гэж бодогдохоор удтал ширтэв. Чухамдаа Миледи зөвхөн өөрий нь ажиж, сэтгэлийг нь татъя гэснээс цаашгүй.

Фельтон гуйж аргадах байртай гараа сарвайхад, Миледи хариуд нь:

-За яахав, ахдаа би итгэе. Би зүрх гаргая гэлээ.

Энэ үеэр Винтер гуайн хөлийн чимээ гарлаа. Миледийн зүрхийг базсан хадам ах нь энэ удаа түрүүчийн адил үүдний дэргэдүүр яваад өнгөрсөнгүй, зогсож харуулын хүнтэй хэд гурван үг солиод орж ирэв. Үүдний цаана тэгж үг солилцох жаахан чөлөөнд Фельтон яаран зайлж амжаад Винтер гуайг орж ирэхэд Миледигээс хэдэн алхмын зайтай зогсож байв.

Бээл алгуурхан орж ирээд хоригдол бүсгүй, залуу хоёрыг хянуур туршин харлаа.

-Жон та энд баахан удах чинь. Энэ бүсгүй танд үйлдсэн гэмт хэргүүдээ ярьж байгаа юм биш биз? Тэгвэл ч та нарын яриа ингэтэл удаан үргэлжилж байгаад би гайхахгүйсэн гэж Винтер бээл өгүүлэв.

Фельтоны бие арзасхийв. Миледи ч мөн энэ хэлмэгдэж орхисон хамсаатандаа тус болохгүй бол өөрөө сүйд боллоо гэдгийг ойлголоо.

-Уухай та хоригдол бүсгүйгээ гараас мултраад явчих бий гэж айв уу? Та наад болсон зохисон хуягаасаа миний ямар өршөөл үзүүлэхийг гуйж байсныг асуу л даа гэж Миледи өгүүллээ. Бээл сэжиг авч, та өршөөл гуйж байсан гэнээ? гэхэд зовж мэгдсэн залуу-тийм ээ Милорд гуай гэж батлав.

-Ямар өршөөл үзүүлэхийг гуйгаа вэ? гэж Винтер гуай асуухад, Фельтон хариу өчиж: -Намайг нэг хутга өгөөч гэж гуйгаад, нэг мөчийн дараа үүдний жижиг нүхээр эргүүлж өгөхийг амласан юм гэлээ.

Винтер гуай ердийнхөө элэг барьсан жигшингүй байраар, үгүй тэгээд энэ хөөрхөн бүсгүйд алуулах хүн энд нуугдаж байгаа юм гэж үү? гэж асуулаа.

-Энд бас байгаа юм гэж Миледи хариу дуугарлаа.

-Таныг би Америк юм уу Рабери хоёрын дуртайгаа шилж ав гэсэн. Миледи та Райберид оч л доо. Хутганд орохноо, олс илүү найдвартай даг, миний үгэнд итгэ гэж Винтер гуай өгүүллээ. Фельтоны царай зэвхийрч, орж ирэх үед нь Миледи олс барьж байсныг санаад урагшаа алхав. Таны хэлдэг үнээн, би энэ тухай бодсон гэж Миледи хэлээд бөглөрсөн дуугаар, би дахин бодъё гэв.

Фельтон хамаг биеэ дагжин чичрэхийг мэдэв, ингэж дагжин хөдөлснийг Винтер гуай ч мөн андалгүй ажсан бололтой.

Үүнд бүү итгэ Жон. Сайн нөхөр Жон минь, би чамд итгэмжилсэн, хянуур байж үз. Би урьдаас сэрэмжлэн сануулсан шүү. Үгүй ингэхэд гурав хоноод бид энэ хүнээс ангижирна, зоригоо чангал, миний явуулах тэр газраас энэ бүсгүй хэнд ч хор хүргэж чадахгүй болно гэж Винтер гуай хэллээ.

Дуулж байна уу та минь гэж Миледи чангаар луу алдахдаа Винтер гуайд бурханд залбиран дуудаж байх мэт санагдахаар боловч Фельтон өөртөө хэлж байгааг ойлгов.

Фельтон толгойгоо унжуулан бодолд автлаа.

Бээл залуу даргыг сугадаж үүд рүү явах зуураа гаран гартлаа Миледиг эргэж харсаар явлаа. Тэднийг гарч үүд хаагдмагц Миледи дотроо бодсон нь:

" Миний хэрэг санасантай минь адил их урагш олоогүй юм байна. Винтер ердийнхөө тэнэг аашийг орхиж үзэгдээгүй их хянуур загнаж байна. Өшөө авахын шунал гэдэг ийм хүчтэй, хүний зан төлөвийг ингэж нарийн болгодог юмаа! Үгүй Фельтон, ингэхэд Фельтон тээнэгэлзэж байна. Энэ чинь нөгөө хараал идсэн д'Артаньян шиг хүн биш юм л даа золиг. Пуритан сүсэгтэн зөвхөн охин хэвээрээ байгаа бүсгүйчүүлийг хүндлэн сүйд болж, тэхдээ бас залбирч, хараад л бахдаж суух дуртай, шадар цэрэг эр гэдэг бүсгүй хүнтэй янагладаг, тэхдээ тэвэрч аваад янагладаг юм" гэж бодов оо.

Гэхдээ Фельтоны буцаж ирэхийг Миледи тэсч ядан хүлээнэ. Энэ өдөртөө түүнтэй дахин уулзана гэдгийг сайн мэдэжбайлаа. Тэгж тэгж энэ явдлаас хойш цаг болсны дараа үүдний дэргэд хүн аяархан ярилцах чимээ гараад үүд нээгдэж Фельтон орж ирлээ.

Залуу үүд дутуу онгойлгож орхиод бушуухан орж ирснээ Миледид дуугүй бай гэж дохив. Царай байдал нь тун, ч их хэлмэгдсэн байртай.

-Та юу гэж ирэв? гэж Миледи асуулаа.

Фельтон нам дуугаар, миний ирснийг хэн ч бүү мэдэг. бидний яриаг хүн бүү чагнаг гэж харуулын хүнийг холдуулж орхисон. Бээл надад сая аймаар муухай юм ярьж өглөө Миледи үүнд хүний эрхшээлд автсан ноомой хүлцэнгүй байдлаар инээмсэглэн толгой сэгсрэв.

Фельтон цаашаа нэг бол та шулам, эсвэл миний ачит хүн эцэг болгон бээл өөрөө бузар булай амьтан. Би таныг дөнгөж дөрөвхөн өдөр харж байна, гэтэл бээлд сайн болоод даруй хоёр жил болж байгаа юм. Тэхлээр та хоёрын нэгийг шилж авахдаа миний эргэлзэж байгаа нь аргагүй.

Миний үгнээс бүү ай. Таны үнэнээ хэлж байгаад би үнэмших учиртай өнөө шөнө дундаас хойно би ирнэ. Та тэгээд надад итгүүлж үз, гэсэнд Миледи,

-Үгүй Фельтон, үгүй, та дэндүү их өгөөмөр сэтгэл гаргаж байна. Энэ явдал өөрт чинь хичнээн их бэрх болохыг би мэдэж байна. Үгүй, би өнгөрлөө. Өөрийгөө бүү надтай цуг хөнөө. Миний үхэл, амьд байгаагаасаа илүү ойлгомжтой болж, дуугүй болсон хүүрийг харахад та хоригдол бүсгүйн үг сонссоноос илүү итгэж үнэмшинэ гэв.

-Авхайтан та дуугүй байгаач!

Над ийм үг бүү ярь! Таныг аминдаа хор хүргэхгүй гэж амлаж, ариун гэгээн юм бүхнийхээ нэрийг барьж андгай тангаргаа өгөг гэж би ирсэн юм гэж Фельтон дуу алдсанд Миледи: -Би амлахгүй. Тангаргаа над шиг хүндэлдэг хүн байхгүй. Би нэг амлавал хэлсэндээ хүрэх хэрэг болно гэж хариулав.

-Тэгвэл ядаж бид дахин уулзтал амиа тэвчихгүй гэж амла. Надтай дахин уулзсанаасаа хойш саналаараа болно гэж зүтгээд байх юм бол одоо яая гэх вэ, та дураараа л болохоос Тэгээд таны гуйсан зэвсгийг би өөрөө өгөмз.

-За, таныг бодож хүлээе.

-Андгайл.

-Тэнгэрийнхээ нэрээр андгайлья. Болов уу?

-Боллоо. Шөнө болохоор уулзъя, Фельтон тэгээд тасалгаанаас харайн гарч, хаалга түгжээд, харуулын цэргийг орлон гартаа цэрэг жад барьж зогсоод хүлээв.

Цэргийг буцаж ирэхэд Фельтон зэвсгийг нь буцааж өгөв. Миледи үүдний цонх руу очоод Фельтоны хичнээн сэтгэл; хөөрөн залбирч, гудмаар бөөн баяр хөөртэй цаашлахыг харав. Миледи байрандаа буцаж ирээд уруулд нь хорон инээд гарч, бурханд сүсэглэхийг ер үл мэдэх тул саяхан андгайлсан бурхны нэрийг дахин дурсч:

-Миний бурхан гэнээ? Тэнэг солиотой амьтан. Миний бурхан бол би өөрөө, өшөөгөө авахад минь туслах тэр хүн хоёр юм гэв.

LVI. ХОРИГДСОНЫ ТАВ ДАХЬ ӨДӨР

Тэр зуур Миледи ялалтын дунд нь хүрээд, амжилт олсондоо давхар хүчтэй болов. Миледийн өнөө болтол хийж ирсэнчлэн, наалдаж налигнахад нь амарханавтдаг, ордны хээнцэр ёсорхог байдлын нь урьханд амархан ордог улсыг дийлэхэд төвөггүй байжээ. Миледи эрэгтэйчүүдийг эрхэндээ оруулахад бие махбодын талаар саатах юмгүй гуа сайхан, сэтгэл санааны саадыг амархан давж чадах овтой хүн билээ.

Гэтэл энэ удаа зэрлэг, зожиг ганцаардмал, биеэ нанчин зовоодгийн учир хэнэггүй хүнтэй үзэлцэхэд хүрчээ. Фельтон шашинд сүсэглэсэн ёс хатуутай хүнболохоор ерийн налигнахад автхааргүй байжээ. Түүний хөөрүү ухаанд өдий төдий өргөн уудам төлөвлөгөө, сэтгэл үймрүүлсэн бодол төрдөг болохоор, дэмий сул сууж, ёс суртахуун алдан завхрахын нөлөөнд гарч ирдэг тачаангуй хүсэл зуурдын янаг амрагийн учралын тухай бодол төрөх зай, зав байдаггүй аж. Миледи буянт хүний хуурамч дүр үзүүлэн, өөрийг нь буруут гэж лавтай бодож байсан хүнд эргэлзэх сэтгэл төрүүлээд, ариун цагаан санаатай голч шударга хүний сэтгэл зүрхийг гуа үзэмжээрээ эрхэндээ оруулан үймүүллээ. Ингээд л байгаль ертөнц, бурхны бүтээж чадах хамгийн зөрүүд амьтан дээр хүчээ сорьж үзэх болоход Миледи өөрөө ч урьд нь мэдээгүй байсан хамаг чадал авьяасаа уудлан гаргаж ирлээ.

Хэдий тийм боловч Миледи тэр оройдоо хувь заяандаа цөхөрч биедээ гутраад, бурхнаас туслан тэтгэхийг гуйгаагүй ч муу зүгийн хүчнээс туслахыг гуйж байлаа. Муу зүгийн юм гэгч хүний амьдралын өчүүхэн илрэлийг хөтөлж, араб үлгэрт гардгаар хумсын чинээ юмаар нүгэлт бүхэл ертөнц бүтээж чадах лут хүчтэй байдаг ажээ. Фельтоныг дахиад ирэхэд яаж байхыгаа Миледи нарийвчлан бодож, сайн бэлтгэв.

Өөрт нь дөнгөж хоёр өдөр үлдэж байгаа. Тушаалд Бекингэм гарын үсэг зураад орхихын хамт (тушаалд өөр нэр тавьсан болохоор юун бүсгүйн тухай хэрэг болохыг Бекингэм мэдэхгүй, лавтай гарын үсэг зурна), давтан хэлэхэд гарын үсэг зурагдахын хамт бээл өөрий нь даруй явуулна гэдгийг Миледи мэдэж байлаа. Мөн цөлөгдөж яваа бүсгүй хүн олны дотор шударга журамтанд тооцогдож, төрөлхийн гуа сайхан нь ихэс дээдсийн эрх сүрээр дэмжигдэж, өндөр язгуур гарлын амтлаг туяагаар чимэгдсэн бүсгүйгээс хүний сэтгэлийг татан булаахаргаар хомс байна гэдгийг бас мэдэж байв.

Гутамшигт цээрлэл хүлээснээр бүсгүй хүний өнгө царай гутчихгүй хэдий боловч дахин эрх сүртэй больё гэхэд давшгүй саад болдог юм Миледи үнэхээр оюун билэг төгс хүмүүсийн нэг мөний тулд төрх галбираараа чухам ямар шүү газар байж сайн таарахаа мэддэг байлаа. Ядуу зүдүү байдал жигшил төрүүлж, доромжлогдон муулагдсанаар сүр жавхааны ихэнх хувь үгүйсэх байлаа. Миледи зөвхөн хатдын дунд хатан байж чадахуйц эрх сүртэй байна гэхэд өөрий нь бардам сэтгэл ханасан байвал зохих хүн билээ. Дорд өчүүхэн хүмүүсийг захирах гэвэл Миледид гутамшигтай санагдахаас биш, хангамжтай санагдахгүй юм.

Цөллөгөөс эргээд ирж чадна гэж Миледи минутын төдий ч эргэлзэх нь үгүй хэдий гэлээч энэ цөллөг хэдий хир их удах бол? Миледи шиг махруу, эрх мэдэлд дуртай хүмүүст дээшилж дэвшээгүй өдөр бүр золгүй муу өдөр шиг санагддаг гэвэл, доромжлуулж, доройтон бий өдрүүд ямар шүү санагдахыг гаргаж хэлэх үг байх уу? Жил, хоёр жил, гурван жил алдана

гэдэг цаглашгүй их хугацаа алдана гэсэн үг. д'Артаньян нөхөдтэйгөө дийлж бахдан, жаргалтай сайхан болж эзэн хатнаас болсон зохисон шагналаа хүртсэн хойно эргэж ирэх гэж үү. Эд бүгд цөм Миледи шиг бүсгүйд тэсэхийн эрхгүй санагдах бодол аж.

Гэхдээ сэтгэл нь ийнхүү үймрэн шимширснээр бүсгүйн хүч чадал хувь илүү чангарч биеийн нь хүч тамир эгшин зуур ч болов оюун ухааны нь хир чинээтэй тэнцэж чаддагсан бол гяндангийнхаа ханыг цөм түлхээд гарахаар ажээ. Эд бүгдийн нөгөөтэйгүүр Хамба ламтны тухай бодол бас Миледиг шаналгана. Өнөө цагт өөрий нь ганц өмөг түшиг, тулгуур болж байгаагаар барахгүй ирээдүйд өшөөгөө авч, жаргахын гол зэвсэг болж өгөх учиртай, энэ хартай, хүнд үл итгэгч, адгуу Хамба ламтан Миледийн ийнхүү таг чиг байгаагюугаар тайлбарлаж, юу бодож байх ёстой вэ? Хамбын занг Миледи андахгүй мэднэ. Бүтэлгүй явж ирээд, шорон гянданд сууж, элдэв зовлон үзсэнээ түүнд хэдий учирлаж тоочоод хэрэггүй, эрх мэдэл оюун ухаан өндөртэй, цэвдэг сэтгэлт хүний ёсоор өөдөөс нь "бүтэлгүйтэхийн хэрэггүй л байж дээ" гэж тайвнаар тохуурхан хэлэх хүн гэдгийг мэддэг байв.

Ийм үед, ийнхүү ёроолд нь унасан энэ тамын дотор өчүүхэн ганц горьдлого төдий санагдах Фельтоны нэрийг Миледи амандаа үглэн хамаг хүч чадлаа шавхана. Тэгээд хүч чадлаа шалган нэг зангирч нэг сулран байх могой мэтээр Миледи овжин сэргэг ухаанаараа Фельтоныг хийдүүлэх элдэв арга сүвэгчилнэ. Цаг өнгөрсөөр нэг нь нөгөөгөө даган улирах далимандаа сүмийн хонхны зэсхэлийг хөдөлгөх мэт, санагдан хонхны дуу бүр хоригдол бүсгүйн зүрхэнд шаналаан төрүүлнэ.

Винтер гуай есөн цагт ирж, ердийнхөө заншлаар цонх, сараалжны бэх бат, үүд, хана, шал зуух, хаалга сэлтийн бүрэн бүтнийг удтал нягтлан үзэх тэр зуур Винтер Миледи хоёр нэг ч үг дуугарсангүй.

Байдал нэн хурцдаж, хий уур хилэн, дэмий үг яриагаар цаг алдахын эрхгүй болсныг энэ хоёрын аль алин нь нэгэнт ойлгож байх мэт. Бээл тэгээд Миледийн өрөөнөөс гарахдаа үгүй энэ шөнөдөө та оргочхож арай амжихгүй дэг гэв. Арван цагт Фельтон хуягууд солилцуулахаар ирснийг Миледи алхаагаар нь танилаа. Сэтгэлтэй болсон бүсгүй, сайн хүнийхээ алхааг таних болдогчлон Фельтоны алхааг Миледи андахгүй болсон боловч чухамдаа сүсэг бишрэлд автсан тэр муу эрийг Миледи үзэн яддаг аж.

Болзсон цаг болоогүй болохоор Фельтон орж ирсэнгүй. Хоёр цагийн дараа шөнө дунд болох үед Фельтон дахин ирж хуяг халалцууллаа. Энэ удаа болзсон цаг нэгэнт болсон болохоор Миледи тэсч ядан хүлээв. Манааны шинэ хүн, гудмаар хойш урагш холхино.

Арван минут өнгөртөл Фельтоны алхаа дуулдсанд Миледи чих тавин чагнав. Залуу дарга ирж хуягт,

-Чи сонсож бай, энэ үүдний эндээс ямар ч шалтгаар бүү холд өнгөрсөн шөнө нэг цэргийг харуулын байраа минутын төдий орхилоо гэж Винтер бээл цээрлүүлснийг мэдсэн биз. Тэр цэргийн түр холдох хооронд нь өөрөө оронд нь манаж байсан юм шүү гэх нь дуулдав.

Цэргийн хүн үүнд, тийм ээ, үүнийг би дуулсан гэв.

Фельтон цаашаа, маш чанд харгалзахыг чамд тушаая. Би өөрөө ийшээ орж энэ бүсгүйн өрөөг дахин нэг сайн нягталъя. Энэ хүн амиа хорлох муу санааөвөрлөөд байна уу гэж санагдана, би ажиглаж харах үүрэг авсан хүн гэв.

-Их сайн, чанд сүсэгт хүн маань худлаа хэлж эхэлж байх шив гэж Миледи шивнэлээ. Цэргийн хүн зөвхөн хариу инээмсэглээд:

-Чөтгөр алгад, бээлтэн тийм тушаал өгсөнд ялангуяа Миледийн өвөрт нь орохыг зөвшөөрсөн бол гомдох юм танд алгаа дэслэгч гуай гэв. Өөр цагт бол цэргийн хүнийг ингэж эрээ цээргүй үг хэлсэнд Фельтон хатуу зэмлэх байсан боловч энэ удаа сэтгэл зовоод юм хэлж зүрхлэхээргүй байсан болохоор царай нь улайж орхив.

-Намайг дуудвал ороорой, мөн ялгаагүй хэн нэг хүн ирвэл намайг дууд гэсэнд цэргийн хүн хариуд нь:

-Сонслоо, эрхэм дэслэгчээ гэв.

Фельтон Миледийн өрөөнд орж Миледи угтан босоод:

-Та юу? гэв.

-Би ирнэ гэж танд ам өгсөн, тэгээд ирлээ.

-Та бас өөр нэг юм амласан шүү дээ.

Залуу дарга хэдий биеэ барьж сурсан хүн гэвч юу тэр билээ. Бурхан минь! гэхдээ өвдөг нь чичирч магнай дээгүүр нь хүйтэн хөлс чийхарчээ.

-Та хутга авч ирээд яриа дууссаны дараа өгнө гэсэн.

-Авхайтан та тэр тухай бүү дурс!

Зовлон хэдий хүнд байлаа ч гэсэн бурхнаас заяасан амьтан амиа хорлох нь зөв гэхээр тийм зовлон байж болохгүй. Би бодож үзээд, тийм их нүглийг яалаа ч гэсэн толгойдоо үүрч болшгүй юм гэж шийдсэн.

-Уухай, та бодож үзээ юу? би ч бас бодож үзээд шийдлээ гэж хоригдол бүсгүй элэг барьсан байртай инээмсэглээд суучхав.

Юу гэж шийдэв.

-Хэлсэн үгэндээ хүрдэггүй хүнд юм ярихын хэрэггүй гэдэг гэхэд Фельтон үүнд, Ээ бурхан минь! гэж шивнэв.

-Би танд юу ч хэлэхгүй, та явж болно шүү. Фельтон амласныхаа дагуу аваад ирсэн хэдий боловч хоригдол бүсгүйд, өгч зүрхлэхгүй байсан хутгыг өврөөсөө гаргаж ирээд,

хутга энэ байна даа! гэв.

-Алив надад үзүүлээч.

-Яах юм?,

-Би бүр андгайлъя, даруйхан танд эргүүлж өгнө.

Та наад хутгаа энэ ширээн дээр тавьчаадөөрөө наана нь зогс л доо.

Фельтон хутгаа өгсөнд Миледи ирийг нь хуруундаа хүргэж сайтар үзэв. Хутгыг залуу даргад эргүүлж өгөөд,

-За сайн, энэ чинь сайн гантай хутга байна. Фельтон та үнэнч нөхөр юм гэлээ. Фельтон хутгыг эргүүлж аваад ярилцсан ёсоороо ширээн дээр тавилаа. Миледи түүнийг ажин харж байгаад сэтгэл ханасан бололтой толгой дохиод:

-За одоо миний яриаг сонс гэв.

Ингэж хэлэхийн ч хэрэггүй, залуу дарга өмнө нь зогсоод Миледийн юу ярихыг шунан хүлээж байлаа.

Миледи ёсорхог гунигт байртай яриа үүсгэн, үүнийг таны бүсгүй дүү, нэг эцгээс төрсөн хүн ярьж байгаа юм гэж Фельтон та сана л даа. Би бас нас бага, гай болоход дэндүү царайлаг байхад, намайг урхинд оруулсан боловч би бууж өгсөнгүй. Миний эсрэг элдэв арга явуулгаа улам хүчтэй хийж эцэст нь хүч хэрэглэсэн боловч би даваад гарсан. Намайг бурхан шажиндаа залбиран сүсэглэдэг болохоор шүтдэг шажин тахидаг бурхны минь доромжилж гарсан боловч би зориг нугараагүй эцэстээ...гээд Миледи яриагаа таслан гашуунаар мушийв. Фельтон бүсгүйн үгийг давган, Эцэст нь, эцэст нь юу болоо вэ? гэлээ. Эцэст нь нэг орой миний тэвчээрт занг нугалж дийлэхгүй болохоороо арга хэрэглэхээр шийджээ. Тэгээд нэг орой миний уудаг усанд тамир алдруулах хүчтэй эм холиод өгсөн байж. Оройн хоол дөнгөж идээд дуустал л хамаг бие хачин хөшөөд ирлээ. Би учир мэдсэн юмгүй гэлээ ч бүүр түүр нэг айдас төрөөд, унтахгүй байх санаатай оролдов.

Би босоод цонх руу ухас хийж хүн амьтан дуудья гэтэл хөл хөшилдөж орхиод хөдөлдөггүй. Өрөөний адар доошилж ирээд бүх жингээрээ дээрээс дараад байгаа юм шиг болчихлоо. Би гараа сарвайгаад юм хэлье гэтэл хэл ээдрээд нэг эвгүй юм дуугарлаа. Хамаг биеяхын эрхгүй, хөшилдөж, унах янзтай болоод сандлаас бариад авгал олигтой нэмэр болсонгүй төдхөн эхлээд нэг, дараа нь хоёр өвдөн дээрээ сөхөрч ойчив. Мөргөл унших гэтэл хөл хөшиж орхиж,

Миний мөргөлийг бурхан лав дуулж, тольдоогүй байх, би тэгээд үхэлтэй төстэй нойронд авгаж шалан дээр ойччихлоо.

Тэр нойрны үед юу болсон, хэдий хир удаан унтсан юм бол санаанд үлдсэн юм ер үгүй. Ганхан сэрэхэд гоё сайхан засалтай, гэрэл адраар нь нэвтрэн тусдаг дугуй өрөөнд орон дээр хэвтэж байсан, тэхдээ тэр өрөө ер үүд хаалга үгүй шорон гэхэд болмоор юм байсан.

Удтал би хаана байгаагаа ойлгож чадахгүй, дөнгөж сая танд ярьж өгсөн энэ явдлыг ухаж чадахааргүй, ухаансанаа минь дийлдэшгүй хүнд нойрноос сэрж ядаж байсан. Сүйхээр явж байсан шиг айхтар муухайгаар хар дарах адил нэг хэцүү юм болсон мэт там тум байв.

Тэр бүгд надад өөрий минь биш. Өөр бусадтай болж байгаа мэт хачин, би өөрөө хоёр хүн болоод, хуваагдаж орхисон. мэт. Тэгээд энэ нь болсон ч юм шиг, санагдсан ч юм шиг саармаг болчихсон юм. Миний тэр хоёрдмол байдал хэсэг зуур тун хачин санагдаад, бүх явдлыг би зүүдлээд байгаа юм шиг байж билээ... Би гуйвж дайвсаар бослоо. Миний хувцас орны хажууд сандал дээр байх боловч би яаж хувцсаа тайлж хэвтсэнээ санахгүй байсан. Тэгтэл ухаан бага багаар тодорч ирээд бүх үнэн булай явдал санаанд орж гэрээсээ өөр газар байгаагаа мэдлээ. Өрөөнд нэвтэрч байгаа нарны гэрлийн байдлаар бол нар жаргах дөхөжбайх бололтой, гэтэл би урьд орой нь унтсан хүн, бүтэн хоног хиртэй ингэж байсан байх нээ. Энэ урт удаан нойрны үеэр юу болсон бол?

Би чадах хирээрээ яаран хувцаслалаа. Хөдөлж барья гэхээс хөшилдөөд нойрны эмийн хор сайн гарч чадаагүй нь илт байв. Өрөөний засал чимэглэлийн байрыг харвал бүсгүй хүн хүлээж авахад зориулсан бололтой ямар ч их маягтай бүсгүй байлаа гэсэн өрөөг эргэцүүлж үзээд хэлэх өө олохгүйгээр аж. Тэр сайхан шоронд хоригдож үзэж байгаа бүсгүй ганц би биш гэдэг эргэлзээгүй. Тэр шоронгийн байдал хэдий тансаг баян болох тусам миний айдас улам их хүрч байсныг Фельтон чи гадарлаж байгаа биз? Тэр өрөө ёстой битүү гяндан мөнбайлаа, юу гэвэл би түүнээс гараад явчих санаатай бүх ханыг нь үзэж тогшиход хаана ч гэсэн хөндий нимгэн байрын дуу гарсангүй.

Гарах нүх сүв эрж би өрөөг лав хорь дахин тойрсон байх. Ингээд айж, ядарч туйлдаж гүйцээд би зөөлөн сандал дээр ойчоод өглөө. Энэ завсар нэгэнт шөнө болж, миний айх нэмэгдлээ. Сууж байсан газартаа байх уу яахаа би мэдэхгүй, тал бүрд л аюул хөнөөл нуугдаж, хөдөлж алхахын хамт л нөмрөөд авах гэж байгаа мэт санагдана. Урьд өдрөөс нь хойш би юу ч идээгүй байсан боловч, айсандаа болоод өлсөхөө ч мэдэхгүй байлаа. Цагийн багцаа мэдэхэд тус болмоор нэг ч авиа чимээ гаднаас дуулдаж өгөхгүй, оройн долоо, найман цагийн хир болов уу гэж би бодож байсан. Тэхэд намрын дунд сар байсан болохоор нэгэнт харанхуй болчихсон байлаа. Гэнэт үүд нээгдэх чимээ гарч би өөрийн эрхгүй цочив. Шилэн адрын дээд талд галт бөмбөлөг аятай харагдах дэн асч өрөөнд хурц гэрэл гарлаа. Тэгтэл миний өмнө хэдхэн алхам газар нэг хүн зогсож байв.

Хоёр хүнд зууш бэлтгэж зассан ширээ өрөөний голд илбийн юм шиг бий болчихлоо. Жил хиртэй намайг эргүүлж, миний ариун цогцсыг бузарлахаар чармайн байсан хүн болохыг таниад тэр хүслээ урьд шөнө нь хангаж авсныг амнаас нь үг цухуймагц л би мэдлээ.

-Булай новш гэж Фельтон шивнэв.

Энэ хачин яриаг залуу дарга хир их анхаарч, сэтгэл хөдөлж чагнаж байгааг Миледи үзээд:

-Нээрээ булай новш! Муухай амьтан гэж дуу алдаад нойронд автсан цагт миний бие цогцсыг эвдсэнээр хамаг хэрэг бүтнэ гэж тэр боджээ. Тэр булай хэрэг нэгэнт болж өнгөрсөн болохоор шившиглэгдэж гүйцсэнээ намайг хүлээнэ гэж тэр бодож иржээ. Тэр хүн элбэг их эд хөрөнгөөгч, хариуд нь миний хайр сэтгэлийг авах гэж ирсэн байлаа. Үүнд бүсгүй хүний

дотор багтаж болох жигшил хорслыг би түүнд гаргаж хэлсэн. Тэр хүн янз нь тиймэрхүү зэмлэл дуулж дөжирсөн бололтой элгээ эвхээд, инээмсэглэнхэн сууж миний үгийг сонсоод, зэмлэж дууслаа гэж санасан бололтой босч над руу дөхлөө шүү. Би ухасхийж ширээн дээрээсхутгаа шүүрч аваад өөрийгөө хутгалахаар зэхэж:

- "Та дахиад наашаа нэг алхвал, миний нэр төрийг бузарлаад зогсохгүй, амийг бусниулсандаа та гэмших болно шүү" гэлээ.

Миний нүдний харц дууны өнгө, биеийн байдал бүр замаа алдаж гүйцсэн хүнийг хүртэл өөрийн эрхгүй үнэмшүүлэхүйц цөхөрсөн харагдсан байх. Тэр хүн зогслоо. "Таны амийг бусниулах гэнээ? Үгүй шүү! Табол хамаг сайн сайхныг чинь дөнгөж ганцхан удаа амталж үзээд алдаж орхиж болмооргүй гойд гоц амраг бүсгүй. Баяртай гуа охин минь. Би таны ааш дээрдэхийг хүлээж байгаад ирье" гэлээ.

Ингэж хэлээд тэр хүн исгэрсэнд өрөөг гийгүүлж байсан галт бөмбөлөг дээшээ өндөр өргөгдсөөр алга боллоо. Төдхөн үүд нээгдэж хаагдах түрүүчийн адил дуу сонсогдов. Тэгтэл галт бөмбөлөг дахин бууж ирээд би ганцаараа хоцорлоо. Үнэхээр хүнд байсан шүү. Тийм зовлон учраагүй болов уу гэж горьдлого төдий юм байсан минь тасраад болсон үнэн явдлыг мэдлээ. Би зөвхөн үзэн ядах төдийгүй жигшин дургүйцдэг хүнийхээ гарт оржээ. Тэгээд ч юу ч хийхээс буцахгүй болсноо энэ хүн түрүүхэн нь ингэж аймшигтайгаар харуулсан, үнэмшүүлсэн байлаа.

-Тэр чинь хэн юм бэ? гэж Фельтон асуулаа. -Би тэр шөнийг сандал дээр сууж, өчүүхэн төдий чимээ сонсогдох бүр цочиж дагжсаар өнгөрөөлөө. Юу гэвэл шөнө дундынүед дэн унтраад би дахин харанхуйд суух болсон юм. Ашгүй тэр шөнө тарчлаагч хүн ахиж намайг хэлмэгдүүлсэн юмгүй өнгөрлөө. Өдөр боллоо, ширээ алга болж хутга л миний гарт атгаастай хэвээрээ үлдлээ.

Тэр хутга л миний ганц найдах юм болж байлаа. Би ядран туйлдаж, нойргүй хоносонд нүд хорсовч би унтаж огтхон ч зүрхлэхгүйбайлаа. Өдрийн гэрэл миний сэтгэлийг уужруулаад, орон дээр гарч, авралт хутгаа дэрэн дороо нууж орхиод унтав. Намайг дахин сэрэхэд зууш тавьсан ширээ бэлэн байж байлаа. Энэ удаа би хэдий их айж, гутарч байсан боловч сүрхий өлссөн байлаа. Би хоёр хоног юм идээгүй байсан юм. Би жаахан талх жимс идээд, усанд нойрны эм хольсон байсныг санаж ширээн дээр байсан уснаас уусангүй, хананд нүүр гар угаах савны дээрээс гантиг чулуунаас гоожиж байсан уснаас алгаа дүүргэж уусан.

Ингэж сэрэмжилсэн хэдий боловч эхлээд би айхтар их зовж байсан, харин энэ удаа би дэмий сэжиглэсэн байжээ. Өдөр өнгөрлөө. Миний айж байсанчлан биед элдэв юм болсон шинж ер мэдэгдсэнгүй. Ингэж сэжиглэсэн шинж авахуулахгүй гэж би савтай усны хагасыг нь асгаж орхисон.

Орой харанхуй болсон боловч миний нүд харанхуйд дасаад, харанхуйд ширээ доошоо алга болоод өгснөө мөчийн дараа оройн хоол тавьж бэлтгэсэн гарч ирэхийг харанхуйд харж чадсан. Төдхөн нөгөө бөмбөлөг дэн бууж ирээд өрөө гэрэлтэв.

Би нойрны эм хольж болохооргүй л юмнаас өөр юу ч идэхгүй гэж шийдлээ. Оройн хоол гэж

би ердөө хоёр өндөг жаахан жимс идсэн. Ингээд нөгөө ачтай сайн гоожуураасаа нэг аяга ус аваад уучихлаа.

Дөнгөж балгатал усны амт өглөөнийхөөсөө нэг өөр юм шиг оргиод явчихсан. Надад хардах сэтгэл төрж , цаашаа уухаа больсон, гэтэл би аяганы дундуур хир ус уучихсан байсан. Усныүлдэгдлийг би сэжиглэж асгаад хүйтэн хөлс даасаар хойч нь юу болохыг хүлээлээ.

Лав далдаас ажиж байсан нэг хүн миний гоожуураас ус авч байхыг харсан бололтой, тэгээд урьдаас бодож, өрөвдөж хайрлах сэтгэлгүйгээр намайг хөнөөх гэсэн зорилгондоо миний гэнэхэн цагааныг ашиглажээ.

Хагас цаг болсонгүй нөгөө түрүүчийнх шиг шинж байдал илэрч ирлээ. Энэ удаа би дөнгөж хагас аяга уусан болохоор орой удаан тэсч бүр унтчихсангүй, нэг хачин нозоорсон байдалд автлаа. Үүнд миний ухаан орчинд болж байгаа бүхнийг мэдээд байх боловч, гүйж зугатаах, өөрийгөө хамгаалах чадалгүй байв.

Би орондоо хүрч, авралт хутгаа авахыг оролдсон боловч орны толгойд хүрч чадалгүй, замдаа сөхөрч, орны хөлнөөс зуурсаар ойчив. Ингээд өнгөрснөө ойлголоо.

Фельтоны царай хувхай цайгаад, хамаг бие нь зарс хийгээд явчихлаа. Миледи тэхдээ хэлмэгдэн цөхөрч байсан шиг сэтгэл нь хөдөлж байх дүрээр хоолойн нь өнгө өөр болж, цааш ярьсан нь,

-Хамгийн аюултай юм нь энэ удаа би өөртөө тулгарч байгаа гайг сайн ухаж байлаа. Миний бие унтаж хөшчихөөд ухаан санаа эрүүлбайсан тэхлээр бүгдийг дуулж, бүгдийг мэдэж байлаа. Чухамдаа бүх хэрэг зүүдэлж байх мэт болж байсан боловч тэр тусмаа аймшигтай муухай байсан. Дэн алгуур дээш өргөгдөн өрөө харанхуй болж байгааг би харлаа. Дараа нь үүд нээгдэх дуу гарах нь энэ чимээг би хоёрхон удаа сонссон боловч андахгүй болжээ. Над руу нэг хүн дөхөж ирэхийг би зөнгөөрөө гадарлав. Америкийн талд гайболж төөрсөн хүн могой гэтэж ирэхийг тэгж гадарладаг юм гэлцдэг.

Би суларсан бие махбодоо захирч, хашгирахыг эрмэлзэв. Үхэн чармайсны хирээр би бүр босоод ирж чадсан боловч даруй тамлагч этгээдийнхээ гарт ойчоод . . . тэврүүлэх нь тэр ээ. , .

Залуу дарга үүнд, хэн юм бэ тэр хүн чинь, хэлж өгч үзээч! гэж дуу алдав. Иймнарийн тодорхой юм ярьснаар Фельтоны сэтгэлийг хир их шаналгаж байгаагаа Миледи эхнээсээ аваад мэдэж байсан боловч аль болохоор сайн тарчлаахыг мэрийж байлаа. Залуугийн сэтгэлийг хир гүн хорсгож чадвал хариу өшөө авах сэтгэл түүнд төдий багтай төрөх юмаа. Тэхлээр Миледи залуугийн ингэж дуу алдсаныг үл анзаарсан болж, эсвэл үүнд хариулах цаг болоогүй гэжүзээд яриагаа үргэлжлүүлэв.

-Энэ удаа булай амьтан түрүүчийнх шиг мэдээ алдсан юмтай учирсангүй. Би ухаан санаагаа бүрэн захирч чадахгүй боловч нөмөрч ирсэн аюулыг би ухамсарлахтай байсан гэж танд ярьсан шүү дээ. Би байдаг чадлаараа ноцолдож удтал тэмцэлдсэн бололтой юу гэвэл түүний:

- " Үгүй энэ муусайн пуритан хүүхнүүд үү! Эд цаазлах хүнийг лавгуйлд нь хүртэл залхаадгийг

би мэднэ, харин явдаг хүндээ ингэж хатуу цэвдэг байдгийг нь би мэдэхгүй юм даа" гэж дуу алдах нь дуулдсан. Хаанаас би тэгж удаан ноцолдож чадах билээ. Хүч тамир барагдаад ирж байгаага би мэдэж байсан. Булай новш энэ удаа миний унтсаныг биш, ухаан алдсаныг ашиглав..

Фельтоны нэг ч үг дуугаралгүй чагнаж, аман дотроо ёолох мэт бөглүү дуугарч гантиг мэт гөлгөр духан дээгүүр нь хүйтэн хөлс дааварлан бурзайжээ. Гараа тас зангидаж зүрхээ дарж суулаа. Би дөнгөж ухаан ороод хөдлөхтэйгөө зэрэг дэрэн дор нуусан, түрүүн нь хүрэх гээд хүрч чадаагүй хутгаа тэмтэрлээ. Тэр хутга биеэ хамгаалахад минь тус болоогүй ч гэсэн ядаж ертөнцөөс ангижрахад минь тус болж чадах байлаа.

Гэтэл тэр хутгыг авахын хамт миний дотор нэг аймаар санаа орж ирлээ, Фельтон би бүгдийг танд ярина гэж андгайлсан, тэхлээр бүгдийг ярина. Би үнэн бүгдийг өөрт чинь хэлнэ гэж амласан. Яахав хэлээд өөртөө хор боллоо ч гэсэн хэлнээ.

-Тэр хүнээс өшөөгөө авах санал танд төрөв үү? гэж Фельтон дуу алдсанд Миледи:

-Тиймээ бурхан минь үнэн шажинтан хүнд тийм санаа байж тааршгүйг би мэднэ. Тэр санааг лав биднийг үргэлж уруу татахуйц бэлэн байдаг муу зүгийн бэлгээр надад төрүүлсэн байх. Ер нь гэхэд л Фельтон танд үнэнээ хэлэхэд тийм санаа надад төрөөд дотроос гарч өгдөггүй гэж Миледи гэмээ хүлээж бий хүний байртай дуугараад, ийм нүгэлт санаа төрсний уршгийг би одоо эдэлж байгаа юм гэлээ.

Фельтон үүнд цааш нь ярьж үз дээ. Таны яаж өшөөгөө авсныг дуулахсан гэж тэсч ядаж байна гэж гуйв.

-Би аль болох түргэн өшөө авахыг хичээж байсан, шөнө болохоор тэр лав ирнэ гэж би итгэж байсан. Өдөр надад айх юм байгаагүй.

Тэгээд өглөөний хоол ирэхээр би бодож санах юмгүй идэж уусан. Оройн хоолон дээр юм идэж байгаа дүр үзүүлээд, юу ч амсахгүй байхаар шийдсэн юм, орой өлсөхгүйн тулд өглөө сайн хооллох хэрэгтэй байсан юм. Өглөөний цайнаас би нэг аяга ус л хойш нуусан, юу гэвэл түрүүн хоёр өдөр хоёр шөнөхоол ундгүй байхад цангах зовлон л онц хүнд байсан билээ. Өдөр өнжин ийм юм бодсоор миний санаа бүр шулуудлаа. Намайг сэм ажиглаж байгааг би лавтай мэдэж байсан болохоор дотоод бодлоо нүүр царайныхаа байраар илрүүлчихгүйг хичээж байсан. Би хоёр ч удаа инээмсэглэж суугаад санаа авч билээ. Фельтон, би юу бодоод инээмсэглэж сууснаа танд хэлж чадахгүй, та намайг жигших болох бий...

Цааш нь яриад байгаарай. Та харж байгаа биз дээ, би чих тавьж чагнаж эд бүгд юу болж төгссөнийг бушуухан мэдэхсэн гэж байна шүү дээ гэж Фельтон гуйв.

-Орой боллоо, бүх юм хуучин журмаараа л байлаа. Түрүүчийнх шиг надад харанхуй байхад ширээ засаж ирүүлээд гэрэл асаж, би ч мөн ширээн дээр очиж суулаа.

Би жимсидэж, савтай уснаас ууж байгаа дүр үзүүлээд, өглөө авч үлдсэн усаа уулаа. Сольж уухдаа тун авхаалжтай аргалсан болохоор намайг хүн тагнаж байсан ч гэсэн юм ажихааргүй

байсан. Оройн хоолны дараа урьдын адил хөшиж, хүндэрсэн байдал үзүүлээд, энэ удаа ядарч туйлдсан юм уу, зовлондоо дасч байгаа дүрээр ор руугаа салгалж очоод, хувцсаа тайлжхаян хэвглээ. Би дэрэн дороо хутгаа зууртал атган, унтаж бий дүр үзүүлж хэвглээ. Хоёр цаг юу ч болсон юмгүй өнгөрлөө. Би түүнийг ирэхгүй юм болов уу гэж айх шахуу байсан. Бурхан минь тэгнэ гэж урьд нь ер яаж санаанд орохсон билээ. Тэгж тэгж дэн алгуур дээшилсээр алга болоод, өрөө тас харанхуй болов.

Гэвч би мэрийн ширтсээр харанхуйд нүдээ жаал дасгаж чадлаа. Арван минут хиртэй боллоо, өчүүхэн ч чимээ дуулдаж өгөхгүй, өөрий минь зүрхний цохилт л дуулдаж байсан.

Тэр хүнийг ирээсэй гэж би бурханд залбирч байлаа. Ашгүй нэг хаалга нээгдэх сайн танил дуу гараад дахин хаагдлаа. Шалан дээр зузаан хивс дэвсээтэй боловч хүний хөлийн чимээнд шал хяхнав. Миний өмнө ойртож яваа хүний бараа сүүмэлзэх шиг...

Фельтон яаруулж тэгээд тэгээд! Та харахгүй байна гэж үү дээ, таны үг бүр намайг халуун төмөр мэт хайрч байгааг? гэв.

Миледи цаашаа, тэгээд би байдаг чадлаа хураан, өшөө авах нарийн яривал өөрийгөө шинээр гарч ирсэн Юдифь болгон санаж, цээрлэл үзүүлэх цаг ирлээ гэж бодсон. Би зүрхээ чангалан хутгаа зууртал атгаж байгаад тэр хүн эрхшээлдээ оруулсан намайг тэмтрэн олох санаатай гараа сарвайн бөхийхөөр нь хорсол гомдлоо гаргаж хашгираад цээж уруу нь хутгалж орхисон.

Муу новш үүнийг урьдаас гадарлаж мэдээд хуяг өмсчихсөн байж, хутга яахав түүнд нь тулаад л зогслоо.

Аа тийм бий гэж тэрхүн дуу тавин гарыг минь шүүрч аван, өдий бага тус хүргэсэн хутгыг булааж аваад, Сүсэгтэн гуа охин та миний амийг хорлох гэж байна уу?

Энэ чинь үзэж чадахгүй байгаа төдийгүй, хүний ачийг үл санасан ясгүй явдал гээч. За,за сайхан охин минь тайвширч үз... Би өөрийг чинь нэгэнт номхорсон юм бодсон. Бүсгүйхүнийг хүчээр барьж байдаг харгис этгээдүүдийн нэг би биш ээ. Та үнэхээр надад дургүй юм байна. Би сэхүүн санаатайдаа үүнд эргэлзэж байсан юм. Одоо үнэмшлээ.

"Та маргааш чөлөөтэй болно" гэв. Тэр хүн намайг алаад өгөөсэй л гэж би хүсэж байлаа. "Та өөрөө болгоомжилбол таарна, би суллагдана гэдэг таны нэр төрл баларна гэсэн үг" гэж би хэлэв.

"Гуа охин минь чи юу гэх гэснээ тайлбарлаад өгөөч"

"Тэгье. Би эндээс гарахын хамт л таны яаж намайг хүчээр доромжилсон, яаж харж цагдаж байсан бүгдийг задрааж ярина. Булай гутамшиг үйл хийгдэж байдаг ордны тухай бүгдийн сонорт хүргэнэ. Ноёнтон та өндөр эрх хэргэмтэй, гэхдээ айжсүрд, таны дээр ван эзэн, ван эзний дээр бурхан бий шүү дээ" гэсэн.

Тэр тамлагч биеэ хэдий сайн барьж чаддаг хүн боловч уур хилэн нь дүрс хийснийг барьж чадсангүй. Би түүний царайны байрыг харж чадаагүй, гэхдээ миний гараас барьсан гар нь

чичирхийлээд явчхыг би мэдсэн.

"Тэгвэл та эндээс гарахгүй дээ"

"Яахав сайн. Миний тамаа эдэлсэн энэ газар миний авс болог. Их сайн! Би энд үхнэ, тэгээд ял нэхэх сүнс гэдэг амьд хүний сүрдүүлгээс илүү хүнд байдгийг өөрөө үз".

"Танд зэвсэг юу ч үлдээхгүй"

"Зориг төгс хүн цөхөрч мухардаад хэрэглэдэг нэг арга над бий. Би өлсөж үхнэ"

"Та миний үгийг сонс. Иймэрхүү янзаар муудалцаж байснаас эвлэрсэн маань дээр юм биш үү. Таныг би даруй суллан тавьж, ариун шударга явдалтай, манай англи нутгийн дагина гэж олонд мэдүүлье" гэж тэр өөдгүй хүн хэлсэн.

"Аа би таныг энэ нутгийн олны адаг шаар гэж мэдүүлнэ. Бурхны өмнө өөрийн чинь нүүр царайг илчилсэн шигээ хүн ардын өмнө илчилнэ. Тэгээд хэрэг боллоо гэхэд үгнийхээ үнэнийг цусаараа баталж үзүүлэхээс буцахгүй" гэж би хэллээ.

Миний өстөн үүнд дооглонгуй байртай:

"Мөн тийм бий! Тэгвэл өөр хэрэг. үнэндээ та энд сайхан сууж байна. Танд дутагдаж гачигдсан юм байхгүй. Та өлсгөлөнгөөр үхэхэд хүрвэл өөрөө л буруутан л болно доо" гэв. Ингэж хэлээд тэр хүн гарч одсон. Үүд дахин нээгдээд хаагдах чимээ гарч, би ганцаараа үлдэхдээ, зовлондоо, чин үнэнийг хэлэхэд өшөө авч чадаагүйдээ ичиж шаналж байв.

Тэр хүн үгэндээ хүрч өдөр шөнө хоёр өнгөртөл надад үзэгдээгүй. Би ч мөн үгэндээ хүрч юу ч идэж уугаагүй. Тэр хүнд хэлсэнчлэн би өлсөж үхэхээр шийдсэн.

Өдөр шөнө хоёр залбирч өнгөрөөгөөд, миний тийнхүү амиа тэвчиж байгааг бурхан өршөөх бий гэж горьдож байлаа.

Дараа шөнө нь үүд нээгдэхэд, би бүр тамирдаж гүйцээд шалан дээр хэвтэж байсан. Үүд нээгдэх чимээгээр би хүчлэн гар дээрээ өндийлөө.

"За яаж байна таны сэтгэл жаал зөөлрөв үү?" гэж миний чихнээ хоногшсон айхтар дуу гараад амаа татаж явна гэдэг ам өгснөөр суллагдаж гарахыг зөвшөөрөх үү? Та миний үгийг сонс, би сайхан сэтгэлтэй хүн шүү. "Би пуритан сүсэгтэн хүнд дургүй хэдий боловч, тэдэнд зөв юм бас бий гэж үзэж даан ялангуяа царай зүстэй пуритан бүсгүйчүүлийг тоож үздэг юм шүү. Загалмай барьж андгайл, би өөр юу ч шаардахгүй" гэсэн.

Тэр хүний зэвүүн дууг сонсмогц би чадал орж, босоод, "Танд загалмай барьж ам өгөх үү? Загалмай барьж шүү! Ямар юм амлаж, яаж ч сүрдүүлж, яаж тамласан ч би дуугүй байхгүй... Загалмай барьж андгайлах гэнээ!... Хаана хэдийд ч гэсэн өөрийг чинь яргачин, хүний нэр төрийн хулгайч, адгийн новш гэж илчлэх болно гэж андгайлъя!..."

Загалмай барьж шүү! Эндээс гарах цаг над байдаг юм бол би бүх хүн төрөлхтнийг өшөөг

минь авч өгөөч гэж гуйна гэж андгайлъя" гэж хашгирсан.

"Болгоомжлоорой!" гэж тэр хүн хачин аймаар дуугараад,

"Таны амыг таглах, үгүй гэхнээ нэг ч үгэнд чинь хүн итгэхийн аргагүй болгох гайгүй сайн арга надад бий, таныг тун болохгүй бол би тэр аргаа хэрэглэнэ ээ" гэв.

Би хамаг чадлаа шавхан түүний ийнхүү сүрдүүлсний хариуд инээд алдав. Цаашид бид хоёр насан туршаа үхэх сэхэхээ үзэлцэх. өштөн болсныг тэр хүн ойлголоо.

"Танд би энэ шөнө, маргааш өдөр бүтэн бодох чөлөө олгоё. Та амаа барьж явахыг амлавал эд хөрөнгөтэй, олонд хүндтэйгээр барахгүй алдартай хүн болно. Та энэ хэвээрээ намайг сүрдүүлээд байвал таныг шившиглэх болно" гэлээ.

"Та юу? та тэр үү?" гэж би дуу алдав.

"Үүрд засрашгүйгээр шившиглэнэ"

"Та тэр үү?" гэж би дахин асуусан. Үнэндээ, Фельтон минь тэр хүнийг би галзуурч гэж бодож билээ. "Тийм ээ би" гэж тэр хариулсан.

Үүнд би, "та явж үзээч, хананд толгойгоо хага мөргөж үхэхийг минь үзэх гээгүй л юм бол зайл" гэв.

"Тэгье. Таны тааллаар больё, маргааш орой уулзъя" гэхэд хариуд нь би:

"Маргааш орой уулзъя" гээд шалан дээр ойчиж хорсож цөхөрсөндөө шүдээрээ хивс зулгааж байсан. Фельтон сандал түшин зогсож, байхдаа яриагий нь дуустал чагнаж чадахгүй байж мэдэхээр болсныг Миледи үзээд шулам мэт хөөрөн баярлав.

LVII. СОНГОДОГ ЭМГЭНЭЛТ ЖҮЖГИЙН ШАЛГАРСАН АРГА

Миледи тэр дуугүй болох зуураа, яриагаа чагнаж байсан залууг сэм ажиглаж байснаа цаашаа өгүүлсэн нь:

-Гурван хоног шахамби юм идэж уугаагүй зовж шаналж байсныг яриад, яахав, үе үе толгой хүндрээд нүд эрээлжлэн дэмийрч эхэлж байсан.

Орой болж, миний бие хариугүй сулраад байн байн ухаан алдаж байсан. Ухаан алдах бүрдээ би үхэж байна гэж санаад баярлан бурханд сүсэглэж байсан.

Нэг ухаан алдсан цагт үүд нээгдэхийг би сонсоод айсандаа сэргэлээ.

Тэр хүн нэг баг өмссөн хүн дагуулсаар орж ирэхдээ, өөрөө мөн багтай байсан боловч дуу, алхаа ихэмсэг сүрлэг байдлаар нь түүнийг би таньсан. Хүн төрөлхтний гай дайрахад ад шулам тэр хүнийг тийм ихэмсэг сүртэй төрүүлсэн биз.

"За яахав. Та миний шаардсанаар ам өгөхөд бэлэн байна уу? гэж тэр асуулаа. "Пуритан сүсэгтэнүгэндээ хүрдэг гэж та өөрөө хэлсэн шүү дээ. Хорвоо дээр байвал таныг хүний шүүхэд, хойт насандаа бол эрлэгийн шүүхэд өгнө гэж ам алдсан, та дуулсан"

" Ингэхлээр та зөрүүд аашилсан хэвээрээ шив? "Миний үгийг сонсож байгаа бурхны өмнө андгайлъя" "Хамаг олныг би таны үйлдсэн хэрэгт гэрч татаад, өшөө авах хүн олдтол бүгдийгуриалж дуудах болно" гэтэл тэр хүн чанга дуугаар:

-" Чи янхан эм. Тэхлээр тийм бүсгүйчүүдийн нэгэн адил цээрлэл үзэх болно. Шившгийн тамга тавиулсан хойноо гуйж уриалах гэж байгаа тэр олон түмэндээ гэм буруугүй, ухаан солиотой биш гэдгээ үнэмшүүлэх гээд үзээрэй" гэсэн.

Ингээд нүүрэндээ багтай хүн рүү эргэж;

-Яргачин, хийх ёстой юмаа хий! гэж тушаасан.

-Пээ тэр чинь хэн бэ? Хэн юм бэ? Нэрийг нь хэлээд өгөөч! гэж Фельтон хашгирав.

-Тэгээд би хэдий орилж хашгиран ноцолдож махаа барсан боловч үхлээс дор нэг аюул тулгарчээ гэдгийг би ойлгож эхэлсэн. Яргачин намайг барьж аван унагаагаад дарж, би уйлж багтран, бараг ухаан алдах дөхөж, бурхан шүтээнд залбиран дуудаж, бурхан миний мөргөлийг тольдож таалахгүй байсан... тэгж байтал гэнэт яргачны улайсгасан төмөр тамга мөрөнд минь шигдэн орж би гол тасартал өвдөж, ичсэндээ муухай дуу тавьж бархирав.

Фельтоны амнаас заналхийлсэн муухай дуу гарлаа.

Миледи эзэн хатан мэт ихэмсэг сүртэй босоод,

-Хар даа Фельтон, хар! Хүчирхийлэлд автсан хөөрхий ариун охинд булай муу хүн ямар шүү шинэ тамлалт бодож олсныг үз. Хүмүүсийн зүрх сэтгэлийг таньдаг болж сураад, тэдний

өслөх муу хэрэгт ухвар мөчдөөр зэвсэг болж, өгөхийг боль! гэлээ.

Миледи даруй энгэрээ ярж, дотуур нимгэн торгон хувцсаа цуу татаад хуурмаар хорсон уурласан, ичсэн дүр үзүүлж, царай нь улайж гуа сайхан мөрөө үүрд шившиглэн тамгалуулсныг залууд үзүүлэв.

-Үгүй энэ чинь хонхон цэцгэн тамга байна шүү дээ! гэж Фельтон гайхлаа -Хамаг булай муу санаа нь үүнд л байхгүй юу.

Английн тамга байсан бол ямар шүүх ийм ял заасныг олж батлах болно. Би улсын дотор байсан ван эзний бүх шүүхийн газарт өргөдөл өгч болох байсан.. Харин Францын тамга уу... Энэ тамга намайг багтай шившиглэжчадсан юм гэж Миледи хариулав.

Эд бүгд Фельтонд даанч хэтэрхий санагдлаа. Миледи саяны аймаар ярианд автаж, энэ бүсгүй биеэ ичгүүр сонжуургүй нүцгэлэн харуулсныг гойд өгөөмөр уудам сэтгэлийн илрэл гэж хууртан хосгүй гуа үзэсгэлэнд нь гялбасандаа Фельтоны царай цонхийж, алмайран бүсгүйн өмнө сөхрөн унав. Урьд шашны төлөө ариун гэгээн явж зовлон эдлэгчдийн өмнө анхны христос шашинтнууд ингэж сүсэглэн мөргөдөг байсан. Тэр зовлон эдлэгчдийг шажны дайсан хаад ихэс үзвэрийн газарт өгч харц олны зугаа цэнгэл болгодог байж билээ. Фельтоны нүдэнд шившгийг тамга үгүй болж, ганцхан гуа сайхан л харагдах боллоо...

-Уучилж үз! Өршөөж үз?! Ээ намайг уучилж үз! гэж Фельтон дуу алдахад Миледи харцаар нь "Хайртай, хайртай боллоо" гэсэн үг болохыг мэдэж байлаа.

-Таныг уучлах гэж юуг тэр вэ? гэж бүсгүй асуулаа. -Таныг мөрдөн зовоогчдын талд орсны минь уучилж үз, гэхэд Миледи өөдөөс нь гараа сунгав.

Фельтон гарыг нь олон олон үнсэж бахдан юутай гуа сайхан, юутай залуухан бэ? гэв.

Миледи үүнд боол хүнийг хаан шигжаргалтай болгодог сайхан харцаар харлаа. Фельтон пуритан сүсэгтэн хүн болохоор яахав бүсгүйн гарыг тавиад хөлийг нь үнсэж гарав. Миледид хайр сэтгэлтэй болохоор барахгүй биширч амиа тавих болсон байлаа.

Уулаас нэг ч сандарч хөөрөөгүй байсан Миледи сэтгэлийн энэ их хямралдаан нь дарагдаж, сэхээ авсан дүр үзүүлж залуугийн тачаал дур шуиалыг улам татах санаагаар хайр сэтгэлийг хөвсөлзүүлсэн гуа сайхан цогцсоо ичингүйрлийн хөшгөөр дахин халхалсны дараа залуугийн хэлсэн нь:

-Одоо танаас гуйх юм ганцхан байна. Таны тэр яргачдын нэг нь нөгөөгийнхөө гар хөл болсон, чухам гэмтэн нь нөгөөдөх нь юм байна. Тэр хүний нэр хэн юм бэ?

_ Юу гэнээ дүү минь! Түүний нэрийг надаар хэлүүлмээр байнагэж үү? Чи өөрөө гадарласангүй юу?

-Юу? Тэр хүн мөн гэж үү?... Бас л тэр байх нь!...Дандаа л тэр хүн! Юу гэнээ! Жинхэнэ буруутай этгээд... гэж Фельтон гайхлаа.

Жинхэнэ гэмтэн этгээд Англи орныг хоосолж үнэн шашинтныг хяхаж хавчин, өдий төдий бүсгүйчүүдийг эвдэн бузарласан хүн, залхай зандаа автан өдий олон англи хүмүүсийн цусыг урсгахаар завдаж байгаа, өнөөдөр буруу номтонд өмөг түшиг болж байгаа, маргааш тэднийгээ урван худалдах этгээд...

-Бекингэм! Үгүй энэ чинь Бекингэм байна! гэж Фельтон хорсон дуу алдав. Миледи энэ нэрийг дуулаад ичгүүрт явдал санагдаж шаналсан дүрээр нүүрээ дарав.

-Энэ гуа сайхан дагина мэт амьтныг Бекингэм тэгж тамлаа юм бий тэнгэр бурхан минь чи тэгээд түүнийг ниргэсэнгүй вэ? Түүгээр бид бүгдийг хөнөөлгөх гэж язгуур сурвалж нэр хүнд, эрх сүртэй хэвээр үлдээжээ! гэв.

Өөрөө өөрийгөө гаргуунд гаргасан хүнийг бурхан мөн гаргуунд нь тавьчихдаг юм гэж Миледи хэллээ.

-Тэгвэл тэр хүн гаргуундаа хаягдагсдад ирдэг цээрлэлийг хар толгой руугаа дуудаж байгаа хүн шив? гэж Фельтон улам бүр сэтгэл хямран өгүүлээд, бурхны цээрлэлээс урьтаж өшөөгөө авах хүний гарт өртөх гээд байгаа юм шив! гэлээ.

Хүмүүс түүнээс айж, бас өрөвддөг юм. Үгүй, би түүнээс айх ч үгүй, өрөвдөж хайрлах ч үгүй гэж Фельтон хариуллаа.

Миледийн шулмын сэтгэл баярлаж тэнийжирлээ.

-Үгүй миний өмөг түшиг эцэг болсон Винтер гуай яагаад эд бүгдэд хамаатай болсон юм бэ? гэж Фельтон асуув.

-Фельтон чи дуулж бай. Хорвоо дээр өчүүхэн сэтгэлт жигшим муу улсаас гадна өгөөмөр сайхан зантай улс байдаг юм.

Би нэг болзоот хүнтэй түүндээ би хайртай сайн, тэр ч надад сайн байлаа. Фельтон тантай адил эр зоригтой сайн хүн. Би тэр хүндээ ирж бүгдийг ярилаа. Тэр хүн намайг сайн мэдэх болохоор өчүүхэн ч эргэлзсэнгүй.

Тэр өөрөө өндөр сурвалжтай аль ч талаар Бекингэмтэй адил зэргийн хүн байсан юм. Тэр тэгээд юу ч дуугаралгүй илд зүүж өргөн нөмөргөөр биеэ ороогоод Бекингэмийн ордон руу явлаа. Фельтон үг оруулж тэгж таарна аа би ойлгож байна.

Тиймэрхүү хүмүүстэй учрахад уул нь илд биш, хутга хэрэгтэй байх юм даг гэв.

-Бекингэм түүний өмнөхөн, тэр үед Уэльсийн хунтайж байсан нэгдүгээр Карл ван эзэнд Испанийн ван эзний охиныг хатан болгоё гэж гуйхаар тийшээ явчихсан байлаа. Манай болзоот хүн тэгээд яаж ч чадсангүй ирлээ. "Тэр хүн яваад өгч. Одоогоор би түүнээс өшөө авч чадахгүй нь ээ. Түүний ирэхийг хүлээж байх, зуураа хоёул ярилцсан ёсоороо гэрлэе. Цаашаа өөрийнхөө болон гэргийнхээ нэр төрийг хамгаалж чадна гэж та Винтерт итгэ гэж нөхөр болох хүн минь хэлсэн.

-Винтер гэнээ? гэж Фельтон дуу алдав.

-Тиймээ, Винтер ноён гэж Миледи давган өгүүлээд, одоо та тэхээр бүгдийг ойлгосон байж таарна тийм биз? Бекингэм яваад жил орчим эзгүй байсан. Тэр хүнийг ирэхээс долоо хоногийн өмнө Винтер ноён гэнэт нас бараад, би түүний хамаг хөрөнгийг өвлөж үлдсэн. Хэн энэ их гай зовлонг ирүүлсэн бэ? Бүхнийг мэдэгч бурхан л үүнийг мэднэ, би хэнийг ч үл буруушаана гэв.

-Пээ яасан булай юм бэ? Ямар ухаанд ч багтамгүй бузар юм бэ? гэж Фельтон тэсэж ядан байлаа.

Винтер ноён ахдаа юу ч хэлээгүй талийгаач болсон. Гэмт этгээдийг аянга мэт ниргэн цээрлүүлэхээс нааш аюултай нууцыг нийтэд задруулахгүй ёстой байсан. Таны өмөг түшиг болсон Винтер гуай ахыгаа инж байхгүй залуу охинтой суусанд дургүй байсан юм. Өв залгамжилж авах горьдлоготой байж байгаад надаас болж горьдлого тасарсан хүний

зүгээс тусламж эрэх хэрэг надад үгүй гэдгийг би ухаж байсан. Би Францад очиж хорвоог өнгөрөөхөөр хатуу шийдээд тийшээ явсан юм. Миний хамаг хөрөнгө Англид байгаа. Дайн болсны уршгаар хоёр улсын харилцаа холбоо муудаад би гачигдах болсон. Тэгээд өөрийн эрхгүй наашаа ирэхэд хүрсэн. Зургаан өдрийн урьд би Портсмугэд хөлгөөс буусан.

Цаашаа? гэж Фельтон асуулаа

-Цаашаа юу? Миний ирж явааг Бекингэм мэдсэн бололтой, тэгээд тэртэй тэргүй миний тухай олиггүй юм санаж явдаг байсан Винтер гуайд танай бэр чинь шившгийн тамгатай, гэмийн хэрэгтэн янхан хүүхэн гэж хэлээ биз. Намайг, өмөөрч шударга үнэн үгээ хэлэх эр нөхөр минь амьд байхгүй. Винтер гуай хэлсэн бүхнийг итгэжээ. Итгэх өөрт нь ашигтай байсан болохоор бүр ч дуртай итгээ биз. Тэгээд намайг баривчлуулж, нааш нь авч ирээд танаар харгалзуулж байна. Бусдыгнь та мэдэж байгаа, нөгөөдөр, тэр намайг цөллөгөнд явуулах гэж байна, Нөгөөдрөөс аваад би бүх амьдарлаа адаг шаар болсон шоовдор хүмүүсийн дотор орж, өнгөрүүлэх болж байна. Итгэж үз, муу үйлийг нарийн бодож олжээ, Уран арга бодож олоод миний нэр төрийг лавтай бузарлах болжээ. Ингэхлээр би үхвэл дээр болсныг Фельтон харж байгаа биз дээ. Фельтон, над хутгаа аль!

Миледи ингэж хэлээд байдаг хүчээ шавхаж туйлдсан байртай залууг түшиж тэврүүлэхэд залуу дарга хайр сэтгэл, уур, хорсол болон урьд хожид үзээгүй их цэнгэлийн хүчинд авгаж бүсгүйн сайхан уруулаас гарах ариухан амьсгаа, догдлон хөөрсөн хөхөнд нь хүрч бахдаж хөөрөн чанга тэвэрч зүрхэндээ наалдууллаа.

Залуу дарга дуу тавьж,

-Үгүй үгүй, чи бүгдэд хүндлэгдэж. ариун сайн, нэртэй өшгнүүдийнхээ хорыг хөдөлтөл сайхан амьдрах ёстой гэв. Миледи түүнийг гараараа түлхэх төдий боловч харцаараа уриалж татахад Фельтон дахин шүүрч тэврээд, бишрэн таалж, хүсэн тачаадсан харцаар эгцлэн ширтэв.

-Бурхан, минь үхье! үхье! Шившиглэгдсэнд орохноо үхсэн нь дээр, Фельтон ах минь нөхөр минь гуйя чамаас, гэж Миледи гуниглангуй өнгөөр дуугараад нүдээ анив. -Үгүй, үгүй чи амьд явна, явахдаа өшөөгөө авахуулаад амьд явна шүү гэж залуу дуу алдана.

-Фельтон хавийнхаа улсад би гай чирдэг хүн. Намайг орхиж үз Фельтон. Би зүгээр үхье. - Тийм юм бол хоёул цуг үхье гэж Фельтон хэлээд хоригдол бүсгүйн уруулыг озон үнсэв. Үүд шамдан тогших дуу гарсанд энэ удаа Миледи Фельтоныг үнэнээсээ түлхэж орхиод: -Чи дуулж байна уу? Бидний яриаг сэм чагнаж байж.

Наашаа хүн ирж явна. Хамаг хэрэг баларч, бид өнгөрлөө гэж Миледиг хэлэхэд Фельтон тайвшруулж:

-Үгүй; гадаах хуяг тогшиж, эргүүл ирж явааг надад мэдэгдэж байгаа юм гэлээ. -Тэгвэл бушууханүүд рүү очиж өөрөө онгойлгож өг. Энэ бүсгүй нэгэнт түүний хамаг ухаан санаа сэтгэлийг эзэмдэж чадсан тул Фельтон үгэнд нь оров.

-Тэгээд үүд онгойлготол харуулын эргүүлийг захирдаг бага даргатай халз тулгараад: -Юу болоов? гэж асуулаа.

-Та дуудсан цагтаа үүд онгойлгоорой гэж надад тушаасан, гэтэл түлхүүрээ үлдээхийг мартаж орхижээ. Би таны хашгирахыг дуулсан. Тэгээд үүд нээх гэтэл дотроосоо түгжээтэй байхаар бага даргыг дуудсан юм гэж цэргийн хүн өчихөд бага дарга мөн:

-Ирснийг мэдэгдье гэлээ.

Фельтон ухаан алдах шахаш алмайран юу ч дуугарч чадахгүй зогсоно. Нийтийн анхаарлыг өөр дээрээ татах хэрэгтэй болсныг Миледи мэдээд ширээн дээр очиж Фельтоны тэнд тавьсан хутгыг шүүрч аваад хашгиран:

-Миний үхэхэд та нар саад хийх ямар эрхтэй юм бэ? гэлээ

Бүсгүйн гарт хутга гялалзахыг Фельтон хараад,

-Тэнгэр минь гэж дуу тавилаа.

Энэ үеэр гудманд хүн дооглон инээх дуулав. Бээл чимээ шуугиан гаргахыг сонсоод, нөмрөг нөмөрч, илд сугандаа хавчуулсаар үүдэн дээр хүрч ирлээ.

-Мөн дөө. Эмгэнэлт жүжгийн эцсийн бүлгийг бид үзэх маань энэ! Фельтон та харж байгаа биз. Жүжиг чухам үе шат дараалан, яг миний урьдчилан хэлж байсанчлан гарч байгаа биз. Гэсэн ч бүү зов, цус урсахгүй гэж бээл алгуур дуугарав.

Фельтонд Миледи өөрийгөө зориг төгсхүн гэж нэн даруй аймшигтайгаар нотлон үзүүлэхгүй бэл өнгөрлөө гэдгээ Миледи ухжээ. Тэгээд:

-Ноёнтон та эндүүрч байна. Цус урсана, энэ цус тэгээд урсгахад хүргэсэн тэр улсын толгойд хүрнэ ! гэв. Фельтон дуу алдаад Миледи рүү ухасхийсэн боловч хожигдож, Миледи өөрийгөө

хутгалж орхилоо. Гэвч аз дайраад ч гэх юм уу үнэнийг нь хэлэхэд чадамгайгийн ачаар хутганы нь үзүүр замдаа тэр цагийн бүсгүйчүүлийн цээжийг хөө хуяг мэт шахаж барьдаг байсан татуурганы төмөрт торж, хувцсыг нь урж ташуу хальтран арьс, хавирга хоёрын завсраар шаачихжээ.

Гэсэн ч Миледигийн хувцас даруй улаан нил болж, Миледи өөрөө ухаан алдаж түрүүлгээ харж ойчив. Фельтон хутгыг сугалж аваад, баргар царайлан,

-Миний харгалзаж байсан бүсгүй ингээд амиа тэвчлээ лээ. Ноёнтон хараа биз? гэв. -Фельтон та бүү сэтгэл зов, цаадах чинь үхээгүй. Шулам гэгч тэгж амархан тонилдоггүй юм. Сэтгэл зоволгүй явж, миний өрөөнд очоод хүлээж бай гэж Винтер гуай маргав.

-Үгүй Милорд..

-Явж бай. Би танд тушааж байна.

Фельтон даргынхаа үгийг дагасан хэдий боловч өрөөнөөс гарахдаа нөгөө хутгыг цээжиндээ нуучихлаа.

Винтер гуай яасан бэ гэвэл Миледид зарагдаж байсан бүсгүйг дуудаж, ухаан ороогүй хэвээр байсан хоригдол бүсгүйг түүнд даалгаж өгөөд, хоёуланг нь үлдээж гарч одлоо. Шарх бас ч санаснаас нь илүү ноцтой байж болох тул юу ч болсон эмч рүү хүн явуулжээ.

LXIII. ЗУГТААВ

Миледийн шарх Винтер гуайн санасанчлан хөнгөн байжээ. Бээлийн дуудаж ирүүлсэн бүсгүйтэй хоёул үлдээд, цаадах нь хувцсыг нь тайлахыг оролдмогц Миледи нүдээ нээв

Гэхдээ өвдөж доройтсон хүний дүр үзүүлэх хэрэгтэй байсан нь Миледи шиг сайн жүжигчинд юун бэрхтэй байх билээ. Хөөрхий зарц бүсгүй бүрмөсөн мэхлэгдэж гүйцээд, Миледийг өөрий нь хориглосоор байтал шөнө дөлөн хажууд нь сахиж суухаар шийджээ.

Зарц бүсгүй хамт байлцлаа гээд Миледийн юм бодож боловсруулахад саад болсонгүй.

Фельтон өөрийн нь үгэнд үнэмшлээ гэдэг эргэлзээгүй. Фельтоны хамаг сэтгэл санаа Миледиг бишрэн дагаад, одоо ийм байгаа цагт нь тэнгэрийн дагина ирээд Миледийн гэм ялыг тоочлоо ч гэсэн түүнийг Фельтон шуламны зараалаар ирсэнд тооцох нь лав юм.

Ингэж бодохдоо Миледи инээмсэглэнэ. Юу гэвэл өнөөгөөс аваад Фельтон түүний ганц итгэл найдлага, аврагдаж гарах ганц зэвсэг нь боллоо.

Гэхдээ Винтер гуай Фельтоныг сэжиглэж, одоо өөрий нь бас давхар хянаж болох юм.

Өглөөний дөрвөн цаг орчимд эмч ирсэн боловч Миледийн шархны ам нэгэнт битүүрч амжаад, аль чигт, хир гүн шар хадсаны нь мэдэхийн эрхгүй болжээ. Гэвч шархадсан хүний судсыг барьж үзвэл биеийн нь байдал санаа, зовохоор юмгүй аж.

Өглөө нь Миледи зарц бүсгүйг унтаагүй амрах хэрэгтэй гэдэг шалтаг зааж явууллаа. Өглөөний цай авчрах үеэр Фельтоныг ирэх байх гэж Миледи горьдсон боловч ирсэнгүй, Үнэхээр өөрийн нь айж байсанчлан боллоо гэж үү? Үнэхээр Фельтоныг бээл итгэхээ байгаад, Фельтон шийдвэрлэх үед ирж тусалж чадахаа байв уу? Хөлөг онгоц хорин дөрвөнд хөдөлнө гэж Винтер дуулгасан, өнөөдөр хорин хоёр болчихоод цаана нь ганцхан өдөр үлдээд байна. Гэхдээ Миледи үдийн хоол хүртэл тэсвэртэй гэгч хүлээлээ. Миледи өглөө юм идээгүй, үдийн хоолыг ердийн авчир" даг цагтаа авч ирсэн хэдий боловч харуулд зогссон цэргийн жагсаал хувцас өөр болчихсон байгааг ажиг хэлмэгдэв. Тэгээд арга буюу зүрх гаргаж Фельтоны тухай асуулаа. Фельтон цагийн өмнө мордоод юманд явчихсан гэдэг хариу дууллаа

Бээл цайзад байгаа эсэх тухай асуулаа. Цэргийн хүн үүнд толгой дохиод, таныг уулзахсан гэвэл өөртөө мэдэгдээрэй гэж бээл захисан гэлээ.

Миледи одоогоор юм ярихын сэхээгүй, ганцаараа байхаас еөр хүсэлгүй байна гэлээ. Цэргийн хүн хоолыг нь ширээн дээр тавиад гарч одлоо.

Фельтоныг зайлуулж, далайн явган цэргүүдийг харуулаас татан буулгажээ. Тэхээр Фельтонд итгэхээ больсон юм байна!

Энэ нь хоригдол бусгүйд эцсийн хүнд цохилт боллоо. Миледи өрөөндөө ганцаараа үлдээд босов. Өглөөнөөс аваад хүнд шархадсан хүний дүр үзүүлэх гэж босолгүй хэвтсэн ор дэвсгэр нь халуун хайруул мэт жигнэх шиг санагдана. Үүд рүү хартал, хардаг цонхыг банзаар таглаж

хадсан байлаа. Тэр цонхоор Миледи харуулын цэргийг яаж ийж байгаад залилав уруу татаж орхих бий гэж бээл айсан бололтой. Миледи баярлан инээмсэглэв. Хүн сэм харж байж магад гэж айхгүй дотроо нууж байсан хилэн хорслоо сая нэг ил гаргах боломжтой болжээ.

Уурандаа бахардаж торонд байгаа барс шиг өрөөн дотуураа холхино. Энэ удаа Миледиг хутга байдагсан бол лав өөрийгөө биш бээлийг алах гээд үзэхсэн бизээ.

Оройн зургаан цагт Винтер гуай ирсэн нь бүрэн зэвсэг агсжээ. Энэ хүртэл ордны нэг тэнэгдүү бараа бологч гэж Миледид санагддаг байсан энэ хүн гайхам лут хуяг болжээ:

Энэ хүн юм бүхнийг мэдэж, урьдаас гадарлаж, сэргийлж байгаа бололтой.

Миледиг нэг хармагцаа бүсгүйн дотор юу болж байгааг тэр даруй ойлголоо.

-За яахав. Та өнөөдөртөө намайг арай алчихгүй, танд зэвсэг үгүй тэгээд ч би сэрэмжтэй байгаа. Та хөөрхий Фельтоныг уруу татаж эхлээд, цаадах чинь таны шулмын нөлөөнд авгаж эхэлжээ. Гэвч би түүнийг аварья гэж санаж байна. Фельтон дахиж таны барааг харахгүй, бүх юм ингээд өнгөрсөн. [

Юмаа бэлд та маргааш замд гарна. Би уул нь таныг хорин дөрвөнд явуулья гэж бодсоноо энэ ажлыг хэдий хурдан амжуулбал төдий сайн гэж шийдлээ. Маргааш үдийн алдад, таныг цөлөх тухай Бекингэмийн гарын үсэгтэй тушаал би авна. Та хөлөг онгоцонд суухаасаа наана хэн нэг хүнтэй ганцын төдий үг соливол манай бага дарга духанд чинь сум зооно. Тэр хүнд тийм тушаал өгсөн юм. Хөлөг онгоцон дээр та хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр хүнтэй ганц ч болов үг соливол таныг усанд хаяж орхино.

Тэр хүнд мөн тийм тушаал өгсөн. За өнөөдөр танд дуулгая гэж санасан юм ийм л байна. Би маргааш ирж тантай уулзаад, хагацна аа. Баяртай.

Ингэж хэлээд бээл гарч одлоо. Энэ айхтар үгсийг Миледи басамжлангуй байртай инээмсэглэн байж сонссон боловч догор нь уур хорсол буцалж байлаа. Оройн хоол авчирч өглөө. Миледи жаал зугаа юм идэж тамир авах хэрэгтэй байлаа. Салхи шуургатай баргар муухай энэ шөнө юу эс учирч магад вэ. Тэнгэрт лүглэгэр хар үүлс нүүж алсад цахилгаан гялбас гялбас хийх нь аадар бороо орох төлөвтэй.

Орой арван цагийн үед аадар бороо цутгалаа. Дотор нь хямарч цухалдсантай тэнгэрийн байдал нийцэж байгаад Миледи тааламжтай байв. Зүрхэнд нь уур хорсол буцалж байгаатай адил тэнгэр нүргэж модны мөчрийг тастан ганхуулж байгаа салхи үе үе нүүр рүү нь үлээх шиг санагдана. Миледи өөрөө салхи шиг гиншгэнэхэд мөн цөхрөнгөө бараад ёолж байгаа мэт хорвоо ертөнцийн лужир их шуугиантай өөрийн нь дуу бас нийлж байв.

Гэнэт цонх тогшихыг Миледи сонсож, цахилгаан гялс хийсэн бүдэгхэн гэрэлд цаана нь хүний царай сүүтгэнэж байхыг хармагц гүйж очоод цонх нээж:

-Фельтон минь! Би амь аврагдлаа шив! гэж дуу тавилаа. Фельтон хариуд нь:

-Тэглээ харин аяархан яриарай. Би бас энэ сараалжны төмрийг хуурайдах учиртай байна. Цаадуул чинь үүдний жижиг цонхоор хараад орхих бий, сэрэмжилж үз гэв.

Цаадуул чинь цонхны нүхийг банзаар таглаж орхисон, биднийг бурхан ивээж байгаагийн баталгаа энэ дээ, Фельтон минь! гэж Миледи хэлсэнд:

-Ашгүй дээ. Тэдний ухаан санааг бурхан төөрөлдүүлжээ гэж Фельтон хариуллаа.

-За би юу хийх ёстой байна? гэж Миледи асуусанд:

-Юу ч хийх хэрэг алга. Зүгээр л бай. Цонхоо хааж орхи. Орондоо ор орж хэвт, үгүй гэхнээ хувцастайгаа хажуулж бай. Би үүнийгээ хийж дуусаад цонх цохино. Ингэхэд та надтай цуг явж чадахаар байна уу гэв.

-Чадалгүй яахав.

-Таны шарх чинь яаж байна.

-Өвдсөн ч явахад саад болохгүй юм.

-Чимээ өгөхийн хамт хөдлөхөд бэлхэн байгаарай. Миледи цонхоо хааж гэрэл унтраагаад, Фельтоны зөвлөсөн ёсоор хөнжилдөө шурган орж атирав. Салхины шуугиан дунд сараалж хуурайдах чимээ дуулдаж, цахилгаан гялбах бүрд цонхны шилэн дээр Фельтоны сүүдэр_ялгарч харагдана. Бүтэн цаг хиртэй, нам хэвтэн амьсгаагаа барьж ядан хүйтэн хөлс нь цутгаж, гудмын зүгээс өчүүхэн төдий чимээ гарах тутам зүрх нь зүсэгдээд явчхаж байв. Жил шиг урт санагдах цаг байдаг билээ. Цагийн дараа Фельтон дахин тогшлоо. Миледи орноосоо үсрэн босоод цонхоо нээхэд, хоёр сараалжийг тас хуурайдаж хүн багтам зай гаргажээ,

_ Та бэлэн үү? гэж Фельтон асуув.

-Бэлэн, юм авсны хэрэг байна уу?

-Мөнгөтэй бол аваарай.

-Бий аз болоход миний биед байсан бүх мөнгийг аваагүй орхисон.

-Ашгүй дээ. Би хамаг мөнгөө хөлөг онгоц хөлслөх ажилд зарцуулчихсан.

-Май үүнийг ав гэж Миледи хавтагатай алтан зоосоо Фельтонд өгөв.

-Фельтон хавтагыг авч доошоо хаячхаад:

-За одоо бууцгаая гэлээ.

-За тэгье гээд Миледи зөөлөн сандал дээр гарч цонхоор гадагшаа өнгийтөл, залуу дарга олсон шатан дээр хий дүүжигнэж, доошоо харанхуйлж харагдлаа.

-Миледид анх удаа айх сэтгэл төрж, бүсгүй хүн гэдэг нь санагдав. Доошоо эх захгүй харлан харагдсанд Миледи айжээ.

-Би ингэнэ байх л гэж айгаад байсан юм даа гэж Фельтоныг дуугарахад:

-Энэ юу ч биш, гайгүй хэргээ... Би нүдээ аниад буучихъя гэж Миледи дуугарлаа.

-Та над итгэж байгаа биз? гэж Фельтоныг асуухад:

-Та бас асууж байнаа! гэв.

-Та гараа нааш нь сунга. Ингэж зөрүүл уухай ингээд байж бай гээд Фельтон Миледийн гарыг алчуураар боож. дээгүүр нь олсоор хүлэв. Миледи гайхаж,—та яаж байна аа? гэж асуусанд:

-Гараа миний хүзүүнд углаад, айх юмгүй бууж үз гэлээ.

-Надаас болж та тэнцвэр алдаж унаад хоёулаа хэмх үсэрснэ.

-Битгий зов. Би далайчин хүн. Цаг алдаж болохгүй байсан тул Миледи хүлээтэй гараа Фельтоны хүзүүгээр углаад, Фельтоноор туслалцуулж цонхоор гулгаж гарлаа.

Фельтон шат, шатаар алгуур доошлон бууж эхлэв. Хоёрын хоёр хүн дүүжигнэсэн хир нь салхи хүчтэй үлээж шатыг ганхуулна.

-Гэнэт Фельтон зогслоо.

-Юу болов оо? гэж Миледиг асуухад:

-Аяар! Хүний хөлийн чимээ дуулдаж байна гэж Фельтон хэлэв.

-Биднийг харчихжээ! Хэсэг зуур тэр хоёр дуугүй чагналаа. Тэгж байснаа Фельтон дуугарч, үгүй айх юм алга гэв.

-Тэгээд энэ чинь юун хөлийн чимээ вэ?

-Харуулын улс цайз эргэж явна.

-Тэд хаагуур өнгөрөх ёстой юм бэ?

-Яг бидний доогуур

-Тэд биднийг харчихна даа.

-Үгүй, цахилгаан цахихгүй бол харахгүй.

-Тэд нар шатны доод үзүүрт хүрээд мэдэж орхино.

-Аз болоход, шат газраас зургаан тохой зайтай байгаа юм.

-За тэр хүрээд ирлээ, бурхан минь!

-Дуугүй!

Тэр хоёр газраас гучаад тохой зайтай дуугүй дүүжигнэн зогссоор байхад доогуур нь харуулын цэргүүд юм ярьж инээлдэн өнгөрөв.

Хоёр оргодолд нэн аюултай цаг ирлээ.

Харуулынхан яваад өнгөрчихлөө. Хөлийн чимээ холдож, яриа нь дуулдахаа болив.

-Бид одоо аврагдлаа гэж Фельтон хэлэхэд Миледи санаа алдаад ухаан тавьчихлаа. Фельтон доошилж гарлаа. Шатны доод гишгүүрт хүрч хөл тулах юмгүй болсонд шатнаас гараараа дүүжигнэсээр доош сунаж өлмийгөөрөө газарт хүрэв. Доош бөхийж хавтагатай мөнгөө олж амандаа зуув. Тэгээд Миледиг тэвэрч аван харуулынхны явснаас эсрэг зүгт хурдан алхаж, удалгүй эргүүл явдаг замаас гарч хоёр цохионы хоорондуур эрэг рүү бугаад, усанд тулж исгэрэв.

Хариуд нь мөн адил исгэрэх дуу гараад, таван минутын дараа дөрвөн сэлүүрчинтэй завь далай дээр гарч ирэв.

Эргийн ус гүехэн байсан тул, завь аль болох хирээр ойртож ирээд зогслоо. Фельтон Миледиг хэнд ч итгэж өгөлгүй өөрөө тэвэрсээр бүсэлхий хүрсэн усаар явж очив.

Аз болоход шуурга намдаж эхэлсэн авч далай давлагаалсан хэвээр жижиг завийг зомгол мэт дайвалзуулав.

-Хөлөг онгоц руу яв, бушуухан шиг сэлж үзээрэй гэж Фельтон тушаалаа.

Дөрвөн усан цэрэг сэлүүрдэж гарсан боловч далай айхтар давлагаалан явахад маш бэрхтэй байлаа. Хэдий тийм боловч оргодлууд, цайзаас холдсоор байсан нь юунаас ч илүү чухал байлаа.

Айхавтар харанхуй шөнө байсан тул завин дээрээс эрэг бараг ялгарч харагдахгүй эргэн дээрээс завийг олж харна гэж огт санахааргүй байв.

Далай дээр нэг бараан юм ганхалзаж байх нь тэднийг хүлээсэн хөлөг онгоц аж. Дөрвөн цэрэг тэр зүг хүчлэн сэлүүрдэж байх зуур Фельтон Миледийн гарыг боосон олс, алчуур хоёрыг тайлж өгөв.

Фельтон, бүсгүйн гарыг суллаад, далайн уснаас хутган нүүр рүү нь шүрссэнд, Миледи санаа алдаад нүдээ нээж:

-Би хаана байнаа? гэж асуухад залуу дарга өөдөөс нь:

-Та аврагдлаа! гэлээ.

-Аврагджээ! Нээрээ тэнгэр энэ, далай энэ байна амьсгалж байгаа агаар минь чөлөөтэй тэнүүн газрын агаар мөн ээ дээ! Гялайлаа Фельтон, танд их гялайлаа гэж Миледи дуу алдан хэллээ. Залуу үүнд бүсгүйг тэврэн авч зүрхэндээ наалдууллаа.

-Үгүй миний гар яаж орхио вэ? Бахиар хавчиж орхисон юм шиг гэж Миледи гайхаад гараа өргөж үзэхэд үнэхээр хөшиж, энд тэндээ хөх няц болсон байлаа.

-Хөөрхий! гэж Фельтон санаа алдаад бүсгүйн гуа сайхан гарыг харж толгой сэгсэрлээ.

-Өө зүгээр зүгээр! Би одоо саналаа! гэж Миледи дуу алдсанаа, хавьдаа нэг юм хайж ийш тийш харав.

-Тэр чинь энд байна гэж Фельтон алтан зоостой хавтагыг хөлөөрөө Миледи рүү дөхүүлж бүсгүйн сэтгэлийг амраав.

Ингээд тэр хоёр жижигхэн хөлөг онгоц руу сэлж очтол, харуулын хүн учир явдал асууж, наадуул хариу хэллээ.

-Энэ юун хөлөг онгоц юм бэ? гэж Миледи сонирхлоо.

-Танд зориулж хөлсөлсөн онгоц,

-Энэ онгоц намайг хаана хүргэх юм?

--Таны хаа таалалтай газарт. Ганцхан намайг л Портсмутод буулгаж өгвөл боллоо гэхэд Миледи:

-Портсмутод та юу хийх юм бэ? гэж асуувал Фельтон зэвүүнээр мөшийгөөд Винтер гуайн тушаалыг биелүүлнэ гэлээ.

-Ямар тушаал?

-Та мэдэхгүй байна гэж үү?

-Үгүй. Та хэлээд өг л дөө.

-Бээл надад итгэхээ болиод өөрөө таныг харгалзахаар шийдэж, таныг цөлөх тухай тушаалд Бекингэмээр гарын үсэг зуруулахаар намайг явуулсан юм.

-Үгүй Бээл танд итгэхээ больсон юм бол энэ тушаалыг яаж өөрийг чинь итгэж өгөв?

-Би авч яваа бичгийнхээ доторхыг мэдэж байх албатай биш шүү дээ.

-Энэ үнэн үгээ. Та тэгээд Портсмутод буух юм бий?

-Би яарах ёстой. Маргааш харин гуравны өдөр, Бекингэм тэнгисийн цэрэг авч мордох гэж байгаа.

-Бекингэм маргааш мордоно оо? хаашаа?

-Ларошель хот руу, Миледи ердийнхөө биеэ сайн барьдаг зангаа мартаад, Бекингэмийг явуулж болохгүй! гэж дуу алдсанд Фельтон хариуд нь:

-Бүү сэтгэл зов. Бекингэм явахгүй гэлээ.

-Залуу сэтгэлийнхээ угт Бекингэмийг алахаар тогтсоныг нь Миледи илт тааж мэдээд баярласандаа хамаг бие нь зарсхийлээ.

-Фельтон... чи суут их хүн юм. Хэрэв чи үхвэл би хамт үхнээ, өөр хэлэх ч үг алгаа гэв.

Аяархан! Бид хүрч ирлээ гэж Фельтон бүсгүйг сэрэмжлэв.

Үнэхээр ч завь хөлөг онгоцонд тулж ирлээ.

Фельтон түрүүлж шатан дээр гараад Миледид гараа өгч далай бас л давлагаатай байсан болохоор усан цэргүүд түшилцэж өглөө. Нэгэн минут өнгөрөхөд тэд цөм онгоцон дээр гарсан байлаа. Фельтон хөлгийн ахмадад хэлсэн нь:

Францын наад эрэгт амар мэнд хүргэж өгөх ёстой гэж миний ярилцсан бүсгүй энэ байна гэж хэлэхэд, хөлгийн ахмад өөдөөс нь

-Мянган зоосоор хүргэж өгнө гэсэн.

-Би танд таван зуун зоос өгч орхиод байгаа.

-Яриагүй үнэн.

Миледи ярианд оролцож, үлдэх таван зуун зоос энэ байна гээд хавтгаа автал хөлгийн ахмад маргаж:

-Үгүй, би хэлсэн үгнээсээ ер буцдаггүй хүн. Үлдэх таван зуун зоосыг би францын эрэгт хүрсэн хойноо авнаа гэж энэ залууд амласан юм гэлээ.

-25 нд тэнд хүрч чадна байгаа?

-Амар мэнд хүрнэ гэж ахмад амлаад, энэ чинь миний нэр Жек Бултер гэдэгтэй адил баттай зүйл гэлээ.

-За ийм байна, та хэлсэн үгэндээ хүрвэл би танд таван зуу биш, мянган зоос өгнө гэсэнд ахмад хөөрч

-Уухай! Сайхан хатагтай!, Эрхэм таны адил ийм хүн бурхны авралаар надад олонхон дайралдаж байгаасай! гэж дуу алдав.

-Юуны өмнө та биднийг нөгөө ярьж байсан боомтод оруулна. Тийшээ хүргэж өгөх талаар бид

ярилцсан шүү дээ гэж Фельтон санууллаа.

Үүний хариунд хөлгийн ахмад зохих чигийг барих, тушаад өгөөд, өглөөний таван цагийн орчим жижиг хөлөг онгоц Фельтоны хэлсэн боомтод хүрч зогслоо,

Ингэж явах зуур Фельтон, Лондон орох тушаал аваад тийшээ явахын оронд яаж хөлөг онгоц хөлсөлсөн, хана өөд яаж завсар зайлхайгаар нь төмөр шааж гишгүүр хийсээр дээшээ авирсан. Яаж арай ядан цонхны сараалжид хүрсэн энэ тэрээ Миледид нэгд нэггүй ярьж өглөө. Үүнээс цааш болсон явдлыг Миледи өөрөө мэдэж байлаа.

Бекингэмийг алах гэсэн Фельтоны сэтгэлийг улам чангалж өгье гэж Миледи боджээ. Гэтэл сүсэгтэн залууг дөнгөж ам нээмэгц л түүнийг өөгшүүлэхийн хэрэггүй, харин хорьж татасхийвэл таарах нь гэж ойлгожээ.

Миледи арван цаг болтол Фельтоныг тэндээ хүлээх, арав болтол ирэхгүй бол замдаа орохоор хоёул ярилцаж тохирлоо

Тэгээд Фельтоныг баригдалгүй амь зайлж чадвал Францад Бетюн гэгч газар байдаг бүсгүйчүүлийн сүмд учрахаар боллоо

LIX. 1628 ОНЫ НАЙМДУГААР САРЫН 23. ПОРТСМУТОД БОЛСОН ХЭРЭГ

Фельтон салж явахдаа, түр зугаалаад ирэхээр явж байгаа ах дүү хоёр мэт Миледигийн гарыг үнсээд одов.

Фельтон гаднаасаа ердийнхөө байдлаар амгалан царайтай боловч нүд нь л хумхаа өвчинд автсан хүнийх мэт хачин гялалзах болжээ. Царайны өнгө ердийнхөөсөө баахан цонхигор, уруулаа тас жимийн үг яриа огцом ширүүн болсон нь түүний дотор гүнээ догдлон донсолсны гэрч буюу.

Хөлөг онгоцноос эрэг өөд завиар хүргүүлж явах зуураа Фельтон, онгоцны тавцан дээр зогсоод хойноосоо харж байсан Миледигээс харц салгаж чадахгүй байлаа. Тэр хоёрын хэн хэн нь хойноосоо нэхэж ирнэ гэж бараг айхгүй байлаа.

Юу гэвэл Миледийн өрөөнд есөн цагаас өмнө ер хүн ордоггүй бас тэр шилтгээнээс Лондон хүртэл гурван цаг давхих газар билээ.

Фельтон эрэг дээр бууж, гүвээний хярыг дагаж явсаар хадан цохионы оройдээр гараад, сүүлчийн удаа Миледид дохио өгч талархал илэрхийлэлцээд хот руу алхав.

Зам цаашаа уруудаж, зуун алхам хир явгал жижиг онгоцны шураг төдий харагдах болжээ. Ингээд Портсмут руу шаламгайлан алхахад боомт хотын цамхаг, байшин барилга хагас мод хирийн газарт өглөөний мананд бүрэлзэн харагдана.

Портсмутуос цаана далайд хөлөг онгоцнууд багширч, шураг сэлтнь цагийн эрхээр навчисгүй болсон царс модон ой шиг сэргийнэ.

Фельтон ийнхүү шаламгайлан алхаж явахдаа VI Яков, I Карл хааны шадар хүн Бекингэмийн тухай пуритан сүсэгтний дунд байхдаа дуулж, хоёр жилийн турш эргэцүүлэн, болсон үнэн, худал ял зэмлэлүүдийг санан санан байлаа.

Бекингэм сайдын олонд илтэд, европ дахинд мэдэгдсэн гэмт буруу хэргүүдийг Миледигийн гаргаж хэлсэн, далдуур үйлдэгч хэргүүдтэй нь харьцуулан үзээд, энэ хоёр хэргийн хэнд ч мэдэгдээгүй нууц гэм нь илүү хүнд юмаа гэж шийдэв, юу гэвэл гэнэт тэгж халуун хайр сэтгэлд автсан Фельтоны сэтгэлд, Винтер авгайн хорт муу санаа агуулан Бекингэмийг хуурмагаар муучилсан зэмлэл хэрээс хэтэрсэн ялт хэрэг санагдах нь үлгэрлэвээс ядаж шоргоолжноос ч жижиг, үнэндээ өчүүхэн хумхийн тоосыг галт шилээр харахад аймаар уухай юм болж үзэгдэхтэй адил болноу.

Хурдан явсандаа Фельтоны цус халаад, ариун дагина мэт бишрэн хайрласан бүсгүй нь ард нь хүлээж, өст хүмүүсийн гарт орох аюул тулгаран байгааг санахаас, мөн саявтархан сэтгэл түгшин зовсон, ядарч байгаа эд бүгд нийлээд залуугийн сэтгэлийг ихэд хөөргөв.

Портсмут боомтод Фельтонөглөөний найман цагийн хирд ирлээ. Хотынхон цөм босож орхисон, онгоцны зогсоол, гудамжинд бөмбөрийн дуу нижгэнэн аянд мордох цэрэг тэнгис тийш цувж байв. Фельтон усан цэргийн яаманд хүрч ирэхдээ нил хөлс, тоос болчихсон,

ердийн цонхигор царай нь халууцсан, уурласандаа улайж орхисон байв. Манааны хүн түүнийг оруулахгүй хориглосон боловч, Фельтон харуулын захирлыг дуудуулж авч яваа дугтуйгаа үзүүлээд:

-Винтер ноёны яаралтай бичиг гэв.

Винтер гуай гэгээн сайдын шадар нөхдийн нэг болохыг хүн бүр мэддэг болохоор түүний нэрийг сонсоод, бас ч Фельтон өөрөө усан цэргийн дарга хувцастай болохоор оруул гэж тушаалаа. Фельтон яаран ордонд гүйж орлоо.

Фельтоныг яг ордны үүдээр ирэх үед, бас нэг сандарч тэвдсэн, тоосонддарагдсан хүн хүрч ирлээ. Тэр хүний хөлсөлсөн өртөөний морь ордны үүдэнд хүрч ирээд зогсмогцоо багтран уналаа, Үл таних хүн, Фельтон хоёулаа герцогийн бүрэн итгэлт хиа Патрикаас Бекингэмд бараалхах зөвшөөрөл зэрэг эрэв.

Фельтон бээл Винтерийн зараалаар ирснээ хэлэхэд, үл таних хүн хэний зараалаар ирснээ хэлэхээс татгалзаж үүнийг зөвхөн герцогт өөрт нь айлтгана гэлээ. Энэ хоёр хүний хэн хэн нь нэгнээсээ түрүүлж орохыг мэрийв.

Винтер гуай герцогтой, алба ажил, анд нөхрийн холбоотойг Патрик мэддэг болохоор Фельтоныг түрүүлж оруулахаар шийдлээ. Нөгөө элч хүлээх болж, ийнхүү цаг саатаж байгаад цухалдаж байх бололтой. Фельтоныг хиа дагуулан, Субизон тайж тэргүүтэй Ларошель хотын төлөөлөгчид хүлээж байсан хүлээлгийн том өрөөгөөр өнгөрч Бекингэмийн өрөөний үүдэнд очив. Герцог өөрөө дөнгөж халуун усанд орж гараад хувцас хунараа ердийнхөө байдлаар нямбай сайн янзлан өмсч байв.

-Винтер ноёны зараалаар дэслэгч Фельтон бараалхах гэж байна гэж Патрик айлтгав.

-Винтер ноёны зараалаар ий? гэж Бекингэм давтан асуугаад, оруул гэв. Фельтон орж ирлээ. Энэ үеэр Бекингэм алтаар хатгамал тавьсан гэрийн хувцсаа тайлж зөөлөн сандал дээр хаяад сувдаар өвч хээ тавьж чимсэн хөх хамба хилэн цамц өмсч байлаа.

-Бээл яагаад өөрөө ирсэнгүй вэ? Өнөө өглөө би түүнийг ирнэ байх гэж бодсон гэж Бекингэм асуулаа.

Фельтон үүнд, шилтгээндээ өөрөө харуул харах учиртай болоод тантай ирж нүүр учрах завшаангүй болсондоо гүнээ харамсаж байгаагаа дуулгаарай гэж над захисан юм гэж өчив.

-Тиймээ, тийм би мэдэж байна. Тэднийд нэг хоригдол бүсгүй байгаа.

-Тэр бүсгүйн тухай би гэгээн ноён тантай ярилцах гэсэн юм.

-За ярь.

-Миний танд хэлэх үгийг, ноёнтон танаас өөр хэн ч сонсох учиргүй юм гэсэнд Бекингэм,

-Патрик биднийг үлдээгээд гарч бай, намайг дуудмагц орж ирэхээр ойрхон байгаарай. Би мөд

таныг дуудна гэв. Патрик гарч одлоо.

-Эрхэм ээ, бид хоёулхнаа боллоо, ярь, ярь гэж Бекингэм хэллээ.

Бээл Винтер гуай хэдэн өдрийн өмнө Шарлотта Баксон гэж нэрлэсэн нэг залуу бүсгүйг цөлөх тушаалд гарын үсэг зурж өгөхийг гуйж бичиг ирүүлсэн байхаа, ноёнтон.

-Тэгсэн, тэр тушаалаа өөрөө аваад ирэх юм уу хүнээр өгөөд явуул гэж би хариулсан. Тэр тушаалд би гарын үсэг зурж өгнө.

-Тэр тушаал энэ байна, ноёнтон.

-Алив гээд герцог Фельтоны гараас бичиг авч гүйлгэн уншиж Винтер гуайн ярьж байсан тэр тушаал мөн болохыг үзээд ширээн дээр тавьж, гарын үсэг зурахыг завдан үзгээ авлаа. Фельтон герцогийг саатуулан, уучилна уу гэгээн ноёнтон. Ингэхэд тэрзалуу бүсгүйн жинхэнэ нэр нь Шарлотта Баксон биш гэдгийг та мэдэж байгаа болов уу гэв.

-Тийм ээ, эрхэм ээ, би тэр тухай мэдэж байгаа гэж герцог хэлээд үзгээ бэхэнд дүрлээ. - Тэхлээр гэгээн ноёнтон та тэр бүсгүйн жинхэнэ нэрийг мэдэж байгаа байх нь ээ?

-Нэрийг нь би мэднээ. Ингээд герцогүзгээ, бичгэнд ойртуулахад Фельтоны дарай зэвхийрээд явчихлаа.

-Гэгээн ноёнтон та бүсгүйн жинхэнэ нэрийг мэдсээр байгаад тушаалд гарын үсэг зурна гэж үү? гэхэд,

-Тэгэлгүй яахав. Эргэлзэх ч юм алга. Фельтон улам огцомхон ширүүн дуугаар: -Винтер авгайн тухай хэрэг гэж гэгээн сайд таныг мэдэж байна гэхэд би үнэмшихгүй байна гэв.

-Би түүнийг сайн мэдэж байна. Харин та яаж мэдсэн юм бол, би гайхаж байна.

-Гэгээн сайд та тэгээд энэ тушаалд сэтгэл зовохгүй гарын үсэг зурах юм биз дээ? гэсэнд Бекингэм, залуугийн өөдөөс дээрэнгүйхэн хараад:

-Ингэхэд, эрхэм та надаас тун хачин юм асуугаад байх чинь. Үүнд хариулж байгаагаараа би танд их өршөөл үзүүлж байгаа юм шүү.

-Хариулж үз, гэгээн ноёнтон, таны бодож байгаагаас хавьгүй эгзэгтэй зүйл байгаа юм гэж Фельтон хэлэв.

Винтер гуайн зараалаар ирсэн залууг Винтерийн нэрийн өмнөөс ярьж байж таарна гэж Бекингэм бодоод жаал зөөлрөн:

-Огт сэтгэл зоволгүй гарын үсэг зурна, Винтер авхай гэмт хэрэг олныг үйлдсэн бүсгүй, түүнийг зөвхөн цөлж шийтгээд зогсож байгаа нь хэлтрүүлэн өршөөл үзүүлж байгаа хэрэг гэдгийг Винтер бээл бид хоёрын хэн хэн маань сайн мэдэж байгаа гээд герцог үзгээ бичгэнд хүргэтэл Фельтон өөдөөс нь алхам ойртоод:

-Та энэ тушаалд гарын үсэг бүү зур! гэж дуу алдав.

-Энэ тушаалд гарын үсэг бүү зур гэнээ? Яагаад тэр билээ? гэж Бекингэм гайхав.

-Яагаад гэвэл та өнгөрсөн явдлаа эргэцүүлэн санаад, Миледид зөв шударгыг баримтлах биз

-Зөв шударгыг баримталбал тэр бүсгүйг тайбернд явуулах байсан юм. Миледи гэдэг шударга журмаа алдсан бүсгүй

-Миледи чухамдаа ариун дагина шиг бүсгүй, гэгээн ноёнтон та өөрөө сайн мэднэ. Тэхлээр бүсгүйг суллан тавихыг танаас би гуйя.

-Та ер өөрийн ухаантай байна уу? Та яаж ийм үг надад хэлж зүрхэлнэ вэ?

-Намайг өршөө ноёнтон минь. Би чадах хирээрээ ярьж биеэ барихыг хичээж байна. Гэхдээ ноёнтон та юу хийх гэж байгаагаа бодож үзээд хирээс хэтрүүлэхээс болгоомжлоорой! гэхэд Бекингэм дуу алдан:

-Юу?...; Үгүй бурхан өршөөг! Энэ хүннамайг сүрдүүлж байх шиг байна гээч! гэв.

-Үгүй, ноёнтон энэ хир би танаас гуйж байна. Таны өдий төдий гэм нүглийг дээд тэнгэр харсаар өршөөж байсан, цаашаа ганцхан дуслын төдий осол гаргавал нүглийн сав дүүрч толгойд чинь хал болж мэднэ! гэдгийг танд хэлж байна гэсэнд Бекингэм хариуд нь:

-Фельтон та эндээс гарч, даруй шоронд оч гэж тушаалаа.

-Ноёнтон та миний үгийг дуустал сонсож хайрла. Та тэр залуу бүсгүйг хууран бузарлаж, хэрцгийлэн доромжлон, нэр төрийг нь гутаасан хүн. Бүсгүйд учруулсан их гай зовлонгоо цагаатгаж, эндээс саад тотгоргүй явуулж үз. Танаас өөр юу ч би шаардахгүй.

-Юу ч шаардахгүй гэнээ! гэж Бекингэм нухацтай хэлээд Фельтоны өөдөөс гайхаж харлаа. Фельтон үг ярих тусмаа сэтгэл нь улам бүр авган хөөрч:

-Ноёнтон та болгоомжлоорой. Таны ёсон бус ааш авираас англи орон залхжээ. Та ван эзний эрх мэдлийг бараг булааж аваад, урвуулан ашиглаж байна. Ноёнтон таныг хүн ч жигшмээр бурхан ч жигшмээр болсон байна. Бурхан таныг хожим гэсгээх биз, өнөөдөр би цээрлүүлнэ дээ! гэлээ.

-Энэ чинь бүр дэндлээ! гэж Бекингэм дуу алдаад, үүд уруу харав.

Тэгтэл Фельтон үүд халхлан зогсоод:

-Винтер авхайг чөлөөлөх тушаал гаргаж өгнө үү гэж танаас хүлцэн гуйя. Тэр бүсгүйг та өөрөө бузарлан хохироосноо санаач гэв.

-Эндээс зайл! Эсвэл би харуулын хүн дуудаад гав гинж зүүлгэж орхино шүү. Мөнгөн чимэгтэй ширээн дээр байсан хонхыг герцогоос халхлан зогсоод:

-Та хэнийг ч дуудахгүй . Милорд та болгоомжлоорой, та нэгэнт бурхны гарт оржээ. Бекингэм шуудхан хүн дуудахаас түдгэлзэсхийн зэргэлдээ өрөөнд байгаа улсын анхаарлыг татах санаатай чанга дуугаар:

-Чөтгөрийн гарт орлоо гэж та хэлэх санаатай байна уу? гэж дуу алдав. Фельтон герцогийн өөдөөс цаас барьж, Милорд та Винтер авгайг суллах тушаал бичиж үз, бичиж аль гэж тулгав.

-Та намайг албадах гээд байна уу? Та надаар тоглоом хийж байна аа? Хөөе Патрик! -Милорд та тушаал бич!

-Яасан ч үгүй.

-Яасан ч үгүй юу?

Герцог илдээ шүүрэн наашаа ирцгээ гэж хашгирлаа.

Гэтэл Фельтон илд сугалах завдал өгөлгүй, Миледийн өөрийгөө шархдуулсан хутгыг бэлэн барьж байснаа далайн ганц үсэрч герцог дээр буув.

Энэ үеэр Патрик өрөөнд орж ирээд:

-Милорд оо, Францаас захидал иржээ! гэж дуулгасанд

-Францаас ий? гэж Бекингэм дуу алдан, захидал ирүүлсэн байж болох хүний тухай л бодоод бусад бүх юмыг мартаж орхилоо.

Энэхэн эгшнийг Фельтон ашиглаж хутгаа герцогийнхавирга руу ишинд нь тултал шааж орхилоо.

-Аа муу новш чи намайг алж орхив оо... гэж Бекингэм хашгирлаа.

-Хүн аллаа! гэж Патрик орилов.

Фельтон зугтаах санаатай ийш тийшээ хартал, өнөөх Ларошель хотын төлөөлөгчдийн хүлээж байсан зэргэлдээ том өрөө рүү орох үүд нээлттэй байсанд ухасхийж өрөөгөөр гүйж өнгөрөөд, шатаар уруудах гэтэлшууд Винтер гуайтай халз тулгарав. Фельтоны царай зэвхий цайгаад харц нь гөлгөнөж гар нүүрэн дээр нь цусан толбо байхыг Винтер гуай хармагцаа залууг багалзуурдан аваад:

-Үүнийг би мэдсэн юм. Би гадарласан юм, гай болж, ганц минут хожигдоод ирлээ. Ээ би бас золгүй хүнээ та минь гэж дуу тавилаа.

Фельтон өчүүхэн ч эсэргүүцсэнгүй. Винтер гуай түүнийг харуулын хүмүүст өгсөнд, тэд цаашдын тушаалыг хүлээж далай руу харсан бяцхан тавцан руу аваачив.

Бээл өөрөө Бекингэмийн өрөө рүү яарлаа.

Герцогийн хашгирч, Патрикийг хүн дуудах чимээгээр нөгөө Фельтонтой зэрэг ирсэн хүн өрөөнд гүйж орлоо.

Герцог зөөлөн вандан дээр хэвтгээд шархаа гараараа тас атгажээ. Герцог суларч доройтсон дуугаар, Ла Порт Ла Порт чамайг тэр явуулав уу? гэсэнд,

Австрийн Анна хатны үнэнч хиа нь, тийм ээ гэгээн ноёнтон даанч би янз нь хожигдоо шив дээ гэв.

-Ла Порт та аяар ярь! Наад үгийг чинь хүн дуулчхаж мэднэ. Патрик чи хүн бүү оруул. Үгүй, би тэгээд Аннагийн надад хэлүүлэх гэсэн юмыг мэдэж чадахгүй нь ээ!

Бурхан минь би үхэх нь!

Ингэж хэлээд герцог ухаан алдлаа. Энэ зуур Винтер гуай Ларошель хотын төлөөлөгчид аян дайнд мордох цэргийн дарга нар, Бекингэмийн бараа бологчид бөөнөөрөө өрөөнд орж ирлээ. Хүний цөхрөн хашгирах дуу газар сайгүй, дуулдана. Ордон дүүрэн гаслан уйлж хайлж гунигт чимээ төдхөн ордны хүрээнээс халин гарч хотоор тарлаа.

Гэнэтийн чухал явдал болсныг мэдэгдэж их буу дуугарав. Винтер гуай үсээ зулгааж: -Ганц минут хожигддог байна шүү! ганц минутаар шүү! Бурхан минь, бурхан минь ямар их гай вэ! гэж дуу тавина.

Үнэхээр ч өглөөний долоон цагийн үед ордны нэг цонхноос олсон шат унжиж байгааг Винтер гуайд хүн ирж мэдэгджээ. Винтер гуай даруй Миледийн өрөө рүү гүйж очвол өрөө эзэнгүй, цонх нээлттэй, сараалж төмрийг хуурайдсан байгааг үзэж, д'Артаньяны амаараа сэрэмжлэн хэлүүлснийг санаж, герцогийн төлөө айж хэлмэгдлээ. Морины саравчинд гүйж очоод морь эмээллэж өгөхийг хүлээлгүй дайралдсан нэг морь авч унан давхисаар ирээд буун харайж шатаар өгсөн гүйж явтал Фельтонтой тулгарсныг бид өгүүлсэн билээ.

Гэхдээ герцог амьтай байлаа. Ухаан орж, нүдээ нээхэд тойрч байсан хүмүүст горьдлого төрөв.

-Эрхмүүдээ, намайг Ла Порт, Патрик хоёртой үлдээгээд гарцгаана уу... Винтер гуай та юу! Та өнөө өглөө над руу нэг хачин солиотой хүн явуулжээ, тэр чинь намайг ийм болгочоод байгааг харав уу гэж Герцог хэллээ.

-Ээ Милорд минь, би насан туршаа тайтгаршгүй зовох болно.

-Винтер найз минь тэгвэл буруудна даа. Хүнд насан турш нь санагдаж уйтгарлуулж явахаар сайн хүн нэг ч үгүйг би мэддэг юм... За биднийг үлдээгээд гарч бай даа. Бээлэгшин уйлсаар гарлаа.

Өрөөнд шархтай герцог, Ла Порт, Патрик гурав л үлдлээ. Герцогийн шадар хүмүүс эмч хайгаад олохгүй байв. Австрийн Анна хатны шадар хиа зөөлөн вандангийн өмнө сөхрөн суугаад, Милорд та эдгэрнэ, амьд явна гэж үглэнэ.

Бекингэмийн цус асгарч, тэнхээ алдравч, хайртай сайн хүнийхээ тухай ярих гэж голоо тасартал өвдөхийг үл хайхран, Анна юу бичсэн байна, юу бичээ вэ, захидлыг нь надад уншаад аль гэв. Ла Порт хиртхийж Милорд оо яаж болох вэ? гэлээ.

-Ла Порт айлдсаныг дага. Надад цаг байхгүй болж байгааг өөрөө үзэж байгаа биз дээ. Ла Порт захидлын лацыг хугалаад, бичгийг нь герцогийн нүдэнд ойртуулсан боловч Бекингэм гаргаж уншихсанаатай хичээгээд чадсангүй.

Алив унш, уншаад аль би нэгэнт юм харахаа больж байна. Унш! Би мөдхөн юм дуулж чадахгүй болчхож мэднэ шүү дээ. Тэгвэл Аннагийн юу бичсэнийг мэдэж чадахгүй үхэх нь байна гэж герцог тушаалаа. Ла Порт цааргалахаа нэгэнт болиод уншсан нь:

Милорд оо!

" Таныг таних болсон цагаас хойш таны өмнөөс, таны төлөө зовж шаналсан бүхнээ барьж гуйя, Та намайг амар тайван байлгая гэж хүсдэг бол францын эсрэг их дайнд бэлтгэхээ больж дайн зогсоож үз. Шажин гэдэг дайны шалтгаан биш зөвхөн халхавч үнэн шалтгаан нь таны надад хайр сэтгэлтэйд байгаа юм гэж улс амьтан ил ярих болж шүү дээ. Энэ дайн Англи Франц орнуудад их гай чирээд зогсохгүй, Милорд танд зовлон учруулж болох юм, үүнийг бодохоос би гүнээ шаналж байна. Бусдад хорлогдох гэж байгаа амь биеэ сайн сэрэмжилж бай. Таныг манайтай дайсагналцахаа больсон тэр цагаас аваад амь бие чинь надад чухаг дотно болох билээ. Талөгч ёсолсон Анна" гэжээ.

Бекингэм хамаг хүчээ шавхан байж захидлыг бүрэн сонслоо. Тэгээд захидлыг уншиж дууссан хойно ихэд урам хугарсан байртай:

-Ла Порт танд надад амаараа хэлэх юм үгүй гэж үү? дээ? гэж асуулаа. Байлгүй яахав гэгээн ноёнтон минь! Таныг болгоомжтой байгаарай гэж хэлүүлсэн, амь биеийг чинь хорлох санаатай байна гэж хатагтай сураг дуулсан байна.

-Ингээд л гүйцээ юу? Өөр юмгүй юу? гэж Бекингэм шавдан асууна.

-Танд хуучин шигээ хайртай сайн байдаг гэж хэлээрэй гэсэн.

-Уухайдаа!... Бурхан минь! гэж дуу алдаад, тэгвэл миний амиа алдсанд Анна гашуудах юм байна!... гэв.

Ла Порт асгартал уйлчихлаа.

Патрик нөгөө алмасан унжуурга хийж байсан хайрцгийгаваад ир гэж герцог айлдав. Патрик түүнийг авч ирэхэд хатагтайн хайрцаг мөн болохыг Ла Порт танилаа.

-Одоо хатны нэрийн эхний үсгийн сувдаар хатгамалласан хавтагыг аваад ир. Патрик энэ хэлснийг ч ёсоор гүйцэтгэв.

-Ла Порт оо, эднийг аваарай. Хатны над тал өгсний тэмдэг нь түүний өгсөн энэ хайрцаг, энэ хоёр захиа л байна. Үүнийг миний тухай эцсийн дурсгал болгож хатан эзэнд өгөөрэй. Бас

үүнийг гэж Бекингэм хэлээд хамт өгчмөөр үнэтэй юм эрж ийш тийш харав.

Бекингэм нүдээрээ бас нэг юм эрэвч үхэх нь ойртож, нүд нь бүртэлзээд, Фельтоны унагаасан ирэн дээгүүр нь цус улайрсан хутганаас өөр юм олж харсангүй. Тэгээд Бекингэм ЛаПортын гарыг атгаж:

-Энэ хутгыг хамт өгөөрэй гэж үгээ гүйцээж хэлэв. Бекингэм бас хавтагыг хайрцагны ёроолд хийж, хутгыг дотор нь хамт хийгээд, юм ярьж чадахаа больсноо Ла Портод дохиж мэдэгдлээ.

Тэгээд энэ удаа үхэхийн өмнөх салганааг давах хүч хүрэлгүй, зөөлөн вандан дээрээс шал дээр өнхрөн унав.

Бекингэм сүүлчийн удаа инээмсэглэх гэтэл амьхурааж, бодол нь тасалдаад, тэр бодол магнайд нь янагийн эцсийн үнсэлт шиг тодрон хоцорлоо.

Энэ үеэр герцогийн эмч сандран орж ирлээ. Эмч жанжны хөлөг онгоцонд суугаад явахаар зэхэж байсан учраас хойноос нь хүн явуулах хэрэг болсон ажээ.

Эмч герцогийн дэргэд очиж, гарын нь судсыг барьж үзээд доош нь тавьж:

-Юу чтусгүй. Герцог нас баржээ гэв.

-Үхчихлээ, үхчихлээ! гэж Патрик чарлав.

Түүний хашгирах чимээгээр тасалгаанд бөөн улс орж ирээд, хүн бүхэн цөхрөнгөө барж, гашуудан эмгэнэж, аль ч учраа олохгүй сандарцгаав.

Бекингэмийн амьсгалаа хураахыг Винтер лорд үзмэгцээ ордны тавцан дээр цэргүүдийн харгалзсаар байсан Фельтон руу ухасхийв.

Бекингэмийн нас барсны дараа шулуудаж гүйцсэн сэтгэл нь амарч, сэхээ орсон залууд Винтер гуай,

-Булай амьтан чи юу хийж орхив оо, новшоо! гэж зандарсанд Фельтон өөдөөс нь: -Би өшөөгөө авсан юм гэж хариуллаа.

-Өшөөгөө гэнэ шүү! Зүгээр тэр нүгэлт бүсгүйн гар хөл болсон гэдгээ хэлсэн нь шулуун биз. Гэхдээ, энэ хэрэг тэр бүсгүйн эцсийн булай үйл болно гэдгийг андгайлъя гэж бээлийг цухалданхэлэхэд Фельтон амгалнаар таны юу гэх гэж байгааг би ойлгохгүй байна, Милорд та хэний тухай ярьж байгаа юм бүү мэд. Надад ахмад цол олгох тухай таны хоёр удаагийн хүсэлтийг Бекингэм зөвшөөрөөгүй учир би түүний амийг хорлосон юм. Шударга бус аашилсны нь хариуг би түүнээс авсан, өөр юм үгүй гэж өчив.

Винтер гуайФельтоныг хүлж бий цэргүүдийг алмайран харж, ийм хэнэггүй цэвдэг байгаад мэл гайхжээ.

Фельтоны амгалан царай ганцхан юманд сэтгэл зовж байх шинжтэй. Алив нэг чимээ гарахын

хамт л, гэнэхэн сэтгэлт сүсэгтэй залууд Миледи ирээд тэврэн авч, гэм буруугаа илчлэн хүлээж, хамт үхэхээр ирж явах, дуу нь гарах шиг санагдаад байв.

Тэгтэл гэнэт Фельтоны дотор нь арзасхийж, өөрий нь зогсож байсан өндөрлөг тагтан дээрээс алсад цэлийж байсан тэнгист нэг юм нарийвчлан харлаа. Жирийн хүнд өдий хол газраас давлагаан дээгүүр хальж бий цахлай мэт харагдахуйц зүйлийг далайчин залуугийн хурц нүд францын эрэг рүү зорьж яваа бяцхан хөлөг онгоцны далбаа мөн гэж таньжээ.

Фельтоны царай зэвхий дааж, үнхэлцэг нь хагарах гэж байгаа юм шиг булгилах зүрхээ базаж авсан нь Миледийн хорт буруу санааг ойлгожээ.

Тэгээд бээлээс, Милорд та эцсийн өршөөл үзүүлээч гэж гуйлаа.

-Ямар өршөөл бэ? гэж Винтер гуайг асуухад:

-Хэдэн цаг болж байгааг хэлж өгөөч гэв.

Бээл цагаа гаргаад, есөн цагт арван минут дутуу байна гэж хариуллаа.

Миледи болзсоноосоо бүтэн хагас цагийн урьд, их буу дуугарч их хэрэг мандсаныг мэдэгдмэгц цаашаа хөдөлсөн байжээ. Тэнгэр сайхан, бяцхан хөлөг эргээс алс гараад цаашилж явна. Фельтон өмнөөс нь амиа золих болж байгаа. гайтай бүсгүйн бараа тавцан дээр нь сүүдэгнэн үзэгдэх шиг санагдах бяцхан хөлөг онгоцноос нүд салгаж чадавч, сүсэг бишрэлд бүрэн автсанхүний ёсоор:

-Бурхны таалал ийм байж дээ гэж хүлцэнгүй дуугарав. Винтер гуай Фельтоны хараа чиглэсэн зүг өөд нэг харснаа залуугийн шаналсан царай өөд хянуур гэгч нэг хараад хамаг учрыг гадарлав.

-Далай руу нүд салгалгүй ширтсээр цэргүүдэд хүлцэнгүйеэ хөтлөгдөн яваа Фельтонд Винтер гуай өөдгүй новш чи эхлээд ганц биеэрээ цээрлэл хүлээнэ хайртай сайн ахынхаа нэрийг барьж андгайлахад, чиний тэр сүлбээтэн чинь амь хэлтэрч бас чадахгүй гэхэд Фельтон ганц ч үг дуугаралгүй толгойгоо гудайлгав. Винтер лорд шатаар гүйн бууч хөлөг онгоцны зогсоол руу яарлаа.

LX. ФРАНЦАД

Бекингэмийн хорлогдсон тухайг Английн нэгдүгээр Карл ван дуулмагцаа юу юуны өмнө энэ аюулт мэдээ Ларошель хотынхны урмыг хугалах бий гэж айгаад, энэ тухай аль болох удаанаар тэдэнд дуулгахгүй байхыг хичээсэн гэж Ришелье дурдатгалдаа бичсэн билээ. Карл ван улсынхаа бүх боомт зогсоолуудыг хааж, Бекингэмийн дайчилж бэлтгэсэн цэргийг мордуултал, гадагшаа ганц ч хөлөг онгоц гаргахгүй байхыг чандлан харгалзах зарлиг буулгажээ.

Бекингэмийн нас барснаас хойш цэрэг мордуулах ажлыг ван эзэн өөрөө даахаар боллоо. Ийнхүү хориглосноо Карл ван нэн чандалж нэгэнт салж мордохын ёслолоо гүйцэтгэсэн Дани орны элчин болон, Нэгдсэн Нидерландад өөрий нь эргүүлж өгсөн баруун Энэтхэгийн хөлөг онгоцнуудыг Флиссингенд хүргэх ёстой байсан Голландын элчинг хүртэл ангилдбарьж үлдээв.

Гэхдээ ван эзэн энэ зарлигийг гунигт хэрэг болсноос таван цагийн дараа, өдрийн хоёр цагт буулгасан учир хоёр хөлөг онгоц буудлаас хөдөлсний нэг нь бидний мэдэж байгаагаар Миледиг авч явсан билээ.

Миледи болсон явдлыг нэгэнт гадарлаж байсны дээр, жанжны хөлөг онгоцон дээр хар далбаа босохыг үзээд үүнд бүр үнэмшлээ.

Хоёр дахьхөлөг онгоцны тухайд гэвэл хэн тэр хөлөг онгоц дээр явсан, яаж хөдөлсөн тухай хожим дурсъя. Ер нь энэ зуур Ларошелийн тэндэх францын цэргийн хуаранд онцын шинэ юм ер болсонгүй. Гагцхүү байнга уйтгарлаж байдаг, тэр дундаа хуаранд газар газраас илүү уйтгарлаж байсан францын ван эзэн, Людовик гэгээний баярын өдрийг Сен Жерменд нууцаар очиж өнгөрүүлэхээр шийдээд Хамбаас дөнгөж хорин шадар цэрэг бараа болгон дагалдуулахыг эрсэнд вангийн уйтгарын нөлөөнд хааяа өөрөө автан орхидог хамбатан дуртайяа зөвшөөрч эзэндээ гуйсан чөлөөгий нь олгов. Тэгээд ч Ван эзэн намрын тэргүүн сарын арван тавны наана буцаж ирэхээр ам алдсан аж.

Де Тревиль гуай өндөр гэгээнтнээс энэ тухай дуулж, эзнийг дагалдахаар зэхэж байхдаа, дөрвөн нөхөд өөрт нь үл мэдэгдэх шалтгаанаар Парис орох хүсэл ихтэй тэр ч байтугай шаардлагатай байгааг мэддэг болохоор цуг явах хүмүүсийнхээ тоонд тэднийг оруулсан нь мэдээжээр хэрэг.

Дөрвөн залуу нөхөд энэ тухай де Тревиль гуайн мэдсэнээс хойш мөч болоод дууллаа, юу гэвэл Тревиль гуай хамгийн түрүүн тэдэнд дуулгасан аж. Өөрийг ньбуучин болохыг Хамба ламтан зөвшөөрснөөр хэдий хир их өршөөл үзүүлснийг д'Артаньян сая ойлгов. Шадар цэрэг болоогүйсэн бол д'Артаньян эндээ үлдэж, нөхөд нь орхид явчих байжээ. Бонасье авгай өөрийн хамгаас өшгөн дайсан болох Миледитэй Бетюнийн сүмд дайралдаад учирч болох аюулын тухай бодохоос Парис руу буцах сэтгэл төрж байсныг дурдаад яахав. Энэ ч учраас Арамис нөгөө Тур хотноо суух өндөр дээд танил талтай оёдолчин бүсгүй Мари Мишонд захидал илгээж, түүгээр Бонасье авгайг уул сүмээс гарч Лотаринг юм уу Бельги руу буруулах зөвшөөрөл эзэн хатнаас гуйлгах гэсэн билээ. Захидлын хариуг удтал хүлээхэд хүрсэнгүй,

арваад хоноод Арамис доорх захидал хүлээн авав.

" Эелдэг хамаатан минь, манай залуу зарц бүсгүйд Бетюнийн сүмийн агаар таны бодлоор зохимжгүй байгаа болохоор, бүсгүйг тэндээс авч болох тухай эгчийн зөвшөөрлийг илгээлээ. Манай эгч үүнийг та бүхэнд дуртайяа зөвшөөрлөө. Юу гэвэл эгч өөрөө тэр сайн бүсгүйд их сайн, хожим хэрэг болбол тус болох санаатай байдаг юм. Үнсэн ёсолсон Мари Мишон" гэлээ. Энэ захидалд хавсаргасан зөвшөөрлийн үгнэ: "Энэ захидлыг авч очсон хүнд Бетюнийн сүмийн даамал нь мөн сүмд миний оруулсан миний өршөөл энэрэлд байдаг бүсгүйг өгч явуулбал зохино. Лувр ордон. 1628 оны 8 дугаар сарын 10. Анна" гэжээ.

Эзэн хатныг эгчээ гэж нэрлэдэг тэр оёдолчин бүсгүйтэй Арамисын ийнхүү садан төрлийн сүлбээтэй нь залуу нөхдөд уран хошин үг урсгах, бөөн далим болсныг хэлээд яахав. Арамис хэд хэдэн удаа час улайснаа, Портосын бүдүүн наргиа үгний хариуд, энэ тухай дахин яриа гаргахгүй байхыг нөхдөөсөө гуйгаад, цаашид энэ талаар ганц ч болов үг дуугарвал, хожим иймэрхүү хэрэг болоход садан бүсгүйгээрээ туслалцуулахгүй шүү гэлээ.

Ийм учраас, бас ч дөрвөн нөхөд хүссэндээ хүрч, Бетюнийн бүсгүйчүүлийн сүмээс Бонасье авгайг авах зөвшөөрөл олсон хойно шадар цэргийн ярианд Мари Мишон дахин дурсагдахаа болилоо. Чухамдаа дөрвөн нөхөд. Ларошелийн хуаранд өөрөөр хэлбэл францын нөгөө хязгаарт байх цагт энэ зөвшөөрлийн ашиг барагтайхан байлаа. Ийм ч учраас д'Артаньян учраа де Тревиль гуайд илэн далангүй хэлээд арга буюу чөлөө олгохыг гуйхаар завдаж байтал гэнэт ван эзэн Парис руу хорин шадар цэрэг дагуулан буцах болсон, бараа болох хүмүүсийн тоонд тэд орсныг де Тревиль гуай дуулгажээ. Дөрвөн нөхөд туйлгүй баярлаж, зарц нараа юмны хамт түрүүлүүлж явуулаад, дараа өглөө нь өөрсдөө мордлоо.

Хамба ламтан ван эзнийг Гюржераас Мо хүртэл үдэж өгөөд, ван сайд хоёр тэнд харилцан найр тавьж салав. Ван эзэн хорин гуравны наана Парист очих санаатай аль болох хурдан явахыг хичээх боловч, үе үе зугаа цэнгэл эрж бүргэдээр ан хийж саатна. Дээр цагт де Люин геоцог эзэн ванг ийм анд сургаад, ван өөрөө их хорхойтой болжээ. Ан авлах болоход хорин шадар цэргийн арван зургаа нь зугаатай цаг өнгөрөөх болсонд баярлан, үлдсэн дөрөв нь хорвоогийн юм бүхнийг муу үгээр зүхэж, ялангуяа д'Артаньян тэсч ядлаа.

д'Артаньяны чих нь үргэлж хангинаад байх болжээ. Үүнийг Портос тайлбарлахдаа урьд нэг ихээ язгууртан бүсгүй надад хэлж байсанчлан таныг нэг газарт дурсан ярьж л дээ гэв.

ХИЙД

Тэгж тэгж хорин гуравны шөнө ван эзэн бараа бологчдын хамт Парист зорьсон газраа хүрч ирлээ. Ван эзэн де Тревиль гуайд талархал илэрхийлээд, дагалдаж ирсэн шадар цэрэгт ээлжээр дөрвөн өдрийн чөлөө олгохыг зөвшөөрөөд аз дайрсан цэргүүдийг олны хөлийн зохисгүй газарт үзэгдэхийг хориглож Бастили гянданд хорих хүртэл шийтгэнэ гэж сүрдүүлэв.

Мэдээжээр эхний удаа чөлөө авсан дөрвөн хүн манай нөхөд байсныг гадарлахад бэрхгүй, тэр ч байтугай Атос дөрвөн өдрийн оронд де Тревиль гуайгаас зургаан өдрийн чөлөө авч, хоёр шөнө бас нэмээд, дөрвүүлээ хорин дөрөвний орой таван цагт мордоход де Тревиль гуай найр тавьж хорин тавны өдрөөр тэмдэглэв. Уулаас юманд эргэлздэггүй зантай д'Артаньяны

хэлсэн нь: Үгүй бурхан минь, миний санахад бид дэмий юмны төлөө өөрсдөө бөөн төвөг учруулж байна даа. Би хоёр өдрийн турш хоёр гурван морь эцээгээд (энэ хялбархан хэрэг, надад мөнгө бий) Бетюнд давхиж хүрээд, хийдийн даамал бүсгүйд хатан эзний захидлыггардуулж өгөөд хонгор бүсгүйгээ Лотаринг, Бельги хоёрын алив руу ч биш Парис руу авч ирнэ.

Ялангуяа Хамба ламтан Ларошелийн тэнд байх цагт тэр маань энд сайн нуугдаж чадна. Аян дайнаас буцаж ирсэн цагтаа бид нэг талаар нөгөө хамаатан бүсгүйн өршөөлөөр, нөгөө талаас өөрсдийн үзүүлсэн тусын ачаар хатан эзэнд бараалхаж, дуртай юмаа хийжчадна. Та нар зүгээр эндээ үлдсэн нь дээр, дэмий их хүч гаргаад юу хийх вэ? Иймхэн нэг хэргийг бүтээхэд Планше бид хоёр яваад элбэг чадна гэв.

Үүнд Атос амгалнаар хариу хэлэхдээ бидэнд ч мөн мөнгө бий. Бөгжний үнэнээс ноогдсон хувиа би дарсанд, Арамис Портос хоёр хоолонд өгч барах болоогүй. Тэхлээр бид нэгморины оронд дөрвөн морь эцээхэд ядах юмгүй байх нь тэгээд ч Бетюн гэдэг чинь нөгөө явсан газар бүхэндээ гай чирч явдаг бүсгүйтэй Хамба ламтны учрахаар болзсон хот гэдгийг бүү март гэж хачин ёозгүй дуугарсанд залуугийн бие өөрийн эрхгүй зарсхийв. Хэрэв та дөрвөн эрчүүлтэй учрах байсансан бол д'Артаньян таныг би ганцааранг чинь явуулчих байсан. Гэтэл та тэр бүсгүйтэй учрах болно, тэхлээр дөрвүүлээ явъя. Бид дөрвүүл дөрвөн зарцаа нэмээд хүч хүрэхтэйбайвал бурхны аврал билээ гэв.

Атос та намайг айлгаж орхилоо шүү! Үгүй та юунаас болгоомжлоод байгаа юм бэ чөтгөр алгад гэж д'Артаньян дуу алдахад Атос:

-Юм бүхнээс гэлээ.

д'Артаньян нөхдийнхөө Атосын нэг адил гүнээ сэтгэл түгшсэн байртай царайг хянуур ажиж хараад нэг ч үг дуугарсангүй, цөм морио давиран цаашодлоо. Хорин тавны орой тэд Аррас гэгч газар хүрч ирээд "Алтан тармуур" гэгч буудлын өмнө д'Артаньян орж аяга дарс уух санаатай буугаад байтал шуудан гардаг хашаанд морио сольсон нэг хүн гарч сэргэлэн мориор Парисын замаар довтолгов. Тэр хүнийг хаалгаар гарч явахад салхи хөдөлж, зуны адаг сар байсан атал нөмөрч явсан цувны ньхормойг хийсгэж, малгайгий нь золтой авч хаясангүй. Гэвч явуулын хүн малгайгаа хийсэнгүүт шүүрч аваад шалмаг гэгч дарж өмсөв.

Тэр хүнийг хянуур ажиж байсан д'Артаньяны царай зэвхийрч барьж байсан аягаа алдаж орхилоо.

-Та яав аа эрхэм ээ? хүүе эрхмүүдээ шалавхан ирж туслаарай, манай эзний дотор муухай боллоо гэж Планше сандрав.

Гурваннөхөд гүйж ирээд хартал д'Артаньян ухаан алдаж барих гэсэн шинж ор үгүй, морь руугаа гүйж байлаа. Гурван нөхөд замыг нь хөндөлдөв.

-Золиг минь чи хаашаа ингэж учир зүггүй тэмүүлнэ вэ? гэж Атос хашгирсанд: -Нөгөөдөх чинь! Нөгөөдөх чинь мөн! Алив би түүнийг гүйцье! гэж д'Артаньян дуу алдлаа.

-Үгүй хэн тэр вэ? гэж Атос асуувал

-Нөгөөх хүн яагаав гэлээ.

-Юун нөгөөх хүн?

-Нөгөөх хараал хүрсэн хар хүн. Надад ямар нэг аюул тулгарсан тухай бүрд дайралдаж байдаг миний муу зүгийн тэнгэр! Тэр айхтар бүсгүйтэй анх намайг дайралдахад, түүнийг дагалдаж явсан хүн. Атос найзтай тулалдахаар ярихдаа миний хойноос нь хөөж явсан хүн. Бонасье авгайг хулгайлагдах яг тэр өдрийн өглөө энэ хүн над үзэгдсэн юм. Би түүнийг харж амжлаа лав мөн. Салхинд нөмрөг нь дэрвэхийн хамт би түүнийг таньсан.

-Чөтгөр алгад гэж Атос бодлогошронгуй дуугарав.

-Мордьё эрхмүүдээ, мордьё. Хойноос нь давхивал бид түүнийг гүйцнэ.

Арамис түүнийг хориглон, найз минь тэр хүн бидний явж байгаазүгээс эсрэг тийшээ явж байгааг, мөн тэр хүн сая сольж унасан морьтой, бидний морьд ядарсан. Тэгэхлээр бид түүнийг гүйцэх горьдлогогүй байж, морьдоо дэмий эцээнэ. д'Артаньян минь, тэр эрийг орхичхоод эмэгтэйгээ аварья гэлээ.

Агтчин хашааны хаалгаар гүйж гарч ирээд, үл таних хүний хойноос ухасхийж: -Хөөе эрхэм ээ! Хөөш эрхэм ээ! малгайнаасааойчсон энэ цаасаа аваарай. Хөөе эрхэм ээ! Хөөш! гэж дуудав.

д'Артаньян түүний хашгирахыг зогсоогоод:

-Ай хө, наад цаасаа над өгөөд 50 зоос авах уу? гэсэнд,

. Ажаана уу, эрхэм ээ. Дуртайяа тэгье. Май ав! гэлээ. Агтчин сайхан наймаа хийсэндээ хөөрч, өртөөний хашаанд орсон хойно цаасыг дэлгэж үзэв.

-Юу бичсэн байна? гэж нөхөд нь асуухад:

-Ердөө ганц үг байна! гэж д'Артаньян хариулав.

-Тийм байна. Энэ тэгээд хот юм уу, тосгоны нэр байна.

- "Арментьер" -гэж Портос уншаад, Арментьер ... ийм газрын нэр дуулаагүй юм байна гэв.

-Энэ хот юм уу, тосгоны нэрийг чинь өнөөх бүсгүй бичиж шүү! гэж Атос ажиглав. -Тийм бол энэ цаасыг эцээхэн нууя. Би 50 зоос төлсөн нь талаар болоогүй байж юу магад. Мордоцгооё, нөхөд минь, мордоцгооё! гэлээ.

Ингээд дөрвөн нөхөд Бетюн орох замаар давхицгаав.

LXI. БЕТЮНИЙ ГЭЛЭН БҮСГҮЙЧҮҮЛИЙН ХИЙД

Их гэмт хэрэгтнүүд амьдралынхаа тодорхой хэсэг үед саад бүхнийг давж, аюул бүхнээс мултарч явсаар, эцэстээ нүгэлт үйлд нь цөхөрсөн дээд тэнгэрийн тааллаар гэмт муу үйлийн нь эцэс ирдэг ажээ.

Миледи ч бас тийм тавилангаар явж, хоёр улсын харуулын хөлөг онгоцны хоорондуур эвтэйхэн шургалж гараад Булоньд гойд төвөггүй хүрч иржээ. Миледи Портсмутод буухдаа өөрийгөө (францчуудад хавчигдан Ларошелиас зайлахад хүрсэн англи хүн гэж баталж) харин далайгаар хоёр өдөр яваад Булоньд буухдаа францчуудыг үзэн яддаг англичуудад хавчигдан Портсмутгоос гарсан франц хүүхэн болгож хэлэв.

Миледи бас гуа үзэсгэлэнт царайтай, ихэс дээдсийн намбатайн дээр мөнгө зоосыг баруун зүүн тийш нь тараан өгөөмөр зан гаргасан нь хамгийн сайн бие хамгаалах бичигнээс илүү тус болжээ. Боомтын дарга өвгөний найрсаг, эелдэг зан авирын ачаар ердийн элдэв ёс үзлэгээс мултарсан Миледи Булоньд ирээд шуудангаар нэг захиа явуулах л гэж түр саатав. Тэр захидлын агуулга нь:

Ларошель хотын дэргэдэх хуаранд байгаа өндөр гэгээнтэн эрхэмсэг хамба ламтан де Ришельед. Гэгээн ноёнтон Бекингэм герцог франц руу мордохгүй. Өндөр их гэгээнтэн та сэтгэл амар байж болно.

Булонь, зуны адаг сарын 25 ны орой "Миледи"

Жич "Өндөр их гэгээнтэн таны айлдсаныг дагаж би Бетюн хотын гэлэн бүсгүйчүүлийн хийдэд очиж таны цаашдын зарлигийг хүлээнэ" гэжээ.

Үнэхээр ч Миледи тэр оройдоо замд гарч шөнөдөө явсаар буудлын газарт хүрч хоноод өглөө таван цагт цаашаа хөдөлж гурван цаг болоод Бетюнд иржээ.

Бүсгүйчүүлийн хийд хаа байдгийг хүнээс сураглаад даруй тийшээ очлоо. Хийдийн ширээт гэлэн бүсгүй угтан гарч ирэхэд Миледи хамба ламтны тушаалыг үзүүлсэнд Миледид өрөө гаргаж, хоол унд өгөхийг ширээт өөрийн хүмүүст даалгалаа.

Өнгөрсөн явдал Миледигийн сэтгэлээс нэгэнт гарч зөвхөн ирээдүйн тухай бодно. Хамба ламтны нэрийг дээрх цуст хэрэгт өчүүхэн ч хутгалдуулалгүй ингэж чадмагаар хүчин зүтгэсэн болохоор өндөр их хишиг өршөөл хүлээж байлаа.

Миледигийн сэтгэлийг эзэмдэгч шинэ шинэ шунал нь нарны гэгээн гэрэл, улбар туяа, салхи шуурганы баргар өнгийг тус тус тусган агаарт хөвж хорвоо дээр зөвхөн үхэл хөнөөлийн ул мөр үлдээж явдаг үйлтэй өөрийн нь амьдралыг төстэй болгодог аж.

Миледийг цай уусны дараа хийдийн даамал уулзахаар ирлээ, хийдэд зугаа цэнгэл тун хомс болохоор сайн санаат бүсгүй шинэ зочин бүсгүйтэй танилцахыг яарчээ.

Миледи өөрөө хийдийн даамалд таалагдъя гэж бодсон нь өдий саруул цэцэн ухаантай, гуа

сайхан хүнд юун бэрх байх билээ. Миледи эелдэг, дур булаам аятайхан байхыг хичээж хийдийн сайхан сэтгэлт бүсгүй даамлыг сонин яриа, эвлэг нийцэнгүй байдлаар бүрэн татаж чадлаа.

Сүмийн ширээт гэлэн бүсгүй өөрөө өндөр язгууртан хүн байсан бөгөөд, улсын алс хязгаар, тэр дундаа хорвоогийн алив шуугиан үймээн босгоны нь дэргэд ирээд замхардаг хийдийн дотор ирж дуулдах нь тун ховор байдаг ордны тухай элдэв ярианд их дуртай хүн аж.

Гэтэл Миледи тав зургаан жилийн туршид ихэс язгууртнуудын дунд байж элдэв арга явуулга бүхнийг нь сайн мэддэг байсан хүн. Иймд францын ван эзний ордныхны нь вангийн хэтэрхий сүсэглэлтэй нам тайвнаар эвлэрэн оршдог хөнгөн хийсвэр зан төлөвийн тухай яриагаар сайн санаатсанваартан бүсгүйн уйтгарыг сэргээж, гэлэн бүсгүйн нэрийг нь мэдэх ордны эрэгтэй эмэгтэй бараа бологчдын хөг шившигтэй явдлаас дуулган, хатан эзэн Бекингэм хоёрын сэтгэлтэй сайны тухай цухас дурсав. Цаашаа бүсгүйгээс юм дуулах санаатай өдий төдий юм ярилаа. Гэтэл санваартан бүсгүй яриа чагнаж, хариу ганц ч үг унагаалгүй инээмсэглэхээс цаашгүй. Гэлээ гэхдээ иймэрхүү яриа дуулах нь бүсгүйд таатай байгааг Миледи үзээд тиймэрхүү юм жаал ярьж байснаа Хамба ламтны тухай ярьж гарлаа.

Ингэхдээ Миледи, гэлэн бүсгүй эзний төр, Хамба ламтан хоёрын алиныг бишрэгч хүн болохыг мэдээгүй болохоор баахан бэрхшээлтэй байдалд ороод, юу ч болов дундыг баримтлахаар шийдлээ. Гэтэл гэлэн бүсгүй улам ч хаширлаж, харин ирсэн эмэгтэйг их гэгээнтний нэрийг дурсах бүрд толгойгоо доош гудайлгаж байлаа.

Миледи эхлээд хийдэд их уйдна гэж боджээ. Тэгээд цаашдаа яаж байхаа даруй мэдэж авах гэж халтай ч гэсэн шулуухан үзэхээр шийдэв. Сайн санаат бүсгүйн хир их биеэ барьдаг тэвчээртэй хүн болохыг Миледи үзэх гэж Хамба ламтныг эхлээд далд утгатай үгээр, сүүлдээ илтээр муу хэлж эхлээд, гэгээн сайдын Д. Эгильон авгай Марион Делори болон бусад завхуул бүсгүйчүүлтэй явдгийг яриу.

Гэлэн бүсгүй улам их анхааран сонсч, бага багаар сэргэж, инээмсэглэх болов.

"За ашгүй, энэ бүсгүй ярианы амтыг нь авч байна. Ер нь Хамба ламын талын хүн байлаа ч гэсэн мухар сүсэг үгүйдэг" гэж Миледи дотроо бодов. Хамба ламөстнөө яаж мөрдөн хавчдагийг Миледи ярьж гарав.

Гэлэн бүсгүй сайшаах ч үгүй, зэмлэх ч үгүй дуугүй л залбирч суув.

Үүнийг үзээд гэлэнг хамбын талыг барихаасаа ван эзний талыг илүү барьдаг юм байна гэж Миледи мэдээд, яриагаа үргэлжлүүлэн, хамбыг хатуу үгээр улам муулав. Эцэстээ гэлэн бүсгүйн хэлсэн нь:

-Энэ бүх юмны талаар минийдуулсан нь даанч хол. Бид ван эзний ордон болоод хорвоогийн бусад бүх явдлаас хэдий хол боловч таны ярьж байгаа гунигт зүйлийн жишээ манайд байж байна. Манди санваартан бүсгүйчүүлийн нэг нь Хамба ламтнаас болж бишгүй зовлон эдэлсэн. Хамба өширхөж их л мөрдөж муучилсан юм байна билээ.

Танай хийдийнхний нэг гэнээ, ээ бурхан минь. Хөөрхий бүсгүйг би өрөвдөж байна! гэж Миледи дагалдан өгүүлэв.

-Таны хэлдэг зөв, хүн өрөвдөхөөр бүсгүй. Хичнээн их юм үзэж өнгөрөө вэ хөөрхий шоронд хорьж, элдвээр сүрдүүлж хатуу ширүүн харилцах цөмийг үзэж. Гэхдээ Хамба ламтанд тэгэх сүрхий үндэстэй ч байж мэднэ. Энэ бүсгүйг гаднаас нь харахад ёстой дагина шиг байвч хүнийг ямар гаднаас нь мэдэж болох биш дээ гэж бүсгүй засаж өгүүллээ.

"Ашгүй дээ, юмыг яаж мэдэх вэ, энд ч би бас нэг юмны сэжим мэдэж болох юм. Би азтай байна" гэж Миледи бодов.

Ингээд үнэн голоосоо ярьж байгаа царай гаргахыг хичээн өгүүлсэн нь:

-Нээрээ тийм шүү. Би мэднээ. Хүний эрээн дотроо гэж олон хүн ярьдаг. Гэтэл бурхны эрхэм сайхан бүтээл болсон хүнд итгэхгүй бол өөр юунд итгэх юм бэ. Би ч насан туршаа эндүүрч явлаа ч гэсэн нүдэнд дулаахан харагдсан хүнд дандаа л итгэчихдэг юм гэв.

Тэхлээр та тэр залуу бүсгүйг хийсэн гэмгүй байх гэж бодож байгаа байх нь ээ? гэж санваартан бүсгүй асуулаа.

-Хамба ламтан гуай гэмт хэрэгтнийг мөрдөхөөр барахгүй, зарим нэг буянт үйлстнийг гэмт хэрэгтнээс доор хавчин хяхдаг удаа бас бий гэж Миледи хариулав.

-Авхайтан таны үгэнд би гайхаж байгаагаа хэлж орхиё, :гэж бүсгүйг хэлэхэд, Миледи гэнэхэн байдлаар:

-Яагаад! тэр билээ? гэв.

-Таныг ийм юм ярьж байгаад, гэхэд Миледи инээмсэглэн:

-Миний ярианаас та юугий нь тэгж гайхаж байна? гэв

-Хамба ламтан таныг наашаа ирүүлсэн хойно та түүний талын хүн байж таарна, гэтэл та...

-Гэтэл би түүнийг муулж байдаг, гэж Миледи цаад бүсгүйн санааг тосчаваад гүйцээв. -Юу ч болсон та Хамбын тухай сайн юм ярьсангүй гэхэд Миледи санаа алдан: -Би Хамба ламтны талын хүн биш, гарт нь өртсөн хүн болоод тэр дээ гэв. -Үгүй тэгвэл, таныг надад захиж бичсэн Хамбын энэ захидал? ...

-Тэр захиа чинь, түүний гар хөл болсон этгээдүүдийн нэг нь иржнамайг автал энд шоронд байгаа юм шиг сууж бай гэсэн тушаал юм даа чухамдаа.

-Тэгвэл та юунд оргоогүй юм бэ?

-Хаашаа? Энэ хорвоо дээр Хамба ламтан өөртөө төвөг удаж намайг олъё л гэвэл эс 'олохоор нуугдаж болохуйц газар байдаг гэж та санана уу? Би эр хүн байсан бол бас ч болж юу магад, гэтэл бүсгүй хүнд..,Бүсгүй хүн ер юу хийж чадах вэ дээ? Үгүй танайд байгаа тэр бүсгүй

оргох гэж оролдсон уу?

-Үгүй оролдоогүй. Тэр хүн ч жич хэрэг. Янз нь нэг хүнд сэтгэлтэй болоод Францад хоригдоод байгаа бололтой, гэхэд Миледи санаа алдан:

-Тэр бүсгүй хүнд сэтгэлтэй юм бол тиймч их зовлонтой хүн биш л юм байна даа, гэлээ. Санваартан бүсгүй улам ч шохоорхсон байртай,

-За ингэхэд бас л нэг хавчигдаж шахагдсан бүсгүйтэй учрах нь энэ үү? гэхэд Миледи хариуд нь:

-Тэглээ. Хөөрхий! гэв.

Санваартан бүсгүй шинэ юм санаж, харц нь сэтгэл зовсон байртай болоод та манай ариун шашны дайсан биш биз? гэж түгдчин асуусанд: Миледи дуу алдан:

-Би юу? би буруу номтон байх гэж үү? үгүй, бидний үгийг сонсож байгаа бурхныг гэрч татаж хэлэхэд би католик шажиндаа гүн сүсэгтэй хүн шүү гэв.

-Тийм бол авхайтан та тайвшир гэж санваартан бүсгүй инээмсэглээд,-таны байгаа энэ газар танд ширүүн хатуу шорон болохгүй, таныг энэ хоригдмол байдалдаа аятай байлгахын тулд бид чадах бүхнээ хийнэ. Тэр ч байтугай, лав л ордны нэг уршигт явуулгын үрээр хясагдах болсон тэр бүсгүйтэй та энд уулзана. Зан сайтай. хөөрхөн хүн бий гэж хэллээ.

-Тэр хүний алдар хэн гэдэг юм бол?

-Нэг маш өндөр хэргэмтэн хатагтай тэр хүнийг надад Кэтти гэдэг нэрийн дор захиж өгсөн юм. Би чухам нэр овгийг нь мэдэх гэж оролдоогүй.

Кэтти гэнээ! Юу гэнээ, та лавтай санаж байна уу? гэж Миледи дуу алдав.

-Тэр хүн өөрийгөө тэгж нэрлэдэг нь үнэн үү? Лав үнэн дээ авхайтан. Та тэр хүнийг таних уу? Хуучин шивэгчин нь байсан бүсгүй мөн байж мэднэ гэж

бодоод Миледи дотроо инээд нь хүрчээ. Залуу бүсгүйн тухай дурсан санамагц Миледнгийн уур хүрч, өшөө авах шунал төрж царай нь муухай хувирав. Гэвч энэ хуурмаг бүсгүй хурамхан зуур хувирсан царайгаа өөрчилж, дахин амгалан найрсаг дүртэй болчихлоо.

-Надад бүр одоо аятайхан санагдаж байгаа тэр бүсгүйтэй би хэзээ нүүр учрах бол? гэж Миледи асуусанд, хийдийн ширээт гэлэн бүсгүй хариуд нь:

-Өнөө оройдоо юм уу, хүсвэл өдөрч уулзаж болно. Харин та дөрвөн өдрийн турш замд явсан гэж өөрөө хэлсэн. Өнөөдөр өглөө таван цагт боссон гэсэн. Тэхлээр та лав амармаар байгаа байх. Хэвтэж унт, өдрийн хоол болоход бид таныг сэрээе гэлээ.

Уулын хэрэг будлианд дуртай сэтгэл нь шинэ явдал учрах төлөвтэй болсонд хөөрсөн Миледи унтаж амрахгүй байхад ажрахгүйгээр байлаа. Гэвч сүүлийн хоёр долоо хоногийн дотор

элдэвт сэтгэл түгшиж, төмөр шиг сайн бие нь дахин нилээд ядралт даахуйц байвч сэтгэлээ тайвшруулмаар болсонд санваартан бүсгүйн үгэнд орлоо. Миледи хийдийн ширээт гэлэнмааг найрсгаар үдэж гаргаад Кэтти гэдэг нэрнээс болон өөрийн эрхгүй төрсөн өшөө авах сайхан санаашралд автан хэвтлээ.

Даалгасан зүйлийг нь урагштай бүтээж чадвал юудуртайгаа хийхийг зөвшөөрөхөөр хамба ламтан бараг шулуухан амласан нь Миледид санагдлаа. Урагштай бүтээж чадаад ирсэн хойно, д'Артаньян эрхэнд нь орсон хэрэг байлаа. Миледийн дотрыг ганцхан юм л харлуулах нь, авааль нөхөр де ла Фер гүнгийн тухай бодол аж. Нөхрийгөө үхчихсэн юм уу, францаас гарч одсон юм бодож байсан гэтэл д'Артаньяны дотно нөхөр Атос гэдэг нь байсныг нэгэнт мэджээ. Атос нэгэнт д'Артаньяны нөхөр болохоор эзэн хагагтайгаас түүний тусламжтайгаар өндөр дээд гэгээнтний санасан хэргийг нурааж унагаах элдэв явдалд туслалцаж байсан байж таарна, Атос нэгэнт д'Артаньяны нөхөр юм бол хамба ламтны дайсан мөн. Тэхлээр залуу шадар цэргийг хөнөөх урих тавьж чадна, түүндээ мөн авааль нөхөр агсан хүнээ хамран оруулж чадах бий гэж Миледи горьдов.

Энэ бүх итгэл горьдлого сэтгэлийг нь баясгаж, түүндээ бүүвэйлэгдсэн Миледи төдхөн нойрслоо. Орны дэргэд хүний аятайхан дуу гарахад Миледи сэрэв. Нүдээ нээтэл хийдийн ширээт гэлэнмаа өөрөө цайвар үстэй, булбарай сайхан царайтай нэг бүсгүй дагуулаад ирсэн, ирсэн бүсгүй өөдөөс нь цагаан цайлган сониуч байртай харж байлаа.

Залуу бүсгүйг Миледи ер зүс үзээгүй ажээ. Хоёр бүсгүй мэнд мэдэж танилцах ердийн үг солилцож хоёр биеэ хянуур ажна. Хоёулаа тун ч царайлаг гуа, гэхдээ өөр өөр төрлийн гуа бүсгүйчүүл аж. Гэвч Миледи өөрөө цаад залуу бүсгүйгээ бодвол ихээ илүү сүр буурьтай, язгууртны намбатай болохоо мэдээд дотроо инээмсэглэв. Чухам гэвэл залуу бүсгүйн өмссөн санваартны хувцас ийнхүү харьцуулахад тохиромжоор барагтай байсан юм. Хийдийн ширээт гэлэнмаа тэднийг танилцуулж өгөөд, сүмд ажил төрөлтэй байсан тул орхин одож, залуу бүсгүйчүүл хоёулаа үлдлээ.

Миледийн босоогүй байгааг хийдийн залуу бүсгүй үзээд ширээтийн хойноос дагаж гарах гэтэл Миледи зогсоогоод:

-Юу гэсэн үг вэ авхайтан, таны зүсийг би дөнгөж хартал намайг ганцаар орхиод явах гэж үү? Үнэнээ хэлэхэд би энд сууж байх зуураа тантай цуг байх болов уу гэж горьдсон юмсан гэж Миледи хэлэхэд хийдийн залуу бүсгүй хариулсан нь:

-Үгүй авхайтан, би зүгээр л зохисгүй цагт ирсэн юм болов уу гэж айсан юм. Та ядарсан, унтаж амарч байна шүү дээ.

Миледи үүнд, тэглээ гэхэд яахав? Унтаж байгаа хүнд юу сайхан байх вэ? сайхан сэрвэл сайн биз! Та намайг аятай сайхан сэрээлээ, тэгээд бүр ч аятайхан болгож өг л дөө гэв. Ингээд Миледи залуу бүсгүйн гараас татаж орныхоо дэргэд байсан зөөлөн сандал дөхүүлж өгөв. Залуу бүсгүй суугаад:

-Бурхан минь, миний хийморь ер яасан дорой байнаа. Энд би хагас жил хир ямар ч зугаа цэнгэлгүй сууж байлаа. Одоо та ирээд хоёулаа цуг хичнээн сайхан баймаар болов. Тэгтэл янз

нь би юу юугүй л энэ хийдийг орхин явах болжбайх бололтой гэв.

-Юу та мөд хийдээс явах нь үү? гэж Миледи гайхав. Залуу бүсгүй баярлаж байгаагаа огт нуулгүй:

-Би тэгнэ байх л гэж горьдож байх юм гэлээ.

-Хамба ламын гайгаар таныг их хавчигдаж зовсон тухай би бага сага юм дуулсан. Тэр үнэн бол та бид хоёр хоорондоо элэгтэй сайн байхын бас нэг шалтаг тэр болноо гэж Миледи хэлэв.

-Тийм бол ширээт гэлэн ээжийн хэлсэн үг үнэн байж. Та миний нэгэн адил тэр хорт муу гэлэнгийн гарт өртсөн хүн байх нээ?

-Аяархан, гэж Миледи залуу бүсгүйн үгийг таслаад энд хүртэл түүний тухай иймэрхүү янзаар ярихаа больё. Би мөн сайн нөхөд өөгөж үзэж байсан бүсгүйн дэргэд таны саяныхархуу үг хэлж орхисноос өдий их гай чирэгдэлд орсон хүн. Миний нөхөр намайг ховлосон юм. Та бас л хов живийн гайгаар ингэсэн хүн үү?

-Үгүй, Би нэг эмэгтэйд хайртай түүнд үнэнч сайнаас болж хавчигдсан юм. Тэр хүний төлөө амиа ч өгөхөөс хайрлахгүй байсан, хожим ч түүнийтөлөө амиа өгөхөөс буцахгүй гэж залуу хүүхэн өчив.

-Таныг гай зовлонд өртмөгц цаад эмэгтэй чинь буруу харчхаа биз дээ? Ямагт тийм байдаг юм!

-Би ч тэр хүнийг хилсдүүлж бас тэгж боддог байсан юм. Гэтэл хоёр гурван өдрийн өмнө би эндүүрснээ мэдэж, бурхны ачийг магтах боллоо. Тэр хүн намайг мартжээ гэж бодохнадад хүнд байхсан. Гэтэл та, авхайтан та сул чөлөөтэй юм шиг санагдана. Та оргоё гэвэл энэ таны дур хүслээс л болох юм биш үү?

-Би нөхөд үгүй, мөнгө үгүй, урьд хожид байж үзээгүй танихгүй нутагт юугаа хийх юм билээ, хайчих юм бэ?

-Үгүй нөхдийн тухайд гэвэл таны хаана байсан газарт л нөхөд бишгүй олдоно! Та янз нь их сайн хүн бололтой бас ийм гуа сайхан гэж залуу бүсгүй дуу алдав.

Үүнд: Миледи дагина гэмээр дур булаам сайхан инээмсэглээд,

-Миний хавчигдаж хяхагдан, ганцаардаж явахад энэ чинь тус болохгүй л байсан юм даа гэхэд залуу бүсгүй тосч аваад:

-Дээдийн авоал өршөөлд найдах хэрэгтэй юм, миний үгэнд итгээрэй. Бидний нэг хийсэн буянг сайн үйл маань бурхны өмнө биднийг хамгаалж өмгөөлөх цаг ирдэг юм. Би хэдий арчаагүй хүч мөхөс, өчүүхэн доорд хүн боловч надтай учирсан чинь таны аз болсон байж юу магад. Эндээс би нэг гардаг юм бол намайг өмөг түшигтээ багтаагаад, цаашдаа таныг өмөөрч чадах чадалтай, нөлөөтэй нөхөд надад олдоно гэв.

Миледи өөрийнхөө тухай юм яривал залуу бүсгүйг илэн далангүй ярихад хүргэх болов уу гэж горилон,

-Би ганцаардмал хүн гэдэг маань, өндөр их эрх хэргэмтэй танил тал үгүй гэсэн үг биш юм. Гэтэл тэр танил талууд маань өөрсдөө хамба ламтнаас айж сүрддэг юм. Эрх сүрт сайдаас хатан эзэн хүртэл өөрөө хэнийг ч өмөөрч зүрхлэхгүй байгаа юм. Хатан эзэн өршөөнгүй сайхан сэтгэлтэй хэдий боловч өөртөө тус хүргэсэн хүмүүсээс арга буюу өндөр их гэгээнтний гарт өгөхөд хүрч байсны баталгаа надад бий юм гэв.

-Миний үгийг итгээрэй, авхайтан. Хатан эзэн тэднийг хайхрахаа больчихсон дүр үзүүлж болох юм. Өнгөний нэг байдлаар юмыг дүгнэж болохгүй шүү дээ. Хөөрхий тэд нар хэдий их хяхагдаж хавчигдах тусам, хатан эзэн тэдний тухай улам их боддог юм. Тэгээд горьдол нэгэнт тасраад байтал хатан эзэн өөрсдий нь өршөөл энэрлээсээ гаргаагүйг мэдэж баярлах удаа олон байдаг юм шүү.

-Хөөрхий минь эзэн хатан тун сайхан сэтгэлтэй хүн, үүнд би итгэж байнаа, гээд Миледи санаа алдсанд залуу бүсгүй тосч аваад хөөрч:

-Манай өгөөмөр сэтгэлт сайхан хатагтайг та ингэж магтаж байгааг үзэхэд түүнийг таньдаг байх нээ! гэж хэлэв.

Миледи хэтэрч ам алдчихсанаа мэдээд:

-Чухам гэвэл хатагтайтай яг өөртэй нь танил байх завшаан надад олдоогүй юм, харин би хатагтайн сайн нөхдөөс олныг танина. Би де Пютанжийг танина. Англид Дюжар гуайтай танил байсан, де Тревиль гуайг танина.

-Де Тревиль гуайг танина аа! гэж залуу бүсгүй дуу алдаад, -Та Де Тревиль гуайтай танил юм уу? гэж лавлав

-Тэгэлгүй яахав. Бүр сайн танина гэлээ.

-Ван эзний шадар цэргийн даамалтай юу?

-Тиймээ ван эзний шадар цэргийн даамалтай:

-Тийм бол та хүлээж байгаарай, бид мөдхөн, тун удалгүй дотно танил, тэр ч байтугай бараг сайн нөхөд болноо. Та де Тревиль гуайтай сайн танил юм бол лав гэрт нь очдог байсан биз дээ?

-Тиймээ, байн байн очдог л байсан гэж Миледи хэллээ. Энэ чиглэлийг барьж аваад овоо урагштай худал хэлж, байгаагаа үзээд энэ л чиглэлээ барихаар шийдэв.

-Тэднийд та шадар цэргийн заримтай лав уулзалдаж байсан байхдаа?

Миледи энэ ярианд өөрөө сүрхий шохоорхож, де Тревиль гуайнд байнга очдог хүмүүсийг цөмийг нь мэднэ гэлээ.

-Тэднийхээ заримын нэрийг хэл дээ, тэгтэл тэд чинь миний нөхөд байж таарна даа үзээрэй.

-За жишээлбэл...гэж Миледи түгдэрсхийгээд де Сувиньи, ле Куртивронь, де Ферюссак гуай нарыг танина.

Хийдийн залуу бүсгүй Миледийн үгийг таслалгүй чагнаж сууснаа, Миледийн дуугүй болохыг үзээд:

-Та Атос гэдэг эрхмийг таних уу? гэв.

Миледи дээр нь хэвтэж байсан цагаан даавуу шигээ хувхай цайгаад хэдий биеэ гойд сайн барьж чаддаг хүн боловч өөрийн эрхгүй дуу алдаж, ярилцаж суусан бүсгүйнхээ гарыг шүүрч аван өөдөөс нь цоо ширтэв.

-Яав аа? Та яав? би арай танд доромжлолтой ямар нэг юм хэлж орхиогүй биз? гэж хөөрхий бүсгүй сандран асуув.

-Үгүй энэ нэрийг сонсоод бихиртхийлээ. Юу гэвэл би тэр эрхмийг бас таньдаг юм, тэгээд түүнийг янз нь сайн таньдаг бололтой хүнтэй уулзаад цочирдож орхилоо. -Тиймээ сайн, их сайн танина, ганц Атосоор барахгүй бас нөхдийг нь мэднэ. Портос, Арамис гуай нарыг танина.

-Нээрээ юу? би тэднийг бас танина гэж Миледи дуу алдахдаа хамаг бие нь хүйт даагаад явчихав.

-Та тэднийг таньдаг бол, эр зоригтой сайн хүмүүс гэдгийг нь мэдэх ёстой. Танд тусламж хэрэгтэй байсан бол тэдэнд дуулгахгүй яагаа вэ?

-Учир юу гэвэл ... гэж Миледи түгдрээд, тэдний хэнтэй нь ч би нөхрийн холбоогүй юм, тэднийг би сайн үерхдэг д'Артаньян гуайн ярианаас л мэдэх болсон юмгэж хариуллаа.

Энэ удаа залуу бүсгүйн царай хувхай цайж Миледийн гараас шүүрч аваал,-та де' Артаньян гуайг мэдэх юм уу? гэж дуу алдаад өөдөөс нь ширтлээ. Тэгээд Миледийн царай хачин янзтай байхыг ажиглаад,

-Уучлаарай авхайтан, д'Артаньянтай та ямар шүү харилцаатай юм бэ? гэж асуув. -Тэр чинь . . . гээд Миледи зовсон байртай, миний сайн нөхөр юм гэхэд цаад бүсгүй тосч аван:

-Авхайтан та намайг мэхэлж байна, та түүнтэй нөхцөж явсан хүн байна! гэв. Миледи санаа авч, үгүй, та л д'Артаньянтай нөхцөж байсан шүү! гэж хариуллаа. Би юу? гэж хийдэд суусан залуу бүсгүйг дуугарахад Миледи:

-Тиймээ та. Би одоо таныг таньж байна. Та Бонасье авгай мөн гэв.

Залуу бүсгүй үүнд гайхсан, айсандаа хэлмэгдэн ухрав.

-Бүү мэлз. Миний асуусан юманд хариу хэл! гэж Миледи шахав.

-Яах вэ дээ! Мөн байна авхайтан. Тэхлээр бид нэг хүнд сэтгэлтэй улс шив дээ?

Миледийн царайнд уур хорслын дөл уласхийснийг Бонасье авгайгаас бусад хүн харсан бол айж зугтаамаар байсан билээ. Гэтэл Бонасье авгай жөтөөрхөх сэтгэлд авгаад байсан болохоор өөрөөс нь гарна гэж итгэмээргүй их шургуу байдлаар:

-Та тэр хүнтэй нөхцсөн гэдэг үнэнээ хүлээж орхи. Аль та дээр цагт нөхцөж явсан юм уу? гэж тулгалаа.

-Миледи үүнд эргэлзэхийн эрхгүй үнэмшмээр дуугаар, Огт үгүй, хэзээ ч, хэзээ ч тийм юм байгаагүй гэж ам алдав.

Бонасье авгай үүнд таны үгэнд би итгэж байна. Гэхдээ та юунд түрүүн тэгж дуу алдсан юм бэ? гэлээ.

Үймэрсэн сэтгэлээ нэгэнт дарж, бүрмөсөн тайвширсан Миледи хариуд нь:

-Үгүй та ойлгохгүй байна гэж үү? гэж гайхсан дүр үзүүллээ.

-Би яаж ойлгох билээ? Надад мэдэж байгаа юм юу ч алга.

д'Артаньян сайн нөхрийн хувьд сэтгэлийнхээ нууцыг надад итгэмжилдэг байжээ гэдгийг та ойлгохгүй байна уу?

-Нээрээ юү?

-Сен-Клу гэгчгазар дахь бяцхан байшингаас таны хулгайлагдсан, д'Артаньян, түүний нөхөд цөхрөнгөө барж үр ашиггүй эрж сүйд болсон тухай бүх учрыг би мэдэж байгаа юм гэдгийг ойлгохгүй байна уу. Тэхлээр тантай ингэж гэнэт учирсанд би яаж гайхахгүй байх билээ. Бид таны тухай үргэлж ярьдаг байсан, д'Артаньян танд голоосоо хайртай сайн юм Тэгээд намайг хүртэл танд эчнээ сайн болгочихсон юм. Хөөрхий хонгор Констанция, явж явж би таныг олдог байна шүү, арай хийж би тантай нэг учирдаг байна шүү! гэв.

Миледи ингээд Бонасье авгайн өөдөөс гараа сарвайхад, саяхан өөрий нь өрсөлдөгч өштнөө гэж үзэж байсан залуу бүсгүй одоо үгэнд нь итгэж, үнэнч сайн нөхрөө гэж тооцохболов. - Уучлаарай намайг, уучлаарай гэж Бонасье авгай дуу алдаад Миледийн мөрөнд нүүрээ наалдуулж

-Би тэр хүнд даанч хайртай юм даа, гэв.

Хоёр бүсгүй хэсэг зуур тэврэлдэн суув. Хэрэв Миледи үзэн ядах сэтгэлтэйгээ дүйцэхээр хүч тамиртай байсан сан бол Бонасье авгай Миледид бяц тэврүүлээд л өнгөрөх байсан бизээ. Гэвч Миледи тас тэврээдалчих чадалгүй болохоороо Бонасье авгайн өөдөөс инээмсэглээд:

-Хөөрхөн хонгор минь, хөөрхий жаал охин минь! Өөртэй чинь учирсандаа би яасан их баярлаж байнаа. Алив нэг сайн ханатлаа харж авья! гэлээ.

Ингэж хэлэх зуураа Миледи бүсгүйг нэвт шувт ширтэнэ.

-Тиймээ, тийм, та яриагүй мөн байна. д'Артаньяны ярьж байсан бүхнээс би таныгтаньж байна, сайн таньж байна, гэлээ.

Миледийн цэлгэр сайхан магнай, өрөвдөж энхрийлэх байртай байгаа гялалзсан харцны цаана хорон муу санаа төрөн нуугдаж байгааг хөөрхий залуу бүсгүй хэрхэн сэжиглэх билээ.

-д'Артаньян танд зовж зүдэрсэн тухайгаа ярьсан бол миний хичнээн их шаналж зовсныг та мэдэх юм шив дээ. Гэвч түүний төлөө зовлон эдлэх гэдэг жаргалын дээд юм шүү гэж Бонасье авгай хэллээ.

Миледи амыг нь дагаж:

-Тиймээ, жаргалын дээд гэж хэлээд өөрөө ондоо юм бодож байжээ.

Бонасье авгай яриагаа залган, тэгээд ч миний зовлон мөдхөн төгсөнө. Маргааш юм уу, магадгүй өнөө орой би түүнтэйгээ дахин учирна. Тэгээд өнгөрсөн гунигт явдал мартагдана даа гэв.

-Бодол бодож сууснаа эдгээр үгийг дуулаад дотор нь сэрхийсэн Миледи өнөө орой юу? маргааш уу? Та юу хэлэх гэж байнаа? Түүнээс ямар нэг мэдээ сураг ирнэ гэж хүлээж байгаа юм уу гэж лавлав.

-Би өөрий нь ирэхийг хүлээж байгаа юм.

-Түүнийг өөрий нь үү? д'Артаньян энд ирэх юм уу?

-Тиймээ, ирнэ.

-Үгүй энэ чинь болшгүйхэрэг шүү дээ! Тэр чинь Хамба ламтантай хамт Ларошель хотыг бүслэн байлдаж байгаа, хотоо эзэлж авсан хойноо л ирэх болноо.

-Та тэгж бодож байна уу? Тэр шударга сайн эр миний д'Артаньяны чадашгүй юм гэж хорвоо дээр байдаг юм уу!

-Би танд итгэхгүй байна.

-Тэгвэл май өөрөө уншаад үз лдээ! гэж золгүй залуу бүсгүй хэт бахдаж баярласан сэтгэлээ барьж чадалгүй нөгөө захидлаа Миледид өгөв.

"Де Шеврез авгайн бичиг мөн байна тэд нар Ларошелийн хуарантай холбоотой байдаг гэдгийг би мэдэж байсан юм" гэж Миледи дотроо бодлоо.

Ингээд доорх мөрүүдийг ховдоглон уншлаа. Үүнд:

-" Хонгор охин минь бэлхэн байж бай. Манай сайн нөхөр мөд өөртэй чинь очиж уулзана.

Очихдоо өөрийн чинь аюулгүй байдлыг бодож түр хоргодуулсан тэр гяндангаас таныг гаргаж авахаар очно. Тэндээсээ гарч явахад бэлтгэ, бидний өмөг түшигт хэзээ ч бүү цөхөр".

"Сайхан гаскон залуу маань саявтар хэзээний зоригтой, голч шударга зангаараа тодров. Түүний сануулж сэрэмж өгсөнд нь нэг хүн их талархаж байгааг уламжлаарай" гэжээ. -Тийм байна, тийм байна, захидалд бүгдийг тов тодорхой бичсэн байна. Харин юун тухай сэрэмжлэл юм бол, та мэдэх үү? гэж Миледи хэллээ.

-Үгүй, Гэхдээ Хамба ламтны ямар нэг хорт явуулгын тухай тэд хатанд мэдэгдсэн байлгүй гэж таах юм..

Миледи захидлыг Бонасье авгайд буцааж өгөөд,

-Тиймээ, энэ лав тийм байж таарах байх гээд толгойгоо унжуулж бодол болов. Энэ үеэр давхиж яваа морин төвөргөөн дуулдлаа.

-Пээ Арай тэр маань биш байгаа? гэж Бонасье авгай дуу тавьж цонх рүү ухасхийв.

Миледи гайхсандаа алмайран хөшөөд орноосоо босч чадсангүй, даанч олон ер бусын явдалтай огцом тулгараад Миледи хүн болсоор анх удаа самгардаж орхилоо.

-Тэр, Тэр! Нээрээ д'Артаньян мөн гэж үү? гэж Миледи шивэгнэнэ.

Тэгээд орноосоо босч чадахгүй дээшээ гөлөрсөөр хэвглээ.

-Өө биш байнаа хөөрхий гэж Бонасье авгай санаа алдаад нэг танихгүй хүн байх юм, харин наашаа ирж байгаа бололтой юм. Тийм байнаа мориныхоо амыг татаж байна. Үүдний тэнд зогслоо... Хаалга тайлах хүн дуудаж байна гэв.

Миледи үсрэн босоод, Тэр хүн биш гэж та лавтай танив уу? гэж асуулаа.

-Тиймээ лавтай таньсан.

-Та сайн харж чадаагүй юм биш үү?

-Үгүй түүний малгайн өд юм уу нөмрөгний нь хормой төдийхнийг л харвал би андахгүй танина.

Миледи хувцсаа өмсөх зуураа:

-Ялгаагүй ээ, та тэр хүн наашаа ирж явна гэв үү?

-Тиймээ, тэр хүн бүр наашаа орчихсон.

-Тэр чинь нэг бол тантай эсвэлнадтай уулзах хэрэгтэй ирсэн хүн дээ.

-Бурхан минь та яасан их сандрав аа!

-Тиймээ, үнэнээ хэлэхэд би таны адил итгэмтгий биш, юм бүхнээс айж болгоомжилдог юм.

-Аяархан! наашаа ирж явна гэж Бонасье авгай сэрэмжлэв.

Үнэхээр ч үүд нээгдэж, хийдийн ширээт бүсгүй орж ирээд, Миледигээс:

-Булонаас наашаа ирсэн хүн табайхаа? гэж асуулаа. Миледи сэхээ самбаатай байхыг хичээж, тиймээ би ирсэн.

Намайг хэн асуугаа юм бол? гэв.

-Хамба ламтны зараалаар яваа гэх юм. Нэрээ хэлэхгүй нэг хүн байна.

-Тэгээд надтай уулзъя гэх юм уу?

-Тэр хүн Булониас ирсэн бүсгүйтэй уулзъя гэж байна.

-Тийм бол авхайтан та тэр хүнийг наашааир гэж үзээч. Бонасье авгай хиртхийж, бурхан минь, бурхан минь, муу мэдээ авч ирсэн хүн биш байгаа даа гэхэд Миледи:

-Тийм л болов уу гэж айж байна гэв.

-Би таныг тэр танихгүй хүнтэй үлдээе, тэгээд түүнийг явмагц, таныг дургүйцэхгүй бол дахиад наашаа ирье,

-Тэгэлгүй яахав. Ирээрэй гэж Миледиг хэлэхэд хийдийн ширээт Бонасье авгай хоёр гарч одлоо.

Миледи ганцаараа үлдээд үүд рүү ширтэж байтал, минут хир болоод давируулын дуу гарч шатаар цууриатан дуулдаад хөлийн чимээ улам ойртсоор үүд нээгдэн нэг хүн орж ирлээ. Хамба ламтны төлөө бие сэтгэлээ зориулсан де Рошфор гүн байхыг хараад Миледи баярлан дуу алдав.

LXII. ШУЛМЫН ХОЁР ТӨРӨЛ

А та юу энэ чинь! гэж Миледи, Рошфор хоёр зэрэг дуу алдлаа. -Тиймээ, би байна.

-Хаанаас явж байна даа тэгээд? гэж Миледи асуув.

-Ларошелийн тэндэх хуарангаас. Та өөрөө?

-Англиас.

-Бекингэм яасан бэ?

-Үхсэн юм уу, хүнд шархадсан. Би юу ч хийж чадалгүй тэндээс гарч явах гэж байхад нэг мухар сүсэгтэн этгээд түүнийг алсан.

-Рошфор инээмсэглэн:

-Тийм үү? үгүй басазтай сайхан тохиолдол оо! Үүнд чинь их гэгээнтэн маш баярлана. Та энэ тухай гэгээнтэнд дуулгасан уу? гэв.

-Би гэгээнтэнд Булонаас захиа бичсэн. Ингэхэд та яагаад энд хүрээд ирэв? -Өндөр их гэгээнтний сэтгэл зовоод, таныг эрж ол гэж намайг явууллаа. -Би дөнгөж өчигдөр ирсэн.

-Тэгээд өчигдөр оройноос нааш та юухийв?

-Би цаг дэмий өнгөрүүлээгүй.

-Өө! түүнд ч би ер эргэлзэхгүй байна шүү.

-Энд намайг хэнтэй дайралдсан гэж санана?

-Мэдэхгүй!

-Таа л даа!

-Би яаж таах вэ дээ.

-Хатагтайн шоронгоос суллаж тавьсан нөгөө залуу бүсгүйтэй дайралдлаа. -Нөгөө д'Артаньян гэдэг жаалын нөхөцсөи хүүхэн үү?

-Тиймээ,хаанабайгаагий нь Хамба ламтан мэдэхгүй байсан Бонасье авгай.

-Энэ чинь түрүүчийнхтэйгээ дүймээр бас нэг азтай сайхан учрал байна. Хамба ламтны үйлс үнэхээр бүтэмжтэй байна шүү гэж Рошфор хэллээ.

Миледи , тэр бүсгүйтэй халз нүүр тулгараад миний гайхсаныг яана гэв.

-Тэр хүн таныг таних юм уу?

-Үгүй.

-Тэгвэл та тэр бүсгүйдгэдний нэг хүн л байх нээ гэхэд Миледи инээмсэглээд: -Би түүний хамгийн сайн нөхөр нь

-Андгайлж хэлэхэд байнаа гүнгийн хатан авхай минь ганц та л ийм гайхалтай юм хийж чадах хүн юм.

Ингэхэд тэр бүсгүйн сайн нөхөр болж чадсан маань их аз болж гээч энд юу болж байгааг та мэдэх үү?

-Мэдэхгүй!

-Маргааш юм уу нөгөөдөр түүнийг аваачихаар хатан эзний зарлигтай улс ирэх юм байна. - Уухай мөн. Хэн тэр билээ? д'Артаньян нөхөдтэйгөө.

-Нээрээ тэд ингэж байж, Бастили гянданд заавал орж салах нээ.

-Тэд яагаад өнөө хүртэл наранд яваа юм бэ?

-Яая гэх вэ. Хамба гуай яагаад ч юм бүү мэл, тэдэнд нэг сайн юм.

-Нээрээ юү?

-Тийм.

-За тийм бол Рошфорта Хамбад ийм юм хэл: "Сайхан тагтаат" буудалд бидний ярилцсан юмыг тэр дөрөв сэм чагнасан байна билээ. Хамбын явсны дараа тэдний нэг нь эргэж над дээр ирээд Хамбын хайрласан ял цагаатгах бичгийг булааж авсан. Тэд мөн намайг ангид очих гэж байна гэж Винтер лордод урьдчилан хэл хүргээд, дээр алмазан унжуургын хэргийг балласан шигээ энэ удаа золтой л авсан үүргээ биелүүлэхэд минь саад болчихсонгүй. Тэр дөрвөн хүний дотроос зөвхөн Атос, д'Артаньян хоёр л аюултай улс. Гурав дахь Арамис нь де Шеврез авгайтай нөхөцсөн хүн. Түүний нууц бидний гарт байгаа хожим хэрэг болж магад болохоор амьд үлдээвэл зүгээр. Дөрөв дөх Портосын тухайд гэвэл гоёж гангалсан цагаан, тэнэг амьтан, түүнийг тоох ч явдалгүй. Үүнийг очиж хэл гэв.

-Одоо тэр дөрөв чинь цөм Ларошелийн хуаранд байх ёстой шүү дээ.

-Би өөрөө ч тэгж бодож байсан юмсан. Тэгтэл де Шеврез авгайгаас авсан захидлаа Бонасье авгай надад үзүүлж гэнэдсэнд, тэр дөрөв одоо энэ бүсгүйг ирж аваачихаар наашаа явж байгаа юм гэж бодох болгов.

-Чөтгөр алгад, яадаг билээ тэгээд?

-Миний тухайд Хамба ламтан юу гэж танд айлдсан бэ?

-Таныг хэлүүлэх юмыг дуулаад юм уу, бичүүлж аваад ир тэсэн. Тэгээд таны хийсэн юмны тухай сайн мэдсэн хойноо, явал зохихыг айлдана гэсэн.

-Тэгвэл би эндээ үлдэх учиртай болж байнаа?

-Энд юм уу, энэ хавийн нэг газарт.

-Та намайг аваад явчхаж чадахгүй юу?

-Үгүй надад, тодорхой тушаал өгсөн. Хуарангийн ойролцоо бол таныг хүн таньж орхиж болох юм. Тэгвэл таны тэнд байгаа явдал их гэгээнтний нэрэнд муу юм болж мэднэ гэдгийг та өөрөө ойлгож байгаа шүү дээ.

-За яая гэх вэ? Би энд юмуу, энэ хавьд нэг газар хүлээх хэрэгтэй болж байх шив. -Ганцхан Хамба ламтны зарлигийг хаана сууж хүлээхээ одоо надад хэлж өг. Сүүлд ирвэл таны хаана байгааг мэдэж байя.

-Ер нь би энд үлдэж чадахгүй байх шүү.

-Яагаад?

-Миний өшгнүүд мөдхөн хүрээд ирэх гэж байгааг та мартав уу.

-Тэр үнэн. Тэгвэл энэ залуу бүсгүй их гэгээнтний гараас бас мултарч одох нээ?

Миледи өөрийнхөө өвөрмөц маягаар инээмсэглээд. Тэр ч үгүй! Намайг тэр бүсгүйн сайн нөхөр гэдгийг та мартаа юу гэв.

-Нээрээ тийм шүү дээ! Тэхлээр тэр бүсгүйн тухай Хамба ламтанд би... -Сэтгэл зоволтгүй гэж хэл.

-Тэгээд болох хэрэг үү?

-Энэ юу гэсэн үг болохыг Хамба ламтан ойлгоно оо.

-Тэр тааварлах байх. Би одоо тэгээд юу хийх ёстой болж байна.

-Даруйхан буцаад яв. Хамба ламтанд ийм юм очиж дуулгахын тулд яарах ёстой, гэж би бодож байна.

-Миний сүйх сая Лилъегэдэг газарт ирээд эвдэрчихсэн

-Сайн байна даа.

-Юу нь сайн байгаа юм бэ?

-Юу гэвэл таны сүйх надад хэрэгтэй юм.

-Тэгвэл би яаж буцаж явах юм бэ?

-Морь унаад, байдгаараа давхи.

-Ингэж хэлэх танд ч амархан байна. Гэтэл зуун мод газар давхих гэдэг надад ямар шүү байх вэ?

-Юухан байхав!

-За тэгж үзэхээс биш дээ. Өөр яах вэ?

-Өөр үү? Та тэр Лильегээр дайрч өнгөрөхдөө сүйхээ нааш нь явуулаад, зарцаа мөн миний мэдэлд бай гэж хэл

-Тэгье.

-Танд лав Хамба ламтны нэг бичиг тушаал байгаа биз дээ?

-Хэрэгтэй гэж үзсэн юмаа хийхийг зөвшөөрч бүрэн эрх олгосон бичиг байна.

-Та тэр бичгээ сүмийн ширээт гэлэнмаад үзүүлээд маргааш юм уу, нөгөөдөр намайг авахаар хүн ирнэ, өөрийнхөө нэрийн өмнөөс ирүүлэх хүнд намайг өгч явуулах ёстой юм гэж хэлээрэй.

-Тэгье.

-Ширээттэй ярилцахдаа марталгүй, миний тухай муу хэлчихээрэй.

-Юунд тэх юм бэ?

-Би Хамба ламтанд хяхагдаж яваа хүн болж байгаа юм. Би тэр тэнэг Бонасье авгайд итгэл олох хэрэгтэй байна.

-Яриагүй зөв. За одоо та болсон явдлын талаар хамбад дуулгах юмаа бичиж үз дээ. -Юу болсон тухай би өөрт чинь ярьж өгсөн шүү ээ. Та ой сайтай хүн миний хэлсэн бүхнийг давтаад орхи. Бичиг чинь хаягдчихаж болно шүү дээ,

-Таны зөвөө. Сүүлд таныг энэ хавиар дэмий эрж давхихгүйн тулд хаана байхыг чинь мэдвэл одоо гүйцлээ.

-Тиймээ. За байзаарай...

-Танд газрын зураг өгөх үү?

-Үгүй би энэ хавийн газрыг сайн мэднэ.

-Та юу? Та хэдийд энд ирж байсан юм бэ?

-Би энд урьд хүмүүжиж байсан юм.

-Тийм бий?

-Урьд нэг цагт хаа нэг газар хүмүүжиж байсан явдал хүртэл хэрэг болох удаа байдаг байна шүү дээ.

-Тэхлээр та намайг хаана хүлээж байх нь вэ?

-Жаахан бодоод. орхиё... За ингэхлээр Армантьергэгч газарт хүлээе.

-Армантьер гэгч чинь ямар газар юм бэ?

-Лис голын эрэг дээр байдаг бяцхан хот. Би нэг жаахан гол гатлаад орхихын хамт л харь улсын нутагт орж явчих юм байгаа юм.

-За их сайн. Та ч яахав аюул тулгарвал л гол гатлах юм байгаа биз дээ? -Тэгэлгүй яахав.

-Тэх учрал дайрчээ гэвэл би таныг хаанаас олох вэ?

-Танд зарц чинь хэрэгтэй юу?

-Үгүй дээ.

-Тэр чинь итгэлтэй хүн үү?

-Бүрэн итгэлтэй. Шалгагдсан хүн.

-Тэр хүнээ надад өг. Түүнийг хэн ч танихгүй. Би явах хэрэг гарвал тэр чинь энд үлдээд, танд миний очсон газрыг зааж өгнөбиз.

-Ингээд та Армантьерт намайг хүлээх болов шив.

-тийм ээ. Армантьерт.

-Тэр нэрээ цаасны өөдсөн дээр бичээд аль. Би мартаад орхих бий. Хотын нэр бичихэд муу юм байхгүй шүү дээ, тийм биз?

-Юмыг яаж мэдэх вэ?... За яахав, би сайн нэрэндээ хөө болж мэдмээр юм хийхээс гэж Миледи зөвшөөрөөдгижиг цаасан дээр тэр хотын нэрийг бичиж өглөө.

Рошфор тэр цаасыг Миледийн гараас авч эвхээд малгайныхаа дотор хавчуулав. -За сайн. Гэхдээ сэтгэл зовох юмгүй би үүнийг хаячихдаг юмаа гэхэд зам зуураа энэ үгийг хүүхэд шиг уншаад явья. За ингээд гүйцэх шив дээ?

-Гүйцсэн байхаа.

-Сайн санаад үзье. Бекингэм үхсэн юм уу, хүнд шархадсан, Хамба ламтан та хоёрын яриаг

дөрвөн цэрэг сэм чагнасан, Таны Портсмутэд очих тухай Винтер Лордод урьдчилан хэл хүргэсэн байсан. д, Артаньян Атос хоёрыг Бастили гянданд хийвэл зохино. Арамис гэгч нь де Шеврез авгайтай нөхөцсөн; Портосыг тоох явдалгүй, Бонесье авгай олдсон... Танд аль болох түргэнээр сүйх илгээх; Зарцаа би танымэдэлд ирүүлэх хийдийн ширээт бүсгүйд элдэв сэжиг төрүүлэхгүйн тулд таныг Хамба ламтанд хавчигдаж яваа хүн мэтээр ойлгуулах; Лис голын эрэг дээрх Армантьер хот, за энэ шив дээ?

-Тиймээ эрхэм та гайхалтай сайн ойтой хүн юм, Ингэхэд бас нэг жаахан юм нэмж орхиорой.

-Юу тэр вэ?

-Хийдийн цэцэрлэгээс цаашаа залгаад сайхан ой байгаа харагдсан. Тэр ойд зугаалахыг надад зөвшөөрсөн юм гэж хийдийн ширээтэд хэлж орхиорой. Арын хаалгаар гарч явахад хүрэхийг хэн байг гэх вэ гэв.

-Та чухам юм бүгдийг нарийн боджээ.

-Та харин бас нэг юм мартаж орхисон байна.

-Юу тэр билээ.

-Надад мөнгө хэрэгтэй эсэхийг асуухаа.

-Нээрээ тийм. Таид хэдий хир юм өгөх вэ?

-Байгаа бүх мөнгөө аль.

-Надад таван зуугаад алтан зоос байна.

-Над д ч мөн төдий хир юм бий. Мянган алтан зоостой хүн ямар ч хүнд байдлаас гарч болох байлгүй. Өвөртөө байгаа бүхнийг гаргаад өг.

-Авч үз.

-За сайн та хэдийд явах вэ?

-Цаг богоод мордье. Би бушуухан нэг юм идээд орхиё. Тэр зуур өртөөний морь руу хүн явууллаа.

-За сайн яваарай эрхэм ээ.

-Сайн суугаарай гүнгийн хатан авхайтан.

-Хамба ламтныг гүнээ хүндэтгэдгийг минь уламжилж үзээрэй.

-А та миний хүндэтгэлийг шуламд уламжлаарай. Рошфор Миледи хоёр инээмсэглээд салав.

Цагийн дараа Рошфор буцаж давхиад таван цагийн дараа Аррас гэдэг газарт хүрчээ.
д'Артаньян түүнийг яаж таньсан, ийнхүү учирсны улмаас дөрвөн нөхдийн сэтгэл улам
түгшин замдаа яарах болсныг уншигч авгай нар мэдэх билээ.

ЛХШ. НҮГЛИЙН ТУЛАМ ДҮҮРЭВ

Рошфорыг гармагц Бонасье авгай эргэж ирээд Миледийн баяртай инээмсэглэж байхыг харав. За ингээд таны айж байсан км чинь ёсоор боллоо шүү. Өнөө орой юм уу маргааш таныг авахуулахаар Хамба ламтан хүн ирүүлэх гэнэ, гэж Бонасье авгай дуулгалаа.

-Үүнийг хэн чамд хэлэв, хүү минь? гэж Миледи асуулаа.

-Үүнийг би ирсэн хүний амнаас чихээрээ дуулсан.

-Наашаа ирээд энд миний дэргэд суу, гэж Миледи хэлэв.

-За.

-Байзаа, бидний үгийг хүн чагнаж байна уу, үгүй юу би үзээд орхиё.

-Юунд ингэж болгоомжлоод байгаа юм бэ?

-Танд одоо хэлж өгнө,

Миледи босч үүд рүү очиж хаалга онгойлгож гудам руу харснаа, эргэж Бонасье авгайн хажууд суугаад асуусан нь:

-За тэгвэл тэр хүн чинь больё гэсэн хүнээ болж чадаа юм шив?

-Хэн тэр вэ?

-Хийдийн ширээтэд хамба ламтны зараалаар яваа хүн болсон тэр хүн. -Тэр хүн тэгээдхудлаа тийм хүн болсон юм уу?

-Тиймээ хүү минь.

-Тэгвэл тэр хүн чинь... юу биш байх нээ?

-Тэр хүн миний ах юм, гэж Миледи шивнэсэнд, Бонасье авгай дуу алдаж: -Таны ах аа? гэв.

-Хүү минь, энэ нууцыг ганц чи л мэдэх боллоо. Үүнийг хэн нэг хүнд задруулбал би дүүрлээ гэсэн үг чи ч бас өртөж магад шүү.

-Ээ бурхан минь!

-Чагнаж бай, ийм хэрэг болсон юм. Манай ах надад туслах хэрэг болбол хүчээр намайг суллаж авах санаатай наашаа яарч явах зуураа, миний хойноос Хамба ламтны явуулсан элчтэй дайралдаад, хойноос нь явжээ. Хүнгүй зэлүүд газар гарсан хойноо ах илдээ сугалаад элчийг сүрдүүлэн үнэмлэх бичгийг нь авах гэсэнд элч хүн биеэ хамгаалах гэжээ. Тэхлээр нь ах түүнийг алчихсан байна.

Бонасье авгайн дотор арзасхийгээд, Пээ та минь! гэж зүрх алдав.

-Бодооч, өөр л аргагүй байж шүү дээ, Ах цаашаа хүчээр биш, аргаар оролдъё гэж шийдсэн гэнэ. Ах тэр хүний үнэмлэх бичгийг аваад, наашаа хамбын өөрийн нь элч болж иржээ. Ингээд нэг юм уу хоёр цагийн дараа, намайг авахаар их хамбын нэрийн өмнөөс сүйх тэрэг ирнэ.

-Би учрыг мэдлээ, тэр сүйхийг танай ах ирүүлэх юм шив.

-Яриангүй зөв. Үүгээр бас зогсохгүй, таны тэр; Щеврез авгайгаас авлаа гэж бодсон захидал чинь...

-Юу гэж?

-Хуурамчзахиа юм байна.

-Яагаад тэр вэ?

-Тиймээ хуурамч юм. Таныг авах гэж ирэх үед эсэргүүцэл гаргуулахгүйн тулд зохиосон ов байж.

-Үгүй д'Артаньян ирнэ шүү дээ,

-Төөрөлдөхөө больж үз, д'Артаньян нөхдийнхөө хамт Ларошелийн хуаранд байгаа. Үүнийг та хаанаас мэдээ вэ?

-Хамба ламтны явуулсан улс шадар цэргийн хувцас өмсөөднаашаа ирж явсныг ах үзсэн байна. Таныг гадаа уулзъя гэж дуудаад, нөхдөө ирлээ гэж санаад гарахын хамт хулгайлан авч, Парис, руу авч очих байж шүү дээ.

-Бурхан минь. Энэ эх захгүй олон гэмт хэргийн дотор миний толгой бүр эргэж орхилоо. Цаашид энэ янзаар үргэлжлэх юм бол би солиорох нь байнаа гэж Бонасье авгай духаа барив. - Байзаа. Юу вэ?

-Морин төвөргөөн сонсогдож байна, манай ах мордож байгаа нь энэ. Ахыгаа дахин нэг хармаар байна, нааш ир гээд Миледи цонх нээж, Бонасье авгайг өөр рүүгээ ир гэж дохив. Залуу бүсгүй босч очлоо.

Рошфор цонхон доогуур давхиж өнгөрөхөд Миледи,

-Сайн яваарай ахаа! гэж хашгирлаа.

Хоёр залуу бүсгүй нэг дор байгааг явуулын хүн харж, Миледид нөхөрсгөөр даллаад давхин одов. Миледи энхрийлсэн, гуньсан царай гартан,-

-Сайн хүн дээ, Жорж ах минь! гэж хэллээ.

-Авхайтан өршөөгөөрэй, таны юм бодоход би саад болоод орхив уу? Та намайг юу хий гэж зөвлөмөөр байна? Бурхан минь. Амьдралын хэрэгт та надаас илүү туршлагатай юм. Явал зохихыг зааж өгөөч гэж Бонасье авгай Миледигээс гуйлаа.

-Юуны өмнө би эндүүрч байж болох юм. д'Артаньян нөхөдтэйгөө нээрээ хүрээд ирж болох юм.

Тэгвэл даанч үнэмшмээргүй сайхан хэрэг болохсон. Би тэгэхээр их азтай хүн биш ээ! гэж Бонасье авгай дуугарав.

Тийм бол энэ зөвхөн цаг хугацааны асуудал, уралдаан аятай, хэн түрүүлж ирэхээс хамаг хэрэг шалтгаацахыг та ойлгож байгаа шүү дээ. Танай нөхөд амжаад ирвэл та аврагдана, Хамба ламын гар хөл бологсод ирвэл дүүрлээ гэсэн үг.

-Нээрээ тийм ээ, тийм, нэгмөсөн дүүрлээ? яах вэ, юу хийвэл таарах вэ? -Янз нь бүтэж болмоор ганц амархан арга байх шиг байна.

-Ямар арга вэ, хэлж өгөөч.

-Ойр хавьд нэг газар нуугдаад, таны хойноос ирсэн улс юун хүмүүс болохыг эхлээд мэдэх арга байна.

-Хаана хүлээх вэ тэгээд?

-Үүнийг бодож олоход ч амархан. Би өөрөө эндээс хэдэн мод газарт очиж, ахыгаа иртэл ньхоргодно. Ингэхэд би таныг аваад явъя, хоёулаа нуугдаад цуг хүлээе.

-Намайг эндээс гаргахгүй шүү дээ, би чинь хоригдол хүний байдалтай байгаа хүн. -Эндхийн улс намайг хамбын тушаалаар явж байгаа гэж бодоод таныг надтай цуг явахыг лав дурлахгүй гэж санана.

-Тэгээд?

-Тэгээд сүйх хүрээд ирнэ. Та надтай салахын үг солилцож, сүйхний гишгүүр дээр гарч сүүлчийн удаа намайг тэврэх гэнэ. Намайг авахаар ирэх ахын зарц урдаас учир мэдсэн байна. Тэгээд хөтчид дохио өгөхийн хамт бид давхиад алга болно гэлээ.

-Үгүй д'Артаньян хэрэв... д'Артаньян яваад ирвэл яах юм бэ?

-Бид энэ тухай мэдэх болно.

-Яаж тэр вэ?

-Түүнийг мэдэхээс амархан юу байх вэ. Бид Бетюн руу манай ахын зарцыг буцааж явуулна. Дахиад хэлэхэд тэр хүнд бид бүрэн итгэж болно. Тэр зарц өөр хувцас өмсөөд хийдийн хажууд ирж сууна. Хамбын хүмүүс ирвэл эндээ сууж л байна. д'Артаньян нөхөдтэйгөө ирвэл бидэн дээр дагуулж ОЧНО гэв.

-Тэр зарц чинь манай нөхдийг таних юм гэж үү?

-Танилгүй яахав. д'Артаньяны манайд ирэхийг тэр бишгүй үзсэн юм чинь.

-Тийм, тийм таны зөв. За тэгвэл бүх юмны арга ая олдож сайн тийшээ болж байх шив. Харин эндээс хол явахаа больё.

-Хамгийн холдоо, долоо найман мод газар очно. Бид яг хилийн дэргэд буйдгазарт хоргодоод, түгшүүртэй байдал илэрсэн тухайд Франц нутгаас гараад явж орхино.

-Тэр болтол юу хийх вэ?

-Хүлээнэ.

-Хэрэв тэд ирвэл яах вэ?

-Манай ахын сүйх түрүүлж. ирнэ.

-Таныг авахаар ирэх үед би цуг байхгүй, ухаан нь тэр үеэр би үдийн юм уу, оройн хоол идэж байвал яах вэ?

-Нэгюм хийх хэрэгтэй.

-Юу тэр вэ?

-Хоёулаа аль болохоор салалгүй цуг байхын тулд үд, оройны хоол надтай хамт идэх зөвшөөрөл сайхан ааштай ширээтээс гуйх хэрэгтэй.

-Зөвшөөрөх болов уу?

-Зөвшөөрөлгүй яахав?

-Их сайн, тэгвэл бид ганц ч минут бүү салъя.

-Та ширээт бүсгүй дээр очиж зөвшөөрөл гуй. Миний толгойнэг дүйрээд байна, гарч цэцэрлэгээр зугаалъя

-Яв даа, тантай би хаана уулзах вэ?

-Нэг цагийн дараа эндээ уулзъя.

-Энд цагийн дараа .. Гялайлаа, та үнэхээр сайн хүн юм.

-Таны төлөө би санаа тавилгүй яах вэ? Та өөрөө ийм дур булаасан гуа сайхан хүн биш байлаа гэж бодсон ч гэлээ. минийхамгийн сайн нөхдийн нэгний дотно хүн шүү дээ.

-Хонгор д, Артаньян минь, танд яасан их баярлах бол.

-Баярлах л байх гэж санаж байна. За бид бүх юмаа ярьж тохирлоо, одоо доошоо бууя. -Та цэцэрлэг рүү орох уу?

-Тэгнэ.

-Энэ гудмаар яваад жижиг шатаар доошоо буу, шулуухан цэцэрлэг рүү оруулж орхино. За ашгүй, гялайлаа, гэж Миледи дуугарав.

Залуу хоёр бүсгүй өөд өөдөөсөө эелдгээр инээмсэглээд саллаа.

Толгой нэг хачин дүйрээд гэж Миледи үнэн хэлжээ. Нарийн цэгцрээгүй элдэв санаа толгойд нь үймэлдэнэ. Санаа бодлоо цэгцлэхийн тулд ганцаараа сэлүүхэн байх хэрэгтэй байжээ. Цаашид болох явдлуудыг Миледи бүдэг бадаг төсөөлж байсан болохоор нам тайван байж тодорхойгүй байгаа санаагаа нарийн оновчтой болгон юу хийх төлөвлөгөөгөө боловсруулах хэрэгтэй байв.

Юуны өмнө Бонасье авгайг аль болох түргэн хулгайлж аваачаад найдвартай газар нуух, хэрэг болох юм бол барьцааны хүч болгох хэрэгтэй байлаа. Миледи өөрөө хэдий их хорсол занал гаргаж байгаачлан өштнүүд нь өчнөөн их няцалтгүй махарч байгаа энэ ширүүн тэмцлийн хойч юу болох бол гэхээс Миледи зүрхшээх болжээ. Тэгээд ч зарим хүн өөртөө аюул учрах гэж байгааг мэдэрдэгчлэнтэмцэлдээний үр уршиг гарах цаг ойртлоо, заавал ч үгүй аймшигтай муухайгаар төгсөх болж гэдгийг Миледи зөгнөөд байлаа.

Ингээд Миледийн гол зорилго нь бидний хэлсэнчлэн Бонасье авгайг гартаа оруулж авах явдал байв. д'Артаньяны амин гол нь амь амьдрал нь Бонасье авгай байлаа. Хайртай сайн бүсгүйнхээ амь насыг өөрийнхөөс илүүд үзнэ. Миледийн хийморьдоройтож, хэрэг нь бүтэлгүй болбол Бонасье авгайг барьцаанд барьж байгаад яриа хэлэлцээ хийж, өөртөө ашигтай юм болзож чадах нь магад билээ. Энэ зорилгоо Миледи нэгэнт биелүүлсэн. Бонасье авгай өөрт нь итгэн, дагаж явахад бэлхэн болсон. Хэрэв хоёулаа Армантьерт нуугдаж орхивол д, Артаньяныг Бетюнд ирсэнгүй гэж Бонасье авгайд итгүүлэхэд хялбархан байхсан. Их удаад хагас сар бололгүй Рошфор эргэж ирнэ. Энэ хагас сарын дотор дөрвөн нөхдөөс өшөөгөө авах аргыг Миледи сүвэгчилж чадна. Бурхны авралаар уйдаахгүй, тиймэрхүү зантай бүсгүйд өшөө авах аргаа нарийн бодож боловсруулах гэдэг хамгийн сайхан зугаа билээ.

Миледи юм бодох зуураа цэцэрлэгийг ажиж, байр, байдлыг нь тогтоож авахыг хичээж байлаа. Цэргийн сайн жанжин хүн дайнд ялж, ялагдаж болох боломжийг адил хянан үзэж, дайны байдлаас болон урагшаа давших юм уу ухрах бэлтгэлээ хийдгийн үлгэрээр Миледи ажиллаж байлаа. Цагийн дараа нэг хүн өөрийн нь эелдэг дуугаар дуудсан нь Бонасье авгай байлаа. Сайн ааштай ширээт, гуйсныг дуртайяа зөвшөөрсөнд, залуу бүсгүйчүүд оройн хоол идэхээр цуг явлаа.

-Тэднийг хашаанд орж иртэл сүйх тэрэг ойртож яваа чимээ дуулдлаа.

Миледи чагнаад, -та юм дуулж байна уу? гэж асуув.

-Дууллаа, үүдэн дээр сүйх тэрэг ирж зогслоо.

-Тэр чинь манай ахын явуулсан сүйх мөн.

-Ээ бурхан минь!

-За боль доо, зоригоо чангал

Миледи андуурсангүй, хийдийн хаалган дээр хонх дуугарч хүн дуулдлаа.

-Таөрөөндөө ор, танд авч явмаар үнэтэй цайтай юм бий байлгүй гэж Бонасье авгайд Миледи хэллээ.

-Надад түүний маань захидлууд бий.

-За түүнийгээ аваад манай өрөөнд ир. Бид шалавхан хоол идэж авна. Шөнө туж явах хэрэг гарч мэднэ. Хүч сэлбэж авах хэрэгтэй гэв.

Бонасье авгай зүрхээ дарж,

-Бурхан минь зүрх туних цохиод байна, би явж чадахгүй нээ, гэж дуугарав.

-Зүрхээ чангал, зоригтой бай гэж танд хэлж байна шүү. Мөчийн дараа та аюулаас аврагдсан байна гэдгийг бодоод үз. Таны хийх гэж завдаж байгаа юм бүхэн чинь д'Артаньяны тулд гэдгийг санаарай.

-Нээрээ тийм тийм, Цөм түүний тулд. Та ганц энэ үгээр л миний зоригийг сэргээлээ. Явж бай, би хойноос чинь очно гэв.

Миледи яаран дээшээ өрөөндөө орж, Рошфорын зарцтай уулзаад зохих заавар өглөө.

Тэр хүн хаалган дээр хүлээж байх, хэрэв шадар цэргүүд хүрээд ирвэл чигээрээ давхиж, хийдийг тойроод ойн цаад талд байгаа жижиг тосгонд хүрч тэндээ хүлээх ёстой боллоо. Тэгвэл Миледи цэцэрлэгээр дамжин тэр ойд орж, явгаар хүрч очих ажээ. Миледи энэ нутгийг сайн мэднэ гэдгийг бид дээр дурссан билээ.

Шадар цэргүүд ирдэггүй юм бол хэргийг түрүүчийн тохирсон ёсоор бүтээх боллоо. Үүнд Бонасье авгай дахин Миледитэй тэврэлцэх л гэж сүйхний гишгүүр дээр гарна тэхлээрнь Миледи тэр чигээр нь авгад давхих юм.

Бонасье авгай орж ирлээ. Түүнд төрж болох элдэв хардлагыг цайруулах зорилгоор сүүлчийн үгээ Миледи дэргэд нь зарцад дахин хэлж өглөө.

Миледи сүйхний тухай зарцаас хэдэн юм асуув. Сүйхэнд гурван морь хөллөсөн өртөөний хөтөч тэргээ жолоодож, Рошфорын зарц зүгээр дагуул хүний журмаар явах учиртай юм байж.

Бонасье авгайд хар төрж магад гэж Миледигийн болгоомжилдог илүү ажил байлаа. Хөөрхий бүсгүйн. сэтгэл даанч ариун цагаан, бүсгүй хүнд өдий муухай хар санаа байна гэж санахааргүй хүн билээ. Тэгээд ч хийдийн даамлаас сонссон Винтер гүнгийн хатан гэдэг

нэрийг ерөөсөө сонсоогүй тэр ч байтугай өөрийг нь ингэж их гай зовлонд учрах явдалднэгэн бүсгүй хүн хүч тавин оролцсоныг ч гадарлаагүй явсан билээ.

Зарцыг гарахын хамт Миледи

-За харж байгаа биз дээ, цөм бэлэн болсон. Хийдийн даамал сэжиг авсан юм юу ч үгүй, Хамбын тушаалаар намайг аваачих гэж иржээ л гэж бодож байна. Энэ хүн одоо хэрэгтэй заавар өгөхөөр явлаа. Жаахан юм ид, балга дарс уучих, тэгээд хөдөлье.

Тэгье, явья, гэж Бонасье авгай аялдан дуугарав.

Миледи бүсгүйг дохиогоор урьж суулгаад испани дарс хундагалж, тахианы өвчүүтэй хэсэг мах тавган дээр нь тавилаа.

-Юм бүхэн бидэнд тохиромжтой болж байгааг хараач! Одоо бүрэнхий болж байна, Үүрээр бид хоргодох газраа хүрнэ, тэхлээр бидний хаана байгааг хэн ч мэдэж чадахгүй. За боль доо. сэргэлэн бай. жаахан юм ид гэж Миледи хэлэв. Бонасье авгай ая дагаж хэдэн үмх мах идээд дарснаас амслаа.

-Үгүй ууж орхи наадахаа, надаас жишээ ав гээд Миледи хундагатай дарсаа барилаа. Гэтэл яг хундагандаа уруул хүргэхээр завдтал нь алсад морин төвөргөөн сонсогдоод, гар нь өргөөстэй хэвээрээ зогсчов. Морин төвөргөөн улам ойртсоор, даруй морь янцгаах чимээ гарлаа.

Биднийг сайхан юм зүүдэлж байтал тэнгэр дуугараад сэрээчихдэгийн адил энэ чимээ Миледигийн баяртай таатай байсан дотрыг эгшин зуур барайлгав. Миледийн царай зэвхийрээд цонх руу ухасхийлээ. Бонасье авгайн хамаг бие дагжиж босоод, ойчихгүй гэж сандлаа түшиж байлаа.

Харагдах юмгүй, морин төвөргөөн л улам улам ойртон сонсогдсоорбайлаа.

-Бурхан минь, энэ чинь юун чимээ вэ? гэж Бонасье авгай асуулаа.

Миледи төрөлхийнхөө айдас хүрэм их самбааг гаргаж,

-Энэ чинь нэг бол манай нөхөд, үгүй бол өшгнүүд ирж байна гэж хариулаад, тэндээ зогсож бай, хэн болохыг нь би одоо танд хэлж өгье гэв. Бонасье авгай гантиг цоолбор шиг цонхигор царайлан үг дуугүй дороо нам зогсоно.

Морин төвөргөөн улам чангарч, морьд одоо хийдээс зуун тавиад алхмаас холгүй ирсэн бололтой, зам тэрүүхэн хавьд тохойрсон болохоор л тэд төдий болтол нүдэнд харагдахгүй байтаа аж. Гэхдээ морин туурайн чимээгээр нь хэдэн хүн явж байгааг нь хүртэл тоолж болмоор тов тодхон дуулдах боллоо.

Ирж яваа улсыг таньж болмоор гэгээ тасраагүй байсан тул Миледи зам руу хүчлэн ширтэж байлаа.

Гэнэт замын тойруугаар гялалзсан чимэг хадсан бүрх малгайн өд салхинд дэрвэж явах

харагдаад эхлээд хоёр, дараа нь тав, эцэстээ найман хүн давхиж ирэхийг Миледи тоолов. Тэдний нэг нь урагшаа хэд хэдэн алхам газар тасран гарчээ. Урагшаа тасран гарсан хүн д'Артаньян мөн болохыг Миледи таниад дотроо ёолоод орхилоо.

-Бурхан минь, бурхан минь юу вэ цаана чинь? гэж Бонасье авгай дуулдлаа. -Энэ чинь Хамба ламын торгон цэргүүдийн жагсаал хувцас байна гэж Миледи хашгираад, явья зугтаая гэлээ.

Бонасье авгай мөн аялдаж, тэгье зугтъя гэсэн боловч айсандаа хөшиж орхиод хөдөлж чадахгүй байв.

Морьтой улс цонхон доогуур давхиад өнгөрөх нь дуулдлаа.

Миледи залуу бүсгүйг гараас нь шүүрч аваад чирэхийг оролдон, явья, явья л даа! гэж дуу алдаад,

-Цэцэрлэгээр дамжаад бид зугтааж амжина, надад түлхүүр бий... Шалавлая дахиад таван минут болбол хамаг хэрэг өнгөрөх нь тэр гэв.

Бонасье авгай явахыг оролдож хоёр алхтал өвдөг нь нугараад ойчив.

Миледи түүнийг өргөж аваад явах гэж үзээд хүч хүрсэнгүй.

Энэ үеэр сүйх тэрэг яваад өгөх чимээ гарлаа. Өртөөний хөтөч шадар цэргүүдийг үзээд хурдлан зугтаажээ. Дараа нь хэд хэд дахин буу дуугарах чимээ гарлаа.

-Та ер явах санаатай байна уу, үгүй юу, эцсийн удаа асууя? гэж Миледи хашгирав. -Ээ бурхан минь, бурхан минь! Миний тэнхээ тасраад байгааг та харж байгаа биз дээ. Би огт явж чадахгүй болоод байна шүү... Та ганцаараазугтааж үз.

-Ганцаараа зугтаах гэнээ! Таныг энд үлдээгээд үү? Үгүй, үгүй яасан ч үгүй! гэж Миледи хэллээ.

Тэгснээ гэнэт зогсож, харц нь хачин ёозгүй гялалзаж, шалавхан ширээ рүү очиж, бөгжнийхөө шигтгээг сурмаг гэгч онгойлгон, дотор нь байсан юмыг Бонасье авгайн хундага руу хийлээ.

Тэр хийсэн улаавтар өнгийн үрэл нь дарсанд тэр дороо уусаж орхилоо.

Ингээд хундагыг шийдмэг авч, май энэ дарсыг уу, танд тэнхээ орно.Уучих гэв. Ингээд хундагыг залуу бүсгүйн аманд хүргэхэд. цаадах нь ая даган ууж орхив.

Миледи хундагыг тавих зуураа шулмым инээдээр инээмсэглэн "Уул нь би ингэж өшөө авья гэж санаагүй юмсан. Болмоорыг хийхэд хүрэх юм, яая гэхвэ" гэж дотроо бодлоо.

Ингээд Миледи өрөөнөөс харайж гарлаа.

Бонасье авгай хойноос нь дагаад явах чадалгүй хараад л хоцров. Хар дарж зүүдлээд, юманд хөөгдөж өөрөө хөдөлж чадахгүй болдогтой адил болчхоод байлаа.

Хэдэн минут өнгөрлөө, гадаа хаалгыг хүн учир зүггүй нүдэх чимээ дуулдана, Бонасье авгай Миледигийн ирэхийг минут тоолон хүлээвч Миледи эргэж ирсэнгүй.

Залуу бүсгүйн дух халуу оргиж, айсандаа ч тэр юм уу, үе үе хүйтэн хөлс нь дааварлав. Тэгж байтал сараалжин төмөр үүд хангинан онгойж гуталтай хүмүүс шатаар алхах чимээ бүсгүйд дуулдлаа. Олон хүний дуу гарч улам улам ойртоход, өөрийн нь нэрээр дуудаад байх шиг боллоо.

Бонасье авгай гэнэт д'Артаньяны дууг таньж баярлан дуу алдаад үүд рүү ухасхийгээд: д'Артаньян! д'Артаньян, та ирэв үү, нааш ир! Нааш ир! гэж хашгирлаа. Залуу эр хариуд нь: - Констанция! Констанция та хаана байнаа, бурхан минь! гэж дуудлаа.

Тэр даруй өрөөний үүд нээгдлээ, чухам гэвэл, гаднаас нь хүмүүс дэлбэ дайраад өрөөнд хэд хэдэн хүн түрэн орж ирлээ. Бонасье авгай хөдлөх тэнхээгүй болоод сандал дээр ойчлоо.

д'Артаньян дөнгөж сая буудсан гар буу барьж явснаа хаячхаад хайртай сайн бүсгүйнхээ өмнө сөхрөн ойчлоо. Атос бугаа бүсэндээ хавчуулж Портос, Арамис хоёр илдээ барьсан байснаа хуйлав.

д'Артаньян минь! Хайрт минь, чи ашгүй нэг ирэв үү? Чи намайг хуурсангүй.... Чи минь мөн байна....

-Мөн, мөн Констанция би байна. Бид дахиад хамтбайх боллоо.

Тэр бүсгүй чамайг ирэхгүй гэж хэдий их ятгасан ч гэсэн би дотроо найдлага тасралгүй, горьдоод зугтаахыг дурлаагүй юм. Хоцорсон минь сайн болжээ. Хичнээн жаргалтай сайхан байнаа! гэв.

Зөөлөн сандал дээр тайван сууж байсан Атос тэр бүсгүй гэдэг үгийг дуулаад цочмог бослоо. -Тэр бүсгүй гэнээ? юун бүсгүй вэ? гэж д'Артаньян асуулаа.

-Миний нэг үерхдэг бүсгүй, надад нөхөрсөг сайн байдаг болоод хавчиж хяхдаг улсаас намайг нууж өгөх гэсэн хүн. Тэр хүн та нарыг хамбын торгон цэрэг гэж эндүүрээд дөнгөж сая эндээс зугтаагаад гарсан.

-Таны үерхдэг бүсгүй гэнээ? Та юун үерхдэг бүсгүйн тухай яриад байнга? гэж д'Артаньян дуу алдаж царайнь хайртай бүсгүйнхээ толгойгоо боосон алчуураас илүү хувхай даагаад явчихлаа.

-Сая сүйх нь гадаа үүдэн дээр зогсож байсан, өөрийгөө таны сайн нөхөр гэж байсан, таны хамаг нууцаа итгэж ярьсан тэр бүсгүй.

-Тэр бүсгүйн нэр нь хэн юм бэ? Бурхан минь. Та түүний нэрийг мэдэхгүй юм гэж үү дээ? гэж д'Артаньян шалгаав.

. -Мэдэлгүй яахав. Миний дэргэд нэрээр нь хэлж л байсан байзаарай.... Ямар хачин юм бэ... бурхан минь миний толгой эргээд байна... нүд харанхуйлаад...

-Нөхөд минь нааш ирээрэй, туслаач! гар нь хөрөөд явчихлаа, унах нь...Бурхан минь! Энэ маань ухаан алдаж орхилоо шүү дээ! гэж д'Артаньян хашгирав.

Портосыг туслаачта минь гэж байдаг чадлаараа хашгирч байх зуур. Арамис ухас хийж аяганд ус хийх гэснээ Атосын царай аймаар муухай хувьсхийгээд явчхыг үзээд зогсов. Атос ширээний өмнө зогсоод хоёр хундаганы нэгийг хэлмэгдэн ширтээд аймшигт сэжиг төрж шаналж байх бололтой:

-Даанч үгүй биз! Арай ч үгүй байгаа! Бурхан эрхбиш ийм муухай нүгэл хийлгэхгүй биз! гэж үглэнэ.

-Ус, ус, ус өгөөчээ гэж д'Артаньян хашгирахад Атос сөөнгөтсөн дугаар хөөрхий, хөөрхий бүсгүй гэж шивнэв.

д'Артаньяныг үнсэн энхрийлэхэд Бонасье авгай сэргэж нүдээ нээсэнд:

-Энэ маань сэхэж байна! Бурхны аврал! гэж залуу дуу алдлаа.

Атос ам нээж,

-Авхайтан, энэ хоосон хундага хэнийх вэ? хэлж өгч үзээч гэлээ.

-Минийхээ эрхэм ээ гэж залуу бүсгүй дорой дуугарав.

-Хундаганд чинь хэн дарс аягалж өгсөн юм бэ?

-Тэр бүсгүй.

-Тэр бүсгүй гэдэг чинь хэн бэ?

-Сая санаанд орлоо. Винтер гүнгийн хатан гэж Бонасье авгайхэлэв.

Дөрвөн нөхөд нэгэн зэрэг дуу алдахад Атос бусдаасаа чанга хашгирч орхилоо.

Бонасье авгайн царай зэвхий дааж хөөрхий бүсгүй өвдөхийн эрхэнд хадуурт өртсөн өвс шиг Портос Арамис хоёрын гар дээр амь тэмцэн ойчоод өглөө.

д'Артаньян учир зүггүй их айж сандраад Атосын гараас шүүрэн авч:

Чи тэгсэн гэж санаж байна уу даа? гээд эхэр татан уйлчихлаа.

-Яасан ч байж мэднэ гэж би санаж байна гэж Атос өгүүлээд өөрийн эрхгүй санаа алдаж орхих гэснээ барьж уруулаа цус гартал хазлаа.

Бонасье авгай д'Артаньян, д'Артаньян чи хаана байна? Би үхэх нь байна шүү надаас бүү холдооч гэж дуудав.

д'Артаньян Атосын гараас мэгдэн зуурч байснаа тавиад Бонасье авгай руу ухасхийв.

Бүсгүйн гуа царай ярвайсандаа муухай болоод харцанд нь ухаантайгаа байгаагийн шинж нэгэнт үгүй болон гөлийж хамаг бие нь дагжин чичрээд магнай дээгүүр нь хүйтэн хөлс дааварлаж байлаа.

-Алив гүйгээч, хүн амьтан дуудаач...Арамис, Портос,, туслах амьтан эрээч! гэтэл Атос: - Тусгүй, тэр хүний уулгасанхорын хорыг авах юм ерөөсөө байдаггүй юм, тус байхгүй, гэж хэллээ.

-Тэгээрэй, туслаарай гэж Бонасье авгай шивнэснээ, хамаг хүчээ шавхаж өндийж залуугийн толгойг хоёр гараараа бариад өөдөөс нь хамаг хайр сэтгэлээ илчлэх мэт ширтсэнээ гацуунаар дуу алдаад уруулыг нь озон үнсэв.

-Констанция! Констанция! гэж д'Артаньян хашгирлаа. Бонасье авгай санаа алдаад, амьсгал нь д'Артаньяны уруулд хүрч мэдэгдлээ. Хөөрхий бүсгүйн цэвэр ариун хайртай сэтгэл нь ийнхүү диваажин руу одов.

Биеийг нь д'Артаньян тэврэн сууснаа мэгдэн хашгираад хайртай сайн бүсгүйнхээ хажуугаар унахдаа, залуугийн царай цаадхынхаа адил зэвхийрэн бие нь хөрчээ.

Портос уйлж, Атос гараа зангидан дээшээ зангахад, Арамис залбирив. Энэ үеэр үл таних нэг хүн орж ирээд зүс царай нь өрөөнд байсан улсынхтай бараг адил зэвхий даажээ.

Тэр хүн ийш тийшээ эргэцүүлээд амь алдсан Бонасье авгай ухаангүй хэвтэж байгаа д'Артаньян хоёрыг харлаа.

Өгүүлшгүй их хүнд гай зовлон учирсны дараа хүмүүс гөлийчихдэг яг тэр үед үл таних хүн орж ирсэн юм.

-Би эндүүрсэнгүй боллотой. д'Артаньян гуай энэ байна, та нар Атос, Портос, Арамис гэгч гурван нөхөд нь шив гэж тэр хүн хэллээ.

Өөрсдийнхөө нэрийг хэлж байгаа үл таних хүнийг гурван нөхөд гайхан харвал урьд нэг үзсэн ч юм шиг санагджээ.

Тэр хүн цаашаа, Эрхмүүдээ, та бүхэн миний нэгэн адил нэг бүсгүй эрж. яваа улс, тэр бүсгүй янз нь үүгээр яваад өнгөрсөн боллотой, юу гэвэл энд хүний хүүр үзэгдэж байна гээд ёозгүй мөшийв. Гурван нөхөд бас л юм дуугарсангүй энэ хүний дуу танимаар юм шиг санагдаад байх мөртөө хаана, хэдийд дуулснаа санаж чадахгүй байв.

Үл таних хүн дахин яриа үүсгэж, Эрхмүүдээ, та бүхэн өөрсдөө хоёр дахин аминд нь орсонхүнээ танил гэхгүй байх шиг байна, тэхлээр би өөрөө нэрээ хэлэхээс биш дээ. Би тэр бүсгүйн хадам ах болох Винтер лорд гэгч байна, гэхэд гурван нөхөд гайхсандаа дуу алдаж орхилоо.

Атос босч Винтер лордтой гар бариад:

Милорд таны ирдэг сайн болж, хамтарч хөдөлцгөөе гэлээ.

Винтер гуайн ярьсан нь:

-Тэр бүсгүйг оргосны дараа таван цаг хиртэй болоод би Портсмутээс гарсан, Булонид гурван цаг хиртэй хоцорч ирсэн. Сент Смерт ирэхдээ дөнгөж хорьхон минутаар зөрсөн байна билээ. Тэгж яваад Лилье гэдэг газар мөрий нь алдаж орхисон. Би улс амьтнаас асуугаад таамгаар явж байтал та нар миний хажуугаар давхиад өнгөрсөн д'Артаньян гуайг би таниад. Та нарыг дуудсан чинь хариу өгсөнгүй, хойноос чинь давхия гэтэл морь муудаад гүйцэх арга байсангүй. Та нар яарсан хир нь хэтэрхий оройтож ирээ шив дээ? гэв.

Атос үүнд амьсгалаа хураасан Бонасье авгай, Арамис, Портос хоёрын сэхээ оруулах санаатай оролдож байсан д'Артаньян хоёрыг зааж:

-Харж байгаа биз дээ гэлээ.

Энэ хоёр хоёулаа амьбалдаа юу гэж Винтер гуай төлөвхөн асуусанд Атос:

-Аз болоход үгүй. д'Артаньян ухаан алдаж орхиод байгаа юм гэж хариуллаа.

Винтер гуай Аа ашгүй дээ гэв. д'Артаньян энэ үеэр нүдээ нээснээ Арамис Портос хоёрын гараас солирсон юм шиг ухасхийн тавиулаад хайртай хүнийхээ хүүрийг тэвэрч авлаа. Атос босч намбатай алгуур явж нөхөр дээрээ очоод энхрийлэн тэврээд цаадахыгаа асгартал уйлаад ирэхээр нь хүний сэтгэлд шингэсэн сайхан дуугаараа:

-Найз минь эр хүн шиг байж үз. Бүсгүй хүн үхсэнийхээ хойноос уйлдаг, эр хүн бол өшөөгий нь авдаг юм гэсэнд д'Артаньян:

-Үнэн! үнэн! хайртынхаа өшөөг авахын тулд би чамайг хаашаа ч гэсэн дагаад явахад бэлэнбайна гэв.

Залуу цэрэг өшөө авах горьдлого төрөөд, дотор нь түрхэн сэргэсхийснийг Атос ашиглаж Арамис, Портос хоёрт хийдийн ширээт рүү оч гэж дохив.

Тэр хоёр ширээт гэлэнмаатай гудамжинд дайралдав. Өдий олон хэрэг явдал дэгдсэнд тэр хүн хэлмэгдэн сандарчээ.

Ингээд хийдийн санваартан бүсгүйчүүл хэдийг дуудаж ирүүлсэнд тэд хийдийн алив бүх дүрэм горимоос гажиж таван эр хүн байгаа өрөөнд орж ирлээ.

Атос д'Артаньяныг сугадаж аваад:

-Авхайтан буянт сайн үйлт та бүхний гар дээр энэ хөөрхий бүсгүйн биеийг бид үлдээе. Бурхны оронд дагина болж төрөхөөсөө өмнө энэ бүсгүй хорвоогийн дагина явсан юм. Хийдийнхээ санваартны ёсоор оршуулаарай. Бид сүүлд шарил дээр нь мөргөл хийхээр ирнэ гэж хэллээ.

д'Артаньян Атосын цээжинд нүүрээ дарж нуугаад асгартал уйлчихлаа.

-Уйл сайн уйлж орхи. Чи идэр залуугаараа, хайр сэтгэлд авгаж чадахтай, амьдрах хүслэнтэй, гандаагүй байна. Би чам шиг ингээд уйлж чадахтайгаа байсан болоосой, гэж Атос хэлээд нөхрөө хөтлөн гарахдаа олон зовлон амсаж. өнгөрүүлсэн хүний бууриар, эцэг шиг энхрийлэн аргадаж, лам багш шиг ятган тайтгаруулж явлаа.

Ингээд тавуул морьд бариад зогсож байсан зарц нараа дагуулан, алсад бараа нь харагдаж байсан Бетюн хотын зүг хөдөлж, замддайралдсан анхны буудлын өмнө зогслоо.

-Бид яагаад тэр бүсгүйн хойноос хөөхгүй байгаа юм бэ? гэж д'Артаньян асуусанд: -Хойноос нь хөөхөө азная, эхлээд жаал зугаа хийх юм байна гэж Атос хариуллаа.

-Тэр чинь бидний гараас мултраад явчихна, үүний бурууг Атос чи үүрнэ шүү, гэж залуу цэрэг сэтгэл түгшин өгүүлэв.

-Үүнийг би даана гэж Атосыг хариулахад, д'Артаньян нөхөртөө гүнээ итгэдэг болохоор хариу маргасангүй, уруу харсаар буудлын газар руу гэлдрэв.

Атосын яагаад ингэж бат итгэлтэй байгаагийн учрыг Арамис, Портос хоёр олохгүй өөд өөдөөсөө харлаа.

д'Артаньяны сэтгэлийг Атос засах санаатай ийм юм ярьж байна гэж Винтер гуай бодлоо.

Буудлын газарт таван сул өрөө байгааг мэдсэний дараа Атос,эрхмүүдээ, одоо тус тусынхаа өрөөнд орё, д'Артаньян ганцаараа жаал уйлж онгойгоод, унтаг. Би бүх юмыг өөрөө хариуцаж авлаа, та нар сэтгэл бүү зов гэж хэллээ.

-Үгүй ингэхэд гүнгийн авхайн эсрэг ямар нэг юм хийнэ гэвэл юуны урьд надад хамаарагдах зүйл шиг санагдах юм. Тэр чиньминий бэргэн эгч юм шүү дээ гэж Винтер гуайг хэлсэнд Атос:

-Надад ч бас хамаарна, тэр чинь миний эхнэр юм гэв. Атос энэ чухаг нууцыг илчилж байгаа хойно, өшөөгөө авах бат итгэлтэй байгаа юм байна гэж д'Артаньян мэдээд инээмсэглэв. Арамис Портос хоёрын царай зэвхийрээд бие биесээ харлаа. Винтер гуай харинАтосыг солиорч гэж санажээ.

-За ингээд өрөө өрөөндөө орж юу хийхийг надад даатга. Тэр хүн миний эхнэр болохоор энэ надад хамаатай хэрэг болохыг та бүхэн мэдлээ шүү дээ. Харин нөгөө хүний малгайнаас унасан, тосгоны нэр бичээстэй цаасаа д'Артаньян та хаячхаагүй бол надад өгөөч гэж Атос хэлэв.

-Уухай, сая л учир ойлголоо. Тэр нэрийг Миледи бичсэн байх нээ... гэж д'Артаньяныг хэлтэл Атос тосч аваад,

-Дээд тэнгэрт бурхан байдаг юмаа гэгчийг чи өөрөө харж байгаа биз гэв.

LXIV. УЛААН НӨМРӨГТЭЙ ХҮН

Атос цөхөрч цухалдахаа болиод дотроо гуниглах бол хурц сэргэлэн ухаан самбаа нь улам нэмэгдлээ.

Атос нөхдөдөө ам өгч, хүлээж авсан чухал хариуцлагынхаа тухай бодсоор бусдаас сүүлдэж өрөөндөө ороод буудлын эзнээс уул нутгийн газрын зураг гуйж авлаа. Ингээд сайтар үзэж Бетюнээс Армантьер орох дөрвөн зам байдгийг мэдэж зарц нараа дуудуулав.

Планше, Гримо, Мушкетон, Базен нар ирж Атосоос нарийн бодож боловсруулсан тодорхой сайн заавар авлаа.

Тэд үүрээр цөм өөр өөр замаар Армантьер руу явах боллоо. Дөрвөн зарцын дотроос Планше хамгийн ухаалаг нь болохоор нөгөө Рошфорын зарцын дагалдаж явдаг, дөрвөн нөхдийн буудсан сүйхний явсан замаар явах боллоо.

Энэ хэрэгт зарц нарыг оролцуулсан учир гэвэл, энэ дөрөв Атос болоод нөхдөд нь зарагдаж байх зуураа багагүй сайн чанартай нь мэдэгдсэн. Цаашлаад замд дайралдсан хүнээс эздийн юм асуух нь илүү их сэжиг төрүүлж, зарц нарыг бага хардаж асуусан юманд нь дуртайяа хариулт өгдөг юм. Миледи мөн эздийгөөрсдий нь таних боловч зарц нарыг танихгүй, зарц нар харин тэр бүсгүйг андахгүй билээ.

Дөрвөн зарц маргааш нь арван нэгэн цагт болзсон нэг газар цугларах, Миледийн нуугдаж байгаа газрыг мэдэж амжвал гурав нь тэндээ манаж үлдээд нэг нь ирж Атост хэл дуулгах, газарчилж аваачих ёстой болов.

Зарц нар ийм заавар аваад одлоо. Арван цаг орчим болж байхад Атос илд зүүж, нөмрөг нөмрөөд гарав. Арван цагийн үед муж газрын хотын гудамжинд голдуу хүн амьтангүй болдог билээ. Гэвч Атос юм асуучхаар хүн хайгаад байгаа нь илт байлаа. Тэгж тэгж оройтсон нэг хүнтэй дайралдаад хэдэн үг хэлтэл цаад хүн хэлмэгдэн ухарсан боловч Атосын үгийн хариуд нэг тийшээ заав. Атос тэр хүнийг зам зааж өгөөч хагас алтан зоос өгье гэсэн боловч цаад хүн татгалзав.

Атос тэр хүний зааж өгсөн замаар цаашилж яваад гудамж огтлолцсон газарт хүрч, хаашаа явахаа тулгуурлахгүй байх бололтой зогсов. Тэгээд гудамжны уулзвар дээр л хүнтэй дайралдаж болох горьдлоготой байсан болохоор тэндээ зогсоод байлаа. Үнэхээр ч шөнийнэргүүл төдхөн хүрч ирээд түрүүчийн хүн шиг Атосын үгэнд хэлмэгдэж, бас л явж зам зааж өгөхөөс татгалзаад, байрнаасаа заав.

Атос заасан чигт нөхөдтэйгөө явж ирсэн зүгийн эсрэг явсаар хотын захад гарч ирэв. Энд ирээд мөн л эргэлзэж, гурав дахь удаагаа яахаа мэдэхгүй тээнэгэлзэн зогслоо.

Аз болоход түүгээр гуйлгачин хүн явж байгаад Атосоос юм гуйх гэж ирлээ. Очих газраа дагуулж аваачвал мөнгөн зоос өгье гэж Атос түүнд хэлтэл, гуйлгачин эхлээд түдгэлзсэнээ, мөнгөн зоос харанхуйд цайран байхыг хараад зориг шийдэж. Атосын урьд ороод явлаа.

Гуйлгачин нэг гудамжны буланд очоод зожиг буйд жижгэвтэр байшинг заалаа. Атос заасан байшин руу явж, гуйлгачин хөлсөө аваад хар хурдаараа буцаж гүйжирлээ.

Байшингийн ханыг цусан улаан өнгөөр будсан тул Атос үүд нь хаанаа байгааг ялгаж олохын тулд бүтэн тойроход хүрлээ. Цонхны хаалтан завсраар гэрэл огт харагдахгүй, байшинд хүн суудаг гэмээр чимээ анир ер үгүй, авс мэт баргар ажээ.

Атос гурав тогшиход хүн хариу юм дуугарсангүй, гэхдээ гурав дахь удаа цохисны дараа цаанаас хүн ойртож яваа хөлийн чимээ гарч, үүд нээгдээд цайвар царайтай, хар үс, хар сахалтай өндөр хүн гарч ирэв.

Үл таних хүн Атос хоёр нам дуугаар хэдэн үг солилцсоны дараа, өндөр хүн нь шадар цэрэгт орохыг зөвшөөрч дохисонд Атос даруй дорхноо ороод, үүд хаагдав.

Атосын ингэтэл хол явж, чадан ядан олсон хүн нь түүнийг ажлынхаа өрөөнд орууллаа. Тэр хүн хүний харжигнасан араг яс төмөр утсаар хэлхэж суусан юм байх. Их биеийг нь хэлхээд гүйцсэн, ганц хохимой толгой л ширээн дээр тусдаа байж байлаа.

Өрөөний бусад засал хэрэгслийг үзвэл эзэн нь түмэн бодисын ухаан судалдаг нь илэрхий байв. Олон янзын могой саванд хийж төрөл ангийгнь бичиж наасан, хатаасан гүрвэлүүд хар модон таазанд суулгасан шигтгээ аятай гялалзсан өрөөний адар, булангуудаар зэрлэг өвс ургамал уяж унжуулсан байлаа.. Эрдэм номгүй хүн тэр өвс ургамлын чанар чадлыг мэддэггүй бололтой.

Гэрийн эзэнд зарц гэж үгүй, өндөр хүн энэ байшинд ганц бие суудаг нь илт байлаа. Саяны хэлдэг юмсыг Атос хэнэггүй тайванхараад эзний урьсан ёсоор суулаа.

Ингээд Атос ирсэн учир шалтгаанаа тайлбарлаж, ямар тус хүргүүлэх гэснээ дуулгамагц үл таних хүн хэлмэгдэн хойш ухраад эрс татгалзав. Тэхлээр нь Атос өврөөсөө хоёр мөр юм бичиж, тамга даран гарын үсэг зурсан цаас гаргаж дургүйцэхээ яарсан хүнд үзүүлэв. Өндөр хүн энэ хоёр мөрийг уншиж, тамга гарын үсгийгүзмэгцээ маргах юмгүй, тушаасан ёсоор явахад бэлэн байгаагаа мэдэгдэн мэхийлээ.

Атосын хэрэг зориг энэ л байсан болохоор салахын үг хэлээд гарч, ирсэн замаараа буцаж буудалдаа ирээд өрөөгөө дотроос нь түгжив.

Үүрээр д'Артаньян өрөөнд нь орж ирээд юу хийвэл таарахыг асуусанд:

-Хүлээ гэж Атос хариулав.

Хэдэн минутын дараа Бонасье авгайг үд дунд оршуулна гэж цэргүүдэд хийдээс мэдэгджээ. Хор уулгасан хүний тухайд гэвэл мэдээ чимээ ер үгүй, цэцэрлэгээр зугтаасан байх л гэж тааварлаж байжээ. Цэцэрлэгт Миледийн мөр байснаас гадна, цэцэрлэгийн үүд хаалттай, түлхүүр нь алга болчихсон байжээ.

Хэлсэн цагт нь Винтер Лорд, дөрвөн нөхөд бүгдээрээ хийдэд ирж, хийдийн хамаг хонхыг

дэлдэн ёсолж, сүмийн хаалга нээлттэй боловч тавцангийн сараалжийг хаасан байлаа.

Хийдийн тавцангийн дунд хорлогдсон хүний хүүрийг авсанд хийгээд тавьсан, хоёр талд нь хүмүүсийн нүднээс далд хийдийн санваартан бүсгүйчүүл цөм ирж, санвааргүй улсыг ч харалгүй өөрснөө ч тэдэнд харагдалгүй зогсоод, лам нарын залбирал уншихад дуугаа нийлүүлэн түрж байв.

Цамхгийн үүд рүү дөхөж ирээд д'Артаньян дахин зоригалдарч ирсэнд Атосыг хайж эргэн харвал Атос үгүй болчихсон байлаа. Атос өшөө авах санаагаа бат барьж, цэцэрлэгт оруулж өгөхийг шаардаад, явсан газар болгондоо цусан мөр үлдээж явдаг бүсгүйн мөр элсэн дээр гарсныг мөрдсөөр ойн цоорхой руу гарсан хаалганд тулж, онгойлгуулаад ой руу оров.

Энд Атосын тухайлан тааварлаж байсан бүхэн зөв болох ньбатлагдав. Нөгөө сүйхний эргэсэн зам ойг тойрдог ажээ. Атос тэр замаар жаал явахад, морьтой дагалдаж явсан хүн юм уу, морьдын нэгийг шархдуулсны улмаас байн байн цус дусалж явсныг харлаа. Хийдээс хагас мод нилээд илүү зайтай, Фестюбер гэгч тосгоны наана тавиад алхам газар цус нилээд их тунасан, хавийн газрыг морьд гишгэлснээс гадна цэцэрлэгт гарсан ойрхон алхаатай хүний мөр энд бас үзэгдлээ. Тэнд сүйх тэрэг зогссон бололтой. Энд Миледи ойгоос гарч сүйхэнд суужээ.

Өөрийн нь бодож байсантай нийлсэн энэ зүйлийг мэдээд Атос сэтгэл ханаж, буудалдаа буцаж иртэл Планше түүнийг хүлээн тэсч ядаж байлаа.

Бас л Атосын тухайлсан ёсоор болжээ.

Планше зам дагаж яваад Атосын нэг адил морьд зогссон, цус тунасан газрыг ажжээ. Атос тэндээс нааш эргэсэн, Планше цааш явж Фестюбер тосгонд ороод буудлын газар дарс ууж суухдаа, түрүүн найман цагийн үед, өртөөний сүйхээр яваа бүсгүйг дагалдаж явсан хүн шархадсаны улмаас цаашаа явж чадахгүй болоод энд буух болсон гэдэг яриа хүн амьтнаас асууж суралгүй зүгээр дуулжээ. Явуулын хүн ингэж шархадсанаа ой дотор дээрэмчид довтолж, сүйх зогсоолоо гэж тайлбарлажээ. Шархтан тосгонд үлдээд, бүсгүй нь морио сольж аваад цааш явжээ.

Планше тэр сүйхний хөтчийг эрж яваад оллоо. Тэр улаач, бүсгүйг Фромель гэгч газархүртэл хүргэж өгсөн, тэндээсээ цаашаа Армантьер руу явсан ажээ. Планше шууд хөдөө замаар тийшээ яваад өглөөний долоон цагт Армантьерт хүрлээ.

Армантьерт ,өртөөний буудлын дэргэд ганцхан буудлын газартай юм байна. Буудлын зарц нартай арван минут хир ярилцаад үзтэл арван нэгэн цагийн алдад дагуулж барьсан хүнгүй нэг бүсгүй ирж өрөө аваад, буудлын газрын бошгыг дуудуулж, Армантьерын ойролцоо хэсэг суух санаатай байгаа гэж хэлснийг Планше мэдэж авлаа.

Планше хэрэгтэй юмаа цөм дуулж аваад болзсон газар руугаа яарч, бусад гуравтайгаа уулзаад, буудлын газрын хаалга бүхнийг сайтар манаж харж байхыг даалгаад өөрөө Атос дээр буцаж иржээ. Планшег хэлэх юмаа дуусаагүй байтал Атосын нөхөд хөөрхий бүсгүйг оршуулаад буцаж ирээд Атосдээр оров.

Номхон дөлгөөн Арамисын царай хүртэл бүгдээрээ ууртай баргар болжээ.

Юу хийх хэрэгтэй болж байна? гэж д'Артаньян асуухад Атос:

-Хүлээ гэв.

Нөхөд цөм өрөө өрөөндөө орлоо.

Оройн найман цагт Атос морьд эмээллэхийг тушаагаад Винтер гуай болоод нөхдийгөө явахад бэлд гэж хэлүүлэв.

Тавуул эгшин зуур бэлэн зэлэн боллоо. Хүн бүр зэр зэвсгээ шалгаж үзэв. Атос сүүлдэж доошоо буухад, д'Артаньян хэдийн мордож орхиод явахыг яаруулж байв.

-Жаахан тогтож үз, нэг хүн ирээгүй байна гэж Атос хэллээ.

Дөрвөн хүн эргэн тойрон гайхан харж, хэн дутаад байгааг санах гэж мэрийнэ. Энэ завсар Планше Атосын морийг эмээллээд ирсэнд мориндоо шалмаг мордож:

-Жаахан хүлээж бай, би одоо ирнэ гээд давхиж одлоо.

Үнэхээр ч мөч болсны дараа Атос нүүрэндээ багтай, том улаан нөмрөгтэй хүн дагуулсаар буцаж ирэв.

Винтер гуай, гурван шадар цэрэг хэдүүл өөд өөдөөсөө гайхан харж, тэр хүнийг таних хүн ганц ч үгүй болохоор хэн нь ч бусдадаа тайлбарлаж өгч чадахгүй байв. Гэхдээ Атосын хийж байгаа ажил хойно хэрэгтэй л юм байлгүй гэж дотроо бодоцгоолоо.

Арван цагт тэр хэсэг хүн Планшег дагаж, нөгөө сүйхний яваад өгсөн замаар хөдөллөө. Тэр зургаан хүн ийнхүү өр төлөөснөөс айж, мухардаж цөхрөхийн адил баргар хар бодолд авган таг чиг явах нь харахад гуниг төрмөөр ажээ.

LXV. ШҮҮСЭН НЬ

Бөөн хар үүлс нүүгэлтэн оддыг халхалж, салхи тавьсан харанхуй, сар шөнө дунд хүргэж байж гарах учиртай шөнө байв.

Үе үе тэнгэрийн хаяанд цахилгаан гялсхийхэд алс одсон зам зурсхийж харагдаад хамаг юм дахин харанхуйд хучигдана. д' Артаньян цаг үргэлж бусдаасаа урагшаа тасарч явчхаад, Атос байн байн түүнийг дуудаж зэрэгцэх боловч, төдхөн дахиад л түрүүлж явчхаад байлаа. Урагшаа. хар хурдаараа тэмүүлэх сэтгэлд л автсан энэ залуу үнэхээр тэмүүлээд л байжээ.

Морьтой улс дуугүй явсаар нөгөө шархтай хүний үлдсэн Фестюбер тосгоныг дайрч гараад Ришбургийн ойг тойрч Эрлие тэгч газарт иртэл газарчилсаар явсан Планше зүүн тийшээ эргэв.

Винтер гуай, Портос, Арамис гурав улаан нөмрөгтэй хүнтэй үг ярилцах гэж хэд хэд дахин оролдсон боловч, цаад хүн юу ч асуухад хариу мэхийхээс өөр дуугарсангүй. Үл таних хүний дуугарахгүй байгаа нь учиртай юм байна гэдгийг наадуул ойлгоод ярих гэж оролдохоо байлаа.

Энэ зуур салхи улам ширүүсэж, цахилгаан гялалзах олширч тэнгэр чанга чанга нижгэнэн түргэн айхтар хүчтэй шуурах төлөвтэй, зам яваа хүмүүсийн үс малгай бүч салхинд дэрвэлзэнэ. Манай хэд хатирууллаа.

Удалгүй Фромель гэгч газрыг өнгөртөл азарган бороо асгарав. Морьтонгууд цуваа нөмөрч үлдэж байгаа гурван мод газрыг тэд хувингаар асгаж байгаа мэт цутгасан бороон дундуур явах ёстой боллоо.

д' Артаньян малгай нөмрөг хоёроо тайлж, гал шатсан магнай халуу оргисон биеэ борооны хүйтэн усанд цохиулсанд сайхан байв.

Манай хэд Госкаль гэгч газрыг дайрч гараад өртөөний буудалд ойртож иртэл модон дор борооноос хоргодож харанхуйд харагдахгүй байсан нэг хүн замын голд гарч ирээд хуруугаа уруулдаа хүргэж, чимээгүй гэсэн дохио өгөв.

Тэр хүн Гримо мөн болохыг Атос танилаа.

-Юу болов оо, тэр авгай Армантьераас арай яваад өгөөгүй биз дээ? гэж л' Артаньян хашгирав.

Гримо толгой дохисонд д' Артаньян тачаадан шүдээ хавирав.

д' Артаньян та дуугүй бай! Би бүх хэргийг өөрөө даасан болохоор Гримог би байцаая гэж Атос хэлээд Гримогоос:

-Тэр бүсгүй хаана байна? гэж асуусанд: Гримо Лис голын чигт гараараа заав.

-Эндээс хол байна уу? гэж Атосыг асуухад Гримо долоовор хуруугаа нугалаад эзэндээ

хариуллаа. Атосыг

-Ганцаараа байна уу? гэж асуухад Гримо толгой дохилоо.

-Эрхмүүдээ, тэр бүсгүй голын чигт эндээс хагас мод хиртэй газар ганцаараа байгаа юм байна гэж Атос дуулгав.

-За ашгүй биднийг дагуулаад яваарай. Гримо минь гэж д' Артаньян хариу дуугарсанд манай нөхөд Гримог дагаж тал дундуур хөдлөв.

Тэд тавиад алхам яваад жижиг горхи гаталж гарав. Цахилгаан гялбасхийхэд Ангенгем гэгч тосгон тэдний нүдэнд үзэгдээд орхилоо.

Тэнд байгаа юм уу, Гримо? гэж Атосын асуухад Гримо толгой сэгсрэв..

-Эрхмүүдээ чимээгүй явцгаая гэж Атос хэлээд хэдүүл цаашаа хөдөллөө.

Дахин цахилгаан гялбасхийхэд могой шиг тахиралдсан цэнхэр туяанд, Гримогийн зангасан зүгт, гарамнаас зуугаад алхмын газар голын эрэг дээр буйдхан байшин байгаа харагдав.

Байшингийн нэг цонх гэрэлтэй байлаа.

-Бид зорьсон газартаа ирлээ гэж Атос хэлтэл, суваг дотор хэвтэж байсан нэг хүн босон харайсан нь Мушкетон байв. Мушкетон гэрэлтэй цонхыг заагаад

-Нөгөө бүсгүй тэнд байгаа гэлээ.

-Аа Базен хаана байгаа вэ? гэж Атосыг асуухад:

-Би цонх манаж, Базен үүд манаж байгаа юм гэв.

-За сайн, та нар үнэнч зарц нар байна гэж Атос тэднийг сайшаав.

Атос морьноос бууж цулбуураа Гримод егөөд, бусдадаа байшинг тойрч үүд рүү нь оч гэж заагаад өөрөө цонх өөд очив.

Байшинг тойруулан нилээд өндөр ургамал хашаа суулгасныг Атос үсрэн давж цонх руу очсонд, гаднаасаа хаалтгүй тэхий дундаа хүрсэн хөшгийг нь сайтар татаж хаасан байв.

Атос чулуун довжоон дээр гарч хөшигний дээгүүр өрөө рүү харлаа.

Дэнгийн гэрэлд хар хувцсаар биеэ ороосон бүсгүй хүн сууж байгаа харагдав. Бүсгүй унтарч байгаа галын захад мухар сандал дээр сууж муу ширээ тохойлдож, зааны ясаар сийлсэн юм шиг сайхан цагаан гараар шанаагаа тулан суужээ.

Бүсгүйн царай харагдахгүй байсан боловч Атос эндүүрсэнгүй эрж явсан хүн нь мөн болохыг таниад зэвүүнээр инээмсэглэв.

Гэнэт морь янцгаасанд, Миледи дээшээ болж Атосын цонхонд наалдсан зэвхий царайг харчхаад дуу алдав.

Миледи өөрий нь таньжээ гэдгийг Атос мэдээд өвдөг, гар хоёроороо цонхны жаазыг түлхсэнд жааз эвдрээд шил үйрэн хангинав.

Атос өрөөнд үсрэн ороод, Миледийн өмнө өшөө хонзон авах эрлэг шиг сүртэй зогслоо.

Миледи үүд рүү ухасхийж онгойлготол босгон дээр Атосоос их цонхийчихсон улам аймаар сүртэй д' Артаньян зогсож байв.

Миледи дуу алдаад ухарлаа. Тэр бүсгүй зугтаах, өөрсдий нь гараас мултраад явчих боломж байгаа юм байх гэж Д' Артаньян бодоод бүсэндээ байсан гар бууг шүүрч автал Атос хориглож гараа өргөв.

д' Артаньян та буугаа буцааж хий. Энэ бүсгүйн хэргийг таслан шүүхээс бус, алж таарахгүй. д' Артаньян чи бас нэг жаахан хүлцэж үз, өшөөгөө авах болноо. Та бүхэн орцгоо гэж Атос төрөлхийн шүүгч хүний сүр буурьтай, тэнгэрээс заяасан юм шиг захирангуй дуугарсанд д' Артаньян үгийг нь дагалаа.

д' Артаньяны хойноос Портос, Арамис, Винтер лорд, улаан нөмрөгтэй хүн цөм орж ирэв. Зарц нар үүд цонх манаж байлаа.

Миледи сандал дээр лаг хийтэл сууж, энэ муухай үзэгдлийг зайлуулах гэсэн шиг гараа сунгалаа. Хадам ахыгаа хараад муухай орилчихов.

Миледи та бүхэнд юу хэрэгтэй юм бэ? гэж дуу алдсанд Атос хариуд нь:

-Де ла Фер гүнгийн хатагтай гэгдэж байсан, хожим нь Шеффильдийн бээл Винтер гуайн хатан гэгдэж байсан Шарлотта Баскон бидэнд хэрэгтэй байна гэв.

Миледи айсандаа амь тэмцэж, тэр чинь би байна, би мөн. Намайг та бүхэн яах гээ вэ? гэж шивнэлээ.

-Таны үйлдсэн гэмт хэрэгт бид өөрий чинь шүүх гэж байна. Та өөрийгөө өмгөөлж, чадвал биеэ цагаатгаж болно гэж Атос хариулаад, Артаньян та эхэлж ял асуу, гэв.

д' Артаньян урагшаа гараад би бурхан болоод хүмүүсийн өмнө энэ бүсгүйд тулгах ял гэвэл: Энэ хүн Констанция Бонасье гэдэг хүүхэнд хор өгсөн, тэр хүн өчигдөр орой нас барсан гээд Портос, Арамис хоёр руу эргэж харлаа.

Хоёр шадар цэрэг үүнд, Бид үүнийг гэрчилж байна гэж зэрэг дуугарлаа.

д' Артаньян цаашаа, Энэ бүсгүйд бурхан болоод хүмүүсийн өмнө ял тулгах зүйл гэвэл: Намайг өөрий минь хордуулах гэж Виллеура гэгч газраас, хор хольсон дарс манай нөхдийн бэлэг гэсэн хуурамч бичигтэй ирүүлсэн. Бурхан намайг аварсан боловч миний оронд Бризмон гэдэг өөр хүн үхсэн. Портос, Арамис хоёр, бид үүнийг гэрчилнэ гэв.

-Энэ бүсгүйд бурхан болоод хүмүүсийн өмнө ял тулгах зүйл гэвэл:

Энэ хүн де Вард гүнг. надаар алуулах гэж намайг хатгаж байсан, энэ хэргийг гэрчлэх хүн энд байхгүй болохоор өөрөө өөртөө гэрч болно, миний хэлэх юм дууслаа, гэв.

д' Артаньян, Портос, Арамис хоёрын хамт өрөөний нөгөө талд гарлаа.

-Одоо Винтер гуай таны ээлж дээ! гэж Атос хэлсэнд бээл урагшаа гарав.

Бурхан болоод хүмүүсийн өмнө энэ бүсгүйд тулгах ял гэвэл: Үүний хатгалгаар Бекингэм герцог алагдсан гэв.

Өрөөнд байсан улс цөм, Бекингэм герцог алагдсан гэнээ? гэж зэрэг дуу алдлаа.

Бээл үүнд, тиймээ алагдсан та бүхний сэрэмжилсэн захидлыг би аваад энэ бүсгүйг баривчлуулсан. Тэгээд өөртөө үнэнч, итгэлтэй нэг хүнээр харгалзуулсан чинь энэ хүн түүнийг талдаа оруулж чадаад герцогийг алах хутга атгуулаад явуулсан байна. Энэ шулмын үйлдсэн булай хэргийн орноос хөөрхий тэр Фельтон өдийд толгойгоо алдаж байж магад юм, гэлээ.

Өөрсдийн нь мэдээгүй энэ шинэ гэмт хэргийн тухай хэрэг шүүж байгаа хүмүүс дуулаад биес нь өөрийн эрхгүй зарсхийв.

Винтер гуай цаашаа үүгээр зогсохгүй, Бэргэн таныг өв залгамжлагч болгосон миний дүү гэнэт хамаг биеэр нь хөхөвтөр толбо гардаг хачин өвчнөөр гуравхан цаг өвдөөд нас барсан. Танай нөхөр ямар учраас үхсэн юм бол бэргэн минь? гэв.

Портос, Арамис хоёр, яасан муухай булай юм бэ? гэж дуу алдав.

-Бекингэмийг алсан, Фельтоныг алсан, миний дүүг алсан хүн үүнийг хууль ёсоор яллахыг шаардаж байна, эс тэгвэл өөрөө яллана гэдгээ дуулгая.

Винтер гуай ял асуух өөр хүнд байраа тавьж өгөөд д'Артаньяны хажууд очиж зогсов.

Миледи толгойгоо унжуулж, нүүрээ дараад, үхтэл айсны харгайгаар самуурч байгаа ухаан санаагаа тогтоохыг мэрийж байлаа,

-За одоо миний ээлж гээд Атос могой харсан арслан шиг бие нь агзасхийж, миний ээлж боллоо. Энэ бүсгүйг залуухан охин байх цагт гэр орныхныхоо үгэнд оролгүй ханилан суусан юм. Би үүнд эд хөрөнгөө, нэрээ өгч, өргөмжилсөн тэгтэл шившгийн тамга даруулсны нь нэг өдөр мэдсэн. Зүүн мөрөн дээрээ цэцэг маягийн тамгатай юм билээ гэв.

Миледи дуу алдаж, тэр муухай тогтоол гаргасан шүүх хаанаас ч олдохгүй гэж би андгайлъя. Мөн тэр тогтоолыг биелүүлсэн хүн бас олдохгүй гэдгийг амлая гэтэл:

-Амаа тат! Үүнд би хариу өгнө гэж нэг хүн дуугарлаа. Улаан нөмрөгтэй хүн урагшаа гарч ирлээ.

Миледи айсандаа багтарч, үс нь задраад, зэвхийрсэн нүүрэн дээгүүр нь амьд юм шиг хөдөлж, энэ хэн бэ? хэн бэ энэ чинь? гэж хашгирлаа.

Хүмүүсийн хараа цөм улаан нөмрөгт дээр туслаа. Атосоос өөр түүнийг таних хүн ер үгүй байв. Атос өөрөө ч гэсэн, төгсгөл нь болж байгаа энэ муухай явдалд энэ хүн ямар хамаатай болохыг ойлгохгүй бусдын адил гайхан харж байв.

Тэр хүн алгуур ихэмсэг алхалсаар Миледийн хажуу дахь ширээнд тулж зогсоод нүүрнийхээ багийг авлаа.

Тэр хүний үс, хууз сахлаар эмжигдсэн цонхигор төлөв амгалан царайг Миледи хэсэг зуур харж улам бүр хэлмэгдэн байснаа гэнэт босон харайж, хана руу ухасхийв.

-Үгүй, үгүй, үгүй! гэж өөрийн эрхгүй хашгираад,

-Энэ чинь эрлэг тамын үзэгдэл байх! Тэр хүн биш!. Туслаарай! туслаачээ таминь! гэж сөөнгөтөн бархираад хана руу эргэж хага түлхээд, дотор нь нуугдах гэсэн юм шиг тас наалдав.

Үүнийг харж байсан улс үгүй та юун хүн бэ, ингэхэд? гэж гайхав, улаан нөмрөгтэй хүн, энэ бүсгүйгээс асуу. Намайг таньж байгаагий нь хараа биз дээ гэлээ.

Миледи айж ухаан нь гарах шахаад унахгүйн тулд хананаас маажилж, Лилль хотын зандалчин байна! Лилль хотын зандалчин мөн байна! гэж бархирлаа. Хүмүүс цөм гэдрэгээ болоод улаан нөмрөгтэй хүн өрөөн дунд ганцаараа үлдлээ.

Булай явдалт бүсгүй сөхрөн унаад та минь намайг өрөвдөж үзээч, уучилж өршөөгөөч гэж хашгирав.

Үл таних хүн нам жим болтол хүлээж байгаад:

-Энэ бүсгүй өөрөө намайг таньжээ гэж та бүхэнд би хэлсэн шүү дээ, үнэхээр би Лилль хотын зандалчин мөн. Тэгээд миний явдал ийм юмаа гэсэнд цөмөөрөө тэр хүнийг нүд салгалгүй ширтэж юу ярихыг нь сэтгэл түгшин хүлээв.

Урьд энэ залуу бүсгүй мөн л ийм гуа сайхан охин байлаа. Тэхэд энэ тамплемарын бүсгүйчүүлийн хийдэд санваартай байсан хүн. Энэ хийдийн сүмд гэнэхэн цагаан сэтгэлтэй сүсэг бишрэл ихтэй нэг залуухан лам ном уншдаг байсан юм. Энэ бүсгүй гэгээн хүнийг ч татаж буруу зам руу оруулчхаар царайлаг байсан болохоор тэр залуу ламыг хөнөөх гэж сэдээд хөнөөж чадсан юм.

Эдний хийдийнхний хүртсэн сахилын журам их хатуу, буцаж няцдаггүй байсан болохоор энэ бүсгүй, залуу лам хоёрын холбоо үүрдийн байж чадахгүй, эрт орой нэгэн цагт хар гай чирэх ёстой байв. Залуу хүүхэн тэр нутгаас оргоё гэж сэтгэлтэй хүнээ ятгажээ. Ингээд өөрсдийгөө хүн үл таних францын өөр хязгаар нутагт очиж амар жимэр сууна гэхэд мөнгө хэрэгтэй, мөнгө тэр хоёрын аль алинд байхгүй байжээ. Тэхлээр лам сүмийн тахилын цөгц сэлтийг

хулгайлж аваад зарж, мөнгөтэй болоод сэтгэлтэй хоёр оргохын даваан дээр баригдсан юм.

Долоо хоногийн дараа энэ хүүхэн шоронгийн хуягийн хүүг өөртөө татаад, зугтааж чадсан. Залуу ламыг шившгийн тамга дараад арван жил гинжтэй хорих тогтоол гарлаа. Энэ бүсгүйн хэлж байгаачлан би Лилль хотын зандалчин байсан. Гэмтэн этгээдийг би тамгалах үүрэгтэй, тэгтэл тэр гэмтэн нь миний дүү байсан юм шүү эрхмүүд ээ.

Тэгээд би дүүгээ хөнөөсөн гэмт хэргийг хамтарч үйлдсэнээс хүнд сэдэж дүүгий минь хатгасан энэ бүсгүй адаглаад адил цээрлэл хүлээх ёстой гэж дотроо андгайлаад үүний хаана нуугдаж байгаагий нь гадарлаж, мөрдөж байж олоод, барьж хүлж байгаад дүүдээ тавьсантай адилхан тамга дарж орхисон юм.

Намайг Лилль хотонд эргэж ирсний дараа өдөр миний дүү бас зугтааж амжжээ. Намайг хуйвалдлаа гэж хардаад, дүүгий маань эргэж ирж биеэ тушаатал хорихоор боллоо.

Хөөрхий дүү минь тэр тогтоолын тухай дуулсан юмгүй дахиад энэ бүсгүйтэй нөхцөж, хоёул хамт Берри гэгч газар руу оргоод тэнд залуу лам бага шиг газар ном уншдаг болж чадсан, Энэ хүүхэн түүний дүү нь гэдэг байж.

Залуу ламын ном уншиж байсан тэр нутгийн эзэн өндөр язгууртан хүн энэ хуурамч дүүг үзээд их сэтгэлтэй сайн болж, өөрийнхөө гэргий болохыг гуйжээ. Тэхлээр энэ хүүхэн нэгэнт хөнөөсөн хүнээ хаяж, өөр хүнийг хөнөөхөөр эхнэр нь болж де ла Фер гүнгийн хатан болсон юм. Атосын жинхэнэ нэр де ла Феэ гүн гэдэг болохоор улс цөм өөдөөс нь харсанд зандалчингийн ярьсан бүхэн цөм үнэн гэж Атос толгой дохив.

Зандалчин яриагаа үргэлжлүүлэн:

-Тэхлээр нь манай дүү цөхөрч гүйцээд, энэ бүсгүйн бүрэлгэж, нэр төр, жаргал баясалгүй болгосон амьдралаасаа салахын түүс болж, Лилль хотонд эргэж ирсэн. Өөрийн нь орноос намайг шоронд сууж байгааг дуулаад өөрөө хүрч ирсэн. Тэгээд ирсэн оройдоо гяндангийнхаа гэгээвчнээс боогоод үхчихсэн юм.

Намайг хорьсон шүүхийнхэн үнэхээр хэлсэндээ хүрч амиа хорлосон хүний бие танигдмагц намайг сулласан.

Энэ бүсгүйд тулгах ял энэ байна, ийм хэргийн учир энэ хүүхэн шившгийн тамга даруулсан юм! гэлээ. Атос ам нээж д' Артаньян гуай та энэ бүсгүйд ямар ял оноохыг шаардаж байна? гэж асуусанд:

-Алах ял оноохыг гэж д' Артаньян хариуллаа.

-Винтер лорд та ямар ял оноохыг шаардаж байна? гэхэд Винтер лорд:

-Алах ял гэв.

Портос, Арамис гуай та хоёр энэ бүсгүйн шүүгчид болж байна. Та бүхэн энэ хүнд ямар ял оногдуулах вэ гэхэд хоёр цэрэг бөглөрөнг дуугаар:

-Алах ял гэж зэрэг хэллээ.

Миледи муухай орилоод, өвдгөөрөө мөлхөн шүүгчид рүүгээ ойртлоо.

Атос гараа өргөөд:

Шарлотта Баксон, де ла Фер гүнгийн хатан. Винтер авгай таны үйлдсэн гэмт хэргүүд газар дээр хүмүүсийн, тэнгэр дээр бурхны хүлцэх хирээс хэтэрчээ. Танд мэдэх мөргөл залбирал байдаг бол түүнийгээ унш. Та нэгэнт яллагдсан одоо үхэх болноо гэлээ. Хамаг горьдлого тасалсан энэ үгийг сонсоод Миледи босч, биеэ цэх болгоод юм хэлэх гэтэл тэнхээ нь тасрах шиг болоод чадсангүй. Тэгтэл хүчтэй шийдмэг гар үсэн дээрээс нь шүүрч аваад эрлэгийн элч хүнийг нэгмөсөн аваад явдгийн адил хөтөлсөнд Миледи эсэргүүцэхийг ч оролдсонгүй байшингаас гарлаа.

Винтер лорд, д' Артаньян, Атос, Портос, Арамис нар бүсгүйн араас дагаж гарав. Зарц нар эзнийхээ хойноос дагалдаж цонх нь яйран үүд нь дэлгээстэй үлдсэн байшинд тортогтой дэн жаргаж байв.

LXVI. ЦААЗЛАВ

Шөнө дунд болж, ширүүн бороо ороод өнгөрсний улмаас улбар туяатай болсон тал сар Армантьерын цаанаас цухуйж, цийлгэр гэрэлд нь байшин сүмийн цамхгийн бараа харлана. Тэдний өмнө Лис голын хайлсан тугалга шиг харагдах ус урсаж, голын цаана, харанхуй шөнө бүрэг гэгээрхүү маягтай харагдах бөөн бөөн хар үүл нүүсэн бүрхэг тэнгэрийн хаяанд хэсэг модны бараа бүүдийж харагдана. Зүүн талд сэнс нь үл хөдлөх хаягдмал тээрэм хүглийж, нурсан ханан дотроос үе үе шар шувууны муухай дуу гарч байлаа.

Гунигт цувааны явж байгаа замын баруун зүүнтээх тал газарт намхан саглагар модны бараа харанхуйгаас ялгаран харагдах нь энэ зэвүүн муухай цагаар хүмүүсийг отоод цөмцийн сууж байгаа аймаар муухай оодойнууд шиг санагдана.

Үе үе цахилгаан гялбан тэнгэрийн хаяаг тэр чигээр нь гийгүүлж, бараалж байгаа бөөн модны дээгүүр тахиралдаад, ид шидийн айхтар мэс шиг тэнгэр, голын ус хоёрыг тас хуваагаад орхих мэт болно. Агаар бөгчим, өчүүхэн төдий ч сэвэлзэх салхигүй байв. Байгаль дэлхий нам гүмд автсан, саяхан хур ороод газар нойтон, бороондсэргэсэн өвс ногооны үнэр улам анхилуун сайхан байв.

Хамгийн түрүүнд Гримо, Мушкетон хоёр Миледийг хөтөлж, хойноос нь зандалчин түүний араас Винтер гуай, д'Артаньян, Атос, Портос, Арамис тавуул дагаж, Планше, Базен хоёр сүүл мушгиж явав.

Хоёр зарц Миледийг гол руу хөтөлж явахад бүсгүйн амнаас үг гарахгүй боловч уулын учиртай нүд нь хүмүүсийг ээлжлэнгуйж, энэрэл эрсэн байртай ширтэх нь айхтар байлаа. Бусдаас хэдэн алхам урагшаа болсноо Миледи ашиглаж зарц нарт хэлсэн нь:

-Намайг зугтаахад тус болбол та хоёрт мянга мянган алтан зоос өгье, харин намайг эздийнхээ гарт өгөх юм бол миний өшөөг та нараас авах хүмүүс ойрхон бий шүү, гэлээ.

Гримо үүнд эргэлзэж Мушкетоны хамаг бие чичирч байлаа.

Миледийн дууг сонсмогц Атос даруй ойртож ирэхэд Винтер гуай бас ойртож ирээд:

-Энэ зарц нарыг холдуул. Эдэнд энэ нэг юм хэлсэн, тэхлээр эдэнд итгэж нэгэнт болохгүй гэв.

Атос тэгээд Планше, Базен хоёрыг дуудаж Гримо, Мушкетон хоёрыг холдуулав. Цөм эрэг дээр ирсэн хойно, зандалчин Миледийн гар хөлийгхүлж гарав.

Тэхэд Миледи ам нээж:

-Та муусайн аймхай алуурчид, ганц бүсгүй хүн алахын тулд та нар арваадаараа цугларчээ. Харж байгаарай! Над туслахаар ирдэггүй юмаа гэхэд миний өшөөг авна шүү! гэж сүрдүүллээ.

Атос үүнд: та бүсгүй хүн биш ерөөс хүн биш, тамаас оргож гарсан шулам, бид таныг буцааж тамд чинь очуулна, гэж хүйтнээр өгүүлэв.

-Сайн үйлт эрхмүүдээ! Миний толгойн үс төдийд л хүрсэн хүн өөрөө мөн хүн алсан болно гэдгийг ухаараарай, гэж Миледи хэлсэнд улаан нөмрөгтэй хүн өргөн илдээ алгадаад: - Зандалчин хүн алаад, алуурчинд тооцогдохгүй байдаг ёс байна. Зандалчин гэдэг хамгийн сүүлчийн шүүгч гэсэн үг. Манай хөрш германчуудын ярьдгаар тийм л байгааюм даа.

Ингэж хэлэх зуураа тэр хүн бүсгүйн гар хөлийг хүлсээр байсан тул Миледи муухай чарласан нь шөнийн нам гүмд зэвүүн эвгүй дуулдаад ойн гүнд замхран намдав.

Хэрэв би та бүхний ярьж байгаа гэмт хэрэг үйлдсэн юм бол намайг шүүхэд аваачиж өг л дөө. Та нар чинь намайг шүүж, тогтоол гаргах шүүгч нар биш шүү дээ? гэж Миледийг хэлэхэд Винтер гуай:

-Таныг би Тайберид оч гэж байсан. Та өөрөө яагаад дургүйцсэн юм бэ? Миледи зандалчингийн гараас мултрахыг хичээн хөрвөлдөх зуураа яагаад гэвэл би үхэх дургүй байна. Би үхнэ гэхэд даанч залуу байна, гэж дуу алдлаа.

-Бетюнд таны хор уулгасан бүсгүй, танаас залуу байсан боловч хорлогдоод үхсэн шүү дээ, гэж д'Артаньян хэллээ. Миледи цаашаа,

-Би хийдэд санваар хүртээд сууя гэхэд зандалчин хариуд нь:

Та хийдэд нэгэнт сууж байсан, миний хөөрхий дүүг хөнөөх гэж тэндээсээ гарсан шүү дээ, гэж маргав.

Миледи хэлмэгдэн дуу тавиад сөхрөн ойчсонд зандалчин түүнийг өргөөд завь руу аваачих гэтэл Миледи чанга дуугаар:

-Бурхан минь, бурхан минь, та нар намайг живүүлж алах гэж үү дээ? гэв.

Ийнхүү хашгирахад өнөө хүртэл Миледийг хамгаас ихээр өшин занаж байсан д'Артаньяны элэг эмтрээд, ойр байсан модны хожуул дээр сууж хоёр алгаар чихээ тагласан боловч, Миледийн орилох занах дуу дуулдаад байлаа.

д'Артаньян хамгийн залуу нь байсан болохоор тэсч чадсангүй:

Би энэ айхтар юмыг харж чадахгүй нээ! энэ бүсгүйг би ийм янзаар үхүүлж чадахгүй нээ! гэлээ. Миледи түүний үгийг сонсоод горьдлого төрж:

-д'Артаньян, д'Артаньян чамд би хайртай сайн байсан шүү дээ! гэж хашгирсанд, залуу цэрэг түүн уруу алхав.

Гэтэл Атос илдээ суга татаж аваад зам хөндөлдөж: д'Артаньян та цаашаа нэг л алхвал бид илд зөрүүлэх нь байна, гэсэнд д'Артаньян сөхөрч унаад залбирал уншив.

-За зандалчин та хийх ёстой юмаа хий гэж Атос дуугарлаа.

-Дуртайяа хийе эрхэм минь, Би сүсэг бишрэлтэй хүн, энэ бүсгүйн тухайд үүргээ

гүйцэтгэснээр сайн үйл үйлдэж байна гэж лавгай итгэж байна гэж цаад хүн хариулав.: -За сайн, хийж үз гээд Атос Миледи рүү очиж

-Та надад их гай зовлон учруулсан ч гэсэн би таныг уучилж байна. Биирээдүйгээ алдаж, нэр төрөө бузарлуулж, хайр сэтгэлээ элэг доог болгуулснаа, мөн танаас болж мухардаж цөхрөөд үүрд харалсан дотортой явах болсон ч таныг уучилъя. Ум сайн амгалан болтугай! гэв.

Винтер гуай мөн бүсгүй рүү очиж:

-Дүүд минь хор идүүлж, гэгээн сайд Бекингэмийг алсан явдлыг тань уучилъя. Хөөрхий Фельтоныг үхэх болгосон нүглийг чинь уучилъя. Миний амийг хорлох гэсэн нүглийг чинь уучилъя, Амгалан болтугай! гэлээ.

-Аа би тайж хүнд зохилдошгүй муу мэх гаргаж таны уурыг хүргэсэндээ авхайтан танаас уучлал гуйя. Өөрөө би хөөрхий, хайрт бүсгүйг минь алсан нүглийг чинь таны хатуу өшөө авсныг чинь уучлаад, өөрийн чинь хойноос уйлж байна. Амгалан болтугай! гэж д'Артаньянхэллээ.

-Би дүүрчээ! би үхэх ёстой болжээ, гэж Миледи англиар шивнэв. Ингээд хэний ч дэмжлэггүй өөрөө босоод орчноо гал цог шиг хурц хараагаараа эргэцүүлэн ширтлээ. Нүдэнд нь юу ч үзэгдсэнгүй. Чагнаад үзсэн чинь юм дуулдсангүй. Миледийн өштнөөс нь өөр хэн ч байсангүй.

-Би хаана үхэх юм бэ? гэж асуухад нь зандалчин:

-Нөгөө талын эрэг дээр гээд Миледийг завинд суулгаад өөрөө суухын нь даваан дээр Атос хэтэвчтэй алтан зоос, түүнд сарвайж:

-Үүнийг ав, тогтоол гүйцэтгэсний шан. Бид шүүгчийн ёсоор гүйцэтгэж байгааг хэн бүхэн мэдэг гэлээ.

. -За сайн, би ч мөн өөрийнхөө эрхэлсэн ажлаа биш шудрага хүний үүргээ биелүүлж байгаа юм гэдгийг энэ бүсгүй мэдэг, гээд зандалчин авсан алтаа усанд хаяж орхив. Завь хөдөлж Лиса голын зүүн эрэг рүү гэмт бүсгүй зандалчии хоёрыг аваад явлаа. Бусад нь баруун эрэг дээр үлдээд цөм сөхрөв.

Усан дээгүүр үүлний бүдэг гэрэлд зурайн харагдаж байгаа гарамны татуургыг дагаад завь алгуур хөдөлнө. Завь нөгөө эрэгт очиж зогсох нь харагдана, зандалчин, Миледи хоёрын бараа баргар тэнгэрийн хаяанд бараантан сүүдийнэ.

Гол гаталж байх зуур Миледи хөлийнхөө хүлээсийг тайлж амжсан байв. Завь нөгөө эргэнд хүрэхийн хамт Миледи хөнгөхөн үсэрч буугаад хурдлан зугтаалаа. Гэтэл газар нойтон байсан болохоор Миледи хэвгий газарт хүрээд хальтирч сөхрөн уналаа.

Миледигийн дотор сүсэг бишрэл төрөөд бурхан надад туслахаас татгалзаж байна гэж санаад толгойгоо гудайлган, гараа зөрүүлж тэр чигтээ нам суулаа.

Тэгтэл зандалчин хоёр гараа алгуур өргөөд сарны гэрэлд өргөн илд гялсхийх нь нөгөө эргээс харагдаад, агаар зүсэн исгэрч, оногдсон хүн бархираад; толгойгүй болсон бие нь ойчоод өгөв. Зандалчин улаан нөмрөгөө тайлж, газар дэвсээд бүсгүйн биеийг дээр нь тавьж, толгойгий нь мөн тийшээ хийж боогоод үүрсээр завин дээрээ гарав.

Лиса голын дунд ирээд авч явсан юмаа өндөр өргөж:

-Бурхны шударга шүүх ёсоор болтугай! гэж чанга хашгираад хүүрийг усанд тавьсанд даруй уснаа живэн далд оров. Гурван өдрийн дараа дөрвөн шадар цэрэг Парист эргэж ирлээ, авсан чөлөөнөөсөө тэд хожимдсонгүй, тэр оройдоо де Тревиль гуайд айлчилж ирлээ.

-За эрхмүүд ээ, чөлөөгөөр яваад сайхан зугаацав уу? гэж тэднээс зоригт дарга нь асуухад Атос өөрийнхөө болоод нөхдийнхөө өмнөөс:

-Яриагүй! гэж хариуллаа.

ТӨГСГӨЛИЙН ҮГ

Дараа сарынзургааны өдөр ван эзэн Ларошельд буцаж очно гэж Хамба ламтанд амласан ёсоороо нийслэл хотоос мордохдоо Бекингэмийн алагдсан тухай шагшин хэлэлцэхийг сонсоод мэл гайхчихжээ.

Үнэн сэтгэлтэй сайн хүний нь амь насанд аюул учирч болзошгүй гэж хатан эзэн урьдаас дуулаад байсан хир нь Бекингэмийн нас барсныг дуулгахад үнэмшихгүй, тэр ч байтугай гэнэнсэргээр: -Худлаа. Тэр чинь саяхан надад захиа явуулсан шүү гэж дуу алджээ.

Гэвч дараа өдөр нь хатагтай аргагүй уг мэдээний үнэнд үнэмшихээс өөр аргагүй боллоо. Ла Порт англиас гарахдаа бусад хүмүүсийн нэгэн адил Карл нэгдүгээр вангийн тушаалаар хөл хоригдож байгаад, хатан эзэнд Бекингэмийн эцсийн бэлгийг авчирч өгчээ.

Ван эзний баярласан гэж их, түүнийгээ нуух нь байтугай, баярласнаа хатны дэргэд зориуд ил харуулж байв. XIII Людовик ван уулын тавьтар муутай болохоор гойдын өгөөмөр сэтгэлтэй хүн биш билээ.

Ван удаан сайхан зантай байж үл чадах хүмүүсийн нэг болохоор төдхөн царай нь дахин барайгаад явчихлаа. Хуаранд эргэж очоод дахин хүний мэдэлд орох болно гэдгээ мэдэж байлаа. Гэвч хуаран руу очиж явлаа. Хамба ламтан нэг ёсондоо ванд могой болж, ван өөрөө мөчир мөчир дамжин жиргэвч могойноос холдоод явчхаж үл чадах шувуу аятай болчихсон ажээ.

Ийм болохоор Ларошель руу буцах зам их гунигтай байсны дээр ялангуяа манайдөрвөн нөхөд уруу царайлж, толгойгоо унжуулан доош харж зэрэгцэж явахад нөхөд нь гайхаж байлаа. Ганцхан Атос л ихэмсэг тэргүүнээ өргөж, нүдэнд нь цог бадраад, гашуунаар инээвхийлэх боловч дараа нь нөхдийнхөө нэг адил дахин бодолд автана.

Алив нэгэн хотонд ирж, ван эзнийг буух байранд нь хүргэж өгмөгц дөрвөн нөхөд даруй

байрандаа очих буюу зайдуу нэг буудалд очиж, очоод шоо хаяж тоглох ч үгүй, дарс ч уухгүй, шивнэлдэн юм ярьж, яриагаа хүн чагнах бий гэж сэрэмжлэн хулмалзах ажээ. Нэг өдөр ван эзэн замдаа ан агнах санаатай үдлэхэд дөрвөн нөхөд анчидтай нийлэхийн оронд ердийнхөө зангаар замын хажуугийн нэг буудалд орлоо. Тэгтэл Ларошелиас хар хурдаараа давхиж ирсэн нэгхүн тэр буудлын өмнө морио зогсоож, аяга дарс уух санаатай, манай дөрвөн нөхдийн сууж байсан өрөө рүү шагайснаа чанга дуугаар:

-Хөөе д'Артаньян гуай! Та энд байж байгаа юм биш биз? гэж хашгирав.

д'Артаньян толгойгоо өндийж хараад баярлаж дуу алдав. Үзтэл д'Артаньяны муу зүгийн тэнгэрээ гэж нэрлэдэг Менге хот, авчины гудамж, Аррас гэдэг газарт дайралдаж байсан өнөөх үл таних хүн зогсож байлаа.

д'Артаньян илдээ суга татаж аваад үүд рүү ухасхийсэнд энэ удаа үл таних хүн буцаж зугтаасангүй мориноосоо үсэрч буугаад, өөдөөс нь ирлээ.

-За өршөөлт эрхэм минь, би арай гэж тантай нэг учирлаа. Энэ удаа та алга болоод өгч чадахгүй бий гэж залуу шадар цэрэг хэллээ.

-Надад тэгэх санаа ер алга, энэ удаа би өөрөө таныг эрж явсан юм. Ван эзний нэрийн өмнөөс таныг баривчиллаа. Өршөөлт эрхэм минь та над илдээ аль! Эсэргүүцэх гэж бүү бод, таны амь настай холбоотой хэрэг гэдгийг сануулъя, гэв.

д'Артаньян илдээ доош болгоод, өгөлгүй түдгэлзэж,

-Та хэн гэгч вэ? гэж асуусанд үл таних хүн:

-Би де Ришелье Хамба ламтны шадар де Рошфор гэгч хүн байна. Таныг их гэгээнтнийд хүргэх тушаал авсан юм гэлээ.

Атос ойртож ирээд ярианд оролцож, бид их гэгээнтэн тийш очиж яваа улс байна эрхэм ээ. д'Артаньян гуай эндээсээ шууд Ларошель руу очно гэвэл та үгэнд нь итгэнэ биз дээ? гэв. - Энэ хүнийг, би хуаранд авч очих хуягуудын гарт шилжүүлж өгөх учиртай юм. -Бид энэ хүнд хуяг больё гэж тайж хүний багтай ам өгье, Өршөөлт эрхэм минь. Мөн д'Артаньян гуай биднээс салангид явахгүй гэдгийг би бас амлая гээд Атос хөмсөгзангидлаа. Де Рошфор эргэж хартал Портос, Арамис хоёр үүд халхалж зогссоныг үзээд энэ дөрвөн хүний гарт бүрэн орсноо мэдэв.

Ингээд тэдэнд хэлсэн нь:

-Эрхмүүд ээ, д'Артаньян гуай надад илдээ өгөөд, мөн та бүхний нэгэн адил Хамба ламтны хуаранд буцаж очно гэдэг ам өгвөл би та бүхний амласанд итгэе гэлээ. -Өршөөлт эрхэм гуай танд ам өгье, май миний илд энэ байна, гэж д'Артаньян хэлэв. -Надад цаашаа явах хэрэг байгаа болохоор энэ чинь аштай юм боллоо гэж Рошфорыг хэлэхэд Атос өөдөөс нь:

-Миледитэй уулзах гэж байгаа бол дэмий, та дахиад тэр бүсгүйтэй уулзахгүй дэг гэж

хүйтнээр дуугарав.

Миледи юу болоо вэ? гэж Рошфор шохоорхон асуухад:

-Хуаранд буцаж оч, тэнд тэр тухай мэднэ биз гэлээ. Рошфор хэсэгхэн зуур бодол болсноо Хамбаламтан, Ван эзнийг угтахаар ирэх Сюржер гэгч газраас өдөрчийн газарт байгаа болохоор Атосын зөвлөгөөг дагаж цуг буцахаар шийдлээ.

Тэгээд ч буцах болбол баригдсан хүнийг өөрөө харгалзаж болох бас нэг сайн талтай байлаа. Ингээд цөм цааш замдаа гарлаа.

Дараа өдрийн гурван цагийн үед тэд Сюржерт ирлээ. Хамба лам энд XIII Людовик вант тосч байлаа. Ван эзэн Хамба лам хоёр уулзаад, бүх европ дахиныг францын эсрэг болгож, байнга дайсагнаж байсан хүнээс азаар хагацсан явдалд эелдэг найрсаг үг хэлэлцэв. Үүний дараа д'Артаньян баригдаад байгааг Хамба ламтан Рошфороос дуулсан болохоор уулзахыг яарч, ван эзэнд салахын үг хэлж, дараа өдөр нь шинэ барьсан далан очиж үзэхийг урилаа.

Хамба ламтан чулуун гүүрийн дэргэдэх хүрээндээ орой эргэж иртэл суудаг байшингийнхаа үүдэнд д'Артаньян илдгүй, зэвсэгтэй гурван шадар цэргийн хамт зогсож байхыг үзлээ. Энэ удаа хүч өөрийн нь талд давуу байсан болохоор Хамба ламтан тэднийг ширүүн хараад, д'Артаньяныг өөрийнхөө хойноос дагаж яв гэж гар, харцаараа дохиод өнгөрөв.

-д'Артаньян хойноос нь дагаж хөдлөхөд Атос хамбад дуулдахуйц чангаар:

-д'Артаньян чамайг бид энд хүлээе гэж хэллээ. Их гэгээнтэн зогсосхийж, хөмсөг зангидсан боловч үг дуугаралгүй байшиндаа орлоо. д'Артаньян хамбын араас дагалдан ороход нөхөд нь хаалганы цаана сахин хоцров.

Хамба ламтан шуудхан ажлынхаа өрөө рүү орохдоо залуу цэргийг өөр дээрээ оруул гэж Рошфорт дохив.

Рошфор Хамбын тушаасан ёсоор залууг оруулаад гарав.

д'Артаньян Хамба ламтантай хоёулхнаа үлдлээ. д'Артаньян Ришельетэй хоёр дахь удаагаа уулзаж байгаа нь энэ билээ. Үүнийг эцсийн уулзалт болно гэж бат санасан гэж д'Артаньян ярьдаг байжээ.

Ришелье ил гал түлэх зуухны хана түшиж зогсоно, д'Артаньян тэр хоёрын хооронд нэг ширээ байлаа.

-Эрхэм гуай та миний тушаалаар баривчлагдсан юм гэж Хамбыг хэлэхэд: Их гэгээнтэн гуай, үүнийг надад түрүүн хүн хэлсэн гэж өчив.

Ямар учраас баривчлагдсанаа та мэдэж байна уу?

-Үгүй, гэгээнтэн. Баригдаж болохуйц ганц хэрэг хийсэн тэр маань танд дуулдаагүй байгаа юм гэхэд Ришелье залуугийн өөдөөс хянуур гэгч ширтээд:

-Уухай! юу гэсэн үг вэ? Энэ чинь

-Гэгээнтэн та эхлээд ямар хэрэг надад тохох гэж байгааг хэлж гийгүүлж хайрлавал сүүлд нь үнэн хийсэн хэргээ би ярьж өгье.

-Эрхэм та байтугай, танаас дээгүүр язгууртай хүнийг ч өршөөлгүй, толгойг нь авдаг тийм хүнд ял танд тохогдож байна, гэж Ришелье хариулахад, д'Артаньян:

-Ямар хэрэг тэр вэ? гэж тун тайван асуусан нь хамбад хүртэл гайхалтай санагджээ.

Таныг улсын дайсантай бичгээр харилцсан улсын нууцыг тагнасан дээд дарга нарынхаа төлөвлөгөөг нураах гэж оролдож байсан ял тохогдож байна. д* Артаньян энэ үг Миледигээс улбаатайг гадарлаад:

-Хэн намайг энэ хэрэгт буруутай гэж байгаа юм бэ, гэгээнтэн? Төрийн цаазаар шившгийн тамга даруулсан, францад нэг хүнтэй суугаад, Англид өөр хүнтэй суусан, хоёр дахь нөхрөө хор өгч алаад, намайг өөрий минь алах гэж оролдож байсан бүсгүй тэр үү? гэв.

-Эрхэм та юу яриад байнаа! та ямар бүсгүйг яриад байна гэж Хамба дуу алдав. -Винтер авхайг хэлж байна. Тэр Винтер авгайн үйлдсэнбүх гэмт хэргийг гэгээнтэн мэдээгүй бололтой, эс тэгвэл тэр хүнийг итгэж дотночлохгүй байсан биз?

-Винтер авхай үнэхээр эрхэм таны ярьж байгаа гэмт хэргийг үйлдсэн юм бол цээрлэл хүлээх болноо.

-Миледи цээрлэл нэгэнт хүлээсэн.

-Хэн түүнийг цээрлүүлээ вэ?

-Бид

-Шоронд байгаа юм уу?

-Үгүй, үхсэн.

Хамба ламтан чихэндээ итгэж чадахгүй,

-Үхсэн гэнээ? үхэж гэв үү? та тэгж хэлэх шив? гэлээ. Тэр бүсгүй намайг гурав дахиж алах гэхэд нь би өнгөрөөсөн, гэтэл тэр бүсгүй миний хайр сэтгэлт хүнийг алчихсан байхаар манай нөхөд бид хөөж бариад, шүүж цаазаар аваачих ял оноосон. Ингээд Бетюна бүсгүйчүүлийн хийдэд Бонасье авгайд хор уулгачихсан байсан, ганц жижиг байшинд хэрэгтасалсан, Лиса голын эрэг дээр цаазалсан тухай д'Артаньян ярьж өглөө.

Хамбын бие зарсхийх нь ховор боловч энэ удаа хамаг бие зарсхийгээд явчихлаа. Гэтэл гаргаж хэлээгүй нэг бодлын улмаас хамбын өнөө хүртэл хөрзгөр байсан царай бага багаар зөөлөрч, энгийн тайван болоод:

-Ингэхлээр хэрэг шүүх эрхгүй мөртлөө, хэрэг тасалсан хүмүүс хүн алсанболдгийг та нар бодож үзэлгүй шүүгчийн эрхийг дураараа эдлээ шив? гэж Хамба зөөлөн дуугаар хэлсэн нь уул хатуу үгтэйгээ сайн авцалдахгүй байв.

-Их гэгээнтэн таны өмнө биеэ зөвтгөх санаа надад өчүүхэн ч байгаагүй гэдгийг амлая. Их гэгээнтэн таны оногдуулах шийтгэлийг би хүлээхэд бэлхэн байна. Би хар амиа нэг их хайрладаггүй болохоорүхэхээс айхаар хүн биш юм, гэсэнд хамба ламтан бараг эелдэг дуугаар:

-Таны эрэлхэг зоригтойг би мэднэ. Тэхлээр таныг шүүж, шийтгэл оногдуулна гэдгийг урьдаас хэлж болно гэв.

-Надаас өөр хүн бол ял хэлтрүүлсэн бичиг өвөрт минь байна гэж их гэгээнтэнд хэлэх биз. Тэхэд би бол юунаас ч буцахгүй гэгээнтэн та айлдаж хайрла гэж байна, гэж д'Артаньян өгүүллээ.

-Ял хэлтрүүлсэн бичиг ий? гэж Ришелье гайхсанд, д'Артаньян:

-Тиймээ гэгээнтэн гэж өчив.

-Хэний гарын үсэгтэй юм бэ? Ван эзний юу? гэхдээ тун үл тоомсорлох дуугаар хэлэв. -Үгүй, их гэгээнтэн таны гарын үсэгтэй юм.

-Миний юу? та яав, солиороогүй биз?

-Гэгээнтэн та өөрийнхөө гарын үсгийг лав танина бизээ, гээд д'Артаньян нөгөө Миледигээс Атосын булааж аваад өөрт нь бие хамгаалах бичиг болж байг гэж өгсөн чухаг бичгийг Хамбад өглөө.

Хамба бичгийг аваад, үг болгоныг таслан хянуур уншсан нь:

" Үүнийг үзүүлэгчийн үйлдсэн бүхэнулсын ашиг тусын тулд, миний тушаалаар хийсэн болно. 1628 оны 8 дугаар сарын 5. Ришелье" гэжээ. Энэ хоёр мөрийг уншаад хамба ламтан гүн бодолд автаад бичгийг д" Артаньянд буцааж өгсөнгүй.

" Намайг яаж цаазлахаа бодож байх бололтой. Юу ч болсон тайж хүн яаж үхдэгийг үзүүлнэ дээ" гэж д'Артаньян дотроо бодов. Залуу цэргийн сэтгэлсайхан уужим байсан болохоор эр хүн шиг байж байгаад нөгөө ертөнцөд тонилоод өгөхөд бэлэн байв. Ришелье бодол болон нөгөө бичгийг нэг хуйлж, нэг дэлгэнэ. Тэгж байснаа толгойгоо сая нэг өргөж д'Артаньян нүдэнд дулаан ухаалаг эрдүү царайг хурц нүдээрээ хянуур ширтээд, залуугийн сүүлийн нэг сард үзэж өнгөрүүлсэн зовлон, нулимсны орыг олж хараад дөнгөж хорин нэгэн нас хүрч яваа энэ залуу цаашдаа хир их сайн хүн болох төлөвтэй байсан, үүнийг захирч чадсан мэргэн хүн эр чадал, оюун самбаагий нь яаж сайн ашиглаж болохыг дотроо хэд хэд дахин эргэцүүлж бодлоо.

Нөгөө талаас Миледийн үйлдсэн гэмт хэрэг, адтай их. чадлаас Хамба өөрөө айх удаа ганц биш дайралдаж байжээ.

Хамба аюултай хамсаатнаас үүрд ангижирчээ гэдгийг бодохоос, сэтгэлийнхээ угт баярлаад байлаа.

д'Артаньяны уудам сэтгэлээр эргүүлж өгсөн цаасыг Хамба алгуурхан ураад хаячхаар "Би ч ингээд өнгөрчээ" гэж д'Артаньян бодоод "Бурхны таалал ёсоор болтугай" гэсэн байртай Хамбын өмнө доор мэхийн ёслол.

Хамба ламтан ширээ рүү очоод, дэлгээстэй байсан, ихэнхийг нь бөглөсөнхуудсан дээр нэмж хэдэн үг бичээд тамгаа дарлаа.

" Миний ялын тогтоол байж таарна. Хамба ламтан намайг Бастили гянданд хоригдож, шүүхээр орж төвөг удах ажлаас хэлтрүүлж байна. Ингэж өгсөн нь их эелдэг хэрэг дээ" гэж д'Артаньян бодлоо.

-Май үүнийг ав. Би танаас нэг бичиг авсан, оронд нь өөрийг өгье. Энэ үнэмлэхэн дээр нэр тавиагүй юм, өөрснөө тавьж орхиорой гэж Хамбыг хэлэхэд д'Артаньян бичгийг түдгэлзэхийн авч үзвэл шадар цэргийн дэслэгч цол шагнасан зарлиг байв. д'Артаньян Хамбын өмнө сөхрөн:

-Гэгээнтэн одооноос эхлээд миний бие таны төлөө зүтгэнэ, өөрийнхөө тааллаар намайг зарж байна уу. Даан ч би таны үзүүлж байгаа энэ өндөр их хишгийгхүртэх болоогүй, надаас илүү их гавьяатай, үүнд тэнцэх гурван сайн нөхөд бий, гэтэл Хамба үгийг нь таслан, энэ зоримог эрийн сэтгэлийг дагуулж чадсандаа дотроо таатай болоод, мөрий нь нөхөрсгөөр алгадан: - д'Артаньян та сайн хүн. Энэ үнэмлэхийг өөрийнхөө дураар хэрэглээрэй. Тэхдээ нэр бичээгүй хэдий боловч энэ үнэмлэхийг би өөрт чинь өгч байгааг бодолцоорой гэлээ.

д'Артаньян: Үүнийг би хэзээ ч мартажгүй, их гэгээнтэн та итгэж болно гэж хариулав. Хамба ламтан эргэж чанга дуугаар:

-Рошфор! гэж дуудсанд үүдний цаана зогсож байсан бололтой шадар хүн даруй орж ирлээ.

-Рошфор оо, таны өмнө д'Артаньян гуай байж байна. Энэ хүнийг би нөхдийнхөө тоонд оруулж авлаа. Тэхлээр та хоёр толгойгоо мэнд авч явах дуртай бол эвлэрч үнсэлцээд тохитой шиг явцгаа, гэж Хамба хэллээ.

-Рошфор, д'Артаньян хоёр уруулаа дөнгөж хүргэх төдий болж үнсэлцэхэд Хамба ламтан дэргэднь зогсоод хурц нүдээ салгалгүй харав. Хоёул өрөөнөөсөө цуг гарлаа.

Эрхэм ээ, бид дахин уулзана, тийм биз? гэхэд д'Артаньян өөдөөс нь:

-Таны таалалтай цагт л уулзана гэв.

-Тохиромжтой цаг мөд олдоно гэж Рошфор хэлтэл Ришелье үүд онгойлгоод: -Юу гэнээ гэж асуулаа.

Хоёр залуу даруй өөд өөдөөсөө харж инээмсэглээдгар барилцсанаа их гэгээнтнийг хүндэтгэн мэхийв.

-Бид бүр хүлцэж ядаж байлаа шүү, гэж Атосыг хэлэхэд д'Артаньян:

-За би гараад ирлээ дээ нөхөд минь! Би сул чөлөөтэйгөөр барахгүй хайр, хишиг хүртлээ гэж хариулав.

-Та цөмий нь бидэнд ярьж өгнө биз?

-Өнөө оройдоо ярина.

Үнэхээр ч д'Артаньян тэр оройдоо Атосынд очтол цаадах нь шил испани дарс ууж суув. Сүүлийн үед Атос орой болгон тэгдэг болжээ. Хамбынд ороод болсон бүх явдлыг д'Артаньян ярьж өгөөд өврөөсөө үнэмлэх гаргаж:

-Эелдэг сайн нөхөр Атос минь үүнийг аваа. Энэ яахын аргагүй чиний юм, гэсэнд Атос ердийн зангаар эелдэг сайхан инээмсэглээд,

-Найз минь энэ чинь Атост дэндүү өндөр, де ла Фер гүнд хэтэрхий өчүүхэн хишиг байна. Энэ үнэмлэхээ өөрөө ав. Энэ чинь аргагүй таны юм. Та үүнийг өндөр их үнээр олж авсан шүү хөөрхий гэж хариуллаа.

д* Артаньян Атосынхаас гарч Портосынд ортол, Портос үнэтэй сайхан хатгамалтай гоё гадуур цамц өмсч тольдон өөрийгөө шохоорхож байснаа:

-Аа найз чи юу! энэ хувцас над хир зохиж байх шиг санагдана, найзаа? гэв. -Их сайхан зохижээ, харин би өөрт чинь арай илүү зохих өөр хувцас өмсөөч гэж хэлэх санаатай ирлээ гэж д'Артаньян хариулав.

-Ямар хувцас тэр вэ?

-Шадар цэргийн дэслэгчийн хувцас гээд, д'Артаньян Хамбатай уулзсан тухай яриад Хамбын өгсөн үнэмлэхийг гаргаж

-Май сайн найз минь энэ үнэмлэхийг аваад нэрээ бичиж над сайн дарга болоорой гэв. Портос үнэмлэхийг үзээд буцааж өгсөнд д'Артаньяны гайхсаныг хэлэхэд бэрх.

-Нээрээ энэ чинь над тааламжтай сайхан байхсан. Гэтэл би энэ хишгийг удаан хүртэж чадахгүй. Биднийг Бетюн оргож явах зуур миний нөгөө холбоотой авхайн нөхөр герцог нас барсан байна. Одоо талийгаачийн авдар миний гарт орж ирэх гээд байна. Эелдэг найз минь би бэлэвсэн эхнэртэй нь сууна. Харж байгаа биз дээ, би хуримынхаа хувцсыг өмсөж үзэж байна. Дэслэгч цолоо өөрөө эдлээрэй. найз минь, өөрөө эдэл, гээд үнэмлэхийг нь буцааж өглөө.

Залуу цэрэг цаашаа Арамисынд очлоо. Арамис бурхны ном дэлгэж тавиад сөхрөн сууж, толгойгоо унжуулан залбирч байв.

д'Артаньян хамбатай уулзсан тухайгаа Арамист ярьж өгөөд үнэмлэхээ гуравдах удаа гарган,

-Та бол бидний ухаалаг сайн нөхөр, далдын өмөг түшиг болсон хүн, энэ үнэмлэхийг аваа. Бидэндээ ямагт урагштай бүтэлтэй зөвлөгөө өгдөг, саруул мэргэн хүн та л үүнийг авч таарах учиртай гэж хэлсэнд Арамис санаа алдаад:

-Үгүй дээ эелдэг найз минь. Бидний сүүлчийн энэ явдал хорвоогийн амьдрал, цэргийн албанд намайг бүрмөсөн дургүй болголоо.. Энэ удаа би эргэж буцалтгүй шийдэж, бүслэлт дуусмагц би сахил хүртэнэ. Наад үнэмлэхээ д'Артаньян та өөрөө ав, цэргийн албанд та хамгаас илүү сайн тохирох хүн. Та авхаалж самбаа, эр зоригтой сайн дарга болно гэв.

д'Артаньян эргэж Атос дээр ирэхдээ нөхдөдөө магнай хагартлаа баярлаж, баярласандаа нүд нь гялалзаж байлаа. Атос түрүүчийнхээрээ ширээний ард сууж, сүүлчийн аяга дарсны өнгийг дэнгийн гэрэлд гэрэлтүүлэн харж суулаа.

-За ингээд нөгөөдүүл маань бас авсангүй гэж д'Артаньян хэлсэнд Атос: -Энэ хишгийг чухам хүртвээс зохих хүн та болохоор тэр шүү дээ гээд үзэг авч үнэмлэхэн дээр д'Артаньяны нэрийг бичээд өгөв. Залуу цэрэг:

-За ингээд би найз нөхөд үгүй болжээ. Өнгөрснийг дурсаж сэтгэл шимшрэхээс өөр юу ч үгүй болох шив дээ хөөрхий! гээд уруу харахад хацрыг нь дагаж бөөн нулимс бөмбөрлөө. -Та идэр залуу байна, өнгөрсөн гунигт явдал чинь мартагдаж баярлах цаг ирнэ гэж Атос хариулав.

LXVII. ТӨГСГӨЛИЙН ҮГ

Дараа сарын зургааны өдөр ван эзэн Ларошельд буцаж очно гэж Хамба ламтанд амласан ёсоороо нийслэл хотоос мордохдоо Бекингэмийн алагдсан тухай шагшин хэлэлцэхийг сонсоод мэл гайхчихжээ.

Үнэн сэтгэлтэй сайн хүний нь амь насанд аюул учирч болзошгүй гэж хатан эзэн урьдаас дуулаад байсан хир нь Бекингэмийн нас барсныг дуулгахад үнэмшихгүй, тэр ч байтугай гэнэнсэргээр:

— Худлаа. Тэр чинь саяхан надад захиа явуулсан шүү гэж дуу алджээ.

Гэвч дараа өдөр нь хатагтай аргагүй уг мэдээний үнэнд үнэмшихээс өөр аргагүй боллоо. Ла Порт англиас гарахдаа бусад хүмүүсийн нэгэн адил Карл нэгдүгээр вангийн тушаалаар хөл хоригдож байгаад, хатан эзэнд Бекингэмийн эцсийн бэлгийг авчирч өгчээ.

Ван эзний баярласан гэж их, түүнийгээ нуух нь байтугай, баярласнаа хатны дэргэд зориуд ил харуулж байв. XIII Людовик ван уулын тавьтар муутай болохоор гойдын өгөөмөр сэтгэлтэй хүн биш билээ.

Ван удаан сайхан зантай байж үл чадах хүмүүсийн нэг болохоор төдхөн царай нь дахин барайгаад явчихлаа. Хуаранд эргэж очоод дахин хүний мэдэлд орох болно гэдгээ мэдэж байлаа. Гэвч хуаран руу очиж явлаа. Хамба ламтан нэг ёсондоо ванд могой болж, ван өөрөө мөчир мөчир дамжин жиргэвч могойноос холдоод явчхаж үл чадах шувуу аятай болчихсон ажээ.

Ийм болохоор Ларошель руу буцах зам их гунигтай байсны дээр ялангуяа манай дөрвөн нөхөд уруу царайлж, толгойгоо унжуулан доош харж зэрэгцэж явахад нөхөд нь гайхаж байлаа. Ганцхан Атос л ихэмсэг тэргүүнээ өргөж, нүдэнд нь цог бадраад, гашуунаар инээвхийлэх боловч дараа нь нөхдийнхөө нэг адил дахин бодолд автана.

Алив нэгэн хотонд ирж, ван эзнийг буух байранд нь хүргэж өгмөгц дөрвөн нөхөд даруй байрандаа очих буюу зайдуу нэг буудалд очиж, очоод шоо хаяж тоглох ч үгүй, дарс ч уухгүй, шивнэлдэн юм ярьж, яриагаа хүн чагнах бий гэж сэрэмжлэн хулмалзах ажээ. Нэг өдөр ван эзэн замдаа ан агнах санаатай үдлэхэд дөрвөн нөхөд анчидтай нийлэхийн оронд ердийнхөө зангаар замын хажуугийн нэг буудалд орлоо. Тэгтэл Ларошелиас хар хурдаараа давхиж ирсэн нэг хүн тэр буудлын өмнө морио зогсоож, аяга дарс уух санаатай, манай дөрвөн нөхдийн сууж байсан өрөө рүү шагайснаа чанга дуугаар:

— Хөөе д' Артаньян гуай! Та энд байж байгаа юм биш биз? гэж хашгирав.

д' Артаньян толгойгоо өндийж хараад баярлаж дуу алдав. Үзтэл д' Артаньяны муу зүгийн тэнгэрээ гэж нэрлэдэг Менге хот, авчины гудамж, Аррас гэдэг газарт дайралдаж байсан өнөөх үл таних хүн зогсож байлаа.

д' Артаньян илдээ суга татаж аваад үүд рүү ухасхийсэнд энэ удаа үл таних хүн буцаж

зугтаасангүй мориноосоо үсэрч буугаад, өөдөөс нь ирлээ.

— За өршөөлт эрхэм минь, би арай гэж тантай нэг учирлаа. Энэ удаа та алга болоод өгч чадахгүй бий гэж залуу шадар цэрэг хэллээ.

— Надад тэгэх санаа ер алга, энэ удаа би өөрөө таныг эрж явсан юм. Ван эзний нэрийн өмнөөс таныг баривчиллаа. Өршөөлт эрхэм минь та над илдээ аль! Эсэргүүцэх гэж бүү бод, таны амь настай холбоотой хэрэг гэдгийг сануулья, гэв.

д' Артаньян илдээ доош болгоод, өгөлгүй түдгэлзэж,

— Та хэн гэгч вэ? гэж асуусанд үл таних хүн:

— Би де Ришелье Хамба ламтны шадар де Рошфор гэгч хүн байна. Таныг их гэгээнтнийд хүргэх тушаал авсан юм гэлээ.

Атос ойртож ирээд ярианд оролцож, бид их гэгээнтэн тийш очиж яваа улс байна эрхэм ээ. д' Артаньян гуай эндээсээ шууд Ларошель руу очно гэвэл та үгэнд нь итгэнэ биз дээ? гэв.

—Энэ хүнийг, би хуаранд авч очих хуягуудын гарт шилжүүлж өгөх учиртай юм.

— Бид энэ хүнд хуяг больё гэж тайж хүний багтай ам өгье, Өршөөлт эрхэм минь. Мөн д' Артаньян гуай биднээс салангид явахгүй гэдгийг би бас амлая гээд Атос хөмсөг зангидлаа.

Де Рошфор эргэж хартал Портос, Арамис хоёр үүд халхалж зогссоныг үзээд энэ дөрвөн хүний гарт бүрэн орсноо мэдэв.

Ингээд тэдэнд хэлсэн нь:

— Эрхмүүд ээ, д' Артаньян гуай надад илдээ өгөөд, мөн та бүхний нэгэн адил Хамба ламтны хуаранд буцаж очно гэдэг ам өгвөл би та бүхний амласанд итгэе гэлээ.

— Өршөөлт эрхэм гуай танд ам өгье, май миний илд энэ байна, гэж д' Артаньян хэлэв.

— Надад цаашаа явах хэрэг байгаа болохоор энэ чинь аштай юм боллоо гэж Рошфорыг хэлэхэд Атос өөдөөс нь:

— Миледитэй уулзах гэж байгаа бол дэмий, та дахиад тэр бүсгүйтэй уулзахгүй дэг гэж хүйтнээр дуугарав.

Миледи юу болоо вэ? гэж Рошфор шохоорхон асуухад:

— Хуаранд буцаж оч, тэнд тэр тухай мэднэ биз гэлээ. Рошфор хэсэгхэн зуур бодол болсноо Хамба ламтан, Ван эзнийг угтахаар ирэх Сюржер гэгч газраас өдөрчийн газарт байгаа болохоор Атосын зөвлөгөөг дагаж цуг буцахаар шийдлээ.

Тэгээд ч буцах болбол баригдсан хүнийг өөрөө харгалзаж болох бас нэг сайн талтай байлаа.

Ингээд цөм цааш замдаа гарлаа.

Дараа өдрийн гурван цагийн үед тэд Сюржерт ирлээ. Хамба лам энд XIII Людовик вант тосч байлаа. Ван эзэн Хамба лам хоёр уулзаад, бүх европ дахиныг францын эсрэг болгож, байнга дайсагнаж байсан хүнээс азаар хагацсан явдалд эелдэг найрсаг үг хэлэлцэв. Үүний дараа д'Артаньян баригдаад байгааг Хамба ламтан Рошфороос дуулсан болохоор уулзахыг яарч, ван эзэнд салахын үг хэлж, дараа өдөр нь шинэ барьсан далан очиж үзэхийг урилаа.

Хамба ламтан чулуун гүүрийн дэргэдэх хүрээндээ орой эргэж иртэл суудаг байшингийнхаа үүдэнд д'Артаньян илдгүй, зэвсэгтэй гурван шадар цэргийн хамт зогсож байхыг үзлээ.

Энэ удаа хүч өөрийн нь талд давуу байсан болохоор Хамба ламтан тэднийг ширүүн хараад, д'Артаньяныг өөрийнхөө хойноос дагаж яв гэж гар, харцаараа дохиод өнгөрөв.

— д'Артаньян хойноос нь дагаж хөдлөхөд Атос хамбад дуулдахуйц чангаар:

— д'Артаньян чамайг бид энд хүлээе гэж хэллээ. Их гэгээнтэн зогсосхийж, хөмсөг зангидсан боловч үг дуугаралгүй байшиндаа орлоо. д'Артаньян хамбын араас дагалдан ороход нөхөд нь хаалганы цаана сахин хоцров.

Хамба ламтан шуудхан ажлынхаа өрөө рүү орохдоо залуу цэргийг өөр дээрээ оруул гэж Рошфорт дохив.

Рошфор Хамбын тушаасан ёсоор залууг оруулаад гарав.

д'Артаньян Хамба ламтантай хоёулхнаа үлдлээ. д'Артаньян Ришельетэй хоёр дахь удаагаа уулзаж байгаа нь энэ билээ. Үүнийг эцсийн уулзалт болно гэж бат санасан гэж д'Артаньян ярьдаг байжээ.

Ришелье ил гал түлэх зуухны хана түшиж зогсоно, д'Артаньян тэр хоёрын хооронд нэг ширээ байлаа.

— Эрхэм гуай та миний тушаалаар баривчлагдсан юм гэж Хамбыг хэлэхэд:

Их гэгээнтэн гуай, үүнийг надад түрүүн хүн хэлсэн гэж өчив.

Ямар учраас баривчлагдсанаа та мэдэж байна уу?

— Үгүй, гэгээнтэн. Баригдаж болохуйц ганц хэрэг хийсэн тэр маань танд дуулдаагүй байгаа юм гэхэд Ришелье залуугийн өөдөөс хянуур гэгч ширтээд:

— Уухай! юу гэсэн үг вэ? Энэ чинь

— Гэгээнтэн та эхлээд ямар хэрэг надад тохох гэж байгааг хэлж гийгүүлж хайрлавал сүүлд нь үнэн хийсэн хэргээ би ярьж өгье.

— Эрхэм та байтугай, танаас дээгүүр язгууртай хүнийг ч өршөөлгүй, толгойг нь авдаг тийм

хүнд ял танд тохогдож байна, гэж Ришелье хариулахад, д' Артаньян:

— Ямар хэрэг тэр вэ? гэж тун тайван асуусан нь хамбад хүртэл гайхалтай санагджээ.

Таныг улсын дайсантай бичгээр харилцсан улсын нууцыг тагнасан дээд дарга нарынхаа төлөвлөгөөг нураах гэж оролдож байсан ял тохогдож байна. д* Артаньян энэ үг Миледигээс улбаатайг гадарлаад:

— Хэн намайг энэ хэрэгт буруутай гэж байгаа юм бэ, гэгээнтэн? Төрийн цаазаар шившгийн тамга даруулсан, францад нэг хүнтэй суугаад, Англид өөр хүнтэй суусан, хоёр дахь нөхрөө хор өгч алаад, намайг өөрий минь алах гэж оролдож байсан бүсгүй тэр үү? гэв.

— Эрхэм та юу яриад байнаа! та ямар бүсгүйг яриад байна гэж Хамба дуу алдав.

— Винтер авхайг хэлж байна. Тэр Винтер авгайн үйлдсэн бүх гэмт хэргийг гэгээнтэн мэдээгүй бололтой, эс тэгвэл тэр хүнийг итгэж дотночлохгүй байсан биз?

— Винтер авхай үнэхээр эрхэм таны ярьж байгаа гэмт хэргийг үйлдсэн юм бол цээрлэл хүлээх болноо.

— Миледи цээрлэл нэгэнт хүлээсэн.

— Хэн түүнийг цээрлүүлээ вэ?

— Бид

— Шоронд байгаа юм уу?

— Үгүй, үхсэн.

Хамба ламтан чихэндээ итгэж чадахгүй,

— Үхсэн гэнээ? үхэж гэв үү? та тэгж хэлэх шив? гэлээ. Тэр бүсгүй намайг гурав дахиж алах гэхэд нь би өнгөрөөсөн, гэтэл тэр бүсгүй миний хайр сэтгэлт хүнийг алчихсан байхаар манай нөхөд бид хөөж бариад, шүүж цаазаар аваачих ял оноосон. Ингээд Бетюна бүсгүйчүүлийн хийдэд Бонасье авгайд хор уулгачихсан байсан, ганц жижиг байшинд хэрэг тасалсан, Лиса голын эрэг дээр цаазалсан тухай д' Артаньян ярьж өглөө.

Хамбын бие зарсхийх нь ховор боловч энэ удаа хамаг бие зарсхийгээд явчихлаа. Гэтэл гаргаж хэлээгүй нэг бодлын улмаас хамбын өнөө хүртэл хөрзгөр байсан царай бага багаар зөөлөрч, энгийн тайван болоод:

— Ингэхлээр хэрэг шүүх эрхгүй мөртлөө, хэрэг тасалсан хүмүүс хүн алсан болдгийг та нар бодож үзэлгүй шүүгчийн эрхийг дураараа эдлээ шив? гэж Хамба зөөлөн дуугаар хэлсэн нь уул хатуу үгтэйгээ сайн авцалдахгүй байв.

— Их гэгээнтэн таны өмнө биеэ зөвтгөх санаа надад өчүүхэн ч байгаагүй гэдгийг амлая. Их

гэгээнтэн таны оногдуулах шийтгэлийг би хүлээхэд бэлхэн байна. Би хар амиа нэг их хайрладаггүй болохоор үхэхээс айхаар хүн биш юм, гэсэнд хамба ламтан бараг эелдэг дуугаар:

— Таны эрэлхэг зоригтойг би мэднэ. Тэхлээр таныг шүүж, шийтгэл оногдуулна гэдгийг урьдаас хэлж болно гэв.

— Надаас өөр хүн бол ял хэлтрүүлсэн бичиг өвөрт минь байна гэж их гэгээнтэнд хэлэх биз. Тэхэд би бол юунаас ч буцахгүй гэгээнтэн та айлдаж хайрла гэж байна, гэж д' Артаньян өгүүллээ.

— Ял хэлтрүүлсэн бичиг ий? гэж Ришелье гайхсанд, д' Артаньян:

— Тиймээ гэгээнтэн гэж өчив.

— Хэний гарын үсэгтэй юм бэ? Ван эзний юу? гэхдээ тун үл тоомсорлох дуугаар хэлэв.

— Үгүй, их гэгээнтэн таны гарын үсэгтэй юм.

— Миний юу? та яав, солиороогүй биз?

— Гэгээнтэн та өөрийнхөө гарын үсгийг лав танина бизээ, гээд д' Артаньян нөгөө Миледигээс Атосын булааж аваад өөрт нь бие хамгаалах бичиг болж байг гэж өгсөн чухаг бичгийг Хамбад өглөө.

Хамба бичгийг аваад, үг болгоныг таслан хянуур уншсан нь:

«Үүнийг үзүүлэгчийн үйлдсэн бүхэн улсын ашиг тусын тулд, миний тушаалаар хийсэн болно. 1628 оны 8 дугаар сарын 5. Ришелье» гэжээ. Энэ хоёр мөрийг уншаад хамба ламтан гүн бодолд автаад бичгийг д« Артаньянд буцааж өгсөнгүй.

«Намайг яаж цаазлахаа бодож байх бололтой. Юу ч болсон тайж хүн яаж үхдэгийг үзүүлнэ дээ» гэж д' Артаньян дотроо бодов. Залуу цэргийн сэтгэл сайхан уужим байсан болохоор эр хүн шиг байж байгаад нөгөө ертөнцөд тонилоод өгөхөд бэлэн байв. Ришелье бодол болон нөгөө бичгийг нэг хуйлж, нэг дэлгэнэ. Тэгж байснаа толгойгоо сая нэг өргөж д' Артаньян нүдэнд дулаан ухаалаг эрдүү царайг хурц нүдээрээ хянуур ширтээд, залуугийн сүүлийн нэг сард үзэж өнгөрүүлсэн зовлон, нулимсны орыг олж хараад дөнгөж хорин нэгэн нас хүрч яваа энэ залуу цаашдаа хир их сайн хүн болох төлөвтэй байсан, үүнийг захирч чадсан мэргэн хүн эр чадал, оюун самбаагийн нь яаж сайн ашиглаж болохыг дотроо хэд хэд дахин эргэцүүлж бодлоо.

Нөгөө талаас Миледийн үйлдсэн гэмт хэрэг, адтай их. чадлаас Хамба өөрөө айх удаа ганц биш дайралдаж байжээ.

Хамба аюултай хамсаатнаас үүрд ангижирчээ гэдгийг бодохоос, сэтгэлийнхээ угт баярлаад байлаа.

д' Артаньяны уудам сэтгэлээр эргүүлж өгсөн цаасыг Хамба алгуурхан ураад хаячхаар «Би ч ингээд өнгөрчээ» гэж д' Артаньян бодоод «Бурхны таалал ёсоор болтугай» гэсэн байртай Хамбын өмнө доор мэхийн ёслол.

Хамба ламтан ширээ рүү очоод, дэлгээстэй байсан, ихэнхийг нь бөглөсөн хуудсан дээр нэмж хэдэн үг бичээд тамгаа дарлаа.

. «Миний ялын тогтоол байж таарна. Хамба ламтан намайг Бастили гянданд хоригдож, шүүхээр орж төвөг удах ажлаас хэлтрүүлж байна. Ингэж өгсөн нь их эелдэг хэрэг дээ» гэж д' Артаньян бодлоо.

— Май үүнийг ав. Би танаас нэг бичиг авсан, оронд нь өөрийг өгье. Энэ үнэмлэхэн дээр нэр тавиагүй юм, өөрснөө тавьж орхиорой гэж Хамбыг хэлэхэд д' Артаньян бичгийг түдгэлзэхийн авч үзвэл шадар цэргийн дэслэгч цол шагнасан зарлиг байв. д' Артаньян Хамбын өмнө сөхрөн:

— Гэгээнтэн одооноос эхлээд миний бие таны төлөө зүтгэнэ, өөрийнхөө тааллаар намайг зарж байна уу. Даан ч би таны үзүүлж байгаа энэ өндөр их хишгийг хүртэх болоогүй, надаас илүү их гавьяатай, үүнд тэнцэх гурван сайн нөхөд бий, гэтэл Хамба үгийг нь таслан, энэ зоримог эрийн сэтгэлийг дагуулж чадсандаа дотроо таатай болоод, мөрий нь нөхөрсгөөр алгадан:

— д' Артаньян та сайн хүн. Энэ үнэмлэхийг өөрийнхөө дураар хэрэглээрэй. Тэхдээ нэр бичээгүй хэдий боловч энэ үнэмлэхийг би өөрт чинь өгч байгааг бодолцоорой гэлээ.

д' Артаньян: Үүнийг би хэзээ ч мартахгүй, их гэгээнтэн та итгэж болно гэж хариулав. Хамба ламтан эргэж чанга дуугаар:

— Рошфор! гэж дуудсанд үүдний цаана зогсож байсан бололтой шадар хүн даруй орж ирлээ.

— Рошфор оо, таны өмнө д' Артаньян гуай байж байна. Энэ хүнийг би нөхдийнхөө тоонд оруулж авлаа. Тэхлээр та хоёр толгойгоо мэнд авч явах дуртай бол эвлэрч үнсэлцээд тохитой шиг явцгаа, гэж Хамба хэллээ.

— Рошфор, д' Артаньян хоёр уруулаа дөнгөж хүргэх төдий болж үнсэлцэхэд Хамба ламтан дэргэд нь зогсоод хурц нүдээ салгалгүй харав. Хоёул өрөөнөөсөө цуг гарлаа.

Эрхэм ээ, бид дахин уулзана, тийм биз? гэхэд д' Артаньян өөдөөс нь:

— Таны таалалтай цагт л уулзана гэв.

— Тохиромжтой цаг мөд олдоно гэж Рошфор хэлтэл Ришелье үүд онгойлгоод:

— Юу гэнээ гэж асуулаа.

Хоёр залуу даруй өөд өөдөөсөө харж инээмсэглээд гар барилцсанаа их гэгээнтнийг хүндэтгэн мэхийв.

— Бид бүр хүлцэж ядаж байлаа шүү, гэж Атосыг хэлэхэд д'Артаньян:

— За би гараад ирлээ дээ нөхөд минь! Би сул чөлөөтэйгөөр барахгүй хайр, хишиг хүртлээ гэж хариулав.

— Та цөмий нь бидэнд ярьж өгнө биз?

— Өнөө оройдоо ярина.

Үнэхээр ч д'Артаньян тэр оройдоо Атосынд очтол цаадах нь шил испани дарс ууж суув. Сүүлийн үед Атос орой болгон тэгдэг болжээ. Хамбынд ороод болсон бүх явдлыг д'Артаньян ярьж өгөөд өврөөсөө үнэмлэх гаргаж:

— Эелдэг сайн нөхөр Атос минь үүнийг аваа. Энэ яахын аргагүй чиний юм, гэсэнд Атос ердийн зангаар эелдэг сайхан инээмсэглээд,

— Найз минь энэ чинь Атост дэндүү өндөр, де ла Фер гүнд хэтэрхий өчүүхэн хишиг байна. Энэ үнэмлэхээ өөрөө ав. Энэ чинь аргагүй таны юм. Та үүнийг өндөр их үнээр олж авсан шүү хөөрхий гэж хариуллаа.

д* Артаньян Атосынхаас гарч Портосынд ортол, Портос үнэтэй сайхан хатгамалтай гоё гадуур цамц өмсч тольдон өөрийгөө шохоорхож байснаа:

— Аа найз чи юу! энэ хувцас над хир зохиж байх шиг санагдана, найзаа? гэв.

— Их сайхан зохижээ, харин би өөрт чинь арай илүү зохих өөр хувцас өмсөөч гэж хэлэх санаатай ирлээ гэж д'Артаньян хариулав.

— Ямар хувцас тэр вэ?

— Шадар цэргийн дэслэгчийн хувцас гээд, д'Артаньян Хамбатай уулзсан тухай яриад Хамбын өгсөн үнэмлэхийг гаргаж

— Май сайн найз минь энэ үнэмлэхийг аваад нэрээ бичиж над сайн дарга болоорой гэв. Портос үнэмлэхийг үзээд буцааж өгсөнд д'Артаньяны гайхсаныг хэлэхэд бэрх.

— Нээрээ энэ чинь над тааламжтай сайхан байхсан. Гэтэл би энэ хишгийг удаан хүртэж чадахгүй. Биднийг Бетюн оргож явах зуур миний нөгөө холбоотой авхайн нөхөр герцог нас барсан байна. Одоо талийгаачийн авдар миний гарт орж ирэх гээд байна. Эелдэг найз минь би бэлэвсэн эхнэртэй нь сууна. Харж байгаа биз дээ, би хуримынхаа хувцсыг өмсөж үзэж байна. Дэслэгч цолоо өөрөө эдлээрэй. найз минь, өөрөө эдэл, гээд үнэмлэхийг нь буцааж өглөө.

Залуу цэрэг цаашаа Арамисынд очлоо. Арамис бурхны ном дэлгэж тавиад сөхрөн сууж, толгойгоо унжуулан залбирч байв.

д'Артаньян хамбатай уулзсан тухайгаа Арамист ярьж өгөөд үнэмлэхээ гуравдах удаа гарган,

— Та бол бидний ухаалаг сайн нөхөр, далдын өмөг түшиг болсон хүн, энэ үнэмлэхийг аваа. Бидэндээ ямагт урагштай бүтэлтэй зөвлөгөө өгдөг, саруул мэргэн хүн та л үүнийг авч таарах учиртай гэж хэлсэнд Арамис санаа алдаад:

— Үгүй дээ эелдэг найз минь. Бидний сүүлчийн энэ явдал хорвоогийн амьдрал, цэргийн албанд намайг бүрмөсөн дургүй болголоо.. Энэ удаа би эргэж буцалтгүй шийдэж, бүслэлт дуусмагц би сахил хүртэнэ. Наад үнэмлэхээ д' Артаньян та өөрөө ав, цэргийн албанд та хамгаас илүү сайн тохирох хүн. Та авхаалж самбаа, эр зоригтой сайн дарга болно гэв.

д' Артаньян эргэж Атос дээр ирэхдээ нөхдөдөө магнай хагартлаа баярлаж, баярласандаа нүд нь гялалзаж байлаа. Атос түрүүчийнхээрээ ширээний ард сууж, сүүлчийн аяга дарсны өнгийг дэнгийн гэрэлд гэрэлтүүлэн харж суулаа.

— За ингээд нөгөөдүүл маань бас авсангүй гэж д' Артаньян хэлсэнд Атос:

— Энэ хишгийг чухам хүртвээс зохих хүн та болохоор тэр шүү дээ гээд үзэг авч үнэмлэхэн дээр д' Артаньяны нэрийг бичээд өгөв. Залуу цэрэг:

— За ингээд би найз нөхөд үгүй болжээ. Өнгөрснийг дурсаж сэтгэл шимшрэхээс өөр юу ч үгүй болох шив дээ хөөрхий! гээд уруу харахад хацрыг нь дагаж бөөн нулимс бөмбөрлөө.

— Та идэр залуу байна, өнгөрсөн гунигт явдал чинь мартагдаж баярлах цаг ирнэ гэж Атос хариулав.

ЖИЧ ӨГҮҮЛЭХ НЬ

Ларошель хот Бекингэмийн амласан ёсоор английн усан цэргээс тусламж авч чадалгүй, жил хир бүслэгдэж байгаад, 1628 оны 10 дугаар сарын 28 ны өдөр бууж өгөв. Ван эзэн мөн оны 12 дугаар сарын хорин гуравны өдөр Парис руу эргэж морджээ. Ван эзнийг францчуудаа номхтгоод ирсэн биш дайснаа дараад ирсэн юм шиг хүнд ёслолоор угтаж авлаа. Парисын Сен Жак гэгч хүрээнд ёслолын хаалга барьж, цэцэг, ногоогоор чимсний доогуур ван эзэн заларч ирэв.

д'Артаньян дэслэгч цол шагнагдсанаа эдэлж, Портос цэргийн албанаас гарч дараа жил нь Кокнар авгайтай гэрлээд, нөгөө хорхой хүргэдэг авдранд нь найман зуун мянган зоос байжээ. Мушкетон зарцын сайхан хувцас өмсөх болж, алталсан сүйхний бүхээгийн хойно сууж явахсан гэж насан туршаа мөрөөдсөн нь биелж жаргалын дээдийг амсав. Арамис, Лотаринг муж руу нэг явж ирээд, гэнэт алга болж, нөхдөдөө ч захиа зангаа бичихээ больчихжээ. Хожим де Шеврез авгай өөрийнхөө явдаг байсан хоёр гурван хүнд ярьснаар Арамис Нажи гэгч газар хийдэд сахил хүртээд суух болжээ. Базен бас гэлэн болсон. Атос 1631 он хүртэл д'Артаньяны захиргаан дор шадар цэрэг байгаад, Гурень гэгч газар яваад ирсний дараа. мөн, Русильон гэдэг газар бага сага хөрөнгө өвлөж авлаа гэдэг шалтгаанаар цэргийн албаа орхив. Гримо эзнээ дагалдан явлаа.

Рошфортой д'Артаньян гурван удаа тулалдахдаа гурвууланд нь цаадахаа шархдуулжээ. Сүүлчийн удаа Рошфорыг түшиж босгохдоо дөрөвдөх удаагаа таныг би лав алах бий, гэхэд Рошфор өөдөөс нь:

Ер нь бид ингээд дуусгавал хэн хэнд маань зүгээр юмсан. Чөтгөр алгад би чамд чиний санадгаас илүү талтай сайн юм шүү. Анх уулзсаны дараа би Хамба ламтанд ганцхан үг хэлсэн бол толгойгий чинь авхуулж орхих байсан даа гэлээ.

Ингээд тэр хоёр энэ удаа ямар ч өшөө хонзон өвөрлөсөн юмгүй, үнэхээр эвлэрэн тэврэлдлээ. Планше, Рошфорын дэмжлэгээр торгон цэргийн бага дарга цолтой болжээ. Бонасье гуай эхнэрийнхээ юу болсныг мэдсэн ч үгүй, хойноос нь сэтгэл нь зовсон юмгүй тайван сууж байж. Тэгснээ нэг өдөр гэнэдээд Хамба ламтанд өөрийнхөө тухай сануулчихсан чинь Хамба хариуд нь Бонасье гуайг одоогоос эхлээд санаа зовох юмгүй байлгана гэжхэлүүлжээ.

Үнэхээр ч Бонасье авгай маргааш нь лувр ордонд очих санаатай гэрээсээ гараад Авсчины гудамжинд эргэж ирсэнгүй. Лавтай учир мэдсэн улсын ярилцах нь Бонасье гуай Хамбын өгөөмөр сэтгэлийн шилтгээнд ван эзний нэгэн адил хоол, байрны үнэ төлнө гэхгүй амар суух болсон гэх боллоо.